

ЖОРЖ
МАРТИН



ИЛДНИЙ
ШУУРГА

1. ГАН болон ЦАС

ЖОРЖ
МАРТИН



ИЛДНИЙ
ШУУРГА

1. ГАН БОЛОН ЦАС

ЖОРЖ МАРТИН
ИЛДНИЙ ШУУРГА

1. ГАН болон ЦАС

www.kiebooks.com

ЭХЛЭЛ

Бүрхэг жихүүн жавартай өдөр ноход үнэр авч чадсангүй.

Том хар жингэр баавгайн сарвуун мөрийг шиншилсэнээ сүрэг өөдөө сүүлээ унжуулан буцлаа. Ноход голын эргийн жихүүн салхинд шавхуурдуулан нэг дороо хургав. Чэтт ч бас үүнийг мэдэрсэн бөгөөд салхи хар ноосон хувцас, ширэн хантаазны завсар нэвт сийгэнэ. Энд тэдний байгаа газар хүн байтугай араатан амьтан тогтохын аргагүй дэндүү хүйтэн ажээ. Түүний ам татвалзахад бараг л хацар дээр шавсан батга, хүзүүн дээр гарсан том улаан хатиг мэдрэгдлээ. *Би одоо ард аюулгүй Ханан дээр хараал идсэн хэрээ тэжээж хөгшин мэйстер Эймоны галыг түлж байх ёстой байсан юм.* Энэ бол бутач Жон Сноу түүний байрыг тарган найз Сэм Тарлидаа өгснөөс болсон хэрэг. Тэднээс л болж тэр энд Сүнстэй ойн гүнд чөмгөө хөлдтөл сүрэг ноходтой байгаа билээ. Чэтт нохдын анхаарлыг татахаар уяанаас нь хүчтэй угзарлаа.

- Долоон там минь гэж. Мөр хайцгаа новшнуудаа. Наана чинь баавгайн мөр байна. Та нар мах идэхийг хүсч байгаа юм уу үгүй юм уу? Хай! гэхэд ноход зөвхөн өөр хоорондоо шахцалдан гиншлээ. Чэтт тэдний толгой дээгүүр богино ташуураар ороолгон урдаас нь архирсан хар жингэрийг,

- Нохойн мах баавгайн махнаас дутахгүй сайхан амттай шүү гэж амьсгалынхаа үг болгонд цан татуулан сүрдүүлэв.

Ларк Систерман ханцуйндаа гараа шургуулан цээжиндээ зөрүүлэн зогсож байв. Тэрбээр хар ноосон бээлий өмссөн ч үргэлж хуруу нь хөлдөх гэж байна гэж гонгиноно.

- Энд агнахад дэндүү хүйтэн байна. Баавгайг хараал идэг түүнтэй түүнгүй осгож үхэх гэж байна гэхэд нь,

- Бид хойшоо хоосон гартай буцаж болохгүй, Ларк. Захирагч лордод энэ таалагдахгүй гэж Бага Пол гэдэг нүүрнийхээ ихэнхийг хучсан бавгар хүрэн сахалтай хүн хэллээ. Түүний навтгар хамрын дор хөлдүү нус унжиж зузаан арьсан бээлийтэй бадируун гартаа жадны иш чанга барьсан байв.

- Хөгшин баавгайг ч гэсэн хараал идэг. Мормонт тэртээ тэргүй үүр цайхаас өмнө үхнэ биз дээ? Түүний юу хэлэх хэнд хамаатай юм? гэж гозгор нүүртэй туранхай бие гүйлгэнэсэн нүдтэй Систерман хэллээ.

Бага Пол жижигхэн хар нүдээ анивчив. Магадгүй тэр мартсан ч байж мэднэ. Чэттийн бодлоор бол тэр юу ч тогтоохын аргагүй усан тэнэг байлаа.

- Яагаад бид Хөгшин баавгайг алах ёстой гэж? Яагаад бид түүнийг зүгээр орхиж болдоггүй юм бэ? гэж тэр хүнгэнүүлэв.

- Харин чи тэр биднийг тайван орхино гэж бодож байна уу? Тэр биднийг хөөж агнана. Чи агнагдахыг хүсээд байгаа юм биз дээ, махан толгойт минь? гэж Ларк хэллээ.

- Үгүй л дээ. Би үүнийг хүсээгүй. Би тэгээгүй.

- Тэгвэл чи түүнийг алах уу?

- Тийм. Би ална. Тэр биднийг агнаж чадахгүй гээд нүсэр биет жадныхаа бөгсөөр хөлдүү голын эрэг дэлсэхэд Систерман ханцуйнаасаа гараа сугалан Чэттийн зүг эргэв.

- Бид албаны бүх дарга нарыг алах хэрэгтэй гэж бодож байна.

Чэтт энэ тухай сонссоор залхжээ.

- Бид энэ тухай ярилцсан биз дээ. Хөгшин баавгай болон Сүүдэрт цамхагаас ирсэн Блэйнийг ална. Харуул шалгуулахгүйн тулд Грабб, Эйтан хоёрыг, араас мөрдүүлэхгүйн тулд Дайвиныг, Баннентай, ноён Гахайг хэрээ илгээхгүйн төлөө ална. Бүгдийг нь. Бид тэднийг унтаж байхад нь чимээгүй ална. Ганц хашгиралт гарах юм бол бид бүгд өтний хоол боллоо гэсэн үг гээд хилэгнэсэндээ батга нь улайлаа.

- Чи зүгээр л өөрийн зүйлээ хийгээд үеэлийнхийгээ ч гэсэн гүйцэтгүүл. Харин Пол чиний ээлж бол гурав дахь харуул болохоос биш хоёр дахь биш гэдгийг санаарай.

- Гурав дахь харуул. Хөнгөн хөлт бид хоёр. Би санах болно, Чэтт гэж том биетэй хүн хөлдүү нус унжсан өтгөн сахлынхаа завсар гүвтнэлээ.

Тэр шөнө саргүй харанхуй болохоор тэд найман хүнээ харуулд, хоёрыг нь морьдын манаанд гарахаар зохион байгуулжээ. Үүнээс сайн боломжийг хүлээхийн ч хэрэг байсангүй. Зэрлэгүүд хэдийд ч хүрч ирж болох байлаа. Чэтт тийм зүйл болохоос өмнө холхон зайлахыг боджээ. Тэр амьд байхыг хүсч байв.

Хойд зүг гурван зуун Шөнийн харуулын тангарагт ахан дүүс мордсоноос хоёр зуу нь Хар цамхаг, нэг зуу нь Сүүдэрт цамхагынх байлаа. Энэ нь амьд хүний дурсамжин дахь хамгийн том эргүүлийн арга хэмжээ болсон бөгөөд ойролцоогоор Харуулын гуравны нэг хэсэг хүч хөдөлжээ. Тэд Бэн Старк, сэр Вэймар Ройс болон өөр бусад алга болсон эргүүлүүдийг хайхын зэрэгцээ зэрлэгүүдийн яагаад тосгоноо орхисны учрыг тодруулах ёстой байв. Гэсэн ч Ханыг орхисон цагаас хойш Старк, Ройсын алиныг олсонгүй хэдий ч зэрлэгүүдийг бурхад мартсан Мөсөн соёотын мөсөн хяр руу явсныг илрүүлжээ. Ингээд тэндээ Чэттийн хатигны нэгээхэн бээр хагарах хүртэл төвхнөсөн байна.

Гэвч үгүй байлаа. Тэд Сүүн усыг уруудан ирж байв.

Чэтт харцаа дээш өргөв. Голын мөсөн унжлагатай чулуун эргийн дагуу Мөсөн соёотоос эх авсан сүүн цагаан ус эцэс төгсгөлгүй урсана. Харин одоо түүний дагуу Манс Райдер болон зэрлэгүүд ижил замаар ирж байв. Гурван өдрийн өмнө Торен Смолвуд эргэн иржээ. Тэр Хөгшин баавгайд туршуулуудынхаа юу харсныг хэлж, түүний хүн Кэдж Вайт үлдсэнийг нь гүйцээн ярьжээ. Тэрбээр галд гараа ээн дулаацуулангаа,

- Тэд толгодын ёроолоос зэгсэн зайд байгаа ч гэсэн ирж байна. Хошууч ангийг нь цоохор гичий Нохойн толгой Харма тэргүүлж байгаа. Годи буудал руу нь мөлхөж хүрээд галын гэрэлд тодорхой харсан гэсэн. Тэнэг Тамбержон түүнийг харвах шахсан ч Смолвуд түүнийг хориглох ухаантай байлаа.

- Тэнд хичнээн хүн байсныг чи мэдэх үү? гээд Чэтт нулимлаа.

- Маш олон. Хорин гучин мянга орчим хүн байсныг бид тоолоогүй. Хармад тус бүр морьтой таван зуун хүнтэй хошууч анги байсан.

Галын эргэн тойрон байсан хүмүүс амаргүй харц солилцлоо. Арван морьтой зэрлэгүүдтэй тааралдах гэдэг ховор зүйл байтал таван зуу гэдэг чинь?

- Смолвуд Баннен бид хоёрыг хошууч ангийг өргөн тойрч гол хүчийг нь тандахаар явуулсан. Тэдний цуваанд эцэс төгсгөл байгаагүй. Дөрөв таван милийн зайд хөлдүү гол шиг алгуурхан бургилан цувж тосгон руугаа буцаж байгаа юм шиг байдалтай харагдаагүй. Ихэнхи хагас нь эмэгтэйчүүд, хүүхдүүд хонь ямаа мал амьтдаа урдаа тууж бух гөрөөс хүртэл чарганд хөллөсөн байсан. Тэд бухал өвс, арьс, мах, тортой тахиа, цөцгий хутгагч, ээрмэлийн дугуй гээд хараал идсэн бүх зүйлээ авч явж байсан. Луус, морьдоо нуруу хугарах нь уу гэмээр хүнд ачаалан эмэгтэйчүүд нь ч гэсэн ижил.

- Тэд тэгээд Сүүн усны дагуу ирж байгаа юм уу? гэж Ларк Систерман асуув.

- Би чамд тийм гэж хэлсэн биз дээ?

Сүүн ус тэднийг Шөнийн харуулын буудалласан Анхны хүмүүсийн Нударга хэмээх эртний дугуй чулуун хэрмээс цааш хөтлөх байлаа. Хуруун чинээ өчүүхэн ухаантай ямар ч хүнд зоосон гадас нь хана руу унах цаг болсон илт байв. Хөгшин баавгай Нударга дээр гадас шаан бэхэлж, шуудуу ухуулан, ямаан зангуу хаяулсан ч дайсны их цэргийн эсрэг ямар ч ашиг байсангүй. Хэрвээ тэд энд үлдэх юм бол хүчинд автан дийлдэх нь зайлшгүй.

Торен Смолвуд дайрахыг хүсч байв. Смолвуд Локийн майхан руу ордог шөнө Хонгор Доннел Хилл сэр Малладор Локийн дагуул хиа байв. Сэр Малладор Хана руу буцахыг шаардаж буй хөгшин сэр Отин Вайтерсийн адил бодолтой байсан ч Смолвуд түүнийг ятгаж үгэндээ оруулжээ.

- Ханын цаадах хаан хэзээ ч бидэнтэй алс хойд зүг тулгарна гэж бодоогүй. Тэгээд ч түүний их цэрэг ямар ч эмх замбараагүй бөөгнөрсөн ашиггүй ам дүүрэн илднийхээ аль талаас барихыг мэдэхгүй хүмүүс байгаа. Ганцхан цохилт өгөхөд тэднийг овоохой руу нь гэдрэг орь дуу тавин зугтаалгаж ахин тавин жилийн турш цухуйлгахааргүй болно гэж Доннел хэлжээ.

Гучин мянган хүний эсрэг гурван зуугуулаа. Чэттийн бодлоор энэ нь цэвэр ухаангүй явдал байсан ч сэр Малладор түүнтэй нийлэн Хөгшин баавгайг ятгахаар болжээ.

- Хэрвээ бид дэндүү алгуурлахад хүрвэл боломж алдагдаж ахин хэзээ ч олдохгүй гэж Смолвуд яриаг нь сонссон бүх хүнд баталж байлаа. Үүний эсрэг сэр Оттин Вайтерс,

- Бид хаант улсын хүмүүсийг хамгаалах бамбай. Чи ямар ч сайн зорилгын төлөө бамбайгаа хаяж болохгүй гэхэд Торен Смолвуд,

- Илдний тулаанд хамгийн найдвартай хамгаалалт бол түргэн цохилтоор дайснаа дарах явдал болохоос биш бамбайн ард нуугдах биш гэж мэтгэв.

Гэсэн ч Смолвуд, Вайтерсийн хоёрын хэн ч захирах эрхгүй лорд Мормонт захирагч байсан болохоор Аварга биетийн гишгүүр лүү өгссөн Жарман Баквелл тэргүүтэй Хашгираа даваа руу явсан Жон Сноу, Мухар гарт Корин зэрэг тандуулуудаа хүлээж байв. Баквелл болон Корины ирэлт хожимдож байгаагаас үзвэл юунаас түрүүнд үхсэн байж болох талтай. Чэтт Жон Сноуг нүцгэн уулын оройд зэрлэгийн жад бутач бөгсөнд нь зоолгоостой хөлдүү хөхрөн хэвтэж буйгаар төсөөлөхөд энэ бодол инээмсэглэлийг нь хүргэв. *Тэднийг бас түүний хараал идсэн чоныг алсан гэж найдаж байна.*

- Энд ямар ч баавгай байхгүй. Зөвхөн хуучин мөр байна. Нударга руу буцацгаая гэж тэр огцом шийдэхэд ноход нь хөл дээрээс нь угз татах шахам ирсэн зүг рүүгээ буцав. Магадгүй тэд хооллохоор явж байна гэж бодсон бизээ. Чэттийн инээд хүрэв. Тэр тэднийг гурван өдрийн турш тэжээгээгүй болохоор улангассан өлсгөлөн байлаа. Өнөө шөнө харанхуйд зугатахын өмнө тэднийг морьдын уяа хооронд суллаад Хонгор Доннел Хилл, Клабфүүт Карл хоёртой зэлний уяаг таслана. *Архирсан ноход айсан морьдыг үргээхэд Нударга дээрх түүдгийн дундуур үймрэн давхилдаж хэрмийн хана дээгүүр харайн майхан савыг гишгэлнэ.* Энэ бүх үймээн самуун дунд арван дөрвөн хүн алга болсныг хэдэн цагийн турш хэн ч анзаарахгүй.

Ларк тоогоо хоёр дахин нэмэгдүүлэхийг хүсчээ. Тэнэг битүү загас ханхалуулсан Систерманаас өөр юу ч хүлээх билээ дээ. Ганц л үг буруу чихэнд шивнэхэд агшин зуур толгойгүй болох аюултай. Үгүй дээ, арван дөрөв бол сайн тоо бөгөөд хэрэгтэй зүйлээ хийхэд нууц хадгалж чадахгүй олон хүн байснаас хамаагүй дээр. Тэдний ихэнхийг нь Чэтт өөрөө элсүүлжээ. Бага Пол түүний нэг байсан бөгөөд Ханан дээрх хамгийн хүчтэй хүн хэр нь үхсэн эмгэн хумс адил удаан байв. Тэр нэг удаа зэрлэгийн нурууг ганц тэврэлтээр хугалжээ. Түүнчлэн дуртай зэвсэг болох хутгаар өөрийгөө нэрлэсэн Чичлүүр болон, ахан дүүсийн Хөнгөн хөлт гэж дууддаг залуудаа зуугаад эмэгтэй хүчиндсэн гэж онгирох дуртай ч хэн ч хэзээ ч түүнийг нь харж сонсож байгаагүй жижигхэн буурал хүнийг элсүүлжээ.

Бүхий л төлөвлөгөөг Чэтт ухаалагаараа бодож олжээ. Тэр бутач Жон Сноу ажлыг нь булаан тарган гахай найздаа булааж авч өгөх хүртэл хөгшин мэйстер Эймонд дөрвөн жил бойдоогоор зүтгэсэн билээ. Өнөө шөнө Сэм Тарлиг алах үедээ зориуд үг шивнэхээр төлөвлөжээ.

- Миний мэндийг лорд Сноуд дамжуулаарай гэж баруун чихэнд нь шивнэн ноён Гахайн хоолойг огтлоход цус өөхөн давхаргыг нэвт бургилан гарна. Чэтт хэрээнүүдийг мэдэх учир Тарлигаас илүү төвөг удах явдал байхгүй. Хутга ганц тулгамагц хулчгар амьтан өмдөндөө тавьж амь аврахыг уйлан гуйна биз. *Гуйж л байг тэглээ гээд түүнд юугаар ч туслахгүй.* Түүний хоолойг огтолсны дараа торыг онгойлгож Хананд захиа хүргэхгүйн тулд шувуунуудыг үргээн нисгэнэ. Энэ хооронд Хөнгөн хөлт, Бага Пол хоёр Хөгшин баавгайг алж, Чичлүүр Блэйний учрыг олоход, Ларк үеэлтэйгээ араас мөр шиншлүүлэхгүйн тулд Баннен, хөгшин Дайвинийг чимээгүй болгоно. Тэд

хоёр долоо хоногийн хүнс нөөцөлсөн бөгөөд Хонгор Доннел, Клабфүүт Карл хоёр морьд бэлэн байлгана. Мормонтыг үхсэн хойно удирдлага сэр Оттин Вайтерсийн гарт шилжих болохоор хөгшин аймхайн дээр зүрхгүй. *Тэр нар жаргахаас өмнө Хана руу зугтан алга болохыг бодохоос биш бидний араас нэхэн хөөх хүн тавихгүй.*

Ноход түүнийг модон дундуур чирэн явлаа. Өмнө мөнх ногоон модон дунд Нударга эгц өлийнө. Энд өдрийн цагаар ч гэсэн харанхуй байдаг учир Хөгшин баавгай эгц чулуун толгодын оройг эмжсэн дугуй хэрмийг тойруулан бамбар зоолгожээ. Тэд гурвуул гадаргуу нь мөстсөн толботой гол туулахад ус мөс шиг хүйтнээр хайрав.

- Би үеэлтэйгээ эрэг рүү явна. Бид завь дархалж Эгч дүүс дэх гэр лүүгээ буцна гэж Ларк Систерман ярив.

Харин гэрт чинь чамайг оргон зайлагч гэж мэдэх болохоор тэнэг толгойг чинь тас цавчина. Энд амлалт хэлсэн тохиолдолд Шөнийн харуулаас буцах зам үгүй байлаа. Долоон ханлигийн хаана ч байсан тэд чамайг барьж аваад алах болно.

Олло Лопханд өчүүхэн хулгай хийсний төлөө гарыг нь цавчих юм уу хүлэг баатрын эхнэрийн өвөрт шургасны төлөө хөлдүү газар цөлдөггүй Тайрош руугаа буцах тухай ярьж байв. Чэтт түүнтэй хамт явахаар бодсон ч охидын хоосон ярианд нь оролцсонгүй. Ер нь тэр Тайрошид юугаа хийх болж байна? Чэтэд арилжаа наймаа хийх авьяас байсангүй. Тэр Шуламын намагт өсөж эцэг нь бүхий л амьдралаа бусдын талбайгаас хануур хорхой барин өнгөрүүлжээ. Эцэг нь ширний өөдсөөс өөр зүйлгүй нүцгэлэн булингартай ус руу орон гарч ирэх үедээ цээжнээсээ шагай хүртлээ хануур хорхойд битүү хучигдсан байна. Заримдаа тэр Чэттийг хануур хорхой салгахад туслалцуулдаг байв. Нэг удаа алганд нь хорхой наалдсанд зэвүүцэндээ няц дарсанд эцэг нь үүний төлөө цус гартал нүджээ. Мэйстерүүд арван хоёр хануур хорхойг нэг пеннигээр авдаг байлаа.

Ларк, хараал идсэн Тайрош хоёр гэр лүүгээ явах дуртай байсан ч Чэтт тэгсэнгүй. Тэр Хөгшин шулмын намгийг ахин хэзээ ч харахгүй. Түүнд Крастерын өргөө таалагдаж байв. Крастер тэнд язгууртан лорд шиг амьдарч байсан байхад тэр яагаад ижил зүйл хийж болохгүй гэж? Энэ тухай бодол инээдийг нь хүргэнэ. Чэтт хануур хорхойчины хүүхэд өргөөний лорд. Магадгүй түүний далбаа ягаан өнгийн талбар дээрх арваад хануур хорхой байх буй за. Гэвч яагаад зөвхөн лордоор зогсох ёстой гэж? Магадгүй тэр хаан болж болох юм. *Манс Райдер хэрээнээс эхэлсэн. Би түүнтэй ижилхэн хаан болж олон эхнэр авч болох юм.* Крастерт орондоо оруулж дэр нэгтгээгүй залуухан багуудыг тооцохгүй арван есөн эхнэр байлаа. Эхнэрүүдийн хагас нь Крастер шигээ хөгшин царай муутай боловч энэ хамаа байсангүй. Хөгшнөөр нь нь Чэтт хоол унд хийлгэн, гэр цэвэрлүүлж, лууван тариулан, гахай маллуулахад залуунууд нь орыг нь дулаацуулж хүүхэд гаргана. Бага Пол түүнийг тэврэх хүртэл Крастерийн урдаас эсэргүүцэл байгаагүй.

Чэттийн мэдэх хүүхнүүд гэвэл Сохор номингийн сууринд авсан янхан байлаа. Түүнийг арай залуу байхад тосгоны охид булдруутай хатиг гарсан нүүр лүү нь хармагц дороо нүүр буруулан эргэдэг байв. Хамгийн дор нь шалиг Бесса байв. Тэр Хөгшин шулмын намгийн хөвгүүн бүртэй унтсан атал яагаад түүнтэй болохгүй гэж хэмээн сэтгэв. Чэтт түүнийг цэцгэнд дуртай гэж сонссон учир өглөөний турш цэцэг түүн өнгөрүүлсэн ч урдаас нь харан шоолон инээгээд түүнтэй нэг оронд

орсноос эцгийнх нь хануур хорхойтой байсан нь дээр гэж хэлжээ. Чэттийг хутга дүрмэгц түүний инээд зогсчээ. Энэ үед царай руу нь харах хамгийн амттай агшин байсан бөгөөд тэр хутгаа сугалснаа ахин дүрлээ. Хүмүүс түүнийг Долоон булгийн ойролцоогоос барихад хөгшин лорд Валдер Фрей өөрийн биеэр шүүх гэж түвэг удсангүй бутчуудынхаа нэг болох Валдер Риверсийг илгээсэнд дараагийн агшинд Чэттийн мэдэх зүйл гэвэл Ханын зүг өмхий үнэртэй хар чөтгөр Йорентой хамт явж байгаа явдал байлаа. Ганцхан амттай мөч түүний бүхий л амьдралыг авчээ.

Гэвч тэр одоо түүнийг буцааж авахын зэрэгцээ Крастерийн эмэгтэйчүүдийг ч гэсэн авах болно. *Тэр хөгшин зэрлэг бүгдийг зөв хийж. Хэрвээ чи эмэгтэй хүнийг эхнэрээ болгон авахыг хүсвэл батгаа нуухын тулд цэцэг бэлэглэх хэрэггүй.* Чэтт ахин ийм алдаа давтахгүй.

Энэ бүтнэ гэж тэр өөртөө зуунтаа андгайлжээ. *Хамгийн гол нь цэвэр зайлах чухал.* Сэр Оттин Хана руу хүрэх хамгийн товч зам болох өмнө зүг Сүүдэрт цамхаг руу хөдлөнө. *Тэр бидэнтэй зууралдаж төвөг удахгүй. Вайтерс л биш шүү. Тэр зөвхөн эсэн мэнд харихыг хүсч байгаа.* Торен Смолвуд дайрахыг хүсч байгаа ч сэр Оттин дэндүү болгоомжтойн дээр удирдах эрхтэй. *Энэ чухал биш. Биднийг явсан хойно Смолвуд хэн рүүгээ дайрна түүний дур биз. Бидэнд ямар хамаа байна? Гэсэн ч тэдний хэн ч Хана руу буцаж очихгүй бол бидний араас эрэх хүн тавихгүй бусадтай хамт үхсэн гэж бодно.* Энэ нь шинэ бодол байсан бөгөөд агшин зуур хорхойг нь хүргэв. Гэвч үүний тулд Смолвудад удирдлагыг өгөхөөр сэр Оттин, сэр Малладор Локийг алах хэрэг гарах бөгөөд харин тэд хоёул өдөр шөнөгүй сайн хамгаалалттай байдаг... үгүй дэндүү эрсдэлтэй юм байна.

- Чэтт шувуунууд яах бол? гэж Бага Пол харуул болон цэрэг нарснуудын дундах ангийн чулуурхаг жимээр явахдаа асуулаа.

- Юун шувуу?

Түүнд зөвхөн энэ махан толгойт шувууны тухай ярих нь дутаад байж гэнэ.

- Хөгшин баавгайн хэрээ. Хэрвээ бид түүнийг алвал шувууг нь хэн тэжээх юм?

- Хэнд хамаатай юм? Хүсвэл шувууг нь алахгүй юу.

- Би шувуунд хор хүргэхийг хүсэхгүй байна. Энэ чинь ярьдаг шувуу шүү дээ. Бидний хэлсэн зүйлийг давтах болов уу? гэж том хүн хэлэхэд Ларк Систерман хөхөрч,

- Хэрмийн хана шиг мулгуу ухаантай Бага Пол гэж шооллоо.

- Чи амаа хамхисан чинь дээр шүү гэж Бага Пол аюултай заналхийлэв.

- Пол тэд өвгөнийг хоолой огтлуулсан цусан дунд хэвтэж байхыг олох үед түүнийг алагдсаныг цааш нь мэдээлэх шувууны хэрэг байхгүй гэж Чэтт түүнийг дэндүү уурлахаас өмнө хэллээ.

Бага Пол хормын турш бодлогоширов.

- Энэ үнэн л дээ. Тэгвэл би шувууг авч болох уу? Би шувуунд дуртай гэхэд,

- Тэр чинийх гэж Чэтт түүнийг дуугүй болгохын тулд хурдхан дуугарав.

- Тиймээ бид өлссөн үедээ үргэлж түүнийг идэж болох юм гэж Ларк наргисанд Бага Пол ахин дүрсхийв.

- Миний шувуунд гар хүрэхгүй байсан чинь дээр шүү, Ларк.

Чэтт модон дунд хоолой гарахыг сонслоо.

- Та хоёр хоёул хараал идсэн амнуудаа хамхи. Бид Нударганд бараг хүрээд байна.

Тэд толгодын баруун талаас гарч ирээд арай намхан өмнө зүг тойрлоо. Ойн захын ойролцоо арваад хүн харвах сургууль хийн модны их биеэнд сийлбэрлэсэн дүрс рүү сум тавина.

- Хараач гахай нум харваж байна гэж Ларк хэлэв.

Тэгтэл ойролцох харваач үнэхээр мэйстер Эймоны дэргэдэх түүний байрыг булаасан тарган хүү сэр Гахай өөрийн биеэр байв. Сэмвэл Тарлигийн барааг хармагц Чэттийн уур хилэн дүрсхийлээ. Мэйстер Эймоны бойдоо байх түүний амьдралын хамгийн сайхан агшин байжээ. Хөгшин сохор хүн шаардамтгай бус Клидас түүний тааллын ихэнхийг гүйцэтгэнэ. Чэттийн үүрэг гэвэл хялбар дээврийн хөндий цэвэрлэн, гал түлж хэдхэн удаа хоол хийх явдал байсан бөгөөд Эймон түүнийг хэзээ ч зодож байсангүй. *Тэр зүгээр л алхаж ирээд язгууртан гаралтай уншиж чаддагаараа намайг түлхэн зайлуулж болно гэж бодож. Магадгүй би түүний хоолойг нь огтлохын өмнө миний хутгыг яаж уншихыг асууж болох юм.*

- Та нар явж бай. Би түүнийг хармаар байна гэж Чэтт бусаддаа хэллээ. Ноход толгодын оройд хоол хүлээж байгаа гэж бодсон бололтой тэдний араас уяагаа чирэн үймэлдэв. Чэтт жингэрийг гутлынхаа өсгийгөөр өшиглөж заримыг нь номхруулав.

Тэр модны цаанаас тарган хүү өөр шигээ өндөр нумыг татахаар дугуй улаан саран шиг царайгаа үрчийлгэн хичээнгүй төвлөрөхийг харав. Түүний урд газар гурван сум байлаа. Тарли нэгийг нь авч удтал онилохыг хичээсний эцэст тавихад сум модон дунд исгэрэн алга болов. Чэтт чанга хөхрөөд зэвүүцсэндээ тургиллаа.

- Одоо тэр олохгүй сумны төлөө намайг буруутгана гэж дүнсгэр царай саарал үстэй бүгдийн Долорус Эдд гэж дууддаг хиа Эдд Толлетт өгүүлэв.

- Намайг морио алдсан цагаас хойш тэд алга болсон юм бүрийн төлөө над руу хараад байгаа. Үүнд би буруугүй. Тэр цас шиг цагаан өнгөтэй байсан байхад надаас юу хүлээнэ гэж? гэхэд,

- Сум салхинд хазайчихлаа. Нумаа тэгшхэн барь, Сэм гэж лорд Сноугын ахин нэг найз Грэнн хэллээ.

- Энэ чинь хүнд юм байна шүү дээ гэж тарган хүү гомдоллосон ч хоёр дахь сумыг авч дэндүү өндөрт онилсон тул байнаас арван фут өндөр зайд мөчир дунд алга боллоо.

- Би чамайг модны навч оносон гэдэгт итгэж байна. Намар тэртээ тэргүй унах хооронд түүний ямар хэрэг байна. Харин бид араас нь юу болохыг мэднэ. Бурхад минь гэж би даарч байна. Сүүлчийн сумаа харва, Сэмвэлл. Тэгэхгүй бол хэлний үзүүр минь хөлдөх нь гэж Долорус Эдд хэллээ.

Сэр Гахай нумаа бөхийлгөхөд Чэтт түүнийг бувтнаж эхэллээ гэж бодов.

- Энэ чинь дэндүү хүнд юм байна.

- Онил тат харва. Алив ээ гэж Грэнн шавдуулав.

Тарган хүү дуулгавартай газар байсан эцсийн сумыг авч урт нуманд онилон татаад харвалаа. Тэр үүнийгээ няхуур татсан өмнөх хоёрыгоо бодвол хяламхийн харахын зуургүй тавьсанд сум дүрсний цээжинд зоогдон чичирлээ.

- Би түүнийг оночихлоо. Грэнн чи түүнийг харав уу? Эдд харсан биз дээ, би түүнийг оночихлоо! гэж ноён Гахай гайхсан байртай дуу алдав.

- Яг хавирганых нь завсар гэж Грэнн батлахад,

- Би түүнийг алсан болов уу? хэмээн тарган хүү мэдэхийг хүслээ.

- Магадгүй уушгитай байсан бол түүнийг нь нэвт хатгасан ч байж мэднэ. Гэхдээ ихэнхи модонд байдаггүй юм гээд Толлет мөрөө хавчсанаа Сэмийн гарнаас нумыг нь авлаа.

- Би үүнээс ч дор харвалт харж байсан. Цөөн хэдийг нь өөрөө хийж байлаа.

Ноён Гахай баясан гийхэд түүнийг харсан хүн үнэхээр ямар нэг зүйл гүйцэтгэж гэж бодохоор байв. Гэвч Чэттийг ноходтой нь хармагц инээмсэглэл нь сарнин арилав.

- Чи мод оносон. Манс Райдерийн залуус ирэх үед яаж харвахыг чинь харцгаая. Тэд чиний өмнө гараа дэлгэн навч сэрчигнүүлэн зогсож байх гэж үү, үгүй дээ. Тэд урдаас чинь хүрч ирээд царай руу чинь догшин уухай хашгирахад чамайг өмдөндөө тавина гэж мөрийцье. Харин тэдний нэг баруун гарын сүхээ бяцхан гахай нүдний чинь хооронд буулгахад чиний сонсох сүүлчийн зүйл гэвэл гавлын яс чинь хэрхэн хяхрах байна.

Тарган хүү хавчганатал чичирэхэд Долорус Эдд мөрөн дээр нь гараа тавиад,

- Дүү минь чамд энэ явдал тохиолдсон учир Сэм шиг зовохгүй гэж ёсорхуу хэлэв.

- Чи юуны тухай яриад байна, Толлетт?

- Гавлыг чинь хуваасан сүхний тухай. Чиний ухааны хагас газар гоожиход ноход чинь идсэн гэдэг үнэн үү?

Грэнн чанга хөхрөхөд Сэмвэлл Тарли хүртэл сулхан инээмсэглэв. Чэтт ойролцоо нохойг

өшиглөөд оосроос нь угзран толгод өөд өгсөв. *Хүссэнээрээ инээмсэглэж л бай, ноён Гахай минь. Өнөө шөнө хэн нь инээхийг чинь харна аа.* Түүнд Толлетийг бас алах цаг байхгүй нь харамсалтай. *Дүнсгэр морин царайтай мулгуу.*

Нударганы налуу талаас өгсөхөд хүртэл эгц байлаа. Замын хагаст ноход удахгүй тэжээгдэх найдлагаар дуу дуугаа авалцан хуцаж түүнийг чангаан зүтгэв. Чэтт оронд нь тэдэнд гутлынхаа хоншоорыг амсуулаад урдаас нь архирсан том нохойг ташуурдав. Буудалд хүрч нохдоо уямагц илтгэхээр явлаа. Мормонтын том хар майхны урд очмогц,

- Аваргын хэлсэн шиг тэнд мөр байгаа ч ноход хөөсөнгүй. Голын уруу ч гэсэн адил хуучин мөр байна гэв.

- Харамсалтай юм гэж халзан толгой, өтгөн буурал сахалтай захирагч лорд Мормонт бувтнахад хоолой нь харц шигээ ядрангуй байлаа.

- Бидэнд шинэхэн мах байвал илүүдэхгүйсэн гэхэд мөрөн дээр нь байсан хэрээ толгойгоо өндөлзүүлэн

- *Мах, Мах. Мах* гэж хашгирлаа.

Бид нохдыг идэж болно гэж Чэтт бодсон ч Хөгшин баавгайг явуулах хүртэл үг дуугарсангүй. *Сүүлчийн удаа би түүнд толгойгоо бөхийлгөж байгаа нь энэ дээ* гэж сэтгэл ханамжтай бодлоо. Түүнд улам тэсэхийн аргагүй хүйтэрч байгаа юм шиг санагдав. Ноход хатуу хөлдүү шалбааг дээр гаслан бөөгнөрөлдөж Чэттэд тэдний дунд шахцалдан дулаацах хүсэл төрөв. Гэвч оронд нь хар ноосон ороолтоор нүүрнийхээ доод хэсгийг ороон зөвхөн амны нүх гаргав. Хөдлөхөд дулаан байсан тул гашуун навч зажлан буудлыг удаан тойрох зуураа харуулд гарсан ах дүүстэй хуваалцангаа үг солилцов. Өдрийн харуулд зогсож байгаа хүмүүсийн хэн ч түүний төлөвлөгөөнд орсонгүй. Ухаанд нь юу байгааг тааварлахтайгаа байлаа.

Тэдний бодлын ихэнхийг тасхийм хүйтэн эзэлж байв.

Сүүдэр уртсах адил салхи ширүүсэн дугуй хэрмэн хананы чулууны ангал цавны завсар нарийхан дуугаар исгэрнэ.

- Би энэ чимээг үзэн ядаж байна. Бургасан дунд сүү нэхэн уйлж байгаа нялх хүүхэд шиг гэж бяцхан Аварга өгүүлэв.

Чэтт тойролтоо дуусган ноход руугаа буцаж ирэхэд Ларк хүлээж байлаа.

- Албаны дарга нар Хөгшин баавгайн майханд ахин цуглараад ямар нэг зүйлийн тухай ширүүн ярилцаж байна.

- Тэдэнд үүнээс өөр хийх зүйл юу байгаа гэж? Блэйнээс бусад нь язгууртан гаралтай болохоор дарсны оронд үг залгилж байгаа гэхэд Ларк хажуулдан ойртлоо.

- Бяслалан толгойт шувууны тухай яриад байна гэж анхааруулаад эргэн тойронд хүн байгаа

эсэхийг сэрэмжлэн харснаа,

- Одоо тэр биднийг хараал идсэн амьтанд нь зориулж үр нөөцөлсөн эсэхийг асууж байна гэв.

- Тэр чинь хэрээ. Хүүр иддэг юм.

- Түүнийхийг байж болох биш үү? гээд Ларк инээлээ.

Эсвэл чинийх ч байж магадгүй. Чэттийн ухаанд тэдэнд Ларкаас илүү том биетэй хүн хэрэгтэй нь илт байв.

- Бага Полд санаа зовох хэрэггүй. Чи өөрийнхийгөө биелүүлэхэд тэр өөрийнхийгөө гүйцэтгэнэ.

Модон дунд бүрий болох үед тэр эцэст нь Систермэнээс ангижиран ойн захад илдээ ирлэхээр суулаа. Бээлийтэй ирлэх хэцүү байсан ч тайлах тухай санахын ч хэрэг байсангүй. Ийм хүйтэнд нүцгэн гараараа төмөрт хүрсэн ямар ч тэнэг арьсныхаа хэсгийг алдах болно.

Нар жаргахад ноход гиншилдсэнд хараал тавин ус өгч,

- Шөнийн хагас өнгөрсөн хойно та нар найрлах болно гэтэл хоолны үнэр ханхийв.

Чэттийг тогооч Хэйкээс хатуу талхны зах, тавагтай буурцаг утсан махны шөл авч байх үед Дайвин түүдэг рүү хүрч ирэв.

- Ой дэндүү нам гүм байна. Ойролцоо голд мэлхий дуугарахгүй, харанхуйд ууль гууглах чимээ алга. Би хэзээ ч ой ийм үхсэн мэт аниргүй байхыг сонсож байсангүй гэж хөгшин түлээчин хэлэв.

- Яг л чиний үхсэн шүд шиг амьгүй юу гэж Хэйк хэлэхэд Дайвин модон шүдээ хавшив.

- Чононууд ч гэсэн алга. Тэд урьд нь байсан ч одоо алга болжээ. Тэднийг хаачсан гэж чи бодож байна?

- Хаа нэгтээ дулаан газар луу гэж Чэтт хэлэв.

Түүдгийн ойролцоо арваад ахан дүүс сууж байснаас дөрөв нь түүний хүмүүс байв. Чэтт хоол идэх зуураа хүмүүсийн төрхийг тандан бүгдийг тойруулан ажиглав. Чичлүүр биеэ барин тайван чимээгүй суух агаад шөнө бүрийн адил хутгаа ирлэж байв. Доннел Хилл тоглоом наадам хийнэ. Тэр цагаан шүд, булцгар улаан уруул, мөр рүүгээ хонхорцоглон унжуулсан шаргал үстэй бөгөөд өөрийгөө Ланнистерийн бутач гэж тунхаглана. Магадгүй тийм ч байж мэднэ. Чэттэд хөөрхөн хөвгүүдийн зэрэгцээ бутчийн хэрэг байсангүй ч Доннел биеэ авч явж чадах шиг санагдав.

Тэр ах дүүсийн Модны хөрөө гэж дууддаг мод хөрөөдөхөөс илүүтэй чанга хурхирдаг түлээчинд итгэлтэй байсангүй. Гэвч тэр одоо ахин хэзээ ч хурхирахгүй болсон юм шиг байж ядан сууж байлаа. Түүнчлэн Маслин түүнээс дор байв. Чэтт хүйтэн салхийг эс харгалзан түүний царайг даган хөлс урсахыг харлаа. Галын гэрэлд нойтон дусал жижигхэн эрдэнийн чулуу мэт гялалзана. Маслин юу ч идэлгүй хоолны үнэрт дотор муухайрсан аятай шөл рүүгээ ширтэж байв. *Би*

түүнийг харж байх хэрэгтэй гэж Чэтт дотроо шийдвэрлэв.

- Цуглараад! Шөнийн харуулын эрчүүд ээ! Төв галыг тойрон цуглар! гэсэн хашгиралт гэнэтхэн амнаас ам дамжин буудал дагуу хадав.

Чэтт хөмсөг зангидан шөлөө дуусгаад бусдын араас дагав.

Хөгшин баавгай галын өмнө зогсоод ард нь Смолвуд, Лок, Вайтерс, Блэйн нар байв. Мормонт зузаан арьсан нөмрөг эгэлдэрэглэн мөрөн дээрээ өд сөдөө цэвэрлэж буй хэрээ суулгажээ. *Энэ ч сайны ёр биш дээ.* Чэтт Хүрэн Бернарр болон Сүүдэрт цамхагын хүмүүсийн дунд шигдлээ. Ойн харуул болон хэрмийн дагуу гаргасан харуулаас бусад бүх хүн цугларахад Мормонт хоолой засан нулимсанд шүлс нь газар хүрэхээс өмнө хөлдөв.

- Ах дүүс минь. Шөнийн харуулын эрчүүдээ.

- *Эрчүүд! Эрчүүд! Эрчүүд!* гэж хэрээ хашгирав.

- Зэрлэгүүд Сүүн усны дагуу уулнаас уруудан ирж байна. Торен тэдний хошууч анги биднээс арван өдрийн зайд бий гэж үзэж байгаа юм. Тэдний ихэнхи чадварлаг дайчид бөгөөд Нохойн толгой Харма удирдан толгойлж яваа. Үүнээс цааш урт замын дагуу цуваа үргэлжилсэн. Тэдэнд цөөн тооны шар үхэр, луус, морь бий. Ихэнхи хүмүүс нь явган, муу зэвсэглэсэн, сургуульгүй байгаа. Авч яваа зэвсэг гэвэл төмрөөс илүүтэй чулуу ясаар хийсэн. Тэд эмэгтэйчүүд, хүүхэд, хонь, ямаа гээд байгаа бүхий л ачаа бараагаа авч явж байгаа. Товчхондоо гэвэл тэд тооны хувьд олуулаа хэдий ч цохилтонд хэврэг бөгөөд хамгийн гол нь... *бидний энд байгааг мэдэхгүй.* Үгүйдээ тийм байгаасай гэж залбирах байна.

Тэд мэдэж байгаа. Хараал идсэн хөгшин ялзарсан уут минь тэд наран мандах адил тодорхой мэдэж байгаа. Мухар хуруут Корин буцаж ирээгүй биз дээ? Жарман Баквелл ч гэсэн. Хэрвээ тэдний нэг нь баригдсан бол хараал идсэн зэрлэгүүд дуу дуулуулж дөнгөх байсан гэдгийг чи мэдэж байгаа гэж Чэтт бодлоо.

Смолвуд урагш алхав.

- Манс Райдер Хана руу цөмөрч долоон ханлигт улаан хядлага авчирах гэж байна. Гэсэн ч ийм тоглоомд хоёр талаар тоглож болно. Маргааш бид тэдэнтэй дайтна гэхэд хүмүүсийн түгсэн шивнэлт дундуур Хөгшин баавгай,

- Бид үүр гэгээрэхэд бүх хүчээрээ мордоно. Бид хойд зүг лүү хөдөлж баруун талаас нь гогцоорон бүсэлж Хармагын хошууч анги Нударгыг нилээн өнгөрсөн хойно буцаж эргэнэ. Мөсөн соёотын хөлийн толгод отолт хийхэд тохиромжтой тахирласан нарийхан хөндийгөөр дүүрэн. Зэрлэгүүдийн цуваа олон милийн газар сунан үргэлжилсэн. Би тэднийг хэдэн газар нэгэн зэрэг гэнэдүүлэн дайрахад гурван зуу биш гурван мянгуулаа байгаа юм шиг болно гэдгийг тангараглаж байна гэв.

- Бид хүчтэй цохилт өгсөн даруй урд талын морьтонгууд цуваагаа эмхэлж нүүр тулахаас урд алга болно. Хэрвээ араас хөөвөл хөгжилтэй мөшгилт рүү хөтөлж дугуйран эргээд ахин цувааны өөр

хэсэгт цохилт өгнө. Бид тэдний хөсөг тэргийг нь шатааж, мал сүргийг сарниулан аль болох олон тооны хүн ална. Боломжтой бол Манс Райдерийг ч гэсэн ална. Хэрвээ тэд овоохой руугаа буцаж зугтвал ялалт биднийх боллоо гэсэн үг. Харин үгүй бол тэднийг ахин Хана хүрэх замын турш гэнэдүүлэн цохиж хэр их цогцосны мөр цувуулан үлдээхийг нь харъя гэж Торен Смолвуд хэлэв.

- Тэд чинь мянгуулаа шүү дээ гэж Чэттийн ард нэг хүн дуугарлаа.

- Бид бүгд үхнэ гэж Маслин айсандаа хоолой чичирүүлэн хэлэв.

- *Үхнэ. Үхнэ, үхнэ, үхнэ* гэж Мормонтын хэрээ хар далавчаа дэвэн хашгирлаа.

- Тиймээ бидний олонхи магадгүй бүгд үхэж ч мэднэ. Гэвч мянган жилийн өмнө өөр нэг захирагч лордын хэлсэн шиг бидний ямар учраас хар хувцас өмссөн минь энэ. Өргөсөн андгайгаа санацгаа, ах дүүс минь. Бид харанхуйн илд, ханын харуул... гэж Хөгшин баавгай хүнгэнүүлэв.

- Бид хүйтний эсрэг дүрэлзэх гал гээд сэр Малладор Лок урт илдээ сугалав.

- Үүрийг авчирах гэгээ гэж бусад нь хариулахад өөр илүү олон илд хуйнаасаа сугарав.

Тэгсээр бүгд сугалан ойролцоогоор гурван зуун илд өргөгдөж хоолойнууд цуурайтав. *Унтаж буйг сэрээгч бүрээ! Хаант улсын хүмүүсийг хамгаалагч бамбай!* Чэттэд нийтийн дуунд хоолой нэмэрлэхээс ондоо сонголт байсангүй. Агаар уур савсуулсан амьсгалд манантаж галын гэрэлд илд гялалзана. Тэр Ларк, Хөнгөн хөлт, Доннел Хилл нар тангарагын үгэнд нэгдэхийг хараад үлдсэн шигээ тэнэг бишэд нь баярлалаа. Энэ нь сайн хэрэг байв. Цаг ийм ойртсон үед бусдын анхаарлыг татах ямар хэрэгтэй гэж.

Тангарагын уриа намдахад зөвхөн дугуй хэрмийн завсар салхи исгэрэх сонсогдоно. Бамбарын дөл хүйтэнд дагжсан мэт чичирэн дүрэлзэхэд гэнэтийн нам гүмд Хөгшин баавгайн хэрээ нэгэнтээ чангаар "*Үхэл*" гэж хэлэв.

Ухаалаг шувуу гэж Чэтт албаны дарга нар тэднийг тус бүр сайтар хооллон өнөө шөнө сайн амрахыг даалган тараахад бодов. Чэтт нохдын ойролцоох үстэй хөнжлийн дор шургалахад толгой нь буруу зүйл хийх гэж байгаа тухай бодлоор дүүрэн байлаа. Хараал идсэн андгай түүний зүрхийг өөрчилнө гэж үү? Гэнэтхэн Бага Пол Мормонтыг алахаа мартаж гурав дахь харуулын оронд хоёр дахь харуулд гарах юм биш байгаа даа? Эсвэл Маслин зоригоо алдан хулчийж хэн нэгэн мэдээлэгч болон хувирах юм билүү...

Тэр шөнийг анирдин чагналаа. Салхи уйлж буй хүүхэд адил улин исгэрч үе үе хүмүүсийн хоолой, морьд янцгаах, түлээ шад падхийн ноцох сонсогдоно. Өөрөөр юу ч сонсогдсонгүй. *Хичнээн нам гүм байна вэ.*

Түүний өмнө Бессагын царай хөвөн гарч ирлээ. *Би чамд хутга дүрэх гээгүй. Би чамд өглөөний турш зэрлэг сарнай, хамба, хонхон цэцэг түүснээ өгөх гэсэн юм* гэж бодолдоо хэлэхийг хүслээ. Зүрх нь бөмбөр адил дэлсэхэд буудал даяар сонсогдон бүгдийг сэрээхээс хулчийв. Амных нь эргэн тойрон сахал цан хүүргэнд хучигджээ. Түүнд хаанаас Бессагын тухай бодол төрөө вэ? Өмнө

нь түүнийг зөвхөн үхэж байгаагаар төсөөлдөг байв. Түүнд юу тохиолдсон хэрэг вэ? Амьсгал нь давхцан авахад бэрх болов. Зүүрмэглэсэн юм болов уу? Өвдөг дээрээ өндийхөд ямар нэг нойтон зүйл хамрыг нь хүйт оргиулсанд дээшээ өнгийн харлаа.

Цас орж байв.

Хацрыг нь даган нулимс урсч хөлдөх мэдрэгдэв. *Энэ чинь шударга биш* гэж хашгирахыг хүслээ. Цас түүний бэлдсэн бүх зүйлийн зэрэгцээ болгоомжтой бодож олсон төлөвлөгөөг нь нураажээ. Хүнд цасан ширхэг дээрээс будран хучина. Тэд цасан дунд хэрхэн хоол хүнс олох юм уу дорно зүг ангийн жим даган хөдлөх болж байна аа? Тэгвэл Дайвин юм уу Баннен мөр нэхэхийн ч хэрэг гарахгүй шинэхэн цасан дээр торойтол дурайх биз. Цасанд газрын өө сэв дарагдан ялангуяа шөнө морьд үндсэнд бүдрэн хөлөө чулуунд хугалах аюултай. *Бид дуусч. Эхэлж амжихаасаа өмнө дуусч. Бид төгсгөл болж* гэж тэр ойлгов. Хануур хорхойчны хүүд лордын амьдрал байхгүй бөгөөд өөрийн гэсэн шилтгээн эхнэр, титэм ч байхгүй. Зөвхөн зэрлэгүүдийн илд гэдсэнд нь шигдсэн нэргүй булш бий. *Цас надад байгаа бүхнийг авлаа. Хараал идсэн цас...*

Цас урьд нь нэг удаа түүний амьдралыг сүйтгэжээ. Сноу болон түүний тэжээвэр гахай хоёр.

Чэтт хөл дээрээ өндийв. Өвдөг нь чилж малгайлан орох цасанд алсад улалзах бамбар бүдэг шаргал толбо адил бүрэлзэнэ. Сүрэг цайвар хүйтэн цохын дарйралт адил цас хүйтнээр цоргиулав. Тэд мөр толгой дээр нь хаялж хамар, нүдэн дээр нь буухад Чэтт хараан нүүрээ арчлаа. *Сэмвэл Тарли. Би ядахдаа ноён Гахайн учрыг олж чадна* гэсэн бодол төрөв. Тэр ороолтоо нүүр лүүгээ дээшлүүлэн юүдэнгээ босгож буудал дундуур хулчгарийн унтаж буй зүг явлаа.

Малгайлан орох өтгөн цасан дунд майхнуудын дунд төөрөх шахсан ч эцэст нь жижигхэн чулуун овоо, хэрээний торны завсар тарган хүү салхинаас хоргодон тухтай унтаж буй газрыг олов. Тарли ноосон хар хөнжил, сэгсгэр арьсан дор шургалжээ. Цас түүний дээрээс лавсан хучихад ямар нэг төрлийн зөөлөн дугуй уул мэт харагдана. Чэтт хутгаа гэрнээс сугалахад ширэн дээр төмөр найдлага шиг нь сулхан чахрав. Хэрээний нэг гуаглав. "Сноу" гэж нөгөөдөх нь гүвтнээд сараалжны завсар гил хар нүдээрээ ширтэв. Эхнийх нь "Сноу" гэж араас нь нэмэрлэлээ. Чэтт тэдний захаар алхам бүртээ болгоомжтой тойрон тарган хүүгийн хашгирахаас сэргийлэн зүүн гараараа дарах гэтэл...

Ууууууууууооооооооооооо.

Тэр алхам дундаа хараал залгин зогсоход бүрэн дуу буудал дундуур алсад хэдий ч эндүүрэхийн аргагүй цуурайтав. *Одоо л биш шүү. Бурхад минь хараал идээсэй. ОДОО Л БИШ ШҮҮ!* Хөгшин баавгайн Нударгыг хүрээлсэн ойд дайсан ойртон ирэхээс сэргийлэн хурц нүдтэй харуул тавьжээ. *Жарман Баквелл Аварга биетийн гишгүүрээс юм уу эсвэл Мухар хуруут Корин Хашгираа даваанаас ирж байна* гэж Чэтт багцаалав. Бүрээний огцом ганц хашгиралт ах дүүсийн эргэн ирэхийг зарладаг байлаа. Хэрвээ энэ Мухар хуруут Корин бол Жон Сноу түүнтэй хамт амьд ирж байгаа гэсэн үг.

Нойрондоо бөлцийсөн нүдтэй Сэм Тарли өнгийн сууж цас руу мэгдэн харав. Хэрээнүүд чимээтэй гуаглан, Чэттэд нохдынх нь хуцах дуу сонсогдов. *Буудлын хагасыг сэрээчихлээ байна.* Тэр

ЖЭЙМИ

Дорно зүгээс үлээх салхин түүний ширэлдсэн үсийг Серсейгийн анхилам зөөлөн хуруу шиг илбэнэ. Шувуу жиргэн, ус долгиолон мяралзахад завь сэлүүрийн аясаар цайвар ягаан үүрийн туяа угтан урагшилна. Удаан хугацаанд харанхуйд хоригдсоны дараа Жэйми Ланнистерт ертөнц туйлын үзэсгэлэнтэй санагдан толгой нь эргэх адил болж байлаа. Би амьд хэвээр нарны гэрлийг ууж байна. Уруулыг нь даван инээд түсхийхэд гэнэтийн цочсон бөднө нуугдсан газраас дэрхийн нисэв.

- Чимээгүй гэж хүүхэн хөмсөг зангидан зандрав. Баргар төрх түүний энгийн өргөн царайд инээмсэглэлээс илүү зохижээ. Жэйми түүний инээмсэглэхийг ер харсангүй. Тэр түүний товчтой ширэн хантаазны оронд Серсейгийн торгон даашинзны нэгийг өмсгөвөл ямар болохыг төсөөлөн зугаацаж байв. *Торгон даашинз өмссөн үнээ шиг л харагдана биз.*

Гэсэн ч үнээ сэлүүрдэж чаддаг байлаа. Тэр бүдүүн даавуу хүрэн өмднийхээ дор гуалин шиг бүдүүн тугалын арьсан гутал өмсч, урт булчинлаг гараа сэлүүрдэхийн тоолон татан тэнийлгэнэ. Шөнийн хагасын турш сэлүүрдсэн ч ядарсан төрх үзэгдсэнгүй харин сэлүүрийн нөгөө талд байгаа Жэймигийн үеэл сэр Клеосын хувьд тэгж хэлж болохооргүй байв. *Харахад хүчирхэг том тариачин эмэгтэй шиг хэр нь ярихдаа язгууртан гаралт хатагтай шиг дээрээс нь бүсэндээ урт илд, чинжаал зүүсэн. Гэхдээ үүнийгээ ашиглаж чаддаг юм болов уу? Жэйми удахгүй энэ дөнгөнөөс ангижирмагц үүнийг мэдэх болно.*

Түүний бугуй шагайд ижилхэн төмөр дөнгө зүүж футын уртаас хэтрэхгүй хүнд гинжээр хооронд нь холбожээ.

- Чи миний үг Ланнистерийнхан шигээ сайн биш гэж бодож байна уу гэж түүнийг гинжлэхэд даажигнажээ. Тэгэхэд Кателин Старкийн ачаар ихэд хөлчүү байсан учраас Риверранаас зугтсан тухайгаа бүдэг бадаг санана. Гяндангын хуягтай бяцхан асуудал тулгарахад том биетэй хүүхэн хүч дийлжээ. Үүний дараа тэд эцэс төгсгөлгүй шатаар тойрон өгсөөд л байлаа. Түүний хөл өвс шиг сульдсан учир хоёр гурван ч удаа бүдэрч унахад хүүхэн хажуугаас нь түшин гарыг нь мөрөн дээгүүрээ тэгнэв. Хэсэг хугацааны дараа түүнийг аян замын нөмрөгөөр хучаад завины ёроол руу түлхсэн байна. Тэр хатагтай Кателин харуулд Усан сараалжин хаалга онгойлгох тушаал өгч байсныг саналаа. Тэр сэр Клеос Фрейг Хааны газар луу буцааж хатанд тавих шинэ нөхцөлтэйгээр илгээж байна гэж маргахын аргагүй өнгөөр хэлсэн юм.

Тэгэхэд л зүүрмэглэсэн байх. Дарс түүний нойрыг хүргэж гянданд гинжтэй хөшсөн хөл гараа тэнийлгэх сайхан байлаа. Жэйми эртнээс эмээл дээрээ явдал дундаа зүүрмэглэж сурсан тул энэ нь бэрх байсангүй. *Тирион намайг оргох замдаа унтсаныг сонсох юм бол нулимсаа гартал инээх байсан даа.* Гэвч одоо сэрүүн байгаа болохоор дөнгө яршигтай санагдана.

- Хатагтай хэрвээ та намайг энэ гинжнээс чөлөөлвөл би сэлүүрийг чинь авъя гэхэд тэр ахин хөмсөг зангидан морины шүдээ гарган сэжигтэй ширтэв.

- Чи дөнгөтэй явах болно, хааны алуурч минь.

- Чи Хааны газар хүрэх бүх замын турш сэлүүрдэх гээ юу, бүсгүй минь?

- Намайг Бриенн гэдэг болохоос бүсгүй биш.

- Тэгвэл намайг сэр Жэйми гэдэг болохоос Хааны алуурч биш.

- Чи хааныг алснаа үгүйсгэж байгаа юм уу?

- Үгүй л дээ. Харин чи хүйсээ үгүйсгэж байгаа юм уу? Тэгвэл өмдөө тайлаад надад юу байгаагаа үзүүл гээд тэр гэмгүйхэн инээмсэглэж,

- Хэрвээ үүнийг чи баталгаа гэж үзэхгүй байгаа бол би чамайг цээживчээ тайлахыг гуйж болох юм гэхэд,

- Үеэл минь эелдэг ёсыг санаж үзээч гэж сэр Клеос сэтгэл түгшин гуйв.

Ланнистерийн цусанд энэ чинь шингэн байдаг юм. Клеос бол түүний авга эгч Женна болон эгчтэй нь гэрлэсэн цагаас эхлэн лорд Тайвин Ланнистераас эмээдэг байсан мулгуу Эммон Фрейн хүү билээ. Лорд Валдер Фрей энэ дайнд Ихрийг Риверраны талд оруулсан ч сэр Эммон эцгийнхээ бус эхнэрийнхээ талыг сонгожээ. *Кастерли Рок үүнээс мууг л хожсон* гэж Жэйми бодов. Сэр Клеос үен шиг төрхтэй, галуу шиг тулалддаг эр зориг нь аймхай эм хониноос хэтрэхээргүй байлаа. Хатагтай Старк түүнийг Тирионд илгээлтийг нь аваачвал суллана гэж амлахад сэр Клеос үүнийг биелүүлэхээр ёс төртэйгээр амалжээ.

Тэд бүхий л амлалтаа гяндангийн өрөөнд гүйцэтгэснээс Жэйми ихэнхийг нь гүйцэтгэжээ. Энэ бол хатагтай Кателин түүнийг сулласны үнэ байв. Тэр том хүүхний илдийг зүрхэнд нь тулгаж байгаад,

- Ахин хэзээ ч Старк, Таллигийнхны эсрэг гар өргөхгүй гэдгээ амал. Дүүгийнхээ нэр төрийн амлалтыг биелүүлэн миний охидыг гэм зэмгүй бүрэн бүтэн буцаалгана гэдгээ амал. Үүнийг хүлэг баатрын нэр төр, Ланнистерийн нэр хүнд, хааны хамгаалалтын тангарагт ах дүүсийн ёс төрөөр амла. Эгч, эцэг, хөвгүүдийнхээ амь, хуучин болоод шинэ бурхдын нэрийн өмнө амлавал би чамайг эгч рүү чинь буцааж явуулъя. Татгалзвал цусыг чинь урсгана гээд илдний үзүүрээр ноорхой хувцсыг нь нэвт хатгажээ.

Их септон хананд гинжлээстэй цээжиндээ илд тулгуулсан согтуу хүн цэвэр ариун амлалт өгснийг сонсвол юу хэлэх байсан бол? Гэсэн ч Жэйми бурхдад зүтгэдэг гэдэг тарган луйварчинд сэтгэл зовсонгүй. Хатагтай Кателин өрөөнд нь байсан хувинг өшиглөн асгасныг саналаа. Нэр хүндээ шивхэнд будсан хүнд охидынхоо хувь заяаг итгэн даатгаж байдаг хачин эмэгтэй. Гэсэн ч тэр түүнд өчүүхэн төдий итгэсэнгүй билээ. *Түүний найдлага Тирионд хандсан болохоос надад биш.*

- Магадгүй эцсийн эцэст тэр тийм ч тэнэг биш байж болох юм гэж чанга хэлэхэд харгалзагч нь энэ үгийг буруугаар өлгөн ойлгосон бололтой,

- Би тэнэг бас дүлий биш гэв.

- Би өөртөө хэлсэн болохоос чамд биш. Гянданд хоригдож байхдаа ийм дадалтай болчихож гэхэд урдаас нь хөмсөг зангидан ширтсэнээ сэлүүрээ урагш хойш даллан юу ч хэлсэнгүй.

Царай шигээ цэцэн цэлмэг хэлтэй юм гээч.

- Ингэхэд чиний тухайд гэснээс би чамайг язгууртан гаралтай гэж бодлоо.

- Миний эцэг Тартын Селвин бурхдын ивээлээр Үдшийн одны лорд гэж хүүхэн үүнийгээ хүртэл баргар хэллээ.

- Тарт гэнэ ээ? Уйтан тэнгис дэх аймшигтай том хад байдаг санагдаж байна. Үдшийн од Шуурганы адагт зүтгэх андгай өргөсөн. Чи яахаараа Винтерфеллийн Роббод явж байдаг билээ?

- Би хатагтай Кателинд зүтгэж байгаа болохоос түүнд биш. Тэр надад чамайг Хааны газар дүү Тирион руу чинь аюулгүй хүргэхийг тушаасан болохоос биш үг хаялц гээгүй. Чимээгүй.

- Би хангалттай чимээгүй байсан, эмэгтэй минь.

- Тэгвэл сэр Клеостой ярь. Надад мангастай үг солих хүсэл алга .

- Энд мангас байгаа хэрэг үү? Усан дор нуугдаж байгаа юм биш биз дээ? Өтгөн удны цаана байгаа юм уу? Тэгэхэд би илдгүй явж байдаг! гэж Жэйми гуугчин хашгирав.

- Эгчтэйгээ нөхцөн, хааныг алж, гэм зэмгүй хүүхдийг хороохоор цонхоор чулуудсан хүнд өөр ямар нэр зүүнэ гэж.

Гэм зэмгүй гэнэ ээ? Өөдгүй хүү биднийг тагнуулдаж байсан. Жэймигийн хүссэн бүх зүйл гэвэл Серсейтэй ганц цаг хамт байх явдал байсан. Умар зүг хийх аян удаан тамлалт болж өдөр бүр түүнийг харж байгаа хэр нь хүрч чадахгүй Робертийн согтуугаар шөнө болгон ор луу нь шургалан том дугуйтай байшинг чахруулж буйг мэдэх хэцүү байв. Тирион түүнд хамаг л сайн хошигнолоо хайрласан ч тайвшируулж дөнгөсөнгүй.

- Чи Серсейн тухай ярихдаа эелдэг байсан чинь дээр шүү, хүүхэн минь гэж Жэйми анхааруулав.

- Миний нэрийг Бриенн гэдэг болохоос хүүхэн биш.

- Мангасын юу гэж дуудах чамд ямар хамаа байна? гэхэд,

- Миний нэрийг Бриенн гэдэг гэж урдаас нь илжиг шиг зөрүүд давтав.

- Хатагтай Бриенн юу? гэхэд эвгүйцсэн төрхтэй болсонд Жэйми тэр даруй сул талыг нь оллоо.

- Эсвэл сэр Бриенн гэвэл илүү таалагдах юм уу? гээд хөхөрч,

- Үгүй дээ, үгүй гэж айж байна. Чи үнээнд морины хуяг дуулга толгойн хамгаалалт өмсгөж торгоор хучаад мэхэлж болох ч түүнийгээ унаад дайнд мордож болно гэсэн үг биш гэлээ.

- Жэйми үеэл минь гуйя ийм бүдүүлэг үг битгий хэл. Бид хол зам туулах болохоор хоорондоо хэрүүл маргаан хийх хэрэг байхгүй гэж сэр Клеос хэлэв. Тэр нөмрөг дотуураа Фрейгийн ихэр цамхаг болон Ланнистерийн алтан арслангийн сүлдтэй цамц өмсчээ.

- Би хэрүүл маргааныг илдээр шийдвэрлэдэг юм даа, үеэл минь. Одоо би хатагтайтай ярьж байна. Надад хэлээч хүүхэн минь Тартын бүх эмэгтэйчүүд чам шиг ийм царайлаг уу? Танай эрчүүдийг бүр өрөвдчихлөө. Магадгүй тэд жинхэнэ эмэгтэй гэж юу болохыг ч мэдэхгүй тэнгисийн нурамгар хадан дээрээ амьдардаг биз.

- Тарт бол үзэсгэлэнтэй газар. Индраанил арал гэж дууддаг юм. Мангас минь хэрвээ чимээгүй байхгүй бол аманд чинь алчуур чихнэ шүү гэж хүүхэн сэлүүрдэх зуураа хэлэв.

- Харж байна уу тэр надаас дутахгүй бүдүүлэг байгаа биз дээ, үеэл минь? гэж Жэйми сэр Клеосоос асуулаа.

- Ган нуруутай бол чинь би чамд үзүүлээд өгөхсөн. Тийм ч олон хүн намайг нүүрэн дээр минь мангас гэж нэрлэж зүрхэлдэггүй юм шүү. *Гэсэн ч нурууны ардаас чөлөөтэй хэлдэг гэдэгт эргэлзэх юм алга.*

Сэр Клеос бухимдангуй ханиалгав.

- Хатагтай Бриенн энэ худал үгийг Кателин Старкаас дуулсан гэдэг нь эргэлзээгүй. Старкийнхан чамайг илдээр ялж чадахгүй болохоор хорон үгээр дайн хийж байгаа юм.

Эрүүгүй мунхаг минь тэд намайг илдээр ялсан. Жэйми учиртай мушилзав. Эрчүүд ийм төрлийн инээмсэглэлийг бүгд уншиж чадна. Үеэл Клеос нь үнэхээр данх дүүрэн шивх залгичихсан юм уу эсвэл өөрийг нь зусардаж байна уу? Бидний урд байгаа хүн үнэхээр дүүрчихсэн тэнэг үү эсвэл бялдууч амьтан уу?

- Хааны хамгаалалтын тангарагт ахан дүү гэж хэзээ ч хүүхдэд гэм учруулахгүйг ямар ч хүн мэднэ гэж сэр Клеос баяртай дуржигнуулав.

Бялдууч байх нь. Үнэнийг хэлэхэд Жэйми Брандон Старкийг цонхоор шидсэндээ харамсаж байлаа. Хүү үхээгүйн дээр Серсейгийн гашуудалд хязгаар байсангүй.

- Тэр чинь ердөө долоотой шүү дээ, Жэйми. Харсан зүйлийнхээ учрыг ч ойлгохгүй бид түүнийг айлгаж чимээгүй болгож болох байсан.

- Чамайг ийм зүйл хүснэ гэж бодсонгүй...

- Чи хэзээ ч боддоггүй. Хэрвээ хүү сэрж харсан зүйлийнхээ талаар эцэгтээ хэлвэл...

- Хэрвээ хэрвээ... гээд Жэйми түүнийг өвдөг дээрээ татан суулгалаа.

- Хэрвээ тэр сэрж юу зүүдэлснээ хэлвэл бид түүнийг далан худалчаар нь дуудан хамгийн муу тохиолдолд би Нэд Старкийг алах болно.

- Тэгвэл Робертийг яана гэж бодож байна?

- Роберт хүссэн зүйлээ хийнэ биз. Хэрэгтэй бол би түүнтэй дайн зарлана. Серсейгийн банзлын төлөөх дайн гэж дуучид үүнийг нэрлэнэ биз.

- Намайг тавь, Жэйми! гээд Серсей уцаарлан өндийхийг оролдов.

Оронд нь тэр түүнийг үнслээ. Тэр хормын турш эсэргүүцсэнээ уруул нь урдаас угтан нээгдэхэд хэлнээс нь дарс, хадаасан цэцэг амтагдаж байсныг саналаа. Бие нь дагжихад Жэймигийн гар торгон цээживчийг нь урж цээжийг нь ил гарган чөлөөлөхөд Старкийн хүү тэр дороо мартагдав.

Серсей үнэхээр дараа нь түүнийг санан хатагтай Кателины ярьсан хөлсний хүнийг хүүг хэзээ ч сэрээхгүйн тулд явууллаа гэж үү? *Хэрвээ тэр түүний үхлийг хүссэн бол намайг илгээх байсан. Энэ Серсейтэй нэг л төсгүй байна даа. Тэр муурын сарвуу болгохоор аллага хийлгэхийн тулд тийм дүүрчихсэн хүн сонгох байсан гэж үү?*

Голын доод хэсэгт нар мандаж салхинд долгионтсон мандлыг гийгүүлнэ. Өмнөд улаан шавартай эрэг ямар ч замаас илүү толигор байлаа. Бяцхан гол горхи судас мэт жирэлзэн томьгоо тэжээж, эргээс үндсээрээ зууралдсан живсэн модны ялзарсан их бие цухуйна. Хойд эрэг арай аглагдуу ажээ. Орой хэсэг нь эвэр мод, царс, туулайн бөөр битүү ургасан хорин футын өндөр чулуун цохио дүнхийнэ. Жэйми урдаа харуулын өндөр цамхаг сэлүүрдэхийн тоолон тодрохыг ажиглав. Харваас удаан хугацааны өмнө орхигдсон бөгөөд нар салхинд элэгдсэн чулуун дээр нь ороонги өвс ургажээ.

Салхины чиг өөрчлөгдөхөд сэр Клеос том хүүхэнд улаан цэнхэр судалтай гурвалжин хатуу далбаа босгоход туслав. Таллигийн өнгө болохоор Ланнистерийн цэрэгтэй голд тулгарвал төвөг удах ч тэдэнд олдсон ганц завь байв. Бриенн залуур дээр суулаа. Жэйми гинжээ хангинуулан дунд талын хэсэг рүү суудал сэлгэв. Дараа нь тэд арай дээр хурд авч салхи урсгал нийлэн нисэх мэт болов.

- Хэрвээ чи намайг дүү рүү аваачихын оронд эцэгт минь аваачвал бидний аялал арай богино болохсон доо.

- Хатагтай Кателины охид Хааны газар байгаа. Би нэг бол охидтой буцна эс бөгөөс үгүй гэхэд,

- Үеэл минь надад хутгаа зээлүүлээч гээд Жэйми сэр Клеос руу эргэлээ.

- Үгүй шүү. Би чамайг зэвсэглэхийг хүсэхгүй байна гээд эмэгтэй чангарч хоолой нь чулуу шиг хатуу дийлдэшгүй болов.

Тэр намайг гинжтэй байсан ч гэсэн айж байна.

- Тэгвэл Клеос би танаас үс хусч өгөхийг гуйх хэрэгтэй болох нь. Сахлыг маань орхиод толгойн үс шүү.

- Чи халзан болох гэж байгаа юм уу? гэж Клеос Фрей асуулаа.

- Хаант улс Жэйми Ланнистерийг намирсан алтан үстэй сахалгүй хүлэг баатраар мэддэг. Бохир шаргал сахалтай халзан хүн ажиглагдахгүй өнгөрч болох юм. Би гинжтэй байгаа үедээ танигдахыг хүсэхгүй байна.

Хутганы ир тийм ч хурц байсангүй. Клеос шийдэмгий хөдөлж огтлон ширэлдсэн үсийг нь хөрөөдөн хажуу тийш авч хаяхад буржгар алтан үс усны мандалд хөвөн хитэгний цаагуур далд оров. Үсгүй болмогц хүзүүний дагуу бөөс гүйхэд Жэйми барьж аваад эрхий хурууныхаа хумсны завсар няцаллаа. Сэр Клеос бусдыг нь хуйхан дээрээс түүж аван ус руу няслав. Жэйми толгойгоо усаар шавшихад сэр Клеос үлдсэн шаргал ёзоорыг хусав. Үүнийхээ дараа сахлыг нь тайран тэгшлэв.

Усанд туссан дүрс түүний мэдэхгүй хүн байлаа. Тэр халзнаар зогсохгүй таван жил гянданд суусан юм шиг хөгширч, царай нь хөнхийн нүдний дор хонхорхой үүсч мэдэхгүй үрчлээс бий болжээ. *Би Серсайд ийм байдалтай харагдаж болохгүй. Тэр үүнийг үзэн ядна.*

Үд дунд сэр Клеос унтлаа. Түүний хурхиралт ороо нь орсон галууг санагдуулна. Жэйми суниагаад дэргэдүүр өнгөрөх ертөцийг харж харанхуй гянданд суусны дараа чулуу, мод бүрийг гайхан сонирхож явлаа.

Эрэг дээр ганц өрөөтэй хэдэн урц далд ороход урт багана нь тогоруу шиг дэнхийнэ. Ойр орчинд нь амьд хүний бараа харагдсангүй. Толгой дээгүүр шувуу нисч, эргийн модонд жиргээд, усан доогуур мөнгөлөг загас зурсхийн өнгөрөв. *Таллигийн хулд загас* энэ бол муу ёр гэж Жэйми бодтол түүнээс ч дор зүйл болох хөвдөг гуалингийн дэргэдүүр өнгөрөхөд цусгүй хөөсөн үхсэн хүн болохыг харлаа. Түүний нөмрөг унасан модны үндсэнд орооцолдож Ланнистерийн улаан хүрэн өнгө нь танигдахгүй болжээ. Тэр цогцсыг таньдаг хүн байсан эсэхийг нь гайхширан бодлоо.

Сэрээний салаа голын эргийн дагуу ачаа бараа тээвэрлэхэд тохиромжтой намуухан зөөлхөн урсгалтай ажээ. Тайван цагт үүгээр завьтай загасчид, үр тариа ачсан сал, худалдаачидын зүү, хувцас, бөс бараа зардаг явуулын хөвдөг мухлагтай тааралдан явуулын жүжигчдийн эрээлжилсэн өнгийн далбаатай хөлөг голын эхээс тосгоноос тосгон дамжин, шилтгээний хооронд явж байдаг байлаа.

Гэвч дайн үүнийг үгүй болгожээ. Тэд тосгоны дэргэдүүр өнгөрсөн ч нэг ч хүний бараа харагдсангүй. Загасчдын байсан тэмдэг болон модноос өлгөөтэй тамтаг болон сийчин урагдсан хоосон тор үлджээ. Жаахан охин голоос морио усалж байснаа завины бараа хармагц даруй уснаас гарав. Дараа нь тэдэнтэй шатсан цамхагын доод талын талбайд ажиллаж буй арваад тариачин тааралдав. Хүмүүс тэдэн рүү дүнсгэр нүдээр харж байснаа завь аюул учруулахгүй гэж үзсэн бололтой талбай дахь ажил руугаа бөхийв.

Улаан салаа өргөн удаан урсгалтай учир тохойрон урсаж гогцоолдсон хэсэгтээ хөвөөлсөн элс, бяцхан модтой аралтай бөгөөд усны гадаргуу дор отсон дархи олонтой. Бриенн аюулыг гярхай нүдээр ажиглаж үргэлж хаагуур нь гарахаа олж байлаа. Жэйми түүний усны тухай мэдлэгийг магтахад урдаас нь сэжиглэнгүй хараад,

- Би голыг мэдэхгүй. Тарт бол арал. Би морин дээр суухаасаа урьд завь сэлүүрдэж сурсан юм гэв.

Сэр Клеос өндийн сууж нүдээ нухлаа.

- Бурхад минь гар бүр холгочихож. Салхи гарна гэж найдахаас гээд агаар шиншилснээ,

- Бороо үнэртэж байна гэв.

Жэйми бороо ороход дуртай байлаа. Риверраны гяндан долоон ханлигийн аятай цэвэр газар байсангүй. Иймээс тэр одоо муудсан бяслаг шиг үнэртэж байгаа нь лавтай.

- Утаа гарч байна гээд Клеос голын уруу хяламхийв.

Нарийхан саарал утаа тэдний урд гогцоолдоно. Энэ нь хэдэн милийн зайтай өмнө эргийн мушгиран өгссөн газар байлаа. Жэйми том байшингын үлдэгдэл цогшин, амьд царсанд дүүрэн үхсэн эмэгтэйчүүд дүүжилснийг олж харав.

Хүүрэн дээр хэрээ цугларч эхэлжээ. Нарийхан олс тэдний хоолойн зөөлөн арьсанд шигдэн салхины аясаар мушгиран найгана.

- Энэ бол хүлэг баатрын үйл хэрэг биш. Жинхэнэ хүлэг баатар ийм хэрцгий аллага хийхгүй байсан гэж Бриенн тэднийг дөхөн очиход хэлэв.

- Жинхэнэ хүлэг баатар дайнд явахдаа үүнээс ч дор зүйл хардаг юм даа. Дээрээс нь үйлддэг, эмэгтэй минь гэж Жэйми хэлэв.

- Би гэм зэмгүй хүмүүсийг хэрээний хоол болгож орхиж чадахгүй гээд Бриенн залуураа эргийн зүг чиглүүллээ.

- Өрөвдөх сэтгэлгүй хүүхэн. Хэрээнүүдэд ч гэсэн идэх юм хэрэгтэй. Голоос гаралгүй үхэгсдийг тайван орхи.

Тэд голын эргийн том царс ус руу тонгойсон хэсэгт газардлаа. Бриенн далбаагаа буулгахад Жэйми завинаас гинжтэйгээ эв хавгүйхэн гарав. Улаан салааны ус гутлынх нь түрийг дүүргэж ноорхой өмдийг нь норгов. Тэр инээд алдан өвдөг сөгдөн унаад толгойгоо усанд дүрж усны дусал цацан сэгсэрлээ. Бохир гараа голын урсгалд үрж угаагаад санаснаас илүү туранхай цонхигор болсныг нь ажиглав. Хөл нь ч гэсэн адил турж биеийн жингээ дааж ядан найгана. *Би Хостер Таллигийн гянданд дэндүү удаан суужээ.*

Бриенн, Клеос хоёр эрэг рүү завиа чирж гаргав. Цогцоснууд тэдний толгой дээр боловсорч гүйцсэн өмхий жимс адил савлана.

- Бидний нэг авирч тэднийг доош буулгах хэрэгтэй гэж Бриенн хэлэв.

- Би авирья. Зөвхөн үүнийг салгачих гээд Жэйми гинжээ хангинуулав.

Хүүхэн үхсэн эмэгтэйчүүдийн нэг рүү ширтлээ. Жэйми гинжний татагдах хэмжээнд ойрхон алхан дөхөв. Тэр цогцосны хүзүүнд зүүсэн бүдүүлэг самбарыг хараад инээмсэглэн "Тэд Арслантай

унтсан" гэж уншив.

- Өө, тийм эмэгтэй минь энэ бол хүлэг баатрын үйл биш... Зөвхөн танай талынхан ингэсэн болохоос манайх биш. Энэ хүүхнүүд хэн байсан юм бол?

- Дэн буудлын хүүхнүүд. Урьд нь энд дэн буудал байсныг санаж байна. Биднийг Риверран руу буцах үед дагуулуудын зарим маань энд хоноглосон юм гэж сэр Клеос Фрей хэлэв. Гэвч овоорч унасан хуйхлагдсан дүнг, том чулуун сууринаас ондоо байшинг санагдуулах зүйл юу ч үлдсэнгүй. Үнсэн дундаас утаа уугина.

Жэйми эмсийн хүрээлэнгийн үүргийг дүү Тириондоо орхижээ. Түүний хүсч байсан цорын ганц эмэгтэй гэвэл зөвхөн Серсей байлаа.

- Харваас энэ охидууд миний эцгийн зарим цэргүүдийг баярлуулсан бололтой. Магадгүй тэдэнд хоол ундаар үйлчилсэн байх. Ийм учраас урвагчийн дүүжлүүрийг үнсэлт аяга шар айрагаараа хүртэж гээд голын адаг руу хүн байгаа эсэхийг шалган харлаа.

- Энэ бол Бракены газар нутаг. Лорд Жонос тэднийг алахыг тушаасан байх. Эцэг минь түүний цайзыг шатаасан болохоор бидэнд хайргүй байх гэж айж байна.

- Эсвэл Марк Пайперын ажил байх. Үгүй бол Берик Дондаррионих ч байж мэднэ. Гэхдээ би түүнийг зөвхөн цэргүүдийг алдаг гэж сонссон. Эсвэл Рус Болтоны умардынхан ч юм билүү? гэж сэр Клеос санал дэвшүүлэв.

- Болтон миний эцэгт Ногоон салаанд цохиулсан.

- Цохиулсан болохоос ялагдаагүй. Тэр лорд Тайвин гармыг орхиход өмнө зүг ахин ирсэн. Миний Риверранд олж сонссоноор тэр Харренхалыг сэр Амори Лорчоос авсан гэсэн гэж хэмээн Клеос хэлэв.

Жэймиг сонссон зүйл нь тийм ч баярлуулсангүй.

- Бриенн гэж тэр эелдэгхэн нэрийг нь хэлвэл сонсож магадгүй гэж найдсандаа хэлэв.

- Хэрвээ лорд Болтон Харренхалыг барьж байгаа бол Сэрээ болон Хааны замыг хоёуланг нь харж байгаа гэсэн үг гэхэд том цэнхэр нүдэнд итгэлгүйхэн оч тодорлоо.

- Чи миний хамгаалалтанд байгаа. Тэд эхлээд намайг алах хэрэгтэй болно.

- Би үүнийг тэдэнд төвөг удна гэж бодохгүй байна шүү.

- Би чамаас дутахгүй сайн дайчин. Би Рэнли хааны сонгосон дойлээрэй. Тэнд завь ирж байна.

Тэднийг чадлаараа хурдлахад Жэйми арай ядан гүйж завь руу үеэл нь татан гаргалаа. Бриенн сэлүүрээ түлхэн далбаагаа яаран босгов.

- Сэр Клеос та надад сэлүүрдэх хэрэгтэй байна гэхэд тэр дагалдлаа.

Хөнгөн завь урсгал, салхи, сэлүүрийн аяс нийлэх агшинд ус зүсэн өмнөхөөс илүү хурдлав. Жэйми гинжтэйгээ суун голын өөд ширтэв. Нөгөө завины далбааны үзүүр үзэгдэх төдий харагдана. Тэд Улаан салааны гогцоорсон хэсэгт талбай хөндлөн хойд зүг рүү хөдөлж байгаа мэт харагдавч нүд хуурсан үзэгдэл болохыг нь мэдэж байв. Жэйми хоёр гараа өргөн нүдээ халхавчилаад,

- Булингартай улаан, усан цэнхэр өнгө байна гэхэд Бриенн том амаа сэвсээ хивж буй үхэр аятай чимээгүй хөдөлгөв.

- Түргэлээрэй, сэр.

Шатсан дэн буудал тэдний ард төдөлгүй далд ороход далбааны орой алга болсон ч нэмэр болсонгүй. Нэхэн хөөгчид гогцоог тойрмогц ахин үзэгдэж эхлэв.

- Бид хүнлэг сэтгэлт Таллигийнхан үхсэн янхнуудыг оршуулахаар зогсоно гэж найдахаас гээд гяндан руугаа буцах хэтийн төлөв Жэймиг огтхон ч баярлуулсангүй. *Хэрвээ Тирион байсан бол одоо ямар нэг ухаалаг зүйл бодож олох байсан даа. Харин миний хувьд илдээр тулалдахаас ондоо бодол алга.*

Цагийн турш тэд нэхэн хөөгчидтэй нуугдаж тоглосны эцэст бяцхан модтой арлын дунд орлоо. Тэгтэл нэхэн хөөгчдийг ардаа орхисон байх найдлага төрж эхлэх агшинд алсад завь ахин үзэгдэж эхлэв. Сэр Клеос сэлүүрдэхээ зогсоож,

- Өөрүүд тэднийг аваасай гээд духныхаа хөлсийг арчив.

- Сэлүүрд! гэж Бриенн тушаалаа.

- Бидний араас голын онгоц ирж байна гэж Жэйми хэсэг харсныхаа дараа хэлэхэд сэлүүрдэх тусам завь улам томрох мэт санагдана.

- Хоёр талдаа есөн сэлүүртэй тус бүр дээр нь арван найман хүн байгаа. Сэлүүрчдээс гадна, дайчид авч яваа болохоор үүнээс ч их хүнтэй биднийхээс том онгоц байна. Бид тэднээс зугтаж чадахгүй гэхэд сэр Клеос сэлүүр дээрээ хөшив.

- Арван найм гэж чи хэлсэн үү?

- Бидэнд тус бүр зургаан хүн оногдож байна. Энэ бугуйвч саад болохгүй бол би наймтай нь тулалдана. Хатагтай Бриенн миний дөнгийг тайлж өгөхгүйсэн болов уу? гээд Жэйми бугуйгаа өргөлөө.

Бриенн түүнийг үл тоомсорлон бүх хүчээ гарган сэлүүрдэв.

- Бид тэднээс хагас шөнийн зайд байна. Тэд хоёр талын сэлүүрчдээ ээлжлэн амрааж үүр гэгээрэх хүртэл сэлүүрдэж ядарсан байгаа. Харин одоо манай онгоцны бараа тэдэнд хүч өгч байгаа ч энэ удахгүй. Бид тэднээс аль болох олныг унагаж чадна.

- Гэхдээ... тэд чинь арван наймуулаа шүү дээ гэж сэр Клеос дуу алдлаа.

- Хамгийн багадаа тэр. Үүнээс гадна хорь юм уу хорин тавуулаа байж мэднэ.

- Бидэнд арван найман хүнтэй байсан ч дийлэх найдлага байхгүй гэж үеэл нь ёолов.

- Би тийм гэж хэлсэн билүү? Бидний ганц найдлага бол гартаа илдтэй үхэх явдал гэж тэр чин сэтгэлээсээ хэлэв. Жэйми Ланнистер хэзээ ч үхлээс айж байсангүй.

Бриенн сэлүүрдэхээ зогсоов. Дух руу нь унжсан сүрлэн өнгөт үснээс хөлс усаж царайгаа үрчийлгэсэн нь урьдынхаас илүү царай муутай болгожээ.

- Чи миний хамгаалалтанд байгаа гэж тэр уур уцаар дүүрэн хоолойгоор хэллээ.

Жэйми түүний байдлыг хараад хөхрөв. *Тэр ч хөхтэй болохоос Хоточ юм даа. Хэрвээ түүнд байдаг бол ч* гэж бодов.

- Тэгвэл намайг хамгаал л даа, бүсгүй минь. Эсвэл чөлөөлж өөрийг минь хамгаалуул.

Сэлүүрт онгоц голын уруу том модон тэмээлзгэнэ адил нисэх мэт цайвалзан ирэхэд сэлүүрийн огцом хөдөлгөөн цагаан ус сахруулна. Бриенн тавцан дээр байгаа хүмүүсийг харж байлаа. Тэдний гарт сэлэм гялалзан нум сум ч гэсэн үзэгдэв. *Харваачид*. Жэйми харваачидийг үзэн яддаг байлаа.

Дайран ирж буй онгоцны хошуун дээр халзан толгой, өтгөн буурал хөмсөг, хүчирхэг гартай бахим хүн зогсчээ. Хуяган дээгүүрээ цайвар ногоон дэвсгэр дээр уйлж буй уд мод хатгамласан бохир цагаан цамц өмсч нөмрөгөө мөнгөн хулд загасаар товчилжээ. *Риверраны харуулын ахмад*. Цагтаа сэр Робин Райгер шаргуу тулаанч байсан ч түүний үе өнгөрч Хостер Таллитай чацуу болохоор лордтойгоо цуг өтөлжээ.

Завины хооронд тавин ярд хүрэхгүй зай үлдмэгц Жэйми гараа амандаа бариад дээшээ хашгирлаа.

- *Надад аян замын ерөөл хүсэхээр ирээ юу, сэр Робин?*

- *Чамайг буцаж авч явахаар ирлээ, хааны алуурч минь. Алтан үсээ хаа гээгээ вэ?* гэж сэр Робин Райгер хариу хашгирав.

- *Би халзан толгойгоо гялбуулан дайсныхаа нүдийг сохлох гэсэн юм. Энэ чамд хангалттай бүтнэ* гэхэд сэр Робин хөгжсөнгүй.

Завь, сэлүүрт онгоц хоёрын хоорондох зай дөчин ярдаас хэтрэхгүй болов.

- *Сэлүүр, зэвсгээ усанд хаявал та нарын хэнд ч гэм учруулахгүй* гэхэд сэр Клеос ухасхийн эргэн харлаа.

- Жэйми түүнд биднийг хатагтай Кателин олзлогсдыг солилцохоор хууль ёсны дагуу сулласныг хэл... гэхэд Жэйми дамжуулав.

- Кателин Старк Риверранд захирдаггүй гэж сэр Робин хариу хашгирав. Түүний хоёр талд дөрвөн харваач байр эзлэн зогсоод хоёр нь зогсож, хоёр нь өвдөглөжээ.

- Илдээ усанд хаяцгаа.

- Надад илд байхгүй гэвч байсан бол гэдсэнд чинь зоож дөрвөн хулчгарийн чинь юмыг огтлох байсан юм.

Харвасан сум хариу болов. Нэг нь шурганд зоогдон, хоёр нь далбаа онож дөрөв дэх нь Жэймигийн хөлний дэргэдүүр өнгөрлөө.

Ахин нэг Улаан салааны өргөн гогцоорсон ус тэдний өмнө гарч ирэв. Бриенн завиа тахир луу чиглүүлэв. Тэднийг эргэхэд далбаа салхинд тас нясхийн дэрвэв. Урд нь голын дунд том арал байлаа. Гол урсгал баруун талаар нь урсаж зүүн тал нь арлыг цохиотой хойд эргээс тусгаарласан нарийхан зурвас үүсгэжээ. Бриенн залуурыг зүүн тийш эргүүлэхэд далбаа даган хуйларлаа. Жэйми түүний нүдийг харав. *Үзэсгэлэнтэй тайван нүд юм.* Тэр хүний нүднээс айдас ямар харагддагыг уншиж мэддэг байв. *Тэр цөхрөөгүй шийдэмгий байна.*

Сэлүүрт онгоц тэдний ардаас гучин ярдын зайд эргэлт рүү орж ирэв.

- Сэр Клеос залуурыг ав. Хааны алуурч сэлүүрийг авч биднийг чулуу өнгөрөхөд тусал гэж хүүхэн тушаав.

- Хатагтайн тушаасан ёсоор больё гээд Жэймид сэлүүр илд биш ч сайтар далайвал хүний нүүр хэмх цохиж, бариулыг нь бултахад ашиглаж болох байлаа.

Сэр Клеос сэлүүрээ Жэймид атгуулаад хитэг рүү ухасхийв. Тэд арлын толгой хэсгийг өнгөрч огцом урсгалд ороход завины хазайлтаар царай руу ус шүршив. Арал дээр орооцолдсон уд, царс, гоолиг нарс шигүү ургаж бургилсан ус рүү гүн сүүдрээ тусган нуугдсан дархи, живсэн модны ялзарсан их биеийг далдлана. Тэдний зүүн талд ёроолд нь цохионы нүүрнээс хэлтэрч унасан хад, үхэр чулуунд ус хөөсрөн бургилсан эгц хадан цохио байлаа.

Тэд нарны гэрлээс сүүдэр лүү орж онгоцны бараанаас модны ногоон хөшиг, саарал чулуун цохиогоор халхлагдан далд оров. Жаахан ч гэсэн сумнаас амсхийх нь гэж Жэйми хагас нь далд орсон үхэр чулууны хажуугаар өнгөрөхдөө бодов.

Завь ганхан ус аяархан цүлхийх чимээ гарахад эргэж харвал Бриенн байсангүй. Хормын дараа тэр ахин гарч ирэхдээ цохионы ёроолын усанд байв. Тэр намхан ус туучин чулуу руу гарснаа дээш мацлаа. Сэр Клеос нүдээ бүлтийлгэн амаа ангайлгав. *Тэнэг амьтан* гэж Жэйми бодоод,

- Хүүхнийг бүү тоо. Жолоогоо зал гэж үеэлээ зандарлаа.

Модны цаанаас далбаа гялсхийн хөдөлснөө төдөлгүй сэлүүрт онгоц бүрэн хэмжээгээр хорин таван ярдын зайд гарч ирлээ. Хамар нь эргэлт хийн хошуулдахад дээрээс нь тав зургаан сум ниссэн ч холуур өнгөрөв. Хоёр завины хөөцөөлдөн харваачдад онилоход хүндрэлтэй байсан ч

Жэйми тэднийг удахгүй дасан байрлалаа олохыг мэдэж байв. Бриенн цохионы нүүрэн талын дунд хэсэг хүртэлх замд гараараа зууран авирна. *Райгер түүнийг харвал харваачддаа буулгах тушаал өгөх байх даа.* Жэйми хөгшин хүний бардам занг хөндөн мунхруулахаар шийдлээ.

- *Сэр Робин ганцхан хором сонсооч* гэж хашгирав. Сэр Робин гараа өргөхөд харваачид нумаа буулгав.

- *Юу хүссэнээ хэл гэвч түргэн шүү, хааны алуурчаа.*

Завь хэмхэрсэн чулуун дундуур гарахад Жэйми,

- *Би үүнийг халз тулаанаар шийдвэрлэх сайн арга мэдэж байна. Чи болон бид хоёрын дунд гэв.*

- *Би өнөө өглөөхөн төрөөгүй шүү, Ланнистер.*

- *Гэвч чи өнөөдөр үд дунд үхнэ* гээд Жэйми гараа өргөн дөнгөө үзүүлэв.

- *Би гинжстэйгээ тулалдана. Яасан чи айгаад байгаа юм уу?*

- *Чамаас л биш шүү, сэр. Хэрвээ надад сонголт байсан бол түүнээс дээр зүйл хүсэхгүй ч надад чамайг аль болох амьдаар нь авчир гэсэн. Харваачдаа. Хөвчил, тат. Хар...*

Тэдний хоорондын зай хорин ярдаас илүүгүй байлаа. Харваачид ийм зайд барагтай алдахгүй ч тэд урт нумаа өргөхөд эргэн тойронд чулуун мөндөр оров. Жижигхэн чулуунууд тавцан таржигнуулан дуулган дээр ойж онгоцны хоёр тал руу ус үсчүүлэн уналаа. Тэгэхэд юу болж буйг ухааран дээшээ харахыг сэхээрсэн хэнд ч үхэр чулууны хэмжээтэй үнээ цохионы оройгоос дүүжлээстэй байгаа үзэгдэхээр байлаа. Сэр Робин зэвүүцсэндээ хашгирав. Дээрээс унасан чулуу агаарт эргэлдэн цохионы нүүрэн талыг мөргөн хоёр хуваагдаад доош тэдэн рүү уналаа. Том нь шураг хугалж далбаа ураад харваачдийн хоёрыг ус руу унагаж сэлүүр лүүгээ бөхийж байсан сэлүүрчний хөлийг хугалав. Хоёр дахь бага хэсэг онгоцны их биеийг цөмлөхөд хөлөг онгоц түргэн усаар дүүрч сэлүүрчний орилох дуун цохионд хадаж усанд унасан харваачид цөхрөн сарвалзана. Тэдний байдлаас үзэхэд хэн нь ч сэлж чаддаггүй бололтой. Жэйми хөхөрлөө.

Тэднийг эргэлтнээс гарах үед сэлүүрт онгоц голын дунд эргүүлэг дархитай хэсэгт орон живсэнд Жэйми Ланнистер бурхад тэднийг ивээж байна гэж шийдэв. Сэр Робин болон түүний хараал идсэн харваачид Риверран хүрэх урт нойтон аян хийн явган буцаж байхад, тэр том үзэмжгүй эмэгтэйгээс ч гэсэн салсан. *Би байсан бол ийм зүйл төлөвлөж чадахгүй юм байна. Энэ гинжнээс сулармагц...*

Сэр Клеос хашгирах дуунаар Жэйми дээш харвал тэдний урд Бриенн цохионы ирмэг даган тохойрсон хэсэгт завины явж буй газар луу гүйж байв. Тэр чулуунаас үсэрч бараг гоолиг хөдөлгөөнөөр шумбахад толгойгоо чулуунд цохин хагалаасай гэвэл бүдүүлэг найдлага болох байв. Сэр Клеос завиа түүний зүг рүү эргүүлэв. Аз болоход Жэймид сэлүүр нь хэвээр байв. *Сэлээд ирэхэд нь ганц сайн далайж дэлсэхэд би түүнээс ангижирч чөлөөтэй болно.*

Гэвч оронд нь тэр сэлүүрээ ус руу сунгалаа. Бриенн барьж авахад Жэйми татаж гаргав. Тэр түүнийг завинд ороход туслахад үснээс нь ус дуслан нойтон хувцсыг нь даган завины ёроол руу гоожив. *[i]Тэр нойтон байхдаа улам ч царай муутай харагдах юм. Хэн үүнийг боломжтой гэж бодох билээ?[/i]*

- Чи ч хараал идсэн тэнэг хүүхэн байна даа. Бид чамгүй явж болох байлаа. Чамайг надад талархал илэрхийлнэ гэж бодож байна.

- Би чамд ямар ч талархал илэрхийлэхгүй, хааны алуурч минь. Би чамайг Хааны газар аюулгүй аваачина гэж амлалт өгсөн.

- Тэгээд үүнийгээ барьж байгаа чинь энэ үү? Гайхамшигтай гээд Жэйми түүнд хамгийн сайхан инээмсэглэлээ бэлэглэв.

КАТЕЛИН

Сэр Десмонд Грелл Таллигийн гэр бүлд бүх насаараа зүтгэжээ. Тэр Кателиныг төрөхөд дагуул хиа байж, түүнийг явж, морь унан, сэлж сурч байхад хүлэг баатар болон, хуримынх нь өдөр зэвсгийн даамал болсон байлаа. Тэр лорд Хостерийн бяцхан Катыг залуухан охин байхаас нь авахуулаад их лордын гэргий, хааны эх болохыг харжээ. *Дээрээс нь одоо бас намайг урвагч болсныг маань харж байна.*

Түүний дүү Эдмур тулаанд мордохдоо сэр Десмондыг Риверраны цайзын захирагчаар томилсон тул Кателины үйлдсэн хэргийг шүүх үүрэг ногджээ. Тэр аягүйцсэн байдлаа хөнгөвчлөхийн тулд эцгийнх нь бойдоо яхир Атерайдес Вайнтай цуг иржээ. Хоёул зогсоод урдаас нь түүнийг ширтэв. Сэр Десмонд бахим бие, улаан царайтай тэвдсэн шинжтэй байхад, Атерайдес буурьтай, хатангир дүнсгэрдүү байлаа. Тэд хоёул тус бүр нэг нь нөгөөгийнхөө ярихыг хүлээв. *Тэд амьдралаа миний эцэгт зүтгэхэд зориулсан байхад харин би үүнийг нь шившигээр эргүүлэн төлж байна* гэж Кателин ядрангуй бодов. Сэр Десмонд эцэст нь ам нээж,

- Чиний хөвгүүд. Мэйстер Вайман бидэнд хэлсэн. Хөөрхий хүүхдүүд. Аймшигтай юм. Аймшигтай гэсэн хэдий ч... гэв.

- Бид таны гашуудлыг хуваалцаж байна, хатагтай. Бүх Риверран таньтай хамт гашуудаж байгаа ч гэхдээ... гэж Атерайдс Вэйн хэлэв.

- Гашуудлын мэдээ чамайг ухаангүй болгосон байх. Уй гашуундаа самуурсан эхийн үйлдлийг ямар ч хүн ойлгоно. Чи юу хийж байгаагаа ч мэдээгүй... гэж сэр Десмонд нэмэрлэв.

- Мэднэ. Би хийсэн зүйлээ урвалт болохыг нь маш сайн мэдэж байсан. Хэрвээ та нар намайг шийтгэхгүй бол хүмүүс Жэйми Ланнистерийг хуйвалдаж сулласан гэж бодно. Энэ бол зөвхөн миний хийсэн үйлдэл болохоор өөрийн биеэр хариуцна. Хэрвээ шаардлагатай бол намайг Хааны алуурчийн хоосон дөнгөнд гавла. Би үүнийг бахархалтайгаар зүүх болно гэж Кателин хатуу хэллээ.

- Дөнгөлөх гэнэ ээ? Хааны ээж, лордынхоо төрсөн охиныг гэж үү? Байж боломгүй юм гэж энэхүү үгэнд цочирдсон хөөрхий сэр Десмонд дуу алдав.

- Магадгүй бид сэр Эдмурыг эргэн ирэх хүртэл хатагтайг өрөөнд нь хорьж болох юм. Ганцаар байж алагдсан хөвгүүдийнхээ төлөө гашуудах цаг олгоё гэж бойдоо Атерайдес Вэйн хэллээ.

- Хорих гэнэ ээ? Тиймээ цамхгын өрөөнд хорих зүйтэй.

- Хэрвээ би хоригдоход хүрвэл эцгийнхээ өрөөнд байж сүүлчийн өдрийг нь хүртэл түшмээр байна гэхэд сэр Десмонд хормын турш эрэгцүүлснээ,

- Маш сайн байна. Таньд тав тух элэгсэг ёс дутахгүй ч цайзын дотор чөлөөтэй явах эрхийг чинь хязгаарлаж байна. Хэрэгтэй бол сүмд очиж мөргөн бусад үед лорд Эдмурыг эргэн ирэх хүртэл лорд Хостерийн өрөөнөөс гарч болохгүй гэв.

- Таны хэлснээр болог. Шаардлагатай бол надад харуул тавьж болох ч би зугтахгүй гэсэн ам өгч байна гээд Кателин дүү нь эцгийнхээ амьд байхад лорд болохгүйг засч хэлсэнгүй.

Сэр Десмонд таагүй даалгавараа дуусгасандаа баяртайгаар толгой дохиод дүнсгэр харцтай Атерайдес Вэйн захирагчийг явсан хойно хормын турш саатав.

- Таны хийсэн зүйл ноцтой ч энэ одоо хамаагүй. Сэр Десмонд сэр Робин Райгерийг Хааны алуурчийн хойноос эргүүлж авчирахаар илгээсэн. Эсвэл бүтэхгүй тохиолдолд толгойг нь авчирна.

Кателин өөр зүйл хүлээсэнгүй. *Магадгүй Дайчин чиний илдтэй гарт хүч өгөх бизээ, Бриенн* гэж мөргөлөө. Тэр чадах бүх зүйлээ хийсэн болохоор найдахаас ондоо зүйл үлдсэнгүй.

Тэр эд зүйлээ эцгийнхээ унтлагын өрөөний дээр нь хорвоод анх мэндэлсэн багана дээр нь үсэрч буй хулд загасны дүрс сийлбэрлэсэн том лаврин бүхий ор луу зөөв. Эцэг нь үүнээс хагас шатны дор эргэлтэнд үргэлж харах дуртай байсан гол өөд хандсан нээлттэй агаар сэнгэнэх гурвалжин тагт руу ороо харуулан хэвтжээ.

Лорд Хостер Кателиныг очиход унтаж байлаа. Кателин тагтан дээр өрөөсөн гараа чулуун хашлага дээр тавин зогслоо. Шилтгээний цаана Унагаа хадны түргэн урсгал, Улаан салааны намуухан урсгалтай нэгдэж доош зурайн одно. *Хэрвээ дорно зүгт судалтай далбаа үзэгдвэл сэр Робин эргэн ирж байгаа гэсэн үг.* Хормын туршид усны мандал хоосон байлаа. Кателин үүний төлөө бурханд талархаад дотогш орон аавынхаа дэргэд суулаа.

Тэр лорд Хостер өөрийг нь тэнд байгааг мэдвэл түүний энд байгаа нь ямар ч тайвширал авчирахгүй ч, өрөөнд нь байх өөрт нь тайвширал болж байгааг яах эсэхийг мэдсэнгүй. *Хэрвээ миний хийсэн гэмт хэргийг мэдвэл эцэг минь юу гэж хэлэх байсан бол? Лайза бид хоёр дайсны гарт байсан бол та бас над шиг зүйл хийх байсан уу? Эсвэл намайг бусдын адил зэмлэж эхийн ухаангүй явдал гэж дуудах байсан уу?* гэж гайхширлаа.

Өрөөнд үхлийн хүнд нялуун өмхий үнэр ханхална. Энэ нь түүнд Нэдийн хүмүүжигч байсан Теон Грэйжойгийн гарт алагдсан хөвгүүд болох хонгор үрс Бран, бяцхан Рикон нарыг нь санагдуулав. Тэр Нэдийн араас гашуудсан хэвээр үргэлж гашуудах хэдий ч хөвгүүдээ алдах гэдэг чинь...

- Хүүхдээ алдах бол аймшигтай хэрцгий явдал гэж тэр өөрөөсөө илүү эцэгтээ шивнэхэд лорд Хостерийн нүд нээгдэж,

- Танси гэж өвчинд шаналсан сөөнгө хоолойгоор дуугарав.

Тэр намайг таньсангүй. Кателин эцэг нь түүнийг эх болон дүү Лайзагаар дууддагт дассан ч Танси гэсэн нэр харь байлаа.

- Би Кателин байна. Кателин байна, аав аа.

- Намайг өршөө... цус... гуйж байна... Танси...

Эцгийнх нь амьдралд өөр хүүхэн байсан юм болов уу? Тосгоны охинтой залуу байхдаа

орооцолдсон юм биш байгаа даа? Эсвэл ээжийн минь үхлийн дараа аль нэг зарц охины гараас тайвширлыг олсон ч юм билүү? Энэ хачин тухгүй бодол байлаа. Тэр гэнэтхэн эцгийнхээ тухай бараг мэдэхгүйгээ ухаарав.

- Танси гэж хэн юм бэ? Та намайг түүн рүү явуулахыг хүсч байна уу? Би энэ эмэгтэйг хаанаас олох вэ? Тэр амьд байгаа юу?

- Үхсэн гэж лорд Хостер ёолоод гараараа хурууг нь тэмтчив.

- Чамд бусад нь бий... хууль ёсны хонгор хүүхдүүд.

Бусад? гэж Кателин бодлоо. *Тэр Нэдийн өнгөрснийг мартлаа гэж үү? Тэр Танситай ярьсан хэвээр байгаа юм болов уу эсвэл надтай, Лайза, ээжтэй ярьж байна уу?*

Эцэг нь ханиалгахад цустай цэр гарлаа. Тэр хуруунаас нь зууран,

- ...сайн эхнэр байгаарай бурхан чамайг ивээг... хөвгүүдийг чинь... хууль ёсны хөвгүүдийг чинь... гэснээ аааа гээд лорд Хостер гэнэтийн хүчтэй өвдөлтөнд чанга базан хумсаа гарт нь шигтгэн бөглүү хашгирлаа.

Мэйстэр Вайман түргэхэн ирж намуу цэцэг сүүтэй холин ханд бэлтгээд эзэндээ уухад туслав. Төдөлгүй лорд Хостер Талли арагш хэвтэн гүн нойронд автлаа.

- Тэр Танси гэдэг эмэгтэйн тухай асуугаад байсан гэж Кателин хэлэв.

- Танси гэнэ ээ? гээд мэйстер түүн рүү анивчин харлаа.

- Та ийм нэртэй хүн мэдэх үү? Зарц юм уу ойролцоо тосгоноос ирсэн эмэгтэй байж магадгүй? Эсвэл өнгөрсөн хүн ч юм уу? гээд Кателин Риверранд удаан хугацааны турш байсангүй.

- Үгүй дээ, хатагтай. Хэрвээ таныг хүсвэл би асууя. Атерайдес Вэйн Риверранд зүтгэж байсан бараг бүх хүмүүсийг мэдэх байх. Танси гэж та хэлсэн үү? Энгийн ардууд ихэнхидээ охидоо цэцэг, ургамлын нэрээр нэрлэдэг гээд мэйстер бодлогоширонгуй ширтсэнээ,

- Тэнд нэг бэлэвсэн эмэгтэй байсныг санаж байна. Тэр шилтгээн рүү ирж хуучин гуталд занга тавьдаг байсан. Түүний нэрийг Танси гэдэг байсан санагдаж байна. Эсвэл Пэнси ч билүү? Тиймэрхүү нэртэй. Гэхдээ тэр олон жилийн турш ирээгүй л дээ... гэв.

- Түүний нэрийг Виолет гэдэг байсан гэж Кателин өөрийн маш сайн мэдэх хөгшин авгайн тухай санаад хэллээ.

- Тийм билүү? Өршөөгөөрэй, хатагтай Кателин би энд үлдэж чадахгүй нь. Сэр Десмонд биднийг таньтай зөвхөн эрх үүргийн дагуу шаардагдах хэмжээнд ярихыг зөвшөөрсөн гээд мэйстер хүлцэл өчин харав.

- Тэгвэл тушаалыг нь биелүүл гээд Кателин сэр Десмондыг буруутгасангүй. Тэр түүнд итгэх

өчүүхэн шалтаг өгсөн болохоор эргэлзээгүй Риверраны хүмүүсийн лордынхоо охинд хандах үнэнч байдлыг ашиглаж ямар нэг хэрэг өдөөхөөс эмээсэн биз. *Би түүр ч атугай хугацаанд дайнаас амсхийх нь* гэж тэр өөртөө хэлэв.

Мэйстерийг явсан хойно Кателин ноосон нөмрөг нөмрөөд түрүүчийн адил тагт руу гарлаа. Нарны гэрэлд шилтгээнийг ороон мурилзах мөрний мандал алтран гялтагнана. Кателин онгоцны бараа харагдахаас эмээн алсад завь эрэн саравчиллаа. Юу ч харагдсангүй ч түүний найдлага хэвээр байх шалтаг байсангүй.

Өдөржингөө зогссоны эцэст шөнө дөхөхөд хөл нь чилж өвдлөө. Цайзад их үдийн алдад хэрээ ирж өргөн хар жигүүрээ дэлгэн дэвсээр дээврийн хөндий рүү буув. *Хар жигүүр хар үг* гэж Кателин бодоод сүүлд ирсэн шувуу ямар аймшигтай мэдээ авчирсныг саналаа.

Мэйстер Вайман үдэш нь лорд Таллиг асрахаар ирэхдээ Кателинд талх, бяслаг, луувантай чанасан үхрийн махтай даруухан зоог авчирав.

- Би Атерайдес Вэйнтэй ярилцлаа, хатагтай. Тэр Танси нэртэй эмэгтэй Риверранд хэзээ ч зарцаар байгаагүй гэдэгт бүрэн итгэлтэй байна.

- Өнөөдөр хэрээ ирэхийг би харсан. Жэйми ахиад баригдаа юу? *Эсвэл алагдсан ч юм уу, бурхад минь?*

- Үгүй, хатагтай бидэнд Хааны алуурчийн тухай ямар ч үг ирээгүй.

- Тэгвэл тулааны тухай юу? Эдмур хүнд байдалд орсон юм биш биз дээ? Эсвэл Робб ч юм уу? Гуйж байна сайхан сэтгэлийн үүднээс сэтгэлийг минь амраагаач.

- Хатагтай би ингэх ёсгүй... гээд Вайман өрөөнд хүн байгаа эсэхийг шалган харснаа, - Лорд Тайвин голын хөндийг орхисон. Бүх гарам нам гүм байгаа гэв.

- Тэгвэл хаанаас хэрээ ирсэн юм? гэхэд мэйстер лорд Хостерийн унтлагын хувцсыг янзлан түүнээс харц буруулж,

- Өрнө зүгээс гэв.

- Роббоос мэдээ ирээ юу? гэхэд Вайман хэсэг зуур тээнэгэлзсэнээ,

- Тиймээ, хатагтай гэлээ.

- Ямар нэг зүйл болоо юу? гээд Кателин түүний занг андахгүй тул ямар нэгэн зүйл нуугаад байгааг нь мэдлээ.

- Надад хэлээч. Энэ Роббын тухай юу? Тэр шархдаа юу? *Үхсэн л биш шүү, бурхад минь надад түүнийг үхсэн гэж бүү хэлээрэй.*

- Эрхэм дээдэс Крагыг дайрахдаа шарх олсон. Гэвч захианд ямар ч сэтгэл зовох зүйл байхгүй

удахгүй эргэж ирнэ гэж бичсэн байсан гэж мэистер Вайман харц буруулсан хэвээр хэлэв.

- Шархадсан гэнэ ээ? Юу нь шархадсан гэж? Хэр ноцтой юм?

- Ямар ч сэтгэл зовох зүйл байхгүй гэж тэр бичсэн байсан.

- Миний сэтгэлийг бүх төрлийн шарх зовоож байна. Түүнийг сувилж байгаа юу?

- Тийм гэдэгт итгэлтэй байна. Крагын мэистер түүнийг сувилж байгаа гэдэгт эргэлзэх зүйлгүй.

- Тэр хаанаа шархдаа вэ?

- Хатагтай надад таньтай ярихыг хориглосон өршөөгөөрэй гээд Вайман уусмал хандаа цуглуулж аваад гарах хаалганы зүг яаран алхахад Кателин эцгийн хамт үлдэв. Намуу цэцэгтэй сүү өөрийн үүргээ гүйцэтгэж лорд Хостер гүн нойронд автжээ. Амнаас нь өрөөсөн завьж дагуу нарийхан шүлс асгарч дэрийг нь норгоно. Кателин дөрвөлжин даавуу аваад зөөлөн арчлаа. Түүнийг хүрэх үед лорд Хостер ёологнов.

- Намайг өршөө. Танси... цус... цус... бурхад минь ивээгээч гэж сонсогдох төдий хоолойгоор аяархан хэлэв.

Түүний үг Кателины сэтгэлийг үймүүлэхэд юу болохыг нь мэдсэнгүй. *Цус. Бүх зүйл цус руу буцаж ирлээ гэж үү? Аав аа энэ эмэгтэй хэн байсан юм бэ? Юу хийсэн болоод та түүнээс өршөөл гуйж байгаа юм?*

Тэр шөнө Кателин өнгөрч алдсан хүүхдүүдийнхээ тухай зүүдлэн тухгүй хонов. Үүр цайхын алдад эцгийнх нь хоолой чихэнд сонсогдоход сэрлээ. *Хууль ёсны хонгор хүүхдүүд... тэр яагаад ингэж хэлсэн юм бол... эсвэл Танси гэдэг эмэгтэйгээс хууль бус хүүхэдтэй болсон юм болов уу?* Кателин үүнд итгэсэнгүй. Түүний дүү Эдмурийн хувьд бол тийм. Хэрвээ Эдмур арваад хүүхэдтэй болсон бол гайхах юм алга. Гэвч түүний эцэг л биш шүү. Лорд Хостер Талли хэзээ ч тэгэх хүн биш.

Танси гэж түүний намайг Кат муурхан гэж дууддагын адил Лайзаг өхөөрдөн дуудсан ямар нэг амьтны нэр биш байгаа даа? Лорд Хостер урьд нь ч түүнийг дүүтэй нь эндүүрч байсан. *Чамд бусад нь бий. Хууль ёсны, хонгор хүүхдүүд гэж тэр хэлсэн.* Лайза таван удаа жирэмслэснээс хоёрыг нь Эйрид, гурвыг нь Хааны газар зулбажээ. Гэвч хэзээ ч лорд Хостерийн гар түүнийг тайвшируулах Риверранд эндэж байсангүй. *Хэзээ ч... эс бөгөөс тэр анх хүүхэдтэй болоогүй бол...*

Тэр дүүтэйгээ нэг ижил өдөр гэрлэж эцгийн халамжаас хөндийрөн шинэхэн нөхрүүд нь Робертийн бослогод оролцохоор явж билээ. Дараа нь сарын юм хугацаандаа ирсэнгүйд Лайза тэднийг хүү тээж байгаа гэдэгт баяртай байсан.

- Чиний хүү Винтерфеллийн залгамжлагч харин минийх Эйригийнх болно. Тэд яг л Нэд, лорд Роберт хоёр шиг сайн найзууд болцгооно. Тэгээд ч үеэлээс илүү ах дүүс бололцохыг би мэдэж

байна. Тэр ийм их баяртай байсан.

Гэсэн ч Лайзагын сарын юм удахгүй ирэхэд түүнтэй цуг бүх баяр хөөр нь сарнин алга болжээ. Кателин үргэлж Лайзаг ердийнхөөр хоцорч байна гэж бодсон ч хэрвээ урьд нь хүүхэдтэй болж байсан бол...

Кателин анх түүнд Роббыг тэврүүлэхээр өгснийг саналаа. Бяцхан улаан нүүртэй уйланхай хэдий ч амьдрал дүүрэн хүчтэй хүү байлаа. Кателиныг дүүгийнхээ гар дээр хүүхдээ тавиад төдий удсангүй Лайзагын нүүрэнд нулимс урсчээ. Тэр хүүхдийг яаран Кателинд буцааж өгөөд зугтсан билээ.

Хэрвээ тэр өмнө нь хүүхдээ алдаж байсан бол энэ аавын үгний учрыг тайлж болох ч үүнээс гадна олон зүйл байна... Лайзаг лорд Арринтай яаран гэрлүүлсэн агаад Жон эцгээс нь хүртэл хөгшин хүн байлаа. Удам залгамжлагчгүй өвгөн. Түүний эхний хоёр эхнэр хүүхэдгүй орхиж, ахынх нь хүү Хааны газар Брандон Старктай алагдаж, зоригт үеэл нь Хонхны тулааны үеэр үрэгджээ. Түүнд Аррины удмыг үргэлжлүүлэхийн тулд залуу эхнэр хэрэгтэй байсан. *Залуухан үржил сайтай.*

Кателин босч нөмрөгөө нөмрөөд эцгийнхээ харанхуй өрөө рүү шат уруудан ороход өгүүлэхийн аргагүй айдас сэтгэлийг нь эзэмдэв.

- Аав аа. Аав аа би таны юу хийснийг мэдлээ.

Тэр төдий удаан толгой нь мөрөөдөлд умбасан гэмгүй сүйт бүсгүй байсангүй. Кателин бэлэвсэн эхнэр, урвагч, гашуудаж буй эхийн дээр ухаалаг, орчлонгийн жамыг мэдэх ухаалаг нэгэн болжээ.

- Та түүнд Лайзаг өгсөн байна. Лайза Жон Арринд Таллигийн овгийн илд жадны төлөөс болжээ.

Дүүгийнх нь гэрлэлтэнд хайр сэтгэл байгаагүй гэдэгт гайхах зүйлгүй. Арринийхан бардам нэр хүндэндээ цочмог улс байлаа. Лорд Жон бослогын үед Таллигийнхантай холбоо тогтоон Лайзатай хүүтэй болох найдлагаар гэрлэсэн ч бохирдсон оронд нь хүсээгүй ирсэн эмэгтэйд дурлах бэрх байлаа. Түүний эелдэг зүтгэлтэй занд эргэлзээгүй ч Лайзад халуун дулаан амьсгал хэрэгтэй байв.

Маргааш өдөр нь Кателин өглөөний цайны дараа үзэг, цаас гуйж Аррины хөндийд байгаа дүүдээ захидал бичлээ. Тэр Лайзад Бран, Рикон хоёрын тухай шимширсэн үг дурдаж ихэнхидээ нь эцгийнх нь тухай бичив. *Тэр чамд буруу зүйл хийсэн гэж бодож байгаа учир одоо цаг нь бага үлдээд байна. Мэйстер Вайман түүнийг намуу цэцэгтэй сүү тэнхрүүлэхгүй гэсэн. Эцэг маань илд бамбайгаа орхих цаг болжээ. Энэ бол түүний амрах цаг. Гэвч тэр шаргуу эсэргүүцэж бууж өгөхгүй байна. Үүнийг чамтай холбоотой гэж бодож байна. Түүнд чиний уучлал хэрэгтэй. Дайнаас болж Эйригээс Риверран хүрэх зам аюултай болсон ч хүчтэй хүлэг баатрын цуваа дагуулахад Сарны уулс дундуур аюулгүй зорчиж болохгүй гэж үү? Зуу юм уу мянган хүнтэй байсан ч хамаагүй. Хэрвээ чи ирж чадахгүй бол ядахдаа түүнд захиа бичнэ биз дээ? Хайртай хэдхэн үг байхад тэр амгалан нойрсоно. Хүсвэл захиа бичээрэй би түүнд уншиж өгөн сэтгэлийг нь амраая.*

Кателин үзэг бэхээ хойш тавиад лацны лав гуйхдаа захиа дэндүү хожимдсоныг ухаарлаа. Мэйстер Вайман лорд Хостер Эйрид хэрээ очоод хүрч ирэх хугацаанд тэснэ гэдэгт итгэлгүй байв. Тэгсэн ч тэр өмнөхийн адил үг хэлсээр байх болно... Таллигийнхан ямар ч хамаарлаас үл шалтгаалан хялбархан бууж өгдөг хүмүүс бус билээ. Дараа нь мэйстерт захиаг даатгасан хойно Кателин сүмд орж аавынхаа эрүүл мэндийн төлөө Эцгийн урд лаа асаан, хоёр дахыг нь ертөнцөд анх үхлийн хаалгыг нээн хэрээ илгээсэн Чавганцийн урд асаан, гурав дахыг нь Лайза тэр хоёрын алдсан хүүхдүүдийн төлөө Ээжийн урд асаалаа.

Тэр өдрийн үдээс хойш Кателин лорд Хостерийн орны хажууд ном нэг газраа ахин дахин уншин цаг нөхцөөж байтал бүрэн дуу тасхийн чанга хоолой гарлаа. *Сэр Робин* гэж даруй давхийн бодов. Тагт руу очиж харвал голд юу ч үзэгдээгүй ч гадна хүмүүсийн хоолой гарч, морьдын туурай тачигнах, хуяг дуулга жингэнэх, хөөрөн хашгирах чимээ сонсогдлоо. Кателин эргүүлгэн шатаар шилтгээний дээвэр лүү өгсөх зуураа *“Сэр Десмонд намайг дээвэр лүү гарахыг хориглоогүй”* гэж өөрийгөө тайвшируулав.

Чимээ шилтгээний цаад хэсгийн төв хаалганы зүгээс гарч байлаа. Сараалжны өмнө зогссон хүн гинжнээс татахад огцом өргөгдөж, түүний цаана цайзын гадна талбайд хэдэн зуун морьтон байв. Салхи үлээхэд далбаа намиран хийсч Кателин Риверраны үсэрч буй хулд загасыг хараад чичирэн тайвширлаа. Эдмур байна.

Эдмурыг түүн дээр ирэх хүртэл хоёр цагийн хугацаа өнгөрчээ. Тэр зуур шилтгээний хүмүүс цугларан шуугилдаж эрчүүд ард үлдээсэн эхнэр хүүхдүүдтэйгээ тэврэлдэнэ. Дээврийн хөндийгөөс гурван хэрээ нисэн гарч хар жигүүрээ дэвэн агаарт одлоо. Кателин тэднийг нисэхийг эцгийнхээ тагтнаас харлаа. Тэр дүүтэйгээ уулзахад бэлтгэн үсээ угааж, хувцсаа сольсон ч хүлээхээс хэцүү зүйл байсангүй.

Эцэст нь хаалганы гадна чимээ гарахад гараа өвдөг дээрээ тавин суулаа. Эдмурын гуталд хатсан улаан шавар наалдаж шилбэвч, хувцас руу нь үсрэн цоохортжээ. Түүний төрхөөс тулаанд ялсныг нь мэдэхийн аргагүй байв. Тэр турж хацар нь зэвхийгээд, сахал арзайж дэндүү цоргисон нүдтэй байв.

- Эдмур чи тааруу харагдаж байна. Ямар нэг зүйл болоо юу? Ланнистерийнхан гол гатлаа юу? гэж Кателин санаа зовон асуулаа.

- Би тэднийг буцаасан. Лорд Тайвин, Грегор Клегэйн, Аддам Марбранд тэднийг бүгдийг буцаасан. Гэсэн ч Станнис... гээд үрчийлээ.

- Станнис гэнэ ээ? Ямар Станнис?

- Тэр Хааны газрын тулаанд ялагдсан байна. Түүний флот шатаж арми нь сарниж гэж Эдмур дургүйхэн хэлэв.

Ланнистерийн ялалт муу мэдээ байсан ч Кателин дүүгийнхээ илэрхий дургүйцлийг хуваалцсангүй. Тэр Рэнлигийн майханд сүүдэр хөдөлж ган холхивч нэвт яран цусан мөр татуулсныг хар даран зүүдэлсэн хэвээр байлаа.

- Станнис лорд Тайвинаас илүү нөхөр биш.
- Та ойлгосонгүй. Хайгарден Жоффригийн талд орсон. Дорн ч гэсэн адил. Бүх өмнө зүг тэр аяараа. Харин та тэгэхэд Хааны алуурчийг чөлөөлсөн байдаг. Таньд ингэх эрх байхгүй гээд Эдмурын ам чангарлаа.
- Надад эхийн эрх бий гэж Кателин тайван хоолойгоор хэлсэн ч Хайгардены тухай мэдээ Роббын найдлаганд хэрцгий цохилт байлаа. Тэр одоо энэ тухай бодож чадсангүй.
- Таньд эрх байхгүй гэж Эдмур давтлаа. - Тэр Роббын олзлогдогч, хааны чинь олзлогдогч болохоор Робб түүнийг аюулгүй байлга гэж надад тушаасан юм.
- Бриенн түүнийг аюулгүй байлгана. Тэр илдээрээ тангарагласан.
- Нөгөө эмэгтэй юу?
- Тэр Жэймиг Хааны газар луу авч яван Арьяа, Санса хоёрыг аюулгүй буцааж авчирна.
- Серсей тэднийг хэзээ ч өгөхгүй.
- Серсей биш. Тирион өгнө. Тэр бүхий л ордны өмнө андгайлсан. Дээрээс нь Хааны алуурч ч гэсэн андгайлсан.
- Жэймигийн үг ямар ч үнэ цэнэгүй. Бяцхан чөтгөрийн хувьд тэр тулааны үеэр толгойдоо сүхний шарх авсан. Тэр таны Бриенниг чинь Хааны газар хүрэхээс өмнө үхнэ.
- Үхэх гэнэ ээ? *Бурхад үнэхээр ийм өршөөлгүй гэж үү?* Тэр Жэймигээс зуунтаа андгай авсан ч дүүгийнх нь амлалтанд найдаж байсан билээ.

Эдмур түүний үймэрснийг анзаарсангүй.

- Жэйми миний даалгавар болохоор би түүнийг буцааж авчирна. Би хэрээнүүд илгээсэн...
- Хэнд тэр вэ? Хичнээн?
- Гурвыг лорд Болтон руу захиа бичсэн юм. Риверранаас Хааны газар хүрэх зам гол, хуурай замын алинаар ч Харренхалын ойролцоо өнгөрөх ёстой.
- Харренхал гэхэд энэ үгийг хэлэхээс өрөөнд улам баргар болгох шиг санагдав. Кателин айдас дүүрэн хоолойгоор,
- Эдмур чи юу хийснээ мэдэж байна уу? гэж дуу алдав.
- Айх хэрэггүй би таныг оролцуулах гээгүй. Би Жэймиг барьсан хүнд мянган луу шагнахаар амласан.

Муу дээр улам ч дордож. Миний дүү бол тэнэг гэж Кателин цөхрөн бодоход хүсээгүй нулимс

нүдийг нь бүрхэв.

- Хэрвээ энэ олзлогдогсод солилцох биш зугталт байсан юм бол яагаад Ланнистерийнхан миний охидыг Бриеннд өгнө гэж?

- Тийм зүйл хэзээ ч болохгүй. Хааны алуурч бидэнд эргэж ирнэ. Би үүнийг баттай хийсэн.

- Чиний баттай зүйлийн ачаар би ахин хэзээ ч охидоо харахгүй нь. Бриенн түүнийг Хааны газар аюулгүй хүргэж өгөх байсан... *тэдний араас хичнээн хүн агнахгүй байх тусам.* Харин одоо бол... гээд Кателин үргэлжлүүлж чадсангүй.

- Намайг орхи, Эдмур гээд шилтгээн удахгүй түүний мэдэлд очих болохоор түүнд тушаах эрх байхгүй байсан ч маргахын аргагүй хоолойгоор, - Намайг эцэг гашуудалтай минь орхи. Надад чамтай ярих зүйл алга. Явж үз. Яв гээд түүний хүсч байгаа ганц зүйл гэвэл хэвтээд нүдээ анин нойрсож ямар ч зүүд бүү зүүдлээсэй гэж залбирах явдал байлаа.

АРЪЯА

Тэнгэр тэдний ард хоцорсон Харренхалын хана шиг тас харанхуйлан зөөлөн жигд бороо морьдын туурайн чимээ зөөллөн нүүр даган урсана.

Тэд хойд зүг нуурнаас холдон дугуйн мөр гарсан энхэл донхолтой замаар тариаг нь хураасан талбай гатлан ой мод, голын зүг явлаа. Арьяа урд нь тэргүүлэн хулгайлсан морио гуядан ширүүн хатируулахад эргэн тойрон модод шахан хүрээлэв. Халуун бялуу, Жэндри хоёр араас нь чадлаараа дагана. Алсад чонон сүрэг ульж, Халуун бялуугийн хүндээр амьсгаадах сонсогдоно. Хэн ч үг дуугарсангүй. Арьяа хоёр хүүг ард унаж хоцорсон эсэх болон араасаа нэхэн хөөгчид ирж байгаа эсэхийг шалгахын тулд үе үе эргэн харж явлаа.

Тэднийг хөөнө гэдгийг Арьяа мэдэж байв. Тэр жүчээнээс гурван морь, Рус Болтоны хувийн өрөөнөөс газрын зураг, хутга хулгайлж, арын хаалган дээр зогсч байсан харуулыг Жэйкен Х'гарын өгсөн төмөр зоосыг авахаар өвдөглөхөд нь хоолойг нь зүсэн алсан билээ. Түүнийг цусандаа хутгалдан үхсэн хэвтэж байхыг нь олсон хүн хашгирах нь лавтай. Тэд лорд Болтоныг сэрээн Харренхалыг хэрмийн шүднээс авахуулаад зорь хүртэл нэгжиж газрын зураг, хутга алдагдан зэвсгийн өрөөнд хэдэн илд дутаж, гал зуухнаас талх бяслагийн зэрэгцээ талхчин хүү, дархны дагалдан, хундага аягалагч Нан... эсвэл хэн асууснаас хамааруулан хэлдэг Үен, Арри алга болсныг мэдэх болно

Дредфортын лорд тэдний араас өөрийн биеэр мордохгүй. Рус Болтон орондоо хэвтэж цонхигор биендээ хануур хорхой тавиулаад шивнэсэн зөөлөн хоолойгоор тушаал өгч байгаа. Түүний хүн болох Волтон магадгүй анг тэргүүлэх бөгөөд үргэлж урт хөлөндөө шилбэвч өмсдөг учир Төмөр шилбэт гэсэн нэрийг авчээ. Эсвэл шүлхий Варго Хот өөрсдийгөө Зоригт нөхөд гэж дууддаг хөлсний цэргүүдтэйгээ байж болох. Хүмүүс тэднийг нүүрнээс нь гадуур Цуст Жүжигчид гэж дуудах бөгөөд лорд Варго дургүй хүргэсэн хүнийхээ гар хөлийг цавчдаг зуршилтай учир заримдаа Хөл цавчигч гэдэг байлаа.

Хэрвээ тэд биднийг барих юм бол Варго гар хөлийг маань огтолж, Рус Болтон арьсыг маань хуулна гэж Арьяа бодлоо. Тэр цээжин дээрээ лорд Болтоны сүлд болох Дредфортын өвчүүлсэн хүнтэй зарцын хувцастай хэвээр байв.

Түүнийг эргэж харах тоолон алсад Харренхалын хаалга, нүсэр том хэрмийн оройд зоосон бамбар улалзаж байснаа үгүй болжээ. Харренхал унтаа чигээрээ харанхуйд модны ард нуугдан далд оров.

Тэднийг эхний гол гатлах үед Арьяа морио хажуу тийш эргүүлж зам руу гаралгүй тахирлан мурилзсан ус даган дөрөвний нэг мил хиртэй явсны эцэст чулуурхаг эрэг өөдөө өгсчээ. Хэрвээ анчид нохойтой бол үүгээр тэдний үнэрийг алдаж магадгүй гэж найджээ. *Тэд зам дээр үлдээж болохгүй. Зам дээр үхэл байгаа. Зам гэдэг бол үхэл гэсэн үг* гэж шийдэв.

Жэндри, Халуун бялуу хоёр түүний сонголтонд асуулт тавьсангүй. Эцсийн эцэст түүнд газрын зураг байгаагийн зэрэгцээ Халуун бялуу араас нэхэн хөөж ирэх хүмүүсээс дутуугүй Арьяагаас айсан байлаа. Тэр Арьяагын харуул алахыг харсан билээ. *Тэр надаас айж байсан нь дээр. Тэгвэл*

урдаас тэнэг юм хэлэхийн оронд миний хэлсэн зүйлийг гүйцэтгэнэ.

Арьяа мөн адил айх ёстойгоо мэдэж байлаа. Тэр ердөө аравтай харанхуй ойд хулгайлсан морь унан араас нь хөлийг нь дуртайяа цавчих хүмүүс хөөж яваа туранхай хэрзгэр охин билээ. Гэсэн ч Харренхалд байсан үеийнхээс илүү сэтгэл нь тайвширчээ. Бороонд хуруунд наалдсан харуулын цус угаагдан арилахад харанхуйд өлөн чононууд саарал сүүдэр шиг гэтэж байсан ч нуруундаа сэлэм үүрсэн Арьяа Старк айсангүй. *Айдас илднээс гүн зүсдэг* гэж Сирио Форелийн зааж өгсөн үгийг шивнээд араас нь бас Жэйкеней *валар моргулис* гэсэн үгийг хэлэв.

Бороо зогссоноо ахин эхэлж тэгсхийгээд намдсанаа шиврэх учир тэд сайн нөмрөгөө уснаас хямгадан явав. Арьяа морио тэргүүлэн жигд удаанаар алхуулав. Модон дор хурдан явахад дэндүү харанхуйн зэрэгцээ хөвгүүдийн хэн ч морьтон биш учир зөөлөн шавартай хөрсөнд хагас нуугдсан үндэс чулуунд бүдрэх осолтой байв. Тэд ахин нэг зам гатлахад дугуйн гүн шигдсэн мөр явсан байсан ч Арьяа зайлсхийв. Тэд дугуй толгодыг өгсөн уруудаж бөөрөлзгөнө, нохойн хошууны ширэлдсэн бут туучин, нарийхан жалганы ёроол даган явахад нойтон навчтай хүнд мөчир нүүр рүү шавхуурдана.

Нэг удаа Жэндригийн гүү шаварт хөл хальтиран хондлойгоороо чанга унахад тэр эмээлээс ховх шидүүлсэн ч морь, хүн хоёрын алин ч гэмтээгүй тул Жэндри зөрүүдлэн хараад ахин мордлоо. Үүнээс төдийлөн удсангүй тэд гурван чоно бугын янзаганы сэг идэж байхтай тааралдав. Халуун бялуугийн морь араатны үнэрийг аваад ухасхийн авч давхилаа. Хоёр чоно зугатсан ч гурав дахь нь олзоо хамгаалахад бэлдэн толгойгоо өргөн шүд ярзайлган архирав.

- Буцаад. Түүнийг үргээхгүйн тулд удаанаар гэж Арьяа Жэндрид хэлэв. Тэд морьдоо чоно болон түүний найр ард хоцрох хүртэл захлан холдлоо. Зөвхөн тэгсэн хойно Арьяа модон дунд эмээлээсээ цөхрөн зууралдаж яваа Халуун бялуугийн араас давхилаа.

Дараа нь шатсан тосгон дайралдахад байшингийн харласан мод дундуур болгоомжтой гарч алимны модноос эгнээгээр нь дүүжилсэн арваад хүмүүсийн хэлхээтэй ястай тааралдав. Халуун бялуу тэднийг хармагц нарийхан хоолойгоор Ээжийг дуудан зальбирч араас нь давтан уншсан бол Арьяа нойтон ялзарсан хувцастай хатангир цогцос руу хараад өөрийн мөргөлөө хэлэв.

- *Сэр Грегор, Дансен, Полливер, Рафф Свитлинг. Гижигдэгч болон Хоточ, сэр Илин, сэр Мерин, хаан Жоффри, хатан Серсей* гээд үүнийгээ валар моргулисаар төгсгөн бүсэндээ зүүсэн Жэйкеней зоосонд хүрээд үхсэн хүмүүсийн доогуур өнгөрөхдөө мөчирт ургасан алим зулгаан авч хэт болсон нялцгай байсан ч өттэй юутай хээтэй нь хамт идлээ.

Тэр өдөр үүр цайсангүй. Тэнгэр алгуурхан гэгээ ороход нарны бараа үзэгдсэнгүй. Харанхуйгаас саарал гэгээ тэмдгэрэн ертөнцийн өнгө хулчгардуухан буцаж ирэв. Бараан ногоон өнгийн шилмүүстэй цэрэг нарс моддын далбагар өргөн навч нь улаан хүрэн өнгөө алдан хүрэн бор болж эхэлжээ. Тэд морьдоо усалж өглөөний цайнд түргэн хүйтэн юм идэхээр зогсоход Халуун бялуугийн гал зуухнаас хулгайлсан талхыг хуваан хатуу шаргал бяслагны өөдөстэй гар дамжуулан идлээ.

- Чи бидний хааш явж байгааг мэдэж байна уу? гэж Жэндри түүнээс асуухад,

- Умард зүг гэж Арьяа хэллээ.
- Умард зүг хаашаа гэж? гээд Халуун бялуу эргэн тойрноо итгэлгүйхэн харав.
- Тийшээ гээд Арьяа баяслагаараа дохив.
- Гэхдээ тэнд чинь нар байхгүй шүү дээ. Чи яаж мэдэж байгаа юм?
- Хөвдөөр нь. Модны нэг талд саглайн ургасан байгааг нь харж байна уу? Энэ бол өмнө зүг.
- Бид умард зүг хаагуур очих юм? гэж Жэндри мэдэхийг хүслээ.
- Сэрээгээр гээд Арьяа хулгайлсан газрын зургаа дэлгэн тэдэнд үзүүлэв.
- Харж байна уу? Бид Сэрээнд хүрмэгц голын эх даган Риверран хүртэл явна. Энэ урт зам болохоор бид голыг алдаж болохгүй гээд хуруугаараа заалаа.

Халуун бялуу газрын зураг луу анивчин харлаа.

- Аль нь Риверран юм?

Риверраныг Унагаа хад, Улаан салааны ацалж урссан голын хоёр цэнхэр шугам дунд шилтгээний цамхаг шиг дүрсэлжээ.

- Энд. Риверран гэж бичээстэй байна гээд хүрлээ.
- Чи уншиж бичиж чаддаг юм уу? гэж Халуун бялуу түүнийг усан дээгүүр явж чаддаг гэж хэлсэн аятай гайхширан хэлэхэд Арьяа толгой дохилоо.
- Бид Риверранд хүрмэгц аюулгүй болно.
- Бид гэнэ ээ? Яагаад?

Учир нь Риверран бол өвөөгийн минь шилтгээн тэнд Робб байгаа болохоор гэж Арьяа хэлэхийг хүссэн ч уруулаа хазаад газрын зургийг буцаж ороов.

- Зүгээр л тэгж байна. Бид зөвхөн тийш явна гээд эмээл дээрээ түрүүлж мордов. Түүнд Халуун бялуугаас үнэнийг нуусан нь таагүй сэтгэгдэл төрүүлэвч нууцаа итгэн хэлсэнгүй. Жэндри мэдэж байгаа ч өөр хэрэг байлаа. Жэндрид өөрийн нууц бий бөгөөд юу гэдгийг нь өөрөө ч мэддэггүй байв.

Тэр өдөр Арьяа явдлаа хурдасгаж морьдоо чадлын хэрээр шогшуулан заримдаа тэгш газар тааралдахад давиран цогиулна. Гэсэн ч энэ нь ховор байв. Газрын байдал тэдний явдал шиг овон товонтой гүвээрхэг байв. Толгод өндөр эгц биш хэр нь эцэс төгсгөлгүй мэт санагдах бөгөөд тэд төдөлгүй өгсөж уруудахаас залхан хэвгий газар голын хөвөө даган толгой дээр ширэлдэн сүлжсэн намхан модтой хөндий рүү орлоо.

- Сэрээ байна! Одоо бид чиний хэлсэн шиг голын эх даган явж болох юм. Бараг л ирчихлээ! гэхэд,
 - Би үүнийг Сэрээ гэж бодохгүй байна гээд Арьяа уруулаа хазлаа. Голын ус бороонд хөөж үерлэсэн ч гучин футээс хэтрэхгүй байлаа. Тэр Сэрээ үүнээс хамаагүй өргөн болохыг санаж байв.
 - Энэ Сэрээний хажууд дэндүү жижигхэн юм. Тэгээд ч бид хангалттай хол яваагүй байна.
 - Үгүй, бид явсан. Бид өдөржингөө явж бараг зогсоогүй. Бид урт зам туулсан байх ёстой гэж Халуун бялуу шаардахад,
 - Алив газрын зургаа ахин нэг хараач гэж Жэндри хэлэв.
- Арьяа мориноос бууж газрын зургаа дэлгэлээ. Бороо элэгдсэн хонины арьсан дээр шивэрч горхилон урсана.
- Бид энд байгаа гэж бодож байна гээд Арьяа заахад хөвгүүд мөрөн дээгүүр нь өнгийн харцгаав.
 - Гэхдээ энэ чинь аль ч зам байж болно шүү дээ. Харж байна уу Харренхал чиний хурууны дэргэд хүрэх шахам ойрхон байна. Харин бид өдөржингөө явсан байдаг! гэж Халуун бялуу зөрүүдлэв.
 - Бид Сэрээнд хүрэх хүртэл олон милийн зай туулах хэрэгтэй. Бид олон өдөр яваагүй. Энэ гарцаагүй өөр гол байх. Эднийг харж байна уу гээд Арьяа дор нь тод үсэг бичсэн газрын зураг дээрх нарийхан цэнхэр шугамуудыг заав.
 - Дарри, Ногоон алим, Охин... өө, энэ Бага уд байх гэхэд Халуун бялуу голын шугам руу харснаа,
 - Энэ чинь надад жижигхэн санагдахгүй байна гэв.
 - Чиний зааж байгаа гол чинь өөр гол руу урсаж байна гээд Жэндри хөмсөг зангидав.
 - Том Уд гэж Арьяа уншлаа.
 - Тэгвэл Том Уд байх нь. Хараач Том Уд Сэрээ рүү урсаж байгаа болохоор бид дагаж болох ч голын өөд биш уруу явах хэрэгтэй юм байна. Зөвхөн энэ гол Бага Уд биш бол шүү дээ өөр бас нэг энд байна...
 - Мяралзсан гол гэж Арьяа уншлаа.
 - Хараач энэ нуурын зүг гогцоорон цутгаж Харренхал руу буцаж байна гээд Жэндри хуруугаараа заав.
 - Үгүй! Тэд биднийг гарцаагүй ална гээд Халуун бялуугийн нүд томорлоо.
 - Бид үүнийг яг ямар гол нь гэдгийг мэдэх хэрэгтэй. Мэдэх хэрэгтэй гэж Жэндри шаргуу хоолойгоор хэлэв.
 - Үгүй бид тэгэхгүй гээд Арьяа газрын зураг дээрх цэнхэр шугамын хажууд нэр тавиастай байсан

ч голын эрэг дээр хэн ч нэр бичсэнгүй тул,

- Бид голын эх өөд юм уу дагаж уруудахгүй. Бид гаталж умард зүгийг барин явна гээд газрын зургаа ороолоо.

- Морь сэлж чадах болов уу? Энэ их гүн харагдаж байна. Тэнд могой байвал яана? гэж Халуун бялуу асуулаа.

- Чи умард зүг явж байгаа гэдэгтээ итгэлтэй байна уу? Энэ бүх толгодын дараа хэрвээ бид эргэсэн байвал... гэж Жэндри хэлэв.

- Модон дээрх хөвдөөр...

- Тэр мод гурван талдаа хөвдтэй байхад, дараагийн модонд хөвд алга. Бид төөрч дугуйрч яваад байгаа юм биш үү гээд Жэндри ойролцоох мод руу заалаа.

- Тэгсэн ч гэсэн би голыг гаталлаа. Харин та нар харин үлдэх эсэхээ өөрөө мэд гээд Арьяа тэр хоёрыг үл тоомсорлон эмээл дээрээ гарлаа. Хэрвээ тэд дагахыг хүсэхгүй бол Риверраныг өөрсдийнхөөрөө олцгооно биз. Түүнээс урьд Жүжигчдийг олох байх даа.

Арьяа эргийн дагуу хагас мил яваад эцэст нь аюулгүй гатлах газар олоход гүү нь ус руу дургүйхэн оров. Гол нэрэндээ нийцсэн түргэн ширүүн урсгалтай дунд хэсэгтээ морины гэдсээр татсан гүнзгий байлаа. Ус гутлыг нь дүүргэхэд тэр морины зоо хавчсан хэвээр цаад эрэг өөд гарлаа. Ард нь ус цацлах чимээ гарч гүү бухимдангуй янцгаах сонсогдоно. *Тэгэхээр тэд араас дагаж байгаа байх нь. Сайн байна.* Арьяа эргэж харахад хөвгүүд цувралдан голоос ус дуслуулан гарч ирэв.

- Энэ бол Сэрээ биш. Энэ биш гэж Арьяа тэдэнд хэллээ.

Дараагийн гол гүехэн хялбар гарамтай байлаа. Энэ ч гэсэн Сэрээ биш бөгөөд Арьяаг гатлах тухай хэлэхэд урдаас нь хэн ч маргалдсангүй.

Үдшийн бүрий болоход тэд морьдоо амраахаар зогсож ахин талх, бяслаг идэв.

- Би норж даарч байна. Бид Харренхалаас одоо урт зайд холдсон болохоор гал түлье гэж Халуун бялуу гонгиноход,

- ҮГҮЙ! гэж Арьяа, Жэндри хоёр зэрэг хэлсэнд Халуун бялуу зүрх алдав. Арьяа Жэндри рүү харлаа. *Тэр Жон Винтерфеллд байхад тэгдэг байсан шиг надтай зэрэг хэллээ.* Тэр Жон Сноуг бусад ах дүү нараасаа илүүтэй үгүйлэн санаж байв.

- Ядахдаа бид унтаж болно биз дээ? Би их ядарлаа, Арри. Тэгээд ч өгзөг маань өвдөөд байна. Цэврүүтсэн байх.

- Хэрвээ чи баригдах юм бол улам олон цэврүүтэй болно доо. Бид цааш явна. Бид явах ёстой.

- Гэхдээ энэ чинь бараг харанхуй болж сар харагдахгүй байна шүү дээ.

- Мориндоо буцаж морд.

Тэд үдшийн гэгээ тасрахтай зэрэгцэн удаанаар сажлуулав. Арьяа туйлын ядарчээ. Түүнд Халуун бялуугаас дутахгүй нойр хэрэгтэй байсан ч унтаж зүрхэлсэнгүй. Хэрвээ тэд зүүрмэглэвэл магадгүй нүдээ нээхэд урд нь Варго Хот, Тэнэг Шагвелл, Сүсэгтэн Өрзвик, Рог, Хазагч, септон Утт болон бусад мангасуудынхаа хамт зогсож байх биз.

Арьяагын зовхи морины зөөлөн явдалд бүүвэйлэгдэн хүндрэв. Тэр агшин зуур аньснаа ахин буцаж нээлээ. *Би унтаж болохгүй* гэж өөртөө чимээгүй анхааруулав. *Би унтаж болохгүй. Би унтаж болохгүй.* Тэр нүдээ нухаад нээлттэй байлгахыг хичээн жолоогоо чанга атган морио гуядан шогшуулав. Гэсэн ч хэдэн хормын дараа морь ахин алхуулж нүд нь хоёр дахь удаагаа анилдлаа. Энэ удаад тийм хурдан нээгдсэнгүй.

Түүний морь зогсож өвс чимхлэн зулгаахад Жэндри гараас нь сэгсэрлээ.

- Чи унтчихсан байна.

- Би нүдээ жаахан амраасан юм.

- Тэгвэл тэднийгээ удаан амраах хэрэгтэй. Чиний морь зогсохгүй ч гэсэн дугуйрч яваад байхаар нь би унтсаныг чинь мэдсэн юм. Халуун бялуу үүнээс ч дор модны мөчир мөргөж унаад хашгирсныг чи сонссон байх ёстой. Тэгсэн ч чи сэрээгүй. Чи зогсож амрах хэрэгтэй.

- Би чамаас илүү удаан явж чадна гээд Арьяа эвшээлээ.

- Худалч. Чи тэнэг байхыг хүсээд байгаа юм бол явж л байхгүй юу харин би зогслоо. Би түрүүлж харуулд гарья. Чи унт.

- Халуун бялуу яах болж байна? гэхэд Жэндри заасанд Халуун бялуу хэдийн газар нөмрөг дороо атиралдан хэвтээд нойтон навчин дээр чимээгүй хурхиран унтаж байв. Нэг гарт нь унтахын өмнө хазсан бололтой том дугуй бяслаг харагдана.

Маргаад ашиггүй гэдгийг Арьяа ойлголоо. Жэндригийн зөв байв. *Жүжигчид ч гэсэн унтаж амрах хэрэгтэй* гэж өөртөө хэлээд тийм байгаасай гэж найдлаа. Тэр дэндүү их ядарсан тул эмээлээсээ хүчлэн буусан ч хусны дор унтах газар олохын өмнө морио чөдөрлөснөө санаж байв. Газар хатуу чийгтэй байлаа. Арьяа ахин орон дээр унтаж, халуун хоол идэн, дулаан галд ээх хүртэл хэр удаан хугацаа өнгөрөхийг бодлоо. Нүд нь өөрийн эрхгүй анилдахад илдээ сугалж дэргэдээ тавиад,

- Сэр Грегор. Дансен, Полливер, Рафф Свитлинг, Гижигдэгч... Гижигдэгч... Хоточ... гэж эвшээн шивнэлээ.

Зүүд нь улаан хэрцгий болов. Жүжигчид тэдний араас дөрвүүл нэхэн цайвар Лайсени, бараан хэрцгий Ибийн сүхчин, Игго гэж дууддаг морьтон лорд сорвитой Дотраки болон нэрийг нь

мэдэхгүй Дорнишийн хүн байлаа. Тэднийг бороон дундуур зэвэрсэн гархин хуяг, нойтон ширэн хувцастай довтолгоход эмээлдээ агссан сүх, илд нь хангинана. Тэд түүний араас агнахаар явж байгаа гэдгийг Арьяа хачирхалтай тод зүүдэндээ мэдэж байсан ч нэг л зүйл биш байсангүй. Тэр тэднийг агнаж байв.

Арьяа зүүдэндээ бяцхан охин байсангүй том хүчирхэг чоно байлаа. Тэр тэдний урд талын модон дотроос гарч ирэн соёогоо ярзайлган нам дуугаар хүржигнэхэд хүн, морь ялгаагүй айдсын эхүүн үнэр сад тавив. Лайсинигийн морь айсандаа цоройн янцгаахад, бусад нь хашгирч хоорондоо хүний хоолойгоор ярилцсан ч ямар нэг үйлдэл хийж амжихаас өмнө харанхуйгаас бороонд бусад чононууд гарч ирээд өлөн хоосон чимээгүй том сүрэг болов.

Тулаан богино цус урсгасан болов. Үсэрхэг хүн сүхээ сугалан шидэхэд, бараан царайт сумаа татан үхэж, цайвар Лайсени ухасхийн зугтахыг оролдлоо. Түүний ах эгч дүүс араас нь хөөн замыг нь хааж тойрч дайран морины хөлийг нь хазан эзнийх нь хоолойг хүүлэхэд газар уналаа.

Зөвхөн гүзээтэй хүн босоо хэвээр үлдэв. Түүний морь эгч дүүсийнх нь нэгний толгойг хага тийрэхэд, эзэн нь өөр нэг чоныг үсний хонхоо жингэнүүлэн тахир мөнгөн сарвугаар цавчив.

Арьяагын уур хүрч араас нь нуруу луу нь үсрэн эмээлээс нь толгойгоор нь газар цохин унагаад эрүүгээ гаранд нь шигтгэхэд шүд нь шир, ноосон хувцас, зөөлөн бие нэвтлэн ширхийн орлоо. Бусад нь дайрахад тэр толгойгоо угз татан мөрнөөс нь гарыг нь тас татан хаяж сэтгэл хөөрөхөд толгойгоо сэгсрэн хүйтэн хар бороон дунд бүлээн улаан цусан дусал цацлав.

ТИРИОН

Тэр хаалганы хуучин төмөр нугас хяхтнах чимээгээр сэрлээ.

- Хэн бэ? гэж сөөнгөтөв. Хоолой нь буцаж ирсэн ч хахир сөөнгө болжээ. Халуун нь намдаагүй хэвээр тул Тирион цаг хугацааг анзаарсангүй. Тэр энэ удаад хэр удаан унтсан бол? Бие нь хараал идсэн сул дорой байлаа.

- Хэн бэ? гэж ахин энэ удаад арай чангаар асуув. Бамбарын гэрэл нээлттэй хаалгаар тусахад өрөөг орны хажууд зоосон лааны ёзоор гэрэлтүүлнэ.

Тирион урдаас нь дүрс ирэхийг хараад чичирлээ. Энд Мэйгорын бэхлэлтэнд байгаа зарц бүхэн хатны хөлсөлсөн хүн, зочин бүр сэр Мандоны эхэлсэн ажлыг дуусгахаар ирсэн Серсейгийн ахин нэг муурын сарвуу байж болох байлаа.

Тэрбээр лааны гэрэлд алхан гарч ирээд одойн зэвхий нүүр лүү сайтар харснаа шогширлоо.

- Сахлаа хусахдаа өөрийгөө эсгэчихээ юу?

Тирионы хуруу өрөөсөн нүдний дээд талаас хамрынх нь талыг дайран эрүү хүрсэн гүн шархыг тэмтэрлээ. Шарх нь шүүрхий хэвээр байсан ч хүрэхэд дулаан байв.

- Тиймээ, аймшигтай том сахлын хутгаар.

Бронн нүүрсэн хар үсээ саяхан угааж царайнаасаа хойш шулуун самнаад өндөр түрийтэй тоногтой зөөлөн ширэн гутал өмсч, мөнгөн аралтай өргөн бүс бүслээд, цайвар ногоон торгон нөмрөг нөмөрчээ. Бараан саарал өнгийн ноосон хантааз дээр нь тод ногоон утсаар шатаж буй хөндлөн гинж хатгамлажээ.

- Чи хаана байсан бэ? Би чам руу аль хоёр долоо хоногийн өмнө... хүн явуулсан гэж Тирион шаардав.

- Дөрвөн өдрийн өмнө гэвэл зохино. Намайг энд хоёр ч удаа ирэхэд чи энэ ертөнцөд үхсэн мэт хэвтэж байсан.

- Хараахан үхээгүй гэвч миний хайрт эгч оролдсон гээд магадгүй тэр ингэж чанга хэлэх ёсгүй байж мэдэх ч Тирион хайхарсангүй. Сэр Мандон түүнийг алах гэсэн оролдлогын цаана Серсей байгааг гүн гүнзгий мэдэж байлаа.

- Наад цээжин дээр чинь байгаа үзэмжгүй зүйл чинь юу юм бэ? гэхэд Бронн инээлээ.

- Миний хүлэг баатрын сүлд. Саарал утаан талбар дээрх галт ногоон гинж. Чиний лорд эцгийн тушаалаар би одоо Хар усны сэр Бронн болсон. Мартахгүйн тулд харж ав.

Тирион өдөн орон дээр гараараа тулан нуруугаараа дэр налан ахилаа.

- Би чамайг хүлэг баатар болгоно гэж амалсныг санаж байна уу? гээд “лорд эцгийн чинь тушаалаар” гэсэн үгэнд дуртай байсангүй. Лорд Тайвин цаг гарзадсангүй. Хүүгээ Гарын цамхагаас зөөлгөсөн нь өөрийгөө өргөмжлөх хэнд ч ойлгомжтой зүйл байсан атал харин энэ нь ондоо зүйл байлаа.

- Би хамрынхаа талыг алдаж харин чи хүлэг баатар хожсон юм биз дээ. Бурхад үүнийг учрыг олох байх даа гээд гашуун хоолойгоор,

- Миний эцэг чамайг өөрийн биеэр өргөмжлөө юу? гэлээ.

- Үгүй. Тэд биднээс тулааны дараа амьд үлдсэнийг нь хүрдэт цамхагт цуглуулж Их Септон тосоор адислан, Хааны хамгаалалтын хүлэг баатрууд илдээр хүрсэн. Цагаан илднээс ердөө гурван хүн үлдсэн болохоор энэ тэр өдрийн хагасыг авсан даа.

- Би сэр Мандоны тулаанд үхсэнийг мэднэ. *Хэрвээ Под гол руу түлхээгүй бол агшин зуур урвагчийн илд миний зүрхэнд зоогдох байлаа.* Өөр хэн байхгүй болсон юм бэ?

- Хоточ. Үхээгүй зүгээр явчихсан. Алтан нөмрөгтөнгүүд чамайг түүний оронд дайралтын цэргийг хошуучилсанд хулчгар болсон гэсэн.

Миний хамгийн сайхан санааны нэг биш байлаа. Тирион хөмсөг зангидахад сорви нь таталдан чангарлаа. Тэр Бронныг сандалд суухыг зангав.

- Миний эгч намайг мөөг гэж эндүүрсэн бололтой. Тэр намайг харанхуйд байлгаж шивхээр бордож байгаа. Под сайн залуу. Гэвч хэл нь Кастерли Рокийн хэмжээтэй зангилаатай болохоор би түүний надад хэлсэн үгийн хагаст итгээгүй. Би түүнийг сэр Жаселинийг авчирахаар явуулсан ч буцаж ирээд түүнийг үхсэн гэж хэлсэн.

- Тэр болон хэдэн мянган хүн үхсэн гээд Бронн суулаа.

- Яаж тэр вэ? гээд Тирион дотор нь эвгүйрхлээ.

- Тулааны үеэр. Эгч чинь Кетлблакийнхныг Улаан шилтгээнд хааныг авчирахаар явуулсан гэж сонссон юм байна. Алтан нөмрөгтөнгүүд түүнийг явахыг хармагц араас нь хамт явахаар шийдсэн. Төмөр гарт өөрийн биеэр тэдний замыг хориглон хэрэм рүү буцах тушаал өгөхийг оролдсон юм. Байвотер тэднийг хангалттай зүрхшээлгэж бараг буцахад бэлэн болоод байтал хэн нэгэн хүзүүнд нь сум зоосон юм байх. Тэгмэгц айдас төрүүлэхээ болиод мориноос нь чирж унаган алжээ.

Серсейгийн хаалганд хэвтэж байгаа ахин нэг өр.

- Миний зээ. Жоффри. Тэр ямар нэг аюулд өртсөн үү?

- Илүү ч үгүй дутуу ч үгүй.

- Тэгвэл ямар нэг гэм учраагүй байх нь ээ? Шархдаж, үс нь сэгсийн, хөлийн хуруугаа хугалж, хумсаа цуулаагүй юу?

- Тэгсэн гэж сонсоогүй юм байна.

- Би Серсейд тийм зүйл болохыг анхааруулсан. Алтан нөмрөгтөнгүүдийг одоо хэн захирч байгаа юм бэ?

- Лорд эцэг чинь өрнөдийнхөө нэг хүнд өгсөн. Аддам Марбранд гэдэг хүлэг баатар гэсэн байхаа.

Алтан нөмрөгтөнгүүд ихэнхидээ гадны хүнээр захируулахад дургүй тул сэр Аддам Марбранд гярхай сонголт болжээ. Тэр яг л Жэймигийн адил хүмүүсийн дагалдах дуртай хүн байв. *Би Хотын харуулыг алджээ.*

- Би Подыг Шаггаг эрэхээр явуулсан ч олсонгүй.

- Чулуун хэрээнийхэн хааны ойд хэвээр байгаа. Шаггад тэндэх таалагдсан бололтой. Тиметт тулааны дараа Түлэгдсэн хүмүүсээ тэргүүлэн Станнисийн буудлаас дээрэмдсэн олзоо ачин гэрлүүгээ буцсан. Шелла арваад Хар Чихтэй Голын хаалга руу нэг өглөө очсон ч эцгийн чинь улаан нөмрөгтөнгүүд тэднийг хөөж Хааны газрынхан шивхээр чулуудан хөхрөлдсөн.

Хүний ач мэдэхгүй амьтад. Хар чихнийхэн тэдний төлөө үхсэн. Тирионыг мансууран нойрсож байх зуур өөрийн цусны хүмүүс сарвууг нь нэг нэгээр сугалжээ.

- Би чамайг эгч рүү минь очихыг хүсч байна. Түүний үнэт хүү тулааны үеэр ганц ч шалбархайгүй үлдсэн болохоор Серсейд барьцааны хүн хэрэггүй. Тэр Алаяаяаг даруй суллахыг амласан...

- Тэр тэгсэн. Найм юм уу есөн өдрийн өмнө ташуурдсаныхаа дараахан гэхэд Тирион мөр лүү нь огцом хатган өвдөхийг үл тоон өндөлзлөө.

- Ташуурдсан гэнэ ээ?

- Тэд түүнийг хашааны багананд хүлж ташуурдаад хаалгаар нүцгэн цус шүүрсэн түлхэн гаргасан.

Тэр уншиж сурч байсан юмсан гэсэн утгагүй бодол Тирионд төрөв. Царайных нь сорви таталдахад толгойд нь хоромхон зуур уур дүрсхийлээ. Алаяаяа янхан нь үнэн хэдий ч түүний ховорхон учирч байсан хайр татам, зоригтой, гэм зэмгүй охин байлаа. Тирион түүнд хэзээ ч хүрч байсангүй. Тэр Шэйг халхалсан гивлүүр төдий байсан юм. Тирионы хайнга зангаас болж түүний тоглосон дүр ямар үнэд хүргэх тухай ер эрэгцүүлсэнгүй.

- Би эгчдээ Алаяаяатай яаж харьцана Томментой тэгж харьцана гэж анхааруулсан юмсан гээд энэ тухай санахаас Тирионы дотор муухайрав. - Би яаж найман настай хүүхдийг ташуурдах болж байна? *Гэвч ингэхгүй бол Серсей ялна.*

- Чамд Томмен байхгүй. Хатан Төмөр гартын үхсэнийг мэдмэгц Кетлблакийнхныг хүүгийнхээ араас илгээн Росбигийнхоос хэнийг нь ч найранд оролцуулаагүй гэж Бронн шулуун хэлэв.

Ахин нэг цохилт хэдий ч Тирионы санаа амарлаа. Тэр Томменд хайртай билээ.

- Кетлблакийнхан манай тал байсан юмсан гэж Броннд уцаарлан сануулав.

- Хатнаас олж ирсэн мэдээ бүрийн төлөө намайг тэдэнд чиний хоёр зоосыг төлж байх хүртэл тийм байсан ч одоо Серсей дэнчингээ өсгөсөн. Осни, Осфрид хоёр тулалдааны дараа надтай адилхан хүлэг баатар болсон. Гэвч тэднийг ямар ч тулалдаанд оролцоогүйг бурхад мэдэх бизээ.

Миний хөлсөлсөн хүмүүс надаас урваж, анд нөхөд маань ташуурдуулж доромжлогдон, өөрөө энд ялзран хэвтэж байна. Би хараал идсэн тулаанд ялсан гэж бодсон юмсан. Энэ ялалтын амт гэж үү? хэмээн Тирион бодлоо.

- Станнис Рэнлигийн сүнсэнд бут ниргүүлсэн гэж үнэн үү? гэхэд Бронн мушилзан инээмсэглэв.

- Хүрдэт цамхагаас бидний харсан зүйл гэвэл шавар дунд дэрвэх далбаа, шидсэн жаданд зугатахдаа оногдож буй хүмүүс байсан ч хэдэн зуун халуун тогоо, янхны газруудад лорд Рэнли хэрхэн тэднийг нэг нэгээр нь алсныг харсан тухай ярьцгааж байгаа. Станнисийн ихэнхи цэрэг эхнээсээ Рэнлигийнх байсан болохоор тэд гялалзсан ногоон хуяг дуулга хараад гэдрэг буцаж орсон.

Түүний бүхий л төлөвлөгөө, цэрэг тэргүүлэн хөлөг онгоцны гүүр дамжин, нүүрээ дундуур нь цавчуулсны эцэст Тирион эрх мэдлээ үхсэн хүнд алджээ. *Хэрвээ Рэнли үнэхээр үхсэн бол.* Түүнд тодруулах зүйл байлаа.

- Станнис яаж зугтсан юм?

- Түүний Лайсени сэлүүрт онгоцоо тохойн гадна гинжний чинь цаана байлгаж байсан. Тулаан муугаар эргэх үед тэд булангийн эрэг рүү дөхөн ирж аль болох олон тооны хүн авсан. Хүмүүс тавцан дээр гарахын тулд нэг нэгнээ алж байлаа.

- Робб Старкийн тухайд юу болж байна?

- Түүний чононуудын нэг хэсэг Даскендэйл хүртэлх замын дагуу шатаасан. Эцэг чинь лорд Тарлиг үүний учрыг олохоор явуулсан. Би түүнтэй нэгддэг юм уу гэж бодож байлаа. Тэр сайн цэрэгт гар татахгүй өгөөмөр олз омог өгдөг гэсэн.

Бронныг алдах тухай бодол Тирионы эцсийн сүрэл байлаа.

- Үгүй. Чиний байр бол энд. Чи Гарын харуулын ахмад гэхэд,

- Чи одоо Гар биш болсон. Эцэгт чинь өөрийн гэсэн харуул бий хэмээн Бронн хурцаар сануулав.

- Чиний надад хөлсөлж өгсөн хүмүүс юу болсон бэ?

- Зарим нь хүрдэт цамхагт үхсэн. Харин авга ах сэр Кеван чинь үлдсэн хүмүүст хөлс төлөн биднээс холдуулсан.

- Түүний хувьд ямар сайн хэрэг вэ. Энэ тэгвэл чи алтны амтыг мартсан гэсэн үг үү? гэж Тирион

гашуунаар хэлэв.

- Огтхон ч үгүй.

- Сайн байна. Учир нь энэ тохиолдолд чи надад хэрэгтэй хэвээр байна. Чи сэр Мандон Моорын тухай юу мэдэх вэ?

- Живж үхсэнийг нь мэдэх юм байна гээд Бронн инээлээ.

- Би түүнд гүнээ өртэй гэвч үүнийгээ яаж төлөх билээ? Үнэнийг хэлэхэд би түүний тухай өчүүхэн мэднэ гээд Тирион нүүрнийхээ сорвийг тэмтэрлээ.

- Тэр загас шиг нүдтэй цагаан нөмрөг нөмөрсөн. Чамд өөр юу мэдэх хэрэг байгаа юм?

- Эхнээс нь авахуулаад бүгдийг гээд Тирионд сэр Мандон Серсейгийн хүн байсан гэдэг баталгаа хэрэгтэй байсан ч чанга хэлж зүрхэлсэнгүй. Улаан шилтгээнд хүн хэлээ хазаж байсан нь дээр. Эндхийн хананд харх, хэтэрхий их зүйл ярьдаг жижигхэн шувуудын зэрэгцээ аалз бий.

- Намайг босоход туслаач. Миний өнгөрсөн удаа уулзсанаас хойш эцэгтээ өөрийгөө харуулах цаг болж гээд тэр унтлагын хувцастайгаа өндийлөө.

- Үзүүштэй зүйл байна гэж Бронн шоолов.

- Хамар нь хагас ч гэсэн царай нь минийх байгаа биз дээ? Ингэхэд үзүүштэй зүйл гэснээс Хааны газар Маржэйри Тайрелл байгаа юу?

- Үгүй. Гэсэн ч ирж байгаа гэж бодож байна. Хот галзууртлаа түүнд дурласан. Тайреллийнхан түүний нэрийн өмнөөс Хайгарденаас хөсөг тэрэг дүүрэн хүнс авчиран тараасан. Өдөр бүр хэдэн зуугаараа ирж байгаа. Энгэртээ жижигхэн алтан сарнай хатгамласан мянгаад Тайреллийн хүмүүсээс хэн ч дарс худалдан авахгүй даналзаж байгаа. Эхнэр, бэлэвсэн авгай, янхан гээд бүхий л эмс хүүхнүүд энгэртээ алтан сарнайтай шингэн сахалтай хүү бүрт ач санан хамаг юмаа зориулж байгаа.

Тэд намайг нулимж Тайреллийнханд уух юм авч өгч байна. Тирион орноос гулган буухад хөл нь гуйван өрөө эргэлдсэнд шалан дээр унахгүйн тулд Бронны гараас шүүрэн авлаа.

- Под! Подрик Пэйн! Долоон там минь гэж чи хаана байна? гэж хашгирахад өвчин түүнийг шүдгүй нохой адил хэмлэв. Тирион сул дорой ялангуяа өөрийнхөө сул дорой байхыг үзэн ядаж байв. Энэ нь түүнийг ичээж, ичгүүр уурыг нь хүргэнэ.

- Под даруй энд ир!

Хүү гүйж ирлээ. Тэр Бронны гараас зууран зогсч байгаа Тирионыг хармагц гөлрөн ширтэв.

- Эрхэм лорд. Та зогсож байна. Энэ таньд... дарс хэрэгтэй юу? Нойрсуулагч дарс уу? Би мэйстер лүү гүйх үү? Тэр таныг үлдэх ёстой гэсэн. Орондоо гэх гэсэн юм л даа.

- Би дэндүү удаан орондоо хэвтлээ. Надад цэвэрхэн өмсгөл аваад ир.

- Өмсгөл гэнэ ээ?

Яаж тулааны талбарт ийм сэргэлэн овсгоотой байсан хүү бусад үед мунхаг болдогийг Тирион ухаарч чадсангүй.

- Хувцас хунар. Цамц, хантааз, өмд, оймс. Надад авчираад хувцасла. Тэгж байж би энэ хараал идсэн өрөөнөөс гарна.

Түүнийг хувцаслахад гурвуулангийн оролцоо шаардагдав. Царай нь хичнээн муухай байлаа гээд суганд нь сум зоогдсон газар болох мөрнийх нь гартай уулзсан мөчний шарх хамаагүй дор байлаа. Мэйстер Френкэний боолтыг нь сольсон биений өнгөгүй хэсгээс идээ цус бээр цувж хөдлөн тоолон хатгуулан өвдөнө.

Эцэст нь Тирион өмдөө өмсөөд томдсон нөмрөг мөрөндөө унжуулав. Бронн гутлыг нь хөлд углах зуур Под тулах таяг хайн явлаа. Тирион тэнхээ орохын тулд аяга дарс балгав. Дарсыг балаар амталж шархны өвчнийг тэсч болохуйц намуу цэцэг хандалжээ.

Гэсэн ч үүд рүү эргэхэд толгой нь эргэж эргүүлгэн чулуун шатаар доош буухад хөл нь чичигнэв. Тирион нэг гартаа таяг тулан нөгөө гараараа Подын мөрнөөс түшлээ. Замд нь урдаас өгсөж буй зарц охин тааралдахад хий үзэгдэл харсан аятай том цагаан нүдээр ширтэв. *Одой үхлээс босон иржээ. Түүний урьдынхаас улам муухай болсныг хараач явж найз нөхөддөө хэл* гэж Тирион бодов.

Мэйгорын бэхлэлт Улаан шилтгээний хамгийн хүчирхэг газар цайзын доторх цайз тул хурц гадас ***** хуурай гүнзгий шуудуугаар хүрээлүүлжээ. Тэднийг хаалганд хүрэх үед буулгадаг гүүр шөнө өргөөстэй байлаа. Сэр Мерин Трант гүүрний өмнө талд цайвар ялтсан хуяг дээр цагаан нөмрөгтэй зогсож байв.

- Гүүрийг буулга гэж Тирион түүнд тушаалаа.

- Хатан хааны тушаалаар гүүрийг шөнө өргөсөн гээд сэр Мерин үргэлж Серсейгийн гарын амьтан байв.

- Хатан унтаж байгаа харин надад аавтайгаа уулзах чухал хэрэг байна.

Лорд Тайвин Ланнистерийн нэрийг дурьдахад илбийн юм шиг нөлөөлөв. Сэр Мерин Трант хуухитнан тушаал өгөхөд гүүр доош буув. Шуудууны цаана хааны хамгаалалтын хоёр дахь хүлэг баатар зогсч байлаа. Сэр Осмунд Кетлблэк Тирионыг хазганан ирэхийг хармагц сулхан инээмсэглэв.

- Бие чинь дээрдэж байна уу, эрхэм лорд?

- Маш их. Дараагийн тулаан хэзээ болох билээ? Тэсэн ядан хүлээх байна.

Под тэр хоёр эргүүлгэн шатанд хүрэхэд Тирион хирдхийн шат руу ширтэв. *Би ийшээ хэзээ ч өөрөө авчирч чадахгүй* гэж өөртөө хүлээв. Иймээс ихэмсэг зангаа залгин Бронноос түүнийг өргөн гаргахыг гуйж энэ шөнийн цагт замд нь хэн ч тааралдан инээмсэглэж одой шатны өөд хүүхэд шиг тэврүүлэн явсан түүх тараахгүй байгаасай гэж найдав.

Гадна талын хашаа майхан асар бүхий дүүрэн хүнтэй байлаа.

- Тайреллийн хүмүүс гэж Подрик Пэйн тэднийг торго, зотон даавуун төөрдөг байшин дундуур гарахад тайлбарлав.

- Лорд Рован болон лорд Рэйдвайныхан ч гэсэн байгаа. Бүгдэд өрөө хангалттай хүрэлцээгүй. Шилтгээнд гэх гэсэн юм л даа. Зарим нь өрөөнд орсон. Хотод өрөө авч дэн буудалд гээд л. Тэд хуриманд оролцохоор ирцгээсэн юм. Жоффри хааны хуримд. Ингэхэд таньд түүнд оролцох хүч байгаа болов уу, эрхэм лорд?

- Шунахай үенгүүд намайг холдуулж чадахгүй гээд энэ нь тулааны дараа хамраа огтлуулсан хүний тухай ярьж байснаас хуримын тухай ярих нь хамаагүй дээр байлаа.

Гарын цамхагын цонхны хаалтны цаана бүдэг гэрэл сүүмэлзэнэ. Хаалган дээр эцгийнх нь овгийн улаан хүрэн нөмрөг, арслангын сүлдтэй дуулгатай хүмүүс зогсож байв. Тирион тэднийг хоёуланг таних тул барааг нь хармагц царай нь руу нь удаан харж чадахгүй байгааг ажиглалаа.

Тэднийг ороход эргүүлгэн шатаар угалзтай хар цээж хуяг, Хотын харуулын албаны даргын алтан нөмрөгтэй сэр Аддам Марбранд бууж ирэв.

- Эрхэм лорд таныг хөл дээрээ боссоныг харахад сайхан байна. Би сонсохдоо...

- ...бяцхан булш ухаж байгаа тухай цуу яриа юу? Би ч гэсэн сонссон. Ийм нөхцөлд боссон нь дээр байдаг юм. Ингэхэд би чамайг Хотын харуулын захирагч болсон тухай сонслоо. Чамд баяр хүргэх үү эсвэл эмгэнэл илэрхийлэх үү?

- Хоёуланг нь гэж айж байна гээд сэр Аддам инээвхийлэв. - Үхэл оргон зайлалт надад дөрвөн зуун дөчин дөрвөн хүн үлдээсэн. Чигчий хуруу тэдний хөлсийг яаж төлж байсныг зөвхөн бурхад мэдэх байх даа. Тэгтэл эгч чинь намайг хүн халахыг хориглосон байдаг.

Сэтгэл чинь зовсон хэвээр байна уу, Серсей? Тулаан дууссан алтан нөмрөгтөнгүүд чамд одоо туслахгүй.

- Чи миний эцэг дээрээс ирэв үү?

- Тийм. Түүнийг сайхан ааштай орхисон гэж хэлж чадахгүй нь дээ. Лорд Тайвин дөрвөн зуун дөчин харуулын хүн ганц алга болсон хиаг олоход хүрэлцээтэй гэж үзэж байгаа ч одоо хэр нь танай үеэл Тайрек олдсонгүй.

Тайрек бол Тайвины талийгаач авга Тайгеттийн арван гурван настай хүү байв. Тэр хатагтай Эрмесандатай гэрлэснийхээ дараа олны самууны үеэр алга болж хөхүүл хүүхдийг Хайфордын

овгийн ганц удам залгамжлагч болгон үлдээжээ. *Долоон ханлигийн түүхэнд эхийн сүүнээсээ гараагүй бэлэвсэрсэн анхны сүйт бүсгүй болох байх даа.*

- Би ч гэсэн түүнийг олж чадаагүй гэж Тирион хүлээв.

- Тэр өт хорхой тэжээж байгаа. Төмөр гарт түүнийг хайж, тайган тарган хэтэвчээ шаржигнуулсан ч тэдний хэнд ч биднийхээс илүү аз тохиолдоогүй гэж Брон ердийнхөө түс тас өнгөөр хэлэв.

Сэр Аддам хөлсний цэрэг рүү зэвүүцэн харлаа.

- Лорд Тайвин мах цусныхаа хүнд санаа тавих зөрүүд хүн. Тэр амьд үхсэний алинд ч залууг олох болохоор би түүнд зүтгэх үүрэгтэй гээд Тирион руу харцаа шилжүүлж,

- Эцэг чинь өөрийнхөө өрөөнд байгаа гэв.

Миний өрөө гэж Тирион бодлоо.

- Би тийшээ хүрэх замыг мэднэ.

Подын мөрөн дээр гараа тавин энэ удаад өөрийн хүчээр дээшээ гишгүүр өгсөхөд Бронн түүнд хаалга онгойлгож өгөв. Лорд Тайвин Ланнистер цонхны доор суугаад тосон дэнгийн бүдэг гэрэлд юм бичиж байлаа. Тэр оньс дуугарах чимээгээр харцаа өргөн харснаа,

- Тирион гээд үзгээ тайвнаар хойш тавилаа.

- Таныг намайг санаж байгаад баяртай байна, эрхэм лорд гээд Тирион Подын түшилтээс гараа султган биеийн жингээ таяг руу шилжүүлж хазганан ойртсон даруй *ямар нэг зүйл биш байна* гэж мэдэв.

- Сэр Бронн, Подрик. Магадгүй та нар биднийг дуустал гадна хүлээж байсан нь дээр байх гэж лорд Тайвин хэлэв.

Бронн Гарын зүг үл ойшоосон өнгөөр бөхийн ёслоод гарахад Под дагалдав. Тэдний ард хүнд хаалга хаагдахад Тирион Ланнистер эцгийнхээ хамт ганцаар хоцорлоо. Шөнийн салхинаас өрөөний цонхыг хаасан ч зэвэргэн байв. *Ямар гээчийн худал үг Серсей түүнд хэлсэн юм болдоо?*

Кастерли Рокийн лорд туранхай шөрмөслөг хорин насаар залуу төрхтэй хахир зантайн дээр царайлаг байлаа. Цайвар шигүү сахал хацрыг нь бүрхэж ширүүн царайг хүрээлэн халзан толгой, чанга амыг нь тодруулна. Тэр хүзүүндээ хуруу тус бүр нь нэг нэгнийгээ атгасан алтан зангидсан гартай гинж зүүжээ.

- Сайхан гинж байна гэж Тирион өгүүлэв. *Надад илүү дээр харагдах байсан даа.*

Лорд Тайвин гашуун егөөг үл тоомсорлов.

- Чи суусан чинь дээр байх. Унтлагын ороо орхих чинь тэгээд ухаалаг хэрэг гэж үү?

Тирион эцгийнхээ сул дорой хүнийг хичнээн үзэн яддагыг мэдэх тул,

- Би хэвтрийн дэглэмд байсаар залхаж гүйцлээ гээд ойролцоо сандал дээр суув.

- Хичнээн таатай өрөө вэ. Та намайг үхсэн гэж бодоод Мэйгорын харанхуй жижигхэн өрөө рүү зөө гэж хэлээ юу?

- Улаан шилтгээн хуримын зочдын хөлд дарагдаад байна. Тэднийг явмагц бид чамд даруй илүү тохирох өрөө хайж олох болно.

- Би тэр сууцандаа идээшчихсэн. Тэгэхээр та энэхүү агуу хуримын өдрийг товлосон юм биз дээ?

- Жоффри, Маржэйри хоёр шинэ жилийн анхны өдөр гэрлэх болохоор шинэ зууны анхны өдөр тохиож байгаа юм. Хуримын ёслол үүрийн шинэ эриний зарч болно.

Ланнистерийн шинэ эрин гэж Тирион бодлогоширов.

- Өө, тэр өдөр надад өөр төлөвлөгөө байгаа гэж сэтгэл маань зовж байгаа юмсан.

- Чи энд унтлагын өрөөнийхөө тухай гомдол мэдүүлж тааруухан хошигнол хийх гэж ирээ юу? Надад дуусгах чухал захиа байна.

- Чухал захиа гэнэ ээ? Тэгэлгүй яахав.

- Зарим тулааныг илд, жадаар ялдаг байхад заримыг нь үзэг, хэрээгээр ялдаг юм. Намайг даруухан зэмлэх хэрэггүй, Тирион. Чамайг үхсэн юм шиг хэвтэж байхад би унтлагын өрөөнд чинь мэйстер Баллабарын зөвшөөрлөөр очиж байсан гээд хуруугаа зөрүүлэн эрүүн дороо тулж,

- Чи яагаад Баллабарыг явуулсан юм? гэв.

- Мэйстер Френкэн намайг ухаангүй байлгахад дэндүү их санаа тавьсан гээд Тирион мөрөө хавчлаа.

- Баллабар лорд Рэдвайны бараа бологчоор хотод ирсэн. Маш авъяаслаг домч гэлцдэг. Серсей сайхан сэтгэлийн үүднээс түүнээс чамайг асрахыг гуйсан. Тэр чиний амины төлөө тун их айсан.

Намайг амьд гарахаас эмээсэн гэж та хэлэх гээ юу.

- Тэгвэл түүний миний орны дэргэдээс ер холдоогүйн учир энэ байх нь дээ.

- Бүдүүлэг аашлах хэрэггүй. Серсей хааны хуримын талаар хөөцөлдөж, би дайн хийж байхад, чи хоёр долоо хоногийн турш аюул дээр дэнжигнэж байсан гээд лорд Тайвин хүүгийнхээ төрх алдсан царай руу цайвар ногоон нүдээрээ цавчилгүй ширтэж,

- Шарх чинь эвгүй эдгэж. Ямар галзуурал нь чамайг тийм зүйл рүү хөтлөө вэ? гэлээ.

- Дайсан хотын хаалгыг мөргүүрээр нүдэж байсан. Хэрвээ Жэйми цэргээ тэргүүлсэн бол та үүнийг эр зориг гэж дуудах байсан даа.

- Жэйми хэзээ ч тулааны үеэр дуулгаа тайлах тэнэг хүн биш. Чамайг цавчсан хүнийг алсан гэдэгт чинь итгэж болох уу?

- Өө, өөдгүй новш хангалттай үхсэн. Үхсэн дайсан үүрдийн баяр хөөр гэдэг байхаа гэж Тирион хэлсэн ч Подрик Пэйн сэр Мандоныг гол руу түлхэхэд хуяг дуулганыхаа жинд татагдан живэн үхсэн билээ. Тэрбээр сэр Мандон жинхэнэ дайсан байсан гэдэгт итгэсэнгүй. Тэр хүнд түүний үхлийг хүсэх шалтгаан байхгүй. *Тэр зөвхөн муурын сарвуу байсан ч би муурыг нь хэн болохыг мэдэж байна. Тэр түүнд намайг тулааны үеэр амьд үлдэх ёсгүй гэж хэлсэн байж таарна.* Гэвч лорд Тайвин ямар ч баталгаагүй ийм зүйлийг сонсох хүн биш байлаа.

- Ингэхэд та яагаад хотод ирсэн юм бэ, аав аа? Лорд Станнис юм уу Робб Старк эсвэл өөр хүнтэй байлдахгүй юм уу? *Аль болох хурдан тусмаа сайн.*

- Лорд Рэдвайн флотоо авчирах хүртэл бид Лууны цохио руу дайралт хийх онгоцоор дутна. Гэвч энэ хамаагүй. Станнис Баратеоны нар Хар усанд жаргасан. Старкийн хүүгийн хувьд өрнө зүгт байгаа хэвээр ч Хелман Толхарт болон Робетт Гловер нараар удирдуулсан умардын томоохон хүч Даскендэйлын зүг уруудаж байгаа. Би лорд Тарлиг тэднийг угтан байлдаж сэр Грегор ухрах замыг нь хаахаар Хааны зам руу илгээсэн. Старкийн гурав дахь хүч болох Толхарт, Гловер хоёр тэдний дунд орж хавчигдана.

- Даскендэйл гэнэ ээ?

Даскендэйлд ийм эрсдэлийн үнэ хүрэх зүйл юу ч байхгүй. Залуу чоно эцэстээ бүдэрлээ гэж үү?

- Чамд үүний төлөө төвөг удах ямар ч хэрэг байхгүй. Царай чинь үхлийн цонхигор, хувцасны чинь завсар цус нэвчиж байна. Ямар зүйл хүссэнээ хэлээд ор луугаа буц.

- Миний хүссэн зүйл гэвэл... гээд Тирионы хоолой бачуурлаа. Ингэхэд тэр юу хүсээ вэ? *Таны надад өгч чадахаас ч илүү зүйлийг, аав аа.* Под надад Чигчий хурууг Харренхалын эзэн болсон гэж хэлсэн.

- Рус Болтон Робб Старкийн нэрийн өмнөөс шилтгээнийг барьж байгаа болохоор хоосон хэргэм. Гэсэн ч лорд Бэйлишийг шагнах ёстой байсан. Тэр Тайреллийн гэрлэлтэнд сайн зүтгэсэн. Ланнистерийнхан түүний өрийг төлсөн.

Тайреллийн гэрлэлт Тирионы бодол байсан ч одоо түүнийгээ тунхаглах бүдүүлэг бодол мэт санагдав.

- Хэргэм таны бодож байгаа шиг хоосон биш шүү. Чигчий хуруу ямар ч ашиггүйгээр юм хийхгүй. Гэхдээ байж болох л юм. Ингэхэд та өрөө төлөх тухай ямар нэг зүйл хэлсэн үү?

- Чи өөрийнхөө гавъяаг нэхэн шагнуулахыг хүсч байгаа биз дээ? Маш сайн байна. Надаас юу

хүсмээр байна? Газар, шилтгээн, ямар нэг албан тушаал уу?

- Эхлэл нь сайхан ч өчүүхэн талархал байна гэхэд лорд Тайвин урдаас нь цавчилгүй ширтэв.

- Хэрмэл жүжигчид болон сармагчин л алга ташилт хүртдэг юм. Чамайг удирдахдаа хамаг авъяасаа гаргасан гэдэгт чинь итгэлтэй байна. Хэн ч чиний тоглосон хэсгийг үгүйсгэхгүй.

- Миний тоглосон хэсэг юм биз дээ? Би хараал идсэн хотыг чинь аварсан санагдаж байна гээд Тирионы хамрын үзүүр сартайлаа.

- Хүмүүсийн ихэнхи миний лорд Станнисийн жигүүр лүү дайрсан дайралт тулааныг явцыг эргүүлсэн гэдэгт итгэж байгаа. Тайрелл, Рован, Рэйдвайн, Тарлигийн лордууд ч гэсэн сайн тулалдаж эгч Серсей чинь пиромансеруудаар Баратеоны флотыг устгасан зэрлэг галыг хийлгэсэн.

- Тэгвэл миний хийсэн бүх зүйл хамрынхаа үсийг тэгшлүүлсэн явдал юм биз дээ? гээд Тирион хоолой дахь гашуун өнгөө нууж чадсангүй.

- Чиний гинж ухаалаг цохилт болж бидний ялалтанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Энэ чиний сонсохыг хүссэн зүйл биз дээ? Бид бас чамд Дорнишийнхныг холбоотноор элсүүлсэнд талархал илэрхийлэх ёстой. Мирцелла Наран жаданд аюулгүй хүрснийг сонсоод сэтгэл чинь амрах байх. Сэр Арис Окхарт түүнийг гүнж Ариннатай сайн, ханхүү Тристэйн их хайртай гэж бичсэн байсан. Би Мартеллийн гэр бүлд барьцааны хүн өгөх дургүй байгаа ч энэ тус болохгүй.

- Бидэнд өөрийн барьцааны хүн бий шүү дээ. Зөвлөлийн суудал бас наймааны хэлэлцээнд багтсан. Доран ханхүү суудлаа элэхдээ бидэнд хүч үзүүлэхийн тулд армиа авчирна.

- Зөвлөлийн суудалд суухад бүх Мартеллийнхан ирнэ. Чи түүнд өшөөгөө бас авахыг амалсан байсан.

- Би түүнд шударга ёсыг амласан.

- Юу хүссэнээрээ хэл. Гэсэн ч цусыг цусаар хэвээр.

- Тийм ч богино шаардлага биш байгаа биз дээ? Би тулааны үеэр нуурын ус цалгилуулсан. Эсвэл та Грегор Клегэйнд түүнгүйгээр байж чадахааргүй хайртай болчихоо юу? гээд Тирион зүрх зүсэгдэх ямар ч шалтгаан олж харсангүй.

- Сэр Грегор дүүгийнхээ адил өөрийнхөө хэргийг гүйцэтгэсэн. Лорд болгонд цаг үеийн өөрийн гэсэн араатан хэрэгтэй байдаг юм... үүнийг чи сэр Бронн болон уулын хүмүүсээсээ суралцсан байх.

Тирион Тиметтийн түлэгдсэн нүд, Шаггагын сүх, Шейлагын хүзүүндээ хэлхэн зүүсэн хатаасан чихийг саналаа. Дээр нь Бронн. Бронн бүгдээс илүүтэй байв.

- Ой мод араатнаар дүүрэн. Явган зам ч гэсэн адил гэж эцэгтээ санууллаа.

- Энэ үнэн. Магадгүй өөр ноход ч гэсэн агнаж байж болно. Би энэ тухай бодож үзнэ. Хэрвээ чамд өөр зүйл байхгүй бол...

- Таньд чухал захиа байгаа, тийм гээд Тирион тэнцвэргүйхэн хөл дээрээ босоход агшин зуур толгой эргэсэнд нүдээ анин хаалганы зүг гуйван хөл тавив. Тэгснээ хоёр гурав дахь алхам хийхийнхээ урд эргэлээ.

- Намайг юу хүсч байна гэж та асуусан билүү? Би таньд юу хүсч байгаагаа хэлье. Би өөрийн эрхийнхээ дагуу зүйлийг хүсч байна. Би Кастерли Рокийг хүсч байна.

- Чи ахын эрхийн үү? гээд эцгийнх нь ам чангарлаа

- Хааны хамгаалалтын хүлэг баатар гэрлэж, үр хүүхэдтэй болж, газар нутаг эзэмших хориотойг надаас дутахгүй та сайн мэдэж байгаа. Жэйми цагаан нөмрөг нөмөрсөн өдөр Кастерли Рокийн эрхээсээ татгалзахад хэзээ ч та хүлээн зөвшөөрөөгүй. Гэвч энэ өнгөрсөн явдал. Би таныг хаант улсын өмнө зогсоод намайг таны хүү хууль ёсны өв залгамжлагч чинь гэдгийг зарлахыг хүсч байна.

Лорд Тайвины цайвар ногоон ногоон нүдэнд өршөөлгүй тод алтан оч гялсхийн үхлийн хүйтэн хатуу өнгөөр,

- Кастерли Рокийг чамд хэзээ ч өгөхгүй гэж хэлэхэд хортой хурц үг тэдний дунд агаарт тогтлоо.

Би асуухаасаа өмнө хариултыг нь мэдэх ёстой байсан юм. Арван найман жилийн өмнө Жэйми хааны харуулд нэгдсэнээс хойш би хэзээ ч энэ асуудлыг сөхөөгүй. Би мэдэх ёстой байж. Би үргэлж мэдэх ёстой байж гэж Тирион бодов.

- Яагаад? гэж тэр асуусан хойноо хэлсэн үгэндээ харамслаа.

- Чи үүнийг бас асууна гэнэ ээ? Чи орчлонд ирэхдээ эхийгээ алсан биз дээ? Чи бол муу ёрын, дуулгаваргүй хорон муу санаагаар дүүрэн өчүүхэн зальтай жижигхэн зэвүүн амьтан. Хүний хууль чамд миний нэрийг зүүж өнгийг маань авах эрх олгосон ч чамайг миний хүүхэд гэдгийг би батлахгүй. Надад даруу зан заахын тулд бурхад эцэг өвөг дээдсийн маань сүлд болох арсланг зүүн хазганахыг чинь харах шийтгэл оноосон. Гэвч бурхад хүмүүсийн алин ч надад чамайг Кастерли Рокийг янхны газраа болгохыг зөвшөөрөхийг албадаж чадахгүй.

- Янхны газар гэнэ ээ? гээд Тирион үүр цайхад цохилт хаанаас ирснийг ойлголоо. Тэр шүдээ зууж,

- Серсей таньд Алаяаяагийн тухай хэлээ юу? гэв.

- Түүнийг тэгж нэрлэдэг хэрэг үү? Үнэнийг хэлэхэд би чиний бүх янхны нэрийг санахгүй байна. Чиний хүүхэд байхдаа гэрлэж байсныг хэн гэдэг билээ?

- Тайша гэж Тирион шазруур зуун хэллээ.

- Тэгвэл Ногоон салааны буудал дагагчийг чинь юу гэдэг юм?

- Таньд ямар хамаатай юм бэ? гээд тэр Шэйгийн нэрийг дурьдахыг хүссэнгүй.
- Надад хамаагүй. Тэдний амьд үхсэн эсэх ер хамаагүй.
- Ийм учраас та Алаяаяаг ташуурдсан хэрэг байх нь ээ гээд энэ асуулт байсангүй.
- Эгч чинь надад зээгийн минь эсрэг сүрдүүлгийг хэлсэн. Эсвэл түүний үг худал уу? гээд лорд Тайвины хоолой мөс шиг хүйтэн боллоо.
- Би сүрдүүлсэн. Алаяаяаг аюулгүй байлгахын тулд, Кетлблакийнхныг түүнд гар хүргэхгүйн тулд гээд Тирион үүнийг үгүйсгэсэнгүй.
- Янхны сайн сайхны төлөө өөринхөө зээг сүрдүүлнэ гэнэ ээ? Тэгэхээр энэ чиний арга юм биз дээ?
- Та урьд нь надад сайн сүрдүүлэг цохилтоос илүү үр дүнтэй гэж сургадаг байсан. Жоффри хэдэн зуун удаа уурыг маань хүргэсэн ч яагаа ч үгүй. Хэрвээ та хүмүүсийг ташуурдахад тэгтлээ санаа зовоод байгаа юм бол түүнээс эхэл. Гэвч Томмений хувьд гэвэл... би яагаад Томменд гэм учруулах ёстой гэж? Тэр өөрийн минь мах цусны сайн хүүхэд.
- Ээж шиг чинь гээд лорд Тайвин огцом өндийн одой хүүгийнхээ өмнө сүндэрлэн зогсов.
- Өрөө лүүгээ буц, Тирион. Цаашид Кастерли Рокийн эрхийнхээ тухай надад ярих хэрэггүй. Чи хичээл зүтгэлдээ тохирсон шагнал хүртэх болно. Дээрээс нь эндүүрэх хэрэггүй... энэ сүүлчийн удаа чиний Ланнистерийн гэр бүлийг шившиглэн намайг гутаасан явдал шүү. Чиний янхнуудтай орооцолдох дууссан. Дараагийн удаа би нэгийг нь чиний оронд байхыг олох юм бол дүүжлэнэ.

ДАВОС

Давос алсад удаанаар урган гарах онгоцны далбаа ширтэн амьд байх үхэх эсэхээ шийдэхийг оролдлоо.

Үхэх хялбар болохыг тэр мэдэж байв. Агуй руугаа мөлхөн орж онгоцыг дэргэдүүр өнгөрүүлэхэд хангалттай. Хэдэн өдрийн турш тасралтгүй халуурсан бие нь халуу шатан гэдсэнд нь хүрэн ус хүржигнэж дагжин чичирсэндээ унтаж чадахгүйд хүрнэ. Өдөр ирэх тусам бие нь улам сульдаж байлаа. *Энэ тийм ч удаан үргэлжлэхгүй* гэж тэр өөртөө хэлэв.

Хэрвээ халуун түүнийг алдаггүй юмаа гэхэд цангалт гарцаагүй алах байлаа. Түүнд чулууны хонхорхойд тогтсон борооны уснаас ондоо цэвэр ус байсангүй. Гурав билүү дөрвөн өдөр өнгөрөхөд (Хадан дээр газардсанаас хойш хэдэн өдөр өнгөрснийг мэдсэнгүй) хонхорхойн тогтоол ус өгөршсөн яс шиг хатаад тохойн эргэн тойрон хуйлран давалгаалах саарал ногоон давалгаа түүнийг бараг тэвчиж чадахгүйд хүргэв. Нэгэнтээ Давос түргэн мөхөл ирэхийг мэдэж байсан ч тэнгисийн ус залгилаад бараг эхний балгалттайгаа зэрэгцэн хоолой нь аргасан хэвээр байхыг мэдрэв. Гэнэтийн аадар орсон явдал түүнийг аварчээ. Тэр ядарч сульдсандаа бороонд нүдээ анин амаа ангайн хэвтэхэд ус омголтсон уруул, хөөж хавдсан хэл рүү нь үсчинэ. Дараа нь бие арай дээрдсэн ч арлын ангал цавд тогтсон усаар амьдрал нь хэмжигдэж байв.

Гэхдээ энэ нь гурав юм уу дөрвөн өдрийн өмнө болсон хэрэг бөгөөд усны ихэнхи одоо байхгүй болжээ. Нэг хэсэг нь ууршиж үлдсэнийг нь тэр шимсэн байна. Маргаашнаас ахин шавар амталж хонхорын ёроолын чийгтэй хүйтэн чулуу долооход хүрнэ.

Гэсэн ч цангалт, халууралт биш юмаа гэхэд өлсгөлөн түүнийг алах байв. Арал цэлийсэн Хар усан тохой дахь нүцгэн шовх чулуунаас өөрцгүй байв. Түрлэг намдахад түүний тулааны дараа эрэг дээр нь угаагдан гарсан чулуун зурвас дээр заримдаа бяцхан наймаалжнууд хаягдах бөгөөд чулуугаар бяц цохин хуяган доторх гэдэс дотор, сарвууны махыг сорохоос урьд хурууг нь өвдтөл хавчина.

Түүнчлэн чулуун зурвас түрлэг ихсэх үеэр далдарч Давос тохой руу усанд туугдан орохгүйн тулд хад руу мацахад хүрнэ. Хадны орой усны мандлаас тавин тохой цухуйсан ч тохойн урсгал ширүүн учир усан дусал өндөрт шүршигдэн агуйд хүртэл хуурай байхын аргагүй бөгөөд энэ нь доошоо өлийсөн чулууны доод талын хөндий нүхнээс өөрцгүй байлаа. Хадан дээр хагнаас өөр зүйл ургахгүй тэнгисийн шувууд хүртэл энэ газраас дайжина. Ойрноос хэдэн цахлай хадны оройд газардахад Давос нэгийг нь барьж авахыг оролдсон ч шувуу ойртохын аргагүй дэндүү хурдан байлаа. Тэр чулуу шүүрч шидсэн ч хүчтэй шидэхэд дэндүү сульдаж доройтсон тул оногдсон цахлай уурсан хашгирч агаарт хөөрнө.

Түүний хоргодсон газраас бусад хадны байдал үзэгдэхүйц зайтай зэргэлдээ орших шовх оргилууд түүнийхээс өндөр байв. Хамгийн ойрынх нь уснаас дээш дөчин фут цухуйсан бөгөөд алсаас тодорхой баримжаалан хэлэх арга байсангүй. Дээгүүр нь цахлайн сүрэг тогтмол эргэлдэхэд Давос үргэлж тэнд хүрч үүрнийх нь өндөг авах тухай бодно. Гэвч эндхийн ус хүйтэн урсгал нь ширүүн хүчтэй болохоор сэлэх хүч хүрэхгүйг мэдэж байлаа. Энэ нь түүнийг гарцаагүй тэнгисийн ус

залгилах адил хөнөөх болно.

Намрын уйтан тэнгис үргэлжид нойтон бороо шороотой байдгийг Давос олон жилийн өмнөөс сайн мэдэх билээ. Өдөр нь нар гарахад таатай хэдий ч шөнө хүйтэрч заримдаа салхи тохойн дагуу хүчтэй салхилахад ус цагаанаар хөөсрөн Давос норж даарсандаа чичирнэ. Халуун хүйтэн хоёр түүн рүү түүн рүү ээлжлэн довтолгосоор эцэст нь тасралтгүй ханиалгах болжээ.

Түүний хоргодох газрынх нь агуй дэндүү бяцхан байлаа. Түрлэг намдах үед усанд хөвж ирсэн шатсан гуалингийн хэмхэрхий зурвас дээр хаягдах хэдий ч гал түлэх юм уу оч ноцоох арга байсангүй. Нэг удаа цөхөрсөндөө хоёр модыг хооронд үрж гал гаргахыг оролдсон ч ялзарсан тул хүчин чармайлтын үр дүнд хуруугаа цэврүүтүүлжээ. Хувцас нь ч гэсэн шалба норж зурвас дээр угаагдан гарахын өмнө өрөөсөн гутал нь гээгдсэн байлаа.

Өлсгөлөн цангалт хоёр түүнийг өдөр шөнөгүй нэрвэн дагасаар хань нөхөд шигээ бодох болжээ. Удалгүй нөхдийнх нь бас нэг болох харуусал түүнийг эцэс төгсгөлгүй зовлонгоос нь чөлөөлөх болно. Эсвэл магадгүй тэр нэг л өдөр ус рүү алхан ороод эргээс холдон хойд зүгийн хаа нэгтээ сэлэх болно. Энэ нь түүн шиг сул дорой хүнд сэлэхэд хол байсан ч хамаа байсангүй. Давос үргэлж далайчин байсан болохоор тэнгистээ нойрсоно. *Усны ёроолд бурхад намайг хүлээж байгаа. Миний тэдэн рүү очих цаг болсон* гэж бодов.

Гэвч одоо тэнгэрийн хаяан дахь цэг шиг тодорсон далбаа улам томорч байлаа. *Байж боломгүй ч гэсэн хөлөг онгоц байна.* Тэр байгаа газар нь илүү ч үгүй дутуу ч үгүй Хар усан тохойноос цухуйсан цувраа хад болохыг мэдэж байв. Тэдний хамгийн өндөр нь уснаас дээш зуун фут цухуйсан бөгөөд арваад бага оргил гуч юм уу жаран футын өндөрт сүндэрлэнэ. Далайчид тэднийг лусын хааны жад гэж нэрлэх бөгөөд зөвхөн хугарсан ганц хэсэг усны мандалд цухуйж байхад олон арван шовх үзүүртэй хэсэг усан дор нуугдаж буйг мэддэг байв. Өөрийн гэсэн ухаантай ямар ч ахмад тэднээс зайлсхийн өнгөрөх дамжиггүй билээ.

Давос улаан эмжээртэй цайвар нүд бүхий далбааг харж салхинд зотон даавуу дэрвэх чимээ сонсохыг хичээлээ. *Тэр ийшээ ирж байна.* Үгүй бол удахгүй зүгээ удахгүй өөрчлөн хоргодож буй өчүүхэн газраас нь холуур зайтай өнгөрнө. Хэрвээ тэр үүнийг хүсч байвал энэ нь амьдрал байж болох байв. Гэвч тэр үүнийг хийхэд итгэл байсангүй.

Яагаад би амьдрах ёстой гэж? Бурхад минь яагаад? Миний хөвгүүд Дэйл, Аллард, Марик, Маттос үхэж магадгүй Деван ч гэсэн үрэгдсэн. Ямар эцэг ийм олон хүчтэй залуу хөвгүүдгүйгээр амьдарч чадна гэж? Би яаж ингэх болж байна? Би үхсэн наймаалж шиг хөндий хуяг болоод дотор маань юу ч үгүй хоосон. Тэд үүнийг мэдээгүй гэж үү? хэмээн нүдэнд нь нулимс бүрэлзэхэд бодов.

Тэд Оргилуун хар ус руу Гэрлийн эзний галт зүрхийг намируулан иржээ. Давос "Хар Бета"-тайгаа дайралтын хоёр дахь эгнээнд Дэйлийн "Сүнс", Аллардын "Хатагтай Мария" хоёрын дунд байлаа. Түүний гурав дахь хүү Марик тэргүүн шугамын төвд "Хилэн"-гийн сэлүүрийн даамал байж, хоёр дахь хүү Маттос нь эцэгтээ зүтгэж байв. Улаан шилтгээний хэрмийн дор Станнис Баратеоны сэлүүрт хөлөг онгоцууд хөвгүүн Жоффри хааны багахан флоттой тулгарахад хэдэн хормын дотор

голоор дүүрэн нумны хөвч исгэрч, төмөр мөргүүрүүд мөргөлдөн, сэлүүр онгоцны их бие ялгаагүй тасхийн хугарч байлаа.

Тэгтэл асар том араатан хүрхрэх лугаа адил чимээ гарахад тэдний тойронд пиромансерийн шээс, чөтгөрийн хаш ногоон дөл зэрлэг гал дүрэлзэв. Онгоц уснаас өцгөс хийн өндийхөд Маттос Давосын тохойны дэргэд "Хар Бета"-гийн тавцан дээр зогсож байжээ. Давос гол руу сарвалзан унахад урсгал түүнийг хаман авч эргэлдүүлэн хөвөв. Голын дээд хэсэгт тэнгэр лүү тавин футын өндөр гал дүрэлзэж байлаа. Тэр "Хар Бета", "Хилэн" болоод арваад онгоц галд автаж шатаж буй хүмүүс нь ус руу үсрэн живэхийг харлаа. "Сүнс", "Хатагтай Мария" хоёр хуйлран боссон зэрлэг галд живж хэмхэрсэн эсэхийн алин мэдэгдсэнгүйд Давос тэднийг хайх завдал болсонгүй голын аман дахь Ланнистерийнхны босгосон том төмөр гинж рүү туугдан ирэхэд голын нэг талын эргээс нөгөө талын эрэг хүртэл зэрлэг галд авалцан шатаж буй хөлөг онгоц битүү хахжээ. Үүнийг хараад зүрх нь зогсох шиг болоход дүрэлзсэн галын дөл, исгэрсэн утаа, үхэж буй хүмүүсийн хашгиралт дунд урсгал түүнийг нүүрний урдаас аймшигтай төөнөсөн халуун тамын зүг урсган аваачив.

Давост хийх зүйл байсангүй. Хэдэн хором өнгөрөхөд хөвгүүдтэйгээ нэгдэж тохойн хүйтэн ногоон шавартай ёроолд хэвтэн загас нүүрийг нь зулгаах болно.

Гэвч тэр оронд нь гүнзгий амьсгаа аваад усны ёроол руу тийрэн шумбаж татсан гинж, шатаж буй хөлөг онгоц, усны мандал дээр ноцож байгаа зэрлэг галын доогуур өнгөрөн цаана нь аюулгүй газар сэлж гарахыг боджээ. Давос үргэлж сайн сэлэгч байсан бөгөөд тэр өдөр хуяг өмсөлгүй, дуулгаа "Хар Бета" дээр гээжээ. Түүнийг булингартай ногоон ус руу шумбан ороход усан дор хуяг дуулганыхаа жинд татагдсан хүмүүс татвалзан живж байв. Давос тэдний дэргэдүүр өнгөрөөд усны ёроол руу хүчтэй тийрэн сэлэхэд нүдэнд нь ус дүүрэв. Тэр улам цааш гүн рүү явсаар байлаа. Цаашлах тоолон амьсгалаа барихад улам бэрхтэй болов. Нүдэнд нь зөөлөн шавартай ёроол бүрэлзэн харагдахад амнаас нь бөмбөлөг сахрав. Ямар нэг зүйл хөлд нь хүрэхэд ургамал, загас, живсэн хүний алин болохыг мэдсэнгүй.

Түүнд агаар хэрэгтэй байвч гинжийг өнгөрч тохойноос гарч чадсан эсэхдээ эргэлзэн айж байлаа. Хэрвээ живсэн онгоцны дор байгаад усны мандалд хөвөн зэрлэг галын дунд гарч ирвэл ганц амьсгаа авахад уушиг нь үнс болно. Дээшээ ус руу харахад бараатан ногоорохоос ондоо зүйл харагдсангүйд хэр хол доошоо явснаа мэдэхгүй сандралд орон гараараа усны ёроолыг самардан бужигнуулж шаварт нүд харанхуйлав. Цээж нь агшин зуур бачуурахад ус самардан дээшээ хөвөө уушиг нь агаар нэхэн багтарч булингартсан харанхуйд хамаг чадлаараа дээшлэн тийрч ам нээн хашгирахад ус садран орж ирэн давс амтагдсанд Давос Сиворт живж буйгаа мэдэрлээ.

Дараагийн агшинд мэдсэн зүйл гэвэл нар дээр хөөрч нүцгэн чулуун шовх оргилын доод талын хаялга дээр хэвтээд эргэн тойрон хоосон ус цэлийж дэргэд нь хугарсан шураг, түлэгдсэн далбаа, хөөсөн цогцос байлаа. Шураг, далбаа, цогцос гурав дараагийн түрлэгээр алга болоход Давос ганцаар лусны хааны жадан дунд хадан дээр үлдэв.

Тэр олон жилийн турш Хааны газрын усанд хийсэн хориотой наймааны туршлагаараа Хааны газрын эргэн тойрныг гарын арван хуруу шигээ мэдэх тул хоргодож буй газар нь газрын зураг дээр цэгээс илүүгүй далайчдын зүглэх бус жийрхэн өнгөрдөг газар болохыг таньжээ. Гэсэн ч түүнд

хориотой наймаа хийж байсан үедээ баригдахгүй өнгөрөхийн тулд ийшээ ганц хоёр ирсэн удаа бий. *Тэд хэзээ нэгэн цагт намайг энд үхсэн байхыг олвол энэ хадыг нэрээр минь нэрлэх биз. Сонгино хад гэж нэрлэн булшны чулуу болон өв хөрөнгө минь болно* гэж бодлоо. Тэр үүнийг хүртэх тавилантай. *Эцэг хүүхдүүдээ хамгаалдаг* гэж септон заадаг ч Давос хөвгүүдээ гал руу түлхжээ. Дэйл хэзээ ч эхнэр авч тэдний хүсч байсан шиг хүүхэдтэй болохгүй. Харин Аллард Хуучин хот, Хааны газар болон Бравост найз охидуудтай байсан болохоор тэд бүгд уйлцгаах болно. Маттос түүний мөрөөддөг байсан шиг өөрийн гэсэн онгоцны ахмад болохгүй. Марик хүлэг баатар болохгүй.

Тэднийг үхсэн байхад би яаж амьд гарч чадав аа? Надаас хамаагүй дээр хичнээн сурвалжит гаралтай зоригт хүлэг баатар, хүчирхэг лордууд үхсэн билээ. Агуй руугаа ор, Давос. Дотор нь орж атиралдаад хөлөг онгоцыг өнгөрүүлвэл хэн ч чамд ахин төвөг удахгүй. Чулуун жинтүүгээ дэрлэн нойрсож цахлай нүдийг чинь тоншин, наймаалж биен дээр чинь найрлаг. Чи тэднээр хангалттай найрласан болохоор өртэй. Нуугд, хориотой наймаачин минь. Чимээгүй нуугдаад үх.

Далбаа бараг түүнд тулан ирлээ. Хэдхэн хором өнгөрөхөд хөлөг онгоц аюулгүй өнгөрч тэр тайван үхэх болно.

Давос хоолой руугаа гараа явуулан хүзүүндээ үргэлж зүүдэг жижигхэн ширэн хүүдийгээ тэмтрэв. Дотор нь хүлэг баатар болсон өдөр нь хааны мухарласан дөрвөн хурууны өөдөс бий. *Миний азын сахиус*. Гэвч мухар хуруугаараа цээжээ тэмтрээд юу ч олсонгүй. Хүүдий байхгүй болоод хурууны яс түүний хамт үгүй болжээ. Станнис түүний яагаад хурууны өөдсөө хадгалдагын учрыг хэзээ ч ойлгож байсангүй. "Надад хааны засгийг сануулахын тулд" гэж омголтсон уруулаараа шивнэлээ. Гэвч одоо тэд үгүй болжээ. *Гал миний азыг хөвгүүдийн минь адил авчээ*. Тэр зүүдэндээ одоо хүртэл голын дээр гал дүрэлзэн усны мандалд галт ташууртай чөтгөр бүжиглэн хүмүүсийг тас нясхийлгэн шилбүүрдэж шатааж байсныг харсан хэвээр байлаа.

- Ээж минь өршөө. Зөөлөн сэтгэлт эх минь намайг өршөө. Бид бүгдийг өршөө. Миний аз хөвгүүдийн минь хамт байхгүй болж гэж залбираад асгаруулан уйлахад давстай нулимс хацрыг нь даган урсав. - Гал бүгдийг авсан... гал...

Магадгүй зөвхөн салхи чулуу руу салхилан тэнгис хад мөргөн давалгаалсан байж болох ч Давос Сиворт хариултаа олж сонслоо. Хясаан дотор бүгтхэн тэнгис шуугих адил зөөлөн гунигтай хоолой,

- Чи галыг дуудсан. Чи биднийг шатаасан... биднийг шатаасан... биднийггггггггггг шатаасанннннн гэж шивнэв.

- Энэ тэр байсан! Ээж минь биднийг битгий орхиоч. Тэр л таныг шатаасан. Улаан эмэгтэй Мелисандра! гэж Давос хашгираад түүний зүрхэн хэлбэртэй царай, улаан нүд, урт хүрэл гээг, явахад нь галын дөл шиг намирдаг улаан торгон даашинзыг саналаа. Мелисандра дорно зүг Ашайгаас Лууны цохионд ирээд Селисаг эрхэндээ оруулан хатны хүмүүсийг элсүүлэн Станнис Баратеон хааныг ч гэсэн бурхныхаа холбоотон болгожээ. Үүнээсээ улам цаашлан Гэрлийн эзэн,

Гал сүүдрийн бурхан Р'хлорын галт зүрхийг далбаа дээр нь мандуулсан байна. Чухам Мелисандрагийн шаардлагаар Станнис Долоо шүтээнийг Лууны цохионы сүмээс чирж гарган шилтгээний гадна хаалганы гадаа шатааж, Шуурганы адгийн бурхдын мод тэр дундаа ёсорхуу нүүртэй том цагаан далан мод зүрх модыг хүртэл шатаажээ.

- Энэ бол түүний ажил гэж Давос улам сул дуугарав. *Түүний дээрээс нь ч гэсэн чиний ажил, сонгино хүлэг баатар минь. Чи түүнийг харанхуй шөнөөр далдлан Шуурганы адаг руу сэлүүрдэн аваачиж сүүдэр хүүхдийг нь төрүүлсэн. Чи гэм зэмгүй биш, үгүй шүү. Чи түүний далбааг шургандаа мандуулан хөдөлсөн. Чи Лууны цохионд Долоо шүтээнийг шатахыг харсан ч юу ч хийгээгүй. Тэр Эцгийн шударга ёс, Эхийн өршөөл, Чавганцийн цэцэн цэцэн ухааныг галд өргөсөн. Дархан, Үл таних хүн, Охин, Дайчин гээд тэднийг бүгдийг хэригий бурхныхаа алдрын төлөө шатаахад чи хэлээ хазан зогсоод юу ч хэлээгүй. Хөгшин мэйстер Крессенийг хөнөөхөд хүртэл чи юу ч хийгээгүй.*

Түүнээс зуун ярдын зайд байсан онгоц тохойн дагуу түргэн өнгөрлөө. Хэдхэн хорром өнгөрөхөд түүнийг орхин далд орох байв.

Сэр Давос Сиворт хад руу мацаж эхлэв.

Чичирсэн гараараа зууран авирахад толгой нь халуундаа дүйрнэ. Хоёр ч удаа мухар хуруу нь нойтон чулуун дээр хальтирч унах шахсан ч ямар нэг аргаар тогтож үлдэв. Хэрвээ тэр унасан бол үхэх байхад амьд байна. Ядахдаа түр ч атугай. Ямар нэг зүйл хийх хэрэгтэй.

Чулууны орой дээр аюулгүй зогсоход дэндүү зай багатай тул тэр сульдсандаа мөлхөн туранхай гараа даллаж,

- Онгоц. Онгоцоо нааш ирээрэй! гэж салхинд хашгирлаа. Эндээс онгоцны судалтай их бие, хүрэл толгой, намирсан далбаа тод харагдаж байв. Их бие дээр нэр байсан ч Давос уншиж чаддаггүй ажээ.

- Онгоцоо надад туслаач, НАДАД ТУСЛААЧ! гэж хашгирлаа.

Онгоцны хошуун дээр байсан далайчин түүнийг харж заахад хашлага дээр бусад нь гарч ирэв. Хэсэгхэн хугацааны дараа онгоцны далбаа доошилж, сэлүүрээ гаргаад хоргодсон газрынх нь зүг тойрон хөвлөө. Ингээд хаданд ойртож очиход дэндүү том байсан тул гучин ярдын зайд жижиг завь буулгав. Давос чулуунаас зуурсан чигээрээ багийнхан түүний зүг ирэхийг ширтэв. Дөрвөн хүн сэлүүрдэж тав дахь нь хитэг дээр нь сууж байв.

- Хөөе тэр хадан дээр байгаа хүн. Чи хэн бэ? гэж тав дахь хүн арлаас хэдэн футын зайд ирэхэд хашгиран асуулаа.

Өөрийгөө дээгүүр гаргасан хориотой наймаачин, хаанд дэндүү хайртай бурхдыг мартсан тэнэг гэж Давос бодлоо.

- Би... гээд хоолой нь аргаж яаж үг хэлдэгийг мартсан тул амнаас нь гарсан үг чихэнд харь

сонсогдов.

- Би тулалдаанд байсан. Би онгоцны ахмад... хүлэг баатар байсан юм. Би хүлэг баатар байсан.

- Аль хааны талд зүтгэж байсан юм, сэр?

Сэлүүрт онгоц Жоффригийн талын байж болохыг Давос гэнэтхэн ухаарлаа. Хэрвээ тэр одоо буруу нэр хэлэх юм бол тэд түүнийг хувь заяанд нь даатган орхих болно. Гэхдээ онгоцны их бие судалтай байна шүү дээ. Тэгэхээр Лайсени Салладор Сааны онгоц байж таарна. Ээж түүнийг илгээн өршөөлөө үзүүлжээ. Тэр түүнд даалгавар оноосон байна. *Станнис амьд. Надад хаан байгаа хэвээр. Дээрээс нь ондоо хөвгүүд үнэнч хайртай эхнэр минь бий.* Тэр үүнийг яаж мартаж чадав аа? Ээж үнэхээрийн өршөөнгүй юм.

- Станнис. Бурхад ивээг би Станнис хаанд зүтгэдэг гэж тэр Лайсени руу буцаж хашгирлаа.

- Аяа бид ч гэсэн гэж завин дээрх хүн хариу хэлэв

САНСА

Урилга гэм зэмгүй мэт санагдсан ч Санса унших тоолон дотор нь аягүйцэв. *Тэр одоо хатан хаан болно. Тэр үзэсгэлэнтэй баян хүн бүхэн хайртай байхад яагаад урвагчийн охинтой зоог барихыг хүсээ вэ?* Энэ нь сонирхолтой байв. Магадгүй Маржэйри Тайрелл түүнийг байрыг нь булаах гэсэн өрсөлдөгч гэж үзсэн юм биш байгаа даа. *Тэр надад дургүйцсэн юм болов уу? Тэр намайг муу зүйл авчирна гэж бодсон хэрэг үү?...*

Санса шилтгээний хэрмийн орой дээрээс Маржэйри Тайрелл Эйгоны өндөр толгод өөд бараа бологсдоо дагуулан өгсөн гарч ирэхийг харжээ. Жоффри шинэхэн сүйт бүсгүйгээ Хааны хаалган дээр угтан авч хот руу урьж оруулаад хөөрөн баярласан олон түмний дундуур мөр зэрэгцэн явлаа. Жоффри гялалзсан алтадмал хуягтай, Тайреллийн охин намрын цэцэгс мөрөндөө хийсгэсэн үзэсгэлэнтэй ногоон нөмрөг нөмөрчээ. Тэр арван зургаан настай хүрэн үс, бор нүдтэй гоолиг үзэсгэлэн төгс байлаа. Хүмүүс дэргэдүүр нь өнгөрөх үед түүний нэрийг дуудаж хүүхдүүдээ өргөн адислуулж мориных нь туурайн дор цэцэгс тараан шиднэ. Бүхээгний хоёр талд дээр нь тус бүр алтадмал гялалзсан зуун сарнай сийлсэн өндөр дугуйтай тэргэн дээр суусан Маржэйригийн ээж, эмээ хоёр араас нь ойрхон дагалдана. Энгийн ардууд тэдэнд ч гэсэн баяр хүргэв.

Хэрвээ Хоточ байгаагүй бол намайг мориноос татан унагаж алах байсан ардууд. Санса Маржэйри Тайрелл тэдний хайрыг булааснаас илүүтэй жирийн ардууд түүнийг үзэн ядах зүйл хийсэнгүй. *Тэр намайг бас түүнд хайртай байхыг хүсч байгаа юм болов уу?* Санса Маржэйригийн өөрийн гараар бичсэн урилгыг шинжин харлаа. *Тэр миний адислалыг хүссэн юм болов уу?* Ер нь Жоффри энэ зоогийн тухай мэдэх болов уу. Түүний мэдэх бүх зүйл гэвэл юу хийж болохыг нь мэдэж байв. Энэ тухай бодохоос эмээх сэтгэл төрлөө. Хэрвээ Жофф урилганы ард байгаа бол эгчмэд охины нүдэн дээр шившиглэн гутаах хэрцгий тоглоом бодож олсноос зайлахгүй. Тэр Хааны харуулд ахин түүнийг нүцгэлэхийг тушаах юм биш байгаа даа? Сүүлчийн удаа ингэх үед нагац ах Тирион нь зогсоосон ч одоо Бяцхан чөтгөр түүнийг аврахгүй билээ.

Миний Флорианаас ондоо хэн ч намайг аврахгүй. Сэр Донтос түүнийг Жоффригийн хуримын шөнө зугтахад туслахыг амалжээ. Төлөвлөгөө сайтар бэлтгэгдсэн үүнийг хүртэл хоног тоолон тэвчин хүлээхээс ондоо аргагүй гэж түүнийг хүлэг баатар байсан салбадай итгүүлжээ.

Гэвч орны хүнтэйгээ барих зоог гэдэг бол...

Магадгүй тэр Маржэйри Тайреллд шударга бус зүйл хийж байгаа юм биш байгаа. Магадгүй урилга ердийн сайхан сэтгэлийн эелдэг ёсны үйлдэл биш байгаа. *Энэ ердийн нэг зоог байж болно.* Гэвч Хааны газар Улаан шилтгээнд эрхэм дээдэс Жоффри Баратеон хааны ордонд Санса Старк ганцхан зүйлийг сурсан нь үл итгэл байлаа.

Гэсэн ч хүлээн зөвшөөрөх ёстой. Тэр бол бослого дэгдээсэн урвагчийн шившигт охиноос ондоо юу ч биш. Түүнд Жоффригийн хатанд татгалзах эрх байхгүй.

Хоточ энд байсан ч болоосой. Тулалдааны шөнө Сандор Клегэйн хотоос авч явахаар өрөө лүү нь ирсэн ч Санса татгалзжээ. Заримдаа шөнө сэрүүн хэвтэж байх үедээ зөв зүйл хийсэн эсэхээ

гайхширдаг байв. Тэр бохирдсон цагаан нөмрөгийг хушин авдарт торгон даашинзны дор нуужээ. Яагаад үүнийг хадгалсан учраа өөрөө ч мэдсэнгүй. Хоточийг тулааны ид дунд согтуу байсан учир Бяцхан чөтгөр цохилтын цэргүүдийг нь тэргүүлсэнд хулчгар болсон гэж дуулжээ. Гэсэн ч Санса үүнийг ойлгож байлаа. Тэр түүний түлэгдсэн царайны нууцыг мэднэ. *Энэ бол ердөө тэр галаас айсан хэрэг.* Тэр шөнө зэрлэг гал гол шатаж буй мэт дүрэлзэн агаарт ногоон дөл өндөр цоролзож байсан. Шилтгээний дотор талд байсан Санса хүртэл айсан байхад гадна ямар байсныг төсөөлөхөд бэрх байв.

Тэр санаа алдсанаа үзгээ бэхэнд дүрээд Маржэйри Тайреллд урилгынх нь хариуд зөвшөөрсөн үг бичлээ.

Товлосон шөнө болоход Сандор Клегэйнээс ондоо Хааны хамгаалалтын хүлэг баатар ирэн. *...нохой байснаа цэцэг болжээ.* Сэр Лорас Тайрелл үүднийх нь босгон дээр зогсоход Сансагын зүрх түргэн цохилон. Энэ бол түүнийг Хааны газар эцгийнхээ цэргийн хошууч ангийг тэргүүлэн ирснээс хойш анх удаагаа ийм ойроос харж байгаа хэрэг байлаа. Агшин зуур ямар зүйл хэлэхээ мэдсэнгүйд эцэст нь,

- Сэр Лорас та... та маш сайхан харагдаж байна гэв. Тэр түүн рүү учир битүүлэг инээмсэглэлээ.

- Хатагтай та дэндүү ялдам юм. Үүнийхээ зэрэгцээ үзэсгэлэнтэй. Миний дүү таныг тэсч ядан хүлээж байгаа.

- Би ч гэсэн зоогонд орохыг тэсэн ядаж байна.

- Маржэйригийн адил эмээ минь ч гэсэн хүлээж байгаа гээд Лорас гарыг нь авч шатны уруу дагуулан явлаа.

- Эмээ чинь гэнэ ээ? гээд Санса сэр Лорасыг гарт нь хүрч байхад явахын зэрэгцээ ярьж, бодох хэцүү байлаа. Түүний гар торго нэвт халуу төөнөнө.

- Хатагтай Олена. Тэр ч гэсэн чамтай зоог барина.

- Өө. Түүнийг Өргөст хатан гэж дууддаг билүү? Тийм байх аа? *Би түүнтэй ярьж, тэр гараас минь барьж надад хүрч байна.*

- Тийм гээд сэр Лорас инээмсэглэхэд *"тэр ямар дулаахан инээмсэглэлтэй юм бэ"* гэж Санса үргэлжлүүлэх зуур нь бодов. - Гэхдээ чи түүний дэргэд ингэж дуудаж болохгүй шүү. Үгүй бол хатгуулна гэж мэдээрэй.

Сансагын нүүр улайлаа. Ямар ч тэнэг хүнд эмэгтэй хүнийг "Өргөст хатан" гэж дуудвал таатай байхгүй нь ойлгомжтой байв. *Магадгүй би үнэхээр Сергей Ланнистерийн хэлдэг шиг дүүрчихсэн тэнэг юм болов уу.* Тэр цөхөрсөндөө ямар нэг аятай ухаалаг зүйл хэлэхийг оролдсон ч хамаг ухаан нь орхин оджээ. Санса бараг л түүнийг хичнээн сайхан харагдаж байгаа тухай хэлэх шахсан хойно аль хэдийн хэлснээ санах.

Тэр үзэсгэлэнтэй юм гэж санаашрав. Лорас түүнтэй анх уулзсанаас хойш өндөр болсон мэт санагдсан ч гоолиг уян налархай хэвээр Санса хэзээ ч ийм гайхамшигтай нүдтэй хүүтэй тааралдаж байсангүй. *Тэр хүү биш эрийн цээнд хүрэн Хааны хамгаалалтын хүлэг баатар болсон.* Санса түүнийг Тайреллийн овгийн ногоон ногоон дээр алтан хувцаснаас улам ч цагаан сайхан харагдаж байна гэж бодлоо. Хувцсан дээр нь цорын ганц толбо болох нөмрөг торгоосон энгэрийн зүү нь гоёмсог хаш ногоон навчин дээр дэлгэрсэн Хайгардений зөөлөн шаргал алтан сарнай байв.

Тэднийг өнгөрөхөд Мэйгорийн хаалган дээр сэр Бэйлон Свон зогсч байв. Тэр бүх биеэ өвч цагаан хувцасласан ч сэр Лорасын гоо үзэмжийн хагастай нь ч дүйсэнгүй. Хурц гадас зоосон шуудууны цаана хориод хүн илд бамбайгаар байлдаж сургуулилна. Шилтгээн дүүрэн хүнтэй болохоор гадна хашаанд ч гэсэн зочид майхан, асраа босгон хашааны дотор талд сургууль хийх жаахан талбай үлдээжээ. Рэйдвайны ихрүүдийн нэг сэр Таладаас бамбайгаа нүдний дор өргөн ухрав. Кэйсийн бахим сэр Кенос урт илд өргөх тоолон аахилж уухилан Осни Кетлблакийн эсрэг үзэлцэхэд, Оснигийн дүү сэр Осфрид бахан нүүртэй дагуул Морос Слингтийг хэрцгий цохилтоор шийтгэж байв. Илдний мохоогоос үл хамааран Слингтийн бие маргааш битүү хөхөрсөн толботой болох нь лавтай. Санса үүнийг хараад өөрийн эрхгүй ярвайлаа. *Тэд сүүлчийн тулалдаанаас амь үрэгдсэн хүмүүсээ оршуулж амжаагүй байж хэдийн дараагийг нь араас сургуулилж байх юм даа.*

Хашааны захад бамбай дээрээ хос алтан сарнайтай хүлэг баатар гурван хүний эсрэг үзэлцэж байв. Тэднийг харахын зуургүй хүлэг баатар өрсөлдөгчийнхөө нэгний толгой руу хажуу талаас нь дүйрч унатал буулгалаа.

- Энэ таны ах уу? гэж Санса асуулаа.

- Тиймээ, хатагтай. Гарлан үргэлж голдуу гурван хүний эсрэг сургуулилдаг ч заримдаа дөрвөн хүнтэй үзэлцэх тохиолдол байдаг. Тулалдаанд ганц хүний эсрэг тулах нь ховор байдаг тул бэлтгэж байна гэж хэлдэг юм хэмээн сэр Лорас хэлэв.

- Тэр маш зоригтой байх даа.

- Тэр агуу хүлэг баатар. Үнэнийг хэлэхэд илдээр надаас илүү ч би жадаар илүү гэж бодож байна.

- Би санаж байна. Та маш сайхан давхиж байсан, сэр.

- Хатагтайн ингэж хэлдэг ямар ялдам юм бэ. Та хэзээ миний давхилтыг хараа вэ?

- Гарын тэмцээн дээр санахгүй байна гэж үү? Та цагаан морь унаж төрөл бүрийн цэцэгстэй хуяг өмссөн байсан. Та надад сарнай өгсөн шүү дээ. Улаан сарнай. Та тэр өдөр бусад охидуудад цагаан сарнай өгч миний гоо үзэсгэлэнгийн хагастай тэнцэх ялалт байхгүй гэж хэлсэн гээд Санса улайхад,

- Би ердөө ямар ч хүний нүдэнд өртөх жирийн үнэнийг хэлсэн гээд сэр Лорас даруухан инээмсэглэв.

Тэр санахгүй байна. Тэр зөвхөн надад элдэг хандаж байгаагаас бус миний тухай болон сарнай

өгсөн тухайгаа юу ч санахгүй байна гэж Санса гайхширан ухаарлаа. Тэр үүнийг гарцаагүй ямар нэг учиртай гэж бодсон. Цагаан биш улаан сарнай шүү дээ.

- Энэ бол таны сэр Робар Ройсийг морьгүй болгосны дараа үе гэж цөхрөн хэлэхэд Лорас гараа татаж,

- Би Робарыг Шуурганы адагт алсан, хатагтай гэж хөөрч догдолсон бус гашуудсан хоолойгоор хэллээ.

Тэр Рэнли хааны Солонгон хүлэг баатрын нэг байсан, тийм. Санса энэ тухай эмэгтэйчүүдийн ярьж байхыг сонссон ч агшин зуур мартжээ.

- Лорд Рэнлиг алагдах үед үү? Хөөрхий дүүд чинь хичнээн аймшигтай зүйл болоо вэ.

- Маржэйрид үү? гээд Лорасын хоолой чангарлаа.

- Тэгэлгүй яахав. Түүнийг Гашуун гүүрэн дээр байсан гэж бодож байна. Тэр үүнийг хараагүй.

- Гэсэн ч энэ тухай сонсох үедээ...

Сэр Лорас цагаан чулуун сарнай толгойтой илднийхээ бариулыг гараараа хөнгөн шүргэн,

- Рэнли үхсэн. Робар ч гэсэн ижил. Тэдний тухай ярих ямар хэрэгтэй гэж? гэхэд хоолойных нь хурц өнгө Сансаг агзасхийхэд хүргэв.

- Би... эрхэм лорд би... би таныг гомдоох гээгүй юм шүү, сэр.

- Үгүй дээ, хатагтай Санса гэж сэр Лорас хэлсэн ч хоолойных нь дулаан өнгө үгүй болжээ. Гэсэн ч тэр гарыг нь ахин авлаа.

Тэд эргүүлгэн шатаар нам гүм буув.

Өө би юунд сэр Робарын тухай дурьдав аа? Би бүгдийг сүйтгэчихлээ. Тэр одоо надад уурлаж байгаа гэж Санса бодов. Тэр үүнийг залруулах ямар нэг зүйл хэлэхийг хичээсэн ч бүх үг нь тааруухан болсонд *"чимээгүй бай үгүй бол чи байдлыг улам дордуулах нь байна"* гэж өөртөө хэлэв.

Лорд Мэйс Тайрелл ордны ард талын Ариун Бэйлор хаан охин дүү нараа нүдэнд нь өртөн нүгэл хилэнцэт бодол төрүүлэхгүйн тулд хорьж байсан Охины бунхан нэртэй урт занар чулуун дээвэртэй цайзад хуарагнан буужээ. Сийлбэртэй өндөр хаалганы гадна гялалзсан хагас дуулга, алтан атлаасан эмжээртэй ногоон нөмрөгтэй цээжин дээрээ Хайгардены алтан сарнайн сүлд бүхий хоёр харуул зогсож байв. Хоёул долоон фут өндөр өргөн мөр нарийхан бүсэлхийтэй гайхамшигтай сайхан булчинлаг ажээ. Санса тэдний царай харагдахаар ойртох үед хооронд нь ялгаж чадсангүй. Тэд ижилхэн хүчирхэг эрүү, гүн цэнхэр нүд, өтгөн улаан сахалтай байлаа.

- Тэд хэн юм бэ? гэж сэр Лорасаас саяхан тэвдсэнээ мартан асуулаа.

- Миний эмээгийн хувийн харуул. Ээж нь тэдэнд Эррик, Аррик гэдэг нэр өгсөн ч эмээ маань ялгадаггүй болохоор зүгээр л Баруун, Зүүн гэж дууддаг юм.

Баруун, Зүүн хоёр хаалга онгойлгоход Маржэйри Тайрелл шатны уруу дэвхрэх шахам тэднийг угтлаа.

- Хатагтай Санса. Чамайг ирсэнд туйлын баяртай байна. Тавтай морилно уу гэхэд Санса ирээдүйн хатан хаанд өвдөг нугалан мэхийн ёслол.

- Та надад гүн хүндэтгэл үзүүллээ, эрхэм дээдсээ.

- Намайг зүгээр л Маржэйри гэж дуудаж болно. Гуйя, босно уу. Лорас хатагтай Сансаг хөл дээр нь босоход туслаач. Харин би чамайг Санса гэж дуудаж болно биз дээ?

- Таны тааллаар болог гэхэд сэр Лорас түүнийг өндийлгөлөө.

Маржэйри ахыгаа дүүгийн ёсоор үнсээд Сансагын гарыг авлаа.

- Явъя эмээ хүлээж байгаа. Тэр тийм ч тэвчээртэй хатагтай нарын нэг биш шүү.

Зууханд гал дүрэлзэн шалан дээр анхилуун үнэртэй сүрэл тараан хаялжээ. Гурвалжин хөлтэй урт модон ширээ тойроод арваад эмэгтэй сууж байв.

Санса эндээс зөвхөн лорд Тайреллийн өндөр хүндтэй эхнэр урт мөнгөлөг гэзгэндээ үнэт чулуун бөгж зүүсэн хатагтай Алериг танилаа. Маржэйри бусдыг нь танилцуулав. Тэнд Сансагын үеийн Тайреллийн гурван үеэл болох Мегга, Алла, Элинор болон Фоссовэйн ногоон алимны нэгтэй гэрлэсэн лорд Тайреллийн дүү том хөхтэй хатагтай Жанна, сэр Гарлантай гэрлэсэн царайлаг хөөрхөн нүдтэй мөн адил Фоссовэйн хатагтай Леонетт, цоохор нүүртэй хөгжилтэй септа Нистерика, удахгүй хүүхдээ төрүүлэх гэж буй цайвар туяхан хатагтай Грэйсфорд, найман настай хатагтай Булвар, "Хөгжилтэй" гэдэг хочтой дуу шуугиантай булцгар Мередит Крэйн, дүрэлзсэн хар нүдтэй Миришийн үзэсгэлэнтэй хатагтай Мерривидер нар байлаа.

Эцэст нь Маржэйри түүнийг ширээний хоймор сууж байгаа үрчлээтэй цагаан үстэй хүүхэлдэй шиг эмгэн рүү авчирлаа.

- Миний эмээ бид бүхний сэтгэлд байдаг талийгаач Хайгардены лорд Лутор Тайреллийн бэлэвсэн эхнэр хатагтай Оленаг танилцуулахдаа баяртай байна.

Хөгшин эмгэнээс сарнайн ус ханхлав. *Яагаад тэр жижигхэн л юм байна шүү дээ.* Түүнд өчүүхэн төдий ч өргөстэй зүйл байсангүй. Хатагтай Олена Сансагын бугуйнаас үрчлээтэй цоохор гараараа угзран,

- Намайг үнс, охин минь. Чиний надтай болон тэнэг эм тахиан сүрэгтэй минь зоог барихыг зөвшөөрсөн нь ямар сайн хэрэг вэ гэв.

Санса дуулгавартай бөхийн хөгшин эмгэний хацар дээр үнслээ.

- Таны намайг дуудсан чинь гэсэн, хатагтай.
- Би өвөөг чинь мэднэ. Лорд Рикард базаахгүй байгаа юу.
- Тэр намайг төрөхөөс өмнө нас барсан.
- Би үүнийг мэднэ. Энэ чиний Таллигийн өвөө чинь бас үхэж байгааг хэлсэн юм. Тэд лорд Хостерийн тухай чамд хэлээгүй юу? Хөгшин хэдий ч надаас төдийлөн ахмад гэж бодохгүй байна. Бид бүгдийн төгсгөл ирсэн шөнө болсон хэвээр дэндүү цөөхүүлээ үлдэж дээ. Чи энэ тухай сайн мэдэж байгаа байх, хөөрхий хүүхэд. Чамайг уй гашуудалтай байгаа гэдгийг би мэднэ. Чамд гашуудал тохиолдсон явдалд чинь бид харуусал илэрхийлье гэхэд Санса Маржэйри руу харлаа.
- Би лорд Рэнлигийн үхлийн тухай сонсоод ихэд гашуудсан билээ, эрхэм дээдсээ. Тэр маш зоригтой байсан гэхэд,
- Чи дэндүү эелдэг юм гэж Маржэйри хэлэв. Эмээ нь тургилаа.
- Зоригтой дур булаам маш цэвэрч. Тэр хувцасыг яаж өмсөж хэрхэн инээмсэглэн усанд орохыг мэддэг байсан нь хаан болгоно гэж бодсон бололтой. Баратеоньхон үргэлж хачин бодолтой хүмүүс. Энэ нь тэдний Таргарианаас өвлөгдөж ирсэн цусанд байдаг гэж бодож байна гээд тургилснаа,
- Тэд урьд нь надтай Таргарианыхны нэгийг гэрлүүлэхээр оролдсон ч би төдөлгүй эцэс болгосон юмдаг гэлээ.
- Рэнли зоригтой эелдэг байсан, эмээ. Аав түүнд Лорасын адил сайн байсан гэж Маржэйри хэллээ.
- Лорас залуухан дээрээс нь хүнийг мориноос саваагаар цохин унагахдаа сайн байх. Энэ нь түүнийг ухаалаг болгохгүй. Эцгийн чинь хувьд гэвэл би том модон халбагатай тариачин эмэгтэй байсан бол толгой дундуур нь ухаан ортол сайтар гөвшөөд өгөх байлаа гэж хатагтай Олена ширүүлэв.
- Ээж ээ гэж хатагтай Алери зэмлэнгүй дуугарав.
- Чимээгүй Алери надтай ийм өнгөөр бүү ярь. Тэгээд ч намайг ээж гэж бүү дууд. Хэрвээ би чамайг төрүүлсэн бол үүнийгээ санах ёстой. Би ердөө чиний нөхөр Хайгардены мулгуу лордыг буруутгаж байна гэхэд,
- Эмээ та хэлсэн үгнийхээ тухай бодохгүй бол Санса бидний тухай юу гэж бодох вэ? гэж Маржэйри аргадав.
- Тэр бидний зарим нэгд ухаан бий гэж бодно. Ядахдаа ганцад нь ч болов гээд эмгэн Санса руу эргэлээ.
- Энэ бол урвалт гэдгийг би тэдэнд анхааруулсан. Роберт хоёр хүүтэй байхад Рэнли яаж дээрээ ахтай байж тэр хахир төмөр сандалд өөрийгөө тунхаглаж болох вэ? гэхэд түт-түт та ач охиноо

хатан болгохыг хүсэхгүй байна уу? гэж миний хүү хэлсэн. Танай Старкийнхан урьд нь хаан байсан. Аррин болоод Ланнистерийнхан ч гэсэн тэр ч байтугай Баратеоньхон хүртэл эмэгтэй талдаа хаан байсан байхад Тайреллийнхан Эйгон луу Ричийн хууль ёсны хааныг Галын талбарт шарах хүртэл захирагчаас хэтэрч байгаагүй. Үнэнийг хэлэхэд манай Хайгардены тунхаглал үргэлж гонгинож байдаг аймшигтай Флорентийнхан шиг бага зэрэг зальжиндуу. Энэ ямар хамаатай юм бэ? гэж чи асуух байх л даа. Мэдээж миний дүйнгэ хүүгээс бусад өөр хэнд ч хамаагүй. Түүний нэг л өдөр ач хүүгийнхээ өгзгийг Төмөр хаан ширээнд залах бодол Мэйсийг яг л... за байз юу гэж хэлдэг билээ? Маржэйри чи ухаантай болохоор хөөрхийлөлтэй хөгшин хагас ухаан галзуу эмэг эхдээ Зуны арлын хэрвээ саваагаар хатгавал өөрийнхөө хэмжээнээс арав дахин хөөн томордог нөгөө загасны нэрийг хэлж өгөөч.

- Түүнийг хөөсөн загас гэдэг, эмээ.

- Мэдээж тэгж таарна. Зуны арлынхан ямар ч төсөөлөлгүй улс. Үнэнийг хэлэхэд миний хүү хөөсөн загасыг сүлдэндээ залах ёстой байсан юм. Тэр Баратеоньхон буга авсан замаар титэм авч байгаадаа баяртай байгаа байх. Хэрвээ чи надаас асуувал үнээний саасан сүүг дэлэн рүү нь буцаан хийдэггүйн адилаар бид энэ бүх тэнэглэлээс холхон байх ёстой. Лорд Хөөсөн загас Рэнлигийн толгой дээр титэм тавьсаны дараа бид чунзанд өвдөглөсөн болохоор энд ийм зүйлийг урьдчилан харах ёстой. Чи энэ тухай юу гэж хэлмээр байна даа, Санса?

Санса амаа нээснээ хамхихад яг л хөөсөн загас болсон аятай сэтгэгдэл төрөв.

- Тайреллийнхан Ногоон гарт Гартаас өвлөгдөн ирсэн эртний удам судартай гээд толгойд нь орж ирсэн ганц бодол байлаа.

Өргөст хатан тургилаа.

- Тэгвэл Флорент, Рован, Окхарт болон өмнө зүгийн бусад сурвалжит гэр бүлүүдийн хагас нь ч гэсэн адил. Гарт үржил шимтэй хөрсөнд үр суулгах дуртай байсан гэж хүмүүс хэлдэг. Түүний гарыг ногоон байсанд гайхах юм алга гэхэд,

- Санса чи их өлссөн байх даа. Бид бодонгийн мах идэх гэж байгаа. Бас нимбэгний бялуутай? гэж хатагтай Алери яриаг нь таслав.

- Би нимбэгний бялуунд дуртай.

- Бидэнд харин тэгж хэлсэн гэж харваас огтхон ч чимээгүй байх бодолгүй хатагтай Олена хэллээ.

- Тэр Варис адгуус биднийг ийм мэдээлэл өгсөнд нь талархах ёстой гэж бодож байгаа байх. Би үнэн хэлсэн байлаа ч гэсэн хэзээ ч тайганы хэлсэн үгэнд итгэхгүй. Надад бол тэд ямар ч ашиггүй хөнгөлүүлсэн амьтад. Алери чи тэдэнд хоол авчир гэж хэл. Эсвэл намайг өлсгөж үхүүлэх гээ юу? Санса энд дэргэд минь суу. Би эд нараас бүр уйдчихсан. Чамайг тэнэгт дуртай гэж найдаж байна гэхэд Санса даашинзныхаа хормойг тэнийлгэн суулаа.

- Би бодохдоо... тэнэг гэнэ ээ, хатагтай? Та эрэн хувцастайг нь хэлж байна уу?

- Энэ тохиолдолд өдтэй нь. Чи намайг юуны тухай хэлсэн гэж бодоо вэ? Миний хүү юу? Эсвэл эдгээр хатагтай нар уу? Үгүй дээ, улайх хэрэггүй үс чинь чамайг анар шиг харагдуулаад байна. Үнэнийг хэлэхэд бүх эрчүүд тэнэгүүд ч эрээн хувцастай нь титэмтэйгээс илүү хөгжилтэй. Маржэйри охин минь Батербампыг дууд үгүй бол бид хатагтай Сансаг инээмсэглүүлж чадахгүй нь. Үлдсэн нь сууцгаа. Би та нарт юм бүхнийг хэлж байх ёстой юу? Санса миний ач охиныг сүрэг хонь бараа болон дагадаг гэж бодож магадгүй.

Хоолны өмнөхөн шаргал өдтэй салбадайн ногоон хувцсан дээр далбагар малгай өмссөн Батербамп ирлээ. Тэр Сарны хүүгээс гурав дахин бүдүүн том бөгөөд танхимд дугуйтай тэрэгтэй давхин орж ирээд ширээний дэргэд зогсож том өндөг Сансагын баруун урд талд тавиад,

- Үүнийг хагал, хатагтай гэж тушаав. Санса үүнийг гүйцэтгэхэд сүрэг шар дэгдээхэй тал бүр тийш бутран зугтав.

- Тэднийг бариарай! гэж Батербамп хашгирлаа. Бяцхан хатагтай Булвар нэгийг барьж өгөхөд тэр толгойгоо хойш гэдийлгэн том амандаа хийн бүхлээр нь залгичихлаа. Тэгснээ хэхрэхэд жижигхэн шар өднүүд хамраас нь бутран хийсэв. Хатагтай Булвар уйлж эхэлснээ дэгдээхэй даашинзных нь ханцуйнаас гарч ирээд гарыг нь даган гүйхэд баярласандаа хашгирлаа.

Энэ зуур зарц нар гогод, мөөгтэй шөл авчирав. Батербамп жонглёрдох зуур хатагтай Елена ширээн дээр тохойгоо тулан урагш бөхийлөө.

- Чи миний хүүгийн тухай мэдэх үү, Санса? Хайгардены лорд Хөөсөн загас?

- Тэр агуу лорд гэж Санса эелдэгээр хариулав.

- Агуу тэнэг. Түүний эцэг нь ч гэсэн мулгуу амьтан байсан юм. Миний талийгаач нөхөр лорд Луторын тухай ярьж байна л даа. Өө намайг түүнд хайртай байсанд эндүүрэх явдалгүй. Эелдэг хэдий ч орондоо чадваргүй бас нэг дүүрчихсэн мулгуу. Тэр харцагаар ан хийхдээ цохион дээгүүр явсан юм. Хүмүүс түүнийг тэнгэр лүү гөлөрснөөс бус морь нь хааш авч явааг хараагүй гэлцдэг.

- Харин одоо миний мулгуу хүү ижил зүйл хийж байна. Тэр зөвхөн морины оронд арслан унасан байх. Арсланг унахад амархан ч салахад амаргүй гэж би түүнд анхааруулсан ч ердөө урдаас инээгээд өнгөрсөн. Санса чи хүүтэй болвол хэлсэн үгийг чинь сонсдог болох хүртэл сайтар гүвж өгч байгаарай. Тэр миний цорын ганц хүү байсан болохоор бараг зоддоггүй байсныг харин одоо Баттербампаас дутуугүй авирлан надад төлж байна. Арслан бол өвөр дээрх муур биш гэж би түүнд хэлэхэд "түт түт ээжээ" гэсэн. Хэрвээ чамайг надаас асуувал түүний хаант улсад нь дэндүү их түт-түт бий. Эдгээр бүх хаад илдээ орхиж эхийнхээ үгийг сонсдог бол үйл хэрэг нь илүү дээр байхсан.

Санса амаа ахин ангайснаа мэдэрлээ. Тэр шөл халбагадахад хатагтай Алери бусад эмэгтэйчүүдтэй Батербампын толгой, тохой, том ууцан дээрээ зүрж ойлгох үзүүлбэрийг үзэн хөхрөлдөж байв.

- Би чамайг энэхүү хаан хөвгүүний тухай үнэнийг хэлэхийг хүсч байна. Тэр Жоффри гэж хатагтай

Олена ширүүн хэллээ.

Сансагын халбага барьсан хуруу чангарав. *Үнэн гэнэ ээ? Би чадахгүй. Битгий надаас асуугаач гуйж байна. Би чадахгүй.*

- Би... би... би...

- Тиймээ, чи. Чамаас ондоо өөр хэн илүү мэднэ гэж? Залуугийн хаанлиг төрхтэйд чамд талархах байна. Жаахан ихэрхүү хэдий ч Ланнистерийн цусанд нь байгаа байх. Гэсэн ч бид хэдэн түүх олж сонссон. Тэдний аль нэг үнэн үү? Хүү чамтай зохисгүй харьцаа юу?

Санса эргэн тойрноо мэгдэн харлаа. Батербамп амандаа бүтэн зүрж хийснээ зажилж залгиад хацар луугаа алгалан үрийг нь хамраараа тургиж гаргалаа. Эмэгтэйчүүд инээлдэн хөхрөлдөнө. Зарц нар орж гаран өрөөнд таваг халбага харших дуу гарна. Дэгдээхэйний нэг ширээн дээр үсэрч гараад хатагтай Грэйсфордын шөл рүү гүйж оров. Түүнийг айн уулга алдахад хэн ч тэдний зүг анхаарал хандуулсангүй.

Хатагтай Оленагын тэвчээр алдагдав.

- Чи яагаад Батербамп руу гөлрөөд байгаа юм? Би асуулт асуусан болохоор түүнийхээ хариултыг авмаар байна. Аль эсвэл Ланнистерийнхан чиний хэлийг сугалчихаа юу, охин минь?

Сэр Донтос Сансад зөвхөн бурхдын модонд чөлөөтэй ярьж болно гэж анхааруулсан билээ.

- Жофф... Жоффри хаан тэр... Эрхэм дээдэс маш үзэсгэлэнтэй царайлаг... арслан шиг зоригтой.

- Тиймээ бүх Ланнистерийнхан арслангууд Тайреллийнхан салхинд сарнай шиг үнэртдэг гэж эмгэн зандаллаа.

- Гэхдээ тэр яг ямархуу юм? Хэр ухаалаг? Уян сэтгэл зөөлөн гартай юу? Хааны зэрэгт хүрэх хүнлэг уужим уу? Тэр Маржэйриг хайрлаж найрсаг харьцан нэр хүндийг нь өөрийнх шигээ хамгаалах уу?

- Тэгнэ. Тэр маш... маш хөөрхөн гэж Санса худал хэллээ.

- Чи наадахаа хэлсэн биз дээ. Зарим нэг хүмүүс чамайг энд байгаа Батербампаас тэнэг гэж хэлснийг мэдэх үү. Би одоо л тэдэнд итгэж эхэлж байх шиг байна. Хөөрхөн гэнэ ээ? Би Маржэйрид хөөрхөн ямар үнэтэйг зааж өгсөн гэж найдаж байна. Харганын унгасаас өөрцгүй. Хурц дөл Эйрион бас хөөрхөн байсан ч үүнийхээ зэрэгцээ мангас байсан. Асуултын гол гэвэл Жоффри яг ямар юм? гээд эмгэн дэргэдүүр өнгөрөх зарцаас шүүрэн авав.

- Би гогдонд дургүй. Энэ шөлийг авч яваад надад бяслаг авчир.

- Бяслагийг бялууны дараа үйлчилдэг шүү дээ, хатагтай.

- Бяслагийг зөвхөн миний хүссэн үед үйлчлэх ёстой харин би одоо идэхийг хүсч байна гээд эмгэн

Санса руу буцаж эргэлээ.

- Чи айгаа юу, охин минь? Айх хэрэггүй дээ энд зөвхөн эмэгтэйчүүд байна. Надад үнэнийг хэлвэл чамд ямар ч гэм учрахгүй.

- Миний эцэг үргэлж үнэн хэлдэг байсан гэж Санса сонсогдохгүй аяархан дуугаар хэллээ.

- Тиймээ лорд Эддарт нэр хүндтэй хүн байсан ч тэд түүнийг урвагч гэж зарлан толгойг нь авсан гээд эмгэн түүнийг илдийн хурц үзүүр шиг шөвөгдсөн харцаар сүлбэв.

- Жоффри. Жоффри үүнийг хийсэн. Тэр надад өршөөнө гэж амлаад эцгийн минь толгойг цавчсан. Тэр үүнийг өршөөл байсан гэж хэлээд намайг хэрэм рүү аваачин толгойг нь албадан харуулсан. Тэр намайг уйлахыг хүссэн ч гэхдээ... гээд Санса огцом зогсон амаа дарлаа. *Би дэндүү их зүйл хэлчихлээ. Өө бурхад минь гэж тэд мэдэх болно. Хэн нэгэн миний тухай хэлэх болохоор тэд сонсоно.*

- Цааш нь үргэлжлүүл гэж Маржэйри шаардангуй хэлэв. Жоффригийн өөрийнх нь хатан шүү дээ. Санса түүнийг хэр сонссоныг мэдсэнгүй.

- Би чадахгүй. *Хэрвээ тэр түүнд хэлвэл яана? Тэр намайг гарцаагүй алах юм уу сэр Илинд өгнө.* Би хэзээ ч... миний эцэг урвагч ах минь ч гэсэн урвагч болохоор би урвагчийн цустай. Гуйж байна надаар өөр зүйл бүү хэлүүлээч.

- Тайвшир, охин минь гэж Өргөст хатан тушаав.

- Тэр айчихаж, эмээ. Хараач гэхэд эмгэн Батербампыг дуудав.

- Тэнэг ээ! Бидэнд дуу дуулж өг. Удаан үргэлжилдэгийг нь шүү."Баавгай ба үзэсгэлэнт охин" сайхан зохицоно гэж бодож байна.

- Ёсоор болгоё. Энэ дуу үнэхээр сайхан байх болно. Би толгой дээрээ зогсож байгаад дуулж болох уу, хатагтай? гэж том биетэй алиа салбайдай хэллээ.

- Ингэлээ гээд дуу дээрдэх үү?

- Үгүй.

- Тэгвэл хөл дээрээ зогсож байгаад дуул. Бид чиний малгайг чинь унахыг хүсэхгүй байна. Миний санаж байгаагаар чи ер үсээ угаадаггүй.

- Хатагтайн тушаасан ёсоор больё гээд Батербамп гүнээ мэхийн ёсолж чанга хэхэрснээ гүзээгээ татан эгцлэн зогсож хангинууллаа.

- *Баавгай, баавгай, БААВГАЙ байжээ! Бүх бие нь хар хүрэн үсээр хучигдсан...*

Хатагтай Олена урагш нүдээ онийлгов.

- Би чамаас ч залуу охин байхдаа Улаан шилтгээний хана бүр чихтэй гэдгийг мэддэг байсан. Тэднийг дуугаар таглаад энэ хооронд нь охин чөлөөтэй ярьж болно.

- Гэхдээ Варис... тэр мэддэг, тэр үргэлж... гэж Санса түгдэрлээ.

- Чанга дуул! Хөгшин чих маань бараг таг дүлий болохыг чи мэднэ. Надад шивнээд байгаа юм уу, тарган тэнэг минь? Би чиний шивнэлтэнд хөлс төлөхгүй. Дуул! гэж Өргөст хатан Батербамп руу хашгирлаа.

- *...БААВГАЙ!* гэж Батербамп дээврийн хөндийг нүргэлтэл гүнзгий баргил хоолойгоор хүнгэнүүлэв.

- *ӨӨ ИРЭЭЧ, ЯАРМАГ РУУ ИРЭЭЧ ГЭЖ ТЭД ХЭЛЖЭЭ. ЯАРМАГ РУУ ГЭНЭ ЭЭ? ГЭХДЭЭ БИ ЧИНЬ БААВГАЙ ШҮҮ ДЭЭ!! БҮХ БИЕ НЬ ХАР ХҮРЭН ҮСЭЭР ХУЧИГДСАН! ГЭЖ ТЭР ХЭЛЖЭЭ.*

Үрчлээтэй хөгшин хатагтай инээмсэглэв.

- Хайгарденд бас цэцгийн дунд олон аалз бий. Бид тэдэнд бяцхан тороо нэхэх хугацаа олгосныхоо дараа няц гишгэдэг юм гээд Сансагын нуруун дээр алгадлаа.

- Одоо охин минь үнэнийг хэл. Баратеон гэж өөрийгөө нэрлэдэг ч Ланнистертай адилхан харагддаг Жоффри яг ямар хүн бэ?

- *ЭНДЭЭС ТЭНД ХҮРТЭЛ ЗАМААР ЯВЛАА. ЭНДЭЭС! ТЭНД ХҮРТЭЛ! ГУРВАН ХҮҮ, ЯМАА, БҮЖИГЛЭГЧ БААВГАЙ!*

Сансагын зүрх цээжнээс нь үсрэн гарах шахам цохиллов. Өргөст хатан дэндүү ойрхон тонгойсон тул хөгшин хүний гашуун амьсгал үнэртэж байв. Тэр хатангир хуруугаараа бугуйг нь чимхлээ. Түүний нөгөө талд Маржэйри бас суугаад сонсож байв. Сансагын бие зарсхийхэд айсандаа сонсогдох төдий хоолойгоор,

- Мангас. Жоффри бол мангас. Тэр нядлагчийн хүүгийн тухай худал хэлж эцгээр маань миний чоныг алуулсан. Бас би түүний уурыг хүргэхэд Хааны хамгаалалтын хүлэг баатраар зодуулсан. Тэр муу ёрын хэрцгий хүн, хатагтай. Хатан ч гэсэн ижилхэн гэхэд хатагтай Олена Тайрелл ач охинтойгоо харц солилцов.

- Ай наадах чинь ямар харамсалтай юм бэ.

Өө бурхад минь. Хэрвээ Маржэйри түүнтэй гэрлэхгүй бол Жофф намайг буруутайг мэдэх болно гэж Санса хирдхийн бодлоо.

- Гуйж байна гэрлэлтээ битгий зогсоогооч...

- Айх хэрэггүй, лорд Хөөсөн загас Маржэйриг хатан болгохыг зорьж байгаа. Тэгээд ч Тайреллийн үг Кастерли Рокийн бүх алтнаас илүү үнэ цэнэтэй. Ямартай ч намайг байхад тийм байсан. Гэсэн ч

бид чамд үнэнийг хэлсэнд баярлалаа, охин минь.

- ...*ЯАРМАГ ХҮРЭХ БҮХ ЗАМЫН ТУРШ БҮЖИГЛЭЖ ЭРГЭЛДЭВ! ЯАРМАГ! ЯАРМАГ!* гээд Баттербамп дэвхцэн хөлөөрөө дэвсэллээ.

- Санса чи Хайгарденд зочилмоор байна уу? гээд Маржэйри Тайрелл инээмсэглэхэд ах Лорастайгаа туйлын адилхан харагдав.

- Одоо намрын цэцэгс цэцэглэж байгаа болохоор тэнд ой шугуй, усан оргилуур, хашааны сүүдрэвч, гантиг багана бий. Миний лорд эцэг үргэлж ордондоо Баттербампаас хамаагүй дээр дуучин байлгадаг цоорчин, бишгүүрчин, хуурчин ч гэсэн бий. Бидэнд хамгийн сайн морьд, Мандерийн хооронд зорчдог зугаалгын завь байгаа. Чи харцагаар авлаж байсан уу, Санса?

- Жаахан л гэж тэр үнэнээ хэллээ.

- *ӨӨ ТЭР ХӨӨРХӨН ЦЭВЭР, ҮЗЭСГЭЛЭНТЭЙ! ҮСЭНДЭЭ БАЛТАЙ ОХИН!*

- Чамд Хайгарден таалагдана гэдгийг би мэдэж байна. Чи тэнд очмогц хэзээ ч явмааргүй санагдана даа. Магадгүй тэгэх хэрэггүй ч байж мэднэ гээд Маржэйри Сансагын сул унжсан үсийг иллээ.

- *ТҮҮНИЙ ҮС! ТҮҮНИЙ ҮС! ҮСЭНДЭЭ БАЛТАЙ ОХИН!*

- Чимээгүй, хүүхэд минь. Санса бидэнд тэнд очих дуртай эсэхээ хэлээгүй байна гэж Өргөст хатан огцом хэлэв.

- Өө, би дуртай байна гэж Санса хэллээ. Хайгарден түүний Хааны газар хайж ирсэн үргэлж мөрөөддөг шидэт ордон шиг сонсогдож байв.

- ...*ЗУНЫ АГААРТ ҮНЭР ХАНХЛАНА. БААВГАЙ! БААВГАЙ! БҮХ БИЕ НЬ ХАР ХҮРЭН ҮСЭЭР ХУЧИГДСАН.*

- Гэхдээ хатан. Тэр намайг явуулахгүй гэж Санса үргэлжлүүлэв.

- Тэр явуулна. Хайгарденгүй бол Ланнистерийнхан Жоффригийн хаан суудлыг барих найдлага байхгүй. Хэрвээ миний мулгуу лорд хүү гуйвал түүнд хүсэлтийг зөвшөөрөхөөс ондоо зам байхгүй.

- Тэр тэгэх болов уу? Тэр асуух уу? гэж Санса асуухад хатагтай Олена хөмсөг зангидав.

- Би түүнд сонголт өгөхгүй. Мэдээж тэр бидний жинхэнэ зорилгын талаар дурьдахгүй л дээ.

- *ТЭР ЗУНЫ АГААР ДАХЬ ҮНЭРИЙГ ҮНЭРЛЭЖЭЭ!*

Санса духаа үрчийлгэлээ.

- Бидний жинхэнэ зорилго гэнэ ээ, хатагтай?

- *ТЭР ҮНЭРЛЭЭД ХҮРХРЭН ТЭНД БАЙХЫГ ҮНЭРЛЭЖЭЭ! ЗУНЫ АГААР ДАХЬ БАЛ!*

- Чиний миний ач хүүтэй хийх аюулгүй гэрлэлтийг гэж эмгэн Батербампыг хуучны дууг нүргэлүүлэхэд хэллээ.

Сэр Лорастай гэрлэх, өө... Сансагын амьсгал давхцав. Тэр сэр Лорас гялалзсан индраанил хуягтайгаа сарнай шидэж байсныг санав. Цагаан торгон хувцастай цэвэр, гэм зэмгүй, үзэсгэлэнтэй сэр Лорас. Инээмсэглэхэд хацар нь хонхойдог, сайхан инээмсэглэл, дулаахан гартай сэр Лорас. Санса түүний цамцыг нь тайлж толигор арьсыг нь энхрийлэн өлмий дээрээ зогсон үнсэж, хуруугаа өтгөн хүрэн буржгар үсэнд нь шигтгэн гүн бор нүдний харцанд уусах ямар болохыг төсөөлөв. Хүзүү нь улайлаа.

- *ӨӨ, БИ ОХИН. БИ ЦЭВЭР ҮЗЭСГЭЛЭНТЭЙ! БИ ХЭЗЭЭ Ч ҮСТЭЙ БААВГАЙТАЙ БҮЖИГЛЭХГҮЙ! БААВГАЙ! БААВГАЙ! БИ ХЭЗЭЭ Ч ҮСТЭЙ БААВГАЙТАЙ БҮЖИГЛЭХГҮЙ!*

- Чамд энэ таалагдаж байна уу, Санса? Надад хэзээ ч охин дүү байгаагүй зөвхөн ах нар бий. Гуйж байна за гэж хэлээч. Ахтай минь гэрлэхийг зөвшөөрч байна гэж хэлээч гэж Маржэйри гуйлаа.

- Тиймээ. Би зөвшөөрч байна. Сэр Лорастай гэрлэж, түүнийг хайрлахыг юунаас ч илүүтэй хүсч...

- Лорас гэнэ ээ? хэмээн хатагтай Олена уцаарлангуй дуугарав.

- Битгий тэнэг юм яриад бай, хүүхэд минь. Хааны хамгаалалтын хүлэг баатар хэзээ ч гэрлэдэггүй юм. Тэд чамд энэ тухай Винтерфеллд заагаагүй юм уу? Бид миний ач хүү Виласийн тухай ярьж байна. Тэр чамаас жаахан ах ч хонгор хүү байгаа. Өчүүхэн ч мулгуу бишийн зэрэгцээ Хайгардены залгамжлагч.

Санса толгой эргэн агшин зуур сэр Лорасаар дүүрэн байсан бодол нь сарнин арилав. *Вилас? Вилас гэнэ ээ?*

- Би гэж тэнэг юм шиг дуу алдав. *Эелдэг ёс бол хатагтай хуяг. Чи тэднийг гомдоож болохгүй юу хэлэхээ болгоомжтой бодох ёстой.*

- Би сэр Виласийн тухай мэдэхгүй. Хэзээ ч энэ тухай сонсож байсангүй, хатагтай. Тэр... ах нар шигээ агуу хүлэг баатар уу?

- *...ОХИНЫГ АГААРТ ӨНДӨР ӨРГӨЛӨӨ! БААВГАЙ! БААВГАЙ!*

- Үгүй. Тэр хэзээ ч андгай өргөж байгаагүй гэж Маржэйри хэллээ.

- Охинд үнэнийг хэл. Хөөрхий хүүгийн тахир дутуу болсныг гээд эмээ нь хөмсөг зангидав.

- Тэр дагуул хиа байхдаа анхны тэмцээнд оролцохдоо гэмтсэн юм. Морь нь унахдаа хөлийг нь дарчихсан гэж Маржэйри хэлэв.

- Тэр Дорнишийн могой Обериан Мартелл үүнд буруутай. Түүний мэйстер нь ч гэсэн гэж эмгэн уухилав.

- *БИ ХҮЛЭГ БААТАР ДУУДСАН Ч ГЭХДЭЭ ЧИ БААВГАЙ БАЙНА! БААВГАЙ! БААВГАЙ!
БҮХ БИЕ НЬ ХАР ХҮРЭН ҮСТЭЙ БААВГАЙ!*

- Вилас хөл муутай ч сайхан зүрх сэтгэлтэй. Тэр намайг жаахан байхад уншихыг зааж ододын зураг зурахыг сургасан. Чи түүнд биднээс дутуугүй хайртай болно, Санса.

- *ҮЗЭСГЭЛЭНТ ОХИН ӨШИГЛӨЖ ТИЙЧИГНЭСЭН Ч БААВГАЙ ҮСЭН ДЭХ БАЛЫГ НЬ
ДОЛООЛОО. ОХИНЫ ҮС! ОХИНЫ ҮС! БААВГАЙ ОХИНЫ ҮСНЭЭС БАЛ ДОЛООЛОО!*

- Би түүнтэй хэзээ уулзах вэ? гэж Санса тээнэгэлзэнгүй асуув.

- Удахгүй. Жоффри бид хоёрыг гэрлэсний дараа чамайг Хайгарденд ирүүлнэ. Эмээ чамайг авч явна гэж Маржэйри амлав.

- Тиймээ. Би авч явна гээд хөгшин эмгэн Сансагын гарыг алгадан зөөлөн нүүрээ үрчийлгэн инээмсэглэв.

- *ТЭР САНАА АЛДАН ХАШГИРЧ АГААРТ ТИЙЧИГНЭВ! МИНИЙ БААВГАЙ! МИНИЙ
БААВГАЙ ҮЗЭСГЭЛЭНТЭЙ! ГЭЖ ДУУЛАВ. ИНГЭЭД ТЭД ЭНДЭЭС ТИЙШЭЭ ЯВЖЭЭ,
БААВГАЙ, БААВГАЙ БОЛОН ҮЗЭСГЭЛЭНТ ОХИН ХОЁР* гээд Батербамп сүүлчийн мөрөн дээр агаарт үсэрснээ ширээн дээрх аяга, таваг тачигнатал буулаа. Эмэгтэйчүүд инээлдэн алга ташив.

- Би энэ аймшигтай дууг хэзээ ч төгсөхгүй нь гэж бодлоо. Гэхдээ хараач миний бяслаг ирж байна гэж Өргөст хатан хэлэв.

ЖОН

Ертөнц харанхуйд сааралтан нарс, хөвд, хүйтэн ханхална. Морьтонгуудыг армаг тармаг үхэр чулуутай сийрэг модон дундуур явахад хар газрын хөрснөөс цайвар манан суунаглан голын хөндийн доод хэсэгт шалан дээр тараан асгасан үнэт чулуу аятай галын гэрэл улалзана. Тэнд Жоны тоолж чадахаас олон гал байсан бөгөөд хэдэн зуу, мянгаараа Сүүн усны мөсөн цагаан эрэг дагуу ахин нэг голын ус шиг давалгаалан мяралзана. Жон илд атгадаг гарынхаа хурууг тэнийлгэснээ атгалаа.

Тэд хярын уруу намирсан далбаа, бүрээгүй уруудахад нам гүмийг зөвхөн алсад гол шуугих, морьдын туурхай тачигнах, Харжигнуур хүрэмтийн ясан хуяг шаржигнах чимээ эвдэж байлаа. Дээр нь хаа нэгтээ бүргэд цэнхэр саарал том жигүүрээ дэлгэн хөөрч дор нь хүмүүс, нохой, морьд нэг цагаан зэрлэг чонын хамт цувна.

Налуугийн уруу туурайн аясаар чулуу өнхрөхөд Жон Сүнсийг гэнэтийн чимээнд толгой эргүүлэхийг харлаа. Чоно морьтонгуудыг сурсан зангаараа өдрийн турш зайтай дагасан ч сар залуу нарсны дээгүүр хөөрөх үед улаан нүд цогшуулан харайлган ирэв. Харжигнуур хүрэмтийн ноход түүнийг архирч хуцах дуугаар угтан зэрлэгээр боргоход чоно үргэлжид байдаг шигээ тоож анхаарал хандуулсангүй. Зургаан өдрийн өмнө зэрлэгүүд шөнө буудаллах үед түүний араас нэг том хоточ нохой дайрахад Сүнс огцом эргэн нохойн гуянаас зуун шиджээ. Үүний дараанаас үлдсэн сүрэг зай барих болсон байна.

Жон Сноугийн морь аяархан янцгаахад илж зөөлөн үгээр аргадан тайвшируулав. Түүний айдсыг ийм хялбар тайвшируулж болдогсон бол. Тэр Шөнийн харуулын тас хар хувцастай урд ар талд нь дайснууд явж байв. Зэрлэгүүд би тэдэнтэй цуг явж байна. Игрит Мухар гарт Корины нөмрөгийг нөмөрчээ. Ленил гархин хуягийг нь, том жад эхнэр Рагвэйл бээлийг нь, харваачдын нэг гутлыг нь авчээ. Корины дуулгыг Урт жад Рик гэдэг намхан хүн хожсон ч хавчиг толгойд нь таарахгүй болохоор Игритэд мөн адил өгчээ. Харин Харжигнуур хүрэмт Корины ясыг Жонтой Хашгираа даваанд туршуулд хамт явж байсан Эббений цустай толгойн хамт хүүдийд хийн ганзаглажээ. *Надаас гадна бүгд үхсэн байхад би ертөнцөд байгаа хэрнээ үхсэн байна.*

Игрит түүний архан талд явлаа. Урд нь Урт жад Рик шогшино. Ясны лорд тэднээс хоёр хүнийг нь харуулд гаргажээ.

- Хэрвээ хэрээ зугтаавал би та нарын ясыг ч гэсэн чанана шүү гэж тэр тэднийг явахад анхааруулан толгойдоо угласан аварга биетийн гавлан дуулга дороос тахир шүдээрээ инээмсэглэжээ.

Гэсэн ч Игрит түүн рүү хашгирлаа.

- Чи түүнийг манахыг хүсээ юу? Хэрвээ чи биднийг үүнийг хийхийг хүсч байгаа бол явж үз. Тэгсэн хойно чинь хийе.

Тэд үнэхээр чөлөөт ард түмэн юм гэдгийг Жон харлаа. Харжигнуур хүрэмт тэднийг удирдаж байж болох ч нөгөөдүүл нь санасан зүйлээ урдаас нь хамаагүй хэлнэ.

Зэрлэгүүдийн удирдагч түүн рүү нөхөрсөг бус нүдээр цоо ширтэв.

- Магадгүй чи эднийг мунхруулсан байж болох ч Мансыг мунхруулна гэж бүү бодоорой, хэрээ минь. Тэр чамайг ганц хараад л худал хуурмагыг чинь мэдэх болно. Тэгээд үүнийг мэдэх үед би чонын арьсаар чинь нөмрөг хийж зөөлөн хүүхдийн гэдэс дотрыг чинь яран дотор нь үен хийж оёно.

Жон илд атгадаг гарынхаа түлэгдсэн хурууг бээлийн дотроо атгаж тэнийлгэсэн ч Урт жад Рик тачигнатал хөхөрлөө.

- Чи цасан дунд үен хаанаас олох гээ вэ?

Эхний шөнө урт өдрийн турш морин дээр явсны дараа тэд нэрийг нь үл мэдэх уулын орой дахь намхан чулуун хонхорт гал түлэн буудаллахад цас хялмаалан орж эхлэв. Жон хаялан орох цасан ширхэг галын дөлд хайлахыг харлаа. Тэр ноосон дээр арьс, шир давхарлан өмссөнөө үл харгалзан ясандаа хүртэл жиндэхийг мэдрэв. Игрит хоол идсэнийхээ дараа хажууд нь сууж юүдэнгээ босгон гараа ханцуй руугаа дулаацуулан шургууллаа.

- Манс чиний Мухар гартыг яасныг сонсвол дор нь авна даа.

- Юунд авна гэж? гэхэд тэр зэвүүцэнгүй инээлээ.

- Бидний нэг болгож. Чи өөрийгөө Хананаас доош ниссэн эхний хэрээ гэж бодоогүй биз дээ? Чиний бүхий л сэтгэл зүрх чөлөөтэй нисэхийг хүсч байсан.

- Хэрвээ би чөлөөтэй болвол сул явж болох уу? гэж Жон удаанаар асуухад Игрит тахир шүдээ үл харгалзан дулаахнаар инээмсэглэж,

- Тэгэлгүй яахав. Бид ч гэсэн чамайг чөлөөтэй алж болно. Чөлөөтэй байх аюултай ч олон хүн үүнийг амтлах дуртай гээд бээлийтэй гараа өвдөгний дээд талд нь хүргэлээ. - Чи үүнийг харах болно.

Би тэгнэ. Би харж, сонсож, суралцаж Хана руу буцахдаа үг дайн очих болно гэж Жон бодов. Зэрлэгүүд түүнийг оргон зайлагчаар хүлээж авсан ч сэтгэл зүрх нь Корины сүүлд оноосон үүргийг гүйцэтгэж байгаа Шөнийн харуулын хүн хэвээр байлаа. Миний түүнийг алахаас өмнөх.

Налуугийн ёроолд тэд толгодын хормойноос урсан Сүүн устай нийлж байгаа бяцхан горхийг гатлав. Энэ нь бүхэлдээ шилэн чулуу шиг харагдах ч хөлдүү гадаргын дор ус хоржигнон урсах сонсогдоно. Харжигнуур хүрэмт нимгэн мөс тачигнуулан тэдний урд тэргүүлэв.

Манс Райдерийн туршуулууд тэднийг ойртоход урдаас нь гарч ирэв. Жоны багцаалснаар арьс, ширээсэн ширэн хувцастай дуулга юм уу хуягны хэлтэрхий өмссөн эрэгтэй, эмэгтэй нийлсэн нийт найман хүн байлаа. Тэд жад, галд шовхолсон модоор зэвсэглэсэн ч удирдагч нь болох усархаг нүдтэй биерхүү цайвар үстэй хүн том тахир хурцалсан хадуураар зэвсэглэжээ. *Уйлагч байна* гэж Жон даруй мэдлээ. Хар ахан дүүс түүний тухай ярилцдаг байв. Харжигнуур хүрэмт, Нохойн

толгой Харма, Хэрээний алуурч Алфин нарын адил тэр алдартай морьтон байв.

- Ясны лорд. Энэ чинь хэн бэ? гэж Уйлагч тэднийг хараад хэлэхэд харц нь Жон, чоно хоёр дээр тусав.

- Ирсэн хэрээ гэж өмссөн харжигнадаг хуягаараа өөрийгөө Ясны лорд гэж дуудуулахыг эрхэмлэдэг Харжигнуур хүрэмт хэлэв.

- Тэр намайг ясыг нь Кориных шиг авахаас айж байгаа гээд хүүдийтэй олзоо бусад зэрлэгүүдэд сэгсрэн үзүүлэв.

- Тэр Мухар гарт Кориныг алсан. Тэр болон чонотойгоо цуг гэж Урт жад Рик хэллээ.

- Ореллийг ч гэсэн тэгсэн гэж Харжигнуур хүрэмт хэлэв.

- Залуу варг юм уу түүнтэй ойролцоо төстэй. Түүний чоно Мухар гартын хөлийг хазсан гэж том жад эхнэр Рагвэйл хажуунаас оролцов.

Уйлагчийн улаан нүд Жоныг ахин шинжин харав.

- Тийм үү? Намайг ойртож харвал чоно нь үсрээд ирэх биз. Түүнийг Мансад хүргэж өг магадгүй үлдээж мэднэ гээд морио эргүүлэн цогиулан одоход морьтонгууд араас нь гүйцэж ядан дагав.

Тэднийг Сүүн усны хөндийг гатлан голын дагуух буудлын дундуур нэг эгнээгээр цувран явахад нойтон хүнд салхи үлээнэ. Сүнс Жонтой ойрхон явсан ч чонын үнэрээр төдөлгүй зэрлэгүүдийн бүх ноход тэднийг тойрон цуглараад архирч чангаар хуцалдав. Ленил тэднийг чимээгүй болгохын тулд хашгиран зандарсан ч нэмэр болсонгүй.

- Тэдэнд энэ араатан чинийх эсэх нь хамаагүй бололтой гэж Урт жад Рик Жонд хэлэв.

- Тэд бол ноход харин энэ чоно. Тэд түүнийг төрөл нь биш болохыг мэдэж байгаа. *Миний та нартай байхаас өөрцгүй.* Гэвч тэр сүүлчийн түүдэг галаа хуваалцах үед Мухар гарт Корины өгсөн даалгавар болох урвагчийн дүрд тоглож зэрлэгүүдийн хахир хүйтэн Мөсөн соёотод юу хайж байгааг мэдэх ёстой байлаа. "Ямар нэг хүч" гэж Корин Хөгшин баавгайд хэлсэн ч Манс Райдерийн юу ухаж байгааг мэдэхээс урьд үхсэн билээ.

Голын дагуу бүхэлдээ сунасан тэрэг, хөсөг, чарган дунд хоолны түүдэг асна. Зэрлэгүүдийн ихэнхи арьс, шир, эсгий майхан босгожээ. Бусад нь хадны ард бүдүүлэг хаалт босгох юм уу тэрэгнийхээ дор унтана. Нэг галд Жон эрэгтэй хүн галд урт модон жад шовхолж хурцлан овоолохыг харлаа. Өөр нэг газар ширээсэн ширэн хувцастай ацан сахалтай хоёр залуу модон саваагаар тулалдан нэг нэгэн рүүгээ гал дээгүүр харайж бие биенээ цохих тоолон хуухитнана. Ойролцоо нь арваад эмэгтэй дугуйран суугаад сум өдөлж байлаа.

Миний ах дүү нарыг харвах сум. Миний эцгийн хүмүүс Винтерфелл, Моттын гүн ой, Эцсийн голомтын хүмүүсийг харвах сум. Умардыг харвах сум гэж Жон бодлоо.

Гэвч түүний харсан бүхэн дайны байдалд байсангүй. Эмэгтэйчүүд бүжиглэн, нялх хүүхэд уйлж, бяцхан хүү мориных нь урд гүйн, арьсан дээлтэй багачууд ааг амьсгаагүй тоглоцгооно. Хонь ямаа сул тэнэж, голын эрэг дагуу шар үхэр өвс хайн идээшилнэ. Шарсан хонины махны үнэр нэг түүдгээс ханхалж байхад өөр нэг түүдэгт ацанд шорлосон бодон эргүүлж байлаа.

Өндөр ногоон нарсаар хүрээлүүлсэн задгай чөлөөнд Харжигнуур хүрэмт мориноос буув.

- Бид энд буудаллана. Морьд, нохдоо тэжээн өөрсдийгөө ч гэсэн хоолло. Игрит, Урт жад хоёр хэрээг Мансад аваачиж өг. Бид дараа нь гэдсийг нь хүүлнэ гэж Ленил, Рагвэйл болон бусад хүмүүст хэлэв.

Тэд замын үлдсэн хэсгийг явган туулж түүдэг гал, майхнуудын дундуур өнгөрөхөд Сүнс араас нь өсгий даран шогшив. Жон хэзээ ч ийм их зэрлэгүүдийг харж байсангүй. Тэр ер нь харсан хүн бий эсэхэд гайхлаа. *Хязгааргүй үргэлжлэх буудал. Гэвч нэгээс зуу дахин их мөртлөө тус бүр нь сүүлчийнхээсээ илүү эмзэг.* Олон бээр сунан үргэлжилсэн зэрлэгүүдэд хамгаалалтын тухай ярих ч хэрэг байсангүй. Хурцалсан гадас зоож, шуудуу ухаагүй зөвхөн багахан хэмжээний бүлэг морьтонгууд орчны нутаг дэвсгэрийг харгалзана. Бүлэг, отог, тосгон бүр хүссэн газраа буудаллах бөгөөд төдөлгүй өөр газар олж хараад нүүж байлаа. Чөлөөт хүмүүс. Хэрвээ ах дүүс нь тэднийг сандраах юм бол тэдний олонхи эрх чөлөөнийхөө хариуг цусаараа төлөх болно доо. Тэд олуулаа хэдий ч Шөнийн харуулынхан сахилга баттай болохоор байлдааны эмх журам өөрөөсөө арав дахин дайсныг дийлдэг гэж эцэг нь урьд нь түүнд ярьжээ.

Хааны майхан алин эсэхэд эргэлзээ байсангүй. Энэ нь дэргэд орших майхангуудаасаа гурав дахин том бөгөөд дотроос нь хөгжим уянгална. Бусад майхнууд малын арьс зүйж хийсэн байтал Манс Райдерийн майхан цагаан баавгайн сэгсгэр цагаан арьс байв. Дээврийнх нь оройд Анхны хүмүүсийн үед долоон ханлигийн нутагт чөлөөтэй хэсүүчилдэг байсан аварга хандгайн нүсэр том эвэр зоожээ.

Ядахдаа энд хамгаалагчид тааралдахад майхны сөхүүрийн хаяанд гартаа суран оосортой дугуй ширэн бамбай барьсан хоёр харуул өндөр жад бөхийлгөн зогсож байв. Тэд Сүнсийн барааг хармагц нэг нь жадны үзүүрээ бөхийлгөөд,

- Наад араатнаа энд үлдээ гэв.

- Сүнс үлд гэж Жон тушаахад зэрлэг чоно оцойн суулаа.

- Урт жад араатныг харж байгаарай гээд Харжигнуур хүрэмт майхны үүдийг угзарч онгойлгон Жон, Игрит хоёрыг ор гэж дохив.

Майханд бүгчим халуун утаатай байлаа. Дөрвөн хаяанд нь шатаж буй хүлэртэй суулга тавьсан нь агаарт бүүдгэр улаан өнгөөр суунаглана. Шалан дээр ангийн арьс үс тараан хаялжээ. Жон энд цорын ганц хар хувцастайгаа мэдэрч өөрийгөө Ханын цаадах хаан гэж дууддаг урвагчийн тааллыг хүлээв. Түүний нүд утаатай улаан бүрэнхийд дасахад дотор зургаан хүн байснаас тэдний хэн ч түүнд анхаарал хандуулсангүй. Хар үстэй залуу, хөөрхөн шаргал хүүхэн хоёр эвэртэй бал хуваалцана. Зуухны дэргэд жирэмсэн эмэгтэй зогсоод шортой тахиа эргүүлэхэд, улаан нөхөөстэй

үнгэгдсэн хар нөмрөгтэй буурал үстэй хүн жинтүүн дээр хөлөө зөрүүлж суугаад пийпаа тоглон дуулж байв.

Дорнишийн эхнэр нар шиг үзэсгэлэнтэй

Үнсэлт нь хавар шиг дулаахан ч

Дорнишийн эрийн илд хар төмөр

Үнсэлт нь хахир хатуу

Жон дууг мэдэх ч дулаахан сэвшээ салхитай Дорнын улаан уулсаас арван мянган бээрийн хол зайд Ханын цаана нэвсгэр арьсан майханд сонсох нь хачин хэрэг байлаа.

Харжигнуур хүрэмт шарласан дуулгаа авч дуу дуусахыг хүлээлээ. Тэр ширэн дээр зүйсэн ясан хуягныхаа дотор жижигхэн хүн бөгөөд аварга биетийн гавалд далдалсан царай нь ёрдгор эрүүтэй ердийн, шингэн сахал шарлангуй хонхойсон хацартай байлаа. Түүний нүд ойрхон нэг хөмсөг нь духан дээгүүрээ зурайж үсний уулзвараас шингэн хар үс арагш унжжээ.

Дорнишийн эхнэр усанд орохдоо дуулахад

Хоолой нь лийр шиг амттай ч

Дорнишийн эрийн илд өөрийнхөөрөө дуулж

Хазалт нь хануур хорхой шиг хури хүйтэн

Зуухны дэргэд тагдгар өргөн биетэй хүн сандал дээр суугаад шорлосон тахиа идэж байв. Халуун шүүс эрүүг нь даган цасан цагаан сахал руу нь урсахад тэрбээр баяртай инээмсэглэнэ. Булчинлаг гартаа дүрс бичиг сийлбэрлэсэн бүдүүн алтан бугуйвч зүүж үхсэн эргүүлээс дээрэмдсэн хүнд хар гархин хуяг өмссөн байв. Түүнээс хэдхэн алхамын зайд хүрэл гархи оёсон ширэн хүрэмтэй өндөр туранхай хүн газрын зураг руу хөмсөг зангидан зогсоод нуруундаа ширэн хуйтай хоёр гараар атгадаг их илд зүүжээ. Тэр жад шиг шулуухан агаад арзайсан урт сахалтай, цэвэрхэн хуссан халзан толгой хүчирхэг шулуун хамар гүн саарал нүдтэй байлаа. Хэрвээ чихтэй байсан бол хамаагүй дээр харагдах ч хоёуланг нь жаварт хайруулсан юм уу дайсны хутганд алдсаны алин эсэхийг Жон мэдсэнгүй. Тэдний үгүйд толгой нь хавчиг нарийхан мэт санагдана.

Цагаан сахалт болон халзан толгойтой хүн хоёр дайчин болох нь Жон ганц харахад илт байв. Энэ хоёр Харжигнуур хүрэмтээс хамаагүй аюултай буй за. Жон тэдний аль нь Манс Райдер болохыг гайхлаа.

Тэр газар хэвтээд эргэн тойрон харанхуй хүрээлэн

Хэлэнд нь цус амтагдана

Ах дүүс нь дэргэд өвдөг сөгдөн мөргөн гуйхад

Инээмсэглэн хөхөрснөө дуулжээ

Ах дүүс минь, ай даа ахан дүүс минь миний өдрүүд энд дуусч

Дорнишийн эр амийг маань авлаа

Гэсэн ч нэгэнт бүх хүн үхэх ёстойгоос хамаагүй

Би Дорнишийн эхнэрийг амталж үзсэн!

Сүүлчийн хөг "Дорнишийн эхнэр" дээр бөхөхөд халзан толгойтой чихгүй хүн газрын зурагнаас өндийн Жонтой зогсож байгаа Харжигнуур хүрэмт, Игрит хоёрыг ууртай хялалзав.

- Энэ чинь юу юм? Хэрээ юу? гэхэд,

- Ореллийг алсан хар новш. Дээрээс нь хараал идсэн варг гэж Харжигнуур хүрэмт хэлэв.

- Чи тэднийг бүгдийг нь алах ёстой байсан юм.

- Энэ бидэн рүү ирсэн. Тэр Мухар гарт Кориныг өөрийн гараар алсан гэж Игрит тайлбарлахад чихгүй хүн үүнийг сонсоод ихээхэн хилэгнэв бололтой,

- Энэ хүү юу? Корин минийх болох ёстой байсан юм. Чиний нэрийг хэн гэдэг юм, хэрээ минь? гэж зандрав.

- Жон Сноу, эрхэм дээдсээ гээд Жон өвдөг сөгдөх ёстой эсэхээ мэдсэнгүй.

- Эрхэм дээдсээ гэнэ ээ? Харж байна уу. Тэр намайг хаан гэж бодож гээд чихгүй хүн том цагаан сахалтай хүн рүү харлаа.

Сахалтай хүн тачигнатал хөхрөхөд тахианы махны өөдөс хаа сайгүй үсчив. Тэр амнаасаа савиран урссан тосыг том гарынхаа араар арчлаа.

- Тэгвэл сохор хүү байх нь. Чихгүй хаан байдаг гэж хаанаас сонссон хэрэг вэ? Титэм нь тогтохгүй хүзүү рүүгээ унана биз дээ! гээд Жон руу инээн хуруугаа цэвэрлэн өмдөндөө арчив. - Хошуугаа хамхи, хэрээ минь. Эргээд харвал чи магадгүй хайж байгаа хүнээ олох биз.

Жон эргэхэд дуучин хөл дээрээ босож пийпаагаа хажуу тийш тавилаа.

- Би Манс Райдер байна. Харин чи Винтерфеллийн Нэд Старкийн бутач Сноу юу?

Жон тэвдсэндээ хэлэх үггүй болсон ч сэхээ ормогц,

- Та яаж... яаж мэдээ вэ гэлээ.

- Энэ тухай дараа ярилцъя. Чамд энэ дуу таалагдав уу? гэж Манс Райдер хэлэв.

- Таалагдсан. Өмнө нь сонсож байсан юм байна.

- *Гэхдээ нэгэнт бүх хүн үхэх ёстойгоос хамаагүй би Дорнишийн эхнэрийг амталж үзсэн гэж Ханын цаадах хаан хөнгөн өгүүлээд,*

- Надад хэлээч Ясны лорд үнэн ярьж байна уу? Чи миний хуучин анд Мухар гартыг алаа юу? гэлээ.

- Би тэгсэн. *Минийхээс илүү түүний хийсэн ажил гэж бодож байна.*

- Сүүдэрт цамхаг ахин хэзээ ч айдас төрүүлэм болохгүй нь дээ гэж хаан гунигтай хоолойгоор хэлээд,

- Корин миний дайсан байсан. Гэвч урьд нь үүний зэрэгцээ ах дүү минь байсан юм. Тэгэхээр... би чамайг түүнийг алсанд талархах ёстой юу, Жон Сноу? Эсвэл хараах ёстой юу? гээд Жоныг шоолонгуй инээмсэглэв.

Ханын цаадах хаанд хаантай байтугай зэрлэгтэй төстэй ямар ч зүйл байсангүй. Тэр дунд зэргийн нуруутай гоолиг, гярхай бор нүдтэй ясархаг царай бууралтаж яваа урт хүрэн үстэй байв. Толгойд нь титэм, гарт нь алтан бөгж, хоолойд нь үнэт чулуу битгий хэл мөнгөн эдлэл байсангүй. Тэр ноосон дээр ширэн хувцас өмсч урагдсан урт цоорхойг нь гандсан улаан торгоор нөхсөн ноорхой хар нөмрөг эгэлдэргэлжээ.

- Та надад дайсныг чинь алсны төлөө талархаж нөхрийг чинь алсны төлөө хараах ёстой гэж Жон эцэст нь хэллээ.

- Ха! Сайн хариуллаа! гэж цагаан сахалт хүнгэнүүлэв.

- Зөвшөөрч байна гээд Манс Райдер Жон руу ойртон бөхийв.

- Хэрвээ чи бидэнтэй нэгдэх гэж байгаа бол мэдэж авсан чинь дээр. Чиний миний оронд андуурсан хүнийг Смир, Тэннийн Магнар гэдэг юм. Магнар гэдэг нь хуучны хэлээр “лорд” гэж байгаа үг гэхэд чихгүй хүн Жон руу хүйтнээр ширтсэнд Манс цагаан сахалтай хүн рүү эргэлээ.

- Манай аймшиггүй тахиа идэгч бол миний үнэнч Тормунд байгаа юм. Харин тэр эмэгтэй... гэхэд Тормунд хөл дээрээ бослоо.

- Хүлээгээрэй. Чи Стирийг бүх цолоор нь хэлсэн байж минийхийг ч гэсэн хэлж аль гэхэд Манс Райдер хөхөрлөө.

- Чинийхээр болог. Чиний өмнө Аварга биетийг дарагч, Өндөр яригч, Бүрээ үлээгч, Мөс хагалагч Тормунд зогсож байна. Үүний зэрэгцээ Аянган нударгат, Баавгайн нөхөр, Улаан өргөөний Балын хаан, Бурхадтай яригч, Бүгдийн эцэг Тормунд гэдэг.

- Наадах чинь одоо л надтай төстэй сонсогдож байна. Сайхан танилцлаа, Жон Сноу. Энэ Старкийнханд тохиогоогүй бол би варгад дуртай гэж Тормунд хэлэв.

- Зуухны дэргэд байгаа үзэсгэлэнт эмэгтэйг Далла гэдэг гэж Манс Райдер үргэлжлүүлэхэд жирэмсэн эмэгтэй ичингүйрэн инээмсэглэв.

- Түүнтэй хатны ёсоор харилцаарай хүүхдийг минь тээж яваа юм гээд сүүлчийн хоёр хүн рүү эргэж,

- Харин энэ хөөрхөн хүүхэн бол түүний эгч Вал. Түүний дэргэд сүүлд тэжээсэн залуу Жарл сууж байна гэхэд,

- Би ямар ч хүний тэжээвэр биш гэж Жарл баргар догшин хэллээ.

- Тэгвэл Валд эр хүн байхгүй. Чи одоо үүнийг ажигласан байх, залуу минь гэж цагаан сахалтай Тормунд тургилав.

- Тэгэхээр чи бидэн дээр ирсэн байх нь, Жон Сноу. Ханын цаадах хаан болон бас бус ордонд нь. Харин одоо чамаас үг сонсох ээлж гэж бодож байна. Ингэхэд чи хаанаас ирээ вэ? гэж Манс Райдер асуулаа.

- Винтерфеллээс Хар цамхаг руу очсон.

- Тэгвэл юу чамайг орон гэрийн гал голомтноос чинь хол Сүүн ус руу авчирав? гээд Манс Жоны хариулахыг хүлээсэнгүй Харжигнуур хүрэмт руу харж,

- Тэд хэдүүлээ байсан бэ? гэв.

- Тавуул. Гурав нь үхэж хүү энд байгаа. Харин нөгөөдөх нь ямар ч морь өгсөж чадахгүй уулын хажуу өөд мацсан гэхэд Райдерийн нүд Жонхтой ахин тулгарав.

- Зөвхөн тавуул байсан юм биз дээ? Эсвэл өөр ахан дүүс чинь хаа нэгтээ далд байгаа юу?

- Бид Мухар гарттай дөрвүүл байсан. Корин энгийн хорин хүнтэй тэнцэнэ гэхэд Ханын цаадах хаан инээмсэглэв.

- Зарим нь тэгж боддог л юм. гэсэн ч... Хар цамхагаас ирсэн хүү Сүүдэрт цамхагын эргүүлүүдтэй явж байдаг? Хаанаас ийм зүйл болоо вэ?

Жон худал хэлэхэд аль хэдийн бэлтгэжээ.

- Захирагч лорд намайг Мухар гарт руу сургахаар явуулахад эргүүлдээ авч явсан юм гэхэд Магнар хөмсөг зангидав.

- Эргүүл хийх гэнэ ээ?... Ямар учраас хэрээнүүд Хашгираа даваа руу эргүүл хийхээр ирдэг билээ?

- Тосгонууд хоосорч бүх чөлөөт хүмүүс алга болсон байсан гэж Жон үнэнээ өчив.

- Алга болсон, тийм. Гэвч зөвхөн чөлөөт хүмүүс ч биш. Ингэхэд биднийг энд байгаа гэж хэн чамд

хэлээ вэ, Жон Сноу? гэж Манс Райдер тулгахад,

- Энэ Крастер биш байвал би ичимхий охин болог. Манс би чамд тэр амьтаны толгойг мухарлах хэрэгтэй гэж хэлсэн биз дээ гээд Тормунд тургилав.

Хаан хижээл хүн рүү уурсангуй ширтлээ.

- Тормунд чи заримдаа ярихын өмнө үгээ бодож байсан нь дээр шүү. Би Крастер болохыг мэдэж байсан. Би зөвхөн Жоноос үнэн хэлэхийг нь харахын тулд асуусан юм.

- Ха гээд Тормунд нулимлаа.

- Тэгвэл би үүнийг чинь баллачихаж! гээд Жон руу инээж,

- Харж байна уу залуу минь яагаад түүний хаан байхад миний хаан биш болохыг. Би түүнээс хавьгүй илүү ууж, зодолдож, сайн дуулж гурав дахин том биетэй байж болох ч Манс зальтай. Түүний хэрээ болон өссөнийг чи мэднэ. Харин хэрээ бол овжин амьтан гэв.

- Би энэ залуутай ганцаарчилан ярилцмаар байна, Ясны лорд минь. Та нар бүгд биднийг орхи гэж Манс Райдер Харжигнуур хүрэмтэд хэллээ.

- Юу гэнээ би ч гэсэн үү? гэж Тормунд дуу алдав.

- Тийм, ялангуяа чи гэж Манс хэллээ.

- Би урин зочлохгүй газар идэхгүй. Миний бие эндхийг тахиатайгаа орхилоо гээд Тормунд хөл дээрээ өндийн зуухнаас ахин нэг тахиа авч нөмрөгнийхөө халаасанд чихээд,

- Ха хэмээн хуруу руугаа гоожсон шүүсийг долоов. Түүний араас бусад нь даган гарсан ч Далла гэдэг эмэгтэй үлдэв.

- Хүсвэл, сууж болно. Чи өлсч байна уу? Тормунд ядахдаа бидэнд хоёр шувуу үлдээсэн байна гэж Райдер тэднийг гарсан хойно хэллээ.

- Идвэл талархах байна, эрхэм дээдсээ. Баярлалаа.

- Эрхэм дээдсээ гэнэ ээ? гээд хаан инээмсэглэв.

- Энэ чинь чөлөөт хүмүүсийн амнаас төдийлөн сонсдоггүй үг байна. Би тэдний ихэнхийн хувьд Манс. Чи эвэртэй бал уух уу?

- Дуртайяа гэж Жон хэллээ.

Хаан өөрийн биеэр бал аягалж өгөхөд Далла шаргалттал шарсан тахиа хуваан хоёуланд нь тус бүр хагасыг өгөв. Жон бээлийгээ тайлж хуруугаараа барин идээд үлдсэн ясыг нь мөлжлөө. Манс Райдер бүтэн талх хэлтлэн хуваав.

- Тормунд үнэн хэлсэн. Хар хэрээ бол овжин шувуу хэдий ч... гэхдээ би чамайг Даллагийн гэдсэнд байгаа хүүхдээс томгүй байхад хэрээ болсон юм, Жон Сноу. Иймээс надтай зальжин тоглох гэж бүү оролдоорой доо.

- Таны хэлснээр болог, эрхэм... Манс гэхэд хаан хөхөрлөө.

- Эрхэм Манс! гэнэ ээ? Яагаад үгүй гэж? Би чамд нэрийг чинь хэрхэн мэдсэнээ ярьж өгөхийг амласан байхаа. Чи тааварлаагүй л байна уу?

- Харжигнуур хүрэмт урьдчилж үг илгээсэн юм болов уу? гээд Жон толгой сэгсэрлээ.

- Шувуугаар уу? Бидэнд сургуультай хэрээ байхгүй. Үгүй дээ, би царайгаар чинь таньсан юм. Би урьд нь чамайг хоёр ч удаа харж байсан.

Энэ нь түүнийг балмагдуулахад Жон хамаг ухаанаа онгичлоо.

- Та Харуулын ахан дүү байхдаа...

- Маш сайн байна! Тийм энэ бол анхны удаа байсан юм. Чамайг жаахан хүүхэд байхад би Винтерфеллд эцэгтэй чинь уулзахаар ирсэн захирагч лорд Коргилийн арван бараа бологсдийн нэг болон хар хувцастай ирж байлаа. Би хашаан дахь хэрмийн дээгүүр алхаж явахдаа чамтай болон дүү Роббтой чинь тааралдсан юм. Урьд шөнө цас орсон болохоор та хоёр хаалган дээр том цасан бөмбөлөг босгож дор нь хүн өнгөрөхөд унагаахаар зэхэж байсан гэхэд,

- Би санаж байна. Залуухан хар ахан дүү хэрмийн дээрх замаар явж байсан, тийм... Та хэнд ч хэлэхгүй гэж амласан гээд Жон инээд алдлаа.

- Тэгээд амлалтаа биелүүлсэн. Ядаж л түүнийг.

- Бид цасаа Бүдүүн Том руу унагасан. Тэр эцгийн маань харуулын хамгийн удаан хүн байсан гээд дараа нь Том гурвуул намрын алим шиг улайтал тэднийг араас нь хашаанд хөөн гүйжээ.

- Гэхдээ та намайг хоёр удаа харсан гэж хэлсэн. Нөгөөдөх нь хэзээ юм бэ?

- Роберт хаан Винтерфеллд эцгийг чинь Гар болгохоор ирэх үед гэж Ханын цаадах хаан энгүүн хэлэв.

Жоны нүд үл итгэсэндээ томорлоо.

- Байж боломгүй юм.

- Тэгсэн. Эцэг чинь хаан ирж байгаа тухай мэдээд Ханан дээр байсан дүү Бэнжиндээ үг илгээж найранд оролцохыг урьсан юм. Хар ахан дүүс болон чөлөөт ардууд хоорондоо арилжаа хийдэгийг чи эс андах хойно энэ тухай удахгүй миний чихэнд хүрсэн. Энэ бол татгалзахын аргагүй сонголт байлаа. Чиний авга ах намайг харж байгаагүй болохоор би өчүүхэн төдий ч айсангүйн дээр эцэг чинь олон жилийн өмнө хальт тааралдсан залуу хэрээг санана гэж бодохгүй байлаа. Би энэхүү

Робертийг өөрийн нүдээр харж хаантай хаан тулан авга ах Бэнжинийг чинь ч гэсэн шинжихийг хүссэн юм. Тэр Эргүүлийн ахлагч болсон болохоор миний хүмүүст багагүй төвөг удаж байлаа. Иймээс би хамгийн хурдан морио эмээллэж мордсон юм.

- Гэхдээ Хана... гэж Жон эсэргүүцэв.

- Хана армийг зогсоож болох ч ганц хүнийг зогсоохгүй. Би хүүдий зоос, пийпаа авч Урт Хиргисүүрийн ойролцоох мөсөн дээгүүр гаран өмнө зүг Шинэ Бэлэг рүү хэдэн бээр явган алхаж морь худалдаж авсан. Энэ бүхнийг хатны ая тухын тулд дугуйтай нүсэр тэргээр аялж яваа Робертоос хамаагүй хурдан хугацаанд амжуулсан юм. Би өмнө зүг Винтерфелл рүү явах замдаа түүний бараа бологсодтой таарсан. Чөлөөт морьтонгууд болон хэрмэл хүлэг баатрууд үргэлж хааны цуваанд багтдаг болохоор миний хаанд зүтгэх найдлага олох горьдлогыг пийпаа минь хялбархан олгосон гээд Манс инээлээ.

- Би Хананаас өмнө, хойд зүгт зохиогдсон бүх завхай дууг мэднэ. Тэнд чи байсан. Эцэг чинь Роберт хаанд зориулан найр хийдэг шөнө би танхимын ард вандан дээр бусад чөлөөт морьтонгуудын хамт суугаад Хуучин хотын Орланд өндөр ятгаар тоглон тэнгисийн ёроол дахь үхсэн хаадын тухай дуулахыг сонсож байлаа. Би лорд эцгийн чинь мах балыг хуваалцан Хааны алуурч, Бяцхан чөтгөрийг харахдаа лорд Эддардын хүүхдүүд өсгийнөөсөө чонын бэлтрэг дагуулан явахыг анзаарсан юм.

- Үлгэрч Бард гэж Жон Игритийг бараг алах шахсан шөнө Мөсөн соёотод ярьсан үлгэрийг санаад хэллээ.

- Наадах чинь байхгүй юу. Бэйлийн гавъяа намайг зоригжуулсныг үгүйсгэхгүй ч охин дүү нарын чинь хэнийг ч хулгайлаагүй. Бэйл өөрийнхөө дууг зохиож түүгээрээ амьдардаг байсан юм. Би зөвхөн дууг зохиосон хүнээс нь илүү сайн дуулсан. Ахиад бал уух уу?

- Үгүй. Хэрвээ та тэгэхэд илэрч... баригдсан бол... гэж Жон хэлэв.

- Эцэг чинь миний толгойг авах байсан гээд хаан мөрөө хавчив.

- Гэсэн ч би түүний ширээнээс идэж зочны эрхийн дагуу хамгаалалтанд байлаа. Зочлох ёсны хууль Анхны хүмүүс шиг эртний, зүрх мод шиг ариун гээд Манс дунд нь байгаа хуваасан талх, тахианы ястай тавиур руу дохив.

- Энд чи зочин болж ирсэн болохоор миний гарт аюулгүй байх болно... Ядахдаа энэ шөнө. Иймээс надад үнэнийг хэл, Жон Сноу. Чи айсандаа нөмрөгөө буруулсан хулчгар уу эсвэл чамайг миний майханд авчирах өөр шалтгаан байгаа юу?

Зочны эрхийн дагуу ч бай үгүй ч бай Жон Сноу өмхөрсөн мөсөн дээр явж буйгаа мэдэж байлаа. Ганцхан буруу алхам хийхэд дотогш цөмрөн хүйтэн ус зүрхийг нь царцаана. *Ярихын өмнө үг бүрээ цэгнэ* гэж өөртөө сануулав. Тэр хариулах хугацаа хожихын тул балнаас удаанаар балгалаа. Ингээд эврийг тавьж,

- Надад яагаад нөмрөгөө буруулсан учраа хэлвэл би өөрийнхийгөө хэлье гэв.

Жоны найдсан ёсоор Манс Райдер инээмсэглэлээ. Хаан өөрийнхөө хоолойд дуртай энгийн хүн байв.

- Чамайг миний оргон зайлсан түүхийг сонссон гэхэд эргэлзэх юм алга.

- Зарим нь титмийн төлөө. Зарим нэг нь хүүхний төлөө гэдэг. Бусад нь зэрлэгийн цустай болохоор тэр гэдэг.

- Зэрлэгүүдийн цус бол Анхны хүмүүсийн цус болохоор Старкийнхны судсаар гүйж буй цустай ижил. Титмийн хувьд чи олж харав уу?

- Би эмэгтэйг харсан гээд Жон Далла руу ширтлээ. Манс түүний гараас атган ойртуулан татав.

- Миний хатагтай үүнд буруугүй. Би түүнтэй эцгийн чинь шилтгээнээс эргэн ирсэн хойно учирсан юм. Кориныг хөгшин царсаар сийлбэрлэсэн байж болох ч би мах цуснаас бүрдсэн хүн болохоор эмэгтэй хүний увидаст туйлын дуртай ч ахан дүүсээс өчүүхэн төдий ялгаагүй. Хар хувцас өмссөн хүмүүс хөөрхий хаанаас арав дахин илүү хүүхэнтэй байдаг. Чи ахин таах болж дээ гэхэд Жон хурамхан зуур бодлогоширлоо.

- Корин таныг зэрлэгүүдийн хөгжимд дуртай гэсэн.

- Тиймээ, би дуртай. Наадах чинь арай дөхөж байна. Гэхдээ оносонгүй гээд Манс Райдер босч нөмрөгнийхөө чагтыг тайлаад сандал дээр тавилаа.

- Энэ бол үүнээс болсон хэрэг.

- Нөмрөгнөөс үү?

- Шөнийн харуулын Тангарагт ахан дүүсийн хар ноосон нөмрөг. Нэг өдөр бид эргүүлд явж байхдаа том хандгай унагаалаа. Биднийг өвчиж байх үед цусны үнэрээр сүүдэрт муур ичээнээсээ гарч ирсэн юм. Би түүнийг унагасан ч нөмрөгийг минь урж амжсан. Харж байна уу? Энд байна гээд мушийлаа.

- Миний гарын ар бас зүсэгдэж хандгайнаас ч долоон дор цус алдлаа. Ахан дүүс минь намайг Сүүдэрт цамхагийн мэйстер Малин руу аваачихаас өмнө үхнэ гэж айсан болохоор анагаах чадвартайг нь мэддэг хөгшин цэцэн эмэгтэй байдаг зэрлэгүүдийн тосгон руу аваачсан юм. Тэр талийгаач болсон байсан ч охин нь намайг домнолоо. Шархыг маань угааж цэвэрлэн оёод намайг ахин морин дээр ахин мордох чадалтай болох хүртэл будаа, ханд өгсөн. Тэр нөмрөгний маань уранхайг оёж өгөхдөө эмээгийнх нь суусан онгоц Хөлдүү эрэгт сүйрэх үед Ашайгаас авч гарсан улаан торгоор нөхсөн юм. Энэ нь түүнд байсан хамгийн үнэт эрдэнэс ч надад бэлэглэсэн юм даа гээд Манс нөмрөгөө мөрөн дээгүүрээ тохлоо.

- Гэсэн ч би Сүүдэрт цамхагт очоод агуулахаас хар эмжээртэй шинэ ноосон нөмрөг хүлээн авч хар өмд, гутал, хантааз, хар гархин хуяган дээрээ өмссөн. Шинэ нөмрөг урагдаж ноороогүй бүтэн

байсан ч улаан тууз байсангүй. Шөнийн харуулын хүн хараар хувцаслах ёстой гэж сэр Денис Маллистер намайг мартахад ширүүнээр сануулсан билээ. Тэр миний хуучин нөмрөгийг шатаахаар өгсөн гэж хэлсэн.

- Тэгсэн ч би маргааш өглөө нь хүн хүссэн нөмрөгөө өмсөх гэмт хэрэг биш болдог газар луу явсан юм гээд Манс нөмрөгөө чагтлан ахин буцаж суулаа.

- Харин чиний хувьд гэвэл, Жон Сноу?

Жон ахин бал залгилав. *Энд түүний итгэх ердөө ганцхан түүх байна.*

- Та эцгийн минь Роберт хаантай найрладаг шөнө Винтерфеллд байсан гэж хэлсэн.

- Тиймээ тэгж хэлсэн.

- Тэгвэл биднийг харсан биз дээ. Ханхүү Жоффри, ханхүү Томмен, гүнж Мирцелла, миний ах дүүс Робб, Бран, Рикон болон охин дүү Арьяа, Санса гээд л. Та тэднийг сандлын төв жигүүр дундуур алхан хаан хатан хоёрын суусан тавцангийн доод талын ширээнд суудал эзлэхэд бүгдийн нүд туссаныг харсан.

- Би санаж байна.

- Тэгвэл намайг хаана суусныг харсан уу? Тэдний бутчийг хаана тавьсаныг харсан уу? гээд Жон урагш бөхийлөө.

Манс Райдер Жоны царай руу удтал ширтсэнээ,

- Бид чамд шинэ нөмрөг олж өгсөн нь дээр гэж бодож байна гээд хаан гараа сунгав.

ДАНЕРИС

Бөмбөрийн удаан хэмнэлээр цохих, онгоцны сэлүүр сулхан исгэрэх чимээнд хөх ус битүү цэнхэртэнэ. Нүсэр дарвуулт хөлөг хоёр онгоцны дундах бүдүүн татлаганд чахран чирэгдэнэ."Балерион"-ы далбаа шурганаас үрчийн унжжээ. Тэгсэн ч Данерис онгоцны хитэг дээр зогсоод үүлгүй цэнхэр тэнгэрт луунууд нь бие биентэйгээ хөөцөлдөхийг харж урьд өмнө байгаагүй их жаргалтай байлаа.

Дотракичууд тэнгисийг хортой ус гэж нэрлэх бөгөөд морьдоо итгэн усалдаггүйн зэрэгцээ унданд хэрэглэдэггүй байв. Картаас гурван хөлөг онгоц зангуугаа өргөн гарсан өдөр тэднийг Пентосын оронд тамын орон руу хөдөлсөн гэж бодож болохоор байлаа. Түүний зоригт залуу цусан морьтонгууд алслан холдох эрэг рүү том цагаан нүдээр ширтэн гурвуул нэг нэгэндээ айдсаа үзүүлэхгүй байхыг хичээхэд гарын зарц Ирри, Жикүй хоёр хашлаганаас цөхрөн зууралдаж өчүүхэн төдий ганхах тоолон огиж байв. Данигийн үлдсэн бяцхан каласар газрын хөрснөөс холдон хөлгүй усанд онгоцон дээр гарсандаа түгшсэн морьдтойгоо тавцангын дор цуг байрлахыг эрхэмлэжээ. Тэдний зургаадах өдрийн аян дээр гэнэтийн шуурга тохиоход Дани нээлхийний завсар морьд тийрэн янцгаах, морьтонгууд "Балериан"-ыг чичирэн савлах тоолон чичирсэн нарийхан хоолойгоор мөргөх дууг сонсчээ.

Шуурга Даниг айлгаж чадсангүй. Түүнийг алс тэртээ Лууны цохионд Вестеросын түүхэнд хамгийн агуу шуурга тохиож шилтгээний ханан дээрх чулуун луунуудыг ховхлон хаяж эцгийнх нь флот хавиралдан сүйрэх үед мэндэлсэн болохоор Данерис Шуурганаар төрөгч гэдэг билээ.

Уйтан тэнгис үргэлжид шуургатай байдгийн зэрэгцээ Дани жаахан байхдаа булаан эзлэгчийн хөлсөлсөн хутганаас нэг алхамын урд Чөлөөт хотуудын нэгнээс нэг рүү зугтан тэнгисийг хагас зуугаад удаа гаталжээ. Дани тэнгист дуртай байв. Тэр агаарт ханхлах хурц давсны үнэр, хөх цэнхэр тэнгэрээр хязгаарлагдсан уудам цэлийх хаяанд дуртай. Энэ нь түүнд өчүүхэн мэт санагдуулахын зэрэгцээ эрх чөлөөтэйгээ мэдрэхэд хүргэнэ. Түүнчлэн "Балерион"-ы хажууд заримдаа даган хурдлах дельфин, давалгааг мөнгөн жад мэт нэвт зүсэн агаарт гялсхийн үсэрдэг нисдэг загас таалагдана. Тэр ч байтугай далайчид тэдний дуу, хууч ярианд дуртай байлаа. Урьд нь нэг удаа Бравосоос аялах үед шуурган дунд тэмцэлдэн том ногоон далбаа буулгахыг харж далайчин байх ямар сайхан хэрэг вэ гэж боджээ. Гэвч энэ тухайгаа ахдаа хэлэх үед Висерис үсийг нь дуу алдтал мушгин,

- Чи бол лууны цустай. Луу болохоос өмхий загас биш гэж хашгирсан билээ.

Тэр энэ тухайд болон өөр бусад зүйлсэд тэнэг байж. Хэрвээ тэр ухаантай илүү тэвчээртэй байсан бол өрнө зүг хууль ёсны хаан ширээгээ авахаар хөдлөх байсан гэж Дани бодлоо. Висерис тэнэг, харгис байсан болохыг Данерис ойлгож байсан ч заримдаа түүнийг үгүйлнэ. Хожим хэрцгий сул дорой хүн болохоосоо урьд ах нь заримдаа шөнө ор руу нь ирж Долоон ханлигийн тухай, титмээ хүртэхэд тэдний амьдрал хэрхэн дээшлэх тухай ярьж өгдөг хүү байв.

Хөлгийн ахмад тохойных нь дэргэд ирлээ.

- "Балерион" нэр шигээ нисэж чадахгүй нь харамсалтай, эрхэм дээдсээ. Тэгвэл бидэнд сэлүүр, татлага, салхи гараасай мөргөхийн алин ч хэрэг гарахгүй гэж Пентосын аялгатай Валирианы хүнд хэлээр хэлэв.

- Яг тийм, ахмадаа гээд Данерис хариуд нь инээмсэглэл шагнаан инээмсэглэлээ. Ахмад Гролео эзэн Иллирио Мопатис шигээ хөгшин Пентоши болохоор гурван луу тээвэрлэхдээ жаахан охиноос дутуугүй тэвдэн сандарчээ. Гал гарсан тохиолдолд хэрэглэх хагас зуун хувинтай ус хашлаганаас дүүжлээстэй хэвээр байв. Эхэндээ Гролео луунуудыг торонд хорихыг хүсэхэд Данис айдсыг нь намдаахын тулд зөвшөөрсөн ч тэдний шаналал илэрхий болмогц төдөлгүй бодлоо өөрчилж сул тавихыг шаардсан билээ.

Ахмад Гролео одоо үүнд баяртай байлаа. Луунуудын галыг хялбархан унтрааж болох бяцханы зэрэгцээ "Балерион" гэнэтхэн Данигийн ирэхээс өмнө "Садулеон" нэртэй хөвж байснаасаа илүү хавьгүй цөөн хархтай болжээ. Онгоцны багийнхан айхын зэрэгцээ сониучирхаж "тэдний" луугаар бахархаж байлаа. Тэдний хүн бүр ахмадаас авахуулаад тогооч хүү хүртэл гурван луугийн нисэхийг харах дуртай байсан ч хэн нь ч Данитай эн зэрэгцсэнгүй.

Тэд бол миний хүүхдүүд. Мэйги үнэн хэлжээ. Тэд надад зөвхөн байгаа хүүхдүүд.

Висерионы хайрс шинэхэн цөцгийний өнгөтэй эвэр, далавч, нурууны залаа нь хар алтан өнгөөр наранд төмөр шиг гялалзана. Рэйгал намрын хүрэл, зуны ногоон өнгөтэй байлаа. Тэд онгоцны дээгүүр өргөн дугуйран эргэлдэж улам дээш хөөрөн нэг нэгнээсээ өндөрт гарахыг хичээнэ.

Луунууд үргэлж дээрээс дайрахыг эрхэмлэдэгийг Дани мэдэж авчээ. Нэг нь нар нөгөө луу хоёрынхоо дунд ормогц далавчаа хумин шумбан хашгирч тэнгэрээс хоёул унан хоорондоо хайрстай бөмбөг болон зууралдаж шүдээ тас няс хийлгэн сүүлээ шавхуурдана. Анхны удаа үүнийг хийх үед нь Дани тэднийг нэг нэгнээ алах нь гэж айсан ч ердөө тоглоом төдий байв. Тэд удалгүй тэнгис рүү ус цалгиулан ороод хоёр тийш салснаа ахин дээш хөөрч хашгирч исгэрэн давстай ус далавчнаасаа савируулан ниснэ. Дрогон нүдэнд үзэгдэхгүй дээшээ хөөрөхдөө гарамгүй байсан бөгөөд олон милийн зайд арагш урагш явж ан хийнэ.

Түүний Дрогон үргэлж өлсгөлөн байдаг байв. Өлсгөлөн дээрээс нь түргэн өсч байна. Ахин нэг юм уу хоёр жил өнгөрөхөд тэр унаж болохуйц том болох бизээ. Тэгвэл надад давст өргөн тэнгисийг туулах хөлөг онгоц шаардагдах хэрэг гарахгүй.

Гэсэн ч тэр цаг хараахан болоогүй байлаа. Рэйгал, Висерион хоёр жижигхэн нохойноос томгүй, Дрогон арай томдуу ч ямар ч нохой тэднийг жингээрээ давах бөгөөд далавч, хүзүү, сүүл нь харагдаж байгаагаасаа илүү хөнгөн байв. Иймээс Данерис Таргариан мод, салхи, дарвуул түүнийг гэрт нь хүргэж өгнө гэж найджээ.

Мод, дарвуул хоёр түүнд сайн үйлчилж байсан ч хуйсагнуур салхи аашаа хувиргалаа. Зургаан өдөр зургаан шөнө тэд тайван зогссон бөгөөд одоо долоо дахь өдөр болоход далбаа өчүүхэн төдий ч дэрвэх салхигүй байв. Аз болоход магистер Иллирио тэдэнтэй цуг тус бүрдээ хоёр зуун сэлүүр, түүнийг хөдөлгөх булчинлаг сэлүүрчид бүхий худалдааны хоёр хөлөг онгоц илгээжээ. Гэвч нүсэр том "Балерион"-ы тухай өөр төрлийн хэрэг байж уужим зайтай өргөн аварга биетэй онгоцонд том

далбааны хэрэг гарсангүй."Вэйгар","Мераксес" хоёр түүнийг татлага олсоор чирж байсан ч дэндүү удаан байлаа. Гурван онгоц бүгд дүүрэн хүн, хүнд ачаатай байв.

- Би Дрогоныг харахгүй байна. Тэр ахиад л алдагдаа юу? гэж сэр Жорах Мормонт онгоцны хошуун дээр гарч ирээд хэлэв.

- Бид л алдагдчихаад байна, сэр. Дрогон энэ нойтон мөлхөө яст мэлхийд надаас дутуугүй дургүй гээд түүний хар луу нөгөө хоёроосоо илүү зоригтой болохоор хамгийн анх усан дээгүүр жигүүр дэвэн нисэх оролдлого хийн онгоцноос онгоцны хооронд нисч хамгийн түрүүнд үүлэн дунд алга болсны зэрэгцээ анхны анг хийжээ. Тэд усны мандал дээгүүр нисдэг загас үсрэхэд галаар тургин шүүрэн авч залгидаг байв.

- Тэр хэр том болох бол? Та энэ тухай мэдэх үү? гэж Дани сониучирхан асуулаа.

- Долоон ханлигт луу тэнгисээс аварга том наймаалж шүүрч авахаар том болдог гэдэг хууч яриа бий.

- Тэгвэл харахад гайхалтай байхдаа гээд Дани инээд алдав.

- Энэ бол ердөө үлгэр, калисий. Тэд бас мянган жилийн турш амьдарсан хөгшин ухаалаг луунуудын тухай ярьдаг гэж цөлөгдсөн хүлэг баатар хэлэв.

- Тэгвэл луу хэр удаан амьдардаг бол? гээд Данерис Висерион онгоцны үл мэдэг дэрвэх далбааны дээгүүр удаанаар далавчаа дэвэн нисэн өнгөрөхийг харлаа.

- Лууны байгалаас амьдрах жам хүнийхээс олон дахин урт гэж дуунд гардагт бид итгэдэг. Гэхдээ долоон ханлигийн луунуудыг Таргарианы овгийнхон хамгийн сайн мэдэх ёстой. Тэднийг дайнд сургаж, дайнд үхсэн. Хэдийгээр лууг алах амаргүй ч гэлээ тэгэх боломжтой гээд сэр Жорах мөрөө хавчив.

Онгоцны хошуун дээрх дүрсний дэргэд өрөөсөн гараараа хатуу модон таяг тулан зогсч байсан Цагаан сахалт хиа тэдний зүг эргэв.

- Хар айдас Балерион Эвлэрүүлэгч Жэйхерисийн хаанчлалын үед үхэх хүртлээ хоёр зуун жил насалсан. Тэр бух гөрөөсийг бүтнээр нь залгихуйц том байсан гэдэг. Хоол, эрх чөлөө нь байх тусам лууны өсөлт хэзээ ч зогсдоггүй, эрхэм дээдсээ гээд түүний нэрийг Арстан гэдэг ч Хүчит Белвас цайвар сахлаар нь Цагаан сахалт гэж дуудах тул ихэнхи хүмүүс ингэж нэрлэх болжээ. Тэр сэр Жорахаас өндөр хэдий ч булчинлаг биш нүд нь цайвар цэнхэр, урт сахал нь цас шиг цагаан торго шиг намирсан байлаа.

- Эрх чөлөө гэнэ ээ? Та юуны тухай яриад байна? гэж Дани сонирхлоо.

- Хааны газар таны өвөг дээдэс луунууддаа зориулан асар том бөмбөгөр цайз босгосон. Үүнийг Лууны нүх гэж нэрлэдэг юм. Энэ нь Рэйнисийн толгодын орой дээр байдаг ч одоо балгас болсон. Тэнд урьдын цагт хааны луунууд амьдарч болохоор уудам, гучин хүлэг баатар мөр зэрэгцэн гарч

болохуйц өргөн төмөр хаалгануудтай байжээ. Гэсэн ч лууны нүхэн дэх луунуудын алин ч өвөг дээдсийнхээ хэмжээнд хүрээгүй гэдэг. Мэйстерүүд үүнийг эргэн тойрон хана хашиж толгой дээр нь бөмбөгөр адар хязгаарлаж байснаас болсон гэж хэлдэг.

- Хэрвээ биднийг хана хязгаарладаг юм бол тариачид бүгд өчүүхэн жижигхэн хаад аварга биет шиг том байх байсан. Би урцанд төрсөн том хүн, ордонд өссөн одой харж байлаа гэж сэр Жорах хэлэв.

- Хүн бол хүн. Луу бол луу шүү дээ гэж Цагаан сахалт хариулахад,

- Ямар их мэдлэгтэй юм бэ гэж сэр Жорах басамжлан тургилаа. Цөлөгдсөн хүлэг баатар эхнээсээ л хөгшин хүнд илт дургүй байлаа. - Ингэхэд чи ер нь лууны тухай юу мэддэг юм бэ?

- Үнэндээ өчүүхэн зүйл мэднэ. Би Эйрис хаан төмөр хаан ширээнд сууж байх үед Хааны газар зүтгэж байхдаа хаан ширээний өрөөнд доош харуулан өлгөсөн лууны гавлын доогуур явдаг байсан.

- Висерис тэр гавлуудын тухай ярьсан. Булаан эзлэгч тэднийг буулган цааш нуусан гэсэн. Тэр тэднийг хулгайлсан хаан ширээндээ суухад харахыг нь тэвчиж чадаагүй байх л даа гээд Данерис Цагаан сахалт руу ойртон бөхийж,

- Та миний хаан эцэгтэй уулзаж байсан уу? гээд хоёрдугаар Эйрис хаан охиноо төрөхөөс өмнө үхсэн байлаа.

- Надад энэ хүндэтгэл тохиож байлаа, эрхэм дээдсээ.

- Та түүнийг эелдэг сайн хүн гэж бодож байна уу? гэхэд Цагаан сахалт сэтгэл хөдлөлөө нуухыг хичээсэн ч царайд нь илхэн байв.

- Эрхэм дээдэс... ихэнхидээ эелдэг байсан.

- Ихэнхидээ гэнэ ээ? Үргэлж биш үү? гээд Дани инээмсэглэв.

- Тэр дайсан гэж бодсон хүндээ маш ширүүн ханддаг байсан юм.

- Ухаалаг хүн хэзээ ч хааны дайсан болохгүй. Та миний ах Рэйгарын тухай ч гэсэн мэдэх үү?

- Үнэнийг хэлэхэд ямар ч хүн ханхүү Рэйгарын тухай мэдэхгүй. Гэхдээ надад түүнийг тэмцээн дээр харах завшаан тохиолдсоноос гадна мөнгөн чавхдастай ятга тоглохыг нь сонсдог байлаа гэхэд,

- Нэртэйгээр нь мянган янзын ургацын баяр дээр хамт байсан гээч. Дараагийн удаа чи өөрийгөө түүний хиа байсан гэх юм байна л даа гэж сэр Жорах эгдүүцэв.

- Би тэгэх гээгүй, сэр. Майлс Мүүтон ханхүү Рэйгарын дагуул түүний дараа Рикард Лонмаут байсан. Тэднийг давируулаа хожих үед тэр өөрийн биеэр хүлэг баатар болгон өргөмжилж ойр

дотны нөхдөө болгосон. Ханхүү бас залуу лорд Коннигтоныг эрхэмлэдэг байсан ч Артур Дэйн түүний дотны анд байлаа.

- Өглөөний илд! Висерис түүний гайхамшигтай цагаан илдний тухай ярьдаг байсан. Тэр сэр Артур зөвхөн ахын маань хаант улсад очиход цорын ганц хүлэг баатар нь гэж ярьдаг байсан юм хэмээн Дани хөөрөн хэлэв.

- Ханхүү Висерисийн үгийг шүүх нь миний эрх биш билээ гээд Цагаан сахалт толгойгоо бөхийлгөлөө.

- Хаан гэж Дани заслаа. - Тэр хаан байсан ч хэзээ ч хаанчилж байгаагүй. Нэрийнхээ гуравдугаар Висерис. Гэхдээ та юу гэсэн бэ? гээд хариулахыг нь хүлээсэнгүй,

- Сэр Жорах Рэйгарыг сүүлчийн луу байсан гэсэн. Түүнийг хосгүй дайчин гэж дуудаг байсан биз дээ? гэв.

- Эрхэм дээдсээ Лууны цохионы ханхүү ялгуусан дайчин байсан ч гэхдээ...

- Үргэлжүүл. Та надтай чөлөөтэй ярьж болно.

- Таны тааллаар больё гээд өвгөн хатуу модон таяг руугаа бөхийн хөмсөг зангидлаа.

- Хосгүй дайчин байсан гэдэг бол... сайн үг байна. Гэвч тулаанд үгээр ялдаггүй юм, эрхэм дээдсээ.

- Илдээр тулаанд ялдаг. Ханхүү Рэйгар үүнийг хэрхэн ашиглахыг мэддэг байсан гэж сэр Жорах няцаав.

- Тэр мэддэг байсан, сэр гэхдээ... Би зуугаад тэмцээн түүнээс ч олон дайнд түүнтэй эн зэрэгцэх хурдан хүчтэй чадварлаг хүлэг баатар харж байсан. Хүн ганц тэмцээнд ялаад дараагийнхад нь түргэн унадаг юм. Өвсөн дээр хальтирч унан ялагдах юм уу урьд орой нь ямар нэг хоол идсэн байж болно. Салхины чиг өөрчлөгдөх хүртэл ялалт авчирдаг гээд сэр Жорах руу харснаа,

- Эсвэл хатагтай туузыг зүүсэн гар гэлээ.

- Хэлж байгаа үгээ болгоомжтой, өвгөн минь гээд Мормонтын царай барайлаа.

Арстан сэр Жорахыг Ланниспортод тулалдахыг харж байсан болохоор Дани Мормонт хатагтайн туузыг гартаа ороон ялсныг мэдэж байв. Тэр хатагтайгаа мөн адил хожиж үзэсгэлэнтэй язгууртан гаралтай Хайтаурын овгийн Лайниссийг хоёр дахь эхнэрээ болгожээ. Гэвч тэр амьдралыг нь сүйтгэж хаяж явсан тул энэ тухай дурсамж бүр гашуун байлаа.

- Тайвшир, хүлэг баатар минь. Арстан гомдоох гээгүй гэдэгт итгэлтэй байна гээд Дани Жорахын гарыг авлаа.

- Таны хэлснээр болог, калисий гэж сэр Жорах сэтгэл дундуур хэлэв.

Данис дагуул хиа руу буцаж эргэлээ.

- Би Рэйгарын тухай бага зүйл мэднэ. Зөвхөн Висерисийн ярьж өгсөн зүйлүүдийг. Харин тэр ахыг маань үхэхэд жижигхэн хүү байсан. Тэр үнэн хэрэгтээ ямар байсан бэ? гэхэд өвгөн хормын турш бодлогоширов.

- Юунаас түрүүнд чадварлаг. Шийдэмгий, хашир, зүтгэлтэй, шулуун зантай. Түүний тухай нэг түүх байдаг. Энэ тухай эргэлзээгүй сэр Жорах мэдэх байх.

- Би танаас сонсмоор байна.

- Таны тааллаар больё. Лууны цохионы ханхүү жаахан байхдаа номонд дурладаг гэмтэй байжээ. Тэр маш эрт уншиж сурсан болохоор хүмүүс хатан Рэйллаг жирэмсэн байхдаа хэвлийдээ ном залгисан байх гэж хэлцдэг байлаа. Рэйгар бусад хүүхдүүдтэй тоглохыг сонирхдоггүй байсан. Мэйстерүүд түүний ухаанд биширдэг ч эцгийнх нь хүлэг баатрууд Ариун Бэйлор ахин төрж гэж гашуунаар ёжлон хэлдэг байв. Нэг өдөр ханхүү Рэйгар хуйлаас бичгээс олсон зүйл түүнийг өөрчилжээ. Юу болохыг нь хэн ч мэдээгүй ч хүү гэнэтхэн өглөө эрт хүлэг баатруудын хуяг дуулгаа өмсч буй хашаанд хүрч очсон байна. Тэр зэвсгийн даамал сэр Вилем Дарри руу алхаж очоод,

- Надад илд, хуяг хэрэгтэй. Би дайчин болох ёстой санагдаж байна гэж хэлжээ.

- Тэгээд болсон! гэж Дани бахдав.

- Тэр үнэхээр болсон гээд Цагаан сахалт мэхийн ёсоллоо.

- Өршөөгөөрэй, эрхэм дээдсээ. Биднийг дайчдын тухай ярьж байх зуур би Хүчит Белвас боссоныг харж байна. Би түүнд үйлчилэх ёстой.

Дани эргэн харлаа. Тайган онгоцны доод тавцангийн өрөөнөөс бахим биенээсээ үл хамааран шалмаг авиран гарч ирэв. Белвас тагдгар өргөн тавин чулууны хэмжээтэй бүдүүн бөгөөд булчинлаг том хүрэн гэдэс дээр нь бүүдгэр цагаан сорви зөрөлдөн зурайжээ. Тэр хэлхгэр өмд, шаргал торгон бүс, төмөр товчтой зохицоогүй гэмээр дэндүү нарийн ширэн хантааз өмсөнө.

- Хүчит Белвас өлсөж байна! Хүчит Белвас одоо идэх ёстой! гэж тэр хэнд ч хандсан юмгүй хүнгэнэн хашгирав. Тэгснээ эргэж хошуун дээр зогсож байсан Арстаныг харлаа.

- Цагаан сахалтаа! Чи Хүчит Белваст хоол авчирч өг!

- Та явж болно гэж Дани дагуулд хэлэхэд ахин мэхийн ёсолсноо эзэндээ үйлчилэхээр одов.

Сэр Жорах энгийн шударга царайдаа хөмсөг зангидан харлаа. Мормонт хүдэр чийрэг том, хүчирхэг эрүү зузаан мөртэй байлаа. Царайлаг хүн биш хэдий ч Данигийн мэдэх хамгийн үнэнч нөхөр байв.

- Тэр хөгшний яриа сайтар давсалсныг та ухаарсан биз дээ гэж тэр Цагаан сахалтыг нүднээс далд

ормогц хэлэв.

- Хатан хүн бүгдийг сонсох ёстой. Язгууртан, дорд гаралтай хүчирхэг, сул дорой, үнэнч урвамтгай байсан ч гэсэн. Нэг хоолой хуурамч ярьж байж болох ч ихэнхи нь үргэлж үнэн байдаг гээд Дани үүнийг номноос уншжээ.

- Тэгвэл миний хоолойг сонсооч, эрхэм дээдсээ. Энэ Арстан Цагаан сахалт таньтай хуурамчаар тоглож байна. Тэр дагуул хиа байхад дэндүү хөгшдэхийн зэрэгцээ мулгуу тайганд үйлчилэхэд дэндүү цэцэн яриатай.

Нээрэн энэ ч үнэхээр хачирхалтай санагдаж байна гэж Дани зөвшөөрөхөд бэлэн байлаа. Хүчит Белвас Мирийний тулааны нүхэнд сургагдсан худалдагдсан боол байлаа. Магистер Иллирио түүнийг Даниг хамгаалуулахаар илгээсэн гэж хэлсэн бөгөөд түүнд хамгаалалт хэрэгтэй нь үнэн байв. Хаан ширээнд нь суусан Булаан эзлэгч түүнийг алсан ямар ч хүнд эдлэн газар, лордын хэргэм шагнахыг амлажээ. Нэг оролдлого хэдийн хийгдсэн нь хордуулсан хундагатай дарстай байв. Түүнийг Вестерост ойртох тусам ахин дайралт ирэх магадлалтай. Карт руу буцвал шидтэн Пиат При Үхэшгүй мөнхийн Тоост өргөөг нь шатаасанд хорсон Гашуудамтгий хүмүүсийг түүний араас өшөө авахаар илгээсэн билээ. Шидтэнгүүд хэзээ ч муу зүйлийг мартдаггүй, Гашуудамтгий хүмүүс хороохдоо эндэж байсан түүхгүй гэж хэлэлцдэг. Дээрээс нь Дотракичуудын ихэнхи түүний эсрэг байв. Кал Дрогогын кос одоо каласарыг удирдаж байгаа болохоор тэдний хэн ч жижигхэн бүлэг рүү нь эргэлзээгүй дайрч хүмүүсийг нь алж хядан, боол болгож Даниг Вэйс Дотраки руу буцаан дош калийн хөгшин чавганц нарын дунд зохих байранд нь аваачиж тавих болно. Дани Заро Зоан Даксос түүний дайсан биш гэж найдсан ч Картын худалдаачин луунуудад нь шунасан билээ. Тэгтэл бас Сүүдрийн Куайт хэмээх улаан маажин багтай хачин эмэгтэй оньсого мэт зөвөлгөө өгсөн байдаг. Тэр дайсан юм болов уу эсвэл осолтой анд нөхөр юм болов уу? Дани үүнийг хэлж мэдсэнгүй.

Сэр Жорах намайг хордуулагчаас аварч, Цагаан сахалт Арстан мантикороос аварсан. Магадгүй дараагийн удаа Хүчит Белвас намайг аврах буй за. Тэр багахан мод шиг бүдүүн гар, булиа биетэй толигор хүрэн хацар дээр нь үс ургадаг бол сахал хусч болом хурц тахир аракхтай байв. Үүний зэрэгцээ бас хүүхэд шиг. *Аз болоход надад сэр Жорах болон цусан морьтонгууд минь бий. Дээрээс нь луунууд байгааг хэзээ ч мартаж болохгүй.* Цаг нь болоход луунууд гурван зуун жилийн өмнө Эйгон байлдан дагуулагч болон дүү нарт нь байсан шиг найдвартай хамгаалагч болох нь гарцаагүй. Харин одоохондоо тэд түүнд хамгаалалтаас илүү аюул авчирч байна. Бүх ертөнцөд байгаа гурван амьд луу түүнийх болохоор гайхширал айдас төрүүлэхийн зэрэгцээ үнэлж барамгүй хосгүй үнэ цэнэтэй байв.

Түүнийг цааш нь юу хэлэхээ тунгааж байтал шилэн хүзүү рүү нь хүйтэн амьсгал сэвэлзэн мөнгөлөг алтан үс нь дух руу нь хийсэв. Зотон даавуу чохарч хөдлөн "Балерион" даяар гэнэтийн хашгиралт цуурайтлаа.

- Салхи! Салхи эргэн ирлээ. Салхи! гэж далайчид хашгиралдав.

Дани нүсэр том онгоцны дарвуул зургаан өдрийн турш алга байсан дуу аялан дэрвэж татлага олс

чангарахыг харлаа. Ахмад Гролео хитэг рүү ухасхийн тушаал хашгирав. Пентошууд баярлан хашгирч шураг руу мацав. Хүчит Белвас хүртэл дуу алдан бүжиглэхчээ аяджээ.

- Бурхдын ивээлээр! Та харав уу, Жорах? Бид ахин замдаа гарлаа гэж Дани дуу алдав.

- Тиймээ гэхдээ хаашаа гэж, хатан минь?

Салхи эхэндээ өдрийн турш дорно зүгээс жигд үлээснээ дараа нь ширүүслээ. Жаргаж буй нарны гэрэл улайрна. *Би Вестеросоос хагас ертөнцийн зайд байгаа ч мөч өнгөрөх тутам улам ойртож байна* гэж Дани өөртөө сануулав. Тэр хууль ёсоор жолоодох ёстой төрсөн газраа анх харах нь ямар мэдрэмж болохыг төсөөлөхийг оролдлоо. *Энэ миний харсан хамгийн сайхан эрэг байх ёстой. Өөрөөр яаж байж болох билээ?*

Тэр шөнө "Балерион" харанхуйд урагшилж байхад Дани ахмадын бүхээгт орон дээрээ хөлөө зөрүүлэн суугаад луунуудаа тэжээж (тэнгист хүртэл хатан ахмадаас дээгүүр тавигдах ёстой гэж Гролео хэлжээ) хаалга чанга цохих чимээ гарлаа.

Ирри орны хөлд унтаж байснаа хаалга цохиход босч үүд рүү явлаа. Орон дээр гурван хүн багтахад дэндүү нарийхан тул өнөө шөнө Жикүйгийн калисийтэй зөөлөн өдөн ор хуваалцах ээлж байв. Дани гарын дор байсан бүтээлэг авч нөмрөв. Тэр ийм шөнө хүн ирнэ гэж санаагүй учир нүцгэн байлаа.

- Ороорой гээд сэр Жорахыг ганхсан дэнлүүний дор зогсож байхыг харлаа.

Цөлөгдсөн хүлэг баатар толгойгоо бөхийлгөн оров.

- Эрхэм дээдсээ таны нойрыг алдагдуулсан явдалд өршөөгөөрэй.

- Би унтаагүй байсан, сэр. Орж ирээд хараач гээд өвдгөн дээрээ тавьсан тавагнаас давсалсан гахайн махны өөдөс авч луунууддаа өргөн үзүүлэхэд гурвуулангых нь нүд шуналтай гялалзлаа. Рэйгал ногоон далавчаа дэвэн агаарт хөөрөхөд, Висерион хүзүүгээ урт цагаан могой аятай гарын хөдлөх аясаар урагш хойш хөдөлгөв.

- Дрогон *дракарис* гэж Дани аяархан хэлээд махыг агаарт шидлээ.

Дрогон дайрч буй хорт могой шиг түргэн хөдлөн амнаасаа шаргал улаавтар хар дөл тургиж махыг унахаас нь өмнө хуйхаллаа. Тэр Рэйгалыг ахынхаа эрүүн дороос олзыг нь хулгайлахаар толгойгоо ойртуулахад хурц хар шүдээ тас няс хийлгэн хашгирснаа махаа залгихад жижигхэн ногоон луу урам хугарсандаа исгэрэв.

- Рэйгал больж үз гэж Дани уурсан хэлээд толгой руу нь цохилоо.

- Чи хамгийн сүүлд идсэн биз дээ. Надад шуналтай луунууд хэрэггүй гээд сэр Жорах руу инээмсэглэв.

- Харж байна уу надад удахгүй тэдэнд өгөх махыг зуухан дээр түлэх хэрэг гарахаа болих нь.

- Харж байна. Дракарис гэнэ ээ?

Гурван луу үг сонсогдох чимээгээр түүний зүг толгойгоо эргүүлэхэд Висерион цайвар алтан дөлөөр тургисанд сэр Жорах яаран ухарлаа. Дани хөхрөв.

- Наад үгээ хэлэхдээ болгоомжтой байхгүй бол тэд сахлыг чинь хуйхалж мэднэ шүү, сэр. Энэ бол эртний Валирианий хэлээр “лууны гал” гэж байгаа юм. Би санамсаргүй явдал гарсан тохиолдолд тушаал өгөх үгтэй болохыг хүссэн юм гэхэд Мормонт толгой дохив.

- Эрхэм дээдсээ. Таньтай ганцаарчилан үг сольж болох уу?

- Бололгүй яахав. Ирри биднийг түр орхи гээд Дани Жикүйгийн нүцгэн мөрөн дээр гараа тавин сэгсэрч сэрээлээ.

- Чи ч гэсэн орхи. Сэр Жорах надтай ярих хэрэгтэй байна.

- Мэдлээ, калисий гээд Жикүй орноос нүцгэн бууж эвшээхэд толгойны орой дахь өтгөн хар үс арзайжээ. Тэр түргэн хувцаслаж Ирригийн хамт гарахдаа ардаа хаалга хаалаа.

Дани луунуудад үлдсэн давстай гахайн махаа өгч дунд нь булаацалдуулан орхиод дэргэдээ Жорахыг суу хэмээн алгадлаа.

- Суугаач таны сэтгэлийг юу түгшээгээ вэ, сэр.

- Гурван зүйл. Хүчит Белвас, Цагаан сахалт Арстан болон тэднийг илгээсэн Иллирио Мопатис гээд сэр Жорах суулаа.

Ахиад л уу? Дани бүтээлэгний төгсгөлийг мөр лүүгээ дээшлүүлэн татлаа.

- Яагаад тэр билээ?

- Картын шидтэн чамаас гурван удаа урвана гэж хэлсэн хэмээн Жорах сануулахад Висерион, Рэйгал хоёр хоорондоо архиран самардалцав.

- Нэгд нь цус нөгөөд нь алт гурав дахь удаад нь хайрын төлөө. Мирри Маз Дуур эхнийх нь байсан гээд Дани энэ тухай мартсангүй.

- Хоёр дахь урвагчийн хувьд хэвээр байгаа. Тэгтэл одоо энэ хоёр гарч ирлээ. Энэ намайг түгшээж байгааг нуухгүй. Хэзээ ч Робертийн чамайг алсан хүнд лордын хэргэм амалсныг бүү мартаж болохгүй.

Дани урагш бөхийн Висерионы сүүлнээс татаж ногоон дүүгээс нь холдуулахад бүтээлэг цээжнээс нь унасанд яаран татаж өөрийгөө халхлав.

- Булаан эзлэгч үхсэн.

- Гэхдээ оронд нь түүний хүү жолоодож байгаа. Эцгийнхээ өрийг төлөхөөр хичээнгүй хүү. Цусан өрийг ч байсан тэр гээд сэр Жорах харцаа өргөхөд бараан нүдний харц нь түүнийхтэй тулав.
- Жоффри намайг амьд байгааг мэдвэл үхэхийг хүсэх нь лавтай. Гэхдээ үүнд Белвас, Цагаан сахалт Арстан хоёр ямар хамаатай юм бэ? Өвгөн илд авч явдаггүй. Та үүнийг харсан биз дээ.
- Тиймээ. Гэхдээ би түүний таягныхаа бариулыг хэрхэн чадамгай эзэмшихийг харсан. Картад мантикор алсныг нь санаж байна уу? Тэгэхэд хоолой руу чинь цохиход ойрхон байлаа.
- Тийм байж болох ч тэгээгүй. Энэ бол мантикорын хатгалт намайг алах байсан. Тэр миний амийг аварсан.
- Калисий та Цагаан сахалт, Белвас хоёрыг алуурчинтай холбоотой гэж бодохгүй байна уу? Энэ итгэлийг чинь олох гэсэн мэх байж болох юм.
- Тэгвэл мэх сайн бүтжээ гээд Дани гэнэтхэн инээд алдсанд Дрогон исгэрч, Висерион цонхны дээрх хонууртаа нисэн суулаа. Сэр Жорах инээмсэглэсэнгүй.
- Энэ бол Иллириогийн онгоц, Иллириогийн ахмад, Иллириогийн далайчид. Хүчит Белвас, Арстан хоёр түүний хүмүүс болохоос чинийх биш.
- Магистер Иллирио намайг өнгөрсөн удаа хамгаалж байсан. Хүчит Белвас түүнийг ахын маань үхлийг сонсоод уйлсан гэж хэлсэн.
- Тийм л дээ гэхдээ Висерисийн төлөө биш түүнд зориулан зохиосон төлөвлөгөөнийхөө төлөө уйлсан юм биш үү?
- Түүний төлөвлөгөө өөрчлөгдөх хэрэг байхгүй. Магистер Иллирио Таргарианы овгийн анд нөхөр дээрээс нь баян...
- Тэр төрөлхийн баян төрөөгүй. Ертөнцөд миний мэдэхээр сайхан сэтгэлээр баян болсон нэг ч хүн байхгүй. Шидтэн хоёр дахь урвалт алтны төлөө гээ биз дээ? Иллирио Мопатис алтнаас илүү юунд дуртай гэж?
- Өөрийнхөө арьсанд. Мирри Маз Дуур надаас урвасан. Би үүнийх нь төлөө түүнийг шатаасан гэхэд бүхээгийн дотуур Дрогон хамраасаа утаа суунаглуулан нааш цааш үймэрлээ.
- Мирри Маз Дуур чиний мэдэлд байсан. Харин Пентост чи Иллириогийн мэдэлд байна. Энэ бол ижил зүйл биш. Би магистерийг чамаас илүү мэднэ. Тэр бол зальжин ухаалаг хүн...
- Надад ухаантай хүн Төмөр хаан ширээг авахад хэрэгтэй.
- Тэр чамайг хордуулахыг оролддог дарсны наймаачин ч гэсэн ухаалаг хүн байсан. Ухаалаг хүн эрх мэдэл хуйвалдаан хөөцөлддөг юм гээд сэр Жорах тургилаа.
- Та намайг хамгаална. Та болон цусан морьтонгууд минь гээд Дани хөлөө бүтээлэг дор

шургуулав.

- Дөрвөн хүн үү? Калисий та Иллирио Мопатисийг мэднэ гэж итгэдэг чинь сайн хэрэг. Гэсэн ч эргэн тойронд чинь хүрээлсэн тарган тайган, хорвоогийн хамгийн хөгшин хиа зэрэг хүмүүсийг мэдэхгүй байна. Пиат При, Заро Зоан Даксос хоёроос хичээл суралц.

Тэр надад сайн сайхныг хүсч байна. Тэр хайрынхаа төлөө бүхнийг хийж байна гэж Дани өөртөө сануулав.

- Надад хэнд ч итгэдэггүй тэнэг хатан байснаас бүх хүнд итгэдэг хатан байсан нь илүү санагдаж байна. Миний зүтгүүлэхээр авсан хүн бүр эрсдэлтэй болохыг ойлгож байгаа ч долоон ханлигийн хаан ширээг яаж ямар ч эрсдэлгүй авах болж байна? Би Вестеросийг нэг цөлөгдсөн хүлэг баатар, гурван Дотракийн цусан морьтонгуудтай хамт эзлэх гэж үү?

- Чиний зам аюултай гэдгийг би үгүйсгэхгүй. Гэсэн ч худал хэлсэн хутган үймүүлэгч бүрт сохроор итгээд байх юм бол ахынхаа адил дуусна даа гээд сэр Жорах эрүүгээ зөрүүдлэн чангалав.

Түүний зөрүүд зан Данигийн уурыг хүргэлээ. *Тэр надтай яг хүүхэд шиг харьцаж байна.*

- Хүчит Белвас өглөөний цай уухдаа хуйвалдаан хийгээгүй. Тэгээд ч Цагаан сахалт Арстан надад ямар худал үг хэлсэн юм бэ?

- Тэр дүр эсгэж байгаа шигээ хүн биш. Тэр чамтай ямар ч хиагийн зүрхлэхгүй зоригтой ярьдаг.

- Тэр миний тушаалаар ний нуугүй ярьсан. Тэр ахыг маань мэднэ.

- Ахын чинь тухай олон хүн мэднэ. Эрхэм дээдсээ Вестеросын хааны хамгаалалтын захирагч лорд бага зөвлөлд суудал эзлэн хаанд илд болон хурц цэцэн ухаанаараа зүтгэдэг. Хэрвээ би Хатан хааны хамгаалалтын эхний хүн юм бол намайг сонс гэж гуйж байна. Надад чамд хэлэх төлөвлөгөө байна.

- Ямар төлөвлөгөө? Надад хэлээч.

- Иллирио Мопатис чамайг Пентос руу дээврийнхээ дор буцаахыг хүсч байна. Маш сайн байна түүн рүү оч гэхдээ цаг нь болоход ганцаар биш. Одоо бид шинэ албатууд чинь үнэн хэрэгтээ хэр үнэнч дуулгавартай болохыг нь харцгаая. Греолеод Боолын булан руу зүгээ өөрчлөх тушаал өг.

Дани сонссон зүйлдээ дуртай байсангүй. Түүний сонссон хүний бие худалддаг боолын томоохон хотууд болох Юнкай, Мийрийн, Астапор нарын тухай сонссон бүхэн аймшигтай байв.

- Боолын буланд надад ямар зүйл хэрэгтэй гэж?

- Арми. Хэрвээ Хүчит Белвас шиг хүнд дуртай бол Мийрийний тулалдааны нүхээс хэдэн зуугаар нь худалдан авч болно. Гэсэн ч би Астапор луу онгоцныхоо жолоог залмаар байна. Астапороос чи Ансаллидуудыг худалдан авч болно.

- Хадаастай хүрэл малгайтай боолууд уу? Би Ансаллидуудаар юугаа хийх юм? Тэдний ихэнхи тарган болохоор морь ч унаж чадахгүй гээд Дани Анссалид харуулуудыг Чөлөөт хотуудад магистер, эзэд, ханхүүгийн харшийн үүдэнд харуулд зогсохыг харсан байлаа.

- Пентос, Мирд чи гэрийн харуул Ансаллидуудыг харсан байж магадгүй. Зөөлөн алба тайгануудыг ямар ч тохиолдолд тарган болгодог юм. Хоол тэдэнд зөвшөөрдөг ганц гэм. Ансаллидуудыг хэдэн хаалганы боолоор үзэх нь бүх хиа нарыг Цагаан сахалт Арстантай жишин үзэхтэй адилхан, эрхэм дээдсээ. Та Кохорын гурван мянган хүний домгийг мэдэх үү?

- Үгүй гээд Данигийн мөрнөөс бүтээлэг гулган унахад дээшлүүлэн татлаа.

- Энэ бол дөрвөн зуун жилийн өмнө Дотракичууд анх дорно зүгт дайлаар мордож замдаа тааралдсан хот суурин болгоныг шатааж байхад болсон явдал. Тэднийг Теммо нэртэй кал тэргүүлж байжээ. Түүний каласар Дрогогынхоос томгүй ч хангалттай том байлаа. Тавин мянгаас доошгүй хүн байсны тэн хагас нь үсэндээ хонх жингэнүүлсэн гээгтэй дайчид байв.

- Кохорикийнхон түүний ирж байгааг мэдэж байлаа. Тэд хэрмээ хүчлэн бэхэлж харуулынхаа тоог хоёр дахин нэмэн Хурц далбаа, Удаах хөвгүүдийн чөлөөт хоёр бүлгийг хөлсөлж авчээ. Үүнийхээ дараа Астапор лүү хүн илгээн гурван мянган Ансаллидуудыг худалдан авахаар явуулав. Энэ нь Кохор луу буцахад удаан аян болсон бөгөөд тэд ойртон ирэх үедээ алсад утаа тоос босч тулалдааны чимээ гарахыг сонссон байна.

- Ансаллидууд хотод нар жаргасан хойно хүрэлцэн иржээ. Хэрмийн хананы доод талд Кохорикийн хүнд морьтон цэргийн үлдэгдэл дээр хэрээ, чононууд найрлаж байв. Хөлсний цэргүүд найдлагагүй зүйлийн эсрэг нүүр тулахыг хүсээгүй учир Хурц далбаа, Удаах хөвгүүдийн бүлэг хоёр зугтжээ. Харанхуй болмогц Дотракичууд буудалдаа эргэн ирж эргэлзээгүй маргааш өглөө хотын хаалгыг хэмх цохин хэрмийг эзэлж олз омог дээрэм, хүчин хийж, боол олзлох найдлагаар идэж уун бүжиглэж найрласан байна.

- Гэвч маргааш нь үүр цайхад Теммо болон түүний цусан морьтонгууд каласараа буудлаас дагуулан хөдлөхөд хаалганы өмнө Хар ямаан сүлдтэй далбааны дор гурван мянган Ансаллидууд зогсож буйтай таарсан байна. Хажуу талаас нь хялбархан цохиж болох багахан хүч байсан ч Дотракичуудын занг юу эс андах билээ. Тэд явган цэргүүд байсан тул явган цэргүүдийг зөвхөн морьтонгууд унагаж болно.

- Дотракичууд дайрчээ. Ансаллидууд бамбайгаа нийлүүлэн урт жадаа бөхийлгөн бат зогсчээ. Хорин мянган гэзгэндээ хонх жингэнүүлсэн хүний эсрэг хатуу зогссон байна.

- Дотракичууд арван найман удаа дайрсан ч бамбай жаданд яг л хад мөргөх давалгаа адил бут үсэрчээ. Теммо гурван удаа харваачдаа урдаа гарган гурван мянган цэрэг рүү суман мөндөр буулгасан ч Ансаллидууд бамбайгаа толгой дээгүүрээ өргөх төдий халхлаад хүчит шуурганд ажирсангүй. Эцэст нь тэднээс зөвхөн зургаан мянган хүн үлдэж кал Теммо, түүний цусан морьтонгууд, кос болон бүх хөвгүүдийг нь оролцуулаад арван хоёр мянган Дотракичууд тулааны талбарт үхдэл болон хэвтэж байлаа. Дөрөв дэх өдрийн өглөө шинэ кал амьд үлдэгсдээ дагуулан хотын хаалгыг сүрлэг цуваагаар орхихдоо дайчин тус бүр гэзгээ огтлон гурван мянган цэргийн

хөлд шидсэн байна.

- Тэр өдрөөс эхлэн Кохорын хотын харуулаар зөвхөн өндөр жадны үзүүрт хүний гээг өлгөсөн Ансаллидууд тавигджээ.

- Ийм зүйлийг та Астасороос олно доо, эрхэм дээдсээ. Тэндхийн эрэгт буугаад Пентос руу хуурай замаар яв. Тиймээ энэ урт аян болох хэдий ч... магистер Иллириогийн талхыг хэлтлэх үед ард чинь ердөө дөрөвхөн биш мянган илд байх болно.

Тиймээ, үүнийг л иэцэн ухаан гэх байхдаа. Гэвч... гэж Дани бодлоо.

- Би яаж мянган боол цэрэг худалдаж авах болж байна? Надад цорын ганц үнэ хүрэх зүйл Турмалины ах дүүсийн өгсөн титэм байгаа.

- Луунууд Картаас дутуугүй Астаспорт гүнээ шохорхлыг төрүүлнэ. Магадгүй тэдгээр боолын худалдаачид чамайг Картынхан шиг бэлэг сэлтээр булж мэднэ. Үгүй бол эдгээр онгоцонд Дотракичууд морьдоос нь илүү олон зүйл ачиж явж байгаа. Тэд Картын худалдааны бараатай байгаа. Би үүнийг онгоцны хөндийд өөрийн нүдээр харсан харсан. Боодолтой торго, хуйлсан барын арьс, хув, хаш сийлбэр, гүргэм, эфирийн тос... хямдхан боолууд гээд л эрхэм дээдсээ. Барын арьс их үнэ хүрнэ.

- Тэр чинь Иллириогийн барын арьс гэж Дани эсэргүүцлээ.

- Харин Иллирио Таргарианы овгийн анд нөхөр.

- Гэсэн ч энэ түүний барааг хулгайлах шалтгаан биш.

- Баян найзуудыг эрх мэдлийнхээ төлөө өмч хөрөнгийг нь ашиглахгүй бол ямар хэрэг байх билээ, хатан минь? Хэрвээ магистер Иллирио үүнийг үгүйсгэвэл тэр зөвхөн Заро Зоан Даксосын салаа сахлын нэг үзүүр гэсэн үг. Хэрвээ тэр үнэхээр чиний үйл хэрэгт хайртай юм бол гурван онгоц дүүрэн худалдааны ачаа барааг нь зарахад дургүйцэхгүй. Барын арьсыг худалдаж арми цуглуулж эхлэхээс илүү яаж сайн ашиглана гэж?

Энэ үнэн. Данигийн сэтгэл хөөрлөө.

- Тийм удаан явган аянд аюул тохиолдож мэднэ.

- Тэнгис ч гэсэн аюултай. Өмнө зүгт торгоны замаар далайн дээрэмчид сүлжилдэж, хойд зүгт Валирианы Утаатай тэнгист чөтгөр байдаг. Бид дараагийн шуурганд живэх юм уу тарж, аварга наймаалж усан дороос гарч ирэн... эсвэл өөрсдийгөө цангаж үхэхгүй гэж тайвшируулан салхи хөдлөхийг хүлээж болно. Явган явахад өөр төрлийн аюултай ч тийм их бус, хатан минь.

- Ахмад Гролео чиглэлээ солихоос дургүйцвэл яах болж байна? Арстан, Хүчит Белвас хоёр яах бол?

- Магадгүй үүнийг цаг нь болоход мэдэх биз гээд сэр Жорах бослоо.

- Тийм. Би үүнийг хийнэ! гэж Дани шийдээд бүтээлгээ хойш унагаж орноос үсрэн буув.

- Би ахмадтай даруйхан уулзаж Астапор луу зүгээ өөрчилөхийг тушаана гээд авдар луу бөхийн тагийг нь онгойлгож гарт тааралдсан эхний хувцас болох элсэн торгон сул өмдийг авч,

- Миний зүүлттэй бүсийг аваад өг гэж Жорахад торгон өмдийг ташаа руугаа татах зуур тушаагаад,
- Бас миний хантаазыг... гэснээ эргэж харлаа.

Сэр Жорах түүнийг бүсэлхийгээр нь тэврээд ойртуулан уруул дээр нь үнсэхэд Дани,

- Өө гэж дуу алдав. Түүнээс хөлс, давс, шир ханхалж төмөр товчтой хантааз чанга тэврэхэд нүцгэн цээжийг нь нухав. Тэр нэг гараараа мөрнөөс нь барьж нөгөө гараа ар нуруугаар нь гулгуулан хэдийгээр хүсээгүй хэдий ч амыг нь хэлээрээ нээв. *Сахал нь хатгаж байгаа ч ам нь амттай юм* гэж Дани бодов. Дотракичууд урт сахлаас ондоо эрүүндээ сахал ургуулдаггүйн зэрэгцээ урьд нь түүнийг Кал Дрогоос өөр хүн үнсэж байсангүй. *Тэр үүнийг хийх ёсгүй. Би түүний хатан болохоос эмэгтэй нь биш.*

Энэ нь удаан үнсэлт байсан бөгөөд хэр удаан болсныг Дани хэлж мэдсэнгүй. Дуусах үед нь сэр Жорах түүнийг тавихад түргэхэн алхам ухарлаа.

- Та... та ингэх ёсгүй...

- Харин би ийм удаан хүлээх ёсгүй байсан гэж үгийг нь дуусгав.

- Би чамайг Вэйс Толорро, Картад байхдаа үнсэх ёстой байсан юм. Би чамайг улаан хязгаарт байхдаа өдөр шөнө болгон үнсэх ёстой байсан. Чи үргэлж үнсүүлж байхын төлөө бүтээгдсэн гээд цээж рүү нь харахад Дани хөхний товч нь сэрийхээс өмнө нүцгэн цээжээ гараараа халхлав.

- Би... ийм зүйл болох ёсгүй. Би хатан чинь байна.

- Миний хатан. Зоригтой, дур булаам миний урьд хожид харсан хамгийн үзэсгэлэнтэй эмэгтэй маань. Данерис...

- Эрхэм дээдэс гээч!

- Эрхэм дээдсээ гурван толгойтой луу гэснийг санаж байна уу? Та энэ тухай Тоост өргөөнд сонссон цагаасаа эхлэн гайхширч ирсэн. Тэгээд энэ нь чиний бодлоор Балерион, Мераксес, Вэйгар нарыг унасан Эйгон, Рэйнис, Висения нар. Таргарианы овгийн гурван толгойтой луу... гурван луу, гурван морьтон.

- Тийм гэвч ах нар маань үхсэн.

- Рэйнис, Висения нар Эйгоны дүү нарын зэрэгцээ эхнэрүүд байсан. Чамд ах байхгүй ч нөхөр авч болно. Харин чамд үнэнийг хэлэхэд ертөнцийн ямар ч эр хүн миний хагастай тэнцэх үнэнч байж чадахгүй гэдгийг хэлэх байна, Данерис.

БРАН

Уулын хяр газраас огцом өгсөн уртаар хөрсөн дээр нугларсан чулуу сарвуутай төстэй харагдана. Налуугийн доод хэсэгт нарс, нохойн хошуу, яшил мод ургасан ч дээшлэх тусам нүцгэрч хярын ирмэг үүлэрхэг тэнгэр лүү өөд өгсчээ.

Тэр өндөр чулуу дуудахыг мэдэрлээ. Дээшээ өгсөхөд эхэндээ амархан байсан ч түргэн өндөрсөж хүчирхэг хөлийг нь гуйвуулна. Түүнийг өнгөрөхөд толгой дээрх мөчирнөөс шувуу дэрхийн тэнгэрт далавчаа дэвэн нисэв. Тэр навчис дунд салхи исгэрэн, хэрэм хоорондоо шогшрох, нарсны боргоцой ойн хөрсөн дээр унах чимээ сонслоо. Эргэн тойрон үнэр ханхалж ногоон ертөнцийг аялгуугаараа дүүргэнэ.

Түүнийг сүүлчийн үлдсэн хэдэн алхмыг хийн уулын орой дээр гарахад сарвууны дороос чулуу өнхрөв. Нар өндөр нарсны дээгүүр том улаанаар жаргаж түүний доор ой мод, толгод нүдний хараа үл хүрэх алсад оджээ. Ягааран харанхуйлах тэнгэрт элээ дугуйран ниснэ.

Ханхүү. Ногоон модны ханхүү, Чонын ойн ханхүү гэх хүний хоолой толгойд нь гэнэт сонсогдоход эрх сүр хүч мэдрэгдэв. Тэр хүчтэй, хурдан, догшин болохоор ногоон ертөнцөд амьдарч байгаа бүхэн түүнээс айж байлаа.

Алсад орших модны ёроолд ямар нэг зүйл модон дунд хөдлөв. Саарал дүрс түргэн гялсхийснээ ахин алга болоход чих нь сортолзлоо. Дор жирэлзсэн ногоон горхины дэргэд өөр нэг дүрс хурдлав. *Чононууд* гэж тэр мэдлээ. Түүний бяцхан төрлүүд ямар нэг олз хөөж байв. Одоо ханхүү тэднийг илүү сайн харж саарал сарвууных нь сүүдрийг харлаа. *Сүрэг байна.*

Түүнд урьд нь ч гэсэн сүрэг байжээ. Тэд тавуул байж зургаа дахь нь арай зайтай байв. Түүний дотор хаа нэгтээ хүн тэднийг хооронд нь ялган нэрлэсэн дуу сонсогдсон ч тэдний хоолой биш болохыг мэдэж байв. Тэр ах дүүсийнхээ үнэрийг саналаа. Тэд бүгд адил үнэртэй нэг сүрэг шиг үнэртдэг ч тус бүр ондоо байв.

Түүний дүрэлзсэн ногоон нүдтэй ууртай дүү ойрхон байхыг ханхүү мэдэрч байсан ч олон удаагийн анд харсангүй. Гэвч нар жаргах тусам тэр улам алсад холдож хамгийн эцсийнх нь байв. Бусад нь ширүүн салхинд үлээгдсэн навчис адил алс хол бутран тарцгаажээ.

Заримдаа түүнд ах дүүс нь хамт байгаа хэвээр үхэр чулуу юм уу модны ард нуугдсан мэт санагдана. Тэр тэднийг үнэрлэж, шөнө улих дууг нь сонсоогүй ч алдсан эгчээсээ бусдыг ардаа байгааг мэдэрсэн хэвээр байв. Энэ тухай санахаас сүүлээ эрхгүй унжуулав. *Тав биш одоо дөрөв болсон. Дөрөв болон нэг цагаан чимээгүй чоно.*

Цастай налуу, чулуун толгод, том ногоон нарс, алтан навчтай царс, түргэн горхи, цагаан хяруугаар эмжигдсэн цэнхэр нуур гээд л эдгээр ойд мод тэднийх байжээ. Гэвч эгч нь ойг орхин өөр анчдын захирдаг хүн хадан өргөө рүү явснаас хойш буцах замаа олж чадсангүй. Чоно ханхүү санав.

Салхины чиг гэнэтхэн өөрчлөгдлөө.

Буга болон айдас, цус. Ангийн олзны үнэр түүний ходоодыг хонхолзуулав. Ханхүү ахин агаар шиншлээд эргэж хярын орой дээрээс эрүүгээ хагас ангайлган үсрэн буулаа. Түүний мацаж ирсэн хярын цаад тал өгсүүр байсан ч итгэлтэй хөлөөр чулуу, үндэс, ялзарсан навчин дээгүүр давхиж налуугийн уруу газар уртаар харайлган модон дунд орлоо. Үнэр түүнийг урагш татахад улам хурдлав.

Түүнийг дор үхэж буй буганд хүрэх үед найман жижиг саарал төрлүүд нь хүрээлсэн байлаа. Сүргийн толгойлогчид болох гичий, азарган чоно хоёр идэж эхлэхэд эхлээд эр нь дараа нь эмэгчин нь ээлжлэн бугын гэдсэн дорхи улаан махнаас зулгаана. Бусад нь тэвчээртэй хүлээж байсан ч сүүл болох чоно бусдаасаа хэдэн алхмын зайд болгоомжтой дугуйран тойрч сүүлээ дор унжуулжээ. Тэр хамгийн сүүлд ах дүүсийнхээ үлдээсэн зүйлийг идэх байлаа.

Ханхүү салхи сөрж уруудсан болохоор тэд түүнийг ангийн газраас нь зургаан алхамын зайтай унасан модны дэргэд хүрэх хүртэл мэдсэнгүй. Сүүл түүнийг эхэлж хармагц өрөвдөлтэй гийнэн цааш зугтав. Сүргийн толгойлогч азарган, өлөгчин чоноос бусад ах дүүс нь чимээгээр эргэж харан шүдээ ярзайлган архирав.

Зэрлэг чоно хариу архираад нам дуугаар хүржигнэн соёогоо ярзайлган үзүүлэв. Тэр туранхай сүүлтэй төрлүүдээсээ хоёр дахин, сүргийн хоёр тэргүүнээс хагас биеэр том байв. Сүргийн дунд үсрэн ороход гурав нь зугтаж бутанд уусан үгүй болов. Өөр нэг нь шүдээ ярзайлган ирлээ. Тэр дайралтыг тэргүүлэгчийг угтан чонын хөлнөөс эрүүгээрээ зуун гасалж доголтол нь хажуу тийш авч шидлээ.

Тэгтэл хоншоор дээрээ бугын зөөлөн хэвлийн цус болсон том буурал сүргийн толгойлогчтой нүүр тулгарав. Хоншоор нь цайрсныг үзвэл хөгшин чоно бололтой ч амаа ангайхад араанаас нь улаан шүлс савиран урслаа.

Тэр надаас дутуугүй айсангүй гэж ханхүү бодов. Энэ нь сайн тулалдаан болж урдаасаа ухасхийн дайрлаа.

Тэд удаан тулалдаж үндэс, чулуу, унасан навч, бугын хүүлэгдсэн гэдэс дотор дээгүүр өнхрөлдөн нэг нэгнийгээ шүдээрээ хазаж, самардан хоёр тийш салснаа дугуйран эргэлдэж ахин ухасхийн тулалдлаа. Ханхүү том биетэй хүчирхэг байхад төрөлд нь сүрэг чоно байв. Өлөгчин чоно тэдний дэргэд тойрон эргэлдэж шиншилж архиран эрэгчингээ цусанд хутгалдвал дайран орж байлаа. Үе үе бусад чононууд бас дайран ханхүүг цааш эргэхэд хөл, чихнээс нь зууна. Нэг чоно бусдаас илүүтэй түүний уурыг илүүтэй хүргэхэд хилэгнэн эргэж довтлогчийн хоолойг тас хазав. Үүний дараанаас бусад нь зай барилаа.

Жаргаж буй нарны сүүлчийн улаан туяа ногоон мөчир дунд алтран гийхэд хөгшин чоно зүдэрсэндээ нуруугаараа газар хэвтэж бууж өгсний тэмдэг болгон хэвлий, хоолойгоо ил гарган дээш харлаа.

Ханхүү түүнийг шиншлээд хүү татуулсан биений арьс даган гоожих цусыг долоолоо. Хөгшин чоно зөөлөн гийнахад зэрлэг чоно цааш эргэв. Тэр одоо маш их өлссөн болохоор олз түүнийх болжээ.

- Ходор.

Гэнэтийн чимээ түүнийг зогсооход архирлаа. Чононууд урдаас нь өдрийн сүүлчийн гэгээнд хурц ногоон шаргал нүдээр ажиглав. Тэдний хэн ч үүнийг сонссонгүй. Хачин салхи зөвхөн чихэнд нь сэвэлзжээ. Тэр эрүүгээ бугын гэдсэнд шургуулан ам дүүрэн мах зулгаалаа.

- Ходор, ходор.

Үгүй. Үгүй, би тэгэхгүй гэж Бран бодлоо. Гэвч энэ бол хүүгийн бодол байснаас зэрлэг чонынх байсангүй. Орчин тойрны ой мод харанхуйлсан ч мододын сүүдэр, үеэлүүдийнх нь цогшсон нүд үлдэв. Тэгтэл тэдгээр нүдний цаана том хүний инээсэн царай нитрийн толботой ханатай чулуун гулданд харагдав. Хэлэнд амтагдсан цусны дулаахан амт бөхлөө. *Үгүй, битгий битгий. Би идэхийг хүсч байна. Би хүсч байна, би хүсч...*

- Ходор, ходор, ходор, ходор, ходор гэж Ходор мөрнөөс нь зөөлхөн урагш хойш сэгсрэн аялгуулан дуудав. Тэр аяархан байхыг хичээн үргэлж болгоомжтой байдаг ч Ходор долоон фут өндөр хүчээ мэддэггүй болохоор том гараараа Браны шүдийг тачигнатал сэгсрэв.

- Үгүй! Ходор орхи. Би энд байна. Би энд байна гэж уурсан хашгирлаа.

- Ходор? гээд Ходор зогсож гайхан харав.

Ой мод, чононууд алга болжээ. Бран мянган жилийн өмнө орхигдсон эртний чулуун харуулын цамхагын доод талын чийгтэй гулданд буцан ирлээ. Энэ нь одоо цамхаг биш болжээ. Чулуунууд нь нурж хөвд, ороонго өвс битүү ургасан болохоор орой дээр нь гарах хүртэл юу байгааг мэдэхэд бэрхтэй байв.

- Нурсан цамхаг гэж Бран энэ газрыг нэрлэсэн бөгөөд Мира чулуун гулдан руу орох замыг олжээ.

- Чи дэндүү удаан явлаа гээд Жожен Рид арван гурван настай Бранаас ердөө дөрвөн насаар ах байв. Жожен биеэр томгүй түүнээс хоёр юм уу гурван инчээр илүү өндөр хэдий ч ёсорхуу ярих аялга нь наснаасаа илүү ахмад ухаалаг мэт санагдуулна. Винтерфеллд Хөгшин Нан түүнийг "бяцхан өвгөн" гэж нэрлэдэг байв.

- Би юм идмээр байна гээд Бран түүн рүү хэмсөг зангидлаа.

- Мира удахгүй хоол авчирна.

- Би мэлхий идэхээс залхаж байна гээд Мира Хүзүүнээс ирсэн мэлхий идэштэн болохоор Бран түүнийг олон мэлхий барьсанд буруутгаж чадсангүй ч,

- Би бугын мах идэхийг хүсч байна гээд агшин зуур цус, түүхий махны амтыг санахад аманд нь арааны шүлс асгарав. *Би үүний төлөө тулалдаж ялсан. Би ялсан.*

- Чи модон дээр тэмдэг тавив уу?

Бран улайлаа. Жожен үргэлж түүнийг гурав дахь нүдээ нээн Зуны арьсанд шилжих үедээ үүнийг хий хэлдэг байв. Модны холтос самардан, барьсан туулайгаа эрүүндээ идэлгүй зуун авчрах юм уу, чулуу эгнээ болгон өрөх гэх мэт. Тэнэг зүйлс.

- Би мартчихаж гэж хэлэв.

- Чи үргэлж мартдаг.

Энэ нь үнэн байлаа. Тэр Жожены хэлдэг зүйлийг хийхээр боддог ч чоно болмогц хэзээ ч чухал санагдаж байсангүй. Тэнд үргэлж харж үнэрлэх зүйлс байж агнах бүхэл бүтэн ногоон ертөнц бий. Дээрээс нь тэр гүйж чадна! Олзны араас давхих нь гүйхтэй юугаар ч зүйрлэшгүй байлаа.

- Би ханхүү байсан, Жожен. Би ойн ханхүү байсан.

- Чи ханхүү шүү дээ. Үүнийгээ санахгүй байна уу? Надад хэн болохоо хэлээч гэж Жожен аяархан сануулав.

- Чи мэдэж байгаа гээд Жожен түүний найзын зэрэгцээ багш хэдий ч Бран заримдаа түүнийг цохимоор санагдана.

- Би чамаар хэлүүлмээр байна. Надад хэн болохоо хэлээч.

- Бран гэж Бран баргар хэллээ. *Хугарсан Бран.* - Бранкон Старк. *Тахир дутуу хүү.* Винтерфеллийн ханхүү гээд Винтерфелл шатаж нуран хүмүүс нь тарж бутран алагджээ. Шилэн цэцэрлэг нурж халуун ус ханын ан цаваар оргилон наранд уур савсуулж байгаа. *Яаж хүн ахин хэзээ ч харахгүй газрын ханхүү байж чадах юм бэ?*

- Тэгвэл Зун хэн юм бэ? гээд Жожен салж өгсөнгүй.

- Миний зэрлэг чоно. Ногоон ойн ханхүү гээд Бран инээмсэглэв.

- Бран бол хүү байхад Зун бол чоно. Чи тэгвэл хоёр уу?

- Хоёр дээрээс нь нэг гээд санаа алдлаа. Тэр Жоженийг иймэрхүү тэнэг зүйлс ярихад үзэн яддаг байв. *Винтерфеллд тэр намайг чонын зүүд зүүдлэхийг хүсч байсан бол одоо харин үргэлж араас маань дуудаж байх юм.*

- Үүнийг санаж яв, Бран. Өөрийнхөө хэн болохыг санахгүй бол чоно чамайг уусгана. Чи түүнтэй нэгдэх үед Зуны арьсан дор гүйж, агнаж, улих хангалтгүй.

Энэ миний төлөө гэж Бран бодлоо. Тэр Зуны арьсан дор байхад өөрийнхөө биенээс илүү дуртай байв. *Хүссэн арьсаа өмсч болохгүй юм бол арьсаа солигч байхын хэрэг юу байсан юм?*

- Чи санав уу? Дараагийн удаад мод тэмдэглээрэй. Ямар мод болох нь хамаагүй үүнийг хийгээрэй.

- Би тэгнэ. Би санах болно. Хэрвээ чи хүсвэл би одоохон буцаж очоод хийе. Энэ удаад мартаггүй. *Гэхдээ би эхэлж бугын махнаас идээд тэр жижигхэн чононуудын заримтай зодолдоно.*

- Үгүй. Энд үлдэж өөрийнхөө амаар юм идсэн чинь дээр. Варг хүн амьтныхаа идсэн зүйлээр амьдарч чадахгүй гээд Жожен толгой сэгсэрлээ.

Чи хаанаас мэдэж байгаа юм? Чи хэзээ ч варг байгаагүй болохоор энэ юутай адил болохыг мэдэхгүй гэж Бран эгдүүцэн бодлоо.

Ходор гэнэтхэн огцом хөл дээрээ босохдоо хүнхэр адарт толгойгоо бараг цохих шахлаа.

- ХОДОР! гэж тэр орилон хаалганы зүг ухасхийв. Мира түүнийг үүдэнд хүрэхээс өмнө онгойлгож тэдний хоргодсон газар орж ирлээ.

- Ходор, ходор гэж том агтчин хүү инээд алдан хэлэв.

Мира Рид арван зургаан настай нас бие гүйцэж яваа эмэгтэй ч зогсоход дүүгээсээ төдийлөн өндөргүй байв. Бүх намгийн хүмүүс намхан гэж Браныг нэг удаа түүнээс яагаад өндөр биш болохыг нь асуухад хэлжээ. Хүрэн үс, ногоон нүд, эрэгтэй хүүхдийнх шиг хавтгай цээжтэй тэрбээр Браны атаархам уян налархай хөдөлгөөнтэ. Мира урт хурц хутга зүүсэн ч тулалдах дуртай зэвсэг нь өрөөсөн гартаа гурван шүдтэй мэлхийн туяхан сэрээ, нөгөө гартаа нэхсэн тор барих явдал байв.

- Хэн өлсөж байна? гэж тэр асуугаад барьсан олз болох хоёр жижигхэн мөнгөлөг хулд загас, зургаан тарган ногоон мэлхий үзүүлэв.

- Би гэж Бран хэллээ. *Гэхдээ мэлхий идэх гээгүй юм шүү.* Энэ бүх муу зүйл тохиолдохын урьд Винтерфеллд байхад Валдерийнхан мэлхий идвэл шүд нь ногоон болж гарынх нь дотор талд хөвд ургадаг гэж хэлжээ. Тэр Валдерийнхныг үхсэн эсэхийг гайхширан бодов. Тэдний цогцос Винтерфеллд харагдаагүй ч тэнд маш олон хүүр байсан бөгөөд тэд байшингийн дотор шагайгаагүй билээ.

- Бид тэгвэл одоохон чамайг хооллоё. Бран чи надад барьсан олзыг маань цэвэрлэхэд туслах уу? гэхэд тэр толгой дохив.

Мирад адайр аашлах бэрх байлаа. Тэр дүүгээсээ илүү хөгжилтэй бөгөөд үргэлж түүнийг хэрхэн инээмсэглүүлэхээ мэддэг мэт санагдана. Юунаас ч айдаггүйн зэрэгцээ уурладаггүй байв. *Заримдаа Жоженээс бусдад нь...* Жожен Рид бусдаас илүүтэй айлгадаг байв. Тэр ногоон хувцастай, нүд нь хөвд шиг бараан ногоон дээрээс нь ногоон зүүд зүүдэлдэг. Жожены зүүд биелдэг байв. *Намайг үхсэн байна гэж зүүдэлснээс бусад нь.* Оронд нь тэр замд гарчээ.

Жожен Ходорыг модонд явуулан багахан түүдэг түлэхэд Бран, Мира хоёр мэлхий, загас цэвэрлэв. Тэд Мирагийн дуулгыг хоолны тогоо болгон ашиглаж барьсан олзоо жижиглэн хэрчээд Ходорын авчирсан зэрлэг сонгинотой усанд хийн мэлхийний шөл чанав. Энэ нь бугынхтай зүйрлэхээргүй байсан ч муугүй байсанд Бран идэхээр шийдэв.

- Баярлалаа, Мира. Хатагтай минь.

- Зүгээр дээ, эрхэм дээдсээ.

- Маргааш болоход бид хөдөлсөн нь дээр гэж Жожен мэдэгдэхэд Бран Мирагийн тэнсэн хөшихийг харлаа.

- Чи ногоон зүүд зүүдлээ юу?

- Үгүй.

- Тэгвэл яагаад явах гэж байгаа юм? Нурсан цамхаг бидний хувьд сайхан газар. Ойр хавьд тосгон байхгүй ойд дүүрэн ан, гол нуурандаа мэлхий загастай. Эндээс биднийг хэн олно гэж? хэмээн эгч нь шаардав.

- Энэ бидний байх ёстой газар биш.

- Энд аюулгүй.

- Аюулгүйг нь мэдэж байна. Гэвч хэр удаан гэж? Винтерфеллд тулалдаан болж бид үхсэн хүмүүс харсан. Тулалдаан дайн болно. Хэрвээ биднийг гэнэгүй байхад аль нэг арми барьж авбал...

- Энэ Роббын арми байж магадгүй. Робб өмнө зүгээс буцаж ирнэ. Би түүнийг буцаж ирэхийг мэдэж байна. Тэр далбаагаа намируулан буцаж ирээд төмөр хүмүүсийг хөөж зайлуулна гэж Бран хэллээ.

- Чиний мэйстер чинь үхлээ хүлээн хэвтэж байхдаа Роббыг дурсаагүй гэж Жожен түүнд сануулав.
- Чулуун эрэгт Төмөр хүмүүс, дорно зүгт Болтоны бутач бий. Кайлины суваг, Моттын гүй ой унаж түүний залгамжлагч Сервин болон Торрений талбайн цайзын захирагч үхсэн. Дайн хаа сайгүй болж хүн бүр хөршийнхөө эсрэг босч байна гэж тэр хэлсэн.

- Бид өмнө нь энэ тухай ярьсан биз дээ. Чи Хана руу гурван нүдтэй хэрээ рүүгээ явахыг хүсээ юу. Наадах чинь сайн хэрэг хэдий ч Хана маш хол болохоор Бранд Ходороос ондоо хөл байхгүй. Хэрвээ бид уналга байсан бол... гэж эгч нь хэлэхэд,

- Хэрвээ бидэнд бүргэд байсан бол нисэх байсан. Гэвч далавчны зэрэгцээ морьд ч байхгүй гэж Жожен ширүүн дуугарав.

- Тэнд морьд бий. Чонын ойн гүнд ч ойн харуул, тариачин, анчид байдаг. Заримд нь морь байгаа.

- Тэдэнд байлаа гээд бид хулгайлах болж байна уу? Бид хулгайч уу? Бидний араас хүн нэхэх нь дутаад байж гэнэ.

- Бид тэднийг худалдан авч болно. Тэдэнтэй арилжаа хийгээд.

- Өөрсдийгөө хараач, Мира. Зэрлэг чонотой тахир дутуу хүү, ухаан мулгуу аварга биет болон

Хүзүүнээс мянган бээрийн алс зайд байгаа хоёр намгийн хүн. *Бид танигдах болно.* Энэ тухай үг тархана. Браныг хичнээн үхсэн гэж бодох тусам тэр аюулгүй. Амьдаараа бол түүний үхлийг хүсч байгаа сайн муу хүмүүсийн золиос болно гээд Жожен галаа саваагаар хутгалаа. - Хойд зүгийн хаа нэгтээ гурван нүдтэй хэрээ биднийг хүлээж байгаа. Бранд надаас илүү ухаалаг багш хэрэгтэй.

- Яаж тэр вэ, Жожен? Яаж явах юм? гэж эгч нь асуулаа.

- Явган. Хөлөөрөө алхаад.

- Саарал уснаас Винтерфелл хүрэх зам мөнх үргэлжлэх мэт санагдахад бид унаатай байсан. Чи биднийг хаана төгсөх нь мэдэгдэхгүй замаар явган удаан аян хийхийг хүсээ юу? Хананаас цааш гэж чи хэллээ. Чи надаас илүүгүй тэнд байгаагүй. Харин би Хананаас цааш асар том газар болохыг мэдэж байна, Жожен. Тэнд олон гурван нүдтэй хэрээ байгаа юу? Эсвэл ганц уу? Бид түүнийг яаж олох болж байна?

- Магадгүй тэр биднийг хайж олох буй за.

Мираг хариу дуугарахаас урд алсад шөнө чонын улих чимээ гарав.

- Зун уу? гэж Жожен чагнан асуулаа.

- Үгүй гээд Бран зэрлэг чонынхоо хоолойг мэдэж байлаа.

- Чи итгэлтэй байна уу? гэж жижигхэн өвгөн хэлэв.

- Итгэлтэй байна.

Зун өнөөдөр алс хол газар явсан болохоор үүр цайх хүртэл эргэж ирэхгүй. *Магадгүй Жожен ногоон зүүд зүүдэлдэг байж болох ч ердийн чоноос зэрлэг чоныг ялган хэлж чадахгүй.* Тэр ер нь яагаад бүгд Жоженыг сонсдог болохыг эрэгцүүллээ. Тэр Бран шиг ханхүү биш, Ходор шиг том хүчтэй биш, Мира шиг сайн анчин биш ч үргэлжид Жожен тэдний юу хийхийг нь хэлдэг байв.

- Бид Мирагийн хэлснээр морьд хулгайлж Эцсийн Голомт дахь Амберийнхан руу явах ёстой гээд Бран хормын турш бодлогоширсноо,

- Эсвэл бид завь хулгайлж Цагаан хутгыг уруудан Цагаан эргийн суурин руу явж болох юм. Тэнд тарган лорд Мандерли захирч байгаа болохоор ургацын баяр дээр их нөхөрсөг байсан. Тэр хөлөг онгоц барихыг хүсч байсан. Магадгүй хэдийг барьсан байвал бид Риверран руу хөвж Роббыг гэрт нь бүх армитай нь авчирна. Тэгвэл миний амьд байгаа эсэхийг мэдэх ямар ч ялгаагүй. Робб бидний хэнд ч гэм учруулахгүй гэв.

- Ходор! Ходор, Ходор гэж Ходор хэхрүүлэв.

Тэр Браны төлөвлөгөө таалагдсан ганц хүн бололтой. Мира түүн рүү инээмсэглэн харахад, Жожен хөмсөг зангидав. Тэд Браныг Старкийн зэрэгцээ ханхүү байхад Хүзүүний Ридийнхэн Старкийн тугчид болохыг үл хамааран хэзээ ч түүний хүслийг сонсож байсангүй.

- Хоооодор. Хоооооооодор, хоооооооодор, ХоДОР, хоДОР, хоДОР гэж Ходор савчин хэлэв. Заримдаа тэр олон янзаар нэрээ давтан хэлэх дуртай байв. Бусад үед байгаа үгүй нь мэдэгдэхгүй чимээгүй болно. Ходор гэдэг үг юу болохыг мэдэх зүйл байсангүй.

- ХОДОР, ХОДОР, ХОДОР! гэж тэр хашгирлаа.

Тэр зогсохгүй нь гэдгийг Бран ойлгов.

- Ходор чи яагаад гадагш гарч илдээрээ сургууль хийж болохгүй гэж?

Агтчин хүү илдийнхээ тухай мартсан байснаа одоо саналаа.

- Ходор! гэж хэхрүүлээд илдийнхээ араас явлаа. Тэд Браныг дүү Риконтойгоо Теон Грэйжойгийн төмөр хүмүүсээс нуугдсан Винтерфеллийн бунхнаас гурван илд авчээ. Бран авга ах Брандоны сэлмийг авсан бол, Мира түүний өвөө лорд Рикардын өвдөг дээр тавьсан сэлмийг авчээ. Ходорын илд хамаагүй хуучин том хүнд төмөр зэвсэг байсан бөгөөд олон зууны явцад зөнд хаягдан битүү цоохортон зэвэрчээ. Ходор үүнийг хэдэн цагийн турш эргүүлэн ойролцоо орших өмхөрсөн мод, унасан чулуу хага цавчина.

Түүнийг гадагш гарсан хойно ханын дагуу явж "ХОДОР!" гэж хүнгэнүүлэн мод цавчих сонсогдож байлаа. Аз болоход Чонын ой том болохоор эргэн тойронд сонсох хүн байсангүй.

- Жожен чи багшийн тухайд юу гэж хэлсэн бэ? Чи миний багш шүү дээ. Би мод тэмдэглээгүйгээ мэдэж байгаа ч дараагийн удаа тэмдэг тавья. Миний гурав дахь нүд чиний хүссэн шиг нээгдсэн...

- Дэндүү өргөн нээгдсэн болохоор чамайг дотор нь уначихаад амьдралынхаа үлдсэн өдрүүдэд ойн чоно болчих вий гэж эмээж байна.

- Би тэгэхгүй гэдгээ амалж байна.

- Хүүгийн амлалт. Чоно үүнийг санах болов уу? Чи Зунтай гүйж, түүнтэй цуг агнаж амьтан алдаг... гэхдээ чи түүний хүсэлд өөрийнхөөсөө илүү захирагдаж байна.

- Би зүгээр л мартчихаж. Би ердөө естэй шүү дээ. Арай ахмад байсан бол хамаагүй дээр байх байсан юм. Тэнэг Флориан, луун хүлэг баатар ханхүү Эймон хүртэл есөн настай байхдаа агуу хүлэг баатрууд байгаагүй гэж Бран гомдоллов.

- Энэ үнэн. Хэрвээ өдөр урт хэвээр байсан бол чи ухаалаг зүйл хэллээ... гэвч тэд урт биш. Чамайг зуны хүүхэд болохыг би мэдэж байна. Надад Старкийн овгийн үгийг хэлээч.

- *Өвөл ирж байна* гээд Бран хэлсэн даруй хүйт даахыг мэдэрлээ.

Жожен ёсорхуу толгой дохив.

- Би газрын хөрсөн дахь чулуунаас гинжлэгдсэн далавчтай чоно зүүдлэн түүнийг суллахаар Винтерфеллд очсон. Харин одоо чиний гинж суларсан ч нисэхгүй хэвээр байна.

- Тэгвэл надад зааж өгөөч. Чи чинь ногоон харагч биз дээ гээд Бран заримдаа зүүдэнд нь орж эцэс төгсгөлгүй нүдний хооронд тус газар тоншин нис гэж хэлдэг гурван нүдтэй хэрээнээс айлаа.

- Үгүй би зөвхөн зүүд зүүдэлдэг хүү. Ногоон харагч үүнээс илүү. Тэд чам шиг варг бөгөөд тэдэн дундаа хамгийн мундаг нь ямар ч нисч, сэлж, мөлхдөг араатан амьтаны арьсыг өмсч далан модны нүдээр нэвт ширтэн ертөнцийн худал үнэнийг олж хардаг.

- Бурхад маш олон авьяас хайрлажээ, Бран. Миний эгч анчин. Тэр түүнд хурдан гүйж алга болсон юм шиг хөдөлгөөнгүй зогсож чаддаг чадварыг хайрласан. Мира сонор чих, хурц нүд тор жад барьдаг чанга гартай. Тэр шавраар амьсгалж, модны хооронд нисч чадна. Харин би эдгээр зүйлийг чамаас дутуугүй хийж чадахгүй. Бурхад надад ногоон зүүд хайрлаад харин чамд... чамд надаас илүү зүйлийг өгчээ, Бран. Чи бол далавчтай чоно... хэрвээ хэн нэгэн зааж өгвөл хэр хол өндөрт нисэхийг чинь хэн ч мэдэхгүй. Би чамд яаж авьяасыг чинь ойлгохгүй байж тусалж чадах болж байна? Бид Хүзүүнд Анхны хүмүүс ойн хүүхдүүдтэй нөхөрлөж байсныг санаж байгаа ч маш их зүйлийг мартсан учир мэдэхгүй байна гэхэд Мира Браны гарыг авлаа.

- Хэрвээ бид энд үлдвэл хэн ч төвөг удахгүй дайн дуустал чи аюулгүй байх болно. Үүнээс гадна чи миний дүүгийн заасан зүйлээс ондоо юу ч суралцахгүй. Чи түүний юу гэж хэлэхийг сонссон. Хэрвээ бид эндээс Эцсийн голомт руу хоргодох газар эрэн явах юм уу Хананаас цааш явбал эрсдэлд орно. Чи ердөө хүү хэдий ч бидний ханхүү, лордын маань хүү, хааны жинхэнэ залгамжлагч болохыг мэдэж байна. Бид чамд газар, ус, хүрэл, төмөр, гал, мөсөөр зүтгэхээ андгайлсан. Тэгэхээр авьяасын зэрэгцээ эрсдэл ч гэсэн чинийх. Сонголт чинийх байх ёстой гэж бодож байна. Бид чиний тушаалыг биелүүлэгч зарц нар. Ядаж үүн дээр гээд инээлээ.

- Та нар миний хэлсэн зүйлийг хийнэ гэж хэлсэн үү? Үнэхээр үү? гэж Бран асуулаа.

- Үнэхээр, ханхүү минь. Сайн бодоорой.

Бран эцгийнхээ байр сууринаас бодохыг оролдлоо. Том Жоны авга болох Янхны гай Хотер, Хэрээний хоол Морс хоёул догшин хүмүүс хэдий ч үнэнч гэж бодож байна. Дэрээс нь Карстаркийнхан ч гэсэн. Кархолд хүчирхэг шилтгээн гэж эцэг нь үргэлж хэлдэг байсан. *Бид Амберийнхан юм уу Карстаркийнханд аюулгүй байж болох юм.*

Эсвэл тэд өмнө зүг тарган лорд Мандерли руу явж болох юм. Винтерфеллд тэр олонтоо инээн хэзээ ч Бран руу бусад лордууд шиг өрөвдсөн нүдээр харж байсангүй. Сервиний цайз Цагаан эргээс ойрхон ч мэйстер Лювин Клей Сервинийг үхсэн гэж хэлсэн. *Амберийнхан болон Карстаркийнхан, Мандерлигийнхан ч гэсэн бүгд үхэж болох юм* гэдгийг ойлгов. Тэр ч гэсэн төмөр хүмүүс юм уу Болтоны бутчид баригдвал үхэх болно.

Харин эндээ үлдэж Нурсан цамхагын дор нуугдвал хэн ч тэднийг олохгүй. Тэр амьд байх болно. *Дээрээс нь тахир дутуу.*

Бран уйлж байгаагаа ойлгов. Тэнэг хүү гэж уур нь хүрэхэд бодлоо. Тэр Кархолд, Цагаан эрэг, Саарал усны харуул гээд хаашаа ч явсан байсан хамаагүй тэнд очсон хойно тахир дутуу байх болно. Тэр гараа нударга зангидлаа.

- Би нисэхийг хүсч байна. Гуйж байна намайг хэрээ рүү аваачиж өгөөч гэж хэлэв.

ДАВОС

Түүнийг хөлөг онгоцны тавцан дээр гарахад Дрифтмаркын урт хошуу ард хол хоцорч Лууны цохио өмнө орших тэнгисээс цухуйж байлаа. Арлын байгаа газар уулын оройгоос цайвар саарал утаа суунаглана. *Драгонмонт галт уул өнөө өглөө тайван бус эсвэл Мелисандра хэн нэгнийг шатааж байна* гэж Давос бодов.

Тэр "Шэйялагийн бүжиг"-ээр Хар усан тохойг Багалзуураар салхин сөрөг гатлах үед бодлынх нь ихэнхийг Мелисандра эзэлжээ. Массэйн Дэгээний эцэс дэх Шовх үзүүрийн харуулын цамхгын орой дээр дүрэлзэх их гал Давост Мелисандрагийн хүзүүндээ зүүсэн бадмааргыг санагдуулахад ертөнцөд үүрийн туяа гийх, үдшийн наран жаргахад сэмжин үүлс улайран түүний сэрчигнэсэн торго, атлаасан даашинзных нь өнгөтэй адил болон хувирна

Түүнчлэн өөрөө ч гэсэн Лууны цохионд бүх үзэсгэлэн гоо, сүр хүч өөрийнхөө бурхан, сүүдэр болон хаантайгаа хүлээж буй. Улаан удган саяхныг хүртэл Станнист үргэлж үнэнч мэт санагддаг байв. *Тэр түүнийг мориноос унасан хүн адил нугачин дарсан. Хэрвээ чадал нь хүрсэн бол миний хөвгүүдийг галд өргөхийн төлөө Станнистай цуг мордох байсан бизээ. Би түүний цээжийг ярж амьд халуун зүрхийг нь сугалан хэр ноцохыг нь харъя.* Давос ахмадын өгсөн сайн чанарын хатаасан урт Лайсени хутганд хүрлээ.

Ахмад түүнд туйлын өгөөмөр ханджээ. Түүний нэрийг Корэйн Сатмантес гэдэг бөгөөд хөлөг онгоцных нь эзэн Салладор Сааны адил Лайсени гаралтай байлаа. Тэр Лайд олонтгоо тааралддаг цайвар цэнхэр нүд, нар салхинд гандсан ясархаг царайтай бөгөөд долоон ханлигийн хооронд наймаа хийн олон жилийг өнгөрүүлжээ. Тэрбээр тэнгисээс аварсан хүн нь сонгино хүлэг баатар болохыг мэдмэгц өөрийн бүхээг хувцас хунар болон бараг л таарсан хос шинэ гутал өгчээ. Түүнчлэн Давосыг хоол ундаа ч гэсэн хуваалцахыг шаардсан ч байдал муугаар эргэжээ. Давосын гэдэс ахмад Корэйний эмгэн хумс, лампрей болоод бусад баян тансаг хоол ундыг тэсч чадалгүй ахмадын ширээнд барьсан анхны зоогынхоо дараа өдрийн үлдсэн хэсгийг хашлаганы нэг талд зүүгдэн өнгөрүүлжээ.

Сэлүүрийн ус хутгах аясаар Лууны цохио улам томров. Давос одоо уулын хэлбэр дүрс болон хажуу талынх нь цамхаг дээрээ чулуун луу бүхий том хар цайзыг харж байлаа. "Шэйялагийн бүжиг"-ийн хошуун дахь хүрэл толгойн дүрс хөөс сахарсан давалгааг давстай ус цацруулан зүснэ. Давос хашлага налан талархан түшив. Хүнд сорилт түүнийг сульдэн доройтуулжээ. Хөл дээрээ удаан зогсвол чичирэх юм уу заримдаа тасралтгүй хахаж цацан цустай цэрээр ханиалгана. *Энэ юу ч биш. Бурхад намайг ханиадаар алахын тулд гал, тэнгис дундуур аюулгүй гаргаагүй нь лавтай* гэж өөртөө хэлэв.

Тэгтэл бөмбөрийн даамлын нүдэх аясаар далбаа дэрвэж, сэлүүр нэгэн хэмнэлээр чахрах сонсогдоход залуу цагийнх нь манантай өглөө адил чимээнд зүрхэнд нь айдас хурж байсан үе рүү эргүүлэн авчирав. Тэд Эйрис Таргариан Төмөр хаан ширээнд сууж байх үед хориотой наймаачдын үхлийн аранга байсан хөгшин сэр Тристманы тэнгисийн харуулд ойртож буйгаа зарлалаа.

Гэхдээ тэр бол өөр үе байсан. Сонгино хөлөг онгоц, Шуурганы адаг, Станнис миний хурууны

үзүүрийг тайрахаас өмнө. Дайн дэгдэн, улаан сүүлт од мандаж, намайг Сиворт болон хүлэг баатар болохоос өмнөх үе. Би лорд Станнис өндөрт өргөмжлөхөөс өмнө тэр үед өөр хүн байсан гэсэн бодол төрөв.

Ахмад Корэйн түүнд гол шатсан шөнө Станнисийн найдлага эцэс болсон тухай хэлжээ. Ланнистерийнхан түүний жигүүр өөд дайрахад урвамтгай тугчид нь хамгийн хэрэгтэй үед орхин оджээ.

- Рэнли хааны сүнс ч гэсэн байсан. Тэр баруун зүүнгүй хядан арслан лордын хошууч ангийг тэргүүлж байсан. Түүний ногоон хуяг зэрлэг галд сүг сүүдэр шиг сүүмэлзэн дуулганых нь эвэрт алтан дөл улалзаж байсан гэсэн.

Рэнлигийн сүнс. Давос хөвгүүдийнх нь сүнс ч гэсэн буцаж ирэх эсэхийг эрэгцүүллээ. Тэр тоолж баршгүй удаа тэнгист хачирхалтай зүйл харсан ч сүнсэнд итгэдэггүй байлаа.

- Хүмүүсийн сүсэг хэвээр үү?

- Хатны төрөл төрөгсөд голдуу цөөн хүн үлдсэн. Бид цэцэгт үнэгтэй олон хүнийг авч явсан ч эрэг дээр мөн адил сүлдтэй бас олон хүн үлдсэн. Лорд Флорент одоо Лууны цохионд Хааны гар болсон.

Цайвар утаа титмийг нь эмжсэн уулс өндөрсөв. Далбай дэрвэн, бөмбөр нүдэх аясаар сэлүүр жигд хутган эргийн урт ам өөдөөс тосон ангайлаа. Хичнээн хоосон гэсэн бодол төрөхөд Давос урьд нь зогсоол бүрт хөлөг онгоц битүү шавааралдан усанд зангуу хаян зогссон байсныг саналаа. Тэр Салладор Сааны тугтай "Валириан", "Хилэн" эгч дүүсийнхээ хамт татлага бэхлэгдсэн зогсоолд зангуу хаян зогссоныг харлаа. Онгоцны хоёр тал Лайсенигийн ёсоор эрээн судалтай байлаа. "Хатагтай Мария", "Сүнс" хоёрыг харах оролдлого нь талаар өнгөрөв.

Тэд эрэгт орж ирмэгц далбаагаа буулгаж зогсоол руу сэлүүрдэн хөдлөв. Онгоцыг бэхлэн уях үед ахмад Давос руу ойртон ирлээ.

- Манай ханхүү таньтай даруй уулзахыг хүсч байна.

Давос хариу хэлэхийг оролдсонд бүгшүүлэн ханиалгаж хашлаганаас зууран хажуу тал руу нь нулимаад,

- Хаан. Би хаан руу очих ёстой гэж хэржигнүүлэв. *Хаан байгаа газраас би Мелисандраг олох болно.*

- Хаан руу хэн ч очихгүй. Салладор Саан гэж хэлсэн шүү. Түүнтэй эхэлж уулзана гэж Корэйн Сатмантес хатуу хэлэв.

Давос түүнийг эсэргүүцэхэд дэндүү сул дорой байсан тул толгой дохив.

Салладор Саан "Валириан"-даа байсангүй. Тэд түүнийг дөрөвний нэг бээрийн зайтай өөр нэг зогсоол дээр цүдгэр гэдэстэй "Өгөөмөр ургац" гэдэг Пентошийн онгоцонд хоёр тайгантай ачаа

бараа тоолж байхад очив. Тайганы нэг дэнлүү барин нөгөө нь лаван хүснэгт, үзэг барьжээ.

- Гучин долоо, гучин найм, гучин ес гэж Давосыг ахмадтай доод талын өрөө лүү ороход бүдүүн хоолойгоор тоолж байв. Өнөөдөр Салладор дарсны өнгөт цамц, өндөр түрийтэй мөнгөн хээтэй гандсан цагаан ширэн гутал өмсчээ. Домбоны таглааг аваад үнэрлэн найтааснаа,

- Хоёрдугаар зэргийн нунтаг кофе гэж миний хамар хэлж байна. Дансны бүртгэлд дөчин гурван домбо гэжээ. Ингэхэд бусад нь хаачсаныг би гайхаж байна? Эдгээр Пентошууд намайг тоолж чадахгүй гэж бодсон хэрэг үү? гээд Давосыг олж харснаа гэнэт зогслоо.

- Чинжүү миний нүдийг хорсгов уу эсвэл нулимс гарав уу? Энэ чинь миний урд сонгино хүлэг баатар зогсож байна уу даа? Үгүй яаж тэр байх билээ. Миний эрхэм анд Давос галт голд шатаж үхсэнийг бүгд мэднэ. Тэр ямар учраас миний араас хий үзэгдэл болон ирнэ гэж?

- Би хий үзэгдэл биш, Салла.

- Тэгвэл өөр юу юм? Миний сонгино хүлэг баатар хэзээ ч чам шиг туранхай цонхигор байгаагүй гээд Салладор Саан домботой халуун ногоо, худалдаачны боодолтой бөс даавуун дундуур зүтгэн Давосыг ширүүн тэвэрч хацар тус бүр дээр нь үнсээд гурав дахыг нь духан дээр үнслээ.

- Чи бие дулаахан зүрх чинь цохилсон хэвээр байна. Энэ үнэн үү? Тэнгис чамайг залгиад ахин нулиман гаргаа юу.

Давост Ширийн гүнжтэй байдаг ухаан муутай тэнэг Нөхөөстэй царайт санагдав. Тэр тэнгис рүү ороод галзуу болон гарч иржээ. *Би бас галзуурсан юм болов уу?* Давос амаа бээлийтэй гараар даран ханиалгалаа.

- Би гинжний доогуур сэлээд лусын хааны жадны эрэг дээр угаагдан гарсан. Хэрвээ "Шэйялагийн бүжиг" ирээгүй бол тэнд үхэх байлаа гэв.

Салладор Саан ахмадын мөрөн дээр гараа тавив.

- Энэ сайн ажил боллоо, Корэйн. Чамд сайн шан хүртээнэ. Мэйзо Мэйр сайн тайган минь миний анд Давосыг эзний өрөөнд хүргэж өг. Түүнд сонгинотой халуун дарс өгөөрэй. Надад ханиалгах дуу нь нэг л таалагдахгүй байна. Жаахан нимбэгний базсан шүүс нэмчихээрэй. Бас бидний түрүүн тоолсон цагаан бяслаг, ногоон оливоос аваачиж өг! Давос би манай сайн ахмадтай ярилцсан даруй чамтай удахгүй нэгдэнэ. Чамайг намайг өршөөнө гэдгийг мэдэж байна. Битгий намайг очтол хамаг олив идчихээрэй.

Давосыг хоёр тайганы ахмад нь тэргүүлэн онгоцны хошуу хэсэг дэх баян сайхан тавилга бүхий том бүхээгийн өрөө рүү дагуулан орлоо. Шалан дээр сахлаг хивс дэвсэж цонхыг өнгөт шилээр доторлоод гурван том ширэн сандлын алин дээр нь ч Давос тухтай сууж болох байлаа. Төдөлгүй бяслаг, оливын хамт аяга уур савсуулсан улаан дарс ирэв. Давос дарсыг хоёр гараараа атган талархан оочиход бүлээн шингэн цээжийг нь тайтгаруулан тархав.

Салладор Саан удалгүй ирэв.

- Чи дарсны тухайд намайг өршөөгөөрэй, анд минь. Эдгээр Пентошууд хүрэн улаан өнгөтэй байвал өөрсдийнхөө шээсийг ч гэсэн уух хүмүүс.

- Энэ миний цээжинд тусаллаа. Халуун дарс жингээс дээр гэж ээж минь үргэлж хэлдэг байсан юм хэмээн Давос хэлэв.

- Чамд жин тавих ч гэсэн илүүдэхгүй гэж бодож байна. Жадан дээр энэ удаан хугацаанд суусан байна. Ингэхэд чи хаанаас ийм сайхан сандал олоо вэ? Тэр махлаг хацартай байсан биш үү?

- Хэн? гэж Давос халуун дарс балгах зуураа асуулаа.

- Иллирио Мопатис. Унжуу сахалт гэж би чамд хэлэх байна. Эдгээр сандлыг түүний жинд тааруулан хийсэн ч Пентосоос дээр нь суухаар өөртөө ховорхон төвөг уддаг. Тарган хүн үргэлж тухтай суухыг боддог болохоор хаа явсан газраа жинтүү авч явдаг байх.

- Чи ингэхэд яаж Пентошийн онгоцтой болоо вэ? Ахин дээрэм хийж эхлээ юу? гээд Давос хоосорсон аягаа тавилаа.

- Муухай гүтгэлэг байна. Салладор Саанаас илүү хэн дээрмээс зовсон гэж? Би зөвхөн авах ёстойгоо авсан. Маш их алт авах ёстой ч би ямар ч шалтгаангүй зоосны оронд сайхан сэрчигнэсэн цаас авсан. Түүн дээр Хааны гар лорд Алестер Флорентийн нэрийн өмнөөс тамгатай байсан. Нэгэнт би Хар усан тохойны лорд болсон болохоор миний эзэмшлийн усанд эзнийх нь зөвшөрөлгүйгээр ямар ч онгоц явж болохгүй. Гэсэн ч эдгээр хууль зөрчигчид хууль ёсны үүргээс минь зайлсхийж харанхуй шөнөөр далимдуулан өнгөрөхийг хичээсэн болохоор тэд хориотой наймаачнаас дээрдэхгүй учир би эрхийнхээ дагуу барих үүрэгтэй гээд хөгшин дээрэмчин паржигнатал инээлээ.

- Би хүний хуруу тасддаггүй. Хурууны өөдсөөр юугаа хийх юм? Түүний оронд хөлөг онгоц, ачаа бараа, цөөн тооны барьцааны хүн авсан гээд Давос руу цоо ширтэж,

- Чиний бие тааруу байна, анд минь. Наадах ханиалгалт чинь болон турж эцээд арьсан дотроос яс чинь нэвт харагдаж байна. Дээрээс нь би хурууны ястай жижиг хүүдийг чинь олж харсангүй гэхэд Давос сурсан заншлаараа ширэн хүүдий байсан газраа хүрч,

- Би түүнийг голд алдчихсан гэв. *Миний аз.*

- Гол аймшигтай байсан. Тохойны гаднаас би хүртэл харж чичирсэн гэж Салладор Саан ёсорхуу хэлэв.

Давос ханиалгаад нулимснаа ахин ханиалгалаа.

- Би "Хар Бета", "Хилэн" хоёр шатахыг харсан. Манай онгоцны нэг нь ч гэсэн галаас зугтаагаагүй гэж үү? гэж сөөнгөтөн хэлэхэд дотор нь найдлага эзэмдсэн хэвээр байлаа.

- "Лорд Стеффон", "Ноорхой Женна", "Хөнгөн илд", "Инээмсэглэгч лорд" болон бусад онгоцнууд пиромансерийн шээснээс зайтай голын дээд хэсэгт байсан. Тэд шатаагүй ч гинж өргөгдөхөд хэн нь ч зугтаж чадаагүй. Зарим нь бууж өгч ихэнхи нь Хар усны дээд хэсэг рүү тулалдаанаас зугтан сэлүүрдээд Ланнистерийнхны гарт оролгүй багийнхантайгаа живсэн. "Ноорхой Женна", "Инээмсэглэгч лорд" хоёр голд дээрэм хийсэн хэвээр байгаа гэж би сонссон ч хэн үүнийг мэдэх билээ?

- "Хатагтай Мария", "Хилэн" яасан бэ? гэж Давос асуухад Салладор Саан бугуйнаас нь атгав.

- Үгүй тэдний хувьд чадаагүй. Намайг уучлаарай найз минь. Чиний Дэйл, Аллард хоёр сайн хөвгүүд байсан. Гэвч чамайг тайтгаруулахад залуу Деваныг чинь бид авч гарсан. Зоригтой хүү хэзээ ч хааны дэргэдээс холдоогүй гэсэн.

Давос агшин зуур санаа амарсандаа толгой нь эргэв. Тэр Деваны тухай асуухаас айжээ.

- Ээж энэрэнгүй ажээ. Би түүн рүү очих ёстой, Салла. Би түүнийг харах ёстой.

- Тийм. Бас Кэйп Врат руу явж эхнэр хоёр бага хүүхэдтэйгээ уулзахыг хүсч байгаа гэдгийг чинь мэднэ. Чамд шинэ онгоц хэрэг болно гэж бодож байна гэхэд,

- Эрхэм дээдэс надад онгоц өгнө гэсэнд Лайсени толгой сэгсэрлээ.

- Онгоцны хувьд эрхэм дээдэст нэг ч үлдээгүй байхад Салладор Саанд олон бий. Хааны онгоцнууд голд шатсан болохоос биш минийх биш. Чи нэгийг нь авч болно, хуучин анд минь. Чи миний төлөө хөвнө биз дээ? Чи Бравос, Мир, Волантис рүү харанхуй шөнөөр үзэгдэхгүй гарч ахин торго, халуун ногоо зөөх болно. Бидний хэтэвч зузаарна, тиймээ.

- Чи сайхан сэтгэлтэй юм, Салла. Гэвч миний үүрэг хааны төлөө зүтгэхээс бус чиний хэтэвчинд биш. Дайн дэгдсэн хэвээр байна. Станнис Долоон ханлигийн хууль ёсны залгамжлагч хэвээр байгаа.

- Энэ бүх хууль чинь хөлөг онгоцнуудыг шатахад тусалж чадаагүй. Хаан чинь ч гэсэн өөрчлөгдсөн гэж айж байна. Тулаанаас хойш тэр хэнтэй ч уулзахгүй Чулуун бөмбөр дотуураа холхиод байгаа. Хатан Селиса Хааны гараар өргөмжлөгдсөн нагац ах лорд Алестертайгаа хамт ордны хэргийг шийдэж байгаа. Хааны тамгыг тэр нагацдаа өгч захиа бичин надад хүртэл сайхан цаас ирүүлсэн. Гэвч тэд хөөрхийлөлтэй чулуурхаг бяцхан хаант улс жолоодож байгаа. Тэнд нь үнэнч Салладор Саанд төлөх өчүүхэн төдий ч алт байхгүй зөвхөн бидний эцэст нь зөөн гаргасан хүлэг баатрууд болон зоригт бяцхан онгоцнуудаас маань ондоо хөлөг байхгүй.

Гэнэтийн хахаж цацсан ханиалгалт Давосыг бөхийлгөв. Салладор Саан туслахаар хөдлөхөд холд гэж зангаад хормын дараа сэргэлээ.

- Хэн ч үү? Хэнтэй ч уулзахгүй байгаа гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж хэржигнэн асуухад хоолой нь чихэнд бөглүү нойтон дуулдаж хормын турш бүхээг эргэн тойронд эргэлдлээ.

- Түүнээс ондоо хэнтэй ч биш гэж Салладор Саан хэлэхэд Давос хэн болохыг нь лавлан асуусангүй.

- Анд минь чи ядарсан байна. Чамд л ор дэвсгэр хэрэгтэй болохоос Салладор Саанд биш. Олон давхар хөнжилтэй ор, цээжин дээр чинь тавих халуун жин, сармистай илүү их дарс хэрэгтэй гэхэд Давос толгойгоо сэгсэрлээ.

- Би зүгээр байна. Надад хэлээч Салла. Би мэдэх ёстой. Мелисандрагаас ондоо хэн ч биш үү? гэхэд Лайсени түүн рүү удтал эргэлзэнгүй харснаа дургүйхэн үргэлжлүүлэв.

- Харуулууд бусад бүх хүмүүсийг хол байлгаж хатан бяцхан охинтой нь хүртэл холдуулсан. Зарц нар хоол зөөж байгаа ч тэр идэхгүй байгаа гээд урагш бөхийн дуугаа намсгалаа.

- Нэг хачин ярианы тухай би сонссон. Ууланд дүрэлзэх өлсгөлөн гал руу Станнис, улаан эмэгтэй хоёр хамтдаа дөл харахаар доош буудаг гэсэн. Тэнд нүх болон уулын зүрхэнд хүрэх нууц шат байдаг бөгөөд зөвхөн Мелисандрагийн шаталгүй явж чадахгүй халуун газар байдаг гэнэ. Энэ түүнийг үхтэл айлгасан болохоор заримдаа арай ядан юм идэх хүчтэй болдог гэсэн.

Мелисандра. Давос чичирлээ.

- Улаан эмэгтэй л үүнийг түүнд хийсэн. Тэр Станнис өөрийг нь хойш тавьсанд шийтгэхийн тулд биднийг түймэрт шатааж ид шид нь байхгүй бол ялах ямар ч найдлага байхгүйг сургахыг хүссэн гэхэд Салладор тэдний дундах тавган дээрээс булцгар олив авлаа.

- Чи үүнийг хэлж байгаа анхны хүн биш. Гэвч би чиний оронд байсан бол энэ тухай чанга хэлэхгүй байсан даа. Лууны цохионд хатны хүмүүс гэтэж байгаа болохоор тэд сонор чихтэйн зэрэгцээ хурц хутгатай гээд жимсийг амандаа хийж хүлхэв.

- Надад хутга байгаа. Ахмад Корэйн надад үүнийг бэлэглэсэн юм гээд Давос чинжаалаа сугалан ширээн дээр тавилаа.

- Мелисандрагын зүрхийг сугалах хутга. Хэрвээ тэр зүрхтэй бол шүү дээ гэхэд Салладор Саан оливийн ясыг нулиман гаргаад,

- Давос, эрхэм Давос минь чи ийм зүйлийг тоглоомоор ч гэсэн хэлэх ёсгүй гэв.

- Тоглоом биш. Би түүнийг алах тухай ярьж байна. *Хэрвээ тэр эгэл зэвсэгт алагддаг бол шүү дээ.* Давос түүнд итгэлтэй байсангүй. Тэр өөрийн нүдээр хөгшин мэйстер Крессенийг түүний дарсанд хор хийхийг харсан болохоор тэд хоёул хордуулсан хундаганаас уухад мэйстер үхсэн ч улаан эмэгтэй үхээгүй. *Зүрхэнд зоосон хутга... чөтгөр хүртэл хүйтэн төмөрт алагддаг гэж дуучид хэлдэг.*

- Энэ чинь аюултай яриа байна. Би чамайг тэнгисийн өвчин чинь гараагүй гэж бодож байна. Халуун чиний ухаан санааг самууруулжээ. Оронд орж тэнхээтэй болох хүртэл удаан амарсан чинь дээр гэж Салладор Саан анхааруулав.

Миний шийдвэрийг сулрах хүртэл гэж чи хэлэх гээ юу. Давос хөл дээрээ бослоо. Түүний бие халуурч толгой нь эргэж байсан ч хамаа байсангүй.

- Чи ч урвагч хөгшин юм даа, Салладор Саан. Гэвч урьдын адил сайн найз маань хэвээр гэхэд Лайсени мөнгөн сахлынхаа үзүүрийг шувтарлаа.

- Тэгэхээр чи энэ сайн найзтайгаа үлдэнэ биз дээ?

- Үгүй, би явлаа гээд Давос ханиалгалаа.

- Явлаа гэнэ ээ? Өөрийгөө хараач! Чи ханиалган чичирч турж эцэн сул дорой болсон байна. Хаашаа явах гээ вэ?

- Цайз руу. Миний ор тэнд болон хүү маань бас байгаа.

- Дээрээс нь улаан эмэгтэй. Тэр цайзад бас байгаа гэж Салладор Саан сэжиглэнгүй хэлэв.

- Тэр ч гэсэн байгаа гээд Давос хутгаа буцааж хуйнд шургууллаа.

- Чи сонгино хориотой наймаа тээвэрлэгч болохоос биш гэтэж хутгалахын тухайд юу мэднэ гэж? Дээрээс нь бас хутгаа ч олигтой барьж чадахгүй бие чинь муу байна. Хэрвээ баригдах юм бол чамд юу тохиолдохыг мэдэж байна уу? Биднийг голд шатаж байхад хатан энд урвагчдийг шатаасан. Харанхуйн зарц гэж тэднийг нэрлэн улаан эмэгтэй галын гэрэлд дуулж байлаа.

Давос үүнд гайхсангүй. *Би мэдсэн юмаа. Би түүнийг надад хэлэхээс өмнө мэдсэн* гэж бодлоо.

- Тэр лорд Санглас болон Хабард Рамбтоны хөвгүүдийг гяндангаас гаргаа юу.

- Яг тийм гаргаад шатаасан. Чамайг ч гэсэн шатаана. Хэрвээ чи улаан эмэгтэйг алвал тэд өшөөг нь авахын тул чамайг шатааж харин бүтэлгүйтвэл алахыг оролдсоны төлөө шатаана. Мелисандра чиний хашгиралтанд дуулж үхэл чинь ирнэ. Харин тэгэхэд чи дөнгөж амьдралд буцаж ирээд байдаг!

- Ийм учраас л байхгүй юу. Үүнийг хийхийн төлөө ирсэн юм. Ашайн Мелисандра болон түүний хийсэн хэргийг дуусгахын төлөө. Үгүй бол юунд тэнгис намайг нулиман гаргасан гэж? Чи Хар усан тохойг надаас дутуугүй сайн мэднэ, Салла. Ямар ч ухаантай ахмад онгоцоо лусын хааны жадны дундуур гаргаж ёроолоо цөмлүүлэх эрсдэл хийхгүй."Шэйяалагийн бүжиг" хэзээ ч миний дэргэдүүр өнгөрөх ёсгүй байсан.

- Салхи энэ бүхэн муу салхинаас болсон биз. Салхи түүнийг өмнө зүг дэндүү хол хөөж гэж Салладор Саан чанга шаардав.

- Тэгвэл хэн салхийг илгээсэн гэж? Салла Ээж надтай ярьсан гэхэд хөгшин Лайсени түүн рүү анивчин харлаа.

- Чиний ээж үхсэн...

- Шүтээн Ээж. Тэр надад долоон хүү хайрласан ч би Мелисандрад шатаалгасан. Ээж надтай ярьсан. Биднийг гал, сүүдэр дуудсан гэж хэлсэн. Би Мелисандраг Шуурганы адгийн агуй руу сэлүүрдэн аваачиж айдас төрүүлэхийг нь харсан гээд Давос одоо хүртэл түүний хөөсөн хэвлийнээс хэрзгэр хар гар цухуйн ташааг нь түлхэн гарахыг хар дарсан зүүдэндээ харсан хэвээр байлаа.

- Тэр Крессен, лорд Рэнли болон Кортни Пенроуз гэдэг зоригтой хүн миний хөвгүүдийг ч гэсэн алсан. Одоо хэн нэгэн түүнийг алах цаг болсон.

- Хэн нэгэн. Тиймээ гэвч өөр хүн болохоос чи биш. Чи хүүхэд шиг сул дорой болохоос дайчин биш. Би чамаас үлдэхийг гуйж байна. Бид цааш ярилцан чи хоол унд идэж магадгүй бид цааш Бравос руу Нүүргүй хүмүүсийг үүнийг хийлгэхээр хөлслөхөөр явах ч юм билүү? Гэвч чи биш. Үгүй шүү чи суугаад юм идэж тэнхрэх ёстой.

Тэр байдлыг улам хүндрүүлэн эхлэхэд бэрхтэй болгож байна гэж Давос зүдрэнгүй бодлоо.

- Би өшөө хорсол гэдсэндээ өвөрлөчихсөн, Салла. Энд хоол багтах зай байхгүй. Намайг одоохон явуул. Бидний нөхөрлөлийн төлөө аз хүсээд намайг явуул гэхэд Салладор Саан хөл дээрээ бослоо.

- Чи миний бодсон шиг жинхэнэ нөхөр биш юм. Чамайг үхвэл хэн үнс ясыг чинь хатагтай эхнэр лүү чинь аваачиж эр нөхөр, дөрвөн хүүгээ алдсан гэж хэлэх юм бэ? Зөвхөн хөгшин гашуудалтай Салладор Саан. Зоригт хүлэг баатар байж булшны нүх рүүгээ ухасхийж байх юм даа. Би чиний ясыг цуглуулж шуудайлаад ард үлдээсэн хөвгүүдэд чинь өгөн хүзүүнд нь жижигхэн хүүдий зүүж өгөх болно гээд хуруу тус бүрдээ бөгжтэй гараа ууртай савчин,

- Яв, яв, яв, яв, яв гэсэн ч Давос ийм байдалтай явахыг хүссэнгүй.

- Салла... гэлээ.

- Яв. Эсвэл үлдсэн чинь дээр. Гэхдээ чи явах гэж байгаа болохоор яв гэхэд Давос гарлаа.

Тэр "Өгөөмөр ургац"-аас гарч уйтгартай зэлүүд Лууны цохионы хаалгаар оров. Зогсоолын хажуугийн гудамжинд бужигнаж байсан цэргүүд, далайчид, жирийн хүмүүс алга болон хоосорчээ. Түүний явсан газар гахай чарлаж, нүцгэн хүүхэд гуйлдэн, харх бужигнана. Хөлөөс нь шавар дүүжилсэн юм шиг хүндрэн гурван удаа ч хахаж цацан хүндээр ханиалгахад зогсож амарлаа. Хэн ч түүнд туслахаар ирсэнгүйн зэрэгцээ болсон явдлыг цонхоороо шагайн харсангүй. Цонхнууд хаалттай, хаалга үүд түгжээтэй байшингуудын тэн хагас уй гашуудлын тэмдэг өлгөжээ. *Оргилуун хар ус руу хэдэн мянган хүн явснаас хэдхэн зуу нь буцаж иржээ. Миний хөвгүүд ганцаар үхээгүй. Магадгүй ээж тэднийг өршөөх буй за* гэж Давос тунгаав.

Түүнийг цайзын хаалганд хүрэх үед бас түгжээтэй байлаа. Давос төмөр товруутай модон хаалгыг нударгаараа нүдэв. Хариу гарсангүйд өшиглөж ахин дахин нүдлээ. Эцэст нь дүүжин цамхагын орой дахь хоёр чулууны лууны дунд харваач цухуйв.

- Тэнд хэн байна вэ?

Давос толгойгоо өлийлгөн гараа амандаа хумин барилаа.

- Сэр Давос Сиворт эрхэм дээдэстэй уулзахаар ирлээ.

- Чи чинь согтуу юм уу? Нүдэхээ болиод цааш замаараа яв.

Салладор Саан түүнд анхааруулсан болохоор Давос өөр төрлийн арга хэрэглэв.

- Тэгвэл хүүтэй минь уулзуул. Деван хааны хиа байгаа юм гэхэд харуул хөмсөг зангидлаа.

- Чамайг хэн гэж хэлсэн бэ?

- Давос. Сонгино хүлэг баатар гэхэд толгой алга болсноо хормын дараа буцаж гарч ирлээ.

- Эндээс зайлж үз. Сонгино хүлэг баатар голд үхсэн. Түүний онгоц шатсан.

- Түүний онгоц шатсан ч эзэн нь амьд энд зогсож байна. Жэйт хаалганы харуулын ахмад хэвээр үү?

- Хэн гэнэ ээ?

- Жэйт Блэкбери. Тэр намайг сайн танина.

- Түүний тухай хэзээ ч сонсож байсангүй. Харваас үхсэн биз.

- Тэгвэл лорд Читтеринг.

- Наадахыг чинь харин мэдэх юм байна. Тэр Хар усанд шатаж үхсэн.

- Дэгээ нүүрт Вилл? Гахай Хол?

- Үхсэн, үхсэн гэснээ харваачийн царай гэнэтхэн тээнэгэлзэж,

- Чи энд хүлээж байгаарай гээд ахин алга болов.

Давос хүлээлээ. *Байхгүй бүгд үгүй болж* гэж гансран бодоод Холын үргэлж тос болсон хантаазныхаа дороос цухуйдаг том цагаан гэдэс, Виллийн царайн зүүн талыг хөндлөн гарсан урт загасны дэгээ хэлбэртэй сорви, Жэйтийн үргэлж тав тавин настай язгууртан дорд гаралтай байсан ч хамаагүй эмэгтэй хүнд малгайгаа өмсгөдөгийг саналаа. *Миний хөвгүүд болоод хэдэн мянган хүмүүс живж шатаагдан тамын хаан руу оджээ.*

Харваач гэнэтхэн буцаж ирэв.

- Гардаг хаалганы сараалж руу эргэвэл тэд чамайг хүлээж байна.

Давос хэлснийг нь дагахад танихгүй харуулууд түүнийг оруулав. Тэд жад барьж цээжин дээрээ Флорентийн овгийн цэцгэн дундах үнэгний сүлдтэй байлаа. Харуулууд түүнийг бодсон ёсоор нь Чулуун бөмбөр лүү хүргэсэнгүй Лууны сүүлийн нуман хаалгаар оруулж Эйгоны цэцэрлэгт аваачив.

- Энд хүлээж байгаарай гэж ахлагч нь түүнд хэлэхэд,

- Эрхэм дээдээс намайг буцаж ирснийг мэдсэн үү? гэж Давос асуулаа.

- Би хаанаас түүнийг чинь мэддэг юм. Хүлээж бай гэж хэлсэн шүү гээд тэр жадчингаа авч явлаа.

Эйгоны цэцэрлэгт нарсны таатай анхилам үнэр ханхалж зүг бүр өндөр хар мод ургажээ. Тэнд бас зэрлэг сарнай байсан бөгөөд өргөст бутан хашаа сүндэрлэн намгархаг хэсэгт цангис ургажээ.

Тэд яагаад намайг энд авчирсан юм бол? гэж Давос гайхширлаа.

Тэгтэл хонх сул жингэнэн, хүүхэд инээлдэх дуу сонсогдож гэнэтхэн Нөхөөстэй царайт тэнэг бутан дундаас үсрэн гарч ирээд түргэн түргэн явахад гүнж Ширийн өсгий даган хоцров.

- Чи одоохон буцаж ир. Нөхөөстөө чамайг буцаж ир гэж байна шүү гэж гүнж араас нь хашгирав.

Тэнэг Давосыг харснаа огцом зогсоход эвэртэй дуулганых нь хонх дин-дан, дин-дан жингэнэв. Тэр өрөөсөн хөл дээрээ догонцоод,

- *Тэнэгийн цус, хааны цус, охины цус гэвч зочид гинжстэй, хүргэн хүү гинжстэй ай, ай, ай* гэж дуулав. Ширийн түүнийг бараг гүйцэн ирэхэд эцсийн удаа догонцсоноо оймын завсар харайлган модон дунд алга болоход гүнж ард нь хоцров. Тэднийг хараад Давос инээмсэглэв.

Тэгтэл ханиалгалт нь эхэлж бээлийтэй гараараа дартал ахин нэг жижиг дүрс хашаан дээгүүр даван дээрээс нь мөргөн унагаалаа.

Хүү бас унасан ч тэр даруй босов.

- Чи энд юугаа хийж байгаа юм бэ? Чи намайг гүйж байхад замд минь зогсох ёсгүй гэж хувцсаа гүвэн асуулаа. Тас хар үс зах руу нь унжиж гайхсан цэнхэр нүд дүгэриглэнэ.

- Тиймээ, ёсгүй гэж Давос зөвшөөрөөд өвдөг дээрээ өндийхийг оролдоход ахин нэг ханиалгалт хаман авлаа.

- Та зүгээр үү? Би мэйстер дуудах уу? гээд хүү гараас нь татан хөл дээр нь босгов.

- Ердийн нэг ханиалгалт. Зүгээр болчихно гээд Давос толгой сэгсэрхэд хүү түүний үгийг авч,

- Бид мангас охин хоёр болж тоглож байгаа юм. Би бол мангас. Хүүхдийн тоглоом хэдий ч үеэл маань дуртай гэж тайлбарлаад,

- Чиний нэрийг хэн гэдэг вэ? гэв.
- Сэр Давос Сиворт гэхэд хүү дээрээс доош эргэлзэнгүй харж,
- Та итгэлтэй байна уу? Та хүлэг баатар шиг харагдахгүй байна даа гэв.
- Би сонгино хүлэг баатар, эрхэм лорд гэхэд цэнхэр нүд анивчив.
- Хар онгоцтой юу?
- Чи миний түүхийг мэдэх юм уу?
- Та миний авга ах Станнист намайг төрөхөөс өмнө лорд Тайреллийн бүслэлтэнд байхад нь загас авчирч өгсөн гээд биеэ цэхлэн эгц зогсож,
- Намайг Эдрик Сторм гэдэг. Роберт хааны хүү гэв.
- Мэдээж тэгэлгүй яахав гээд Давос даруй танилаа. Хүү Флорентийн дэлдэн чихтэй ч үс, нүд, эрүү, хацар нь Баратеонх байв.
- Та миний эцгийг мэдэх үү? гэж Эдрик Сторм шаардлаа.
- Би авга ахыг чинь ордонд дуудах үед түүнийг олон удаа харж байсан ч хэзээ ч ярилцаж байсангүй.
- Миний эцэг надад тулалдахыг зааж өгсөн. Тэр надтай уулзахаар бараг жил бүр ирж бид заримдаа хамт сургуулилдаг байсан. Миний сүүлчийн төрсөн өдрөөр тэр надад жижигхэн болохоос биш яг өөрийнх шигээ дайны алх явуулсан байсан. Тэд намайг Шуурганы адагт орхисон юм. Миний авга Станнис хурууг чинь тайрсан гэж үнэн үү?
- Зөвхөн сүүлчийнх нь үеийг. Надад богинохон гэсэн ч хуруу маань байгаа хэвээр.
- Надад үзүүлээч гэхэд Давос бээлийгээ тайлахад хүү гарыг нь болгоомжтой сонирхов.
- Тэр таны эрхий хурууг тайраагүй юм уу?
- Үгүй. Үгүй тэр үүнийг үлдээсэн гээд Давос ханиалгалаа.
- Тэр таны аль ч хурууг тайрах ёсгүй байсан юм. Үүнийг муу зүйлийн төлөө хийдэг гэж хүү шийдэв.
- Би хориотой наймаачин байсан шүү дээ.
- Тийм л дээ гэхдээ та түүнд загас, сонгино хулгайгаар авчирч өгсөн.
- Лорд Станнис намайг сонгинын төлөө хүлэг баатар болгож, хууль бус зүйлийн төлөө хурууг минь тайрсан гээд Давос бээлийгээ буцаж өмслөө.

- Миний аав байсан бол хурууг чинь тайрахгүй байсан.

- Таны хэлснээр болог, эрхэм лорд. *Роберт Станнисаас өөр хүн байсан нь үнэн. Хүү түүнтэй адилхан юм. Бас Рэнлитэй ч гэсэн адил.* Энэ тухай бодол сэтгэлийг нь зовоолоо.

Хүү өөр зүйл хэлэхийг завдахад хөлийн чимээ сонсогдсонд Давос эргэв. Сэр Аксел Флорент цэцэрлэгийн замаар хөвөнтэй хантаазтай арваад харуулын хамт ирж байв. Тэдний цээжин дээр Гэрлийн эзний галт зүрх байлаа. Хатны хүмүүс гэж Давос бодтол гэнэтхэн ханиалгав.

Сэр Акселл намхан булчинлаг түгдгэр цээж, бүдүүн гар, майга хөлтэй чихэнд нь үс ургасан хүн байлаа. Тэр хатны нагац ахын зэрэгцээ Лууны цохионд арван жил цайзын захирагч хийсэн болохоор Давосыг лорд Станнисийн таалалд нийцдэгийг мэдэх тул үргэлж эелдэг харьцдаг байлаа. Гэсэн ч одоо түүний дуунд өчүүхэн төдий ч дулаан өнгө байсангүй.

- Сэр Давос живээгүй байна. Яаж тийм байж болох билээ? гэв.

- Сонгино хөвдөг юм, сэр. Та намайг хаанд аваачихаар ирэв үү?

- Би чамайг гянданд аваачихаар ирлээ гээд сэр Акселл хүмүүсээ урагш зангаж, - Түүнийг баривчилж хутгыг нь хураа. Тэр үүнийгээ манай хатагтайн эсрэг ашиглах гэж байсан юм гэв.

ЖЭЙМИ

Жэйми дэн буудлыг түрүүлж тандлаа. Үндсэн барилга гол руу бөхийсөн урд талын эрэг дээр голын уруу хөвж яваа аялагчдыг тэврэх мэт хоёр урт намхан жигүүр сунган байрлажээ. Байшингийн доод давхрыг саарал чулуугаар барьж дээд талынх нь цайвар мод бөгөөд дээвэр нь занар чулуу байлаа. Түүнчлэн жүчээ, битүү ороонго сүлжсэн сүүдрэвч харагдана.

- Яндангаас нь утаа гарч цонхонд нь гэрэл асахгүй байна гэж Жэйми тэднийг ойртоход хэлэв.

- Намайг сүүлчийн удаа үүгээр явахад дэн буудал онгорхой байсан. Тэд сайн шар айраг нэрдэг. Зооринд нь хэсэг үлдсэн байж магадгүй гэж сэр Клеос Фрей хэлэв.

- Бас хүмүүс байж болно. Нуугдсан эсвэл үхсэн ч юм уу гэж Бриенн хэллээ.

- Хэдэн цогцосноос айж байна уу, бүсгүй минь? гэж Жэйми асуухад,

- Миний нэрийг... гээд урдаас нь муухай харав.

- ...Бриенн гэдэг тийм. Чи шөнө орон дээр хоногломооргүй байна уу, Бриенн? Бид задгай голд байснаас энд аюулгүй байж дээрээс нь юу болсныг тодруулж болох юм.

Тэр хариулсангүй ч хормын дараа завиныхаа залуурыг гандсан модон тавцан руу эргүүлэв. Сэр Клеос завинаас мацан бууж тэднийг зогсоол аяархан мөргөхөд дээшээ авиран завийг уяв. Жэйми түүний араас гинжиндээ татагдан эв хавгүйхэн авирлаа.

Тавцангийн эцэст төмөр багананд савлах яйжгий банзан дээр үнэнч зүтгэхийн тэмдэг болгон хоёр гараа өргөсөн өвдөг сөгдөж буй хааны зураг зуржээ. Жэйми үүнийг хараад чанга хөхөрч,

- Бидэнд үүнээс дээр буудал олдохгүй нь гэхэд,

- Энэ тийм онцгой газар уу? гэж хүүхэн сэжигтэй асуулаа.

- Энэ бол Өвдөг сөгдөж байгаа хүний буудал, хатагтай. Умардын сүүлчийн хаан Эйгон байлдан дагуулагчийн өмнө бууж өгсний тэмдэг болгон өвдөг сөгдсөн тэр газар. Энэ бол түүний тэмдэг гэж бодож байна гэж сэр Клеос хариулав.

- Торрен Галын талбарт хоёр хаан унасны дараа өмнө зүгээс хүчээ авчирсан. Гэвч тэр Эйгоны луу болон цэргийнх нь хэмжээг хармагц хөлдүү өвдгөө нугалах ухаалаг замыг сонгосон юм даа гээд Жэйми морь янцгаах дуунд зогслоо.

- Жүчээнд морь байна. Хамгийн багадаа нэгээс доошгүй. *Хүүхнийг ардаа орхиход надад хэрэгтэй гани морь.* Явж хэн гэрт байгааг харцгаах уу? гээд хариулт хүлээлгүй зогсоолын уруу гинжээ хангинуулан явж хаалгыг мөрөөрөө түлхэн онгойлготол нүднийх нь өмнө холхивч нум татаастай байлаа. Ард нь арван таван настай бахим хүү байв.

- Арслан, загас, чонын алин вэ? гэж хүү шаардангуй асуув.

- Бид шарсан шувууны мах горилж ирлээ. Нум сум бол хулчгар хүний зэвсэг гээд Жэйми түүний араас хамтрагч нь ирэхийг сонслоо.

- Намайг горхио мулталвал энэ ялгаагүй зүрхийг чинь нэвт харвана.

- Магадгүй л юм. Гэхдээ чамайг ахин сумлахаас урьд үеэл минь гэдэс дотрыг чинь шалан дээр цувуулна гэхэд,

- Битгий айлгаад бай, хүү минь гэж сэр Клеос хэлэв.

- Бид ямар ч гэм хийх гээгүй. Хоол унд, уух юмандаа мөнгө төлнө гээд хүүхэн хавтаганаасаа мөнгөн зоос гаргалаа.

Хүү зоос руу болон Жэймигийн дөнгө рүү сэжиглэнгүй ширтэв.

- Яагаад энэ дөнгөтэй байгаа юм?

- Зарим нэг нум сумчинг алсан юм. Чамд шар айраг байна уу? гэж Жэйми хэлэв.

- Байгаа гээд хүү нумаа үл ялиг доошлуулж, - Илднийхээ бүсийг тайлж газар хаявал бид та нарыг хооллож болох юм гээд зузаан дөрвөн өнцөгт хэлбэртэй цонхны шил рүү эргэн гадаа өөр хүн байгаа эсэхийг харснаа,

- Энэ Таллигийн завь байна гэв.

- Бид Риверранаас ирсэн гээд Бриенн бүсээ тайлж шалан дээр хангинатал унагахад сэр Клеос дагалдав.

Шарангуй хөөсөн цоохор царайтай хүн зоорины хаалгаар гарч ирэхдээ гартаа нядлагчийн хүнд заазуур барьжээ.

- Та нар гурвуулаа юу? Бидэнд гурван хүнд хангалттай адууны мах бий. Хөгшин туранхай адуу ч мах нь шинэхэн гэв.

- Энд талх бий юу? гэж Бриенн асуулаа.

- Хатсан талх, овъёосны нэгширсэн боов бий.

- Ёстой үнэнч буудлын эзэн байна даа. Тэд чамайг хатсан талх бүлхтэй махаар тэжээдэг ч ихэнхи нь үүнийгээ зарлаад байдаггүй гээд Жэйми инээлээ.

- Би буудлын эзэн биш. Түүнийг эхнэртэй нь хамт ард оршуулсан.

- Чи тэднийг алаа юу?

- Тэгсэн гэж би хэлээ юу? гээд эрэгтэй нулимлаа.

- Чононууд юм уу арслангуудын хийсэн ажил биз. Ямар ялгаа байна? Эхнэр бид хоёр тэднийг үхсэн байхыг олсон юм. Бид үүнийг харсан болохоор энэ газар одоо манайх болсон.

- Чиний эхнэр чинь хаана байгаа юм? гэж сэр Клеос асуулаа.

- Чи яагаад үүнийг мэдэхийг хүсээд байгаа юм? Тэр энд байхгүй... мөнгөн зоосыг чинь амталж үзэхээс нааш та гурав ч гэсэн байхгүй гээд эрэгтэй түүнийг сэжиглэнгүй сөлийв.

Бриенн зоосыг түүн рүү шидэхэд агаарт барьж аваад хазсанаа далд хийв.

- Түүнд олон байсан гэж холхивч нумтай хүү хэлэв.

- Тиймээ түүнд байгаа. Хүү минь доошоо бугаад надад хэдэн сонгино аваад ир.

Залуу нум сумаа мөрөн дээрээ тавиад тэднийг сүүлчийн удаа дүнсгэр харцаар харснаа зоорь луу алга болов.

- Энэ танай хүү юу? гэж сэр Клеос асуув.

- Эхнэр бид хоёрын авсан хүү. Бидэнд хоёр хүү байсан ч нэгийг нь арслангууд алж нөгөө нь ханиаданд үхсэн. Энэ хүү ээжийгээ Цуст жүжигчдэд алдсан юм. Эдгээр өдрүүдэд хүнд унтаж байхад нь харж байх хүн хэрэгтэй биз дээ гээд эрэгтэй заазуураа ширээ рүү зангаж,

- Тэнд сууж болно гэв.

Зуух хүйтэн байсан ч Жэйми үнсний ойролцоо сандал дээр суугаад ширээн доогуур урт хөлөө тэнийлгэхэд хөдөлгөөн бүрд нь гинж хангинан дуугарав. *Зэвүү хүргэмээр дуу. Энэ бүхэн дуусахаас өмнө гинжийг хүүхний хоолойд ороож яаж таалагдахыг нь харах юмсан.*

Буудлын эзний оронд байгаа эрэгтэй сонгинотой шарсан гурван том адууны мах, өөхтэй гахайн утсан мах, овъёсны хатсан боовтой авчирав. Жэйми, Клеос хоёр шар айраг ууж, Бриенн аяга алимны шүүс даруулав. Хүү зайтайхан шиг алимны шүүсний торхон дээр сууж татсан нум сумаа өвдөг дээрээ тавьжээ. Тогооч аягатай шар айраг авчиран тэдэнтэй суугаад,

- Риверранаас ямар мэдээ байна? гэж удирдагч нь гэж бодсон сэр Клеосоос асуулаа.

Сэр Клеос хариулахын өмнө Бриенн рүү хяламхийв.

- Лорд Хостер бие нь доройтсон ч хүү нь Улаан салааг Ланнистерийнхны эсрэг барьсан хэвээр байгаа. Тэнд тулалдаан болсон.

- Тулалдаан хаа сайгүй болж байна. Та нар хаачиж яваа юм бэ, сэр?

- Хааны газар луу гээд сэр Клеос уруулынхаа тосыг арчлаа.

- Тэгвэл та гурав тэнэг юм байна. Намайг сүүлчийн удаа сонсоход Станнис хаан хотын хэрмийн

гадна байсан. Хүмүүс түүнийг зуун мянган цэрэг, шидэт сэлэмтэй гэсэн гээд эзэн тургилав.

Жэйми бугуйгаараа холбосон гинжтэй гараа чангалж хоёр хуваах чадалтай болоосой хэмээн хүсэв. *Тэгвэл би Станнист шидэт сэлмийг нь хаана хуйлахыг нь үзүүлэх байсан юм.*

- Би та нарын оронд байсан бол Хааны замаас холхон явах байсан даа. Тэнд байдал улам дордсон гэж сонссон. Чоно, арслангууд болон бүлэг дээрэмчид хэнийг ч хамаагүй барьсан хүнээ дээрэмдэж байгаа гэж эзэн үргэлжлүүлэв.

- Шимэгчид. Зэвсэгтэй хүмүүс рүү хэзээ ч халдаж зүрхлэхгүй байсан даа гэж сэр Клеос зэвүүцэнгүй хэлэв.

- Өршөөл хүсье, эрхэм ээ. Гэсэн ч би эмэгтэй хүнтэй хамт гинжтэй хоригдол авч яваа нэг зэвсэглэсэн хүнийг харж байна гэхэд Бриенн түүнийг хүйтэн харцаар ширвэв.

Хүүхэн өөрийг нь эмэгтэй гэдгийг сануулахыг үзэн яддаг гэдгийг Жэйми ухаараад гинжээ ахин мушгихад биенд хүрсэн хүйтэн хатуу гогцооны төмөр дийлдсэнгүй. Гав бугуйг нь цус шүүртэл холгожээ.

- Би Сэрээний тэнгис рүү цутгаж буй урсгал дагана. Бид Охины цөөрмөөс уналга олж Даскендэйлийн замаар Росби хүрнэ. Энэ зам биднийг замд тохиолдох муу зүйлээс зайлуулна гэж Бриенн хэлэхэд эзэн толгой сэгсэрлээ.

- Та нар Охины цөөрөм рүү хэзээ ч голоор хүрэхгүй. Эндээс гучин мил орчим зайтай газар сувгийн шаварт хоёр завь ч шатаж живсэн. Тэнд гатлахыг оролдсон ямар ч хүнийг дээрэмддэг дээрэмчдийн үүр уурхай байгаа. Голын уруу Долоолгодог чулуу, Улаан бугын арлын эргэн тойронд ч гэсэн байдал ижил. Дээрээс нь тэнд аянгат лорд байгаа. Тэр голыг хүссэн газраараа гаталж нааш цаашаа гардаг юм.

- Аянгат лорд гэж хэн юм бэ? гэж сэр Клеос Фрей шаардав.

- Таны таалалд нийцвэл лорд Берик, сэр. Хүмүүс түүнийг цэлмэг тэнгэрээс аянга буух шиг гэнэтийн цохилт өгдөг учир ингэж нэрлэсэн юм. Түүнийг үхэшгүй гэлцдэг.

Чамайг илд нэвт дүрсэн байхад хэн ч байсан ялгаагүй үхнэ гэж Жэйми бодлоо.

- Мирийн Торос түүнтэй хамт явсан хэвээр үү?

- Тиймээ, улаан шидтэн. Би түүнийг эгэл бус хүчтэй гэж сонссон.

Түүнийг уух юманд цөөн тооны хүний адил Роберт Баратеонтой эн тэнцэх хүчтэй гэдэг. Жэйми урьд нь Торосыг хаанд архины улаан толбоо нуухын тулд улаан хувраг болсон гэж хэлж байхыг сонсчээ. Роберт үүнийг сонсоод Серсейгийн торгон нөмрөг рүү шар айргаа цацтал үхтлээ хөхөрсөн байна.

- Миний хувьд татгалзах явдалгүй ч Сэрээ бидний хувьд аюулгүй зам биш байж болох юм гэж

Жэйми хэлэв.

- Би ч гэсэн тэгж хэлэх байна. Та нар Улаан бугын арлыг лорд Берик болон улаан хуврагтай нь тааралдахгүй өнгөрөөдөг юмаа гэхэд урд чинь бадмаараг гарам хэвээр байгаа. Миний сүүлд сонссоноор Хануур лорд чононуудтайгаа гармыг эзэлсэн гэсэн. Гэвч одоо ахин арслангууд юм уу лорд Берик эсвэл ондоо хэн ч байж магадгүй гэхэд,

- Эсвэл хэн ч биш гэж Бриенн санал болгов.

- Хэрвээ хатагтай арьсандаа ийм бооцоо тавих гэж байгаа бол би таныг зогсоохгүй... гэсэн ч би та нарын оронд байсан бол эндээс голыг орхин хуурай газар явах байсан даа. Гэсэн ч та нар төв замаас хол шөнө модон доор хоноглон нуугдаж явлаа гэхэд жүжигчдэд бас баригдаж болох учир би хамт явахыг хүсэхгүйсэн гэхэд том биетэй хүүхэн эргэлзэнгүй харлаа.

- Бидэнд морьд хэрэгтэй.

- Тэнд морь байсан. Би жүчээнд нэгийг нь сонссон гэж Жэйми тодруулав.

- Тэнд байгаа. Гурван морь байгаа ч зарахгүй гэж буудлын эзэн хэлэв.

- Мэдээж үгүй байж таарна. Гэхдээ бидэнд ямар ч гэсэн үзүүлэх юм байгаа биз дээ гээд Жэйми хөхөрлөө.

Бриенн хөмсөг зангидан буудлын эзэнтэй цавчилгүй нүдний харц тулгарснаа хормын дараа дургүйхэн,

- Надад үзүүл гэхэд тэд бүгд ширээнээс босч явлаа.

Жүчээний бууцыг удтал цэвэрлээгүй учир адууны баас ханхална. Сүрлэн дунд тарган хар ялаа шавааралдан морины өрөө хооронд дүнгэнэлдэж хаа сайгүй хэвтэх морины хомоол дээр овоорох хэдий ч ердөө гуравхан морь байв. Тэднийг гурав гэхэд ч хэцүү агаад зовлогоо чирсэн хүрэн анжисны морь, өрөөсөн нүд сохор хөгшин цагаан болон цоохор саарал хүлэг баатрын унаа байлаа.

- Тэднийг ямар ч үнээр байсан зарахгүй гэж эзэн мэдэгдэв.

- Чи эдгээр морьдыг хаанаас олж аваа вэ? хэмээн Бриенн мэдэхийг хүслээ.

- Эхнэр бид хоёрыг буудалд ирэхэд та нарын сая иддэг морьтой цуг нэг нь тэргэнд хөллөгөөтэй байсан. Харин цагаан нь шөнө тэнүүчилж ирэн хүү хүлэг баатрын морийг эмээл хазаартайгаа сул давхиж явахад нь барьсан юм. Энэ байна би та нарт үзүүлье.

Тэрбээр мөнгөн шигтгээгээр чимсэн эмээлийг тэдэнд үзүүлэв. Эмээлийн олом хар ягаан өнгөтэй байсан ч одоо хүрэн болжээ. Жэйми ямар өнгөтэй байсныг нь мэдсэнгүй ч цусны толбыг харахад хялбар байлаа.

- Тэгэхээр эзэн нь ойрын хугацаанд ирж нэхэхгүй л юм байна гээд саарал морины хөлийг үзэж

цагаан морины шүдийг нь тоолоод,

- Саарал моринд эмээлийг нь оролцуулаад алтан зоос өг. Анжисны морь харин мөнгөн зоос хүрнэ. Харин цагаанаас салгасны төлөө тэр бидэнд төлөх ёстой гэж Бриеннд зөвлөв.
- Өөрийнхөө унаанд эелдэг бус үг бүү хэл, сэр гээд хүүхэн хатагтай Кателины өгсөн хавтагыг нээж гурван алтан зоос гаргав.
- Би тус бүрд нь алтан луу төлье гэхэд эзэн анивчин алтанд хүрснээ гараа тээнэгэлзэн буцаж татлаа.
- Сайн мэдэхгүй байна. Хэрвээ хэрэгтэй цаг тохиолдвол би алтан лууг чинь унаад явж чадахгүй. Өлсвөл нэгийг нь ч алж идэхгүй.
- Чи бас манай завийг авч болно. Голын өөд уруу хүссэн зүгтээ явна биз гэж Бриенн хэлэв.
- Алив надад алтныхаа амтыг үзүүлээч гээд эзэн зоосны нэгийг алган дээрээс нь авч хазаж үзсэнээ,
- Хм. Жинхэнэ юм байна. Тэгэхээр гурван луу болон нэг завь уу? гэхэд,
- Тэр чамайг нүцгэртэл чинь дээрэмдэж байна, бүсгүй минь гэж Жэйми хошигнов.
- Би бас хүнсний зүйл авмаар байна. Таны юу илүүчилж чадахыг чинь гэж Бриенн эзэнд Жэймигийн үгийг үл тоон хэллээ.
- Овьёосны боов илүүчилж болох юм гээд эзэн үлдсэн хоёр лууг алган дээрээс нь аваад гартаа жингэнүүлэн сэгсэрч чимээнд нь инээмсэглэлээ.
- Утсан давстай загас бас байгаа ч мөнгөн зоосны үнэтэй. Миний ор дэвсгэр ч гэсэн үнэтэй. Та нар өнөө шөнө энд хоноглоно биз дээ.
- Үгүй гэж Бриенн даруйхан дуугарав.
- Эмэгтэй минь та харанхуй шөнө таньж мэдэхгүй нутагт зангий нь мэдэхгүй морьтой явахыг хүсэхгүй л байх шүү. Чи намганд бүдэрч мориныхоо хөлийг хугалж болно гээд эзэн хөмсөг зангидлаа.
- Өнөө шөнө тод сартай байна. Бидэнд замаа олоход төвөг байхгүй гэхэд эзэн үгийг нь тоолгүй,
- Хэрвээ та нарт мөнгөн зоос байхгүй бол хүрэл зоосоор ор болон хоёр чинь дулаан хучих хөнжил авч болно. Хэрвээ миний бодлыг сонирхож байвал би аянчдыг буцаадаг хүн биш гэлээ.
- Наадах чинь шударга сонсогдож байна гэж сэр Клеос дэмжив.
- Хөнжлийн тухайд саяхан угаасан байгаа. Миний эхнэр явахаасаа өмнө хийсэн юм. Ямар ч нохой бөөс байхгүй гэдэгт итгэж болно гээд эзэн зоосыг ахин жингэнүүлснээ мушийн инээмсэглэв.

Сэр Клеос эрхгүй татагдаж,

- Бид бүхэнд нийцтэй ор дэвсгэр байна, хатагтай. Бид амарсныхаа дараа маргааш өглөө замаа үргэлжлүүлж болох юм гээд Жэйми рүү дэмжлэг эрэн харлаа.

- Үгүй дээ үеэл минь хүүхний зөв. Бид өгсөн ам болон өмнө маань урт зам байна. Бид явах ёстой.

- Гэхдээ чи саяхан... гэж Клеос хэлэв.

- Тэгээд юу гэж. *Би буудлыг хоосон гэж бодсон юм чинь.* Одоо миний гэдэс цатгалан сарны гэрэлд унах унаатай байна гээд хүүхэн рүү инээмсэглэв.

- Чи намайг анжисны морины нуруун дээр шуудайтай гурил шиг тэгнэх гээгүй юм бол дөнгөний тухайд ямар нэг юм хийнэ байгаа. Шагай холбосон гинжтэй мордож явахад хэцүү гэхэд Бриенн гинж рүү нь хяламхийв.

- Жүчээний араар тойроод дархан байгаа гээд эзэн эрүүгээ үрчихэд,

- Надад үзүүл гэж Бриенн хэллээ.

- Тиймээ түргэн явсан нь дээр. Энд миний бодсоноос илүү их морины хомоол байна. Дундуур нь алхахыг үзэн ядаж байна гээд Жэйми хүүхэн рүү хараад үгийг нь ойлгосон эсэхийг гайхлаа.

Тэр бугуйныхаа дөнгийг ч гэсэн цохиж салгуулахыг эрмэлзсэн ч Бриенн сэжиглэсэн хэвээр байлаа. Тэр төмөр цүүцний мохоо үзүүр дээр дархны алхаар хэд цохисны эцэст шагайных нь гинжийг голоор нь хуваахад Жэйми бугуйныхаа гинжийг салгахыг санал болгосон ч үл тоомсорлов.

- Голын уруу зургаан мил яваад та нар шатсан тосгонтой тааралдана гэж эзэн тэднийг морьдоо эмээллэн ачаа ачихад туслах зуураа хэлэв. Энэ удаад тэр Бриеннд зөвөлгөө өгөхөөр эргэжээ.

- Зам тэндээс хоёр хуваагдана. Хэрвээ та нар өмнө зүг эргэх юм бол сэр Варрений чулуун цамхгын байшин руу очино. Сэр Варрен үхсэн болохоор хэн эзэгнэж байгааг нь мэдэхгүй ч энэ газраас дөлж явсан чинь өлзийтэй. Та нар модон дундуур замаа даган зүүн урд зүг явсан нь дээр.

- Бид тэгэх болно. Миний талархалыг хүлээж авна уу гэж Бриенн хариулав.

Чиний төлсөн алт хангалттай гэж Жэйми бодсон ч өөртөө үлдээв. Тэр том царай муутай үнээний үл тоосон байдалд залхаж гүйцсэн байлаа.

Бриенн анжисны морийг өөртөө авч хүлэг баатрын унааг сэр Клеост өгөв. Жэймид өрөөсөн нүд сохор морь оногдсоноор морио давхиран хүүхнийг ардаа тоосоор булж хаях бодол нь эцэс боллоо.

Эзэн, хүү хоёр гарч ирэн тэднийг явахыг харлаа. Эзэн тэдэнд аз хүсэн буцаж ирэхийг ерөөсөн авч залуу холхивч нумаа гартаа барин чимээгүй зогсов.

- Жад юм уу мунатай болсон чинь дээр гэж Жэйми түүнд зөвлөхөд хүү үл итгэсэн байртай харлаа. *Хичнээн нөхөрсөг ёсны зөвөлгөө гээч.* Тэр мөрөө хавчсанаа морио эргүүлээд эргэн харсангүй.

Сэр Клеос замын турш өдөн ороо алдсандаа гомдоллосоор явав. Тэд зүүн зүг сарны гэрэлд голын эргээр явлаа. Улаан салаа энд маш өргөн хэдий ч гүехэн эрэг нь шавар зэгсээр хучигджээ. Жэймигийн морь намуухан сажлахад хөөрхий хөгшин адгуус сайн нүдтэй тал руугаа хазайна. Ахин морь унах сайхан байлаа. Тэр Робб Старкийн харваачид Шивнэдэг ойд азаргыг нь алсан цагаас хойш ахин морины нуруун дээр гарсангүй.

Тэд шатсан тосгонд хүрэхэд урд нь тариачны үр тариа ачсан тэрэгний дугуйн мөр гүнзгий гарсан эн тэнцүүхэн нарийхан хоёр зам тулгарав. Нэг нь зүүн өмнө зүг одон алсад орших модон дунд алга болоход нөгөө нь чулуурхаг газар шулуун үргэлжлэн өмнө зүг чиглэжээ. Бриенн тэдэнтэй товч зөвлөөд морио өмнө зүгийн зам руу эргүүлэв. Жэйми бас ижил сонголт хийх байсан болохоор таатай гайхширлаа.

- Гэхдээ буудлын эзэн биднийг эсрэг талынх нь замаар яв гэсэн шүү дээ гэж сэр Клеос эсэргүүцэв.

- Тэр буудлын эзэн биш гээд Бриенн эмээл дээрээ зохимжгүй бөгцийсөн ч итгэлтэй суужээ.

- Тэр хүн биднийг аль талын эргэлт рүү эргэхийг онцгойлон сонирхоод байсан. Модон дунд дээрэмчид орогнодогоороо нэртэй газар. Тэр биднийг урхинд оруулах гэж байсан байх.

- Ухаалаг хүүхэн. Манай эзэнд энэ замд нөхөд бий гэдэгт итгэлтэй байна. Өөр хэний морьд жүчээнд тийм мартагдашгүй үнэр үлдээнэ гэж гээд Жэйми үеэл рүүгээ инээмсэглэлээ.

- Тэр бидэнд морьдыг өгөхийн тулд голын тухайд ч гэсэн худал хэлсэн байж таарна. Гэхдээ би эрсдэл хийхийг хүсээгүй. Бадмаараг гарц болон замын уулзвар дээр цэргүүд байгаа гэж Бриенн хэлэв.

Тэр царай муутай байж болох ч дүүрчихсэн тэнэг юм байна. Жэйми түүнд инээмсэглэл шагнав.

Чулуун цамхагын байшингийн дээд талын цонхноос бүүдгэр гэрэл тусч зайтай явахыг анхааруулахад Бриенн тэднийг талбай дундуур дагуулан явлаа. Зөвхөн бэхлэлт орхигдсон хойно замдаа ахин оров.

Шөнийн хагас өнгөрөхөд хүүхэн тэднийг аюулгүй болсон болохоор зогсохыг зөвшөөрөв. Тэд гурвуул эмээлээсээ бууж шавартай горхины дэргэдэх багахан царс, яшил модон дунд буудаллав. Хүүхэн гал түлэхийг зөвшөөрсөнгүйд овъёосны нэгширсэн боов, давсалсан загас хувааж идлээ. Шөнө хачирхалтай тайван байв. Хавирган саран харанхуй тэнгэрт ододын дунд мандаж алсад чоно улих чимээ сонсогдоно. Тэдний морьдын нэг түгшин янцгаалаа. Өөр чимээ гарсангүй. *Энэ газар дайн хүрээгүй байна* гэж Жэйми бодов. Тэр эсэн мэнд байж Серсей рүү буцаж байгаадаа баяртай байлаа.

- Би түрүүлж харуулд гарья гэж Бриенн сэр Клеост хэлэхэд Фрей төдөлгүй зөөлөн хурхирлаа.

Жэйми царсны хожуул налан суугаад Серсей, Тирион хоёр одоо юу хийж байгаа эсэхийг гайхширлаа.

- Чамд төрсөн ах, эгч байгаа юу, хатагтай? гэж асуухад Бриенн түүнийг сэжиглэнгүй ширтэв.

- Үгүй. Би аавынхаа цорын ганц... хүүхэд нь.

- Хүү гэж чи хэлэх гээ юу. Тэр чамайг хүү шигээ боддог юм биз дээ? Чи ч хачин маягийн охин байх даа гээд Жэйми инээд алдав.

Бриенн илднийхээ бариулыг чанга атган үг дуугүй цааш эргэлээ. *Ямар хорон санаатай юм бэ.* Хэдийгээр анх харахад огт адилгүй ч гэлээ тэр түүнд зарим нэг талаар Тирионыг санагдуулна. Магадгүй дүүгийнх нь тухай бодол ингэж хэлүүлэхэд хүргэсэн ч байж магадгүй,

- Би чамайг гомдоох гээгүй юм шүү, Бриенн. Намайг уучлаарай гэв.

- Чиний хийсэн гэмт хэргийг уучлахын аргагүй, хааны алуурчаа.

- Ахиад л нөгөө нэр үү. Би чамайг яагаад ингэтэл чинь уурлуулаа вэ? Чамд хэзээ ч гэм учруулснаа мэдэхгүй байна гээд Жэйми гинжээ залхуутай хөдөлгөв.

- Чи өөр хүмүүст гэм учруулсан. Хамгаалахыг андгайлсан хүмүүстээ. Сул дорой, гэм зэмгүй хүн болон...

- ...хаанд уу? гээд энэ нь үргэлж Эйрис рүү буцаж ирдэг байв.

- Ойлгохгүй зүйлийнхээ талаар шүүхийг бүү оролд, бүсгүй минь.

- Миний нэрийг...

- ...Бриенн гэдэг, тийм. Хэн нэгэн чамд царай муутай шигээ залхуутай гэж хэлж байгаагүй юу?

- Намайг уурлуулах гэж өдөх хэрэггүй шүү, хааны алуурчаа.

- Өө, би чадах байсан бол оролдох л байлаа.

- Тэгвэл чи яах гэж тангараг өргөсөн юм бэ? Яагаад энэ бүхнээсээ урвах байсан юм бол цагаан нөмрөг нөмөрсөн юм? гэж тэр шаардав.

Яагаад гэнэ ээ? Тэр ер нь юу гэж хэлвэл ойлгох юм болоо?

- Би арван таван настай хөвгүүн байсан юм. Залуу хүнд асар их нэр хүндийн хэрэг байлаа гэхэд,

- Наадах чинь хариулт биш гэж зэвүүцлээ.

Чамд үнэн таалагдахгүй л байх даа. Тэр Хааны хамгаалалтанд хайрынхаа төлөө орсон билээ.

Эцэг нь Серсейг арван хоёр настай байх үед хаантай гэрлүүлэхийг горилон ордонд дууджээ. Тэр түүний гарыг гуйсан санал бүрт татгалзан насанд хүрэн илүү эмэгтэйлэг гоо үзэсгэлэнтэй болтол Гарын цамхагт өөртэйгээ байлгажээ. Тэр эргэлзээгүй ханхүү Висерисийг эрийн цээнд хүрэх юм уу эсвэл Рэйгарын эхнэр хүүхэд төрүүлэхдээ нас барахыг хүлээж байсан байх. Дорнийн Элиа хэзээ ч бие сайтай эмэгтэй байсангүй.

Жэйми энэ зуур дөрвөн жилийг сэр Самнэр Крэйкхолд дагуул хийн өнгөрүүлж Хааны ойн Ахан дүүсийн эсрэг тулалдаанд давируулаа хүртжээ. Гэсэн ч Кастерли Рок руу буцах замдаа эгчтэйгээ уулзах зорилгоор Хааны газар түр очиход Серсей хажуу тийш нь аваачаад лорд Тайвин түүнийг Лайза Таллитай гэрлүүлэхийн тулд сүй бэлгээ зөвлөлдөхөөр лорд Хостерийг хотод урьсан хэлжээ. Гэхдээ Жэйми цагаан болвол түүний дэргэд үргэлж байх болно. Хөгшин сэр Харлан Грандисон нойрсож байхдаа сүлдэн дээрх унтаж буй арслан шиг нас баржээ. Эйрис залуу хүн түүний байрыг эзлэхийг хүссэн тул яагаад нойрссон хүний оронд хүрхэрч буй арслан байж болохгүй гэж?

- Аав үүнийг хэзээ ч зөвшөөрөхгүй гэж Жэйми эсэргүүцэв.

- Хаан түүнээс гуйхгүй. Бүх зүйл ёсоор болсон үед аав илэрхий татгалзаж чадахгүй. Эйрис сэр Илин Пэйний хэлийг Долоон ханлигийг жинхэнэ Гар захирч байгаа гэж бардсаных нь төлөө огтолсон. Тэр Гарын харуулын ахмад байсан ч аав зогсоож зүрхлээгүй! Тэр үүнийг яасан ч зогсоож чадахгүй.

- Гэхдээ Кастерли Рок байгаа шүү дээ... гэж Жэйми хэлэв.

- Чи чулуу хүсээ юу? Эсвэл намайг уу?

Жэйми тэр шөнийг өчигдөрхөн юм шиг санаж байлаа. Тэд Могой загасны гудамжны хуучин буудалд соргог нүднээс далд шөнийг өнгөрүүлжээ. Серсей энгийн зарц хүүхний хувцастай ирсэн нь түүнийг юунаас ч илүүтэй баярлуулжээ. Жэйми түүнийг ийм тачаангуй байхыг хэзээ ч харж байсангүй. Түүний нойр хүрэн унтах тоолон Серсей ахин сэрээж байлаа. Өглөө нь гэхэд Кастерли Рок дэргэд нь үргэлж байхтай харьцуулахад өчүүхэн зүйл шиг санагджээ. Жэймиг зөвшөөрөхөд Серсей үлдсэнийг нь хийхээр амласан байна.

Сарын дараа Кастерли Рокод ордны хэрээ ирж түүнийг Хааны харуулд сонгогдсоныг зарлав. Тэр хаан Харренхалд зохиох том тэмцээн дээр андгай өргөж нөмрөгөө хүлээн авахад бэлтгэхийг тушаасан байв.

Ингэж Жэйми Лайза Таллигаас ангижирчээ. Өөрөөр төлөвлөсөн зүйл байсангүй. Эцэг нь урьд хожид байгаагүй уурсан хилэгнэв. Тэр үүнийг Серсейн хэлсэнчлэн ил эсэргүүцэж зүрхлээгүй ч өчүүхэн шалтаг гарган Гарын тушаалаасаа огцорч Кастерли Рокод охиноо аван иржээ. Ингээд тэд хамтдаа байхын оронд Серсей, Жэйми хоёрын байр солигдож тэр ордонд ганцаар галзуу хааныг хамгаалах зуур эцгийнх нь суудалд дөрвөн хүн ээлжлэн солигдож хааны хутганы ирэнд бүжиглэжээ. Гарууд яах ийхийн зуургүй түргэн өргөмжлөгдөж байсан учир Жэйми царайг нь санахаас урьд сүлдийг нь санаж байлаа. Элбэг дэлбэгийн бүрээ, бүжиглэж буй гриффинтэй Гар хоёул цөлөгдөж, бороохой хутганы сүлдтэй Гар зэрлэг галд дүрэгдэн амьдаараа шатаагджээ. Лорд

Россарт эцсийнх нь байлаа. Түүний сүлд шатаж буй бамбар байсан нь өмнөх хүнийхээ хувь заяаг давтах золгүй сонголт байсан ч хааны галын таашаалыг хуваалцан өргөмжлөгдсөн алхимич байжээ. *Би Россартыг гэдсийг хүүлэхийн оронд живүүлэх ёстой байсан юм.*

Бриенн түүний хариултыг хүлээсэн хэвээр байлаа. Жэйми,

- Чи Эйрис Таргарианыг мэдэх насны хүн биш гэхэд тэр үүнийг хэрэгссэнгүй.

- Эйрис галзуу хэрцгий байсныг хэн ч үгүйсгэхгүй. Гэсэн ч тэр титэм зүүж адислагдсан хаан байсан. Харин чи түүнийг хамгаалахаар андгай өргөсөн гэв.

- Би юу андгайлснаа мэдэж байна.

- Бас юу хийснээ ч гэсэн гээд дээрээс нь зургаан футын өндөрт сэвхтэй, хөмсөг зангидсан морин шүдтэй зэмлэнгүй царайгаар өлийлөө.

- Тиймээ чи ч гэсэн адил зүйл хийсэн. Хэрвээ миний сонссон үнэн бол бид хоёул хааны алуурчид.

- Би Рэнлид хэзээ ч гэм хийхгүй. Намайг хийсэн гэж хэлсэн хүнийг ална.

- Тэгвэл Клеосоос эхэлсэн чинь дээр. Дараа нь чамд түүний үгийг давтаж тооцоо бодох олон хүн гарч ирнэ.

- Худал үг. Хатагтай Кателин эрхэм дээдсийг алагдахад тэнд байсан. Тэр харсан. Тэр бол сүүдэр байсан. Лааны гэрэл чичигнэн агаар хүйтэн болж цус...

- Өө, маш сайн байна гээд Жэйми инээд алдав.

- Чиний ухаан минийхээс хамаагүй сэргэлэн гэдгийг хүлээх байна. Тэд намайг үхсэн хааны дэргэд зогсож байхыг олоход миний ухаанд хэзээ ч "Үгүй, үгүй энэ би байгаагүй. Энэ бол сүүдэр байсан аймшигтай хүйтэн сүүдэр байсан" гэж хэлэх тухай орж ирээгүй гээд ахин хөхөрснөө,

- Нэг хааны алуурч нөгөөдөө хэлж байгаагийн адил надад үнэнийг хэлээч. Старкийнхан чамд түүнийг хоолойг огтол гэж хөлс төлсөн үү эсвэл Станнис байсан уу? Рэнли чамайг үл ойшоодог байсан биз дээ? Эсвэл чиний сарын юм ирсэн байсан юм уу? Хэзээ ч юм нь ирсэн эмэгтэйд илд бариулж болохгүй гэдэг гэв.

Агшин зуур Жэйми Бриенниг түүн рүү дайрах нь гэж бодлоо. *Ганиц алхам ойртох юм бол би хутгыг нь хуйнаас булааж аваад хэвлийд нь дүрэх болно доо.* Тэр хөлөө татан харайхад бэлтгэсэн ч эмэгтэй хөдөлсөнгүй.

- Хүлэг баатар байх ховорхон үнэ цэнэтэй зүйл. Дээрээс нь хааны хамгаалалтын хүлэг баатар шүү. Энэ бол цөөн хэдэн хүнд олддог бэлэг байхад чи жигшүүртэйгээр гутаасан байна.

Чиний үхтлээ хүсч байгаа ч хэзээ ч олдохгүй бэлэг, бүсгүй минь.

- Би хүлэг баатраа хүлээн авсан. Энэ надад юу ч өгөөгүй. Би арван гурван настай дагуул байхдаа тэмцээний халз тулаанд ялж байлаа. Арван тавтайдаа сэр Артур Дэйнтэй Хааны ойн Ахан дүүсийн эсрэг мордож тэр намайг тулааны талбар дээр хүлэг баатар болгосон. Энэ бол би цагаан нөмрөгийг биш тэр намайг гутаасан хэрэг. Иймээс надад атаархалаасаа ангижруулж үз. Бурхад л чамайг эрэгтэй болгоогүйгээс биш би биш.

Бриенн түүн рүү зэвүүцэл дүүрэн харав. *Тэр намайг дуртайяа хэдэн хэсэг болгон цавчин хаяж чадах байсан ч үнэ цэнэтэй амлалт нь байна. Сайн байна. Надад сулхан бишрэл охины зэмлэл хангалттай гэж бодлоо.* Хүүхэн үг дуугүй цааш явлаа. Жэйми Серсейгийн тухай зүүдлэхийг мөрөөдөн нөмрөг дороо атиралдав.

Гэвч тэр нүдээ аньсан хойно хаан ширээний өрөөнд ганцаар цус болсон эсгэсэн гараа барин холхиж байгаа Эйрис Таргарианыг харлаа. Тэрхүү тэнэг үргэлж өөрийгөө төмөр хаан ширээний орооцолдсон сэлмийн ирэнд эсгэдэг байжээ. Жэйми хааны хаалгаар алтан хуяг дуулгатай гартаа илд барин орлоо. *Алтан болохоос цагаан хуяг биш байсныг хэн ч санахгүй байгаа. Би тэр хараал идсэн нөмрөгийг ч гэсэн тайлж хаясан.*

Эйрис түүний илдэнд наалдсан цусыг хараад лорд Тайвиных эсэхийг мэдэхийг хүсэв.

- Би тэр урвагчийг үхсэн байхыг хүсч байна. Би чамайг түүний толгойг авчиран үлдсэн хэсгийг нь шатаахыг хүсч байна. Бүх урвагчийнхыг ч гэсэн. Россарт тэднийг хэрмийн дотор нэвтэрсэн гэж хэлсэн! гэснээ түүний хоолойны дулаахан өнгө алга болж,

- Хэний цус? Хэний цус бэ? гэлээ.

- Россартынх гэж Жэйми хариулав.

Хүрэн нүдний аньсага томрон хааны ам хашгирахаар нээгдлээ. Тэр үхтлээ айсандаа ухаанаа алдаж цааш эргээд төмөр хаан ширээний зүг зугтлаа. Хананд өлгөсөн гавлуудын хоосон нүдний ухархайн дор Жэйми сүүлчийн луун хааны биеийг гишгүүр дамжин хөөхөд гахай шиг чарлан өмхий ханх тавив. Ганцхан цавчилтаар тэр хоолойг нь огтлон зүйл дуусгалаа. *Дэндүү амархан юм. Хаан үүнээс амаргүй үхэх ёстой* гэж бодсоноо санав. Россарт ядахдаа тулалдахыг оролдсон ч үнэнийг хэлэхэд яг л алхимичийн ёсоор сарвалзжээ. *Тэдний хэзээ ч Россартыг хэн алсныг асуудаггүй нь хачирхалтай. Гэхдээ мэдээж тэр хэн ч биш дорд гаралтай ердөө хоёрхон долоо хоног Хааны гар байсан, Галзуу хааны ахин нэг зугаа төдий хүн.*

Сэр Элис Вестерлинг, лорд Крэйкхол болон эцгийнх нь бусад хүлэг баатрууд танхимд хүч түрэн орж ирээд болсон явдлыг хармагц Жэймид алга болох юм уу бардамнан өөрийгөө магтах арга байсангүй. Энэ зэмлэгдэх болно гэдгийг тэр тэдний харцнаас мэдэрлээ эсвэл магадгүй айдас ч байсан байж болох. Ланнистер ч бай үгүй ч бай тэр Эйрисийн долоон хүлэг баатрын нэг байлаа.

- Шилтгээн биднийх болсон, сэр. Хот ч гэсэн гэж Роланд Крэйкхол түүнд хэлсэн үгний хагас нь үнэн байлаа. Таргарианд үнэнч үлдсэн хүмүүс эргүүлгэн шат болон зэвсгийн агуулахад эсэргүүцэн тулалдсан хэвээр үхэж Грегор Клегэйн, Амори Лорч Мэйгорын бэхлэлтийн хана руу авиран, Нэд Старк умардынхаа дагуулан Хааны хаалгаар орж ирж байсныг Крэйкхол мэдсэнгүй.

Тэр Жэйми хааны харуул болохоос урьд лорд Тайвины хүү болохоор Эйрисийн алагдсаныг хараад гайхсангүй.

- Тэдэнд галзуу хааныг үхсэн гэж хэл. Бууж өгсөн хүмүүсийг өршөөж олзлогсдыг хорь гэж Жэйми тушаав.

- Би шинэ хааныг бас тунхаглах уу? гэж Крэйкхол асуухад Жэйми асуултыг тодорхой уншлаа. Эцэг чинь юм уу Роберт Баратеон эсвэл чи өөрөө шинэ луун хаан болох гэж байна уу? Тэр агшин зуур Лууны цохио руу зугтсан хөвгүүн Висерис болон Рэйгарын хөхүүл хүүхэд Эйгон Мэйгорын бэхлэлтэнд ээжтэйгээ байгаа тухай бодлоо. *Шинэ Таргариан хаан сууж миний эцэг Гар нь болно. Чононууд хэрхэн ульж шуурганы лордууд уурандаа хахаж цацах болоо.* Тэр хормын зуур үүнд хорхойссон ч шалан дээр цусанд далайд хэвтэх бие рүү ахин харлаа. *Тэдэнд хоёул түүний цус бий.*

- Хэн дуртайгаа зарла гэж Крэйкхолд хэлэв. Ингээд төмөр хаан ширээнд гарч илдээ өвдөг дээрээ тавин суугаад хэн хаант улсыг шаардахаар орж ирэхийг харахаар хүлээлээ. Энэ явдал болоход Эддард Старк түрүүлж орж иржээ.

Чамд ч гэсэн намайг шүүх эрх байхгүй, Старк.

Түүний зүүдэнд хуйларсан ногоон дөл дүрэлзэн шатаж буй үхдлүүд ирэв. Жэйми тэднийг тойрон алтан илдтэй бүжиглэн нэгийг цавчих тоолон оронд нь хоёр босч ирж байлаа.

Бриенн түүнийг гутлынхаа хоншоороор ёврон сэрээв. Ертөнц харанхуйлсан хэвээр бороо орж эхэлжээ. Тэд овъёсны боов, давсалсан загас болон сэр Клеосын эмээлийн ганзаганаас олсон бөөрөлзгөнө идээд нар мандахаас өмнө мордов.

ТИРИОН

Тайган хаалгаар чимээгүй гүнгэнэн орж ирэхдээ тоорын өнгөт намирсан торгон жанч өмсч нимбэгний үнэр ханхлуулжээ. Тэр зуухны дэргэд сууж байгаа Тирионыг хармагц дороо зогсож,

- Эрхэм лорд Тирион гэж тасалданги дуугаар хөхрөн хэлэв.

- Тэгэхээр чи намайг санаж байгаа хэрэг үү? Би бүр гайхаж эхэлж байлаа.

- Таныг эрүүл хүчтэй байгааг харах туйлын таатай байна. Гэсэн ч даруухан өрөөнд минь байгааг олно гэж бодоогүйгээ хүлээх ёстой гээд Варис нялуун инээмсэглэв.

- Өрөө чинь үнэхээр даруухан юм. Үнэнийг хэлэхэд бүр дэндүү гэмээр гээд Тирион Варисийг эцэг дээр нь дуудагдахыг хүлээж байгаад араар нь сэмхэн оржээ. Тайганы өрөө хойд ханын доод талд байрладаг гурван тохьтой цонхгүй сийрэгхэн жижигхэн тасалгаа байв.

- Би хүлээх зуураа дүүрэн сагс дүүрэн сонирхолтой нууц олохоор найдсан ч энд ямар ч цаас байсангүй гээд Тирион бас Аалзны үзэгдэлгүй орж гардаг нууц гарц эрсэн ч ижилхэн үр дүнгүй өнгөрчээ.

- Бурхад өршөөг домбонд чинь хоосон ус байна лээ. Чи авс шиг нарийхан өрөөнд унтаж эсвэл надад тэгж санагдсан ч байж болох юм чулуугаар хийсэн ор дэрэн дээр хэвтдэг бололтой гэхэд Варис хаалга хааж оньслов.

- Би нурууны өвчинтэй болохоор хатуу гадаргуу дээр унтахыг эрхэмлэдэг юм, эрхэм лорд.

- Би чамайг өдөн дэвсгэр дээр унтдаг хүн гэж бодсон юмсан.

- Би туйлын гайхаж байна. Та намайг тулааны дараа орхисонд уурлаа юу?

- Энэ бүр чамайг гэр бүлийн маань нэг гишүүн гэж бодогдуулахад хүргэсэн шүү.

- Энэ бол хайрын төлөө болсон хэрэг биш, эрхэм лорд. Би чинь уяхан сэтгэлтэй хүн харин таны сорви харахаас ч аймшигтай гээд тайган чичирч,

- Хөөрхий хамар чинь гэв. Тирион шархныхаа товрууг ууртай үрлээ.

- Магадгүй би ахин нэгийг алтаар хийлгэж болох юм. Харин чи ямар төрлийн хамар санал болгох вэ, Варис? Өөрийнх шигээ нууц үнэрлэдэг хамар уу? Эсвэл би алтны дарханд эцгийнх шигээ хамар хүсч байна гэж хэлэх үү? гээд мушийж,

- Миний хүндэт эцэг хичээнгүй хөдөлмөрлөж байгаа болохоор би барааг нь арай ядан харж байгаа. Надад хэлээч тэр эрхэмсэг мэйстер Пациллыг бага зөвлөлд сэргээн томилсон гэсэн үнэн үү? гэлээ.

- Тиймээ, эрхэм лорд.

- Тэгвэл би үүний төлөө хайрт эгчдээ талархах ёстой юу? гээд Пацилл эгчийнх нь гарын амьтан байсан тул Тирион түүнийг албанаас нь сахал сүр жавхлантай нь хамт мултлан харанхуй гянданд хаяулжээ.

- Тийм биш, эрхэм лорд. Эрхэмсэг мэйстерийг зөвхөн Нууц зөвлөл халж томилдог тул Пациллыг байр сууринд нь эргээн тавихыг шаардсан Хуучин хотын арчмэйстерүүдэд талархсан чинь дээр.

Хараал идсэн тэнэгүүд гэж Тирион бодлоо.

- Би Хэрцгий Мэйгорын зандалчин гурвыг нь сүхээр халсан гэдгийг санаж байна.

- Туйлын үнэн. Харин хоёрдугаар Эйгон эрхэмсэг мэйстер Жерардисаар луугаа тэжээсэн.

- Харамсалтай нь надад ямар ч луу байхгүй. Би Пациллыг зэрлэг галд дүрээд шатаах ёстой байж. Цайзынхан үүнийг эрхэмлэх байсан болов уу?

- Энэ илүү уламжлалыг ёсыг хадгална гээд тайган хөхрөв.

- Аз болоход ухаалаг толгойнууд давамгайлан Нууц зөвлөл Пациллыг халсан нөхцөлийг зөвшөөрөн залгамжлагчийг нь томилсон. Гуталчны хүү мэйстер Туркин, хэрмэл хүлэг баатрын бутач хүү мэйстер Эррек нарын өгсөн саналыг харгалзан тэд албан тушаал, угсаа гарлаас илүү авьяас чадварыг эрхэмлэдэгийн баталгаа болгон Нууц зөвлөл бидэнд Хайгардены Тайреллийн мэйстер Гормоныг илгээсэн. Намайг энэ тухай лорд эцэгт чинь мэдэгдсэн даруй хөдөлсөн.

Нууц зөвлөл Хуучин хотод хаалттай хаалганы цаана хуралддаг болохоор хэлэлцүүлэг нь нууц байдлыг Тирион мэдэж байв. *Тэгэхээр Варист Цайзад ч гэсэн жижигхэн шувууд байгаа байх нь.*

- Би ойлголоо. Тэгэхээр миний эцэг сарнайг цэцэглэхээс нь өмнө цомирлогийг нь чимхэхээр шийдсэн хэрэг үү. Пацилл бол бах. Гэхдээ Тайреллын бахнаас илүү Ланнистерын бах дээр юм биз дээ? гээд Тирион инээвхийлэв.

- Эрхэмсэг мэйстер Пацилл үргэлж танай овгийн сайн анд нөхөр байсаар ирсэн. Магадгүй та сэр Борос Болунтыг ч гэсэн байр сууриндаа эргэн тавигдсаныг мэдээд сэтгэл чинь тайтгарах бизээ.

Серсей сэр Боросын цагаан нөмрөгийг Бронн ханхүү Томменыг Росбигийн зам дээр барьж авах үед амиараа хамгаалсангүй хэмээн мулт татан авсан билээ. Энэ хүн Тирионы нөхөр биш ч үүний дараанаас Серсейг дутахааргүй үзэн ядах болжээ. *Би үүнийг ямар нэг зүйлд ашиглаж болох юм.*

- Блоунт ч сагсуу хулчгар амьтан даа.

- Тийм гэж үү? Гэсэн ч Хааны хамгаалалтын хүлэг баатар болохоор уламжлалын дагуу насаараа зүтгэх ёстой. Сэр Борос магадгүй ирээдүйд эр зориггоо баталж болох юм. Түүнийг туйлын үнэнч хэвээр гэдэгт эргэлзэх зүйлгүй гэхэд,

- Миний эцэгт гэж Тирион цохон хэллээ.

- Бидний нэгэнт Хааны хамгаалалтын тухай сэдэв ярилцаж байгаагынх... энэхүү гэнэтийн таатай зочлолт чинь сэр Боросын амь үрэгдсэн ах зоригт сэр Мандон Моортой холбоотой юм биш биз дээ? Таны хүн Бронн түүний тухай сүүлийн үед ихэд сонирхож байгаа гээд тайган энгэсэгтэй хацраа үрчив.

Бронн сэр Мандоны тухай бүх зүйлийг онгичсон ч Варис энэ тухай олон зүйл мэдэж байгаа нь эргэлзээгүй бөгөөд зөвхөн хуваалцах юм бол ч...

- Тэр хүн ямар ч найз нөхөдгүй бололтой гэж Тирион болгоомжтой хэлэв.

- Гашуудалтай хичнээн гунигтай гээч. Хэрвээ та Хөндийн чулуунуудыг эргүүлэн нэгжвэл ямар нэг хамаатан садныг нь олж магадгүй ч харин энд бол... лорд Аррин түүнийг Хааны газар авчирч Роберт цагаан нөмрөг шагнасан ч хэн нь ч хайргүй байсан гэж эмээж байна. Тэр эргэлзээгүй гарамгай хүч чадлаа үл харгалзан жирийн ардуудыг тэмцээн дээр баясгах төрлийн хүн биш. Хааны хамгаалалтын ахан дүүс нь хүртэл дулаан харьцаж байгаагүй. Сэр Барристан нэг удаа тэр хүнийг сэлэмнээсээ ондоо анд нөхөргүй үүргээсээ одоо амьдралгүй гэж хэлж байсан ч... та юу эс андах хойно гэхдээ Сэлмиг магтаж хэлсэн гэж бодохгүй байна. Энэ тухай бодож үзэхэд хачирхалтай байгаа биз дээ? Бид Хааны харуулд өөрийнхөө төлөө амьдрах бус хааны төлөө амь биеэ зориулдаг хүн эрдэг. Гэхдээ энэ тухайд бол манай зоригт сэр Мандон төгс цагаан хүлэг баатар байсан. Тэгээд ч Хааны хамгаалалтын хүлэг баатрын ёсоор гартаа илдтэй хааны удмын цусны хүнийг хамгаалан үхсэн гээд тайган нялуун инээмсэглэн түүнийг цоо ширтэв.

Хааны удмын цусны хүнийг алахыг оролдсон гэж чи хэлэх гээ юу. Тирион Варисийг хэлж байгаагаасаа илүү зүйлийн тухай мэдэх эсэхийг гайхширлаа. Тэр түүнээс шинэ зүйл сонссонгүй. Бронн ижилхэн мэдээлэл авчирчээ. Харин түүнд Серсейтэй холбоотой сэр Мандон эгчийнх нь муурын сарвуу байсан гэдэг баримт хэрэгтэй байв. *Бид үргэлж хүссэн зүйлээ авдаггүй хойно* гэж гашуудалтай бодов.

- Энэ бол Сэр Мандон намайг энд авчирсан хэрэг биш.

- Тийм гэдэгт итгэлтэй байна гээд тайган өрөөн дундуур яван домботой усаа аваад,

- Би таньд үйлчлэх үү, эрхэм лорд? гээд аяганд дүүргэв.

- Тийм. Гэхдээ усаар биш. Би чамайг надад Шэйг авчирч өгөхийг хүсч байна гээд Тирион гараа энгэртээ зөрүүлэхэд,

- Энэ ухаалаг хэрэг гэж үү, эрхэм лорд? Хөөрхий хонгор хүүхэд. Эцэг чинь түүнийг дүүжилвэл хичнээн ичгүүртэй хэрэг байх вэ гээд Варис ус залгилав.

Варис энэ тухай мэдэж байгаа явдал нь Тирионыг гайхуулсангүй.

- Үгүй энэ ухаалаг биш хэрэг. Гэхдээ би түүнийг явуулахаасаа өмнө сүүлчийн удаа харах гэсэн юм. Түүнийг ийм ойрхон байхыг тэвчиж чадахгүй нь.

- Би ойлгож байна.

Чи хаанаас ойлгох юм? Тирион түүнийг ердөө өчигдөрхөн эргүүлгэн шатаар хувинтай устай өгсөж байхыг нь харжээ. Түүнчлэн залуу хүлэг баатар хүнд хувинг нь өргөж явахыг санал болгохыг харсан байна. Шэй түүний гарт хүрэн инээмсэглэхэд Тирионы дотор зангирчээ. Тэд түүний хажуугаар өгсөн Шэйгийн угаасан үсний цэвэрхэн үнэр ханхлахаар инчийн зайтай өнгөрчээ.

- Эрхэм лорд гэж Шэй үл мэдэг мэхийн хэлэхэд Тирион гараа сунган түүнийг тэвэрч газар дээр нь үнсэхийг хүссэн ч чадах бүх зүйл гэвэл хөшүүн толгой дохиод цааш сажлан холдох явдал байлаа.

- Би түүнтэй хэдэн удаа тааралдсан ч ярилцаж зүрхэлсэнгүй. Миний үйл хөдлөлийг тандаж байгаа гэж сэжиглэж байна.

- Таны сэжиглэл ухаалаг байна, эрхэм лорд.

- Хэн юм? гээд Тирион толгой сэжлээ.

- Кетлблакийнхан эгчид чинь алхам тутам бүрийг чинь мэдээлж байгаа.

- Би тэдгээр өөдгүй амьтдад хичнээн зоос төлсөн билээ. Чи тэднийг илүү их алт Серсейгээс холдуулж чадна гэж бодож байна уу?

- Боломж үргэлж байдаг ч би амжилтанд хүрнэ гэж мөрий тавихгүйсэн. Тэд одоо гурвуул хүлэг баатар болсны дээр эгч чинь цаашдын өсөлтийг амласан байгаа гээд тайганы уруул дээр хорон инээмсэглэл тодорлоо.

- Хамгийн том нь болох Хааны хамгаалалтын сэр Осмунд гарцаагүй өөр ивээлийн талаар мөрөөдөж байгаа. Та хатантай зоосоороо тэнцэж болох ч түүнд шавхагдашгүй ундаргатай хоёр дахь хэтэвч бий гэж бодож байна.

Долоон там минь гэж Тирион бодлоо.

- Чи Серсейг Осмунд Кетлблактай унтаж байгаа гэж хэлэх гээ юу?

- Өө, үгүй ээ үүнийг туйлын аюултай гэж бодохгүй байна уу? Үгүй дээ хатан зөвхөн... маргааш юм уу эсвэл хуримын өдөр болохын дохио болгон.. инээмсэглэн, шивнэж, бүдүүлгээр хошигнон... дэргэдүүр нь өнгөрөхөд Осмунд ханцуйгаараа цээжийг нь хөнгөн шүргэж байгаа нь тийм зүйл санагдуулсан хэрэг. Гэхдээ тайган хаанаас ийм зүйлийг мэднэ гэж? гээд хэлний үзүүрээрээ доод уруулаа ичимхий ягаан амьтан шиг долоолоо.

Хэрвээ би ямар нэг аргаар тэдний зальжин энхрийлэлийг цааш түлхэж чадах юм бол аавыг оронд хамт байхад нь барихаар зохион байгуулж болох юм... Тирион хуруугаараа хамрынхаа шархыг маажлаа. Тэр үүнийг яаж хийхийг мэдээгүй боловч магадгүй дараа боломж гарч ирэх бизээ.

- Зөвхөн Кетлблакийнхан байгаа юу?

- Энэ үнэн ч болоосой, эрхэм лорд. Гэсэн ч би таныг олон нүд харж байгаа гэж эмээж байна. Та юу гэж ч хэлмээр юм дээ нүдэнд өртөмтгий хүн шүү дээ. Бас хайр хүндлэл хүлээдэггүй гэдгийг гашуудалтайгаар хэлэх байна. Жэйнос Слингтийн хөвгүүд эцгийнхээ өшөөг авахын тулд таны тухай дуртайяа мэдээлж, манай эрхэм лорд Петайрт Хааны газрын эмсийн хүрээлэнгийн тэн хагаст нь найз нөхөд бий. Хэрвээ болчимгүй зан гарган тэдний нэгд орвол тэр даруй мэдэх болохоор дараа нь лорд эцэг чинь мэдэх болно.

Энэ миний айснаас ч дор юм байна.

- Харин миний эцэг? Тэр намайг хэнээр тандуулж байгаа вэ? гэхэд энэ удаад тайган чангаар инээлээ.

- Яагаад би байж болохгүй гэж, эрхэм лорд.

Тирион ч гэсэн хөхрөв. Тэр Варист цаашид итгэхээр дүүрчихсэн тэнэг биш ч тайган хэдийн Шэйгийн тухай дүүжилэхэд хүрэхээр хангалттай мэдэх байв.

- Чи Шэйг над руу ханан дотуур энэ бүх нүднээс далдуур авчир. Өмнө хийж байсан байсан шигээ гэхэд Варис гараа базаж,

- Өө эрхэм лорд намайг үүнээс ондоо юу ч баярлуулахгүй ч гэхдээ... та миний санааг асуувал Мэйгор хаан ханандаа хархтай байхыг хүсээгүй. Тэр дайснаа занганд оруулахын тулд нууц гарцууд хийсэн ч хаалга нь бусад хонгилтой холбогддоггүй. Би Шэйг хатагтай Лоллисоос хэсэг хугацаанд хулгайлж чадлаа гэхэд унтлагын өрөө рүү чинь хүний нүдэнд үзэгдэхгүй аваачиж чадахгүй.

- Тэгвэл түүнийг хаа нэгтээ өөр газар аваач.

- Гэхдээ хаашаа гэж? Энд аюулгүй газар байхгүй.

- Байна энд. Чиний чулуу шиг хатуу орыг арай дээр ашиглах цаг болсон гэж бодож байна гээд Тирион инээлээ.

Тайган амаа ангайснаа хөхрөв.

- Лоллис сүүлийн үед амархан ядардаг болсон. Тэр хүүхэдтэй болохоор гэдэс нь томорсон байгаа. Би түүнийг сар мандахад аюулгүй нойрсоно гэж бодож байна.

- Тэгвэл сар мандахад шүү. Дарс байлгах талаар санаа тавиарай. Бас хоёр цэвэр аяга гээд Тирион сандлаас үсрэн буулаа.

- Эрхэм лордын тушаасан ёсоор больё гээд Варис бөхийв.

Өдрийн үлдсэн хэсэг бурманд мөлхөж яваа өт мэт удаан өнгөрөв. Тирион өөрийгөө

сатааруулахын тулд цайзын номын сан руу очиж Белдесарын "Ройнишийн Дайны түүх"-ийг уншихыг хичээсэн ч зааны зургийг Шэйгийн инээмсэглэл болгон хараад байлаа. Үдээс хойш болоход номоо хажуу тийш тавиад халуун ус бэлдэхийг тушаав. Тэр ус хөртөл өөрийгөө сойздон угааж Под сахлыг нь авлаа. Түүний сахал цагаан, шаргал, хар үс холилдсон алаг цоог ширүүн ургаж царайных нь зарим хэсгийг халхалж байсан тул хамаагүй дээрдлээ.

Цэвэрхэн ягаан болж сахлаа эмжин тайруулсан хойно Тирион хувцасны шүүгээ рүүгээ очиж Ланнистерийн улаан хүрэн өнгийн бариу атлаасан өмд, арслангын толгойн товчтой хамгийн сайн хилэн хар хантаазаа өмслөө. Түүнчлэн үхлээ хүлээн хэвтэж байхад нь эцгийнхээ хулгайлсан гарын дүрстэй алтан гинжийг ч гэсэн зүүв. Ингээд хувцаслаж дууссан хойно хичнээн тэнэг болохоо мэдлээ. *Долоон там минь гэж чи бүх ухаанаа хамартайгаа алдаа юу? Чамайг харсан хэн ч гэсэн ордны хувцастай тайган руу очиж юу хийх гэж байгааг гайхна биз дээ.* Тирион хараал тавьсаар тайчаад ахин хувцаслахдаа энгийн хувцас болох хар ноосон өмд, хуучин цагаан цамц, гандсан хүрэн ширэн хантааз өмслөө. *Энэ хамаагүй. Чи юу ч өмссөн байсан одой хэвээр байх болно. Чи хэзээ ч шатан дээр байсан хүлэг баатар шиг өндөр, урт шулуун хөл хатуу гэдэс, өргөн эр хүний мөртэй болохгүй* гэж сар гарахыг хүлээх зуураа өөртөө хэлэв.

Хэрмийн ханан дээгүүр саран мандахад Подрик Пэйнд Варистай уулзахаар очих болсноо хэлэв.

- Та удах уу, эрхэм лорд? гэж хүү асуулаа.

- Өө, тэгнэ гэж найдаж байна.

Улаан шилтгээн дүүрэн хүнтэй байсан болохоор Тирионд анзаарагдалгүй өнгөрөх найдлага байсангүй. Сэр Бэйлон Свон хаалган дээр, сэр Лорас Тайрелл буулгадаг гүүрэн дээр харуулд зогсож байлаа. Тэр зогсож хоёулантай хэдэн аятай үг солив. Өмнө нь үргэлж солонго шиг тод хувцасладаг байсан Цэцэгт хүлэг баатрыг цасан цагаан хувцастай байхыг харах нь хачирхалтай хэрэг байлаа.

- Сэр Лорас та хэдтэй билээ? гэж Тирион түүнээс асуув.

- Арван долоо, эрхэм лорд.

Арван долоотой, үзэсгэлэн гоо аль хэдийн домог болсон. Долоон ханлигийн охидын хагас нь түүнтэй нэг оронд орж бүх хөвгүүд түүний оронд байхыг хүсч байгаа байх даа.

- Миний асууж буй өршөөгөөрэй сэр... гэхдээ яагаад арван долоотой хүн Хааны хамгаалалтанд орохыг сонгодог байна?

- Луун хүлэг баатар ханхүү Эймон арван долоотойдоо тангараг өргөсөн. Таны ах Жэйми ч гэсэн ижил залуу байсан гэж сэр Лорас хэлэв.

- Би тэдний шалтгааныг мэднэ. Харин чинийх юу юм? Мерин Грант, Борос Блоунт мэтийн үлгэр жишээ хүмүүсийн дэргэд зүтгэх явдал уу? гээд Тирион шоолонгуй мушийлаа. - Хааныг амьдралыг хамгаалж өөрийнхийгөө гарзанд гаргана. Чамд газар нутаг, хэргэм зэрэг гэрлэж үр хүүхэдтэй

болох найдлага байхгүй...

- Тайреллийн овгийг миний ах нар үргэлжлүүлнэ. Гурав дахь хүү заавал гэрлэж хүүхэдтэй болох албагүй.

- Албатай биш л дээ гэхдээ зарим нэг таашаалыг яах вэ. Хайр яах болж байна?

- Нар жаргахад лааны дөл орлож чадахгүй.

- Энэ дуунд гардаг уу? Тиймээ, чамайг арван долоотой болохыг би одоо л харлаа гээд Тирион толгойгоо гилжийлгэн инээмсэглэв.

- Та намайг шоолж байна уу? гээд сэр Лорас биеэ хөвчиллөө.

Өрвөлзсөн залуу байх нь.

- Үгүй. Хэрвээ чамайг гомдоосон бол намайг өршөөгөөрэй. Би урьд нь өөрийн хайртай байсан болохоор бидэнд дуу ч гэсэн байлаа гээд тэр сэр Лорасд үдшийг тавтай өнгөрүүлэхийг ерөөгөөд замаа үргэлжүүлэв. *Би нарны гэрэл үсэнд нь тоглосон зун шиг үзэсгэлэнтэй бүсгүйд хайртай.*

Нохдын байрны ойролцоо бүлэг цэргүүд хоёр нохой зодолдуулж байлаа. Тирион зогсож багавтар нохой нь томынхоо нүүрний талыг хүүчин хаяхыг харж Сандор Клегэйнийг санагдуулам цөөн хахир дуугаар инээд алдаад үүгээр тэдний сэжиглэлийг арилгасан гэж найдан хойд хэрэм рүү зүглэн хэсэг уруудаад тайганы даруухан оромжинд оров. Түүнийг цохихоор гараа өргөхөд хаалга нээгдлээ.

- Варис? Чи энд байна уу? гээд Тирион дотогш гулган оров. Ганц лааны дөл бүүдгэр харанхуйг гийгүүлж агаарт мэлрэг цэцгийн үнэр ханхлана.

- Эрхэм лорд гээд лааны гэрэлд булцгар зөөлөн намбатай өтгөн хар буржгар үсний дор дугуй ягаан сар шиг царайтай эмэгтэй хөндлөн гарч ирэхэд Тирион эрхгүй ухарлаа.

- Ямар нэг зүйл болохгүй байна уу? гэж урдаас нь асуухад Варис болохыг уурсан ойлгов.

- Аймшигтай нэг агшинд би чамайг Шэйгийн оронд Лоллисийг авчирсан гэж бодлоо шүү. Ингэхэд тэр хаана байна?

- Энд байна, миний лорд. Миний юу өмссөнийг таагаач? гээд Шэй араас нь нүдийг гараараа таглав.

- Юу ч биш үү?

- Өө, та ямар ухаалаг юм бэ. Яаж мэдээ вэ? гээд тэр хошуу цорвойлгон гараа холдуулав.

- Чи юу ч өмсөөгүй үедээ маш үзэсгэлэнтэй байдаг.

- Би юу? Үнэхээр тийм гэж үү?

- Тэгэлгүй яахав.

- Тэгвэл ярихын оронд надтай хавьтахгүй юм уу?

- Бид эхлээд хатагтай Варисаас салах хэрэгтэй. Би үзэгчтэй байх дургүй төрлийн одой шүү гэхэд,

- Тэр явчихсан гэж Шэй хэллээ.

Тирион эргэж харахад энэ үнэн байв. Тайган банзалтайгаа алга болжээ. *Энд хаа нэгтээ нууц гарц байна.* Түүнийг энэ тухай бодож амжихаас урьтаж Шэй толгойг нь эргүүлэн үнслээ. Түүний уруул нойтон шуналтай байсан бөгөөд сорви, хамрынх нь шүүрхий товрууг анзаарсангүй бололтой. Тирион торго шиг зөөлөн бүлээн арьсан дээр нь хуруу гүйлгэн эрхий хуруугаараа зүүн талын хөхний товчийг имрэх төдий хатуурав.

- Түргэлээрэй, түргэлээрэй. Би чамайг намайг эзэмдэхийг хүсч байна гэж Шэй үнсэлт дундуураа шавдуулан хуруугаараа өмднийх нь үдээсийг тайлав. Тирионд хувцсаа зохистой тайлах ч цаг байсангүй. Шэй өмдийг нь угз татан түүнийг шалан дээр түлхэж хэвтүүлээд дээр нь мордож хашгиран ёолон цовхчиж,

- Миний аварга, аварга, аварга гэж дээш доош болох тоолон хашгирав. Тирион тэсгэлгүй байж ядсан болохоор тав дахь удаад нь тавихад Шэй хайхарсангүй. Шүршихийг нь мэдээд инээмсэглэн урагш бөхийж духан дээрх хөлсийг нь үнсэж,

- Миний аварга Ланнистер. Дотроос минь битгий гаргаарай. Чамайг тэнд байхыг мэдрэх таатай байна гэж шивнэв.

Тирион хөдөлсөнгүй гар сунган түүнийг тэвэрлээ. *Түүнийг ахин тэврэх сайхан байна. Яаж ийм сайхан зүйлийг гэмт хэрэг гэж тооцон түүнийг дүүжилж болох юм бэ?* гэж бодов.

- Шэй хонгор минь бид хамгийн сүүлчийн удаа хамт байна. Аюул дэндүү их. Хэрвээ миний лорд эцэг чамайг олвол...

- Надад сорви чинь таалагдаж байна. Энэ чамайг хүчтэй догшин харагдуулж байна гээд Шэй хуруугаараа илбэхэд,

- Маш үзэмжгүй гэж чи хэлэх гээ юу? гээд Тирион хөхөрлөө.

- Миний лорд хэзээ ч нүдэнд минь үзэмжгүй харагдахгүй гээд Шэй хамрынх нь ёзоорыг халхалсан шархны товрууг үнслээ.

- Чамд миний царайд санаа зовох хэрэг байхгүй. Хэрвээ миний эцэг...

- Тэр намайг айлгахгүй байна. Миний лорд одоо үнэт эрдэнэ торгыг маань эргүүлж өгөх болов уу? Би тулалдаанд шархадсан хойно чинь Варисаас асуусан ч тэр надад өгөөгүй. Хэрвээ чамайг үхсэн

бол тэд яах байсан бол?

- Би үхээгүй. Энд байна.

- Мэдэж байна гээд Шэй дээр нь мурилзан инээмсэглэлээ. - Хаана байх ёстой газартаа гээд хошуугаа цорвойлгон,

- Гэхдээ одоо бие чинь сайжирсан болохоор би хэр удаан Лоллистэй хамт байх ёстой юм бэ? гэв.

- Чи сонссонгүй юу? Чи Лоллистой хэр удаан хугацаагаар хамт байж болох ч хотыг орхисон чинь дээр.

- Би эндээс явахыг хүсэхгүй байна. Чи тулалдааны дараа намайг харш руу маань ахин аваачихыг амласан. Ланнистерийнхан үргэлж өрөө төлдөг гэж чи хэлсэн гээд хэвлийн доод хэсгээ чангалахад Тирионы эрхтэн ахин хатуурч эхлэв.

- Шэй бурхад минь гэж үүнийгээ зогсоо. Намайг сонс. Чи явах ёстой. Хот одоо Тайреллийнхнаар дүүрэн болохоор намайг ойроос харуулдаж байгаа. Чи ямар аюултай болохыг ойлгохгүй байна.

- Би хааны хуримын найранд орж болох уу? Лоллис явахгүй гэсэн. Би түүнд эзэн хааны өрөөнд хэн ч хүчиндэхгүй гэж хэлсэн ч тэр дэндүү тэнэг болохоор гээд Шэй дээш болоход Тирионы эрхтэн нойтон чимээ гарган мултарлаа.

- Саймон тэнд дуучид дуулж, жонглёрчид жонглёрдон, тэнэгүүдийн ирүүл тулаан хүртэл болно гэж хэлсэн.

Тирион Шэйгийн гурав дахин хараал идсэн дуучингийн тухай бараг мартсан байлаа.

- Чи Саймонтой яаж яриа вэ?

- Би хатагтай Тандад түүний тухай хэлэхэд Лоллист тоглуулахаар хөлсөлж авсан. Хүүхэд нь дотроос өшиглөж эхлэхэд хөгжим түүнийг тайвшируулдаг. Саймон тэнд найран дээр бүжиглэдэг баавгай ирж, Арбороос дарс авчирна гэсэн. Би хэзээ ч бүжиглэдэг баавгай харж байгаагүй.

- Тэд үүнийг надаас хамаагүй дор бүжнэ гээд Тирионы сэтгэлийг дуучин зовоож байгаагаас бус баавгай биш байлаа. Ганц хайхрамжгүй үг буруу чихэнд сонсогдоход Шэй дүүжлэгдэх болно.

- Саймон тэнд далан долоон төрлийн хоолоор үйлчилж, зуун тагтаатай том бялуу ирнэ гэсэн. Оройг нь онгойлгоход шувуу дотроос нь дүрсхийн ниснэ.

- Харин дараа нь дээврийн нуруунд суусныхаа дараа доошоо зочид руу сангасаар бороо оруулна гээд Тирион урьд нь ийм хуримын бялуунд өртөж байжээ. Тэр онцгойлон тагтаанууд дээрээс нь сангасаа унагах дуртай гэж сэжиглэдэг байв.

- Би зарц эмэгтэйн оронд торго хилэн даашинзаа өмсөж хатагтай шиг очиж болохгүй юу? Хэн ч намайг биш гэдгийг мэдэхгүй.

Чамайг биш гэдгийг хүн бүхэн мэднэ гэж Тирион бодлоо.

- Хатагтай Танда Лоллисийн зарц хаанаас ийм олон зүүлттэй болсныг гайхна биз.

- Тэнд мянган зочин ирнэ гэж Саймон хэлсэн. Тэр намайг олж харах ч үгүй. Би тавцангийн доод талын харанхуй буланд зогсоод чамайг жорлон явахаар босоход гарч уулзана гээд эрхтэнийг нь зөөлөн үрлээ.

- Би даашинзан дотроо ямар ч дотуур хувцас өмсөхгүй болохоор миний лордод тайлах ч хэрэг гарахгүй гээд хуруугаа дээш доош шувтарч,

- Эсвэл тэр намайг үүнийг хийвэл дуртай байх уу гээд амандаа үмхлээ.

Тирион төдөлгүй ахин бэлэн болов. Энэ удаад тэр удаан тэслээ. Дуусах үед нь Шэй дээшээ харан гарыг нь дэрлэн хэвтэв.

- Чи намайг авч явах уу?

- Шэй энэ аюулгүй биш гэж Тирион дуу алдан гонгинов.

Энэ удаад тэр юу ч хэлсэнгүй. Тирион түүнтэй өөр зүйлийн тухай ярилцахыг хичээсэн ч дотогш алхан орж ирсэн хойд хэрэм шиг нь дийлдэшгүй хүйтэн хатуу дүнсгэр эелдэг байдалтай тулгаргав. *Бурхад минь би яаж Тайшагийн дараа энэ бүх зүйлийг болохыг зөвшөөрөө вэ? Би үнэхээр эцгийнхээ боддог шиг дүүрчихсэн тэнэг гэж үү?* хэмээн лааны тос хайлан анивчихад ядрангуй бодлоо. Тэр дуртайяа түүний хүссэн зүйлийг баяртайгаар өгч унтлагын өрөө рүүгээ гар дээрээ авч яван торго хоргой, хилэн зэрэг дуртай зүйлсээр нь хувцаслах байв. Түүний сонголтоор болдог байсан бол Шэй Жоффригийн хуримын найр дээр дэргэд нь суугаад баавгайтай цуг бүжиглэх байв. Гэсэн ч Тирион түүнийг дүүжлүүлэхийг харж чадахгүй.

Лааны дөл унтрахад Тирион дээшээ босч нэгийг асаалаа. Тэр ханыг тойрон явж тус бүрийг нь тогшин нууц гарц хайв. Шэй өвдгөө тэврэн суугаад түүнийг ширтэж байв. Эцэст нь,

- Тэр орон доор байгаа. Нууц шат гэв.

- Ор гэнэ ээ? Ор хагас тоннын жинтэй цул чулуун дээр байна шүү дээ гээд Тирион гайхширан ширтлээ.

- Тэнд Варис түлхэхэд дээшээ өргөгддөг юм. Би түүнээс яаж гэдгийг нь асуусан ч энэ бол ид шид гэж хэлсэн.

- Тиймээ. Эсрэг жингийн шид гээд Тирион инээхэд Шэй босч зогсов.

- Би буцах ёстой. Заримдаа Лоллисийн хүүхэд тийрэхэд сэрээд намайг дууддаг.

- Варис удахгүй ирнэ. Тэр гарцаагүй бидний үг бүрийг сонссон байх гээд Тирион лаагаа доош тавилаа. Түүний өмдний урд тал нойтон толбо болсон ч харанхуйд мэдэгдсэнгүй. Тирион Шэйд

хувцасла гэж хэлээд тайганыг хүлээв.

- Би тэгнэ. Чи миний арслан биз дээ? Миний аварга Ланнистер?

- Тиймээ мөн. Харин чи бол...

- ...янхан чинь гээд Шэй хуруугаа уруул дээр нь тавилаа.

- Би чиний хатагтай хэзээ ч болж чадахгүй гэдгээ мэднэ. Үгүй бол чи намайг найр луу аваач. Гэхдээ тэр хамаагүй. Би чиний янхан байхдаа дуртай байна, Тирион. Зөвхөн намайг өөртэйгээ байлгаж аюулгүй байлгаарай, арслан минь.

- Тэгнэ ээ гэж Тирион амлалаа. *Тэнэг, тэнэг. Чи яах гэж ингэж хэлж байгаа юм бэ? Чи энд түүнийг явуулахын төлөө ирсэн биш үү!* гэж дотроос нь хоолой хашгирлаа. Гэсэн ч оронд нь тэр ахин үнслээ.

Буцаж явах уйтгартай ганцаардмал санагдав. Подрик Пэйн Тирионы хөлд дэвсгэр дээр унтаж байхад нь сэрээгээд,

- Бронн гэж хэлэв.

- Сэр Бронн уу? гээд Подрик нойрмог нүдээ нухав.

- Өө. Би түүнийг авчирах ёстой юу? Эзэнтээн?

- Яагаад үгүй гэж би чамайг түүний хувцасны тухай яриа өдүүлэх гэж сэрээсэн юм гэж Тирион даажигнан хэлсэн ч хошигнол нь талаар өнгөрөв. Под урдаас нь самгардан гөлөрсөнд гараас нь татан,

- Тиймээ, түүнийг авчир. Яг одоо гэв.

Залуу түргэхэн хувцаслаад хар хурдаараа өрөөнөөс гарч гүйлээ. *Би тийм аймшигтай байсан юм болов уу?* гэж Тирион гайхшираад унтлагын хувцсаа сольж өмсөн өөртөө дарс аягаллаа.

Түүнийг гурав дахь аягаа ууж байтал шөнө дунд өнгөрөхөөс өмнө Под эцэст нь эргэж ирэхдээ хөлсний цэрэг хүлэг баатрыг чаргууцалдан авчирав.

- Хүү намайг хараал идсэн сайн шалтгааны улмаас Чатаяагаас чирж гаргасан гэж найдъя хэмээн Бронн суух зуураа хэлэв.

- Чатаяа гэнэ ээ? гэж Тирион уурсан асуулаа.

- Хүлэг баатар байх сайхан юм. Гудамжны дагуу хямдхан эмсийн хүрээлэн эрэхийн ч хэрэг байхгүй. Одоо Алаяая, Марай хоёр өдөн оронд сэр Броннтой цуг байгаа гээд Бронн инээлээ.

Тирион уураа арай ядан барилаа. Бронн өөр бусад хүмүүсийн адилаар Алаяаяатай хоноглох

эрхтэй ч... *Миний хичнээн хүсч байсан ч түүнд хүрэхгүй байсныг Бронн мэдэхгүй. Тэр түүнээс зайтай байх ёстой.* Тирион Чатаяа руу явж зүрхэлсэнгүй. Хэрвээ ингэвэл Серсей мэдээд эцэгт нь дуулгаж Алаяаяа ташуурдуулахаас ч илүү зовлон амсана. Тэр охинд уучлалт гуйсны тэмдэг болгон хос бугуйвчтай нь ижилсүүлсэн хаш чулуутай мөнгөн гинж илгээсэн ч...

Энэ бүхэн үр дүнгүй болжээ.

- Тэнд өөрийгөө Мөнгөн хэлт Саймон хэмээгч дуучин байна. Тэр хатагтай Тандагын охинд заримдаа хөгжим тоглож өгдөг гэж Тирион гэмээ хойш тавин ядрангүй хэллээ.

- Тэр яасан гэж?

Түүнийг ал гэж хэлмээр байсан ч тэр хүн хэдэн дуу дуулснаас өөр хэрэг хийгээгүй билээ. Дээрээс нь Шэйгийн толгойг тагтаа, бүжиглэдэг баавгайгаар дүүргэсэн. Гэсэн ч оронд нь,

- Түүнийг ол. Түүнийг өөр хэн нэгэн олохоос өмнө хайж ол гэж хэлэв.

АРЪЯА

Тэр үхсэн хүний цэцэрлэгээс ногоо зулгааж байтал дуу дуулах сонсогдлоо.

Арьяа чулуу шиг хөшин сонсоход гартаа барьсан гурван лууван мартагдаж Цуст жүжигчид болон, Рус Болтоны хүмүүсийн тухай бодол төрөхөөс айсандаа нуруугаар нь чичрүүдэс хүрлээ. *Энэ чинь шударга биш байна. Бид эцэст нь Сэрээнд хүрч бараг л аюулгүй болсон гэж бодож байхад.*

Гэхдээ жүжигчид яагаад дуулдаг билээ?

Дуу голын зүүн тийш багахан өгссөн хэсгийн цаанаас дуулдаж байлаа.

- *Би Цахлай суурин руу үзэсгэлэнт охинтой уулзахаар явлаа даа хэй-хо хэй-хо...*

Арьяа гартаа луувангаа барин өндийлөө. Энэ нь дуучин голын замаар өгсөн ирж буйтай адил сонсогдож байв. Байцаан дунд байсан Халуун бялуугийн царайны байдлаас үзвэл бас сонссон бололтой. Харин Жэндри шатсан байшингийн сүүдэрт унтахаар явсан болохоор юу ч сонссонгүй.

- *Би амтат үнсэлтийг нь илднийхээ үзүүрээр хулгайлна даа хэй-хо, хэй-хо.* Арьяад гол зөөлөн хоржигнох чимээ, дуучны хоолойноос гадна модон ятга бас сонсогдох шиг болов.

- Чи сонсов уу? Хэн нэгэн ирж байна гэж гартаа дүүрэн байцаа тэвэрсэн Халуун бялуу сөөнгөтөн шивнэв.

- Жэндриг сэрээ. Чимээ гаргалгүй мөрнөөс нь сэгсрээрэй гэж Арьяа хэлэв. Жэндриг сэрээхэд амархан байхад Халуун бялууг өшигчиж хашгичих хэрэг гарна.

- *Би түүнийг хайртаа болгож сүүдэрт амарна даа хэй-хо, хэй-хо* гээд дууны үг улам чангарлаа.

Халуун бялуу гараа дэлгэхэд байцаа газар зөөлөн түсхийн уналаа.

- Бид нуугдах хэрэгтэй.

Хаана? Шатсан байшинтай цэцэрлэг Сэрээний эргийн дэргэд байв. Тэнд голын эрэг дагуу цөөн хэдэн уд ургаж түүнээс цааш зэгс ургасан шаварлаг гүехэн устай ихэнх хэсэг нь нүцгэн газар байлаа. Бид ойгоос гарах ёсгүй байсныг мэдсэн юмаа гэж Арьяа бодлоо. Тэд өлсөж байсан учир цэцэрлэг хорхойг нь дэндүү хүргэжээ. Харренхалаас хулгайлсан талх, бяслаг зургаан өдрийн өмнө ойд байхад дуусчээ.

- Жэндриг аваад морьдоо байшингийн ард оруул гэж Арьяа хэлэв. Тэнд өрөөсөн талын ганц хана үлдсэн болохоор хоёр хөвгүүн гурван морийг халхалж хүрэлцэхүйц байлаа. *Хэрвээ морь янцаах юм уу дуучин цэцэрлэг рүү ирдэггүй л юм бол.*

- Чи яах юм?

- Би модны цаана нуугдана. Тэр ганцаар байж магадгүй. Хэрвээ надад саад учруулвал би алах болно. Яваач!

Халуун бялуу явахад Арьяа луувангаа хаяад мөрөндөө үүрсэн хулгайлсан илдээ сугаллаа. Тэр үүнийг бүсэлхийндээ зүүхэд нас бие гүйцсэн хүний урт илд учир газар цохиод байсан учир нуруундаа хуйтай зүүжээ. *Дээрээс нь дэндүү хүнд юм* гэж бодоод болхи илдийг гартаа барих тоолон "Зүү"-г санаж байлаа. Гэсэн ч энэ нь илд болохоор алахад хангалттай.

Тэр түргэн хөдөлж замын эргэлтний дэргэд ургасан том хөгшин уд руу очиж унжсан мөчрийн цаана шавартай өвсөн дээр өвдөглөв. *Хуучин бурхад минь, модны бурхад минь намайг нууж түүнийг дэргэдүүр өнгөрүүлээч* гэж дуучны хоолой улам чангарахад залбирлаа. Тэгтэл морь янцгаахад дуучны хоолой гэнэтхэн зогсов. *Тэр сонсчихлоо. Магадгүй ганцаараа байж мэднэ. Хэрвээ үгүй байвал тэд биднийг айлгасан шигээ биднээс айж болох юм.*

- Чи үүнийг сонсов уу? Ханын ард ямар нэг зүйл байна гэх хүний хоолой сонсогдов.

- Яг тийм. Чи үүнийг юу гэж бодож байна, харваач аа? гэж хоёр дахь бүдүүн хоолой хариуллаа.

Тэд хоёул байна. Арьяа уруулаа хазлаа. Арьяа тэднийг сөгдсөн газраасаа хараагүй ч дууг нь сонсож байв.

- Баавгай гэж нэг хүн дуугарав. Гурав дахь хоолой юу эсвэл эхнийх нь үү?

- Баавгайнд их мах бий. Бас намар таргалсан байгаа. Хэрвээ зөв янзалвал идэхэд амттай гэж бүдүүн хоолой хэлэв.

- Чоно ч байж болно. Эсвэл арслан юм уу.

- Чи тэднийг дөрвөн хөлтэй гэж бодож байна уу? Эсвэл хоёр уу?

- Хоол хийхэд ялгаагүй биз дээ. Тийм үү?

- Тэгж болох юм. Ингэхэд чи наад сумаараа яах гэж байгаа юм, харваачаа?

- Ханан дээгүүр хэдэн сум харвая. Ард нь нуугдаж байсан ямар ч зүйл түргэн үсрэн гарч ирэх болохоор тэгэхэд нь харъя.

- Тэнд хананы ард үнэнч хүн байгаа юм биш биз дээ? Эсвэл хөхүүл хүүхдээ цээжиндээ тэвэрсэн хөөрхийлөлтэй эмэгтэй ч юм уу?

- Үнэнч хүн байвал гарч ирээд бидэнд царайгаа үзүүлнэ. Зөвхөн дээрэмчин л гэтэж нуугдаж явдаг.

- Наадах чинь тийм шүү. Тэгвэл сумаа харваадах даа гэхэд Арьяа хөл дээрээ үсрэн босоод,

- Битгий! гэж хашгиран илдээ босголоо. Тэд гурвуул болохыг харлаа. *Ердөө гурвуул.* Сирио гурваас олон хүнтэй тулалдаж чадах ч магадгүй Халуун бялуу, Жэндри хоёр дэргэд нь зогсох

байх. Гэхдээ тэднийг хөвгүүд байхад тэд бол нас бие гүйцсэн эрчүүл байна.

Тэд явган аян замд гундаж шаварт цоохортсон хувцастай эрчүүл байлаа. Арьяа дуучинг хүүхдээ тэвэрсэн эх шиг цээжиндээ барьсан модон ятгаар нь мэдлээ. Тэр харваас тавин насыг өнгөрч яваа намхан хүн бөгөөд том ам, шовх хамар, шингэн хүрэн үстэй ажээ. Энд тэндгүй хуучин ширээр нөхсөн гандсан ногоон нөмрөг нөмөрч бүсэлхийндээ шиддэг хутга зүүгээд, нуруундаа модчины сүх үүрчээ.

Дэргэд нь тохой өндөр цэрэг байрын эр зогсож байв. Урт илд болон чинжаал тоногтой ширэн бүсэнд зүүж, цамцандаа шигүү ган цагариг бэхлэн оёод толгойдоо шовгор хэлбэртэй хар төмөр богино дуулга өмсчээ. Тэр муухан шүд, өтгөн хүрэн сахалтай нүдэнд өртсөн юүдэнтэй шаргал нөмрөгтэй байв. Энэ нь ногооны шүүс, цусны толбо болж ёроолоороо сэмрэн баруун мөрөндөө бугын арьсаар нөхсөн зузаан хүнд нөмрөг бөгөөд эзнээ том шар шувуутай төстэй харагдуулна.

Сүүлчийнх нь урт нум шигээ туранхай төдийлөн өндөргүй залуу ажээ. Улаан үс, сэвхтэй агаад товчтой хантааз, урт түрийтэй гутал, хуруугүй ширэн бээлий өмсөн нуруундаа саадаг агсчээ. Тэр сумаа галууны өдөөр өдөлсөн бөгөөд зургааг нь урдаа газар жижигхэн хашаа шиг эгнүүлэн өржээ.

Гурван эр замын дунд гартаа илд барин зогсч байгаа Арьяа руу харав. Тэгтэл дуучин залхуутай чавхдасаа шударлаа.

- Хүү минь наад илдээ одоохон хаявал чамд ямар ч муу зүйл учрахгүй. Тэгээд ч чамд дэндүү томдож байна. Энгай чамайг бидэнд хүрэхээс өмнө гурван ч сум харвана гэв.

- Тэр чадахгүй. Тэгээд ч би охин байна гэж Арьяа хэллээ.

- Тийм үү. Өршөөгөөрэй гээд дуучин бөхийв.

- Та нар өөрсдийнхөө замаараа яв. Эндээс цааш дуулсан хэвээрээ өнгөрвөл бид хаана чинь байгааг мэдэх болно. Биднийг орхиж цааш явбал та нарыг алахгүй гэхэд,

- Лем чи түүний биднийг алахгүй гэснийг нь сонсов уу? гээд сэвхтэй нүүртэй харваач инээд алдлаа.

- Сонссон гэж бүдүүн хоолойтой том цэрэг Лем хэллээ.

- Хүүхэд минь наад илдээ доош нь тавьбал бид чамайг гэдсэнд чинь хоол унд олдох аюулгүй газар аваачъя. Энэ газар чононууд хөлхөж арслан болон түүнээс ч дор зүйл бий. Бяцхан охин ганцаар тэнэхэд тохиромжгүй газар.

- Тэр ганцаар биш гээд Жэндри байшингийн хананы араас гарахад араас нь Халуун бялуу Арьяагын морийг хөтлөн дагав. Тэр гархин хуяг, гартаа илдтэйгээ бараг л насанд хүрсэн эр хүн шиг аюултай харагдаж байлаа. Халуун бялуу харин Халуун бялуу шигээ харагдаж байв.

- Түүний хэлсэн ёсоор бидний орхи гэж Жэндри анхааруулав.

- Хоёр гурав гэж дуучин тоолов. - Ингээд л болоо юу? Дээрээс нь бас сайн морьд байна. Та нар тэднийг хаанаас хулгайлаа вэ?

- Энэ манай морьд гэж Арьяа тэднийг болгоомжтой ширтэн хэлэв. Дуучин түүнийг яриагаараа саатуулж байх хооронд хамгийн аюултай нь харваач байлаа. *Хэрвээ тэр газар зоосон сумаа авах юм бол...*

- Та нар бидэнд үнэнч хүний ёсоор нэрээ хэлэхгүй юу? гэж дуучин хөвгүүдээс асуухад,

- Намайг Халуун бялуу гэдэг гэж Халуун бялуу тэр дор нь хэлэв.

- Чамд зохиж байна. Би өдөр бүр ийм амттай нэртэй залуутай тааралдаад байдаггүй гээд тэр инээмсэглэж,

- Харин найзуудыг чинь юу гэж дууддаг юм? Хонины давтсан мах болон Шарсан дэгдээхий юу? гэв.

- Би та нарынхыг сонсоогүй байж чамд яагаад нэрээ хэлэх ёстой юм бэ? гээд Жэндри эмээлээсээ хөмсөг зангидав.

- Тэгвэл намайг Долоон чавхдаст Том, Долоон чавхдас Том өөрөөр Долоот Том гэж найзууд маань нэрлэдэг юм. Энэ хүрэн шүдтэй болхи хүнийг Лем товчоор Зүрж нөмрөгт гэдэг. Ааш зан нь нимбэг шигээ гашуун хүн дээ. Харин залуу нөхрийг минь Энгай гэдэг. Харваач гэж бид дууддаг юм.

- Одоо та нар хэн юм? гэж Лем Арьяагын модны мөчрийн завсар сонссон бүдүүн хоолойгоор шаардав.

Арьяа жинхэнэ нэрээ ийм амархан хэлсэнгүй.

- Та нарынхаар болог. Хүсвэл Шарсан дэгдээхий болсон ч надад хамаагүй гэхэд том хүн инээлээ.

- Илдтэй шарсан дэгдээхий. Өдөр бүр ийм зүйлтэй тааралдахгүй байх.

- Харин намайг Бух гэдэг гээд Жэндри Арьяагын жишээг даган хэлэхэд тэр түүнийг Хонины давтсан махнаас Бух гэдэг нэрийг сонгосонд буруутгасангүй.

Долоон чавхдас Том ятгаа цохив.

- Халуун бялуу, Шарсан дэгдээхий, Бух. Лорд Болтоны гал зуухнаас зугтаа юу?

- Чи хаанаас мэдсэн юм бэ? гэж Арьяа эвгүйцэн асуулаа.

- Чиний цээжин дээр түүний сүлд байна, бяцхан охин минь.

Арьяа үүнийг мартжээ. Тэр нөмрөгнийхөө дотуур цээжин дээрээ Дредфортын өвчүүлсэн хүний

сүлдтэй зарцын хувцастай хэвээр байв.

- Намайг бяцхан охин гэж бүү дууд!

- Яагаад үгүй гэж? Чи чинь бяцхан юм байна шүү дээ гэж Лем хэлэв.

- Үгүй би том. Тэгээд ч хүүхэд биш гээд үнэндээ хүүхэд түүн шиг хүн алдаггүй билээ.

- Би үүнийг чинь харлаа, Шарсан дэгдээхэй минь. Та нар хүүхэд ч биш Болтоных ч биш юм байна.

- Бид тийм биш. Бид түүнийг ирэхээс өмнө Харренхалд байсан тэгээд л тэр гэж амаа хамхихыг ер мэддэггүй Халуун бялуу хэлэв.

- Тэгвэл та нар арслангийн зулзага байх нь ээ? гэж Том асуув.

- Үгүй, тийм биш. Бид хэний ч хүмүүс биш. Харин та нар хэний хүмүүс юм?

- Бид хааны хүмүүс гэж Энгай харваач хэлэв.

- Ямар хааны? гээд Арьяа хөмсөг зангидлаа.

- Роберт хааны гэж шаргал нөмрөгтэй Лем хариулав.

- Хөгшин согтуу юу? Тэр үхэж бодонд алагдсаныг нь бүгд мэдэж байгаа гэж Жэндри зэвүүцэн хэллээ.

- Тиймээ залуу минь туйлын харамсалтай гээд Долоон чавхдас Том ятгаараа гунигтай аялгуу шударлаа.

Арьяа тэднийг хааны хүмүүс гэж бодсонгүй. Тэд юунаас түрүүнд ноорхой нөхөөстэй хувцастай дээрэмчид шиг харагдаж байв. Тэр бүү хэл унах морь ч байсангүй. Хааны хүмүүс морьтой байдаг билээ.

Тэгтэл Халуун бялуу тэсгэлгүй,

- Бид Риверраныг эрж явна. Тийшээ явахад хичнээн өдөр орохыг мэдэх үү? гэж асуухад,

- Чимээгүй болохгүй бол би том тэнэг амыг чинь чулуугаар таглана шүү гээд Арьяа түүнийг алахад ч бэлэн байлаа.

- Риверран голын өөд хол газар байгаа. Удаан өлсгөлөн зам. Ингэхэд та нар замд гарахын өмнө халуун хоол идэхээс татгалзахгүй биз дээ? Тэнд холгүйхэн манай нөхдийн дэн буудал байгаа. Бид нэг нэгэнтэйгээ үзэлцэхийн оронд ширээнд суун шар айраг, зүсэм талх хуваалцаж болох юм гэж Том хэлэв.

- Дэн буудал гэнэ ээ? гээд халуун хоолны тухай бодохоос Арьяагийн гэдэс хүржигнэсэн ч Томд итгэсэнгүй. Чамтай элэгсэг ярьсан бүхэн анд нөхөр чинь байдаггүй билээ. - Холгүй байгаа гэж

хэлсэн үү?

- Голын дээшээ хоёр милийн зайд. Бараг л бээр гэхэд Жэндри Арьяагын адил тээнэгэлзэн,

- Танай нөхдийн гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж болгоомжтой асуув.

- Зүгээр л нөхөд. Чи нөхөд гэж юу байдгыг мартаа юу?

- Буудлын эзэгтэйн нэрийг Шарна гэдэг юм. Тэр эмэгтэй хурц хэл, цоргисон нүдтэй ч зүрх нь эелдэг бяцхан охидод хайртай гэдгийг чамд хэлэх байна.

- Би бяцхан охин биш гэж Арьяа уурсан хэллээ.

- Тэнд өөр хэн байгаа юм? Чи нөхөд гэж хэлсэн.

- Шарнагын нөхөр болон тэдний үрчилж авсан өнчин хүү байгаа. Тэд та нарт ямар ч гэм хийхгүй. Хэрвээ та нар уухаар насанд хүрсэн гэж бодож байгаа бол шар айраг бий. Шинэхэн талх, жаахан мах ч олдож болох юм. Тэгээд ч та нар Хөгшин Пэйтийн цэцэрлэгээс ногоо хулгайлж байсан биз дээ гээд Том байшингийн зүг харлаа.

- Бид хэзээ ч хулгай хийгээгүй гэж Арьяа эсэргүүцэв.

- Тэгвэл чи Хөгшин Пэйтийн охин нь байх, тийм үү? Эсвэл дүү нь? Эхнэр нь үү? Надад бүү худал хэл. Би Хөгшин Пэйтийг чиний нуугдаж байсан удны дор өөрийн гараар оршуулсан. Харин чи түүнтэй адилгүй юм байна гээд ятгаараа гунигтай ая дарж,

- Бид өнгөрсөн жил олон сайн хүнийг оршуулсан ч та нарыг оршуулахыг хүсээгүй гэдгийг ятгаараа тангараглах байна. Харваачаа түүнд үзүүлээч гэв.

Харваачийн гар Арьяагын итгэмээргүй хурдан хөдлөв. Түүний сум исгэрэн чихний хажуугаар нь инчийн зайтай өнгөрөөд ард нь байсан модонд зоогдлоо. Тэгтэл харваач хоёр дахь сумаа авч онилов. Арьяа Сириогийн *могой шиг хурдан, зуны торго шиг зөөлөн* гэсэн үгийг ойлгосон гэж бодсон ч юу болохыг нь анх удаагаа харлаа. Сум ард нь зөгий шиг дүнгэнэв.

- Чи алдчихлаа.

- Тэгж бодож байвал чи тэнэг юм байна. Миний сум илгээсэн газар луу минь явдаг юм даа гэж Энгай хэллээ.

- Тиймээ тэгдэг гэж Зүрж нөмрөгт Лем зөвшөөрөв.

Тэнд харваач болон илдний үзүүрийн хооронд арваад алхам зай байлаа. *Бидэнд боломж байхгүй* гэдгийг Арьяа ойлгоод түүн шиг эзэмшсэн нум сум байхгүйдээ харамслаа. Тэр дүнсийн хүнд илднийхээ үзүүрийг газар луу буулгаад,

- За яахав та нарын буудлыг очиж харъя. Зөвхөн та нар бидэнд юу хийж байгаагаа харуулахын

тулд урд яваарай гэж зоригтой үгнийхээ цаана эргэлзээгээ далдлахыг хичээн хэллээ.

Долоон чавхдас Том гүнээ мэхийн ёслоод,

- Ард нь явна уу урд нь явна уу хамаа алга. Явцгаая залуусаа тэдэнд зам зааж өгье. Энгай сумаа цуглуул бидэнд хэрэг болно гэв.

Арьяа илдээ хуйлаад зам хөндлөн гурван үл таних хүнээс зайтай нөхдийнхөө морьтой хүлээж буй газар луу очлоо.

- Халуун бялуу тэр байцаануудыг ав. Лууванг ч гэсэн гэж эмээлдээ гарахдаа хэлэхэд тэр урдаас нь маргасангүй.

Тэд түүний хүссэн ёсоор дугуйны мөр гарсан зам дээр гурван явган хүнийг арван алхамын зайтай морьтойгоо удаан дагасан ч удалгүй морьд нь зэрэгцэн очлоо. Долоон чавхдас Том удаанаар явах зуураа модон ятгаа дарна.

- Та нар ямар нэг дуу мэдэх үү? Би дуулдаг хүнд маш дуртай. Лем ая аялж чаддаггүй, манай урт нумтай залуу тус бүр нь зуугаад мөртэй аяны туулиас ондоо зүйл мэдэхгүй.

- Бид аянд явахдаа жинхэнэ дуу дуулдаг гэж Энгай намуухан хэлэв.

- Дуулах бол тэнэг хэрэг. Дуулахад чимээ гарна. Бид та нарыг холоос сонсон алж болох байлаа гэж Арьяа хэлэхэд Том тэгж бодсонгүй бололтой инээмсэглэв.

- Уруул дээрээ дуутай үхэхээс ч дор зүйл бий.

- Хэрвээ ойр хавьд чононууд байсан бол бид мэдэх байсан. Эсвэл арслангууд ч юм уу. Энэ бол манай ой гэж Лем өгүүлэв.

- Та нар бидний байгааг мэдээгүй гэж Жэндри хэллээ.

- Тийм итгэлтэй байх хэрэггүй дээ, залуу минь. Заримдаа хүн ярьж байгаагаасаа илүү олон зүйл мэддэг юм гэж Том анхааруулав. Халуун бялуу суудлаа сэлгэлээ.

- Би баавгайн тухай жаахан дуу мэднэ.

- Тэгвэл сонсоцгооё, бялуу хүү минь гээд Том хуруугаа чавхдас дээгүүр гүйлгэн толгой гэдийлгэж,

- *Баавгай, баавгай, баавгай байжээ. Бүх бие нь хүрэн үсээр хучигдсан...* гэж дуулав.

Халуун бялуу дуртайяа нэгдэж хөгжмийн аяар эмээл дээрээ савлан ганхав. Арьяа түүнийг алмайран харлаа. Тэр сайхан хоолойтой сайн дуулж байв. Арьяа түүнийг бялуунаас ондоо зүйл хийж чаддаг гэж ер мэдсэнгүй.

Сэрээний цаахан талд жижигхэн горхи урсаж байв. Тэд ус гатлахад чимээнд нь зэгсэн дундаас нугас нислээ. Энгай зогсоод мөрнөөсөө нумаа авч сум онилон харвалаа. Шувуу эргээс холгүй гүехэн усанд унав. Лем шаргал нөмрөгөө тайлж өвдөг хүрсэн гүнзгий ус гомдоллон туучив.

- Чи Шарнагын зооринд зүрж байгаа гэж бодож байна уу? Дорнишийн охин нэг удаа надад зүржтэй нугас шарж өгч билээ гэж Энгай Томоос Лемийн ус цацлан хараан туулахыг харж санаашрангуй асуулаа.

Том, Халуун бялуу хоёр голын нөгөө талд дуугаа сэргээхэд Лем нугасыг шаргал нөмрөгнийхөө доор бүсэндээ зүүлээ. Яагаад ч юм дуулахад газар түргэн хорох шиг санагдав. Төдөлгүй дэн буудал тэдний өмнө Сэрээний хойд зүг томоор тохойрсон газар голын эрэг дээр урган гарч ирэв. Арьяа ойртохдоо сэжиглэнгүй ширтэв. Энэ нь дээрэмчдийн ичээ шиг харагдсангүй бараг л нөхөрсөг тохьтой гэмээр цагаан модон дээд давхар, занар дээвэртэй яндангаас нь утаа залхуутай суунаглана. Байшингийн гадна жүчээ байсан бөгөөд ард нь алимны модтой бяцхан цэцэрлэг байлаа. Дэн буудал гол руу орсон хэсэгтээ өөрийн гэсэн зогсоолтой байв. Харин тэнд нь...

- Жэндри тэнд завь байна. Бид завийг авч Риверран хүрэх үлдсэн замыг туулж болох юм. Энэ мориор явахаас хурдан гэж бодож байна гэж Арьяа нам дуугаар шивнэв.

- Чи завь жолоодож чадах юм уу? гээд Жэндри эргэлзэнгүй харлаа.

- Далбааг нь босгоход л салхи аваад явчихна.

- Салхи буруу тийш салхилвал яах болж байна?

- Тэгвэл сэлүүрдэнэ.

- Урсгалын эсрэг үү? гээд Жэндри хөмсөг зангидлаа.

- Надад энэ удаан санагдаж байна. Завь хөмөрч бид усанд унавал яах болж байна? Тэгээд ч энэ манай завь биш дэн буудлынх.

Бид үүнийг авч болно. Арьяа уруулаа хазаад юу ч хэлсэнгүй. Тэд жүчээний урд мориноос буув. Өөр морь харагдсангүй ч Арьяа морины тасалгаанд шинэхэн овоолттой олон хомоол байхыг харлаа.

- Биднийг нэг морио харж үлдэх ёстой гэж болгоомжтой хэлэхэд Том сонсчээ.

- Тэгэх хэрэг байхгүй. Явж юм ид тэд аюулгүй.

- Би үлдэе. Чи дараа нь надад хоол авчираарай гэж Жэндри дуучинг үл ойшоон хэлэв.

Арьяа толгой дохиод Халуун бялуу, Лем хоёрын араас орлоо. Тэр илдээ нуруунд зүүсэн хэвээр байсан тул дотор эвгүй явдал болоход хүрвэл гараа Рус Болтоноос хулгайлсан хутганы бариулд ойрхон байлгалаа.

Хаалганы дээд талын самбар дээр өвдөг сөгдөж байгаа хөгшин хааныг дүрсэлжээ. Дотор нь нийтийн өрөөнд маш өндөр, ёрдгор эрүүтэй царай муутай эмэгтэй гараа ташаандаа тулан зогсоод муухай харлаа.

- Босгон дээр битгий зогсоод бай, хүү минь. Эсвэл чи охин юм уу? Алин ч байсан миний хаалгыг хаагаад байна. Орох юм бол ор эсвэл гар. Лем би чамд шалныхаа тухай юу гэж хэллээ? Чи бөөн шавар тариад байна.

- Бид нугас харвасан гээд Лем түүнийг энхийн далбаа аятай гаргалаа. Эмэгтэй гараас нь шүүрэн авав.

- Энгай нугас харвасан гэж чи хэлэх гээ юу. Гутлаа тайл гээд байхад чи чинь дүлий юм уу эсвэл тэнэг юм уу? гээд цааш эргэж,

- Эр нөхөр минь! Нааш ирээч залуус буцаж ирлээ. Нөхөр минь! гэж дуудав.

Зоорины шатаар бохир толботой хормогчтой хүн гүвтнэн гарч ирлээ. Тэр эмэгтэйгээс толгой өндөр, булдруутай цоохор салхин цэцгийн оромтой шарангуй царайтай байв.

- Би энд байна эмэгтэй минь. Орилохоо боль. Яах гээ вэ?

- Үүнийг өлгө гээд нугасыг гардуулав. Энгай хөлөө сэлгэлээ.

- Бид үүнийг зүржтэй иднэ гэж бодсон юм, Шарна. Хэрвээ чамд байгаа бол.

- Зүрж гэнэ ээ. Бид түүнийг чинь хаанаас олох болж байна? Чи Дорнд байгаа гэж бодсон биш биз дээ, сэвхтэй тэнэг минь? Чи яагаад арын зүржийн мод руу авирч бидэнд сагс дүүрэн олив, анар түүж өгч болохгүй гэж гээд хуруугаа сэгсэрлээ.

- Эсвэл би Лемийн нөмрөгтэй цуг шарж болох юм. Гэвч хэдэн өдөр өлгөхөөс наашгүй шүү. Чи туулайн мах иднэ үү байна уу өөрөө мэд. Хэрвээ өлсөж байгаа бол шоронд шарсан туулай хамаагүй хурдан гэж мэд. Эсвэл шар айраг, сонгинотой жигнүүлмээр байна уу гэхэд Арьяа бараг л туулайны махны амтыг мэдэрлээ.

- Бидэнд зоос байхгүй ч жаахан лууван байцаа бий. Таньтай арилжиж болох юм.

- Одоо юу? Хаана байгаа юм?

- Халуун бялуу түүнд байцаануудыг өг гэж Арьяа хэлэхэд тэр хижээл эмэгтэй рүү Рог, Хазагч эсвэл Варго Хот байгаа аятай хянуур ойртов.

Эмэгтэй ногоонуудыг ойроос харснаа хөвгүүнд,

- Халуун бялуу нь хаана байгаа юм? гэв.

- Энд би байна. Миний нэр байгаа юм. Харин тэр бол... Шарсан дэгдээхий...

- Миний дээвэр дор л биш шүү. Би өөрийнхөө хоол, суулгуудаа хооронд нь ялгахын тулд янз бүрийн нэр өгдөг. Нөхөр минь!

Нөхөр нь гадагш гарсан ч хашгирах дуугаар бушуухан орж ирэв.

- Нугасыг өлгөлөө. Одоо яах гэв, эмэгтэй минь?

- Энэ ногоонуудыг угаагаадах. Харин та нар намайг туулай бэлтгэж бай зуур сууж бай. Хүү та нарт уух юм авчирч өгнө гээд эзэгтэй урт хамрынхаа цаанаас Арьяа, Халуун бялуу хоёр луу харлаа.

- Би хүүхдүүдэд шар айраг өгдөг дадалтай хүн биш ч алимны шүүс дуусч, энд үнээний сүү байхгүй харин голын уруу бүх үхсэн хүн хөвж байгаа болохоор уснаас нь дайн амтагдаж байгаа. Хэрвээ би та нарт аяга үхсэн ялаатай шөл аягалж өгвөл уух уу?

- Арри ууна. Шарсан дэгдээхий гэх гэсэн юм л даа гэж Халуун бялуу хэллээ.

- Лем ч гэсэн гэж Энгай зальжин инээмсэглэв.

- Лемийн тухайд санаа зовох хэрэггүй. Бүгдэд шар айраг өгнө гээд Шарна гал зуухны зүг явлаа.

Энгай, Долоон чавхдас Том хоёр зуухны ойролцоо ширээнд суухад Лем том шаргал нөмрөгөө дэгээнээс өлгөв. Халуун бялуу хаалганы хажуудах ширээний вандан дээр лагхийтэл суусанд Арьяа дэргэд нь суув.

Том ятгаа авч,

- *Ойн зам дээрх сайхан буудал. Буудлын эзэгтэй бах шиг царайтай* гэж удаанаар үгээ зохион дуулав.

- Амаа хамхихгүй бол бидэнд туулайн мах олдохгүй шүү. Чи түүнийг ямар болохыг мэдэж байгаа гэж Лем анхааруулав.

Арьяа Халуун бялуу руу бөхийлөө.

- Чи завь жолоодож чадах уу? гэхэд хариулахаас нь өмнө өрөөнд арван тав зургаан насны бахим хүү шар айрагтай аяга зөөн авчирлаа. Халуун бялуу аягатайгаа хоёр гараа барин уугаад Арьяагын хэзээ ч харж байгаагүй нүүр дүүрэн инээмсэглэв.

- Шар айраг дээрээс нь бас туулай.

- Эрхэм дээдсийн төлөө. Долоо хааныг авраг! гэж Харваач Энгай хөгжилтэй хэлээд хундага өргөв.

- Арван хоёруулаа гэж Зүрж нөмрөгт Лем гүвтнэн хөнтөрснөө уруулдаа наасан хөөсийг гарынхаа араар арчив.

Урд талын хаалгаар эзэгтэйн нөхөр хормогч дүүрэн угаасан ногоотой орж ирэнгээ,

- Жүчээнд танихгүй морьд байна гэж тэднийг мэдээгүй хэмээн бодсон байртай хэллээ.

- Тиймээ. Чиний гурван хүнд өгч явуулснаас хамаагүй дээр морьд гэж Том модон ятгаа хажуу тийш тавин батлав.

Эзэн ногоонуудаа ширээн дээр асгаад ууртайгаар,

- Би тэдэнд морьдыг өгч явуулаагүй. Харин сайн үнэ хүргэн зарж завийг нь ч гэсэн авсан. Тэгээд ч та нар тэднийг буцааж авчирах ёстой байсан биз дээ

Би тэднийг дээрэмчид гэж мэдсэн юмаа гэж Арьяа чагнах зуураа бодлоо. Тэр хутгаа байгаа эсэхэд итгэлтэй болохын тулд ширээн доогуур бариулд нь хүрлээ. *Хэрвээ тэд биднийг дээрэмдэхийг оролдвол харамсах болно доо.*

- Тэд манай замаар яваагүй гэж Лем тодруулав.

- Би тэднийг илгээсэн юм чинь. Та нар согтуу юм уу унтсан байж таарна.

- Бид үү? Согтуу юу? Хэзээ ч үгүй гээд Том шар айргаа том балгав.

- Чи тэднийг барих ёстой байсан юм гэж Лем оролцов.

- Юу хүүтэй цуг хоёул уу? Би та нарт хичнээн удаа эзэгтэй Ламбсволд руу Фернийн хүүхэд төрөхөд туслахаар явсан гэж хэлэх юм бэ. Харин чамаас өөр хэн хөөрхий охины хэвлийд бутач суулгасан гэж гээд Том руу гашуунаар харж,

- Чамайг ятгатайгаа гунигтай дуугаа дуулж хөөрхий Фернийн дотуур хувцсыг тайлсан гэж мөрийцөхөд ч бэлэн байна гэв.

- Хэрвээ дуу охиныг хувцсаа тайлан дулаахан нар арьсан дээрээ үнсэхийг хүсэхэд хүргэвэл дуучин ямар буруутай юм бэ? Тэгээд ч тэр Ангайд талтай. "Би чиний нуманд хүрч болох уу? Өө ямар гөлгөр хатуу юм бэ. Би жаахан татаж болох уу? Чи юу гэж бодож байна?" гэж би асуухыг нь сонссон гэхэд эзэн тургилаа.

- Энгай та хоёрт ямар ч ялгаа байхгүй. Чи намайг тэдэнд морьд өгсний төлөө буруутгаж байна. Тэд гурвуул байсан байхад ганц хүн гурвын эсрэг юу хийж чадна гэж?

- Тэр гурвын чинь нэг нь эмэгтэй нөгөө нь гинжтэй байсан гэж чи хэлсэн биз дээ гэхэд эзэн нүүрээ үрчийлгэлээ.

- Эрэгтэй хүн шиг хувцасласан том биетэй эмэгтэй байсан. Харин гинжтэй нь... надад түүний харц нэг л таалагдаагүй.

- Хэрвээ надад хүний харц таалагдахгүй байвал ухархайд нь сум зоодог юм даа гээд Энгай шар

айраг дээгүүрээ инээмсэглэв.

Арьяа чихийг нь шүргэсэн сумны тухай санаад нум сумаар харваж чадахгүйдээ ахин харамслаа. Эзэн тоосонгүй.

- Ахмад хүмүүс ярьж байхад чи чимээгүй бай. Шар айргаа уугаад дуугүй суухгүй бол би эзэгтэйгээр чамайг халбагаар цохиулна шүү.

- Ахмад хүмүүс дэндүү их ярьж би чамтай чамгүй шар айраг ууж байна гээд Энгай хэлсэн үгээ батлан том залгиж үзүүлэв.

Арьяа түүний жишээг дагалаа. Сүүлийн үед тэд гол, цөөрөм, шавартай Сэрээний уснаас ууж байсан болохоор шар айраг эцгийнх нь заримдаа уухыг зөвшөөрдөг байсан дарс шиг сайхан амттай санагдав. Гал зуухны өрөөнөөс ханхлах үнэр шүлсийг нь асгаруулсан ч завины тухай бодсон хэвээр байлаа. *Завийг хулгайлахад амархан ч түүгээр явах хэцүү. Хэрвээ бид тэднийг унтахыг хүлээвэл...*

Үйлчлэгч хүү том дугуй талх барьсаар гарч ирэв. Арьяа томыг хэлтэлж аваад шуналтайгаар хазахад ширүүн хатуу овон товон бөндгөртэй ёроол нь түлэгдсэн байлаа.

Халуун бялуу амталж үзмэгц ярвайлаа.

- Энэ муу талх байна. Түлэгдсэн дээрээс нь хатуу юм байна.

- Шөлөнд дүрвэл дээр гэж Лем зөвлөв.

- Үгүй тэгсэн ч дээрдэхгүй. Хэрвээ чи шүдээ хугалахыг хүсээгүй юм бол гэж Ангай хэллээ.

- Та нар идэхгүй юм бол хоосон сууж бай. Би хараал идсэн талхчин шиг харагдаад байна уу? Надаас дээр хийхийг харах юмсан гэж эзэн хэллээ.

- Би чадна. Энэ амархан. Та нар гурилаа дэндүү удаан зуурсан учир залжлахад ийм хатуу байгаа юм гээд Халуун бялуу шар айраг балгаснаа талх, бялуу, жимстэй боов гээд өөрийнхөө дуртай зүйлсийнхээ тухай хөврүүлж гарлаа. Арьяа нүдээ эргэлдүүлэв.

Том эсрэг талд нь ирж суугаад,

- Шарсан дэгдээхий минь эсвэл жинхэнэ нэр чинь Арри байлаа ч хамаагүй чамд үүнийг өгье гээд тэдний дунд модон ширээн дээр бохир цаасны өөдөс тавилаа.

- Энэ юу юм? гээд Арьяа сэжигтэй өлийв.

- Гурван алтан луу. Бид танай морьнуудыг худалдаж авах хэрэгтэй байна.

- Тэд чинь бидний морьд гээд Арьяа сэрэмжтэй харлаа.

- Та нар тэднийг хулгайлсан биз дээ? Үүнээс ичих хэрэггүй дээ, охин минь. Дайн олон үнэнч хүмүүсийг хулгайч болгож байна гээд Том хуруугаараа хуйлсан цаас тогшив.

- Би чамд сайн үнэ төлж байна. Үнэнийг хэлэхэд нэг ч морь үүнээс илүү үнэ хүрэхгүй гэхэд Халуун бялуу цаасыг авч дэлгээд,

- Энд чинь алт алга. Зөвхөн бичиг байна гэж чангаар гомдоллов.

- Тийм. Намайг өршөөгөөрэй. Гэвч дайны дараа бид үүнийг алт болгон хувиргана гэж хааны хүний амыг өгье гэхэд Арьяа ширээ түлхэн хөл дээрээ бослоо.

- Та нар хааны хүмүүс биш дээрэмчид.

- Хэрвээ чи жинхэнэ дээрэмчидтэй учирсан бол тэд чамд цаасны өөдөс ч төлөхгүй байсан. Бид морьдыг чинь өөрсөндөө авах гэсэн биш. Хаант улсын сайн сайхны төлөө тулалдах хэрэгтэй газар түргэн хүрэхийн төлөө авч байгаа юм. Бид хааны үйл хэргийн төлөө тулалдаж байгаа болохоор чи хааныг эсэргүүцэхгүй юм байгаа биз дээ?

Харваач, том Лем, шарангуй царайтай гүйсэн нүдтэй эзэн гээд бүгд түүн рүү харлаа. Гал зуухны үүдэн дээр зогсож байсан Шарна хүртэл нүдээ сүүмийлгэв. *Тэд намайг юу ч хэлсэн байсан хамаагүй морьдыг маань авах болно. Бид Риверран руу явган алхана. Хэрвээ зөвхөн...* гэж Арьяа ойлголоо.

- Бидэнд цаас хэрэггүй. Та нар манай морьдыг авч гадаа байгаа завийг өг. Гэхдээ яаж залахыг нь үзүүлсэн хойноо шүү гээд Арьяа Халуун бялуугийн гарт байсан цаасыг цохилоо.

Долоон чавхдас Том түүн рүү хормын турш алмайран харснаа гунигтай инээмсэглэв. Тэгснээ чанга хөхрөхөд Ангай тэргүүтэй Зүрж нөмрөгт Лем, Шарна, эзэн, торхны цаана гартаа холхивч нумтай зогсож байсан үйлчлэгч хүү гээд бүгд инээлдлээ. Арьяа тэдэн рүү хашгирах гэснээ больж инээмсэглэв. Тэгтэл хаалга тасхийн нээгдэж,

- Морьтонгууд! Цэргүүд. Голын замаар арваад хүн уруудан ирж байна гэх Жэндригийн түгшүүртэй хашгиралт гарав.

Халуун бялуу үсрэн босохдоо аягатайгаа цохин асгахад Том болон бусад хүмүүс байрнаасаа хөдөлсөнгүй.

- Үүний төлөө сайн шар айргийг шалан дээр минь асгах хэрэг байхгүй. Буцаж суугаад тайвшир хүү минь туулайн мах болох гэж байна. Чи ч гэсэн охин минь. Хааны хүмүүстэй хамт байгаа болохоор та нарт ямар ч муу зүйл учрахгүй. Бид та нарыг чадахаараа өмгөөлнө гэж Шарна хэлэв.

Арьяа хариуд нь мөрөндөө зүүсэн илдэнд хүрсэн ч сугалахаас нь өмнө Лем бугуйнаас нь барилаа.

- Больж үз. Бидэнд наадхын чинь хэрэг байхгүй гээд гарыг нь тавьтал мушгилаа. Түүний гар эвэртэй ширүүн хүчтэй байлаа. *Ахиад л! Ахиад л тосгонд болсон явдал давтагдаж Чизвик, Рафф, Хөдөлж буй Уул ирж байна* гэж Арьяа бачимдан бодов. Тэд түүний илдийг хулгайлж

хулгана болгон хувиргасан билээ. Арьяа нөгөө гараараа аяга шүүрэн аваад Лемийн нүүр лүү савахад шар айраг нүд рүү нь цацагдаж хамар нь хугаран цус садарлаа. Тэр хашгиран нүүрээ гараараа дарахад Арьяа мултран,

- Зугтаарай! гэж хашгираад хаалганы зүг ухасхийв.

Гэвч Лем түүнийг урт хөлөөрөө гуравхан том алхан гүйцээд агаарт өргөлөө. Арьяа мурилзан тийрсэн ч хөлөөс нь уруу харуулан өлгөхөд цус нүүрийг нь даган урсав.

- Больж үз, бяцхан тэнэг минь. Одоохон боль! гэж Арьяаг урагш хойш сэгсрэн хашгирлаа. Жэндри туслахаар хөдөлсөн ч Долоон чавхдас Том урд нь хутгатай хөндөлсөв.

Тэгтэл зугтахад хэтэрхий оройтжээ. Гадаа морины туурай сонсогдон хүний хоолой гарлаа. Хормын дараа нээлттэй хаалгаар Лемээс ч том биетэй үзүүр хэсгээрээ бууралтаж яваа тод ногоон өнгийн өтгөн бавгар сахалтай Тайроши орж ирэв. Араас нь шархадсан хүнээ сугадан яваа хоёр нумчин болон бусад нь цувлаа.

Арьяа хэзээ ч ийм ноорхой хүмүүс харж байгаагүй ч илд, сүх, нум сум нь элэгдсэн хуучин байсангүй. Нэг хоёр нь орж ирэхдээ сониучирхан харсан ч үг хэлсэнгүй. Өрөөсөн нүдтэй зэвэрсэн дуулгатай хүн агаар шиншлээд инээмсэглэхэд шар үстэй залуу харваач шар айраг нэхэн хашгирлаа. Тэдний араас арслангийн сүлдтэй дуулгатай жадчин, доголон өвгөн, Бравосын хөлсний цэрэг болон...

- Харвин? гэж Арьяа шивнэлээ. *Энэ тэр байна!* Ширэлдсэн үсний дорх сахалтай царай хашаанд морийг нь хөтлөн явж Жон, Робб хоёртой жадаар бай сургуулилан найран дээр дэндүү их уудаг байсан Халлений хүү байлаа. Тэр турж эцэн Винтерфеллд ургуулж байгаагүй сахалтай байсан ч эцгийнх нь хүн байлаа.

- Харвин! гээд тэр Лемийн төмөр мэт хатуу атгалтаас салахын тулд урагш зүтгэлээ.

- Энэ би байна. Харвин би байна. Чи намайг танихгүй байна уу? гээд нулимс нь урсахад яг л жаахан хүүхэд бяцхан охин аятай уйллаа.

- Харвин, энэ би байна!

Харвины нүд түүний царай дээр туссанаа хувцсан дээрх өвчүүлсэн хүнийг нь харав.

- Чи намайг хаанаас мэддэг юм? Өвчүүлсэн хүн бол... чи Хануур лордын зарц хүү юу? гэж хөмсөг зангидан сэжиглэнгүй хэлэв.

Агшин зуур Арьяа юу хэлэхээ мэдсэнгүй. Тэр дэндүү олон нэртэй байв. Арьяа Старкийг зөвхөн зүүдэлсэн юм биш байгаа даа?

- Би охин. Би лорд Болтоны хундагачин байсан ч тэр явах гээд намайг ямаанд орхиход Жэндри, Халуун бялуу хоёртой хамт зугтсан. Чи намайг таних ёстой! Чи намайг жаахан байхад морийг маань хөтөлдөг байсан гэхэд нүд нь томорсноо,

- Бурхад минь. Хөл нүцгэн Арьяа юу? Лем түүнийг тавь гэв.

- Тэр миний хамрыг хугалсан. Долоон там минь гэж энэ хэн юм бэ? гээд Лем түүнийг шалан дээр бүдүүлгээр тавилаа.

- Гарын охин. Винтерфеллийн Арьяа Старк гээд Харвин түүний өмнө өрөөсөн өвдөг сөхөрлөө.

КАТЕЛИН

Робб гэж тэр нохдын шуугин хуцах дууг сонсоод даруй мэдлээ.

Хүү нь Риверранд Хөнгөн салхитай цуг эргэн иржээ. Зөвхөн том саарал зэрлэг чонын үнэр нохдыг ингэж галзууртал боргон хуцуулж чадна. *Хүү минь над руу ирнэ* гэж Кателин мэдэж байв. Эдмур анхны ирсэн цагаасаа хойш эргэж орж ирэлгүй өдрийг Марк Пайпер, Патрик Маллистер хоёртой Раймунд Раймерийн Чулуун тээрэмд болсон тулалдааны дууг сонсон өнгөрүүлэхийг эрмэлзэх болжээ. *Робб бол Эдмур биш. Робб надтай уулзахаар заавал ирнэ.*

Ойрын үед бороорхог өдрүүд үргэлжилсэн болохоор хүйтэн саарал зүсэр бороо Кателины араншинтай яг тохирч байлаа. Эцэг нь улам доройтож өдөр ирэх тусам хийрхэл нь нэмэгдэн зөвхөн "Танси" гэж уучлал гуйн бувтнасаар сэрэх болжээ. Эдмур түүнээс зай барин, сэр Десмонд Грелл хэдий дургүй байсан ч цайзад явах эрх чөлөөг нь хориглосон хэвээр байв. Кателины сэтгэлийг зөвхөн сэр Робин Райгер хүмүүстэйгээ ясандаа хүртэл нэвт норон явган ирсэн явдал бүлээцүүлж байв. Тэд харваас алхаж ирсэн бололтой. Ямар нэгэн аргаар Хааны алуурч онгоцыг нь живүүлэн зугтсан гэж мэйстер Вайман хэлжээ. Кателин сэр Робинтой ярилцан болсон явдлын тухай илүү зүйл мэдэхийг хүссэн ч түүнд татгалзжээ.

Үүний зэрэгцээ ямар нэг зүйл болов. Дүү нь эргэж ирсэн өдөр тэдний маргаанаас хэдэн цагийн дараа дор хашаанд ууртай хоолойнууд сонсогдов. Кателин юу болсныг мэдэхээр дээвэр лүү гарахад шилтгээний хажуугийн төв хаалган дээр бөөн хүмүүс цугларсан байв. Жүчээнээс морьдыг хөтлөн гаргаж эмээллэж хазаарлан хоорондоо хашгиралдаж байсан ч Кателинд үг нь сонсогдоход дэндүү хол байлаа. Роббын газар хэвтэж байсан цагаан далбаа дээгүүр нэг хүлэг баатар морио эргүүлэн зэрлэг чоныг гишгүүлэн хаалганы зүг давхихад бусад нь ч гэсэн тэглээ. *Эдгээр хүмүүс Эдмуртай хамт гарман дээр тулалдсан. Юу тэдний уурыг ингэтэл хүргээ вэ? Миний дүү тэднийг доромжлон гомдоосон юм болов уу?* Тэр Шуурганы адаг болон Гашуун гүүр лүү хамт явсан сэр Первин Фрей болон эцэг нэгтэй дүү Мартин Риверийг нь таньсан ч ийм холоос итгэлтэй байхад бэрх байлаа. Ойролцоогоор дөчөөд тооны хүн цайзын хаалгаар цуван гарсныг ямар учраас гэдгийг мэдсэнгүй.

Тэд буцаж ирсэнгүй бөгөөд мэйстер Вайман Кателинд тэдний хэн байсан болон хаашаа явсан яагаад ийм уурласан учрыг хэлсэнгүй.

- Би энд зөвхөн эцгийг чинь үзэхээр ирсэн, хатагтай. Дүү чинь удахгүй Риверраны лорд болно. Хэрвээ тэр таньд мэдэгдэхийг хүссэн бол хэлэх бизээ хэмээн хэлжээ.

Гэтэл одоо Робб өрнө зүгээс ялалт байгуулан ирлээ. *Тэр намайг өршөөнө. Тэр Аръяа, Санса хоёртой адилхан өөрийн минь мах цусны хүү болохоор намайг өршөөх ёстой. Тэр намайг эдгээр өрөөнөөс суллаж би юу болсныг мэдэх болно* гэж өөртөө хэлэв.

Сэр Десмондыг түүн рүү ирэх үед Кателин угаалга хийж хувцаслаад улаан хүрэн үсээ самнасан байлаа.

- Робб хаан өрнө зүгээс эргэн ирсэн, хатагтай. Таныг их танхимд бараалхахыг тушаалаа гэж хүлэг

баатар хэлэв.

Энэ түүний эмээж мөрөөдсөн агшин байлаа. *Би гурав дахь хүүгээ алдсан болов уу?* Тэр үүнийг удахгүй мэдэх болно.

Тэднийг ороход танхим дүүрэн хүнтэй байлаа. Бүгдийн нүд тавцан руу чиглэсэн байсан ч Кателин нуруугаар нь танилаа. Хатагтай Мормонтын нөхөөстэй гархин хуяг, танхимд байсан бүгдийн толгой дээгүүр сүндэрлэх Том Жон хөвгүүдтэйгээ, цагаан үстэй далавчтай дуулгаа нугалсан гартаа барьсан лорд Жэйсон Маллистер, гоёмсог сайхан хэрээний өдөн нөмрөгтэй Титос Блаквүүд гээд л. Тэдний хагас нь намайг одоо дүүжлэхийг хүсч байгаа. Нөгөө хагас нь зөвхөн харцаа буруулах болно. Кателинд бас ямар нэг зүйл байхгүй мэт эвгүй мэдрэмж төрлөө.

Робб тавцан дээр зогсож байв. *Тэр хөвгүүн байхаа больжээ. Тэр арван зургаан настай нас бие гүйцсэн эр болсон байна. Зүгээр л барааг нь хараач* гэж эмзэглэн ойлголоо. Дайн түүний царайны зөөлөн өнгийг арчин эрс хатуу туранхай болгожээ. Тэр сахлаа хуссан ч тайрч янзлаагүй өтгөн хүрэн үс мөр лүү нь унжина. Саяхан орсон бороонд хуяг нь цоохортон хүрэм, цагаан нөмрөгнийхээ зүүн талд хүрэн толботой байлаа. Магадгүй цусны толбо бизээ. Толгой дээрээ илд дуурайлган хийсэн хүрэл төмөр титэм тавьжээ. *Тэр үүнийг одоо хамаагүй дээр зүүж байна. Тэр яг л хаан шиг титэм зүүж байна.*

Тавцангийн дор зогссон Эдмур Роббыг ялалтыг нь магтахад толгойгоо даруухан бөхийлгөжээ.

- ...Чулуун тээрэм унасныг хэзээ ч мартаж болохгүй. Лорд Тайвиныг Станнистай тулалдахаар зугтсанд гайхах зүйлгүй. Тэр умардынхан болон голынхонд шахагдсан байсан гэхэд инээд хадан дэмжсэн хашгиралт цуурайтахад Робб гараа өргөн чимээгүй болгов.

- Ланнистерийнхан эргэн ирнэ гэдэгт эндүүрэх хэрэггүй. Бидэнд хаант улсын аюулгүй байдлын төлөө ахин тулалдаанд ялах хэрэг гарна.

- *Умардын хаан!* гэж Том Жон бээлийтэй гараа агаарт өргөн хашгирав. Голын лордууд "*Сэрээний хаан!*" гэж хариу хашгирав. Танхимд нударга нүдэн, хөл дэвслэх чимээ нүргэллээ.

Чимээ шуугианы дунд цөөн хэдхэн хүн Кателин, сэр Десмонд хоёрыг ажиглаад бусдыгаа тохойгоор нудрахад эргэн тойрон аажмаар чимээгүй болгов. Кателин хүмүүсийн нүдний харцыг үл тоомсорлон толгойгоо дээш өргөлөө. *Тэд хүссэн зүйлээ бодож байг хамаагүй. Роббын юу гэж хэлэх хамгийн чухал.*

Тавцан дээр харагдах Сэр Бринден Таллигийн дүнхэр царай Кателиний сэтгэлийг тайтгаруулав. Роббын дагуул бололтой түүний танихгүй нэг хүү байлаа. Ард нь элсний өнгөт хувцсан дээр дүрэлзсэн тэнгисийн дунтай залуу хүлэг баатар, ногоон мөнгөн судалтай талбар дээр хөндлөн татсан улбар шар туузанд гурван хар чинжүүний савтай хөгшин хүний хамт зогсчээ. Тэдний дунд царайлаг хөгшин хатагтай харваас охин нь бололтой хөөрхөн охины хамт зогсож байлаа. Тэнд бас Сансагын үеийн нэг охин байв. Тэнгисийн дунгын сүлд бол доод овгийнх болохыг Кателин мэдэж байсан ч хөгшин хүнийг таньсангүй. *Хоригдол юм болов уу?* Робб яагаад олзлогдогчоо тавцан руу гаргадаг билээ?

Сэр Десмонд түүнийг дагуулан урагш гарахад Атерайдес Вэйн таягаараа шал цохив. *Хэрвээ Робб надтай Эдмурын харьцсан шиг харьцвал би яахаа ч мэдэхгүй нь.* Гэвч Кателин хүүгийнхээ харцанд уур хилэн олж харсангүй. Эсвэл айдас юм болов уу? Үгүй утгагүй юм. Тэр юунаас айх ёстой гэж? Тэр бол Залуу чоно Сэрээ болон Умардын хаан.

Авга ах нь түрүүлж түүнтэй мэндчилэв. Үргэлжид хар загас байсан шигээ сэр Бринден бусдын бодлыг тоодоггүй байлаа. Тэр тавцангаас үсрэн буугаад Кателины гарыг атгаж,

- Чамайг гэртээ байхыг харахад сайхан байна, Кат гэхэд Кателин биеэ барихыг хичээн,

- Та ч гэсэн гэж шивнэв.

- Ээжээ.

Кателин өндөр хаанлиг төрхтэй хүү рүүгээ харлаа.

- Эрхэм дээдсээ, би таныг аюулгүй эргэж ирэхийг залбирч байлаа. Би чамайг шархадсан гэж сонссон.

- Би Краг руу дайрах үедээ гартаа сумны шарх авсан ч сайн эдгэсэн. Надад санаа сайн тавьсан.

- Бурхдын авралаар гээд Кателин гүнзгий амьсгаа авлаа. *Үгээ хэл. Үүнээс зайлахын аргагүй.*

- Тэд чамд миний хийсэн зүйлийг хэлсэн. Харин яагаад гэдгийг нь хэлсэн үү?

- Охидын төлөө гэсэн.

- Надад таван хүүхэд байсан. Одоо гурав үлдлээ.

- Ай хатагтай минь гээд лорд Рикард Карстарк Том Жоны дэргэдүүр хар хуяг, урт буурал сахал, цонхигор хүйтэн гонзгой царайтайгаа баргар сүнс шиг түлхэн өнгөрч,

- Надад гурав байснаас ганцхан хүү үлдсэн. Харин чи миний өшөө хорслыг дээрэмдлээ гэхэд Кателин түүний нүүр лүү тайван харав.

- Лорд Рикард Хааны алуурч үхвэл хүүхдүүдийн чинь амийг эргэн авчирахгүй. Тэр амьд байвал миний хүүхдүүдийнхийг арилжин авч болох юм гэхэд Карстарк тайтгарсангүй.

- Жэйми Ланнистер чамайг тэнэг болгон тоглосон байна. Чи хүүдий дүүрэн хоосон үг авснаас юу ч өөрцгүй. Миний Торрен, Эддарт хоёр чамаас илүүг хүртэх тавилантай байсан гэв.

- Больж үз, Карстарк. Энэ бол эхийн тэнэглэл. Эмэгтэйчүүд ийм зантай гэж Том Жон цээжиндээ гараа зөрүүлэн хүнгэнэв.

- Эхийн тэнэглэл гэнэ ээ? Харин би үүнийг урван тэрслэлт гэх байна гээд лорд Карстарк лорд Амбер луу эргэлээ.

- Хангалттай гэж Робб тасхийхэд агшин зуур эцгээсээ илүү Брандонтой адилхан сонсогдов. - Нэг ч хүн миний ээж Винтерфеллийн хатагтайг урвагч гэж хэлэх ёсгүй, лорд Рикард гээд Кателин руу эргэж дуугаа намсган,

- Хэрвээ би Хааны алуурчийг ахин гинжилж чадах бол тэгнэ. Та түүнийг намайг мэдээгүйд зөвшөөрөлгүй сулласан байсан. Гэхдээ би таныг хайрынхаа төлөө хийснийг мэдэж байгаа. Бран, Рикон хоёрын араас гашуудан Арьяа, Санса хоёрын төлөө. Хайр үргэлж ухаалаг байдаггүйг би суралцсан. Энэ нь биднийг том тэнэглэл рүү хөтөлдөг ч бид сэтгэл зүрхээ хаа хүргэх газар нь дагадаг. Тийм биз дээ, ээж ээ? гэв.

Энэ миний хийсэн зүйл гэж үү?

- Хэрвээ сэтгэл зүрх минь намайг тэнэглэл рүү хөтөлсөн бол би лорд Карстарк та хоёрыг тайтгаруулахын тулд чадах бүх зүйлээ хийнэ гэхэд лорд Рикардын царай өөрчлөгдсөнгүй,

- Чи Торрен, Эддарт хоёрыг маань Хааны алуурчийн булшилсан хүйтэн булшнаас босгон дулаацуулж чадах юм уу? гээд Том Жон, Мэйж Мормонт хоёрын дундуур мөрлөн танхимыг орхин гарлаа.

Робб түүнийг саатуулахаар хөдөлсөнгүй.

- Түүнийг өршөөгөөрэй, ээжээ.

- Харин чи намайг өршөөвөл.

- Би өршөөнө. Би үүнийг таныг агуу хайрын төлөө хийсэн гэж мэдэж байгаа болохоор өөр зүйл санах хэрэггүй гэхэд Кателин толгойгоо бөхийлгөв.

- Баярлалаа. *Би ямар ч байсан энэ хүүгээ алдаагүй юм байна.*

- Бид ярилцах ёстой. Та болон нагац нартайгаа. Энэ болоод... өөр бусад зүйлсийн тухай. Даамал алба дууссаныг зарла гэж Робб яриагаа үргэлжлүүлэв.

Атерайдес Вэйн таягаа шалан дээр цохин тарсныг мэдэгдэхэд голын лордууд умардынхантай хаалганы зүг явцгаав. Тэгэхэд Кателин юу эзгүй байсныг ойлголоо. *Чоно. Чоно энд байхгүй байна. Хөнгөн салхи хаана байгаа юм бол?* Тэр зэрлэг чоно Роббтой цуг эргэж ирснийг нохдын хуцах дуугаар мэдсэн ч танхимд болон байх ёстой газартаа хүүгийнх нь дэргэд байсангүй.

Тэрбээр энэ тухай Роббоос асууж амжихаас урьтаж сайн сайхныг хүссэн хүмүүсийн хүрээлэлд хүрээлэгдэв. Хатагтай Мормонт гарыг нь атган,

- Хатагтай хэрвээ Серсей Ланнистер миний хоёр охиныг барьж байсан бол би ч гэсэн адил зүйл хийх байсан гэхэд дүрэм журмыг үл ойшоодог Том Жон дээш нь өргөн гарыг нь том үсэрхэг гараараа атгалаа.

- Чиний чоно хүү Хааны алуурчийг урьд нь нэг удаа барьсан болохоор хэрэгтэй цагт ахин барина

гэхэд Галбарт Гловер, лорд Жэйсон Маллистер хоёр хүйтэвтэр, Жонос Бракен бараг л мөс шиг хүйтэн байсан ч элэгсэг ёсны үг нь хангалттай байлаа. Эцэст нь дүү нь ойртож ирэв.

- Би охидыг чинь сайн байгаасай гэж залбирч байна, Кат. Таныг хийсэн зүйлдээ эргэлзээгүй гэж найдна.

- Мэдээж үгүй. Би үүнийг хайрынхаа төлөө хийсэн гээд Кателин түүнийг үнслээ.

Бүхий л үгс дууссан хойно Риверраны их танхим хоосорч Роббоос гадна гурван Таллигийнхан болон Кателины мэдэхгүй зургаан үл таних хүн үлдэв. Кателин тэдэн рүү сониучирхан харлаа.

- Хатагтай, сэрүүдээ та нар миний хүүгийн шинэ дагаар орогсод уу?

- Тиймээ шинэ гэхдээ бидний эр зориг хатуу үнэнч байдлыг таньд батлана гэж найдаж байна, хатагтай гэж тэнгисийн дунгийн сүлдтэй залуу хүлэг баатар хэлэв.

Робб аягүйцэн харлаа.

- Ээжээ би Крагын лорд Гавен Вестерлингийн эхнэр хатагтай Сибеллийг танилцуулахыг зөвшөөрнө үү гэхэд ёсорхуу царайтай хижээл эмэгтэй урагш гарлаа.

- Түүний нөхөр Шивнэдэг ойд бидний олзолсон хүмүүсийн нэг.

Вестерлингийнхэн, тиймээ. Тэдний далбаа дээр цагаан элсэн дээр зургаан тэнгисийн дун байдаг. Ланнистерийнхэнд зүтгэх андгайтай доогуур овог гэж Кателин бодлоо.

Робб үлдсэн танихгүй хүн бүрийн зүг зангав.

- Хатагтай Сибеллийн ах сэр Рольф Спайсер. Тэр биднийг Крагыг эзлэхэд шилтгээний захирагч байсан гэхэд чинжүүний савтай хүлэг баатар толгой бөхийлгөв. Тэр хугарсан хамар богинохон тайрсан буурал сахалтай дөрвөлжин хүн бөгөөд баатарлаг харагдаж байлаа.

- Лорд Гавен болон хатагтай Сибеллийн хүү сэр Рэйналд Вестерлинг гэхэд тэнгисийн дунтай хүлэг баатар бавгар сахлынхаа дор инээмсэглэв. Залуу туранхай болхидуу тэрбээр сайхан шүд, өтгөн хүрэн үстэй ажээ.

- Охин Эления гэхэд жижигхэн охин цомцойн ёслов.

- Роллам Вестерлинг, миний хиа байгаа юм гэхэд хүү өвдөг сөгдөх гэснээ хэн ч сөгдөхгүй байгааг хармагц оронд нь толгой бөхийлгөв.

- Миний хувьд их нэр хүндийн хэрэг гэж Кателин хэллээ. *Робб Крагынханыг холбоотноо болгосон юм болов уу?* Хэрвээ тийм бол Вестерленгийнхныг хамт байгаад нь гайхах зүйлгүй. Кастерли Рокод ийм мэтийн өчүүхэн урвалт нөлөөлөхгүй. Тайвин Ланнистер дайнд явж дадсан хүн...

Эцэст нь туйлын ичимхий охин урагш гарлаа. Робб түүний гараас барив.

- Ээжээ би таньд хүндэтгэлтэйгээр хатагтай Жэйн Вестерлингийг танилцуулъя. Лорд Гавений ууган охин харин миний... аа... хатагтай эхнэр минь.

Кателины ухаанд хэдэн бодол зурсхийлээ.

Хамгийн түрүүнд. *Үгүй ээ ингэж болохгүй чи зөвхөн хүүхэд шүү дээ.*

Хоёрдугаарт нь. *Тэгээд ч чи өөр хүнд амласан шүү дээ.*

Гуравдугаарт нь. *Ээж минь өршөө. Робб минь чи юу хийчихэв дээ?*

Зөвхөн тэгэхэд л түрүүний үгийг санав. *Хайрын төлөө хийсэн тэнэглэл гэнэ ээ? Тэр намайг урхинд орсон туулай шиг хянамгай баглаж авсан байна. Би түүнийг аль хэдийн уучилсан. Түүний дотор хааны ч юм уу... зальжин зохион байгуулсан жүжгийн үйл явдалд уур хилэн, харуусал, бахдал холилдон төрөхөд Кателинд Жэйн Вестерлингийн гарыг авахаас ондоо сонголт үлдсэнгүй.*

- Би шинэ охинтой болж гэж санаснаас ч хөшүүн хэлээд айсан охины хоёр хацар дээр үнслээ.

- Манай өргөө танхим гал голомтонд минь тавтай морилно уу.

- Баярлалаа, хатагтай. Би Роббын үнэнч сайн эхнэр болно гэдгээ андгайлж байна. Бас чадах чинээгээрээ цэцэн хатан болно.

Хатан. Тийм энэ хөөрхөн бяцхан охин бол хатан гэдгийг би санаж байх ёстой. Тэр гарцаагүй хөөрхөн хүрэн үс зүрхэн хэлбэртэй нүүр, ичингүйрсэн инээмсэглэлтэй ажээ. Гоолиг хэдий ч сайн ташаатай юм гэдгийг Кателин анзаарлаа. Ядахдаа хүүхэд төрүүлэхэд асуудалгүй юм.

Хатагтай Сибелл цааш олон үг хэлэхээс урьтаж гарыг нь атгалаа.

- Бид Старкийн овогтой нэгдэж байгаа нь туйлын нэр хүндийн хэрэг, хатагтай. Гэвч ихэд ядарч байна. Богино хугацаанд урт зам туулах шаардлага гарсан юм. Магадгүй өрөөндөө амарч та хүүтэйгээ зочилж болохгүйсэн болов уу?

- Тэгсэн нь дээр. Даамал чамд тохиромжтой өрөөнд олно гээд Робб Жэйнийг үнслээ.

- Би түүнийг даамалд хүргэж өгье гэж сэр Эдмур Талли сайн дураар санал болгов.

- Та их эелдэг юм гэж хатагтай Сибелл хэллээ.

- Би бас явж болох уу? Таны хиа чинь шүү дээ гэж Роллам хүү асуухад,

- Одоохондоо надад хиагийн хэрэг байхгүй гээд Робб хөхөрлөө.

- Өө.

- Роллам эрхэм дээдэс чамтай чамгүй арван зургаан жил явж ирсэн болохоор хэдхэн цаг тэсч чадна гэж бодож байна гээд тэнгисийн дунгын сүлдтэй сэр Рэйналд бага дүүгийнхээ гараас чанга атган танхимаас гарлаа.

- Чиний эхнэр хөөрхөн, Вестерленгийнхэн хүндтэй санагдаж байгаа ч лорд Гавен Тайвин Ланнистерт зүтгэх андгай өргөсөн хүн биз дээ? гэж Кателин тэднийг хараанаас далд ороход асуув.

- Тийм. Жэйсон Маллистер түүнийг Шивнэдэг ойд барьж аваад Сигардаас барьцаа ирэх хүртэл хүлээж байсан юм. Мэдээж одоо би түүнийг сулласан ч надтай нэгдэхийг хүсээгүй. Бид түүний зөвшөөрөлгүй гэрлэж энэ гэрлэлт түүнд хүндээр туссан гэж бодож байна. Краг бол хүчтэй газар биш. Надад дурласнаараа Жэйн бүгдийг алдсан гэхэд,

- Чи ч гэсэн Фрейгийнхныг алдсан гэж Кателин аяархан хэллээ.

Тэр ярвайлаа. Кателин одоо л ууртай хоолой болон Первин Фрей, Мартин Риверс нар яаран гарахдаа газар хэвтсэн Роббын тугийг гишгэцсэнийг ойлгов.

- Чамаас сүйт бүсгүйтэй чинь хичнээн цэрэг ирсэнийг асууж болох уу, Робб?

- Тавь. Арваад хүлэг баатар гээд хоолой нь баргар дуулдлаа. Ихэртэй хийсэн гэрлэлтийн хэлэлцээрийн дагуу хөгшин лорд Валдер Фрей Роббод мянган морьтой хүлэг баатар ойролцоогоор гурван мянган явган цэрэг илгээсэн билээ.

- Жэйн ухаалаг үзэсгэлэнтэй. Бас сайхан сэтгэл, уяхан зүрхтэй.

Чамд илд хэрэгтэйгээс бус уяхан зүрх биш. Чи яаж үүнийг хийж чадав аа, Робб? Яаж ийм ухаангүй тэнэг авирлаж байгаа юм? Чи яаж ийм... ийм... залуухан байж. Гэсэн ч зэмлээд бүтэхгүй тул Кателин,

- Надад энэ бүхэн яаж болсныг хэлээч гэв.

- Би түүний цайзыг эзэлж тэр миний сэтгэл зүрхийг эзэлсэн гээд Робб инээмсэглэв.

- Краг сул хамгаалалттай болохоор бид ганц шөнийн дайралтаар эзэлсэн. Хар Валдер болон Бага Жон хоёр ханан дээгүүр дэгээ шидэн давах хэсгийг тэргүүлэх зуур би төв хаалгыг нь мөргүүрээр эвдэлсэн. Би сэр Рольфыг шилтгээнээ бууж өгөхөөс өмнө гартаа сумны шарх авсан юм. Эхэндээ юу ч биш мэт санагдсан ч цааш бугласан. Жэйн намайг өөрийнхөө оронд оруулан халуун өнгөртөл сувилсан. Тэр Том Жон надад Бран, Рикон хоёрын тухай Винтерфеллийн тухай мэдээ авчирах үед надтай хамт байсан юм гээд дүү нарынхаа нэрийг шаналангуй хэлснээ,

- Тэр шөнө Жэйн... намайг тайтгаруулсан, ээжээ гэв.

Кателинд Жэйн Вестерлинг хүүг нь ямар төрлийн аргаар тайтгаруулсныг асуухын ч хэрэг байсангүй.

- Харин чи түүнтэй дараагийн өдөр нь гэрлэсэн гэхэд Робб түүн рүү бардам хэрнээ золгүй харав.

- Энэ бол нэр хүндийн хэрэг байсан. Тэр зөөлөн эелдэг сэтгэлтэй. Тэр миний сайн эхнэр болно, ээжээ.
- Магадгүй л юм. Гэхдээ энэ лорд Фрейг тайтгаруулахгүй л болов уу даа.
- Мэдэж байна гэж хүү нь нэрвэгдсэн дуугаар хэлэв.
- Би тулалдаанаас бусад бүх зүйлийг муу хийсэн. Би тулалдаан үүнийг хамгийн хүнд хэсэг гэж бодсон ч... хэрвээ таны үгийг сонсон Теоныг олзлогдогч хэвээр байлгасан бол умардыг захирсан хэвээр Бран, Рикон хоёр ч гэсэн Винтерфеллд аюулгүй амьд байх байсан.
- Магадгүй. Эсвэл үгүй ч байж мэднэ. Лорд Бэйлон дайтах боломж хайсан хэвээр байгаа. Тэр сүүлчийн удаа титэм хүртэх үед хоёр хүүгийнхээ амиар төлсөн. Энэ удаад зөвхөн ганцыг алдана гэж бодсон биз гээд гарт нь хүрлээ.
- Чамайг гэрлэсний дараа Фрейгийнхэн яасан бэ? гэхэд Робб толгой сэгсэрлээ.
- Сэр Стевронтой байсан бол би эвийг нь олохын тулд чадах бүхнээ хийх байсан ч сэр Райман бул чулуу шиг хатуу авиртай харин Хар Валдер зөвхөн сахлынхаа өнгөнөөс тийм нэртэй болоогүй гэдгийг би таньд амлах байна. Тэр дэндүү цаашилж эгч дүүс нь бэлэвсэн эртэй гэрлэхийг хүсэхгүй гэсэн. Би үүнийх нь түүнийг алах байсан ч Жэйн өршөөхийг гуйсан юм.
- Чи Фрейгийн овгийг гутаан доромжилсон, Робб.
- Би ерөөсөө тэгэх гээгүй. Сэр Стеврон миний төлөө үхэж, Оливар ямар ч хаанд байх ёсны үнэнч хиа байсан. Тэр надтай үлдэхийг гуйсан ч сэр Райман үлдсэн хүмүүсийнхээ хамт бүх цэргээ авч явсан. Том Жон намайг тэдэн рүү дайрахыг ятгасан ч...
- Дайсныхаа дунд өөрсдийнхөнтэйгээ байлдана гэнэ ээ? Энэ чиний төгсгөл болох байсан.
- Тиймээ. Гэвч би лорд Валдерийн охидод өөр зохицох хүн олж өгдөг юм уу гэж бодож байгаа. Сэр Вендел Мандел нэгийг нь авахыг санал болгож, Том Жон авгууд нь ахин гэрлэхийг хүсч байгаа гэсэн. Хэрвээ лорд Валдер ухаалаг байвал...
- Тэр ухаалаг хүн биш. Тэр бардам зантай дүрэлзсэн өөнтөгч хүн. Чи үүнийг мэдэж байгаа. Тэр ач хүүгээ хаан болгохыг хүссэн байхад чи түүнийг хоёр буурал дээрэмчин болон долоон ханлигийн хамгийн тарган хүний хоёр дахь хүүг гэрлүүлэхийг санал болгосноор тайтгаруулж чадахгүй. Чи зөвхөн өгсөн амлалтаа эвдээд зогсохгүй Ихрийн нэр хүндийг дорд овгоос гэрлэх сүйт бүсгүй сонгосноороо гутаасан гэхэд Робб дүрсхийлээ.
- Вестерлингийнхэн Фрейгийнхэнээс дээр цустай. Тэд Анхны хүмүүсээс залгамжлан ирсэн эртний удам судартай. Байлдан дагуулалтын өмнө Чулууны хаад Вестерленгийнхэнтэй гэрлэж, өөр нэг Жэйн Вестерлинг гурван зуун жилийн өмнө хаан Мэйгорын хатан болж байсан.
- Энэ бүхэн чинь зөвхөн лорд Валдерийн шарх руу давс цацах болно. Түүнийг үргэлж хуучны овгууд Фрейгийнхныг дээрээс нь хардаг явдал эмзэглүүлж байсан. Энэ түүний үүрсэн анхны

доромжлол биш. Жон Аррин ач хүүгээ хүмүүжүүлэхээр өгөхийг дургүйцэж миний эцэг охидынх нь нэгтэй Эдмурыг гэрлүүлэх саналаас татгалзсан гээд Кателин буцаж ирж байгаа дүүгийнхээ зүг толгойгоо хандуулахад,

- Эрхэм дээдсээ бид яриагаа тусдаа үргэлжлүүлсэн нь дээр байх гэж Бринден Хар загас хэлэв.

- Тиймээ. Би хувьдаа хундага дарс цааш харуулмаар байна. Уулзалтын өрөөнд орцгооё гэж Робб ядарсан дуугаар хэлэв.

Тэд шатны гишгүүр өгсөхөд Кателин танхимд орж ирсэн цагаас сэтгэлийг нь зовоож байсан зүйлээ асуулаа.

- Робб Хөнгөн салхи хаана байна?

- Хашаанд хонины гуя идэж байгаа. Би нохой маллагчид түүнийг хоолло гэж хэлсэн.

- Чи урьд нь үргэлж түүнийг өөртэйгээ хамт байлгадаг байсан.

- Танхим бол чоно байлгах газар биш. Түүний тогтож ядсан байдлыг та харсан биш дээ. Архирч хүржигнээд л. Би түүнийг тулалдаанд авч явах ёсгүй байж. Тэр дэндүү олон хүн алсан болохоор хүмүүсийг одоо айлгадаг болсон. Жэйн түүнийг ойр хавьд байхад санаа зовж ээж нь бас түүнээс айдаг.

Үүнд л гол учир байгаа юм гэж Кателин бодлоо.

- Робб тэр чиний нэг хэсэг. Түүнээс айсан зүйл чамаас айна.

- Тэдний намайг юу гэж дуудах хамаагүй би чоно биш, ээжээ. Хөнгөн салхи Краг, Эшмаркад хүн алж, Окскроссод долоон хүн алсан. Хэрвээ та тэр үед нь харсан бол гэж Робб уурсангүй хэлэв.

- Би Браны чоно Винтерфеллд түүнд хайртай болохоор хүний хоолой тас хазахыг харсан.

- Тэр чинь өөр хэрэг. Крагын хүн бол Жэйний бүх насаараа мэдэх хүлэг баатар байсан. Та түүнийг айсных нь төлөө буруутгаж болохгүй. Хөнгөн салхи нагац ахад нь ч гэсэн дургүй. Тэр сэр Рольфыг ойртох тоолон шүдээ ярзайлгаад байдаг юм гэхэд Кателины дотор хүйт даалаа.

- Сэр Рольфыг холдуул. Даруйхан шүү.

- Хааш нь? Ланнистерийнханд толгойг нь хадаасанд өлгүүлэхийн тулд Краг руу буцааж уу? Жэйн түүнд хайртайн зэрэгцээ сайн хүлэг баатар. Надад Рольф Спайсер шиг хүн олон хэрэгтэй байгаа ч цөөхөн байна. Би түүнийг зөвхөн чоно минь үнэрт нь дургүй байсны төлөө хөөж чадахгүй.

- Робб гээд Кателин зогсож гараас нь атгалаа.

- Би урьд нь чамд Теон Грэйжойг ойрхон байлга гэж хэлэхэд сонсоогүй. Намайг одоо сонс. Энэ хүнийг явуул. Би чамд түүнийг хөө гэж хэлээгүй байна. Эр зориг шаардагдах даалгавар өгөх юм

уу хүндтэй үүрэг онооно уу хамаагүй явуул. Гэвч түүнийг өөртэйгээ ойрхон битгий байлга.

- Би Хөнгөн салхиар бүх хүлэг баатруудаа үнэрлүүлэх болж байна уу? Тэнд түүний дургүй өөр хүмүүс бий гээд Робб хөмсөг зангидлаа.

- Би Хөнгөн салхийн дургүй ямар ч хүнийг чамтай ойрхон байлгахыг хүсэхгүй байна. Эдгээр чононууд бол ердийн нэг чоно биш, Робб. Чи үүнийг мэдэх ёстой. Би тэднийг бурхад бидэн рүү илгээсэн гэж бодож байна. Чиний эцгийн бурхад, хуучин умардын бурхад. Старкийн таван хүүхдэд илгээсэн таван бэлтрэг.

- Зургаа. Жонд ч гэсэн ижилхэн чоно илгээсэн. Намайг тэднийг олсныг санаж байна уу? Би тэднийг хэд байсан болон хаана байсныг нь мэднэ. Би бас тань шиг чононууд бидний харуул, хамгаалагч гэж бодож байсан ч хүртэл...

- Хүртэл гэнэ ээ? гэхэд Роббын ам чангарлаа.

- Надад Теон Грэйжой Бран, Рикон хоёрыг алсан гэж хэлэх хүртэл. Чононууд нь үүнд тэдэнд багахан тус болсон. Би хөвгүүн байхаа больсон, ээжээ. Би хаан болохоор өөрийгөө хамгаалж чадна гээд санаа алдаж,

- Би сэр Рольфод ямар нэг үүрэг оноон явуулъя. Чонын үнэрлэснээс ч биш таны сэтгэлийг тайвшируулахын тулд. Та хангалттай зовсон гэв.

Кателин санаа амран хацар дээр нь үнсэхэд тойрон зогссон бусад хүмүүс шат руу эргэхээс урьд агшин зуур тэр хаан биш ахин хүү боллоо.

Их танхимын дээд талд байрлах Лорд Хостерийн хувийн уулзалтын танхим жижигхэн бөгөөд дотны яриа өрнүүлэхэд зохимжтой байв. Робб өндөр суудал эзлэн титмээ тайлж шалан дээр дэргэдээ тавихад Кателин дарс авчрахыг дуудлаа. Эдмур авга ахынхаа чихийг Чулуун тээрэмд байлдсан бүхэл бүтэн тулалдаанаар дүүргэж байв. Зарц нарыг явсан хойно Хар загас хоолойгоо засаад,

- Бид чиний бардамналыг хангалттай сонссон гэж бодож байна, зээ минь гэхэд Эдмур гайхан балмагдаж,

- Бардамнал гэнэ ээ? Та юуны тухай яриад байна? гэв.

- Би чамайг эрхэм дээдэст худал хэлснийх нь төлөө талархах өртэй гэж бодож байна. Тэр Их танхимд чамайг хүмүүсийн чинь өмнө гутаахгүйн тулд хошин жүжиг тоглосон. Би байсан бол чамайг тэнэг гарамнуудаа магтсаны төлөө арьсыг чинь өвчих байсан юм гэв.

- Тэдгээр гармыг хамгаалж олон сайн хүн үхсэн, авга ахаа. Залуу Чоноос өөр хэн ч ялж болдоггүй юм уу? Намайг Роббын гавъяанаас хулгайлсан гэж хэлэх гээ юу? хэмээн Эдмур уурлалаа.

- Эрхэм дээдэс гэж Робб хүйтнээр засав. - Чи намайг хаан болгосон, нагац ах минь. Эсвэл үүнийгээ ч гэсэн бас мартаа юу? гэхэд Хар загас,

- Чи Эдмурт Риверраныг хамгаалахаас ондоо зүйл тушаагаагүй гэв.

- Би Риверраныг барьж лорд Тайвины хамраас цус гартал...

- Чи тэгсэн. Гэвч цустай хамраар дайнд ялахгүй биз дээ? Чи ер нь яагаад биднийг өрнө зүг Окскроссын дараа удаан үлдсэн тухай бодож үзсэн үү? Чи надад Ланниспорт, Кастерли Рокийг сүрдүүлэх хэмжээний цэрэг байгаагүйг мэдэж байгаа гэж Робб хэлэв.

- Яагаад гэвэл тэнд өөр бусад шилтгээн... алт, мал сүрэг байгаа...

- Чи биднийг олзны төлөө үлдсэн гэж бодоо юу? Нагац ах бид хоёр лорд Тайвиныг өрнө зүг ирэхийг хүссэн юм гэж Робб үл итгэсэн байртай хэллээ.

- Бид бүгд морьтой байсан. Ланнистерийн цэргийн ихэнхи хэсэг явган байлаа. Бид лорд Тайвинтай эргийн дээш доош хөгжилтэй мөшгөн хөөцөлдөж ард нь сэмхэн гараад гарч тагнуулуудын минь олсон туйлын тохиромжтой газар алтан замыг сөрөн хаасан хүчтэй бэхлэлтийн байр эзлэхээр төлөвлөсөн юм. Хэрвээ тэр тэгэхэд бидэн рүү ирсэн бол харамсмаар үнэ төлөх байлаа. Гэвч тэр дайралгүй баруун зүг хэрэгтэй газраасаа мянган бээрийн зайд занганд орсон хэвээр байсан. Энэ бүх хугацаанд бид түүний газарт амьдарч байхад тэр манай нутаг дэвсгэрт амьдарч байлаа гэж сэр Бриенден хэлэв.

- Лорд Станнис Хааны газар сүйрсэн. Тэр биднийг Жоффри, хатан, Бяцхан чөтгөрийн улаан дайралтаас салгаж өгөх байсан юм. Тэгсэн бол бид энхийг байгуулах боломжтой байлаа гэж Робб хэлэв.

- Та надад хэлээгүй гээд Эдмур авга ах руугаа харлаа.

- Би чамд Риверраныг барь гэж хэлсэн. Энэ тушаалын юу нь чамд ойлгомжгүй байна? гэж Робб асуув.

- Чи лорд Тайвиныг Улаан салаа дээр зогсоож Гашуун гүүрнээс гарсан морьтон өмнө зүгт юу болсныг дуулгах хугацаанд удаан саатуулсан байна. Лорд Тайвин цэргээ даруй эргүүлэн Хар усны эхэнд байсан Маттис Рован, Рэндилл Тарлитай нартай нэгдээд Мэйс Тайрелл хоёр хөвгүүн болон усан онгоцны флот их хэмжээний цэргийн хамт хүлээж байсан Хүрхрээний уналт рүү хөдөлсөн байна. Тэд голын уруу хөвж хотоос хагас өдрийн зайд газардан Станнисийг ар талаас нь дайрсан гэж Хар загас хэлэв.

Кателин Рэнли хааны ордонд Гашуун гүүрийг харснаа саналаа. Мянган алтан сарнай салхинд намирч, хатан Маржэйригийн зальжин инээмсэглэл зөөлөн үг, чамархайд нь судал хүрэнгэсэн түүний ах Цэцэгт хүлэг баатар гээд л. *Хэрвээ чи эмэгтэй хүний гарт унах байсан юм бол яагаад Маржэйри Тайреллийнх байж болоогүй юм бэ, хүү минь?* Хайгардены хүч эд баялаг тулалдааныг өөр тал руу нь эргүүлэх байлаа. *Магадгүй Хөнгөн салхи түүний үнэрт дуртай байх байсан ч юм билүү.*

Эдмур балмагдсан харагдав.

- Би хэзээ ч... хэзээ ч Робб чи надад залруулах боломж өгөх ёстой. Би дараагийн тулалдаанд хошууч цэргийг тэргүүлнэ!

Залруулахын төлөө юу, дүү минь? Эсвэл алдар гавъяаны төлөө юу? гэж Кателин гайхширав.

- Дараагийн тулалдаан удахгүй болно биз. Жоффри гэрлэмэгц Ланнистерийнхан тулааны талбарт миний эсрэг ахин гарна гэдэгт эргэлзэхгүй байна. Энэ удаад Тайреллийнхан тэдний дэргэд мөр зэрэгцэн хөдөлнө. Дээрээс нь би Хар Валдер өөрийнхөө замаар зүтгэсэн хэвээр байвал Фрейгийнхэнтэй ч гэсэн тулалдах хэрэг гарна...

- Дүү нарын чинь цусаар гараа будсан Теон Грэйжой эцгийн чинь суудал хичнээн удаан суух тусам бусад дайсан хүлээж байг. Чиний эхний үүрэг бол өөрийнхөө хүмүүсийг хамгаалж Винтерфеллийг буцааж аван Теоныг хэрээний торонд удаан зовж үхэхээр дүүжлэх явдал. Эсвэл титмээ авч тавьсан чинь дээр, Робб. Тэгвэл хүмүүс чамайг жинхэнэ хаан биш гэдгийг мэднэ.

Энэ удаад Робб түүн рүү харахад Кателин удаан хугацаанд хэний ч зүрхлээгүй хурц мохоо үг хэлснээ мэдлээ.

- Тэднийг надад Винтерфелл унасан гэж хэлэхэд би даруйхан умард зүг хөдлөхийг хүссэн гэж Робб өөрийгөө өмгөөлөнгүй хэлээд, - Би Бран, Рикон хоёрыг суллахыг хүссэн ч... Теоныг хэзээ ч тэдэнд жинхэнээсээ гэм учруулна гэж төсөөлсөнгүй. Хэрвээ би....

- Хэрвээ чинь дэндүү хожимдож аврахад оройтсон байна. Одоо зөвхөн өшөө хорсол үлдсэн.

- Бидний умард зүгээс авсан сүүлчийн мэдээгээр сэр Родрик төмөр хүмүүсийн цэргийн хүчийг Торрений талбайн ойролцоо ялж, Сервений цэрэгтэй хүч хавсран Винтерфеллийг авахаар хөдөлсөн гэсэн. Гэвч одоо дууссан ч байж магадгүй. Тэндээс удаан хугацаанд сураг ирээгүй. Сэрээний хувьд би умард зүг эргэх үү? Би голын лордуудаадс өөрийнхөө хүмүүсийг орхихыг гуйж чадахгүй.

- Үгүй. Чи тэднийг хүмүүсээ хамгаалуулан орхиод хойд зүгийг умардынхантай авах ёстой.

- Та нар яаж умардынхантай хойд зүг явах гэж байгаа юм бэ? Төмөр хүмүүс наран жаргах тэнгисийг хянаж байгаа. Грэйжойгийнхон Кайлины сувгийг ч гэсэн адил барьж байгаа. Кайлины сувгийг өмнө зүгээс ямар ч арми эзэлж байсан түүхгүй. Үүний эсрэг хөдлөх хүртэл ухаангүй хэрэг. Бид далангийн зам дээр занганд орж төмөр хүмүүс урдаас дайрахад ууртай Фрейгийнхан араас дайрна гэж Эдмур хэлэв.

- Бид Фрейгийнхныг буцааж авах ёстой. Тэдэнтэй бол амжилтанд хүрэх найдлага өчүүхэн ч гэсэн байхад байхгүй бол би ямар ч найдлага олж харахгүй байна. Би лорд Валдераас уучлал гуйж, нэр хүнд, газар нутаг, алт гээд бахархлыг нь тайвшируулах ямар ч зүйл байсан өгнө гэхэд,

- Ямар ч зүйл биш. Хэн нэг хүнийг гэж Кателин хэллээ.

ЖОН

- За чамд хангалттай юу? гээд Тормундын өргөн царайд цоохортсон цасан ширхэг үс сахалд нь хайллаа.

Арслан заан унасан аварга биетүүд удаанаар ганхан дэргэдүүр нь хоёр хоёроороо өнгөрөв. Жоны морь тэдгээр хачин амьтдаас айхад арслан заан юм уу морьтонгуудын аль нь түүнийг айлгасныг хэлэхэд бэрхтэй байлаа. Сүнс хүртэл алхам ухран шүдээ ярзайлган чимээгүй архирав. Зэрлэг чоно биерхүү ч арслан заанууд хамаагүй том дээрээс нь маш олуулаа байлаа.

Жон морио тайвшируулан илээд Сүүн усны дагуу хуйлран дэгдэх салхинд хийсэх цас цайвар манан дундаас гарч ирэх аварга биетүүдийг тоолов. Түүнийг тавь хүрээд байтал Тормунд ямар нэг зүйл хэлж тоог нь алдуулав. Тэд хэдэн зуугаараа байх. Дэргэдүүр хичнээн өнгөрсөн хамаагүй төгсгөлгүй цуврах шиг санагдана.

Хөгшин Нанын үлгэрт аварга биетүүд нүсэр том шилтгээнд амьдардаг ердийн хүмүүс бөгөөд том илдээр тулалдаж дотор нь хүүхэд багтчихмаар том гутлаар явдаг байв. Үнэн хэрэгтээ тэд хүнээс илүү баавгайтай төстэй унаж яваа арслан заан шигээ үс ноостой ажээ. Заан дээр суусан учир хэр том болохыг нь хэлэхэд бэрх байлаа. *Арав магадгүй арван хоёр футын өндөр байх. Эсвэл арван дөрөв түүнээс хэтрэхгүй* гэж Жон бодов. Тэдний цээжний яс хүнийхээс хамаагүй том гар нь доош дэндүү урт бөгөөд биеийн доод хэсэг нь дээд талаасаа хагас дахин өргөн байлаа. Хөл нь гараасаа богинохон ч маш бүдүүн гутал өмсдөггүй учир палбигар майга хатуу эвэртэй хар байв. Их бие нь хүзүүгүй учир хүнд том толгой хоёр мөрний дундаас урагш түрж царай нь хавтгай хэрцгий байв. Эвэрлэг үрчлээтэй арьсан дунд жижигхэн бөөрөнхий хархны нүд бараг алдагдаж харахаас илүү үнэртдэг бололтой хамар нь үргэлж шиншилнэ.

Тэд амьтны арьс өмсөөгүй үс юм байна гэж Жон ойлгов. Биеийг нь битүү үс хучиж бүсэлхий хэсгээрээ арай өтгөн дээгүүрээ сийрэгдүү ажээ. Арслан заанаас болсон ч байж магадгүй амьсгаа бөглөрөм өмхий үнэр ханхлав. *Жорамун Өвлийн бүрээг үлээж аварга биетүүдийг газрын хөрснөөс сэрээжээ.* Жон арван фут урт сэлэм эрэн харсан ч зөвхөн бороохой байлаа. Бороохойны ихэнхи үхсэн модны их биеэр хийсэн зарим нь хугарсан мөчиртэйгээ байв. Цөөн хэд нь үзүүр хэсэгтээ бөндгөр чулуутай асар том муна аж. *Дуунд хэзээ ч бүрээ тэднийг буцаан унтуулаагүй гэдэг.*

Аварга биетүүдийн нэг харваас бусдаасаа ахмад бололтой. Түүний арьсны үс бууралтсан цагаан судалтай бусдаасаа хавьгүй том цагаан саарал арслан заан дээр явж байлаа. Тормунд түүнийг өнгөрөхөд Жоны ойлгохгүй хэлээр ямар нэг зүйл хашгиран хахир хэдэн үг хэлэв. Аварга биетийн ам дүүрэн том дөрвөлжин шүдтэй уруул нээгдэн хэхрэх гүнгэнэхийн завсар авиа гарахад хормын дараа Жон инээж буйг нь ойлгов. Арслан заан нүсэр толгойгоо тэдэн рүү эргүүлэн өнгөрөхөд том соёоны нэг Жоны толгой дээгүүр өнгөрч адгуус голын эргийн дагуух шинэхэн цасны зөөлөн шавар дээр том хөлийн мөр үлдээсээр гэлдэрч одов. Аварга биет Тормунд руу адилхан сөөнгө хэлээр юм хашгирлаа.

- Энэ тэдний хаан уу? гэж Жон асуув.

- Арслан заан, цасны баавгай, саарал тэнгисийн том халимуудад хаан гэж байдаггүйн адил аварга биетүүдэд хаан байхгүй. Энэ бол Маг Мар Тун Доб Вэг буюу Хүчит Маг. Чи хүсвэл өвдөг сөгдөж болно тэр татгалзахгүй. Би чиний өвдөг ямар нэг хаанд мөргөхийг хүсэн загатнаад байгааг мэднэ. Дээрээсээ битгий гишгүүлчихээрэй. Аварга биетүүд хараа муутай болохоор хөл дороо байгаа бяцхан хэрээг харахгүй байж магадгүй.

- Чи түүнд юу гэж хэлсэн бэ? Хуучны хэл байсан уу?

- Тийм. Би түүнээс эцэг нь бас дээр явж байгаа эсэхийг асуусан юм. Эцэг нь арай дээр үнэртэйгээс биш тэд хоёул адилхан.

- Харин тэр чамд юу гэж хэлсэн юм? гэхэд Тормунд Аянгын нударгат онгорхой шүдээрээ инээмсэглэв.

- Тэр надаас зөөлөн ягаан хацартай миний дэргэд байгаа хүн охин минь эсэхийг асуусан юм гээд мөрөн дээрх цасаа сэгсрэн морио эргүүлэв.

- Энэ магадгүй түүний урьд нь хэзээ ч сахалгүй хүн харж байгаагүйгээс болсон байж мэднэ. Хойшоо буцацгаая. Манс намайг байх ёстой газартаа байхгүйг мэдвэл уурлана.

Жон морио эргүүлэн Тормундын араас цувааны толгой руу буцахад шинэхэн хүнд нөмрөг мөрөнд нь намирав. Энэ нь зэрлэгүүдийн ёсоор угаагаагүй хонины нэхийг дотогш харуулан оёсон нөмрөг байв. Нөмрөг салхи нэвтрүүлэхгүй шөнө сайхан дулаахан байсан ч Жон хар нөмрөгөө хадгалсан хэвээр эмээлийн дор хуйлж хийжээ.

- Чамайг урьд нь аварга биет алсан гэж үнэн үү? гэж Тормундаас явах замдаа асуулаа. Сүнс тэдний дэргэд шинэхэн цасан дээр сарвууны мөр гарган шогшив.

- Чи яахаараа над шиг ийм хүчирхэг хүнд эргэлздэг билээ? Энэ бол намайг бүх хөвгүүдийн адил тэнэг жаахан байхад өвөл болсон явдал юм. Би дэндүү хол явсан болохоор морио үхүүлж шуурганд өртлөө. Жинхэнэ шуурга болохоос биш иймэрхүү жижигхэн тоос босгосон зүйл биш. Хар! Би цөхөрхөөсөө урьд хөлдөж үхэхээ мэдэж байлаа. Ингээд би унтаж буй аварга биет олж гэдсийг нь яран дотор нь мөлхөн орж унтсан юм. Тэр намайг дулаацуулсан ч өмхий үнэр нь тэсэхийн аргагүй байлаа. Хамгийн дор нь гэвэл тэр хавар сэрээд намайг шинэ төрсөн хүүхдээ гэж бодсон бололтой тэндээс зугатах хүртэл гурван сарын турш хөхүүлж хооллосон. Хар! Би одоо хүртэл аварга биетийн сүүг санаж байна шүү.

- Хэрвээ тэр чамайг тэжээсэн юм бол алаагүй юм уу?

- Хэзээ ч тийм биш. Гэхдээ энэ тухай хүнд битгий хэлээрэй. Тормунд Аварга биетийн хүүхэд байснаас Тормунд Аварга биетийг хөнөөгч байсан нь хамаагүй дээр сонсогдоно.

- Тэгвэл чи бусад нэрээ хаанаас авсан юм бэ? Манс чамайг Бүрээ үлээгч, Улаан өргөөний Балын хаан, Баавгайн нөхөр гэж дуудаж байсан биз дээ? гээд Жон ялангуяа бүрээ үлээсэн тухай сонсохыг хүссэн ч шууд асууж зүрхэлсэнгүй. *Жорамун Өвлийн бүрээг үлээж аварга*

биетүүдийг газрын хөрснөөс сэрээсэн. Энэ тэдний ирсэн газар бол арслан заанууд нь хамт байсан юм болов уу? Манс Райдер Жорамуны бүрээг олж Тормунд Аянгын нударгатад үлээлгэхээр өгсөн юм биш биз дээ?

- Бүх хэрээнүүд чам шиг ийм сониуч байдаг уу. Тэгэхээр би чамд ярьж өгье. Энэ бол аварга биетийн гэдсэнд өнгөрүүлснээс ч хүйтэн өөр нэг өвөл болсон явдал юм. Тэгэхэд цас өдөр шөнөгүй орж чиний толгойноос ч том цасан ширхэгтэй байснаас биш ийм өчүүхэн биш. Маш их цас орсон болохоор бүтэн тосгоны тал дарагдлаа. Би Улаан танхимын дотор торхонцортой балнаас ондоо ханьгүй суугаад уухаас ондоо хийх зүйл юу ч үгүй байв. Ингээд би уух тусам хөрш амьдардаг чиний урьд хожид харсан хамгийн том хөхтэй хүчтэй эмэгтэйн тухай бодлоо. Тэр муухай ааштай ч бие нь зуух шиг халуун болохоор өвлийн гүнд эр хүнд дулаан хэрэгтэй байлаа.

- Тэгээд улам их ууж түүний тухай бодох тусам тэсгэл алдан цааш тэсэхгүй болов. Тэнэг байсан болохоор хөлөөс толгой хүртлээ арьсаар баглаж аваад нүүрээ ноосоор ороож түүнийг хайхаар явлаа. Цас маш ширүүн орж байсан болохоор би хоёр гурван ч удаа төөрч салхи над руу үлээн ясандаа хүртэл хөлдөх шахсан хойно түүн рүү багласан чигээрээ очсон юм даа.

- Тэр эмэгтэй аймшигтай муухай ааштай байсан болохоор намайг гараас нь барихад эсэргүүцсэн. Миний чадах бүх зүйл гэвэл түүнийг гэр лүүгээ аваачиж арьс үснээс нь салгах байсан бөгөөд дээлийг нь тайлсан хойно миний санаснаас ч илүү халуухан байж бид хуучны сайхан цагийг өнгөрүүлээд би унтсан. Маргааш өглөө нь би сэрэхэд цас намдаж нар гарч байсан ч баярлах зүйл байсангүй. Бүх бие маань зулгарч урагдан эрхтэний минь хагас алга болж шалан дээр эмэгчин баавгайн арьс байлаа. Удалгүй чөлөөт хүмүүс ойд хоёр бамбаруушаа дагуулан яваа нүцгэн баавгай харсан байна лээ. Хар-р! гээд тэр махлаг гуяа алгадлаа.

- Би түүнийг ахин олсон ч болоосой. Тэр баавгайтай унтахад хичнээн сайхан байсан гээч. Хэзээ ч ямар ч эмэгтэй надтай тийм халуухан байж хүчирхэг хөвгүүд төрүүлж өгч байгаагүй.

- Чи түүнийг олсон бол яах байсан юм? Эрхтэний чинь тал байхгүй болсон гэсэн биз дээ? хэмэн Жон инээмсэглэв.

- Зөвхөн тал нь. Үлдсэн хагас нь ямар ч эр хүнийхээс илүү хоёр дахин урт гээд Тормунд тургилж,

- Харин чиний хувьд... тэд чамайг Ханан дээр очиход чинь эрхтэнийг чинь огтолсон гэсэн үнэн үү? гэв.

- Үгүй гэж Жон доромжлогдон хэллээ.

- Би үүнийг үнэн гэж бодож байна. Үгүй бол яагаад Игритээс татгалзана гэж? Тэр чамд эсэргүүцэхгүй юм шиг санагдаж байна. Охин чамайг хүсч байгаа нь харваас илт байна шүү дээ.

Цувааны хагас нь хүртэл харахаар дэндүү илт гэж Жон бодов. Тэр улайснаа харуулахгүйн тулд бударч байгаа цас руу эргэлээ. Би Шөнийн харуулын эр хүн гэж өөртөө сануулав. Ингэхэд тэр яагаад ичимхий охин шиг улайсан юм бол?

Жон өдрийн ихэнхи болон шөнийн ихэнхийг ч гэсэн Игриттэй өнгөрүүлж байлаа. Манс Райдер Харжигнуур хуягтын хэрээнд итгэхгүй байгааг харахгүй сохор хүн биш тул Жонд хонины арьсан шинэ нөмрөг өгөхдөө Тормунд Аварга биетийг хөнөөгчтэй хамт явахыг зөвлөжээ. Жон үүнийг баяртайгаар зөвшөөрөн тэр өдрөө Игрит, Урт жад Рик хоёртой Харжигнуур хуягтын бүлгийг орхин Тормундынхтай нэгджээ.

- Чөлөөт хүмүүс хүссэн газраа явдаг бид Хүүдийтэй ясанд гэдэс цадаж ханалаа гэж охин түүнд хэлжээ.

Тэднийг шөнө буудаллах болгонд Игрит түүнийг галын хол ойр байсан хамаагүй дэргэд нь хонины арьсан хөнжилтэйгээ унтдаг байв. Нэг удаа Жон сэрээд түүнийг налж гараа цээжин дээгүүр нь тавсан байхыг харжээ. Жон амьсгалахыг нь удаан хугацаанд сонсон хэвтэж биенийхээ хөвчирөхийг тоохгүй байхыг оролдлоо. Эргүүлүүд дулаан байхын тулд үргэлж арьсан дэвсгэр хуваалцдаг ч Жон Игритийг дулаацахыг хүссэндээ тэгээгүй гэж сэжиглэж байв. Үүнээс хойш Жон түүнийг хол байлгахын тулд Сүнсийг ашиглах болсон байна. Хөгшин Нанын үлгэрт хүлэг баатар хатагтай нар нэг оронд унтахдаа нэр хүндийн тэмдэг болгон дундаа илд тавьдаг байсан тухай санамагц анх удаа илдний оронд чоно ашиглажээ.

Тэгсэн ч Игрит салж өгсөнгүй. Түүний дараагийн өдөр Жон санаандгүй халуу устай онгоцонд орох тухай мөрөөдөн ярьжээ.

- Хэрвээ чамайг дараа нь дулаацуулах хүн байгаа бол хүйтэн ч гэсэн дээр. Голын ус бүрэн хөлдөөгүй байгаа.

- Чи намайг хөлдөөж алах гээ юу? гээд Жон инээлээ.

- Бүх хэрээнүүд хүйтэн уснаас айдаг юм уу? Зүгээр дээ жаахан мөс чамайг алахгүй. Би батлахын тулд чамтай хамт орьё.

- Тэгээд бид өдөржингөө нойтон арьсан хувцастай явах болж байна уу? гэж Жон эсэргүүцлээ.

- Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Чи хувцастайгаа орохгүй шүү дээ.

- Тэгсэн ч гэсэн би орохгүй гэж хатуу хэлэхэд Тормунд Аяндын нударга чанга инээлээ.

Зэрлэгүүд Игритийг үснээс нь болж туйлын үзэсгэлэнтэй гэж боддог ажээ. Улаан үс чөлөөт ард түмний дунд ховорхон болохоор ийм үстэй хүнийг гал үнсэгч гэж нэрлэн аз авчирдаг гэж итгэнэ. Магадгүй үнэхээр аз авчирдаг байж мэдэх ч Игритийн улаан үс битүү ширэлдсэн болохоор Жон өөрийн эрхгүй түүнийг улирал солигдоход зөвхөн үсээ самнадаг юм болов уу гэж асуух шахлаа.

Лордын ордонд бол охин жирийн хүмүүсээс өчүүхэн төдий ч ялгагдахгүйг Жон мэдэж байв. Тэр тариачны дугуй царай, навтгар хамартай, шүд нь үл мэдэг тахир, нүд нь хоорондоо хол зайтай байв. Жон үүнийг хамгийн анх хоолойд нь хутга тулгах үедээ анзаарчээ. Хожим нь бусад зүйлийг анзаарсан байна. Гэвч түүнийг инээх үед нь тахир шүд хамаа байсангүй. Магадгүй нүд нь хоорондоо дэндүү зайтай байж болох ч хөөрхөн сааралдуу цэнхэр өнгөтэй түүний мэдэх ямар ч

нүднээс илүү золбоотой байлаа. Заримдаа Игритийг намуухан сөөнгө хоолойгоор дуулах үед Жоны сэтгэл догдолно. Түүнчлэн галын дэргэд өвдөө тэврэн суугаад дөл улаан үсэнд жирвэхийн түүн рүү харан инээмсэглэхэд... бүр их догдолдог байлаа.

Гэвч тэр Шөнийн харуулын тангараг өргөсөн хүн билээ. Би эхнэр авч, газар нутаг эзэмшин, үр хүүхдийн эцэг болохгүй. Жон үүнийг эцгийнхээ бурхдын урд далан модны өмнө хэлсэн. Тэр хэлсэн үгээ буцаахгүй учир Тормунд Аяндын нударгат, Баавгайн нөхөрт дургүй шалтгаанаа хэлж чадсангүй.

- Эсвэл чи түүнд дургүй юм уу? гэж Тормунд тэднийг аварга биетийн оронд зэрлэгүүдийн өндөр модон цамхаг ачсан хориод арслан зааны дэргэдүүр өнгөрөхөд асуулаа.

- Үгүй л дээ гэхдээ би... *Би юу гэж хэлвэл тэр итгэх юм бол?* Би гэрлэхэд дэндүү залуугаараа байна.

- Гэрлэх гэнэ ээ? Хэн хуримын тухай ярьсан юм? Өмнө зүгт эр хүн орондоо оруулсан охид бүртэй гэрлэх ёстой юу? гээд Тормунд хөхөрлөө.

Жон ахин улайхаа мэдэрлээ.

- Тэр Харжигнуур хуягт намайг алах гэж байхад өмгөөлсөн. Би түүнийг гутааж чадахгүй.

- Чи одоо чөлөөт хүн болсон болохоор Игрит ч гэсэн чөлөөт эмэгтэй. Та хоёр хамтдаа унтахад юунд нь гутамшиг байна?

- Би түүнийг хүүхэдтэй болгож болно.

- Харин ч тэгээсэй гэж найдах байна. Хүчтэй хүү, золбоолог инээмсэглэж буй гал үнсэгч охин үүнд юу нь муу байна? гэхэд Жон юу хэлэхээ мэдсэнгүй.

- Хүү... бутчийн хүүхэд болно гэв.

- Тэгээд бутчийн хүүхэд бусад хүүхдүүдээс сул дорой байдаг юм уу? Бие муутай эсвэл амьдарч чадахгүй хэрэг үү?

- Үгүй л дээ гэхдээ...

- Чи өөрөө л бутач байх. Игрит хүүхэд хүсэхгүй бол ойн ямар нэгэн шившлэгтэй эм рүү очоод аяга сарны цай уучихна. Тэгээд ч энэ түүний ажил болохоос биш чинийх биш.

- Би бутчийн эцэг болохгүй гэхэд Тормунд арзгар үсээ сэгсэрлээ.

- Өвдөг сөгдөгч та нар юутай тэнэг вэ. Хэрвээ чи түүнийг хүсэхгүй юм бол охиныг яах гэж хулгайлсан юм бэ?

- Хулгайлах гэнэ ээ? Би хэзээ ч...

- Чи тэгсэн. Чи түүнтэй байсан хоёр хүнийг алж түүнийг авч явснаа юугаар тайлбарлах гэж байна?

- Би түүнийг олзлогдогч болгон авсан.

- Чи түүнийг өөртөө бууж өгүүлсэн.

- Тийм л дээ гэхдээ... Тормунд би хэзээ ч түүнд хүрэхгүй гэдгээ тангараглаж байна.

- Чи үнэхээр тэднийг эрхтэнийг чинь огтлоогүй гэдэгт итгэлтэй байна уу? гээд Тормунд хэзээ ч ийм зүйлийг ойлгохгүй гэдгээ илэрхийлэх мэт мөрөө хавчлаа.

- Тэгэхээр чи одоо чөлөөт хүн болсон болохоор охин авахгүй бол өөртөө эмэгчин баавгай хайж ол. Хэрвээ эр хүн өөрийн зүйлээ ашиглахгүй бол жижигэрсээр байгаад нэг л өдөр шээх гээд олж чадахгүй болдог гэдэг.

Жонд үүнд хариулах зүйл байсангүй. Долоон ханлигт чөлөөт хүмүүсийг хүний тоонд оруулдаггүйд гайхах юм алга. *Тэдэнд хууль дүрэм, нэр хүнд өчүүхэн төдий ч ёс журам байхгүй. Тэд эцэс төгсгөлгүй нэг нэгнээсээ хулгайлан, араатан шиг өсч, гэрлэлтийг хүчээр эзэмдэн ертөнцийг дорд гаралтай хүүхдүүдээр дүүргэж байна.* Гэсэн ч Жон шуудай дүүрэн худал ярьдаг байлаа ч хамаагүй Тормунд Аварга биетийг хөнөөгчид дуртай болжээ. Урт жадад ч гэсэн. *Бас Игрит... үгүй би Игритийн тухай бодож болохгүй.*

Зэрлэгүүдийн дунд Тормунд, Урт жад нараас гадна Харжигнуур хуягт, Уйлагч мэтийн хүний хоолой хэрчихийг нулимаж шиг үздэг өөр төрлийн хүмүүс бий. Тэнд бас Нохойн толгой Харма гэдэг шар айрагны торх шиг тагдгар, том бандгар хацартай нохойнуудыг үзэн ядаж хоёр долоо хоног тутамд нэгийг алан цустай толгойг нь тугандаа өлгөдөг эмэгтэй, өөрийнхөө хүмүүсийн дунд лордоос илүү бурхны зэрэгт хүндлэгддэг чихгүй Тэннийн Магнар Стер болон Зургаан арьст Варамир гэдэг хулгана шиг жижигхэн хойд хоёр хөл дээрээ босох үед арван гурван фут өндөр болдог цасны зэрлэг баавгай унаж явдаг хүн бий. Түүнийг явсан газар болгон баавгай, гурван чоно, сүүдэрт муур дагана. Жон түүний барааг анх харсан даруй бие нь агзасхийн өрвийхөд баавгай, урт хар цагаан судалтай муурыг хараад Сүнсийн шилэн хүзүүний арьс өрвийлөө.

Түүнчлэн Сүнстэй ойн хойд зах, Мөсөн соёотын нууц хөндийгөөс ирсэн болон түүнээс ч хачин газар болох Хөлдүү эргийн далайн морины ясаар хийсэн чарганд сүрэг догшин ноход хөллөсөн хүмүүс, хүний махаар найрладаг аймшигтай мөсөн голын овог, царай нь хөхөрч, хүрэн ногоон болсон агуйн оршин суугчид зэрэг Варамираас ч догшин хүмүүс байлаа. Жон өөрийн нүдээр Эвэр хөлт хүмүүс цувааны дагуу ширээсэн шир шиг хатуурсан нүцгэн хөлөөрөө явахыг харжээ. Тэр ямар ч грамкин, снарк олж хараагүй ч Тормунд заримаар нь зоог барьсныг мэдэж байв.

Зэрлэгүүдийн цэргүүдийн хагас нь амьдралдаа нэг ч удаа Ханыг харж байгаагүй ихэнхи нь нийтийн хэлээр ярьж чаддаггүй байлаа. Гэвч энэ хамаа байсангүй. Манс Райдер хуучны хэлээр ярьж тэр ч байтугай дуулж чаддаг болохоор пипаны чавхдсыг хуруугаараа дарж шөнийг зэрлэгүүдийн хачин хөгжмөөр дүүргэнэ.

Манс энэ бүх сунжирсан олон цэргээ цуглуулахын тулд олон жилийг зарцуулан энэ ч кланы ээж,

тэр ч кланы магнартай ярилцан нэг тосгоныг амтат үгээрээ урхидан нөгөөг нь дуугаараа авч гурав дахийг нь илдийн ирээр эзэлж хоорондоо дайсагналцдаг Нохойн толгой Харма, Ясны лорд болон Эвэр хөлт Шөнөөр гүйгч, Хөлдүү эргийн далайн морин хүмүүс, том мөсөн голын хүний мах иддэг овгуудын дунд энхийг тогтоон зуун янзын хутгыг нэг том жад болгон давтаж Долоон ханлигийн зүрх рүү онилжээ. Түүнд титэм, очирт таяг, торго хилэн нөмрөг байхгүй ч Жоны хувьд Манс Райдер нэрэндээ дүйцсэн хаан болох нь илт байлаа.

Жон зэрлэгүүдтэй Корины тушаалаар нэгдсэн билээ.

- Тэдэнтэй цуг мордон, цуг хооллож, цуг тулалд. Дээрээс нь ажигла гэж эргүүл үхэхийн өмнөх шөнөө хэлжээ. Гэхдээ түүний бүх харсан зүйлд мэдэх зүйл бага байлаа. Корин зэрлэгүүдийг хахир зэлүүд Мөсөн соёотод Ханыг нурааж чадах ямар нэгэн зэр зэвсэг, хүч чадал, шид эрж байна гэж бодсон ч тэд ийм зүйл олсон тухайгаа хэн ч сагсуурах юм уу сайрхан үзүүлсэнгүй. Манс Райдер төлөвлөгөөнийхөө ямар ч хэсгээс итгэн хэлсэнгүй. Анхны шөнөөс хойш Жон барааг нь зөвхөн алсаас харж байлаа.

Хэрвээ шаардлага гарвал би түүнийг ална. Ийм аллага түүнд нэр хүнд авчрахгүй өөрийнх нь аминд хүрэх болохоор Жоныг энэхүү хэтийн төлөв баярлуулсангүй. Гэсэн ч тэр зэрлэгүүдийг Хана руу цөмрөн Винтерфелл болон умард зүг, хиргисүүрийн хоосон тал, Цагаан боомт, Чулуун эрэг, Хүзүү рүү заналхийлэхийг зөвшөөрөхгүй. Найман мянган жилийн турш Старкийн овгийн эрчүүд хүмүүсээ иймэрхүү цөлмөгч дээрэмчдээс амь биеэрээ хамгаалж байсан байхад бутач гаралтай ч гэсэн түүний судсанд ижил цус гүйж байгаа билээ. *Дээрээс нь Бран, Рикон хоёр ч гэсэн Винтерфеллд байгаа. Мэйстер Лювин, сэр Родрик, Хөгшин Нан, Фарлен нохдын байранд, Миккен дархны газраа, Гэйж зуухныхаа дэргэд... гээд түүний мэдэх хайртай бүх хүмүүс байгаа.* Хэрвээ Жон хүн алах ёстой бол тэднийг Харжигнуур хуягт, нохойн толгой Харма болон чихгүй Теннийн Магнар нарын үзүүлэх өршөөлөөс аврахын тулд үүнийг хийнэ.

Гэсэн ч эцгийнх нь бурхад ийм найдлагагүй даалгавраас ангижируулах буй за хэмээн мөргөлөө. Цэргүүд зэрлэгүүдийн ачаа бараа, мал сүрэг, хүүхэд багачууд, эд баялагт түүртэн удаан хөдөлж цас хөдөлгөөнийг нь улам удаашруулна. Цувааны ихэнхи хэсэг одоо толгодын хормойгоос гараад Сүнстэй ойн зүрх рүү урсаж буй Сүүн усны өвлийн хүйтэн өглөө сархинагтай бал шиг нэвчсэн баруун эргийн дагуу уруудаж байв.

Урд нь хаа нэгтээ модны орой дээгүүр цухуйсан Анхны хүмүүсийн нударга дээр Шөнийн ахан дүүсийн гурван зуун зэвсэглэсэн, морьтой хүмүүс хүлээж буй. Хөгшин баавгай Кориноос гадна ондоо туршуулууд илгээсэн болохоор гарцаагүй Жарман Баквелл юм уу Торен Смолвүүд одоо буцаж очоод зэрлэгүүдийн уулнаас бууж байгаа тухай дуулгасан байгаа.

Мормонт зугтахгүй. Тэр хөгшиний зэрэгцээ дэндүү хол явсан. Тэр дайсныхаа тооноос үл харгалзан цохилт өгнө гэж Жон бодлоо. Нэг л өдөр тэр дайны бүрээ хадаж эгнэсэн морьтонгууд тэдний зүг хар нөмрөг намируулан гартаа хүйтэн илдтэй дайрахыг харах болно. Гурван зуун хүн тэднээс зуу дахин их хүмүүсийг алах найдлага байхгүй ч Жон тэднийг тэгнэ гэж бодсонгүй.

Түүнд мянга биш гани л хүн алах хэрэгтэй. Зөвхөн Манс энэ бүхнийг хамтад нь зангидаж

байгаа.

Ханын цаадах хаан чадах бүх зүйлээ хийсэн ч зэрлэгүүд найдлагагүй сахилга батгүй болохоор энэ нь байдлыг эмзэг болгож байлаа. Эндээс тэнд хүртэл олон бээрийн зайд могой шиг урт сунасан ямар ч Харуулаас догшин дайчидтай аяны цуваа явахад гурав дахь хэсэг бүр цувааны хоёр талд хуваагдаж Нохойн толгой Хармагын хошууч анги тэргүүлэн, аварга биетүүд, бух гөрөөс, гал шидэгчдийн хэрцгий арын хамгаалалт араас нь хааж байв. Ахин нэг гурав дахь хэсгийг Манс төвийн ойролцоо тэргүүлэн хөсөг тэрэг, чарга, нохойтой чарга, зуны сүүлчийн ургацнаас үлдсэн том бух хөллөсөн цэргийн хоол хүнсийг хамгаалж явлаа. Үлдсэн нь Харжигнуур хуягт, Жарл, Тормунд, Уйлагч зэрэг хүмүүсийн дор жижиг бүлэг болон хуваагдаж туршуул, түлээчин, тэрэгчид, ташуурчдын үүрэг гүйцэтгэн цувааны эхнээс адаг руу эцэс төгсгөлгүй давхиулан ердийн журам сахиулна.

Үүнээс гадна бас нэг зуун морьтой зэрлэгүүд байв. *Хөгшин баавгай тэдний дундуур будаа нэвтэлсэн сүх шиг хяргана.* Ийм явдал болвол Манс төвийн хүчтэйгээ нэхэж мохоон сүрдүүлэхийг оролдоно. Хэрвээ тэр тулалдаанд унавал Хана ахин зуун жилийн турш аюулгүй байх болно гэж Жон эрэгцүүлэв. Харин үгүй бол...

Жон илд барьдаг гарынхаа түлэгдсэн хурууг атгалаа. Урт сарвуу эмээлийнх нь ганзганд дүүжлээстэй бариулынх нь толгойд чулуун чонын толгой сийлбэрлэсэн зөөлөн ширэн бариултай эрлийз сэлэм дурын агшинд авахад хялбар газар байв.

Тэднийг хэдэн цагийн дараа Тормундын бүлэгт хүрэхэд цас хүндээр лавсан хаялав. Сүнс замдаа ганцаар салж ангийн үнэр хайн ой руу уусан алга болжээ. Зэрлэг чоно тэднийг шөнө хоноглоход буюу үүр цайхад эргэж ирнэ. Сүнс ямар ч хол явсан хамаагүй үргэлж буцаж ирдэгтэй Игрит адилхан санагддаг байв.

- Тэгэхээр чи одоо надад итгэв үү, Жон Сноу? Чи арслан заан унасан аварга биетүүдийг харав уу? гэж охин түүний барааг хармагц асуув.

- Хар! Хэрээ дурлачихсан! Тэр нэгтэй нь гэрлэхийг хүссэн! гэж Тормунд Жоныг хариулахаас өмнө хашгирлаа.

- Аварга биеттэй юу? гээд Урт жад Рик инээд алдлаа.

- Үгүй, арслан заантай! Хар! гэж Тормунд хэлэв.

Жон мориныхоо алхалтыг удаашруулахад Игрит зэрэгцэн ирэв. Тэр өөрийгөө гурван насаар эгч гэдэг ч хагас тохой намхан хамаагүй жижиг байв. Тэднийг Хашгираа даваанд Игритийг барих үеэр Чулуун могой түүнийг "жад эхнэр" гэж дуудаж байсан билээ. Тэр гэрлээгүй зэвсэг болгон сонгосон эвэр модон богино тахир нумтай ч ижилхэн жад эхнэр байв. Тэр Жонд бага дүү Арьяаг санагдуулах бөгөөд дүү нь арай залуухан туранхай байв. Игритийн багласан арьсан дотор хэр зэрэг биетэй болохыг хэлэх арга байсангүй.

- Чи "Сүүлчийн аварга биет" гэдэг дууг мэдэх үү? гээд Игрит хариу хүлээсэнгүй. - Чи минийхээс

илүү баргил хоолойтой болохоор дуулахад зохимжтой гээд,

- Өөө би сүүлчийн аварга биет миний ард түмэн газрын хөрснөөс арчигдан алга болсон гэж дуулахад Тормунд үгийг нь сонсож инээгээд,

- Намайг төрөхөд сүүлчийн уул шиг аварга биет ертөнцийг захирч байсан гэж цасан дундуур хангинуулав.

- Өө жирийн хүмүүс миний ой, гол мөрөн толгодыг маань хулгайлсан гээд Урт Жад Рик дуунд нэгдэн орлоо.

- Тэд хөндий талд минь аварга хана барьж гол горхины минь бүх загасыг барьсан гэж Игрит, Тормунд хоёр Жоны ард чанга хоолойгоор дуулав.

Тэгтэл дуунд Тормундын хөвгүүд Торегг, Дормунд хоёр баргил хоолойгоо нэмэрлэн, охин Мунда нь ч гэсэн оролцлоо. Бусад нь ширэн бамбайгаа жадаараа нүдэн дуулахад бүх аяны цуваа түрэн авлаа.

Чулуун өргөөг маань тэд дүрэлзсэн галаар шатааж

Чулуун танхимыг маань хурц жадаараа сийчин

Уулсын дунд би нулимснаас ондоо ханьгүй

Ганцаар тэнүүчилэхэд

Тэд миний араас өдөр нь нохойтой

Шөнө нь бамбарын гэрэлд агнаж

Аварга биетүүдийг ертөнцөд алхаж байх үед

Эдгээр хүмүүс хэзээ ч өндөр болохгүй жижигхэн билээ

Өөөө би дууныхаа үгийг сайн суралцсан

Сүүлчийн аварга биет билээ

Намайг унахад дуу үгүй болж

Нам гүм удтал өнө удаан үргэлжилнэ

Тэгтэл дуу дуусахад Игритийн хацар дээр нулимс мэлтэрлээ.

- Чи яагаад уйлж байгаа юм? Энэ чинь ердөө дуу шүү дээ. Тэнд зуугаад аварга биетүүд байна. Би сая харсан гэж Жон хэллээ.

- Зуугаад гэнэ шүү гэж тэр уурсан хэлээд, - Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Чи... гэснээ,

- ЖОН! гэж хашгирав.

Жон далавчны дэвэлт сонсогдоход эргэж харлаа. Нүдний өмнө саарал цэнхэр өд бүрхэж хурц хумс нүүрэнд нь шигдэн гэнэтийн хүчтэй өвдөлтөнд далавчны үзүүр толгой руу нь ууртай нүдлээ. Тэр хурц хошууг харсан ч гараа өргөн халхлах юм уу зэвсгээ авах завдал болсонгүй. Арагш болох гээд хөл нь дөрөөнөөс мултрахад морь нь цочсондоо ухасхийн унаж буйгаа мэдэрлээ. Тэгсэн ч бүргэд түүний нүүрийг тавихгүй хумсаараа урж, далавчаараа нүдэн хашгиран тоншлоо. Ертөнц дээрээс доош хөмрөхөд өд, морины бие, цус холилдон газар урдаас нь угтан ирэв.

Дараагийн агшинд мэдсэн зүйл гэвэл нүүрээрээ газар шаварт хэвтэн аманд цус амтагдаж Игрит дэргэд нь гартаа ясан хутга барин хамгаалан бөхийжээ. Далавчны дэвэлт сонсогдсон хэвээр ч бүргэд харагдсангүй. Ертөнцийн тал харлажээ.

- Миний нүд гэж гэнэт балмагдан хэлээд гараа нүүрэндээ хүргэв.

- Энэ ердөө цус, Жон Сноу. Тэр нүдийг чинь оносонгүй арьсыг чинь урсан байна.

Царай нь халуу шатан өвдөв. Тормунд дээр нь хашгиран зогсохыг Жон зүүн талын нүднээс цус урсаж байсан учир баруунаараа харлаа. Тэгтэл хатсан хуучин яс шархийн морин туурай, хашгиралт сонсогдов.

- Хүүдийтэй яс тамын хэрээгээ дуудаач! гэж Тормунд хашгирав.

- Энэ чиний тамын хэрээ байна! гээд Харжигнуур хуягт Жон руу заав.

- Итгэл даахгүй нохой шиг шаварт цусанд хутгалдаад хэвтэж байгааг нь! гэхэд бүргэд далавчаа дэвэн толгойны оройд дуулганы оронд өмссөн аварга биетийн хугарсан гавал дээр суув.

- Би энд түүний хойноос ирсэн.

- Тэгвэл авч яваач. Гэхдээ илдтэй гараараа дээр шүү эсвэл бөгөөс чи минийхийг ч гэсэн олох болно. Би чиний ясыг буцалгаж гавлыг чинь шээлтүүр болгон ашиглана. Хар! гэж Тормунд зандрав.

- Харин би чиний гэдсийг хүү татаж агаарт цацахад энэ охиноос жижигхэн болно. Хойшоо бол үгүй бол Манс энэ тухай дуулах болно шүү.

- Манс түүнтэй уулзахыг хүсээ юу? гээд Игрит бослоо.

- Би үгүй гэж хэлээ юү? Алив түүнийг хар хөл дээрээ босгоодох гэхэд Тормунд Жон руу хөмсөг зангидлаа.

- Явсан чинь дээр. Манс чамтай уулзахыг хүсч байна.

Игрит Жоныг өндийхөд туслав.

- Тэр нядлуулсан гахай шиг цус алдаж байна. Орелл царайг нь яасныг хараач.

Шувуу үзэн ядаж чадна гэж үү? Жон Орелл гэдэг зэрлэгийг алсан ч түүний нэг хэсэг бүргэдэд үлдсэн билээ. Шувууны алтан нүд түүн рүү хорсолтой харав.

- Би явна гээд Жон цус нүднээс нь доош урсахад хацар нь халуу оргин өвдсөнд хар бээлийгээрээ хүртэл улаан болов.

- Надад морийг минь бариад өгөөч гээд түүнд морь бус Сүнс илүү хэрэгтэй байсан ч зэрлэг чоно хаана ч харагдсангүй. *Тэр одоо эндээс олон бээрийн зайд хандгайны хоолой тас хазаж байгаа биз.* Магадгүй тэр нь ч дээр байж болох юм.

Жоныг дөхөхөд морь царайных нь цусыг хараад үргэсэн ч зөөлөн дуугаар аргадан эцэст нь жолоонд нь хүрэв. Тэр эмээл дээрээ буцаж суухад толгой нь эргэлээ. *Би үүнийг янзлах ёстой ч одоо биш. Ханын цаадах хаан бүргэд нь надад юу хийснийг хараг.* Тэр баруун гараа атгаж тэнийлгэн Урт сарвууг авч нуруундаа үүрээд хүмүүсийнхээ хамт хүлээж байгаа Ясны лорд руу давхилаа.

Игрит бас морины нуруун дээр ширүүн царайтай хүлээж байв.

- Би бас явна.

- Арилж үз. Намайг хэрээг авчир гэж явуулсан болохоос бус өөр хүн биш гээд Харжигнуур хуягтын цээжний яс харжигнав.

- Чөлөөт эмэгтэй хүссэн зүгтээ явж болно гэж Игрит хэллээ.

Салхи Жоны нүд рүү цас үлээхэд царай руу нь урссан цус хөлдөхийг мэдрэв.

- Бид яриад байх уу эсвэл явах юм уу?

- Явна гэж Ясны лорд хэллээ.

Энэ нь дүнсгэр цогиулалт болов. Тэд хуйлран шуурах цасанд цуваа уруудан хоёр мил яваад Сүүн усыг ус цацлуулан гаталж байгаа орооцолдсон ачаатай тэрэгнүүд дундуур гарч дорно зүг рүү томоор гогцоорон тойрч явлаа. Голын нимгэн мөс бүрхсэн гүехэн хэсэгт морьдын туурайд тачигнана. Зүүн эрэг дээр цас улам лавсан орж хунгар гүнзгийрэх шиг санагдав. Салхи нь ч гэсэн хүйтэн юм. Дээрээс нь шөнө болж байлаа.

Малгайлан орох цасан дунд модны орой дээгүүр том цагаан толгод дүнхийн харагдана. *Анхны хүмүүсийн Нударга.* Жон толгой дээр бүргэд хашгирахыг сонслоо. Морьтонгуудыг өнгөрөхөд нарсан дээр суусан хэрээ гуаглав. *Хөгшин баавгай дайралтаа хийсэн юм болов уу?* Гэвч илдийн дуу хангинан сум исгэрэн нисэхийн оронд Жон ердөө морины туурайд хөлдүү цас зөөлөн хяхрах сонсогдов.

Тэд нам гүмд толгодын өмнө талын налууг тойрон арай нам газар гарч ирэв. Жон толгодын ёроолд цасанд хагас булаатай үхсэн морь тэрийн хэвтэж байхыг харлаа. Морины гэдэс дотор хэвлийнээс нь хөлдүү могой шиг цувж өрөөсөн хөл нь байхгүй болжээ. *Чононууд* гэж Жон анх бодсон ч буруу болохыг ойлгов. Чононууд агнасан олзоо иддэг билээ.

Налууны дагуу улам ч олон морь үхэж хөлөө эв хавгүй нугалан сохор нүдэнд нь үхлийн айдас тодорчээ. Зэрлэгүүд тэдэн дээр ялаа шиг шавж эмээл, хазаар, ачаа, хуягийг нь мулталж махыг нь чулуун сүхээр цавчин авч байлаа.

- Дээшээ. Манс орой дээр байгаа гэж Харжигнуур хуягт тушаав.

Тэд дугуй хэрмийн гадна мориноос бууж ханын ангархайн завсар орлоо. Хөгшин баавгайн гарц болгон дээр зоолгосон хурц гадсанд сэгсгэр хүрэн морь зоогдон үхжээ. *Тэр гарахыг оролдсоноос биш орох гээгүй байна.* Энд морьтоных нь бараа харагдсангүй.

Дотор улам дор байлаа. Жон урьд нь хэзээ ч ягаан цас харж байсангүй. Эргэн тойрон салхи хүчтэй шуурч хонины арьсан хүнд нөмрөгийг нь дэрвүүлнэ. Хэрээнүүд үхсэн мориноос нисэн нөгөөд сууж байлаа. Энэ зэрлэг хэрээ юм болов уу эсвэл манайх уу? гэдгийг Жон мэдсэнгүй. Тэр хөөрхий Сэм хаана байгааг гайхширлаа. Бас ямар болсныг нь.

Хөлийн дор хөлдүү цустай цас чахрана. Зэрлэгүүд үхсэн морины бүх төмөр тоног ширний өөдөс бүрийг мултлан тахыг нь хүртэл мулзалж байлаа. Хэсэг хүмүүс ачаа онгичин идэх юм, зэр зэвсэг эрнэ. Жон цустай шалбаагт хэвтэж буй Чэттийн нохдын нэгний дэргэдүүр өнгөрөв.

Буудлын цаад захад босоогоороо үлдсэн хэдэн майхны нэгд Манс Райдер зогсож байв. Тэр хар гархин хуяг, үстэй өмдөн дээр улаан торгон судалтай хар ноосон нөмрөг нөмөрч толгойдоо хоёр талдаа хэрээний далавчтай том хүрэл дуулга өмсчээ. Түүний дэргэд Жарл, Нохойн толгой Харма, Стир, Зургаан арьст Варамир болон чононууд нь сүүдэрт мууртайгаа цуг байлаа.

Манс Жон рүү хүйтнээр баргар харав.

- Чиний царай яасан юм?

- Орелл түүний нүдийг сугалахыг оролдсон гэж Игрит хэлэв.

- Би чамаас биш түүнээс асууж байна. Тэр хэлээ алдчихаа юу? Магадгүй бидэнд худал хэлж байснаас тэгсэн нь дээр биз гэхэд Магнар Стир урт хутгаа сугалав.

- Хүү хоёрын оронд нэг нүдтэй байвал илүү тод харах биз.

- Чи нүдтэйгээ үлдэхийг хүсч байна уу, Жон? Тэгвэл надад тэдний хэдүүл байсныг хэл. Харин энэ удаад үнэнийг хэлэхийг хичээгээрэй дээ, Винтерфеллийн бутач минь гэж Ханын цаадах хаан хэллээ.

- Эрхэм лорд... юу бол... гээд Жоны хоолой хатав.

- Би лорд чинь биш. Тэгээд ч юу гэдэг нь тодорхой байгаа биз дээ. Чиний ах дүүс үхсэн. Асуудлын гол нь тэдний хэд гэдэгт байна?

Цас Жоны царай руу хаялахад шархиран өвдөж бодохтой манатай байлаа. *Чи тэдний хэлсэн ямар ч зүйлийг тээнэгэлзэлгүй хийх ёстой* гэж Корин түүнд хэлжээ. Хоолойд нь үг тээглэхэд Жон хүчлэн,

- Бид гурван зуугуулаа байсан гэв.

- Бид гэнэ ээ? гэж Манс ширүүн дуугарлаа.

- Тэд. Тэд гурван зуугуул байсан. *Ямар ч зүйлийг гэж Корин хэлсэн. Гэхдээ надад яагаад ийм хулчгар санагдаад байгаа юм бол?* Хар цамгаас хоёр зуу, Сүүдэрт цамхагаас зуун хүн ирсэн.

- Наадах чинь чиний миний майханд дуулснаас хамаагүй үнэн дуу байна гээд Манс Нохойн толгой Харма руу харлаа. - Бид хичнээн морь олсон бэ?

- Зуугаас илүү хоёр зуугаас багагүй. Дорно зүгт цасан дор өшөө олон морь үхсэн болохоор хэд гэдгийг нь мэдэхгүй байна гээд тэр далбаа болгон модонд өлгөсөн шинэхэн цустай нохойн толгойнхоо ард зогслоо.

- Жон Сноу чи надад худал хэлэх ёсгүй байсан юм гэж Манс хэллээ.

- Тиймээ... би үүнийг мэдэж байсан. *Тэр өөр юу хэлэх байсан гэж?*

Зэрлэгүүдийн хаан царайг нь шинжив.

- Энд хэн захирч байсан бэ? Надад үнэнийг хэл. Риккер үү? Смолвүүд үү? Витерс лав биш шүү. Тэр хэтэрхий сул дорой. Энэ хэний майхан юм?

Би хэдийн дэндүү их зүйл хэлсэн.

- Та нар биеийг нь олоогүй юм уу? гэхэд,

- Энэ хар хэрээнүүд ямар тэнэг юм бэ гээд Харма зэвүүцсэндээ хамрын нүхээрээ уур савсуулан тургилав.

- Дараагийн удаа чи надад асуулт тавьж зүрхлэх юм бол Ясны лордод өгнө шүү гэж Манс Райдер амлаад алхам ойртов.

- Энд хэн ахалж байсан бэ?

Ганихан алхам. Ахин нэг ойртовол гэж Жон бодов. Тэр урт Сарвууны бариул руу гараа ойртуулав. *Хэрвээ би чимээгүй байвал...*

- Хэрвээ чи эрлийз илдэндээ хүрэх юм бол бутач толгойг чинь сугалахаас нь өмнө тас цавчина

шүү. Би чамд тэвчээр алдаж байна, хэрээ минь гэж Манс анхааруулав.

- Хэлчих. Тэр хэн ч байсан үхсэн болохоор ямар ялгаа байна гэж Игрит ятгав.

Жон хатсан цус болсон хацар дээрээ хөмсөг зангидав. *Энэ дэндүү хүнд юм байна. Би яаж урвалгүйгээр зүсээ буруулагч болж тоглох юм бэ?* гэж цөхрөн бодов. Корин түүнд энэ тухай юу ч хэлээгүй. Гэсэн ч хоёр дахь алхам эхнийхээсээ үргэлж хялбар байдаг билээ.

- Хөгшин баавгай.

- Тэр өвгөн үү? Тэр өөрийн биеэр ирээ юу? Тэгвэл Хар цамхагыг хэн захирч байгаа юм? гэж Харма үл итгэн асуулаа.

- Боуэн Марш гэж Жон энэ удаад түгдрэлгүй хариулав. *Чи тэдний хэлсэн ямар ч зүйлийг эргэлзэлгүй хийх ёстой.*

- Хэрвээ тийм бол бид дайнд ялсан гэсэн үг. Боуэн тоолж мэдэхээс яаж ашиглахыг нь мэдэхгүй хүн гээд Манс инээд алдав.

- Хөгшин баавгай захирч байсан. Энэ газар өндөр хүчтэй болохоор тэр улам бэхэлсэн. Тэр шуудуу ухуулж гадас зоолгон, ус хүнсний нөөц бэлтгэсэн. Тэр бэлтгэж... гэж Жон хэлэхэд,

- Намайг ирэхэд үү... гэж Манс Райдер гэж яриаг нь дуусгав.

- Тэгэлгүй яахав. Хэрвээ би энэ толгод руу дайрахаар хангалттай тэнэг бол алсан хэрээ болгоныхоо төлөө таван хүнээ алдсанаа өөрийгөө азтайд тооцох байлаа гээд ам нь чангарч.

- Гэхдээ үхэгсэд явж байх үед хэрэм, гадас, илд юу ч биш. Чи үхэгсэдтэй байлдаж чадахгүй, Жон Сноу. Үүнийг надаас илүү ямар ч хүн мэдэхгүй гээд харанхуйлж буй тэнгэр лүү ширтлээ.

- Хэрээнүүд бидэнд өөрсдийнхөө мэдсэнээс ч тусалж болох юм. Би яагаад дайралтанд өртөхгүй байгаагаа гайхсан юмаа. Гэхдээ тийшээ хүртэл зуун бээрийн хол хэвээр хүйтэн байна. Варамир чононуудаа үхэгсдийн араас явуулж шиншлүүл. Би гэнэтийн дайралтанд өртмөөргүй байна. Ясны лорд харуулын тоог хоёр дахин нэмж хүн бүрт бамбар, цахиур өгөх талаар санаа тавиарай. Стир, Жарл хоёр үүр гэгээрмэгц морд гэв.

- Манс би хэрээний ясыг авмаар байна гэж Харжигнуур хуягт хэлэв.

- Чи ах дүүсээ хамгаалахын тулд худал хэлсэн хүнийг алж болохгүй гээд Игрит Жоны урд зогслоо.

- Тэд түүний ах дүүс хэвээр гэж Стир хэлэв.

- Тийм биш. Тэр тэдний хэлсэн шиг намайг алаагүй. Бас Кориныг алахыг бид харсан гэж Игрит зөрүүдлэв.

Жоны амьсгал цан татуулав. *Хэрвээ би түүнд худал хэлсэн бол мэдэх байсан.* Тэр Манс Райдерийн нүд рүү харж түлэгдсэн гараа атгаж тэнийлгэлээ.

- Би таны надад өгсөн нөмрөгийг зүүж байгаа, эрхэм дээдсээ.

- Хонины нэхий нөмрөг! Бид түүний доор маш олон шөнийг бүжиглэж өнгөрүүлсэн! гэж Игрит дэмжив.

Жарл инээд алдахад Нохойн толгой Харма хүртэл мушийлаа.

- Энэ чиний зам уу, Жон Сноу? Тэр болон чи? гэж Манс Райдер зөөлөн асуув.

Хананаас цааш замаа алдахад хялбархан байв. Жон аль нь нэр хүнд ичгүүр буруу зөв болохыг мэдсэнгүй. *Эцэг минь намайг өршөө.*

- Тиймээ гэхэд,

- Сайн байна. Чи Жарл, Стер хоёртой маргааш яв. Тэр ч гэсэн явна. Надаас хол байх тусам хоёр зүрх ганц шиг цохилно гээд Манс толгой дохив.

- Хаашаа явах юм? гэж Жон асуулаа.

- Хананаас цааш. Чиний үнэнч гэдгээ үгээр бус үйл хэргээр батлах цаг болжээ, Жон Сноу гэхэд,

- Би энэ хэрээгээр юу хийх юм? гэж Магнар дургүйцэв.

- Тэр Харуулыг Хана шиг сайн мэднэ. Дээрээс нь Хар цамхагыг ямар ч морьтонгоос дутуугүй мэднэ. Чи түүнийг ашиглахгүй бол тэнэг болно.

- Түүний зүрх хар хэвээр бол яах юм? гээд Стер муухай харлаа.

- Тэгвэл огтол гээд Манс Харжигнуур хуягт руу эргэв.

- Ясны лорд минь цувааг хамаг хүчээр явуул. Хэрвээ Мормонтоос өмнө Хананд хүрвэл ялалт биднийх гэсэн үг.

- Тэд явах болно гэж Харжигнуур хуягт ууртай хэллээ.

Манс толгой дохиод Харма, Зургаан арьст хоёрын хамт явахад Варамирийн чононууд болон сүүдэрт муур араас нь дагалаа. Жон, Игрит хоёр Жарл, Харжигнуур хуягт, Магнартай хоцров. Нөгөө хоёр зэрлэг Жон руу сэрдсэн харцаа нуулгүй харахад Жарл,

- Та нар сонссон. Бид үүр цайхад хөдөлнө. Ан хийх цаг байхгүй тул чадах чинээгээрээ хоол авч ирээрэй. Бас наад царай зүсээ янзал, хэрээ минь. Чи бүр цусанд хутгалдчихаж гэв.

- Тэгнэ гэж Жон хэллээ.

- Харин чи худал хэлэхгүй байсан бол дээр шүү, охин минь гэж Харжигнуур хуягт Игритийг аварга биетийн гавлын цаанаас харж заналхийлэхэд,
- Биднээс холд үгүй бол Корины авсан зүйлийг хүртэнэ шүү гээд Жон Урт сарвууг сугалав.
- Чамд чоно чинь туслахгүй, хүү минь гээд Харжигнуур хуягт сэлэмдээ хүрлээ.
- Чи итгэлтэй байна уу? гээд Игрит инээд алдав.

Дугуй хэрмийн оройд Сүнс цагаан зогдроо сэргийлгэн бөхийжээ. Тэр чимээ гаргаагүй ч бараан улаан нүд нь цусан улаан байв. Ясны лорд гараа илднээсээ удаанаар холдуулан алхам ухарч хараал тавин одлоо.

Жоныг Игриттэй Нударга уруудахад Сүнс морьдынх нь хажууд шогшуулав. Тэднийг Сүүн ус хүрэх замын хагаст орсон хойно Жон аюулгүй болмогц,

- Би чамаас миний төлөө худал хэлэхийг гуйгаагүй гэв.
- Би тэгээгүй. Зүгээр л ярьсан юм.
- Чи хэлэхдээ...

- ...бид нөмрөгөн дор чинь олон шөнийг өнгөрүүлсэн гэж үү. Би хэзээ эхэлснийг нь хэлээгүй санагдаж байна гээд түүн рүү ичингүйрэн инээмсэглэж,

- Өнөө шөнө Сүнсэд унтах өөр газар олоорой, Жон Сноу. Мансын хэлсэн шиг үгээ үйл хэргээр батлах цаг болж гэв.

САНСА

- Шинэ даашинз гэнэ ээ? хэмээн Санса мэл гайхсандаа болгоомжтой хэлэв.
- Чиний өмсөж байсан ямар ч даашинзнаас хамаагүй үзэсгэлэнтэй, хатагтай гэж хөгшин хатагтай амлаад Сансагын ташааны хэмжээг зангилаатай урт утсаар авлаа.
- Атлаасан дотортой Миришийн торон эмжээртэй торгон даашинз. Чи маш үзэсгэлэнтэй харагдана. Хатан үүнийг өөрийн биеэр тушаасан юм.
- Ямар хатан? гээд Маржэйри Жоффын хатан болоогүй ч Рэнлигийнх байсан билээ. Эсвэл тэр Өргөст хатны тухай ярьсан юм болов уу? Эсвэл...
- Эрх баригч хатан.
- Хатан Серсей юу?
- Өөр ямар хатан байна гэж. Тэр надад олон жилийн турш хувцас оёх хүндэтгэл оноож байгаа гээд хөгшин эмэгтэй утсаараа Сансагын хөлийн дотрыг хэмжив.
- Эрхэм дээдэс чамайг одоо эмэгтэй хүн болсон гэж хэлсэн болохоор жаахан охин шиг хувцаслах ёсгүй гэсэн. Гараа дэлгэ дээ.

Санса гараа өргөлөө. Түүнд шинэ даашинз хэрэгтэй нь үнэн байв. Өнгөрсөн жилийн даашинз нь гурван инчээр багадаж хуучин хувцасны шүүгээн дэх хувцас нь цэцэглэдэг өдрөө орны гудсаа шатаахыг оролдоход утаанд сүйдсэн билээ.

- Чиний цээж хатных шиг сайхан болох нь. Чи үүнийгээ нуух ёсгүй шүү гэж хөгшин эмэгтэй утсаараа Сансагын цээжийг ороох зуураа хэллээ.

Энэ үг түүнийг улайлгав. Түүнийг сүүлд мориор явах үед замын турш үдээстэй хантаазтай байж чадаагүй болохоор агтчин хөвгүүд мордоход нь туслах зуураа гөлрөн ширтэж байлаа. Ууж нь амьсгалахын аргагүй дэндүү бариу тул заримдаа нас бие гүйцсэн эрэгтэйчүүд ч гэсэн цээж рүү нь ширтэнэ.

- Ямар өнгөтэй болох юм бэ? гэж үйлчингээс асуулаа.
- Өнгийг нь надад орхи, хатагтай. Чи мэдэх үедээ баярлах болно. Би баярлана гэдгийг чинь мэдэж байна. Чамд бас дотуур хувцас, оймс, банзал, цув нөмрөг гээд язгууртан гаралтай залуу хатагтайн хэрэгцээнд байвал зохих бүх зүйлийг оёж өгнө.
- Хувцас хааны хурим гэхэд бэлэн болох болов уу?
- Өө, удахгүй дээ. Тун удахгүй гэж эрхэм дээдэс шаардаж байгаа. Надад зургаан үйлчин арван хоёр дагалдан сурагч охид байгаа болохоор бусад бүх захиалгаа хойш тавина. Сүүлийн үед маш олон хатагтай бидэн рүү ирж байгаа ч энэ бол хатны тушаал шүү дээ.

- Эрхэм дээдсийн сайхан сэтгэлд талархая. Тэр надад дэндүү сайн юм гэж Санса эелдэгээр хэлэв.

- Эрхэм дээдэс туйлын өгөөмөр гэж оёдолчин зөвшөөрөөд юм хумаа цуглуулан гарахаар явлаа.

Гэхдээ яагаад? Би энэ даашинз Маржэйри юм уу эмэг эхийнх нь хийсэн ажил гэж мөрийцөхөд бэлэн байна? гэж Санса ганцаар үлдмэгц бодоход дотор нь эвгүйцлээ.

Маржэйригийн сайхан сэтгэл хязгааргүй болохоор түүний оролцоо юм бүхнийг өөрчилж байлаа. Түүний хатагтай нар нь ч гэсэн Сансатай сайхан харилцаж байв. Тэр бусад эмэгтэйчүүдтэй хөгжилдөлгүй дэндүү удсан болохоор хичнээн таатай болохыг мартаж шахжээ. Хатагтай Леонетт түүнд өндөр ятгаар тоглох хичээл заан, хатагтай Жанна ойр зуурын хов жив хуваалцана. Мерри Крейн үргэлж хөгжилтэй түүх ярьж, бяцхан хатагтай Булвер дүүг нь санагдуулдаг ч Арьяа шиг ширүүн биш байлаа.

Сансатай ойролцоо насны үеэлүүд болох Элиноор, Алла, Мегга нар Тайреллийн овгийн доод мөчрөөс гаралтай байв.

- Сарнай доод бутнаас ургадаг гэж ухаалаг гоолиг биетэй Элиноор хошигноно.

Мегга дугуй чанга дуутай, Алла ичимхий хөөрхөн, Элиноор эмэгтэй хүний гурван эрхийг эзэмшин нас бие гүйцсэн байхад Мегга, Алла хоёр охид байлаа.

Үеэлүүд Сансаг амьдралынхаа туршид таньдаг мэт өөрсдийнхөө хүрээлэлдээ авчээ. Тэд үдээс хойшийн уртыг зүү утас нэхэх зуураа нимбэгний бялуу, балтай дарс уун ярилцан өнгөрүүлж, үдэш нь хавтан өрөн тоглон, шилтгээний сүмд хамтдаа дуулах юм уу голцуу нэг хоёроороо Маржэйригийн орыг хуваалцахаар сонгогдож шөнөжингөө шивнэлддэг байлаа. Алла сайхан хоолойтой болохоор модон ятга тоглон хүлэг баатар, алдагдсан хайр сэтгэлийн тухай дуулна. Мегга дуулж чадахгүй ч үнсэлтэнд галзуу байв. Алла тэр хоёр заримдаа үнсэлддэг тоглоом тоглон хаанаас гадна үнсээгүй хүн нэг ч үлдээгүй гэж хэлжээ. Санса Мегга Хоточийг үнссэн болов уу гэж гайхлаа. Тэр Санса руу тулааны шөнө дарс, цус ханхлуулан ирсэн билээ. *Тэр намайг алахаар сүрдүүлэн үнсэж өөртөө дуу дуулуулсан.*

- Жоффри хаан ямар сайхан уруултай гээч. Хөөрхий Санса чи түүнийг алдсандаа зүрх чинь эмтэрсэн байх даа. Хичнээн их уйлсан бол! хэмээн Мегга дэврүүн сэтгэлээр хэлэв.

Жоффри намайг чиний мэдэхээс ч олон удаа уйлуулсан гэж Санса хэлэх гэсэн ч энэ удаад Баттербамп хоолойг нь дуугаараа дарахгүй болохоор амаа хамхилаа.

Элиноорын хувьд лорд Амброузын хүү залуу хиатай суухаар амласан болохоор удахгүй давируулаа хожсоных нь дараа гэрлэх байлаа. Тэр Элиноорын дурыг Хар усны тулалдаанд Миришийн нум сумчин, Маллендорын хүнд морьтон цэргийг алснаараа олжээ.

- Алин түүнийг хайр аймшиггүй болгосон гэсэн. Тэр түүний нэрийг тулалдаанд хашгирсан болохоор маш зоригтой байгаа биз дээ? Би нэг л өдөр миний дурыг хүлээх зуун хүн алсан аваргатай болно доо гэж Мегга хэлэхэд Элиноор түүнд чимээгүй бай гэж хэлсэн ч царай нь

баярласан байлаа.

Тэд бол хүүхдүүд. Тэд бол тэнэг бяцхан охид. Элинор хүртэл адилхан. Тэд хэзээ ч тулалдаанд хүн үхэхийг харж байгаагүй болохоор юу ч мэдэхгүй байна гэж Санса бодлоо. Тэдний мөрөөдөл Жоффри эцгийг нь цаазлахаас өмнө толгойд нь байсан шиг дуу хуур, үлгэр домгоор дүүрэн байсанд Санса өрөвдөж атаархлаа.

Маржэйригийн хувьд өөр хэрэг байв. Уяхан хонгор ааштай хахир эмээгээсээ дуурайсан зүйл бага ажээ. Өмнөх өдөр тэр Сансаг харцагачилахад авч явжээ. Энэ нь Сансагын тулалдааны дараа хотын гадна анх гарсан үе байв. Үхсэн хүмүүсийг шатаан оршуулсан ч Шавар хаалга лорд Станнисийн мөргүүр цохьсон газар хугарч ором гаран, хэмхэрсэн онгоцны их биеүүд Хар усны хоёр талд овоорон хуйхлагдсан шураг нь гүехэн уснаас аварга том хэрзгэр хар хуруу шиг ёрдойно. Усанд явж байгаа онгоц гэвэл зөвхөн хавтгай ёроолтой худалдааны онгоц байсан бөгөөд тэднийг зөөж үнс нурам болсон модтой Хааны ойд хүргэв. Гэсэн ч усны шувуу тохойн дагуу намагт язганаж Сансагын шонхор гурван нугас авчирч өгөхөд, Маржэйригийн шувуу нисч байгаа дэглий агналаа.

- Вилласт долоон ханлигийн хамгийн сайн шувуу байгаа. Тэр заримдаа бүргэдээр агнадаг юм. Чи үүнийг харах болно, Санса гэж Маржэйри тэднийг түр зуур ганцаар салахад хэлээд,

- Дүү минь гэж гарыг нь атгалаа.

Дүү. Санса урьд нь Маржэйри шиг үзэсгэлэнтэй эелдэг ертөнцийг уян налархайгаараа эзэмдсэн эгчтэй болохыг мөрөөддөг байжээ. Арьяа үүнд барагтай байв. Гэхдээ би яаж эгчийгээ Жоффритэй гэрлүүлж болох билээ? гэж бодтол гэнэтхэн нүдэнд нь нулимс дүүрэв.

- Маржэйри гуйж байна чи ингэх ёсгүй. Чи түүнтэй гэрлэх ёсгүй. Тэр харагдаж байгаа шигээ хүн биш. Тэр чамайг өвтгөнө гээд үг амнаас нь гарахад бэрх байлаа. Маржэйри итгэлтэй инээмсэглэн,

- Би тэгж бодохгүй байна. Чиний надад анхааруулдаг их зоригтой хэрэг ч айсны хэрэггүй. Жофф бардам авиртай ч чиний хэлсэн шиг хэрцгий гэдэгт би эргэлзэхгүй байна. Гэвч аав түүнийг Лорасыг хааны хамгаалалтанд авахыг тулгасан. Ханхүү Эймон Нэйрисийг хамгаалж байсан шиг намайг долоон ханлигийн хамгийн сайн хүлэг баатар өдөр шөнөгүй хамгаална. Тэгэхээр манай бяцхан арслан биеэ зөв авч явсан нь дээр биз дээ? гээд инээд алдан,

- Дүү минь гол руу буцацгаая. Манай харуулууд уурлаж байгаа байх гээд хариу хүлээлгүй өсгийгөөрөө морио гуядан давхилаа.

Тэр их зоригтой юм гэж Санса бодоод араас нь цогиулсан ч эргэлзээнд автсан хэвээр байв. Лорас агуу хүлэг баатар гэдгийг бүгд мэднэ. Гэсэн ч Жоффрид өөр бусад хааны хамгаалалтын хүлэг баатар, алтан нөмрөгтөнгүүд болон улаан нөмрөгтэй цэргүүдийн зэрэгцээ өөрийн гэсэн арми бий. Хүндгүй Эйгон дүү Луун хүлэг баатраас айсандаа хатан Нэйрист хэзээ ч гэм учруулаагүй байж болох ч өөр нэг хүлэг баатар нь эзэгтэйдээ дурлах үед хаан хоёулангийнх нь толгойг авсан билээ.

Сэр Лорас бол Тайрелл. Тэр хүлэг баатар бол зөвхөн Тойнийх байсан. Түүний ах дүүст арми болон илдээр өшөө авах арга байхгүй байсан гэж Санса өөртөө санууллаа. Гэсэн ч энэ тухай

бодлгоширох тусам улам их гайхлаа. *Жофф магадгүй жил юм уу түүнээс их хугацаанд биеэ барьж болох ч төдөлгүй эсвэл хожим сарвуугаа гаргана. Харин түүнийг ингэх үед...* Долоон ханлигт хоёр дахь хааны алуурч бий болон хотын дотор дайн дэгдэж арслангийн талынхан сарнайтай үзэлцэн улаан цус урсгана.

Санса Маржэйри үүнийг олж харсан эсэхийг эрэгцүүллээ. *Тэр надаас эгч болохоор ухаалаг байх ёстой. Бас түүний аав Лорд Тайрелл ч гэсэн хийж байгаа зүйлээ мэдэж байгаа гэдэгт итгэлтэй байна. Зөвхөн би л тэнэг байж таарна.*

Санса сэр Донтост Хайгарден руу явж Виллас Тайреллтай гэрлэх гэж байгаа тухайгаа ярих үед түүнийг санаа амран баярлана гэж боджээ. Гэвч оронд нь тэр гарыг нь атган,

- Чи ингэж болохгүй! гэж айдас дүүрэн согтуу хоолойгоор дуу алдав.

- Би чамд Тайреллийнхан Ланнистерийнхны хувьд зөвхөн цэцэг гэдгийг хэлэх байна. Би чамаас гуйж байна. Энэ тэнэглэлээ мартаад бидний төлөвлөсөн ёсоор чамайг авч явахыг амласан Флорианаа үнс. Жоффригийн хуримын шөнө удахгүй болох болохоор чи миний хэлсэн шиг үсний мөнгөн тороо зүүж дараа нь бид зугтана гээд хацар дээр нь үнсэхийг оролдоход Санса гараас нь мултраад алхам ухарлаа.

- Би тэгэхгүй. Би чадахгүй. Зарим зүйл буруу байна. Намайг зугтахыг хүсэх үед чи авч яваагүй болохоор одоо хэрэггүй болсон.

- Гэхдээ зохион байгуулалт бэлэн болсон шүү дээ. Чамайг гэр лүү чинь авч явах хөлөг онгоц, онгоц руу зөөх завь гээд Флориан чинь Жонкүйлийн төлөө бүх зүйлийг хийсэн гээд Донтос түүн рүү дүйнгэтэн ширтэв.

- Энэ бүхнийг хийлгэн таньд төвөг удсанд уучлаарай гэхдээ одоо надад завь, онгоц хэрэггүй болсон.

- Энэ бүхэн чамайг аюулгүй болгоно.

- Би Хайгарденд аюулгүй байна. Виллиас намайг аюулгүй байлгана.

- Тэр чамайг мэдэхгүй тэгээд ч хайртай биш. Жонкүйл минь, Жонкүйл минь нүдээ нээгээч. Эдгээр Тайреллийнхан чамд санаа тавьж байгаа нь юу ч биш. Энэ чиний эрхийн төлөө тэд гэрлэх гэж байгаа юм.

- Миний эрх гэнэ ээ? гээд агшин зуур балмагдлаа.

- Хонгор минь чи Винтерфеллийн залгамжлагч шүү дээ гээд Донтос түүнээс ахин зууран ийм зүйл хийхгүй байхыг гуйхад Санса мултран зугатаж зүрх модны дор ганхсан хэвээр орхив. Түүнээс хойш бурхдын мод руу очсонгүй.

Гэсэн ч Санса түүний үгийг мартсангүй. *Винтерфеллийн залгамжлагч. Энэ чиний эрхийн төлөө тэд гэрлэх гэж байгаа юм* гэж шөнө сэрүүн хэвтэхдээ бодлоо. Санса хоёр эрэгтэй дүү, нэг ахтай

өсчээ. Тэр хэзээ ч удам залгамжлах эрхийн тухай бодож байгаагүй ч Бран, Рикон хоёр үхсэн болохоор... Энэ хамаагүй. Тэнд Робб байгаа. Тэр одоо нас бие гүйцсэн болохоор удахгүй гэрлэж хүүтэй болно. Тэгсэн ч гэсэн Виллас Тайрелл Хайгарденд байх болохоор Винтерфеллийг хүсэх ямар хэрэгтэй гэж?

Заримдаа Санса түүний нэрийг дэрэнд шивнэн чимээг нь сонсдог байлаа.

- Виллас, Виллас, Виллас гээд Виллас бол Лорас шиг сайхан нэр байлаа. Тэр ч байтугай жаахан ч атугай ижилхэн сонсогдож байв. Түүний хөл хэнд хамаатай юм? Виллас Хайгардены лорд болохоор тэр хатагтай нь болно.

Санса тэд хоёул цэцэрлэгт өвдгөн дээрээ гөлөг тавин суух юм уу дуучны пийпаа цохиж дуулахыг чагнан Мандерийн уруу зугаалгын онгоцоор хөвж байна гэж төсөөлдөг байв. *Хэрвээ би түүнд хүү төрүүлж өгвөл тэр надад хайртай болно.* Тэр хөвгүүддээ Эддарт, Брандон, Рикон гэдэг нэр өгч бүгдийг нь сэр Лорас шиг эр зоригтой өсгөнө. *Дээрээс нь Ланнистерийнхныг үзэн яддаг болгож хүмүүжүүлнэ.* Сансагын мөрөөдөлд хүүхдүүд нь алдсан дүү нартай нь адилхан харагддаг байв. Заримдаа Аръяатай адилхан охин хүртэл харагдана.

Гэсэн ч тэр Вилласийн тухай зураглалыг толгойдоо удаан барьж чадахгүй төсөөлөл нь ямагт залуу, жавхаалаг үзэсгэлэнтэй сэр Лорас руу буцна. *Чи түүний тухай ингэж бодох ёсгүй. Үгүй бол Виллас чамтай уулзах үедээ нүдэнд чинь тодрох урам хугарлыг хараад ахдаа хайртайг мэдэх юм бол чамтай хэрхэн гэрлэх билээ?* Виллас Тайрелл түүнээс хоёр насаар ах, доголлон тэр ч байтугай булцгар тарган, эцэг шигээ улаан нүүртэй байж магадгүй гэж Санса өөртөө тогтмол сануулж байлаа. Гэсэн ч хөөрхөн ч бай үгүй ч бай түүний цорын ганц аварга болно.

Нэг удаа тэр Жоффри Маржэйритэй биш түүнтэй урьдын адил гэрлэх хэвээр тэдний хуримын шөнө толгой цаазаар авагч зандалчин Илин Пэйн болж хувирч байна гэж зүүдэлжээ. Тэр Маржэйриг зовоохыг хүсээгүй ч Тайреллийнхан гэрлэлтээс татгалзаж магадгүй гэж бодлоо. *Би Маржэйрид анхааруулж түүний тухай үнэнийг хэлнэ.* Эсвэл Маржэйри түүнд итгэхгүй ч байж магадгүй. Жофф урьд нь Сансатай байхдаа үргэлж төгс хүлэг баатрын дүрд тоглодог байсан. *Тэр удахгүй түүний үнэн төрхийг олж харна.* Гэхдээ хуримын дараа болохоос өмнө биш. Санса дараагийн удаа сүмд очихдоо Ээжид лаа өргөн Маржэйриг Жоффригийн хэрцгий зангаас хамгаалахыг гуйхаар шийдлээ. Бас Лорасын төлөө Дайчинд ч гэсэн ижил мөргөнө.

Тэр оёдолчинг сүүлчийн хэмжээс авах үед Бэйлорын Их сүмд болох ёслол дээр шинэ даашинзаа өмсөхөөр шийджээ. *Серсей намайг хурим дээр ноорхой харагдуулахгүйн тулд үүнийг хийлгэж байгаа байх.* Сансад найрын дараа үнэхээр өөр дашинз хэрэгтэй ч хуучнаа өмсөхөөр бодлоо. Тэр шинэ дашинзандаа хоол унд, дарс хүргэхгүй. *Би үүнийг Хайгарден руу цуг авч явна.* Тэр Виллас Тайреллд үзэсгэлэнтэй харагдахыг хүсч байлаа. *Донтосын зөв байгаад тэр Винтерфеллийг болохоос намайг хүсээгүй байж болох ч надад дурлаж магадгүй.* Санса биеэ чанга тэврэн дашинз хэзээ бэлэн болох тухай бодлоо. Тэр үүнийг өмсөхийг тэсэн ядан хүлээж байв.

АРЪЯА

Бороо орж намдан тэнгэр цэлмэг байхаас илүүтэй бүрхэг байж бүх гол горхины түвшин дээшлэв. Гурав дахь өдрийн өглөө Арьяа модны буруу талд голцуу хөвд ургасан байхыг анзаарчээ.

- Бид буруу зүг яваад байна. Бид өмнө зүг явах ёстой. Модон дээр хөвд яаж ургасныг харав уу? гэж Жэндрид саглагар хөвдтэй хайлаасны дэргэдүүр өнгөрөхдөө хэлэв. Тэр нүд рүүгээ унасан өтгөн хар үсээ түлхээд,

- Бид зам даган явж байна. Тэгээд л тэр. Эндээс зам өмнө зүг хүрдэг гэв.

Бид өмнө зүг өдөржинөө явсан. Бас өчигдөр голын дэргэд явахдаа ч гэсэн гэж Арьяа хэлэхийг хүслээ. Гэсэн ч өчигдөр үүнийг анзаараагүй болохоор итгэлгүй байв.

- Бид төөрсөн гэж бодож байна. Бид голыг дагах ёстойгоос биш орхих ёсгүй гэхэд,

- Гол гогцоорон тахирлан урсаж байгаа. Үүнийг товч зам гэдэгт мөрийцөхөд ч бэлэн байна. Дээрэмчдийн нууц жим байх. Лем, Том хоёр энд олон жилийн турш амьдарсан гэж Жэндри хэлэв.

Энэ үнэн байсанд Арьяа уруулаа хазлаа.

- Гэхдээ хөвд..

- Борооны орж байгаа байдлаас бидний чихэнд хүртэл удахгүй хөвд ургах нь байна гэж Жэндри гомдоллов.

- Зөвхөн манай өмнө зүгийн чихэнд гэж Арьяа зөрүүдлэн хэллээ. Бухыг ямар ч зүйл итгүүлэхийг оролдох аргагүй байв. Гэсэн ч тэр түүний цорын ганц анд бөгөөд Халуун бялуу тэднийг орхисон билээ.

- Шарна намайг талх жигнэхэд хэрэгтэй гэсэн гэж Халуун бялуу тэднийг морддог өдөр хэлжээ.

- Тэгээд ч би бороонд ядарч эмээлэнд холгогдож цаг үргэлж айж явахаас залхаж байна. Энд шар айраг ууж, туулай идэн барьсан талхаа идэж байсан нь дээр. Чи буцаж ирэхдээ хараарай. Чи буцаж ирнэ биз дээ? Дайн хэзээ дуусах бол? гэснээ Арьяагын хэн болохыг санамагц улайн,

- Хатагтай гэлээ.

Арьяа дайн хэзээ дуусахыг мэдээгүй ч толгой дохив.

- Намайг чамайг зодсонд уучлаарай гээд Халуун бялуу тэнэг хулчгар хэдий ч Хааны газраас ирсэн бүх замын турш Арьяа үргэлж түүнийг ашигласаар иржээ. - Би чиний хамрыг хугалсан.

- Чи Лемийнхийг ч гэсэн хугалсан. Энэ сайн хэрэг шүү гээд Халуун бялуу инээлээ.

- Лем тэгж бодоогүй гэж Арьяа дүнсгэр хэлэв. Тэгтэл явах цаг болоход Халуун бялуу хатагтайн

Арьяа үнсэж болох эсэхийг асуусанд Арьяа мөрнөөс нь чимхээд,

- Намайг ингэж битгий дууд. Чи бол Халуун бялуу харин би Арри гэжээ.

- Би энд Халуун бялуу биш. Шарна намайг зүгээр л хүү гэж дууддаг юм. Тэр нөгөө хүүг ч гэсэн ингэж дууддаг болохоор жаахан будилмаар.

Арьяа түүний тухай санаснаас илүү бодсон ч Харвин сатааруулжээ. Арьяа түүнд зугтдаг өдрөө Улаан хэрмийн жүчээнд эцэг Халленийг нь хэрхэн үхэж байхыг олсон тухайгаа ярьж өгчээ.

- Тэр үргэлж жүчээнд үхнэ гэж хэлдэг байсан болохоор бид түүнийг ааш муутай азарганд өшигүүлэн үхнэ гэж боддог байснаас биш арслангийн сүрэгт бариулна гэж бодсонгүй гэж Харвин хариулав. Түүнчлэн Арьяа Йорен болон тэдний Хааны газраас зугтсанаас хойш тохиолдсон явдал, агтчин хүүг "Зүү"-гээр сүлбэн, Харренхалаас гарахдаа харуулын хоолой огтолсон гээд бүгдийг ярьжээ. Харвинд ярих нь бараг л эцэгтээ ярьж байгаатай адил байсан ч зарим нь эцгийнх нь сонсож тэвчихээргүй зүйл байв.

Гэсэн ч Жэйкен Х'гар болон түүний амалж төлсөн гурван үхлийн тухай ярьсангүй. Арьяа түүний өгсөн төмөр зоосыг бүснийхээ дотор хийгээд заримдаа шөнө гаргаж ирэн гараа нүүрнийхээ урдуур явуулах үед царай нь хэрхэн өөрчлөгдсөнийг санадаг байв.

- *Валар моргулис*. Сэр Грегор, Дансен, Полливер, Рафф Свитлинг, Гижигдэгч болон Хоточ. Сэр Илин, сэр Мерин, хатан Серсей, хаан Жоффри гэж амандаа шивнэв.

Эцгийнх нь баруун зүг Берик Дондаррионтой илгээсэн хүмүүсээс Винтерфеллийн зөвхөн зургаан хүн үлдэж сарнисан гэж Харвин ярив.

- Энэ бол урхи байсан, хатагтай. Лорд Тайвин Уулыг Улаан салаа руу гал, илдтэй илгээж лорд эцгийг чинь барихаар найдсан юм. Тэр лорд Эддардыг өрнө зүг өөрийн биеэр Грегор Клегэйний учрыг олохоор ирнэ гэж тооцсон. Хэрвээ тэгсэн бол алах юм уу хоригдол болгон олзолж хатагтай ээжийн чинь тэр үед барьсан Бяцхан чөтгөрөөр солих байлаа. Зөвхөн Хааны алуурч лорд Тайвины төлөвлөгөөг мэдээгүй болохоор дүүгийнхээ баригдсан тухай сонсмогц эцэг рүү чинь Хааны газар гудамжинд дайрсан юм.

- Би санаж байна. Тэр Жориг алсан гээд Жори үргэлж түүн рүү инээмсэглэн хөл нүцгэн явахад нь үг хэлдэггүй байлаа.

- Тэр Жориг алсан гэж Харвин зөвшөөрлөө.

- Бас мориноос унах үед эцгийн чинь хөл хугарсан. Ийм учраас лорд Эддарт өрнө зүг яваагүй. Тэр оронд нь лорд Берикийг өөрийнхөө Винтерфеллээс ирсэн хорин хүнтэй цуг илгээхэд дунд нь би оролцсон. Тэнд бас өөр хүмүүс байсан. Торос, сэр Райман Дарри хүмүүстэйгээ, сэр Гладден Вайлд, Лотар Маллери гэдэг лорд гээд л. Гэвч Грегор биднийг Жүжигчний гарамд хүмүүсээ хоёр талын эрэгт бүгүүлэн хүлээж байсан. Биднийг гатлахад тэр ар өврөөс зэрэг гэнэдүүлэн дайрсан.

- Би Уул Райман Дарриг ганцхан аймшигт цавчилтаар алж, Дарригийн гарыг тохойгоор нь тас цавчин алж морийг нь ч гэсэн хороохыг харсан. Тэгэхэд Гладден Вайлд түүнтэй цуг үхэж, лорд Маллери доош унаж живсэн. Бид зүг бүрээсээ арсланд хүрээлэгдэхэд би бусдын хамт дууслаа гэж бодсон ч Алин хашгиран тушаал өгч манай эгнээг сэргээн морьтой үлдсэнгүүд нь цугларахад Торос зугтах замыг цавчин чөлөөлсөн юм. Бид тэр өглөө зургуул үлдсэн байлаа. Харанхуй болоход хоёроос хэтрэхгүй үлдэж лорд Берик хүндээр шархадсан. Торос шөнө нь түүний цээжинд зоогдсон жадыг сугалж буцалгасан дарсаар оромны нүхийг ариутгасан.

- Бид бүгд лордыг үүр цайхад үхнэ гэдэгт итгэлтэй байв. Гэвч Торос шөнөжингөө галын дэргэд зальбирч үүр гэгээрэхэд тэр амьд хэвээр урьдынхаасаа хүчирхэг болсон байлаа. Хоёр долоо хоногийн дараа морь унах чадалтай болж эр зоригоороо биднийг хатуужуулсан. Тэр бидэнд манай дайн Жүжигчний гарамд дуусаагүй зөвхөн эхэлж байгаа болохоор унасан хүн бүрийнхээ төлөө арав дахин өшөө авна гэсэн.

- Тэгэхэд тулалдаан биднийг өнгөрсөн байв. Уулын хүмүүс зөвхөн лорд Тайвины цэргийн хошууч анги байлаа. Тэд Улаан салааг гаталж голын хөндийг арчин хаяж замдаа тааралдсан бүхнийг галдаж шатаасан. Бид цөөн хэдүүл тэднийг араас нь гэнэдүүлэн довтолж хоорондоо Роберт хаан лорд Тайвины бослогыг няц дарахаар өрнө зүг ирнэ гэж ярьдаг байлаа. Зөвхөн тэгэхэд Робертийн үхсэн тухай сонсон лорд Эддарт цаазлуулан Серсей Ланнистерийн гөлөг төмөр хаан ширээнд суусныг мэдсэн юм.

- Энэ нь ертөнцийг орвонгоор нь эргүүлэх аятай болсон. Биднийг Хааны гар дээрэмчдийн учрыг олохоор илгээсэн ч одоо бид хууль зөрчигч болоод лорд Тайвин Хааны гар болсон байлаа. Зарим маань бууж өгөхийг хүсэхэд лорд Берик хэрэгсээгүй. Бид хааны хүмүүс хэвээр хааны хүмүүс арслангуудыг хэрцгийлэн дарна гэж хэлсэн. Хэрвээ бид Робертийн төлөө байлдахгүй бол сүүлчийн хүнээ үхэх хүртэл тэдэнтэй байлдана гэж хэлсэн. Ингээд бид тулалдахад зарим хачирхалтай явдал болж алдсан хүн бүрийн маань оронд нь хоёр хүн ирж байлаа. Доогуур гаралтай цөөн хэдэн хүлэг баатар, хиа болон ихэнхи нь жирийн ард болох тариачин, хийлчин, буудлын эзэн, зарц, гуталчин тэр ч бүү хэл хоёр септон хүртэл байлаа. Бүх төрлийн хүмүүс болон эмэгтэйчүүд, хүүхдүүд, ноход ч гэсэн... гэхэд,

- Ноход гэнэ ээ? хэмээн Арьяа хэлэв.

- Тийм. Манай залуусын нэгд чиний урьд өмнө харж байгаагүй хамгийн догшин нохой бий гээд Харвин инээлээ.

- Би догшин нохойтой болох юмсан. Арслан алдаг нохой гэж Арьяа гунигтай хэлэв. Урьд нь түүнд Намериа гэдэг зэрлэг чоно байсан ч хатанд алуулахгүйн тулд чулуугаар шидэн зугтаалгасан билээ. *Зэрлэг чоно арсланг алж чадах болов уу?* гэж гайхширан бодлоо.

Үдээс хойш нь ахин бороо зүсэрч эхэлснээ үдэш хүртэл үргэлжилэв. Аз болоход дээрэмчдэд нууц нөхөд байдаг болохоор задгай газар буудаллах юм уу Халуун бялуу, Жэндри тэр гурвын хоноглодог байсанчилан цоорхой саравчин дор хоргодох хэрэг байсангүй.

Тэр шөнө шатаагдан эзгүйрсэн тосгонд хоноглов. Тосгон хаягдсан мэт харагдсан ч Азтай Жак

хоёр удаа богино хоёр удаа уртаар ангийн бүрээ үлээхэд нууц зоорь, нурангин дундаас төрөл бүрийн хүмүүс мөлхөн гарч ирэв. Тэдэнд шар айраг, хатаасан алим, арвайн талх харин дээрэмчдэд Энгайгийн замдаа харвасан галуу байсан болохоор тэр шөнө бараг найр боллоо.

Арьяа далавчинд үлдсэн сүүлчийн махыг шимэн мөлжихөд тосгоны оршин суугчдын нэг Шаргал нөмрөгт Лем рүү эргэж,

- Үүгээр хоёр өдрийн өмнө Хааны алуурчийг хайсан хүмүүс өнгөрсөн гэхэд Лем тургиллаа.

- Тэд Риверранд хайсан нь дээр байлгүй. Хамгийн гүн чийгтэй сайхан гянданд гээд хамар нь бяцарсан алим шиг улаанаар хавдаж хөөсөн болохоор авир нь тааруухан байлаа.

- Үгүй тэр зугтсан гэж өөр нэг хүн хэлэв.

Хааны алуурч. Арьяагын шилэн хүзүүний үс өрвийлөө. Тэр амьсгаа даран чагнав.

- Энэ үнэн үү? гэж Долоо'т Том асуув.

- Би итгэхгүй байна. Би тэдний гянданг амталж үзэж байсан. Тэндээс хэрхэн зугтсан байж таарах вэ? гэж зэвэрсэн дуулгатай өрөөсөн нүдтэй хүн хэлэв. Бусад дээрэмчид түүнийг Азтай Жак гэж дуудах бөгөөд өрөөсөн нүдээ алдсан болохоор Арьяад тийм ч азтай санагдсангүй.

Тосгоныхон үүнд мөрөө хавчлаа. Ногоон сахалт буурал ногоон өтгөн сахлаа илбэв.

- Хэрвээ Хааны алуурч ахин чөлөөтэй болвол чононуудын цус асгарна. Торост үүнийг хэлэх ёстой. Гэрлийн эзэн түүнд Ланнистерийг галын дөлд үзүүлнэ гэхэд,

- Энд сайн гал дүрэлзэж байна даа гээд Энгай инээмсэглэв.

Ногоон сахалт инээмсэглэн харваачийн чихийг үрлээ.

- Би чамд хуврагийг үзүүлэх үү, харваачаа? Тайрошийн Пелло гал дээгүүр өнгийн сахлынхаа үзүүрийг хуйхалсан гэдэг гэхэд Лем нударга нужигнуулан,

- Лорд Берик Жэйми Ланнистерийг барих дуртай байгаа гэж бодож...

- Лем тэр түүнийг дүүжлэх болов уу? Би тийм царайлаг залууг дүүжилвэл хальт ичингүйрэх байна? гэж тосгоны эмэгтэйчүүдийн нэг асуулаа.

- Эхлээд шүүнэ! Лорд Берик үргэлж тэднийг шүүдгийг та нар мэднэ. Тэгээд л дүүжилнэ дээ гээд Энгай инээмсэглэв.

Эргэн тойрон инээд хадлаа. Том хуруугаа модон ятганы чавхдас дээгүүр гүйлгэн зөөлөн дуу аялав.

Хааны ойн ах дүүс

Хууль зөрчсөн хэрмэл дээрэмчид байлаа

Ой тэдний цайз хэрэм болж

Хөндий тал руу уулгалан

Ямар ч хүний алт тэднээс нуун аврагдсангүй

Ямар ч охин гарт нь өртөлгүй үлдсэнгүй

Өө Хааны ойн ахан дүүс

Аймшигтай бүлэг дээрэмчид байлаа

Арьяа дулаахан хуурай буланд Жэндри, Харвин хоёрын дунд суугаад дуучны дуулахыг сонсож нүд нь анилдан нойрслоо. Тэр зүүдэндээ Риверраныг биш Винтерфеллийн гэрээ зүүдлэв. Энэ нь сайхан зүүд байсангүй. Тэр шилтгээний гадна талд өвдөг тулсан шаварт ганцаар зогсож байлаа. Урд нь саарал хана сүндэрлэж тэр хаалганд хүрэхийг хичээсэн ч алхам бүр нь урьдынхаас хэцүү болсоор боржин утаа шиг сарнихад шилтгээн сүүмэлзэн алга болов. Тэгтэл эргэн тойрон хүрээлсэн модон дундаас гуринхалсан саарал чононууд нүдээ гялалзуулан гэтэв. Арьяа тэдэн рүү харгал цусны амтыг саналаа.

Маргааш өглөө нь тэд замыг орхиж талбай дундуур хөндлөн явав. Салхи үлээхэд морьдын туурайн аясаар хатсан хүрэн навч бужигнан бороо орсонгүй. Нар үүлний цаанаас гарахад маш хурц байсан тул Арьяа нүдээ халхлан юүдэнгээ урагшлуулав.

Тэр гэнэтхэн жолоогоо татлаа.

- Бид буруу зүг яваад байна!

- Яасан ахиад л хөвд үү? гэж Жэндри дуу алдан ёолов.

- Нар луу хараач. Бид өмнө зүг явж байна! гээд Арьяа эмээлийнхээ ганзагыг онгичин газрын зураг гарган ирээд тэдэнд үзүүлж,

- Бид ерөөсөө Сэрээг орхих ёсгүй байсан. Харж байна уу Риверран энд голын дунд байна гээд газрын зургийг хөл дээрээ дэлгэхэд бүгд түүн рүү харцгаав.

- Тэгсэн ч бид Риверран хаана байдгийг мэднэ. Бидний хүн бүр гэж Азтай Жак хэллээ.

- Чи Риверран руу яваагүй гэж Лем тодруулав.

Би бараг л тэнд хүрч байсан. Би тэдэнд морьдоо орхих ёстой байсан юм. Би үлдсэн замыг явган туулж чадах байсан гэж Арьяа бодлоо. Тэр зүүдээ санаад уруулаа хазлаа.

- Битгий гомдсон юм шиг хараад бай. Чамд ямар ч муу зүйл тохиолдохгүй гэдэгт миний амыг авч

болно гэж Долоон чавхдас Том хэлэв.

- Өөдгүй худал үг!

- Хэн ч худал хэлээгүй. Бид ямар ч амлалт өгөөгүй. Тэгээд ч чамайг яахыг бид шийдэхгүй гэж Лем хэллээ.

Лем Томоос илүүтэй удирдагч биш ч Ногоон сахалт Тайроши удирдагч байв. Арьяа түүний царай руу эргэлээ.

- Намайг Риверран руу хүргэж өгвөл та нар шан хүртэнэ гэж цөхрөн хэлэв.

- Бяцхан охин минь тариачин тогоондоо ердийн хэрэм хийдэг ч ойгоос алтан хэрэм олвол эзэндээ аваачиж өгдөг.

- Би хэрэм биш гэж Арьяа дургүйцэв.

- Чи мөн гээд Ногоон сахалт хөхрөв. - Хүссэн ч бай үгүй ч бай аянгат лордтой уулзахаар явж байгаа жижигхэн алтан хэрэм. Тэр чамайг яахаа мэднэ. Би түүнийг чиний хүссэнээр хатагтай ээж рүү чинь явуулна гэж мөрийцөхөд ч бэлэн байна.

- Лорд Берик гарцаагүй тэгнэ. Тэр чамд зөв зүйл хийнэ гээд Долоон чавхдас Том толгой дохив.

Лорд Берик Дондаррион. Арьяа Харренхалд байхдаа түүний тухай Ланнистерийнхан болон Цуст жүжигчдээс сонссоноо саналаа. Лорд Берик бол модон дахь утаа байв. Лорд Берик Варго Хотод алагдаж түүнээс өмнө сэр Амори Лорчод болон хоёр ч удаа Хөдөлж буй Уулд үхжээ. *Хэрвээ тэр намайг гэр лүү минь явуулахгүй бол би бас түүнийг ална.*

- Би яагаад лорд Бериктэй уулзах ёстой юм? гэж тэр аяархан асуув.

- Бид түүнд язгууртан гаралтай бүх олзлогдогчдоо аваачиж өгдөг гэж Энгай тайлбарлалаа.

Олзлогдогч. Арьяа тайвширахын тулд гүн амьсгаа авлаа. *Ус шиг тайван.* Тэр морьтой дээрэмчид рүү харснаа мориныхоо толгойг эргүүлэв. *Одоо могой шиг хурдан* гэж бодоод мориныхоо ташааг өсгийгөөрөө гуядлаа. Тэр Ногоон сахалт, Азтай Жак хоёрын дундуур зугтахад Жэндригийн гайхсан царай хальт харагдсанаа гүү нь цааш авч давхилаа. Арьяа задгай газар гараад хурдлав.

Хойд, урд, баруун зүүн зүгийн алин ч хамаа байсангүй. Дараа нь тэднээс мултарсан хойно Риверран хүрэх замаа олно. Арьяа мориныхоо дэл рүү бөхийн шавдуулан хатируулав. Араас нь дээрэмчдийн хараал тавин эргэж ир гэж хашгирах сонсогдлоо. Гэвч үүнийг үл тоомсорлон мөрөн дээгүүрээ эргэж харахад дөрвөн хүн хөөж Энгай, Харвин, Ногоон сахалт гурав мөр зэрэгцэн давхиж Лем арай цаахан том шаргал нөмрөгөө ардаа намируулан элдэж байв.

- Буга шиг хурдан. Хурдал давхиад байгаарай гэж мориндоо хэллээ.

Арьяа бүсэлхий хүрсэн өндөр хүрэн зэрлэг өвстэй талбай дундуур давхихад морины өнгөрөхөд

хатсан навч бутран хийсэв. Тэгтэл зүүн талд нь ой байхыг харлаа. *Би тэднийг ойд хаяж чадна.* Талбайн нэг талд үргэлжлэх бохир шуудуу дээгүүр жолоо таталгүй харайлгаж гараад хайлаас, улаан мод, хусны дундуур давхив. Хойш түргэхэн эргэж харахад Энгай, Харвин хоёр араас нь нэхсэн хэвээр байлаа. Ногоон сахалт ард хоцорч, Лем үзэгдсэнгүй.

- Түргэл чи чадна гэж Арьяа мориндоо хэллээ.

Хоёр хайлаасны дундуур гарахад аль талд нь хөвд ургасныг харахын завдал байсангүй. Тэр том талбайд савах зориулттай хугарсан шовх үзүүртэй мөчиртэй асар том урхи болох өмхөрсөн модон дээгүүр харайв. Тэгтэл нөгөө талд нь зөөлөн налуу уруудсанд хурдаа удаашруулснаа ахин нэмэхэд морины тахнаас чулуунд хавиран оч үсрэв. Толгодын орой дээр гараад эргэж харлаа. Харвин Энгайг урдаа оруулсан ч хоёул хүчтэй нэхэж байв. Ногоон сахалт тэртээ цаана харагдана.

Замыг нь гол хаахад Арьяа нойтон хүрэн навчистай усыг цацлуулан туулав. Нөгөө талын эрэг дээр гарахад мориных нь хөлөөс нэг юм зуурлаа. Энд шигүү ургасан залуу ойд газраар дүүрэн үндэс, чулуу явдлыг нь удаашруулахад чадах чинээгээрээ хурдан алхуулав. Ахин нэг эгц толгод урд нь бослоо. Дээш гараад ахин уруудав. *Энэ ой хичээн том юм бол?* Арьяа Рус Болтоны Харренхалын жүчээнээс хурдан морь хулгайлснаа мэдэж байвч хурдных нь хэрэг гарсангүй. *Би ахин тал газар гарах хэрэгтэй. Би замыг олох хэрэгтэй.* Гэвч оронд нь тэр ангийн жим оллоо. Энэ нь нарийхан овон товон чулуутай хэдий ч зам байв. Арьяа урагш давхихад нүүр рүү нь мөчир шавхуурдана. Нэг мөчир юүдэнгээс нь зууран арагш чангаахад агшин зуур тэдэнд баригдах нь гэж айв. Бутны дэргэдүүр өнгөрөхөд үнэг чавхдан гарснаа гайхширч уурсан зугтаалаа. Ангийн жим түүнийг ахин нэг гол руу аваачив. Эсвэл ижилхэн юм болов уу? Тэр тойроод эргэсэн юм болов уу? Үүнийг таах хугацаа байсангүй ард нь модон дунд морины давхих чимээ гарлаа. Өргөс нүүрийг нь Хааны газар барьж авахаар хөөдөг байсан муурнууд шиг маажна. Нигүүрсний мөчир дээрээс бор шувуу дэрхийн нисэв. Тэгтэл ой шингэрэн гэнэтхэн задгай газар гарахад нойтон хөлд тахлагдсан хогийн өвс, зэрлэг буудай битүү ургасан өргөн тал өмнө нь сунав. Арьяа морио гуядан давхиулав. *Зугт Риверран руу зугт. Гэр лүүгээ зугт* гэж бодов. Ингэхэд тэр тэднийг орхисон болов уу? Арьяа түргэн эргэж харахад Харвин зургаан ярдын зайтай ард нь давхин ирж байв. *Үгүй, үгүй. Тэр чадахгүй тэр биш шүү энэ чинь шударга биш байна.*

Хоёр морь цуцаж хөлрөхөд Харвин дэргэд нь зэрэгцэн ирж бөхийгөөд жолооноос нь цулбуурдан авлаа. Арьяа багтрах шахам амьсгаадав. Тэр тулаан дууссаныг мэдэж байлаа.

- Чи яг умардын хүн шиг давхиж байна, хатагтай. Авга эгч хатагтай Лианна чинь бас ижилхэн байсан юм. Гэвч миний эцэг агтын даамал болохыг санаж байгаа биз дээ гэж Харвин тэднийг зогсоход хэлэв.

Арьяа түүн рүү гомдол дүүрэн харлаа.

- Би чамайг эцгийнхээ хүн гэж бодсон юмсан.

- Лорд Эддарт үхсэн, хатагтай. Би одоо аянгат лорд болон ах дүүсийнхээ хүн болсон.

- Ямар ах дүүс? гээд Хөгшин Халлен өөр хүүтэй болохыг Арьяа санасангүй.

- Энгай, Лем, Долоон чавхдас Том, Ногоон сахалт, Жак гээд тэд бүгд. Бид чиний ах Роббод муу зүйл хийхгүй ч түүний төлөө тулалдаагүй. Түүнд өөрийн гэсэн арми, өвдөг сөхөрсөн олон агуу лорд бий. Харин бидэнд зөвхөн жирийн ард гээд тэр шинжин харснаа,

- Чи миний ярьж байгаа зүйлийг ойлгож байна уу? гэлээ.

- Тийм гээд Харвин Роббын хүн биш болохыг Арьяа хангалттай ойлгожээ. Дээрээс нь тэр бас олзлогдогч болсон. *Би Халуун бялуутай үлдэх ёстой байсан юм. Бид жижигхэн завийг авч Риверран руу хөвөх ёстой байсан.* Тэр Шарсан дэгдээхий байсан бол дээр байлаа. Шарсан дэгдээхий, Нан, Үен юм уу өнчин хүү Арриг хэн ч олзлохгүй. *Би чоно байсан гэтэл одоо ахин тэнэг бяцхан хатагтай боллоо* гэж уурсан бодов.

- Чи одоо буцаж тайван явах уу эсвэл би чамайг хүлж морины нуруунд тэгнэх ёстой юу? гэж Харвин асуулаа.

- Би тайван явъя гэж Арьяа уруу царайлан өчив. *Одоохондоо шүү дээ.*

СЭМВЭЛ

Сэм уйлан ахин нэг алхлаа. *Энэ миний сүүлчийн, хамгийн сүүлчийн алхалт. Би цаашаа явж чадахгүй нь. Би чадахгүй.* Гэвч хөл нь урагш явахад нөгөө хөл нь дагаж хөдлөн нэг алхам хийснээ ахин нэг алхам урагшилахад бодлоо. *Тэд миний хөл биш. Өөр хүний хөл. Өөр алхаж яваа хүний хөл болохоос биш минийх биш.*

Тэр доошоо цасанд бүдчин яваа хэлбэр дүрсгүй болхи хөл рүүгээ харав. Өмнө нь гутал нь хар өнгөтэй байсан ч цас шаван хэлбэр дүрсгүй цагаан бөөрөнхий зүйл болжээ. Яг л цасаар хийсэн майжгий хөл шиг.

Цас орохоо зогссонгүй. Өвдөг тулсан хунгар туулахад хөлийнх нь доод хэсэгт цас цагаан шилбэвч шиг битүү баглажээ. Тэр хөлөө чирэн гуйван алхахад үүрч яваа ачаа нь аварга том бөгтөр нуруутай юм шиг харагдуулна. Дээрээс нь маш их туйлын зүдэрч байлаа. *Би цааш явж чадахгүй нь. Ээж минь өршөө би чадахгүй нь.*

Ойролцоогоор дөрөв юм уу таван алхам тутамд тэр унжсан илдний бүсээ дээшлүүлж байлаа. Сэм илдээ Нударга дээр алдсан ч хуй нь бүсэнд санжигнасан хэвээр байв. Түүнд хоёр хутга байсны нэг нь Жоны өгсөн лууны шилэн хутга нөгөө нь мах огтолдог хутга байв. Энэ бүгдийн жинд дарагдан дээрээс нь цүдгэр том гэдэстэй болохоор дээшээ татахыг мартсан тохиолдолд бүс нь хичнээн чанга горхилсон хамаагүй шагайнд нь орооцолдон унана. Тэр гэдэснийхээ дээгүүр бүсэлхийг оролдсон ч бараг сугаар нь татжээ. Грэнн түүнийг хараад шоолон инээж харин Долорус Эдд,

- Би урьд нь нэг удаа илдээ хүзүүндээ гинжээр оосорлон зүүсэн хүн харж байсан юм байна. Нэг өдөр тэр бүдэрч унахад бариул нь хамар луугаа гударсан гэж хэлжээ.

Сэм бас бүдэрч байлаа. Цасан дор чулуу, модны үндэс тааралдан заримдаа хөлдүү газар гүнзгий нүх байна. Гурван өдрийн өмнө Хар Бернар тийм нүхэнд унаж шагайгаа хугалжээ. Эсвэл магадгүй дөрвөн өдөр ч билүү тэр хэдэн өдөр өнгөрснийг мартжээ. Үүний дараа захирагч лорд Бернарыг морин дээр суулгахыг тушаасан байна.

Сэм мэгшин уйлж ахин нэг алхав. Энэ нь тэр явж байхдаа унаж байгаа юм шиг санагдан эцэс төгсгөлгүй унасаар байсан ч хэзээ ч газар хүрэхгүй зүгээр л урагш унаад байгаа мэт байлаа. *Би зогсох ёстой. Энэ дэндүү их өвдөж байна. Би маш их өлсөж даарсан болохоор унтах хэрэгтэй. Галын дэргэд жаахан унтаж хөлдөөгүй юм идэхэд болно.*

Гэсэн ч зогсох юм бол үхнэ гэдгийг мэдэж байв. Тэд бүгд мэдэж байсан бөгөөд цөөхүүл үлдсэн байлаа. Тэд Нударгаас зугтахад тавиул магадгүй түүнээс ч их байсан болох ч зарим нь цасан дунд төөрч будилан, цөөн хэд нь шархнаасаа цус алдан үхжээ. Заримдаа Сэм арын харуулаас хашгиралт гарахыг сонсдог байлаа. Нэг удаа аймшигтай хашгиралт гарчээ. Тэр үүнийг сонсохоороо зугтаж хорь юм уу гучин ярд чадах чинээгээрээ хурдан хөшсөн өвдгөөрөө цас хутган гүйдэг байв. Хөл нь хүчтэй байсан бол одоо хүртэл гүйсээр байсан байх биз. *Тэд бидний ард байна. Тэд бидний ард явсан хэвээр нэг нэгээр маань авч байна.*

Сэм мэгшин ахин нэг алхав. Тэр маш удаан хугацаанд даарсан учир дулаахан байх гэж юу

болохыг мартжээ. Сэм гурван давхар оймс, давхар хурганы арьсан цамцны дотуур хоёр давхар дотуур хувцас өмсөж дээр нь хүйтэн төмөр гархин хуягнаас жийрэглэн зузаан хөвөнтэй хүрэм өмсчээ. Хуяган дээгүүрээ урт сул хүрэм углан ясан товчтой гурав дахин зузаан нөмрөг эрүүн дороо зангидсан байв. Юүдэнгээ толгой руугаа унжуулан, нимгэн ноосон арьсан бээлий дээр зузаан үстэй нударга буулгаж, ороолтоор нүүрнийхээ доод хэсгийг халхлан зангидаад юүдэнгийнхээ дотуур үстэй малгай чих рүүгээ даран өмсчээ. Гэсэн ч ялангуяа хөл хэсэг нь даарсан хэвээр байлаа. Одоо бараг мэдрэгдэхээ больсон ч өчигдөрхөн зогсохын аргагүй өвдөж байсан тул алхам тутамд хашгиралтаа арай ядан тэвчиж байв. Өчигдөр тэгсэн билүү? Тэр үүнийг санасангүй. Сэм Нударганаас гарсан цагаас эхлэн бүрээ үлээгдсэнээс хойш унтаагүй байлаа. Эс бөгөөс алхаж байхдаа унтсан байж таарна. Ер нь хүн явуут дундаа унтаж чаддаг болов уу? Тэр мэдэхгүй юм уу эсвэл мэддэг байсан ч мартжээ.

Уйлсаар цааш алхлаа. Эргэн тойронд цас будрана. Заримдаа цагаан заримдаа хар тэнгэрээс орж байснаараа өдөр шөнө ялгагдаж байв. Мөрөн дээр нь цасан ширхэг хоёр дахь нөмрөг мэт шавж өндөр овоорсон тул ачаа нь улам хүнд болж байлаа. Бүсэлхийнийх нь ар тал алхам тутамд хэн нэгэн хутга зоож сугалж байгаа юм шиг зэвүүн хатгуулж, мөр нь хуягныхаа жинд дарагдан янгинана. Тэр хуягаа тайлахын тулд бүхнийг өгөх байсан ч айлаа. Үүний тулд хүрэм нөмрөгөө тайлах хэрэгтэй болохоор хүйтэн түүнийг гүйцнэ.

Хэрвээ би хүчтэй байсан бол... Гэсэн ч тэр хүчтэй биш тул сайн зүйл байсангүй. Сэм сул дорой тарган маш бүдүүн өөрийнхөө жинг арай ядан авч явж байсан болохоор хуяг нь дэндүү ихээр дарж байв. Энэ нь мөрийг нь төмөр арьс хоёрын дунд хөвөн жийрэглэснийг үл харгалзан цус шүүртэл холгоно. Түүний хийж чадах ганц зүйл гэвэл уйлах байсан болохоор хацар дээр нь хөлдүү нулимс тогтож байлаа.

Тэр уйлсаар ахин нэг алхам алхав. Хөлд нь шигдсэн цасыг бутлахгүй бол цааш алхахын арга байсангүй. Будран орох цасан дунд баруун зүүн талд нь модон дундуур бамбарын шаргал гэрэл сүүмэлзэнэ. Сэм толгойгоо эргүүлэн тэднийг модон дундуур чимээгүй нааш цааш болон явахыг харлаа. *Хөгшин баавгайн галт хүрээ түүнээс гарсан хүн дайсанд өртөнө* гэж өөртөө санууллаа. Тэр өмнөө байгаа бамбарыг хөөн алхахад тэд ч гэсэн хөл урган түүнийхээс урт хүчтэй хөлтэй болсон мэт хэзээ ч гүйцэж чадахгүй байлаа.

Өчигдөр Сэм тэднээс цувааны гадна захад харанхуй хүрээлсэн талд явах байсан ч хамаагүй бамбарчны нэг болгохыг гуйжээ. Тэр галтай болохыг хүсч мөрөөдөж байлаа. *Хэрвээ надад гал байсан бол даарахгүй байсан.* Гэвч хэн нэгэн түүнд эхэндээ бамбартай байгаад цасанд унаган галаа унтраасныг сануулав. Сэм бамбараа унагааснаа санахгүй байсан ч үнэн бололтой. Тэр гараа дээш удаан өргөж явахад дэндүү сульджээ. Ингэхэд хэн түүнд бамбарын тухай сануулсан билээ. Эдд билүү Грэнн билүү? Тэр алин болохыг санасангүй. *Би тарган сул дорой ямар ч ашиггүй дээрээс нь ухаан маань хүртэл хөлдөж байна.* Тэр ахин нэг алхам хийлээ.

Сэмийн хамар аман дээгүүрээ боосон ороолт нус нь гоожин хатуурсан болохоор царай нь хөлдөх нь үү гэж айлаа. Амьсгалахад хүртэл хэцүү хүйтэн агаар залгихад бэрх байв.

- Ээж минь өршөө гэж багалсан хөлдүү ороолтон дороо бөглүү дуугаар шивнэлээ.

- Ээж минь өршөө, Ээж минь өршөө, Ээж минь өршөө гээд мөргөх тоолон нэг алхам хийж хөлөө цасан дээгүүр чирэн явлаа.

- Ээж минь өршөө, Ээж минь өршөө, Ээж минь өршөө.

Түүний өөрийн төрсөн ээж өмнө зүг мянган бээрийн хол зайд охин дүүс, жижигхэн эрэгтэй дүү Диконтой нь Бүрээн толгод дахь шилтгээнд аюулгүй байгаа. *Тэр намайг дээд тэнгэрийн Ээж шиг сонсож чадахгүй. Ээж өршөөнгүй гэж бүх септон сургадаг ч Долоо шүтээнд Хананаас цааш чадал байхгүй байв. Энд хуучны хөгшин бурхад, ойн нэргүй бурхад, чоно, цас ноёлоно.*

- Өршөө. Өршөө, намайг өршөө, намайг өршөө гэж хуучин шинэ бурхад болон сонсож байвал чөтгөрт ч хамаагүй шивнэв.

*Маслин өршөөл гуйн хашгирсан. Сэм яагаад гэнэтхэн үүнийг санасан юм бол? Энэ бол түүний санахыг хүссэн зүйл биш байлаа. Тэр хойшоо бүдрэн илдээ хаяад бууж өгөхийг хашгирч тэр ч байтугай зузаан хар бээлийгээ тайлан өмнөө ган бээлий шиг шидсэн. Тэр арваад минут өршөөл гуйн хашгирсан ч цагаан үхдэл хоолойноос нь базан агаарт өргөөд толгойг нь тас татах шахам шиджээ. *Үхэсэгд өршөөл гэдгийг мэдэхгүй ч Өөрүүд бол... үгүй би энэ тухай бодох ёсгүй. Бодох ёсгүй санах ёсгүй зүгээр алхаад, алхаад, алхаад л байх ёстой.**

Тэр гиншин уйлсаар цааш нэг алхав.

Хөлийн дор хөлдүү үндэс дайралдахад Сэм бүдрээд өрөөсөн өвдөг дээрээ айхтар чанга унахдаа хэлээ хазчихлаа. Аманд нь Нударганаас гарснаас хойш амталсан анхны дулаан зүйл болох цус амтагдав. *Энэ бол төгсгөл* гэсэн бодол төрөв. Одоо тэр унасан болохоор ахин босох хүч байхгүй болжээ. Сэм модны мөчрөөс зууран хөл дээрээ өндийхийг оролдсон ч хөшсөн хөл нь дэмжсэнгүй. Хуяг нь хэт хүнд дээрээс нь дэндүү тарган, дэндүү сул дорой дэндүү ядарсан байлаа.

- Хөл дээрээ босооч, гахай минь гэж дэргэдүүр нь хэн нэгэн өнгөрөхдөө зандарсан ч Сэм тоосонгүй. *Би зүгээр цасан дээр жаахан хэвтээд нүдээ анина.* Энд үхвэл муугүй байлаа. Тэр ахиж даарсангүй нурууны өвдөлт, мөрний аймшигтай янгиналт болон хөлөө мэдэрсэнгүй. *Ямар ч байсан намайг түрүүнд үхсэн гэж тэд хэлэхгүй.* Нударган дээр түүний эргэн тойронд зуугаад хүн үхсэнээс түүний дараа улам олон хүн үхэхийг харжээ. Сэм чичирэн зуурсан мөчрөө тавиад цасан дээр тарайв. Цас хүйтэн нойтон байсан ч хувцасны цаанаас бараг мэдрэгдсэнгүй. Тэр дээшээ цайвар тэнгэрээс цасан ширхэг гэдэс, цээж, сормуусан дээр нь буухыг ширтлээ. *Цас намайг зузаан цагаан бүтээлэг шиг хучиж байна. Цасан дор дулаахан болохоор тэд намайг Шөнийн харуулын эр хүний ёсоор үхсэн гэж хэлнэ. Би тэгсэн. Би үүргээ гүйцэтгэсэн. Хэн ч намайг андгайгаа зөрчсөн гэж хэлэхгүй. Би тарган, сул дорой, хулчгар гэсэн ч үүргээ гүйцэтгэсэн.*

Түүний үүрэг бол хэрээ хариуцах явдал байв. Ийм учраас түүнийг аянд авч явжээ. Сэм явахыг хүсэлгүй тэдэнд хичнээн хулчгар болохоо хэлжээ. Гэсэн ч мэйстер Эймон маш их хөгширч сохорсон тул Сэмийг хэрээ арчлуулахаар явуулжээ. Тэднийг Нударган дээр буудаллах үед захирагч лорд түүнийг дуудан тушаал өгсөн байна.

- Чамайг дайчин биш гэдгийг бид хоёул мэднэ, хүү минь. Хэрвээ бид дайралтанд өртвөл өөрийгөө батлах гэж бүү холдоорой зүгээр л замаас холд, хүү минь. Чиний ажил бол захиа илгээх. Харин над руу гүйж ирээд захианд юу бичихийг битгий асуугаарай. Өөрийнхөөрөө бичиж Хар цамхаг руу нэгийг, Сүүдэрт цамхаг руу нэгийг илгээ гээд Хөгшин баавгай бээлийтэй гараар Сэмийн нүүр лүү зангаж,

- Надад чиний айсандаа өмдөндөө тавьсан ч бай хамаагүй. Мянган зэрлэгүүд ханан дээгүүр даван цусыг чинь нэхэж хашгирсан ч байсан хамаагүй чи шувуунуудаа явуулах ёстой. Хэрвээ үгүй бол би чамайг долоон там хүртэл мөшгөн агнаж үүнийг хийгээгүйдээ гүн харамсуулах болно гэдгийг амлая гэхэд Мормонтын хэрээ толгойгоо,

- *Харамсана, харамсана, харамсана* гэж хашгирлаа.

Сэмд харамсах зүйл олон байв. Тэр зоригтой, хүчтэй, илдэнд сайн биш, эцгийнхээ сайн хүү Дикон болон охидын сайн ах байж чадаагүйд харамсана. Тэр бас Нударга дээр түүнээс хавьгүй дээр хүмүүс жинхэнэ эрчүүд үхсэн болохоос биш түүн шиг чарласан тарган хүү үхээгүйд харамсана. Ядахдаа л Хөгшин баавгай там хүртэл агнан мөрдөхгүй гэж бодож болох байлаа. *Би шувуунуудыг илгээсэн. Би ядаж түүнийг зөв биелүүлсэн.* Тэр Анхны хүмүүсийн нударга руу дайралт болсон тухай товч энгийн захиа урьдчилан бичээд цаасны хүүдийд хийж хэзээ ч илгээх шаардлага гарахгүй байх хэмээн найджээ.

Бүрээн дуу тасхийхэд Сэм унтаж байв. Тэр эхэндээ зүүдэлж байна гэж бодсон ч нүдээ нээхэд буудал дээр цас орж хар ахан дүүс нум сум, жадаа шүүрч аваад хэрмэн хүрээ рүү гүйлдэж байлаа. Зөвхөн мэистер Эймоны хуучин бойдоо царайгаараа дүүрэн батга хүзүүн дээрээ том хатигтай Чэтт дэргэд нь байв. Сэм бүрээн дуу гурав дахь удаагаа үлээх үед хэзээ ч Чэттийнх шиг ийм их айсан хүний царай харж байсангүй.

- Надад шувуунуудыг гаргахад туслаач гэж гуйсан ч Чэтт цааш эргээд гартаа хутгатай зугтан оджээ. *Тэр нохдод санаа тавих ёстой* гэж Сэм санав. Гарцаагүй захирагч лорд түүнд бас тушаал өгсөн хэрэг бизээ.

Тэр айдас болон хүйтэнд чичирч байсан болохоор бээлий дотор бээрсэн хуруугаар цаасны хүүдийнээс бичсэн зурвасаа ухан гаргалаа. Сэм Хар цамхагын торыг онгойлгоход хэрээнүүд уурсан хашгирч тэдний нэг царай руу нь нисэв. Араас нь хоёр хэрээ ухасхийхэд нэгийг нь барьж авсанд бээлийг нь цус гартал нэвт тоншив. Гэсэн ч тэр тогтоон барьж жижигхэн хуйлсан цаасыг хавсаргалаа. Дайны бүрээ намдаж нам гүм болсон ч Нударганд хашгирсан тушаал хадаж илд хангинана. "Нисээрэй!" гээд Сэм хэрээг агаарт тавив.

Сүүдэрт цамхагын хэрээний торонд шувууд хашгиран далавчаараа нүдэхэд хаалгыг нь онгойлгохоос айсан ч хүчлэн нээлээ. Энэ удаад тэр зугтахыг завдсан эхний хэрээг барьж авав. Хормын дараа бударч буй цасанд дайралтын тухай үг тээсээр нисч одов.

Сэм үүргээ дуусгасан хойно айсандаа захирагдахаа больсон болхи хуруугаар хувцаслаж малгайгаа углан хүрэм болон юүдэнтэй нөмрөг нөмөрч илдний бүсээ унахгүйгээр чанга бүслэв. Тэгээд нөөц дотуур хувцас, дулаан оймс, Жоны өгсөн лууны шилэн сумны толгой, жадны зэв,

хуучин бүрээ болон бичиг цаас, бэх, үзэг, өөрийнхөө зурсан газрын зураг, Хананаас авч гарсан чулуу шиг хатуу сармистай зайдас ээрэг бүх зүйлийг багтаасан үүргээ олж аваад чанга зангидаж нуруундаа үүрлээ. *Захирагч лорд намайг хэрмэн хананаас гарах ёсгүй гэж хэлсэн ч намайг түүн рүү гүйж очих ёсгүй гээгүй* хэмээн санав. Сэм гүн амьсгал аваад дараагийн агшинд юу хийхээ мэдэхгүй байгаагаа ойлгов.

Тэр байрандаа дугуйран эргэлдэхэд үргэлж байдаг шигээ айдас нь улам өслөө. Ноход хуцаж, морьд янцгаан битүү орох цасан дунд чимээ алс байгаа юм шиг бөглүү дуулдана. Сэм толгодын оройг эмжсэн намхан чулуун ханын оройд улалзаж буй бамбар битгий хэл гурван ярдын зайнаас цааш юу ч харсангүй. *Бамбарууд унтарсан юм болов уу?* Энэ тухай бодохоос аймшигтай байлаа. *Бүрээ гурван удаа удаан дуугарахад, гурван урт дуугаралт бол Өөрүүд гэсэн үг.* Ойн цагаан явагчид бол хүүхэд байхад нь айсандаа дуу алдан чичирдэг байсан үлгэрт гардаг хүйтэн сүүдэр мангас бөгөөд аварга цасны аалз унаж цус эрэн явдаг байлаа.

Сэм эв хавгүйхэн сэлмээ сугалаад цасан дундуур хүндээр сажлав. Дэргэдүүр нь нохой хуцан өнгөрөхөд Сүүдэрт цамхагын урт сүх, найман фут өндөр жадтай том сахалтай хэсэг хүмүүсийг харлаа. Тэдний дунд аюулгүй санагдахад араас нь даган хана руу очлоо. Сэм дугуй хэрмийн оройд бамбар ассан хэвээрийг хармагц чичирэлт нь гүнзгий санаа амарлаа.

Хар ахан дүүс гартаа илд, жад барин зогсоод хаялан орох цас руу харж хүлээнэ. Дэргэдүүр нь цасанд цоохортсон дуулгатай сэр Малладор Лок морьтойгоо өнгөрөв. Сэм хүмүүсийн ард зогсоод Грэнн, Долорус Эдд хоёрыг хайлаа. *Хэрвээ би үхэх ёстой бол нөхдийнхөө дэргэд үхнэ* гэж тэгэхэд бодсоноо санав. Гэвч эргэн тойронд нь Блэйн гэдэг эргүүлийн захиргаан дорх Сүүдэрт цамхагын үл таних хүмүүс байлаа.

- Тэд ийшээ ирж байна гэж нэг хүний хэлэх хоолой гарав.

- Онил гэж Блэйн хэлэхэд арван хоёр хар сум саадагнаас суглагдан нумны хөвчинд татагдав.

- Бурхад минь тэд хэдэн зуугаараа байна гэж өөр хүн аяархан хэллээ.

- Татаад гэж Блэйн тушаав. Сэм харахыг хүсээгүй тул юу ч харсангүй. Шөнийн харуулын хүмүүс бамбарын ард зогсон чихээ хүртэл хөвчөө татан хүлээхэд ямар нэг зүйл харанхуйд цасан дундуур гулгамтай налуу өгсөн ирлээ.

- Татаад, татаад гэж Блэйн хэллээ. Тэгснээ,

- Харваад гэж тушаахад сумнууд исгэрэн алга болов.

Хэрмэн ханын дагуу хэдэн хүний баярласан уухай гарснаа түргэн намдав.

- Тэд зогссонгүй, эрхэм лорд гэж Блэйнд нэг хүн хэлэхэд өөр нэг нь,

- Улам олон байна! Тийшээ хараач модон дундаас гарч ирж байна гэж хашгирлаа.

- Бурхад минь өршөө тэд мөлхөж байна. Тэд бараг л бидэн дээр ирлээ!

Сэм арагш ухран айсандаа хүйтэнд салхинд үлээгдсэн модны сүүлчийн навч шиг чичирлээ. Тэр шөнө маш хүйтэн байв. *Одооноос илүү хүйтэн байсан. Цасанд бараг дулаахан болохоор би одоо дээрдэнэ. Жаахан л амралт надад хэрэгтэй. Магадгүй хэсэг хугацааны дараа ахин алхаж чадахуйц хүчтэй болно. Жаахан л хугацааны дараа.*

Толгой дээгүүр нь цас болсон дэлтэй туурай нь мөсөнд хучигдсан сэгсгэр буурал морь өнгөрлөө. Сэм түүний өнгөрөхийг дагуулан харав. Дараа нь цасан дундаас ахин нэг гарч ирэхэд жолоог нь хар ахан дүү хөтөлж явав. Тэр замдаа тааралдсан Сэмийг харснаа хараан морио цааш хөтлөн одов. *Надад морь байсан ч болоосой. Хэрвээ би морьтой байсан бол явж чадах байлаа. Би морин дээр сууж эмээл дээрээ хэсэгхэн ч атугай зүүрмэглэх байсан.* Гэвч тэдний морьдын ихэнхи Нударга дээр алагдаж үлдсэн нь хоол хүнс, бамбар, шархдагсдыг зөөн явж байлаа. Сэм шархадсангүй. *Зөвхөн тарган сул дорой долоон ханлигийн хамгийн хулчгар хэвээр байна.*

Тэр туйлын хулчгар байв. Түүний эцэг лорд Рэндилл үргэлж тэгж хэлдэг бөгөөд энэ нь үнэн байв. Сэм хэзээ ч түүний залгамжлагч байж тэнцэхгүй учир эцэг нь Хана руу явуулжээ. Түүний бага дүү Дикон Тарлигийн газар нутаг, шилтгээн, олон зууны турш удмын бахархал болсон их илд "Зүрх хөнөөгч"-ийг залгамжилан авна. Сэм дүүгээ ах нь ертөнцийн хязгаарт цасан дунд үхсэнийг мэдвэл нулимс унагах эсэхийг гайхширлаа. *Тэр яагаад тэгэх ёстой гэж? Хулчгарын араас уйлах ямар ч үнэ цэнэгүй.* Эцэг нь энэ тухай ээжид нь хичнээн удаа давтан хэлсэн билээ. Хөгшин баавгай ч гэсэн мэдэж байв.

- Галт сум. Тэднийг галаар харва гэх захирагч лордын тушаал Нударга дээгүүр шөнийн харанхуйд хадахад тэр гэнэтхэн морьтойгоо гарч ирснээ Сэмийг ажигламагц,

- Тарли! Эндээс холд! Чиний байр бол хэрээнүүдийн дэргэд гэв.

- Би... би... би захиануудыг илгээчихсэн.

- Сайн байна гэхэд Мормонтын мөрөн дээрх хэрээ,

- *Сайн байна, сайн байна* гэж давтлаа. Захирагч лорд хуяган дээр үслэг нөмрөг нөмөрсөн нь улам ч том биетэй болсон харагдав. Тэр хар төмөр дуулгавчны халхавчны цаанаас оч цацартал догшин нүдээр ширтэв.

- Чи энд зөвхөн саад болно. Тор луугаа буц. Надад ахин мэдээ илгээх шаардлага гарвал чамайг хайхыг хүсэхгүй байна. Хэрээнүүдээ бэлэн байлгаарай гээд хариу хүлээлгүй морио эргүүлж хэрмийн дагуу давхиулан,

- Гал! Тэднийг галаар харва! гэж хашгирав.

Сэмд давтаж хэлүүлэх хэрэг байсангүй. Тэр хэрээ рүүгээ тарган хөлийнхөө чадах хурдаар аль болох түргэн буцав. *Би захиагаа өмнө бичвэл бид шувуунуудаа хэрэгтэй цагт түргэн явуулна* гэж бодлоо. Энэ нь түүнийг хөлдүү бэх гэсгээхийн тулд бяцхан гал түлэн удахад хүргэв. Сэм хадны дэргэд суугаад үзэг цаас гарган захиа бичлээ.

Цас хүйтэн дунд дайралт болж бид тэднийг галт сумаар буцааж байна гэж бичтэл Торен Смолвудын чанга тушаал хашгирах сонсогдов.

- Онил, тат... харва гэхэд сумны исгэрэлт эхийн мөргөл шиг чихэнд таатай сүнгэнэн одов.

- Шатацгаа үхсэн новшнуудаа гэж Дайвин хөхрөн хашгирав. Ах дүүс хөгжин хараал тавилаа. *Бүгд аюулгүй. Бид Анхны хүмүүсийн Нударга дээр хэвээр байна гэж Сэм бичээд тэднийг өөрөөс нь хамаагүй дээр харвах байх гэж найдлаа.*

Тэр бичгээ хажуу тийш тавиад ахин нэг хоосон цаас гаргав. *Нударган дээр хүчтэй будрах цасан дунд байлдсан хэвээр* гэж бичтэл хэн нэгний,

- Тэд ирсэн хэвээр байна гэсэн хашгиралт гарав. *Үр дүн тодорхойгүй байна.*

- Жадандаа гэж өөр хүн хашгирлаа. Энэ нь сэр Малладор байж болох ч Сэм тодорхой мэдсэнгүй. *Үхдлүүд бидэн рүү цасан дунд дайрч байгаа ч бид тэднийг галаар харваж байна* гэж бичээд толгойгоо эргүүлэн харахад хунгарласан цасан дунд буудлын голд том түүдэг асааж морьтой хүмүүс эргэн тойронд нь үймэж байв. Дайсан хэрмийг давбал тулаанд бэлэн нөөц хүч. Тэд илдний оронд бамбараар зэвсэглэж түүдгээс асааж байлаа.

Өөрүүд бидний эргэн тойронд байна гэж бичтэл хойд зүгээс хашгиралт гарав. *Тэд хойд болон өмнө зүгээс зэрэг ирж байна. Илд, жад тэдний өмнө хүчгүйдэн зөвхөн гал зогсоож байна.*

- Харваад, харваад, харваад гэсэн хоолой цуурайтахад өөр нэг нь,

- Хараал идсэн том юм байна гэж хашгирч гурав дахь нь,

- Аварга биет! гэхэд дөрөв дэх хүн,

- Баавгай, баавгай! гэж ориллоо. Морь янцгаан, ноход хуцаж тэр гэхийн тэмдэггүй шуугиан дэгдэхэд Сэм дундаас нь хоолой ялган сонсож чадсангүй. Тэр нэг захианы араас нөгөөг нь бичлээ. *Үхсэн зэрлэгүүд, аварга биет өөр магадгүй баавгай биднийг хүрээлж байна.* Тэгтэл модонд илд хангинахад ганцхан зүйл илт байв. *Өөрүүд хэрмийг давлаа. Тулалдаан буудлын дотор явагдаж байна.* Тус бүртээ гартаа шатаж буй галтай мөчир барьсан арваад морьтой ахан дүүс түүний дэргэдүүр зүүн талын хана руу давхилдав. *Захирагч лорд Мормонт тэднийг галаар угтаж байна. Бид ялсан. Бид ялж байна. Бид эгнээнээ барьж байна. Бид замыг нь таслан Хана руу ухарч байна. Бид Нударган дээр занганд орлоо.*

Сүүдэрт цамхагын нэг хүн харанхуйгаас гуйвлан гарч ирээд Сэмийн хөлд унав. Тэр галын зах руу мөлхөн хүрэхээсээ өмнө үхлээ. *Гарз. Тулаанд гарз гарч байна. Бид хүмүүсээ алдлаа.*

Ер нь тэр яагаад Нударганы тулалдааныг санах ёстой юм бэ? Сэм юу ч санахыг хүссэнгүй. Үүнийг л биш шүү. Тэр хүчлэн ээж, охин дүү Талла, Крастерийн эдлэнгийн Гиллиг санахыг хичээлээ. Тэгтэл хэн нэгэн мөрнөөс нь сэгсэрч,

- Босоорой. Сэм чи энд унтаж болохгүй. Босоод цааш явах хэрэгтэй гэв.

Би унтаагүй байна. Би санаж байна.

- Цаашаа яв. Би зүгээр. Зүгээр л амрахыг хүссэн юм гэж хүйтэн агаарт уур савсуулан хэллээ.

- Босооч гэж Грэнний хоолой хахир сөөнгө дуугаар хэлэв. Тэр Сэмийн дээрээс бөхийхөд хар хувцас нь битүү цас болжээ. -

- Амарч болохгүй гэж Хөгшин баавгай хэлсэн. Чи үхнэ.

- Грэнн. Би үнэнээсээ хэвийн байна. Чи зүгээр л яв. Би жаахан амраад чамайг гүйцнэ гээд Сэм инээмсэглэв.

- Чи тэгэхгүй. Чи хөлдөх юм уу Өөрүүд чамайг авна. Сэм бос! гээд Грэнний битүү цан хучсан өтгөн хүрэн сахал хөгшин өвгөн шиг харагдуулав.

Тэднийг Хананаас явахын өмнөх шөнө Пип Грэннийг даажигнан айхад дэндүү тэнэг болохоор нь эргүүлд сонгосон гэж хэлжээ. Грэнн урдаас нь юуны тухай хэлж байгаагаа ч ойлголгүй амнаасаа хөөс сөхөртөл маргажээ. Тэр пагдгар бүдүүн хүзүүтэй хүчтэй болохоор сэр Аллисер Торн түүнийг "Бух гөрөөс" гэж дуудан Сэмийг "Ноён Гахай", Жоныг "Лорд Сноу" гэж дууддаг байсан ч Жоны ачаар Грэнн Сэмтэй үргэлж найрсаг харилцдаг байлаа. *Энэ зөвхөн Жоноос болсон. Хэрвээ Жон байгаагүй бол тэдний хэн ч надтай сайн харьцахгүй байсан.* Одоо Жон явж Хашгираа даваан дээр Коринтой хамт алга болж магадгүй үхсэн байх. Сэм түүний араас уйлсан ч нулимс нь хөлдсөн тул нүдээ арай ядан нээлттэй байлгалаа.

Тэдний дэргэд бамбар барьсан өндөр ахан дүү зогсоход гайхамшигтай нэг агшинд Сэмийн царайд дулаан илч мэдрэгдлээ.

- Түүнийг орхи. Явж чадахгүй бол дууссан гэсэн үг. Хүчээ өөртөө зориулан хадгал гэж тэр Грэннд хэлэв.

- Тэр босно. Түүнд зөвхөн туслах гар хэрэгтэй байгаа юм гэж Грэнн хариуллаа.

Нөгөө хүн таатай дулааныг өөртэйгээ авч одоход Грэнн Сэмийг хөл дээр нь татаж босгохыг хичээв.

- Энэ чинь өвдөж байна шүү дээ. Больж үз. Грэнн чи миний гарыг өвтгөөд байна. Үүнийгээ зогсоо гэж Сэм гонгинов.

- Чи дэндүү хараал идсэн хүнд юм байна гээд Грэнн гараа Сэмийн суган доогуур оруулан шуухитнан өргөж дээш босголоо. Тэгээд хормын дараа тавихад тарган хүү цасан дээр буцан суув. Грэнн түүнийг өшиглөхөд гуталд нь барьцалдсан хатуу цас хаа сайгүй үсчив.

- Босооч! Босоод алх. Чи явах ёстой гээд ахин өшиглөлөө.

Сэм хажуу тийшээ өнхөрч өшиглөлтөөс хамгаалан агийлаа. Тэр зузаан давхарласан хувцсан дундуураа өшиглөлтийг бараг мэдрэхгүй байсан ч өвтгөж байлаа. *Би Грэннийг нөхрөө гэж*

бодсон. Чи нөхрөө өшиглөх ёсгүй. Тэд намайг яагаад зүгээр орхиж болдоггүй юм бэ? Надад зөвхөн амралт хэрэгтэй тэгээд л боллоо. Амралт болон жаахан нойр тэгээд магадгүй үхнэ биз.

- Хэрвээ чи миний бамбарыг авбал би тарган хүүг авъя.

Гэнэтхэн тэр хүйтэн агаарт сэвхийтэл өргөгдөн аятай зөөлөн цаснаас хөндийрөв. Хэн нэгэн өвдөгнийх нь доогуур гар оруулж нуруугаар нь тэвэрчээ. Сэм толгойгоо өндийлгөн анивчин харахад навтгар хамар, жижигхэн хар нүд, өтгөн хүрэн сахалтай өргөн хэрцгий нүүр харагдав. Тэр энэ царайг урьд нь харж байсан ч хэн болохыг нь даруй санасангүй. *Пол. Бага Пол байна.* Бамбарын дулаанд нүдэнд нь барьцалдсан мөс хайлан урсав.

- Яасан дааж байна уу? гэж Грэнний асуух сонсогдов.

- Би урьд нь түүнээс ч хүнд тугал өргөж байсан. Би сүүг нь хөхүүлэхийн тулд түүнийг ээжид нь аваачиж өгсөн юм.

Бага Полийн алхаа тутамд Сэмийн толгой дээш доош бөнжигнөв.

- Зогсооч намайг доош нь тавь. Би жаахан хүүхэд биш. Би Шөнийн харуулын эр хүн. Намайг зүгээр л үхүүлээч гээд уйллаа.

- Чимээгүй, Сэм. Хүчээ гамна. Дүү нарынхаа тухай, мэйстер Эймон, дуртай хоолныхоо тухай бод. Хүсвэл дуу дуулсан ч болно гэж Грэнн хэлэв.

- Чанга уу?

- Зөвхөн толгойдоо.

Сэм олон дуу мэддэг ч алийг нь ч санах гээд чадсангүй. Толгойноос нь мөрүүд арилан оджээ. Тэр ахин уйллаа.

- Би ямар ч дуу мэдэхгүй, Грэнн. Би урьд нь мэддэг байсан ч санахгүй байна.

- Зүгээрээ чи санана. Хүн бүрийн мэддэг "Баавгай ба үзэсгэлэнт охин" байвал ямар байна. *Баавгай, баавгай, баавгай байжээ! Бүх бие нь хар хүрэн үсээр хучигдсан!*

- Үгүй, энэ л биш шүү гэж Сэм гуйлаа. Нударган дээр ямар ч арьс хөрсгүй ялзарсан биетэй нүцгэн баавгай мацан гарч иржээ. Тэр баавгайн тухай бодохыг хүссэнгүй.

- Дуу хэрэггүй. Гуйж байна, Грэнн.

- Тэгвэл хэрээнүүдийнхээ тухай бод.

- Тэд хэзээ ч минийх байгаагүй. *Тэд Захирагч лорд, Шөнийн харуулын хэрээ байсан.* Тэд Хар цамхаг, Сүүдэрт цамхагынх гэхэд Бага Пол хөмсөг зангидлаа.

- Чэтгт намайг Хөгшин баавгайн ярьдаг хэрээнүүдийн нэгийг авч болно гэсэн. Би түүнд зориулан хоол хадгалж байсан гээд толгойгоо сэгсэрлээ.

- Би мартчихаж. Би хоолоо нуусан газар үлдээчихэж гээд хэсэг зуур чимээгүй амнаасаа алхам тутамд цагаан уур савсуулан явснаа гэнэтхэн,

- Би чиний хэрээнүүдийн нэгийг авч болох уу? Зөвхөн ганцыг. Би хэрхэвч Ларкад идүүлэхгүй гэв.

- Тэд явчихсан. Намайг уучлаарай. *Өршөөгөөрэй*. Тэд Хана руу буцаад нисчихсэн гээд Сэм хэрээнүүдээ Харуулуудыг мориндоо мордох бүрэн дуу сонсогдоход суллажээ. *Хоёр удаа богино, нэг удаа урт дуу бол мориндоо мордох гэсэн үг*. Гэсэн ч Нударгыг орхих гээгүй л юм бол мориндоо мордох хэрэггүй байсан тул энэ нь тулалдаанд ялагдсан гэсэн үг байлаа. Ухаангүй айдас эзэмдэхэд Сэмийн чадах ганц зүйл тор онгойлгох явдал байлаа. Тэр сүүлчийн хэрээ цасан шуурган дунд нисэн одохыг хармагц бичсэн захиануудаа илгээхийг мартсанаа сая санав.

- Үгүй ээ, үгүй, үгүй гэж дуу алдлаа. Цас битүү хаялан бүрэн дуу хадав. Ахооо ахооо ахоооо гэж мориндоо, мориндоо, мориндоо хэмээн хашгирав. Сэм чулуун дээр хоёр хэрээ сууж байхыг хараад араас нь ухасхийсэн ч шувуунууд хуйлран шуурах цасан дунд залхуутайгаар эсрэг тал руу нисэн одов. Тэр нэгийг нь хамраасаа бөөн цагаан уур савсуулан хөөж хэрэмнээс арван футын зайд бүдэрч уналаа.

Үүний дараа санасан зүйл гэвэл царай болон хоолойд нь сум зоогдсон үхэгсэд чулууны цаанаас гарч ирснийг саналаа. Зарим нь гархин хуяг, зарим нь хувцасгүй шахам нүцгэн байсан бөгөөд ихэнхи нь зэрлэгүүд, цөөн хэд нь гандсан хар хувцастай байлаа. Сэм Сүүдэрт цамхагын нэг хүн үхдлийн цайвар гэдэс рүү нуруугаар нь гартал нэвт жадлахад ганхсанаа модыг нь урагш шувт татан харласан гараараа харуулын толгойг хуга мушгихад цус амаар нь сад тавихыг харлаа. Тэгэхэд анхны удаа өмдөндөө норгосон гэдэгтээ итгэлтэй байв.

Сэм зугтаж гүйснээ санаагүй ч тэгсэн бололтой учир нь дараагийн агшинд хөгшин сэр Отин Вайтерс хэсэг харваачдын хамт байгаа буудлын дундах гал руу очсон байв. Сэр Отин цасан дээр өвдөг сөгдөн эргэн тойронд дэгдэх самуун руу ширтэхэд эзэнгүй морь дэргэдүүр нь өнгөрөхдөө нүүр лүү нь өшиглөлөө. Харанхуй дахь сүүдэр лүү галт сум тавьж байсан харваачид үүнийг тоосонгүй. Сэм нэг үхдэл оногдон дөл дүрэлзэн шатахад ард нь арваад хүн болон баавгай бололтой том цагаан дүрс гарч ирэхийг харж удалгүй харваачдад сум үлдсэнгүй.

Тэгтэл морин дээр мордохдоо сэхээ оржээ. Энэ нь түүний морь биш бөгөөд яаж мордсоноо санасангүй. Магадгүй сэр Отиний нүүр лүү өшиглөсөн морь ч байж болох юм. Бүрэн дуу татсан хэвээр тэр морио чимээ гарсан зүг рүү давиран эргүүлэв.

Тулааны гүнд бужигнасан самуун дунд цас шууран шавхуурдаж хар далбаатай жад барьсан Долорус Эдд морин дээрээ суугаатай тааралдав.

- Сэм чи намайг сэрээж өгөөч? Би аймшигтай хар дарсан зүүд зүүдэлж байна гэж Эдд түүнийг хармагц хэллээ.

Энэ нь Анхны хүмүүсийн Нударгатай холбоотой сүүлчийн дурсамж байв. Хэдэн цагийн дараа тэр хагас нь унаатай хагас нь явган бусад амьд үлдсэн хүмүүсийн дунд чичирэн зогсч байв. Энэ зуур Нударгаас хэдэн милийн зайд холдсон бөгөөд яаж гэдгээ Сэм санасангүй. Дайвин хоол хүнс, тос, бамбар ачсан таван ачааны морь хөтөлж ирснээс гурав нь энд хүрчээ. Хөгшин баавгай ахин морь алдахгүйн тулд тэдний ачааг ахин хуваарилж, эрүүл хүмүүсийн морийг авч шархдагсдад өгөн алхагсдын эгнээг зохион байгуулж хоёр жигүүр болон ар талаас нь бамбарчдаар хамгаалуулжээ. *Надад хэрэгтэй зүйл гэвэл зөвхөн явах* гэж Сэм өөртөө хэлээд гэр лүүгээ хүрэх эхний алхамаа хийжээ. Гэсэн ч цаг хүрээгүй байхад амьсгаадан хоцорч эхлэв.

Одоо ч гэсэн тэд хоцорчээ. Сэм Пипийн Бага Полыг Харуулын хамгийн хүчтэй хүн гэж хэлснийг санах. *Тийм учраас намайг өргөж яваа байх.* Гэсэн ч цас гүнзгий газар гулгамтгай болохоор Полын алхаа богиносж эхлэв. Араас нь морьтой хэдэн хүн өнгөрөхөд шархадсан хүн Сэмийн зүг сонирхолгүй харлаа. Бамбар барьсан хүмүүс ч гэсэн өнгөрөв.

- Та нар ард хоцорч байна гэж нэг нь хэлэхэд,

- Хэн ч та нарыг хүлээхгүй, Пол. Гахайг үхсэн хүмүүст орхи гэж нөгөө нь зөвлөв.

- Тэр надад шувуу өгнө гэж амалсан гэж Бага Пол Сэмийг тэгж хэлээгүй хэр нь хэллээ. *Тэд минийх биш.* - Би гараас минь шиш тоншдог ярьдаг шувуутай болмоор байна.

- Дүүрсэн тэнэг гээд бамбартай хүн цааш явлаа.

Хэсэг хугацааны дараа Грэнн огцом зогсов.

- Бид ганцаар хоцорч. Би хүмүүсийн бамбарыг олж харахгүй байна. Арын хамгаалалт байгаа болов уу? гэж сөөнгө хоолойгоор хэлэв.

Бага Пол түүнд хариулсангүй. Том хүн хуухиран өвдөг сөгдөж гар нь Сэмийг цасан дээр зөөлөн тавихдаа чичирлээ.

- Би чамайг цааш нь авч явж чадахгүй нь. Авч явах байсан ч чадахгүй нь гээд агзасхийн чичирэв.

Модон дундуур салхи исгэрэхэд цас нүүр лүү нь пургилна. Аймшигтай хүйтэн байсан учир Сэмд нүцгэн байгаа мэт санагдав. Тэр бамбар хайн харсан ч тэднийхээс ондоо байхгүй болжээ. Энд зөвхөн Грэнний барьж явсан бамбарын дөл цайвар шаргалаар улалзан түүний цаана харанхуй байв. *Удахгүй энэ бамбар унтархад бид хоол хүнс, нөхөд, галгүй ганцаар үлдэнэ* гэж Сэм бодов.

Энэ нь буруу байлаа. Тэд ганцаар байсангүй.

Том ногоон харуул модны доод талын мөчир дээр тогтсон цас зөөлөн пүргэхэд Грэнн тэр зүг бамбараа сунган эргэлээ.

- Тэнд хэн байна? гэхэд харанхуйгаас морины толгой гарч ирэв. Сэм агшин зуур санаа амарсан ч морины биеийг хараад балмагдлаа. Цан хүүрэг биеийг нь гялалзсан хөлс шиг бүрхэж хатуу хар гэдэс дотор ангайсан хэвлийнээс нь унжжээ. Нуруун дээр нь мөс шиг цайвар морьтон байв.

Сэмийн амнаас гиншгэнэсэн авиа гарлаа. Тэр үхтлээ айсандаа өмдөндөө ахин шээхэд тэсгим хүйтэнд хөлдөх шахлаа. Өөрүүд эмээлээсээ гоолиг гулган буугаад цасан дээр зогсоход сүүн цагаан нимгэн илд барьсан байв. Хуяг нь хөдлөх тоолон долгиолон хөл нь шинэхэн орсон цасанд шигдсэнгүй.

Бага Пол урт иштэй сүхээ нуруунаасаа сугалав.

- Чи яагаад морийг ийм болгож байгаа юм? Энэ чинь Монигийн морь байна.

Сэм илдний бариулаа тэмтэчсэн ч хуй нь хоосон байсанд Нударга дээр хаяснаа хэтэрхий хожим санав.

- Эндээс холд! Холдохгүй бол шатаана шүү гээд Грэнн урагш алхан бамбараараа савлан чичилэв.

Өөрүүдийн илд цайвар цэнхэр сүүмэлзсэнээ Грэнн рүү цахилгаан шиг түргэн цавчлаа. Цэнхэр мөсөн илд дөлийг шүргэхэд Сэмийн чихэнд зүү шиг хурц чахраан сонсогдов. Бамбарын толгой хажуу тийш гүн цасанд унаад гал нь шажигнан унтрахад Грэнн богинохон модон саваа барин зогсож байв. Тэр үүнийгээ Өөрүүд рүү шидээд хараал тавихад, Бага Пол дайсан руугаа сүх барин ухасхийв.

Сэмийг амьдралдаа үзсэн бүх айдсаас илүү айдас эзэмдэв.

- Ээж минь өршөө. Аав хамгаалаач өө... өө гэж айсандаа хуучин бурхдыг мартан уйлагнаж хуруугаараа бүсэндээ зүүсэн хутганы бариул тэмтчин атгав.

Үхдлүүд удаан болхи байхад Өөрүүд салхинд хаялах цас шиг хөнгөн байлаа. Тэр Полын сүхнээс дуулгаа мяралзуулан бултаад болор илдээр Полын гархин хуягны төмөр цагаригийг шир ноос, яс арьс нэвт эргэлдэн цавчив. Илдний үзүүр нуруугаар нь ширхийн гарч ирэхэд Сэм Полын дуу алдан сүхээ унагахыг харлаа. Цоо хатгасан шархаар илдний үзүүрт цус уур савсаж том хүн алуурчиндаа хүрэхийг хичээсэн ч унахад хүндийн жинд нь Өөрүүдийн цайвар илд хуга үсрэв.

Одоо хөдөл. Уйлахаа болиод тулалд, нялх хүүхэд минь. Тулалдаач, хулчгар минь. Энэ бол эцгийнх нь болон Аллисер Торн, дүү Дикон, Растын хэлсэн үг байлаа. Хулчгар, хулчгар, хулчгар. Хэрвээ тэр үхдэл болвол үхэжсэн хөлдөө үргэлж тээглэн бүдэрч унадаг цайвар цагаан үхдэл болох эсэхээ гайхширан хийрхэн хөхрөв. Алив үүнийг хий, Сэм. Энэ Жон байсан болов уу? Гэхдээ Жон үхсэн. Чи үүнийг чадна зүгээр л хий. Сэм урагш бүдрэн ухасхийхдээ гүйхээс илүү унаж байгаага мэдрэн нүдээ анин хутгаа урдаа хоёр гараар атгалаа. Тэгтэл хөлийн дор мөс хагарах шиг тас хийх сонсогдон чих дөжрөм хахир чарлаан гарахад хоёр гараараа чихээ даран гуйвлан ухраад өгзөгөөрөө цасан дээр лагхийн суулаа.

Нүдээ нээх үед Өөрүүдийн хуяг хөл рүү нь урсаж хоолойд нь зоогдсон хар лууны шилэн хутгыг тойроод цайвар цэнхэр цус исгэрэн утаа савсаж байв. Тэр ясан цагаан гараараа хутгыг бариад угз татахад хуруунууд нь галт уулын шилэнд хүрсэн газар уур савслаа.

Сэм хажуу тийш нүдээ томруулан өнхрөхөд Өөрүүд жижгэрсээр хайлан алга болж арван агшинд

бие нь үгүй болж цагаан манан хуйлран ууршив. Ясны дор цайвар гялалзсан сүүн цагаан шил үлдсэн нь мөн хайлж байв. Эцэст нь зөвхөн лууны шилэн хутга уур савсуулан үлдэхэд Грэнн бөхийн авснаа доош унагалаа.

- Ээж минь ямар хүйтэн юм бэ.

- Галт уулын шил. Хүмүүс лууны шил гэж нэрлэдэг юм. Лууны шил. Лууны шил гээд Сэм дөрвөн хөллөн хөхөрлөө.

Грэнн түүнийг хөл дээр нь татан босгоод Бага Полын цээжин дээр чагнаж үзсэнээ нүдийг нь аниулж хутгаа ахин авлаа. Энэ удаад барих тэнхээтэй болсон байв.

- Чи наадахаа авч болно. Чи над шиг хулчгар биш гэж Сэм хэлэв.

- Өөрүүдийг алахаар хулчгар гээч гээд Грэнн хутгаар дээш зангав.

- Тийшээ модон дундуур хараач. Үүрийн ягаан гэрэл байна, Сэм. Үүр. Тэгэхээр энэ дорно зүг байх ёстой. Хэрвээ бид тэр зүг явбал Мормонтыг гүйцнэ.

- Чинийхээр болог гээд Сэм гутлаа модонд хавиран цасыг нь унагаснаа нөгөө хөлөө бас гүвлээ. - Би оролдоё гээд үрчийн гишгэснээ,

- Би хичээнэ ээ гээд ахин нэг алхлаа.

ТИРИОН

Лорд Тайвины бараан хүрэн улаан өнгийн хилэн цамцан дээр гарын дүрстэй алтан гинж гялалзана. Тайрелл, Рэдвайн, Рованы лордууд түүнийг орж очиход тойрон цугларав. Тайвин бүгдэнтэй нь ээлж дараалан мэндлээд Варистай хэдэн үг сольж, Их септоны бөгж, Серсейгийн хацар дээр үнсээд эрхэмсэг мэйстер Пациллтай гар барьж урт ширээний хойморт охин болон ах хоёрынхоо дунд хааны байрыг эзлэн суув.

Тирионд ширээний хөл дэх жинтүү тавьсан Пациллын хуучин суудал оногджээ. Эрхийг нь хассан Пацилл хааны суудалд сууж чадахгүй болсон одойгоос холхон шиг Серсейгийн дэргэд суужээ. Эрхэмсэг мэйстер хөлөө чирсэн араг яс шиг болж тахир бариултай таяг руугаа хүндээр бөхийн явах зуураа чичирэхэд урьд нь байсан сүрлэг сайхан цагаан сахлын оронд урт тахианы хүзүүн дээр нь цөөн хэдэн сахал өрвийжээ. Тирион түүн рүү гэмшсэн сэтгэлгүй харлаа.

Бусад хүмүүс болох буржгар хүрэн үс, буурал сор суусан өтгөн сахалтай бадируун махлаг лорд Мэйс Тайрелл, халзан толгойг нь шаргал туг үс эмжсэн бөгтөр мөртэй туранхай Арборын Пакстер Рэдвайн, сахлаа цэвэрхэн хуссан бахим хөлс нь гоожсон Алтан шугуйн лорд Матис Рован, эрүүндээ шингэн цагаан сахалтай эцэнхий их септон нар тарж сууцгаав. *Дэндүү олон шинэ царай дэндүү олон шинэ тоглогчид. Намайг орон дээр ялзран хэвтэж байх зуур тоглоом өөрчлөгдсөн ч хэн ч надад дүрмийг хэлсэнгүй* гэж Тирион бодов.

Лордууд эелдэг найрсаг байсан ч харц нь Тирионыг эрхгүй эвгүйцүүлэв.

- Таны гинж маш сайхан хийцтэй юм гэж Мэйс Тайрелл хөгжилтэй хэлэхэд лорд Рэдвайн толгой дохиод,

- Яг тийм. Хайгардены эрхэм лорд бид бүхэнд маш зөв хэллээ гэж туйлын баясгалантай хэлэв.

Үүнийгээ энэ хотын хүмүүст хэл. Рэнлигийн сүнсний тухай дуулж байгаа хараал идсэн дуучдад хэл гэж Тирион бухимдан бодов.

Авга ах Кеван элэгсэгээр хацар дээр нь үнсээд,

- Лансел чамайг хичнээн зоригтой байсныг хэлсэн, Тирион. Тэр чамайг маш өндөр үнэлсэн гэв.

Тэгсэн нь дээр байлгүй үгүй бол надад түүний тухай хэлэх хэдэн үг байгаа. Тирион хүчлэн инээмсэглээд,

- Миний үеэл дэндүү найрсаг ажээ. Түүний шарх эдгэж байгаа гэдэгт итгэж болох уу? гэхэд сэр Кеван хөмсөг зангидав.

- Заримдаа дээрдсэнээ зарим өдөр нь муудаад байгаа. Би түүнд санаа зовж байна, Тирион. Эгч чинь үргэлж шахам түүнийг эргэж сэтгэл санааг нь өргөн биеийнх нь төлөө зальбирдаг юм.

Гэхдээ тэр түүнийг амьд гарахын төлөө зальбирч байгаа юм болов уу эсвэл үхэхийн төлөө

зальбирч байна уу? Серсей үеэлээ ичгүүр сонжуургүй ашиглан орондоо оруулсан болохоор эцэг нь энд байхад Лансел хэрэггүй болсон учир бяцхан нууцыг нь эргэлзээгүй булшиндаа авч орно гэж найдсан биз. *Тэр түүнийг алахаар бодсон болов уу?* Гэвч өнөөдөр харахад Серсейгээс тийм хэрцгий зан гарна гэж огт сэжиглэхээргүй байлаа. Тэр лорд Тайреллтай Жоффригийн хуримын найрын тухай ярилцан дур булаам сээтэгнэж, лорд Рэдвэйнд ихрүүдийнх нь эр зоригийг тал засан магтаж, лорд Рованы уцаарыг инээд наадмаараа зөөлрүүлж, Их септонд шүтлэгтэй хүний дүр эсгэж байлаа.

- Бид хуримын бэлтгэл ажлын тухай хурлаа эхэлж болох уу? гэж тэр лорд Тайвиныг суудлаа эзэлмэгц асуухад,

- Үгүй. Дайны тухай ярья. Варис гэж эцэг нь хэлэв.

Тайган нялуун инээмсэглэлээ.

- Надад маш сайхан мэдээ байна, эрхэм лордуудаа. Өчигдөр үүрээр манай зоригт лорд Рэндилл Робетт Гловерийг Даскендэйлийн гадна талд тэнгист шахан занганд оруулсан байна. Хоёр тал хоёул хүнд хохирол амссан ч эцэст нь манай үнэнч хүмүүс давамгайлжээ. Сэр Хелман Толхарт мянган цэргийн хамт амь үрэгдсэн гэсэн мэдээ байна. Робетт Гловер үлдсэн цэргүүдээ дагуулан Харренхалын зүг эмх замбараагүй зугтахдаа замыг нь зоригт сэр Грегор таслана гэж өчүүхэн төдий ч төсөөлөөгүй биз.

- Бурхдын аврал бадраг! Хаан Жоффригийн агуу ялалт! гэж Пакстер Рэдвайн дуу алдав.

Жоффри үүнд юугаа хийсэн юм бэ? гэж Тирион бодлоо.

- Умардынхны хувьд хүнд цохилт болсон нь гарцаагүй ч Робб Старк үүнд оролцоогүй. Залуу чоно тулалдааны талбарт ялагдаагүй хэвээр байгаа гэж Чигчий хуруу хэлэв.

- Ер нь бид Старкийн үйл хөдлөл төлөвлөгөөний тухай юу мэдэх юм бэ? гэж Матис Рован ердийн мохоо зангаараа асуулаа.

- Тэр өрнө зүгт эзэлсэн шилтгээнээ орхин Риверран руу дээрэмдсэн олз омогтойгоо зугтсан. Манай үеэл сэр Давен Ланниспортод талийгаач эцгийнхээ армийн үлдэгдэл хүчийг эмхлэн цуглуулж байгаа. Тэднийг бэлэн болмогц Алтан шүдэнд байгаа сэр Форли Престертэй нийлэх юм. Старкийн хүүг умард руу хөдөлсөн даруй сэр Форли, сэр Давен хоёр Риверран руу уруудана гэж лорд Тайвин мэдээлэв.

- Та лорд Старкийг умард зүг явна гэдэгт итгэлтэй байна уу? Кайлины сувагт төмөр арлын хүмүүс байгаа шүү дээ? гэж лорд Рован асуухад Мэйс Тайрелл,

- Хаангүй хаант улс шиг утгагүй зүйл байдаг юм уу? Үгүй дээ хүү голын хөндийг орхин Рус Болтонтой хүчээ ахин нэгтгэж бүх хүчээ Кайлины суваг руу хаях нь тодорхой. Би түүний оронд байсан бол тэгэх байсан гэв.

Тирион үүнд хэлээ хазлаа. Робб Старк Хайгардены эзнийг хорьтой байх үеийнхээс илүү олон тулалдаанд ялсан байлаа. Тайреллийн алдар хүнд Роберт Баратеоныг Эшфордод ялсан ганц ялалтаар хязгаарлагдан үнэнийг хэлэхэд лорд Тарлигийн хошууч анги үндсэн хүчээ хүрэлцэн ирэхээс өмнө тулалдааны ихэнхийг ялжээ. Шуурганы адгийн бүслэлтэнд Мэйс Тайрелл захирч байсан ч жилийн турш ямар ч үр дүнгүй сунжран, Сэрээнд болсон тулалдааны дараа Хайгардены лорд Эддарт Старкад далбаагаа хүлцэнгүй бөхийлгөсөн билээ.

- Би Робб Старкад хатуухан үгтэй захиа бичнэ. Түүний хүн Болтон ямаагаа өргөөнд минь хашиж байгаа нь туйлын дэндсэн хэрэг байна гэж Чигчий хуруу хэлэв.

- Старкийн тухай гэснээс... Бэйлон Грэйжой одоо өөрийгөө Умард зүг болон арлуудын хаанаар зарлаад байгаа. Бидэнд холбоотон болох нөхцөл бичгээр санал болгосон гээд сэр Кеван Ланнистер хоолой заслаа.

- Тэр бидэнд үнэнч зүтгэлээ илэрхийлэх ёстой байсан юм. Өөрийгөө хаан гэж дуудах ямар эрхтэй юм гэж? хэмээн Серсей тас нясхийв.

- Байлдан дагуулагчийн эрх. Бэйлон хаан хуруугаараа Хүзүүг багалзуурдсан. Робб Старкийн залгамжлагчид үхэж Винтерфелл унан, төмөр арлынхан Кайлины суваг, Моттын гүн ой болон Чулуун эргийн ихэнхи газрыг барьж байгаа. Бэйлон хааны урт онгоцууд наран жаргах зүгийн тэнгисийг эзэгнэж Ланниспорт, Үзэсгэлэнт арал, Хайгарденд хүртэл занал учруулж байна гэж лорд Тайвин хэлэв.

- Тэгвэл бид түүнтэй холбоо тогтоохыг зөвшөөрөх үү? Тэр ямар нөхцөл санал болгосон юм? гэж лорд Матис Рован асуув.

- Бид түүнийг хаан болохыг зөвшөөрч Хүзүүнээс цааш умард хэсгийг бүхэлд нь өгөх ёстой гэж.

- Хүзүүнээс хойш хэсгийг ямар ухаантай хүн хүсэх юм бэ? Хэрвээ Грэйжой илд, онгоцоо чулуу, цасаар арилжихыг хүссэн юм тэгнэ л биз бидний хувьд азтай хэрэг байна гээд лорд Рэдвайн хөхөрлөө.

- Яг үнэн. Би ч гэсэн тэгэх байна. Биднийг Станнисийг дарах зуур Бэйлон хаан умардынхны учрыг олог гэж Мэйс Тайрелл дэмжив.

Лорд Тайвины царайд ямар ч сэтгэл хөдлөл илэрсэнгүй.

- Дээрээс нь бас Лайза Арриний бас учрыг олох ёстой. Жон Аррины бэлэвсэн эхнэр, Хостер Таллигийн охин, Кателин Старкийн дүү... нөхөр нь үхэхийн өмнө Станнис Братеонтой хуйвалдаж байсан.

- Өө, эмэгтэйчүүд дайнд зүрхгүй улс. Түүнийг байгаагаар нь орхивол бидэнд ямар ч төвөг удахгүй хэмээн Мэйс Тайрелл баяртай хэлэв.

- Би ч гэсэн зөвшөөрч байна. Хатагтай Лайза ямар ч талд орон урван тэрсэлсэн зүйл хийгээгүй

гэж Рэдвайн хэлэхэд Тирион өрвөлзөн,

- Тэр намайг гянданд чулуудаж амийг минь шаардсан шүүх хурал хийсэн. Түүнээс гадна Хааны газар тушаасан ёсоор Жоффод үнэнч зүтгэл илэрхийлэхээр ирээгүй. Эрхэм лордууд надад цэрэг өгвөл би Лайза Арриний учрыг олъё гээд түүнийг Серсейгийн хоолойг багалзуурдахаас ондоо ямар ч зүйл ингэтэл баярлуулахгүй байлаа. Зарим шөнө Тирион Эйригийн тэнгэрийн гянданг зүүдлэн хүйтэн хөлс цутган сэрдэг байв.

Мэйс Тайрелл зэвүүцлээ далдлан хөгжүүн инээмсэглэв.

- Магадгүй чи тулалдааны талбарт дайтахгүй байсан нь дээр биз. Чамаас хамаагүй дээр хүмүүс Сарны ууланд хамаг армия алдаж Цуст хаалганд хэмх цохиулж байсан. Бид чиний ямар шуухан болохыг мэдэх болохоор тийм хувь заяа хэрэггүй гэж Хайгардены лорд хэлэв.

Тирион дүрсхийн жинтүүнээсээ өндийсөн ч эцэг нь ярианд оролцлоо.

- Надад Тирионд өгөх ондоо даалгавар байгаа болохоор лорд Петайрд Эйригийн түлхүүр байгаа гэдэгт итгэлтэй байна.

- Өө, тэгэлгүй яахав. Хөлийн маань хооронд бий гээд Чигчий хуруугийн сааралдуу ногоон нүдэнд нь дүрсгүй өнгө тодров.

- Эрхэм лордууд зөвшөөрвөл би Хөндий рүү аялж хатагтай Лайза Арриний сэтгэл зүрхийг эзэмдэхэд бэлэн байна. Би түүний нөхөр болсноор Аррины хөндий та нарт дусал цус ч гарздахгүй ирнэ.

- Хатагтай Лайза чамайг хүлээж авах юм уу? гээд лорд Рован тээнэгэлзэнгүй харлаа.

- Тэр надтай урьд нь хэдэн удаа уулзахдаа гомдоллож байгаагүй юм даа, лорд Матис.

- Оронд орох бол хурим биш. Лайза Аррин шиг үнээ хүртэл ялгааг нь ойлгож байгаа гэж Серсей хэллээ.

- Тийм гэдэгт итгэлтэй байна. Би урьд нь Риверраны охинтой гэрлэхэд гарал угсаа минь зохицохгүй доогуур байсан. Харин одоо... Эйригийн хатагтай, Харренхалын лорд хоёрын хооронд зохицохгүй явдал байхгүй биз дээ? гээд Чигчий хуруу гараа дэлгэлээ.

Тирион Пакстер Рэдвайн болон Мэйс Тайрелл хоёр харц солилцохыг анзаарлаа.

- Энэ бүтэж болох юм. Хэрвээ чи эрхэм дээдэст эмэгтэйг үнэнч байлгаж чадвал гэж лорд Рован хэллээ.

- Эрхэм лордуудаа одоо намар ирсэн болохоор бүх хүний зүрх дайнд ядарч байна. Хэрвээ лорд Бэйлиш бидэнд Хөндийг энхийн замаар цус урсгалгүй авчирвал бурхад түүнийг гарцаагүй адислах болно гэж Их септон айлдав.

- Гэхдээ тэр чадах юм уу? Жон Аррины хүү одоо Эйригийн лорд болсон. Лорд Роберт гэж лорд Рэдвайн цохлоо.

- Ердөө хүүхэд. Би түүнийг Жоффригийн хамгийн үнэнч албат бидний нөхөр болгон өсгөх талаар санаа тавина гэж Чигчий хуруу хэллээ.

Тирион шовх үзүүртэй сахалтай үл ойшоосон сааралдуу ногоон нүдтэй гоолиг хүнээс харц салгасангүй. *Тэгэхээр Харренхалын лорд бол хоосон нэр хүнд юм биз дээ? Хараал ид, аав аа. Тэр хэзээ ч цайздаа хөл тавьж чадахгүй болохоор хэргэм зэргийг гэрлэлтэнд туслах талаар эхнээсээ мэдэж байж.*

- Бидэнд дайсан дутаагүй. Хэрвээ Эйриг дайнаас холхон байлгаж чадвал сайн хэрэг. Би хувьдаа лорд Петайрийг амжилттай биелүүлэхийг харахаас буцахгүй гэж сэр Кеван Ланнистер хэлэв.

Сэр Кеван дүүгийнхээ зөвлөлийн тэргүүн болохоор хэзээ ч лорд Тайвины толгойд ороогүй бодлыг хэлэхгүй гэдгийг Тирион урт хугацааны туршлагаараа мэдэж байв. *Энэ бүхнийг урьдаас бэлтгэсэн болохоор зөвөлгөөн бол ердөө үзүүлэх тоглолтоос хэтрэхгүй.*

Хонинууд хичнээн нямбай хяргуулж байгаагаа мэдэлгүй зөвшөөрөн майлсан бол Тирион эсэргүүцэв.

- Лорд Петайргүй бол титмийн өрийг яаж төлөх юм бэ? Тэр манай зоосны шидтэн болохоор бидэнд орлох хүн байхгүй гэхэд Чигчий хуруу инээмсэглэв.

- Миний бяцхан анд дэндүү сайхан сэтгэлтэй ажээ. Би ердөө Роберт хааны хэлдэг байсан шиг зоос тоолдог хүн. Ямар ч ухаалаг худалдаачин тэгж чадах байхад Ланнистерийн хувьд бол Кастерли Рокийн алтан хүрэлтэнд адислагдсан болохоор надаас хавьгүй давна гэдэг нь эргэлзээгүй.

- Ланнистер гэнэ ээ? гээд Тирионд таагүй мэдрэмж төрлөө.

Лорд Тайвины алтан очтой нүд хүүгийнхээ нийцээгүй нүдний харцтай тулгарав.

- Чамайг энэ үүрэгт гайхалтай тохирно гэж бодож байна.

- Тэгэх нь гарцаагүй! Би чамайг тун сайн зоосны эзэн болно гэдэгт эргэлзэхгүй байна, Тирион гэж авга ах сэр Кеван хэллээ.

Лорд Тайвин Чигчий хуруу руу эргэв.

- Хэрвээ Лайза Аррин чамайг нөхөр болгон авч хааны энхийг тогтоовол бид лорд Робертийн Дорнодыг хамааран захирагч цолыг сэргээнэ. Ингэхэд чи хэр түргэн явж чадах вэ?

- Салхины аяс таарвал маргааш гэхэд хөдөлнө. Одоо Бравосын "Лусын хаан" гэдэг сэлүүрт онгоц гинжийг өнгөрөөд ачаагаа ачиж байгаа. Би ахмадтай нь уулзан өрөө гаргаж өгөхийг гуйсан юм.

- Чи хааны хуриманд оролцож чадахгүй өнгөрөх нь гэж Мэйс Тайрелл хэлэв.

- Давалгаа, сүйт бүсгүй хоёр хэнийг ч хүлээхгүй, эрхэм лорд. Намрын шуурга эхэлвэл аялал аюултай болохоор живэх нь миний хүргэн хүүгийн увьдсийг байхгүй болгоно гээд Петаир Бэйлиш мөрөө хавчлаа.

- Яг үнэн. Чи саатахгүй гарсан чинь дээр гээд лорд Тайрелл хөхрөв.

- Бурхад аян замыг чинь ивээж хурд хайрлаг. Хааны газар даяар таны үйлс бүтэхийн төлөө зальбирна гэж Их септон хэллээ.

- Бид Грэйжойтой холбоо байгуулах хэрэгт эргэн орж болох уу? гээд Лорд Рэдвайн хамрын үзүүрээ чимхэв. - Миний бодлоор энэ олон талын ашигтай санагдаж байна. Грэйжойгийн урт онгоцууд манай флотыг ихэсгэн бидэнд Лууны цохио руу дайрч Станнис Баратеоны санаархлыг бут цохих хангалттай хэмжээний хүчтэй болох боломж өгнө.

- Бэйлон хааны урт онгоцууд бидэн шиг юу ч эзлээгүй. Грэйжой холбоотон болсны дүнд хаант улсын хагасыг шаардаж байгаа юм бол үүнийг хүртэх юу хийсэн юм бэ? Старкийнхантай байлдах уу? Тэр үүнийг хэдийн хийсэн. Бид яагаад түүнд биднээс чөлөөлөгдсөний төлөө хөлс төлөх ёстой гэж? Миний бодлоор Пайкийн лордод юу ч хэлэхгүй байсан нь дээр. Цаг нь болохоор бидэнд хаант улсын хагасыг шаардахаас илүү сонголт гарч ирнэ гэж лорд Тайвин эелдэгээр хэлэв.

Тирион эцгээ ойроос ажлаа. *Энд түүний хэлээгүй нэг л зүйл байна даа.* Тэр Кастерли Рокийн эрх шаарддаг шөнө лорд Тайвины бичиж байсан чухал захианы тухай саналаа. *Тэгэхэд юу гэж хэлсэн билээ? Зарим тулалдааныг илд, жадаар биш үзэж, хэрээгээр ялдаг гэсэн...* Тирион "илүү сонголт" гэдэг нь ямар төрлийн үнэ шаардахыг гайхлаа.

- Одоо хуримын тухай хэрэгт орцгооё гэж сэр Кеван хэлэв.

Их септон Бэйлорын их сүмд явагдаж байгаа бэлтгэл ажлын тухай ярихад, Серсей хуримын найр хийх дэлгэрэнгүй төлөвлөгөөний тухай ярихад. Тэд хаан ширээний өрөөнд мянган хүний зоог зохион байгуулахаас гадна түүнээс хавьгүй их хүнийг гадна найрлуулах аж. Хуримын найранд орж чадаагүй хүмүүст зориулан гадна болон дунд талын хашаанд торгон асар барьж хоол унд торхтой шар айраг сөгнөнө.

- Эрхэм дээдсээ зочдын тооны хувьд гэснээс... бидэнд Наран жаднаас хэрээ ирсэн. Биднийг хуралдаж байх зуур гурван зуун Дорнишийнхон Хааны газар луу ирж байгаа болохоор хуримнаас өмнө амжина гэж найдаж байна хэмээн эрхэмсэг мэйстер Пацилл хэлэв.

- Ирж байгаа гэдэг чинь юу гэж байгаа юм? Тэд миний газар дээгүүр гарах зөвшөөрөл асуугаагүй гэж Мэйс Тайрелл бувтнахад бүдүүн хүзүү нь улайхыг Тирион харлаа. Дорнишийнхон Хайгардентай хэдэн зууны турш хэзээ ч бие биендээ хайртай байсангүй болохоор хилийн хязгаар дээрээ тоо тоомшгүй дайтаж энхийн цагт ч гэсэн уулс, намгаар бие биенийхээ газар руу дээрэм хийнэ. Дорн долоон ханлигийн нэг хэсэг болсноор дайсагнал намдсан ч Улаан хорт могой гэж дууддаг Дорнишийн хунтайж Хайгардены залуу залгамжлагчийг тэмцээн дээр зэрэмдэг болгосноор ахин сэргэжээ. *Энэ ч ээдрээтэй хэрэг байна даа* гэж одой бодоод эцгийнхээ байр суурийг харахаар хүлээлээ.

- Дорнийн ханхүү миний хүүгийн урилгаар ирж байгаа. Тэр манай хуримын ёслолд оролцоод зогсохгүй зөвлөлийн суудал дахь байр сууриа эзлэн Робертийн няцааж байсан дүү Элиа нь хүүхдүүдийнхээ хамт алагдсан явдлыг шүүхээр ирж байгаа гэж лорд Тайвин тайван хэлэв.

Тирион Тайрелл, Рэдвайн, Рованы лордуудын царайг харж энэ гурвын аль нь "Гэхдээ лорд Тайвин та л Робертод тэдний биеийг Ланнистерийн нөмрөгөөр ороон үзүүлсэн биз дээ?" гэж хэлэх эсэхийг цэгнэлээ. Гэвч тэдний хэн ч хэлж зүрхэлсэнгүй царай нь илхэн байв.

Рэдвайн тоосонгүй ч, Рован амандаа алчуур чихүүлсэн юм шиг харагдаж байна.

- Хаан Маржэйритэй чинь гэрлэхэд Мирцелла ханхүү Тристэйнтэй гэрлэж бид нэгэн том овог болно. Дайсагналаа хойш тавих цаг болсон гэж бодохгүй байна уу, эрхэм лорд? гэж сэр Кеван Мэйс Тайреллд сануулав.

- Энэ бол миний охины хурим болохоос биш... гэхэд,

- ...дээрээс нь миний ч гэсэн ач хүүгийнх. Хуучны маргаан сөхөж байх газар биш гэж лорд Тайвин хатуу таслав.

- Би Доран Мартеллтай маргаан хийх гээгүй байна. Хэрвээ тэр Ричийг тайван туулахыг хүссэн бол надаас зөвхөн зөвшөөрөл асуухад болох байсан гэж лорд Тайрелл шаардангуй хэлэхэд дууны өнгө нь илүү дургүйцсэн байлаа.

Өчүүхэн ч боломж байхгүй. Тэр Ясан жим рүү өгсөөд дорно зүг Зуны өргөөний ойролцоо эргэж Хааны зам руу гарч ирнэ гэж Тирион бодлоо.

- Гурван зуун Дорнишийнхон манай төлөвлөгөөнд саад учруулахгүй. Бид цэргүүдийг нь хашаанд хооллож, хаан ширээний өрөөнд хэдэн сандал шахаж тавиад лорд, язгууртан гаралтай хүлэг баатруудыг нь суулгаж, хүндэтгэлийн тавцан дээр Доран ханхүүд байр олоход болно гэж Серсей хэлэв.

Миний л дэргэд биш шүү гэсэн үгийг Тирион Мэйс Тайреллийн нүдэнд харсан ч Хайгардены эзэн үг дуугарсангүй товч толгой дохив.

- Одоо бид илүү таатай даалгаварт шилжиж болох юм. Ялалтын үр жимс хуваахыг хүлээж байна гэж лорд Тайвин сануулав.

- Үүнээс илүү амттай зүйл юу байх билээ? гэж хэдийн өөрийнхөө жимс болох Харренхалыг залгисан Чигчий хуруу хэллээ.

Лорд болгон өөрийнхөө шаардсан энэ ч шилтгээн тэр ч тосгон, газар нутаг, бяцхан гол горхи, ой тайга, тулалдаанд эцэггүй үлдсэн хүүхдүүдийг хүмүүжүүлэх эрхээ авлаа. Азаар эдгээр үр жимс хангалттай байсны дээр шилтгээн болгонд өнчин хүүхэд байлаа. Варис жагсаалт гаргажээ. Дөчин долоон доогуур гаралтай лорд, зургаан зуун арван есөн хүлэг баатар болон хэдэн мянган ердийн цэрэг Станнисийн Гэрлийн эзний галт зүрхний дор амиа алджээ. Тэдний залгамжлагч төрөл

төрөгсөд урвагч болсон болохоор газар нутаг, цайз эзэмших эрхээ алдаж үнэнчээ баталсан хүнд үлдэж байв.

Хайгарден хамгийн өгөөмөр ургац хураав. Тирион Мэйс Тайреллийн бүдүүн гэдэс рүү харан хаанаас ийм их хоолны дуршил гарч байгааг бодлогоширов. Лорд Тайрелл эхэндээ Рэнлиг дагаж байгаад дараа нь Станнисийг дэмжсэн өөрийнхөө тугчин Алестер Флорентийн газар нутаг, шилтгээнийг шаардав. Лорд Тайвин хүслийг нь биелүүлэхэд Брайтвотерийн шилтгээн бүх газар нутаг, орлогын хамт лорд Тайреллийн хоёр дахь хүү сэр Гарланд шилжиж нүд ирмэхийн зуур түүнийг том лордын нэг болгов. Түүний ууган ах мэдээж Хайгарденyг өв залгамжлах байлаа.

Лорд Тарли, хатагтай Окхарт, лорд Хайтауэрийг хойш тавиад арай жижиг газрууд лорд Рованд оногдов. Лорд Рэдвайн Арборын хамгийн сайн дарс үйлдвэрлэдэг Чигчий хуруу тэр хоёрын байгуулсан үйлдвэртээ гучин жил татвараас чөлөөлөх хөнгөлөлт гуйв. Үүнийг нь зөвшөөрөхөд сэтгэл ханаснаа мэдэгдэж Арборын торх алтан дарс авчруулан Жоффри хаан болон өгөөмөр сэтгэлт Гарынх нь төлөө хундага өргөхийг санал болгоход Серсейгийн тэвчээр алдагдлаа.

- Жоффрид илд хэрэгтэй болохоос биш хундага биш. Түүний хаант улс булаан эзлэгч өөрийгөө хаан хэмээн өргөмжлөгчдийн тахалд дарагдсан хэвээр байна гэж зандрав.

- Гэвч удахгүй гэж найдаж байна хэмээн Варис нялуун хэлэв.

- Одоо хэдхэн зүйл үлдлээ, эрхэм лордуудаа гээд сэр Кеван цаасаа харж, - Сэр Аддам Их септоны титмээс алдагдсан болрын хэсгийг олсон. Хулгайчид болрыг сугалж алтыг нь хайлуулсан зайлшгүй гэв.

- Манай дээд тэнгэрийн Эцэг тэдний гэм нүглийг мэдэж байгаа болохоор бүгдийг нь шүүлтийн суудалд суулгах биз гэж Их септон шүтлэгтэй хүний ёсоор мэдэгдэв.

- Түүнийг тэгнэ гэдэгт эргэлзэх юмгүй. Гэсэн ч ялгаагүй чи хааны хурим дээр титэмтэй байх ёстой. Серсей алтны дархнуудаа дуудаж орных нь титмийг хийлгэнэ биз гээд лорд Тайвин хариу хүлээлгүй Варис руу эргэв.

- Чамд ондоо мэдээлэл байна уу?

Тайган ханцуйнаасаа цаас сугаллаа.

- Хурууны ойролцоо аварга наймаалж үзэгджээ гээд хөхөрч, - Та нарын бодсон шиг Грэйжой биш жинхэнэ аварга наймаалж. Тэр Иббенсийн халим агнуурын хөлөг рүү дайрч усан доогуур авч орсон байна. Чулуун гишгүүр дээр байлдаан өрнөн Тайрош, Лисийн хооронд шинэ дайн дэгдэж хоёул Миртэй холбоотон болгоно гэж найдаж байгаа. Хаш тэнгисээс буцаж ирсэн далайчид Картад гурван толгойтой луу төрж хотын гайхлыг төрүүлсэн гэсэн... гэхэд,

- Толгойных нь тоо хэд байсан ч хамаагүй луунууд, аварга наймаалжууд миний сонирхлыг татахгүй байна. Чиний шивнэгчид миний ач хүүгийн ул мөрийг гаргаагүй юм болов уу? гэж лорд Тайвин асуув.

- Халаг гэж манай хайрт Тайрек ул мөргүй алга болжээ, хөөрхий залуу гэж Варис нулимс унагах шахам хэлэхэд лорд Тайвиныг дургүйцлээ илэрхийлж амжихаас нь өмнө сэр Кеван,

- Тайвин тулааны үеэр алтан нөмрөгтөнгүүдийн алга болсон нэг хэсэг хуаран руугаа ахин зүтгэх найдлага өвөрлөн эргэн иржээ. Сэр Аддам тэднийг яахыг мэдэхийг хүсч байна гэв.

- Тэдний хулчгар зан Жоффод аюул учруулж болзошгүй. Би тэдэнд үхэл оноохыг хүсч байна гэж Серсей тэр дор нь хэлэв.

- Тэд гарцаагүй үхлийг хүртэх тавилантай, эрхэм дээдсээ. Хэн ч үүнийг няцаахгүй. Гэсэн ч бид тэднийг Шөнийн харуул руу илгээвэл ухаалаг хэрэг болохсон. Сүүлийн үед Хананаас түгшүүртэй мэдээ ирэх болсон. Зэрлэгүүд хөдөлгөөнд орж... гээд Варис санаа алдав.

- Зэрлэгүүд, наймаалж, луунууд. Хөдөлгөөнд ороогүй зүйл ер нь байна уу? гээд Мэйс Тайрелл инээд алдав.

Лорд Тайвин үүнийг үл тоомсорлолоо.

- Оргон зайлагчид хичээл суралцах ёстой. Тэдний өвдгийг алхаар хуга цохь. Тэгвэл ахиж зугтахгүй болно. Гудамжинд гуйлга гуйхыг нь харсан өөр ямар ч хүн үүнийг хүсэхгүй биз гээд ширээний дагуу үл зөвшөөрсөн хүн байгаа эсэхийг харлаа.

Тирион урьд нь Ханан дээр очихдоо хөгшин лорд Мормонт болон албаны хүмүүстэй нь наймаалж хуваалцан идсэнээ саналаа. Түүнчлэн Хөгшин баавгайн айдсыг ч гэсэн санаж байв.

- Магадгүй бид сэр Жаселинийг алсан хэдэн хүмүүсийн өвдгийг хугалаад үлдсэнийг нь Марш руу илгээсэн дээр байхаа. Харуулд хүний тоо хүрэлцээгүй байгаа. Хэрэв Хана унавал...

- ...зэрлэгүүд умард руу сад тавьж Старкийнхан, Грэйжойгийнхон шинэ дайсантай болно гэж аав нь төгсгөв.

- Тэд Төмөр хаан ширээний албат байхыг хүсэхгүй байгаа болохоор хаан ширээнээс тусламж хүлээх ямар хэрэгтэй гэж? Робб хаан, Бэйлон хаан хоёул умардыг захирах эрхээ тунхагласан. Тэгвэл чаддаг юм бол хамгаалаг л дээ. Хэрвээ үгүй бол Манс Райдер илүү ашигтай холбоотон болж болох юм гээд лорд Тайвин ах руугаа ширтэн,

- Өөр зүйл байна уу? гэхэд сэр Кеван толгой сэгсрэв.

- Бүх зүйл дууссан. Эрхэм лордуудаа эрхэм дээдэс Жофрри хаан эргэлзээгүй та бүхний цэцэн ухаан мэргэн зөвөлгөөнд талархах бизээ.

- Би хүүхдүүдтэйгээ хэдэн үг сольмоор байна. Таньтай ч гэсэн, Кеван гэж лорд Тайвин бусад хүмүүсийг босоход хэллээ.

Үлдсэн зөвлөлийнхөн дуулгавартай үгийг нь дагалдав. Варис түрүүлж гарахад, Тайрелл болон Рэдвайнийхан араас нь дагалаа. Өрөө хоосорч дөрвөн Ланнистер үлдэхэд сэр Кеван хаалга хаав.

- Зоосны эзэн гэнэ ээ? Энэ хэний санаа болохыг мэдэж болох уу? хэмээн Тирион нарийхан хүчилсэн хоолойгоор асуув.

- Лорд Петайрийнх. Гэвч эрдэнэсийн сан Ланнистерийн гарт шилжиж байгаа болохоор энэ нь сайн хэрэг. Чи чухал ажил даалгахыг гуйсан. Энэ даалгаварыг биелүүлж хүчрэхгүй гэж эмээж байна уу? хэмээн эцэг нь хэлэв.

- Үгүй л дээ. Зөвхөн занганаас айж байна. Чигчий хуруу зальжин нэр төрд дуртай. Би түүнд итгэхгүй байна. Таньд ч гэсэн тэгж зөвлөхгүй гэж Тирион хэлэхэд,

- Тэр Хайгарденыг манай талд оруулж... гэж Серсей эхэллээ.

- ...Нэд Старкийг чамд худалдсаныг мэдэж байна. Тэр биднийг түргэхэн зарна. Буруу гарт орсон зоос илднээс дутуугүй аюултай гэхэд авга ах Кеван нь хачирхан ширтэж,

- Бидэнд биш гэдэгт итгэлтэй байна. Кастерли Рокийн алт...

- ...газрын хөрснөөс ухааж гаргадаг. Харин Чигчий хуруугийн алт агаарт хуруугаа инчдэхэд бий болдог.

- Чинийхээс хамаагүй ашигтай чадвар, дүү минь гэж Серсей хорон санаатай найрсаг дуугаар хэлэв.

- Чигчий хуруу бол худалч...

- ...дээрээс нь хоёр хар хэрээ бие биенийгээ хэлдэг шиг тас хар гэхэд лорд Тайвин гараараа ширээр алгадлаа.

- Хангалттай! Би та хоёрын маргааныг цааш сонсмооргүй байна. Та хоёр Ланнистер болохоор биеэ зохистой авч яв гэхэд сэр Кеван хоолой засав.

- Надад хатагтай Лайзагийн ямар ч сүйт залуугаас илүү Петайр Бэйлиш Эйриг захирсан нь дээр санагдаж байна. Йон Ройс, Лин Корбрэй, Хортон Рэдфорт нар бол нэг нь нэгнээсээ дутахгүй аюултайн дээр бардам хүмүүс. Чигчий хуруу ухаалаг ч язгууртан гарал, зэвсгийн чадвар байхгүй болохоор Хөндийн лордууд хэзээ ч түүнийг эзнээрээ хүлээн авахгүй байж магадгүй гээд дүү рүүгээ харахад лорд Тайвин руу харахад толгой дохисонд үргэлжлүүлэв.

- Үүнээс гадна лорд Петайр үргэлж үнэнчээ илэрхийлсээр ирсэн. Зөвхөн өчигдөр гэхэд тэр бидэнд Тайреллийнхан Санса Старкийг Хайгарденд зочлуулах нэрийдлээр лорд Мэйсийн ууган хүү Вилластай гэрлүүлэх гэж байгаа хуйвалдааны тухай хэлсэн.

- Чигчий хуруу хэлсэн гэнэ ээ? Манай шивнэгчдийн тэргүүн биш юм биз дээ? Ямар сонирхолтой юм бэ? гээд Тирион ширээ руу тонгойв.

Серсей авга ах руугаа үл итгэн харлаа.

- Санса бол миний барьцааны хүн. Тэр хаашаа ч миний зөвшөөрөлгүй явахгүй.

- Лорд Тайрелл хүсвэл чи дуртай ч дургүй ч зөвшөөрөх болно доо. Түүнд татгалзах нь бидний итгэхгүй байгаа гэсэн үг болохоор өөрийгөө доромжлогдсонд тооцно гэж эцэг нь тодотгов.

- Тэгнэ л биз. Бидэнд ямар хамаатай юм?

Дүүрчихсэн мулгуу гэж Тирион бодлоо.

- Хонгор эгч минь Тайреллийг гомдоох нь Рэдвайн, Тарли, Рован, Хайтауэрийг гомдоож байна гэсэн үг. Магадгүй тэд Робб Старк илүү хүсэлд нь нухацтай хандана хэмээн бодож эхлэнэ гэж тэвчээртэйгээр тайлбарлав.

- Би сарнайг зэрлэг чонотой дэр нэгтгэхийг хүсэхгүй байна. Бид түүнээс урьтаж хөдлөх ёстой гэж лорд Тайвин хэлэв.

- Яаж? гэж Серсей асуулаа.

- Гэрлэлтээр. Чи гэсэн хамт гэрлэнэ.

Гэнэтийн үгэнд Серсей гайхширсанаа хацар нь алгадуулсан мэт улайв.

- Үгүй. Ахин биш шүү. Би нөхөрт гарахгүй.

- Эрхэм дээдсээ та залуухан эмэгтэй болохоор үзэсгэлэнтэй үр хүүхэд төрүүлэх чадвартай хэвээр байгаа. Үлдсэн амьдралаа ганцаар туулахыг хүсэхгүй байгаа биз дээ? Шинэ гэрлэлт энэ бүх цус холилдсон тухай яриаг дарна гэж сэр Кеван эелдэгээр хэлэв.

- Чамайг хэр удаан гэрлэхгүй байх тусам Станнис бузар гутгэлгээ тараах болно. Чи шинэ нөхөрт гарч хүүхдүүдийг нь төрүүлэх ёстой гэж лорд Тайвин охиндоо хэллээ.

- Надад гурван хүүхэд хангалттай. Би Долоон ханлигийн Эрх баригч хатан болохоос үржлийн гүү биш!

- Чи миний охин болохоор тушаасныг маань хийх болно.

- Би иймэрхүү зүйл сонсон энд суухыг хүсэхгүй байна гээд Серсей бослоо.

- Хэрвээ чи хүсвэл гэрлэх нөхрийнхөө талаар саналаа хэлж болно гэж лорд Тайвин тайван хэлэв.

Серсей эргэлзсэнээ буцаж суухад Тирион чанга дуу алдсаныг нь үл харгалзан ялагдсаныг нь мэдэв.

- Би ахин гэрлэхийг хүсэхгүй байна!

- Чи гэрлэж хүүхэд төрүүлнэ. Чамаас төрсөн хүүхэд бүр Станнисийг илүү худалч болгоно гээд эцэг нь сандалтай нь хадах шахам цоо ширтэж,

- Мэйс Тайрелл, Пакстер Рэдвайн, Доран Мартелл нар насаа уртасгахын тулд залуу эмэгтэйтэй дуртайяа гэрлэнэ. Бэйлон Грэйжойгийн эхнэр нас дээр гарсан болохоор тийм гэрлэлт биднийг төмөр арлуудтай холбоотон болоход туслах ч би энэ алхам хийх талаар итгэлгүй байна гэв.

- Үгүй. Үгүй, үгүй, үгүй гэж Серсей жимийсэн уруулынхаа завсраар хэлэв.

Тирион эгчийгээ Пайк руу явуулах тухай бодолд уруулынхаа завсар түсхийх инээдээ арай ядан барилаа. *Зөвхөн үүнийг л өгөөч гэж мөргөх байна ариун бурхад минь надад ийм бэлэг хайрлаач.*

- Оберин Мартел чамд илүү таарч болох ч Тайреллийнханд дургүй. Иймээс бид хөвгүүдийг ч гэсэн авч үзэх ёстой. Чи татгалзахгүй бол гэрлэх хүнээрээ залуу хүн сонгож болно гэж лорд Тайвин үргэлжлүүлэв.

- Би ямар ч хүнтэй гэрлэхээс татгалзаж байна...

- Би Рэдвайны ихрүүд, Теон Грэйжой, Квентин Мартелл болон бусад хүмүүсийн тухай бодож үзсэн. Гэвч манай Хайгардентай тогтоосон илдийн холбоо Станнисийг сулруулсан. Үүнийг илүү бэхжүүлэх хэрэгтэй. Сэр Лорас цагаан болж сэр Гарлан Фоссовэйн нэгтэй гэрлэсэн болохоор тэдний Санса Старктай гэрлүүлэхээр төлөвлөж байсан ууган хүү нь үлдсэн.

Виллас Тайрелл. Тирион Серсейгийн өгүүлэшгүй хилэнд автахыг мэдрэн баясаж,

- Тэр ч тахир дутуу хүү дээ гэхэд эцэг нь түүн рүү хүйтнээр харав.

- Виллас бол Хайгардены залгамжлагч бүх мэдээнд түүнийг номхон дөлгөөн зантай ном уншиж, од ширтэх дуртай залуу гэж бичсэн байсан. Тэр бас амьтны үүлдэр үржүүлэх дуртай болохоор долоон ханлигт хамгийн сайн ноход, харцага, морьдтой.

Төгс зохицол. Серсей бас үүлдэр үржүүлэх дуртай гэж Тирион бодлоо. Тэр хөөрхий Виллас Тайреллийг өрөвдсөн ч эгчийгээ уйлах инээх эсэхийг мэдсэнгүй.

- Миний сонголт бол Тайреллийн залгамжлагч ч хэрвээ чи өөр хүнийг эрхэмлэж байвал шалтгааныг чинь сонсоё гэж лорд Тайвин яриагаа дуусгав.

- Таны зүгээс ямар эелдэг хэрэг вэ, аав аа. Та надад маш хүнд сонголт өглөө. Би удахгүй хөгшин наймаалж, тахир дутуу нохойтой хүү хоёрын нэгтэй гэрлэх нь байна. Надад бодох хэдэн өдөр хэрэгтэй. Би явж болох уу? гэж Серсей мөс шиг хүйтнээр хэлэв.

Чи бол хатан шүү дээ. Тэр л чамаас зөвшөөрөл асуух ёстой гэж Тирион хэлэхийг хүслээ.

- Явж болно. Чамайг тайвширсан хойно энэ тухай дараа ахин ярилцъя. Үүргээ санаарай гэж эцэг нь хэллээ.

Серсей өрөөнөөс хөшүүн гарахад уур хилэн царайд нь илхэн байлаа. *Гэвч эцэст нь тэр эцгийнхээ даалгасан зүйлийг хийх хойно.* Тэр үүнийг Роберт дээр баталсан билээ. *Ер нь бол бас Жэйми байсан юм.* Серсейг анхны удаа гэрлэх үед ах нь хавьгүй залуу байсан болохоор хоёр дахь

гэрлэлтийг амар зөвшөөрөхгүй байж магадгүй. Золгүй Виллас Тайрелл гэнэтхэн гэдсэндээ илд дүрүүлвэл Хайгарден болон Кастерли Рокийн хооронд ямар гашуун холбоо тогтох бол. *Би энэ тухай ямар нэг зүйл хэлэх ёстой ч юу гэж? Намайг өршөө аав аа. Гэвч тэр манай ахтай гэрлэхийг хүсч байгаа гэх үү.*

- Тирион гэхэд тэр инээмсэглэв.

- Би зарчийн намайг жагсаалтанд оруулсныг сонссон билүү?

- Чиний янхандалт сул дорой болгож. Гэвч зарим буруу нь минийх. Чамайг хөвгүүнээс өндөргүй болохоор би нас бие гүйцсэн эр хүнд хэрэгтэй зүйлийг мартаж. Чамайг аль эрт гэрлүүлэх ёстой байсан юм.

Би урьд нь хэдийн гэрлэсэн гэдгийг та мартаа юу? Тирионы ам татвалзахад инээд архираан холилдсон авиа гарлаа.

- Гэрлэлтийн төлөв чиний инээдийг хүргээд байна уу?

- Би зүгээр л хэр үзэсгэлэнтэй хүргэн болохоо төсөөлсөн юм гээд чухамдаа эхнэр түүнд хэрэгтэй байв. Хэрвээ тэр түүнд газар нутаг, шилтгээн авчирвал Серсей, эцэг болон Жоффригийн ордноос хол тайван байх байлаа.

Нөгөө талаар Шэйгээс болж байв. *Тэр өөрийгөө миний эмэгтэй гэж хэлсэн ч үүнд дургүйцнэ.*

Гэвч эцэг нь үүнийг авч хэлэлцэхгүй тул Тирион суудалдаа өндийн,

- Та намайг Санса Старктай гэрлүүлэх гээ юу. Тайреллийнхны охинд хандсан хандлагыг доромжлоод уу? гэж асуув.

- Лорд Тайрелл Жоффригийн хурим өнгөрөх хүртэл Старкийн охины тухай яриа цухуйлгахгүй. Хэрвээ Санса өмнө нь гэрлэвэл тэр бидэнд санаагаа хэлээгүй байж хэрхэн гомдох болж байна?

- Яг зөв хэрвээ тэр эгдүүцсэн хэвээр байвал бид Серсейгийн Вилластай хийх гэрлэлтээр тайтгаруулна гэж сэр Кеван хэллээ.

Тирион хамрынхаа мухрыг үрчив. Сорви нь заримдаа тэсэхийн аргагүй загатнадаг байлаа.

- Эрхэм дээдэс Сансагын амьдралыг эцгийнх нь үхлээс хойш там болгон хувиргасан байхад эцэст нь түүнийг Жоффригоос ангижирсан хойно надтай гэрлүүлэх гэж байдаг. Энэ таньд хүртэл хэрцгий санагдахгүй байна уу, аав аа?

- Яасан чи бас түүнтэй муухай харьцах гээ юу? гэж эцэг нь сэтгэл зовсноос илүү сонирхсон байртай асуув. - Охиныг жаргалтай байлгах бол миний зорилго бишийн дээр чинийх ч байх ёсгүй. Хэдийгээр бидний өмнө зүгтэй тогтоосон холбоо Кастерли Рок шиг хатуу ч үлдсэн умард зүгийн хувьд бол ялах түлхүүр нь Санса Старк байгаа юм.

- Тэр ердөө хүүхдээс илүүгүй.

- Эгч чинь түүнийг цэцэглэсэн гэсэн. Хэрвээ тийм бол дэр нийлүүлэх насанд хүрсэн гэсэн үг. Чи түүний охин насыг авбал ямар ч хүн гэрлэлт төгс болоогүй гэж хэлэхгүй. Үүний дараа чи эр нөхрийн үүргээ биелүүлэхийн тулд түүнтэй ахин дэр нэгтгэх хүртлээ ахин нэг хоёр жил хүлээж болно.

Таны юу ч гэж хэлсэн бай хамаагүй Шэй надад хэрэгтэй хүүхэн болохоос биш Санса шиг охин биш.

- Хэрвээ таны зорилго түүнийг Тайреллийнханд алдахгүй байх явдал юм бол яагаад ээж рүү нь буцааж болохгүй гэж? Магадгүй үүнд Робб Старк өвдөг сөгдөх ч юм билүү гэхэд лорд Тайвин зэвүүцэл дүүрэн ширтлээ.

- Түүнийг Риверран руу илгээвэл ээж нь хүүгийнхээ Сэрээний холбоог бэхжүүлэхийн тулд Блэквуд юм уу Маллистерийн хүүтэй гэрлүүлнэ. Умард зүг рүү илгээвэл сар хүрээгүй байхад Мандерли юм уу, Амбертай гэрлэнэ. Энд ордонд ч гэсэн байлгахад аюулгүй биш болохыг Тайреллийнхан баталлаа. Тэр аль болох түргэн Ланнистертай гэрлэх ёстой.

- Санса Старктай гэрлэх хүн Винтерфеллийг түүний нэрийн өмнөөс эзэмшинэ. Энэ чиний санаанд орсонгүй юу? гэж авга ах Кеван нь хэлэв.

- Хэрвээ чи охиныг авахгүй юм бол бид үеэлүүдийн чинь нэгд өгч болох юм. Кеван Ланселд гэрлэх хүч байгаа болов уу? гэхэд сэр Кеван эргэлзлээ.

- Хэрвээ бид охиныг түүний орны дэргэд аваачвал үг хэлж магадгүй ч гэрлэх тухайд бол үгүй байх. Би түүнд ихрийн нэгийг санал болгомоор байгаа ч Старкийнхан хоёуланг нь Риверранд хорьж байгаа. Түүнд Женнагын хүү Тион илүү зохицох байсан юм.

Тирион тэдний ярианд оролцолгүй Санса Старкийн тухай гүн бодолд автлаа. Зөөлөн яриа урьхан инээмсэглэлтэй торго дурдан, дуу, эр баатрын дууль, өндөр зоригт царайлаг хүлэг баатард дуртай Санса. Тэр ахин хөлийн дор онгоцны тавцан савлан хөдлөхийг мэдэрлээ.

- Чи надаас тулалдаанд байгуулсан гавъяаныхаа төлөө шан гуйсан. Энэ чиний боломж болохоор авсан чинь дээр шүү, Тирион гэж лорд Тайвин хүчээр сануулаад хуруугаараа ширээ тэвчээргүйхэн бөмбөрдөж, - Би урьд нь ахыг чинь Лайза Таллитай гэрлүүлэх гэж байсан ч Эйрис Жэймиг гэрлэлтээс өмнө хааны хамгаалалтанд авсан. Би тэгэхэд лорд Хостерд Лайзатай оронд нь чамайг гэрлүүлэхийг санал болгосон ч тэр охиндоо хагас биш бүтэн хүн хүсч байна гэсэн.

Тиймээс л тэр түүнийг өвөө шиг нь хөгшин Жон Арринтай гэрлүүлсэн байх нь. Тирион Лайза Аррин одоо ямар болсон тухай санамагц уурлахаасаа илүү талархах сэтгэгдэл төрөв.

- Би чамайг Дорнд санал болгоход тэдний хувьд доромжлол гэсэн. Дараагийн жилүүдэд нь Йон Ройс, Лэйтон Хайтаурээс адилхан хариу авсан. Эцэст нь чамайг Робертийн дүүгийнхээ хурим дээр охин насыг нь авсан охинд санал болгоход эцэг нь өөрийнхөө хүлэг баатруудын нэгтэй

суулгахыг эрхэмлэсэн.

- Хэрвээ чи Старкийн охиныг авахыг хүсэхгүй бол би өөр эхнэр хайж олъё. Заримдаа хаант улсад Кастерли Роктой нөхөрлөхийн тулд охиноо дуртайяа өгөхөд бэлэн жижиг лордууд байдаг юм. Хатагтай Танда Лоллисийг санал болгож байгаа... гэхэд,

- Түүний оронд эрхтэнээ огтолж ямаа тэжээсэн нь дээр биз гээд Тирион агзасхийн чичирлээ.

- Тэгвэл нүдээ нээ. Старкийн охин залуу гэрлэх насанд хүрсэн дуулгавартай язгууртан гаралтай охин биеэр хэвээр байгаа. Царай зүс нь ч гэсэн муугүй. Ингэхэд чи юундаа эргэлзээд байгаа юм бэ?

Үнэн хэрэгтээ юу юм бол?

- Миний хоосон маяг. Хэлэхэд хачин байгаа ч би намайг хүсдэг хүнийг эхнэрээ болгохыг хүсч байна.

- Хэрвээ чи янхнуудынхаа нэгтэй оронд орохыг хүсч байгаа бол миний бодсоноос ч дор тэнэг юм байна. Чи миний урмыг хугаллаа, Тирион. Би чамайг үүнд баярлана гэж найдсан юмсан хэмээн лорд Тайвин хэлэв.

- Тиймээ бид бүгд таныг намайг яаж баярлуулахыг хүсч байгааг мэднэ, аав аа. Гэхдээ үүнээс гадна зүйл байна. Умардын түлхүүр гэж та хэлсэн үү? Грэйжойгийнхон одоо умардыг барьж байгаа болохоор Бэйлон хаанд ч гэсэн охин байгаа. Ингэхэд яагаад тэр биш Санса Старк биш гэж? гээд Тирион эцгийнхээ хүйтэн ногоон нүдэнд хурц алтан оч зурсхийхийг харлаа.

Лорд Тайвин эрүүн дороо хуруугаа тулав.

- Бэйлон Грэйжойн дээрэм тонуулын тухай бодож байгаагаас биш удирдан жолоодох биш. Түүнд намрын титэм өмсч умардын өвөлд зовох хугацаа өгье. Түүнд албатууд нь дурлах шалтгаан байхгүй. Хавар болоход умардынхан наймаалжаар гэдэс дүүрэн цадах болно. Чи Эддарт Старкийн ач хүүг төрсөн гэрт нь аваачин эрхийг нь тунхаглахад лорд, эгэл ардууд ялгаагүй өндөр суудалд өвөг дээдсийнх нь залгамжлагчийг суулгахын төлөө босоцгооно. Чамайг эмэгтэй хүнийг хүүхэдтэй болгож чадна гэж найдаж болох уу?

- Тийм гэж бодож байгаа ч баталж чадахгүй нь. Гэхдээ хэн ч намайг хичээгээгүй гэж хэлэхгүй. Би бяцхан үрээ үргэлж...

- Шуудуун дахь бохирын сувагт тарьдаг гэж лорд Тайвин төгсгөв. - Ердийн газар зөвхөн бутач ургамал үндэснээс ургадаг юм. Одоо ч өөрийнхөө цэцэрлэгийг тарих цаг болж. Чамд хэзээ ч Кастерли Рок оногдохгүй гэдгийг амалж байна. Гэхдээ Санса Старктай гэрлэвэл Винтерфеллийг авч болох юм гээд бослоо.

Тирион Ланнистер Винтерфеллийг хамгаалагч. Энэ тухай бодол түүнийг хүйт даалгалаа.

- Маш сайн байна, аав аа. Гэхдээ таны сүрэлд том жоом байна. Робб Старк надаас дутуугүй

чадвартай болохоор удахгүй Фрейгийн нэг охинтой гэрлэхээр андгайлсан. Залуу чоны ямар ч бэлтрэг нь Сансагийн залгамжлах эрхийг байхгүй болгоно гэхэд лорд Тайвин тоосонгүй.

- Робб Старк Фрейгийн охиноос хүүхэдтэй болж чадахгүй гэдэгт чи миний амыг авч болно. Зөвлөлийн хуралд хуваалцах шаардлагагүй гэж бодсон нэг мэдээ байгаа ч удахгүй манай сайн лордууд сонсоно гэдэг нь эргэлзээгүй. Залуу чоно Гавен Вестерлингийн ууган охиныг эхнэрээ болгосон.

Хормын зуур Тирион эцгийнхээ хэлсэн зүйлд итгэсэнгүй.

- Тэр өргөсөн андгайгаа эвдээ юу? Тэр Фрейгийнхнийг... гээд цааш нь юу хэлэхээ мэдсэнгүй.

- Жэйн гэдэг арван зургаан настай охины төлөө хаясан. Лорд Гавен түүнийг Виллем, Мартин хоёртой гэрлүүлэхээр санал болгож байсан ч би татгалзсан. Гавен сайн хүн хэдий ч эхнэр нь Сибелл Спайсер. Тэр хэзээ ч түүнтэй гэрлэх ёсгүй байсан юм. Вестерлингийнхэн үргэлж ухаанаас илүү нэр төрд хөтлөгддөг. Хатагтай Сибеллагийн өвөө гүргэм, чинжүүний худалдаачин байсан болохоор бараг л Станнисийн дэргэдээ байлгадаг хориотой наймаачнаас дутуугүй дорд гаралтай. Харин авгай нь түүний дорно зүгээс авчирсан эмэгтэй байсан юм. Аймшигтай хөгшин чавганц удган байсан гэлцдэг. Жинхэнэ нэрийг нь хэн ч мэдэхгүй мэйги гэж дууддаг байсан юм. Ланниспортын хагас нь түүнээс эм тан, хайрын уусмал болон бас бус зүйл авахаар явдаг байлаа гээд сэр Кеван мөрөө хавчлаа. - Тэр аль эрт үхсэн ч Жэйн хонгор хүүхэд санагдаж байна. Би түүнийг урьд нь нэг удаа харсан. Гэсэн ч ийм эргэлзээтэй цустай болохоор...

Тирион урьд нь янхантай гэрлэж байсан болохоор өвөг эцэг нь сармис зардаг байсан охинтой гэрлэх авга ахынхаа айдсыг хуваалцсангүй. Тэгсэн ч гэсэн... хонгор хүүхэд гэж сэр Кеван хэлсэн болохоор ихэнхи хор амттай байдаг билээ. Вестерлингийнхэн эртний удамтай болохоор хүч чадлаас илүү бардам. Хэрвээ хатагтай Сибелл язгууртан гаралтай нөхөртээ инжгүй ирсэн бол гайхах юмгүй. Вестерлингийн уурхай олон жилийн өмнө үгүй болж хамгийн сайн газраа зарах юм уу алдан Краг шилтгээнээс илүү балгас болсон. *Тэнгисээс бардам цухуйж буй романтик балгас.*

- Та намайг ихэд гайхууллаа. Робб Старкийг арай илүү ухаантай гэж бодсон юмсан гэж Тирион хүлээв.

- Тэр арван зургаантай хүү. Түүний насанд хүсэл тачаал, хайр, нэр хүндийн эсрэг цэгнэх ухаан байхгүй гэж лорд Тайвин хэлэв.

- Тэр амлалтаа зөрчин холбоотноо гутаасан. Үүнд юуных нь нэр хүнд байна?

- Тэр охины нэр хүндийг өөрийнхөөсөө илүү сонгосон. Түүнтэй унтмагц өөр зам үлдээгүй гэж сэр Кеван нэмэрлэхэд,

- Түүнийг гэдсэнд нь бутачтай орхисон бол дээр байсан юм гэж Тирион хэлэв. Одоо Вестерленгийнхэн газар нутаг, шилтгээн амьдрал гээд бүх зүйлээ алджээ. *Ланнистерийнхан үргэлж өрөө төлдөг.*

- Жэйн Вестерлинг ээжийнхээ охин байхад Робб Старк эцгийнхээ хүү нь гэж лорд Тайвин хэллээ.

Харваас Вестерлингийнхны урвалт Тирионы бодсон шиг эцгийг нь уурлуулсангүй бололтой. Саяхныг хүртэл лорд Тайвин хамжлагуудынхаа үнэнч бус байдалд зовж байсангүй. Тэр Тарбекийн өргөөний эртний Тарбекийн үндэс мөчир болон Кастамерийн бардам Рэйнисийг жаахан хөвгүүн байхад нь даржээ. Дуучид энэ тухай баргар дуу дуулдаг байлаа. Хэдэн жилийн дараа Гэрэлт шилтгээний лорд Фарман биеэ сэжигтэй авч явж эхлэхэд лорд Тайвин түүн рүү захианы оронд хөгжимтэй элч илгээжээ. Лорд Фарман өргөөнд нь цуурайтсан "Кастамерийн Рэйнс" гэсэн дууг сонсоод ахин төвөг удсангүй байна. Хэрвээ дуу хангалтгүй байвал Рэйнис, Тарбакийн сүйрсэн шилтгээн Кастерли Рокийн эсрэг босох гэсэн бүх хүнд гашуун сануулга болон зогсдог байлаа.

- Краг Тарбекийн өргөө болон Кастамерээс холгүй. Та Вестерлингийнхэн дэргэдүүр нь хичээл суралцахаар өнгөрсөн гэж бодохгүй байна уу гэж Тирон хэллээ.

- Тэгсэн ч байж магадгүй. Тэд Кастамерийн хувь заяаг сайн мэдэх болно гэдгийг чамд амлах байна.

- Вестерлингийнхэн, Спайсерийнхан үнэхээр чоно арсланг ялж чадна гэж бодсон дүүрчихсэн тэнэгүүд гэж үү?

Удаан хугацааны дараа анх удаа лорд Тайвин Ланнистер инээмсэглэхэд сүрдүүлэг нь аймшигтай байлаа.

- Дүүрчихсэн тэнэгүүд тэднийг шоолон инээж байгаа хүмүүсээс илүү хавьгүй ухаантай байдаг юм. Чи Санса Старктай аль болох түргэн гэрлэ, Тирион.

КАТЕЛИН

Тэд цогцоснуудыг мөрөн дээгүүрээ дамнан ирж тавцангийн доод талд тавилаа. Бамбарын гэрэлтэй танхимд нам гүм болоход Кателин шилтгээний гадна Хөнгөн салхи улихыг сонслоо. *Тэр чулуун хана, модон хаалга, шөнийн бороон дундуур цус үнэрлэсэн болохоор үхэл сүйрлийн үнэрийг мэдэж байна.*

Кателин Роббын өндөр суудлын хажууд зүүн гар талд зогсоод агшин зуур өөрийнхөө үрэгдсэн хүүхдүүд Бран, Рикон хоёр луу харж байгаа юм шиг мэдрэмж төрөв. Тэдгээр нь арай ахмад хөвгүүд байсан ч үхэл биеийг нь жижигрүүлжээ. Нойтон нүцгэн бие нь эгээ л жаахан хүүхдийнх шиг харагдахад амьд байхдаа ямар байсныг санахад бэрх байлаа.

Цайвар үстэй хүү сахлаа ургуулахыг оролджээ. Цайвар шаргал сахал хацрыг нь бүрхэн хутганд огтлуулсан хоолойны дээд талын эрүүнд сөрвийжээ. Урт алтан үс нь саяхан угаасан гэлтэй нойтон байлаа. Түүн рүү харахад үхэхдээ бараг унтаж байгаа юм уу гэмээр амгалан царайтай байсан ч хүрэн үстэй үеэл нь амьдралынхаа төлөө ширүүн тэмцсэн байв. Түүний гар илдийг хаахыг оролдсон газраа цавчуулж цээж, хэвлий ар нуруугаар нь нэвт сүлбэсэн ангайсан ам шиг улаан шархнаас цус удаанаар урсан бороонд угаагдан бараг цэвэрхэн болжээ.

Робб танхимд титмээ зүүн орж ирэхэд хүрэл төмөр бамбарын гэрэлд бараанаар гялалзав. Үхэгсэд рүү харахад нүд нь сүүдэрт далдлагдав. *Тэр ч гэсэн Бран, Рикон хоёрыг бас харсан болов уу?* Кателин уйлахыг хүссэн ч нулимс нь гарсангүй. Амь үрэгдсэн хөвгүүд удаан хугацаанд хоригдон зэвхийн цайсан ч хоёул час улаан цусан дээр толигор цагаан арьстай царайлаг үзэгдэн харж тэвчихийн аргагүй байлаа. *Тэд Сансаг алсныхаа дараа бас төмөр хаан ширээний хөлд нүцгэн хаях болов уу? Түүний арьс цагаан, цус нь час улаан байх болов уу?* Гадаа бороо нэгэн жигд шивэрч чонын тасралтгүй улих сонсогдоно.

Түүний дүү Эдмур Роббын баруун гар талд өрөөсөн гараа эцгийнхээ суудлын түшлэгэн дээр тавьж хавдсан нойрмог царайтай зогсож байлаа. Хүмүүс түүнийг Кателины адил харанхуй шөнө хаалгыг нь нүдэн нойрноос нь бүдүүлгээр угзран сэрээжээ. *Чи сайхан зүүд зүүдэлж байсан уу, дүү минь? Чи нарны гэрэл, инээд хөөр, охины үнсэлтийг зүүдэлж байсан болов уу? Чамайг тэгсэн гэж залбиръя.* Кателины зүүд айдаст хүлэгдсэн бараан харанхуй байлаа.

Роббын ахмадууд, лорд тугчид танхимд зогсоод зарим нь хуягтай зэвсэглэсэн бусад нь гартаа тааралдсан янз бүрийн хувцас өмсчээ. Тэдний дунд сэр Рэйналд, авга сэр Рольфын хамт байсан ч Робб хатныгаа ийм таагүй үйл явдалд оролцуулсангүй. *Краг бол Кастерли Рокоос холгүй. Жэйн хүүхэд байхдаа эдгээр хөвгүүдтэй тоглож байсан байж болох гэж* Кателин бодлоо.

Кателин дагуул хиа Тион Фрей, Виллем Ланнистерийн цогцоснууд руу харж хүүгийнхээ ярихыг хүлээлээ.

Робб үхсэн хүмүүсээс харцаа салгах хүртэл маш удаан хугацаа өнгөрөх шиг санагдав.

- Бага Жон эцэгтээ тэднийг авчир гэж хэл гэхэд Бага Жон Амбер үг дуугүй дагалдан эргэхэд хөлийн чимээ нь том чулуун танхимд цуурайтав.

Том Жон хоригдолуудын хамт хаалгаар орж ирэхэд Кателин зарим хүмүүс урван тэрслэлт халдах юм шиг тэдэнд зай тавин ухарч харж ханиалгахыг харлаа. Барьсан баригдсан хүмүүс ялгаагүй том бие, өтгөн сахал, урт үстэй байлаа. Том Жоно хоёр хүн хоригдлуудын гурав нь шархаджээ. Зөвхөн тэдний зарим нь жадтай байсан бол бусад нь хоосон хуйтай байв. Бүгд гархин хуяг, цагариг ширж оёсон цамц өмсөж хүнд гутал, ноосон болон үстэй зузаан нөмрөг нөмөрчээ. *Умард хатуу хүйтэн өршөөлгүй* гэж Нэд Кателиныг бараг мянган жилийн өмнө Винтерфеллд ирэхэд хэлж байсан билээ.

- Тав. Ингээд бүгд болсон уу? гэж Робб норсон хоригдлууд урд нь чимээгүй зогсоход хэлэв.

- Тэд наймуул байсан. Бид хоёрыг нь барихдаа алж гурав дахь нь сая үхсэн гэж Том Жон хүнгэнүүлэв.

Робб баригдсан хүмүүсийн царайг шинжлээ.

- Хоёр зэвсэггүй дагуулыг алахад та нарт найман хүн шаардагдаа юу гэхэд Эдмур Талли,

- Тэд цамхаг руу ороходоо миний хоёр хүнийг ч гэсэн алсан. Делф, Элвүүд хоёрыг гэв.

- Энэ бол аллага биш, сэр. Ямар ч хүн эцэг хүнийг үхлийн өшөө авахад дундуур нь орох ёсгүй гэж бугуйгаа олсоор хүлүүлэн нүүрийг нь даган цус дусалж байгаа лорд Рикард Карстарк хэллээ.

Түүний үг Кателины чихэнд дайны хахир хатуу бөмбөрийн дуу шиг нүргэлэхэд хоолой нь арган хатлаа. *Би үүнийг хийсэн. Эдгээр хоёр хөвгүүн миний охидыг амьдруулахын төлөө үхсэн.*

- Би Шивнэдэг ойд тэр шөнө хөвгүүд чинь үхэхийг харсан. Тион Фрей Торренийг алаагүй. Виллем Ланнистер Эддардыг алаагүй. Үүнийг яаж өшөө авалт гэж дуудаж болох юм бэ? Энэ бол хараал идсэн тэнэг цуст аллага. Чиний хөвгүүд тулааны талбарт гартаа илдтэй нэр хүндтэй үхсэн.

- Тэд үхсэн. Хааны алуурч тэднийг цавчин унагасан. Энэ хоёр бол түүний төлөөс. Цусны хариуг зөвхөн цус төлж чадна гээд Рикард Карстарк бууж өгсөнгүй.

- Хүүхдүүдийн цус уу? Тэд хэдэн настай байсан билээ? Арван хоёр уу арван гурав уу? Ердийн дагуул гээд Робб цогцос руу зангалаа.

- Тулаан болгонд дагуул үхдэг.

- Тулалдаж үхдэг, тиймээ. Тион Фрей, Виллем Ланнистер хоёр Шивнэдэг ойд илдээ хураалгасан. Тэд олзлогсод болон цоожтой өрөөнд зэр зэвсэггүй унтаж байсан хөвгүүд. Тэднийг хараач!

- Ээждээ тэднийг хар гэж хэл. Тэр надаас дутуугүй тэднийг алсан гээд лорд Карстарк оронд нь Кателин руу хяламхийв.

Кателин гараа Роббын суудлын түшлэгэн дээр тавихад танхим эргэлдэх шиг санагдан дотор нь эвгүйрхлээ.

- Миний ээж хийсэн зүйлд чинь ямар ч хамаагүй. Энэ бол чиний ажил. Чиний аллага. Чиний урван тэрслэлт гэж Робб уурсан хэлэв.

- Ланнистерийнхныг суллахыг урвалт гэхгүй байж Ланнистерийнхныг алахыг урван тэрслэлт гэж яаж хэлж болох юм бэ? Эрхэм дээдэс бидний Кастерли Роктой дайн хийж байгааг мартаа юу? Дайнд дайснуудаа алдаг. Эцэг чинь чамд үүнийг сургаагүй юу, хүү минь? гэж Карстарк хахир хоолойгоор асуув.

- Хүү гэнэ ээ? гээд Том Жоны Рикард Карстаркыг ган бээлийтэй нударгаар дэлсэхэд өвдөг сөгдөн уналаа.

- Түүнийг орхи! гэж Роббын хоолойноос тушаал цуурайтав. Амбер баригдсан хүмүүсээс алхам холдлоо.

Лорд Карстарк хугарсан шүдээ нулимав.

- Тиймээ, лорд Амбер намайг хаанд орхи. Тэр намайг өршөөхийн өмнө зэмлэг. Энэ бол манай Умардын хааны урван тэрслэлттэй хийдэг зүйл гээд улаан цустай амаараа инээмсэглэж,

- Эсвэл би чамайг Умардыг алдсан хаан гэж дуудах уу, эрхэм дээдэс ээ? гэв.

Том Жон дэргэдээ байсан хүний жадыг мөрнөөс нь угз татан авлаа.

- Надад түүнийг сүлбэх боломж өгөөдөх, сэр. Хэвлийг нь ярахад бид гэдэс дотор нь ямар өнгөтэй болохыг харъя.

Танхимын хаалга тасхийн нээгдэж дуулга нөмрөгнөөсөө ус дуслуулсан Хар загас орж ирэв. Таллигийн цэргүүд түүний араас дагалдахад гадаа тэнгэрт аянга цахиж ширүүн хар аадар Риверраны чулуун дээр шаагин орж байлаа. Сэр Бринден дуулгаа тайлаад өрөөсөн өвдгөө сөхрөн,

- Эрхэм дээдсээ гэж баргар хоолойгоор хэлэв.

- Би сэр Бриндентэй бараалхах танхимд тусдаа уулзана. Том Жон лорд Карстаркийг намайг эргэн иртэл энд байлгаж байгаарай. Үлдсэн долоог нь дүүжил гээд Робб хөл дээрээ бослоо.

- Үхсэн хүмүүсийг хүртэл үү? гээд Том Жон жадаа буулгав.

- Тийм. Би ийм зүйлээр нагац ахынхаа голыг бузарламааргүй байна. Тэднээр хэрээ тэжээ гэхэд олзлогсдын нэг өвдөг сөгдөн,

- Өршөө, сэр. Би хэнийг ч алаагүй зөвхөн хаалган дээр харуулд зогсож байсан гэхэд Робб хормын турш бодлогширов.

- Чи лорд Рикардыг ямар зорилготой байсныг мэдэж байсан уу? Чи хутга дүрэхийг харж орилж хашгиран өршөөл гуйхыг сонссон уу?

- Тиймээ тэгсэн. Гэвч би үүнд оролцоогүй. Би зөвхөн харуул байсан гэдгээ тангараглаж...

- Лорд Амбер энэ хүн зөвхөн харуулд гарч байж. Түүнд бусдыгаа үхэхийг харахын тулд хамгийн сүүлд дүүжил. Ээжээ, нагац ахаа надтай явна уу гээд цааш эргэхэд Том Жоно хүмүүс хоригдлуудыг шахан танхимаас жадны үзүүрээр туун гарлаа. Гадаа аадар хүчтэй шаагиж тэнгэр чанга нүргэлэхэд шилтгээний дотор сонсогдоно. *Энэ хаант улсын уналтын чимээ юм болов уу?* гэж Кателин бодлогоширлоо.

Бараалхах танхимд харанхуй байсан ч зузаан хананд аадрын шаагих чимээ бүдгэрчээ. Тосон дэнлүүтэй зарц орж ирээд гэрэл асаахад Робб цааш явуулан дэнлүүг нь авлаа. Өрөөнд байсан ширээ сандал дээр зөвхөн Эдмур сууснаа бусад нь зогсож байгааг ойлгомгогц босож зогсов. Робб титмээ авч өмнөө ширээн дээр тавилаа.

- Карстаркийнхан явцгаажээ гээд Хар загас хаалга хаав.

- Бүгд үү? гээд Роббын хоолойд цөхрөл хилэнгийн алин сонсогдсоныг Кателин мэдсэнгүй.

- Бүх тулалдааны цэргүүд нь. Хэдхэн буудал дагагчид үйлчлэгч хүмүүсийн хамтаар шархдагсдаа сахин хоцорсон байсан. Бид үнэнийг тодруулахын тулд олон хүнийг байцаасан. Тэд эхэндээ шөнө дунд ганц нэгээр явж эхэлснээ дараа нь бөөнөөрөө явцгаасан байна. Шархадсан хүмүүс, зарц нарт буудлын галаа сахиж бай гэж хэлсэн болохоор тэдний хаачсаныг хэн ч мэдсэнгүй бороо орж эхэлсэн хойно бүр хамаагүй болжээ.

- Тэд Риверранаас холдсон хойно эргэн нэгдэх юм болов уу? гэж Робб асуув.

- Үгүй. Тэд агнахаар тарцгаасан. Лорд Карстарк Хааны алуурчийн толгойг авчирсан ямар ч хүнд язгууртан дорд гаралтай байсан хамаагүй охиныхоо гарыг өгөхийг амласан.

Бурхад минь гэж. Кателин ахин муу совин төрөхийг мэдэрлээ.

- Ойролцоогоор гурван зуун морьтой цэргүүд болон үүнээс хоёр дахин их морьтонгууд шөнийн харанхуйд уусан алга болсон байна. Кархолдын бүх морин цэргийн хүч алга болжээ гэхэд Робб чамархайны тус газар чихнийхээ дээд талд зөөлөн арьсан дээр үлдсэн титмийн ором дээр дарлаа.

Надаас болж явжээ. Надаас болж бурхад минь минь намайг өршөөгөөч. Кателинд цэргүүд Роббыг занганд оруулсныг хэлэх хэрэг байсангүй. Хормын зуур тэр голын хөндийг барьж байснаа хаант улс нь Лайзагийн тусгаарлагдсан уулын орой дээр сууж байгаа шиг зүг бүрээсээ дайснуудаар хүрээлэгджээ. Сэрээ хүртэл Уулзварын лорд холбоотноо хэр удаан барих хүртэл аюулгүй биш байлаа. *Харин одоо Карстаркийнхныг ч гэсэн алдаж...*

- Энэ тухай үг Риверранаас тарааж болохгүй. Лорд Тайвин... Ланнистерийнхан үргэлж өрөө төлдөг гэж тэд хэлдэг. Ээж минь өршөө хэрвээ тэр сонсвол гэж дүү Эдмур нь хэлэв.

Санса. Кателин зөөлөн гарын алганд хумсаа шигдтэл чанга атгав.

- Та намайг алуурчин шигээ худалч болгох гээ юу, нагац ах минь? гээд Робб Эдмур руу хүйтнээр

харлаа.

- Бидэнд худал үг хэлэх хэрэг байхгүй. Зүгээр л юу ч ярихгүй байсан нь дээр. Хөвгүүдийг булж дайн дуустал хэлээ хазахад болно. Виллем бол сэр Кеван Ланнистерийн хүү лорд Тайвины зээ. Тион хатагтай Женна болон Фрейгийн хүүхэд. Бид энэ мэдээг Ихрээс хүртэл нуух ёстой...

- Үхэгсдийг буцаан амь оруулах хүртэл үү? Үнэн Карстарктай хамт зугтан одсон, Эдмур. Ийм тоглоом тоглоход дэндүү оройтсон гэж Бринден Хар загас ширүүн хэлэв.

- Би тэдний эцэгт үнэнийг хэлэх шударга ёсны өртэй. Бас тэдэнд үүний ч гэсэн өртэй гээд Робб төмөр илд дугуйрсан бараанаар гялалзах хүрэл титэм рүүгээ харлаа.

- Лорд Рикард намайг эсэргүүцэж урвалаа. Надад түүнийг цаазаар авахаас өөр сонголт алга. Эзнийг нь урвагч гэж цаазаар авсныг сонсмогц Карстаркийн хүү Рус Болтонтой нийлээд яахыг бурхад мэдэх бизээ. Болтоноос болгоомжтой байх ёстой.

- Лорд Карстаркийн залгамжлагч Харренхалд ч гэсэн байсан. Ууган хүүг нь Ланнистерийнхан Ногоон салаанд олзолсон гэж сэр Бринден сануулав.

- Харрион. Түүнийг нэрийг Харрион гэдэг. Хаан хүн дайсныхаа нэрийг мэдэж байх ёстой биз дээ гээд Робб гашуунаар инээлээ.

- Чи үүнийг хийхдээ итгэлтэй байна уу? Энэ чамайг залуу Карстаркийн дайсан болгоно? гээд Хар загас түүн рүү ширүүн харав.

- Өөрөөр яах гэж? Би түүний эцгийг алсан болохоор надад талархахгүй нь лавтай.

- Тэгэхгүй ч байж магадгүй. Заримдаа эцгийгээ үзэн яддаг хөвгүүд байдаг болохоор чи түүнийг Кархолдын лорд болгоно гэхэд Робб толгойгоо сэгсэрлээ.

- Харрион тийм хүн байсан ч хэзээ ч эцгийнхээ алуурчинг амар уучлахгүй. Өөрийнх нь хүмүүс түүний эсрэг эргэнэ. Тэд бол умардынхан, нагац ах минь. Умард санаж байдаг юм.

- Тэгвэл түүнийг өршөө л дөө гэж Эдмур Талли шаардав.

Робб түүн рүү илэн далангүй үл итгэн харахад Эдмурын царай улайв.

- Амийг нь хэлтрүүл гэх гэсэн юм. Надад чамаас илүү үүний амт таалагдахгүй байна, сэр. Тэр бас миний хүмүүсийг алсан. Хөөрхий Делф сэр Жэймигийн учруулсан шархнаас дөнгөж эдгэрч байсан юмсан. Карстаркийг мэдээж шийтгэх ёстой. Түүнийг гинжил гэх гэсэн юм л даа.

- Барьцааны хүн болгон уу? гэж Кателин асуув. *Энэ магадгүй дээр ч байж болох юм...*

- Тиймээ, барьцааны хүн! гэж дүү нь эрэгцүүлэх зуураа зөвшөөрлөө.

- Хүүд нь түүнийг хичнээн удаан үнэнч байх тусам эцэгт нь гэм учрахгүй гэж хэл. Үгүй бол... бид

одоо Фрейгийнхэнд лорд Валдерийн бүх охидтой гэрлэн дамнуургыг нь зөөх хүн санал болгохгүй бол найдалтгүй болсон. Хэрвээ бид Карстаркийнхныг хүртэл алдвал ямар найдлага байх юм бэ?

- Юун найдлага... гээд Робб гүн амьсгаа аван нүд руугаа унасан үсээ холдуулав. - Бидэнд умард зүг сэр Родрикоос ямар ч сураг дуулдсангүйн дээр Валдер Фрей шинэ саналын хариуд хариу өгөлгүй, Эйригээс чимээгүй байна гээд ээж рүүгээ хандан,

- Дүү чинь бидэнд хариу өгөхгүй юм болов уу? Би хичнээн удаа түүнд бичив дээ? Ямар нэг шувуу хүрээгүй гэдэгт итгэж чадахгүй нь гэв.

Хүү нь үүнийг хэвийн гэж тайтгарахыг хүсч байгааг Кателин ойлгов. Гэвч хаанд үнэн хэрэгтэй билээ.

- Шувууд түүнд хүрсэн. Гэсэн ч тэр ирсэн ч байсан үгүй гэж хэлж магадгүй. Түүнээс ямар ч тус хүлээх хэрэггүй, Робб.

- Лайза хэзээ ч зоригтой байгаагүй. Биднийг жаахан хүүхэд байхдаа хамт байхад ямар нэг буруу зүйл хийвэл зугтаж нуугддаг байсан. Магадгүй тэр одоо манай лорд эцэг захиа бичээд байхад мартсанд нь уурлаж байгаа гэж бодсон байж болох юм. Одоо үүнд ялгаа байхгүй болсон. Тэр Хааны газраас айсандаа зугтаж ирээд аюулгүй газар болохыг нь мэддэг ууландаа суугаад бүгд түүнийг мартана гэж найдаж байгаа.

- Хөндийн хүлэг баатрууд дайны явцыг өөрчилнө. Гэхдээ тэр тулалдахыг хүсэхгүй бол тэгнэ л биз дээ. Би зөвхөн түүнийг Цуст хаалгаа бидэнд нээж Цахлай хотын хөлөг онгоцуудыг умард руу оруулахыг хүсэх гэсэн юм. Уулын зам хүнд ч Хүзүүгээр тулалдаж гарахтай харилцан адилгүй хүнд биш. Хэрвээ би Цагаан боомтод газардаж чадвал Кайлины сувгийг хажуу жигүүрээс нь довтлон төмөр хүмүүсийг умардаас хагас жилийн дотор хөөнө.

- Ийм зүйл болохгүй, сэр. Катын зөв. Хатагтай Лайза Хөндийд арми оруулахад дэндүү аймхай. Ямар ч арми шүү. Цуст хаалга хаалттай байх болно гэж Хар загас хэлэв.

- Өөрүүд түүнийг аваасай гэж Робб цөхөрсөндөө уурсан хараалаа. - Хараал идсэн Рикард Карстаркийг ч гэсэн. Бас Теон Грэйжой, Валдер Фрей, Тайвин Ланнистер гээд тэд бүгдийг аваасай. Бурхад минь гэж яагаад хүн бүхэн хаан болохыг хүснэ вэ? Хүмүүсийг Умардын хаан, Умардын хаан гэж хашгирах үед би өөртөө... эцэг шигээ хүндтэй хүчтэй нөхөддөө үнэнч дайсантай нүүр тулахад зоригтой сайн хаан болно гэж андгайлсан. Гэвч одоо эдний алиныг ч биелүүлсэн гэж хэлж чадахгүй нь. Би яаж энэ бүх будлианы учрыг олох болж байна? Лорд Рикард миний дэргэд мөр зэрэгцэн олон тулалдаанд тулалдсан. Хөвгүүд нь миний төлөө Шивнэдэг ойд үхсэн. Тион Фрей, Виллем Ланнистер хоёр бол миний дайснууд байсан. Гэтэл одоо би тэдний төлөө амь үрэгдсэн нөхдийнхөө эцгийг алах гэж байна гээд тэдэн рүү ширтсэнээ,

- Ланнистерийнхан надад лорд Рикардын толгойны төлөө талархах болов уу? Фрейгийнхэн ч гэсэн гэв.

- Үгүй гэж Бринден хар загас үргэлжид байдаг шигээ шулуухан хэллээ.

- Энэ бүх шалтгааны улмаас лорд Рикардын амийг хэлтрүүлж барьцааны хүн болго гэж Эдмур шаардав.

Робб доошоо сунган хоёр гараараа хүнд хүрэл төмөр титмээ авч толгой дээрээ тавиад гэнэтхэн ахин хаан боллоо.

- Лорд Рикард үхнэ.

- Гэхдээ яагаад? Чи өөрөө хэлсэн биз дээ... гэж Эдмур хэлэв.

- Би юу хэлснээ мэдэж байна, нагац ах минь. Гэсэн ч энэ хийх ёстой зүйлийг маань өөрчлөхгүй гээд илдтэй титэм хөмсгөн дээр нь ширүүн зурайв.

- Тулалдаанд би Тион, Виллем хоёрын алиныг ч алж болох байсан ч энэ бол тулалдаан биш. Тэд миний оруулсан өрөөнд ор дэвсгэртээ зэр зэвсэггүй нүцгэн унтаж байсан. Рикард Карстарк Фрей, Ланнистерийнхнаас илүү олон зүйл алсан. Тэр миний нэр хүндийг алсан. Би түүний учрыг үүр гэгээрэхэд олно.

Бүрхэг чийгтэй үүр цайхад шуурга намдан бороо нэгэн жигд шивэрч бурхдын модонд дүүрэн хүнтэй байлаа. Голын лордууд, умардынхан язгууртан дорд гаралтай хүлэг баатрууд, хөлсний цэргүүд, агтчин хөвгүүд шөнийн бүүдгэрч буй харанхуйн захад модон дунд зогсчээ. Эдмур тушаал өгөхөд цаазын тавцанг зүрх модны өмнө авчирч тавилаа. Эргэн тойрон навчин дээр бороо шавшиж Том Жоно хүмүүс лорд Рикард Карстаркийг цугласан олны дундуур гарыг нь хүлээстэй авчирав. Түүний хүмүүсийг Риверраны өндөр хэрмээс хэдийн дүүжилсэн болохоор урт олсны үзүүрт санжигнан бороонд харласан нүүр нь угаагдана.

Лонг Лью тавцангийн дэргэд хүлээж байсан ч Робб цаазын сүхийг авч түүнийг хажуу тийш холдохыг тушаав.

- Энэ бол миний ажил. Тэр миний үгээр үхэж байгаа болохоор миний гарт үхэх ёстой.

Лорд Рикард Карстарк толгойгоо дээш нь өргөв.

- Үүний чинь төлөө чамд баярлалаа. Гэхдээ энэ хамаагүй гээд тэр үхэхдээ овгийнхоо цагаан нарны цацрагтай хар ноосон урт хүрэм өмсчээ.

- Анхны хүмүүсийн цус миний судсанд чинийхээс дутуугүй гүйж байгаа, хүү минь. Чамд үүнийг санавал дээрсэн. Би өвөг эцгийн чинь төлөө зүтгэж, эцгийн чинь төлөө далбаагаа Эйрис хааны эсрэг мандуулж, чиний төлөө Жоффри хааны эсрэг боссон. Окскросс, Шивнэдэг ой болон Буудлын тулаанд би дэргэд чинь мордож Сэрээнд лорд Эддардын хамт зогсож байлаа. Бид бол төрлүүд Старкийнхан болоод Карстаркийнхан.

- Төрөл садан чамайг надаас урвахыг зогсоосонгүй. Түүн шигээ одоо чамайг аврахгүй. Өвдөг сөгд, эрхэм лорд.

Лорд Рикард үнэнийг ярьж байгааг Кателин мэдэж байв. Карстаркийнхан мянган жилийн өмнө

бослогын лордыг дарсан Винтерфеллийн залуу хүү Карлон Старкаас удамтай бөгөөд эр зоригынхоо төлөө газар нутгаар шагнуулжээ. Тэр шилтгээнээ барихдаа анх Карлын Холд гэж нэрлэсэн ч удалгүй Кархолд болон олон зууны явцад Кархолдын Старкууд нь Карстарк болжээ.

- Хуучин болоод шинэ бурхад байсан ялгаагүй ямар ч хүн төрөл саднаа хөнөөж болохгүй гэж лорд Рикард хүүд нь хэлэв.

- Өвдөг сөгд, урвагчаа. Эсвэл би чиний толгойг тавцан дээр хүчээр тавиулах уу? гэж Робб ахин хэллээ.

Лорд Карстарк өвдөг сөгдлөө.

- Чиний намайг шүүсэн шиг бурхад чамайг шүүх буй за гээд толгойгоо тавцан дээр тавилаа.

Робб хүнд сүхээ хоёр гараараа өргөв.

- Кархолдын лорд Рикард Карстарк. Бурхад болон хүмүүсийн нүдний өмнө би чиний аллага хийн өндөр урвалт хийсэн гэм бурууг шүүж байна. Өөрийнхөө нэрийн өмнөөс би чамайг цаазаар авч гараараа чиний амийг авна. Чамд хэлэх сүүлчийн үг байна уу?

- Намайг ал хараал идмэр. Чи бол миний хаан биш.

Сүх исгэрэн буухад хүнд цохилт ганцхан цавчилтаар алсан ч толгойг нь биенээс салгахын тулд гурван цавчилт шаардаж үүнийг гүйцэтгэхэд амьд үхсэн хоёул цусанд будагдсан байлаа. Робб сүхээ зэвүүцэн шидээд зүрх модны зүг чимээгүй эргэв. Тэр нударгаа хагас атган чичирэн зогсоход бороо хацрыг нь даган урсав. *Бурхад минь түүнийг өршөө. Тэр ердөө хүү. Түүнд өөр сонголт байгаагүй* гэж Кателин чимээгүй мөргөлөө.

Энэ нь түүний тэр өдөр хүүгээ сүүлчийн удаа харсан явдал байлаа. Бороо өглөөний турш үргэлжлэн голын мандлыг шавхуурдан шаагиж бурхдын модны зүлгийг шавар шалбааг болгон хувиргав. Хар загас зуун хүн цуглуулан Карстаркийнхны араас мордоход хэн ч түүнийг олон хүн авчирна гэж хүлээсэнгүй.

- Би зөвхөн тэднийг дүүжлэх хэрэг гарахгүй байгаасай гэж мөргөх байна гэж мордохдоо хэлжээ. Түүнийг мордсон хойно Кателин эцгийнхээ өрөөнд ороод лорд Хостерийн орны дэргэд суув.

- Тэр удаан тэсэхгүй. Сүүлчийн хүч нь барагдсан ч тэмцэхийг оролдож байна гэж мэйстер Вайман үдээс хойш орж ирэхдээ анхааруулав.

- Тэр үргэлжид дайчин байсан. Хонгор зөрүүд дайчин.

- Тийм гэвч энэ тулаанд тэр ялахгүй. Энэ удаад тэр илд бамбайгаа доош тавьж бууж өгөх цаг болсон.

Бууж өгч амгалан болох гэж Кателин бодлоо. Мэйстер эцгийнх нь тухай ярьсан юм болов уу эсвэл хүүгийнх нь тухай хэлсэн хэрэг үү?

Үдэш нь Жэйн Верстерлинг түүнтэй уулзахаар ирлээ. Залуу хатан өрөөнд хулчгардуухан орж ирэв.

- Хатагтай Кателин би таныг үймүүлэх гээгүй юм шүү...

- Та энд тавтай морилно уу, эрхэм дээдсээ гээд Кателин юм нэхэж байсан зүүгээ хойш тавилаа.

- Гуйж байна. Намайг Жэйн гэж дуудна уу. Би эрхэм дээдэс болмооргүй байна.

- Тэгсэн ч та эрхэм дээдэс шүү дээ. Сууна уу, эрхэм дээдсээ.

- Жэйн гээд тэр зуухны дэргэд банзлынхаа хормойг тэнийлгэн сэтгэл зовсон байртай суулаа.

- Таны тааллаар болог. Би таньд юугаар туслах вэ, Жэйн?

- Энэ Роббын тухай. Тэр их гутарсан болохоор ууртай ганцаардмал байгаа. Би түүнийг яахыг мэдэхгүй байна.

- Хүний амийг авах бол хүнд хэцүү зүйл.

- Би мэднэ. Би түүнд зандалчингаар авахуул гэж хэлсэн. Лорд Тайвин хүнд үхэл онооход зандалчин тушаалыг нь гүйцэтгэдэг. Энэ хамаагүй амархан гэж та бодохгүй байна уу?

- Тийм гэхдээ миний лорд нөхөр хөвгүүддээ алах бол хэзээ ч амар зүйл биш гэж сургасан юм.

- Өө гээд Жэйн хатан уруулаа норгов. - Робб өдөржингөө юм идсэнгүй. Би Ролламаар түүнд сонгинотой шарсан бодонгийн хавирга, шар айрагтай сайхан хоол авчруулсан ч гар хүрээгүй байсан. Тэр өглөөний турш захиа бичин надад битгий үймүүл гээд захиагаа дууссан хойно шатааж байгаа. Одоо газрын зураг гөлрөөд суучихсан. Би түүнээс юу эрж байгааг асуусан ч хариу дуугараагүй. Ер нь намайг сонссон гэж бодохгүй байна. Өмссөн хувцсаа хүртэл солиогүй. Хувцас нь өдөржингөө нойтон цустай байсан. Би түүний сайн эхнэр байхыг хүсч байгаа ч юугаар туслахаа мэдэхгүй байна. Түүнийг хөгжөөх юм уу тайтгаруулахаа. Би түүнд яг юу хэрэгтэйг нь мэдэхгүй байна. Гуйж байна хатагтай та эх нь юм чинь надад юу хийхийг минь хэлж өгөөч.

Надад юу хийхийг минь хэлж өгөөч гэж Кателин эцэг нь эрүүл энх байсан бол ижилхэн асуулт тавих байлаа. Гэвч лорд Хостер үгүй болж өөрөөр өөд болохын даваан дээр байв. Түүний Нэд нь ч гэсэн үгүй болсон. *Бран, Рикон хоёр ч гэсэн. Бас ээж, Брендон хоёр ч гэсэн удаан хугацааны өмнө үгүй болсон.* Зөвхөн Робб түүнд үлдсэн ч охидынх нь найдлагыг бүдгэрүүлжээ.

- Заримдаа юу ч хийхгүй байсан нь дээр үе байдаг юм. Намайг анх Винтерфеллд очих үед Нэд бурхдын мод руу очиж зүрх модон доор суухад сэтгэл минь шаналдаг байлаа. Түүний сэтгэлийн нэг хэсэг мод болохоор хэзээ ч хуваалцахгүйгээ мэдэж байсан юм. Гэсэн ч удалгүй тэр хэсэггүйгээр Нэд биш болохыг би ойлгосондоо. Жэйн хүүхэд минь чи над шиг умардын хүнтэй гэрлэсэн болохоор... умардад өвөл ирж байна гээд инээмсэглэхийг хичээн,

- Тэвчээртэй бай. Ойлго. Тэр чамд хайртай тэр чамд хэрэгтэй болохоор удахгүй буцаж ирнэ.

Магадгүй өнөө шөнө ч байж болох. Энэ бол миний чамд хэлэх бүх зүйл гэхэд залуу хатан анхааралтай сонсоод Кателинийг дуусмагц хөл дээрээ бослоо.

- Би тэгнэ. Би тэнд байна. Би буцаж явах ёстой. Тэр намайг үгүйлж байж магадгүй. Очиж үзэхээс. Хэрвээ тэр газрын зураг харсан хэвээр байвал би тэвчээртэй байна.

- Тэгээрэй гээд Кателин охиныг хаалган дээр очсон хойно санаанд нь өөр зүйл ороход,

- Жэйн Роббод чамаас өөр нэг зүйл хэрэгтэй байгааг тэр одоохондоо мэдэхгүй ч байж магадгүй. Хаанд залгамжлагч хэрэгтэй гэв.

Охин үүнд инээмсэглэлээ.

- Ээж минь бас адил зүйл хэлсэн. Тэр намайг жирэмсэн болгоход тусалж ургамал, шар айраг, сүү хольсон ундаа хийж өгсөн. Би өглөө болгон түүнийг ууж байгаа. Би Роббод хоёр ихэр төрүүлж өгнө гэдэгтээ итгэлтэй байна гэж хэлсэн. Эддарт, Брандон хоёр. Түүнийг дуртай байна гэж бодож байна. Бид... бид бараг өдөр бүр хичээж байгаа, хатагтай. Заримдаа хоёр ч удаа болон түүнээс их гээд хөөрхөн улайснаа,

- Би удахгүй хүүхэдтэй болно гэдгээ таньд амлая. Би шөнө болгон тэнгэрийн Ээжид мөргөж байгаа гэв.

- Сайн байна. Би ч гэсэн хуучин болон шинэ бурхдад мөргөнө.

Охиныг гарсан хойно Кателин эцэг рүүгээ эргээд духан дээр нь байгаа шингэн цагаан үсийг холдуулан зөөлөн санаа алдлаа.

- Эддарт, Брандон хоёр. Магадгүй Хостер болох цаг болсон биз. Таньд таалагдаж байна уу? гэхэд хариу хэлсэнгүйд Кателин ч хэлнэ гэж хүлээсэнгүй. Борооны дусал дээвэр нүдэх чимээ эцгийнх нь амьсгалтай холилдоход Жэйний тухай бодлоо. Охиныг сайхан сэтгэлтэй гэж Робб хэлсэн. *Дээрээс нь бас сайн ташаатай. Энэ хамгийн чухал шүү дээ.*

ЖЭЙМИ

Хааны замын хажуугаар хоёр өдөр явсны эцэст тэд бээрийн зайтай хуйхлагдсан талбай, шатсан цэцэрлэг, харласан мод агаарт харваачийн бай шиг ёрдойсон томоохон эвдэрч сүйрсэн газрыг өнгөрлөө. Гүүрнүүд бас шатаж гол горхи намрын бороонд эргээ хальсан учир тэд гарам хайж эргийн дагуу удаан явахад хүрэв. Шөнөдөө чоно улих сонсогдож байсан ч хүмүүс үзэгдсэнгүй.

Охины цөөрөмд лорд Мутоны улаан яргай загас толгодын дээрх шилтгээний оройд дэрвэсэн хэвээр байсан ч хотын хэрэм хоосорч хаалга нь хэмхрэн байшин мухлагийн хагас дээрэмдүүлэх юм уу шатаагджээ. Тэдэнд хэдэн зольбин нохойноос ондоо юм үзэгдсэнгүй ч ойртох чимээгээр нь зугтлаа. Тэнэг Флориан Жонкүйлийг эгч нартайгаа усанд орж байхыг нь анх харсан гэдэг хотыг нэрээр нь нэрлэсэн домогт цөөрөм ялзарсан хүүрэнд хахаж ус нь булингартай ногоон саарал өнгийн болжээ.

Жэйми үүнийг хармагц дуу аялав.

- *Зургаан охин хаврын усаар тэжээгдсэн цөөрөмд байжээ...* гэхэд,

- Чи юу хийж байгаа юм? гэж Бриен шаардав.

- Дуулж байна."Цөөрмийн зургаан охин" гэдэг дууг чи лав сонссон байх. Ичингүйрсэн бяцхан охид байсан юм. Яг л чам шиг. Гэхдээ арай хөөрхөн гэж мөрийцөх байна.

- Чимээгүй гэж хүүхэн түүнийг цөөрмийн усанд хөвж байгаа цогцсон дунд дуртайяа шидэх харцаар хэллээ.

- Гуйж байна, Жэйми. Лорд Мутон Риверранд зүтгэх андгайтай болохоор бидэнд түүнийг шилтгээнээс нь гаргах хэрэг байхгүй. Тэгээд ч нурангин дунд өөр дайснууд нуугдаж байж магадгүй гэж үеэл Клеос хэлэв.

- Түүнийх үү биднийх уу? Тэд бол ижил зүйл биш, үеэл минь. Би хүүхнийг зүүсэн илдээ хэрхэн хэрэглэж чаддагыг үзмээр байна гэхэд,

- Хэрвээ чи амаа татахгүй бол алчуур чихэхээс өөр сонголт алга даа, хааны алуурч минь гэж Бриен хэлэв.

- Миний гарны гинжийг суллавал Хааны газар хүрэх бүх замын турш чимээгүй явъя. Үүнээс илүү шударга зүйл юу байх билээ, бүсгүй минь?

- Бриен! Миний нэрийг Бриен гэдэг! гэхэд гурван хэрээ чимээнд цочсондоо агаарт нисэн одлоо.

- Усанд ормооргүй байна уу, Бриен? гээд Жэйми хөхөрлөө.

- Чи охин болохоор энэ цөөрөмд орж болно. Би нурууг чинь угааж өгье гээд тэр Кастерли Рокод жаахан хүүхэд байхдаа Серсейгийн нурууг угааж өгдөг байжээ.

Хүүхэн мориныхоо амыг эргүүлэн цааш хатируулав. Жэйми, сэр Клеос хоёр араас нь даган Охины цөөрмийн үнс нурангинаас холдов. Хагас милийн зайд ертөнцөд ногоон өнгө ахин эхэлж байлаа. Жэйми үүнд баяртай байв. Шатсан газар нутаг түүнд Эйрисийн тухай дэндүү санагдуулна.

- Тэр Даскендэйлийн замын тухай ярьж байсан. Эргийн дагуу явсан бол аюулгүй байсан даа гэж сэр Клеос гүвтнэв.

- Аюулгүй хэдий ч удаан байна. Би Даскендэйлийнх, үеэл минь. Үнэнийг хэлэхэд чамтай явахаас уйдаж байна шүү. *Чи хагас Ланнистер байж болох ч эгчээс минь хамаагүй хол цуурай.*

Жэйми ихрээсээ хэзээ ч ийм удаан хугацаанд салж байсангүй. Хүүхэд байхдаа хүртэл тэр хоёр нэг нэгнийхээ оронд ороод хоорондоо тэврэлдэн унтдаг байжээ. *Эхийн хэвлийд байхдаа хүртэл.* Эгч нь насанд хүрч тэр эрийн цээнд хүрэхээс өмнө хоёул тал дээр азарга гүү, нохойн байранд жингэр нохой харсан болохоор адилхан тоглодог байж. Нэг удаа ээжийнх нь зарц тэднийг үйлдэл дээр нь барихад яг юу хийж байснаа санахгүй байгаа ч хатагтай Жонна аймшигт автжээ. Тэр зарцаа явуулаад Жэймигийн унлагын өрөөг Кастерли Рокийн нөгөө тал руу зөөн Серсейгийн өрөөний гадна харуул тавьж тэднийг ахин ингэвэл эцэгт нь хэлэхээс өөр сонголтгүй болно гэж хэлжээ. Гэвч үүнд айх хэрэг байсангүй. Үүнээс төдийлөн удалгүй эх нь Тирионыг төрүүлэхээр өнгөрчээ. Жэйми ээж нь ямар төрхтэй байсныг бүдэг бадаг санаж байв.

Магадгүй Станнис Баратеон болоод Старкийнхан түүнд сайн зүйл хийжээ. Тэд долоон ханлиг даяар Серсей тэр хоёрын нөхцсөн түүхийг тараасан болохоор нуух зүйл үлдсэнгүй. *Би яагаад Серсейтэй ил гэрлэж шөнө болгон дэр нэгтгэж болохгүй гэж? Луунууд үргэлж эгч дүүстэйгээ гэрлэдэг байсан.* Септон, лорд жирийн ардууд Таргарианийханд хэдэн зууны турш нүдэн балай чихэн дүлий явсан болохоор Ланнистерийнханд ч гэсэн ижил зүйл хийг л дээ. Энэ нь Жоффригийн титмийг сүйрүүлж болох ч эцсийн эцэст Роберт төмөр хаан ширээг илдийн хүчээр авсан болохоор илд Жоффриг ч гэсэн хэний үр болох нь хамаагүй аюулгүй байлгана. *Бид Санса Старкийг эх рүү нь буцаасан хойно түүнийг Мирцеллатай гэрлүүлж болох юм. Тэгвэл хаант улсад Ланнистерийнхан хуулиас дээгүүр Таргарианийхан шиг бурхдын зэрэгт өргөмжлөгдөж болох юм.*

Жэйми харьсан даруй Сансаг олдвол бага дүүгийнх нь хамтаар буцаахаар шийджээ. Энэ нь түүнд алдсан нэр хүндийг нь эргүүлэн авчирахгүй ч бүх хүмүүсийн хүлээж байсан шиг урвалт биш үнэнч байх бодол сэтгэлийг нь ихэд хөгжөөнө.

Тэд гишгэгдсэн тариан талбай намхан чулуун хэрмийн дэргэдүүр өнгөрөхөд Жэйми ард нь сүрэг шувуу нэгэн зэрэг дэрхийн нисэх мэт зөөлөн исгэрэх чимээ сонслоо.

- Доошоо! гэж хашгираад мориныхоо хүзүү рүү нугдайхад гуянд нь сум зоогдон янцгааж цоройлоо. Бусад сумууд хажуугаар нь нисэн өнгөрөв. Жэйми сэр Клеос эмээлээсээ гуйван унаад хөл нь дөрөөнд орооцолдохыг харахад морь нь ухасхийн авч давхисанд Фрей толгойгоороо газар нүдэн хашгиран чирэгдэв.

Жэймигийн морь өвдсөндөө тургилан хүндээр сажлуулав. Тэр эргэн тойрон хүзүүгээ сунган Бриениг хайн харахад морьтойгоороо хэвээр нэг сум нуруунд нь зоогдож өөр нэг сум хөлөнд нь

зоогдсон ч мэдрэхгүй байх шиг санагдлаа. Бриен илдээ сугалаад харваачийг хайн дугуйран эргэлдэж байв.

- Ханын цаана гэж Жэйми хашгираад өрөөсөн нүд сохор морио тулалдааны зүг эргүүлэн давхлаа. Агаарт ахин дүүрэн сум исгэрэхэд жолоо нь хараал идсэн гинжтэй орооцолдов.

- Тэдэн рүү! гэж Жэйми хашгираад яахыг нь үзүүлэн гуядахад хөгшин хөөрхийлөлтэй морь хаанаас гарч ирснийг үл мэдэх хүчээр ухасхийж тариан талбай дээгүүр будааны сүрэл бужигнуулан давхлаа. *Тэднийг урдаас нь зэвсэггүй гинжтэй хүн дайрч байгааг мэдэхээс өмнө хүүхэн дагасан нь дээр* гэсэн бодол зурсхийхэд араас нь давхиж яваа дуулдав.

- Үдшийн бүрий! Тарт! Тарт! гэж Бриен анжисны морьтойгоо тачигнуулан хашгирахад урт илдээ сугалан барьжээ.

Дэргэдүүр нь хэдэн сум онолгүй өнгөрөхөд харваачид хүлэг баатрын дайралтын өмнө дэмжлэггүй үедээ үргэлж зугтдаг шигээ бутран зугатав. Бриен ханын дэргэд жолоогоо татлаа. Жэйми түүний дэргэд очиход харваачид хорин ярдын зайтай модон дунд уусан алга болж байв.

- Яасан тулалдааны амтаа алдаа юу?

- Тэд зугтаж байна.

- Энэ бол тэднийг алах хамгийн дээр үе гэхэд Бриен илдээ хуйлаад,

- Чи яагаад дайрсан юм? гэлээ.

- Харваачид ханын ард зогсон чам руу алсаас харвах үедээ аймшиггүй байдаг ч тэдэн рүү очвол зугтдаг. Тэд чамайг хүрвэл юу болохыг мэдэж байгаа. Ингэхэд нуруунд чинь сум зоогдсоныг мэдэж байна уу. Бас нэг сум хөлөнд чинь байна. Хэрвээ чи намайг суллавал би сумыг чинь сугалъя.

- Чи юу?

- Өөр хэн гэж? Сүүлчийн удаа намайг үеэл Клеосоо харах үед морь нь толгойгоор нь газар хагалан давхиж байсан. Тэгсэн ч бид түүнийг олох ёстой. Тэр ямар ч гэсэн Ланнистер шүү дээ.

Тэд дөрөөндөө орооцолдсон хэвээр байгаа Клеосийг оллоо. Баруун гарт нь нэг сум зоогдож өөр нэг сум цээжинд нь оносон ч газар түүнийг зүйл дуусгажээ. Толгойны орой нь цусанд зунгааралдан хүрэхэд зөөлөн нялцганаж арьсны дор Жэймигийн хүрэлтэнд хугарсан яс мэдрэгдэв.

Бриен өвдөг сөгдөн гарыг нь аваад,

- Түүний бие бүлээн байна гэв.

- Тэр удахгүй хөрнө. Би түүний морь, хувцсыг авмаар байна. Ноорхой хувцас, нохой бөөснөөс залхаж гүйцлээ.

- Тэр чиний үеэл шүү дээ гээд Бриен цочирдон харлаа.

- Байсан гэж Жэйми зөвшөөрөв. - Айх хэрэггүй дээ би хангалттай олон үеэлтэй. Бас түүний сэлмийг ч гэсэн авна. Чамд харуулд гарах хүн хэрэгтэй гэхэд,

- Чи зэвсэггүй харуулд зогсож чадна гээд Бриен бослоо.

- Модонд гинжлээстэй юу? Магадгүй би чадах л байх л даа. Эсвэл дараагийн удаа дээрэмчид гарч ирэхэд наймаалцан чиний бүдүүн хүзүүг мушгих боломж өгдөг ч юм билүү, бүсгүй минь.

- Би чамайг зэвсэглэхгүй. Тэгээд ч миний нэрийг...

- ...Бриен гэдэг би мэднэ. Хэрвээ би чамд гэм учруулахгүй гэдгээ тангараглавал жаахан охины айдас чинь тайвширах уу.

- Чиний ам ямар ч үнэ цэнэгүй. Чи Эйрист андгайлсан.

- Чи миний мэдэхээр хэнийг ч хуяганд нь жигнэхгүй байх. Бид хоёул намайг Хааны газар эсэн мэнд энх аваачихыг хүсч байгаа биз дээ? гээд Жэйми Клеосын дэргэд явган суун илдний бүсийг нь тайлж эхлэв.

- Түүнээс холд. Одоохон наадхаа зогсоо.

Жэйми залхаж гүйцжээ. Түүний эцэс төгсгөлгүй сэжиглэл, доромжлолд туйлдаж тахир шүд, өргөн цоохор царай үлбэгэр шингэн үснээс нь залхаж байлаа. Тэр эсэргүүцлийг үл тоомсорлон үеэлийнхээ урт илдний бариулаас хоёр гараараа атгаж цогцсон дээр жийн татлаа. Илд хуйнаасаа сугарахад тэр хэдийн сууриндаа эргэлдэн толгой дээгүүрээ үхлийн тойрог эргүүлэв. Илд илдтэйгээ тулгарахад яс янгинам хангиналаа. Бриен хэдий завандаа бүү мэд өөрийнхөө илдийг сугалжээ. Жэйми хөхөрлөө.

- Маш сайн байна, бүсгүй минь.

- Надад илдээ өг, хааны алуурчаа.

- Өө тэгэлгүй яахав гээд хөл дээрээ үсрэн босч ухасхийхэд урт илд гарт нь амилан бүжиглэв. Бриен арагш үсрэн цохилтыг няцаахад араас нь даган дайралтаар шахлаа. Хоёр илд тулгарснаа хангинан салж ахин үнсэлдэхэд Жэймигийн цус хөөрөв. Үүнийг л хэлээд байсан юм. Тэр үүний төлөө төрсөн болохоор хэзээ ч тулалдаж байх үеийнх шигээ амьд, цохилт бүр нь үхлийн аюултай байсангүй. *Миний бугуй гинжтэй болохоор хүүхэнд өрсөлдөгч болох цаг олгож байгаа юм.* Гинж нь түүнийг хүчээр хоёр гараар бариулж байгаа ч илд нь хоёр гараар барьдаг жинхэнэ их илдний хэмжээ жинд хүрэхгүйд ямар хамаа байна. Үеэлийнх нь илдний урт Тартын Бриениг дуусгахад хангалттай хүрнэ.

Өндөр нам, дээшээ доошоо гээд тэр илдийн цохилт ар араас нь буулгалаа. Зүүн, баруун, хойшоо налуу эргэлдэн хүчтэй цавчихад илд мөргөлдөн оч үсэрч дээшээ, доошоо, хажуугийн гээд үргэлж түүн рүү дайран хөдөлж алхам гулган, алхам хөдөлж, алхам дайран улам түргэн цавчилтаар

нүдсээр...

Эцэст нь амьсгаадан алхам ухраад илдийн үзүүрийг газар шигтгэн Бриенд амсхийх хором өглөө.

- Хүүхэн гэхэд муугүй шүү гэж цэгнэв.

Бриен удаан гүн амьсгал авч түүнийг болгоомжтой ширтлээ.

- Би чамд гэм учруулахгүй, хааны алуурчаа.

- Чаддаг юм бол тэгээрэй гээд Жэйми илдээ ахин толгой дээрээ эргүүлэн гинжээ хангинуулан довтлов.

Жэйми хэр удаан дайснаа мэдсэнгүй. Хэдэн хором эсвэл хэдэн цаг өнгөрсөн ч байж болох илдний сэрэхэд цаг хугацаа нойрсчээ. Тэр түүнийг үеэлийнхээ цогцосноос холдуулан зам хөндлөн мод руу шахлаа. Бриен нэг удаа үндсэнд харалгүй бүдрэхэд Жэйми агшин зуур төгсгөл нь ирлээ гэж бодсон авч унахдаа өрөөсөн өвдгөө өвдөглөн тэнцвэр алдсангүй. Түүний илд дээрээс буусан цавчилтыг хааж мөр салтаа руу цавчин ахин дахин тулалдсаар хөл дээрээ бослоо.

Илдийн бүжиг үргэлжлэв. Жэйми түүнийг царсанд шахан хажуу тийш мултрахад нь хараал тавиад унасан навч дүүрэн хөвсөн гүехэн гол руу орлоо. Илд хангинан дуулж оч асгаруулан чахрахад Бриен хавиралт бүрд гахай шиг хүржигнэж байсан ч ямар нэг аргаар өөртөө хүргэсэнгүй. Төмөр торны хамгаалалтанд байгаа аятай цавчилт бүрийг зогсоолоо.

- Ямартай ч муугүй шүү гээд Жэйми хоёр дахь удаагаа амьсгаа даран баруун талаар нь дугуйран тойрлоо.

- Эмэгтэй хүн гэхэд үү?

- Ногооноороо байгаа дагуулын хувьд гээд Жэйми хэржигнэн хөхөрч, - Алив ээ хүрээд ир хонгор минь хөгжим эгшиглэсэн хэвээр. Би таньтай бүжиглэж болох уу, хатагтай? гэв.

Бриен шуухитнан босч ирээд илдээ цавчихад гэнэтхэн Жэйми арьсандаа шүргэх шахам тулсан илдийг хаалаа. Өөр нэг цавчилт хөмсгийг нь зурахад баруун нүдийг нь даган доош цус урсав. *Өөрүүд түүнийг аваасай. Риверраныг ч гэсэн!* Жэймигийн чадвар хараал идсэн гянданд зэвэрч үгүй болон гинж нь саад болж байлаа. Нүд нь хаагдаж мөр нь хөшин бугуй нь гинж, дөнгө, илдний жинд янгинана. Урт илд нь цавчилт бүрд улам хүнд болсоор Жэйми урьдынх шигээ түргэн цавчиж өндөр өргөж чадахаа больсоноо мэдэв.

Тэр надаас илүү хүчтэй юм байна.

Үүнийг ойлгоход дотор нь жихүүцлээ. Роберт түүнээс хүчтэй байжээ. Залуу үед нь цагаан бух Геролд Хайтаур, сэр Артур Дэйн нар хүчтэй байв. Амьд үлдсэн хүмүүсийн дунд Том Жон Амбер, Крэйкхолын Хүчит бодон болон хоёр Клегэйн гарцаагүй хүчтэй байлаа. Уулын хүч чадал хүний бус байв. Гэвч энэ хамаа байсангүй. Хурд чадвараар Жэйми тэднийг бүгдийг дийлнэ. Гэтэл энэ эмэгтэй хүн шүү дээ. Том үнээ хүүхэн хэдий ч... түүнийг дийлэх нь гарцаагүй.

Гэвч оронд нь Бриен түүнийг ахин гол руу шахаж,

- Бууж өг! Илдээ доош нь хая! гэж хашгирав.

Жэймигийн хөлөнд гөлгөр чулуу таараад золгүй нь дайрахдаа хальтираад уначихлаа. Бриен цохилтоос бултахад илдний үзүүр гуяных нь дээгүүр зуран өнгөрөв. Улаан цус дуслахад Жэйми цусны бараа хараад сэтгэлийн цэнгэл эдлэхэд өвдгөөрөө чулуу цохин унаж тэсэхийн аргагүй өвдөв. Бриен ус цацлуулан илдийг нь өшиглөн холдуулаад,

- БУУЖ ӨГ! гэж хашгирахад Жэйми хөл рүү нь мөргөн дээр нь даран уналаа.

Тэд өнхрөн өшиглөж бие биенээ нудрахад эцэст нь Бриен дээр нь гарав. Жэйми хутгыг нь хуйнаас нь сугалсан ч гэдсэнд нь зоож амжихаас өмнө тэр бугуйнаас нь барьж мушгин гарынх нь арыг чулуун дээр цохиход мөр нь мултрах шиг санагдав. Бриен нөгөө гараараа нүүрэн дээр нь дарж,

- Бууж өг! гээд толгойг нь усанд дүрснээ дээш татан гаргалаа.

- Бууж өг! гэхэд Жэйми царай руу нь ус нулимтал ус цацлуулан ахин усан дор оронд амьсгалахын тулд хөлөөрөө тийчигнэхэд татан гаргав.

- Бууж өг эсвэл би чамайг живүүллээ шүү!

- Амлалтаа эвдэх нь үү? Над шиг уу? гэж Жэйми архирав.

Бриен түүнийг тавихад ус цацлан хойш унасанд модонд хахир инээд хадав.

Бриен хөл дээрээ ухасхийн бослоо. Тэр битүү шаварт будагдан бүсэлхий доогуураа цус болж хувцас хэлтийгээд царай нь улайжээ. *Тэр яг л тулалдахын оронд надтай унтаж байгаад баригдсан юм шиг харагдаж байна. Жэйми гүехэн усанд чулуун дээр мөлхөн нүднээсээ гоожсон цусыг гинжтэй гараараа арчив. Голын хоёр талд зэвсэглэсэн хүмүүс зогсчээ. Бид лууг ч гэсэн сэрээхээр их чимээ бгаргасан юм чинь өчүүхэн ч гайхах зүйл алга.*

- Уулзахад таатай байна, нөхдөө. Та нарыг үймүүлсэн бол өршөөгөөрэй. Та нар намайг эхнэрээ зодож байхад барьж авлаа гэж хөгжилтэй хэлэхэд,

- Харин надад тэр чамайг зодож байх шиг санагдсан гэж хамрынхаа хоосон нүхийг далдлан хамгаалалттай төмөр богино дуулга өмссөн бүдүүн хүчтэй хүн хэлэв.

Тэднийг сэр Клеосыг алсан дээрэмчид биш болохыг Жэйми гэнэтхэн ойлголоо. Ертөнцийн хамаг хог шавхруу болох бор царайтай Дорнишийн хүн, цайвар Лайсени, гэзгэндээ хонх зүүсэн Дотраки, үсэрхэг Иббенс, Зуны арлын өдөн нөмрөгтэй нүүрсэн хар хүмүүс тэднийг тойрон зогсож байв. Жэйми тэднийг танилаа. *Зоригт нөхөд.*

- Надад зуун мөнгөн буга байгаа гэж Бриен дуугарав.

Нөхөөстэй ширэн нөмрөгтэй зэвхий цонхигор хүн,

- Бид эхлээд түүнийг чинь авна, хатагтай гэв.

- Тэгээд чамайг нухна. Эрхтэн чинь биений бусад хэсэг шиг царай муутай биш байх гэж хамаргүй хүн хэлэв.

- Түүнийг цааш нь харуулаад өгзөг рүү нь хий, Рог. Тэгвэл царайг нь харах шаардлагагүй гэж улаан торгон ороолт дуулган дээгүүрээ боосон Дорнишийн жадчин шавдуулав.

- Дараа нь надад таашаал өгснийх нь төлөө дээрэмдэнэ гэж хамаргүй хүн хэлэхэд бусад нь инээлдэв.

Царай муутай зөрүүд ч бай Бриен иймэрхүү бүлэг амьтанд хүчиндүүлэхээс дээрийг хүртэх тавилантай байлаа.

- Энд хэн захирч байгаа юм? гэж Жэйми чанга асуув.

- Надад энэ хүндэтгэл оногдсон, сэр Жэйми гээд зэвхий царайт улаан хөвөөтэй нүдээр ширтэхэд шингэн үс нь бохир хиртэй байлаа. Түүний гар, царайны цайвар арьсан дор бараан цэнхэр судас нэвт харагдана.

- Намайг Өрзвик гэдэг. Сүсэгтэн Өрзвик гэж дууддаг юм.

- Чи намайг хэн гэдгийг мэдэх үү?

- Зоригт нөхдийг мэхлэхийн тулд илүү их үс сахлаа хусах хэрэгтэй дээ гээд гээд хөлсний цэрэг толгойгоо гилжийлгэв.

Цуст жүжигчид гэж чи хэлэх гээ юу. Жэйми Грегор Клегэйн, Амори Лорч нарын адил эдгээр хүмүүсийг ашиглаж байсангүй. Тэднийг ноход гэж эцэг нь дуудах бөгөөд ноход шиг ашиглан үхтлээ айсан олзныхоо араас тавьдаг байв.

- Хэрвээ чи намайг таньж байгаа бол шан хүртэнэ гэдгээ мэдэж байгаа, Өрзвик. Ланнистерийнхан үргэлж өрөө төлдөг. Хүүхний хувьд гэвэл язгууртан гаралтай болохоор сайн золиос хүрнэ гэхэд,

- Тийм гэж үү? Ямар азтай юм бэ гээд тэр толгойгоо сэжлээ.

Өрзвигийн инээмсэглэлд байсан ямар нэг зальжин зүйл Жэймид огтхон ч таалагдсангүй.

- Чи намайг сонссон. Ямаа хаана байна?

- Эндээс хэдэн цагийн зайд байгаа. Тэр чамайг хараад баярлана гэдэгт эргэлзэхгүй байгаа ч би оронд чинь байсан бол нүүрэн дээр нь ямаа гэж дуудахгүй байсан даа. Лорд Варго бахархлыг нь хөндсөн хүнд дургүй байдаг юм.

Тэр шүлсээ гоожуулсан зэрлэгт ямар юмных нь бахархал байдаг юм?

- Тэгвэл түүнтэй уулзах үедээ үүнийг чинь санаж явъя. Юуны лорд гэсэн бэ?

- Харренхал. Үүнийг түүнд өгөхөөр амалсан.

Харренхал гэнэ ээ? Миний эцэг галзуурсан юм байх даа?

- Миний гинжийг суллаадах гээд Жэйми гараа өргөхөд Өрзвик хуурай инээд алдав.

Энд ямар нэг зүйл маш буруу байна даа. Жэйми эвгүйцсэнээ мэдэгдэхгүйн тулд инээмсэглэв.

- Би ямар нэг хөгжилтэй зүйл хэлсэн билүү?

- Чи бол намайг Хазагчийн септагийн хөхийг зулгаахыг харснаас хойш хамгийн хөгжилтэй зүйл гээд хамаргүй хүн инээлээ.

- Чи болон эцэг чинь дэндүү олон тулалдаанд ялагдсан болохоор бид арслангийн арьсаа чонынхоор сольсон гэж Дорнишийн хүн хэлэв.

Өрзвик гараа зөрүүллээ.

- Тимеон Зоригт нөхөд Ланнистерийн овогт хөлслөгдөхөө болиод удаагүй гэж хэлэх гэсэн байх даа. Бид одоо лорд Болтон болон Умардын хаанд зүтгэж байгаа.

- Хүмүүс намайг зөвхөн нэр хүндээ нулимсан гэдэггүй бил үү? гээд Жэйми хүйтнээр тоомсоргүй инээмсэглэлээ.

Өрзвигт энэ үг таалагдсангүй. Түүнийг дохио өгөхөд хоёр Жүжигчин Жэймигийн гарнаас барьж аван Рог төмөр бээлийтэй нударгаар гэдэс рүү нь цохив. Түүнийг дөрвөн хөллөн дуу алдахад Бриенигийн эсэргүүцэх сонсогдлоо.

- Больцгоо түүнд ямар ч гэм учрах ёсгүй! Хатагтай Кателин биднийг олзлогсад солилцохоор явуулсан болохоор тэр миний хамгаалалтанд байгаа... гэтэл Рог түүнийг ахин уушигнаас нь амьсгал гартал хүчтэй цохив. Бриен илдээ голын усанд унагасан болохоор эрж олохоос нь өмнө жүжигчид түүн рүү хүрч очсон ч хүчтэй болохоор буулгаж авахад дөрвөн хүний туслалцаа шаардагдав.

Эцэст нь Бриенигийн нүүр Жэймигийнхээс дутуугүй цус болон хавдаж хоёр шүдээ булга цохиулжээ. Тэглээ гээд гадаад төрх нь сайжирсангүй. Бүдчин цус урсгасаар хоёр олзлогдогч модон дундуур морь луугаа чирэгдэн буцлаа. Бриен гуянд олсон шархнаас доголно. Жэйми түүнийг өрөвдөх сэтгэл төрлөө. Тэр өнөө шөнө охин насаа алдах нь эргэлзээгүй. Хамаргүй дээрэмчин гарцаагүй үүнийг хийх болохоор бусад нь ч гэсэн дуртайяа ээлжлэнэ.

Дорнишийн хүн тэр хоёрыг Бриенигийн анжисны морин дээр суулган хүлэхэд өөр нэг дээрэмчин сэр Клеосын хувцсыг нэгжин юмыг нь хувааж авлаа. Рог Ланнистер, Фрейгийн бардам сүлдтэй цусанд будагдсан хүрмийг нь хожжээ. Сумны нүх арслан, цамхагын алинд ялгаагүй гарсан байв.

- Чамайг баярлана гэж найдаж байна, бүсгүй минь. Хэрвээ чи намайг зэвсэглэсэн бол бид хэзээ ч баригдахгүй байсан даа гэж Жэйми Бриенд шивнээд ханиалган ам дүүрэн цус нулимхад хариу дуугарсангүй. *Дүүрчихсэн зөрүүд гичий. Гэхдээ зоригтой л доо* гэж бодлоо. Тэр үүнийг нь түүнээс авч чадахгүй.

- Бид өнөө шөнө буудаллахад чи ар араас нь ахин дахин хүчиндүүлнэ. Эсэргүүцэхгүй байсан чинь дээр шүү. Хэрвээ тэдний урдаас эсэргүүцвэл ахин хэдэн шүдээ алдана гэхэд Бриенигийн нуруу чангарлаа.

- Энэ чиний хийдэг зүйл үү? Хэрвээ чи эмэгтэй хүн байсан бол яах байсан юм?

Хэрвээ би эмэгтэй байсан бол Серсей байх байсан юм.

- Хэрвээ би эмэгтэй хүн байсан бол тэдэнд өөрийгөө алуулах байсан. Гэхдээ тийм биш гээд Жэйми морио давиран хатирууллаа.

- Өрзвик! Хэлэх үг байна.

Ноорхойн ширэн нөмрөгтэй зэвхий царайт хөлсний цэрэг жолоогоо татаж зэрэгцэн ирэв.

- Ямар учраас миний хэрэг гараа вэ, сэр? Амаа мэдэж ярихгүй бол ахин нүдүүлнэ шүү.

- Алт. Чи алтанд дуртай юу? гэж Жэйми хэллээ.

- Хэрэг болж болох л юм гээд Өрзвик улаан нүдээрээ түүнийг шинжив.

Жэйми Өрзвигийг ойлгосон байртай инээмсэглэв.

- Кастерли Рок бол бүхэлдээ алт. Яагаад ямаа үүнийг хүртэх ёстой гэж? Яагаад чи биднийг Хааны газар аваачиж золиосны мөнгийг минь өөрөө авч болохгүй гэж? Хүсвэл түүнийхийг ч гэсэн ав. Тартыг Индраанил арал гэж дууддаг гэж урьд нь надад нэг хүүхэн хэлсэн юм гэхэд Бриен биеэ чангалсан ч юу ч хэлсэнгүй.

- Чи намайг талаа буруул гэж байгаа юм уу?

- Гарцаагүй. Өөр юу байна гэж?

Хэсэг зуур Өрзвик саналыг эрэгцүүлж үзэв.

- Хааны газар хүртэл хол зам туулна. Тэгээд ч эцэг чинь тэнд байгаа. Лорд Тайвин биднийг Харренхалыг лорд Болтонд зарсанд дургүйцнэ.

Тэр харагдаж байгаагаасаа илүү ухаалаг юм гээч. Жэйми түүнийг халаас нь түнтийсэн алттай дүүжлүүлсэнээр төсөөлжээ.

- Намайг эцэгтэй минь учрыг олуулахаар орхи. Би чамд ямар ч хэрэг хийсэн байсан хамаагүй

хааны өршөөл гаргуулья. Би чамайг хүлэг баатар болгоно.

- Сэр Өрзвик. Хүндэт эхнэр минь үүнийг сонссон бол хичнээн бахархах байсан бол. Звхөн би түүнийг алаагүй бол шүү дээ гэж тэр санаа алдан хэлснээ,

- Зоригт лорд Варго яах юм бэ? гэлээ.

- Би чамд "Кастамерийн Рэйнс" гэдэг дуу дуулж өгөх үү? Ямаа миний эцэгт баригдах үедээ тийм ч зоригтой байхгүй.

- Тэр үүнийг яаж хийнэ гэж? Эцгийн чинь гар урт болохоор Харренхалын хэрмийг даван биднийг сугалж гаргах уу?

- Шаардлагатай бол тэгнэ гээд Харрен хаан унахаасаа өмнө дүүрчихсэн тэнэг байжээ. - Чи ямаа арсланг дийлнэ гэж бодохоор тийм тэнэг хүн үү?

Өрзвик түүн рүү бөхийн бараг залхуутайгаар царайг нь алгадахад хайш яйш их зан нь цохилтоосоо дор байлаа. *Тэр надаас айхгүй байна* гэж Жэйми хирдхийн ойлгов.

- Би чамайг хангалттай сонслоо, хааны алуурчаа. Чам шиг амлалтаа зөрчигчийг өгсөн амаа биелүүлнэ гэж итгэж байвал би дүүрчихсэн тэнэг болно биз дээ гээд морио гуядан урагш давхиуллаа.

Эйрис. Үргэлж Эйрис руу эргэн ирж байх юм гэж Жэйми эгдүүцэн бодов. Тэр морины явдалд ганхан илдтэй байсан ч болоосой гэж хүслээ. Хоёр илдтэй бол бүр дээр. Нэгийг нь хүүхэнд нэгийг нь өөртөө. Бид үхэж болох ч тэдний хагасыг там руу хамт авч явна.

- Чи яагаад түүнд Тартыг Индраанил арал гэж хэлж байгаа юм бэ? Тэр миний аавыг баян эрдэнийн чулуутай гэж бодно хэмээн Бриен Өрзвигийн чихэнд сонсогдохгүй болсон хойно хэлэв.

- Түүнийг тэгээсэй гэж мөргөсөн чинь дээр шүү.

- Ингэхэд чиний хэлсэн үг бүр чинь худал байдаг уу, хааны алуурчаа? Тартыг цэнхэр усанд байдаг учраас Индраанил арал гэж дуудаг юм.

- Тэгвэл үүнийгээ чанга хашгир, бүсгүй минь. Би Өрзвик чамайг сонсоно гэж бодохгүй байна. Тэд чамайг ямар бага золиосны үнэ хүрэхийг ойлгомогц удахгүй хүчиндэж эхлэнэ. Хүн бүр дээр чинь гарах болохоор юу хийх чинь ямар хамаатай юм бэ? Зүгээр л нүдээ аньж хөлөө тэнийлгээд бүгдийг нь лорд Рэнли гэж бодохыг хичээгээрэй.

Азаар энэ үг Бриенигийн амыг хамшилаа.

Өдрийн төгсгөл дөхөхөд тэд арваад Зоригт нөхдийн хамт сүйрсэн жижиг дуганд байгаа Варго Хот руу очив. Хээтэй цонхнуудыг хагалж сийлбэртэй модон бурхдыг нарны гэрэлд гарган шиджээ. Тэднийг орж очиход Жэймигийн урьд хожид хараагүй хамгийн тарган Дотраки Ээжийн цээжин дээр сандайлан суугаад мана эрдэнийн чулуун нүдийг нь хутганы үзүүрээр ухаж байлаа. Ойролцоо

нь туранхай халзан спетоныг туулайн бөөр модны мөчрөөс толгойг нь уруу харуулан дүүжилжээ. Гурван Зоригт нөхөд цогцсон дээр харвах сургууль хийж байсны нэг нь сайн харваач бололтой үхсэн хүний хоёр нүдний ухархайд сум битүү шивжээ.

Хөлсний цэргүүд Өрзвигийг олзны хүмүүстэйгээ ирэхийг ажигламагц хэдэн янзын хэлээр хашгиралдав. Ямаа түүдгийн дэргэд суугаад шүүрхий болсон шортой шувууны мах идэхэд урт сахал, хурууг нь даган тос цус урсана. Тэр гараа цамцандаа арчаад бослоо.

- Хааны алуурт. Чи миний олзлогдогт болсон гэж шүлхий дуугаар хэлэв.

- Эрхэм лорд минь намайг Тартын Бриен гэдэг. Хатагтай Кателин Старк надад сэр Жэймиг хааны газарт байгаа дүүд нь хүргэж өгөхийг тушаасан юм гэж Бриен хэлэхэд ямаа түүнийг сонирхсон шинжгүй харлаа.

- Түүнийг дуугүй болго.

- Намайг сонсооч. Та нарын зүтгэдэг Умардын хааны нэрийн өмнөөс сонсооч... гэж Бриен Рогын Жэйми тэр хоёрыг хүлсэн уяаг огтлоход хэлэхэд мориноос гулдран буулгаад өшигчиж эхлэв.

- Ясыг нь битгий хугалчихаарай. Морин царайтай гичий биеийнхээ жингээр индраанил чулууны үнэтэй шүү гэж Өрзвик хэлэв.

Дорнишийн Тимеон, өмхий үнэртэй Иббенс хоёр Жэймиг эмээлээс угз татан буулгаж түүдгийн зүг бүдүүлгээр аваачив. Жэйми тэгэхэд нэгнийх нь илдийг сугалахад хэцүү биш байсан ч тэд дэндүү олуул байсны дээр тэр дөнгөтэй байлаа. Тэр магадгүй нэг хоёр хүнийг цавчин унагаасан ч эцэст нь үхэх болно. Жэйми үхэхэд хараахан бэлэн болоогүйн дээр Тартын Бриен ч гэсэн дуртай байсангүй.

- Өнөөдөр сайхан өдөр байна гэж Варго Хот хэлэв. Тэр хүзүүндээ янз бүрийн хэлбэр дамжаа төрхтэй хаан, шидтэн, бурхад, чөтгөр болон бүх төрлийн этгээд араатны дүрстэй зоос зүүжээ.

Түүний тулалдсан газар бүрийн зоос гэж Жэйми ухаарлаа. Шунал бол энэ хүний түлхүүр. Хэрвээ тэр нэг удаа урвасан бол ахин урвах болно.

- Лорд Варго та эцэгт минь зүтгэхээ болин тэнэг зүйл хийсэн ч одоо засахад тийм ч оройтоогүй байна. Түүнийг надад сайн шан төлнө гэдгийг чи мэдэж байгаа.

- Өө, тэгэлгүй яахав. Кастерли Рокийн алтын хагасыг би авна. Гэхдээ эхлээд би түүнд илгээмж явуулна гээд ямааны хэлээрээ ямар нэг зүйл хэлэв.

Өрзвик түүнийг араас нь түлхэхэд ногоон ягаан эрээн өнгийн хувцастай тэнэг хөл рүү нь өшиглөн суулгав. Жэймиг газар унахад харваачид гинжтэй бугуйнаас нь барьж урагш нь татлаа. Тарган Дотраки хутгаа хойш тавиад морьтон лордуудын дуртай хурц илдэн хадуур болох том тахир аракхаа сугалав.

Тэд намайг айлгах гэж байгаа юм. Дотраки түүн рүү ихэмсэгээр даналзан алхахад тэнэг

Жэймигийн ард дэвхцэн хөхрөв. *Ямаа намайг өмдөндөө тавьж өршөөл гуйхыг хүсч байгаа ч хэзээ ч энэ бүтэхгүй.* Тэр бол Кастерли Рокийн Ланнистер, Хааны хамгаалалтын захирагч болохоор ямар ч хөлсний цэрэг түүнийг хашгируулж дөнгөхгүй.

Нарны гэрэл аракхын мөнгөн ирмэг дээр тоглон доош чичигнэхэд харахын зуургүй түргэн исгэрэв. Тэгтэл Жэйми хашгирлаа.

АРЪЯА

Тал нь нурсан жижигхэн дөрвөлжин бэхлэлтэд зөвхөн ганц том буурал хүлэг баатар амьдарч байв. Тэр маш хөгшин болохоор асуултыг нь ойлгосонгүй. Тэдний юу ч хэлсэн байсан хамаагүй урдаас нь зөвхөн инээмсэглэн,

- Би сэр Мэйнардын эсрэг гүүрийг тогтоосон. Улаан үс дүрэлзсэн авиртай тэр намайг хөдөлгөж чадаагүй. Би түүнийг алахаасаа өмнө зургаан шарх авсан. Зургаа шүү! гэж бувтнаад байлаа.

Түүний шархыг үзэж байсан мэйстер аз болоход залуу хүн байв. Хөгшин хүлэг баатар сандал дээр унтсан хойно тэр тэднийг хажуу тийш нь аваачаад,

- Би та нарыг сүнсний араас нэхэж яваа гэж айж байна. Бидэнд бараг хагас жилийн өмнө шувуу ирсэн. Ланнистерийнхан лорд Берикийг Бурхдын нүдний ойролцоо барьж аваад дүүжилсэн гэв.

- Тиймээ түүнийг дүүжилсэн ч Торос үхэхээс нь өмнө олсыг огтолсон. Эрхэм лорд алахад бэрх хүн гэж хугарсан хамрынх нь хавдар бууран мурий эдгэж царай нь хазгайдуу төрхтэй болсон Лем хэлэв.

- Дээрээс нь олоход ч гэсэн бэрх хүн санагдаж байна. Та нар Навчсын хатагтайгаас асуув уу? гэж мэйстер асуухад,

- Бид асууна гэж Ногоон сахалт хэллээ.

Маргааш өглөө нь тэд цайзын ард талын жижигхэн чулуун гүүрийг гатлахад Жэндри хөгшин хүний тулалдсан гүүр мөн эсэхийг гайхширахад хэн ч үүнийг мэдсэнгүй.

- Харваас тийм бололтой. Өөр гүүр харагдахгүй байна гэж Азтай Жак хэлэв.

- Хэрвээ энэ тухай дуу зохиогдсон бол бид тодорхой мэдэх байсан даа. Ганц сайн дуу байхад бид сэр Мэйнард хэн байсан яагаад гүүрийг гатлахыг тэгтлээ хүссэнийг мэдэх байсан. Хөөрхий хөгшин Лайчестер дэргэдээ дуучин байлгах ухаантай байсан бол луун хүлэг баатраас дутуугүй алдартай болох байлаа гэж Долоон чавхдаст Том хэлэв.

- Лорд Лайчестерийн хөвгүүд Робертийн бослогын үеэр үхсэн. Зарим нь нэг талд нөгөөдүүл нь өөр талд. Түүнээс хойш ухаан орон гаран болсон болохоор ямар ч дуу үүнд тусалж чадахгүй гэж Лем бувтнав.

- Мэйстер Навчсын Хатагтайн тухай юу хэлсэн бэ? гэж Арьяа явах зуураа Энгайгаас асуухад,

- Хүлээгээд өөрөө хараарай гээд харваач инээмсэглэв.

Тэднийг гурван өдрийн турш шаргалтсан ой дундуур явсны эцэст Азтай Жак бүрээгээ сугалан урьдынхаас өөр дохио үлээхэд бүрэн дуу намдаж амжаагүй байхад модны мөчрөөс олсон шат дэлгэгдэн унжлаа.

- Морьдоо тушаад дээшээ өгслөө гэж Том аялав. Тэд алтлаг улаан навчсын хананы ард далдлагдсан олсон замаар холбогдсон хөвдөнд хучигдсан байшинтай модны мөчир дээрх нууц тосгон руу авирахад Навчсын хатагтай гэдэг саваа шиг туранхай цагаан үстэй бүдүүн даавуугаар хувцасласан эмэгтэйд хүргэлээ.

- Намар болсон болохоор бид энд удаан үлдэж болохгүй. Хэйфордын замаар арваад чоно есөн өдрийн өмнө агнан өнгөрсөн. Хэрвээ тэд дээшээ харсан бол биднийг харж болох байлаа гэж эмэгтэй ярихад,

- Та лорд Бериктэй уулзаагүй юу? гэж Долоон чавхдаст Том асуув.

- Тэр үхсэн. Уул түүнийг барьж аваад нүдэнд нь хутга зоосон гэж гуйлгачин ах дүү бидэнд хэлсэн. Тэр өөрийн нүдээр хараагүй зүйлийг амаар хэлэх хүн биш гэж эмэгнэсэн дуугаар хэллээ.

- Хуучирсан хуурамч түүх байна. Аянгат лордыг алахад амаргүй. Сэр Грегор нүдийг нь сугалсан байж болох ч хүн үүний төлөө үхдэггүй. Жакаас энэ тухай асуугаарай гэж Лем өгүүлэв.

- Тиймээ би үхээгүй. Харин эцэг минь илүү дээрийг хүртэн лорд Пайперт дүүжлүүлж, дүү Ват маань Хана руу илгээгдэн, Ланнистерийнхан бусад ах дүүсийг минь алсан. Нүд бол юу ч биш гэж өрөөсөн нүдтэй Азтай Жак хэлэв.

- Чи түүнийг үхээгүй гэж андгайлж байна уу? гээд эмэгтэй Лемийн гараас зуурлаа.

- Бурхад чамайг ивээг, Лем. Энэ бидний хагас жилийн хугацаанд сонссон хамгийн сайхан мэдээ байна. Магадгүй Дайчин түүнийг ивээж улаан хувраг хамгаалах бизээ.

Дараагийн шөнө тэд Сэлиданс гэдэг шатсан тосгоны харласан сүмд толгой хорогдов. Хээтэй шилэн цонхноос зөвхөн хагархай үлдэж настай септон тэднийг угтан дээрэмчид Ээжийн үнэт хоргой жанчийг хуулан, Чавганцын алтадсан дэнлүү, Эцгийн мөнгөн титмийг авсан гэж хэллээ.

- Тэд Охины хөхийг цавчсан ч зөвхөн мод байсан. Бас хаш, номин, тана нүднүүдийг нь хутгаараа ухан авсан. Магадгүй Ээж тэднийг өршөөх буй за.

- Энэ хэний хийсэн ажил вэ? Жүжигчдийнх үү? гэж Шаргал нөмрөгт Лем асуулаа.

- Үгүй. Тэд умардынхан байсан. Модонд мөргөдөг зэрлэгүүд. Тэд Хааны алуурчийг хайж яваа гэж хэлсэн.

Арьяа үүнийг сонсоод уруулаа хазан Жэндриг ширтэхэд ичсэндээ уурлах сэтгэл төрөв.

Сүмийн доод талын зооринд аалзны шүлс, модны үндэс, хэмхэрсэн дарсны торхны дунд арваад хүмүүс байсан ч Берик Дондаррионы тухай ямар ч үг сонссонгүй. Тэдний удирдагч нь болох хөөн хар хуяг дээр бүдүүлэг аянгын цахилгаантай нөмрөг нөмөрсөн хүн хүртэл мэдэхгүй байлаа. Ногоон сахалт Арьяагын түүн рүү харахыг мэдмэгц инээд алдан,

- Аянгат лорд хаа сайгүй явдаг юмдаа, туранхай хэрэм минь гэв.

- Би хэрэм биш. Би удахгүй нас бие гүйцсэн эмэгтэй болно. Би арван нэгтэй.

- Тэгвэл надтай гэрлэхгүйн тулд харж яваарай! гээд тэр эрүүг нь гижигдэхийг оролдоход Арьяа гарыг нь цохилоо.

Лем, Жэндри хоёр тэр шөнө нутгийн хүмүүстэй мод тоглоом тоглоход Долоон чавхдаст Том Бүдүүн гэдэстэй Бен, Их септоны галууны тухай тэнэг дуу дуулав. Энгай Арьяад нум сум зааж өгөхийг оролдсон ч уруулаа хичнээн хазсан ч хамаагүй хатуу хөвчийг татаж дийлсэнгүй.

- Чамд хөнгөн нум хэрэгтэй, хатагтай. Риверраны ойд тохиромжтой мод байвал би чамд нэгийг хийж өгье гэж сэвхтэй харваач хэллээ.

Том үүнийг сонсоод дуугаа таслав.

- Чи ч тэнэг юм даа, харваачаа. Хэрвээ бид Риверран явлаа гэхэд зөвхөн түүний золиосыг авахын тулд явахаас биш чамд нум сум хийгээд сууж байх зав байхгүй. Арьсаа бүтэн авч гарсандаа талархсан чинь дээр. Лорд Хостер дээрэмчдийг сахал хусахын зуургүй дүүжилдэг. Харин түүний хүү.... хөгжимд дургүй итгэж болохгүй хүн гэж би үргэлж хэлдэг биз дээ гэхэд,

- Энэ бол түүний хөгжимд дургүйгээс болсон биш. Чамаас болсон, тэнэг минь гэж Лем хэллээ.

- Түүнд шалтгаан байхгүй. Тэр өөрийг нь эр хүн болгохыг хүссэн эмэгтэйд хэргээ гүйцэлдүүлж чадахааргүй болтлоо согтсон нь миний буруу юм уу? гээд Лем хугарсан хамраараа тургилав.

- Тэгвэл тэр дууг чи зохиосон юм уу эсвэл өөрийнхөө хоолойд дуртай өөр нэг хараал идсэн өгзөг зохиосон юм уу?

- Би зөвхөн нэг удаа дуулсан. Ингэхэд түүний тухай дуу гэж хэн хэлж байгаа юм? Тэр бол загасны тухай дуу байсан гэж Том гомдоллоход,

- Лазан загас гээд Энгай инээд алдав.

Арьяад Томын тэнэг дууны тухай хамаагүй байсан тул тоосонгүй Харвин руу эргэлээ.

- Тэр золиосны тухай юу хэлсэн бэ?

- Бидэнд морь туйлын хэрэгтэй, хатагтай. Бас зэр зэвсэг, хуяг дуулга, илд, бамбай, жад, үр тариа болон зоосоор худалдан авдаг бүхэн хэрэгтэй. Өвөл ирж байгааг санаж байна уу? гээд Харвин эрүүн дор нь хүрч,

- Чи бол бидний золиос авсан анхны язгууртан гаралтай олзлогдогч биш. Бас эцсийнх ч гэсэн биш гэж найдаж байна гэлээ.

Энэ үнэн болохыг Арьяа мэдэж байв. Хүлэг баатрууд баригдах үедээ үргэлж золиос төлдөг бөгөөд заримдаа эмэгтэйчүүд ч гэсэн тэгдэг байлаа. *Гэхдээ Робб тэдний нэхсэн үнийг төлөхгүй бол яана?* Арьяа алдартай хүлэг баатар биш болохоор хаан дүүгээсээ өмнө хаант улсыг тавьж

таарна. Түүний тухай хатагтай ээж нь юу гэж хэлэх бол? Энэ бүх хийсэн зүйлийн дараа ээж нь түүнийг буцааж авахыг хүсэх болов уу? Арьяа тээнэгэлзэн уруулаа хазлаа.

Маргааш өдөр нь тэд Өндөр зүрх гэдэг өндөрт сүндэрлэсэн газар очиход толгодын оройгоос Арьяад ертөнцийн хагас харагдах шиг санагдлаа. Оройн эргэн тойрон урьд нь хүчирхэг далан мод байсан газар цайвар том хожуулууд дугуйрчээ. Арьяа, Жэндри хоёрыг толгодыг тойрон явж тэднийг тоолоход гучин нэгэн ширхэг зарим нь дээр нь унтаж болохуйц өргөн байлаа.

Урьд нь Өндөр зүрх ойн хүүхдүүдийн ариун газар байсан болохоор ид шидийнх нь үлдэгдэл оршсон хэвээр гэж Долоон чавхдаст Том түүнд хэлжээ.

- Энд унтахад ямар ч муу зүйл тохиолддоггүй гэж дуучин хэлсэн байна. Арьяа үүнийг үнэн байх гэж бодлоо. Толгод маш өндөр эргэн тойрон задгай газраар хүрээлэгдсэн учир дайсан үзэгдэлгүй ойртож чадахгүй ажээ.

Андалын Ах дүүсийнхээ алуурч Эррег гэдэг хаан моднуудыг цавчин унагахад амь үрэгдсэн ойн хүүхдүүдийн сүнс байдаг гэж ярьдаг тул жирийн ардууд энэ газраас зайлсхийдэг гэж Том ярив. Арьяа ойн хүүхдүүд болон Андалуудын тухай мэдэх болохоор сүнснээс айсангүй. Тэр жаахан байхдаа Винтерфеллийн бунханд нуугдаж хаан ширээнд суугаа чулуун хаадын дунд "миний шилтгээн рүү ир" болон "мангас ба охин" зэрэг тоглоом тоглодог байлаа.

Тэгсэн ч шөнө унтаж байхад шилэн хүзүүний үс нь өрвийлөө. Түүнийг унтаж байхад нь шуурга сэрээж салхи нөмрөгийг нь хуулан бут руу хийсгэв. Арьяа араас нь явахдаа хоолой сонслоо.

Буудлын цогшсон түүдгийн дэргэд Том, Лем, Ногоон сахалт гурав Арьяагаас тохой намхан Хөгшин Нанаас ч өндөр настай булцуутай хар модон таяг тулсан бөгтөр үрчлээтэй бяцхан эмгэнтэй ярьж байв. Түүний цагаан үс газар шүргэх шахам урт бөгөөд салхины үлээх аясаар үүл шиг намирна. Бие нь сүү шиг цагаан, Арьяад улаан нүдтэй санагдсан ч бутан дунд хэлэхэд бэрх байлаа.

- Хуучин бурхад намайг унтуулсангүй. Би зүүдэндээ дүрэлзсэн зүрхтэй сүүдэр алтан буга алахыг харсан. Би савласан гүүрэн дээр зогсож байгаа нүүргүй хүн харсан. Түүний мөрөн дээр живсэн хэрээ суугаад далавчнаас нь тэнгисийн замаг унжиж байлаа. Би оволзсон голд загас эмэгтэй зүүдэлсэн. Тэр үхсэн чигээр хөвж хацар дээр нь улаан нулимс байсан ч нүдээ нээх үед би айсандаа цочин сэрсэн. Энэ бүхэн болон өөр олон зүйл зүүдэлсэн. Та нарт миний зүүдэнд төлөх шан байна уу? гэж эмгэн хэлэв.

- Зүүдэнд сайн юм юу байна? Загас эмэгтэй, живсэн хэрээ гээд л. Би өнгөрсөн шөнө урьд нь таньдаг байсан дэн буудлын эмэгтэй үнсэж зүүдэлсэн. Чи надад үүнийг төлөө төлөх үү, эмгэн минь? гэж Шаргал нөмрөгт Лем хэлэв.

- Чиний эмэгтэй үхсэн. Одоо түүнийг зөвхөн өг үнсэж магадгүй гээд эмгэн Долоон чавхдаст Том руу хандан,

- Надад дуу дуулж өг эсвэл эндээс явцгаа гэв.

Дуучин түүнд зориулан зөөлөн атлаа гунигтай аялгуу тоглоход Арьяа үгийг нь сонсмогц танил санагдав. Санса үүнийг мэдэх байсан гэж мөрийцсөн ч болох юм. Эгч нь бүх дууг мэддэг заримыг нь тоглон сайхан дуулдаг байлаа. Харин Арьяагын чадах зүйл гэвэл үгийг нь хашгирах явдал байв.

Маргааш өглөө нь сэрэхэд бяцхан цагаан эмгэн хаа ч байсангүй. Морьдоо эмээллэх зуур Арьяа Долоон чавхдаст Томоос ойн хүүхдүүд урьдын адил Их зүрхэнд байгаа хэвээр эсэхийг асуухад дуучин инээмсэглэн,

- Чи түүнийг хараа юу? гэлээ.

- Тэр сүнс байсан юм уу?

- Сүнс үе мөч нь чухарч байгаа тухай гомдоллодог билүү? Үгүй дээ, тэр ердөө одой эмэгтэй байсан юм. Муу ёрын нүдтэй этгээд эмгэн. Гэхдээ тэр хэний ч мэдэхгүй зүйлийг мэддэг болохоор заримдаа чамайг хараад таалагдвал хэлдэг юм.

- Тэр чамайг хараад таалагдаа юу? гэж Арьяа тээнэгэлзэн асуухад дуучин хөхөрлөө.

- Надад биш дуунд минь дуртай. Тэр үргэлж надаар ижилхэн дуу дуулуулдаг. Муугүй дуу ч би өөр бусад олон сайн дуу мэднэ гээд толгой сэгсэрч,

- Гэхдээ хамгийн чухал нь бид одоо мөрөөр орсон болохоор чамайг удахгүй Аянгат лорд, Торос хоёртой уулзана гэж мөрийцсөн ч болох байна гэв.

- Хэрвээ та нар тэдний хүмүүс юм бол яагаад нуугдаад байгаа юм?

Долоон чавхдаст Том үүнд нүдээ эргэлдүүлсэн бол Харвин хариулав.

- Би үүнийг нуугдах гэж нэрлэхгүй ч үнэн байж болох талтай, хатагтай. Лорд Берик нэг газартаа тогтож суудаггүйн дээр бидэнд төлөвлөгөөгөө ховорхон дэлгэдэг. Ийм учраас хэн ч түүнээс урваж чаддаггүй юм. Гэвч одоо бид зуугаад эсвүүл мянгуул байсан ч түүнтэй мөр зэрэгцэн явах боломжгүй. Бид зэлүүд газар хоол ундгүй болж тулалдаанд өөрсдөөсөө их цэрэгт дийлдэж болзошгүй. Тийм учраас жижигхэн бүлэг болон тарж дайсныг сэхээрч амжаагүй байхад нэгэн зэрэг арван газар цохилт өгч чаддаг. Хэрвээ хэн нэг маань баригдаж байцаагдвал лорд Берикийг хаана байгаа болон юу хийж байгааг мэдэхгүй гээд тээнэгэлзсэнээ,

- Чи байцаагдах гэж юу болохыг мэдэх үү? гэхэд Арьяа толгой дохив.

- Гижигдэх гэж тэд үүнийг нэрлэдэг юм. Поливер, Рафф болоод бусад нь гээд Бурхдын нүдний тосгонд Жэндритэй баригдах үед Гижигдэгчийн асуудаг байсан асуултын тухай ярьж өглөө.

- Тосгонд нуусан алт байгаа юу? гэж тэр үргэлж эхэлдэг байсан. Мөнгө, үнэт эрдэнэс? Хоол байгаа юу? Лорд Берик хаана байна? Тосгоны ямар хүмүүс түүнд тусалж байсан бэ? Тэр аль зүг явав? Түүнтэй цуг хичнээн хүн байсан бэ? Хэдэн хүлэг баатар хичнээн нум сумчин байв? Тэд хичнээн морьтой хэр зэвсэглэсэн байсан бэ? Хэдэн хүн нь шархадсан байв? Хаашаа явж байгаа гэж хэлсэн бэ? гээд энэ тухай санахад ахин хашгиралт сонсогдон цусны эхүүн үнэр, ялгадас,

түлэгдсэн биений үнэр ханхлахыг мэдэрлээ. - Тэр үргэлж адилхан асуулт асуудаг байсан ч өдөр бүр гижигдэлтээ өөрчилдөг байсан гэхэд,

- Хүүхэд ийм зүйл үзэх ёсгүй гэж Харвин түүнийг яриагаа дууссан хойно хэлэв.

- Бид Уулыг Чулуун тээрэмд хүмүүсийнхээ хагасыг алдсан гэж сонссон. Магадгүй Гижигдэгч одоо Улаан салааны дагуу хөвж загас нүүрийг нь хэмлэж байж мэднэ. Хэрвээ үгүй бол тэд хийсэн гэмт хэргийнхээ төлөө хариулах болно. Би лордыг дайн эхэлж Гар түүнийг хааны зарлигийг биелүүлэн Грегор Клегэйнийг барихаар явуулахад ингэж хэлэхийг нь сонссон гээд мөрийг нь тайвшируулан алгадаж,

- Мордсон чинь дээр байх, хатагтай. Боргоцой танхим хүртэл удаан өдрийн газар байгаа болохоор эцэст нь бид дээвэр дор толгой хоргодож гэдсэндээ халуун хоол хийх нь гэлээ.

Энэ нь үнэхээр удаан өдрийн аян болсон бөгөөд бүрий болоход голын гарам гатлан чулуун хэрэм, том царсан бэхлэлттэй Боргоцой танхим руу өгсөв. Гэрийн эзэн хаа нэгтээ өөрийнхөө эзэн лорд Вэйнсд бараа болон дагалдаж тулалдаж байгаа учир эзгүйд нь цайзын хаалга хаалттай цоожтой байлаа. Гэвч хатагтай эхнэр нь Долоон чавхдаст Томын хуучин анд бөгөөд Энгай тэднийг урьд нь хайртууд байсан гэж хэлжээ. Энгай Арьяагын дэргэд үргэлж явах бөгөөд Жэндриг эс тооцвол түүнтэй ойролцоо насны тул Дорнишийн Маршийн тухай инээдтэй зүйл ярина. Тэгсэн ч Арьяа хууртагдсангүй. *Тэр миний найз биш. Тэр зөвхөн намайг ахин зугтаалгахгүйн тулд ойроос харж байгаа юм.* Арьяа ч гэсэн харж чадна. Сирио Форел түүнд үүнийг сургасан билээ.

Хатагтай Смолвуд дээрэмчдийг эелдэгээр угтсан ч жаахан охиныг дайн дундуур дагуулан явсанд зэмлэлээ. Түүнчлэн Лем Арьяаг язгууртан гаралтай гэж хэлэхэд улам уурлав.

- Хөөрхий хүүхдийг хэн Болтоны ноорхой хувцсаар хувцаслаа вэ? Тэр сүлдийг нь хараач. Цээжин дээрээ өвчүүлсэн хүний сүлдтэй хувцас өмссөний төлөө олон хүн түүнийг нүд ирмэх зуур дүүжилж болох байлаа гээд Арьяаг нэн даруй шат өгсүүлэн хүчээр түмпэнд оруулан халуун усаар шалз угаалаа. Хатагтай Смолвудын зарц эмэгтэй биеийг нь дэндүү чанга үрсэн учир Арьяад арьсаа өвчүүлж байгаа юм шиг санагдан тэр ч байтугай усанд нь цэцэгний үнэртэй нялуун зүйл нэмэрлэв.

Үүний дараа тэд түүнийг охины хувцас болох хүрэн ноосон оймс, цайвар судалтай цамцан дээгүүр цээжин дээрээ болон эмжээр захиараа хүрэн утсаар царсны боргоцой оёсон цайвар ногоон даашинз өмсөхийг шаардав.

- Миний ээжийн авга эгч Хуучин хотын эхийн байшингийн септа гэж хатагтай Смолвуд зарц нь Арьяагын нурууны даашинзыг үдэж өгөхөд хэлэв.

- Би дайн эхлэхэд охиноо тийш нь илгээсэн. Тэр одоо том болсон болохоор эргэж ирэхэд даашинз нь багадна гэдэгт эргэлзэхгүй байна. Охин минь чи бүжиглэх дуртай юу? Миний Кареллен бүжиглэх дуртай сайхан дуулдаг байсан. Харин чи юу хийх дуртай вэ? гэхэд Арьяа хөлөөрөө сүрэл оролдон,

- Зүүгээр юм хийх гэв.

- Их тайван ажил биз дээ?

- Намайг хийхэд лав тийм биш гэж Арьяа хэлэв.

- Үгүй гэнээ. Би үргэлж тэгж боддог байсан. Бурхад бидэнд бүгдэд бяцхан авьяас бэлэглэсэн учир түүнийг нь ашиглах ёстой гэж авга эгч маань хэлдэг байсан юм. Ямар ч зүйл мөргөл байсан ч болно. Зөвхөн сайн мөргөх хэрэгтэй. Энэ сайхан бодол байгаа биз? Чи дараагийн удаа зүүгээр юм хийхдээ үүнийг санаарай. Ингэхэд чи өдөр болгон зүүгээр юм хийдэг байсан уу?

- Би Зүүгээ алдсанаас хойш хийгээгүй. Миний шинэ нь сайн болохгүй байгаа.

- Тэгвэл бид хамгийн сайн чаддаг зүйлээ хийсэн нь дээр гээд хатагтай Смолвуд даашизыг нь засаад,

- Одоо чи яг л жинхэнэ залуу хатагтай шиг харагдаж байна гэлээ.

Би хатагтай биш. Би чоно гэж Арьяа түүнд хэлэхийг хүслээ.

- Би чамайг хэн болохыг мэдэхгүй, хүүхэд минь. Энэ ч дээр байж болох юм. Чухал хүнээс би айдаг гээд Арьяагын захыг тэнийлгэж, - Ийм цагт хэнд ч анзаарагдахгүй байсан нь дээр. Би чамайг өөртэйгээ үлдээж болох ч энд аюулгүй биш. Надад хэрэм байгаа ч хамгаалах хүн дэндүү цөөхөн гээд санаа алдлаа.

Цэмцийтэл угааж үсээ самнан даашиз өмссөн Арьяа танхимд орох үед оройн хоол өгч байлаа. Жэндри түүн рүү ганц харснаа хамрынхаа нүхээр дарс суга үсэртэл инээхэд Харвин чих рүү нь алгадав. Хоол унд ердийн ч гэдэс цатгам хонины мах, мөөг, хар талх, вандуйны чунз, шаргал бяслагтай жигнэсэн алим байлаа. Хоол идсэний дараа зарц нар ширээ цэвэрлэн явахад Ногоон сахалт дуугаа намсган хатагтайгаас аянгат лордын тухай сураг сонссон эсэхийг асуулаа.

- Сураг гэнэ ээ? Тэд үүгээр ердөө хоёр долоо хоногийн өмнө өнгөрсөн. Арваад хонь дагуулан явж байсан. Би нүдэндээ ч итгээгүй. Торос надад талархсаны тэмдэг болгон гурвыг өгснөөс та нар өнөө орой нэгийг нь идэж байна.

- Торос хонь хариулж байсан гэнэ ээ? гээд Энгай чанга хөхөрлөө.

- Тиймээ харахад хачин байсан ч Торос хувраг хүн сүрэг яаж хариулахыг мэддэг байх ёстой гэсэн.

- Бас яаж хяргахыг ч гэсэн гээд Шаргал нөмрөгт Лем хөхрөв.

- Хэн нэгэн энэ ховор зүйлийн тухай дуу зохиох хэрэгтэй гээд Том модон ятганыхаа чавхдсыг шудрахад,

- Хэн нэг сээтэгнэсэн дуу зохиодог хүн биш. Эсвэл "Зүлгэн дээрх миний хонгор бүсгүй" гэдэг дуу дуулж саальчинбүртэй учран хоёрыг нь том гэдэстэй болгосон хүн биш гээд хатагтай Смолвуд

түүнийг цоргисон харцаар төөнөв.

- Энэ бол "Үзэсгэлэн гоог чинь ууя" гэдэг дуу байсан юм. Саальчин хүүхнүүд үүнийг сонсох үргэлж дуртай байдаг. Зарим язгууртан гаралтай хатагтай нар ч гэсэн дуртай байсныг санаж байна. Таалалд чинь нийцвэл би тоглож өгье гэхэд хатагтай Смолвудын хамар нь сартайлаа.

- Голын хөндийгөөр дүүрэн чиний таалалд нь нийцүүлсэн хүүхнүүд цэцгийн ханд ууж байна. Чиний насны хүн тэдний хэвлийд яаж хүүхэд хийхгүйгээ мэддэг байх ёстой. Удахгүй чамайг Долоон хөвгүүнт Том гэх нь байна шүү.

- Би олон жилийн өмнө долоон хөвгүүнтэй болсон. Гургалдай шиг сайхан хоолойтой сайн хөвгүүд гээд Том тоосонгүй.

- Эрхэм лорд хаана очихоо хэлсэн үү, хатагтай? гэж Харвин асуулаа.

- Лорд Берик хэзээ ч төлөвлөгөөгөө хуваалцдаггүй ч Чулуун сүм, Трипеннигийн ойн ойролцоо явсан. Би та нарын оронд байсан бол тэнд эрэх байсан даа. Харин над дээр таатай зочид бага ирдэгийг та нар мэднэ. Намайг Жэйми Ланнистертай байж магадгүй гэж сүрэг чоно хаалгыг минь тойрон ульсан гээд хатагтай Смолвуд дарс балгахад,

- Тэгвэл Хааны алуурч ахин сул тавигдсан гэдэг нь үнэн байх нь ээ? гээд Том ятга дарахаа зогслоо.

- Хэрвээ түүнийг Риверранд гинжтэй байсан бол араас нь хөөхгүй байсан гэж бодож байна гээд хатагтай Смолвуд түүнийг ширвэв.

- Хатагтай та тэдэнд юу гэж хэлсэн бэ? гэж Азтай Жак асуулаа.

- Сэр Жэйми миний оронд нүцгэн доошоо бууж ирж чадахааргүй сульдаад хэвтэж байна гэсэн. Тэдний нэг намайг ичгүүргүйгээр худалч гэхэд цааш хэсэг маргасан. Тэднийг Блэкботом Бэнд руу явсан гэж бодож байна.

- Ямар умардынхан хааны алуурчийг хайж байгаа юм? гээд Арьяа суудал дээрээ өндөлзөв.

Хатагтай Смолвуд түүнийг үг хэлсэнд гайхсан бололтой.

- Тэд нэрээ хэлээгүй ч энгэр дээрээ цагаан нарны сүлдтэй хар хувцас өмссөн байсан гэв.

Хар дэвсгэр дээр цагаан нарны сүлд бол лорд Карстарк гэж Арьяа бодлоо. *Тэд бол Роббын хүмүүс байна.* Ингэхэд ойрхон байгаа болов уу. Хэрвээ тэр дээрэмчдээс мултарч тэднийг олж чадвал магадгүй Риверран руу хатагтай ээжид нь аваачиж өгөх ч юм билүү.

- Тэд Ланнистерийг яаж оргосныг хэлсэн үү? гэж Лем асуулаа.

- Хэлсэн ч би үгэнд нь итгээгүй. Тэд хатагтай Кателинийг сулласан гэсэн.

- Больж үз. Энэ чинь ухаангүй явдал гээд Том гайхсандаа чавхдасаа шудрав.

Энэ үнэн биш. Үнэн байж болохгүй гэж Арьяа бодлоо.

- Би ч гэсэн тэгж бодож байна гэж хатагтай Смолвуд хэлэв.

Тэгэхэд л Харвин Арьяаг саналаа.

- Ийм яриа таны чихэндээ сонсох зүйл биш, хатагтай.

- Үгүй би сонсмоор байна гэж эсэргүүцсэн ч дээрэмчид няцашгүй байлаа.

- Явж үз, туранхай хэрэм минь. Биднийг ярилцаж байх зуур бяцхан сайн хатагтайн ёсоор хашаанд тоглож бай гэж Ногоон сахалт хэлэв.

Арьяа гадагш ууртай гарч хаалга савах гэсэн ч дэндүү хүнд байлаа. Боргоцой танхим дээгүүр харанхуй нөмөрчээ. Ханан дээр цөөхөн бамбар улалзаж бяцхан шилтгээний хаалга цоожтой байв. Арьяа Харвинд ахин зугтахыг оролдохгүй гэж амалсан ч тэдний ээжийнх нь тухай худал хэлэхийн өмнөх үе билээ.

- Арьяа. Хатагтай Смолвуд энд дархан байгаа гэж хэлсэн. Явж харах уу? гээд Жэндри түүний араас гарч ирэв.

- Хүсвэл тэгье л дээ гээд түүнд өөр хийх зүйл байсангүй.

- Тэр Торос Хааны газрын шилтгээнд амьдарч байсан Торос мөн болов уу? Халзан толгойтой бүдүүн улаан хувраг? гэж Жэндри нохойн байрны дэргэдүүр өнгөрөхөд хэлэв.

- Тийм гэж бодож байна гээд Арьяа Хааны газар Торостой ярьж байгаагүй ч царайг нь санаж байлаа. Жалабар Зо тэр хоёр Роберт хааны ордонд хамгийн анхаарал татсан хувцастай хүмүүс байсны дээр Торос хааны сайн нөхөр байлаа.

- Тэр намайг санахгүй ч гэсэн манай дархны газар ирдэг байсан.

Смолвудын дархны газар хэсэг зуур ашиглаагүй ч дархан нь багаж хэрэгслээ хананд нямбай өлгөжээ. Жэндри лаа асааж дөшин дээр тавиад тонгойн чимхүүр авав.

- Манай эзэн үргэлж түүнийг галт илднийх нь төлөө зэмлэдэг байсан. Энэ бол илдтэй сайн харьцах арга биш гэж хэлдэг байсан ч Торос хэзээ ч сайн илдтэй байгаагүй. Тэр хямдхан илд зэрлэг галд дүрээд гал асаадаг байсан. Энэ бол алхимикийн мэх гэж эзэн хэлдэг байсан ч морьдыг болон зарим ногооноороо хүлэг баатруудыг айлгадаг байсан юм.

Арьяа нүүрээ үрчийлгэн эцгийнхээ Торосын тухай юу хэлснийг санахыг оролдлоо.

- Тэр тийм ч шүтлэгтэй хүн биш биз дээ?

- Тийм. Эзэн Мотт Торосыг Роберт хаанаас хүртэл илүү уудаг байсан гэсэн. Тэд хоёул нэг тэрэгний өрөөсөн дугуй ховдог дүүрчихсэн архичид.
- Чи хааныг архичин гэж болохгүй гээд Роберт хаан их уудаг байсан ч эцгийнх нь анд байсан билээ.
- Би Торосын тухай ярьж байна гээд Жэндри чимхүүрээ хамарт нь ойртуулахад Арьяа цохин холдуулав.
- Тэр найр тэмцээнд дуртай байсан болохоор Роберт хаан түүнд туйлын дуртай байсан. Бас Торос зоригтой. Пайкийн хэрэм нурах үед тэр хамгийн түрүүн цоорхойгоор нь орж галт илднийхээ нэгээр тулалдан төмөр хүмүүсийг цавчилт бүртгээ галаар шатааж байсан гэдэг.
- Би галт илдтэй болох юмсан гээд Арьяа маш олон дуртайяа галаар цавчих хүмүүсийн тухай бодлоо.
- Үүнийг ердөө мэх гэж би хэлсэн биз дээ. Зэрлэг гал төмрийг сүйтгэдэг. Миний эзэн тэмцээн болгоны дараа тулалдах болгонд илд нь хугардаг учир Торост шинэ илд зардаг байсан гээд Жэндри чимхүүрээ ханан дахь байранд нь өлгөн хүнд алх авлаа.
- Эзэн Мотт намайг анхны урт илдээ хийх цаг боллоо гэсэн. Тэр надад сайн төмрийн хэсэг өгөхөд би яаж хийхээ мэдэж байлаа. Тэр үед Йорен ирж намайг Шөнийн харуул руу авч явсан юм.
- Хэрвээ чи хүсвэл илд давтаж болно. Биднийг Риверранд очих үед миний ах Роббод илд хийж өгч болно.
- Риверран гэнэ ээ? гээд Жэндри алхаа доош тавин түүнийг харж, - Чи одоо өөр харагдаж байна. Яг л бяцхан охин шиг гэв.
- Би энэ тэнэг боргоцойнуудтай царс шиг харагдаж байгаа байх даа.
- Сайхан харагдаж байна. Хөөрхөн царсны мод гээд Жэндри алхам ойртон үнэрлэсэнээ,
- Чи бүр урьдынхаас илүү сайхан үнэртэй болчихож гэв.
- Үгүй тэгээгүй. Чи өөрөө өмхий гээд Арьяа түүнийг дөш рүү түлхээд ухасхийн зугтаахад Жэндри гараас нь барьж авлаа. Арьяа хариуд нь хөлөөрөө дэгээдэхэд доош нь хамт татаж унан дархны шалан дээгүүр өнхрөлдөв. Жэндри хүчтэй ч Арьяа шалмаг байлаа. Жэндри түүнийг барихыг оролдох болгонд мултарч гараад дээрээс нь нүднэ. Жэндри цохилтонд нь хөхрөн уурыг нь улам хүргэлээ. Тэр эцэст нь Арьяагын бугуйг өрөөсөн гараараа нийлүүлэн бариад нөгөө гараараа гижигдэхэд Арьяа өвдөгнийх нь завсар өшиглөөд мултарч зугтлаа. Тэд хоёул шороо тоосонд хутгалдаж тэнэг боргоцойтой даашинзны өрөөсөн ханцуй урагдчихсан байв.
- Би одоо сайхан харагдахгүй байгаа гэж мөрийцөх байна гэж Арьяа хашгирлаа.

Тэднийг танхимд эргэн ирэх үед Том дуулж байв.

Би зөөлөн өдөн орон дээрээ чамайг хэвтүүлнэ

Шаргал торгоор хувцаслаж

Толгойд чинь титэм өмсгөнө

Чи миний хатагтай хайрт минь болж

Харин би чиний лорд болно

Би үргэлж чамайг дулаан аюулгүй байлгаж

Илдээрээ хамгаална

Харвин тэднийг харсан даруй тачигнатал хөхрөхөд Энгай сэвхтэй царайгаараа тэнэгдүүхэн инээмсэглэж,

- Энэ манай язгууртан хатагтай юм биз дээ? гэхэд Шаргал нөмрөгт Лем Жэндригийн шилэн хүзүү рүү цохиод,

- Чи зодолдохыг хүсч байвал надтай зодолд! Тэр чамаас хоёр дахин дүү охин хүүхэд. Чи гараа түүнээс хол байлгасан нь дээр шүү. Намайг дуулав уу? гэж зандарлаа.

- Би эхэлсэн. Жэндри зүгээр ярьж байсан юм гэж Арьяа хэлэв.

- Хүүг орхи, Лем. Арьяаг эхэлсэн гэдэгт эргэлзэхгүй байна. Тэр Винтерфеллд байхдаа ч иймэрхүү байсан гэж Харвин хэлэв.

Том түүн рүү ирмэснээ дууллаа.

Тэгэхэд ойн охин инээмсэглэн хөхрөөд

Түүний гараас эргэлдэн мултарч

Надад өдөн ор хэрэггүй ээ

Би алтан навчин дашинз өмсөж

Үсээ өвсөөр гоёдог

Харин чи миний ойн хайрт болох юм бол

Би чиний ойн бүсгүй больё гэжээ

- Надад навчин дашинз байхгүй ч Карелланы дашинзнаас өөр үлдсэн зүйл байж магадгүй. Явъя охин минь дээш гарцгааж чамд таарах зүйл олъё гэж хатагтай Смолвуд инээмсэглэн хэлэв.

Энэ удаа өмнөхөөс дордлоо. Хатагтай Смолвуд Арьяаг ахин усанд орохыг шаардаж үсийг нь самнаж өгөөд хөх ягаан өнгийн жижигхэн сувдаар чимэглэсэн дашинз өмсгөв. Ганцхан сайн зүйл нь тийм гоёмсог дашинзыг морь унахад өмсөж болохгүй байлаа. Маргааш өглөө нь тэднийг өглөөний цайгаа уухад хатагтай Смолвуд Арьяад өмд, бүс, цамц, төмөр товчтой цаа бугын арьсан хантааз өглөө.

- Энэ миний хүүгийн хувцас. Тэр долоон настай байхдаа өнгөрсөн юм гэхэд Арьяа гэнэтхэн эвгүй санагдаж ичсэндээ,

- Намайг боргоцойтой дашинзыг чинь урсанд өршөөгөөрэй, хатагтай. Тэр хөөрхөн дашинз байсан гэж хэллээ.

- Тиймээ, чи ч гэсэн охин минь. Зоригтой байгаарай.

ДАНЕРИС

Бахархлын Талбайн төвд орших уснаас нь хүхэр үнэртсэн улаан тоосгон усан оргилуурын голд хорин фут өндөр нүсэр том хүрлээр цутгасан харпигийн хөшөө байлаа. Хөшөө алтадсан үстэй эмэгтэй хүний царайтай, зааны ясан нүд, үзүүртэй шовх шүдтэй байлаа. Хүнд цээжнээс нь шаргал ус оргилно. Гарны оронд сарьсан багваахай, лууны адил далавчтай бөгөөд хөл нь бүргэдийн сарвуу, ардаа хилэнцийн нумарсан том хорт сүүлтэй байв.

Гисийн харпи гэж Дани бодов. Түүний санаж байгаагаар Эртний Гис таван зуун жилийн өмнө үгүй болж цэргүүд нь хүчирхэг залуу Валириад бут цохиулан, тоосгон хана нь нурж гудамж талбай нь лууны галд үнс нурам болон хувираад давс, гүргэм тариалдаг талбай нь хохимой толгойгоор дүүрчээ. Гисийн бурхад ч гэсэн хүмүүсийнхээ хамт үгүй болсон байна. Эдгээр Астапорынхон бол ердөө ноход гэж сэр Жорах хэлсэн бөгөөд боолын хотууд булаан эзэлсэн Их Валирианы хэлээр ярьдаг болсон цагаас хойш Гисарийн хэл бараг мартагджээ.

Гэсэн ч эртний хаант улсын бэлэг тэмдэг энд оршсон хэвээр том хүрэл мангас хумсандаа заналхийллийн тэмдэг болгон хүнд гинж атгажээ. *Гисийн харпигийн сарвуунд аянгын цахилгаан байдаг. Харин энэ бол Астапорын харпи байна.*

- Вестеросын янханд харцаа доошлуул гэж хэл хэмээн боолын худалдаачин Кразнис мо Наклоз дэргэдээ зогсож байсан боол охинд гомдоллон хэллээ.

- Би мах зарах гэснээс биш төмөр зарах гээгүй. Энэ хүрлийг худалдахгүй. Түүнд цэргүүд рүү хар гэж хэл. Наран жаргах зүгийн зэрлэг бүүдгэр хөх ягаан өнгийн нүдтэй байсан ч гэсэн миний амьтад ямар гайхамшигтай болохыг харах бизээ.

Кразнис Гисийн онцлог аялгатай эртний Валирианы хэлээр ярьж байсан ч үг нь боолын эзний этгээд үгээр хачирлагджээ. Дани түүнийг сайн ойлгож байсан ч инээмсэглэн боол охин руу харж юу хэлэхийг нь хүлээлээ.

- Сайн эзэн Кразнис тэднийг гайхамшигтай болох эсэхийг асууж байна? гэж охин Вестеросд очиж байгаагүй хэр нь нийтийн хэлээр хэлэв. Тэр арав гаруй насны дугуй хавтгай царай, бор арьстай Наатын алтан нүдтэй байлаа. Тэднийг *тайван хүмүүс* гэж нэрлэгдэг бөгөөд үүнийг батлан хамгийн сайн боол болдог ажээ.

- Тэд миний шаардлаганд нийцэж болох юм гэж Дани хариуллаа. Тэр сэр Жорахын хэлсэн ёсоор Астапорд байхдаа зөвхөн ердийн хэл юм уу Дотракийн хэлээр ярьж байв. *Миний баавгай харагдаж байгаагаасаа илүү ухаантай юм.* Надад тэднийг хэрхэн сургасныг хэлээч.

- Вестеросын эмэгтэйн санаанд тэд нийцэж байгаа ч үнийг нь буулгахын тулд магтсан үг хэлэхгүй байна. Тэр тэднийг яаж сургагдсаныг мэдэхийг хүсч байна.

Кразнис мо Наклоз толгойгоо бөнжигнүүлэн дохив. Түүнээс бөөрөлзгөнөтэй усанд орсон юм шиг жимсний үнэр ханхлан ширвээ улаавтар хар сахлаа тослон гялалзуулжээ. *Тэр минийхээс илүү том хөхтэй юм* гэж Дани бодов. Тэр түүнийг өрөөсөн мөр давуулан ороосон алтан цацагтай

тэнгисийн ногоон өнгийн нимгэн торгон токар нэвт харж байлаа. Боолын эзэн зүүн гараа токар дээр тавин явж баруун гартаа богино суран ташуур атгажээ.

- Вестеросын бүх гахайнууд үнэхээр ийм харанхуй мунхаг гэж үү? Бүхий л ертөнц даяар Ансаллидуудыг богино илд, жад, бамбай гарамгай эзэмшсэн болохыг мэднэ гээд Дани руу нүүр дүүрэн инээмсэглэж,

- Түүнээс боолын тухай юу мэдэхийг хүсч байгааг нь асуу. Зөвхөн түргэн шүү өнөөдөр халуун байна гэв.

Ядахдаа энэ чинь худал биш юм. Тэдний ард хоёр боол охин судалтай торгон халхавч толгой дээр нь барьж зогсож байсан ч Дани сүүдэрт хүртэл халууцаж толгой нь эргэхэд Кразнисийн хөлс нэвт урсаж байв. Бахархлын талбай өглөөнөөс хойш мандсан наранд жигнэгдэж байлаа. Данигийн өмссөн зузаан ултай шаахайн ул нэвт улаан тоосгоны халуун илч мэдэгдэнэ. Бүгчим халуун давалгаа хөөрч талбайн эргэн тойрны Астапорын гишгүүртэй пирамидууд зэрэглээ шиг жирэлзэнэ.

Ансаллидууд халуунд шарагдаж байсан ч үүнийгээ мэдэгдсэнгүй. *Тэд зогсож байгаа газраа тоосгоор цутгасан юм шиг байна.* Данигийн багцаалснаар хуарангаас гарсан мянган цэрэг том хүрэл харпитай усан оргилуурын өмнө арван эгнээ зуутаар жагсан цэх зогсож чулуун харц нь урагш чиглэжээ. Бүсэлхийгээ цагаан даавуугаар ороосноос ондоо өмсгөлгүй толгой дээрээ футын өндөр хурцалсан хадаастай хүрэл дуулга өмсчээ. Кразнис тэдэнд Вестеросын хатанд биеийнхээ гоолиг булчинг үзүүлэхийн тулд илдний бүс, хөнгөн хуягаа тайлахыг тушаав.

- Тэднийг хүүхэд байхад нь биеийн өндөр хурд хүчээр нь сонгосон. Бэлтгэл сургуулилтаа таван жилийн турш хийдэг. Үүрийн гэгээ цайхаас үдшийн бүрий болтол өдөр бүр богино илд, бамбай, гурван үзүүртэй жад гаргуун эзэмших хүртлээ сургуулилдаг. Бэлтгэл сургуулилт нь маш хатуу болохоор зөвхөн гурван хөвгүүнээс нэг нь үлддэг, эрхэм дээдсээ. Ансаллидууд хадаастай малгай хүртэх өдөр муу зүйл ард хоцордог болохоор хүнд хэцүү бэлтгэл сургуулилттаас нь илүү ямар ч үүрэг байхгүй гэж хэлдэг гэж боол охин түүнд хэлэв.

Кразнис мо Наклоз ердийн хэлээр ярьдаггүй ч сонсох зуураа толгой дохиж үе үе боол охиныг ташуурынхаа үзүүрээр хатгаж байлаа.

- Түүнд тэднийг энд хоол унд усгүй өдөр шөнөгүй зогсож чадна гэж хэл. Тэднийг намайг боль гэж тушаах хүртэл зогсож есөн зуун ерэн ес нь тоосгон дээр унаж үхсэн ч сүүлчийнх нь үхлээ ирэх хүртэл хөдлөхгүй гэж хэл. Тэд ийм л зоригтой. Түүнд ингэж хэл.

- Би үүнийг чинь эр зориг биш ухаангүй явдал гэж хэлэх байна гэж Цагаан сахалт Арстан охиныг хөрвүүлж дуусахад хэлэв. Тэр хатуу модон таягныхаа үзүүрийг дургүйцлээ илэрхийлэх мэт тоосгон дээр тог тог тогшино. Хөгшин хүн Астапор луу жолоогоо залахыг хүсээгүй шигээ боолын арми худалдан авах санааг нь дэмжсэнгүй. Гэвч хатан хүн шийдвэр гаргахын урд бүх талын үгийг сонсох ёстой. Ийм учраас Дани түүнийг аюулгүй байдлаа хамгаалуулахын төлөө бус Бахархлын талбай руу авчирчээ. Хамгаалалтанд цусан морьтонгууд нь хангалттай. Сэр Жорах Мормонтыг "Балерион" дээр хүмүүсээ болон луугаа хамгаалуулахаар үлдээн хичнээн дургүй байсан ч луунуудаа онгоцны тавцангийн доод талын өрөөнд цоожилсон байна. Тэднийг хот

дундуур чөлөөтэй нисгэхэд дэндүү осолтой бөгөөд ертөнцөд "луу алагч" гэсэн нэрийг зүүхийн тулд ямар ч шалтгаангүй дуртайяа алахад бэлэн хүмүүс дүүрэн билээ.

- Өмхий хөгшин өвгөн юу гэж хэлсэн бэ? гэж боолын эзэн хэлмэрчээсээ шаардан хэлсэн үгийг нь сонсож инээмсэглээд,

- Зэрлэгүүдэд бид үүнийг хүлцэнгүй байдал гэж нэрлэдгийг хэл. Бусад цэргүүд Ансаллидуудаас хүчтэй хурдан том, тэдэнтэй эн зэрэгцэхээр илд, жад, бамбай эзэмшсэн байж болох ч уудам тэнгисийн хаанаас ч та нар ийм хүлцэнгүй цэргүүд олохгүй гэв.

- Хонь ч гэсэн хүлцэнгүй гэж Арстан үгийг хэлмэрчлэхэд хэлэв. Тэр Данигаас арай тааруухан Валирианы хэлийг мэдэх ч адилхан мэдэхгүй эсгэж байлаа.

Кразнис мо Наклоз үгийг сонсоод том цагаан шүдээ ярзайлгав.

- Намайг ганц үг дуугарахад эдгээр хонинууд түүний өмхий хөгшин гэдэс дотрыг нь тоосгон дээр цувуулж чадна. Гэхдээ үүнийг хэлэх хэрэггүй. Тэдэнд эдгээр амьтад хониноос илүү ноходтой төстэй гэж хэл. Долоон ханлигт тэд нохой, адуу иддэг билүү?

- Гахай, үхрийн мах идэхийг эрхэмлэдэг, эзэнтээн.

- Үхрийн мах. Түй. Бохир зэрлэгүүдийн хоол.

Дани тэднийг үл тоомсорлон боол цэргүүдийн эгнээ дагуу удаан алхлаа. Араас нь торгон халхавч барьсан охид дагалдахад өмнө нь зогсоо мянган хүнд хайр найргүй шарах нарнаас ийм хамгаалалт байсангүй. Ихэнхи нь хүрэл арьс бүйлсэн нүдтэй Дотраки Лазеринчууд байсан ч бас Чөлөөт хотын хүмүүс байсан бөгөөд цайвар Картынхан, хар царайтай Зуны арлынхантай эгнэн бусад нь ямар үндэстнийг нь мэдэхгүй хүмүүс байлаа. Зарим нь Кразнис мо Наклозийн адил шаргал арьс, өөрсдийгөө харпигийн хөвгүүд гэж нэрлэдэг эртний Гисийн хүмүүсийн тэмдэг болох ширүүн улаан хар үстэй байв. *Тэд өөрсдийнхөө хүмүүсийг ч гэсэн зарж байна.* Дани үүнд гайхсангүй. Дотракичууд ч гэсэн өвсөн тэнгист нэг каласар нөгөө каласартай тулгарах үед ингэдэг билээ.

Цэргүүдийн зарим нь өндөр зарим нь намхан арван дөрвөөс хорин орчим насны ажээ. Хацар нь толигор нүд нь хар, хүрэн, цэнхэр, саарал, шаргал өнгөтэй байсан хамаагүй бүгд ижил байв. Тэд нэг хүн шиг адилхан юм гэж Данис бодоод тэднийг эр хүн биш болохыг саналаа. Ансаллидууд бүгд тайган байв.

- Тэднийг яагаад хөнгөлсөн юм бэ? Миний сонссоноор бүтэн эр хүн тайганаас хүчтэй гэж Дани Кразнисаас боол охиноор асуулгалаа.

- Залууд нь хөнгөлсөн тайганууд танай Вестеросын хүлэг баатрууд шиг хэзээ ч бүдүүлэг хүчтэй болохгүй нь үнэн. Гэхдээ бух ч гэсэн хүчтэй ч өдөр бүр тулалдааны нүхэнд үхэж байдаг. Гурван өдрийн өмнө Жотиэлийн нүхэнд есөн настай охин нэгийг нь алсан. Ансаллидуудад хүчнээс хамаагүй дээр зүйл болох сахилга бат бий гэж түүнд хэл. Бид Хуучин эзэнт улсын маягаар тулалддаг. Тэд Хуучин Гисийн нарийн дэг журамтай легионы ёсоор бүрэн дуулгавартай, туйлын

үнэнч өчүүхэн төдий ч аймшиггүй гэж Кразнис мо Наклоз асуулт тавигдахад хариулав.

Дани хөрвүүлгийг тэвчээртэй сонслоо.

- Хамгийн зоригтой хүн хүртэл үхэл, зэрэмдэг болохоос айдаг гэж Арстан охиныг хэлж дуусмагц хэлэв.

Кразнисд хэлэх үед үүнийг сонсоод инээмсэглэлээ.

- Хөгшин хүнд түүнээс шээс үнэртэж байгаа болохоор таягаа тулахгүй бол тогтож чадахгүй гэж хэл.

- Үнэхээр тэгж хэлэх уу, эзэнтээн? гэхэд тэр ташуураараа ёвров.

- Үгүй, үнэнээсээ биш. Чи чинь ийм тэнэг юм асууж байдаг охин юм уу ямаа юм уу? Ансаллидуудыг хүн биш болохоор тэдний хувьд үхэл тахир дутуу болохоос дутуугүй юу ч биш гэж хэл гээд биерхүү Лазарины өмнө зогсож ташуураа өргөн хүчтэй шавхуурдахад хүрэн хацар дээр нь цусан мөр үлдэв. Тайган нүдээ анивчсан ч хөдөлсөнгүй цусаа урсган зогссон хэвээр байлаа.

- Чи ахин хүсч байна уу? гэж Кразнис түүнээс асуув.

- Хэрвээ эзний таалалд нийцвэл.

Үүнийг ойлгоход бэрх байлаа. Дани Кразнисийг ташуураа ахиж далайхаас нь өмнө гарт нь хүрэв.

- Сайн эзэнд би Ансаллидуудыг хичнээн хүчтэй хэр өвчин тэвчих зоригтой болохыг харлаа гэж хэл гэхэд Кразнис Валирианы хэлээр Данигийн үгийг сонсмогц инээд алдав.

- Энэхүү мулгуу өрнөдийн янханд эр зориг үүнд хамаагүй хэл.

- Сайн эзэн үүнийг эр зориг биш гэж хэлж байна, эрхэм дээдсээ.

- Түүнд янхны нүдээ хоёуланг нь нээ гэж хэл.

- Тэр таныг анхаарал хандуулахыг гуйж байна, эрхэм дээдсээ.

Кразнис эгнээнд зогсож байгаа дараагийн цэнхэр нүд, Лисийн цайвар үстэй өндөр тайган руу очив.

- Илдээ өг гэхэд тайган өвдөг сөгдөн илдээ сугалж бариул талаар нь өгөв. Энэ нь цавчихаас илүү хатгахад тохиромжтой богино илд байсан ч ир нь сахлын хутга шиг хурц байлаа.

- Бос гэж Кразнис тушаав.

- Таны тааллаар больё, эзэнтээн гээд тайган босоход Кразнис мо Наклоз сэлмийг бие дээгүүр нь удаанаар зүсч хавирганы дор гэдсэн дээр улаан мөр татуулав. Дараа нь илдний үзүүрийг өргөн ягаан хөхний товчны доогуур хатгаад тойруулан зурав.

- Тэр юу хийж байгаа юм? гэж Дани боолын цээжийг даган цус урсахад шаардахад,
- Наад үнээдээ мөөрөхөө боль гэж хэл хэмээн Кразнис хөрвүүлэхийг хүлээлгүй хэлэв.
- Энэ түүнд хор болохгүй. Эр хүнд хөхний толгой хэрэггүй болохоор тайганд бол бүр ч хэрэггүй гээд хөхний толгой нь нимгэн арьсан дээр торгоогдон үлдлээ. Тэр ганц хөдөлгөөнөөр цавчин тоосгон дээр унагаахад ард нь үлдсэн дугуй улаан нүхнээс цус шүүрэн нэвчив. Тайган Кразнис илдийг бариулаар нь буцааж өгөх хүртэл огтхон ч чадавхийсэнгүй.
- Май би чамтай дууслаа.
- Таньд зүтгэхэд баяртай байна.
- Тэдний өвчин мэдэрдэггүй болохыг харав уу гээд Кразнис Дани руу буцаж эргэлээ.
- Яаж тэр вэ гэж? гэж Дани хэлмэрчээс асуулаа.
- Эр зоригийн дарс. Үнэн хэрэгтээ жинхэнэ дарс биш үхлийн гувай хатан, цусан ялааны авгалдай, хар лянхуаны үндэс болон өөр бусад нууц жороор хийсэн ханд. Тэд үүнийг хөнгөлүүлснээсээ хойш хоол идэх бүрдээ өдөр болгон уусаар жил ирэх тусам өвчин мэдрэх нь улам багасдаг. Ийм учраас тулаанд аймшиггүй зоригтой. Тамлалтанд яах ч үгүй тэсвэртэй. Зэрлэгүүдэд Ансаллидуудыг байхад нууц нь ямар ч аюулгүй гэж хэл. Тэд түүнийг зөвөлгөөнийхөө үүдэнд, унтлагын өрөөндөө хүртэл харуулд зогсоож хэзээ ч сонсоно гэдэгт нь санаа зовохгүй байж болно.
- Юнкай, Мирийны тайганууд голцуу хөвгүүн үеийнхээ төмсгийг авахуулж эрхтэн нь үлддэг. Тиймэрхүү амьтад үр тогтоох чадваргүй ч хөвчирч чадна. Зөвхөн үүнээс асуудал үүсч болно. Бид эрхтэнийг нь ч гэсэн юу ч үлдээхгүй огтлон авдаг. Ансаллидууд бол ертөнцийн хамгийн цэвэр амьтад гээд Дани, Арстан хоёр луу ахин өргөн цагаан шүдээрээ инээмсэглэж,
- Би Наран жаргах зүгийн хаант улсад ариун байдал тэвчин үр хүүхдийн эцэг болохгүй гэж андгай өргөн зөвхөн үүргээ гүйцэтгэхийн төлөө амьдардаг хүмүүс байдаг гэж сонссон. Энэ үнэн үү? гэж асуув.
- Тийм. Тэд олон янзын үүрэгтэй. Цайзын мэистер, Долоод зүтгэдэг сүмийн септон, үхсэн хүмүүс оршуулдаг чимээгүй эгч дүүс, Хааны хамгаалалт болон Шөнийн харуул... гэж Арстан асуултыг сонсоод хэлэв.
- Хөөрхийлөлтэй амьтад гэж боолын эзэн орчуулгын дараа гүвтнэв.
- Эр хүн ийм амьдралын төлөө бүтээгдээгүй. Тэднийг дур хүсэлдээ зовж хамгийн дорой зүйлд ялагдах нь эргэлзээгүй гэдгийг ямар ч тэнэг харж чадна. Манай Ансаллидууд тийм биш. Тэд танай Тангарагт ахан дүүсийн эн зэрэгцэхгүй замаар илдтэйгээ гэрлэдэг. Ямар ч эмэгтэй хүн болон эр хүн тэдний шохоорхлыг татахгүй гэхэд охин яриаг арай эелдэгээр дамжуулав.
- Хүнд биенээс гадна шунах зүйлс байдаг гэж Цагаан сахалт Арстан татгалзав.

- Эр хүнд байдаг ч Ансаллидуудад байдаггүй. Олз омог тэдний сонирхлыг хүчин хийхээс илүү татахгүй. Тэдэнд зэр зэвсгээс нь өөр юу ч байхгүй. Бид тэдэнд өөрийн нэртэй байхыг хүртэл зөвшөөрдөггүй.

- Нэргүй гэнэ ээ? Сайн эзэн юу гэж хэлсэн бэ? Тэдэнд нэр байхгүй юм уу? гэж Дани хөмсөг зангидлаа.

- Яг тийм, эрхэм дээдсээ.

Кразнис өөрийнх нь ах нь баймаар өндөр Гискаригийн урд зогсоод хөлд нь хэвтэж байгаа илдний бүсэн дэх жижигхэн хүрэл дугуй таваг руу ташуураараа заалаа.

- Энэ бол түүний нэр. Вестеросын янханд Гискаригийн бичээсийг уншиж чадах эсэхийг нь асуу гэхэд Дани чадахгүй гэсэнд боолын худалдаачин Ансаллид руу эргээд,

- Чиний нэрийг хэн гэдэг юм бэ? гэж асуув.

- Миний нэрийг Улаан нохой бөөс гэдэг, эрхэм дээдсээ гэхэд охин ердийн хэлэнд хөрвүүлэн давтав.

- Харин өчигдөр юу байсан бэ?

- Хар харх, эзэнтээн.

- Түүний өмнөх өдөр?

- Хүрэн нохой бөөс, эзэнтээн.

- Түүнээс өмнө?

- Санахгүй байна, эрхэм дээдсээ. Цэнхэр бах юм уу Цэнхэр өт байсан байх.

- Түүнд энэ бүх нэрийг хэл. Энэ нь тэдэнд ямаршуухан хорхой шавьж болохыг нь сануулж байгаа юм. Нэрийн дугуй пайзыг өдрийн үүргийн төгсгөлд хоосон торхонд хийгээд үүр цайх бүрд ахин таамгаар олгодог юм.

- Ёстой ухаангүй юм. Хүн яаж өдөр болгон шинэ нэрээ тогтоож чадах юм? гэж Арстан сонсмогц дуу алдав.

- Бэлтгэл сургуулилтанд шантардаггүй, өдөржингөө хүнд үүрэгтэй гүйдэг, харанхуй шөнө уул руу авирдаг, улайссан нүүрс дээгүүр алхдаг, нялх хүүхэд алдаг хүн чадна.

Дани үүнийг сонсоод өөрийн эрхгүй ярвайлаа. *Тэр үүнийг харсан болов уу? Эсвэл энэ худалдаачин хэргийг шигээ сохор юм болов уу?* Дани түргэн цааш эргэж орчуулахыг нь сонстол царайгаа тайван байлгахыг хичээлээ. Зөвхөн тэгсэн хойно,

- Хэний нялх хүүхдийг тэд алдаг юм бэ? гэв.

- Хадаастай малгай өмсөх эрхтэй болохын тулд Ансаллидууд боолын зах руу мөнгөн тэмдэгтэй явж шинэ төрсөн уйлж байгаа хүүхэд олоод эхийн нүдэн дээр нь алдаг юм. Ийм замаар бид тэдэнд сул тал үлдээгүй эсэхийг шалгадаг гэхэд Дани толгой нь сулхан эргэхэд халуунаас болсон гэж өөртөө сануулав.

- Та нар нялх хүүхдийг эхийн гараас нь авч түүний нүдэн дээр алаад зовж шаналсаных нь төлөө мөнгөн зоос төлдөг хэрэг үү?

Үүнийг орчуулахад Кразнис мо Наклоз чанга инээлээ.

- Юу гээчийн мяу дуугарсан сул дорой тэнэг вэ. Вестеросын янханд тэр бол хүүхдийн эзний мөнгө болохоос биш ээжийнх нь биш гэж хэл. Ансаллидуудад хулгай хийхийг зөвшөөрдөггүй гээд ташуураараа хөлөө тогшлоо.

- Түүнд энэ сорилтонд хэдхэн хүн унадаг гэж хэл. Нохой илүү хэцүү гэж хэл. Бид хөвгүүн бүрт хөнгөлүүлсэн өдөр нь нялх гөлөг тэжээлгэхээр өгдөг. Анхны жилийн эцэст түүнийг боож алах хэрэгтэй. Алж чадаагүй хүнийг амьд үлдсэн нохдын хоол болгодог. Энэ нь хатуу сайн хичээл болохыг бид мэдсэн юм.

Цагаан сахалт Арстан үүнийг сонсоод таягныхаа үзүүрээр удаан бөгөөд жигд тоосго тогшив. *Тог тог тог. Тог тог тог.* Дани түүнийг Кразнис руу удаан харж тэсэлгүй нүд буруулахыг ажиглав.

- Сайн эзэнд эдгээр тайганууд зоос, биед шунадаггүй юмаа гэхэд зарим дайснууд маань тэдэнд надаас урвасны төлөө эрх чөлөө санал болгож болох эсэхийг хэл гэж Дани охинд хэлэв.

- Тэгвэл тэд түүнийг дор нь алж түүнд толгойг нь авчирч өгнө гэж хэл. Бусад боолууд хулгай хийж эрх чөлөөгөө олж авахын тулд мөнгө зоос хураадаг бол Ансаллидууд бэлэг болгон өгсөн өчүүхэн зүйлийг ч хүлээж авахгүй. Тэдэнд үүргээс нь ондоо амьдрал байхгүй. Тэд бол цэргүүд ердөө тэр.

- Надад цэргүүд л хэрэгтэй гэж Дани хүлээлээ.

- Тэгвэл түүнд Астапор луу ирсэн нь сайн хэрэг боллоо гэж хэл. Түүнээс хэр том арми худалдаж авахыг хүсч байгааг нь асуу.

- Та надад хичнээн Ансаллидууд зарж чадах вэ?

- Яг одоо бүрэн бэлтгэгдсэн найман зуун хүн байна. Би тэднийг зөвхөн мянга юм уу зуугаар нь бүхлээр зарна. Урьд нь бид гэрийн харуулаар арваар нь зарж байсан ч муу дагавартай болохоо нотолсон. Арав бол дэндүү цөөхөн. Тэд бусад боол эрх чөлөөт хүмүүстэй орооцолдон өөрсдийнхөө хэн болохыг мартдаг гээд Кразнис ердийн хэлэнд хөрвүүлэхийг хүлээж байгаад үргэлжлүүлэв.

- Энэ гуйлгачин хатан ийм гайхамшигтай зүйлийг хямдхан авч чадахгүйгээ ойлгох ёстой. Юнкай,

Мирийнд боол цэргүүдийг илднээс нь хямд авч болох ч, Ансаллидууд бол олон жилийн бэлтгэл сургуулилтын үр дүнд бий болсон ертөнцийн хамгийн шилдэг явган цэрэг. Түүнд тэднийг Валирианы ган шиг олон жилийн турш нугалан давтагдсан болохоор ертөнцийн ямар ч төмрөөс илүү хүчтэй мятаршгүй болсон гэж хэл.

- Би Валирианы ганг мэднэ. Сайн эзнээс Ансаллидуудад удирдах хүн бий эсэхийг асуу даа.

- Байхгүй. Чи өөрийн хүмүүсээр тэднийг захируулж болно. Бид тэднийг дагалдахыг сургаснаас биш бодохыг биш. Хэрвээ тэр ухаантай бол хэлмэрчийг нь ч гэсэн худалдаж аваг.

- Зэвсэг хэрэгсэл нь яах юм?

- Илд, бамбай, жад, хөнгөн шаахай, хуягалсан цамц багтана. Хадаастай малгай ч гэсэн орно. Тэд чамайг өгвөл ямар ч хуяг байсан өмсөнө.

Дани өөр юу асуухаа мэдсэнгүй Арстан руу харлаа.

- Та ертөнцөд удаан насыг насалсан, Цагаан сахалт. Тэднийг хараад юу гэж хэлмээр байна?

- Би үгүй гэж хэлнэ, эрхэм дээдсээ гэж хөгшин хүн даруй хэлэв.

- Яагаад? Чөлөөтэй ярьж болно гээд Дани түүний юу хэлэхийг тааварласан ч боол охиноор дамжуулан Кразнис мо Наклозод сонсохыг хүслээ.

- Хатан минь долоон ханлигт мянган жилийн турш боол байгаагүй. Хуучин болоод шинэ бурхад алин ялгаагүй боолчлолыг жигшиж муу ёр гэж үздэг. Хэрвээ та Весторост боолын армитай газардвал олон сайн хүмүүс үүнийг чинь эсэргүүцэх болно. Үйл хэрэг, овгийн чинь нэр хүндэд аюул учрана.

- Тэгсэн ч надад арми хэрэгтэй. Хөвгүүн Жоффри төмөр хаан ширээг эелдэгээр гуйсны төлөө өгөхгүй.

- Цаг нь ирж чамайг далбаагаа босгомгоц Вестеросын тэн хагас араас чинь дагалдана. Тэд чиний ах Рэйгарт одоо хүртэл хайртай санасан хэвээр байгаа гэж Цагаан сахалт амлав.

- Тэгвэл миний эцгийг? гэж Дани асуухад хөгшин хүн хариулахын өмнө ялимгүй тээнэгэлзсэнээ,

- Эйрис хааныг ч гэсэн санаж байгаа. Тэр хаант улсад олон жилийн турш энх амгалан авчирсан. Эрхэм дээдсээ таньд боолууд хэрэггүй. Магистер Иллирио таныг луунууд чинь өсөх хүртэл аюулгүй байлгаж чадах болохоор нэрийн чинь өмнөөс уйтан тэнгис дээгүүр язгууртан лордуудад зорилгыг чинь мэдэгдэхээр нууц элч илгээсэн гэв.

- Миний эцгийг Хааны алуурчид орхиж булаан эзлэгч Робертод өвдөг сөгдсөнтэй ижилхэн язгууртан лордууд уу?

- Тэд өвдөг сөгдсөн ч зүрх сэтгэл зүрхнийхээ гүнд луунууд эргэн ирэхийг хүсч байгаа.

- Магадгүй л юм гэж Дани хэлэв. Магадгүй гэдэг нь ямар ч хэлэнд гулгамтгай үг байлаа. Тэр Кразнис мо Наклоз болон боол охин руу эргэлээ.

- Би энэ тухай анхааралтай бодож үзье гэхэд боолын эзэн мөрөө хавчив.

- Түүнд түргэн бод гэж хэл. Намайг олон худалдан авагчид хүлээж байгаа. Ердөө гурван өдрийн өмнө би үүнтэй ижил Ансаллидуудыг бүгдийг нь худалдаж авах найдлагатай далайн дээрэмчдийн хаанд үзүүлсэн.

- Далайн дээрэмчин зөвхөн зууг хүсч байсан, эзэнтээн гэж боол охин хэлэв. Кразнис түүнийг ташуурынхаа үзүүрээр хатгалаа.

- Далайн дээрэмчид үргэлж худал хэлж байдаг. Тэр тэднийг бүгдийг худалдан авна. Түүнд үүнийг хэл, охин минь.

Дани байгаа бүхнээ шавхсан ч зуугаас илүүгүйг худалдан авч чадахаа мэдэж байлаа.

- Сайн эзэнд намайг хэн болохыг маань сануул. Намайг Лууны эх, Шаташгүй, Вестеросын долоон ханлигийн хууль ёсны хатан хаан, Данерис Шуурганаар төрөгч гэж хэл. Миний судсанд эртний Валирианы болон Эйгон байлдан дагуулагчийн цус гүйж байгаа.

Түүний үгийг дамжуулахад тарган сүрчиг ханхлуулсан боолын эзэн өөрийн хахир аялгаар,

- Валириануудыг хонь байхад Эртний Гисийн эзэнт улс захирч байсан. Бид бол харпигийн хөвгүүд гээд мөрөө хавчиж, - Миний хэл эмэгтэй хүнд годолзож цуцлаа. Өрнө дорныхон алин ч ялгаагүй амтат махаар бөөцийлүүлэн зусардан долигнохоос нааш шийдвэр гаргаж чадахгүй амьтад. Миний хувь заяа ийм бол тэгэг л дээ. Янханд хэрэгтэй бол түүнийг манай сайхан хотоор дагуулж явна гэж хэл. Кразнис мо Наклоз түүнийг харагдаж байгаагаасаа илүү эмэгтэй бол хэр сайн үйлчлэх тусам дуртайяа зүтгэнэ.

- Сайн эзэн Кразнис таныг тунгааж байх зуур Астапорыг дуртайяа үзүүлнэ гэж байна, эрхэм дээдсээ.

- Би түүнийг цэлцгэнэсэн нохойн тархи, улаан наймаалжны өтгөн шөл, төрөөгүй нохойн гөлгөөр дайлна гэж хэл гээд худалдаачин уруулаа арчлаа.

- Маш олон янзын сайхан хоол унд байгаа гэж хэлж байна.

- Түүнд пирамидууд шөнө хичнээн үзэсгэлэнтэй байдгийг хэл. Түүнд би цээжнийх нь балыг долоож хүсвэл өөрийнхөө ч гэсэн цээжний балыг долоолгоно гэж хэл.

- Астапор үдэш маш сайхан үзэсгэлэнтэй байдаг, эрхэм дээдсээ. Сайн эзэд сэрүүн асар бүрт торгон дэнлүү өлгөж, бүх пирамидууд өнгө бүрийн гэрлээр гялалзаж байдаг. Өтний голоор зугаалгын онгоцууд зорчиж, намуухан ая тоглон бяцхан арлынхныг хоол унд, дарс болон бусад зугаа цэнгэлд урин дуудаж байдаг юм.

- Түүнд хэрвээ хүсвэл манай тулалдааны нүхийг үзэж болно гэж хэл. Дукорын нүх үдшийн хөгжилтэй зугаагаараа алдартай. Баавгай болон гурван бяцхан хөвгүүн. Нэг хөвгүүн бал, нөгөөдөх нь цус, гурав дахь муудсан загастай болохоор түүнд баавгай хэнийг нь эхэлж идэхийг мөрийцөж болно гэж хэл.

Тог, тог тог гэж Дани сонслоо. Цагаан сахалт Арстаны царай хувиралгүй байсан ч таягаа ууртай нүдэж байв. *Тог, тог, тог.* Дани хүчлэн инээмсэглэв.

- Би "Балерион" дээрээ өөрийн гэсэн баавгайтай. Хэрвээ намайг түүн рүү эргэж ирэхгүй байвал тэр надтай цуг зоог барьж болно гэж хэлмэрчид дамжуулан хэлэв.

- Үгүй ер. Үүнийг эмэгтэй хүн шийддэггүй юм. Тэр эр хүний заасан газар луу гүйж байх ёстой. Үргэлжид! гэж Кразнис түүнийг сонсоод хэлэв.

- Сайн эзэнд тэвчээртэй сайхан сэтгэлд нь талархаж намайг энд мэдсэн бүх зүйлийнхээ тухай бодох болно гэж хэл гээд Данерис гараа цагаан сахалт Арстанд өгч талбай гатлан дамнуурга руугаа буцав. Эгго, Жого хоёр тэдний хоёр талд эгэл ардуудын адил газар явган явж байгаадаа морьтон лордуудын таахалзсан майга хөлтэй алхаагаар алхав.

Дани дамнуурганд хөмсөг зангидан ороод Арстаныг дэргэд суухыг дохив. Тэр настай хүн тул ийм халуунд явган алхаж болохгүй байлаа. Тэдний замдаа орох үед хөшгөө хаасангүй. Нар улаан тоосгон хотыг өршөөлгүй жигнэж улаан тоос босох байсан ч хамаагүй сэвшээ салхи санагалзана. Үүнээс гадна би харах хэрэгтэй.

Астатор бол Тоост өргөөнд орж, Уулсын эхийн дор Ертөнцийн хэвлийд угаагдсан хүнд хүртэл этгээд хачин хот байлаа. Бүх гудамжууд нь ижилхэн улаан тоосгоор хийгдэж талбай нь чулуу дэвссэн ажээ. Гишгүүртэй пирамид, үзэгчдийн уруудсан тойрог суудалтай гүн тулалдааны нүх, хүхэрлэг усан оргилуур, дүнсгэр дарсны агуулах, эртний хананууд тэднийг тойрон дугуйрна. *Тоосгонууд нь маш эртний болохоор хагарч бутарч байна.* Энд тэнд хаа сайгүй улаан тоос дэгдэж салхи сэвэлзэх тоолон хуйлран бужигнана. Астаторын эмэгтэйчүүд нүүрээ гивлүүрээр халхалдагт өчүүхэн ч гайхах зүйлгүй тоосгоны тоос нүдэнд орох нь элснээс дор байлаа.

- Зам тавь! гэж Жого дамнуурганых нь урд явах зуураа хашгирна.

- Лууны Эхэд зам тавь! гээд тэр мөнгөн бариултай ташуураа агаарт тас няс хийлгэхэд Дани урагш бөхийн хэрэггүй гэж Дотракийн хэлээр хэллээ.

- Энэ газар болохгүй, миний цусны цус минь. Эдгээр тоосгонууд ташуурын чимээг дэндүү их сонссон.

Тэднийг өглөө боомтоос гарахад гудамж хүнгүй хоосон байсан ч одоо пиг дүүрэн хүнтэй болжээ. Дэргэдүүр нь сараалжин дамнуурга нуруун дээрээ тэгнэсэн заан өнгөрөв. Хуурай борооны ус дамжуулах тоосгон сувагт арьс нь гуужсан нүцгэн хүү суугаад хамраа чимхэн шоргоолжнууд гүйхийг харна. Тэр туурайн чимээ сонсоод толгойгоо өндийлгөн морьтой харуулууд улаан тоосон үүл босгон тачигнатал инээлдэн өнгөрөхийг харав. Тэдний шаргал торгон нөмрөгтөө оёсон хүрэл

цагаригууд олон нарны туяа шиг гялалзаж хатгамалтай даавуу цамц өмсөөд бүсэлхийнээсээ доогуур судалтай банзал, шаахай өмсчээ. Хүн бүр толгой нүцгэн агаад ширүүн улаан хар үсээ эвэр, далавч, илд бүр атгаж байгаа гарын хэлбэр дүрс гарган тосолсон нь морьтонгуудыг долоон тамаас зугтсан чөтгөрүүд шиг харагдуулна. Нүцгэн хүү тэднийг Данигийн хамт дагуулан харснаа өнгөрсөн хойно хамраа чимхэн шоргоолжныхоо ажилд буцаж оров.

Хуучин хот алдар цуутай байсан үеийнх шигээ хүн ам ихтэй биш ч Карт, Пентос, Листэй ойролцоо хүнтэй юм гэж Дани сэтгэв.

Гудамжны огтлолцол дээр дамнуурга нь гэнэт зогсоход харгалзагчийн ташуур дорх боолчуудын цуваа өнгөрөв. Эд нар нь Ансаллидууд биш ердийн ардууд болох цайвар хүрэн арьс, хар үстэй хүмүүс байлаа. Тэдний дунд эмэгтэйчүүд байсан ч хүүхдүүд байсангүй. Бүгд нүцгэн байв. Араас нь илжигтэй хоёр Астапори явахад эрэгтэй нь улаан торгон токар өмсөж, эмэгтэй нь цэнхэр судалтай гивлүүрээ оюу номингоор чимэглэн улаан хар үсэн дээрээ зааны ясан сам хатгажээ. Эрэгтэй инээмсэглэн түүнтэй шивнэлдэж Данид боолууд болон булчинлаг өргөн цээжин дээрээ харпи, гинжний шивээстэй таван салаа ташуур бүхий Дотраки харгалзагчаасаа илүү анхаарал хандуулалгүй өнгөрөв.

- Астапорыг тоосго цусаар босгосон. Тоосго болон хүмүүсийнх нь цусаар гэж Цагаан сахалт хажуу талд нь гүвтнэв.

- Энэ чинь юу гэж байгаа юм? гэж Дани сониучирхан асуулаа.

- Намайг хүүхэд байхад хөгшин мэйстер энэ үгийг зааж өгсөн ч ямар үнэн болохыг одоо л ойлгож байна. Астапорын тоосгонууд тэднийг барьсан боолчуудын цус шигээ улаан.

- Наадах чинь үнэн гэж Дани хэллээ.

- Тэгвэл зүрх сэтгэл чинь ч гэсэн тоосго болж хувираас өмнө энэ газрыг орхи. Өнөө шөнө үдшийн түрлэгээр хөдлөхийг тушаана уу.

Чаддагсан бол гэж Дани бодлоо.

- Би сэр Жорахын хэлсэн ёсоор Астапорыг армитай орхино.

- Сэр Жорах өөрөө ч гэсэн боолын худалдаачин, эрхэм дээдсээ. Та Пентос, Мир, Тайрошоос хөлсний цэрэг хөлсөлж болно. Зоосны төлөө алдаг хүн нэр хүндгүй ч тэд боол биш. Армиа тэндээс хайгаач гэж танаас гуйх байна.

- Миний ах Пентос, Мир, Бравос болон бараг бүх Чөлөөт хотуудад очиж байсан. Магистер эзэд түүнийг дарсаар зочилж амлалтаар цатгасан ч сүнс нь өлсөж үхсэн. Гуйлгачины аяганаас хооллосон хүн амьдралынхаа туршид тийм чигээр үлдэнэ. Би Картад хангалттай амталсан. Би Пентост гуйлгын аягатай очихгүй.

- Боолын эзэн байснаас гуйлгачин байсан нь дээр.

- Энэ аль алиных нь ч тухай ярьж байна. Та зарагдах гэж юу болохыг мэднэ гэж үү? Харин би мэднэ. Миний ах намайг Кал Дрогод алтан титмийн төлөө зарсан. Дрого түүнд алтан титэм шагнасан ч хүссэн шиг нь биш байсан. Нар од минь намайг хатан болгосон ч ондоо хүн байсан бол амьдрал маань өөр тийшээ эргэх байлаа. Та намайг айх гэж юу болохыг мартсан гэж бодож байна уу? гээд Данигийн хамар сартайлаа.

- Эрхэм дээдсээ би таныг гомдоох гээгүй юм шүү гээд Цагаан сахалт толгойгоо бөхийлгөв.

- Зөвхөн худал үг намайг гомдоодог болохоос биш үнэнч зөвөлгөө биш гээд Дани Арстаны үрчгэр цоохор гаран дээр тайвшируулан алгадлаа.

- Би ердөө лууны түргэн ааштай болохоор тэр. Би таныг айлгах гээгүй юм шүү.

- Санаж явахыг хичээе гээд Цагаан сахалт инээмсэглэлээ.

Тэр сайхан царай их хүчтэй юм гэж Дани бодлоо. Тэр яагаад сэр Жорахын хөгшин хүнд итгэхгүй байгааг ойлгосонгүй. Намайг ярилцах өөр хүн олсонд атаархсан юм болов уу? Бодол нь өөрийн эрхгүй цөлөгдсөн хүлэг баатар түүнийг "Балерион" дээр үнссэн шөнө рүү буцлаа. Тэр хэзээ ч ийм зүйл хийх ёсгүй байсан. Тэр надаас гурав дахин ах дэндүү дорд гаралтай болохоор би үүнийг зөвшөөрөх ёсгүй байсан. Жинхэнэ хүлэг баатар хатнаа зөвшөөрөлгүй үнсдэггүй юм. Үүний дараанаас хойш Дани сэр Жорахтай хамт ганцаар үлдэхгүйн тулд онгоцон дээр гарын зарц нарынхаа нэгтэй болон заримдаа цусан морьтонгуудтайгаа байлаа. Тэр намайг ахин үнсэхийг хүсч байгаа. Би үүнийг түүний нүднээс харж байна.

Дани юу хүсч байгаагаа мэдээгүй ч Жорахын үнсэлт Кал Дрогог үхсэнээс хойш дотор нь унтаж байсан ямар нэг зүйлийг сэрээжээ. Хавчиг орон дээрээ нүцгэн хэвтэж байхдаа дэргэд нь зарцын оронд эр хүнд хэвтэж байвал яахыг төсөөлөхөд сэтгэл нь хөөрнө. Заримдаа нүдээ анин эр хүн мөрөөдөхөд хэзээ ч Жорах Мормонт байсангүй хайрт нь үргэлж залуу царайлаг бөгөөд царай нь ямагт сүүдэрт далдлагдсан байна.

Нэг удаа үүнд тамлагдан унтаж чадсангүйд гараа хөлнийхөө хооронд явуулан чийг даасан хэсэгт хүргэлээ. Дэргэдээ унтаж байсан Ирриг сэрээхгүйн тулд үл мэдэг амьсгалан хуруугаа удаанаар нааш цааш болгож чимчигнэсэн хэсгийг олоод эхэндээ хулчгардуухан хөнгөн хүрснээ дараа нь түргэслээ. Тэгсэн ч хүсэл нь амраагүй байхад луунууд нь үймэлдэн нэг нь торондоо хашгирахад Ирри цочин сэрээд юу хийж байгааг нь харчихлаа.

Данигийн царай улайсан ч харанхуйд Иррид харагдсангүй. Зарц нь үг дуугүй гараа цээжин дээр нь тавиад бөхийн хөхний толгойд нь амаа хүргэв. Түүний нөгөө гар хэвлий рүү нь зөөлөн гулгаж мөнгөлөг алтан үс рүү шурган Данигийн гуяны хооронд ажиллаа. Энэ нь хэдхэн хормоос хэтэрсэнгүй Данигийн гуя чангарч цээж нь оволзон бүх бие нь чичирэхэд хашгирав. Эсвэл магадгүй Дрогод хашгирсан буй за. Ирри үг дуугүй буцаж хэвтээд агшин зуур атиралдан унтлаа.

Дараагийн өдөр нь энэ бүхэн зүүд санагдав. Сэр Жорах түүнд юу хийсэн хэрэг вэ? Би нар од минь болсон Дрогог л хүсч байгаа болохоос Ирри, сэр Жорахыг биш зөвхөн Дрого гэж Дани өөртөө сануулав. Гэвч Дрого үхсэн. Тэр эдгээр мэдрэмж улаан хязгаарт түүнтэй цуг үхсэн гэж бодсон ч

ганцхан урвасан үнсэлтэнд буцаж иржээ. *Тэр намайг үнсэх ёсгүй байсан юм. Түүнд дэндүү их зүйл зүрхлэхийг би зөвшөөрчээ. Ийм явдал ахин болох ёсгүй.* Дани уруулаа гунигтай жимийн толгойгоо сэгсрэхэд гэзэгнийх нь хонх зөөлөн жингэнэлээ.

Тохойн ойролцоо хотын үзэмж сайжирлаа. Эргийн дагуу нүсэр тоосгон пирамидууд эгнэж хамгийн том нь дөрвөн зуун футын өндөр ажээ. Өргөн сэрүүн асарт янз бүрийн мод, ороонго, цэцэг цэцэглэж салхины сэвшээнд анхилуун ногоон үнэр түгээнэ. Хаалган дээр өөр нэг нүсэр харпи байсан ч хүрэл биш жигнэсэн улаан шавраар хийсэн нь мэдэгдэхүйц үйрч бутран хилэнцийн сүүл нь мухар болж сарвуундаа барьсан гинж өгөршин зэвэрчээ. Ус сэрүүн байсан тул давалгаа ялзарсан шон мөргөхөд хачирхалтай тайтгаруулам чимээ гарна.

Эгго Даниг дамнуургаас буухад туслав. Хүчит Белвас том шон дээр суугаад томоохон шарсан хүрэн мах идэж байв.

- Нохойн мах. Астапорын сайн нохой, бяцхан хатан минь? Идэх үү? гэж тэр Даниг хармагц баяртай хэлээд тостой амаараа инээмсэглэв.

- Наадах чинь сайхан хэдий ч үгүй, Белвас гээд Дани урьд нь өөр газар нохойн мах идэж байсан ч одоо зөвхөн Ансаллид болон тэдний тэнэг гөлөгнүүдийг бодож байлаа. Тэр том тайганыг өнгөрч онгоцны дамнуургаар "Балерион"-ы тавцан руу гарав.

Сэр Жорах Мормонт түүнийг хүлээн зогсож байлаа. Тэр толгойгоо бөхийлгөн,

- Эрхэм дээдсээ боолын эзэд ирээд явсан. Тэд гурвуул арваад хэлмэрч түүнээс ч олон боолтой байсан. Тэд хөлөө хүрэх бүх газар шурган бидэнд байгаа бүхнийг үзсэн гээд хитэг рүү дагуулан алхаж,

- Тэд хичнээн хүн зарна гэж байна? гэв.

- Хэд ч биш гээд Дани Мормонтод юм уу эсвэл хотын бөгчим халуун өмхий үнэр, үйрсэн тоосгонд уурласан эсэхээ алин мэдсэнгүй. - Тэд тайган зарж байгаагаас биш хүн биш. Астапорын бусад хэсэг шиг тоосгоор хийсэн тайган. Би хэзээ ч байрнаасаа хөдөлдөггүй үхмэл харцтай хадаастай малгайны төлөө нялх хүүхдийг хороож, нохдыг боож алдаг найман зуун тоосгон тайган худалдан авах ёстой юу? Тэдэнд ядаж нэр ч байхгүй. Ийм байхад би тэднийг яаж хүн гэж дуудах болж байна, сэр.

- Калисий Ансаллидуудыг хөвгүүн байхаас нь сонгон сургадаг... гэж Жоран уур хилэнд нь балмагдан хэллээ.

- Би тэднийг яаж бэлтгэдэг тухай бүгдийг сонссон гээд Данигийн нүдэнд гэнэтхэн нулимс цийлэгнэхэд сэр Жорахын царай руу чанга алгадав. Ингэхгүй бол уйлах байлаа.

Мормонт алгадуулсан хацартаа хүрлээ.

- Хэрвээ би хатны тавыг алдагдуулсан бол...

- Чи тэгсэн. Чи миний тавыг ихээр алдагдуулсан, сэр. Хэрвээ чи миний жинхэнэ хүлэг баатар байсан бол хэзээ ч намайг энэ өөдгүй хотод авчирахгүй байсан. *Хэрвээ чи миний жинхэнэ хүлэг баатар байсан бол хэзээ ч намайг үнсэх юм уу хөх рүү минь харахгүй байсан...*

- Эрхэм дээдсийн тушаасан ёсоор больё. Би ахмад Гролеод далбаагаа өргөн үдшийн түрлэгээр хөдлөхөд бэлдэхийг тушаая гэхэд,

- Үгүй гэж Данни хэллээ. Гролео тэднийг харахад багийнхан нь бас ширтэж байв. Цагаан сахалт, цусан морьтонгууд, Жикүй гээд бүгд алгадах чимээнд юу болсныг харахаар зогсчээ.

- Би одоо явмаар байгаа ч энэ түрлэгээр биш. Би аль болох түргэн алс явж хэзээ ч эргэж харахгүй байхыг хүсч байгаа ч чадахгүй нь. Энд найман зуун тоосгон тайган зарж байгаа болохоор би тэднийг худалдаж авах арга олох ёстой гээд түүнийг орхин доош явлаа.

Ахмадын бүхээгийн сийлбэртэй модон хаалганы цаана луунууд нь тавгүйцэн үймэлдэнэ. Данигийн орж ирэхийг хараад Дрогон цайвар утаа хамрынхаа нүхээр суунаглуулан толгойгоо өргөн хашгирахад, Висерион жаахан байх үеийнх шигээ мөрөн дээр нь суухыг хичээн далавчаараа нүдэв.

- Үгүй. Чи одоо үүнд дэндүү томдоно гээд Дани түүнийг зөөлхөн холдуулахыг хичээсэн ч луу цагаан алтан сүүлээрээ гарыг нь ороож хар хумсаа ханцуйны хувцсанд шигтгэн салж өгсөнгүйд аргагүйдэн Гролеогийн том арьсан сандал руу хөхрөн унав.

- Тэд таныг явснаас хойш тухгүй байгаа, калисий. Висерион хаалгыг үйртэл хумсаараа базсаныг харж байна уу? Харин Дрогон боолын эзэд харахаар орж ирэхэд золтой зугтаагүй. Би түүнийг сүүлнээс нь барин буцааж татахад над руу эргээд хазсан гээд Данид гаран дээрх шүдний ормыг нь үзүүлэв.

- Тэд замаа галаар чөлөөлөн гарахыг оролдсонгүй юу? гээд Дани үүнээс л хамгийн их айж байлаа.

- Үгүй, калисий. Дрогон зөвхөн хоосон агаарт тургисан. Боолын эзэд түүнд ойртохоос айсан гэхэд Дани Ирригийн гаран дээрх Дрогоны хазсан ормыг үнсэв.

- Чамайг өвтгөсөнд өршөөгөөрэй. Луунууд давчуу онгоцны бүхээгт хоригдох амьтад биш.

- Луунууд үүгээрээ морьдтой адилхан. Бас морьтонтой ч гэсэн. Дор морьд унгалдан модон хана өшиглөхийг би сонссон, калисий. Харин Жикүй таныг энд байхгүйг мэдээд хөгшин эмгэнээс авахуулаад бяцхан хүүхэд хүртэл уйлж хашгирсан гэсэн. Тэд усан тэрэг давстай хар тэнгист дургүй.

- Би мэдэж байна. Би мэднэ гэж Дани хэллээ.

- Миний калисий гунигтай байна уу?

- Тийм. *Гунигтай бас хаягдсан.*

- Би калисийг баярлуулах уу?

- Үгүй, Ирри чи үүнийг хийх хэрэггүй. Тэр шөнө чамайг сэрэхэд болсон явдал бол... чи орны боол биш. би чамайг чөлөөлснийг санаж байгаа биз дээ? Чи... гээд Дани түүнээс алхам холдлоо.

- Би Лууны эхийн гарын зарц болохоор калисийг баярлуулах нь миний хувьд нэр төрийн хэрэг.

- Би үүнийг хүсэхгүй байна. Би үгүй. Намайг одоо орхи. Би ганцаар үлдэн бодохыг хүсч байна гээд Дани цааш огцом эргэлээ.

Даниг тавцан руу гарч ирэхэд Боолын булан дээгүүр үдшийн бүрий нөмөрчээ. Тэр хашлага руу очин Астапорын зүг ширтэв. *Эндээс үзэсгэлэнтэй харагдаж байна* гэж бодлогоширов. Кразнисийн хэлмэрчийн хэлсэн ёсоор дээр нь одод түгж дор нь торгон дэнлүү анивалзан тоосгон пирамидуудад гэрэл улалзана. *Гэвч гудамж, талбай, тулааны нүх харанхуй бяцхан хүү эр хүний тэмдгийг нь авсан өдөр өгсөн гөлгөө тэжээж байгаа хуаранд бүр харанхуй байгаа.*

Ард нь хөлийн зөөлөн чимээ гарлаа.

- Калисий. Би таньтай илэн далангүй ярьж болох уу?

Дани эргэж харсангүй. Түүнд одоо түүнийг харах хүч байхгүй байв. Хэрвээ тэгвэл ахин алгадах юм уу эсвэл уйлах байх. Өөрөөр үнсэх ч юм уу. Тэр алин зөв, буруу, ухаангүй явдал болохыг мэдэхээ болжээ.

- Хүссэнээ хэл, сэр.

- Эйгон луу Вестеросын эрэгт газардахад Хөндий, Хад, Талын лордууд түүнд титэм гардуулахаар хуйлраагүй. Хэрвээ та төмөр хаан ширээнд нь суухыг хүсч байгаа бол түүний хийсэн жишгээр илд, лууны галаар олж авах ёстой. Харин энэ бүхэн гараа цусаар будахыг шаардана.

Гал болон цус гэж Дани бодлоо. Түүний бүхий л амьдралынхаа турш мэддэг байсан Таргарианы овгийн үг.

- Би дайснуудынхаа цусыг баяртайяа урсгах болно. Харин гэм зэмгүй хүмүүсийн цус бол өөр хэрэг. Тэд надад найман зуун Ансаллид санал болгосон. Найман зуун амь үрэгдсэн хүүхэд. Найман зуун боомилж алуулсан гөлөг.

- Эрхэм дээдсээ. Би Хааны газрыг уналтынх нь дараа харсан. Тэр өдөр тоглож байсан хүүхэд, хөгшин хөвөө хүмүүс алагдаж тоолж чадахаас чинь их эмэгтэй хүчиндүүлсэн. Хүн бүрт зэрлэг араатан байдаг болохоор хэрвээ тэр хүний гарт илд, жад атгуулан дайнд илгээвэл араатан хөдөлнө. Цусны үнэр түүнийг сэрээнэ. Гэсэн ч би хэзээ ч Ансаллидууд удирдагчийнхаа тушаалгүй хүчиндэх юм уу хотын хүмүүсийг хядаж, дээрэм тонуул хийж байна гэж сонсоогүй. Тэд таны хэлсэн шиг тоосго байж магадгүй ч тэднийг худалдаж авбал зөвхөн үхэхийг нь хүссэн нохдыг алах болно. Харин чамд миний санаж байгаагаар үхэхийг хүссэн ноход байгаа биз дээ.

Булаан эзлэгчийн ноход.

- Тийм гээд Дани дэнлүүний зөөлөн гэрэл харахад сэрүүн сэвшээ давстай салхи нүүрийг нь илбэв.

- Та эзлэгдсэн хотын тухай ярилаа. Надад үүнийг хариулаач, сэр... яагаад Дотракичууд энэ хотыг хэзээ ч эзлээгүй юм бэ? гээд зангаж,

- Энэ ханануудыг захаасаа авахуулан хэрхэн үйрснийг хараач. Эдгээр цамхгуудын аль нэгэнд харуул байна уу? Би харахгүй байна. Эсвэл тэд нуугдчихсан юм болов уу, сэр? Би өнөөдөр эдгээр язгууртан дайчин шиг бардам харпигийн хөвгүүдийг харлаа. Тэд судалтай банзал өмсөж догшин шрүүн үстэй байсан. Хамгийн дорой каласар хүртэл Астапорыг самар шиг хагалж дотор нь дотор нь ялзарсан идээг бяц шахаж чадах байсан. Надад хэлээч яагаад энэ үзэшгүй муухай харпигийн хөшөө Вэйс Дотракийн бурхдын замын дэргэд бусад хулгайлсан бурхдын дунд байхгүй байгаа юм бэ?

- Та лууны нүдтэй юм, калисий. Энэ харваас илт байна.

- Би хариулт хүссэн болохоос магтаал биш.

- Энэ нь хоёр шалтгаантай. Астапорын зоригт хамгаалагчид хадсан сүрэлнээс өөрцгүй гэдэг нь үнэн. Эртний нэр тарган хэвтэвчтэй тэд өргөн уудам хаант улсыг одоо хүртэл захирч байгаа юм шиг дүр эсгэн тус бүр өндөр алба хашдаг. Баярын өдөр нүхэнд хиймэл тулаан зохиож хүмүүсийн нүдэн дээр хичнээн хурц ухаантай удирдагчид болохоо үзүүлдэг ч үүнд тайганчууд үхдэг. Гэсэн ч Астапорыг эзлэхийг хүссэн дайсан бүр Ансаллидуудтай нүүр тулгарахаа мэдэж байгаа. Боолын эзэд хотын хамгаалалтанд бүх ангиа гаргана. Дотракичууд Кохорын хаалган дээр гээгээ тэдэнд орхисон цагаас хойш Ансаллидуудын эсрэг мордон дайрахаа больсон.

- Тэгвэл хоёр дахь шалтгаан нь юу юм?

- Астапорыг хэн дайрна гэж? Мирийн, Юнкай хотууд өрсөлдөгч хэдий ч дайснууд биш. Валирианыг сүйрэл устгахад дорно зүг бөглүү нутаг бүгд Гискарийгийнхан түүний толгодоос цааш Лазаринчууд нутагладаг. Тэднийг Дотракичууд Хурган хүмүүс гэж нэрлэдэг дайчин бус гэдгээрээ алдартай.

- Тийм л дээ гэхдээ хойд зүгийн боолын хотууд Дотракийн тэнгист байхад хоёр зуун хүчит калын алин ч хотыг эзлэн хүмүүсийг нь боол болгон авч чадахгүй гэж үү?

- Тэднийг хааш нь аваачих гэж? Боолын эздийг аллаа гээд боолуудад сайн зүйл юу байна? Валириа байхгүй болж, Карт улаан хязгаарын цаана оршин, Чөлөөт есөн хот өрнө зүг мянган бээрийн зайд байгаа. Тэгээд ч харпигийн хөвгүүд зөрж өнгөрсөн кал бүрт Пентос, Норвос, Мирийн магистерууд шиг өгөөмөр ханддаг. Тэд морьтон лордуудыг найрлуулж бэлэг сэлт өгвөл удахгүй явахыг нь мэдэж байна. Энэ нь тулалдаж байснаас илүү хямд найдвартай.

Тулалдаж байснаас илүү хямд. Тиймээ, болох л юм гэж Дани бодлоо. Хэрвээ түүний бүх зүйл ийм амар байсан бол Хааны газар луутайгаа буугаад хөвгүүн Жоффрид авдар алт өгөн яв гэж хэлвэл хичнээн таатай билээ.

- Калисий? гэж сэр Жорах түүнийг удтал дуугарахгүй болохоор нь хэлээд тохойнд нь аяархан хүрэхэд Дани угз татан авав.

- Висерист мөнгө байсан бол чадах чинээгээрээ олон Ансаллид авах байсан. Гэхдээ та намайг урьд нь Рэйгартай адилхан гэж хэлсэн биз дээ...
- Би санаж байна, Данерис.
- Эрхэм дээдсээ гэж Дани заслаа.
- Ханхүү Рэйгар чөлөөт хүмүүсийг дайнд удирддаг болохоос биш боолуудыг биш. Цагаан сахалт түүнийг дагуулуудаа адислан маш олон хүнийг хүлэг баатар болгосон гэсэн.
- Лууны цохионы ханхүүгийн гараас хүлэг баатрын зэрэг хүртэхээс илүү өндөр ямар нэр хүнд байх билээ.
- Тэгвэл надад хэлээч... тэр хүний мөрөнд илдээр хүрэхдээ юуг гэж хэлдэг байсан бэ? Явж сул доройг ал? Эсвэл тэднийг хамгаал гэдэг байсан уу? Висерис Сэрээнд лууны далбаан дор олон зоригт хүмүүс үрэгдсэн гэж ярьдаг байсан ч... тэд амиа Рэйгарын төлөө зориулж байна гэж итгэсэн учраас өгсөн үү эсвэл үүнийх нь төлөө худалдаж авсан гэж бодсон хэрэг үү? гээд Дани Мормонт руу гаргаа зөрүүлэн эргэж хариулт хүлээлээ.
- Хатан минь таны хэлсэн бүх зүйл үнэн. Гэвч Рэйгар Сэрээнд ялагдсан. Тэр тулаанд дайнд ялагдсан болохоор хаант улс амиа ч гэсэн алдсан. Түүний цус голын уруу цээж хуягнийх нь бадмаарагтай хуйлран урсахад булаан эзлэгч Роберт цогцсон дээгүүр нь мориор гаран төмөр хаан ширээг хулгайлсан. Рэйгар зоригтой тулалдаж, Рэйгар хүлэг баатрын ёсоор уужим дайтсан ч, Рэйгар үхсэн.

БРАН

Тэдний явж буй уулсын тахирласан хөндийд зам харгуй гэх юм байсангүй. Саарал хадан оргилуудын хооронд урт сунаж тогтсон гүн цэнхэр нууруудын толигор мандал цэлийж, эцэс төгсгөлгүй үргэлжлэх шилмүүст ногоон ой сүглийнэ. Чонын ойг[1] орхин эртний цахиур чулуун толгод руу авирч эхлэхэд намар цагийн шар бор, алтан шаргал навчисын тоо цөөрсөөр цахиур чулуун толгод уулс болон хувирахад бүр үзэгдэхээ болив. Аварга том саарал ногоон шилмүүст модод тэдний дээгүүр дүнхийж, гацуур, жодоо болон цэх сайхан нарс модод эцэс төгсгөлгүй ярайна. Моддын ёроолоор гавьтай ургасан зүйлгүй боловч ойн хөрс хар ногоон шилмүүсээр хучигдсан байв.

Замаа олохгүй төөрөх тохиолдол нэг хоёр удаа гарч байсан ч хүйтэн жавартай шөнийн үйлгүй цэлмэг үдшийг хүлээн тэнгэр өөд харан Мөсөн Лууг олоход л болдог байв. Луугын нүдний цэнхэр од хойд зүгийг заадаг хэмээн Оша түүнд хэлсэн ажээ. Ошагийн тухай бодол Браныг түүнийг хаана байгаа бол хэмээн эргэцүүлэхэд хүргэв. Ошаг аль хэдийнээ Рикон болон Сэгсгэр нохойн хамтаар Цагаан Боомтод аюулгүй хүрчихсэн тарган Лорд Мандерлитэй цуг могой загас, загас болон халуухан хавчтай бялуу зооглон суугаадаа хэмээн дүрслэн бодов. Эсвэл тэд Эцсийн Голомтод хүрчихсэн Том Жоно түүдэг галын өмнө дулаацан суугаа ч байж мэдэх юм. Гэтэл Браны амьдрал Ходорын нуруунд бэхэлсэн сагсанд суугаад уулсын энгэрээр өөд уруугүй хэрэн тэнүүчлэх эцэс төгсгөлгүй үргэлжлэх жихүүн өдрүүд болон хувирчээ.

- Дээшээ доошоо, өөдөө уруу. Тэгснээ бас л өгсөж уруудна. Би чиний энэ тэнэг уулсад чинь дүргүй хүрч байна, ханхүү Бран хэмээн алхлах зуураа Мира гомдоллов.

- Өчигдөрхөн л чи эдгээр уулсад дуртай гэж хэлсэн биз дээ.

- Тийм л дээ. Лорд эцэг маань надад өндөр уулсын тухай ярьж өгдөг байж билээ. Өмнө нь нэгийг ч харж байсангүй. Би тэдэнд өөрөө ч мэдэхгүй ихээр дуртай.

- Бран түүн рүү нүүрээ мушилзуулан, “Гэтэл чи дөнгөж сая тэдэнд дургүй гэж хэллээ шүү дээ.”

- Яагаад хоёулаа байж болохгүй гэж? хэмээн Мира хэлээд гараа сунган түүний хамрыг чимхэв.

- Яагаад гэвэл тэр хоёр чинь *өөр шүү дээ*. Өдөр шөнө шиг. Гал мөс шиг өөр хэмээн Бран зүтгэв.

- Мөс галд шатдаг шиг хайр үзэн ядалт хоёр хослон оршиж болно. Уулс байна уу намаг байна уу ямар ч ялгаа байхгүй. Газар нутаг бол ганц гэж Жожен нухацтай хоолойгоор хариулав.

- Ганц гэхдээ дээгүүрээ атираа нугачаатай гэж эгч нь түүнтэй санал нийлэв.

Умардаас өмнөд рүү, эсвэл өмнөдөөс умард руу сунаж тогтсон уул нурууд ховорхон таарна. Тиймээс тэд чигээ алдан олон арван бээр газар явах тохиолдол бишгүйдээ нэг гарч байв. Заримдаа ирсэн замаараа буцаж явах ч үе гарна.

- Хэрвээ бид хааны замаар явсан бол Хананд хэдийн хүрчих байсан гэж Бран Ридийнхэнд

сануулна. Бран гурван нүдтэй хэрээг олж нисч сурахыг хүсч байсан болохоор урьд нь хэлсэн зүйлээ байнга давтсаар байгаад Мира зэрэг даган хэлж түүгээр тохуурхдаг болжээ.

Тэгэхээр нь Бран, хэрвээ бид хааны замаар явсан бол ингэж өлсөхгүй байх байсан гэж хэлдэг болов. Намхан хөндий толгодын дундуур явахад тэд хоол ундаар дутагдаж байсангүй. Мира зэгсэн сайн анчин байв. Гурван салаа үзүүртэй мэлхийний жадаараа голын уснаас загас барихдаа бүүр ч гаргуун. Бран түүнийг ажиг дуртай байлаа. Түүний хурдан шалмаг хөдөлгөөн болон хэрхэн жадаа эвлэгхэн шидээд л үзүүрт нь мурилзан хөдлөх мөнгөн хулд загас зоон гаргаж ирэхийг нь харах дуртай байв. Түүгээр ч зогсохгүй Зун тэдэнтэй ангийн олзоосоо хуваалцна. Зэрлэг чоно ихэнхи шөнө нар жаргангуут л бараа сураггүй алга болдог ч үүр цайхаас өмнө амандаа хэрэм юмуу туулай зуучихсан эргэн ирдэг байв.

Гэтэл эдгээр өндөр уулсын дунд гол горхиуд нарийсан зайрмагтаж ан амьтны бараа цөөрчээ. Мира боломж гарвал л ангуучлах юм уу загасчилна. Гэвч олз омог багатай буцаж ирнэ. Зарим шөнө Зун хүртэл хоосон эргэн ирнэ. Олон шөнө өлөн гэдэстэй унтахад хүрч байв.

Гэвч Жожен зам харгуйгаас хол хөндий байх дээр хөдлөшгүй бат зогсож байв.

- Зам харгуйгаар явбал аянчин хүмүүстэй таарна. Аянчид мэдээж харах хоёр нүдтэй. Мөн зэрэмдэг хүү, түүний үлэмж биетэн, тэднийг даган гэлдрэх чонын тухай сонин хачин дуулгах хэлтэй хэмээн Жожен хэлнэ. Хэн ч Жожен шиг зөрүүдэлж үл чадна. Тэгэхээр тэдэнд аглаг зэлүүд уулсын дундуур явахаас өөр зам байсангүй. Бага багаар мацсаар л, сөөм сөөмөөр дөхсөөр л.

Зарим өдөр бороо асгаран орж, зарим өдөр салхи улин исгэрнэ. Нэг удаа тэд хүчтэй шамарганд цохиулж Ходор хүртэл тэсвэр алдан бархирахад хүрч байв. Цэлмэг саруул өдрүүдэд зөвхөн тэд л хорвоо дэлхий дээр алхалж яваа мэт сэтгэгдэл төрнө. Винтерфеллтэй дүйцэхүйц нүсэр том боржин чулуун цохиог тойрон гарч явахдаа, энэ нутагт хэн нэгэн амьдардаггүй юм уу? хэмээн Мира Рид асуув.

- Хүмүүс амьдардаг. Амберийнхан ихэвчлэн хааны замын зүүн талаар нутагладаг. Гэхдээ тэд зуны цагаар өндөрлөг нуга хөндийд хонио бэлчээдэг. Вуллынхан уулсын баруун талаар Мөсөн Булангийн эргээр оршин суудаг. Харклэйгийнхэн бидний ард толгодын дунд үлдсэн. Өндөр уулсын дунд Нотт, Лиддл, Норрейгийнхэн бас зарим Плинтийнхэн нутагладаг гэж Бран хариулав.

Түүний аавын ээжийнх нь ээж уулсаар нутагладаг Плинтүүдийн нэг байжээ. Хөгшин Нан нэгэн удаа түүний судсаар гүйж байгаа элэнц эмээгийнх нь цус Браныг авирч мацсан мунхаг амьтан болгосон хэмээн хэлж байжээ. Браны элэнц эмээ түүнийг төрөхөөс олон жилийн өмнө, бүр түүний аавыг нь ч төрөөгүй байхад өөд болсон гэдэг.

- Вулл гэнэ ээ? хэмээн Мира гайхав. “Жожен, дайны үед нэг Вулл аавтай цуг дайнд мордсон гэдэг биз дээ?”

- Тео Вулл гэж удаан мацсанаасаа болоод Жожен амьсгаагаа дарж ядан хариулав. “Хувингууд гэж түүнийг дууддаг байсан.”

- Тэр чинь тэдний сүлд тэмдэг хэмээн Бран өгүүлэв. “Цагаан саарал дөрвөлжин хээгээр эмжээрлэгдсэн цэнхэр дэвсгэр дээр гурван бор хувинтай. Лорд Вулл нэг удаа аавд үнэнчээ илэрхийлэхээр Винтерфеллд зочилж байсан. Тэр бамбайгаа гурван хувингаар чимэглэсэн байсан. Яг үнэндээ тэр жинхэнэ лорд биш л дээ. Уул нь ч лорд л доо. Гэхдээ хүмүүс түүнийг зүгээр л Вулл гэж дууддаг. Бас Нотт, Норрей, Лиддлийнхэн байна. Винтерфеллд бид тэднийг лорд гэж нэрлэдэг. Харин тэдний албатууд нь тэгдэггүй.”

Жожен Рид амьсгаагаа дарахын тулд түр зогсов. “Чи уулынхан биднийг энд байгааг мэдэж байгаа гэж бодож байна уу?”

- Тэд мэдэж байгаа хэмээн Бран хариулав. Тэднийг өөрсдийг нь ажиглаж байхыг өөрийнхөө нүдээр биш харин Зуны юуг ч анзаарахгүй үл орхих хурц нүдээр олж харжээ. “Бид тэдний морь ямааг хулгайлах гэж оролдохгүй л бол тэд бидэнд саад болохгүй.”

Үнэхээр л нутгийнхан саад тотгор болсонгүй. Нэг удаа тэд гэнэт цутгасан хүйтэн борооноос зугтан нөмөр газар хайж явахдаа нутгийн хүнтэй таарчээ. Саарал ногоон мөчрүүд нь толгой дээгүүр дүнхийх аварга шилмүүст модны ард нуугдсан жижигхэн агуйг Зун шиншилж яваад олжээ. Чулуун халхавчин доогуур Ходор бөхийн ороход Бран агуйн эцэст сүүмэлзэх шар туяаг хараад өөрсдийгөө ганцаар биш гэдгийг ойлгожээ.

- Наашаа дөхөж дулаацацгаа. Биднийг борооноос хамгаалах хангалттай зай бий хэмээн эр хүний дуу гарав.

Үл таних хүн тэднийг овъёосны бин, цусан зайдас болон өөрийн дамшигтай шар айргаар хүртэл дайджээ. Гэвч өөрийн нэрийг хэлсэнгүй. Тэдний нэрийг ч асуусангүй. Бран түүнийг Лиддл байх хэмээн таамаглав. Үл таних хүн хэрмийн арьсан нөмрөгөө алт хүрлээр урласан боргоцойн хэлбэртэй товчоор товчилжээ. Лиддлийнхэн ногоон цагаан бамбайныхаа цагаан хэсгийг боргоцойн дүрсээр чимдэг байв.

Бороо зогсохыг хүлээх зуураа Бран түүнээс, “Хана хүртэл хол уу?” хэмээн асуужээ.

- Хон хэрээн жигүүртэй бол холгүй. Жигүүргүй бусдад нь хол гэж Лиддл өөрөө хон хэрээ юм шиг хариулав.

- Бран, “Тэнд хүрчихсэн байх байсан даа. Хэрвээ бид ...” гэж эхэлтэл,

- ... хааны замаар явсан бол хэмээн Мира түүний үгийг гүйцээв.

Лиддл хутга гаргаж ирэн нэгэн мөчрийг жижиглэж эхлэв.

- Винтерфеллд Старк байхад онгон залуу бүсгүй хааны замаар эхээс төрсөн биеэрээ аялахад ч айх аюул байсангүй. Аянчин хүмүүст дэн буудал, цайз бэхлэлтэнд халуун гал, аяганы амсар олддог цаг байлаа. Гэвч одоо цаг цөвүүн болж нээлттэй хаалга олдохоо больсон. Далайн арваалж[2] чонын ойгоор хэрж, арьсаа өвчүүлсэн хүмүүс хааны замаар явуулын хүмүүсийг сураглах болж.

Жожен Мира хоёр харц солилцов.

- Арьсаа өвчүүлсэн хүмүүс гэнэ ээ? хэмээн Жожен асуув.

- Тийм, Бутчийн гар хөлүүд. Уул нь Бутчийг үхчихсэн гэж байсан. Харин одоо амьд гэлцэх юм билээ. Чононы арьсны төлөө чамгүй мөнгө амлаж байна гэж хүмүүс ярьж байна лээ. Бас өөр бас нэг амьд үхдлийн тухай сураг чимээний төлөө алт амласан сураг гарсан. Ингэж хэлэх зуураа тэрээр Бран болон түүний хажууд тэрийн хэвтэж байгаа Зуныг харав.

- Харин Ханын хувьд ч миний очихыг хүсэх газар лав биш. Хөгшин Баавгай Харуулынхныг дагуулаад Сүнстэй ой[3] руу явсан боловч нэг ч захиа тээгээгүй шахуу хэдэн хон хэрээнээс өөр юм эргэж ирээгүй гэнэ. *Хар жигүүр, хар үг* гэж ээж минь хэлдэг байж билээ. Гэвч үг хэлгүй нисч ирсэн шувууд надад бүр ч илүү хар юм шиг санагдаж байна. Түүдэг галыг мөчрөөр онгичих зуураа, “Винтерфеллд Старк байхад арай ч ийм байдаггүй байлаа. Хөгшин чоно амиа алдаж, залуу чоно өмнө зүгт хаан ширээний тоглоом тоглохоор явчихлаа. Бидэнд одоо хэдэн сүнснээс өөр юм үлдсэнгүй.”

- Чононууд эргэн ирэх болно оо хэмээн Жожен нухацтайгаар хэлэв.

- Чи хаанаас мэдсэн юм, хүү минь?

- Би зүүдэлсэн юм.

- Зарим шөнө би есөн жилийн өмнө өөд болсон муу эхийгээ зүүдэлдэг юм. Өглөө босоход эх минь бидэндээ эргэж ирээгүй л байдаг гэж өнөөх хүн өгүүлэв.

- Тэд чинь зүгээр л зүүд шүү дээ, эзэн минь.

- Ходор хэмээн Ходор хэлэв.

Бороо шөнө дөл болтол зогсоогүй тул тэд хамтдаа шөнийг өнгөрөөв. Зөвхөн Зун л агуйгаас гарахыг хүсэж байв. Түүдэг гал шатаж дуусаад цог үлдэхэд Бран түүнийг явуулав. Зэрлэг чоно хүмүүс шиг чийг мэдэрдэггүй болохоор шөнө түүнийг дуудаж байв. Сарны гэрэлд нойтон модод мөнгөн өнгөөр туяарч, саарал оргилууд цагаан өнгөөр дүнхийнэ. Шар шувуу шөнийн харанхуйд улин нарсны дундуур чимээгүйхэн ниснэ. Цайвар ямаан сүрэг уулын энгэрээр бэлчинэ. Бран нүдээ анин өөрийгөө чонон зүүдэнд бүрэн эзэмдүүлэв. Шөнө дөлийн чимээ, үнэр түүнийг дуудаж байлаа.

Дараагийн өглөө нь тэднийг сэрэхэд гал унтарчихсан, Лиддл явчихсан байв. Гэвч Лиддл ногоон цагаан өнгөтэй даавуунд цэмцгэр гэгч нь боосон нэг зайдас, арван хэдэн ширхэг овъёосны бин орхисон байлаа. Зарим бин нь жигнэсэн нарсан самартай, зарим нь үхрийн нүдтэй ажээ. Бран аль алианаас нь идэж үзсэн боловч аль нь илүү таалагдсанаа хэлж мэдэхгүй байв. Хэзээ нэг өдөр Винтерфеллд Старк эзэгнэн суух болно хэмээн Бран өөрөө өөртөө хэлэв. Тэгээд Лиддлийнхэнд нэг самар, нэг үхрийн нүд бүрийнх нь төлөө зуун зуун ширхэгийг эргүүлэн өгнө хэмээн бодов.

Тэр өдөр бартаа саад багатай жижиг жимээр тэд замнав. Үд дундын алдад нар бүрхэг үүлсыг нэвтлэн туслаа. Ходорын нуруун дахь сагсан дотор суугаа Бран бараг л сэтгэл хангалуун явав. Үлэмж биет агтач хүүгийн зөөлөн савлаанд бүүвэйлэгдэж, түүний алхах зуураа аялах намуун аялгуунд мансуурч зүүрмэглээд хүртэл авав. Мира түүний гарт хөнгөхөн хүрч сэрээв.

-Хараач бүргэд байна хэмээн хэлээд тэнгэр өөд мэлхийний жадаараа заав.

Саарал жигүүрээ дэлгэн салхины аясаар хөвөх мэт тогтуун нисэх бүргэдийг Бран толгойгоо өргөн харав. Бүргэдийг дүүлэн эргэлдэхэд алдалгүй дагуулан харж, дэлхий дээгүүр ямарч саадгүй элин халих ямар байдаг бол доо хэмээн эргэцүүлэв. *Авирахаас ч илүү сайхан байх даа.* Бран бүргэдэд хүрэхийг хичээв. Өөрийнхөө тэнэг зэрэмдэг биеийг орхин Зунтай нэгддэг шигээ тэнгэр өөд дүүлэн түүнтэй нэгдэхийг хүсэв. *Ногоон зөнчид тэгж чаддаг шүү дээ. Би ч гэсэн чадах ёстой.* Дахин дахин оролдов. Эцэстээ бүргэд үдийн нарны алтан шаргал униарт уусан үзэгдэхээ болив.

- Бүргэд явчихлаа гэж Бран гунигтайхан өгүүлэв.

- Бид дахиад бүргэдтэй таарах болно оо. Бүргэдүүд энэ уулсын дунд нутагладаг хэмээн Мира түүнийг тайтгаруулав.

- Тийм л байх.

- Ходор хэмээн Ходор хэлэв.

- Ходор гэж Бран санал нэгдэв.

Жожен самрын боргоцой өшиглөх зуураа, “Ходор чамайг өөрийнхөө нэрийг хэлэхэд дуртай байдаг байх,” хэмээн өгүүлэв.

- Ходор гэж түүний жинхэнэ нэр биш ээ гэж Бран тайлбарлав. “Ходор гэж зүгээр л түүний хэлдэг үг. Түүний жинхэнэ нэрийг Валдер гэдэг гэж Хөгшин Нан хэлсэн. Тэр Ходорын эмээгийнх эмээ ч юм уу нэг тиймэрхүү л гээд Хөгшин Нанын тухай дурсахад түүнд гунигтай санагдав. “Төмөр арлынхан түүнийг алчихсан гэж бодож байна уу?” хэмээн Бран асуув.

Тэд түүний цогцосыг Винтерфеллд олж хараагүй ажээ. Ямар нэгэн эмэгтэй хүн үхсэн байхыг Бран эргэн санахгүй байв. “Тэр хэнд ч муу юм хийж байгаагүй. Бүр Теонд ч тэр. Хөгшин Нан зөвхөн үлгэр л ярьдаг байсан. Теон тийм хүнийг хорлохгүй байлгүй дээ. Тийм биз дээ?”

Жожен, “Зарим хүмүүс бусдыг ямар нэгэн шалтгаангүйгээр зөвхөн тэгж чадах болохоороо л хорлодог,” гэв.

- Тэгээд ч Винтерфеллийн хүмүүсийг алсан хүн Теон биш байсан хэмээн Мира нэмэв. Маш олон төмөр арлынхан үхсэн байсан гэж хэлээд Мира нэг гараасаа нөгөө гар луугаа мэлхийний жадаа шилжүүлэв. “Хөгшин Нанын үлгэрүүдийг санаж яв даа, Бран. Түүний хэрхэн ярьж байсныг, түүний дуу хоолойг ч гэсэн бас. Хэрэв чи тэгж явах юм бол түүний нэг хэсэг чиний дотор үргэлж амьд байх болно.”

- Би санах болно оо гэж Бран амлав. Хоёр хадан оргилыг холбосон өндөр хөтөл дээгүүр тахирласан ангийн жимээр мацахдаа тэд удаан гэгч нь дуугүй явцгаав. Эргэн тойронд хатингар нарс модод сүглийнэ. Мөс шиг гялалзах тунгалаг горхи уулын хажуу руу мяралзан урсахыг Бран холоос харав. Жожений амьсгаа, Ходорын хөлийн дор саржигнах шилмүүсийн чимээг анхааран явж байснаа, “Та хоёр ямар нэг түүх мэдэх үү?” гэж эгч дүү хоёроос гэнэт асуув.

- Цөөхнийг л гэж Мира инээн хариулав.

- Цөөхөн гэж түүний дүү батлав.

- Ходор хэмээн Ходор дуу аялангаа нэмэрлэв.

- Алхах зуураа та хоёр нэгийг ярьж өгөөч хэмээн Бран хэлэв. “Ходор хөлөг баатруудын тухай сонсох дуртай. Би ч бас.”

- Хүзүүнд[4] хөлөг баатрууд байхгүй шүү дээ гэж Жожен өгүүлэв.

- Усан дээр гэж Мира түүнийг засав. “Намаг дотор бол үхсэн хөлөг баатрууд дүүрэн бий.”

- Тэр ч үнэн шүү хэмээн Жожен хэлэв. “Андал болон Төмөр арлынхан, Фрейгийнхэн гээд өөр олон мунхагууд. Саарал усыг[5] эзлэхээр ирсэн тэдгээр бүх бардам дайчид. Гэвч хэн ч Саарал усыг олж чадаагүй. Хүзүү рүү довтлон орсон боловч буцаж гараагүй. Тэд удалгүй тэд намагт шигдэн ган төмрийн жинд дарагдан хуяг дуулгатайгаа живж үхэцгээсэн.”

Усан дор живж үхсэн хөлөг баатруудын тухай бодол Браныг жихүүцүүлэв. Гэсэн ч тоосонгүй, Бран жихүүдэс хүрэхэд дуртай ажээ.

- Нэг хөлөг баатар байсан гэж Мира өгүүлэв. Хуурамч хаврын жилд болсон явдал. Инээж буй Модот Хөлөг Баатар гэж хүмүүс түүнийг нэрлэдэг. Тэр баатар намгийн хүн байж болох юм.

- Биш ч байж болно гээд Жожений царай ногоон сүүдрээр цоохортов. “Ханхүү Бран түүний тухай түүхийг хэдэн зуун удаа сонссон гэдэгт итгэлтэй байна.”

- Үгүй хэмээн Бран хариулав. “Би сонсож байгаагүй юм байна. Сонссон байсан ч хамаагүй. Заримдаа Хөгшин Нан өмнө нь ярьсан түүхээ бидэнд давтан ярьж өгдөг байсан. Хэрвээ сонирхолтой түүх бол бид дахиад л сонсчихдог. Хуучин сонссон түүх, яг л хуучны дотно анд шиг байдаг гэж Хөгшин Нан хэлдэг байж билээ. Хааяа хааяа уулзах хэрэгтэй гэж.”

- Тэр ч үнэн шүү гээд бамбайгаа нуруундаа үүрсэн Мира мэлхийний жадаараа үе үе таарах мөчрийг замаасаа зайлуулан алхална. Бран түүнийг түүхээ ярьж өгөхгүйдээ гэж бодогдохоор хугацаа өнгөрсний дараа Мира ярьж эхлэв. “Эрт цагт нэгэн сониуч хүү Хүзүүнд амьдардаг байжээ. Тэр намгийн хүмүүсийн нэгэн адил давжаа биетэй ч эр зориг ихтэй оюун ухаан саруул нэгэн байв. Хүү ой тайгаар ангуучлан, гол усаар загасчлан, модод төглөөр авиран манай хүмүүсийн бүхий л ур чадварыг эзэмшин хүүхэд насаа өнгөрөөжээ.”

Бран энэ тухай сонсоогүй гэдэгтээ бүрэн итгэлтэй байв. “Тэр Жожен шиг ногоон зүүд зүүдлэдэг

байсан уу?”

- Үгүй, гэхдээ тэр балчиг дотор амьсгалж, навчис дээгүүр дүүлж чадна. Шившин хэлсэн хэдхэн үгээр л газрыг ус, усыг газар болгож чадна. Тэр мододтой ярьж, увьдаст үгээр цайз цамхагийг алга болгож, ил гаргаж чадна.

- Би тэгж чаддаг болох юмсан хэмээн Бран гунигтайхан хэллээ. “Хэзээ тэр Модот Хөлөг Баатартай уулзах вэ?”

- Мира түүн рүү харан нүүрээ мушилзуулав. “Хэрэв нэгэн ханхүү чимээгүй байвал тун удахгүй уулзна.”

- Би зүгээр л асуусан юм.

- Хүү намгийн хүмүүсийн ид шидийг мэддэг байв хэмээн Мира үргэлжлүүлэв. “Гэвч хүү илүү ихийг мэдэхийг хүсчээ. Чи мэднэ дээ, манай хүмүүс нутгаасаа хол аялдаггүйг. Бид давжаа хүмүүс. Бидний амьдардаг ёс зарим хүмүүст хачин жигтэй санагддаг. Тийм болохоор том биетэй хүмүүс бидэнтэй үргэлж сайхан харьцдаггүй. Гэвч өнөөх хүү бусдаас илүү зоригтой нэгэн байжээ. Хүү эрийн цээнд хүрсэн өдрөө намгийн хүмүүсийг орхин Нүүрний Арал[6] руу очихоор шийджээ.”

- Хэн ч Нүүрний Арал руу очдоггүй хэмээн Бран зөрөв. “Тэнд чинь ногоон увидастнууд амьдардаг.”

- Хүү ногоон увидастнуудыг олохыг хүссэн юм. Минийх шиг хүрэл хайрсаар урласан цамцаа өмсөөд, арьсан бамбай, гурван салаа жадаа бариад, жижиг арьсан завиа сэлүүрдэн Ногоон Салааг[7] уруудан одсон гэдэг.”

Бран нүдээ анин жижигхэн арьсан завьтай хүүг дүрслэн харахыг хичээв. Түүний толгойд намгийн хүү Жоментэй адилхан харагдав. Гэхдээ Жоженоос том хүчтэй, Мира шиг хувцасласан.

- Фрейгийнхны хараанд өртөхгүйн тул намгийн хүү шөнийн харанхуйгаар Ихрийн хажуугаар өнгөрчээ. Сэрээнд[8] хүрээд голоос гарч, арьсан завиа толгой дээрээ тавиад цааш явжээ. Олон хоног аялсны эцэст Бурхдын Нүдэнд хүрэв. Завиа нуурын усанд тавиад Нүүрний Арлыг чиглэн цааш оджээ.

- Тэр ногоон увидастнуудтай уулзсан уу?

- Тийм гэж Мира хариулав. “Гэвч тэр тухай бол миний ярих ёсгүй өөр нэгэн түүх бий. Миний ханхүү надаас хөлөг баатрын тухай асуусан шүү дээ.”

- Ногоон увидастнуудын тухай байсан ч гэсэн сонирхолтой.

- Тийм шүү гэж Мира санал нийлэв. Гэвч тэдний тухай дахиж ярьсангүй. “Намгийн хүү бүхэл өвлийн турш арал дээр амьдарчээ. Хавар болж өргөн дэлхий дуудахыг сонсоод явах цаг болсныг мэджээ. Арьсан завь нь түүний орхисон газраас хөдлөөгүй байв. Аралтай салах ёс гүйцэтгээд

завиндаа суун нуурын эргийг чиглэн сэлүүрджээ. Сэлүүрдээд л байж, сэлүүрдээд л байж. Эцэстээ нуурын эрэг дээрх их цайзын барааг алсад олж харжээ. Цайзын цамхагууд эрэг рүү дөхөх тусам улам өндөрсөн сүрлийж, дэлхий дээрх хамгийн агуу том цайз байна хэмээн намгийн хүү бодов.

- Харренхал гэж Бран шууд л мэдэв. “Тэр бол Харренхал!”

Мира инээмсэглэв. “Тийм үү? Цайзын хананы доор олон өнгийн асрууд ярайж, тод өнгийн далбаанууд салхинд дэрвэгнэж, хуягт хүлэгээ унасан хөө хуягт хөлөг баатрууд сүлжилдэн байв. Шарсан махны үнэр түүний хамрыг цоргиож, инээд хөгжөөн болон зарчийн бүрээн дуун түүний чихнээ уянгалжээ. Хөлөг баатруудын их тэмцээнд оролцохоор аймшиггүй зоригт дайчид хаант улсын өнцөг булан бүрээс цугларчээ. Хаан өөрийн биеэр заларч, луун ханхүү ч түүнтэй хамт иржээ. Өөрсдийн эгнээндээ шинээр элсэх нэгэн ахан дүүгээ угтахаар Цагаан Илднүүд ч гэсэн ирсэн байв. Шуурганы лорд, сарнай цэцгийн лорд ч бас. Асгатын их арслан хаантай мууцалдсан болохоор тэмцээнд ирсэнгүй. Гэвч түүний олон арван тангараг өргөсөн ноёд, хөлөг баатрууд нь морилон иржээ. Намгийн хүү ийм их сүр жавхланг урьд хэзээ ч үзэж байсангүй. Мөн дахин үзэж чадахгүй гэдэгтээ ч итгэлтэй байв. Энэ бүхэнд оролцохыг юунаас ч илүүтэйгээр хүсэв.”

Бран тийм мэдрэмжийг сайн ойлгож байлаа. Багадаа хөлөг баатар болохыг хүсэн тэмүүлж өдрийн бодол шөнийн зүүд болон суудаг байв. Гэвч энэ мөрөөдөл нь түүнийг унаж хөлөө гэмтээснээс хойш замхран алга болжээ.

- Тэмцээн эхлэхэд цайзын эзний охин хайр сэтгэл, үзэсгэлэн гоогийн хатан хааны титмийг зүүн суужээ. Аймшиггүй зоригт Харренхалын таван хөлөг баатар түүний титмийг хамгаална хэмээн андгайлав. Тэд бол түүний дөрвөн ах болон алдарт авга ах нь болох Хааны Хамгаалагчийн нэг цагаан нөмрөгт хөлөг баатар нар ажээ.

- Тэр үзэсгэлэнтэй байсан уу?

- Тиймээ, тэр үзэсгэлэнтэй байсан хэмээн Мира чулуун дээгүүр харайх зуураа хэлэв. “Гэвч түүнээс үзэсгэлэнтэй бүсгүйчүүд цугласан байжээ. Тэдний нэг нь арван хэдэн дотны хатагтайчуудаа дагуулан ирсэн луун ханхүүгийн хатан байв. Олон хөлөг баатрууд тэднийг төлөөлөн тулалдаж, алчууруудыг нь жадныхаа үзүүрт зүүхийг хүсэж байв.”

- Энэ одоо бас л нэг *хайрын түүх* биш биз дээ. Тийм үү? хэмээн Бран сэжиглэнгүй асуув. “Ходор тийм түүхэнд дургүй.”

- Ходор хэмээн Ходор дэмжив.

- Ходор хөлөг баатрууд мангасуудтай тулалддаг түүхэнд дуртай.

- Заримдаа хөлөг баатрууд ч гэсэн мангасууд шүү дээ, Бран. Жижигхэн намгийн хүү маань тал дундуур зугаалан хаврын дулаан өдрийг таалан хэнд ч гай болохгүй явж байв. Гэтэл тэр гурван илд баригч[9] дагуултай санамсаргүй тааржээ. Тэр гурав арван таваас хэтрэхгүй настай байсан ч гурвуулаа намгийн хүүгээс том биетэй байв. Энэ бол тэдний ертөнц байлаа. Тиймээс тэдний хувьд намгийн хүү тэнд байх эрхгүй байв. Тэд түүний жадыг булаан авч газар түлхэн унаган мэлхий

иддэг хэмээн зүхэв.

- “Тэд Валдерийнхэн байсан уу?” Бранд тэд яг л Бага Валдер Фрейтэй адилхан санагдав.

- Нэг нь ч нэрээ хэлээгүй боловч, намгийн хүү маань тэднээс өшөөгөө авахын тулд царайг нь сайтар тогтоожээ. Тэд түүнийг босох гэж оролдох болгонд газар лүү түлхэж, унангуут нь дээрээс нь өшиглөж байв. Гэтэл хэн нэгэн хүнгэнэхийг тэд сонсов. “Та нарын өшиглөж байгаа наад хүн чинь манай аавын албат хэмээн эмэгчин чоно хашгирав.”

- Дөрвөн хөлтэй чоно уу, хоёр хөлтэй юу?

- Хоёр хэмээн Мира хариулав. “Эмэгчин чоно тэмцээний илд[10] барин гурван илд баригч руу дайран тэднийг хөөв. Гэмтэж шархадсан болохоор намгийн хүүг эмэгчин чоно үүр лүүгээ дагуулан очиж шархыг нь цэвэрлэн хөвөн даавуугаар боож өгчээ. Эмэгчин чонын үүрэнд сүрэг ах дүү нартай нь намгийн хүү учирчээ. Тэднийг толгойлж байсан догшин чоно, түүний хажуу дахь дуугүй чоно болон тэр дөрвийн хамгийн бага нь болох чонын бэлтрэг нар байв.”

- Тэр оройноо тэмцээний нээлтэнд зориулан их найр Харренхалд болов. Эмэгчин чоно намгийн хүүг заавал найранд оролц хэмээн ятгав. Намгийн хүү язгууртан удамтай болохоор найрын ширээнд аль ч эртэй зэрэгцэн суух эрхтэй ажээ. Эмэгчин чоноос татгалзахад тийм ч хялбар биш байсан болохоор намгийн хүү чонын бэлтрэгийн олж өгсөн найрын ширээний хувцасыг өмсөөд их цайз руу найранд орохоор явжээ.

- Намгийн хүү Харрений найрын ширээнээ чононууд болон тэдний андгайлсан албатууд болох толгодынхон, хандгайнууд, баавгайнууд, болон лусын хүмүүстэй зэрэгцэн суугаад цадталаа идэж ханатлаа уужээ. Найран дээр луун ханхүү уйтгар гунигаар дүүрэн дуу дуулсанд чонон бүсгүйн сэтгэл уярч хамар нь шуухитнажээ. Түүнийг уйлсан хэмээн шоолсных нь төлөө чонон бүсгүй чонын бэлтрэгийн толгой дээр дарстай хундага хөмөрчээ. Найран дээр Хар ахан дүүсийн нэг хөлөг баатруудыг Шөнийн Харуулд нэгдэн орохыг уриалж байв. Шуурганы лорд дарс уух тэмцээнд гавлын яс болон үнсэлтийн хөлөг баатрыг ялжээ. Намгийн хүү инээд дүүрэн нил ягаан нүдтэй нэгэн үзэсгэлэнт бүсгүй цагаан илд, улаан хорт могой, гриффиний[11] лорд нартай бүжиглээд хамгийн сүүлд суудлаасаа ч босохоосоо ичимхий дуугүй чонотой догшин чонын хүсэлт ёсоор бүжиглэхийг анзаарчээ.”

- Энэ бүх баяр цэнгүүний дундуур жижигхэн намгийн хүү маань өөрт нь халдсан гурван илд баригчийг ажиглажээ. Тэдний нэг нь өвсний сэрээн хөлөг баатарт, нөгөөдөх нь үхэр зараан хөлөг баатарт харин гурав дахь нь бүх намгийн хүмүүсийн сайн мэдэх бэлгэ тэмдэг болох ихэр цамхаг хатгасан жанчтай хөлөг баатарт үйлчилж байв.

- Фрейгийнхэн гэж Бран дуу алдав. “Гармын Фрейчүүд.”

- Өдгөө байгаа шигээ л тэгэхэд ч гэсэн хэвээр байсан Фрейгийнхэн хэмээн Мира санал нийлэв. “Тэднийг чонон бүсгүй бас анзаарч ах дүү нартаа зааж өгөв. ‘Би чамд тохирохоор морь, хуяг дуулга олж өгч болох юм,’ хэмээн бэлтрэг санал болгожээ. Намгийн хүү түүнд талархаснаа илэрхийлээд өөр хариу хэлсэнгүй. Тэр эргэлзэж байв. Хэдий намгийнхан жижиг биетэй ч тэд нэр

төрөө машинд эрхэмлэдэг хүмүүс байжээ. Намгийн хүмүүсийн нэгэн адилаар өнөөх хүү маань хөлөг баатар биш байв. Манай хүмүүс морины нуруунаас завины арал дээр суухыг илүүд үздэг. Бидний гар жаднаас илүүтэйгээр сэлүүрэнд дадамгай байдаг билээ. Тэр өшөөгөө авахыг ихэд хүсэж байсан ч нэр төрөө хугалж өөрийн хүмүүсээ шившиг болгохоос эмээж байв. Шөнө болоход дуугүй чоно хүүг өөрийн асартаа хоноглохыг урьжээ. Намгийн хүү унтахынхаа өмнө нуурын эрэг дээр очоод Нүүрний Арал руу харан сөхрөн суугаад умардын болон Хүзүүний бурхадаас ивгээл хүсчээ ...”

- Энэ түүхийг ааваасаа сонсож байгаагүй гэж үү? хэмээн Жожен асуув.

- Хөгшин Нан л бидэнд түүх домог ярьж өгдөг байсан. Мира битгий зогсооч, үргэлжлүүлээч.

- Ходор ч бас адил санаатай байсан биз ээ. “Ходор, ходор ходор ходор” хэмээн тэрээр ахин дахин хэлэв.

- Хэрвээ, чи үргэлжлүүлэхийг хүсч байвал ...

- Тэгэлгүй дээ. *Үргэлжүүлээч.*

- Таван өдрийн турш жадны тулаан болохоор төлөвлөгдсөн байжээ хэмээн Мира цааш ярив. “Мөн долоон талт их гарын халз тулаан, сур харвалт, сүх шидэлт, морины уралдаан, дуучдын тэмцээн гээд ...”

- Тэд нар хамаагүй ээ хэмээн Бран тэвчээр алдан Ходорын нуруун дахь сагсан дотроо холбилзов. “Жадны тулааны тухай ярь.”

- Ханхүүгийн тушаалыг дагая. Цайзын эзний охин хайр сэтгэл, гоо үзэсгэлэнгийн хатан хаан байлаа. Түүний титмийг хамгаалахаар тулалдсан дөрвөн ах нь тулааны эхний өдөр ялагджээ. Тэднийг ялсан баатрууд төд удалгүй өөрсдөө ч бас бусдад ялагджээ. Эхний өдрийн төгсгөл болоход үхэр зараан хөлөг баатар ялагчдын дунд байр эзэлсэн байлаа. Харин хоёр дахь өдрийн өглөө өвсний сэрээн болон ихэр цамхагт хөлөг баатар нар ялагч болцгоожээ. Гэтэл хоёр дахь өдрийн үдийн хойно сүүдэр уртасах цагаар нэгэн нууцлаг хөлөг баатар тэмцээний талбар дээр гарч иржээ.”

Бран мэргэн гэгч нь толгой дохив. Нууцлаг хөлөг баатрууд тэмцээнд оролцох нь элбэг тохиолддог үзэгдэл байв. Тэд нүүр царайгаа далдалсан дуулгатай, хоосон эсвэл элдэв янзын сонин зүйлийг илэрхийлсэн зурагтай бамбайтай ирдэг байжээ. Заримдаа алдар цуу нь түгсэн эрэлхэг хөлөг баатрууд өөрсдийгөө нууцлан ирдэг байв. Луун Хөлөг Баатар нэгэн удаа хааны амраг бус өөрийн эгчээ хайр сэтгэл, үзэсгэлэн гоогийн хатан хаанаар өргөмжлөхийн тулд Нулимсан Хөлөг Баатрын дүрд хувиран тэмцээнд оролцон түрүүлж байжээ. Зоригт Барристан хоёр ч удаа нууцлаг баатрын хуяг дуулгыг өмсөж байв. Эхний удаа тэрээр аравхан настай байжээ. “Тэр жижигхэн намгийн хүү байсан гэж би мөрийцөхөд ч бэлэн байна.”

- Түүний хэн болохыг хэнч мэдээгүй хэмээн Мира өгүүлэв. “Гэвч тэр нууцлаг баатар давжаа биетэй, эрээвэр хураавар зүйлсээр хуягласан байжээ. Түүний бамбай дээр инээж буй улаан

нүүртэй эртний бурхадын зүрхэн мод болох цагаан далан мод байлаа.”

- Магадгүй тэр Нүүрний Арлаас ирсэн биз хэмээн Бран хэлэв. “Ногоон увдистан байсан уу?” Хөгшин Нанын домгуудад гардаг хамгаалагчид хар ногоон өнгийн арьстай, толгойдоо үсний оронд навчтай хэмээн дүрслэгддэг. Заримдаа тэд бүр бугын эвэр ургуулсан байдаг байлаа. Гэвч Бран нууцлаг хөлөг баатар бугын эвэртэй байсан бол хэрхэн дуулга өмссөн байж болох тухай төсөөлж чадсангүй. “Хуучин бурхад түүнийг илгээсэн гэж би бодож байна.”

- Тэгсэн ч байж магадгүй юм. Нууцлаг хөлөг баатар хааныг хүндэтгэн жадаа бөхийлгөөд таван ялагч асраа босгосон талбарын төгсгөл рүү давхин одов. Хэнийг тулаанд дуудсаныг чи мэдэж байгаа.

- Үхэр зараан хөлөг баатар, өвсний сэрээн хөлөг баатар, ихэр цамхагийн хөлөг баатар хэмээн *энэ зэргийг* таахтай болсон Бран хэлэв. “Тэр жижигхэн намгийн хүү байсан гэж би хэлсэн шүү дээ.”

- Тэр хэн ч байсан гэсэн хуучин бурхад түүнд хүч хайрлажээ. Үхэр зараан хөлөг баатар эхлээд, дараа нь өвсний сэрээн хөлөг баатар, эцэст нь ихэр цамхагийн хөлөг баатар түүнд ялагджээ. Тэр гурав бусдын хайр хүндлэлийг хүлээгээгүй байсан болохоор Инээж буй Модот Хөлөг Баатрыг ард түмэн удахгүй ялагчаар тодрох эрэлхэг баатраас дутахааргүйгээр уухайлан дэмжижээ. Ялагдсан өрсөлдөгчид нь түүнээс хүлэг морь, хөө хуягаа золиос төлөн буцаан авах гэтэл Инээж буй Модот Хөлөг Баатар дуулганыхаа цаанаас хүнгэсэн аргил хоолойгоор, *‘Өөрсдийн илд баригч нартаа хүндлэл журам гэдгийг сурга. Тэр та нарын золиос болог,’* хэмээн хэлжээ. Ялагдсан хөлөг баатрууд өөрсдийн илд баригч нараа хүндээр шийтгэсний дараа, хүлэг морь, хөө хуягаа эргүүлэн авчээ. Ингээд жижигхэн намгийн хүүгийн хүсэл биелэв. Түүнд ногоон увидастан, эртний бурхад, ойн хүүхдүүд гээд хэн тусласныг хэн мэдэх билээ.”

- Их гоё түүх байна хэмээн Бран хэсэг бодсныхоо эцэст шийдэв. “Тэгээд юу болсон бэ? Инээж буй Модот Хөлөг Баатар тэмцээнд ялж гүнжтэй гэрлэсэн үү?”

- Үгүй ээ. Тэр орой шуурганы хөлөг баатар, гавлын яс болон үнсэлтийн хөлөг баатар хоёр түүнийг илчлэнэ хэмээн андгайлжээ. Дуулганы цаана байгаа царай түүний нөхөр биш хэмээн хаан зарлаж хөлөг баатруудыг түүнийг тулаанд дуудахыг уриалжээ. Дараагийн өглөө зарч нар бүрэн дуу эгшиглүүлж хаан эзэн суудалдаа заларсан боловч хоёрхон хөлөг баатар тулалдахаар гарч иржээ. Инээж буй Модот Хөлөг Баатар бараа сураггүй алга болжээ. Хаан ихэд хилэгнэж өөрийн хүүгээ түүнийг олуулахаар илгээжээ. Луун ханхүү түүний модноос өлгөж орхисон бамбайнаас өөр юу ч олж чадаагүй гэдэг. Эцэст нь луун ханхүү тэрхүү тэмцээнд түрүүлжээ.

- Өө гээд Бран саяын түүхийн талаар хэсэг бодов. “Энэ их гоё түүх байлаа. Гэвч жижигхэн намгийн хүүг доромжилсон хүмүүс нь гурван муу хөлөг баатар байсан нь дээр байсан юм. Тэдний илд баригч нар биш. Тэгсэн бол тэр тэд нарыг бүгдийг нь алах байсан. Тэр золиосын тухай тэнэг хэсэг байна. Нууцлаг баатар бүх өрсөлдөгч нараа ялж тэр тэмцээнд түрүүлэх хэрэгтэй байсан юм. Тэгээд тэр чонон бүсгүйг хайр сэтгэл, гоо үзэсгэлэнгийн хатан хаанаар өргөмжлөх байсан.”

- Чонон бүсгүй өргөмжлөгдсөн дөө. Гэвч энэ тухай илүү гунигтай түүх бий хэмээн Мира өгүүлэв.

- Энэ түүхийг өмнө нь сонсож байгаагүй гэдэгтээ итгэлтэй байна уу, Бран? хэмээн Жожен асуув.
“Лорд эцэг чинь ярьж өгч байгаагүй гэж үү?”

Бран толгойгоо сэгсрэв. Уулсын сүүдэр уртасан нарс моддын завсраар тусаж өдөр орой болсныг илтгэв. *Хэрэв жижигхэн намгийн хүү Нүүрний Арал руу очиж чадсан юм чинь яагаад би очиж болохгүй гэж.* Бүх л домгууд дээр ногоон увидастнуудыг хачин жигтэй ид шидтэй хэмээн гардаг биз дээ. Магадгүй тэд түүнд дахин алхахад нь туслах ч юм билүү. Бүр хөлөг баатар болгон хувиргах ч юм билүү. *Хэдий ганцхан өдөр болсон ч гэлээ тэд жижигхэн намгийн хүүг хөлөг баатар болгосон шүү дээ* хэмээн Бран эргэцүүлэв. *Нэг өдөр ч байсан миний хувьд хангалттай.*

ДАВОС

Шоронгийн өрөө ямар ч гянданд зохисгүй баймаар дулаахан байв.

Гэвч өрөө мэдээж харанхуй байв. Өрөөний гаднах хананы сууринд зоолттой бамбарын сүүмэлзэх шаргал туяа хуучин төмөр торны завсраар үл ялиг тусна. Гэсэн хэдий ч өрөөний хойд хагас түнэр харанхуйн дунд сүлэлднэ. Лууны Цохио арал далайн дунд орших тул өрөө чийгтэй байв. Мөн ямарч гянданд ихдэхээр олон тооны харх өрөөгөөр гүйлдэнэ.

Гэвч Давост хүйтний тухай гомдлох хэрэг байсангүй. Аварга том Лууны Цохион доорх мөлгөр чулуун хонгилууд үргэлж дулаан байдаг, мөн доошлох тусам улам халуун болдог хэмээн сонсож байжээ. Давос өөрийгөө Цайзын түвшингээс хамаагүй доор хоригдсон болохыг тааварлав. Гяндангийн хананд алгаараа дарахад дулаахан санагдаж байлаа. Лууны Цохиог тамын чулуугаар барьсан гэх хууч яриа үнэн ч байж болох юм шиг санагдав.

Гяндангийн өрөөнд анх ирэхдээ түүний бие тун тааруухан байжээ. Тулалдаанаас хойш түүнийг зовоож байсан ханиалга улам дордож бүр халуурч эхлэв. Уруул нь цэврүүтэн хагарч өрөө хэдий дулаан ч дагжин чичрэхийг нь болиулж үл чадна. *Би удаан тэсэхгүй* хэмээн Давос бодлоо. *Би удахгүй энэ харанхуйн дунд үхэх болно.*

Давос бусад олон зүйлийн адилаар үхэх тухайгаа ч бас буруу бодож байснаа удахгүй олж мэджээ. Зөөлөн гар, тууштай хоолой болон залуу Мэйстер Пайлос түүний дээрээс тонгойн харж буй төрхийг Давос бүүр түүрхэн санав. Давост халуун сармистай шөл уулгаж, өвчнийг нь намдааж дагжин чичрэхийг нь зогсоох гэж намуу цэцгийн сүү[1] өгчээ. Намуу цэцгэнд автан бөх унтсан хойно хануур хорхойгоор муу цусыг нь ханасан бололтой сэрэхэд гаран дээр нь хануур хорхойн ором үлдсэн байлаа. Төдөлгүй ханиалгалт нь намдахын зэрэгцээ цэврүүнүүд нь арилж түүний хамтаар цагаан загасны мах, лууван сонгинотой шөл нь ч гэсэн үгүй болов. Нэг мэдэхэд түүний бие сайжирч *Хар Бета* хөлөн доор нь сүйрч түүнийг гол руу авч одсоноос хойш мэдэрч байгаагүй их хүч тэнхээтэй болжээ.

Түүнийг хоёр хуяг харгалзаж байв. Нэг нь намхан боловч бахим биетэй. Зузаан мөртэй, том хүчирхэг гартай ажээ. Төмөр товруу шигтгэсэн арьсан хуяг[2] өмсөнө. Овьёосон зутанг өдөрт нэг удаа Давост авчирч өгнө. Заримдаа зутангаа зөгийн балаар амтлах юм уу сүүтэй хольсон байдаг байлаа. Нөгөө хуяг нь хөгшин бөгтөр, цонхигор царайтай угаагаагүй тослог бохир үс, үрчгэр арьстай байв. Энгэр дээрээ алтан утсаар дугуйрсан оддыг хатгасан цагаан хилэн хүрэм[3] өмсчээ. Хүрэм түүнд богинодож бас өргөдсөний дээр бохирдож урагдсан байв. Хуяг Давост тавагтай мах болон нухаш эсвэл загсны шөл авчирч өгнө. Нэг удаа бүр нүд загасан бялууны тал авчирч өгчээ. Нүд загас Давосын ходоод гэдэс шингээхийн аргагүй тослог байсан ч гяндангийн хоригдлын хувьд ховорхон олдох зоог билээ.

Гяндангийн зузаан чулуун хана цонхгүй болохоор нар сарны гэрлийн аль нь ч үл нэвтрэнэ. Хуягуудын орж гарахаас өөр өдөр шөнийн багцаа авах юм байсангүй. Тэдний хэн нь ч түүнтэй үл ярина. Давос тэднийг ээлж солихдоо хоорондоо солилцох хэдэн үгнээс нь хэлгүй биш гэдгийг нь мэджээ. Хуягууд түүнд нэрээ хүртэл хэлээгүй тул Давос тэдэнд өөрөө нэр өгөв. Намхан бахим

эрийг Зутан. Харин бөгтийсөн цонхигор өвгөнийг авчирч өгсөн бялууных нь төлөө Нүд загас гэв. Цаг хугацаа хэрхэн өнгөрч буйг тэдний авчирах хоолоор болон өрөөний гаднах бамбарын солилтоор баримжаалж байв.

Хүн харанхуйд удахаараа ганцаардаж хүний хоолойн дууг мөрөөсдөг билээ. Түүнд хоол авчирахаар юм уу бохирын хувинг солихоор ирэх болгонд хуягуудтай Давос ярьдаг байв. Тэднээс эрх чөлөө, өршөөл авралыг гуйгаад нэмэргүйг мэдэж байсан тул оронд нь хариулж магадгүй хэмээн горьдон асуултууд асууна. “Дайн юу болж байна?”, “Хааны бие сайн уу?”. хэмээн шалгааж хүү Деван, Ширийн гүнж, Салладор Сааны тухай асууна. “Цаг агаар ямархуу байна?, Намрын шуурга эхлэсэн үү?, Уйтан тэнгисийг хөлөг онгоцууд гаталж байгаа юу?”

Юу ч асуусан гэлээ тэд үл хариулна. Заримдаа Зутан хэсэгхэн зуур ч гэсэн хариулах нь уу гэлтэй ширтэн хардаг байв. Харин Нүд загасны хувьд ямар ч горьдлого байсангүй. *Би түүний хувьд хүн биш шүү дээ* хэмээн Давос бодов. *Зөвхөн ууж идэж, хэлж ярихаас цаашгүй чулуу.* Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэрээр Зутанг илүү найрсаг нэгэн хэмээн шийдэв. Зутан ядаж л түүнийг амьд гэдгийг ойлгож байх шиг сэтгэгдэл төрнө. Хачин жигтэй ч гэмээр нинжин сэтгэл түүнд байлаа. Давос түүнийг хархнуудыг тэжээсэн учир ингэтэл олширсон байх гэсэн сэжиг төржээ. Хуягийг хүүхдүүдтэй харьцаж байгаа мэт хархнуудтай ярьж байхыг сонссон шиг түүнд бодогдов. Давос тэгж зүүдэлсэн ч байж болох юм.

Тэд намайг үхүүлэх хүсэлгүй юм байна хэмээн Давос бодов. *Тэд намайг ямар нэгэн зорилгын төлөө амьд байлгаж байна.* Юуны төлөө байж болохыг Давос бодохыг ч хүссэнгүй. Түүдэг галын дөлд шатахаасаа өмнө Сэр Хабард Рамбтоны хөвгүүд, Лорд Сангласс нар Лууны Цохион доорх гянданд хэсэг хугацаанд хоригдсон билээ. *Би өөрийгөө тэнгист өргөх ёстой байж* хэмээн Давос торны цаана сүүмэлзэх бамбарыг ширтэн суухдаа эргэцүүлэв. *Эсвэл далбаат онгоцыг өнгөрүүлэн хадан дээрээ зүйл дуусах ёстой байж.* *Галын дөлийн оронд хавчны хоол болсон минь илүү дээр.*

Нэгэн үдэш оройн хоолоо дуусган суусан Давос, түүний биеэр хачин жигтэй халуу дүүгэхийг мэдрэв. Төмөр торны завсараар өнгийн хартал гал улаанаар туяаран гялалзах бүсгүй зогсож байлаа. Нижгэр том бадмаараг хүзүүнд нь гялтагнана. Түүн дээр сүлжилдэх бамбарын гэрлээс ч дутахгүй хурцаар гал улаан нүд нь төөнөнө. “Мелисандра” хэмээн Давос түгшсэн сэтгэлээ далдлан хэлэв.

- Сонгино Хүлэг Баатар хэмээн Мелисандра тэр хоёр шатан дээр ч юм уу талбайд ч юмуу санамсаргүй уулзаад эелдэгхэн мэнд солилцож байгаа мэт дөлгөөхөн хариулав. “Бие чинь сайн уу?”

- Урьдахаасаа дээрдсэн.

- Чамд дутагдаж байгаа зүйл байна уу?

- Миний хаан, миний хүү надад дутагдаж байна гээд Давос өмнөх тавгаа түлхэн босож зогсов. “Намайг шатаахаар ирээ юу?”

Улаан хүүхний хүйтэн жигтэй улаан нүд нь Давосыг торны завсараар алдалгүй ажив. “Энэ муу газар биш гэж үү? Харанхуй, жигшүүрт газар. Гэрэлт нарны туяа энд тусдаггүй. Тунгалаг саран ч мөн адил.” Ханан дээрх сууринд зоосон бамбар луу гараараа заан, “Сонгино Хүлэг Баатар, энэ бол чи болон харанхуйн хооронд зогсож буй цорын ганц зүйл. Энэ бяцхан гал. Р’хлорын бэлэг. Би бөхөөчих үү?”

- Битгий хэмээн Давос төмөр тор луу дөхөв. “Гуйж байна.” Хархнуудаас өөр ханьгүй түнэр харанхуйн дунд гарцаараа үлдэхийг тэсэж чадахгүйгээ тэр мэдэж байлаа.

Улаан эмэгтэйн уруул дээр инээмсэглэл тодров. “Галын ивээлийг хайрлах болсон юм биз дээ тэгэхээр.”

- Надад энэ бамбар хэрэгтэй гээд Давос нудрагаа зангидав. *Би түүнээс гуйхгүй. Яасан ч үгүй.*

- Би энэ бамбартай адилхан шүү дээ, Сэр Давос. Бид хоёул Р’хлорын зэвсэг. Бид харанхуйг тогтоох ганцхан зорилгын төлөө бүтээгдсэн. Итгэхгүй байна гэж үү?

- Тийм хэмээн Давос хариулав. Магадгүй Мелисандрад сонсохыг хүссэн зүйлийг нь худал хэлж болох байсан ч Давос үнэнийг хэлэхэд дэндүү дасал болжээ. “Чи харанхуйн эх. Шуурганы адагт төрүүлсэн зүйлийг чинь би хоёр нүдээрээ харсан.”

- Зоригт Сонгино Хүлэг Баатар зөрөн өнгөрч буй сүүдрээс тэгтлээ айлаа гэж үү дээ? Зүрхээ чангал тэгвэл. Сүүдэр зөвхөн гэрлээс төрдөг. Хааны галын дөл хүчгүй болж дахин түүнээс хүү төрүүлэхээс эмээж байна. Энэ нь түүний аминд ч хүрч мэднэ гэж хэлээд Мелисандра түүн рүү дөхөв. “Өөр нэгэн эртэй ... галын дөл нь халуунаар төөнөн шатаж буй нэгэнтэй бол ч ... хэрэв хааныхаа төлөө зүтгэхийг чин сэтгэлээ хүсч байгаа бол миний өргөөнд шөнөөр зочлоорой. Чиний амьдралдаа эдэлж байгаагүй жаргалыг би амсуулах болно. Өөрийн чинь амьдралын галаар тэгээд би юу төрүүлнэ гээч.”

- Аймшиг гэж хэлээд Давос түүнээс холдов. “Хатагтай, би чамаас юуг ч хүсэхгүй байна. Чиний бурханыг чинь ч бас. Магадгүй Долоо намайг хамгаалах бизээ.”

Үүнийг сонсоод Мелисандра санаа алдав. “Тэд чинь Гүнсер Санглассийг хамгаалаагүй биз дээ. Өдөрт гурван удаа залбирч долоон талт одоор бамбайгаа чимсэн байсан ч Р’хлорын гар түүнд хүрэхэд залбиралууд нь хашгиралт болон хувирч галын дөлд шатаж үхсэн. Хуурамч бурхдад сүсэглэх хэрэг байна уу?”

- Би бүх насаараа тэдэнд залбирч ирсэн.

- Бүх насаараа гэж үү Давос Сиворт. *Өчигдрийг хүртэл тийм байсан* гэж хэлээч гээд Мелисандра толгойгоо гунигтайгаар сэгсрэв. “Хаадын өмнө үнэнийг өчихөөс хэзээ ч айж байгаагүй хэр нь яагаад өөртөө худал хэлнэ вэ? Нүдээ нээгээч, Эрхэм баатар минь.”

- Надад юу харуулахыг хүсээв.

- Хорвоо дэлхий хэрхэн бүтсэнийг. Үнэн нүдний чинь өмнө дэлгээтэй байна шүү дээ. Шөнө бол түнэр харанхуй, айдсаар хүйдсээр дүүрэн. Өдөр бол цэлмэг үзэсгэлэнтэй, итгэл найдвараар дүүрэн. Нэг нь хар. Нөгөөдөх нь цагаан. Мөс ба гал. Үзэн ядалт ба хайр нигүүсэл. Гашуун ба амттай. Эрэгтэй, эмэгтэй. Өвчин зовлон ба жаргал цэнгэл. Өвөл ба зун. Хорон муу, сайн сайхан гэж хэлээд Мелисандра түүн рүү улам дөхөв. “Үхэл ба амьдрал. Бүгд л эсрэг тэсрэг. Бүгд л дайн дажин.”

- Дайн гэнэ ээ? хэмээн Давос асуув.

- Дайн хэмээн улаан эмэгтэй түүнийг батлав. “Сонгино баатар минь хоёр дайн болж байна. Долоо биш, ганц биш, зуу ч биш, мянга ч биш. *Хоёр!* Чи намайг ахин нэг бүтэлгүй хааныг хоосон хаан ширээнд залах гэж ертөнцийн хагасыг туулж ирсэн гэж бодоо юу? Цаг хугацааны эхлэлтэй зэрэгцэн энэ дайн эхэлсэн. Дайн дуусахаас өмнө бүх хүмүүс хэний талд зогсохоо сонгох ёстой. Нэг талд Гэрлийн Эзэн, Галын Зүрх, Галын дөл ба Сүүдрийн Бурхан Р’хлор. Түүний эсрэг нэрийг нь дурсаж үл болох Харанхуйн Эзэн, Мөсний Сэтгэл, Шөнө ба Айдсын Бурхан аугаа Нэгэн бий. Бидний хийх ёстой сонголт бол Баратеон Ланнистерийн хооронд биш. Грэйжой болон Старкийн хооронд ч биш. Бид үхлийг юм уу амьдралыг сонгох ёстой. Харанхуйг эсвэл Гэрлийг.” Улаан эмэгтэй ингэж хэлээд гоолиг цагаан гараараа Давосын өрөөний төмөр торыг атгав. Түүний хүзүүндэх нижгэр том бадмаараг өөрийн туяагаар лугших мэт гэрэлтэх ажээ. “Надад хэлээч, Сэр Давос Сиворт. Чин сэтгэлээсээ хэлээч. Чиний зүрх Р’хлорын туяарсан гэрэлтэй цуг дүрэлзэж байна уу? Эсвэл харанхуй хүйтэн өт хорхойгоор дүүрэн байна уу? гээд ноос ширэн хувцастай биенийх нь цаанаас үнэнийг мэдэх гэсэн шиг торны завсраар гараа сунган гурван хуруугаа цээжинд нь хүргэв.

- Миний зүрх эргэлзээгээр дүүрэн хэмээн Давос удаан гэгч нь хариулав.

- Давос минь. Сайн хүлэг баатар минь эцсээ хүртэл үнэнч байх юм даа. Энэ хар бараан өдрүүдэд хүртэл. Намайг хуураагүй чинь сайн болж. Тэгвэл би мэдэх байсан. Өөрийн зарц нар хар зүрхээ хуурамч гэрлээр далдалдаг учраас худал хуурмагийг нэвт харах хүчийг Р’хлор удган нартаа өгдөг юм гэж хэлээд улаан эмэгтэй түүний өрөөнөөс хөнгөн алхан холдлоо. “Юунд миний аминд хүрэхийг санаархна вэ?”

- Хэрэв надаас урвасан хүнийг илчлэвэл би чамд хэлье хэмээн Давос хариулав. Хэдий Салладор Саан л урвасан байж болох авч тэр үүнд итгэхийг хүссэнгүй.

- Хэн ч чамаас урваагүй ээ, Сонгино Хүлэг Баатар. Би чиний зорилгыг галын дөлөнд харсан юм хэмээн улаан эмэгтэй инээд алдав.

-*Галын дөл.* Хэрэв чи ирээдүйг галын дөлнөөс харж чаддаг юм бол бид яагаад Хар усан дээр шатсан юм. Чи миний хөвгүүдийг галд өргөсөн... миний хөвгүүд, миний хөлөг, миний эрчүүд, бүгд шатсан ...

- Мелисандра толгой сэгсрэв. “Чи намайг гүтгэж байна шүү, Сонгино Хүлэг Баатар. Тэр бол миний гал биш байсан. Би хэрэв чамтай цуг байсан бол тулалдаан чинь өөр төгсгөлтэй байх байсан. Гэвч эрхэм дээдэс үл итгэгчдээр хүрээлүүлж бардам зан нь сүсэг бишрэлээс нь илүү

хүчтэй болохыг баталсан. Түүний шийтгэл хүнд байсан ч алдаагаа ухаарсан.”

- *Миний хөвгүүд зүгээр л нэг хааны сургамж байсан гэж үү, тэгээд?* хэмээн Давосын хоолой зангирав.

- Одоо чиний Долоон Ханлиг улсад чинь шөнө нүүрлээд байна хэмээн улаан эмэгтэй цааш үргэжлүүлэв. “Гэвч удахгүй нар дахин мандна. Дайн үргэлжлэх болно, Давос Сиворт. Удахгүй нурман дундах бяцхан цог ч дүрэлзэх их дөлийг ноцоож чаддагийг харуулах болно.. Хөгшин мэйстер Станнисийг зөвхөн эр хүнээр хардаг байсан. Харин чи хааныг л хардаг. Та хоёр хоёулаа эндүүрсэн. Тэр бол Лордын сонгосон галын дайчин. Би түүнийг харанхуйн эсрэг тулалдааныг манлайлж байхыг галын дөлд харсан. Галын дөл худлаа хэлдэггүй юм. Үгүй бол чи энд байхгүй байх байсан. Энэ тухай зөнд бичээтэй бий. Улаан од цусаар асгарч харанхуй цугларах цагаар Азор Ахай давс утаан дундаас дахин төрж чулуун дотроос луунуудыг сэрээх болно. Цуст од ирээд буцлаа. Лууны Цохио бол давс утааны газар. Станнис Баратеон бол дахин төрсөн Азор Ахай!” гэж хэлээд түүний улаан нүд ихэр гал шиг дүрэлзэн Давосын сэтгэлийн гүн рүү өнгийн харах шиг санагдлаа. “Чи надад үл итгэнэ. Одоо хэр нь Р’хлорын үнэнд эргэлзсээр ... гэвч чи түүнд үнэнчээр зүтгэсэн. Дахиад ч зүтгэх болно. Би чамайг хэлсэн бүхнийг минь эргэцүүл хэмээн энд үлдээ. Р’хлор сайн бүхний эх учраас бамбарыг ч гэсэн үлдээ.”

Инээмсэглэл, гал улаан хормойн эргэлтийн хамтаар улаан эмэгтэй түүнийг орхин одов. Түүний үнэр л үлджээ. Мөн бамбар ч гэсэн. Давос газар луу шигдэн суугаад өвдгөө тэвэрлээ. Сүүмэлзэх бамбарын гэрэл түүн дээр бүжиглэнэ. Мелисандрагийн хөлийн чимээ намжихад зөвхөн хархны мэрэх дуу л түүнд хань болов. *Мөс ба гал* хэмээн Давос бодов. *Хар ба цагаан. Харанхуй ба гэрэл.* Улаан эмэгтэйн бурхны хүчийг Давос басамжилж чадахгүй байв. Мелисандрагийн хэвлийнээс мөлхөн гарах сүүдрийг тэр нүдээрээ харжээ. Мөн удган бүсгүй мэдэхийн аргагүй зүйлүүдийг ч хүртэл мэдэж байлаа. *Тэр миний зорилгыг галын дөлөнд харжээ.* Саллаг өөрөөс нь урваагүйг мэдэх сайхан байлаа. Гэвч улаан эмэгтэй түүний нууцыг галын дөлөнд тагнан харж буй тухай бодол түүний сэтгэлийг ихэд үймүүлэв. *Би түүний бурханд үйлчилсэн, дахин үйлчлэх ч болно* гэж улаан эмэгтэй юуг хэлэв. Энэ тухай бодол Давосын сэтгэлийг бачимдууллаа.

Давос бамбар өөд ширтэв. Галын дөл сүүмэлзэн сүүтэгнэхийг нүд анивчалгүй удаан гэгч нь ажиглав. Хилэнт хөшгийг нэвтлэн түүний ард юу нуугдаж байгааг олж харахыг хичээв. Гэвч галаас өөр юу ч байсангүй. Хэсэг ширтсэний дараа түүний нулимс гоожив.

Бурхдын дунд төөрч ядарсан Давос сүрэл дээр эвхэрэн хэвтээд гүн нойронд автлаа.

Гурван өдрийн дараа буюу Зутан гурван удаа, Нүд Загас хоёр удаа ирсний дараа Давосын өрөөний гадна дуу гарав. Давос босон сууж чулуун ханыг налан тэмцэлдэх чимээг сонсов. Түүний нэг хэвийн үргэлжлэх өдрүүдийн хувьд энэ шинэ үзэгдэл байлаа. Чимээ гадагш гэрэл өөд хөтлөх зүүн талын шатан дээр гарч байв. Хашгирах, гуйж гувших нэгэн хүний дуу гарах ажээ.

- *Галзуурал!* Хэмээн өнөөх хүн энгэр дээрээ дүрэлзэж буй зүрхтэй хоёр харуулд чирүүлэн Давосын өрөөний хажууд ирэхдээ хашгирав. Хэлхсэн түлхүүрээ харжигнуулсаар Зутан тэдний өмнө алхаж харин Сэр Акселл Флорент араас нь дагажээ. Акселл хэмээн хоригдол цөхрөнгүй

хэлэв. “Намайг гэсэн сэтгэлээ бодоод *намайг тавь!* Чи ингэж болохгүй. Би урвагч биш.” Тэр өндөр туранхай биетэй мөнгөн саарал үстэй шовгор сахалтай айдас хүйдэст автсан урт цэмцгэр царайтай хөгшин эр байв. “Сэлис хаана байна? Хатан хаана байна? Би түүнтэй уулзахыг шаардаж байна. Өөрүүд та нарыг бүгдийг чинь аваасай! *Намайг сулла!*”

Түүний үгийг харуулууд огт тоосонгүй. Энд үү? хэмээн Давосын гяндангийн өмнө ирээд Зутан асуув. Давос хөл дээрээ бослоо. Хаалга нээгдэнгүүт тэдэн рүү түлхэн дайръя хэмээн сэтгэв. Гэвч энэ нь галзуурал байлаа. Тэд олуулаагаас гадна харуулууд илд зүүсэн байв. Дээр нь Зутан бух шиг хүчтэй амьтан байлаа.

Сэр Акселл хуягт толгой дохин зөвшөөрөв. “Урвагчид бие биендээ хань болог.”

- *Би урвагч биш!* хэмээн хоригдол Зутанг хаалга онгойлгох зуур орь дуу тавив. Хоригдол хэдийгээр энгийн саарал ноосон хүрэм, хар өмдтэй байсан ч түүний ярианаас сурвалжит гаралтай нь илхэн байв. *Сурвалжит гарал нь энд түүнд туслахгүй* хэмээн Давос бодлоо.

Зутан төмөр торыг өргөн гэгч нь дэлгэж Сэр Акселлийн зөвшөөрлөөр харуулууд хоригдлыг өрөө рүү түлхэн оруулав. Хоригдол бүдэрч унахын алдад Давос түүнийг барьж авлаа. Давосын гараас зүтгэн мултарч хаалга өөд гуйван очиход түүний зэвхий даасан эмзэгхэн нүүрэн дээр тас хийн хаагдав. Үгүй ээ хэмээн өнөөх эр орилов. “Үгүй ээ ээ.” Бүх тамираа барсан тэрээр төмөр торыг атгасан чигээрээ шал руу гулсав. Сэр Акселл болон харуулууд аль хэдийнээ гянданг орхин буцацгааж байв. Та нар ингэж болохгүй хэмээн хоригдол тэдний араас хашгирав. “*Би бол Хааны Гар!*”

Түүний хашгирахыг сонсоод хэн болохыг нь Давос мэдэв. “Та Алистер Флорент уу?” гэхэд,

Өнөөх эр толгойгоо эргүүлэн, “Хэн бэ... ?” гэв.

- Сэр Давос Сиворт.

Лорд Алистер нүдээ анивчив. “Сиворт ... Сонгино Хүлэг Баатар. Чи Мелисандраг хорлох гэж оролдсон.”

Давос түүнийг хэлснийг үгүйсгэсэнгүй. Шуурганы адагт байхдаа та номин цэцэг шигтгэсэн цээж хамгаалалт бүхий улаан алтан хуягтай байсан гэж хэлээд Давос гар сунган түүнийг хөл дээрээ босоход нь туслав.

Лорд Алистер хувцасаа гөвж цэвэрлээд, “Би ... би өөрийнхөө байгаа байдлаас уучлал гуйх ёстой байх хэмээн бодож байна, Сэр. Миний авдар сав Ланнистерийн довтолгоонд алдагдсан. Би нуруундаа хөө хуяг, хуруундаа хэдэн бөгжнөөс өөр юмгүй зутган амь гарсан.”

Тэдгээр бөгжөө зүүсэн хэвээр байх шив хэмээн Давос анзаарав. Давост бөгж битгий хэл хуруунууд нь ч бүрэн бүтэн байсангүй.

- Миний хэрчлээт хилэн хүрэм, эрдэнэсээр чимсэн нөмрөгийг маань нэг муу тогоочийн банди

эсвэл нэг барлаг өмсчихсөн Хааны газраар[4] цовхчиж яваа биз хэмээн Лорд Алистер эргэн тойрноо үл анзааран ярьж гарав. “Дайнд гай зовлон тохиолдох нь мэдээж. Бүгд л мэднэ шүү дээ. Өөрт чинь ч гэсэн гарз хохирол учраа биз.”

- Миний хөлөг онгоц хэмээн Давос хариулав. “Миний бүх эрчүүд. Дөрвөн хүү маань.”

- Гэрлийн Эзэн тэднийг харанхуйн дундуур хөтлөн илүү сайхан ертөнц рүү аваачих бол... болтугай хэмээн өнөөх эр өгүүлэв.

- Эцэг тэднийг шудрагаар шүүж, Эх тэдэнд өршөөл нигүүсэл хайрлаасай билээ хэмээн Давос бодов. Гэвч залбирлаа тодроо хадгалав. Лууны Цохио дээр одоо Долоод орох газар байсангүй.

- Миний хүү Цэнгэг усанд[5] аюулгүй байгаа хэмээн өнөөх лорд үргэлжлүүлэв. “Гэвч би *Хилэн* дээр үеэл дүүгээ алдсан. Миний дүү Риамын хүү Сэр Имри.”

Голын аман дахь жижиг чулуун цамхагуудыг үл тоон Хар усны[6] урсгал өөд бүх сэлүүрийн хүчээр тэднийг сохроор дагуулан орсон хүн бол Сэр Имри байсан билээ. Давос түүнийг мартаггүй нь мэдээж юм. Миний хүү Марик таны үеэлийн сэлүүрчдийн ахлагч[7] байсан гэж хэлээд Давос зэрлэг галын[8] дөлд залгиулж буй Хилэнгийн сүүлчийн дүр зургийг нэхэн санав. “Амьд үлдэгсэдийн тухай ямар нэгэн сураг байна уу?”

- *Хилэн* шатаж бүгдийг голын гүн рүү авч одсон хэмээн өнөөх эрхэм хэллээ. “Олон сайн эрчүүдийн хамтаар та хүүгээ, би үеэлээ алдсан. Тэр өдөр бид дайнд ялагдсан, сэр.”

Энэ эр ялагджээ. Давос нурман дундах бяцхан цог дүрэлзэн асах тухай Мелисандрагийн ярьсныг эргэн санав. *Энэ эр гянданд хоригдсоныг гайхах юм алга.* “Эрхэм дээдэстэн хэзээ ч бууж өгөхгүй ээ, Лорд Алистер.”

- Тэнэглэл, тэр бол тэнэглэл гэж хэлээд хөл дээрээ тогтох ч тэнхээгүй болсон Лорд Алистер шалан дээр дахин суув. “Станнис Баратеон хэзээ ч Төмөр Хаан Ширээнээ суухгүй. Үнэнийг хэлэх нь урвалт байдаг юм уу? Гашуун ч гэсэн үнэн шүү дээ. Лисений дээрэмчингээс бусад түүний усан флот сүйрсэн. Ланнистерийн эхний далбаан бараагаар л Салладор Саан зугтан одох болно. Станнисийг дэмжиж байсан ихэнх лордууд Жоффрид дагаар орсон эсвэл үхсэн ...”

- Уйтан тэнгисийн лордууд хүртэл үү? Лууны Цохионд тангараг өргөсөн лордууд ч гэсэн үү?

Лорд Алистер сулхан гэгч нь гараа сэгсрэв. “Лорд Сэлтигар баригдаж өвдөг сөхөрсөн. Монфорд Виларион хөлөг онгоцтойгоо зүйл дууссан. Улаан эмэгтэй Сангласыг галд өргөсөн. Лорд Вар Эммон дөнгөж арван тавтай, дээрээс нь тарган дорой. Чиний тэр Уйтан тэнгисийн лордууд чинь эд нар шүү дээ. Хайгарден[9], Наран Жад[10], Кастерли Рок[11] болон одоо дээрээс нь шуурганы ихэнх лордын хамтарсан их хүчний эсрэг зөвхөн Флорентийхон л Станнисд үлдсэн. Энхийн хэлэлцээрээр л гарах арга зам хайх ганцхан боломж үлдсэн. Би үүнийг л хийхийг хүссэн. Бурхан өршөө, тэд яаж *урвалт* гэж нэрлэж чадав аа?”

- Лорд Алистер та юу хийсэн хэрэг вэ? хэмээн баргар царайлан Давос асуув.

- Урвалт лав биш. Хэзээ ч урвалт байгаагүй. Би Эрхэм Дээдэстэнг чин сэтгэлээсээ хайрладаг. Миний өөрийн үеэл охин дүү хүртэл түүний хатан шүү дээ. Ухаантай хүмүүс бүгд зугтаж байхад би түүнд үнэнчээр үлдсэн. Би түүний *Гар*, Хааны Гар шүү дээ. Би яагаад урвагч болчихов оо? Би зөвхөн өөрсдийнхөө амийг аврах гэсэн юм. Бас нэр төрөө гэж хэлээд Алистер уруулаа долоов. “Би нэгэн захиаг үзэглэсэн юм. Салладор Саан тэр захиаг Хааны Газар луу Лорд Тайвинд аюулгүй хүргэж өгнө гэж амласан. Лорд Тайвин юманд учиртай ханддаг хүн. Тэгээд ч миний санал болгосон нөхцөл шударга байсан. Шударгаас ч илүү байсан.”

- Ямар нөхцлүүд байсан гэж Лорд Алистер?

- Энд их бохир юм хэмээн Лорд Алистер гэнэт яриагаа таслан хэлэв. “Тэгээд энэ үнэр ... юуны үнэр вэ?”

- Хувин хэмээн Давос заав. ”Бидэнд энд бие засах газар байхгүй. Ямар нөхцлүүд?”

Лорд Алистер хувин руу айдас дүүрэн нүдээр ширтэв. “ Хэрэв Лорд Станнис хааны өмгөөлөлд дахин орж Лууны Цохио болон Шуурганы Адгийн Лордоор эргэн өргөмжлөгднө гэвэл Төмөр Хаан Ширээний төлөөх тэмцлээ зогсоож Жоффригийн тухай хэлсэн бүхнээ буцаана. Би өөрөө ч мөн Цэнгэг усны Бэхлэлт болон миний эзэмшлийн бүх газрыг буцаан өгвөл адил зүйл хийнэ хэмээн тангарагласан. Лорд Тайвин миний саналыг утга учиртай хэмээн хүлээн авна гэж би бодсон. Лорд Тайвинд Старкуудтай мөн төмөр арлынхантай учраа ололцох шаардлага байгаа шүү дээ. Би хэлэлцээрийг баталгаажуулахын тулд гүнж Ширийнийг Жоффрийн дүү Томменд богтолж өгөхийг хүртэл санал болгосон. Нөхцлүүд ... хамгийн боломжтой сайн нөхцлүүд байсан. Чамд хүртэл ойлгомжтой байгаа биз дээ?”

- Тийм хэмээн Давос зөвшөөрөв. “Надад хүртэл.” Станнис хүүтэй болдоггүй л юм бол Ширийнтэй гэрлэснээр Лууны Цохио арал, Шуурганы Адаг хоёр эцэстээ Томмений мэдэлд очих болно. Энэ санал мэдээж Лорд Тайвиныг баярлуулна. Үүний хажуугаар Ланнистерууд Ширийнийг барьцаанд байлгаж Станнисийг дахин шинэ бослого гаргахаас сэргийлж чадна. “Тэгээд энэ нөхцлүүдээ эрхэм дээдэст санал болгоход ямар хариу хэлэв?”

- Эрхэм дээдэс тэр улаан эмэгтэйгээс салахаа больсон. Тэгээд ухаан санаа нь урдынх шигээ саруул биш болжээ гэж би айх юм. Энэ чулуун лууны тухай яриа бол зүгээр л галзуурал. Жинхэнэ галзуурал. Аерион Хурц Галаас, есөн шидтэнээс, алхимичдээс сургамж аваагүй гэж үү бид чинь? *Зуны Өргөөнөөс*[12] юу ч сураагүй гэж үү? Лууны тухай мөрөөдлөөс сайн юм гарсан түүхгүй. Би Акселлд ч сануулж хэлсэн. Миний арга зөв байсан. Тэгээд ч Станнис надад тамгаа өгсөн. Надад удирдах эрхийг өгсөн. Гар хааны хоолойгоор захирдаг шүү дээ.

- Үүн дээр бол биш хэмээн Давос шулуухан хэлэв. Тэрээр өөрийнхөө үгийг зөөлрүүлэх гэж оролдсонгүй. “Өөрийнхөө зөв гэж мэдэж байгаа тохиолдолд бууж өгөх нь Станнисийн зан биш. Жоффригийн тухай хэлсэн үгээ үнэн гэдгийг нь мэдэж байгаа үед буцаан авна гэж байхгүй. Гэрлэлтийн хувьд бол Томмен Жоффритэй нэгэн адил цус холилдон гарсан. Эрхэм Дээдэстэн Ширийнийг тийм амьтантай гэрлэснээс үхсэн нь дээр гэж үзнэ.”

- *Түүнд сонголт байхгүй шүү дээ* гээд Флорентийн духны судас тодрон лугшив.

- Та буруу бодож байна. Тэр хаан ёсоор үхэхийг сонгож чадна.

- Бид бүгдийн хамт уу? Тийм зүйл болохыг хүсээ юу, Сонгино Хүлэг Баатараа?

- Үгүй. Гэвч би хааны албат, түүний зөвшөөрөлгүйгээр энхийн гэрээ хэзээ ч хийхгүй.

Лорд Алистер түүн рүү удаан гэгч нь дэмий ширтснээ уйлж гарав.

ЖОН

Сүүлчийн шөнө саргүй тас харанхуй байсан ч тэнгэр цэлмэг байлаа.

- Би толгод руу өгсөж Сүнсийг хайхаар явлаа гэж Жон агуйн аманд байсан Тэннийнхэнд хэлэхэд амандаа бувтнан өнгөрүүлэв.

Хичнээн их од вэ гэж нарс, жодоо, яшил мод ургасан налуу руу өгсөж явахдаа бодов. Мэйстер Лювин түүнийг Винтерфеллд хөвгүүн байхад нь тэнгэрийн арван хоёр ордны нэр эзнийг нь тус бүр зааж өгсөн болохоор Мөсөн лууны хуучин анд Итгэлийн ариун долоон бадарчин, Сүүдэрт муур, Сарны охин, Өглөөний илдийг олж харлаа. Тэр үүний тухай Игриттэй хуваалцсан ч бусдад нь хэлсэнгүй. *Бид ижилхэн од харж байгаа ч өөр өөр зүйлээр бодож байна.* Хааны титмийг Өлгий, Азаргыг Эвэртэй лорд, улаан бадарчины септонуудын ариун гэж сургадаг Дархныг Хулгайч гэж зэрлэгүүд нэрлэнэ. Хулгайч Сарны охинд дөхөх үед хүүхэн хулгайлахад тохиромжтой цаг гэж Игрит хэлжээ.

- Яг чиний намайг хулгайлсан шөнө шиг. Тэр шөнө Хулгайч тод байсан.

- Би хэзээ ч чамайг хулгайлах гээгүй. Би хоолойнд чинь хутга тулгах хүртэл эмэгтэй хүн байна гэж мэдээгүй.

- Хэрвээ чи хүн алах гэсэн бол бол тэр үхэж л таарна гэж Игрит зөрүүдлэн хэлэв. Жон жижигхэн дүү Арьяагаасаа өөр хэзээ ч ийм зөрүүд хүнтэй таарч байсангүй. *Ингэхэд тэр миний дүү хэвээр болов уу? Ер нь байсан болов уу?* гэж бодлогоширлоо. Тэр хэзээ ч жинхэнэ Старк байгаагүй зөвхөн лорд Эддардын эхгүй бутач хүүхэд болохоор Винтерфеллд Теон Грэйжойгоос илүү байр суурьгүй байв. Тэр ч байтугай тэднээс салжээ. Шөнийн харуулын хүн хуучин гэр бүлээ хойш тавьж шинэ гэр бүлдээ нэгдэх андгай өргөдөг ч Жон Сноу ахан дүүсээ бас алдсан байв.

Түүнийг толгодын орой руу очиход Сүнс магадгүй гэж бодсон газар нь байж байлаа. Цагаан чоно ульдаггүй ч ямар нэг зүйл түүнийг өндөрт аваачсан учир хойд хөл дээрээ оцойн суугаад улаан нүдээрээ од ширтэхэд халуун амьсгал нь цагаан уур савсуулна.

- Чамд бас тэдэнд өөрийн гэсэн нэр байгаа юу? гэж Жон асуугаад зэрлэг чонын дэргэд өрөөсөн өвдөг сөхрөн сууж шилэн хүзүүнийх нь зузаан цагаан үсийг маажив.

- Туулай? Согоо? Эмэгчин чоно гэдэг үү? гэхэд Сүнс Жоно хацар дээрх бүргэдийн хумсанд урагдсан сорвийг ширүүн нойтон хэлээрээ шажигнуулан нүүрийг нь долоолоо. *Шувуу биднийг хоёуланг маань тэмдэглэж* гэж Жон бодов.

- Сүнс бид маргааш явна. Тэнд шатны гишгүүр, өргөдөг тор байхгүй учир би чамайг ханын нөгөө талд өөртэйгээ авч гарч чадахгүй. Бид салах болох нь. Чи үүнийг ойлгож байна уу?

Харанхуйд зэрлэг чонын улаан нүд тас харлана. Тэр Жоно хүзүүг үргэлжид байдаг шигээ хошуугаараа чимээгүй шиншлэн амьсгалаасаа халуун уур савсуулав. Зэрлэгүүд Жон Сноуг варг гэж дууддаг ч энэ талаар туйлын хөөрхийлөлтэй ажээ. Жон Ореллийн үхэхийнхээ өмнө бүргэдийн

биед орсон шиг чонын арьсанд яаж орохыг мэдсэнгүй. Нэг удаа Сүнс болж гэж зүүдлэн Манс Райдерийн хүмүүсээ хуралдуулсан Сүүн усны хөндий рүү доош харж байна гэж зүүдлэхэд зүүд нь үнэн байсан билээ. Гэхдээ одоо зүүдлэхгүй болохоор зөвхөн үг хэлэх үлдлээ. Жон чонынхоо толгойг хоёр гараараа барин нүд рүү нь ширтэж,

- Чи надтай явж болохгүй. Чи Хар цамхаг руу явах ёстой. Үүнийг ойлгосон уу? Хар цамхаг. Чи үүнийг олж чадах уу? Гэртээ буцах замаа? Мөсийг даган дорно зүг нар луу яваад байвал олж чадна. Тэд чамайг Хар цамхагт таних болохоор магадгүй ирсэн явдал чинь анхааруулга болж болох юм гээд Сүнсэд бичгээр анхааруулсан үг дайдаг юм уу гэж бодсон ч бэх, цаас, үзэг байхгүйн дээр илэрхэд хүрвэл дэндүү осолтой байлаа.

- Би чамтай Хар цамхагт ахин уулзъя. Гэхдээ чи тэнд өөрөө хүрэх хэрэгтэй. Бид хэсэг хугацаанд ганцаар агнах ёстой. Ганцаар шүү.

Зэрлэг чоно Жоны барилтаас мушгиран мултараад чихээ сортойлгосноо гэнэтхэн үсрэн давхилаа. Тэр орооцолдсон бут сөөг, занга саалин дээгүүр харайлган толгодын хажуугийн цайвар зурвас модон дундуур харайлгалаа. *Ингэхэд Хар цамхаг руу давхисан юм болов уу? Эсвэл туулайны араас хөөв үү?* гэж Жон гайхширан мэдэхийг хүслээ. Тэр хичнээн тааруу варг шигээ тангарагт ахан дүү, тагнуул болохоо сая батлав бололтой.

Модон дундуур салхи исгэрэхэд нарсны өтгөн шилмүүсийн үнэр ханхалж гандсан хар хувцсыг нь дэрвүүлнэ. Өмнө зүгт өндөр харанхуй Ханын сүүдэр ододыг хаан сүндэрлэнэ. Газрын овор товонтой толгодын байдлаас үзэхэд тэд Сүүдэрт Цамхаг, Хар цамхаг хоёрын дунд хаа нэгтээ байгаа ч эхнийхтэй нь илүү ойрхон байгаа бололтой. Тэд олон өдрийн турш давчуу хөндийд урт нарийхан хуруу шиг сунасан гүнзгий нуурууд, цахиур хяртай нарсаар хучсан шахцалдан бөөр бөөрөө дэрлэсэн толгод дундуур өмнө зүг явжээ. Ийм газар удаан явахад хүрэх болохоор Хананд үзэгдэхийг хүсээгүй ойртохыг хүссэн хүнд хялбар далдлалт болно.

Зэрлэгүүдийн морьтонгууд. Бидэн шиг. Над шиг.

Ханын цаана түүний бүх зүйлээрээ хамгаалахыг андгайлсан Долоон ханлиг бий. Тэр өөрийн амь нэр хүндээрээ андгай тавьсан болохоор тэнд харуулд зогсож байх ёстой. Тэр бүрээгээ уруулдаа хүргэн үлээж Шөнийн харуулын цэргийг босгох ёстой. Гэвч түүнд бүрээ байсангүй. Зэрлэгүүдийн нэгнээс хулгайлж болох ч үүнийг яаж биелүүлэх билээ? Үлээлээ гэхэд хүн сонсохгүй бол яана. Хана зуун бээрийн зайд сунах тусам харуулын тоо эрс цөөрдөг. Гурван бэхлэлт эзгүйрсэн болохоор эндхийн дөчин бээрт Жоноос гадна өөр ахан дүү байхгүй байж магад. Хэрвээ тэр ахан дүү хэвээр бол...

Би Нударган дээр амиа өгөөд ч хамаагүй Манс Райдерыг алахыг оролдох ёстой байсан юм. Корин үүнийг хийх байсан билээ. Гэвч Жон эргэлзэн боломжийг алджээ. Маргааш тэр Магнар Стир, Жарл болон Тэннийн сонгож авсан зуугаад морьтонгуудтай хамт явна. Жон энэ нь зөвхөн хугацаа хожиж байгаа явдал цаг нь ирэхэд мултарч Хар цамхаг руу явна гэж өөртөө хэлжээ. Гэвч цаг нь ирсэнгүй. Тэд ихэнхи шөнө зэрлэгүүдийн хоосон тосгонд хоноглож Стир үргэлж Тэннийнхээ арван хүнээр морьдоо харгалзуулна. Жарл түүнийг сэжигтэй ажиглана. Харин Игрит

өдөр шөнөгүй холдохгүй байлаа.

Хоёр зүрх ганц шиг цохилно. Манс Райдерийн шоолж хэлсэн үг толгойд нь гашуунаар дуулдав. Жон заримдаа самгардахад хүрнэ. *Надад сонголт байхгүй. Хэрвээ түүнээс татгалзвал намайг урвагч болохыг маань мэдэх болно. Би Корины надад хэлсэн дүрд тоглох ёстой* гэж Игритийг анх унтлагын арьсан хөнжил дор нь шурган орж ирэхэд өөртөө хэлжээ.

Бие нь ч үүнд муугүй оролцов. Жон уруулаа түүнд хүргэхэд гар нь согооны арьсан цамцан доогуур нь шурган хөхийг нь барьж Игрит хувцасных нь гаднаас доод талыг нь үрэхэд хатуурлаа. *Миний амлалт* гэж бодоод сийлбэртэй улаан нүүрээрээ харж сонсож байгаа есөн том цагаан мод дугуйрсан далан модны өмнө хэлсэн үгээ саналаа. Гэвч Игритийн хуруунууд өмднийх нь үдээсийг тайлж хэл нь аманд нь шурган, гараа дотуур хувцас руу нь оруулахад түүнээс ондоо далан мод байтугай юу ч нүдэнд нь үзэгдсэнгүй. Игрит хүзүүг нь хазахад Жон түүнийхийг шөргөөж хамраа өтгөн улаан үсэнд нь шургуулав.

Азтай, тэр азтай гал үнсэгч гэж бодлоо.

- Энэ сайхан байгаа биз тийм үү? гэж Игрит түүнийг удирдан дотогш оруулахдаа хэлэв. Түүний доод тал шал нойтон охиноороо биш болох нь илт байсан ч Жон тоосонгүй. Түүний амлалт, Игритийн охин нас хамаа байсангүй зөвхөн биенийх нь халуун, ам нь чухал байж хуруугаараа хөхний толгойг нь чимхлээ.

- Энэ сайхан байгаа биз дээ? гэж Игрит ахин хэлэв.

- Тийм хурдан бишээ удаан тиймээ яг тэгж. Наана чинь, тиймээ яг наана чинь сайхан байна. Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Би чамд яаж хийдгийг нь зааж өгье. Одоо чанга. Тиймээ.

Дүр. Би дүрд тоглож байгаа. Би үүнийг хийж байж андгайгаа зөрчсөнөө батална. Би түүнийг итгэлийг олох ёстой гэж түүний нэг хэсэг өөртөө сануулахыг оролдов. Ийм явдал ахин хэзээ ч болохгүй. Тэр Шөнийн харуулын эр хүн, Эддарт Старкийн хүү хэвээр. Тэр шаардлагатай зүйлийг хийх ёстой болохоор батлах ёстой зүйлийг батлах болно.

Баталгаа дэндүү амттай байсан болохоор Игрит хажууд нь цээжийг нь толгойгоороо дэрлэн унтахад сайхан бүр зүйрлэшгүй сайхан байлаа. Жоны бодол далан модны өмнө өргөсөн андгай руу хүрч ирэв. *Энэ бол зөвхөн нэг удаа хийсэн зүйл. Эцэг маань хүртэл урьд нь бүдэрч гэрлэлтийн андгайгаа мартан бутач хүүхэдтэй болсон.* Жон ч гэсэн түүнтэй ч ижил гэж өөртөө андгайллаа. *Ийм явдал ахин болохгүй.*

Гэвч тэр шөнө ийм явдал хоёр удаа болж Игрит түүнийг тэмтрэхэд өглөө нь ахин давтагдав. Эргэн тойрон зэрлэгүүд босоход зарим нь арьсан хөнжлийн дор юу болж байгааг анзаарчээ. Жарл тэднийг түргэл гээд дээрээс нь хувинтай ус цацав. Яг л ороо нь орсон ноход шиг гэж Жон дараа нь бодлоо. Тэр хэн болсон хэрэг вэ? Би шөнийн харуулын эр хүн гэж дотроос нь аяархан хоолой шаардаж байсан ч шөнө болгон улам бүдгэрсээр Игрит чихэн дээр нь үнсэх юм уу хүзүүг нь хазахад сонсохоо больдог байлаа. *Эцэгт минь энэ ямар байсан бол? Тэр ээжийн маань оронд нэр хүндээ гутаахдаа над шиг сул дорой байсан болов уу?*

Ямар нэг зүйл ард нь толгод руу гарч ирэхийг Жон гэнэтхэн анзаарлаа. Тэр агшин зуур Сүнс эргэж ирж байна гэж бодсон ч зэрлэг чоно чимээ гаргадаггүй билээ. Жон Урт сарвууг ганцхан хөдөлгөөнөөр сугалахад зөвхөн Тэнний нэг болох хүрэл дуулгатай бүдүүн хүн байв.

- Сноу. Явъя. Магнар чамтай уулзъя гэж байна гээд Тэннийн хүмүүс хуучны хэлээр ярьдаг ч ихэнхи нь ердийн хэлнээс хэдэн үг мэддэг байлаа.

Жон Магнарын дуудсаныг тоосонгүй ч өөрийг нь барагтай ойлгох хүнтэй маргах ашиггүй учраас түүнийг даган толгодын уруу буулаа.

Агуйн амны ангархайн чулуу бараг морь багтахуйц өргөн залуу нарс модны цаана халхлагджээ. Эндээс хойд зүг удам цэлийх ч Ханан дээрээс дотор асч байгаа гал үзэгдэхгүй байлаа. Тохиолдлоор ямар нэг харуул Ханын оройгоор өнөө шөнө өнгөрдөг юмаа гэхэд толгод, нарс оддын гэрэлд мөс нь гялалзах хөлдүү нуураас ондоо юу ч харахгүй байв. Манс Райдер дайралтаа сайтар төлөвлөжээ.

Хадны хонгил хорин фут уруудаад Винтерфеллийн Их танхим шиг том задгай зайд цэлийжээ. Чулуун баганын дунд түүдэг гал улалзан утаа чулуун адрьг харлуулан долооно. Морьдыг ханын нэг талд чөдөрлөж дэргэд нь бяцхан цөөрөм байлаа. Агуйн шалан дээр ангайх нүхнээс дор улам том агуй байж магадгүй ч харанхуйд хэлж болохгүй байлаа. Жон хаа нэгтээ доор урсах газар дорх голын зөөлөн хоржигнох чимээ сонслоо.

Жарл, Магнартай хамт байв. Манс тэдэнд хамтдаа удирдах эрх өгсөн ч Стир үүнд баярлаагүйг Жон аль эрт анзаарчээ. Манс Райдерын "тэжээвэр" гэж дуудаж байсан хатан Даллагынх нь эгчтэй хамт байсан хар үстэй залуу Жарлын урьд нь Ханын цаадах хаан байсан хүний хамаатан сайн ахан дүү нь байв. Магнар эрх мэдлээ хуваалцаж байгаадаа илт дургүйцэж байлаа. Тэр Жарлын хүмүүсээс тав дахин их зуун Тэнн авчирсан учир ихэнхидээ ганцаарчилсан тутшаал өгнө. Гэвч залуу хүн тэднийг мөсөн дээгүүр давуулахыг Жон мэдэж байв. Жарл хорин наснаас хэтрээгүй ч найман жилийн турш мордон явж Ханан дээгүүр Хэрээний алуурч Алфин, Уйлагч болон өөрийнхөө хүмүүстэй арваад удаа давжээ.

- Жарл надад өндөрт харуулдаж байгаа хэрээнүүдийн тухай анхааруулсан. Надад харуулын талаар мэдэх бүх зүйлээ ярь гэж Магнар шулуухан хэлэв.

Надад гэснээс бидэнд хэл гээгүйг Жон дэргэд нь зогсож байгаа Жарлаас харлаа. Жон ийм бүдүүлэг шаардлаганд татгалзахаас буцахгүй ч Стир түүнийг өчүүхэн төдий үнэнч бус байдал гаргавал алах болохоор Игритийг ч гэсэн түүний гэмт хэргийн төлөө хөнөөхийг мэдэж байв.

- Тэнд харуул тус бүрт дөрвөн хүн хоёр эргүүл, хоёр баригч байдаг. Баригчид ханын ан цав хайлсан газар болон бусад зүйлийг шалгах хооронд эргүүл дайсны бараа харуулддаг. Тэд луустай явдаг.

- Луус гэнэ ээ? Луус удаан шүү дээ гээд чихгүй эр хөмсөг зангидлаа.

- Удаан ч гэхдээ мөсөн дээр итгэлтэй хөлтэй. Эргүүлүүд ихэнхидээ Хар цамхагын хажуугийн

замаар Ханын орой дээгүүр явдаг болохоор тэнд олон жилийн турш хайрга дэвсээгүй. Дорнод харуулд луус тэжээж тусгайлан үүрэг биелүүлэхэд сургадаг юм.

- Тэд Ханын ихэнхидээ оройгоор явдаг гэнэ ээ? Үргэлж биш үү?

- Үгүй. Заримдаа дөрвөн хүн Ханын ёроолоор явж мөсөнд суурь хонгил үүссэн эсэхийг болон ан цав байгаа эсэхийг шалгадаг гэхэд,

- Хамгийн алс Тэннд хүртэл Мөсөн сүхт Арсон болон түүний хонгилыг мэднэ гээд Магнар толгой дохив.

Жон энэ түүхийг бас мэдэх байлаа. Мөсөн сүхт Арсон Хана руу орох замын хагаст хонгил ухсаныг Найтфортын эргүүлүүд илрүүлжээ. Тэд түүнийг ухахад нь саад бололгүй зөвхөн замыг нь мөс чулуу цасаар бөглөөд орхисон байна. Долорус Эдд хэрвээ чихээ Хананд сайн наавал Арсон сүхээрээ цавчин явахыг сонсож болно гэдэг байлаа.

- Энэ харуулууд хэзээ явдаг юм? Хэр зэрэг ихэвчилэн? гэхэд Жон мөрөө хавчлаа.

- Эргүүлийн хуваарь өөрчлөгддөг. Би захирагч лорд Коргил тэднийг Хар цамхагаас Дорнод тэнгисийн харуул руу гурав дахь өдөр болгон илгээж, Хар цамхагаас Сүүдэрт цамхаг руу хоёр дахь өдөр болгон явуулдаг гэж сонссон. Тэр үед Харуулын хүмүүс олон байсан. Захирагч лорд Мормонт янз бүрийн тоотой харуул явуулдаг болсон болохоор тэдний ямар хуваарьтай болсныг мэдэхэд бэрх болсон. Заримдаа Хөгшин баавгай орхигдсон цамхгууд руу хоёр долоо хоногт юм уу сард нэг удаа томоохон хүч илгээдэг юм гээд авга ах нь ийм тактик баримтлах байсныг Жон мэдэж байлаа. Дайсан юунд ч итгэлтэй байх ёсгүй.

- Чулуун хаалга, Саарал харуул хоёр дээр хүнтэй байгаа юу? гэж Жарл асуулаа.

Тэгэхээр бид тэр хоёрын дунд байгаа хэрэг байх нь ээ гээд Жон царайныхаа хувирлыг болгоомжтой барив.

- Намайг Хананаас явахад зөвхөн Дорнод харуул, Хар цамхаг, Сүүдэрт цамхаг хүнтэй байсан. Би түүнээс хойш Боуэн Марш, сэр Денис нар юу болсныг мэдэхгүй.

- Цайзад хичнээн хэрээ байгаа вэ? гэж Стир асуулаа.

- Хар цамхагт таван зуу. Сүүдэрт цамхагт хоёр зуу, Дорнод харуулд барагцаалбал гурван зуу байгаа гэж Жон дээрээс нь гурван зуун хүн нэмж хэлэв. *Хэрвээ энэ ийм амархан бол...*

Жарл хууртагдсангүй.

- Тэр худал ярьж байна. Эсвэл Нударган дээр алагдсан хүмүүсээ оролцуулж байна гэж Стирд хэлэв.

- Хэрээ минь намайг Манс Райдер гэж бүү бодоорой. Хэрвээ надад худал хэлвэл хэлийг чинь огтлоно шүү гэж Магнар анхааруулав.

- Би хэрээ биш дээрээс нь худал ч биш гээд Жон хуруугаараа илднийхээ бариулыг атгалаа.

Тэннийн Магнар Жоныг хүйтэн саарал нүдээрээ өрөмдөв.

- Бид удахгүй тэдний тоог мэдэх болно. Явж болно. Би чамаас асуух зүйл гарвал дуудна гэж хормын дараа хэллээ.

Жон толгойгоо хөшүүн дохиод явлаа. *Бүх зэрлэгүүд Стир шиг бол тэднээс урвахад амархан юм.* Гэвч Тэннийнхэн өөр чөлөөт хүмүүст дургүй байлаа. Магнар Анхны хүмүүсийн сүүлчийн удам болохоор төмөр нударгаар атгадаг гэж андгайлна. Түүний Тэннийн бяцхан нутаг Мөсөн соёотын хойд хэсгийн оргил дахь өндөр уул, хөндий дунд нуугдан Эвэр хөлт, аварга биет, мөсөн голын хүний махчин омгоор хүрээлүүлэн амьдарна. Игрит Тэннийнхнийг зэрлэг дайчид Магнар тэдний дундаа бурхан гэж хэлжээ. Жон үүнд итгэлээ. Жарл, Харма, Харжигнуур хуягттай адилгүй нь Стир бүрэн дуулгавартай хүмүүс захирдаг болохоор Манс яагаад түүнийг Хана давуулахаар сонгосон нь эргэлзээгүй бизээ.

Жон хүрэл дуулганы орой дээр түүдэг тойрон суусан Тэннийнхны дэргэдүүр өнгөрөв. *Игрит хаачсан юм бол?* Түүний ачаа нь байсан ч охины бараа хаа ч байсангүй.

- Тэр бамбар авч тийшээ явсан гэж Ямаа Григ түүнд агуйн арагш заан хэллээ.

Жон түүний хуруугаараа заасан зүг рүү унжсан чулуу баганатай бүүдгэр арын өрөө рүү оров. *Тэр энд байхгүй нь* гэж бодтол инээх дуу нь сонсогдов. Жон чимээ гарсан зүг арав алхаад нүцгэн цагаан чулуун ханатай хоосон мухарт туллаа. Мухардан ирсэн замаараа буцах гэтэл нойтон чулууны доод талд гарсан хар нүхийг харав. Тэр өвдөг сөгдөн усны зөөлөн хоржигнох чимээг сонсов.

- Игрит?

- Би энд байна гэж хоолой нь сулхан цуурайтав.

Жон агуй онгойн нээгдтэл арван алхам мөлхлөө. Түүнийг ахин босч зогсох үед нүд нь харанхуйд дасав. Игритийн барьсан бамбараас ондоо өөр гэрэл байсангүй. Тэр хадны ангархайнаас өргөн хар цөөрөм руу бууж байгаа бяцхан хүрхрээний дэргэд зогсож байлаа. Бамбарын анивчсан шар дөл цайвар ногоон усанд гялалзана.

- Чи энд юу хийж байгаа юм бэ?

- Усны чимээ сонсож байна. Би агуй хэр гүн болохыг үзэхийг хүссэн юм гээд Игрит бамбараараа зангаж,

- Энэ хонгил доошоо илүү хол явсан. Би зуун алхам дагаад буцаж эргэсэн гэв.

- Мухар байгаа юм уу?

- Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Энэ цаашаа хязгааргүй яваад л байдаг. Эдгээр толгодын

олон зуун агуйнууд газрын гүндээ бүгд холбогддог. Танай Ханан доогуур хүртэл гарсан зам бий. Горны зам.

- Ханын цаадах хаан Горн гэж Жон хэллээ.

- Тийм. Дүү Женделтэйгээ гурван зуун жилийн өмнө хамт явсан. Тэд чөлөөт хүмүүсийн цэргийг агуй дотуур дагуулан ороход Харуулуудын хэн ч мэдээгүй. Гэвч тэднийг гарч ирэхэд Винтерфеллийн чононууд унасан юм даа.

- Тэнд тулаан болсон. Горн Умардын хааныг алсан ч хүү нь далбааг нь авч эцгийнхээ титмийг толгой дээрээ тавиад Горныг хариуд нь цавчиж унагасан гэж Жон саналаа.

- Илдийн чимээ цайзын хэрээнүүдийг сэрээж тэд бүх хүчээрээ очин чөлөөт хүмүүсийг ухраасан.

- Тийм. Жендел өмнө зүгийн хаан, дорно зүгээс Амберийнхан, хойд зүгээс Харуулуудын дунд орсон. Тэр үхсэн.

- Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Жендел үхээгүй. Тэр хэрээнүүдийн дундуур замаа цавчилан чөлөөлж хүмүүсээ дагуулан хойд зүг рүү зугтахад чононууд өсгий даран улин хөөжээ. Гэвч Жендел агуйг Горн шиг сайн мэдэхгүй болохоор буруу зүг рүү эргэсэн байна гээд Игрит бамбараа урагш хойш савахад сүүдэр нь үсчин тусав.

- Цааш улам гүн рүү явсаар тэр буцаж гарахыг оролдсон ч танил зам нь чулуунд хаагджээ. Төдөлгүй бамбар нь нэг нэгээр унтарч эхлэхэд эцэст нь тас харанхуй болжээ. Женделийн хүмүүсийг ахин хэзээ ч гарч ирээгүй ч шөнө болохоор хүүхдүүд нь толгодын доогуур буцаж гарах замаа эрэн уйлж байгааг сонсож болно гэдэг. Сонсож байна уу? Чи тэднийг сонсов уу?

Жоны олж сонссон зүйл гэвэл усны хүрхрэн, галын сулхан тас нясхийх чимээ байлаа.

- Ханын доогуурх зам бас алга болсон уу?

- Зарим нь үүнийг эрж байгаа. Тэд Женделийн хүүхдүүдийг хайхаар дэндүү гүн явсан болохоор Женделийн хүүхдүүд үргэлж өлсгөлөн байдаг гээд Игрит инээмсэглэн бамбараа чулууны ангархайд болгоомжтой суурилуулаад түүн рүү ирж, - Тэдэнд харанхуйд хүний биенээс өөр идэх юм байхгүй гэж хүзүүг нь хазан шивнэв.

Жон үсийг нь үнэрлэхэд үнэр нь хамар дүүргэлээ.

- Чи яг л Бранд аймшгийн үлгэр ярьж байгаа Хөгшин Нан шиг сонсогдож байна гэхэд,

- Би хөгшин хүн шиг харагдаад байна уу? гээд Игрит мөрийг нь чимхлээ.

- Чи надаас хөгшин шүү дээ.

- Дээрээс нь ухаалаг. Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу гээд Игрит түүнийг түлхэн туулайн арьсан хүрмээ тайллаа.

- Чи юу хийж байна?

- Чамд хэр хөгшнөө үзүүлэх гэж байна гээд Игрит согооны арьсан цамцныхаа үдээсийг нь тайлж хажуу тийш шидээд дотор нь давхарлан өмссөн гурван ноосон цамцаа толгой дээгүүрээ зэрэг давуулав.

- Би чамд өөрийгөө харуулахыг хүсч байна.

- Бид ингэж болохгүй...

- Бид болно гээд өрөөсөн хөл дээрээ зогсон гутлаа тайлаад нөгөө хөл дээрээ үсрэн догонцоход том дугуй ягаан толгойтой хөх нь дээш доош ойж донслов.

- Чи ч гэсэн тайл. Хэрвээ үзэхийг хүсч байвал өөрөө ч гэсэн харуул. Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу.

- Би чамайг хүсч байгаагаа мэдэж байна гэж Жон хэлэхэд өргөсөн бүх андгай нэр хүнд нь мартагдсан байлаа. Игрит түүний өмнө эхээс төрсөн биеэрээ нүцгэн зогсоход Жоны бие эргэн тойрны чулуу шиг хатуурав. Тэр өмнө нь үүнийг олон удаа хийсэн үргэлж арьсан хөнжил доор эргэн тойронд нь хүмүүс байжээ. Жон хэзээ ч түүний хичнээн үзэсгэлэнтэй болохыг харж байсангүй. Хөл нь туранхай ч сайтар булчинлаг гуяных нь завсар уулзварын үс толгойных оройноос тод улаан байлаа. *Энэ нь улам ч азтай юм болов уу?* Жон түүнийг татан ойртуулав.

- Би чиний үнэрт дуртай. Би чиний улаан үсэнд дуртай. Би чиний ам намайг үнсдэгт арганд чинь дуртай. Би чиний инээмсэглэлд хайртай. Би чиний хөхөнд хайртай гээд нэг нэгээр нь үнслээ.

- Би чиний туранхай хөл түүний хооронд байгаа зүйлд дуртай гээд өвдөг сөгдөн амаараа хөнгөн үнсэхэд Игрит хөлөө бага зэрэг тэнийлгэсэнд дотор нь байсан ягаан зүйлийг бас үнсэж амтыг нь амтлав. Игрит дуу алдлаа.

- Хэрвээ чи надад ийм их хайртай юм бол яагаад хувцастай чигээрээ байгаа юм бэ? Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Юу ч...өө. Оо. Ох.

Үүний дараа Игрит хэзээ ч байгаагүй ичимхий болов.

- Чиний хийсэн зүйл. Чиний амаараа хийсэн... зүйл гэж овоолсон хувцас дээр хамтдаа хэвтэхдээ тээнэгэлзэн хэлснээ,

- Энэ өмнөдийн лордууд хатагтай нартаа хийдэг зүйл үү? гэв.

- Би тэгж бодохгүй байна гээд хэн ч Жонд лордууд хатагтай нартайгаа юу хийдгийг хэлсэнгүй.

- Би зөвхөн чиний тэнд үнсэхийг хүссэн юм. Тэгээд л тэр. Чи дуртай байх шиг санагдсан.

- Тийм. Би үүнд дуртай байна. Хэн ч чамд ийм зүйл зааж өгөөгүй гэж үү?

- Хэн ч биш. Зөвхөн чи.

- Охин. Чи охин юм байна гэж Игрит шоолов.

Жон хуруугаараа хөхний толгойг нь тоглон чимхлээ.

- Би Шөнийн харуулын эр хүн байсан гээд “байсан” гэж өөрийн мэдэлгүй хэллээ. Тэр одоо юу болсон бол? Тэр үүнийг мэдэхийг хүссэнгүй.

- Чи охин байсан уу? гэхэд Игрит тохойн дээрээ өндийв.

- Би арван естэй, жад эхнэр гал үнсэгч. Хаанаас охин байх юм?

- Тэр чинь хэн байсан бэ?

- Таван жилийн өмнө найран дээрх хүү байсан. Тэр ах дүүстэйгээ наймаа хийхээр ирээд миний гал үнсэж байгаа үс таалагдсан тул өөрийгөө азтай гэж бодсон байх. Гэвч тэр дорой байсан. Намайг хулгайлахаар буцаж ирсэн ч Урт жад гарыг нь хугалан хөөхөд хэзээ ч ахин эргэж ирээгүй.

- Тэгвэл Урт жад биш байсан юм уу? гээд Жоны санаа амарлаа. Тэр Урт жадад дуртай нөхөрсөг энгийн царай нь таалагддаг байв.

- Наадах чинь өөдгүй зүйл. Чи дүү нартайгаа дэр нэгтгэдэг бил үү? гээд Игрит чимхлээ.

- Урт жад чиний ах биш.

- Тэр манай тосгоных. Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Жинхэнэ эр хүн овгоо хүчирхэгжүүлэхийн тулд хүүхнийг холоос хулгайлдаг юм. Ах дүүс, эцэг, отгийнхоо хүмүүстэй дэр нэгтгэсэн хүн бурхдыг гомдоож хараалд өртөгдөн сул дорой бие муутай хүүхэд төрүүлдэг. Заримдаа бүр мангас гардаг гээч.

- Крастер охидтогоо гэрлэдэг биз дээ гэж Жон тодруулахад Игрит ахин чимхлээ.

- Крастер манайхаас илүү та нарын төрөл. Түүний эцэг нь Цагаан мод тосгоны эмэгтэйг хулгайлсан хэрээ байсан ч үүнийхээ дараа Хана руугаа буцаж ниссэн. Эмэгтэй Хар цамхаг руу хэрээнд хүүг нь үзүүлэхээр явсан ч ах дүүс нь бүрээгээ үлээж зугтаалгасан. Крастерийн цус хар тэр хүнд хараал тээж явдаг гээд Игрит хуруугаа гэдсэн дээгүүр нь хөнгөн гүйлгэв.

- Би урьд нь чамайг ижилхэн гэж эмээж байлаа. Хана руугаа буцаж ниснэ гэж. Харин чи намайг хулгайлсны дараа юу хийхээ мэдээгүй.

- Игрит би чамайг хэзээ ч хулгайлаагүй гээд Жон өндийн суулаа.

- Чи тэгсэн. Чи уулнаас үсрэн бууж Ореллийг алаад намайг сүхээ авахын зуургүй хоолойнд минь хутга тулгасан. Би тэгэхэд чамайг намайг эзэмдэх юм уу алах эсвэл хоёуланг нь хийнэ гэж бодсон ч тэгээгүй. Намайг чамд Винтерфеллд сарнай зулгаасан Үлгэрч Бардын тухай түүх ярьж өгөх

гарцаагүй чангаах байх гэж бодсон ч тэгээгүй. Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Чамайг зарим нэг зүйлийг сурах ёстой гэж бодож байна гээд ичингүйрэн инээмсэглэв.

Тэдний эргэн тойронд гэрэл анивчихыг Жон гэнэтхэн анзаарлаа. Тэр эргэн тойрноо харав.

- Бид буцсан нь дээр байх. Бамбар унтарч байна.

- Хэрээ Женделийн хүүхдүүдээс айгаа юу? Жаахан яваад л дээшээ гарах болохоор би чамтай дуусаагүй байна, Жон Сноу гээд Игрит түүнийг хувцас руу буцаж түлхэн дээр нь гарснаа,

- Чи... гээд тээнэгэлзлээ.

- Яасан? гэж Жон бамбар унтарч эхлэхэд хэлэв.

- Нөгөөдхөө ахин хийж чадах уу? Амаараа? Лордын үнсэлтийг? Би... хэрвээ чамд таалагдсан бол.

Бамбар унтрахад Жон Сноу тоосонгүй.

Тэр дараа нь буруугаа мэдэрсэн ч урьдынхаас сул байлаа. *Хэрвээ энэ тийм буруу юм бол яагаад бурхад ийм сайхан мэдрэмж бий болгосон юм бэ?* гэж бодлоо.

Тэднийг дуусгах үед агуйд тас харанхуй болсон байв. Гал дүрэлзэж байгаа том агуй руу буцах хонгилд бүдэг гэрэл улалзана. Тэд харанхуйд тэмтчиж бие биетэйгээ мөргөлдөн хувцаслав. Игрит цөөрөм рүү бүдрээд хүйтэн усанд хашгирлаа. Жоныг хөхрөхөд түүнийг бас түлхэв. Тэд ноцолдон ус үсчүүлж Игрит гарт нь баригдахад дуусгаагүй ажлаа үргэлжлүүлэхээр эргэв.

- Жон Сноу одоо битгий хөдлөөрэй, хонгор минь. Би чамайг дотроо байлгахыг хүсч байна. Смир, Жарл хоёр луу буцахаа больё. Доошоо явж Женделийн хүүхдүүдтэй нийлье. Би энэ агуйг хэзээ ч орхихыг үсэхгүй байна, Жон Сноу. Хэзээ ч шүү гэж Игрит шивнэв.

ДАНЕРИС

- Бүгдийг нь гэнэ ээ? Эрхэм дээдсээ миний дорд чих таныг зөв сонсов уу? гэж боол охин болгоомжтой хэлэв.

Сэрүүн ногоон гэрэл ромбо хэлбэрт цонхны өнгөт шилийг нэвтлэн гурвалжин хана руу налуу тусч асрын хаалгаар зөөлөн салхи сэвшин гадна цэцэрлэгийн жимс, цэцгийн үнэрийг авчирна.

- Чиний чих зөв сонссон. Би тэднийг бүгдийг нь худалдаж авахыг хүсч байна. Сайн эздэд үүнийг дамжуул гэж Дани хэлэв.

Данерис өнөөдөр хөх ягаан өнгийн нүдтэйгээ ижилсүүлэн ягаан өнгийн зүүн талын нүцгэн цээжээ ил гаргасан Картын даашинз өмсөхөөр сонгожээ. Астапорын сайн эзэд хоорондоо нам дуугаар зөвлөлдөхөд Дани өндөр мөнгөн цомноос илжгэн чихний исгэлэн дарс шимлээ. Тэр тэдний юу хэлснийг ойлгоогүй ч шунаж байгааг нь мэдэж байлаа.

Найман худалдаачин тус бүр хоёроос гурван боол дагуулснаас хөгшин Граздан зургаан боолтой байлаа. Иймээс Дани гуйлгачин шиг харагдахгүйн тулд элсэн торгон өмд, хээтэй хантаазтай Ирри, Жикүй тэргүүтэй хөгшин Цагаан сахалт, хүчит Белвас болон цусан морьтонгуудаа бараа болон дагуулж иржээ. Ард нь бүгчим халуунд цээжин дээрээ Мормонтын овгийн хар баавгай хатгамласан ногоон хүрэм өмссөн сэр Жорах зогсчээ. Түүний хөлсний үнэрт Астапорын хөрсөнд нэвчсэн анхилуун үнэр хариулна.

- Бүгдийг нь гэнэ ээ? хэмээн өнөөдөр тоорын үнэр ханхлуулсан Кразнис мо Наклоз асуухад боол охин Вестеросын нийтийн хэлээр давтлаа.

- Тэд найман мянгуулаа байгаа. Тэр үүнийг бүгдийг нь гэж байгаа юм уу? Дээрээс нь бас ес дэх мянга болох зургаан зуун хүн байгаа. Тэр тэднийг бас авах уу?

- Тийм. Найман мянга болон зургаан зургаан зуун хүн дээр хадаастай малгай өмсөөгүй сургагдаж байгааг нь ч гэсэн хэмээн Дани асуулт тавигдахад хариулав.

Кразнис нөхөд рүүгээ эргэн хоорондоо ахин зөвлөлдлөө. Хэлмэрч охин Данид тэдний алдрыг хэлсэн ч шуудхан тогтооход бэрх байв. Дөрвөн хүнийг нь эрт цагт Хуучин Гисийг үндэслэсэн Агуу Гразданы хүндэтгэл болгон Граздан гэдэг бололтой. Тэд бүгд адилхан махлаг тарган хуван шар арьс, өргөн хамар, хар нүдтэй байлаа. Ширүүн буржгар үс нь Гискаригийн улаан хар өнгө холилдсон этгээд маягаар хар юм уу бараан улаан өнгийн ажээ. Бүгд Астапорын зөвхөн чөлөөт хүмүүст өмсөхийг зөвшөөрдөг үнэт даавуун хувцас болох токараар биеэ ороожээ.

Токарын цацаг нь тухайн хүний зэргийг илтгэдэг гэж Данид ахмад Гролео хэлжээ. Пирамидын орой дахь энэхүү хүйтэн ногоон өрөөнд байгаа боолын эзний хоёр нь мөнгөн цацагтай, тав нь алт, нэг нь болох хөгшин Граздан хөдлөх суух тоолон зөөлөн харшдаг бүдүүн цагаан сувдан цацагтай байлаа.

- Бид дутуу бэлтгэгдсэн хөвгүүдийг зарахгүй гэж мөнгөн цацагтай Граздануудын нэг бусаддаа

ХЭЛЭВ.

- Хэрвээ түүний алт хүрэлцээтэй бол бид зарна гэж алтан цацагтай тарган хүн хэллээ.

- Тэд бол Ансаллидууд биш. Тэд нялх амьтдаа алаагүй. Хэрвээ тэд тулааны талбарт унавал бидний нэрийг гутаана. Бид маргааш гэхэд таван мянган хөвгүүн шинээр хөнгөлсөн ч зарахад бэлэн болох хүртэл арван жилийн хугацаа шаардагдана. Дараагийн худалдан авагч Ансаллидуудыг үзэхээр ирвэл юу гэж хэлэх болж байна?

- Бид түүнд хүлээж бай гэж хэлнэ. Алт ирээдүйд байхаас илүү миний хэтэвчинд байсан нь дээр гэж тарган хүн хэллээ.

Дани тэдний маргааныг орхиод илжгэн чихний дарс шимж царайгаа тоомсоргүй тайван байлгахыг хичээв. *Би ямар ч үнэ хүрсэн хамаагүй тэднийг бүгдийг авна.* Энэ хотын зуун боолын худалдаачнаас энэ найм хамгийн том нь ажээ. Тэд хоорондоо ор дэрний боол, талбай дээр ажиллах хүн, бичээч, гар урлалчин, багш зарах тал дээр өрсөлддөг ч өвөг эцгүүдийнхээ ёсоор Ансаллидуудыг зарахдаа хоорондоо холбоо байгуулна. *Астапорыг цус, тоосгоор барьсан. Тоосго болон хүмүүсийнх нь цусаар.*

Эцэст нь Кразнис гаргасан шийдвэрээ мэдэгдэв.

- Түүнд алт нь хүрэлцвэл найман мянгыг ав гэж хэл. Хүсвэл зургаан зууг ч гэсэн аваг. Харин жилийн дараа ирэхэд нь бид үлдсэн хоёр мянгыг зарна гэж хэл.

- Жилийн дараа гэхэд би Вестеросд байна. Тэд надад одоо хэрэгтэй. Ансаллидууд сайн бэлтгэгдсэн ч тулаанд олон хүн нь унана. Надад тэднийг унахад орлон сэлмийг нь барих хөвгүүд хэрэгтэй гэж Дани хэлмэрчлэхийг сонсоод хэлэв. Тэр дарсаа хойш тавиад боол охины зүг бөхийлөө.

- Хүндэт эздэд намайг гөлөгтэйгээ байгаа хамгийн бяцхан хөвгүүдийг нь хүртэл авна гэж хэл. Тэдэнд намайг өчигдөрхөн Ансаллид болон хадаастай малгай өмсөхийн төлөө хөнгөлүүлсэн хөвгүүдийг авна гэж хэл.

Охин үүнийг тэдэнд дамжуулсан ч хариулт нь үгүй хэвээр байлаа.

Дани уурсан хөмсөг зангидав.

- Маш сайн байна. Тэдэнд намайг бүгдийг нь худалдвал хоёр дахин үнэ илүү төлнө гэж хэл.

- Хоёр дахин гэнэ ээ? гээд алтан цацагтай тарган хүний шүлс гоожлоо.

- Энэ бяцхан янхан үнэхээр тэнэг юм байна. Түүнээс гурав дахин хөлс нэхвэл төлөхөд бэлэн байна. Боол болгонд арав дахин их үнэ өгсөн ч хамаагүй төлөх л болно гэж Кразнис мо Наклоз хэлэв.

Шовх сахалтай өндөр Граздан нийтийн хэлээр ярьдаг ч боол охин шиг сайн байсангүй.

- Эрхэм дээдсээ Вестерос баян тансаг ч та одоохондоо хатан болоогүй байна. Тэр ч байтугай хэзээ ч болохгүй байж мэднэ. Ансаллидууд долоон ханлигийн догшин ган хуягтай хүлэг баатруудад тулаанд үрэгдэж болно. Би Астапорын сайн эзэд хоосон амлалтын төлөө бие зардаггүйг сануулах байна. Чамд авахыг хүсч байгаа бүх тайгандаа төлөх ачаа бараа, алт мөнгө бий юу?

- Та хариултыг нь надаас дутуугүй мэдэж байгаа, хүндэт эзэн минь. Танай хүмүүс миний онгоц руу очиж хувны ширхэг болгон, домботой гүргэм бүрийг харсан. Тэгэхээр надад хэр их байна вэ?

- Мянган хүнийг худалдаж авахад хүрэлцээтэй гээд сайн эзэн зэвүүцэнгүй инээмсэглэж,

- Гэсэн ч чи хоёр дахин төлнө гэж хэлсэн болохоор таван зуун хүнийг л авна гэв.

- Чиний үзэсгэлэнтэй титэм магадгүй ахин зууг худалдан авч болох юм. Гурван луутай титэм чинь гэж Валирианы тарган хүн хэлэв.

Дани үг хөрвүүлэгдэхийг хүлээж байгаад,

- Би титмээ зарахгүй гээд Висерис ээжийнхээ титмийг зарсан цагаас хойш түүнтэй цуг эцсийн хөөр нь үгүй болон зөвхөн уур хилэн үлдсэн билээ.

- Бас хүмүүсээ боол болгон худалдах юм уу тэдний ачаа бараа, морьдыг зарахгүй. Гэхдээ та нар миний онгоцыг авч болно. Том далбаат онгоц "Балерион", сэлүүрт хөлөг "Вэйгар", "Мераксес" хоёрыг гээд Гролео болон бусад ахмадуудад ийм зүйл болж магадгүй гэж анхааруулахад шийдвэрийг нь урдаас эсэргүүцэн ууртай хүлээж авчээ. - Гурван сайн онгоц хэдэн өчүүхэн тайганаас хамаагүй үнэтэй.

Тарган Граздан бусад руугаа эргэж хоорондоо ахин нам дуугаар зөвлөлдөв.

- Хоёр мянга. Энэ бол сайн эзэд чамд хэрэгтэй зүйлд туйлын өгөөмөр хандаж байгаа хэрэг гээд шовх сахалт эргэлээ.

Хоёр мянга дэндүү хангалтгүй байлаа. *Би тэднийг бүгдийг нь авах ёстой.* Дани юу хийх ёстойгоо мэдэхэд аманд нь илжгэн чихний дарс хүртэл дарж чадахааргүй гашуун амт амтагдав. Тэр удаан шаналангүй бодлогошироод өөр арга олсонгүй. *Энэ зөвхөн миний сонголт.*

- Надад бүх хүнээ өгвөл лууг маань авч болно гэхэд Жикүй дэргэд нь дуу алдах сонсогдов.

- Би та нарт хэлээгүй юу? Түүнийг хамаг зүйлээ өгнө гэж гээд Каразнис нөхөд рүүгээ инээмсэглэлээ.

Цагаан сахалт балмагдсандаа үл итгэн ширтэхэд таяг атгасан гар нь чичирлээ.

- Үгүй гээд тэр Данигийн өмнө өрөөсөн өвдөг сөхрөв.

- Эрхэм дээдсээ би танаас гуйж байна. Хаан ширээг луугаар авахаас биш боолоор биш. Та ийм

зүйл хийж болохгүй...

- Намайг сургах хэрэггүй. Сэр Жорах Цагаан сахалтыг эндээс холдуул.

Мормонт хөгшин хүний тохойноос бүдүүлгээр угзран хөл дээр нь босгож сэрүүн асарт гаргалаа.

- Сайн эздэд намайг саяны тасалдсан явдалд харамсаж хариултыг нь хүлээж байна гэж хэл хэмээн Дани боол охинд хэлэв.

Гэсэн ч тэр тэдний гялалзсан нүд, далдлахыг хичээсэн инээмсэглэлээс нь хариултыг мэдэж байлаа. Астапорт хэдэн мянган тайган түүнээс ч их хөнгөлүүлэхээ хүлээж байгаа боол хөвгүүд байгаа ч өргөн ертөнцөд амьд луу гуравхан билээ. *Дээрээс нь Гискаричууд луунд шунадаг.* Тэд яаж үгүй байх билээ? Ертөнц залуу байхад Эртний Гис Валириатай таван удаа тулалдан нам ялагджээ. Валирианд луунууд байхад харин эзэнт улсад юу ч байсангүй.

Хөгшин Граздан сувднуудаа зөөлөн харшуулан суудал сэлгэн хөдлөв.

- Лууг бид сонгоно. Хамгийн том хүчтэй хар өнгөтэйг нь авна гэж нарийхан хоолойгоор хэлэв.

- Түүнийг Дрогон гэдэг гээд Дани толгой дохив.

- Бид бүх ачаа бараа, титэм, хатан хааны хувцсыг чинь үлдээж гурван онгоц болон Дрогоныг авна.

- Тохирлоо гэж Дани нийтийн хэлээр хэллээ.

- Тохирлоо гэж хөгшин Граздан Валирианы хэлээр хариулав. Үлдсэн нь зэрэг дэмжлээ.

- Тохирлоо, тохирлоо найм дахин тохирлоо гэж боол охин орчуулав.

- Ансаллидууд танай зэрлэгүүдийн хэлийг түргэн сурна. Гэвч тэр хүртэл чамд боолуудтай ойлголцох хүн хэрэгтэй. Энэ охиныг бидний наймаа сайн тохирсоны бэлэг болгон ав гэж Кразнис мо Наклоз бүх тохиролцоо хийгдсэн хойно хэлэв.

- Тэгье гэж Дани хэллээ.

Боол охин тэдний үгийг хөрвүүлэхэд Дани бэлэг өгсөн явдалд царайны хувиралаа үзүүлсэнгүй.

Цагаан сахалт Арстан Даниг асарт хүлээж байлаа. Тэр шатны уруу араас нь чимээгүй дагахад улаан тоосгон дээр модон таягны тог тог тогших чимээ сонсогдов. Дани түүнийг уурласанд буруутгасангүй. Тэр өөдгүй зүйл хийжээ. *Лууны эх хамгийн хүчтэй хүүгээ зарлаа.* Зөвхөн энэ тухай бодохоос дотор нь муухайрав.

Дор пирамид болон тайгануудын хуарангын дунд байрлах Бахархлын талбайн халуун улаан тоосго руу буухад Дани хөгшин хүн рүү эргэв.

- Цагаан сахалтаа та намайг зөвөлгөө хүсэхэд биднийг ганцаар байхад бодлоо хэлэхээс айдаггүй

билээ. Харин танихгүй хүмүүсийн урд хэзээ ч битгий асуулт тавьж бай. Үүнийг ойлгосон уу?

- Тиймээ, эрхэм дээдсээ гэж тэр золгүй хариулав.

- Би хүүхэд биш. Хатан хаан.

- Хатан хаан хүртэл алдаа гаргадаг. Астапорынхан таныг мэхэлж байна, эрхэм дээдсээ. Луу ямар ч армиас илүү үнэтэй. Эйгон үүнийг гурван зуун жилийн өмнө Галын талбарт баталсан.

- Би Эйгоны юу баталсныг мэдэж байгаа болохоор өөрийнхөөрөө батална гээд Дани дамнуурганых нь хажууд зогсож байгаа боол охин руу эргэв.

- Чамд нэр бий юу? Эсвэл өдөр болгон ямар нэгэн торхны нэр авдаг уу?

- Зөвхөн Ансаллидууд л тэгдэг гэснээ охин гэнэтхэн Данигийн эртний Валирианаар асуусныг ойлгоод нүд нь томорлоо.

- Өө.

- Чиний нэрийг Өө гэдэг юм уу?

- Үгүй. Эрхэм дээдсээ зохисгүй дуу алдсаныг уучил. Таны боолын нэрийг Миссандей гэдэг гэхдээ...

- Миссандей чи цаашид боол байхаа больсон. Энэ мөчөөс эхлэн би чамайг чөлөөлж байна. Надтай цуг дамнуурганд минь суу. Би чамтай яримаар байна гээд Ракаро тэдэнд ороход тусалсанд Дани халуун тоосноос хамгаалан хөшиг татлаа.

- Хэрвээ чи надтай үлдвэл гарын минь зарцын нэг болж би чамайг Кразнистай ярьж байсан үеийнх шиг дэргэдээ байлган хэлмэрчлүүлэх болно. Гэхдээ чи надад зүтгэлгүй эцэг эх рүүгээ явахыг явж болно. Сонголт чинийх.

- Боол үлдэнэ. Түүнд... надад явах газар байхгүй. Би таньд дуртайяа зүтгэнэ.

- Би чамд эрх чөлөө өгсөн ч аюулгүй байдал амалж чадахгүй. Би ертөнцийн хагасыг туулан дайн тулаанд явна. Чи өлсөж, өвдөж, алагдаж магадгүй гэхэд,

- Валар моргулис гэж Миссандей эртний Валирианы хэлээр хэлэв.

- Тиймээ бүх хүн үхэх ёстой ч бидний үхэх цаг хараахан болоогүй гэж найдаж байна гэж Дани зөвшөөрөөд жинтүү налан охины гарыг авлаа.

- Эдгээр Ансаллидууд үнэхээр аймшиггүй юу?

- Тиймээ, эрхэм дээдсээ.

- Чи одоо надад зүтгэх болсон. Тэд үнэхээр өвчин мэдэрдэггүй юу?

- Эр зоригийн дарс ийм мэдрэмжийг үгүй болгодог. Тэд нялх гөлөг, хүүхэд алсан цагаасаа хойш түүнийг жил болгон уудаг.

- Тэд дуулгавартай юу?

- Тэдний мэдэх ганц зүйл бол дуулгавартай байх явдал. Хэрвээ та тэдэнд амьсгалахгүй байхыг тушаавал даруй биелүүлнэ гэхэд Дани толгой дохилоо.

- Тэднийг надад хэрэггүй болсон хойно яах вэ?

- Өршөөгөөрэй эрхэм дээдсээ?

- Би дайнд ялж эцгийнхээ хаан ширээг буцаан авах үед хүлэг баатрууд маань илдээ хуйлан ард хүлээж байгаа амьдрал, шилтгээн, эхнэр хүүхэд, ээж рүүгээ буцна. Гэтэл энэ тайгануудад амьдрал байхгүй. Би тулалдах хэрэггүй болсон хойно найман мянган тайганыг яах вэ?

- Ансаллидууд маш сайн харуул болно, эрхэм дээдсээ. Тэгээд ч ийм сайн бэлтгэгдсэн цэргийг худалдаж авах хүнийг олоход бэрх биш гэж Миссандей хариулав.

- Вестеросын хүмүүс хүн худалдан авч зардаггүй гэдэг.

- Эрхэм дээдсээ таньд толилуулахад Ансаллидууд бол хүн биш.

- Хэрвээ би тэднийг зарвал миний эсрэг ашиглахгүй гэдгийг нь яаж мэдэх болж байна? Тэд үүнийг хийвэл яах билээ? Миний эсрэг тулалдаж хор учруулвал?

- Хэрвээ эзэн нь тушаавал биелүүлнэ. Тэд асуулт тавьдаггүй, эрхэм дээдсээ. Бүх асуулт тэднийг хөнгөлөхөд дууссан. Тэд хүлцэнгүй дагалдана гээд Миссандей түгшүүртэй ширтсэнээ,

- Та тэднийг хэрэгцээ нь дуусах үед илдэндээ унахыг тушааж болох юм гэв.

- Тэгвэл тэд үүнийг хийнэ гэж үү?

- Тиймээ. Эрхэм дээдсээ гэж Миссандей аяархан хариулав.

- Гэхдээ чи намайг ийм зүйл тушаахыг хүсэхгүй байгаа биз дээ? Энэ ямар учраас чамд хамаатай юм бэ? гээд Дани гарыг нь атгалаа.

- Таны боол... би эрхэм дээдсээ...

- Надад хэл гэхэд охин харцаа буруулав.

- Тэдний гурав нь урьд нь миний ах нар байсан, эрхэм дээдсээ.

Тэгвэл ах нарыг чинь чам шиг зоригтой ухаантай гэж найдахаас. Дани буцаж жинтүү налахад дамнуурга сүүлчийн удаа ертөнц нь болсон "Балерион" руу буцав. Дээрээс нь Дрогон руу буцаж байна. Дани дүнсийн амаа жимийлээ.

Үүний дараа салхитай урт харанхуй шөнө болов. Дани луунуудаа үргэлж өөрөө тэжээдэг ч өнөөдөр дур хүрсэнгүй. Тэр өрөөндөө ганцаар уйлж нулимсаа хатсан хойно Гролеотой ахин нэг удаагийн маргаан хийхээр гарлаа.

- Магистер Иллирио энд байхгүй. Байлаа ч гэсэн надад эсэргүүцэхгүй байсан. Надад Ансаллидууд энэ хөлөг онгоцнуудаас илүү хэрэгтэй. Би цааш нь энэ тухай сонсохыг хүсэхгүй байна гэж Дани түүнд эцэст нь хэлэв.

Уур хилэн гашуудал айдсыг нь хөдөлгөхөд хэдэн цагийн турш бухимдал нь салсангүй. Дараа нь тэр өрөөндөө цусан морьтонгуудаа сэр Жорахын хамт дуудлаа. Тэд түүний итгэдэг цорын ганц хүмүүс байв.

Ингээд маргааш нь сэргэлэн байхын тулд унтаж амрахыг оролдсон ч цагийн дараа бүтэхгүй болохыг нь ойлгов. Гадна хаалган дээр Эгго тосон дэнлүүний савах гэрэлд нумандаа шинэ хөвч хийж байлаа. Дэргэд нь тавцан дээр Ракаро хөлөө завиан суугаад аракхаа билүүгээр хурцалж байв. Дани тэднийг ажлаа үргэлжлүүл гээд тавцан дээгүүр явж шөнийн сэрүүн агаар амьсгалав. Багийнхан өөрсдийн ажил төрлөөрөө оролдон садаа болсонгүй ч төдөлгүй сэр Жорах хашлаган дээр түүнтэй нэгдлээ. *Тэр хэзээ ч холдохгүй юм. Тэр миний аашийг дэндүү сайн мэдэж байна* гэж Дани бодлоо.

- Калисий. Та унтаж амрах хэрэгтэй. Маргааш халуун хүнд өдөр болно. Чамд хүч хэрэгтэй.

- Чи Еройхийг санаж байна уу? гэж Дани асуулаа.

- Лазарийн охин уу?

- Би түүнийг хүчиндүүлж байхад аварч хамгаалалтандаа авсан. Гэвч миний нар-сар минь үхмэгц Маго түүнийг буцааж аваад ахин ашиглаж алсан. Эгго түүний хувь тавилан ийм байж гэсэн гэхэд,

- Би санаж байна гэж сэр Жорах хэлэв.

- Би удаан хугацаанд ганцаар байсан, Жорах. Ахыгаа тооцохгүй бол цор ганцаар. Ердөө бяцхан айсан амьтан байлаа. Висерис намайг хамгаалах ёстой байсан ч оронд нь зодож улам айлгадаг байсан. Тэр үүнийг хийх ёсгүй байсан юм. Тэр зөвхөн миний ах төдийгүй хаан минь байсан. Бурхад яагаад өөрийгөө хамгаалж чадахгүй хүнийг хамгаалдаггүй юм бол хаад хатдыг бүтээдэг биз дээ?

- Зарим хаад тэгдэг. Роберт тэгдэг байсан.

- Тэр жинхэнэ хаан биш. Тэр шударга биш. Шударга ёс бол хаадын хийх ёстой зүйл.

Сэр Жорах хариулсангүй зөвхөн инээмсэглэн үсэнд нь зөөлөн хүрлээ.

Тэр шөнө Дани Сэрээнд Рэйгар болж гэж зүүдлэн морины оронд луу унасан байлаа. Булаан эзлэгчийн бослогын цэрэг голын цаана мөсөн хуягтай ирэхэд тэр тэднийг лууны галд шүүдэр болгон хайлуулж Сэрээний урсгал болгон хувиргав. Түүний нэг хэсэг зүүдэлж байгаагаа мэдэж

байсан ч сэтгэл нь өөрийн эрхгүй хөөрлөө. Энэ зүйл ийм л байх ёстой. Бусад нь зөвхөн хар дарсан зүүд байсан би одоо л сэрж байна.

Тэр гэнэтхэн харанхуйд өрөөндөө сэрэхэд сэтгэл нь догдолсон хэвээр байлаа. "Балерион" түүнийг сэрээсэн бололтой ус онгоцны их бие рүү давалгаалахад мод сулхан чахран толгой дээр нь хөлийн чимээ сонсогдов. Эсвэл өөр зүйл ч юм уу.

Хэн нэгэн өрөөнд нь байлаа.

- Ирри? Жикүй? Та нар хаана байна? гэхэд зарц нар нь хариу өгсөнгүй. Өрөөнд тас харанхуй байсан ч тэдний амьсгалах сонсогдож байлаа.

- Жорах энэ чи юу?

- Тэд унтаж байна. Тэд бүгд унтаж байна. Луунууд хүртэл унтах хэрэгтэй гэж эмэгтэй хүний хоолой маш ойроос хэллээ.

Тэр миний дэргэд зогсож байна.

- Энд хэн байна? гээд Дани харанхуй руу ширтэхэд бүрэлзсэн дүрс харагдах шиг болов.

- Чи надаас юу хүсээ вэ?

- Санаж яв. Хойд зүг рүү явахын тулд өмнө зүг явах ёстой. Дорно зүг хүрэхийн тулд өрнө зүг явах ёстой. Урагш явахын тулд хойш эргэж гэрэлд хүрэхийн тулд сүүдрийн доогуур өнгөрөх ёстой.

- Куайт уу? гээд Дани орноосоо үсрэн бууж хаалга онгойлголоо. Өрөөнд дэнлүүний цайвар шаргал гэрэл тусахад Ирри, Жикүй хоёр нойрмоглон өндийлөө.

- Калисий? гэж Жикүй нүдээ нухан шивнэв. Висерион бас сэрж амаа ангайлган харанхуй буланд хурц дөл үлээв. Улаан маажин багтай эмэгтэйн бараа хаа ч байсангүй.

- Калисий та зүгээр үү? гэж Жикүй асуув.

- Ердөө зүүдэлснээс ондоо зүйлгүй. Буцаж унт. Би ч гэсэн унтлаа гээд Дани толгой сэгсэрч унтахыг оролдсон ч нойр нь буцаж ирсэнгүй.

Хэрвээ би эргэж харвал үгүй болно гэж Дани маргааш өглөө нь Астапорын эргийн хаалгаар орохдоо бодлоо. Тэр үнэн хэрэгтээ өөрийнхөө хичнээн өчүүхэн болохыг сануулж зүрхэлсэнгүй. Тэгвэл бүх зоригоо алдах байлаа. Өнөөдөр Дани мөнгөлөг гүүгээ унаж адууны дэлээр хийсэн өмд, зурагтай ширэн хантааз өмсөж хүрэл зүүлттэй бүс бүслээд, цээжиндээ хоёр зүүлт унжуулсан байв. Ирри, Жикүй хоёр гэзгийг нь сүлжиж Картын үхэшгүй мөнхийн шатсан Тоост өргөөг жингэнэн дуулах бяцхан мөнгөн хонх зүүж өглөө.

Астапорын улаан тоосгон гудамжууд өнөө өглөө бараг дүүрэн хүнтэй байв. Замын дагуу боол, зарц нар эгнэж токар өмссөн боолын эзэд хүүхнүүдтэйгээ гишгүүртэй пирамидын орой дээрээс

харна. Эцсийн эцэст тэдэнд Картынхнаас ялгагдах зүйл байхгүй. Тэд лууг цухас болтугай харж үр ач нартаа ярихыг хүсч байгаа гэж Дани бодлоо. Энэ нь тэдний хичнээн нь хүүхэдтэй бол гэж бодоход хүргэв.

Эгго түүний өмнө Дотракийн том нумтайгаа явж байлаа. Хүчит Белвас мориных нь баруун талд алхаж, Миссандей зүүн талд нь байлаа. Араас нь хүрмэн дээр хөө хуяг өмссөн сэр Жорах Мормонт дагаж хэт ойртсон хүмүүс рүү муухай ширтэнэ. Ракаро, Жого хоёр луутай дамнуургыг нь хамгаалж байв. Дани жуузны оройг авч гурван луугаа гинжлэхийг тушаажээ. Ирри, Жикүй хоёр тэдэнтэй явж аргадан тайвшируулна. Гэсэн ч Висерион сүүлээ урагш хойш шавхуурдан уурласандаа хамрынхаа нүхнээс утаа савсуулна. Рэйгал бас ямар нэг муу зүйл болж байгааг мэдсэн бололтой. Гурван ч удаа далавчаа дэлгэн нисэхийг оролдоод Жикүйгийн гарт байгаа хүнд гинжинд татагдан буув. Дрогон далавч сүүлээ чанга хумин бөмбөг шиг атираад зөвхөн нүднээс нь унтаагүйг мэдэж болох байлаа.

Араас нь үлдсэн хүмүүс болох Гролео болон бусад хоёр ахмад багийнхантайгаа, Дрогогын каласарын зуун мянган хүнээс үлдсэн наян гурван Дотракичууд явж байв. Дани хөгшин сул дорой, хүүхэдтэй эмэгтэй, бяцхан охид, гээгээ сүлжих насанд хүрээгүй залуу хөвгүүдийг цувааны дотор оруулжээ. Бусад дайчид цувааны гадна талаар нь улаан хязгаар, хар давст тэнгисээс амьд үлдсэн зуугаад хэрзгэр морьдын хамт явна.

Би далбаа оёулах ёстой байж гэж Дани ноорхой хүмүүсээ Астапорын тахирласан голын дагуу дагуулан явахдаа бодлоо. Тэр нүдээ анин үүнийг ямар болохыг болохыг төсөөлөхөд хар торгон дэвсгэр дээр Таргарианы овгийн алтан дөлөөр амьсгалж байгаа улаан гурван толгойтой луу байв. Рэйгарын далбаа ийм байсан байх даа. Голын эрэг хачирхалтай нам гүм байлаа. Астапорынхон мөрөнгөө "Өт" гэж дуудна. Энэ нь өргөн тахирласан намуухан урсгалтай дундаа бяцхан модтой арлуудтай байлаа. Дани нэг арал дээр гоёмсог гантиг хөшөөний дунд хүүхдүүд тоглон, өөр нэг арал дээр дурлалт хос Дотракийн хуримнаас ч ичгүүргүй өндөр ногоон модны сүүдэрт үнсэлдэж байхыг харлаа. Тэд хувцасгүй болохоор боол юм уу чөлөөт хүмүүсийн алин болох мэдэгдсэнгүй.

Том хүрэл харпигийн хөшөөтэй Бахархлын талбай худалдаж авч байгаа бүх Ансаллидуудыг нь багтаахын аргагүй жижигхэн байлаа. Иймээс оронд нь тэднийг гартаа авсан даруй хотоос шулуухан гаргахын тулд Астапорын төв хаалганы өмнө байдаг Шийтгэлийн талбайд жагсаажээ. Энд хүрэл хөшөө байсангүй зөвхөн бослого гаргасан боолуудыг дүүжилж, арьсыг нь өвчдөг модон тавцан байв.

- Сайн эзэд хотод орж ирсэн шинэ боолуудад харуулахын тулд хүүрүүдийг энд орхидог юм гэж Миссандей Данид талбайд орж ирэхдээ хэлжээ.

Дани цогцоснуудыг анх хармагц Жогос Найгийн тахь шиг адилхан судалтай арьстай гэж бодсон ч гүүгээрээ ойртож очих үедээ улаан махан дээр хар судал хөдөлж байхыг харав. *Ялаанууд. Ялаа болон өтнүүд байна.* Эсэргүүцэл үзүүлсэн боолуудын арьсыг яг л алимны хальс шиг урт нарийхнаар хуулан өвчжээ. Нэг хүний гар тохойноос хуруугаа хүртэл битүү ялаанд харлан дор нь улаан цагаан мах харагдаж байлаа. Дани дэргэд нь жолоогоо татав.

- Энэ хүн ямар хэрэг хийгээ вэ?

- Тэр эзнийхээ эсрэг гар далайсан юм.

Дотор нь муухайрч огиулахад Дани гүүгээ эргүүлээд өндөр үнээр худалдаж авсан арми нь байгаа талбайн төв рүү хатирууллаа. Хагас нь чулуунаас бүрдсэн тоосгон зүрхтэй цэргүүд эгнээ эгнээгээрээ ханаран зогсоход найман мянга зургаан зуун хадаастай хүрэл дуулгатай бүрэн бэлтгэгдсэн Ансаллидууд болон тэдний арын нүцгэн толгойтой жад, богино илдээр зэвсэглэсэн таван мянган хүн зогсч байлаа. Түүнээс цааш зөвхөн хөвгүүд байсан ч бусад шигээ цэх шулуун байв.

Кразнис мо Наклоз нөхөдтэйгээ түүнийг угтав. Бусад баян тансаг язгууртан гаралт Астапорчууд тэдний ард цугларан мөнгөн цомноос дарс шимж дундуур нь тавагтай олив, интоор, инжир жимс барьсан боолчууд гүйлдэнэ. Хөгшин Граздан дөрвөн биерхүү хүрэл арьстай боол мөрөн дээрээ дамнасан дамнуургатай жуузан дээр суужээ. Хэсэг морьтой жадчид талбайн захад сонирхохоор ирсэн хүмүүсийг тогтоон хаана. Нарны гэрэл тэдний нөмрөгөндөө оёсон толигор зэс цагаригт нүд гялбам ойход Дани морьдынх нь түгшсэнийг ажиглав. *Тэд луунаас айжээ. Тэгсэн нь дээр дээ.*

Кразнисын боол түүнийг мориноос буухад туслав. Кразнис өрөөсөн гараараа токараа атган нөгөө гартаа сийлбэртэй ташуур барьжээ.

- Тэд энд байна. Түүнд хэрвээ төлж чадах юм бол... тэд өөрийнх нь болно гэж хэл гээд Миссандей рүү харлаа.

- Тэр чадна гэж охин хэлэв.

Сэр Жорах тушаал өгөхөд бараа таваарыг урагш зөөв. Зургаан хуйлаастай барын арьс, гурван зуун боодол сайн чанарын торго, гүргэмтэй ваар, домботой мирр, савтай халуун ногоо, элдсэн арьс, гартааман баг, арван хоёр хаш сармагчин, сагстай улаан хар ногоон бэх, хайрцагтай үнэт ховор хар болор, хүүдийтэй сувд, торхтой дарсан олив, арван торх давсалсан загас, том зэс харанга цохиурын хамт, арван долоон зааны ясан нүд, том авдар дүүрэн үл мэдэх хэлээр бичсэн ном байлаа. Данигийн хүмүүс эднийг боолын эздийн урд овоолов.

Төлбөр хийгдэх зуур Кразнис мо Наклоз Данитай цэргийнх нь тухай эцсийн хэдэн үг солилцов.

- Тэд ногооноороо байгаа. Вестеросын янханд тэднийг аль болох түргэн тулаанд оруул гэж хэл. Эндээс тэнд хүртэл хаа сайгүй олон жижиг хот байгаа болохоор баян тансаг хотуудыг дээрэмд. Ямар ч олз омог олсон тэр бүгдийг ганцаар авна. Ансаллидууд алт, эрдэнэсийн чулуунд шунадаггүй. Тэр бас олзлогсод барьж цөөн тооны харуулын хамт Астапор луу буцааж болно. Бид эрүүл чийрэгийг нь сайн үнээр худалдаж авна. Түүний илгээсэн хөвгүүд цаг нь ирэхэд арван жилийн дараа Ансаллид болохыг хэн мэдэх билээ дээ. Энэ бол маш хожоотой зүйл.

Эцэст нь ачаа бараа овоолж дуусахад Дотракичууд ахин мориндоо мордож Дани,

- Энэ бол бидний авчирч чадах бүх зүйлс. Үлдсэн нь болох үлэмж хэмжээний хув, дарс, хар үзэм

онгоцон дээр хүлээж байгаа. Онгоц ч гэсэн та нарынх болсон. Одоо зөвхөн үлдсэн зүйл гэвэл... гэхэд,

- Луу гэж нийтийн хэлээр ярьдаг шовх сахалтай Граздан хэлэв.

- Тэр энд хүлээж байна гээд сэр Жорах, Белвас хоёр наранд Дрогон дүү нартайгаа наранд ээн хэвтэж байгаа дамнуурга руу хамт очив. Жикүй гинжний нэг үзүүрийг тайлж Данид өгөв. Дани түүнээс татахад хар луу толгойгоо өргөн хар улаан далавчаа дэлгэн исгэрсэнд Кразнис мо Наклоз нүүрийг нь сүүдэр бүрхэхэд баясгалантай инээмсэглэв.

Дани боолын эзэнд Дрогоны гинжний үзүүрийг өгөхөд хариуд нь ташуураа бэлэглэв. Энэ нь лууны хар ясан бариултай, гоёмсог чимэглэж алт шигтгэсэн эд байв. Үзүүрээс нь тус бүр алтадсан сарвуутай есөн ширхэг урт сур унжина. Ташуурын бариул зааны ясан хурц шүдтэй эмэгтэй хүний толгой байлаа.

- Харпигийн хуруунууд гэж Кразнис ташуурыг хэлэв.

Дани ташуурыг гартаа атган эргэлээ. *Ийм хөнгөн зүйл ямар жинтэй юм бэ.*

- Одоо болсон уу? Тэд минийх болсон уу?

- Болсон гэж Кразнис зөвшөөрөөд Дрогоныг дамнуурганаас буулгахаар гинжнээс татав.

Дани мөнгөлөгөө унахад зүрх нь цээжинд нь багтахгүй цохиллов. Түүнийг хязгааргүй айдас эзэмджээ. *Ах нь түүний оронд байсан бол ийм зүйл хийх байсан болов уу? Ханхүү Рэйгар булаан эзлэгчийн цэрэг Сэрээнд далбаагаа салхинд намируулан ирэхийг хараад сэтгэл нь ингэж түгшсэн байх даа.*

Дани дөрөөн дээрээ босон Ансаллидуудад харуулахын тулд харпигийн хурууг толгой дээрээ өргөв.

- **НАЙМАА ГҮЙЦСЭН! ТА НАР МИНИЙХ БОЛСОН!** гэж чанга хашгираад гүүгээ давиран эхний эгнээний урдуур ташуурыг өндөрт өргөн давхив.

- **ТА НАР ОДОО ЛУУНЫХ БОЛСОН! БИ ТА НАРЫГ ХУДАЛДАН АВЧ ҮҮНИЙ ТӨЛӨӨ ТӨЛСӨН! ЭНЭ ГҮЙЦСЭН!**

Дани хөгшин Граздан буурал толгойгоо огцом эргүүлэхийг харлаа. *Тэр миний Валирианаар ярихыг сонсож.* Бусад боолын эзэд сонссонгүй. Тэд дамнуургыг тойрон цуглараад Кразнист зөвөлгөө өгч байв. Астатор хичнээн угзарч чангаасан ч Дрогон дамнуурганаас ховхорсонгүй. Амнаас нь саарал утаа уугиж урт хүзүүгээ урагш огцом тэнийлгэн боолын эзний царай луу ярзайлаа.

Сэрээг гатлах цаг болж гэж Дани бодоод гүүгээ эргүүлэн буцахад цусан морьтонгууд нь ойртон ирлээ.

- Та хүндрэлд орсон бололтой гэж боолын эзэнд хэлэхэд,

- Тэр явахыг хүсэхгүй байна гэж Кразнис хэлэв.

- Энэ бол шалтгаантай. Луу бол боол биш гээд Дани ташуураараа боолын эзний царай луу хүчтэй ороолгов. Кразнис хашгиран ганхан ухрахад улаан цус хацрыг нь даган сүрчиг цацсан сахал руу нь урсав. Харпигийн хуруу ганц шавхуурдалтаар нүүрнийх нь хагасыг огил татсан ч Дани зогссонгүй.

- Дрогон. *Дракарис* гэж хамаг айдсаа мартан чанга дууллаа.

Хар луу далавчаа өргөн хүрхрэв.

Хуйларсан хар дөл Кразнисийн нүүр лүү бүхлээрээ буулаа. Түүний нүд хайлж хацар луу нь урсаад тосолсон үс сахал нь дүрэлзсэн галд авалцаж агшин зуур толгойндоо өндөр галт титэм өмссөн мэт боллоо. Гэнэтхэн хуйхлагдсан махны эхүүн үнэр сүрчигнийх нь үнэрийг дарахад хашгиралт нь чанга цуурайтав.

Шийтгэлийн талбайд цус, үймээн самуун дэгдлээ. Сайн эзэд хашгиран хоорондоо түлхэлцэж токарын цацгандаа бүдчин гүйлдэв. Дрогон хар далавчаа дэлгэн залхуутай нисэж боолын эзэн рүү ахин нэг удаа галын дөл буулгахад Ирри, Жикүй хоёр Висерион, Рэйгал хоёрыг суллаж агшин зуур гурван луу агаарт хөөрлөө. Дани эргэн харахад Астапорын бардам чөтгөрийн эвэртэй дайчид айсан морьд дээрээ тогтох гэж оролдон, нэг хэсэг нь зэс цагариг дээрээ гэрэл ойлгон зугтаж байлаа. Нэг хүн эмээл дээрээ тогтоод илдээ сугалахад Жогогын ташуур хүзүүг нь ороон авч хашгиралт нь тасалдав. Өөр нэг хүн Ракарогийн аракхд гараа алдаж цус садруулан давхилаа. Эгго тайван сууж нумны хөвчөө татан алт, мөнгө энгийн цацагтай хамаагүй токар луу илгээв. Хүчит Белвас аракхаа бас сугалж толгой дээгүүрээ эргэлдүүлэн тулаанд орлоо.

- Жадандаа! гэж Астапоруудын нэг нь хашгирлаа. Энэ нь сувдан цацагтай токартай хөгшин Граздан байлаа.

- Ансаллидууд аа! Биднийг хамгаал тэднийг зогсоо. Эздээ хамгаалцгаа! Жад, илдэндээ!

Эггогын сум аманд нь зооход дамнуурга өргөж байсан боолууд тарж зугтан эзэн нь газар онхолдон уналаа. Хөгшин хүн тоосгон дээр цусан мөр татуулан тайганы эхний эгнээнд хүртэл мөлхөв. Ансаллидууд түүний үхэхийг тоосонгүй эгнээ эгнээгээрээ зогссон хэвээр байлаа.

Тэд хөдөлсөнгүй. *Бурхад миний мөргөлийг сонсож.*

- Ансаллидууд аа! гээд Дани тэдний урдуур цогиулахад мөнгөлөг алтан гээг нь морины явдалд хонхоо жингэнүүлэн арагш хийсэв.

- Сайн эзэд, цэргүүд болон токар өмсч гартаа ташуур барьсан бүх хүнийг ал. Гэхдээ арван хоёроос доош насны хүүхдэд бүү хүрээрэй. Замдаа тааралдсан бүх боолын гинжийг тасал гээд харпигийн хурууг агаарт өргөж хажуу тийш шавхуурдав.

- *Эрх чөлөө! Дракарис! Дракарис!* гэж хашгирав.

- *Дракарис! Дракарис! Дракарис!* гэж тэд хариу хашгирахад Данигийн сонссон хамгийн сайхан үг байлаа. Тэдний эргэн тойронд боолын эзэд цурхиран амь гуйн үхэж агаарт тоос бужигнан, жад цоролзон галын дөл дүрэлзэв.

САНСА

Түүний шинэ дашинз бэлэн болсон өглөө зарц охин Сансагын угаалгын онгоцыг уур савссан халуун усаар дүүргэн хөлөөс толгой хүртэл биеийг нь мөлгөр ягаан болтол сойздон угаалаа. Серсейгийн гарын зарц хумсыг нь авч будаад, үсийг нь буржийлган нуруу руу нь цагариг болгон унжуулав. Тэр хатны дуртай үнэртэнгүүдийг ч гэсэн авчирчээ. Санса цэцэгний үнэр дор зүрж ханхалсан хурц сүрчиг сонголоо. Зарц хуруугаа норгоод Сансагын чихний ард, эрүүний дор түрхэж хөхний толгойг нь хөнгөн шүргэв.

Сансагын шинэ хувцас хэр болсныг харахаар Серсей өөрийн биеэр үйлчинтэй хамт ирэв. Дотуур хувцас нь бүгд торго, дашинз нь мөнгөн атлаасан эмжээртэй зааны ясан хоргой байлаа. Гараа доошлуулахад урт ханцуйных нь үзүүр бараг газар шүргэх шахам унжина. Энэ нь эмэгтэй хүний дашинз болохоос биш охиных биш болох нь илт байлаа. Цээж хэсгээрээ урд энгэртээ бараг гэдэс хүртэл гурвалжин хэлбэртэй онгорхой Миришийн хөх саарал торон эмжээртэй байлаа. Хормой нь бүхэлдээ урт бүсэлхий хэсгээрээ маш бариу тул Санса үдэхэд нь амьсгаагаа татав. Түүнчлэн шинэ гутал ч гэсэн авчирсан бөгөөд зөөлөн саарал согооны арьсан шаахай хөлөнд нь аятай зохицжээ.

- Та маш үзэсгэлэнтэй байна, хатагтай гэж оёдолчин түүнийг хувцаслахад хэлэв.

- Тийм гэж үү? гээд Санса хормойгоо намируулан хөхрөн эргэлдсэнээ,

- Өө, тийм байна гээд Вилласт ийм хувцастайгаа харагдахыг тэсэн ядан хүлээлээ. *Тэр надад дурлана. Гарцаагүй дурлах болно... Тэр намайг хараад Винтерфеллийг мартана. Би үүнд санаа тавина.*

Хатан Серсей Сансаг шүүмжлэнгүй ширтэв.

- Хэдэн үнэт чулуу нэмэхэд илүүдэхгүй гэж бодож байна. Жоффригийн түүнд өгсөн сарны чулууг зүү гэхэд,

- Даруйхан гүйцэтгэе, эрхэм дээдсээ гэж зарц нь хэлэв.

Санса сарны чулуун ээмгийг чихэндээ зүүж хүзүүндээ зүүлтийг нь унжуулахад хатан толгой дохив.

- Тиймээ. Бурхад чамд элэгсэг хандаж, Санса. Чи дур булаам охин юм. Ийм гэм зэмгүй ариухан зүйлийг тэр чулуун лууд өгөх ичгүүргүй санагдаж байна.

- Юун чулуун луу? гээд Санса ойлгосонгүй. Тэр Вилласийг хэлсэн юм болов уу? *Тэр хаанаас мэдсэн хэрэг байх вэ?* Үгүй Маржэйри, Өргөст хатан болон түүнээс ондоо хэн ч үүнийг мэдэхгүй. Дээрээс нь Донтос байгаа ч үүнийг тооцох хэрэггүй.

Серсей Ланнистер асуултыг үл тоомсорлов.

- Нөмрөг гэж тушаахад зарц эмэгтэй сувдан чимэглэлтэй цагаан хилэн хүнд урт нөмрөг авчирав. Нөмрөгний голд мөнгөн утсаар догшин зэрлэг чоно хатгамлажээ. Санса үүнийг хараад гэнэтхэн эмээлээ.

- Эцгийн чинь өнгө гэж Серсей зарц нарыг хүзүүнд нь гоёмсог мөнгөн гинжээр товчилж өгөхөд хэлэв.

Охины нөмрөг. Сансагын гар хоолой руугаа явлаа. Тэр чаддагсан бол үүнийг урж хаях байсан ч зүрхэлсэнгүй.

- Чи амаа хамхисан үедээ хөөрхөн байх юм, Санса. Алив одоо явцгаая септон хүлээж байгаа. Хуримын зочид ч гэсэн гэж Серсей хэлэв.

- Үгүй. Үгүй гэж Санса дуу алдлаа.

- Тийм чи бол титмийн хүмүүжигч. Ах чинь урвагч болсон болохоор хаан эцгийн чинь байрыг эзлэх болно. Энэ бол тэр чиний гарыг өгөх бүрэн эрхтэй гэсэн үг. Чи миний дүү Тирионтой гэрлэж байгаа.

Миний үе залгамжлах эрх гэж Санса балмагдан бодлоо. Эцсийн эцэст тэнэг Донтос мулгуу байсангүй үнэнийг олж харжээ. Санса хатнаас алхам ухарлаа.

- Би тэгэхгүй. *Гуйж байна би Вилластай гэрлэж Хайгардены хатагтай болмоор байна...*

- Би чиний дургүй байгааг ойлгож байна. Хүсвэл чи уйлсан ч болно. Би чиний оронд байсан бол үсээ зулгааж хаях байлаа. Тэр эргэлзээгүй жигшмээр бяцхан одой хэдий ч чи түүнтэй гэрлэх болно.

- Та нар намайг гэрлүүлж чадахгүй.

- Мэдээж бид чадна. Чи сүм рүү чимээгүй явж хатагтайн ёсоор амлалтаа хэлэх үү эсвэл жүчээний хөвгүүдийн нүдэн дээр тэмцэн хашгирч инээдийг нь хүргэнэ үү эцэст нь ижилхэн дэр нэгтгэж дуусна гээд хатан хаалга онгойлгоход хааны хамгаалалтын цагаан ялтсан хуягтай сэр Мерин Трант, сэр Осмунд Кетлблак хоёр хүлээж байв.

- Хатагтай Сансаг сүм рүү дагуулж яв. Хэрэгтэй бол чирсэн ч болно. Гэхдээ даашиныг нь урахгүй байхыг хичээгээрэй дээ. Маш үнэтэй шүү.

Санса зугтахыг оролдсон ч Серсейгийн гарын зарц хашаанд гарч амжихаас нь өмнө барив. Сэр Мерин Трант түүнийг дальдиртал ширтэхэд Кетлблак бараг зөөлөн гэмээр хүрч,

- Та хэлснийг нь хийвэл муу зүйл болохгүй. Чононууд зоригтой байдаг биз дээ? гэв.

Зориг. Санса гүн амьсгал авлаа. *Би Старк болохоор зоригтой байж чадна.* Хашаанд сэр Борос Блоунт хувцсыг нь урдаг өдөр бүгд түүнийг харцгаасан. Харин зодуулдаг өдөр Бяцхан чөтгөр түүнийг аварсан болохоор түүнтэй ижилхэн хүн хүлээж байгаа. *Тэр ядахдаа л бусад шигээ муу*

Биш юм.

- Би явъя.

- Би чамайг тэгнэ гэдгийг мэдсэн юмаа гээд Серсей инээмсэглэлээ.

Үүний дараа Санса өрөөнөөс хэрхэн гарч шат уруудан хашаан дундуур гарснаа санасангүй. Түүний бүх анхаарал зөвхөн ганц алхам хөлийн урд зүйлд чиглэжээ. Сэр Мерин, сэр Осмунд хоёр түүний дэргэд явж сувд, эцгийнх нь зэрлэг чоныг эс тооцвол даашинз шиг нь цагаан нөмрөгтэй байлаа. Жоффри түүнийг шилтгээний сүмийн шатан дээр хүлээж байв. Хаан хүрэн улаан өнгийн алтлаг гоёмсог сайхан хувцас өмсөж толгой дээрээ титэм тавьжээ.

- Би өнөөдөр эцэг чинь болно гэж Сансаг хараад мэдэгдэв.

- Чи чадахгүй. Хэзээ ч болохгүй гэж Санса дүрсхийхэд түүний царай барайлаа.

- Би болно. Би чиний эцэг болохоор хүссэнтэйгээ гэрлүүлж чадна. Ямар ч хүнтэй шүү. Чи намайг хэлвэл гахайчинтай гэрлэж пүнзэнд нь унтах болно гээд ногоон нүд нь хөөрөн гялалзаж,

- Эсвэл би чамайг Илин Пэйнд өгдөг юм уу? Чи түүнд илүү дуртай байна уу? гэхэд Сансагын зүрх палхийлээ.

- Гуйж байна, эрхэм дээдсээ. Хэрвээ та надад өчүүхэн ч гэсэн хайртай бол намайг битгий гэрлүүлээч өөрийнхөө...

- Нагацтай юу? гээд Тирион Ланнистер сүмийн хаалгаар гарч ирэв.

- Эрхэм дээдсээ. Таны таалалд нийцвэл надад хатагтай Сансатай байх ганцаар байх хэдэн мөч олгоно уу.

Хаан татгалзах байсан ч ээж нь ширүүн харлаа. Тэд хэдэн алхам холдов.

Тирион алтан хээ угалзтай хар хилэн хантааз, гурван инчийн зузаан өндөр өсгийтэй гутал өмсөж, арслангийн бадмаараг толгойтой гинж зүүжээ. Гэвч царайг нь дайрсан шарх шүүрхий улаан хэвээр хамар нь аймшигтай хатсан товруутай байлаа.

- Санса чи маш үзэсгэлэнтэй харагдаж байна.

- Таны ингэж хэлдэг ямар эелдэг хэрэг вэ, эрхэм лорд гээд Санса өөр ямар зүйл хэлэхээ мэдсэнгүй. *Би түүнийг сайхан харагдаж байна гэх үү? Тэр намайг тэнэг дээрээ худалч гэж бодох байх даа.* Тэр харцаа буулган хэлээ хазав.

- Хатагтай таныг хуримд чинь ингэж авчирах ёсгүй байсан юм. Намайг үүнд уучлаарай. Энэ бол гэнэтхэн гаргасан нууц шийдвэр. Миний лорд эцэгт үүнийг хийх гарцаагүй шаардлага байсан юм. Үгүй бол би өмнө нь чам руу хүссэн шигээ очих байлаа гээд ойртож,

- Чамайг надаас дутуугүй энэ гэрлэлтийг гуйгаагүй болохыг чинь мэдэж байна. Хэрвээ би татгалзвал тэд чамайг миний үеэл Ланселтай гэрлүүлэх байх. Магадгүй чамд энэ илүү таалагдах байсан бизээ. Тэр чиний настай ойролцоо дээрээс нь хамаагүй царайлаг. Хэрвээ чи үүнийг хүсч байгаа бол зөвхөн хэлэхэд би энэ наадмыг төгсгөл болгоё гэв.

Би Ланнистерийн алинтай ч гэрлэхийг хүсэхгүй байна. Би Вилластай гэрлэж Хайгарденд очин гөлөг, зугаалгын онгоц, Эддарт, Бран, Рикон гэдэг хөвгүүдтэй болохыг хүсч байна гэж Санса хэлэхийг хүслээ. Гэвч тэр Донтосын бурхдын модонд хэлсэн үгийг санав. Тайрелл, Ланнистер байна уу хамаа алга тэд намайг биш зөвхөн удам залгамжлах эрхийг минь хүсч байгаа.

- Та дэндүү сайхан сэтгэлтэй юм, эрхэм лорд. Би хаан ширээний хүмүүжүүлэгдэгч болохоор миний үүрэг бол хааны тушаалын дагуу гэрлэх явдал гэж эрхгүй ялагдан хэллээ.

Тирион түүнийг нийцээгүй нүдээрээ ажиглав.

- Би залуу охидын мөрөөдлийн нөхөр биш гэдгээ мэдэж байна, Санса. Гэсэн ч би Жоффри биш гэж зөөлөн хэлэв.

- Үгүй. Таны надад сайн хандсан болохыг санаж байна.

Тирион түүнд мойног хуруутай бүдүүн гараа сунгав.

- Тэгвэл явцгаая. Биднийг үүрэг маань хүлээж байна.

Санса түүнд гараа өгөхөд Тирион Эж, Эцэг хоёрын дунд амьдралыг нь нэгтгэхийг хүлээн зогсож байгаа септоны гэрлэлтийн шүтээн рүү дагуулан очлоо. Санса тэнэгийн эрээн хувцастай Донтос том дугуй нүдээрээ ширтэхийг харахыг харлаа. Тэнд хааны хамгаалалтын цагаан хувцастай сэр Бэйлон Свон, сэр Борос Блоунт хоёр байсан ч сэр Лорас байсангүй. Ер нь Тайреллийнхны хэн нь ч энд алга гэж гэнэт ойлголоо. Гэвч бусад гэрч болох Варис тайган, сэр Аддам Марбранд, лорд Филип Фоот, сэр Бронн, Жалабар Зо болоод олон арван тооны хүрэлцээтэй хүн байлаа. Лорд Жайлс ханиалган, хатагтай Эрмесанда цээжээ тэврэн, хатагтай Тандагын жирэмсэн охин ямар ч шалтгаангүй уйлна. *Тэр уйлж л байг. Магадгүй би ч гэсэн энэ өдөр дуусахын өмнө ижил зүйл хийх байх* гэж Санса бодлоо.

Хуримын ёслол зүүдэн дунд өнгөрөв. Санса түүнээс шаардсан бүхнийг гүйцэтгэн мөргөж, амлалтаа хэлэн, дуулахад өндөр лааны зуугаад анивчсан гэрэл нулимс цийлэгнэсэн нүдэнд нь мянга болон бүрэлзэв. Аз болоход хэн ч түүнийг эцгийнхээ овгийн хувцастай зогсоод уйлж байхыг анзаарсангүй эсвэл тийм дүр үзүүлсэн ч байж магад. Нэг их хугацаа өнгөрөөгүй байхад нөмрөгийг нь солих цаг ирлээ.

Хаант улсын эцгийн ёсоор Жоффри лорд Эддарт Старкийн байрыг эзлэв. Санса түүний гар мөрөн дээгүүр нь нөмрөгнийх нь тээгийг тайлахаар тэмтчихэд жад шиг цэх зогсов. Тэгтэл нэг гар хөхийг нь шүргэж аяархан базлаа. Тээг нээгдэхэд Жофф охины нөмрөгийг хуулан авч хааны ёсоор тэнэгдүүхэн инээмсэглэв.

Нагац ахынх нь үүрэг сайн болж өгсөнгүй. Тэр арслангын дүрс хатгамласан том хүнд хүрэн улаан өнгийн алтан атлаас бадмааргаар эмжсэн хилэн нөмрөг барин зогсчээ. Хэний ч толгойд түүнд сандал авчирч өгөх бодол ороогүй болохоор Тирион сүйт бүсгүйнхээ хагастай тэнцэх намхан байлаа. Тэр ард нь очиж зогсоход хормойноос нь чанга угзрах мэдэгдлээ. *Тэр намайг өвдөг сөгдөхийг хүсч байна* гэж Санса улайн ойлгов. Энэ нь доромжлол байлаа. Ийм зүйл болох ёсгүй. Санса хуримын өдрийнхөө тухай мянган удаа мөрөөдөхдөө үргэлж ард нь өндөр хүчтэй сүйт залуу зогсож мөрөнд нь хамгаалан нөмрөг нөмөргөөд урагш товчилж өгөхөөр бөхийхдөө хацар дээр нь энхрийлэн үнсэж байгаагаар төсөөлдөг байжээ.

Тэгтэл хормойноос нь илүү шургуу угзрах мэдэгдэв. *Би сөгдөхгүй. Би яагаад хэн ч минийхэд санаа тавихгүй байхад түүний мэдрэмжийг хуваалцах ёстой юм бэ?*

Одой гурав дахь удаагаа угзрав. Санса анзаараагүй дүр эсгэн уруулаа зөрүүдлэн жимийлээ. Ард нь нэг хүн инээлээ. *Хатан* гэж бодсон ч хамаа байсангүй. Тэд бүгд инээлдэхэд Жоффри хамгийн чанга хөхрөв.

- Донтос гараа доошлуулаад өвдөг сөгд. Миний нагац ах сүйт бүсгүй рүүгээ өргүүлэх хэрэгтэй байна гэж хаан тушаав.

Ингэж л түүний лорд нөхөр нь Ланнистерийн овгийн нөмрөгийг тэнэгийн нуруун дээр зогсож байж нөмөргөлөө.

Санса эргэхэд жижигхэн хүн түүн рүү уруулаа чанга жимийн Сансагын нөмрөг шиг час улайсан царайгаар ширтэж байв. Тэр гэнэтхэн зөрүүд зан гаргасандаа ичлээ. Санса хормойгоо тэнийлгэн түүний урд өвдөг сөгдөхөд толгой нь ижилхэн түвшинд ирэв.

- Энэ үнсэлтээр би хайраа андгайлж чамайг лорд нөхрөө болгон авч байна.

- Энэ үнсэлтээр би хайраа андгайлж чамайг хатагтай эхнэрээ болгон авч байна гэж одой сөөнгөтөн хэлээд урагш бөхийж уруул дээр нь товч үнслээ.

Тэр хичнээн муухай юм бэ. Тэр Хотчоос ч илүү царай муутай юм гэж Сана царайг нь ойртоход бодлоо.

Септон болор титмээ өргөхөд солонгорсон гэрэл тэдэн рүү тусав.

- Бурхад болон хүмүүсийн нүдний өмнө би Ланнистерийн овгийн Тирион, Старкийн овгийн Санса хоёрыг эхнэр нөхөр болон одооноос эхлэн үүрд нэг бие, зүрх, сэтгэл болж дундуур нь орсон хэн ч гэсэн хараал хүрэхийг ёс төртэйгээр мэдэгдэж байна.

Санса уйлахгүйн тулд уруулаа хазлаа.

Хуримын найр Бага танхимд болов. Тэнд ойролцоогоор тавиад зочин цугласнаас ихэнхи нь хуримын ёслолд оролцсон Ланнистерийн хүмүүс байлаа. Түүнчлэн Тайреллийнхан байв. Өргөст хатан Баруун, Зүүн хоёрынхоо дунд майжигнахад Маржэйри түүн рүү гунигтай харсан ч эмгэн

тоож харсангүй. Элиноор, Алла, Мегга нар түүнийг танихгүй мэт царайлж байлаа. *Миний найзууд* гэж Санса гашуунаар бодлоо.

Түүний нөхөр ихэд ууж бага идэв. Тэр хэн нэгэн хундаганы үг хэлэн босч зогсоход сонсож хүлээж авсны тэмдэг болгон үе үе толгой дохиж байсан ч бусад үед бол чулуугаар хийсэн юм шиг царайтай байв. Найр үүрд үргэлжлэх мэт санагдсан ч Санса хоолонд ам хүрсэнгүй. Тэр үүнийг дуусахыг хүсч байсан ч төгсгөлөөс нь айж байлаа. Найрын дараа дэр нэгтгэх явдал болно. Эрчүүд түүнийг хуримын ор луу авчирч хувцсыг нь тайлан даавуун дээр хүлээж байгаа хувь тавилангынх нь тухай бүдүүлэг тоглоом шоглоом хийхэд Тирионд эмэгтэйчүүд ч гэсэн мөн ижил хүндэтгэл үзүүлнэ. Зөвхөн тэд түүнийг бүрэн нүцгэлж оронд оруулсны дараа ганцаар орхих ч зочид хосын өрөөний гадаа зогсон хаалгаар завхай зөвөлгөө хашгиран өгнө. Сансаг жаахан охин байхад дэр нэгтгэх явдал ер бусын муухай хэр нь сэтгэл хөөрөм санагддаг байсан ч харин одоо бол үүнээс зөвхөн айж байлаа. Тэр хувцсыг нь урахыг тэвчиж чадна гэж бодоогүй болохоор анхны бүдүүлэг хошигнолд нулимс нь урсах байх.

Хөгжимчид тоглож эхлэхэд Санса хулчгардуухан Тирион дээр гараа тавилаа.

- Эрхэм лорд бид бүжгийг эхлүүлэх ёстой юу?

- Бид ганцхан өдрийн дотор хангалттай элэг доог болсон гэж бодохгүй байна уу? гээд түүний ам ярвайлаа.

- Таны тааллаар болог гээд Санса гараа буцааж татлаа.

Тэдний оронд Жоффри, Маржэйри хоёр бүжгийг эхлэв. *Ийм мангас яаж үзэсгэлэнтэй сайхан бүжиглэж чаддаг байна аа?* гэж Санса гайхан бодлоо. Тэр үргэлж хуримын бүжиг бүжиглэхэд нь бүгдийн нүд царайлаг лорд тэр хоёр луу тусч байгаагаар мөрөөддөг байв. Тэгээд ч түүний мөрөөдөлд бүх хүмүүс инээмсэглэж байдаг. *Миний нөхөр хүртэл инээмсэглэж байдаг.*

Бусад зочид удалгүй хаан сүйт бүсгүй хоёртой бүжигт нэгдлээ. Элиноор залуу хиатайгаа бүжиглэхэд, Мегга ханхүү Томментой бүжиглэв. Миришийн үзэсгэлэнтэй хар үс, том хар нүдтэй хатагтай Меривидер маш өдөөн хатгасан байртай эргэлдэхэд танхимд байсан бүх хүн түүн рүү ширтэв. Ноён хатагтай Тайрелл намбатай хөдөлгөөнөөр бүжив. Сэр Кеван Ланнистер лорд Тайреллийн дүү хатагтай Жанна Фосовэйтэй бүжиглэх зөвшөөрөл гуйж, Мерри Крэйн гоёмсог өдөн хувцастай цөлөгдсөн ханхүү Жалабар Зотой бүжиглэв. Серсей Ланнистер эхлээд лорд Рэдвайнтай хос болсноо дараа нь лорд Рован эцэст нь үл инээмсэглэгч царайтай эцэгтэйгээ бүжиглэлээ.

Санса гараа өвдгөн дээрээ тавин суугаад хатан хэрхэн инээмсэглэн бүжиглэх зуураа буржгар цайвар үсээ хойш шидэхийг харав. *Тэр тэднийг ховсдож байна. Түүнийг хичнээн үзэн ядаж байна гээч* гэж бодлоо. Санса Сарны хүү, Донтос хоёрын бүжиглэж буй зүг рүү харц буруулав.

- Хатагтай. Та надтай бүжиглэхийг зөвшөөрнө үү? Хэрвээ лорд чинь зөвшөөрвөл гээд сэр Гарлан Тайрелл тавцангын дэргэд зогслоо.

- Миний хатагтай хүссэн хүнтэйгээ бүжиглэх болно гээд одойн нийцээгүй нүд зэвүүцэн нарийслаа.

Магадгүй тэр нөхрийнхөө дэргэд үлдэх ёстой байсан ч Санса Маржэйри, Виллас, Цэцэгт хүлэг баатрын ах дүү сэр Гарлантай бүжиглэхийг ихэд хүсчээ.

- Би яагаад тэдний таныг Зоригт Гарлан гэдэг болохыг харлаа, сэр гээд гараа өгөв.

- Хатагтайн ингэж хэлдэг ямар нигүүлсэнгүй юм бэ. Миний ах Виллас намайг хамгаалахын тулд энэ нэрийг өгсөн юм.

- Таныг хамгаалахын тулд гэнэ ээ? гээд Санса тааварлангуй харлаа.

- Би бяцхан тарган хүү байхдаа Догшин Гарт гэж дууддаг авга ахаасаа ихэд айдаг байсан юм. Тэгэхээр Виллас намайг Ногоон Гарлан, Цочимтгой Гарлан, Чулуун луу Гарлан гэж нэрлэснийхээ дараа оноосон хэрэг.

Энэ нь утгагүй хэдий ч хөгжилтэй байсан болохоор Санса бүхнийг үл харгалзан инээлээ. Дараа нь талархах сэтгэл төрөв. Ямартай ч инээд түүнд өчүүхэн атугай найдвар төрүүлжээ. Санса инээмсэглэн хөгжмийн аялгуу лимбэ, бишгүүр, ятга, бөмбөрийн цохих хэмнэлд хөлийн гишгэгдэлдээ уусан үе үе сэр Гарланы гарт эргэн ирж байлаа.

- Миний хатагтай эхнэр чамд ихэд сэтгэл зовж байгаа гэж тэр нэг удаад нь хэлэв.

- Хатагтай Леонетт дэндүү сайхан сэтгэлтэй юм. Түүнд намайг сайн гэж хэлээрэй.

- Хуримаа хийж байгаа сүйт бүсгүй үүнээс ч сайн байх ёстой. Чи нулимс унагаахад ойрхон харагдаж байна.

- Баярын нулимс, сэр.

- Хэл чинь худал хэлж байгаа ч нүд чинь үнэнийг хэлж байна гээд сэр Гарлан түүнийг эргүүлэн хажуудаа авчирлаа.

- Хатагтай би чамайг дүү рүү минь яаж харж байхыг харсан. Лорас зоригтой царайлаг бид бүгд үнэн зүрхнээсээ түүнд хайртай ч чиний одой илүү дээр нөхөр болно. Би түүнийг харагдаж байгаагаасаа илүү том хүн гэж бодож байна.

Сансаг хариу хэлэх үг бодож амжихаас урд хөгжим тэднийг салгав. Түүний эсрэг талд улаан нүүртэй хөлс нь урссан Мэйс Тайрелл болон лорд Мерривидер, ханхүү Томмен нар ээлжлэн ирлээ.

- Би бас гэрлэхийг хүсч байна. Би нагац ахаасаа илүү өндөр! гэж есөн настай жижигхэн булцгар ханхүү хэлэв.

- Би таныг тийм болохыг мэднэ гэж Санса хос нь солигдохоос өмнө хэллээ. Сэр Кеван түүнийг үзэсгэлэнтэй гэж магтахад, Жалабар Зо Зуны арлын хэлээр ямар нэг ойлгомжгүй зүйл бувтнан,

лорд Рэдвайн түүнд тарган хүүхдүүд олон жилийн аз жаргалтай амьдрал ерөөлөө. Тэгтэл бүжиг түүнийг Жоффритой нүүр тулгаруулав.

Санса түүний гар хүрэхэд хөшсөн ч хаан атгалтаа чангалан ойртуулан татав.

- Чи ийм гунигтай харагдах ёсгүй. Миний нагац ах үзэмжгүй бяцхан амьтан хэдий ч чамд би байгаа.

- Чи Маржэйритай гэрлэнэ биз дээ!

- Хаан өөр эмэгтэйтэй байж болно. Янхнууд. Миний эцэг тэгдэг байсан юм. Эйгоны гурав билүү дөрөв дэх хаадын нэг ч гэсэн тэгдэг байсан. Тэр маш олон янхан дүүрэн бутач хүүхэдтэй байсан гээд тэднийг хөгжмийн аясаар эргэхэд Жофф нойтноор үнсээд,

- Миний нагац ах чамайг тушаасан үед ор луу минь авчирна гэв.

- Үгүй, тэр тэгэхгүй гээд Санса толгой сэгсэрлээ.

- Тэр тэгнэ үгүй бол би түүний толгойг авна. Эйгон хаан гэрлэсэн эсэх нь хамаагүй хүссэн хүүхнээ авдаг байсан.

Аз болоход энэ үед солигдох цаг ахин боллоо. Сансагын хөл мод шиг хөшсөн болохоор лорд Рован, сэр Таллад, Эллинорын хиа гээд бүгд түүнийг тааруухан бүжигчин гэж бодох шиг боллоо. Тэгтэл Санса ахин сэр Гарлантай тааралдсанд аз болж бүжиг дуусав.

Гэвч сэтгэл амралт удсангүй. Хөгжим намдсан хойно Жоффри,

- Тэднийг оронд нь оруулах цаг боллоо! Сансагын хувцсыг тайлж ямаршуухан эмэгчин чоно нагац ахад минь өгч байгааг харцгаая! гэж хэлэхэд бусад хүмүүс дэмжин хашграв.

Түүний одой нөхөр хундаганаасаа харцаа удаанаар салгалаа.

- Би оронд орохгүй гэхэд Жоффри Сансагын гарыг шүүрэн авч,

- Чи миний тушаасан зүйлийг гүйцэтгэнэ гэв.

Одой хутгаа ширээн дээр тасхийтэл зооход чичигнэн тогтов.

- Тэгвэл чи сүйт бүсгүйдээ модоор хатгаж өгч үйлчилээрэй. Би чамайг хөнгөлнө гэдгээ, андгайлж байна.

Цочирдсон нам гүм боллоо. Санса Жоффригоос мултрах гэсэн ч гарыг нь тавьсангүйд ханцуй нь урагдлаа. Хэн ч үүнийг сонссонгүй. Хатан Серсей эцэг рүүгээ эргэлээ.

- Та түүнийг сонсов уу? гэхэд лорд Тайвин суудлаасаа өндийлөө.

- Бид энэ оронд оруулах явдалгүй болно гэж бодож байна. Би чамайг хааныг сүрдүүлэх гээгүй

гэдэгт итгэлтэй байна шүү, Тирион.

Санса нөхрийнхөө царай уурандаа татвалзахыг харлаа.

- Би буруу ярьсан байна. Энэ муухан шоглоом боллоо, сэр.

- Чи намайг хөнгөлнө гэж сүрдүүлсэн! гэж Жоффри чанга хэллээ.

- Тиймээ, эрхэм дээдсээ. Гэхдээ зөвхөн хааны эрхтэнд чинь атаархсан учраас тэгсэн юм. Миний өөрийнх жижигхэн богино гээд Тирион шүд зууж,

- Тэгээд ч та миний хэлийг огтлох юм бол надад өгсөн хонгор эхнэрийг маань баярлуулах зүйл үлдэхгүй нь гэв.

Сэр Осмунд Кетлблэк түсхийтэл инээхэд араас нь өөр хүн даган инээв. Гэвч Жофф болон лорд Тайвины алин ч инээсэнгүй.

- Эрхэм дээдсээ миний хүү согтуу болохыг та харж байгаа биз дээ.

- Тиймээ би согтуу. Гэсэн ч орондоо үүргээ гүйцэтгэж чадахааргүй согтуу биш байна гээд Тирион тавцангаас үсрэн бууж Сансаг бүдүүлгээр чангаалаа.

- Явъя эхнэр минь сараалжин хаалтыг чинь цөмлөх цаг болж. Би"Миний шилтгээн рүү орж ир"-ийг тоглохыг хүсч байна.

Царай нь улайсан Санса түүнтэй цуг Бага Танхимаас гарлаа. *Түүнд өөр ямар сонголт байсан гэж?* Тирион ялангуяа түргэн явах үедээ улам ч их майжигнадаг болохоор одоо тэгж байлаа. Бурхдын авралаар Жоффри болоод бусад хүмүүсийн хэн нь ч араас нь дагасангүй.

Тэдний хуримын шөнөд зориулан Гарын өндөр цамхагт уужим өрөө өгчээ. Тирион ардаа хаалга өшиглөн хаалаа.

- Хажуугийн шүүгээн дээр Арборын домбо сайн дарс байна. Чи надад хундагалж өгөхгүй юу?

- Энэ ухаалаг хэрэг гэж үү, эрхэм лорд?

- Юунаас ч ухаалаг биш. Миний тэгтлээ согтоогүй болохыг чи харж байгаа биз дээ. Гэхдээ би согтмоор байна.

Санса өөрсдөдөө зориулан хоёр хундага дүүргэлээ. *Би согтуу байвал энэ хамаагүй амархан өнгөрч магадгүй.* Тэр хагасыг нь татсан том хөшигтэй орны ирмэг дээр суугаад хундагатайгаа удаанаар балгалаа. Сайн дарс нь эргэлзээгүй ч Санса амтыг нь мэдрэхэд дэндүү сэтгэл хөдөлсөн байв. Дарсанд толгой нь эргэлээ.

- Та миний хувцсыг тайлах уу, эзэнтээн?

- Тирион. Миний нэрийг Тирион гэдэг, Санса гээд тэр толгойгоо сэжлээ.

- Тирион. Эрхэм лорд. Би даашинзаа тайлах уу эсвэл та хувцсыг минь тайлахыг хүсч байна уу? гээд Санса ахин нэг дарс балгалаа.

Одой түүнээс эргэв.

- Миний анхны удаа гэрлэлтийн үед согтуу септон, гахайнууд гэрч болсон. Бид хуримын найран дээрээ гэрчүүдийнхээ нэгийг идэж билээ. Тайша надад шарсан мах өгөхөд би хуруунд нь наалдсан тосыг долоож бид ор луугаа инээлдэн унацгаасан.

- Та урьд нь гэрлэж байсан хэрэг үү? Би... би мартчихаж.

- Чи мартаагүй. Чи энэ тухай юу ч мэдэхгүй.

- Тэр хэн байсан юм бэ, эрхэм лорд? гээд Санса сонирхлоо нууж чадсангүй.

- Мөнгөн нударгын овгийн хатагтай Тайша. Тэдний сүлд гарт атгасан ганц алтан зоос юм уу цустай даавуун дээр зуун мөнгөн зоос байдаг. Би маш жижигхэн хүн учраас... бидний гэрлэлт маш богино болсон гэж бодож байна гээд ам нь мурийлаа.

Санса гар луугаа ширтэн юу ч хэлсэнгүй.

- Санса чи хэдэн настай вэ? гэж Тирион хормын дараа асуулаа.

- Сарын дараа арван гурав хүрнэ.

- Бурхад минь өршөөг. Тэгэхээр ярилаа гээд нас чинь нэмэгдэхгүй. Бид хэргээ гүйцэлдүүлэх үү? Энэ чиний сэтгэлд нийцэж байна уу? гээд одой дарснаасаа ахин балгав.

- Лорд нөхрийн минь таалалд нийцэж байгаа бүхэн миний сэтгэлд нийцнэ гэхэд энэ нь түүнийг уурлуулав бололтой.

- Чи шилтгээний хана шиг эелдэг ёсны ард нуугдах юмаа гэв.

- Эелдэг ёс бол хатагтайн хуяг гэж Санса хэллээ. Септа нь үргэлж түүнд ингэж хэлдэг байжээ.

- Би чиний эр нөхөр. Чи одоо хуягаа тайлж болно.

- Хувцсаа ч гэсэн үү?

- Наадхаа ч гэсэн. Миний лорд эцэг надад энэхүү гэрлэлтийг төгс гүйцэтгэхийг тушаасан гээд Тирион дарстай аягаа савчлаа.

Санса чичирсэн гараар хувцсаа тайлж эхлэв. Хуруундынх нь оронд арван эрхий хуруу байгаа юм шиг болж тэд бүгд хугарсан байлаа. Ямартай ч үдээс товчнуудаа тайлж чадахад нөмрөг, даашинз, цээживч нь шалан дээр гулган унахад эцэст нь дотуур хувцан дээгүүрээ алхан гарлаа. Сэрүүн

өрөөнд бие нь жихүүцэн арзайлаа. Тэр Тирион руу харахаас ичин шалнаас харц салгаагүй ч тайлж дууссан хойно урдаас нь ширтэж байхыг ажиглав. Түүний ногоон нүд шунаг байсан бол хар нь хилэнтэй байх шиг санагдав. Санса энэ хоёр нүдний алин түүнийг илүү айлгасныг мэдсэнгүй.

- Чи хүүхдээрээ байна.

- Би эмэгтэй хүний зэрэгт хүрсэн гээд Санса цээжээ гараараа халхаллаа.

- Хүүхэд гэхдээ би чамайг хүсч байна. Энэ чамайг айлгаж байна уу, Санса?

- Тийм.

- Намайг ч гэсэн. Би хичнээн царай муутайгаа мэднэ.

- Үгүй, миний...

- Битгий худал хэл, Санса гээд тэр хөлөө дэвслэв.

- Би зэрэмдэг, сорвитой, жижигхэн ч лаа унтран оронд ороход бусад эр хүнээс дутахгүй. Харанхуйд би Цэцэгт хүлэг баатартай ижилхэн гээд дарсаа хөнтөрснөө,

- Дээрээс нь өгөөмөр. Надад үнэнч хүнд үнэнч ханддаг. Хулчгар биш болохоо баталсан. Хэрвээ ухааныг тооцдог бол би бусдаас илүү ухаантай. Тэр ч байтугай сайхан сэтгэлтэй ч байж чадна. Сайхан сэтгэл Ланнистерийнхны зуршсан зүйл биш ч надад байгааг нь мэдэж байна. Би чамд... би чамд сайн байж чадна гэв.

Тэр надаас дутуугүй айж байна гэж Санса ойлголоо. Магадгүй тэр бас түүнд элэгсэг сэтгэл өвөрлөх ёстой байсан ч тэгсэнгүй. Түүний мэдэрсэн зүйл гэвэл харамсал үхлийг хүссэн харуусал байлаа. Тирион түүн рүү харж ямар нэг зүйл хэлэхийг хүлээхэд бүх үг нь алга болжээ. Санса зөвхөн чичирэн зогслоо.

Тирион эцэст нь түүнийг ямар ч хариу хэлэхгүйг ойлгомогц сүүлчийн дарсаа хөнтөрлөө.

- Би ойлгож байна. Ор луу гар, Санса. Бид үүргээ гүйцэтгэх хэрэгтэй байна гэж гашуунаар хэлэв.

Санса өдөн ор луу гарахад түүний ширтэхийг мэдрэв. Орны хажуугийн ширээн дээр зөгийн лавны анхилуун үнэртэй лаа асааж орны даавуун дээр сарнайн дэлбээ цацжээ. Санса хөнжлөө хучихаар таттал түүний "үгүй" гэж хэлэхийг сонслоо.

Хүйтэнд чичирч байсан ч дагалдлаа. Тэр нүдээ анин хүлээв. Барагцаалбал хормын дараа нөхөр нь гутлаа сугалж, хувцсаа шаржигнуулан тайлах сонсогдов. Тэр ор луу үсрэн гарснаа цээжин дээр нь гараа тавихад Санса өөрийн эрхгүй чичирлээ. Тэр нүдээ аньсан хэвээр бүх биеэ чангалж дараа нь юу болохыг эмээн хүлээлээ. Тэр түүнд ахин хүрэх болов уу? Түүнийг үнсэх болов уу? Тэр одоо түүнд хөлөө дэлгэж өгөх ёстой юм болов уу? Санса түүнээс юу хүлээж байгааг мэдсэнгүй.

- Санса. Нүдээ нээ гээд гар алга боллоо.

Санса дагалдахыг амласан болохоор нүдээ нээв. Тирион хөлнийх нь дэргэд нүцгэн сууж байв. Түүний хөлийн хооронд өтгөн ширүүн шаргал үстэй зүйл хатуу гозойсон нь биенийх нь ганц шулуун зүйл байв.

- Хатагтай та дур булаам нь эргэлзээгүй ч би үүнийг хийж чадахгүй нь. Миний эцгийг хараал идээсэй. Бид хүлээх хэрэгтэй. Сар, жил, улирал өнгөрсөн хамаагүй хэрэгтэй хугацаа хүртэл. Чамайг намайг илүү дээр мэддэг болж жаахан ч гэсэн итгэдэг болох хүртэл гээд итгүүлэн инээмсэглэсэн ч хамаргүй болохоор царай нь зэрэмдэг муухай харагдав.

Түүн рүү хар. Нөхөр болон бүх зүйл рүү нь хар. Септа Мордэйн бүх эр хүн үзэсгэлэнтэй гэж хэлсэн болохоор үзэсгэлэнг нь олж харахыг хичээ гэж Санса өөртөө хэлэв. Тэр богинохон хөл, ширүүн овгор хөмсөг, нэг нь ногоон нөгөө нь хар нүд, хамрынх нь улаан мухар, тахирласан ягаан сорви болон хар шаргал өнгийн ширэлдсэн сахал руу нь харлаа. Эр хүний зүйл нь хүртэл үзэмжгүй бүдүүн судалтай бөндгөр ягаан толгойтой байлаа. *Энэ чинь буруу шударга биш байна. Би яаж бурхдын өмнө үүнийг хийж чадах юм бэ?*

- Би Ланнистерийн нэр хүндээр чамайг хүсэх хүртэл гар хүрэхгүй гэдгээ андгайлж байна гэж одой хэлэв.

Санса үүнд зоригжин нийцээгүй нүд рүү нь ширтлээ.

- Хэрвээ би таныг хэзээ ч хүсэхгүй бол яах вэ? гэхэд,

- Хэзээ ч гэнэ ээ? гээд ам нь алгадуулсан юм шиг татвалзлаа.

Сансагын хүзүү чангарахад үл мэдэг толгой дохив.

- Яагаад. Ийм л учраас бурхад над шиг одойд зориулан янхнуудыг бүтээсэн юм биз дээ гээд Тирион богинохон бүдүүн хуруугаа нударга болгон зангидаж орноос буулаа.

АРЪЯА

Чулуун дуган бол Арьяагын Хааны газраас хойш харсан хамгийн том хот байсан бөгөөд Харвин түүнд эцэг нь энд алдартай тулалдааны ялалт байгуулсан гэж хэлжээ.

- Галзуу хааны хүмүүс Робертийн араас хөөж эцэгтэй чинь нэгдэхээс өмнө барьж авахыг оролдсон юм гэж тэр хаалгаар орох зуураа хүүрнэв.

- Роберт шархдаж нөхдийнхөө заримаар асруулахад Хааны Гар лорд Коннигтон хотыг хүчирхэг цэргээр эзлэн байшин бүрийг эхнээс нь нэгжиж эхэлжээ. Гэвч тэднийг олохоос урд лорд Эддарт өвөөтэй чинь хот руу ирж хэрэм рүү дайрсан юм. Лорд Коннигтон ширүүн эсэргүүцэн тулалдсан. Тэд гудамж явган зам, байшингийн дээвэр хүртэл дамжин тулалдахад септонгууд жирийн ардуудад хаалгаа түгжихийг анхааруулан хонхоо цохьсон. Роберт хонхны дуугаар тулалдаанд оролцохоор нуугдсан газраасаа гарч ирчээ. Түүнийг тэр өдөр зургаан хүн алснаас нэг нь ханхүү Рэйгарын дагуул байсан алдарт хүлэг баатар Майлс Мүүтон байсан гэдэг. Тэр Гарыг ч гэсэн алах байсан ч тулалдаанд хоорондоо тааралдаагүй байна. Коннигтон танай өвөө Таллиг шархдуулж, Хөндийн сэр Денис Арриныг алсан. Гэвч тэр ялагдахаа мэдсэн даруй бамбай дээрх гриффинээсээ ч хурдан улаа гялалзуулан зугтсан. Үүнийг дараа нь Хонхны тулаан гэж нэрлэдэг болсон бөгөөд Роберт үргэлж эцгийг чинь ялсан гэж хэлдэг юм.

Газрын байдлаас үзэхэд саяхан энд тулалдаан болсон бололтой гэж Арьяа бодов. Хотын хаалгыг нойтон модоор хийж хэрмийн гадна талд хуйхлагдсан хуучин дүнзийг нь овоолжээ.

Чулуун сүм хаалттай байсан ч хаалганы ахмад тэдний хэн болохыг таньмагц давст модон хаалтаа өргөв.

- Та нар хоол ундаар ямархуу байна? гэж Том орохдоо асуув.

- Өмнөхөөс муугүй л байна. Анчин сүрэг хонь авчирч, Хар усны цаанаас хэсэг худалдаачин ирсэн. Голын өмнө талын ургац шатаагүй. Мэдээж тэд бидний өгч чадахаас илүүг хүсч байсан. Чононууд нэг өдөр нь ирэхэд, Жүжигчид дараагийн өдөр нь ирсэн. Гэхдээ тэд хоол хүнс, олз омог, хүүхэн, алт эрж яваагүй хараал идсэн Хааны алуурчийг эрж байсан. Түүнийг лорд Эдмурын хурууны завсраас мултарсан гэж ярилцаж байна лээ.

- Лорд Эдмур гэнэ ээ? Лорд Хостер таалал төгссөн хэрэг үү? гээд Лем хөмсөг зангидав.

- Таалал төгссөн юм уу түүний даваан дээр байгаа. Ланнистерийг Хар ус руу гарна гэж бодож байна уу? Энэ бол Хааны газар хүрэх хамгийн дөт зам гэж Анчин хэлсэн гээд ахмад хариу хүлээлгүй,

- Тэр нохдоо авч мөр шиншлүүлэхээр явсан. Хэрвээ сэр Жэйми ойр хавьд байгаа бол тэд түүнийг олно. Би түүний ноход баавгай хэрхэн хүү татахыг харсан. Тэдэнд арслангын цусны амт таалагдана гэж бодож байна уу? гэв.

- Хүү татсан цогцос хэнд ч хэрэггүй. Анчин үүнийг хэнээс ч дутуугүй сайн мэдэж байгаа гэж Лем

ХЭЛЭВ.

- Өрнөдийнхөн ирж Анчины эхнэр, эгчийг хүчиндэж ургацыг нь шатаагаад, сүргийнх нь хагасыг идэж нөгөө хагасыг нь хорон санаагаар хядсан. Зургаан нохдыг нь ч гэсэн алж хүүрийг нь худаг руу хаясан. Хүү татсан цогцос надаас дутуугүй түүний хувьд хангалттай гэж бодож байна.

- Тэр тэгэхгүй байсан нь дээр дээ. Үүнийг л би хэлэх байна. Харин чи дүүрчихсэн тэнэг байна.

Арьяа дээрэмчдийг эцгийнх нь тулалдаж байсан гудамжны дагуу уруудахад Харвин, Энгай хоёрын дунд явлаа. Толгодын орой дээрх сүмийн доод талын саарал чулуун бат бөх бэхлэлт ийм том хотод дэндүү өчүүхэн санагдав. Тэд харласан ханатай гурван ч байшин өнгөрсөн хүмүүс харагдсангүй.

- Хотын бүх хүмүүс үхчихсэн юм уу?

- Үгүй дээ, зүгээр л ичээд байгаа юм гээд Энгай дээвэр дээр байгаа хоёр нумчин болон шар айрагны мухлагны нуранги дунд мөлхөж байгаа тортог болсон нүүртэй хөвгүүдийг заав. Түүнээс цааш явахад талхчин хэмхэрсэн цонх нээж Лемийг дуудав. Түүний дуугаар хүмүүс нуугдсан газраасаа гарч ирэхэд Чулуун дуганы эргэн тойрны амьдрал алгуурхан сэргэлээ.

Хотын төвийн зээлийн талбай дахь үсэрч буй хулд загасны дүрстэй усан оргилуурын гүехэн уснаас эмэгтэйчүүд хувин домбоо дүүргэж байв. Түүнээс хэдэн алхмын зайд чахарсан модон багананд арваад төмөр тор дүүжлээстэй байлаа. *Хэрээний тор* гэж Арьяа танилаа. Гэвч хэрээнүүдийн ихэнхи торны гадна усан оргилуурт ус үсчүүлэх юм уу оройд нь сууж дотор нь хүмүүс байлаа. Лем жолоогоо татан хөмсөг зангидав.

- Энэ чинь одоо юу вэ?

- Шударга ёсны шүүлт гэж усан оргилуурын дэргэд байсан эмэгтэй хэлэв.

- Юу та нар чинь дүүжлүүрийн олсгүй болоо юу?

- Үүнийг сэр Вилбертийн зарлигаар гүйцэтгэсэн хэрэг үү? гэж Том асуухад нэг хүн гашуунаар инээв.

- Арслангууд сэр Вилбертийг жилийн өмнө алсан. Түүний хөвгүүд бүгд өрнө зүг Залуу чонотой явсан. Чи тэднийг бидний төлөө ийм зүйл хийнэ гэж бодож байна уу? Энэ бол Галзуу анчин чононуудыг барьсан хэрэг.

Чононууд. Роббын болон эцгийн маань хүмүүс. Арьяагын дотор хүйт даахад торны зүг эрхгүй татагдав. Торны дотор хоригдол суух юм уу эргэж чадахааргүй давчуу нар салхинд шарагдан бороонд нүдүүлэн зогсохоос өөр замгүй байв. Эхний гурван торонд үхсэн хүмүүс байлаа. Хэрээ тэдний нүдийг ухсан ч хоосон нүдний ухархай нь дагуулж харах мэт санагдана. Арьяаг өнгөрөхөд дөрөв дэх торны хүн хөдлөв. Амных ноорхой сахалд цус наалдан хатаж ялаа шавжээ. Түүнийг үг хэлэхэд ялаанууд үргэн нисч толгойг нь тойрон дүнгэнэлдэв.

- Ус. Гуйж байна... ус өгөөч... гэж сөөнгөтсөн дуу гарахад дэргэдэх торны хүн хоолойных нь чимээгээр нүдээ нээлээ.

- Наашаа. Наашаа над руу гээд тэр буурал сахал, цоохор толботой халзан толгойтой хөгшин хүн байлаа.

Түүний цаана илжирсэн саарал боолтоор шанааныхаа хажуугаар зүүн чихээ тойруулан боосон том улаан сахалтай үхсэн хүн байв. Хамгийн дор нь гэвэл түүний хөлийн хооронд юу ч байхгүй хатсан хүрэн нүхэнд өт мөлхөж байв. Түүний цаана давчуу хэрээний торонд яаж багтсан нь мэдэгдэхгүй тарган хүн байв. Төмөр сараалж гэдсэнд нь өвдтөл шигдэж торны завсар бүлтийн гарчээ. Удаан өдрийн наранд шарагдан хөлөөс толгой хүртэл час улайж жингээ сэлгэн хөдлөхөд торны чахран найгах аясаар Арьяа бие нь наранд түлэгдсэн газар торны цагаан ором гарсныг харлаа.

- Та нар хэний хүмүүс вэ? гэж Арьяа тэднээс асуув.

Чимээгээр тарган хүн нүдээ нээлээ. Тэдний арьс эргэн тойрон цустай тавганд хөвөн гарсан чанасан өндөг шиг хөөн улайжээ.

- Ус... уух юм өгөөч...

- Хэний хүмүүс вэ? гэж тэр ахин асуулаа.

- Тэднийг тоох хэрэггүй, хүү минь. Энэ чиний сэтгэл зовох асуудал биш. Цаашаа яв гэж хотын нэг хүн хэлэв.

- Тэд юу хийсэн юм бэ? гэж Арьяа түүнээс асуулаа.

- Тэд Унаж буй хүрхрээнд найман хүнийг илдээр алсан. Тэд Хааны алуурчийг эрсэн ч тэнд байгаагүй болохоор аллага хүчин хийсэн юм гээд эрхий хуруугаараа гуяны завсар өтсөн цогцос руу заалаа.

- Энэ хүн хүчин хийсэн юм. Одоо явж үз.

- Ганцхан балга ус өгөөч. Өршөө хүү минь, балга ус гэж тарган хүн хэлэв. Өвгөн гараа дээшлүүлэн торны завсраас барихад хөдөлгөөнийх нь аясаар тор хүчтэй санжигнав.

- Ус гэж сахал дээр нь ялаа шавсан хүн дуу алдлаа.

Арьяа тэдний бохир үс, ноорхой сахал, улаан нүд ангаж хатан цус шүүрсэн уруулыг харлаа. *Надтай адилхан чононууд* гэж ахин бодов. Энэ түүний сүрэг гэж үү? *Тэд яаж Роббын хүмүүс байж чадах юм бэ?* Арьяа тэднийг цохиж уйлахыг хүслээ. Тэд амьд үхсэн ялгаагүй бүгд түүн рүү ширтэж байх шиг санагдав. Өвгөн торны завсар гурван хуруугаа чихэв.

- Ус. Ус.

Арьяа мориноосоо буулаа. *Тэд үхэж байгаа болохоор надад гэм хийж чадахгүй.* Арьяа

дэвсгэрийнхээ завсраас аяга авч усан оргилуур луу очлоо.

- Чи өөрийгөө юу хийж байна гэж бодоо вэ, хүү минь? Энэ чиний сэтгэл зовох хэрэг биш гэж нөгөө хүн зандарсан ч Арьяа загасны аманд аягаа тосов. Ус хурууных нь завсар ханцуй руу нь үсэрч байвч Арьяа аяганы амсар дүүртэл хөдөлсөнгүй. Түүнийг торны зүг эргэхэд хотын хүн түүнийг зогсоохоор хөдөллөө.

- Тэднээс хол бай, хүү....

- Тэр охин. Түүнийг орхи гэж Харвин хэлэв.

- Яг тийм. Лорд Берик хүнийг торонд цангаж үхтэл нь хорихгүй. Та нар яагаад тэднийг зүй ёсны дагуу дүүжилсэнгүй вэ? гэж Лем асуув.

- Тэдэнд Хүрхрээнд хийсэн зүйлийнх нь төлөө зүй ёсны хүртэх зүйл байхгүй гэж хотын хүн урдаас нь эсэргүүцлээ.

Торны завсар аяга багтахад дэндүү нарийхан байсан тул Харвин, Жэндри хоёр түүнийг хөлөөс нь өргөлөө. Арьяа хөлөө Харвины гар дээр тавиад Жэндригийн мөрөн дээр тулан торны оройгоос барилаа. Тарган хүн хацраа төмөрт наан царайгаа дээш болгоход Арьяа дээрээс нь ус цутгав. Тэр толгой хацар гарыг нь даган ус урсахад хомхойрон залгиж торны норсон төмрийг долоолоо. Түүнчлэн Арьяаг буцааж татаагүй бол хурууг нь ч гэсэн долоох байв. Түүнийг нөгөө хоёр хүнд бас ус өгөх зуур харахаар хүмүүс цугларчээ.

- Галзуу Анчин үүнийг сонсоно доо. Түүнд энэ таалагдахгүй байх даа гэж нөгөө эр сүрдүүлэв.

- Түүнд энэ бүр ч таалагдахгүй гээд Энгай урт нумаа авч саадагнаасаа сум сугалан хөвчлөн харвалаа. Тарган хүн эрүүнд нь сум зоогдоход чичирсэн ч торны завсар уналгүй тогтов. Ахин сум илгээхэд нөгөө хоёр умардын хүмүүс дуусч зээлийн талбайд зөвхөн ус хоржигнон, ялаа дүнгэнэх чимээ сонсогдоно.

Валар моргулис гэж Арьяа бодлоо.

Зээлийн талбайн баруун талд цагаанаар будсан хана эвдэрхий цонхтой даруухан дэн буудал байлаа. Дээврийнх нь хагас саяхан шатсан ч цоорхойг нь ахин бөглөжээ. Хаалганы дээр том хазсан лийр хэлбэртэй шараар будсан саваа мод байлаа. Тэд жүчээнд уналгаа тавихад Ногоон сахалт морь баригчийг дуудав.

Улаан үс том хөхтэй буудлын эзэгтэй тэднийг хараад баярлан дуу алдаж хөөрхөн чимхэв.

- Энэ чинь Ногоон сахалт уу даа? Эсвэл Буурал сахалт юм уу? Ээж минь өршөө чи чинь хэзээдээ ингэтэл хөгширчихөө вэ? Лем энэ чи юу? Нөгөө ноорхой нөмрөгөө өмссөн хэвээр байна уу? Би чамайг яагаад хэзээ ч угаадаггүй болохыг чинь мэднэ. Чи бүх шээсийг нь угаачихвал Хааны хамгаалалтын хүлэг баатар шиг харагдана гэдгээс айдаг биз дээ! Харин Долоон чавхдаст Том чи бол завхай хөгшин ямаа! Чи хүүгээ эргэхээр ирэв үү? Тэгсэн бол дэндүү хожимдож. Тэр галзуу

Анчинтай хамт явчихсан. Надад түүнийг өөрийнхөө биш гэж битгий л хэлээрэй дээ!

- Түүнд миний хоолой байхгүй гэж Том урдаас нь сулхан эсэргүүцэв.

- Тэгвэл түүнд хамар чинь байгаа. Охидын яриаг сонсоход бусад хэсэг нь ч гэсэн гээд Жэндриг ажигламагц хацрыг нь чимхлээ.

- Энэ залуу чийрэг бухыг хараач. Алис энэ булчинлаг гарыг нь хартал хүлээгээрэй. Хөөх бас охин шиг улайдаг юм байна. Сайн байна Алис наадхыг чинь засаад өгнө өө, хүү минь.

Арьяа хэзээ ч Жэндригийн тэгтэл улайхыг харж байсангүй.

- Танси чи Бухыг чи зүгээр орхи. Тэр сайн залуу байгаа юм. Бидэнд чамаас хэрэгтэй зүйл гэвэл зөвхөн өнөө шөнө аюулгүй ор гэж Долоон чавхдаст Том хэлэв.

- Наадхаа өөртөө л хэл, дуучин минь гээд Энгай өөр шигээ сэвхтэй залуухан зарц охины араас тэврэв.

- Бидэнд ор байгаа. Лийрэнд хэзээ ч ор дэвсгэр дутаж байгаагүй. Гэхдээ та нар эхлээд усанд ороорой. Сүүлчийн удаа манайд хонох үед чинь зөндөө нохой бөөс үлдсэн байсан шүү гээд Ногоон сахалтын цээж рүү ёворлоо.

- Чиний ч гэсэн ногоон бөөс байсан. Та нар хоол идмээр байна уу?

- Хэрвээ чамд байгаа бол бид татгалзахгүй гэж Том найр тавив.

- Би чамд хэзээ байхгүй гэж хэлсэн удаа байгаа юм бэ, Том? Би нөхдөд чинь шарсан хонины мах, чамд хөгшин хатуу харх өгнө. Энэ чиний хүртэхээс хамаагүй илүү зүйл хэдий ч надад гурван удаа дуу дуулж өгвөл зөөлөрч магадгүй. Би үргэлж өрөвчхөн сэтгэлтэй хүн байсан. Алив орцгоо. Касс, Ланна хоёр тогоонд ус халааж надад тэдний хувцсыг тайлахад тусал. Бид үүнийг нь ч гэсэн буцалгах хэрэгтэй байна.

Тэр бүх сүрдүүлгээ сайн хэрэгжүүлэв. Арьяа тэдэнд Боргоцой танхимд хоёр удаа усанд орсноос хойш хоёр долоо хоногийн хугацаа ч өнгөрөөгүй гэж хэлэхийг оролдсон ч улаан үстэй эмэгтэй үүнийг тоосонгүй. Хоёр зарц хүүхэн түүнийг шатны өөд өргөн гаргах зуураа хүү охин эсэхийг нь маргалаа. Тэдний нэг болох Хелли хожиход нөгөөх нь халуун ус авчиран Арьяагын нурууг арьсыг хуу татах шахам ширүүн сойздов. Тэд хатагтай Смолвудын өгсөн бүх хувцсыг хулгайлж Арьяаг Сансагын торон хувцастай хүүхэлдэй шиг болгон хувцаслав. Үүнийг дууссан хойно доош хоол идэхээр буув.

Арьяа нийтийн өрөөнд охины тэнэг хувцастай суухдаа Сирио Форелийн нүдээрээ хар гэснийг саналаа. Эднийх ямар ч буудлаас илүү олон залуу царайлаг хүүхнүүдтэй ажээ. Үдэш болоход Лийр лүү олон эрчүүд орж ирэв. Тэд Томын модон ятгаа даран "Цөөрөмд байгаа зургаан охин"-ыг дуулж байсан нийтийн өрөөнд удаан саатсангүй. Эрчүүлийн нэг шатны өөд хүүхэн авч гарах тоолон эгц хуучин модон гишгүүр чанга чахарч байлаа.

- Би үүнийг янхны газар гэж мөрийцье гэж Арьяа Жэндрид шивнэв.

- Чи янхны газар гэж ямар байдгыг ч мэдэхгүй биз дээ.

- Би мэднэ. Дэн буудал шиг мөртлөө охидтой байдаг юм гэж Арьяа дургүйцэхэд Жэндри ахин улайлаа.

- Тэгвэл чи энд юугаа хийж байгаа юм? Янхны газар бол язгууртан гаралт хатагтайн байх газар биш гэдгийг бүгд мэднэ гэхэд охидын нэг сандал дээр түүний дэргэд суулаа.

- Хэн язгууртан гаралт хатагтай юм? Энэ жижигхэн туранхай охин уу? гээд Арьяа руу харж хөхөрснөө,

- Тэгвэл би хааны охин байна гэв.

- Чи биш гээд Арьяа түүний шоолж байгааг мэдлээ.

- Би байж болно гээд охин мөрөө хавчихад даашинзы мөр нь өрөөсөн тийшээ мултрав.

- Хүмүүс Роберт хааныг тулалдааны өмнө энд нуугдах үедээ миний ээжтэй унтсан гэдэг. Тэр бусад хүүхнүүдтэй ч гэсэн орооцолдсон ч Леслин түүнийг миний ээжид илүү сайн байсан гэсэн.

Охин хөгшин хаантай адилхан өтгөн нүүрс шиг хар үстэй юм гэж Арьяа бодлоо. *Гэхдээ энэ юу ч биш. Жэндри бас ижил үстэй. Ер хүмүүсийн ихэнхи хар үстэй байдаг.*

- Намайг тулалдааны дурсгалд зориулан Белла гэдэг. Би чиний хонхыг ч гэсэн жингэнүүлж чадна гэж бас мөрийцөх байна. Чи үүнийг хүсч байна уу? гэж охин Жэндрид хэлэхэд,

- Үгүй гэж тэр ширүүн дуугарлаа.

- Би чамайг хүсч байна гэж мөрийцөх байна. Би Торос болон аянгат лордын нөхдөөс их хөлс нэхэхгүй гээд тэр гараа Жэндри дээр тавилаа.

- Би үгүй гэж хэлсэн шүү гээд Жэндри ширээнээс огцом босч гадаа гарлаа.

- Тэр охидод дургүй юм уу? гээд Белла Арьяа руу эргэлээ.

- Зүгээр л тэнэг байхгүй юу. Тэр дуулгаа зүлгэж илд алхаар давтах дуртай гээд Арьяа мөрөө хавчлаа.

- Өө гээд Белла даашинзныхаа мөрийг буцаж дээшлүүлээд Азтай Жактай ярихаар явлаа. Төдийлөн удсангүй өвөр дээр нь хөхрөн суугаад аягатай дарснаас нь хөхрөн балгав. Энгай сэвхтэй царайтай хүүхэнтэй алга болж, Лем бас явлаа. Долоон чавхдаст Том галын дэргэд суугаад “Хаврын дэлбээлсэн цэцэг шиг бүсгүй” гэдэг дуу дуулав. Арьяа эзэгтэйн зөвшөөрсөн усаар шингэлсэн дарс шимэх зуураа дуу чагналаа. Талбайн цаана үхсэн хүмүүс хэрээний торонд ялзарч байхад Лийрний дотор бүгд хөгжилтэй байсан бөгөөд зарим нь бүр дэндүү чанга инээж байх шиг

санагдав.

Энэ нь морь хулгайлж зугтахад туйлын тохиромжтой цаг байсан ч Арьяа бүтэх эсэхийг нь мэдсэнгүй. Тэр зөвхөн хотын хаалга руу мордож зүрхлэх байлаа. *Ахмад намайг дэргэдүүрээ өнгөрүүлэхгүй зөвшөөрсөн байлаа гэхэд Харвин юм уу Анчин ноходтойгоо араас ирнэ.* Арьяа газрын зураг нь байсан бол Чулуун дуган Риверранаас хэр алс болохыг мэдэхийг хүслээ.

Энэ зуур аяга нь хоосорч Арьяа эвшээлгэлээ. Жэндри буцаж ирсэнгүй. Долоон чавхдаст Том “Хоёр зүрх ганц шиг цохилно” гэдэг дуу дуулж бадаг болгоныхоо төгсгөлд өөр өөр охиныг үнсэж байв. Булангын цонхон дээр Лем, Харвин хоёр суугаад улаан үстэй Танситай нам дуугаар ярилцана...

- ...Жэймигийн өрөөнд шөнийг өнгөрүүлжээ. Тэр нэг хүүхэнтэй Рэнлиг алсан гэсэн. Тэд гурвуул байгаад өглөө нь хатагтай Кателин гашуудсандаа хайрынхаа төлөө түүнийг сулласан гэсэн гээд эмэгтэй хөхөрлөө.

Энэ үнэн биш. Тэр хэзээ ч ингэхгүй гэж Арьяа бодоход ганцаардал уур хилэн төрөв.

Дэргэд нь ахимаг насны хүн суулаа.

- Энэ чинь харин хөөрхөн бяцхан лийр үү? Миний амтат лийрэнд нэр байна уу? гээд түүний амьсгал үхсэн хүнтэй тор шиг өмхий, дээш доош гүйсэн жижигхэн гахайн нүдтэй байлаа.

Агшин зуур Арьяа хэн болохоо мартлаа. Тэр ямар ч лийр биш ч энд өмхий үнэртэй согтуу хүнтэй байх Арьяа Старк бас биш билээ.

- Би...

- Тэр миний дүү. Түүнийг орхи гээд Жэндри хүнд гараа хижээл хүний мөрөн дээр тавин базлаа.

Тэр маргахаар эргэсэн ч Жэндригийн хэмжээг хармагц арай өөр зүйл бодсон бололтой.

- Чиний дүү гэнэ ээ? Та хоёр ямар төрлийн ах дүү юм? Би хэзээ ч дүүгээ Лийр лүү авчирахгүй байсан гээд сандлаас босч амандаа үгэлсээр шинэ найз хайхаар явлаа.

- Чи яагаад тэгж хэлсэн юм бэ? Чи миний ах биш шүү дээ гээд Арьяа үсрэн бослоо.

- Тийм л дээ. Би өндөр төрөлт хатагтайн төрөл байхад дэндүү дорд гаралтай гэж Жэндри уцаарлав.

- Би ингэж хэлэх гээгүй гэж Арьяа түүний хилэгнэсэн хоолойд балмагдан хэллээ.

- Тиймээ тэгсэн. Эндээс яв. Би дарсаа тайван уумаар байна. Тэгвэл магадгүй хар үстэй охиныг олж хонхыг нь жингэнүүлж магадгүй гээд тэр сандал дээр суун гартаа дарсны аяга атгав.

- Гэхдээ...

- Би чамайг яв гэсэн шүү. Хатагтай минь.

Арьяа түүнийг орхин огцом эргэлээ. *Тэнэг бухын толгойтой бутач хүү.* Тэр хүссэн хонхоо жингэнүүлнэ биз түүнд ямар хамаатай юм.

Унтлагын өрөө шатны дээд талд саравчны дор байлаа. Лийрэнд ор дэвсгэр хүрэлцэхгүйгээс болсон уу зөвхөн ганц том ор байв. Шалан дээр бүгд багтахуйц том хуучирсан сүрлэн дэвсгэр дэвсчээ. Одоохондоо Арьяа ганцаар байв. Тэр хувцсаа ханын дэгээнд Жэндри, Лемийн хоёрын юман дунд өлгөөд цамцныхаа үдээсийг тайлж толгой дээгүүрээ давуулан ор луу мөлхөн орж хөнжил дор шургав.

- Хатан Серсей. Хаан Жоффри. Сэр Илин, сэр Мерин, Дансен, Рафф, Поливер, Гижигдэгч, Хоточ, Уул сэр Грегор гэж дэрэндээ шивнэв. Тэр заримдаа нэрсийн байрыг солих дуртай байлаа. Энэ нь тэдний хэн болох юу хийснийг нь сануулахад туслана. *Тэдний зарим үхсэн ч байж болох юм. Магадгүй хаа нэгтээ төмөр торонд өмхөрч хэрээ нүдийг нь тоншиж байгаа байх* гэж бодлоо.

Нойр нь түргэн хүрэхэд нүдээ анив. Арьяа тэр шөнө чононуудыг зүүдэлж борооны үнэртэй нойтон ой дундуур тэнүүчилэн ялзарсан навч, цусны үнэр агаарт ханхална. Энэ нь зүүдэнд сайхан үнэр болохоор айх зүйл юу ч үгүй байлаа. Тэр хүчтэй хурдан догшин ах дүүс болох сүрэг нь хүрээлж байв. Тэд айсан морины араас гүйцэж хоолойг нь хага татан найрлав. Тэгтэл сар үүлний цаагуур далд ормогц Арьяа толгойгоо өргөн улилаа.

Гэвч гэгээ ороход нохдын хуцах дуунаар сэржээ.

Арьяа өндийн суугаад эвшээлээ. Жэндри зүүн талд нь хөдлөн, Шаргал нөмрөгт Лем баруун талд нь чанга хурхирч байсан ч гадаа хуцах дуу чимээг нь дарлаа. *Энд хагас зуугаас доошгүй ноход байгаа байх.* Арьяа хөнжлийн дороос шурган гарч Лем, Том, Азтай Жакийн дээгүүр догонцон цонх руу явлаа. Цонхонд хүрмэгц хаалтыг нь том нээхэд чийгтэй хүйтэн салхи урсан орж ирэв. Бүрхэг үүлтэй өдөр байв. Дор талбайд ноход дугуйран гүйлдэж хуцан архирч гийнана. Тэд сүргээрээ байсан бөгөөд том хар мастиф, туранхай хоточ нохой, хар цагаан өнгийн хоньч ноход болон Арьяагын мэдэхгүй урт шаргал шүдтэй сэгсгэр алаг нохой байлаа. Буудал усан оргилуурын дунд арваад морьтон морин дээрээ суугаад нутгийн хүн тарган хүний торыг онгойлгон хөөсөн цогцсыг газарт татан унагахыг харна. Ноход түүн рүү даруй ухасхийн биеийг нь яснаас хүүчин идлээ.

Арьяа морьтонгуудын нэг инээд алдахыг сонсов.

- Энэ чиний шинэ шилтгээн байна даа, хараал идсэн Ланнистер минь. Чамд тохь тух багатай ч санаа зовох хэрэггүй бид чихээд багтаана гэхэд түүний дэргэд олсоор бугуйг нь чанга хүлсэн дүнсгэр хоригдол сууж байв. Хотын хүмүүс түүн рүү шивх шидэхэд дальдирсангүй.

- Чи энэ торонд ялзрах болно доо. Бид чиний Ланнистерийн алтыг чинь үрж байх хооронд хэрээ нүдийг чинь тоншино. Хэрээ тоншиж дууссан хойно биенээс чинь үлдсэн зүйлийг дүү рүү чинь илгээх болно. Түүнийг чамайг танина гэдэгт эргэлзэхгүй байна гэж олзлогч хашгирав.

Чимээ шуугиан Лийрний хагасыг сэрээлээ. Жэндри Арьяагын дэргэд цонхоор чихэн харахад Том ард нь нүцгэн босч ирэв.

- Юу гээчийн шуугиан болоод байна? Хамаг нойр хулгайлчихлаа гэж Лем орноосоо гомдоллов.

- Ногоон сахалт хаана байна? гэж Том түүнээс асуулаа.

- Танситай унтаж байгаа. Яасан?

- Түүнийг олсон чинь дээр. Харваачийг ч гэсэн. Галзуу Анчин торонд хорих өөр нэг хүнтэй эргэн ирж.

- Ланнистер. Би түүнийг Ланистер гэж хэлэхийг нь сонссон гэж Арьяа хэллээ.

- Тэр Хааны алуурчийг бариа юу? гэж Жэндри мэдэхийг хүслээ.

Дор талбайд баригдсан хүн хацрыг нь чулуу оноход толгойгоо нааш эргүүлэв. *Хааны алуурч биш байна* гэж Арьяа царайг нь хараад бодлоо. Бурхад түүний мөргөлийг эцсийн эцэст сонсчээ.

ЖОН

Зэрлэгүүдийг агуйгаас морио хөтлөн гарч ирэхэд Сүнс явсан байлаа. *Тэр Хар цамхагын тухай ойлгосон болов уу?* Жон өглөөний жихүүн агаарт найдан амьсгал авлаа. Дорно зүгт тэнгэрийн хаяа ягаарч цайвар саарал үүрийн гэгээ оржээ. Өглөөний илд өмнө зүг түгсэн хэвээр бариулын тод өнгийн цагаан од үүрийн гэгээнд алмааз шиг гялалзахад бараантан харанхуйлах саарал ой ногоорсноо аажмаар алтлаг, улаан шаргал боллоо. Нарс, царс, яшил, харуул модны орой дээгүүр Хана өндийн сүндэрлэж тоос шороонд будагдсан гадаргууны дор цайвар мөс гялалзана.

Магнар өндөр толгод дээр гарч эргүүлүүдийн ойгоос гарч ирэх юм уу Ханан дээр харуул байгаа эсэхийг харуулдуулахаар баруун болон зүүн зүгт арав арван хүн илгээжээ. Харуулууд үзэгдсэн тохиолдолд Тэннийнхэн хүрэл туузтай дайны бүрээ үлээх ёстой байлаа. Үлдсэн зэрлэгүүд Жарл, Жон, Игрит нартай хамт хоцорчээ. Залуу морьтоны хувьд алдрын мөч байв.

Ханыг долоон зуун футын өндөр гэж хэлдэг ч Жарл үүнээс хоёр дахин өндрийн зэрэгцээ намхан газар олжээ. Тэдний өмнө модны оройд мөс нүсэр цохио шиг өлийж салхинд идэгдсэн хэрмийн орой нь найман зуугаас багагүй есөн зуун фут өндөр байлаа. Гэвч энэ нь хуурамч болохыг Жон ойртохдоо мэдлээ. Брандон Баригч аварга том мөсөн суурийг эндхийн эгц өндөр толгодод түшиглэн байгуулжээ.

Жон урьд нь авга ах Бэнжинийхээ Хана дорно зүг Хар цамхагаас илд ч өрнө зүгээс бол могой гэж хэлэхийг сонсож байжээ. Энэ нь үнэн байв. Хана хөндий руу уруудсан бөгтөр том толгод дээр шовх нуруу дамжин байрлаж хутганы ирмэг шиг урт боржин хярын дагуу бээрийн зайтай үргэлжилснээ ахин хөндий рүү доош гүнзгий бууж толгодоос толгод дамжин өгссөөр нүдний хараа үл хүрэх алсад уулархаг өрнө зүг үргэлжилжээ.

Жарл дайралт хийх газраа хярын дагуу сунасан мөснөөс эхлэхээр сонгожээ. Энэ нь Ханын орой модноос найман зуун фут өндөр сунаж, газраас гурав дахин өндөр бөгөөд мөснөөс илүү чулуурхаг газар байлаа. Налууны дагуу морьтой өгсөхөд дэндүү эгц авирахад Анхны хүмүүсийн нударганаас дутуугүй хүнд ч өргөн тал нь Ханын эгц нүүр лүү авирахад хялбар ажээ. Дээрээс нь хярын өтгөн ургасан модон дунд далдлагдахад амархан байв. Эрт цагт хар ахан дүүс өдөр бүр сүх барин Ханын ойролцоо ургасан модыг огтолдог байсан ч тэр үеэс хойш урт хугацаа өнгөрсөн тул ой мөс рүү өгсөн ургажээ.

Чийгтэй хүйтэн өдөр байсан бөгөөд Хана руу ойртох тусам олон тонн мөсний ёроол улам чийгтэй хүйтэн байв. Тэднийг ойртож очиход Тэннийнхэн арагш ухрав. *Зөвхөн Магнар ч биш тэд урьд нь хэзээ ч Ханыг харж байгаагүй юм байна. Энэ нь тэднийг айлгаж байна* гэж Жон ойлголоо. Долоон ханлигт Ханыг ертөнцийн хязгаар гэж ярьцгаадаг. *Энэ тэдний хувьд ч гэсэн үнэн.* Бүх зүйл зөвхөн хаана зогсож байгаагаас хамаарна.

Харин тэр аль талд нь зогсож байгаа вэ? Жон үүнийг мэдсэнгүй. Игриттэй үлдэхийн тулд тэр зэрлэгүүдийн зүрх сэтгэлтэй байх хэрэгтэй. Хэрвээ тэр Игритийг орхин үүргээ биелүүлэхээр буцвал Магнар зүрхийг нь сугалж болох байв. Хэдийгээр үүнд итгэлгүй байгаа ч өөртэйгээ явахыг ятгаж чадлаа гэхэд Хар цамхаг руу авчирч ахан дүүстэйгээ амьдрах арга байхгүй. Оргон зайлагч

болон зэрлэгийг долоон ханлигийн хаана ч таатай угтахгүй нь лавтай. *Бид Женделийн хүүхдүүдийг эрэхээр явж болох юм. Тэд биднийг идэхээс илүү талдаа авах дуртай байх.*

Гэсэн ч Хана Жарлын морьтонгуудыг зүрхшээлгэсэнгүй болохыг Жон харлаа. *Тэд бүгд урьд нь үүгээр давж байсан.* Жарл нэр дуудахад тэд хярын дор мориноосоо буун арван нэгэн хүн тойрон цугларав. Бүгд залуучууд байлаа. Хамгийн ахмад нь хорин таваас хэтрэхгүй хамгийн бага нь Жоноос ч хоёр насаар дүү байв. Тэд бүгд туранхай чанга биетэй шөрмөслөг булчин нь Харжигнуур хуягт араас нь хөөж агнах үед Корины уул руу явган явуулсан Чулуун могойг санагдуулна.

Ханын сүүдэрт зэрлэгүүд авирахад бэлтгэн боодолтой зузаан олс цээжээрээ оруулан мөрөндөө үүрч, согооны арьсан зөөлөн этгээд гутал үдэв. Гутлын ул хадаастай бөгөөд Жарл болон хоёр хүнийх төмөр байсан бол, зарим нь хүрэл ихэнхи нь шовх үзүүртэй ястай байлаа. Тэд ташааныхаа нэг талаас жижигхэн чулуун толгойтой алх дүүжилж, нөгөө талд нь гадастай ширэн хүүдий зүүв. Мөсний сүхийг үзүүрийг нь шовхолсон бугын эврээр хийж модон бариулд нь ширэн гогцоо углажээ. Арван нэгэн авирагч дөрвөн хүнтэй гурван баг болон хуваагдахад Жарл арван хоёр дахь хүн нь боллоо.

- Манс орой дээр түрүүлж гарсан багийн бүх хүмүүст илд өгөхийг амласан. Цайзад давтаж хийсэн өмнөдийн жинхэнэ сэлэм. Дээрээс нь алдар нэрийг чинь магтсан дуу зохионо. Чөлөөт хүнд өөр юу хэрэгтэй гэж? Дээшээ гарцгаа. Өөрүүд хоцорсон хүнийг аваасай! гэж Жарл хүйтэн агаарт амьсгалаасаа уур савсуулан хэлэв.

Өөрүүд тэднийг бүгдийг аваасай гэж Жон тэднийг хярын эгц налуу руу авирч эхлэн модон дунд алга болохыг хараад бодов. Энэ бол зэрлэгүүдийн анх удаа Хана руу авирч байгаа хэрэг биш зуу дахь нь ч биш байлаа. Харуулууд жилд хоёр гурван удаа тиймэрхүү авирагчийг барьж аван эргүүлүүд үе үе унаж үхсэн хүний цогцос олно. Дорнод эргийн зэрлэгүүд ихэвчилэн завь дархалж Далайн хавны буланг гатлахыг оролддог байлаа. Харин баруун зүгт тэд Сүүдэрт цамхагын дэргэдүүр өнгөрөхийн тулд Горгын харанхуй гүн рүү орно. Эдний дунд Ханыг зөвхөн дээгүүр нь давж гардаг учир олон хүн оролджээ. Үүнээс хэдхэн нь буцаж ирсэн гэж Жон дүнсгэр бахархан бодов. Зэрлэгүүд морьдоо ханын цаана орхидог болохоор залуухан шинэхэн морьтонгууд нь голцуу тааралдсан эхний морио авна. Тэгтэл чимээ шуугиан дэгдэж хэрээ нисэхэд Шөнийн харуулынхан голцуу тэднийг дээрэмдсэн олз омог, хулгайлсан эмэгтэйтэйгээ буцахаас өмнө барьж аван дүүжилдэг байлаа. Жарл тийм алдаа хийхгүй гэдгийг Жон мэдэж байсан ч Стир яахыг нь мэдсэнгүй. *Магнар толгойлогч болохоос биш морьтон биш. Тэр энэ тоглоомыг яаж тоглохыг мэдэхгүй байж болох юм.*

- Тэд тэнд байна гэж Игрит хэлэхэд Жон анхны авирагч модон дээр гарч ирэхийг харлаа. Энэ нь Жарл байв. Тэр Хана руу налсан харуул мод олж түргэн эхлэхийн тулд хүмүүсээ их бие рүү нь дагуулан авирчээ. Ой ийм ойрхон байх ёсгүй байсан юм. Тэд гурван зуун фут авирсан ч мөсөнд хараахан хүрэхгүй байсан.

Жон зэрлэг хэрхэн модноос Хана руу дамжин болгоомжтой гарч мөсний сүхээрээ тулгуур цавчилан зүүгдэн авирахыг харлаа. Бүсэлхийндээ бэхэлсэн аргамжаатай олсноос холбоотой хоёр

дахь хүн модны захад суусан хэвээр байв. Жарл алхам алхмаар хадаастай гутлаа зоосоор өндөрт гарлаа. Тэр харуул модноос арван фут өндөр гармагц нарийхан мөсөн буланд зогсоод сүхээ бүсэндээ хавчуулж алхаа сугалаад хаданд төмөр гадас зоолоо. Хоёр дахь хүн араас нь Хана руу гарч очиход гурав дахь нь модны оройгоос мацав.

Нөгөө хоёр багт дээшээ авирах тохиромжтой мод байгаагүй тул Тэннийнхэн тэднийг авирах газраа олсонгүй гэж бодож байтал Жарлын хэсэг Хананд наян фут өндөр хүрсэн хойно бусад бүлгүүд гарч ирэв. Тэд хоорондоо хорин ярдын фут зай барин явлаа. Жарл дөрвөн хүнтэйгээ голд нь оржээ. Тэдний баруун талд урт цайвар гэгээр нь дороос хялбархан таньж болох Ямаа Григгийн баг авирч байлаа. Харин зүүн талд нь Эррок гэдэг туранхай хүн авирагчдийг тэргүүлж байв.

- Дэндүү удаан байна. Тэр хэрээнүүдийг мартсан юм болов уу? Биднийг илрүүлэхээс өмнө түргэн авирах ёстой байсан юм гэж Магнар тэдний ирмэг рүү өгссөн замыг харж чанга гомдоллов.

Жон үг дуугарсангүй тэслээ. Тэр сарны гэрэлд Чулуун могойтой авирсан Хашгираа давааг сайн санаж байв. Тэгэхэд хөл гар нь чилж хуруунууд нь бээрэн бадайрахад хэдэн ч удаа зүрх алдсан билээ. Тэгээд ч тэр бол мөс биш чулуу байсан. Чулуу бол хатуу. Мөс осолтой гулгамтгай бөгөөд иймэрхүү Хана уйлсан өдөр авирагчдийн дулаахан гарт дороо хайлна. Том мөсөн хавтан дотроо чулуу шиг хатуу ч гадна талдаа ус гоожсон гулгамтгай, агаар нэвтэрсэн хэсгээр мөсөнд сэмэрсэн цоорхой гарсан байна. Зэрлэгүүд ямар ч байсан зоригтой юм.

Гэсэн ч Жон Стирийн айдсыг батлагдах байх гэж найдлаа. *Хэрвээ бурхад ивээвэл харуулууд ирж бүгдийг таслан зогсооно.*

- Ямар ч хана чамайг аюулгүй байлгаж чадахгүй. Хана зөвхөн хүн хамгаалж байгаа үед хүчтэй байдаг юм гэж эцэг нь урьд Винтерфеллийн хэрмэн дээгүүр алхаж байхад хэлжээ. Зэрлэгүүд зуун хорин хүнтэй байсан ч дөрвөн хамгаалагч байхад тэднийг сайн онилсон сум, чулууны хүчээр буцааж чадна.

Гэсэн ч дөрөв байтугай нэг ч хамгаалагч үзэгдсэнгүй. Зэрлэгүүдийг Хананд гарахад нар тэнгэрт хөөрлөө. Жарлын дөрвөн хүн үд дунд гэхэд бусдыгаа тэргүүлэн хэврэгхэн мөстэй газар хүрлээ. Жарл салхинд идэгдсэн шовх мөсөнд биеийнхээ жинг дэмнэн олс бэхэлтэл гэнэтхийн тасхийн хугарч унахдаа түүнийг доош хамт унагалаа. Үлдсэн гурван хүний дээрээс хүний толгойн чинээ хэмжээтэй мөсний хэлтэрхий нурахад гадас бэхэлсэн газраасаа зууран тэссэнд Жарл олсны үзүүрт дүүжлэгдэн тогтов.

Тэднийг авиралтаа сэргээх зуур Ямаа Григг бараг л зэрэгцэн ирлээ. Эррокийн дөрвөн хүн ард хэвээр байлаа. Тэдний авирч байгаа гадаргуу гөлгөр өө сэвгүй наранд хайлсан нойтон мөс гялтагнана. Григгийн хэсэг илүү бараан байсан бөгөөд давхарласан хавтангийн урт хөндлөн ирмэг уулзсан газар нар салхинд идэгдэн хүн нуугдаж болмоор том нүх үүсчээ.

Жарл удалгүй хүмүүстэйгээ ахин авирлаа. Түүний дөрвөн хүн Григгийнхтэй зэрэгцэн ирэхэд Эррокийн хүмүүс тавин футын дор байлаа. Бугын эвэр сүх цавчин хэлтлэх аясаар гялтагнсан мөсний хэлтэрхий мод руу бутарна. Чулуун алхаар мөсөнд гүн гадас зоох тул тэднийг замынхаа

хагаст орохын урд төмөр гадас дууссанд дараа нь авирагчид эвэр болон хурцалсан яс ашиглах болжээ. Дээрээс нь хатуу мөсөнд тулгуур олохын тулд хадаастай гутлаараа амсхийх завгүй өшиглөнө. *Тэдний хөл нь хөшиж байгаа байх. Тэд хэр удаан ингэж тэсэх бол?* гэж Жон хэдэн цагийн дараа бодов. Тэр алсад Тэннийн дайны дун үлээх чимээ сонсогдохыг хүлээн Магнараас дутуугүй байж ядаж байлаа. Гэвч бүрээ чимээгүй байж Шөнийн харуулын бараа харагдсангүй.

Гурван цагийн дараа Жарл Ямаа Григгийг ахин гүйцэж тэдний хоорондын зай өргөслөө.

- Мансын тэжээвэр илд хүсч байна гэж Магнар нүдээ гараараа саравчлан хэлэв. Нар тэнгэрт өндөр хөөрч Ханын дээд талын гуравны нэг хэсэг болор шиг цэнхэртэн нүд өвтгөм хурц гялалзана. Жарлын дөрвөн хүн, Григгийнхтэй мөсний гялбаанд далд ороход Эрркийн баг сүүдэрт хэвээр байлаа. Тэд дээш авирахын оронд таван зуун фут хажуу тийш сунасан ирмэг даган явлаа. Жон тэднийг инч инчээр ахихыг дагуулан харж байтал гэнэтхэн мөс тасхийн цуурах чимээ сонсогдоход түгшсэн хашгиралт гарлаа. Тэгтэл агаарт бутарсан мөсний хэлтэрхий дүүрч хүн хашгиран унахад мөсний гадаргуунаас фут зузаан тавин фут өргөн дөрвөлжин талбай ховхрон цуурснаа чахран дороо байсан бүхнийг хаман нурахад хярын хөлд хүртэл мөсний хэлтэрхий модон дундуур эргэлдэн налууны уруу унав. Жон Игритийг татан хамгаалан татахад, Тэннийн хүмүүсийн нэг царайгаа мөсөнд цохиулж хамар нь хугарлаа.

Тэднийг дээшээ харахад Жарлын багийнхан хүн, олс, гадас юутай хээтэйгээ алга болж зургаан зуун футын өндөрт юу ч үлдсэнгүй. Тэдний хормын өмнө Хананд байсан газар гүнзгий хонхорхой үүсч толигор цагаан гантиг шиг мөс наранд гялалзаж түүнээс доохон хэн нэгэн унахдаа мөсний ирмэгт цохиулсан газар бүдэг улаан толбо сүүмэлзэнэ.

Хана өөрийгөө хамгаалж байна гэж Жон бодоод Игритийг хөл дээр нь татаж босгов.

Тэд Жарлыг модны хугарсан мөчирт зоогдон дор нь олсонд хэлхээтэй гурван хүн дарагдсан байхыг олов. Нэг нь амьд байсан ч хөл, нуруу болон хавирганых нь ихэнхи хугарчээ.

- Өршөө гэж тэднийг дэргэд нь очиход ёолоход Тэннийхны нэг том чулуун бороохойгоор толгойг нь бяц цохилоо. Үлдсэн хүмүүс Магнарын тушаалаар түүдгийн шатаах мод өрдөв.

Үрэгдсэн хүмүүсийг шатаах үед Ямаа Григг Ханын оройд хүрлээ. Эррокийн дөрвөн хүн тэдэнтэй нэгдэх зуур Жарлын багийнхнаас түлэгдсэн яс, үнснээс өөр зүйл үлдсэнгүй.

Нар шингэж байсан учир авирагчид цаг гарзадсангүй. Тэд цээжиндээ үүрсэн багласан олсныхоо гогцоог задлан нийлүүлэн уяж нөгөө үзүүрийг нь доош шидлээ. Таван зуун футын өндөрт олсоор авирах явдал Жоны сэтгэлийг баярлуулсангүй ч Манс арай илүү зүйл төлөвлөжээ. Жарлын морьтонгууд хүний гарын чинээ бүдүүн зангидсан шат орхисныг олсны үзүүрт уялаа. Эррок, Григгийн хүмүүс түүнийг дээш татаж гадсанд зоогоод хоёр дахь шатыг татахаар олсыг ахин буулгав. Тэдэнд нийт таван шат байв.

Шат бүгд байраа эзлэхэд Магнар хуучны хэлээр хашгиран тушаал өгч Тэннийн таван хүн хамтдаа дээш өгслөө. Шаттай байхад хүртэл авирахад хялбар байсангүй. Игрит тэдний араас харж байснаа,

- Би Ханыг үзэн ядаж байна. Чи ямар хүйтэн болохыг нь мэдэрч байна уу? гэж уурласан хоолойгоор хэлэв.

- Мөсөөр хийсэн юм чинь гэж Жон хэллээ.

- Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Энэ ханыг цусаар хийсэн.

Үүнийг даваадуулж хэлсэнгүй. Нар жаргахад Тэннийн хоёр хүн шатнаас унаж үхсэн ч тэд эцэст нь гарлаа. Шөнө дунд болохын алдад Жон ханын оройд хүрэв. Тэнгэрт од түгэхэд Игрит айсандаа болоод авиралтаасаа чичирч байв.

- Би хоёр гурван удаа золтой унасангүй. Хана намайг сэгсэрч унагаахыг оролдсон. Би үүнийг мэдэрсэн гэж нүдэндээ нулимс цийлэгнүүлэн хэлэхэд дусал нулимс хацрыг нь даган удаанаар бөмбөрлөө.

- Муу зүйл ард үлдсэн. Айх хэрэггүй гэж Жон зоригжуулахыг хичээн гараа мөрөн дээр нь тавихад Игрит цээжийг нь гараараа маш хүчтэй түлхсэнд ноос ширэн хувцас нэвт доргив.

- Би айгаагүй. Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу.

- Тэгвэл яагаад уйлж байгаа юм бэ?

- Айсандаа бишээ! гээд тэр өсгийгөөрөө мөс бутартал чанга дэвслэв. - Бид хэзээ ч Өвлийн бүрээг олоогүй учир уйлсан юм. Бид зуугаад булш ухаж бүх сүнсийг нь ертөнцөд чөлөөлсөн ч энэ хүйтэн мөсийг чинь нураах Жорамуны бүрээг олоогүй!

ЖЭЙМИ

Түүний гар халуу шатан өвдөв.

Тэд цустай шархыг нь бамбараар төөнөн унтрааснаас хойш хэдэн өдөр өнгөрсөн ч тэр гал түлэхийг мэдэрсэн хэвээр хуруугүй атлаа хуруунууд нь тарчилан сарвалзаж байлаа.

Жэйми урьд нь шархдаж байсан ч ийм байсангүй. Тэр хэзээ ч ийм өвдөлт мэдэрч байгаагүй билээ. Заримдаа гэнэтхэн аманд нь хүүхэд байхдаа сурсан Серсейтэй анх Кастерли Рокийн сүмд анх сөхрөн уншсан мартагдсан залбирал орж ирнэ. Тэр ч байтугай уйлж унжихад Жүжигчид тачигнатал шоолон инээлджээ. Тэгэхээр нь Жэйми зүрх нь үхэж нүдээ хуурай байлган биенийх нь халуун нулимсыг нь хатаагаасай гэж мөргөх болжээ. *Одоо л би Тирионы үргэлж хүмүүс шоолон инээлдэхэд ямар байдгийг мэдэж байна.*

Түүнийг хоёр дахь удаагаа эмээлээсээ унасны дараа Тартын Бриентэй холбон хүлж ахин нэг морь хуваалцан унах болжээ. Нэг өдөр тэднийг шилэн хүзүүгээр нь биш царайг нь урд урдаас нь харуулан хүлэв.

- Дурлалт хос ямар сайхан харагдаж байна гээч. Сайн хүлэг баатрыг хатагтайгаас нь салгах нь хэрцгий хэрэг болно гэж Шагвелл чанга хэлээд чих дөжрөм хөхөрч,

- Гэхдээ тэдний аль нь хүлэг баатар аль нь хатагтай бол? гэжээ.

Хэрвээ надад гар минь байсан бол чи удахгүй үүнийхээ хариуг амсах байсан даа гэж Жэйми бодлоо. Түүний гар хөл олсонд хүлээстэй чилж байсан ч тоосонгүй. Ертөнц хий үзэгдэл гарынх нь өвчин шаналалд жижигэрч Бриен урдаас нь наалджээ. *Тэр ядахдаа л дулаахан юм* гэж өөрийгөө тайвшируулахад хүүхний амьсгал өөрийнхөөс нь дутахгүй өмхий байлаа.

Түүний цавчуулсан гар үргэлж тэдний дунд байв. Өрзвик үүнийг хүзүүнд нь уяагаар оосорлож зүүсэн нь цээж рүү унжиж Жэймиг ухаан алдан унахад Бриенигийн цээжийг нүднэ. Жэймигийн баруун нүд хавдаж тагларан Бриентэй тулалдахад олсон шарх нь үрэвсэж өвдөж байсан ч гар нь хамгаас дор зовоож байлаа. Цавчуулсан гарынх нь угнаас цус идээ бээр шүүрч морины явдал тутамд байхгүй гар нь хатгуулан өвдөнө.

Хоолой нь юм идэж чадахааргүй шархалсан учир тэднийг дарс, ус гээд өгсөн бүгдийг ууж байлаа. Нэг удаа тэдний өгсөн аягатайг нэг амиар ёроолыг нь хөнтрөхөд Зоригт нөхөд чихийг нь янгинатал чанга инээлджээ.

- Наад чиний уусан зүйл чинь морины шээс, хааны алуурчаа гэж Рог түүнд хэлэв. Жэйми цангасандаа болоод анзааралгүй уусан ч дараа нь бүгдийг нь бөөлжин гаргажээ. Тэд Бриенигээр сахалд нь наалдсан бөөлжсийг угаалгаж эмээл дээрээ бие засахад нь цэвэрлүүлж байлаа.

Нэг чийгтэй хүйтэн өглөө Жэйми ялимгүй сэхээ ороход зүүн гараараа Дорнишийн хүний хуйнаас илдийг нь сугалах ухаангүй бодол төрөв. Тэд намайг алж л байг. *Би ямар ч байсан гартаа илдтэй тулаанд үхнэ* гэж бодлоо. Гэвч энэ бүтсэнгүй. Шагвелл Жэймигийн цавчилтаас өрөөсөн

хөл дээрээ ээлжлэн догонцон шалмаг бултав. Тэр тэнцвэрээ алдан урагш гуйвахдаа илдээ савчин тэнэгийг хамаг байдгаараа цавчсан ч Шагвелл эргэлдэн бултаад Жүжигчид Жэймигийн бүтэлгүй цавчилт бүрт хөхрөн инээлдэж байлаа. Эцэст нь Жэйми чулуунд бүдрэн өвдгөөрөө унахад тэнэг үсрэн ирж толгойных нь орой дээр шовхийтэл үнсжээ.

Рог түүнийг хойш болгож Жэймигийн сулхан атгасан хуруунаас илдийг өшиглөн холдуулав.

- Наадах чинь хөгжилтэй байлаа, хааны алуурчаа. Гэхдээ чи ахиж ийм зүйл хийхийг оролдвол би нөгөө гарыг чинь юм уу хөлийг чинь цавчина гэж Варго Хот хэлэв.

Жэйми дараа нь нуруугаараа арагш налан хэвтээд шөнийн тэнгэрийг харж хөдлөх тоолон өвчин мушгирах баруун гарынхаа өвдөлтийг тоохгүй байхыг оролдов. Тэр шөнө хачин үзэсгэлэнтэй байлаа. Гоолиг хавирган саран мандаж хэзээ ч ийм олон од хараагүй мэт санагдана. Хааны титэм оройд байрлаж, Азарга цоройн, Хун хөвж байна. Сарны охин үргэлжид байдаг шигээ ичингүйрэн нарсны ард нуугджээ. *Шөнө яаж ийм үзэсгэлэнтэй байж болох юм бэ? Яагаад одод над шиг ийм амьтан руу доош ширтэнэ вэ?* хэмээн өөрөөсөө асуулаа.

- Жэйми. Чи юу хийж байна? гэж Бриен зүүдэлж байгаа мэт сулхан дуугаар шивнэлээ.

- Үхэж байна гэж тэр хариу шивнэв.

- Үгүй чи амьд гарах ёстой.

- Наад үгээ хэлэхээ больж үз, бүсгүй минь. Би баяртайгаар үхэх байна гээд Жэйми инээхийг хүслээ.

- Чи ийм хулчгар байсан юм уу?

Энэ үг түүнийг цочирдуулав. Тэр Хааны хамгаалалтын хүлэг баатар Жэйми Ланнистерийн зэрэгцээ Хааны алуурч байлаа. Ямар ч хүн түүнийг хулчгар гэж дуудаж байгаагүй. Харин өөр зүйл болох амлалтаа зөрчигч, худалч, алуурчин гэж дууддаг байв. Түүнчлэн хэрцгий, итгэл эвдэгч, хөнгөмсөг гэж хэлдэг байсан ч хэзээ ч хулчгар гэж хэлж байсангүй.

- Би үхэхээс өөр юу хийж чадна гэж?

- Амьд гар. Амьдарч тулалдан өшөөгөө ав гээд Бриен дэндүү чанга хэлчихлээ. Рог түүний хоолойг сонсоод үгийг нь ойлгоогүй ч ирж өшиглөн хэлтэйгээ үлдэхийг хүсч байгаа бол амаа хамхи хэмээн хашгирав.

Хулчгар. Ийм байж болох уу? Тэд миний илд барьдаг гарыг авсан. Би зөвхөн илд барьдаг гар байсан гэж үү? Бурхад минь энэ үнэн үү? гэж Жэйми Бриенигийн бөглүү ёолох дуунд бодлоо.

Хүүхний зөв байв. Тэр үхэж болохгүй. Серсей түүнийг хүлээж байгаа. Түүнд тэр хэрэгтэй байгаа. Дээрээс нь дүү Тирион нь түүний худал үгэнд хайртай. Үүний зэрэгцээ дайснууд нь болох Шивнэдэг ойд дийлж хүмүүсийг нь алсан Залуу чоно, харанхуй гянданд гинжилсэн Эдмур Талли болон эдгээр Зоригт нөхөд хүлээж байгаа.

Өглөө нь Жэйми хүчлэн юм идэв. Тэд түүнд морины хоол болох овъёосны нухаш өгсөн ч хүчээр халбага бүрийг нь хоолой давуулав. Түүнчлэн үдэш болон дараагийн өдөр нь ч гэсэн идлээ. *Амьд гар. Серсейгийн төлөө амьдар. Тирионы төлөө амьдар. Өшөө хорслынхоо төлөө амьдар. Ланнистерийнхан үргэлж өрөө төлдөг* гэж хоолойд нь нухаш тээглэхэд хахир хоолойгоор өөртөө хэлэв. Гарных нь хоосон ор халуу шатан өвдөж өмхий байлаа. *Би Хааны газар хүрвэл алтаар шинэ гар хийлгэж хэзээ нэг цагт Варго Хотын хүзүүг хага базах болно доо.*

Өдөр шөнө манантсан өвчин дунд балартан ээлжлэнэ. Жэйми Бриенид наалдан ялзарсан гарын өмхий үнэрт хамраа утуулан зүүрмэглэж шөнө нь хатуу газар унтаж хар дарсан зүүд зүүдэлнэ. Түүнийг маш сул дорой байсан ч байнга модонд хүлж байв. Энэ нь тэдний түүнээс одоо хүртэл хэр айж байгааг мэдрүүлэхэд хүйтнээр тайтгарах сэтгэл төрлөө.

Бриен үргэлж дэргэд нь хүлээстэй байлаа. Тэр хүлээстэйгээ яг л үхсэн үнээ шиг гулдайн үг дуугүй хэвтэнэ. *Хүүхэн дотроо цайз босгож. Тэд түүнийг удахгүй хүчиндсэн ч хэрмийнх нь ард хүрч чадахгүй.* Харин Жэймигийн хэрэм нуржээ. Тэд гарыг нь авч, илд барьдаг гар нь байхгүй болсон болохоор түүнгүй бол юу ч биш байлаа. Зүүн гарынх нь хэрэг байсангүй. Тэр явж сурснаасаа хойш зүүн гараа зөвхөн бамбай барихад ашиглаж байжээ. Баруун гар нь л түүнийг хүлэг баатар болгож, баруун гар нь л түүнийг эр хүн болгосон билээ.

Нэг өдөр Өрзвик Харренхалын тухай дурсахыг сонсоод тэдний зорилгыг саналаа. Энэ нь түүнийг чанга хөхрүүлэхэд Тимеон нүүр лүү нь урт нарийхан ташуураар ороолгов. Шавхуурдсан ормоор цус гарсан ч гарны өвчний хажууд юу ч биш байлаа.

- Чи яагаад инээсэн юм бэ? гэж Бриен шөнө шивнэн асуув.

- Харренхалд би цагаан нөмрөгөө хүртсэн. Вентийн зохион байгуулсан том тэмцээн байсан. Тэр бидэнд хэр том шилтгээн хичнээн сайн хөвгүүдтэйгээ үзүүлэхийг хүссэн юм. Би бас тэдэнд үзүүлж өгөхийг хүссэн. Би тэгэхэд ердөө арван тавтай байсан ч тэр өдөр намайг хэн ч дийлэхгүй байсан. Гэсэн ч Эйрис намайг тэмцээнд оруулаагүй. Тэр намайг цааш явуулсан ч одоо би буцан ирж байна гээд тэр ахин инээлээ.

Энэ удаад Жэйми өшиглөлт зодуурыг амсав. Тэр зодуулахыг барагтай мэдрээгүй ч Рог хүнд гутлаараа шархтай гар луу нь өшиглөхөд ухаан алдлаа.

Дараагийн шөнө хамгийн дор гурван новш болох Шагвелл, хамаргүй Рог, гарыг нь тас цавчсан тарган Дотраки Золло нар эцэст нь ирлээ. Золло, Рог хоёр хэн нь түрүүлж хүүхнийг эзэмдэх талаар маргалдан харваас тэнэг хамгийн сүүлд бололтой. Шагвелл тэдэнд хоёул зэрэг хүүхний урд ардаас нь хийхийг зөвлөв. Золло, Рог хоёрт санаа таалагдсан ч удалгүй хэн нь урд хэн нь ард гарах талаар маргалдаж эхэллээ.

Тэд түүнийг тахир дутуу болгосон ч зөвхөн дотроо болохоос гаднаа гаргаж үзүүлэхгүй.

- Бүсгүй минь. Тэдэнд биеэ орхиод өөрөө алс од. Тэгвэл бүх зүйл түргэн дуусч тэд таашаал бага амсана гэж Золло, Рог хоёр бие биенийгээ хараан хэрэлдэхэд шивнэв.

- Тэд надаас ямар ч таашаал амсахгүй гэж хүүхэн эсэргүүцлээ.

Тэнэг зөрүүд зоригтой гичий. Тэр урдаас нь эсэргүүцвэл алагдахыг нь Жэйми мэдэж байв. *Тэгээд түүний юу хийх надад ямар хамаатай гэж? Хэрвээ тэр ийм илжиг шиг зөрүүд байгаагүй бол би гартайгаа байх байсан.* Гэсэн ч тэр,

- Тэгвэл тэднийг үүнийг хийх үед нь дотогш ор гэж шивнэлээ. Жэйми үүнийг Старкийнхан нүдэн дээр нь үхэж лорд Рикард хуягандаа шарагдан, хүү Брандон нь аврахын тулд тийчлэн боож үхэх үед хэрэглэжээ.

- Хэрвээ түүнд хайртай юм бол Рэнлигийн тухай бод. Тартын тухай уул, тэнгис, цөөрөм, хүрхрээ болон Индраанил аралд чинь байдаг бүх зүйлийн тухай бод...

Тэгтэл Рог маргаанд ялжээ.

- Чи миний харсан хамгийн царай муутай хүүхэн байна. Гэхдээ намайг чамаас үүнээс ч царай муутай болгоно гэж бүү бод. Чи минийх шиг хамартай болмоор байна уу? Урдаас эсэргүүцвэл үүнийг хүртэнэ шүү. Хоёр нүд чинь ч гэсэн ихдэж байна. Ганц л дуу хашгирахад би өрөөснийг нь сугалж аваад чамд идүүлэн шүдийг чинь нэг нэгээр нь сугална.

- Үүнийг хий л дээ, Рог. Тэр шүдгүй бол миний хайрт хөгшин ээжтэй адилхан харагдах болно. Би үргэлж хайрт хөгшин ээжийнхээ араас хавьтахыг хүсдэг байсан юм гэж Шагвелл гуйлаа.

- Хөгжилтэй тэнэг вэ гээд Жэйми хөхөрлөө. - Надад чамд таалгах таавар байна, Шагвелл. Чи яагаад түүний хашгиралтанд ийм санаа тавиад байгаа юм бэ? Өө хүлээж байгаарай би мэдэх юм байна гээд хамаг чадлаараа,

- ИНДРААНИЛ гэж чанга хашгирлаа.

Рог хараал тавин мухар гар луу нь өшиглөхөд Жэйми дуу алдан гиншив. *Би хэзээ ч ертөнцөд ийм өвдөлт байдгийг мэдэхгүй юм байна* гэж сүүлчийн удаа саналаа. Тэр хэр удаан ухаан алдсанаа мэдэхгүй ч өвчин хатгуулахад сэрэхэд Өрзвик болон Варго Хот тэнд өөрийн биеэр ирсэн байлаа.

- Түүнд хүрч болохгүй. Тэнэг минь тэр охиноороо байх ёстой! Тэр хүүдий дүүрэн идраалын үнэтэй! гэж ямаа Золло руу хамаг шүлсээ үсчүүлэн хашгираад түүнээс эхлэн шөнө бүр тэднийг өөрийнхнөөсөө хамгаалан харуул гаргах болжээ.

Хоёр шөнө өнгөрсний дараа эцэст нь хүүхэн юм шивнэх зоригтой болов.

- Жэйми? Чи яагаад хашгирсан юм бэ?

- Намайг яагаад "индраанил" гэж хашгирсан юм бэ гэж үү? Тархиа ашигла, бүсгүй минь. Намайг "хүчин" гэж хашгирсан бол тэд нар тоох байсан гэж үү?

- Чи ингэж хашгирах хэрэггүй байсан юм.

- Чи хамартайгаа тэртэй тэргүй онцгүй харагдаж байна. Дээрээс нь би ямааг "идраал" гэж хэлүүлэхийг хүссэн юм. Миний ийм худалч байсан нь чиний аз. Өөр үнэнч хүн байсан бол Индраанил арлын тухай үнэнийг хэлэх байсан.

- Тэгсэн ч гэсэн. Би чамд талархаж байна, сэр.

Гар нь янгинан өвдөхөд Жэйми шүдээ зуугаад,

- Ланнистерийнхан үргэлж өрөө төлдөг. Энэ бол чиний голд Робин Райгер руу чулуу унагасны чинь төлөө хийсэн зүйл гэв.

Ямаа ёслолын жагсаал хийхийг хүссэн учир Жэймиг Харренхалын хаалганаас милийн зайтай мориноос нь буулгав. Түүний бүсэлхийнээс олс зангидаж хоёр дахыг нь Бриенигийн бугуйнд хүлээд үзүүрийг нь Варго Хотын эмээлийн бүүргэнд уяжээ. Тэд Кохорикийн судалтай тахины ард мөр зэрэгцэн бүдчин явав.

Жэймиг зөвхөн хөл дээр нь уур хилэн тогтоож байв. Гарыг нь боосон даавуу сааралтан өмхий идээ бээр ханхална. Хий хуруунууд нь алхам тутамд шархиран өвдөж байлаа. *Би тэдний бодож байгаагаас илүү хүчтэй. Би Ланнистер хэвээр. Дээрээс нь Хааны хамгаалалтын хүлэг баатар* гэж өөртөө хэлэв. Тэр Харренхалд хүрсэн болохоор Хааны газарт хүрэх болно. Тэр амьд гарна. *Тэгээд энэ өрөө онцгойлон төлнө дөө.*

Тэд Хар Харрены нүсэр шилтгээний цохио шиг хананд ойртоход Бриен гарыг нь ёворлоо.

- Лорд Болтон энэ цайзыг барьж байгаа. Болтоныхон бол Старкийн тугчид.

- Болтоныхон дайсныхаа арьсыг хуулдаг гэж Жэйми умардынхны тухай саналаа. Тирион байсан бол Дредфортын лордын тухай бүхнийг мэдэх байсан ч мянган бээрийн алсад Серсейтэй хамт байгаа билээ. *Би Серсейг амьд байхад үхэж болохгүй. Бид хамтдаа төрсөн болохоор хамтдаа үхнэ.*

Шилтгээний гадна талын хэрмийн чулуу харлан шатаж хуурамч хаврын жил лорд Вэнтийн том тэмцээн зохиосон нуурын эрэг дээр саяхан дүүрэн хүмүүс морь малтайгаа хуарагнажээ. Тэднийг тахлагдсан газар дээгүүр явахад Жэймигийн уруул дээр гашуун инээмсэглэл тодров. Хэн нэгэн түүний урьд нь хааны өмнө өвдөг сөгдөн амлалтаа хэлж байсан газар жорлонгийн нүх ухжээ. *Би тэр амтат агшин хичнээн түргэн гашуунаар солигдоно гэж хэзээ ч төсөөлсөнгүй. Эйрис тэр шөнө надад тааллаа өгөх ёсгүй байсан юм. Тэр намайг өргөмжилсний зэрэгцээ нулимсан.*

- Далбааг нь хараач. Ихэр цамхаг болон, өвчүүлсэн хүн байна. Робб хааны тангарагт хүмүүс. Хаалганы цамхаг дээр цагаан дэвсгэр дээр саарал зэрлэг чоно байна.

Жэйми толгойгоо эргүүлэн дээш харлаа.

- Энэ чиний хараал идсэн чоно нь үнэн байна. Харин хоёр талд нь толгойнууд байна.

Цэргүүд, зарц, буудал дагагсад тэднийг гуугчин угтав. Цоохор толботой гичий тэднийг буудлаас

даган удтал хуцан гүйсэнд Лайсенигийн нэг эмээлээсээ жадалж жагсаалын урд цогиуллаа.

- Би Хааны алуурчийн далбааг авч явна гэж тэр үхсэн нохойг Жэймигийн толгой дээр сэгсрэн хашгирлаа.

Харренхалын хана маш зузаан учир доогуур нь гарахад чулуун хонгил дундуур яваа шиг сэтгэгдэл төрөв. Варго Хот лорд Болтонд ирж яваагаа дуулгахаар хоёр Дотраки урьдчилан илгээсэн учир гадна талын хашаанд сонирхсон хүн пиг цугларчээ. Тэд Жэймиг гуйвлан өнгөрөхөд зам тавьж бүсэлхийн дэх олсноос нь татаж чангаан удаашрууллаа.

- Би та нарт Хааны алуурчийг авчирлаа гэж Варго Хот шүлсээ үсчүүлэн мэдэгдэв. Тэгтэл хэн нэгэн Жэймигийн нуруу руу жадалж газар тэрийлгэв.

Тэр зөнгөөрөө унахдаа гараа сарвайжээ. Шархдсан гар нь газар цохиход ухаан балартам өвдсөн ч яаж ийгээд өрөөсөн өвдөг дээрээ өндийлөө. Түүний өмнө Харренхалын асар том дугуй цамхгын нэгэн рүү орохыг хөтөлсөн өргөн чулуун гишгүүр байв. Шатны дээд талд таван хүлэг баатар нэг умардын хүн байсан нь цайвар нүд ангийн үнэт үсэн хувцастай, нөгөө тав нь хуяг дуулган дээр ихэр цамхгын сүлдтэй байлаа.

- Хичнээн Фрей байна вэ. Сэр Данвел, сэр Эйнис, сэр Хостин гээд Жэйми авга эгч нь тэдний нэгтэй гэрлэсэн болохоор лорд Валдерийн хөвгүүдийг хармагц танив.

- Миний гашуудлыг хүлээн авна уу.

- Юуны төлөө билээ, сэр? гэж сэр Данвел Фрей асуув.

- Танай ахын чинь хүү, сэр Клеосын төлөө. Тэр бидэнтэй дээрэмчид дүүрэн сум зоох хүртэл хамт байсан. Өрзвик түүний ачааг авч биеийг нь чононуудад үлдээсэн.

- Эрхэм лордуудаа! Би та нарын далбааг харсан. Намайг өргөсөн амлалтынхаа төлөө сонсооч гээд Бриен урагш мултран гарлаа.

- Энэ хэн ярьж байна? гэж сэр Эйнис Фрей асуув.

- Ланнистерийн нялх асрагч.

- Би Үдшийн одны лорд Селвины охин Тартын Бриен байна. Старкийн овогт та нар шиг зүтгэх андгай өргөсөн.

- Чиний тэр амлалт чинь энэ байна. Бид Робб Старкийн үгэнд итгэж байсан ч тэр итгэлийг минь урвалтаар төлсөн гээд сэр Эйнис хөл рүү нь нулимлаа.

Энэ чинь сонирхолтой зүйл болж байх чинь. Жэйми Бриенигийн энэ зэмлэлийг яаж хүлээж авахыг мэдэхээр эргэхэд хүүхэн луус шиг зөрүүд урагш зүтгэж олсонд холгосон бугуйгаа өргөв.

- Би ямар ч урвалтын тухай мэдэхгүй. Хатагтай Кателин намайг Ланнистерийг Хааны газар байгаа

дүүд нь хүргэж өгөхийг тушаасан....

- Тэр биднийг очиход түүнийг живүүлэхийг оролдож байсан гэж Өрзвик хэлэхэд Бриен улайлаа.
- Би уурандаа өөрийгөө мартсан байсан ч хэзээ ч түүнийг алахгүй байсан. Хэрвээ тэр үхсэн бол Ланнистерийнхан миний хатагтайн охидыг илдээр алах байсан.
- Бидэнд наадах чинь ямар хамаатай юм бэ? гээд сэр Эйнис хөдөлсөнгүй.
- Түүнийг Риверран руу золиосоор буцаа гэж сэр Данвел хэлэв.
- Кастерли Рок илүү их алттай гэж нэг дүү нь эсэргүүцлээ.
- Тэгвэл түүнийг ал! Нэд Старк шиг толгойг нь ав! гэж нэг нь хэлэв.

Тэнэг Шагвелл шатны хөл дээр саарал ягаан өнгийн эрээн хувцастайгаа тонгорон гарч ирээд дуулж эхлэв.

- Урьд нэг цагт баавгайтай бүжиглэдэг байсан арслан байжээ. Өө ля ля...

- Чимээгүй, тэнэг минь. Энэ Хааны алуурчийг баавгайд өгөхгүй. Тэр минийх гээд Варго Хот түүнийг нударгалав.

- Тэр хэнд ч үхэх ёсгүй. Тэгээд ч миний санаж байгаагаар чи намайг умард зүг явах хүртэл Харренхалын эзэн биш байхаа гэж Рус Болтон чимээгүй хэлэхэд бүгд сонсохын тулд чимээгүй боллоо.

Жэйми халуундаа солиорон аймшиггүй болжээ.

- Энэ чинь нөгөө Дредфортын лорд гэж үү? Миний сүүлд сонссоноор эцэг минь чамайг сүүлчийг чинь хавчтал зугтаалгасан гэсэн. Та хэзээ гүйхээ зогсоо вэ, эрхэм лорд?

Болтоны чимээгүй байдал Варго Хотын шүлсээ үсчүүлэн зандрахаас зуу дахин илүү аймшигтай байлаа. Өглөөний манан шиг цайвар нүдэнд нь ярихаас илүү зүйл нуугдаж байв. Жэймид түүний нүд таалагдсангүй. Энэ нь түүнд Хааны газар Нэд Старк төмөр хаан ширээнд сууж байхад нь орж ирсэн өдрийг дэндүү сануулна. Дредфортын лорд эцэст нь жимийсэн уруулаа нээж,

- Чи гараа алдаж гэв.

- Үгүй дээ би алдаагүй. Хүзүүндээ зүүчихсэн байна.

Рус Болтон доош буун Жэймигийн уяаг мулт татан гарыг Хот руу шидлээ.

- Үүнийг зайлуул. Харахаас ой гутаж байна.

- Би үүнийг лорд эцэг рүү нь явуулна. Би түүнд зуун мянган алтан луу төлөхгүй бол Хааны алуурчийг хэсэг хэсгээр нь илгээнэ гэж хэлнэ. Дараа нь бид алтыг авсан хойно сэр Жэймиг

Карстарк руу охиныг нь бас авахаар илгээх болно! гэхэд Зоригт нөхөд түсхийтэл инээлдлээ.

- Сайхан төлөвлөгөө байна гэж Рус Болтон оройн хоолон дээр "сайн дарс байна" гэж байгаатай адилхан өнгөөр хэлэв.

- Зөвхөн лорд Карстарк чамд охиноо өгч чадахгүй нь дээ. Робб хаан урван тэрсэлж аллага хийснийх нь төлөө түүний толгойг авсан. Лорд Тайвины хувьд тэр одоо шинэ он гарч ач хүүгээ Хайградены сүйт бүсгүйтэй хуримлах хүртэл Хааны газар байна.

- Та Винтерфелл гэж хэлэх гээ юу. Жоффри хаан Санса Старктай сүй тавьсан шүү дээ гэж Бриен хэлэв.

- Түүнээс больсон. Хар усны тулаан бүгдийг өөрчилсөн. Арслан цэцэг хоёр хамт нэгдэж Станнис Баратеоны цэргийг бут цохин флотыг нь үнс болгон шатаасан.

Би чамд анхааруулсан биз дээ, Өрзвик. Чамд ч гэсэн ямаа минь. Та нар арслангийн эсрэг мөрийцвөл хэтэвчнээсээ илүү их зүйлийг алдах болно доо гэж Жэйми бодлоо.

- Миний эгчийн талаар сураг байна уу?

- Тэр сайн байгаа. Яг л чиний... зээ шиг гээд Болтон "зээ" гэж хэлэхийн өмнө би түүнийг ямар болохыг нь мэднэ гэсэн шиг түр алгуурлав.

- Чиний дүү амьд байгаа ч тулааны үеэр шарх авсан гээд товчтой арьсан хүрэмтэй ширүүн умардын хүн рүү дохиж, - Сэр Жэймиг Кайбөрн рүү аваач. Харин энэ эмэгтэйг сулла гээд Бриенигийн бугуйн хүлээсийг хоёр хэсэг болгон цавчсан хойно,

- Биднийг өршөөгөөрэй, хатагтай. Энэ хүнд бэрх цагт нөхөр дайснаа ялгахад хэцүү юм гэв.

Бриен олсонд цус шүүртэл үрэгдсэн бугуйныхаа арьсыг үрлээ.

- Эрхэм лорд тэд нар намайг хүчиндэхийг оролдсон.

- Тэд тэгээ юу? Надад энэ таалагдахгүй байна. Сэр Жэймигийн гар ч гэсэн гээд лорд Болтоны цайвар нүд Варго Хот руу чиглэв.

Энд умардын таван хүнээс гадна Зоригт нөхдөөс хамаагүй их Фрейгийнхэн хашаанд байлаа. Ямаа төдийлөн ухаалаг биш ч их багыг ялгаж чадахтайгаа байсан тул үг дуугарсангүй.

- Тэд миний илд хуягийг авсан... гэж Бриен хэлэв.

- Таньд энд хуяг хэрэггүй, хатагтай. Харренхалд та миний хамгаалалтан дор байна. Амабел хатагтай Бриенид тохирох өрөө ол. Валтон чи сэр Жэймид даруй санаа тавь гээд Болтон хариу хүлээлгүй арьсан эмжээртэй нөмрөгөө ардаа намируулан шатны гишгүүр лүү эргэлээ. Жэйми салахын өмнө Бриентэй түргэн харц солилцож амжив.

Дээврийн доод талын мэистерийн өрөөнд буурал үстэй эцэг ёсны Кайбөрн гэдэг хүн Жэймигийн мухар гарыг боосон ороолтыг хуулахдаа дуу алдав.

- Тийм муу байна уу? Би үхэх болов уу?

Кайбөрн шархыг хуруугаараа дарж үзээд идээ буцлан гарсанд хамраа үрчийлгэв.

- Үгүй дээ. Гэхдээ хэдэн өдөр болоход халдвар тархах болно. Бие чинь яаж зөөлөрснийг харж байна уу? Үүнийг бүгдийг нь огтлох ёстой. Хамгийн аюулгүй арга гэвэл гарыг чинь тайрах гээд Жэймигийн ханцуйг хайчиллаа.

- Тэгвэл чи үхнэ гэж Жэйми амлав. - Мухрыг нь цэвэрлээд оё. Би боломжоо ашиглана.

- Би тохойг чинь огтолж гарын чинь дээд хэсгийг үлдээж болох ч... гээд Кайбөрн хөмсөг зангидлаа.

- Хэрвээ чи миний гарын ямар ч хэсгийг огтолвол нөгөөдөхийг нь ч гэсэн тайрсан нь дээр шүү. Үгүй бол би чамайг дараа нь багалзуурдах болно.

Кайбөрн түүний нүд рүү ширтгээд юу ч олж харсан юм зөөлөрлөө.

- Маш сайн байна. Би зөвхөн идээлсэн хэсгийг тайрч авъя. Халдварыг зогсоохын тулд буцалгасан дарсаар ариутгаж халгай, гичийн үр, талхны хөгцөөр жин тавина. Тэгвэл болно байх. Энэ чиний шийдэх асуудал. Чи намуу цэцэгтэй сүү уумаар байна уу...

- Үгүй гээд Жэйми унтахыг хүссэнгүй. Тэр сэрсэн хойно мөрөөрөө тайруулсан гартай байж болох болохоор түүний юу ч хэлсэн хамаа байсангүй.

- Гэхдээ өвдөнө шүү дээ гээд Кайбөрн гайхширлаа.

- Би хашгирна.

- Маш их өвдөнө.

- Би маш чанга хашгирна.

- Ядаж дарс уух юм байгаа биз дээ?

- Их септоноос мөргөхийг асуудаг бил үү?

- Тийм гэдэгт итгэлгүй байна. Би дарс авчиръя. Буцаж хэвт. Гарыг чинь хүлэх хэрэгтэй байна.

Хул аяга, хурц хутгатай авчираад Кайбөрн шархыг цэвэрлэж эхлэхэд Жэйми хатуу дарс залгилахдаа хагасыг нь өөр лүүгээ асгачихлаа. Түүний зүүн гар амаа олохгүй байсан ч ямартай ч сайнаар эргэн дарсны үнэрт норсон сахал идээний өмхий үнэрийг дарахад туслав.

Гэвч биений өмхөрсөн хэсгийг тайрах үед юугаар ч тусалсангүй. Жэйми хашгиран нударгаараа

ширээ чанга балбалаа. Тэр Кайбөрнийг мухар гар луу нь буцалгасан дарс хийх үед ахин хашгирч өгсөн ам, айдсаа үл харгалзан ухаан алдав. Сэхээ орох үед мэйстер гарыг нь зүү, гэдэсний өлөн утсаар оёж байв.

- Би бугуйнд чинь эргүүлэх арьс үлдээсэн.

- Чи үүнийг урьд нь хийж байсан юм байна гэж Жэйми сулхан гүвтнэхэд аманд нь хазагдсан хэлний цус амтагдлаа.

- Варго Хот шиг хүнд зүтгэдэг хүнд тайруулсан үе мөч харь биш. Тэр хаа явсан газартаа үүнийг хийдэг юм.

Кайбөрн мангас шиг харагдахгүй байна гэж Жэйми бодлоо. Тэр зөөлөн яриа дулаахан хүрэн нүдтэй байлаа.

- Мэйстер хүн яахаараа Зоригт нөхөдтэй явдаг байна?

- Цайз миний гинжийг хураасан. Би нүдний чинь шархыг бас үзэх ёстой. Бие чинь их үрэвссэн байна гээд Кайбөрн зүүгээ хойш тавилаа.

Жэйми Кайбөрнийг ажиллах зуур нүдээ аниад дарс уув.

- Надад тулааны тухай яриач гээд Харренхалын хэрээг хариуцдагын хувьд Кайбөрн мэдээг хамгийн түрүүнд сонсдог байлаа.

- Лорд Станнис танай эцэг галт хана хоёрын дунд орсон. Бяцхан чөтгөр голыг шатаасан гэж ярьж байна лээ.

Жэйми цамхаг шиг өндөр ногоон дөл тэнгэрт хүртэл хүрхрэн шатаж хүмүүс гудамжинд хашгирч байгааг харлаа. *Би үүнийг урьд нь зүүдэлж байсан. Энэ нь хөгжилтэй байсан ч харамсалтай нь хуваалцах хүн байсангүй.*

- Нүдээ нээ гээд Кайбөрн бүлээн усанд даавуу норгон хатсан цусыг нь арчив. Зовхи нь хавдсан ч Жэйми хүчлэн хагасыг нь нээхэд Кайбөрний царай дээрээс нь ширтэж байв.

- Хэн чамайг ингэдэг байна?

- Хүүхний бэлэг.

- Тааруухан сээтэн болсон юм биз дээ, эрхэм лорд?

- Тэр хүүхэн надаас том биетэй чамаас ч царай муутай. Чи түүнд ч гэсэн санаа тавьсан нь дээр. Биднийг хоорондоо тулалдах үед хөл дээрээ олсон шарханд доголсон хэвээр байгаа.

- Би түүнийг дараа нь үзнэ. Энэ хүүхэн чиний юу юм бэ?

- Миний хамгаалагч гээд Жэйми өвдөлтөө үл хайхран хөхөрлөө.
- Би халууныг чинь намдаахын тулд дарстай хольсон ургамлын ханд өгье. Маргааш өглөө буцаж иржцээд нүдний чинь муу цусыг чинь хануур хорхойгоор соруулна.
- Хануур хорхой гэнэ ээ. Гайхамшигтай.
- Лорд Болтон хануур хорхойнд маш дуртай гэж Кайбөрн хатуу хэлэв.
- Тийм. Тэгэх нь гарцаагүй гэж Жэйми хэллээ.

ТИРИОН

Хааны хаалганаас үнс нурам, шавар, түлэгдсэн яснаас ондоо зүйл үлдсэнгүй ч хүмүүс хэдийн хотын хэрмийн сүүдэрт суурьшиж тэргэнцэр дээрээс болон торхтой загас зарна. Тирион дэргэдүүр нь шогшуулан гарах зуураа хүйтэн, ууртай, үл өрөвдсөн харц ширтэхийг мэдрэв. Дэргэд нь тосолсон хар хуягтай Бронн явж байсан тул хүмүүс түүнтэй үг өдөх юм уу замыг нь хоргоохыг оролдсонгүй. *Хэрвээ би ганцаар байсан бол тэд намайг газар гулдран унагаж сэр Престон Гринфилд шиг нүүрийг минь чулуугаар бяц цохих байсан бизээ.*

- Тэд хархнаас ч түргэн буцаж ирцгээх юм. Бид тэднийг нэг удаад шатааж зайлуулсан ч сургамж авсан гэж бодож байна уу? гэж Тирион гомдоллов.

- Надад хориод алтан нөмрөгтөн өгвөл би бүгдийг нь хороочихъя. Тэднийг үхвэл хэн ч буцаж ирэхгүй гэж Бронн хэлэв.

- Үгүй бусад нь ирж тэдний байрыг эзлэнэ. Тэднийг орхи. Харин тэд урцаа ахин хананд тулган барьж эхэлвэл даруй буулгаж хаяна. Дайн хараахан дуусаагүй болохоор тэнэгүүдийн юу гэж бодох хамаа алга гээд Тирион урдаа байсан Шавар хаалгыг ажсанаа,

- Би өнөөдөр хангалттай харлаа. Маргааш нийгэмлэгийн мастеруудтай буцан ирж тэдний төлөвлөгөөг сонсоё гээд санаа алдлаа. *Би эд нарын ихэнхийг нь шатаасан ч чухамхуу өөрөө ахин эргэн барих гэж байна.*

Энэ нь авга ахынх нь даалгавар байсан ч шийдэмгий хатуу эцэж цуцахыг мэддэггүй сэр Кеван Ланнистер Риверранаас хүүгийнх нь үхсэн тухай мэдээ хэрээ авчирсан цагаас хойш өөрийгөө мэдэхээ больжээ. Виллемийн ихэр Мартин бас Робб Старкад олзлогдож ууган ах Лансел нь хэвтэрт шарх нь хэзээ эдгэрэх тодорхойгүй байв. Нэг хүү нь үхэж нөгөө хоёр нь үхлийн аюулд байгаа болохоор сэр Кеван уй гашуу айдаст автжээ. Лорд Тайвин үргэлж ахыгаа түшдэг ч одоо одой хүү рүүгээ ахин эргэхээс ондоо арга байсангүй.

Байлдааны сүйрлийг эргэн босгох зардал үлэмж их болохоор үүнийг хаанаас олох нь тодорхойгүй байлаа. Хааны газар Хуучин хотыг эс тооцвол хаант улсын үндсэн боомт байв. Гол эргэн нээгдэхэд удахгүй нөхцөл дээрдэнэ. *Харин би тэр хараал идсэн зоосыг нь хаанаас олох болж байна?* Энэ нь түүнийг хоёр долоо хоногийн өмнө хойд зүг онгоцоор явсан Чигчий хурууг санагалзахад хүргэлээ. *Түүнийг Лайза Арринтай гэрлэж Хөндийн зэрэгцээ өөрийг нь гартаа оруулж байх хооронд би ардаа үлдээсэн заваан юмыг нь цэвэрлэж байна.* Ядаж л эцэг нь түүнд ач холбогдолтой ажил өгчээ. *Тэр намайг Кастерли Рокийн залгамжлагч болгоогүй ч боломж гарсан үе бүрдээ ашиглаж байна* гэж Тирион тэднийг Шавар хаалгаар орох зуур алтан нөмрөгтөнгүүдийн ахлагч даллахад бодлоо.

Гурван янхан хаалганы дотор талын талбай дээр ноёрхсон хэвээр одоо сул зогсож үхэр чулуу, торхтой давирхайг өнхрүүлэн холдуулжээ. Түүний их бие рүү хүүхдүүд авиран шиддэг гар дээр нь сармагчин шиг шавааралдаж бие бие рүүгээ хашгиран дуу шуу болно.

- Намайг сэр Аддамд алтан нөмрөгтөнгүүдийг энд харуулд гаргахыг сануулаарай. Аль нэг тэнэг

хөвгүүн унаж нуруугаа хугалах бий дээ гэж Тирион Броннд харвагчийн дундуур гарахдаа хэлэв. Тэгтэл дээр нь хашгиралт гараад урд нь газар бөөгнөрсөн шивх унаж задархад Тирионы гүү цочсондоо цоройн золтой авч шидсэнгүйд,

- Би бодлоо өөрчиллөө энэ хүмүүжилгүй зулбасагнууд газар болсон хулуу шиг бяц унавал унаж байг гэлээ.

Тирион хэдэн гудамжны тэнэмэл хүүхэд шивхээр шидсэний төлөө биш ер нь ааш муутай байлаа. Түүний гэрлэлт өдөр тутмын зовлон болж хувирчээ. Санса Старк охин хэвээр одоо шилтгээний хагас нь үүнийг мэдэх болжээ. Тэднийг өглөө мордох үед Тирионы ард хоёр агтчин хүү шивнэлдэн инээлдэхэд бараг л морьд нь хүртэл унагалдан инээх шиг санагдав. Тэр дэр нэгтгэх явлаас зайлсхийн хувийн тусгай унтлагын өрөөтэй болох гэсэн ч найдлага нь түргэн замхарчээ. Хэрвээ Санса зарц нарынхаа нэгд итгэн хэлэхээр тэнэг байгаагүй бол, бүх хүн Серсейгийн тагнуул байж эсвэл Варисийн жижиг шувуудыг үүнд буруутгах байлаа.

Үүнд ялгаа байсангүй. Тэд түүнийг ижилхэн шоолон инээсэн хэвээр байх болно. Улаан шилтгээнд зөвхөн цорын ганц хүн хатагтай эхнэрээсээ болж гэрлэлтийн ийм доог тохууны байдалд орох байх даа.

Санса өдөр ирэх тусам улам гунигт шанална. Тирион түүний эелдэг ёсыг эвдэж тайвшируулахын тулд бүхнийг хийх байсан ч бүтсэнгүй. Ямар ч үг түүнийг үзэсгэлэнтэй болгохгүй. Эсвэл Ланнистер биш болгохгүй билээ. Ийм л эхнэрийг тэд түүнд өгсөн болохоор үлдсэн амьдралын турш хамт байж өөрийг нь үзэн ядах болно.

Шөнө нь том орондоо хамт орох ахин нэг зовлонгийн үндэс болно. Тирион сурсан заншлаараа нүцгэн унтаж чадахаа больжээ. Түүний эхнэр эелдэг бус үг хэлэхээргүй дэндүү сайн сургагдсан ч биеийг нь харахад нүдэнд нь Тирионы дааж гарахаас илүү жигшил тодрону. Тэрбээр Сансад унтлагын хувцас өмсөхийг тушаажээ. *Би түүнийг хүсч байна. Би Винтерфеллийг хүсч байгаа ч гэсэн түүнийг хүүхэд эмэгтэй алин байсан хамаагүй хүсч байна. Би түүнийг тайтгаруулж инээдийг нь сонсон над руу дуртай ирж баяр, гуниг, хүслээ хуваалцахыг хүсч байна* гэж тэр ойлгов. Тирионы ам гашуунаар инээмсэглэлээ. *Тиймээ дээрээс нь ч гэсэн Жэйми шиг өндөр, Уулсэр Грегор шиг хүчтэй болохыг хүсч байна.*

Гэнэтхэн бодол нь Шэй рүү буцлаа. Тирион түүнд энэ тухай өөр хүний амнаас сонсохыг хүсээгүй болохоор Варист хуримын өмнөх шөнө авчирахыг тушаажээ. Тэднийг тайганы өрөөнд уулзахад Шэй хантаазных нь үдээсийг тайлж эхэлсэнд бугуйнаас нь барин түлхлээ.

- Хүлээж бай чамд хэлэх зүйл байна. Маргааш гэхэд би...

- ...Санса Старктай гэрлэнэ. Би мэднэ гэхэд Тирион балмагдсандаа хэлэх үггүй болов. Санса хүртэл тэгэхэд мэдээгүй байсан билээ.

- Чи хаанаас мэдээ вэ? Варис хэлээ юу?

- Намайг Лоллисийг сүмд хүргэхээр явах үед сэр Талладын зарц нарын нэг хэлсэн. Тэр зарц

охиноос сэр Кеваны аавтай чинь ярьсан яриаг сонссон гэсэн гээд Шэй түүний атгалтаас мурилзан мултарч даашинзаа толгой дээгүүрээ тайлахад үргэлжид байдаг шигээ дотуур нь нүцгэн байв.

- Надад хамаагүй. Тэр ердөө жаахан охин. Чи түүнийг том гэдэстэй болгоод над руу буцаж ирнэ.

Түүний нэг хэсэг дотроо найдахгүй байж чадсангүй. *Найдаж л бай гэхдээ чи одоо мэдсэн нь дээр одой минь. Шэй чамд олдох ганц хайр чинь* гэж ёжлон бодов.

Шавар зам дүүрэн хүнтэй байсан ч Тирионыг дагуултайгаа явахад цэргүүд, хотын хүмүүс ярагдан зай тавьж өглөө. Хоосон харцтай хөл нүцгэн хүүхдүүд араас нь шавж зарим нь дээшээ чимээгүй ширтэхэд зарим нь чангаар гуйлга гуйна. Тирион хэтэвчнээсээ атга зоос аваад агаарт шидэхэд хүүхдүүд бутран хашгиралдаж хоорондоо түлхэлцэн гүйлдлээ. Тэдний хамгийн азтай нь өнөө шөнө хатсан талхны зах худалдан авах байв. Тирион хэзээ ч зах ийм дүүрэн хүнтэй байхыг хараагүй ч Тайреллийн авчирсан бүх хоол хүнс тэнгэрт тулсан үнэтэй байлаа. Тарвас зургаан зэс зоос, боодол эрдэнэ шиш мөнгөн буга, үхрийн махны хаа юм уу зургаан туранхай тоорой алтан лууны үнэтэй байв. Гэлээ ч худалдан авагчид дутсангүй. Турж эцсэн хүмүүс мухлаг тэрэг бүрийг тойрон шавахад бусад нь дүнсгэр харцаар гудамжны ам руу харж байв.

- Ийшээ. Хэрвээ чи хэвээр бол...? гэж Бронн Дэгээний ёроолд хүрэхэд хэллээ.

- Тиймээ хэвээр гээд голын урд хэсгийг тохинуулахаас гадна Тирионд өнөөдөр биелүүлэх ёстой өөр зорилго байв. Тэд Эйгоны өндөр толгод руу эргэж Висениагийн ёроолд шавааралдсан олон жижигхэн тахир гудамж руу эргэлээ. Бронн урд нь зам тэргүүлж явав. Тирион араас дагаж байгаа хүн байгаа эсэхийг мэдэхээр мөрөн дээгүүрээ эргэн хэдэн удаа хяламхийхэд ердийн хүмүүс бужигнан, тэрэгчин морио зодож, эмгэн цонхоор шөнийн бохироо асган, хоёр хүүхэд саваагаар байлдаж, гурван алтан нөмрөгтөн олзлогсдыг авч яваагаас ондоо зүйл харагдсангүй. Тэд бүгд гэм зэмгүй харагдсан ч дунд нь заншлаач байж болох байв. Варисийн мэдээлэгчид хаа сайгүй бий.

Тэд нэг булангийн араас нөгөө рүү эргэж бөөгнөрсөн эмэгтэйчүүдийн дундуур удаан явлаа. Бронн түүнийг мухар гудамжны ойролцоох эвдэрхий нуман хаалгатай нарийхан гудамжаар дагуулан явав. Тэд шатсан байшингийн нурангин дундуур өнгөрч морьдоо чулуун гишгүүр дээгүүр алхуулав. Эндхийн байшингууд нь хоорондоо шахцалдсан давчуу ядуу байлаа. Бронн хоёр хүн зэрэгцэж явахад багтмааргүй тахир гудамжны аман дээр зогслоо.

- Тэнд хоёр домбоны цаана мухар бий. Дарсны газар сүүлчийн байшин шүү гэхэд Тирион мориноосоо доош буулаа.

- Намайг эргэж иртэл хэнийг ч битгий оруулж гаргаарай. Би удахгүй гээд нөмрөгнийхөө нууц халаасанд хийсэн алт нь байгаа эсэхийг шалган гараа явууллаа. Гучин луу. *Хүнээр хүссэн зүйлээ хийлгэх хараал идсэн аз.* Тирион гудамжны дагуу хийх зүйлдээ сэтгэл зовсоор түргэн явлаа.

Дарсны газар харанхуй чийгтэй цайвар өнгийн нитрдсэн ханатай дүнсгэр байшин байсан бөгөөд Бронн тонгойхгүй бол толгойныхоо оройгоор мөргөх байсан ч Тирион Ланнистерт төвөг удсангүй. Энэ цагт модон хашлаганы цаана сандал дээр сууж байгаа үхмэл харцтай эмэгтэйг эс тооцвол урд талын өрөө хоосон байв. Тэр Тирионд гашуун дарс аягалаад,

- Арагш ор гэв.

Ар талын өрөө бүр харанхуй байлаа. Намхан ширээн дээр домботой дарсны хажууд тавьсан лааны дөл сүүмэлзэн анивчина. Түүний ард зэрвэс харахад аюултай байрын шингэн хүрэн үс, ягаан хацар, ясан товчтой бугын арьсан хантаазаа түрсэн цүдгэр гэдэстэй намхан хүн сууж байсан ч Тирионоос өндөр байлаа. Тэр зөөлөн гартаа урт илднээс ч үхлийн аюултай арван хоёр чавхдастай модон ятга барьжээ.

Тирион түүний урдаас харан суулаа.

- Мөнгөн хэлт Саймон гэхэд тэр халзан оройтой толгойгоо бөхийлгөн,

- Эрхэм лорд Гар минь гэв.

- Чи намайг эндүүрч байна. Миний эцэг Хааны гар болсон. Надад хуруу ч байхгүй болсон гэж эмээж байна.

- Таныг ахин өснө гэдэгт итгэлтэй байна. Тань шиг хүн тэгдэг юм. Миний хонгор хатагтай Шэй надад таныг саяхан гэрлэсэн гэсэн. Тэгсэн бол намайг эртхэн дуудахгүй. Хуриман дээр чинь дуулах миний хувьд нэр төрийн хэрэг.

- Миний эхнэрт хэрэгтэй хамгийн эцсийн зүйл гэвэл дуу болоод байна. Шэйгийн хувьд бид хоёул түүнийг хатагтай биш гэдгийг мэдэх хойно нэрийг нь чанга дурьдахгүй байвал талархах байна.

- Гарын тушаасан ёсоор больё гэж Саймон хэлэв.

Тирион түүнтэй сүүлд уулзсанаас хойш хөлс чахруулам хурц үгтэй болсон нь дуучин хаа нэгтгээгээс зоригоо сэлбэсэн бололтой. *Ихэнхи нь энэ домбоноос биз.* Эсвэл Тирион түүний шинэ зоригт өөрийгөө буруутгаж болох юм. *Би түүнийг ямар ч сүрдүүлэг байхгүй үед сүрдүүлсэн болохоор одоо намайг шүдгүй нохой адил үзэх болжээ.* Тэр санаа алдан,

- Надад чамайг маш авъяаслаг дуучин гэсэн гэв.

- Таны ингэж хэлдэг ямар эелдэг хэрэг вэ, эрхэм лорд гэхэд Тирион инээмсэглэлээ.

- Би чамайг хөгжмөө Чөлөөт хотод аваачих цаг болсон гэж бодож байна. Бравос, Пентос, Лайсд дуунд маш дуртай болохоор дуулдаг хүнд нь өгөөмөр ханддаг юм гээд урдах дарсаа балгахад өмхий хэдий ч хүчтэй байлаа. - Есөн хотоор аялж тоглосон нь хамаагүй дээр. Чи дууг чинь хүн сонсолгүй үлдэхийг хүсэхгүй байгаа биз дээ. Энэ эхний нэг жилд хүрэлцээтэй байх гээд нөмрөгнийхөө дотор талын нууц алт руу гар сунгаж,

- Боомт хаалттай учир чи онгоцонд суухын тулд Даскендэйл рүү явах хэрэгтэй болохоор миний хүн Бронн чамд морь олж өгөн би аялалын чинь зардлыг туйлын баяртай төлөх байна... гэтэл,

- Гэхдээ эзэнтээн та миний дуулахыг хэзээ ч сонсоогүй шүү дээ. Ганцхан хором сонсооч гээд Саймон хуруугаа модон ятганы чавхдас дээгүүр шалмаг гүйлгэхэд зооринд уянгалаг аялгуу хадан

дуулж эхэллээ.

Тэр өндөр толгодыг уруудан

Хотын гудамжаар явлаа

Тахирласан гудамж, гишгүүр, чулуун замын тэртээ

Эмэгтэй хүний шүүрс алдалт хүлээж буй

Тэр түүний нууцхан эрдэнэс байж

Ичгүүр баяр жаргал нь билээ

Харин эмэгтэй хүний үнсэлттэй харьцуулахад

Гинж нь юу ч байсангүй

- Үүнээс цааш байгаа. Маш сайн дуу шүү. Дахилт нь бүр ч онцгой доо. *Алтан гар үргэлж хүйтэн байдаг ч эмэгтэй хүний гар дулаахан байдаг...*

- Хангалттай. Би наад дууг чинь ахиж сонсмооргүй байна. Хэзээ ч шүү гээд Тирион нөмрөгнөөс хоосон гараа гаргахад Мөнгөн хэлт Саймон ятгаа хажуу тийш тавьж дарс шимэв.

- Үгүй гэнэ ээ? Харамсалтай л юм. Гэвч хүн бүрт өөрийн гэсэн дуу байдаг гэж миний хөгшин багш минь надад тоглохыг зааж өгөхдөө хэлдэг байсан юм. Бусад хүмүүст миний ая таалагдаж болох юм. Хатанд юм уу танай лорд эцэгт гэхэд Тирион хамрынхаа сорвийг маажгаад,

- Миний эцэгт дуучдыг сонсох цаг байхгүй харин эгч минь зарим хүмүүсийн бодож байгаа шиг тийм ч өгөөмөр биш. Ухаалаг хүн бол дуулснаас чимээгүй байсан нь илүү ихийг хожно гэж аль болох илэрхий хэлэв.

Саймон бодлыг нь даруйхан ойлгожээ.

- Та миний үнэ даруухан болохыг мэдэх бизээ, эрхэм лорд.

- Наадхыг чинь мэдэхэд таатай байна. Надад хэлээч гээд Тирион гучин алтан луунаас гадуур хэрэг болов уу гэж айлаа.

- Жоффри хааны хурим дээр дуучдын тэмцээн болно гэсэн.

- Жонглёрчид, тэнэгүүд, бүжиглэдэг баавгайнууд ч гэсэн байгаа.

- Зөвхөн ганц бүжиглэдэг баавгай, эрхэм лорд гэж Саймон Серсейгийн бэлтгэл ажилд Тирионыхоос илүү санаа хандуулан хэлээд,

- Гэвч долоон дуучин байна. Кьюгий Галейон, Шалмаг хуруут Бетани, Эймон Костан, Эйзений

Аларик, Ятгачин Хэмиш, Коллио Къянис, Хуучин хотын Орланд нар мөнгөн чавхдастай алтадсан ятганы төлөө өрсөлдөх ч.... үүнд урьдчилан тооцоогүй урилгагүй хүн түрүүлэх болно гэв.

- Наадхыг чинь хэн болохыг таая. Мөнгөн хэлт Саймон уу? гэхэд Саймон даруухан инээмсэглэв.

- Би хаан болоод ордны өмнө бардамналаа үнэн болохыг батлахаар бэлдэж байгаа. Хэмиш хөгширч дуулахдаа юу дуулж байгаагаа мартдаг болсон. Харин Коллио Тайрошийн этгээд аялгатай. Гурван үгийнх нь нэгийг ойлговол өөрийгөө азтайд тооцож болно.

- Миний эгч найрын бэлтгэл ажлыг зохион байгуулж байгаа. Би чамд энэ урилгыг олж өглөө ч гэсэн хачин санагдах зүйл байна. Долоон ханлиг, долоон амлалт, долоон өрсөлдөгч, далан долоон төрлийн хоол зууш... гэвч найман дуучин гэж үү? Үүнийг Их септон юу гэж бодох бол?

- Надтай шүтлэгтэй хүн шиг бүү харьц, эрхэм лорд.

- Сүсэг бишрэл үүнд хамаагүй. Гарцаагүй зүйлийг биелүүлэх ёстой.

- Гэхдээ дуучны амьдрал аюул ослоор дүүрэн. Бид шар айрагны мухлаг, дарсны газар бүдүүлэг согтуу хүмүүсийн өмнө дуугаа дуулдаг. Хэрвээ танай эгчийн долоон хүний нэгд ямар нэг гай тохиолдвол намайг байранд нь тавих талаар таныг бодож үзнэ гэдэгт итгэж байна гээд Саймон бодож олсон санаандаа хөөрөн зальжин инээмсэглэж дарсаа балгалаа.

- Зургаан дуучин наймаас илүү азтай болохгүй нь эргэлзээгүй. Би Серсейгийн долоон хүний эрүүл мэндэд санаа тавих болно. Хэрвээ тэдний нэгд өвчин тохиолдвол миний хүн Бронн чам дээр ирэх болно.

- Маш сайн байна, эрхэм лорд гээд Саймон үүгээр орхиж болох байсан ч байгуулсан ялалтандаа хөөрөн,

- Би Жоффри хааны хуримын шөнө дуулах болно. Хэрвээ намайг ордонд уривал хаанд мянга дахин дуулсан хамгийн сайн дуугаа санал болгох болохоор хүмүүст таалагдахыг нь мэдэж байна. Эсвэл ямар нэгэн дарсны газар дууллаа гэхэд шинэ дуугаа турших боломжийг алдахгүй. *Алтан гар үргэлж хүйтэн байдаг ч эмэгтэй хүний гар дулаан байдаг.*

- Тэгэх заавал шаардлагагүй. Чи миний Ланнистерийн амлалтыг авч болно. Бронн чамайг удахгүй дуудна.

- Маш сайн байна, эрхэм лорд гээд халзан толгойтой цүдгэр гэдэстэй дуучин ахин модон ятгаа авлаа.

Бронн гудамжны аманд морьдтойгоо хүлээж байв. Тэр Тирионыг эмээлдээ морьдоход тусаллаа.

- Би түүнийг хэзээ Даскендэйл рүү авч явах вэ?

- Тэгэх хэрэггүй гээд Тирион морио эргүүлэв.

- Түүнд гурван өдрийн хугацаа өгөөд очиж Ятгачин Хэмиш гараа хугалсан гэж хэл. Түүнд хувцас нь ордонд таарахгүй тул өөр шинэ хувцас хэрэгтэй гэж хэлээрэй. Тэр чамтай дуртайяа явна гээд үрчийж,

- Миний ойлгосноор түүний хэл мөнгөн болохоор чи авахыг хүсч магадгүй. Харин үлдсэн хэсэг нь хэзээ ч олдохгүй байх ёстой шүү гэв.

- Нохой бөөсний мухарт амтлаг хүрэн шөл хийдэг халуун тогооны газар байдгийг би мэдэх юм байна. Бүх төрлийн махаар хоол хийдэг гэж сонссон гээд Бронн инээхэд,

- Тэнд чинь хоол идэхгүй гэдэгтээ итгэлтэй байна гээд Тирион морио давиран хатируулав. Тэр халуун байсан болохоор усанд орохыг хүсч байлаа.

Гэвч хамгийн даруу хүсэл нь хүртэл үгүйсгэгдэж өрөөндөө ирээд удаагүй байхад Подрик Пэйн Гарын цамхагт дуудсаныг мэдэгдэв.

- Эрхэм лорд таньтай уулзахыг хүсч байгаа. Гар. Лорд Тайвин.

- Би Гарыг хэн болохыг санаж байна, Под. Би хамраа алдсан ч ухаанаа алдаагүй юм шүү.

- Хүүгийн толгойг хэмлэх хэрэггүй гээд Бронн инээлээ.

- Яагаад хэрэггүй гэж? Тэр хэзээ ч ашигладаггүй юм чинь гээд Тирион яах эсэхээ тунгаалаа. *Би бас ямар зүйлд буруудсан юм бол доо.* Лорд Тайвины дуудлага үргэлж шахуу байдаг бөгөөд эцэг нь түүнийг хундага дарс, хоол хуваалцахын тулд уриагүй нь лавтай билээ.

Хэдэн хормын дараа Тирион лорд эцгийнхээ өрөөнд ороход хоолой сонсогдов.

- ...цэвэр алтан арслангийн цувраа толгой шигтгэсэн улаан арьсан гадартай интоорын модон хуй байна. Нүдэнд нь анар шигтгэж болох юм... гэхэд,

- Бадмаараг. Анарт галын дөл байхгүй гэж лорд Тайвин хэлэв.

- Эрхэм лорд та намайг дуудав уу? гээд Тирион хоолой засахад эцэг нь өндийн харлаа.

- Тиймээ би дуудсан. Хүрч ирээд үүнийг хараач гээд ширээн дээр тавьсан тостой даавуун боодлоос лорд Тайвин гартаа урт илд барьжээ.

- Жоффригийн хуримын бэлэг гэж тэр Тирионд хэлэв. Ромбо хэлбэрийн шилэн цонхоор гэрэл тусахад лорд Тайвин илдний ирийг эргүүлэн шалгасанд хар улаанаар гялалзан хамгаалалт болон толгойноос нь алтан дөл улалзана.

- Энэ бүх Станнисийн шидэт илдний тухай тэнэг ярианы дараа бид Жоффрид ямар нэг ер бусын юм өгөх ёстой. Хаан хүн хаан ёсны зэвсэг хэрэглэх ёстой.

- Энэ Жоффод дэндүү томдоно гэж Тирион ажиглав.

- Тэр илдээ барихаар өснө. Жинг нь мэдэрч байна уу гээд эцэг нь түүнд илдийг бариулаар нь өглөө.

Илд санасныг бодоход хөнгөн ажээ. Тирион гартаа эргүүлэн үзэхдээ яагаад тийм болохыг нь мэдлээ. Зөвхөн ганцхан ганыг тулалдаан даахуйц ийм нимгэн болтол давтаж болох бөгөөд хэдэн мянга удаа эргүүлэн давтсаны тэмдэг болох долгион мяралзана.

- Валирианы ган уу?

- Тийм гэж лорд Тайвин дээд зэргийн сэтгэл ханамжтай хоолойгоор хэлэв.

Ийм удаан хугацааны эцэст гэж үү, аав аа? Валираны ган туйлын ховор үнэтэй ертөнцөд хэдхэн мянга үлдсэнээс Долоон ханлигт хоёр зуугаадхан нь байлаа. Ланнистерийн овогт ганц ч илд байдаггүй явдал эцгийг нь үргэлж уурлуулна. Хадны хуучин хаад өөрийн гэсэн илдтэй байсан ч их илд "Чанга хүрхрэлт" хоёрдугаар Томмен хаан Валириа руу утгагүй дэмий зүйлийн араас хөөцөлдөн явахад алдагджээ. Тэр эргэж ирээгүй учир эцгийнх нь дүү нараас хамгийн залуу хөнгөмсөг болох авга ах Гери найман жилийн дараа алдагдсан илдийг хайхаар яваад бас эргэж ирсэнгүй.

Лорд Тайвин гурван ч удаа Валирианы урт илдийг ядуурч хоосорсон дорд овгуудаас худалдаж авахыг санал болгосон ч хүсэлт нь үргэлж хатуу татгалзалтай тулгарч байлаа. Жижиг лордууд охидоо Ланнистерийн гуйхад дуртайяа өгөх хэдий ч эртний гэр бүлийн уламжлалт илдээ хадгалахыг илүүд үзнэ.

Тирион илдийн хаанаас гарч ирснийг гайхширлаа. Валириа мөхөх үеэр нууц нь алдагдсан болохоор хэдхэн тооны зэвсгийн дархан эртний Валирианы гантай ажиллаж чадах байв.

- Өнгө нь хачин юм гээд Тирион илдийг нарны гэрэлд тойруулан ажиглав. Валирианы ихэнхи илд бараан сааралдуу бараг хар гэмээр байдаг болохоор энэ нь тийм бөгөөд давхаргад нь саарлын адил гүн улаан өнгө холилджээ. Хоёр өнгө нэг нэгэндээ хүрэлгүй зөрөн умбаж долгион нь хүртэл зайтай харанхуй шөнийн ган эрэг дэх цусан долгион шиг харагдана.

- Чи яаж ийм хээ гаргаа вэ? Би хэзээ ч үүн шиг зүйл харж байсангүй.

- Би биш, эрхэм лорд. Би ийм өнгө гаргах гээгүй ч яаж давтахыг мэдсэнгүй. Таны лорд эцэг надаас танай овгийнхоо хүрэн улаан өнгийг гаргаж өгөхийг хүссэн учир би тийм өнгө гарган авахыг хичээсэн. Гэвч Валирианы илд дийлдэшгүй зөрүүд байсан. Хуучин илд санадаг гэж хэлцдэг болохоор өнгө нь хялбархан өөрчлөгддөггүй юм. Би тод улаан болгодог хагас зуун янзын шившлэг ар араас нь оролдож үзсэн ч илд нарны гэрлийг уух адил өнгө нь бараан хэвээр байсан. Зарим долгионы улаан өнгө аваагүйг харж байгаа биз дээ. Хэрвээ Ланнистерийн лордуудын таалалд нийцэхгүй байгаа бол би шаардлагатай хугацаанд оролдож үзэж болох ч...

- Хэрэггүй. Энэ болно гэж лорд Тайвин хэлэв.

- Хүрэн улаан илд наранд сайхан гялалздаг ч үнэнийг хэлэхэд надад энэ өнгө таалагдаж байна.

Энэ нь сүрлэг үзэсгэлэн болохоор илдийг улам ч ховор болгож байгаа юм. Ертөнцөд өөр ийм илд байхгүй гэж бодож байна гэж Тирион хэлэв.

- Энд ахиж нэг бий гээд зэвсгийн дархан ширээн дээр тавьсан тос болсон хуйлаастай даавуунаас хоёр дахь урт илдийг гаргалаа.

Тирион Жоффригийн илдийг тавьж нөгөөг нь авлаа. Энэ хоёр ихэр биш ч хоорондоо ойролцоо ах дүүс байв. Энэхүү илд нь хүнд зузаан хагас инчээр өргөн, гурван инчээр урт бөгөөд ижилхэн тол шугам, ижилхэн өвөрмөц хээ болох шөнийн мяралзсан цусан долгионтой байлаа. Гурван гүн хагалбар хоёр дахь илдний үзүүрээс бариул руу гүйсэн байхад хааны илдэнд зөвхөн хоёр байлаа. Жоффригийн илдний бариул илүү их хээ угалзтай хуйны хамгаалалтын бариул нь арслангийн бадмаараг сарвуу байхад хоёр дахь илдний бариулыг сайн чанарын улаан хүрэн өнгийн ширээр бүрж алтан арслангийн толгой хийжээ.

- Гайхамшигтай. Би хэзээ ч ийм сайхан тэнцвэрийг мэдэрч байсангүй гээд Тирионы дадлагагүй гарт хүртэл илд амьд мэт мэдрэгдэв.

- Энэ миний хүүгийнх.

Ямар хүүгийнх гэдгийг нь асуухын ч хэрэг алга. Тирион Жэймигийн илдийг ширээн дээр Жоффригийн илдний хажууд буцааж тавиад Робб Старк ахыг нь хэр удаан хугацааны дараа тавих эсэхийг гайхширлаа. *Манай эцэг үүнийг тооцсон байх ёстой. Үгүй бол хаанаас ийм илд хийлгэнэ гэж?*

- Та сайн ажиллажээ, дархан Мотт. Миний бойдоо хөлсийг чинь төлөх болно. Дээрээс нь хуйны бадмааргыг сануулаарай гэж лорд Тайвин дарханд хэлэв.

- Тэгнэ ээ, эрхэм лорд. Та дэндүү өгөөмөр юм гээд дархан илднүүдийг тостой даавуунд буцаж боон өрөөсөн гартаа бариад өвдөг сөгдлөө.

- Хааны гарт зүтгэх нь нэр хүндийн хэрэг. Би илднүүдийг хуримын өмнөх өдөр илгээе.

- Түүний тулд хичээгээрэй.

Харуулууд дархныг гаргамагц Тирион сандал руу мацан авирлаа.

- Тэгэхээр Жоффод илд, Жэймид илд одойд хутга ч байхгүй юм биз дээ. Энэ таны арга уу, аав аа?

- Ган хоёр илд хийхэд хүрэлцээтэй байснаас биш гурав биш. Хэрвээ чамд чинжаал хэрэгтэй юм бол зэвсгийн агуулахаас нэгийг авч болно. Роберт үхэхдээ зуугаадыг үлдээсэн. Герион түүнд зааны ясан бариул, индраанил толгойтой алтадсан чинжаал хуримын бэлэг болгон өгч ордонд ирсэн элчүүдийн тэн хагас нь эрхэм дээдсийн таалалд нийцэхийн тулд үнэт чулуун шигтгээтэй хутга, мөнгөн хээтэй илд бэлэглэдэг байсан.

- Тэд түүнд охидоо бэлэглэсэн бол илүү баярлуулах байсан даа гээд Тирион инээмсэглэв.

- Тийм нь гарцаагүй. Тэр зөвхөн хүүхэд байхад нь Жон Аррин бэлэглэсэн ангийн хутгийг хэрэглэдэг байсан юм гээд лорд Тайвин Роберт хаан болон хутганых нь тухай яриа дууссаны тэмдэг болгон гараа дохив.

- Чи голын өмнө талын эрэгнээс юу олов?

- Шавар шороо хэн ч оршуулахыг санаа тавиагүй хэдэн үхдэл. Бид боомтыг ахин нээхээс өмнө Хар усыг живсэн хөлөг онгоцны сэгээс цэвэрлэх хэрэгтэй. Зогсоолын дөрөвний нэгийг засах юм уу буулгаж эргэн барих хэрэгтэй байна. Загасны зах бүхэлдээ үгүй болж Голын хаалга, Хааны хаалга хоёул Станнисийг нүдэх үед хэмхэрсэн болохоор солих шаардлагатай. Би үүний зардал ямар болох тухай бодохоос ч эмээж байна гээд *хэрвээ та алтаар баадаг бол жорлонд суугаад завгүй ажиллаж эхэлсэн чинь дээр дээ* гэж хэлэхийг хүссэн ч хэлэхгүй байсан нь дээр гэдгийг мэдэж байлаа.

- Чи шаардагдах хэмжээний алтыг ол.

- Би юу? Хаанаас тэр вэ? Эрдэнэсийн сан хоосорсон гэж би таньд хэлсэн биз дээ. Бид алхимичдэд зэрлэг галынх нь үнэ, дархнуудад миний гинжний хөлсийг төлөөгүй. Серсейгийн хааны титэм Жоффригийн хуримын зардал болох... далан долоон төрлийн хоол, дотроо тагтаатай бялуу, дуучид, жонглёрчдийн дөнгөж хагасыг төлж....

- Тансаг байдал ашигтай. Бид бүхий л хаант улсад Кастерли Рокийн эд баялаг сүр хүчийг үзүүлэх ёстой.

- Тэгвэл Кастерли Рок худалд л даа.

- Яах гэж тэр вэ? Би Чигчий хуруугийн данс бүртгэлийг харсан. Титмийн татвар Эйрисийн үеийнхээс арав дахин илүү нэмэгдсэн.

- Зардал нь ч гэсэн. Роберт шигээ зоосондоо самуун явдал шигээ өгөөмөр байсан. Чигчий хуруу баруун солгойгүй зээл тавьсан. Таны хувьд бусадтай ижил. Тиймээ, татварын хувьд нэмэгдсэн ч Чигчий хуруугийн зээллэгийн хүүг дөнгөж дарах төдий хүрэлцээтэй. Та хаан ширээний Ланнистерийн овогт тавьсан өрийг мартчихаа юу?

- Битгий утгагүй юм яриад бай.

- Тэгвэл долоон төрлийн хоол байхад хангалттай. Мянгын оронд гурван зуун зочин уриг л дээ. Би энэ гэрлэлтийг бүжиглэдэг баавгүйгээр бүтнэ гэж бодож байна.

- Тайреллийнхан биднийг харамч нарийн гэж бодно. Би хуримыг, усны өмнө талын эрэгтэй адил гүйцэлдүүлнэ. Хэрвээ чи тэдний зардлыг олж чадахгүй гэж байгаа бол би зоосны сангийн эзнээр чадах хүн олохоос.

Ийм богино хугацааны дараа халагдах нь шившиг тул Тирион хүссэнгүй.

- Би мөнгийг чинь олъё гэв.

- Чи тэгэх болно. Чамайг үүнийг хайж байх зуураа эхнэрийнхээ орыг ч гэсэн олж чадна гэж найдья.

Тэгэхээр энэ яриа түүнд хүртэл хүрээ шив дээ.

- Тиймээ, таньд баярлалаа. Энэ бол цонх зуух хоёрын дунд байдаг хилэн хөшигтэй галууны өдөн гудаастай тавилга.

- Чамайг мэдэж байгаад чинь баяртай байна. Одоо ороо хуваалцаж байгаа эмэгтэйг нь мэдэх гээд үзвэл яасан юм.

Эмэгтэй хүн гэнэ ээ? Хүүхэд гэж та хэлэх гээ юу?

- Аалз таны чихэнд шивнээ юу эсвэл би хонгор эгчдээ баярлалаа гэж хэлэх ёстой юу? гээд Серсейгийн хөнжил доторх явдлыг анхааралд нь оруулвал тэр хамраа Тирионы хэрэг рүү дүрэхгүй байлаа.

- Надад хэлээч яагаад Сансагын бүх зарц эмэгтэйчүүд Серсейд үйлчилдэг юм бэ? Би унтлагын өрөөндөө хүртэл тагнуулахаас залхаж байна.

- Хэрвээ чамд эхнэрийн чинь зарц нар таалагдахгүй байгаа бол халаад хүссэнээ хөлслөхгүй юу. Энэ бол чиний эрх. Чиний эхнэрийн охин нас намайг зовоож байгаагаас биш түүний зарц нар шиг миний сэтгэлийг зовоохгүй байна. Энэ эелдэг байдал чинь гайхширал төрмөөр байна шүү. Чи янхантай төвөггүй оронд ордог мөртлөө Старкийн охины хувьд өөр байна уу?

- Та яагаад миний ор дэрний асуудлыг ингэтэл сонирхоод байгаа юм бэ? Санса дэндүү залуу байна шүү дээ.

- Тэр ах нь үхмэгц Винтерфеллийн хатагтай болох хангалттай насанд хүрсэн. Түүний охин насыг авбал чи умардыг авах эрхэд нэг алхам ойртох болно. Хэрвээ хүүхэдтэй болговол бүх шагналыг хожлоо гэсэн үг. Чамд зохицоогүй гэрлэлтийг цуцалж болдогийг сануулах хэрэг алга.

- Их септон юм уу Итгэлийн зөвлөл тэгдэг. Манай Их септон тушаал хэлсэн хэний ч үгийг биелүүлэх сургуультай амьтан. Сарны хүү түүнээс илүү миний гэрлэлтийг цуцалж чадна.

- Тэгвэл би Санса Старкийг Сарны хүүтэй гэрлүүлэх ёстой байж. Тэр түүнд юу хийх ёстойгоо мэдэх байсан даа гэхэд Тирионы гар сандлын түшлэг атгалаа.

- Би эхнэрийнхээ охин насны тухай бүх яриаг сонслоо. Гэвч биднийг гэрлэлтийн тухай ярилцсан энэ удаан хугацаанд яагаад эгчийн минь хуримын ёслолын талаар дурьдагдахгүй байна вэ? Миний санаж байгаагаар...

- Мэйс Тайрелл залгамжлагчийг нь Серсейтэй гэрлүүлэх миний саналаас татгалзсан гэж лорд Тайвин яриаг нь таслав.

- Манай үзэсгэлэнт Серсейгээс татгалзсан гэнэ ээ? гээд Тирион сэтгэл хамаагүй дээрдлээ.

- Би түүнтэй анх удаа энэ тухай ярих үед лорд Тайрелл хамаагүй дээр хүлээн авч байсан юм. Гэвч нэг өдрийн дараа гэхэд бүх зүйл өөрчлөгдсөн. Хөгшин эмгэний хийж байгаа ажил. Тэр хүүгээ толгой түрүүгүй загнаж байдаг. Варис түүнийг өрөөсөн хөлтэй үнэт ач хүүд нь дэндүү хөгшин дэндүү ашиглагдсан гэж хэлсэн гэсэн.

- Серсейд энэ лав таалагдсан байх даа гээд Тирион инээд алдлаа.

Лорд Тайвин түүнийг хүйтнээр ширвэлээ.

- Тэр энэ тухай мэдээгүй. Мэдэх ч ёсгүй. Бид нар үүнийг санал болгоогүй байсан бол дээр байсан юм. Үүнийг санаж яв, Тирион. Саналыг хэзээ ч тавиагүй гэдгийг.

- Ямар санал? гээд Тирион лорд Тайреллийг няцаагдсандаа харамсаж байна гэж бодлоо.

- Эгч чинь хүнтэй гэрлэх болно. Асуудлын гол нь хэнтэй гэдэгт байна? Надад хэдэн бодол байгаа ч... гээд түүнийг энэ тухай хэлж амжихаас өмнө хаалга тогших чимээ гарч харуулын хүн толгойгоо цухуйлган эрхэмсэг мэйстер Пациллыг ирснийг мэдэгдэв.

- Түүнийг оруул гэж лорд Тайвин хэллээ.

Пацилл таягаа тог тог хийлгэн орж ирснээ зогсож Тирион руу гашилсан сүү аятай царайгаа үрчийлгэн харлаа. Түүний урьдын сүрлэг цагаан сахлыг хэн нэгэн хайр найргүй огтолсон болохоор буцаж шингэн сөрвийн ургажээ.

- Эрхэм лорд гар минь Хар цамхагаас ахин нэг шувуу иржээ. Бид тусдаа үг сольж болох уу? гээд аль болох унахгүйн тулд чадах чинээгээрээ бөхийн ёслол.

- Тэгэх шаардлагагүй. Тирион үлдэж болно гээд лорд Тайвин эрхэмсэг мэйстер Пациллыг суу хэмээн зангав.

Өө би болно гэж үү? Тирион хамраа үрчин хүлээлээ.

Пацилл удтал хоолой засан ханиалгав.

- Захиа сүүлд ирсний адил цайзыг захирч үлдсэн Боуэн Маршаас иржээ. Тэр лорд Мормонт зэрлэгүүд өмнө зүг их хэмжээний хүчээр хөдөлсөн тухай мэдээ илгээснийг бичжээ.

- Хананаас цаадах газар нутаг өргөн хэмжээний хүчийг дэмжихгүй. Энэ анхааруулга шинэ биш гэж лорд Тайвин шийдэмгий хэлэв.

- Энэ бол эцсийнх нь, эрхэм лорд. Мормонт сүнстэй ойгоос шувуу илгээн дайралтанд өртсөн тухайгаа мэдэгджээ. Гэвч үүнээс хойш ирсэн хэрээнүүдэд ямар ч захиа байсангүй. Иймээс Боуэн Марш лорд Мормонтыг бүх хүмүүсийнхээ хамт алагдсан гэж эмээж байгаа юм.

Тирионд хөгшин Жеор Мормонтын ширүүн авир, ярьдаг шувуу нь таалагддаг байлаа.

- Энэ баталгаатай юу? гэж тэр асуулаа.

- Баталгаатай биш. Гэхдээ Мормонтын хүмүүсээс хэн нь ч эргэж ирээгүй байгаа. Марш зэрлэгүүд тэднийг алсан болохоор Хана дараагийн удаад нь дайралтанд өртөнө гэж бодож байгаа юм гээд жанчаа тэмтчин хуудас цаас гаргаж ирлээ.

- Энэ таван хаанаас бүгдээс нь гуйсан захиа нь байна, эрхэм лорд. Тэр биднийг чадах чинээгээрээ олон хүн тооны илгээхийг хүсчээ.

- Таван хаан гэнэ ээ? Вестеросд ганц хаан бий. Тэр хар тэнэгүүд эрхэм дээдсээс тусламж гуйхдаа үүнийг санаж байвал дээрсэн. Чи хариу захиандаа Рэнли үхсэн болохоор бусад нь урван тэрслэгч, дүр эсгэгчид гэж бич хэмээн лорд Тайвин хилэглэв.

- Тэд үүнийг мэдэхдээ эргэлзээгүй туйлын баяртай байх бизээ. Хана ертөнцийн хязгаарт байдаг болохоор сүүлийн үед мэдээ тэдэнд хожуу очдог юм гээд Пацилл толгойгоо дээш доош бөнжигнүүлэв.

- Би Маршад гуйсан хүнийх нь талаар юу гэж хэлэх вэ? Бид зөвлөлийг хуралдуулвал...

- Тэгэх шаардлагагүй. Шөнийн харуул бол хулгайч, алуурчин, дорд гаралтай бүдүүлгүүдийн бүлэг болохоор зөвхөн сахилга баттай гараар захирах хэрэгтэй. Хэрвээ Мормонт үнэхээр үхсэн бол хар ахан дүүс шинэ захирагч лордоо сонгох ёстой гэхэд Пацилл Тирион руу зальжин хяламхийв.

- Маш сайхан бодол байна, эрхэм лорд. Би түүнд тохирох хүнийг мэднэ. Жэйнос Слингт гэхэд Тирионд энэ бодол огтхон ч таалагдсангүй.

- Хар ахан дүүс өөрсдийн удирдагчаа сонгодог. Лорд Слингт Ханан дээр шинэ хүн. Би түүнийг илгээсэн болохоор сайн мэдэж байна. Бид яагаад түүнийг бусад ахмад тушаалын хүнээс нь дээгүүр тавих ёстой гэж?

- Учир нь тэд хэлсэн ёсоор санал өгөхгүй бол Хана өөр хүн олохоос өмнө нуран унана гэж эцэг нь Тирионыг гэнэн хүн мэт сургамжлан хэлэв.

Тиймээ, энэ бүтэж болох юм. Гэсэн ч Тирион урагш зүтгэлээ.

- Жэйнос Слингт бол буруу хүн, аав аа. Бид Сүүдэрт цамхаг юм уу Дорнод тэнгисийн харуулын захирагчаас арай илүү тохиромжтой хүн олох ёстой.

- Сүүдэрт цамхагын захирагч бол Сигардын Маллистер. Дорнод харуулыг төмөр арлын хүн барьж байгаа гээд тэдний алин ч зорилгод нь нийцэхгүй нь лорд Тайвины хоолойны өнгөнд илхэн байлаа.

- Жэйнос Слингт бол нядлагчийн хүү. Та өөрөө л түүнийг надад... гэж Тирион эцэгтээ сануулав.

- Би чамд хэлсэн үгээ санаж байна. Гэсэн ч Хар цамхаг бол Харренхал биш. Шөнийн харуул бол хааны зөвлөл биш. Зорилго бүрт тохирох хэрэгсэл байдаг юм харин хэрэгсэл бүрт өөрийн арга зам бий.

- Лорд Жэйнос бол өөрийгөө өндөр үнэ өгсөн хүн бүрт зардаг хоосон хөндий хуяг гээд Тирионы уур дүрсхийлээ.

- Би түүний энэ занг тооцсон. Биднээс өөр хэн өндөр үнэ өгнө гэж? гээд Тайвин Пацилл руу эргэлээ.

- Хэрээ илгээ. Хаан Жоффри захирагч лорд Мормонтын үхлийг сонсоод гүнээ харамсан гашуудаж байгаа ч одоо маш олон бослого дэгдээгч булаан эзлэгч тулааны талбарт байгаа учир илүүчлэх хүн байхгүйд харамсаж байна. Хаан ширээний аюулгүй байдлын тулд... хаан Харуулын захирагчид бүрэн итгэлтэй байх хэрэгтэй гээд Маршад эрхэм дээдэс үнэнч нөхөр зарц лорд Жэйнос Слингтэд дуртайг сануулаарай.

- За, эрхэм лорд. Би Гарын тушаалын дагуу захиа бичье. Туйлын хүндэтгэлтэйгээр гээд Пацилл толгойгоо ахин бөнжигнүүлэв.

Би түүний сахлыг биш толгойг нь хяргах ёстой байж. Слингтийг хүндэт нөхөр Аллар Диймийнх нь араас сэлүүлэх ёстой байж гэж Тирион тунгаав. Ядаж л тэр Мөнгөн хэлт Саймонд ижил алдаа хийхгүй. Намайг харж байна уу, аав аа? Хэр түргэн хичээлээ суралцаж байгаа минь? гэж дуу алдан хашгирахыг хүслээ.

СЭМВЭЛ

Дээд талын дээврийн хөндийд төрж байгаа эмэгтэй чимээтэй ёолоход, дор галын дэргэд нас нөгчиж буй эрэгтэй хэвтэж байлаа. Сэмвэл Тарли хэнээс нь илүү айхаа мэдсэнгүй.

Хөөрхий Баннений дээр овоолсон арьс хучиж галаа өндөр өрдсөн ч тэр үргэлж,

- Би даарч байна. Гуйж байна даараад байна гэж хэлээд байлаа. Сэм түүнд сонгинотой халуун шөл өгөхийг оролдсон ч уусангүй дахин халбагадахын зуургүй уруулыг нь даван эрүүг нь дагаж урсав.

- Наадах чинь үхэж байна. Хэрвээ надаас асуувал ам руу нь шөл халбагадахын оронд цээжинд нь хутга зоосон нь хамаагүй энэрэнгүй хэрэг гэж Крастер зайдас зулгаах зуураа хайхрамжгүй ширтэн хэллээ.

- Чамаас асууснаа санахгүй л юм байна. Хөнөөгчөө чи Крастераас зөвөлгөө асуусан уу? гэж жинхэнэ нэрийг нь Бедвик гэдэг таван фунтаас өндөргүй жижигхэн биетэй ч эрс зантай Аварга хэлэв.

Сэм нэрийг нь хэлэхэд атийснаа толгой сэгсэрлээ. Тэр ахин шөл халбагадаж Баннений аманд уруулынх нь завсар хийхийг хичээлээ.

- Бид чамаас зөвхөн гал, идэх юм гуйсан. Харин тэгэхэд чи биднээс хоолоо харамлаж байна гэж Аварга үргэлжлүүлэв.

- Та нараас бас галаа харамлаагүйдээ баярлаж байна гээд Крастер өдөр шөнөгүй өмсдөг өмхий ноорхой хонины арьсан дээлтэй махлаг бүдүүн хүн байлаа. Тэр өргөн навтгар хамар, өрөөсөн тал руугаа унжсан амтай, чихгүй ажээ. Даахирч ширэлдсэн үс сахалд нь цагаан өнгө бууралтаж яваа цохиход хүчтэй хатуу ясан нударгатай байлаа.

- Би та нарыг байгаа бүхнээрээ тэжээсэн ч хэрээнүүд үргэлж өлсгөлөн байдаг. Хэрвээ би шүтлэгтэй хүн байгаагүй бол та нарыг хөөж зайлуулах байлаа. Та нар надад түүний шалан дээр минь үхэх таалагдаж байгаа гэж бодож байна уу? Чи амаа нээхийн өмнө бодож байсан чинь дээр шүү, бяцхан хүн минь? гээд зэрлэг нулимж,

- Хэрээнүүд. Хар хэрээнүүд хэзээ хүний орон гэрт сайн зүйл авчирч байсан юм бэ гэж би та нараас асуух байна? Хэзээ ч шүү. Хэзээ ч тийм зүйл байхгүй гэв.

Баннений амны булангаас улам их шөл асгарахад Сэм ханцуйныхаа үзүүрээр арчив. Эргүүлийн нүд нээлттэй байсан ч юу ч харахгүй байлаа.

- Би даарч байна гэж ахин сулхан гиншив. Мэйстер байсан бол түүнийг яаж аврахыг мэдэх байсан ч тэдэнд мэйстер байсангүй. Цагаан нүдэт Кэж Баннений зэрэмдэглэгдсэн хөлийн тавхайг есөн өдрийн өмнө тайрч хаясан ч аль хэдийн хожимджээ.

- Би даарч байна гэж цайвар уруул өмөлзөн давтав.

Өргөөний дотор ойролцоогоор хориод тооны хар ахан дүүс шалан дээр юм уу бүдүүлэг хийцийн модон сандал дээр суугаад аяганаас ижилхэн сонгинотой шингэн шөл оочин хатсан талхны өөдөс хэмлэнэ. Хоёр хүн Банненаас ч дор шархаджээ. Форнио хэдэн өдрийн турш халуундаа солиорч, сэр Биамын мөрнөөс өмхий шаргал идээ шүүрнэ. Тэд Хар цамхагаас гарах үед Хүрэн Бернар хүүдийтэй Миришийн гал, гичний тос, нунтаг сармис, танси, намуу цэцэг, хааны зэс болоод өөр бусад эмчилгээний ургамалтай хүүдий авч гарчээ. Тэр бүү хэл өвдөлтгүй үхүүлдэг "амтат нойр" хүртэл байлаа. Гэвч Хүрэн Бернар Нударган дээр алагдсан учир хэн ч мэйстер Эймоны эмийн ургамал хаана байгааг мэдсэнгүй. Хэйк хоол хийхийн хажуугаар бага сага өвс ургамал мэддэг байсан ч бас үрэгджээ. Одоо амьд үлдсэн хүмүүсийн дунд шархадсан хүнийг эмчилэх талаар мэдэх хүн цөөхөн байв. *Ядахдаа л тэд энд галын дэргэд хуурай дулаахан байна. Гэхдээ тэдэнд илүү хоол хэрэгтэй.*

Тэдэнд бүгдэд хоол хэрэгтэй байв. Хүмүүс дургүйцлээ илэрхийлэн өдрийн турш чанга гүвтнэнэ. Модон хөлт Карл Крастерийн хүнсний нууц агуулахын тухай эцэс төгсгөлгүй ярьж, Хуучин хотын Гарт захирагч лорд сонсоогүй үед түүнийг нь хадны цуурай мэт давтана. Сэм шархтай хүмүүсийг хооллох жаахан хүнс гуйдаг юм уу гэж бодсон ч зориг нь хүрсэнгүй. Крастерийн нүд хүйтэн хэрцгий бөгөөд зэрлэг Сэм рүү харах болгондоо нударга зангидах гэж байгаа юм шиг гар нь татвалзана. *Тэр намайг энд сүүлд байхдаа Гиллитэй ярьсаныг мэдсэн юм болов уу? Тэр түүнд намайг авч явна гэснийг маань хэлсэн юм болов уу? Тэр түүнийг үүний төлөө зодсон болов уу?*

- Би даарч байна. Гуйж байна даараад байна гэж Баннен яраглав.

Крастерийн өргөөнд дүүрэн утаа дулаахан байсныг үл харгалзан Сэм даарч байгаагаа мэдэрлээ. *Дээрээс нь ядарч байна. Хичнээн их зүдэрч байна гээч.* Тэр унтаж амрах хэрэгтэй байсан боловч нүдээ анимагц исгэрэн буй цасан шуурганд хөлөө чирэн ойртох хар гар, тод цэнхэр нүдтэй үхдлүүд харагдаад байлаа.

Дээврийн хөндийд Гилли чичирэн уйлахад намхан цонхгүй танхимд цуурайтана.

- Дүл. Ахиад хүчтэй. Улам хүчтэй. Хүсвэл хашгирсан ч болно гэж Крастерийн хөгшин эхнэрүүдийн нэг түүнд чанга хэлэхэд Гилли хашгирсанд Сэм өөрийн эрхгүй ярвайлаа.

Крастер толгойгоо эргүүлэн муухай харлаа.

- Би наад хашгиралтанд чинь ханаж цадаж гүйцлээ. Түүний аманд алчуур чихэхгүй бол би дээшээ гарч нударганыхаа амтыг үзүүлэх болно шүү гэж дээшээ хашгирав.

Түүнийг тэгнэ гэдгийг Сэм мэдэж байв. Крастер арван есөн эхнэртэй ч шат өгсөн гарсан тохиолдолд хэн ч түүнд садаа болохгүй. Хар ахан дүүсийг ирээд хоёр ч хоноогүй байхад тэр залуухан охидын нэгийг нүдэхэд тэд хоорондоо шивнэлджээ.

- Тэр түүнийг алах нь байна гэж Ногоон замын Гарт хэлэхэд, Модон хөлт Карл инээд алдан,

- Хэрвээ тэр ийм жижигхэн аятайхан амьтныг хүсэхгүй бол надад өгвөл таарна гэж хэлжээ. Хар Бернар аяархан хоолойгоор ууртайгаар хараахад, Росбигийн Алан сонсож тэвчилгүй босож

гадагш гарав.

- Түүний дээвэр хойно түүний дүрэм. Крастер бол Харуулын анд нөхөр гэж Роннел Харкли тэдэнд санууллаа.

Нөхөр гэж Сэм Гиллигийн бөглүү хашгиралтыг сонсох зуураа бодов. Крастер эхнэр охидоо төмөр гараар хатуу баздаг хэрцгий хүн бөгөөд толгой хоргодож буй хүмүүстээ ч гэсэн үүнийгээ үзүүлнэ.

- Хөлдүү хэрээнүүд. Хойд зүг явсан шигээ том сүрэг буцаж ирсэнгүй шив дээ гэж тэднийг анх хөрцас, үхдэл, тэсгим жавраас амьд үлдсэн хэсэг нь гэлдрэн орж ирэхэд хэлжээ. Гэсэн ч тэр тэдэнд шалан дээрээ зай гарган өгч дээвэр дороо цаснаас хоргодуулан, гал түлэн дулаацуулж, эхнэрүүд нь дотрыг нь дулаацуулах халуун дарстай аяга авчирч өгчээ.

- Хараал идсэн хэрээнүүд гэж тэрбээр тэднийг хомсхон хоолоор тэжээхдээ дуудна.

Бид бол зочид. Гилли бол түүнийх. Түүний охин, эхнэр нь. Түүний дээвэр хойно түүний дүрэм гэж Сэм өөртөө санууллаа.

Тэднийг анх Крастерийн өргөөнд ирэх үед Гилли тусламж гуйхад Сэм том гэдсийг нь далдлан хар нөмрөгөө нөмрүүлээд Жон Сноутай уулзуулсан билээ. *Хүлэг баатрууд хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах ёстой. Хэдийгээр хар ахан дүүсийн дунд цөөхөн тооны хүлэг баатар байсан хэдий ч... Бид бүгд андгайн үгээ хэлсэн. Би хаант улсын хүмүүсийг хамгаалах бамбай.* Эмэгтэй хүн бол эмэгтэй хүн болохоор зэрлэг байсан ч гэсэн эмэгтэй хүн. *Бид түүнд туслах ёстой. Бид ёстой.* Гилли хүүхдийнхээ төлөө түүнийг хүү байхаас айж байжээ. Крастер охидоо өсч том болоход нь эхнэр болгон авдаг болохоор хөвгүүдийнхээ хэнийг ч үлдээдэггүй байв. Гилли Жонд Крастерийг хөвгүүдээ бурхдад өргөдөг гэж хэлжээ. *Хэрвээ бурхад ивээвэл түүнд охин заяагаасай* гэж Сэм мөргөлөө.

Дээр ханзан дээр Гилли гиншин хашгирав.

- Болж байна. Ахиад нэг дүл. Одоо толгой нь цухуйж байна гэж эх барьж байсан эмэгтэй хэлэв.

Охин. Охины толгой гэж Сэм цөхрөн бодлоо.

- Хүйтэн байна. Гуйж байна би даараад байна гэж Баннен сулхан шивнэв. Сэм аяга халбагаа хажуу тийш тавьж нас нөгчиж буй хүн дээр арьс нэмэн нөмөргөөд галдаа гишүү нэмэн өрдлөө. Гилли хашгиран хүндээр амьсгаадаж эхлэв. Крастер хатуу хар зайдас зулгаана. Тэр зайдсыг өөртөө болон эхнэрүүдээ зориулснаас биш Харуулуудад хамаагүй гэж хэлжээ.

- Үргэлж л орилж байх юм даа энэ эмэгтэйчүүд. Надад ганцхан хүржигнээд найман торой төрүүлдэг тарган мэгж байсан гээд Крастер амаараа дүүрэн юм зажлангаа толгойгоо эргүүлж Сэм рүү зэвүүцэн хяламхийснээ,

- Тэр бараг л чам шиг тарган байсан, хүү минь. Хөнөөгчөө гээд хөхөрлөө.

Сэм үүнийг тэсч чадсангүй. Галаас бүдчин холдож эргэн тойронд шалан дээр унтаж байгаа болон

үхэж байгаа хүмүүсийн дээгүүр эв хавгүйхэн алхан гарлаа. Утаа хашгиралт ёлолт дотрыг нь муухайруулахад толгойгоо бөхийлгөн Крастерийн хаалганы бугын арьсан сөхүүрийг түлхэж гадагш гарлаа.

Бүрхэг хэдий ч тод өдөр байсан тул харанхуй газар байсны дараа нүд нь гялбалаа. Цасан ширхэг эргэн тойрны модны мөчрийг зузаан дарж алтан шаргал толгодыг хучжээ. Крастерийнд ирснээс хойш шуурга намдсан ч дулаан ч биш хүйтэн ч биш байлаа. Сэм дээврийн зузаан ширэгний эмжээрээс унжсан мөсний подхийн дуслах чимээг сонсов. Биеэ жихүүцтэл гүн амьсгаа аваад эргэн тойрноо харлаа.

Хашааны баруун хэсэгт Өрөөсөн гарт Олло, Тим Стоун хоёр морины уяа дагуу явж үлдсэн морьдоо усалж тэжээнэ.

Салхины уруу талд хэсэг ах дүүс явж чадахааргүй сульдсан морьдоо алж өвчиж байв. Крастерийн ой талаас нуугдсан цорын ганц хамгаалалт болох шороон далангийн ард жад, нум сумтай харуул зогсож арваад задгай түлсэн галаас саарал цэнхэрдүү өтгөн утаа баагина. Сэмд алсад шөнийн турш түлэх мод түүж буй хүмүүсийн сүхний хангинах чимээ сонслоо. Шөнө хамгийн аюултай үе байсан бөгөөд харанхуй хүйтэн болдог билээ.

Тэд Крастерийнд ирсэн цагаас хойш Өөрүүд болон үхдлүүдийн дайралтанд өртсөнгүй. Өртөх ч үгүй гэж Крастер хэлжээ.

- Шүтлэгтэй хүнд ийм зүйлээс айх шалтгаан байхгүй. Би урьд нь Манс Райдерийг үүгээр шиншлэн өнгөрөхөд үүнийг хэлсэн ч тэр сонсоогүй. Танай хэрээнүүд ч гэсэн адилхан илдтэйгээ тэнэг галаа түлсэн. Цагаан хүйтэн ирэх үед эд нарын алин ч та нарт тус болохгүй. Зөвхөн бурхад чамд туслана. Та нар зөв бурхдаа шүтэж эхэлсэн чинь дээр байх шүү.

Гилли бас цагаан хүйтэн болон Крастерийн бурхдадаа ямархуу төрлийн өргөл өргөдөг тухай ярьжээ. Сэм тэгэхэд түүнийг алахыг хүссэн ч *хананаас цааш хууль байхгүй. Крастер бол Харуулын анд нөхөр* гэж өөртөө санууллаа.

Шавардсан бургасан ханатай байшингийн цаана сөөнгө хашгиралт гарахад Сэм юу болсныг харахаар явлаа. Хөл нь газар хайлсан цас, Долорус Эддийн Крастерийн ялгадас гэж хэлж байсан зөөлөн шаварт шигдэнэ. Энэ нь ялгадаснаас өтгөн бөгөөд Сэмийн гутлыг чанга хөхөн сороход арай ядан сугалж байлаа.

Ногооны талбай, хоосон хонины хашааны ард арваад хар ахан дүү сүрлэн чихмэл рүү бай харвана. Хонгор Доннел гэж дууддаг гоолиг шаргал үстэй бойдоо тавин ярдын зайд бухын нүд оноод,

- Алив ээ үүнээс илүү гарах гээд үз дээ, хөгшин минь гэж хэллээ.

- Тэгье л дээ гээд буурал сахалтай хэлхгэр хувцастай Улмер тэмдэглэсэн газар луу алхан бүсэлхийндээ зүүсэн саадагнаас сум сугалж авлаа. Тэр залуу байхдаа алдарт Хааны ойн ахан дүүсийн дээрэмчдийн нэг байсан бөгөөд Хааны хамгаалалтын хүлэг баатар Цагаан бухын гарыг нэвт харваж, Дорнишийн гүнжийн уруулыг гал халуун үнсэлтээр үнсэж явсан гэж ярина. Тэр

түүнээс авдар дүүрэн алт, үнэт чулуу хулгайлсанч хундаганы ард үнсэлтийн тухай илүү хөөрөх дуртай байв.

Тэр зуны торго шиг хөнгөн хөдөлгөөнөөр онилж татсанаа тавихад сум нь байнд Доннел Хиллийнхээс дотогш инчийн зайтай онолоо.

- За залуу минь, ямар байна даа? гээд Улмер арагш ухарлаа.

- Зүгээр л юм байна. Эсрэг талын салхи чамд тусалжээ. Намайг харвах үед арай хүчтэй үлээж байсан юм гэж Доннел жөтөөрхсөн байртай хэлэв.

- Тэгвэл ахиад харваач дээ. Чиний нүд хурц, гар чинь чанга ч Хааны ойн шилдэг харваачийг дийлэхэд их хүч хэрэгтэй шүү. Энэ ертөнцийн хамгийн сайн харваач Флетчер Дик надад өөрийн биеэр нум сум харвахыг зааж өгсөн юм. Ингэхэд би чамд хөгшин Дикийн тухай ярьсан билүү?

- Ердөө гурван зуухан удаа гээд Хар цамхагын хүн бүр алдарт дээрэмчин агуу Улмер тэргүүтэй Саймон Тойн, Инээмсэглэгч хүлэг баатар, гурван удаа дүүжлүүлсэн Урт хүзүүт Освин, Цагаан янзага Ванда, Флетчер Дик, Бүдүүн гэдэст Бен зэрэг бусад хүмүүсийн тухай түүхийг сонссон байлаа. Хонгор Доннел зайлсхийх шалтаг хайн тойрноо ширтсэнээ өтөг бууцан дунд зогсож байгаа Сэмийг харчихлаа.

- Хөнөөгчөө. Нааш ирж бидэнд Өөрийг яаж алснаа үзүүлээч гээд өндөр урт нумаа сунгав.

Сэмийн царай улайлаа.

- Тэр чинь нум сум биш лууны шилэн хутга байсан юм гээд хэрвээ нумыг авбал юу тохиолдохыг мэдэж байлаа. Тэр байг алдаж сумыг далан дээгүүр давуулан ойн зүг нисгэхэд шоолон инээлдэх болно.

- Тэр хамаагүй. Бид зөвхөн Хөнөөгчийн хэрхэн харвахыг харахыг хүссэн юм. Тийм биз дээ, залуус аа? гэж бас нэг сайн харваач болох Росбигийн Алан хэллээ.

Тэр тэдний шоолсон инээмсэглэл, алиа зангаа, нүдэнд нь тодорсон зэвүүцэлтэй тулгарахгүйн тулд ирсэн замаараа буцахаар эргэхэд баруун хөл нь шаварт гүн шигдсэн тул сугалахыг оролдоход гутал нь үлдэхэд өвдөг сөгдөн чангаан сугалж авсанд нирхийтэл инээд хадлаа. Сэм цааш зайлсхийн зугтсанд хэдэн давхар оймстойгоо үл харгалзан хөл нь нэвт норжээ. *Ашиггүй амьтан. Эцэг минь намайг үнэн хэлжээ. Би ийм олон зоригт хүн амь үрэгдсэн байхад амьд байх эрхгүй* гэж дүнсийн бодов.

Грэнн өмнө талын сүлжмэл хаалган дээр түүдэг асаан бүсэлхий хүртэл нүцгэлээд түлээ хагалж байлаа. Түүний нүүр хүч гаргасандаа улайж арьснаас нь хөлс уур савсана. Тэр Сэмийг уухилсаар очиход инээн өндийлөө.

- Өөрүүд гутлыг чинь аваа юу, Хөнөөгчөө?

Тэр ч гэсэн үү?

- Шаварт шигдчихсэн юм. Гуйж байна намайг битгий тэгж дуудаач.

- Яагаад болохгүй гэж? Энэ сайн алдар болохоор чи шударгаар хүртсэн гээд Грэнн үнэн сэтгэлээсээ гайхлаа.

Пип үргэлж Грэнийг шилтгээний хана шиг зузаан бүдүүн хүзүүтэй гэж шоолдог болохоор Сэм тэвчээртэйгээр тайлбарлав.

- Энэ бол намайг хулчгар гэж өөр аргаар хэлж буй гэсэн үг. Тэд намайг Бедвикийг Аварга гэж дууддагтай адилхан шоолж байгаа юм гээд зүүн хөл дээрээ зогсон шигдсэн гутлаа сугалж авлаа.

- Тэр аварга биш тэгээд ч Пол хэзээ ч жижиг байгаагүй. Магадгүй тэр хүүхэд байхдаа тийм байсан болох ч дараа нь өсөж том болсон. Харин чи Өөрийг алсан болохоор ижилхэн биш гэж бодож байна.

- Би ердөө... айсандаа тэгсэн юм!

- Би ч гэсэн. Пип намайг аяхад дэндүү дүйнгэ гэж хэлдэг ч би хэнээс ч дутуугүй айдаг гээд Грэнн тонгойн хагалсан түлээгээ авч гал руу шидлээ.

- Би Жонтой тулалдахдаа айдаг байсан. Тэр маш шалмаг болохоор тулалдах болгондоо алах гэж байгаа юм шиг санагддаг байж билээ гэхэд нойтон ногоон мод галд өтгөн утаа суунаглуулав.

- Гэхдээ би энэ тухай хэнд ч хэлээгүй. Заримдаа хүн бүр зоригтой юм шиг дүр эсгэхийг оролддог ч бидний хэн ч үнэндээ тийм биш. Магадгүй зоригтой дүр эсгэвэл зоригтой болдог ч юм билүү. Тэд чамайг Хөнөөгч гэж дуудаж л байг хэнд хамаатай юм бэ?

- Чи сэр Аллисериин Бух гөрөөс гэж дуудахад дургүй л биз дээ.

- Тэр намайг том биетэй тэнэг гэж хэлж байсан юм. Харин Пип, Жон та гурав тэгж хэлсэн бол өөр хэрэг. Бух гөрөөс догшин хүчтэй адгуус болохоор би том биетэй тул муугүй л байна. Харин чамд ноён Гахай гэж дуудуулахын оронд Хөнөөгч Сэм гэвэл дээр санагдахгүй байна уу? гээд Грэнн сахлаа маажлаа.

- Яагаад намайг зүгээр л Сэмвэл Тарли гэж дуудаж болдоггүй юм бэ? Түүнийг лууны шил л алсан болохоос биш би биш. Лууны шил гээд Сэм Грэнний хагалж байсан нойтон хүнд дүнзэн дээр суулаа.

Тэр тэдэнд хэлсэн. Тэр тэдэнд бүгдэнд нь хэлсэн. Гэвч тэдний зарим нь хэлсэн үгэнд итгээгүйг Сэм мэдэж байв. Дирк Сэмд чинжаалаа үзүүлээд,

- Надад төмөр хутга байхад шилний хэрэг юу байх вэ? гэжээ. Харин Хар Бернар болон Гурван Гарт бүхий л ярианд эргэлзэж байгаа нь илт байсан бөгөөд, Систертаны Ролли урдаас нь шууд,

- Чамайг шаржигнасан бут хутгалахад үүнийг сонсоод Бага Пол өмдөндөө алдсан болохоор худал хэлж байгаа биз гэжээ.

Гэвч Дайвин, Долорус Эдд анхааралтай сонсож Сэм, Грэнн хоёрыг захирагч лордод хэл гэжээ. Мормонт болсон явдлыг хөмсөг зангидан сонсоод давуу тал олгохоос зайлсхийсэн болгоомжтой асуулт тавьжээ. Тэр Сэмээс уутанд нь байсан бүх лууны шилийг асуусан ч үнэндээ хэдхэн байлаа. Сэм Жоны Нударганы дороос олсон булсан зүйлийн тухай бодохоос уйлахыг хүслээ. Тэнд чинжаал, жадны зэв, хоёр гурван зуун ширхэг сумны толгой байсан. Жон хутгыг өөртөө аван Сэм, захирагч лорд Мормонтод өгч Сэмд жадны зэв, хуучин эвдэрхий бүрээ хэдэн сумны толгойтой өгчээ. Грэннд бас атга сумны толгой өгснөөр энэ бүхэн гүйцэж байв.

Одоо тэдэнд зөвхөн Мормонтын хутга болон Сэмийн Грэннд өгсөн арван есөн суман дээр нэмээд хар лууны шилэн зэвтэй урт хатуу модон жад үлджээ. Жадыг харуулууд манаанд гарахдаа дамжуулан хэрэглэж Мормонт сумыг хамгийн сайн харваачиддаа тараан өгчээ. Үглээ Билл, Саарал өд Гарт, Роннел Харкли, Хонгор Доннел Хилл болон Росбигийн Алан нарт тус бүр гурван сум харин Улмерт дөрвийг өгчээ. Гэсэн ч тэд бүгдийг тодорхой байнд зоолоо ч гэсэн удалгүй бусад шигээ галт сум хэрэглэх байв. Тэд Нударган дээр зуугаад галт сум тавьсан ч үхдлүүд ирсэн хэвээр байсан билээ.

Энэ хангалтгүй гэж Сэм бодлоо. Крастерийн хайлсан цастай шавар шавхай нэлийсэн хашаа үүнээс ч эгц Нударга руу авиран дугуй хэрэм рүү шавааралдан гарч ирсэн үхдлүүдийг удаашруулахгүй байв. Тэгээд ч тэднийг ирэхэд сахилга баттай эгнэсэн гурван зуун ах дүүгийн оронд дөчин нэгэн зүдэрсэн амьд үлдэгч, есөн тулалдахад хүнд шарх олсон хүн учрах болно. Крастерийн гэрт Нударганаас замаа цавчин чөлөөлж буусан жаран хүнээс дөчин дөрвөн нь шуурганаас хоргодохоор ирсэн болохоор гурав нь шархандаа өнгөрч Баннен удахгүй дөрөв дэх нь болох байлаа.

- Чи үхдлүүдийг явсан гэж бодож байна уу? Тэд яагаад биднийг дуусгахаар ирсэнгүй вэ? гэж Сэм Грэннээс асуув.

- Тэд зөвхөн хүйтэн болох үед ирдэг.

- Тийм л дээ гэхдээ хүйтнийг үхдлүүд авчирдагаас биш хүйтэн үхдлүүдийг авчирдаггүй биз дээ?

- Хэнд хамаатай юм? Тэд хамтдаа ирдэг болохоор ямар ч ялгаа алга. Одоо бид лууны шил тэднийг алдагыг мэдсэн болохоор ирэхээ больсон биз. Магадгүй биднээс айж ч байгаа юм билүү! гээд Грэнн сүхээ буулгахад модны зомгол ийш тийш үсрэв.

Сэм үүнд итгэхийг хүссэн ч үхлийн айдас нь өвчин, хайр, үүрэг хариуцлагаас илүү байлаа. Тэр гараараа өвдгөө тэврээд үстэй хувцасныхаа дор хөлрөн суулаа. Лууны шилэн хутга модон дунд цагаан зүйл болон хайлсан болохоор Грэнн үхдлийг ч гэсэн тийм болсон гэсэн. *Бид үүнийг мэдэхгүй. Бид үнэндээ юу ч мэдэхгүй. Би Жоныг энд байсан ч болоосой гэж хүсч байна.* Тэр Грэннд дуртай ч Жонтой ярьдаг шигээ хандаж чадсангүй. *Жон намайг Хөнөөгч гэж дуудахгүй байсныг мэдэж байна. Би түүнтэй Гиллигийн хүүхдийн тухай ярьж болох байсан даа.* Гэвч Жон Коринтой явснаас хойш ямар ч сураг чимээ байсангүй. *Түүнд лууны шилэн хутга бас байгаа ч яаж ашиглахыг мэдэж байгаа болов уу? Эсвэл ямар нэг гуу жалганд хөлдүү үхдэл болон хэвтэж эсвэл түүнээс ч дор үхээд алхаж байвал яана?*

Тэр яагаад бурхад Жон Сноу, Баннен нар шиг хүмүүсийг аваад түүн шиг хулчгар болхи бойнго хүнийг орхисон явдлыг ойлгосонгүй. Тэр өмдөндөө гурван ч удаа шээс алдан илдээ гээхдээ Нударган дээр үхэх ёстой байсан билээ. Түүнчлэн ойд Бага Пол авахаар ирээгүй бол бас үхэх байсан. *Энэ бүхэн зүүд байсан ч болоосой. Тэгвэл ердөө сэрэхэд болно.* Нударган дээр эргэн тойрон хүрээлсэн ах дүүсийнхээ дунд сэрж Жон, Сүнс хоёр хамт байвал хичнээн сайхан байхсан билээ. Эсвэл үүнээс бүр илүү Ханын цаана Хар цамхагт сэрж нийтийн өрөө рүү ороод Гурван хуруутай Хоббын хийсэн голд нь цөцгийн зэрэгцээ хайлсан бал хийсэн будааны шөлийг авч том модон халбагаар хутган идвэл бүр ч зүгээр байхсан. Энэ тухай бодохоос хоосон гэдэс нь хүржигнэв.

- Сноу.

Сэм чимээгээр эргэн харахад захирагч лорд Мормонтын хэрээ гал дээгүүр дугуйран өргөн хар далавчаа агаарт дэвэн нисэж байв.

- Сноу. Сноу. Сноу гэж тэр гуаглав.

Хэрвээ хэрээ байгаа бол Мормонт удахгүй ирнэ гэсэн үг. Захирагч лорд ойн хөвөөнөөс шогшин гарч ирэхэд хоёр талд нь Хөгшин Дайвин, Торен Смолвудын оронд өргөмжлөгдсөн үнэгэн царайт Роннел Харкли нар явж байлаа. Хаалган дээр зогсч байсан жадчин хашгирахад Хөгшин баавгай хариуд нь чанга гүвтнэв.

- Долоон там минь гэж чи хэнийг байна гэж бодсон юм бэ? Өөрүүд нүдийг чинь авчихаа юу? гээд нэг талд нь аргал, нөгөө талд нь баавгайн гавал зоосон шонгийн дундуур орж ирэн жолоо татан зогсож нударгаа өргөн исгэрлээ. Хэрээ дуудсан зүг далавчаа дэвэн нисэв.

- Эрхэм лорд бидэнд ердөө хорин хоёр морь үлдсэнээс хагас нь Хана хүрч чадах эсэх нь эргэлзээтэй гэж Роннел Харкли хэлэв.

- Мэдэж байна. Тэгсэн ч бид явах ёстой. Крастер үүнийг маш тодорхой хэлсэн гээд Мормонт бараан үүлний цаана нар нуугдсан өрнө зүг ширтэж, - Бурхад бидэнд амсхийх боломж өгсөн ч гэхдээ хэр удаан гэж? гээд эмээлээсээ доош буухад хэрээ агаарт ухасхийн буцаж нисэв. Тэгснээ Сэмийг хармагц,

- Тарли! гэж хашгирлаа.

- Би юу? гээд Сэм эв хавгүйхэн босов.

- *Би юу? Би юу?* гээд хэрээ Мормонтын толгой дээр газардлаа.

- Чиний нэрийг Тарли гэдэг биз дээ? Эсвэл ойр хавьд өөр ах дүү чинь байгаа юм уу? Тиймээ, чи. Амаа хамхиад надтай яв.

- Таньтай юу? гэж амнаас нь үг өөрийн эрхгүй бүдчин гарав.

Захирагч лорд Мормонт түүн рүү цоргитол ширтэв.

- Чи бол Шөнийн харуулын эр хүн. Намайг чам руу харах болгонд өмдөндөө битгий дусаачих гээд бай. Явъя гэж би хэлсэн шүү гээд гутлаараа шавхай үсчүүлэн явахад Сэм яаран гүйцлээ.

- Би чиний лууны шилний тухай бодож байлаа.

- Тэр миний шил биш.

- Тэгвэл Жон Сноугын лууны шил. Хэрвээ лууны шил бидэнд хэрэгтэй юм бол яагаад зөвхөн хоёрхон байгаа юм бэ? Түүгээр Ханан дээрх хүн бүрийг амлалтаа өгсөн цагаас нь эхлэн зэвсэглэх ёстой байсан юм.

- Гэхдээ бид энэ тухай мэдээгүй...

- Мэдээгүй гэнэ ээ! Тэгвэл мэдэх ёстой байсан. Шөнийн харуул үнэн зорилгоо мартжээ, Тарли. Чи долоон зуун фут өндөр ханыг зэрлэгүүдийг хүүхэн хулгайлахаас хамгаалан босгоогүй. Ханыг хүмүүсийн эсрэг биш хаант улсын хүмүүсийг хамгаалахын тулд босгосон юм. Эрин зуун гээд дэндүү их цаг хугацаа өнгөрчээ. Бид жинхэнэ дайснаа хараанаасаа алдсан байна. Харин одоо түүнийг ирэхэд бид яаж тулалдахыг мэдэхгүй байна. Энэ шилийг лууных гэж энгийн ардууд хэлцдэг билүү?

- М-мэйстерүүд тэгж боддоггүй. Тэд үүнийг газрын гүний галаас бий болсон галт уулын шил гэдэг юм хэмээн Сэм ээрэв.

- Тэд үүнийг нимбэгний бялуу гэж дууддаг ч байна уу хамаа алга. Хэрвээ чиний хэлснээр алж чадсан бол би аль болох олныг хүсч байна гээд Мормонт тургилаа.

- Жон Нударганаас зуугаад сумны толгой, жадны зэв гээд олныг олсон.

- Чи тэгж хэлсэн. Тэгэхдээ багахан тус болсон доо. Нударга руу хүрэхийн тулд бид зэвсэглэх хэрэгтэй болохоор тэр хүртэл хараал идсэн Нударганд хүрч чадахгүй. Дээрээс нь зэрлэгүүдтэй учраа олох хэрэгтэй байна. Бид лууны шилийг өөр газар хайх ёстой.

Сэм ийм их зүйл болсны дараа зэрлэгүүдийн тухай бараг таг мартжээ.

- Ойн хүүхдүүд лууны шилийг ашигладаг байсан. Тэд галт уулын шилийг хаанаас олохыг мэддэг байсан.

- Ойн хүүхдүүд байхгүй болсон. Анхны хүмүүс хагасыг нь хүрэл зэвсгээр хядаж, Андалсынхан үлдсэнийг нь төмөр зэвсгээр дуусгасан. Яагаад шилэн хутгыг... гэснээ Хөгшин баавгай Крастер хаалганы бугын арьсан сөхүүрийн завсар гарч ирмэгц яриагаа таслав. Зэрлэг ам дүүрэн өмхөрсөн хүрэн шүд гарган инээмсэглэлээ.

- Би хүүтэй болсон.

- Хүү. Хүү, хүү, хүү гэж Мормонтын хэрээ гуаглав.

- Би чиний төлөө баяртай байна гээд Захирагч лордын царай хатуурлаа.

- Тийм гэж үү? Харин би танай хэрээнүүдийг явсан цагт баярлах байна. Аль эрт тэгэх ёстой байсан юм.

- Бид шархадсан хүмүүсээ тэнхэрсэн даруй явна...

- Тэднийг тэнхрэхгүй гэдгийг хөгшин хэрээ минь чи надаас дутуугүй мэдэж байгаа. Тэд нэгэнт үхэж байгаа болохоор хоолойг нь огтолж зүйл дуусгах хэрэгтэй. Эсвэл тэднийг орхи. Хэрвээ чиний зүрх хүрэхгүй байгаа бол би учрыг нь олъё гэхэд захирагч лорд Мормонт дүрсхийн,

- Торен Смолвуд чамайг Харуулын анд нөхөр гэсэн... гэв.

- Тэгэлгүй яахав. Би та нарт чадах бүх зүйлээ илүүчилсэн ч өвөл ирж байгаа болохоор харин одоо охин минь ахин нэг нойтон тэжээх ам нэмлээ гэхэд,

- Бид түүнийг чинь авч явъя гэж хэн нэгний дуу часхийв.

Крастерийн толгойгоо эргүүлэн нүдээ нарийсгаж Сэмийн хөл рүү нулимав.

- Чи юу хэлсэн бэ, Хөнөөгчөө?

Сэм амаа ангайснаа хамхив.

- Би... би... би зөвхөн... хэрвээ та түүнийг хүсэхгүй байвал... амыг нь тэжээхийг хүсэхгүй бол... өвөл ирж байгаа болохоор... бид түүнийг авч явж болно гэх гэсэн юм...

- Энэ миний хүү. Миний цус. Чи намайг түүнийг танай хэрээнүүдэд өгнө гэж бодож байна уу?

- Би зөвхөн бодохдоо... *Чамд хөвгүүд байхгүйн учир чи тэднийг ил тавьдаг гэж Гилли хэлсэн. Чи тэднийг ойд орхидог учир чамд ердөө эхнэрүүд байдаг. Харин охидууд чинь өсч том болоод эхнэр болдог.*

- Амаа тат, Сэм. Чи хангалттай ярилаа. Дотогш ор.

- Э-эрхэм лорд...

- Дотогш ор гэж би хэлсэн шүү!

Царай нь улайсан Сэм бугын арьсан сөхүүрийг сөхөн бүрэнхий өргөө рүү ороход Мормонт араас нь дагав.

- Чи чинь ямар дүүрчихсэн тэнэг амьтан бэ? Крастер бидэнд хүүхдээ өглөө ч гэсэн Хананд хүрэхээс маань өмнө үхнэ. Бидэнд шинэ төрсөн хүүхдэд санаа тавихаас илүү цасанд анхаарах хэрэгтэй байна. Чамд түүнийг тэжээх сүү, том хөх байгаа юу? Эсвэл чи бас ээжийг нь авч явах гээ юу? гэж хөгшин хүн ууртай зандрав.

- Тэр явахыг хүсч байгаа. Тэр надаас гуйсан...

- Би цааш нь энэ тухай сонсмооргүй байна, Тарли. Чамайг Крастерийн эхнэрүүдээс хол бай гэж хэлсэн шүү гээд Мормонт гараа өргөв.

- Тэр охин нь гэж Сэм сулхан дуугарлаа.

- Явж намайг дэндүү уурлаагүй байгаа дээр Банненийг хар. Яг одоо шүү.

- За, эрхэм лорд гээд Сэм яаран явлаа.

Түүнийг гал руу очиход Аварга, Баннены толгой дээгүүр арьсан нөмрөг бүтээж байв.

- Тэр даарч байна гэж хэлсэн. Би түүнийг хаа нэгтээ дулаан газар очсон байх гэж найдья хэмээн жижигхэн хүн хэлэв.

- Ийм шархтай... гэж Сэм хэллээ.

- Шархыг нь хараал идэг. Түүний хөл нь өвдсөн юм. Би манай тосгонд ийм хөлөө тайруулсан хүн байсныг мэдэх юм байна. Тэр дөчин найм насалсан гээд Дирк цогцсыг хөлөөрөө чичихэд,

- Түүнд хүйтэн байсан. Тэр хэзээ ч дулаацаагүй гэж Сэм хэлэв.

- Дээрээс нь хэзээ ч цадаж зохих ёсны хоол унд идээгүй. Бутаг Крастер түүнийг үхтэл нь өлсгөсөн гэж Дирк хилэгнэв.

Сэм эргэн тойрноо сэтгэл түгшин харахад Крастер орж ирээгүй байв. Хэрвээ тэгсэн бол байдал тааруу болж болох байлаа. Харуулууд түүнийг дорд гаралтай эх нь зэрлэг, эцэг нь урт хугацааны өмнө үхсэн хэрээ гэж ярьдаг учир зэрлэг "бутаг" гэсэн үгийг үзэн ядна.

- Крастер өөрийнхөө хүмүүсийг тэжээх хэрэгтэй. Бүх эмэгтэйчүүдээ. Тэр бидэнтэй чадах бүх зүйлээ хуваалцсан гэж Аварга хэлэв.

- Үүнд битгий итгэ. Биднийг явмагц тэр балтай торх ханзалж суугаад гахайн утсан мах, балаар найрлах биз. Дээрээс нь биднийг цасанд өлсөж үхнэ гэж хөхрөнө. Тэр бол хараал идсэн зэрлэг. Тэдний хэн ч Харуулын нөхөр биш гээд Дирк Баннены цогцос руу өшиглөж,

- Хэрвээ та нар надад итгэхгүй бол түүнээс асуу гэв.

Харуулын цогцсыг нар жаргах үеэр Грэнний өдөр эрт түлсэн түүдэг галд шатаалаа. Тим Стоун, Хуучин хотын Гарт хоёр нүцгэн цогцсыг авчирч хоёр саваад түүдэг рүү шидлээ. Бусад үлдсэн ах дүүс түүний хувцас, зэвсэг, хуяг гээд өөрийн гэсэн бүх зүйлийг нь хуваан авчээ. Хар цамхагт Шөнийн харуулууд үхсэн хүмүүсээ ёслолын хүндэтгэлтэй шатаадаг ажээ. Энд Хар цамхаг биш ч гэлээ шатаасан байхад тэр эргэж ирэхгүй байв.

- Түүнийг нэрийг Баннен гэдэг. Тэр зоригтой хүний зэрэгцээ сайн эргүүл байсан. Тэр бидэн рүү...

ингэхэд хаанаас ирсэн билээ? гэж захирагч лорд Мормонт талийгаачийг галын дөл нөмрөн авахад хэллээ.

- Цагаан эргийн тэндээс гэж нэг хүн хэлэхэд Мормонт толгой дохилоо.

- Тэр бидэн рүү Цагаан эргээс ирж хэзээ ч үүргээ унагаагүй. Тэр өргөсөн андгайгаа чадах чинээгээрээ биелүүлж алс хол мордон зоригтой тулалдсан. Тийм хүн ахин бидэнд олдохгүй.

- Харин одоо түүний харуулын үүрэг дуусч байна гэж хар ахан дүүс ёслол төгөлдөр хэллээ.

- Харин одоо түүний харуулын үүрэг дуусч байна гэж Мормонт цуурайтуулав.

- *Дууссан, дууссан* гэж хэрээ хашгирав.

Сэмийн нүд утаанд хорсон улайлаа. Тэр гал руу харахад агшин зуур Баннен өндийж галын дөлтэй нударга зангидан тэмцэлдэж байх шиг харагдсан ч хуйларсан утаа бүгдийг далдлав. Хамгийн таагүй нь үнэр байлаа. Энэ нь өмхий таагүй хэдий ч шатаж буй ахан дүү шарсан гахай шиг үнэртэхэд Сэмийн аманд шүлс асгарлаа. Энэ аймшигтай байсан тул шувуу "дууссан" гэж хашгирахад байшингийн ар талын шуудуу руу гүйн бөөлжлөө.

Түүнийг өвдгөө хүртэл шаварт зогсож байтал Долорус Эдд хүрч ирэв.

- Өт хорхой ухаж байна уу, Сэм? Эсвэл дотор чинь муухайраа юу?

- Муухайрсан. Үнэрээс болж... гэж Сэм сулхан хэлээд амаа гарынхаа араар арчив.

- Банненийг хэзээ ч ийм сайхан үнэртэнэ гэдгийг мэдсэнгүй. Би түүний махнаас золтой хэрччихсэнгүй. Хэрвээ бидэнд алимны сүмс байсан бол үүнийг хийж болох байлаа. Шарсан гахай үргэлж алимны сүмстэй сайхан амттай байдаг юм гэж Эдд хэзээний дүнсгэр аялгаараа үргэлжлүүлээд шээхээр өмднийхөө урд талын үдээсийг тайлж, - Чи үхэхгүй байсан чинь дээр шүү, Сэм. Эс бөгөөс би тэсэхгүй нь гэж эмээж байна. Чи Банненийхнаас илүү өөхтэй болохоор би үргэлж шажигнасан маханд дуртай байдаг юм гээд шаргал шээс гожгодуулан шүршингээ,

- Биднийг үүр гэгээрэхэд мордоно гэдгийг чи сонссон уу? Цастай ч бай үгүй ч бай хамаагүй мордоно гэж Хөгшин баавгай надад хэлсэн гэв.

Цастай ч бай үгүй ч бай. Сэм сэтгэл түгшин тэнгэр лүү харлаа.

- Цас гэнэ ээ? Бид... мордох юм уу? Бүгдээрээ юу?

- Үгүй дээ зарим нь явган алхах хэрэгтэй болох байх. Дайвин биднийг Өөрүүд шиг үхсэн морьдоо унаж сурах хэрэгтэй гэсэн. Тэр үүнийг тэжээхгүй байж болно гэж хэлж байгаа юм. Үхсэн моринд хэр идэх зүйл хэрэгтэй гэж? гээд өмдөө татлаа.

- Гэхдээ би үүнийг сайхан санаа гэмээргүй байна. Тэд үхсэн морьдоо ажилуулах тухай бодож эхэлсэн бол бид дараагийнх нь болно. Азгүйгээрээ би эхэнд байна биз. Эдд үхсэн ч хэвтэхийг

өршөөхгүй шүү. Босч жадаа аваад өнөө шөнө харуулд гар гэнэ. За яахав тийм ч баргар биш байж магад. Магадгүй тэднийг ажиллуулахаас өмнө би үхсэн ч байж болох юм.

Магадгүй бид бүгд удахгүй үхэж болох юм гэж Сэм бодоод хөл дээрээ арай ядан өндийлөө.

Крастер урилгагүй зочдоо маргааш явахыг мэдмэгц ааш зан нь сайжиран бараг л хэзээ ч байгаагүй ялдам мэт болов.

- Аль хэдийн тэгэх хэрэгтэй байсан юм гэж би хэлсэн биз дээ. Тэгсэн ч гэсэн би та нарыг зохих ёсны найраар үднэ. Миний эхнэрүүд та нарын нядалсан адууг шарах болохоор би шар айраг, талх гаргая гээд хүрэн шүдээрээ инээмсэглэж,

- Адууны махтай шар айрагнаас дээр зүйлгүй. Хэрвээ та нар түүнийг унаж чадахгүй бол идэх л хэрэгтэй гэж би хэлэх байна гэв.

Эхнэр охид нь урт дүнзэн ширээний дагуу сандал тавин хоол унд зэхэхийн зэрэгцээ үйлчилэв. Гиллигээс бусдыг нь Сэм ялгаж хооронд нь чадсангүй. Зарим нь хөгшин, зарим нь залуу өөр бусад нь жаахан охид байх ч Крастерийн эхнэрийн зэрэгцээ охид болохоор бүгд хоорондоо адилхан харагдаж байв. Тэд ажиллах зуураа өөр хоорондоо аяархан дуугаар ярилцах хэдий ч хар ах дүүст хандсангүй.

Крастер цор ганц түшлэгтэй сандлыг эзэгнэн ханцуйгүй хонины арьсан хантаазтай суув. Түүний бүдүүн гар битүү цагаан үстэй бөгөөд өрөөсөн бугуйндаа мушгиа алтан бугуйвч зүүжээ. Захирагч лорд Мормонт баруун гар талд нь вандан сандлын эхэнд байр эзлэхэд гадаа хаалган дээр харуул хийж, түүдэг өрдөж байгаа арваад хүмүүсээс бусад нь өвдөг нийлүүлэн шахцалдан суув.

Сэм Грэнн, Өнчин Осс хоёрын дунд суугаад гэдэс нь тэсгэлгүй хүржигнэлээ. Тос дуслуулсан хуйхлагдсан адууны махыг Крастерийн эхнэрүүд галан дээр шороор эргүүлэхэд аманд нь шүлс асгарсан ч Банненийг санагдуулав. Тэр өлсөж байсан ч идэх л юм бол огиулан гаргахаа мэдэж байлаа. Тэд яаж ийм хол чирж авчирсан хөөрхий үнэнч морьдоо идэх юм бэ? Харин Крастерийн эхнэрүүд сонгино авчирахад Сэм нэгийг нь авлаа. Өрөөсөн тал нь харлаж хөгцөрсөн байсан ч хутгаараа хуваагаад нөгөө хагасыг нь идэв. Тэнд бас талх байсан ч ердөө хоёр бүтэн дугуй байлаа. Улмер ахиад байна уу гэж асуухад эмэгтэй ердөө толгой сэгсрэв. Үүнээс л хамаг асуудал эхэлжээ.

- Хоёрхон талх уу? Ямар тэнэг эмэгтэй вэ? Бидэнд үүнээс их талх хэрэгтэй! гэж Модон хөлт Карл сандлын эцсээс гомдоллов.

Захирагч лорд Мормонт түүн рүү ширүүн харлаа.

- Өгснийг нь аваад баярлалаа гэж хэл. Удахгүй шуурганд цас идэх юм байж.

- Бид түүнийг чинь хангалттай идсэн. Би удахгүй Крастерийн нөөцийг иднэ, эрхэм лорд гээд Карл Хөгшин баавгайн хилэнгээс дальдирсангүй.

- Би чамд хангалттай өгсөн хэрээ минь. Би бас эмэгтэйчүүдээ тэжээх хэрэгтэй гээд Крастер нүдээ зэвүүцэн онийлголоо.

- Тэгэлгүй яахав. Тэгэхээр чи нууц хүнсний нөөц байгаагаа хүлээж байна уу. Үгүй бол яаж өвлийг давах билээ дээ? гээд Дирк адууны маханд хутга зоов.

- Би шүтлэгтэй хүн... гэж Крастер эхлэв.

- Чи бол харамч дээрээ худалч хүн гэж Карл хэлэв.

- Гахайн мах. Тэнд биднийг сүүлд ирэх үед гахай байсан. Би түүнийг гахайн махаа хаа нэгтээ нуусан гэж мөрийцье. Давсалж утаад гахайн өөх ч бас байгаа биз гэж Хуучин хотын Гарт бишрэнгүй хоолойгоор хэлэв.

- Зайдас. Жилийн турш хадгалагдан чулуу шиг хатуу болсон хар зайдас. Би түүний зооринд зуугаад өлгөөстэй байгаа гэж мөрийцье гэж Дирк дэмжив.

- Овьёос, шиш, арвай гэж Өрөөсөн гарт Олло хэллээ.

- *Шиш. Шиш, шиш, шиш, шиш, шиш* гэж Мормонтын хэрээ далавчаа дэвэн хашгирав.

- Хангалттай. Та нар бүгд чимээгүй. Энэ чинь тэнэг хэрэг гэж захирагч лорд Мормонт шувууны хахир дуу дундуур хэлэв.

- Алим. Бүтэн торх дүүрэн намрын даршилсан шүүслэг алим. Энд алимны мод байхыг би харсан гэж Ногоон талбайн Гарт сөргүүлэв.

- Хатаасан жимс. Байцаа. Нарсны самар.

- *Шиш. Шиш. Шиш.*

- Давсалсан хонины мах. Тэнд хонины хашаа байсан. Түүнийг торхонцор торхонцороор нь хонины мах хураасныг та нар мэдэж байгаа.

Крастер тэдэн рүү галаар төөнөх адил харав.

- Чимээгүй. Би цааш нь ийм зүйл сонсмооргүй байна гээд захирагч лорд дээш өндийлөө.

- Тэгвэл талхаараа чихээ бөглө, өвгөн минь. Эсвэл чи хэдийн хараал идсэн үйрмэгээ хүртчихээ юу? гээд Модон хөлт Карл ширээ түлхэн бослоо.

Хөгшин баавгайн царай минчийн улайв.

- Чи миний хэн болохыг мартчихаа юу? Суугаад наадхаа идэж чимээгүй бол. Энэ бол тушаал шүү.

Хэн ч үг хэлж хөдөлсөнгүй. Бүгдийн харц ширээний хоёр талаас бие биеэ ширтсэн захирагч лорд болон модон хөлт биерхүү эргүүл рүү ханджээ. Сэмд Карл одоохон тэсрэх мэт санагдсан ч

дүнсийн суулаа.

Гэсэн ч Крастер Мормонтын бэлэглэсэн том хар сүхийг барин босов.

- Үгүй шүү. Чи суухгүй. Намайг харамч гэж дуудсан ямар ч хүн миний дээвэр дор унтаж ширээнээс минь хоол идэхгүй. Эндээс зайл, тахир дутуу минь. Чи чи бас чи ч гэсэн гээд сүхний толгойгоор Дирк, хоёр Гарт луу ээлжлэн заалаа.

- Гадаа хүйтэнд гарч хоосон гэдэстэй унт...

- Хараал идсэн бутач! гэж Гартын нэг хараахад тэр хэн нь болохыг мэдсэнгүй.

- Хэн намайг бутач гэж дуудсан бэ? гэж орилоод ширээн дээр байсан тавагтай мах, дарсны аягыг зүүн гараараа арчин хаяад сүхээ баруун гартаа өргөлөө.

- Чамайг бутач гэдгийг бүх хүн мэдэж байгаа гэж Карл хариулав.

Крастер ширээний дагуу гартаа сүхтэй Сэмийн итгэмээргүй хурдан хөдлөв. Эмэгтэйчүүд хашгирч, Ногоон талбайн Гарт, Өнчин Осс хоёр хутгаа сугалахад, Карл шалан дээр хэвтэж байсан сэр Биамд арагш бүдэрч уналаа. Агшин зуур Крастер хараал тавин түүний зүг ухасхийсэн ч дараагийн агшинд цусанд хутгалдлаа. Дирк түүний үснээс зуураад толгойг нь гэдийлгэж хоолойг нь нэг чихнээс нөгөө чих хүртэл огтолж урагш хүчтэй түлхэхэд сэр Биам руу царайгаа харуулан уналаа. Биам Крастерийн цусанд будагдан сүхэнд цавчуулсан хуруундаа шаналан хашгирлаа. Крастерийн хоёр эхнэр орь дуу тавин, гурав дахь нь хараан дөрөв дэх нь Хонгор Доннел руу ухасхийн нүдийг нь маажихыг оролдоход шалан дээр цохин унагав. Захирагч лорд Крастерийн хүүрэн дээр багтарсан уур хилэнгээ барьж ядан зогсов.

- Бурхад биднийг хараана. Хүнийг зочилж буй орон гэрт нь алахаас ондоо бузар хэрэг байхгүй. Бид бүх хуулиар...

- Хананаас цааш хууль байхгүй гэдгийг мартаа юу, өвгөн минь? гээд Дирк Крастерийн эхнэрүүдийн нэгний бугуйнаас барьж аваад цусанд будагдсан хутгаа эрүүн дор нь тулгав.

- Бидэнд хаана хоол нуусныг хэлэхгүй бол чамайг ч гэсэн ижилхэн тэгэх болно шүү, эмэгтэй минь.

- Түүнийг тавь. Би үүний төлөө чиний толгойг... гээд Мормонт урагш алхлаа.

Ногоон замын Гарт замыг нь хаахад, Өрөөсөн гарт Олло буцаж түлхэв. Тэд хоёул гартаа зэвсэг барьжээ.

- Амаа тат гэж Олло анхааруулсан ч оронд нь захирагч лорд хутгаа сугалав. Олло өрөөсөн гартай ч түргэн байлаа. Тэр ухасхийн хөгшин хүний атгалтаас мултраад хутгаа Мормонтын гэдэс рүү зоосноо битүү цус болсон гаргаж ирэв. Тэгтэл ертөнцөд үймээн самуун дэгдлээ.

Үүнээс хойш хэсэг хугацаа өнгөрсний дараа Сэм Мормонтын толгойг өвдөг дээрээ тавин шалан

дээр завилан суужээ. Тэр яаж ингэснээ мэдэхгүй байгаа ч Хөгшин баавгайг хутгалснаас хойш юу болсныг бараг санахгүй байв. Яагаад ч юм Ногоон замын Гартыг, Хуучин хотын Гарт алжээ. Систертонь Ролли Крастерийн эхнэрүүдийг амталж үзэхээр шатаар дээш авиран дээврийн хөндийгөөс унаж хүзүүгээ хугалжээ. Харин Грэнн...

Грэнн түүнийг хашгиран алгадаж байснаа Аварга, Долорус Эдд болон хэсэг хүмүүсийн хамт гарч явжээ. Крастер сэр Биамын дээр тэгнэсэн хэвээр шархадсан хүлэг баатар ёолохоо больсон байв. Дөрвөн хар ахан дүү ширээнд суугаад түлэгдсэн адууны махны хэсэг зулгаахад, Олло уйлж буй эмэгтэйг ширээ рүү түлхэн авчирлаа.

- Тарли. Тарли яв. Яв гэж Хөгшин баавгай хэлэхийг оролдоход амнаас нь цус бургилан сахлыг нь даган урсав.

- Хаашаа тэр вэ, эрхэм лорд? Энд явах газар байхгүй гэж Сэм дүйнгэ хайхрамжгүй бувтнав. *Би айхгүй байна.* Энэ нь хачин мэдрэмж байлаа.

- Хана руу. Хана руу яв. Яг одоо.

- *Одоо. Одоо. Одоо* гэж хэрээ гуаглав. Шувуу хөгшин хүний гар, цээжин дээгүүр нь алхаж сахлынх нь үсийг зулгаалаа.

- Чи явах ёстой. Тэдэнд хэл.

- Тэдэнд юу хэлэх юм бэ? хэмээн Сэм эелдэгээр асуулаа.

- Нударга, зэрлэгүүд, лууны шил гээд бүгдийн тухай. Энэ бүх зүйлийг гээд амьсгал нь дор ороход хоолой нь шивнэх төдий болов.

- Миний хүү Жорахад хэл. Түүнд хар бол гэж хэл. Үхэхийн өмнөх эцсийн хүсэл маань.

- *Хүсэл?* гээд хэрээ толгойгоо гижийлгэснээ сувдан хар нүдээ гялтагнуулан,

- *Шиш?* гэж асуув.

- Шиш байхгүй. Жорахад намайг уучилсан гэж хэл. Миний хүү. Гуйж байна яв гэж Мормонт сулхан хэллээ.

- Энэ дэндүү хол болохоор би хэзээ ч Хана хүрч чадахгүй, эрхэм лорд гээд Сэм дэндүү их ядарсан байлаа. Түүний хүсч байгаа ганц зүйл гэвэл унтах, унтаад хэзээ ч сэрэхгүй байх явдал болохоор энд үлдвэл удахгүй Дирк юм уу, Өрөөсөн гарт Олло, Модон хөлт Карлын нэг нь түүнд дургүй болохоор дуусгах нь лавтай.

- Би таньтай үлдэнэ. Харж байна уу би танаас болон юунаас ч айхгүй байна.

- Чи явах ёстой гэж эмэгтэй хүний хоолой хэллээ.

Крастерийн гурван эхнэр тэдний дээр зогсож байв. Хоёр нь танихгүй эцэнхий хөгшин эмэгтэй бөгөөд Гилли тэдний дунд цагаан үстэй хүрэн нэхийнд өлгийдсөн хүүхдээ барин зогсчээ.

- Бид Крастерийн эхнэрүүдтэй ярилцах ёсгүй. Бидэнд тушаасан гэж Сэм тэдэнд хэлэхэд,

- Тэр чинь одоо дууссан гэж баруун талын хөгшин эмэгтэй хэллээ.

- Хар хэрээнүүд доош зоорь луу орж хагартлаа юм идэх юм уу дээш дээврийн хөндийн залуу хүүхнүүд рүү гарсан. Тэд удахгүй буцаж ирнэ. Чи тэднийг ирэхээс өмнө явсан чинь дээр. Морьд зугтсан ч Диа хоёрыг барьж авсан гэж зүүн талынх нь хэлэв.

- Чи надад тусална гэж хэлсэн биз дээ хэмээн Гилли санууллаа.

- Би Жоныг чамд тусална гэж хэлсэн. Жон зоригтой, сайн дайчин ч одоо үхсэн гэж бодож байна. Харин би хулчгар дээрээс нь бүдүүн. Миний хичнээн тарган болохыг харж байна уу. Тэгээд ч лорд Мормонт шархдчихаад байна. Та нар үүнийг харахгүй байна гэж үү? Би захирагч лордоо орхиж чадахгүй.

- Хүүхэд минь хөгшин хэрээ чамаас өмнө явчихсан. Хараач нэг эмэгтэй нь хэллээ.

Мормонтын толгой өвдгөн дээр нь тавиастай нүд нь нээлттэй байвч уруул нь хөдлөхөө больжээ. Хэрээ толгойг нь тоншин гуаглаж Сэм рүү харлаа.

- *Шиш?*

- Үгүй шиш байхгүй. Түүнд шиш байхгүй гээд Сэм Хөгшин баавгайн нүдийг аниулж залбирал санахыг хичээхэд толгойд нь цорын ганц залбирал орж ирсэнд,

- Ээж минь өршөө. Ээж минь өршөө. Ээж минь өршөө гэж мөргөлөө.

- Ээж чинь чамд юугаар ч тусалж чадахгүй. Наад үхсэн өвгөн чинь ч гэсэн. Чи түүний илд, том дулаахан арьсан нөмрөгийг нь аваад олдох юм бол морийг нь унаад яв гэж зүүн талын хөгшин эмэгтэй хэлэв.

- Охин худал хэлээгүй. Тэр миний охин болохоор багаас нь худал хэлэхэд зоддог байсан юм. Чи түүнд тусална гэж хэлсэн. Фернигийн хэлснийг хий, хүү минь. Охиныг аваад түргэн яв гэж нөгөө талынх нь гуйлаа.

- *Түргэн. Түргэн, түргэн, түргэн* гэж хэрээ давтав.

- Хаашаа? Би түүнийг хааш нь авч явах гэж? хэмээн Сэм гайхширан асуухад,

- Хаа нэгтээ дулаахан газар луу гэж хоёр эмэгтэй зэрэг хэллээ. Гилли гиншин уйлав.

- Гуйж байна намайг хүүхэдтэй минь авч яваач. Тэгвэл би Крастерийнх байсны адил чиний эхнэр чинь больё. Гуйж байна, сэр хэрээ минь. Тэр бол хүү болохоор Неллагийн хэлсэн шиг болно.

Хэрвээ чи түүнийг авахгүй бол тэд түүнийг авна.

- Тэд гэнэ ээ? хэмээн Сэм лавлахад хэрээ хар толгойгоо өндийлгөн,

- *Тэд. Тэд. Тэд* гэж гуаглав.

- Хүүгийн ах дүүс. Крастерийн хөвгүүд. Цагаан хүйтэн ирж байна, хэрээ минь. Би үүнийг ясаараа мэдэрч байна. Хөгшин яс худал хэлдэггүй юм. Тэд удахгүй энд ирнэ гэж зүүн талын хөгшин эмэгтэй хэллээ.

АРЪЯА

Түүний нүд харанхуйд дассан хойно Харвин толгойд нь угласан юүдэнг угз татан авсанд хөндий толгодын доторх бүрэнхий харанхуйд Аръяа тэнэг ууль аятай нүдээ анивчлаа.

Газрын хөрсөн дээр голд ухсан нүхэнд түлсэн том задгай галын дөл хуйлран дүрэлзэж утаанд харласан адар руу тас нясхийн цоролзоно. Хөндийн дотор хана чулуу шорооноос бүтэж завсар хооронд нь том цагаан үндэс мянган цагаан могой шиг битүү хэржээ. Хүмүүс үндсэн дундаас гарч ирээд харанхуй сүүдэрт ан цав гарсан хар хонгилуудын нэгнийх нь ам руу орж байлаа. Галын цаана үндэс шатны гишгүүр шиг дээш мурилзан сүлжиж өгссөн хөндий газар нэг хүн орооцолдсон шигүү далан модны дунд үзэгдэхтэй үгүй сууна.

Лем Жэндригийн толгойд угласан юүдэнг авахад,

- Энэ юун газар вэ? гэж асуулаа.

- Хуучны газрын гүн нууц газар. Дотор нь хоргодсон байхад арслан чонын алин ч гэтэж чадахгүй.

Арслан чонын алин ч. Аръяагын дотор зарсхийхэд хүний мөрнөөс гарыг нь тас татах үед аманд нь амтагдсан цусны амт санагдав.

Түүдэг гал том байсан ч агуй бүр том бөгөөд хаанаас эхэлж хаана дуусч байгааг мэдэхэд бэрх ажээ. Хонгилын ам хоёр фут гүн юм уу эсвэл хоёр мил гаруй урт бололтой. Аръяа тэндээс эрэгтэй, эмэгтэй хүн, жаахан хүүхдүүд түүн рүү болгоомжлон ширтэхийг харав.

- Энд шидтэн бий, туранхай хэрэм минь. Чи одоо асуултынхаа хариултыг авч болно гээд Ногоон сахалт Долоон чавхдаст Томын ноорсон хуучин хуяган дээр ягаан нөмрөг нөмөрсөн өндөр хүнтэй ярилцан зогсож буй зүг заалаа. *Энэ Мирийн Торос байж боломгүй юм.* Аръяа улаан хувраг махлаг тарган бие гөлгөр царай, гялалзсан халзан толгойтой байсныг саналаа. Харин энэ хүн унжуу царай, толгой дүүрэн сэгсгэр буурал үстэй байв. Том нэг зүйл хэлэхэд тэр Аръяа руу ширтсэнд урдаас нь ирэх нь үү хэмээн бодлоо. Зөвхөн Галзуу анчин ирж олзолсон хүнээ гэрэлд түлхэн гаргасан даруй Аръяа тэр хоёр мартагдав.

Анчин халзан толгой, унжуу эрүүтэй нөхөөстэй ширэн хувцас бүхий яхир ааштай бахим хүн байлаа. Чулуун дуганд Лем, Ногоон сахалт хоёр түүнтэй хэрээний торонд байгаа хүнийг аянгат лордод аваачихаар маргалдах үедээ хэдэн хэсэг болгон тасар татахад бэлэн байсан ч эргэн тойрон шиншлэн гүйлдэж байсан хоточ ноход тойрон ирж архирчээ. Гэвч Долоон чавхдаст Том тэднийг дуугаараа тайвшируулан, Танси хормогчны хормой дүүрэн яс, тарган хонины мах аваачиж өгөхөд, Лем буудлын цонхоор харвахад бэлэн сумаа онилон зогсож буй Энгайг харуулжээ. Галзуу анчин тэднийг зусарч амьтад гэж хараасан ч эцэст нь лорд Берикийн шүүхээр шангаа авахыг зөвшөөрсөн байна.

Тэд баригдсан хүний бугуйг олсоор хүлж хүзүүгээр нь гогцоо оруулан шуудай дүүжилсэн ч аюултай хэвээр байлаа. Аръяа үүнийг агуй даяар мэдрэв. Торос... хэрвээ энэ Торос мөн бол барьсан баригдсан хүн хоёул галтай учирч байсан билээ.

- Та нар түүнийг яаж бариа вэ? гэж хувраг асуулаа.

- Ноход үнэрийг нь авсан юм. Түүнийг удны доор согтуу унтаж байсан гэвэл чи итгэх үү?

- Өөрсдийнхнөөсөө урвагч гээд Торос хоригдол руу эргэн толгойд нь угласан даавууг мулт татан авч,

- Манай даруухан өргөөнд тавтай морилно уу, нохой минь. Энэ Робертийн хаан ширээний өрөө шиг сүрлэг сайхан биш ч бидэнд болоод байдаг юм гэв.

Галын анивчсан дөл Сандор Клегэйний түлэгдсэн царайг шаргал өнгөөр гийгүүлэхэд өдрийн гэрэлд байдгаасаа илүү аймшигтай харагдав. Тэр бугуйныхаа хүлээсийг угзрахад хатсан цусны хэлтэрхий бутарч унав. Хоточийн ам татвалзаж,

- Би чамайг мэдэх юм байна гэж Торост хэллээ.

- Мэдэлгүй яахав. Халз тулаанд чи миний галт илдийг харааж байсан ч би чамайг гурван удаа дийлсэн.

- Мирийн Торос. Чиний толгой халзан байсан.

- Даруухан зүрхний минь илрэл ч үнэн хэрэгтээ зүрх минь эсрэгээрээ бардам байсан. Би сахлын хутгаа модон дунд хаяж урьдынхаасаа арай турсан. Хээр хөдөө өнгөрүүлсэн жилийн хугацаанд биений минь өөх хайлжээ. Дээрээс нь унжсан арьсаа татуулах үйлчин олчихвол ахин залуу харагдаж хөөрхөн охид намайг үнсэлтээр булж юуны магад гээд хувраг гэдсээ алгадлаа.

- Зөвхөн сохор нь тэгэх байх даа.

Дээрэмчид шуугилдсан ч Торосын дууг давсангүй.

- Яг тийм. Гэсэн ч миний хуурамч хувраг биш болохыг чи мэднэ. Гэрлийн эзэн миний зүрхийг сэрээсэн. Түүнээс гадна удаан хугацаанд унтаж байсан маш их хүч сэрж газар дээгүүр явж байна. Би тэднийг дөлөндөө харсан гэхэд Хоточ тоосонгүй.

- Чиний дөлийг хараал идэг. Чамайг ч гэсэн гээд эргэн тойрон байсан хүмүүс рүү харж,

- Чи ариун санваартан гэхэд хачирхалтай нөхөдтэй юм гэв.

- Тэд бол миний ах дүүс гэж Торос энгүүн хэллээ.

Шаргал нөмрөгт Лем урагш гарав. Энд байгаа хүмүүсээс зөвхөн Ногоон сахалт тэр хоёр Хотчийн нүдэнд дүйцэхүйц өндөр байлаа.

- Үгээ хуцахдаа болгоомжтой байгаарай, нохой минь. Бид чиний амийг гартаа барьж байна шүү.

- Тэгвэл хурууныхаа ялгадасыг арчсан чинь дээр дээ. Та нар хэр удаан энэ нүхэнд нуугдаж байгаа

юм гээд Хоточ хөхөрлөө.

Харваач Энгай хулчгар гэж хэлсэнд дүрсхийн уурлав.

- Биднийг хэр нуугдаж байсан эсэхийг ямаанаас асуугаарай, Хоточ оо. Ахаасаа асуу. Хануур лордоос асуу. Бид тэднийг бүгдийг нь болгож тавьсан.

- Одоо та нар уу даа? Битгий инээд хүргээд бай. Та нар цэргээс илүү гахай маллагч шиг харагдаж байна.

- Зарим маань урьд нь гахай маллагч байсан. Зарим нь элдүүрчин, дуучин, чулуучин байсан. Гэхдээ энэ бүхэн дайнаас өмнө явдал гэж Аръяагын танихгүй намхан хүн хэллээ. Тэгтэл,

- Бид Хааны газрыг Винтерфелл, Дарри, Блэкхэвен, Маллери, Вайлдын хүмүүстэй орхисон. Бид хүлэг баатар, дагуул хиа, хүнд морьтон цэрэг, лорд, энгийн ард байсан ч хамтдаа нэгэн зорилгын төлөө зангилагдсан байлаа гэсэн хоолой далан модны үндэсний цаана хүн сууж байгаа газраас гарч яригч орооцолдсон гишгүүр уруудан бууж ирлээ.

- Бид зуун хориулаа хааны шүүхийг ахад чинь авчирахаар гарсан юм. Зуун хорин зоригт үнэнч хүмүүсийг одтой нөмрөгтэй тэнэг толгойлж байлаа гээд тэр одод түгсэн уранхай ноорхой хар нөмрөг, олон удаагийн тулаанд өм цөм хонхойсон төмөр цээж хуяг бүхий мануухай шиг ноорсон хувцас өмсчээ. Өтгөн улаавтар үс царайных нь ихэнхийг далдалж зүүн чихний дээд талд толгой руугаа няц цохиулсан газарт халцарсан байв.

- Манай нөхдийн ная илүүтэй нь үхэхэд бусад нь тэдний гараас унасан илдийг нь авсан юм гээд доош бууж ирэхэд дээрэмчид хажуу тийш болон зай тавьж өгөв. Түүний нэг нүд байхгүй болж хоосон нүдний ухархай нь умайж үрчийгээд хүзүүнд нь хар цагаригласан ором гарчээ.

- Бид тэдний тусламжтай чадах чинээгээрээ Робертийн хаант улсын төлөө байлдсан.

- Роберт гэнэ ээ? хэмээн Сандор Клегэйн үл итгэн хэллээ.

- Нэд Старк биднийг илгээн төмөр хаанд ширээнд сууж тушаал өгсөн ч бид хэзээ ч түүний хүн байгаагүй Робертийнх байсан гэж дугуй дуулгатай Азтай Жак нэмэрлэв.

- Роберт одоо өт хорхойн хаан болсон. Ийм учраас та нар түүнд ордон зэхэн газар дор байгаа юм уу?

- Хаан үхсэн ч бид хааны хүн хэвээр гэвч Жүжигчний гарамд танай ахын алуурчид дайрах үеэр бид хааны далбаагаа алдсан гээд ноорхой хувцастай хүлэг баатар энгэртээ нударгаа хүргэж,

- Роберт алагдсан ч хаант улс нь хэвээр байх болно. Харин бид түүнийг нь хамгаалж байна гэв.

- Түүнийг нь гэнэ ээ? Тэр чиний ээж үү, Дондаррион? Эсвэл явдаг эм чинь үү? гээд Хоточ тургилаа.

Дондаррион гэнэ ээ? Берик Дондаррион царайлаг сайхан залуу байсан болохоор Сансагын найз Жэйн түүнд дурласан билээ. Жэйн Пүүл ийм хүнийг царайлаг гэдэг арай сохорчихоогүй байгаа даа. Гэсэн ч Арьяа түүнийг ахин ажих үедээ ан цав суусан цээж хуягнийх нь толин дээр үлдсэн салаа ягаан цахилгааны ормыг харлаа.

- Чулуу, мод, гол танай хаант улс чинь юм биз дээ. Чулууг хамгаалах хэрэг байдаг юм уу? Роберт тэгж бодоогүй. Хэрвээ тэр зугаа цэнгэл хөөгөөгүй бол тулалдах юм ууж бусад нь хамаагүй байдаг болохоор та нарт ч гэсэн хамаагүй... зоригт нөхөд минь гэж Хоточ хэлэв.

Хөндий толгодын дотор уур хилэн дэгдлээ.

- Биднийг ахин ингэж дуудах юм бол чамд үүнийг амсуулна шүү гээд Лем урт илдээ сугалахад Хоточ түүн рүү тоомсоргүй ширтлээ.

- Энд нэг зоригтой хүн хүлээтэй хүнд илдээ тулгаж байна. Миний хүлээсийг тайлчих л даа. Тэгвэл хэн нь илүү зоригтойгоо харья гээд ард нь байсан Галзуу анчин руу ширтэж,

- Чиний байвал яаж байна? Эсвэл чи бүх зоригоо нохойн хонууртаа орхичихоо юу? гэв.

- Үгүй дээ гэхдээ би чамайг хэрээний торонд орхих ёстой байсан юм. Тэгсэн ч болно гээд Галзуу анчин хутгаа сугалахад Хоточ түүний царай руу хөхөрлөө.

- Бид энд нэгэн ах дүүс. Хаат улс бурхад болон бие биендээ андгай өргөсөн ариун ах дүүс гэж Мирийн Торос мэдэгдэв.

- Далбаагүй ах дүүс. Хөндий толгодын хүлэг баатрууд гээд Долоон чавхдаст Том чавхдасаа дарав.

- Хүлэг баатрууд гэнэ ээ? хэмээн Клегэйн мушийлаа. - Дондаррион хүлэг баатар байж болох ч үлдсэн нь миний харж байсан хамгийн хөөрхийлөлтэй дээрэмчид тарж бутарсан хүмүүс байна. Би та нараас ч дээр хүн рүү нулимж явлаа.

- Ямар ч хүлэг баатар хүнийг мөрөн дээр нь илд тавиад хүлэг баатар болгож болно. Бид бол мартагдсан ах дүүс гэж Берик Дондаррион хэлэв.

- Намайг замаар минь явуулбал би ч гэсэн та нарыг мартая. Гэхдээ та нар намайг алах гэж байгаа бол үүнийгээ гүйцэтгэсэн чинь дээр дээ. Та нар миний илд, морь, алтыг авсан болохоор амийг минь ав... зөвхөн шударга журамтай хүний дүр эсгэн майлалдахаа больж үз.

- Чи удахгүй үхнэ, нохой минь гэхдээ энэ аллага биш шударга шүүхээр гэж Торос амлав.

- Тиймээ. Танайхны бүх хийсэн зүйлээс чи хамаагүй энэрэнгүйг хүртэх болно. Та нар өөрсдийгөө арслангууд гэж нэрлэдэг. Шеррер, Жүжигчний гарамд зургаа, долоон настай охидууд хүчиндүүлж нялх хүүхдийг ээжийнхээ цээжинд тэврүүлээстэй байхад эхийнх нь нүдэн дээр нь алж байлаа. Арслангуудаас илүү хэрцгий зүйл үгүй гэж Галзуу анчин хэлэв.

- Би тэр Шеррер болон Жүжигчний гарамд чинь байгаагүй. Үхсэн хүүхдүүдээ өөр хүн рүү чих гэж

Хоточ хэлэв.

- Тэгвэл чи Клегэйний овгийг үхсэн хүүхдүүдээр босгосныг үгүйсгэж байгаа юм уу? Би ханхүү Эйгон, гүнж Рэйнис хоёр төмөр хаан ширээний өмнө хэвтэж байхыг харсан. Та нар хоёр нялх хүүхдийг алсныхаа төлөө новшийн нохойгоо хүртээ биз дээ гэж Торос хэлэв.

Хоточийн ам татвалзлаа.

- Та нар намайг ах минь гэж бодоо юу? Клегэйн гэмт хэрэг хийсэн юм биз дээ?

- Аллага бол гэмт хэрэг.

- Би хэнийг алсан юм бэ?

- Лорд Лотар Маллери, сэр Гладден Вайлд гэж Харвин хэлэв.

- Миний ах дүү Листер, Леннок хоёрыг гэж Азтай Жак нэмэрлэв.

- Бек Гүүдмэн, Доннелвүүдийн тээрэмчний хүү Мажийг гэж харанхуйгаас нэг хөгшин эмгэн хэлэхэд,

- Амттанд дуртай Мерримэний бэлэвсэн эхнэрийг гэж Ногоон сахалт дэмжив.

- Шавар цөөрөм тосгоны септонуудыг.

- Ноён хатагтай Деддингийнхныг дэндүү баян байсных нь төлөө.

- Винтерфеллийн Алин, Хурдан нум Жот, бяцхан Маттыг эгч Рэндигийн хамт, Анвил Рин, сэр Ормонд, сэр Дадли, Морийн Пэйт, Лансвүүдийн Пэйт, Хөгшин Пэйт, Шермерийн төглийн Пэйт, Сохор мужаан Вил, сайн эхнэр Мэйри, биеэ үнэлэгч Мэйри, Талхчин Бека, сэр Рэйман Дарри, лорд Дарри, залуу лорд Дарри, Бракены Бутагч, Флетчер Вилл, Харсли, сайн эхнэр Нолла... хэмээн Долоон чавхдаст Том хуруу даран тоолов.

- Хангалттай. Чи миний чихийг дүнгэнүүлээд байна. Эдгээр нэр чинь юу ч биш. Тэд хэн байсан юм бэ? гээд Хоточийн царай уурандаа чангарлаа.

- Хүмүүс. Энгийн язгууртан, хөгшин залуу хүмүүс. Ланнистерийн жадны үзүүрт өлгөгдөн, Ланнистерийн илдэнд гэдсээ хүүлүүлсэн сайн муу хүмүүс гэж лорд Берик хэллээ.

- Миний илд тэдний гэдсийг хүүлээгүй. Хэн ч хэлсэн бай бүгд худал үг.

- Чи Кастерли Рокийн Ланнистерийнханд зүтгэж байсан биз дээ гэж Торос хэлэв.

- Урьд нь тэгсэн. Би болон олон мянган хүмүүс. Бид бүгд тэдний гэм бурууг үүрэх ёстой юм уу? гээд Клегэйн нулимж, - Магадгүй та нар хүлэг баатрууд байж болох юм. Та нар хүлэг баатрууд шиг худал хэлж байгаа болохоор хүлэг баатрууд шиг аллага хийдэг ч байж болох гэв.

Лем, Азтай Жак хоёр түүн рүү зэрэг хашгирсан ч Дондаррион гараа өргөн чимээгүй болголоо.

- Чи юу хэлэх гэсэн юм бэ, Клегэйн?

- Хүлэг баатар бүр илд, морьтой байдаг. Түүнээс гадна ариун тосоор тослуулан андгай өргөж хатагтайгийн тааллыг хүртэн торгон туузыг нь илдэндээ уядаг. Магадгүй тууз илдийг сайхан харагдуулж болох ч хамаагүй ална. Тэгэхээр та нарын туузыг хараал идэг илдээ өгзөг рүүгээ чихэцгээ. Би та нартай ижил. Зөвхөн ганц ялгаа нь гэвэл өөрийнхөө тухай худал хэлээгүй. Иймээс намайг алж болно гэхдээ битгий алуурчин гэж дуудах юм уу бие биенийхээ ялгадсыг өмхий биш гэж хэлээд бай. Та нар намайг сонсов уу?

Арьяа Ногоон сахалтын хажуугаар яах ийхийн зуургүй чихэж,

- Чи бол алуурчин! Чи Микахыг алсан гэдгээ хэлсэнгүй. Чи түүнийг алсан! гэж хашгирлаа.

Хоточ түүнийг огтхон ч танилгүй гайхан ширтэв.

- Энэ Миках гэж хэн юм бэ, хүү минь?

- Би хүү биш! Харин Миках хүү байсан. Тэр чиний алсан нядлагчийн хүү байсан. Жори чамайг түүнийг зэвсэггүй байхад биеийх нь талыг тас цавчсан гэсэн гэж хэлэхэд өөрсдийгөө хөндий толгодын хүлэг баатрууд гэж дууддаг эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүд Арьяа руу ширтлээ.

- Энэ одоо хэн юм? гэж хэн нэгэн асуусан ч Хоточ хариуллаа.

- Долоон там минь гэж. Бага дүү нь байна шүү дээ. Энэ охин Жоффригийн гоёмсог илдийг гол руу шидсэн гээд Хоточ хуцан инээж,

- Чи үхсэн гэдгээ мэдэж байна уу? гэлээ.

- Үгүй ээ, чи үхсэн гээд Арьяа урдаас нь ширтэв.

Харвин түүнийг гарнаас нь барин хойшлуулахад лорд Берик,

- Охин чамайг алуурчин гэж нэрлэлээ. Чи нядлагчийн хүү Микахыг алснаа үгүйсгэж байна уу? гэж асуув.

Хоточ хайнгадуухан мөрөө хавчив.

- Би Жоффригийн тангарагт бамбай байсан. Нядлагчийн хүү ханхүү рүү дайрч шархдуулсан.

- Наадах чинь худал! Тэр чинь би байсан юм. Би Жоффриг цохиж Арслангийн сарвууг нь булаан гол руу шидсэн. Миках зүгээр л миний хэлснээр зугтчихсан гээд Арьяа Харвины гараас мултрахыг хичээн мурилзав.

- Чи хүүг ханхүү Жоффри руу дайрч байхыг харсан юм уу? гэж лорд Берик Дондаррион Хоточоос

асуув.

- Би үүнийг хааны өөрийнх нь амнаас сонссон. Миний байр бол ханхүүд асуулт тавих явдал биш гээд Клегэйн Арьяа руу гараа чичиж,

- Түүний эгч нь ч гэсэн танай үнэт Робертийн өмнө зогсож байгаад адилхан зүйл хэлсэн гэв.

- Санса бол худалч. Энэ түүний хэлсэн шиг байгаагүй. Тийм биш гэж Арьяа эгчийгээ ахин гарч ирсэн явдалд уурсан хэлэв.

Торос лорд Берикийг хажуу тийш аваачлаа. Тэд хоёул цааш зогсож нам дуугаар аяархан шивнэлдэхэд Арьяагын уур дээд цэгтээ хүрэв. *Тэд түүнийг алах ёстой. Би түүнийг үхээсэй гэж олон зуун удаа зальбирсан.*

Берик Дондаррион Хоточ руу эргэлээ.

- Чи аллага хийсэн хэрэгт буруутгагдаж байгаа болохоор хэн ч хэргийн худал үнэнийг мэдэхгүй тул бид чамайг шүүж чадахгүй. Зөвхөн Гэрлийн эзэн үүнийг хийж чадна. Би чамд халз тулааны шийтгэл оноож байна гэхэд Хоточ чихэндээ итгээгүй бололтой сэжигтэй хөмсөг зангидав.

- Чи чинь тэнэг юм уу эсвэл галзуурчихаа юу?

- Алин ч биш. Би зүгээр л лорд. Чи илдээр гэм зэмгүйгээ баталвал хүссэн зүг рүүгээ чөлөөтэй явж болно гэхэд Арьяа,

- Үгүй ээ гэж орилсон ч Харвин амыг нь дарлаа. *Үгүй, тэд түүнийг тавьж сул явуулж болохгүй.* Хоточ илдэндээ үхлийн аюултай гэдгийг бүгд мэднэ. *Тэр тэднийг шоолон инээх болно.*

Тэгтэл ч үнэхээр зэвүүцэл дүүрэн урт хахир инээд агуйн хананд цуурайтав.

- Тэгээд хэн чинь гарах юм бэ? Шээсэн шар нөмрөгтэй зоригтой хүн үү? Үгүй юу? Чи байвал яаж байна, Анчин минь? Чи намайг барихыг оролдохдоо нохдоо өшиглөж байсан биз дээ гээд Ногоон сахалтыг харснаа,

- Чи хангалттай том биетэй юм байна урагш гараад ир, Тайрош минь. Эсвэл намайг энэ бяцхан охинтой үзэлцүүлэх гээ юу? Алив ээ хэн үхэхийг хүсч байна? гээд ахин хөхөрлөө.

- Би чамтай нүүр тулна гэж лорд Берик Дондаррион хэлэв.

Арьяа түүний тухай бүх яриаг саналаа. Тэр алагддаггүй гэж бодохоос дотор нь найдлага төрөв. Галзуу анчин Сандор Клегэиний гарыг хүлсэн олсыг огтоллоо.

- Надад илд, хуяг хэрэгтэй гээд Хоточ олсонд холгогдсон гараа үрэв.

- Чамд илд өгч болох ч гэм зэмгүй хуяг чинь болог гэж лорд Берик хэлэхэд,

- Миний гэм зэмгүйгийн эсрэг чиний цээж хуяг юм биз дээ? Энэ чиний арга уу? гээд Клегэйний ам татвалзлаа.

- Нэд надад энэ цээж хуягийг тайлахад туслаадах.

Арьяа лорд Берик эцгийнх нь нэрийг хэлэхэд дотор нь хирдхийсэн ч Нэд ердөө шаргал үстэй арав, арван хоёр орчим насны дагуул хөвгүүн байв. Тэр түргэн гарч ирээд Маршийн лордын үнгэгдсэн ган хуягний горхийг тайллаа. Дотор талын хөвөнтэй цамцыг тайлахад аль зууны өмнө хөлсөнд идэгдэн ялзарчээ.

- Ээж минь өршөө гэж Жэндри амьсгаа даран дуу алдав.

Лорд Берикийн хавирга арьсан дороо ёрдойжээ. Цээжин дээр нь зүүн хөхнийх нь дээд талд галт уулын тогоо шиг умайсан гүн сорви бөөгнөрөн илд бамбайгаа авахаар эргэхэд Арьяа ижилхэн сорви нуруун дээр нь байхыг олж харлаа. *Жад түүнийг нэвт жадалжээ.* Хоточ үүнийг бас харжээ. *Тэр айсан болов уу?* Арьяа түүнийг үхэхийнхээ өмнө Миках шиг айхыг хүслээ.

Нэд лорд Берикийн урт хар хүрмийг илдний бүстэй авчирав. Энэ нь хуяган дээр өмсөх зориулттай болохоор биенийх нь гадуур сул унжиж дээр нь овгийнхоо сүлд болох хөх ягаан өнгийн тахирласан цахилгаантай байлаа. Дондаррион илдээ сугалаад бүсийг хиад буцааж өглөө.

Торос Хоточийн илдний бүсийг авчирав.

- Нохойнд нэр хүнд байдаг юм уу? Чи эндээс илдээр замаа чөлөөлөн зугатах оролдох юм уу ямар нэг хүүхдийг барьцаалахыг оролдвол Энгэй, Деннет, Кайл гурав урван тэрслэлтийн эхний шинж тэмдэг гарсан даруй өдтэй сум зоох болно шүү гээд зөвхөн гурван харваач сумаа онилсон хойно Торос Клегэйнд бүсийг өгөв.

Хоточ илдийг хуйнаас нь хангинатал сугалав. Галзуу анчин түүнд төмөр товруу шигтгэсэн шаргал дэвсгэр дээр Клегэйний овгийн гурван хар нохой гүйж буй царсан бамбай өгөв. Нэд хүү лорд Берикт илдний цавчилтанд үнгэгдэн ягаан өнгийн цахилгаан, түгсэн од нь бараг байхгүй болсон бамбай авчирч өглөө.

Хоточ дайсныхаа зүг алхахад Мирийн Торос зогсоолоо.

- Эхлээд бид мөргөнө гээд гал руу эргэн гараа өргөж,

- Гэрлийн эзэн минь биднийг ариун мэлмийдээ тольдон хараач гэв.

Агуйн эргэн тойронд далбаагүй ах дүүс хариуд нь хоолойгоо өргөн нэмэрлэв.

- *Гэрлийн эзэн минь биднийг хамгаалаач.*

- Гэрлийн эзэн минь биднийг харанхуйгаас хамгаалаач.

- *Гэрлийн эзэн минь бидний царайг гэрэлтүүлж өгөөч.*

- Биднийг дөлөөрөө гийгүүлж өгөөч, Р'хлор. Бидэнд энэ хүний үнэн худлыг ялгаж өгөөч. Хэрвээ тэр буруутай бол доош цавчуулан хэрвээ үнэн хэлсэн бол илдэнд нь хүч өгөөч. Гэрлийн эзэн минь бидэнд цэцэн ухаан хайрла гэж улаан хувраг зальбирал.

- *Шөнө харанхуй айдсаар дүүрэн* гэж бусад нь аялгуулан давтахад Харвин, Энгай хоёр бусдаас хамгийн чанга хэлж байлаа.

- Энэ агуй бас харанхуй болохоор би айдас нь болно. Танай бурхныг чинь элэгсэг гэж найдья, Дондаррион. Чи түүнтэй удахгүй уулзах болно гэж Хоточ хэлэв.

Лорд Берик инээмсэглэсэнгүй урт илднийхээ ирийг зүүн гарынхаа алган дээр тавиад удаанаар доошлуулахад цус илдний дагуу зүссэн газрын шархнаас урсав.

Ингээд тэр илдэндээ гал авахууллаа.

Арьяа Жэндригийн шивнэн мөргөхийг сонсов.

- Торос та хоёр Долоон тамд шатаасай. Намайг түүнийг дуусгахад чи дараагийнх нь шүү, Мир гэж Хоточ хараалаа.

- Хэлсэн үг бүр чинь чиний гэм бурууг илчилж байна, нохой минь гэж Торос хэлэхэд Лем, Ногоон сахалт, Азтай Жак нар сүрдүүлэн хашгирлаа. Лорд Берик ус шиг тайван чимээгүй зүүн гартаа бамбай барьж, баруун гартаа галт илд барин хүлээлээ. *Түүнийг ал. Гуйж байна түүнийг алж өгөөч* гэж Арьяа бодлоо. Дороос тусах гэрэлд Дондаррионы царай үхлийн баг өмссөн юм шиг харагдан байхгүй болсон өрөөсөн нүд нь хилэнт шарх шиг улайна. Илдний дөл үзүүр хэсгээс бариулын хамгаалалт руу гүйхэд Дондаррион халууныг мэдэрсэнгүй. Тэр сийлбэртэй чулуу шиг зогссон хэвээр байлаа.

Гэвч Хоточ довтлох үед тэр маш түргэн хөдлөв.

Галт илд агаарт цойлон хүйтэн төмөртэй тулгарахад хөвөрсөн урт гал Хоточийн ярьсан тууз шиг зам татуулав. Илд илдтэйгээ харшилдан дуугарав. Клегэйн эхний цавчилтыг хаагаад хариу цавчилт хийхэд лорд Берик бамбайгаараа хаасанд модон дээр нь туссан хүчтэй цохилтонд хэлтэрхий үсэрлээ. Хүчтэй, хурдан, дээшээ, доошоо, баруун, зүүн гээд цавчилт ар араасаа ирэхэд Дондаррион бүгдийг нь хааж тогтоов. Түүний илдэнд дөл хуйлран улаан шаргал сүнсэн өнгөөр сүүмэлзэнэ. Лорд Берикийг хөдлөх тоолон дөл улалзан бадарч улам гэгээтэй ноцоход аянгат лорд галт торны дунд зогсож буй мэт болов.

- Энэ зэрлэг гал уу? гэж Арьяа Жэндригээс асуув.

- Үгүй. Арай л өөр юм. Энэ бол...

- ...шидэт үү? гэж Арьяа Хоточийг арагш болоход дуусгав. Одоо лорд Берикийн дайрах ээлж ирж агаарт дүрэлзсэн гал гогцоорон Хоточийг арагш ухраалаа. Клегэйн дээрээс ирсэн цохилтыг бамбайгаараа хаахад нохойны зурагны толгой үгүй болов. Тэр эсрэг цавчилт хийхэд Дондаррион

бамбайгаараа хаан маш хүчтэй хойш эргэн цавчлаа. Дээрэмчин ах дүүс толгойлогчоо дэмжин хашгиралдана. *Тэр чинийх болсон! Түүнийг унага! Түүнийг унага! Түүнийг унага!* гэж хашгирахыг Арьяа сонслоо. Хоточ толгой руу нь ирсэн цавчилтыг хааж дөлний халуун илч нүүр лүү нь төөнөхөд ярвайлаа. Тэр шуухитнан харааж арагш ухрав.

Лорд Берик түүнд амсхийх мөч өгсөнгүй. Тэр Хоточийг өсгий даран мөрдөж гар зогсолтгүй цавчив. Сэлэм хангинан тулснаа хоёр тийш салж ахин урд урдаасаа хангир жингэр хийн золгоход аянгын цахилгаантай бамбайнаас цавчигдсан хэлтрэхий үсчин хуйларсан дөл нохойн зургийг гурвантаа үнслээ. Хоточ түүний баруун талаар хөдөлсөн ч Дондаррион түргэн хажуу тийш алхан хааж нөгөө тийш газар нүхэнд дүнсгэр улалзах галын дөл руу шахлаа. Клегэйн нуруу руу нь гал төөнөхөд зогсож мөрөн дээгүүрээ түргэн эргэж харах үедээ лорд Берикийн шинэ дайралтанд золтой толгойгоо алдсангүй.

Арьяа Сандор Клегэйн цагаан нүд урагш хүчлэн давшихад эргэлдэхийг харав. Тэр гурван алхам урагшилснаа хоёр алхам ухарч зүүн тийш болсон ч лорд Берик хаахад ахин хоёр алхам урагшилснаа нэг алхам буцаж илд илдтэйгээ харшин том царсан бамбайнууд дээр цохилтын араас цохилт буусаар байлаа. Хоточийн шулуун хар үс духанд нь гялалзах хөлсөнд наалджээ. *Дарсны хөлс* гэж Арьяа бодоод түүнийг согтуу баригдсаныг саналаа. Арьяагын харснаар түүний нүдэнд айдас илрэх шиг болов. *Тэр ялагдана* гэж лорд Берикийн галт илд дөл хуйлруулан цавчихад сэтгэл нь хөөрөн бодлоо. Ганцхан хүчит галт цавчилтаар аянгат лорд Хоточийг ахисан бүх газраас нь ухрааж галын нүхний ирмэг дээр ахин ганхан тогтоолоо. *Тэр, тэр, тэр үхэх болно.* Арьяа сайн харахын тулд өлмийгөө өргөв.

- Хараал идсэн новш! гэж Хоточ галын дөл ташааных нь арыг долооход хашгирав. Тэр хүнд илдээ улам хүчтэй эргүүлэн давшилж жижигхэн хүнийг хэрцгий цавчилтаар унаган илдийг нь хугалах юм уу бамбайг нь гараас мулт татахыг хичээв. Гэвч Дондаррионы цавчилтын дөл нүд рүү нь тас нясхийхэд арагш дальдиран бүдрээд өрөөсөн өвдөг дээрээ уначихлаа. Үүнийг ашиглан лорд Берик ойртож дээрээс доош хүчтэй цавчихад агаарт гал дарцаглан мөр татуулав. Клегэйн тулалдаанд амьсгаадан бамбайгаа толгой дээрээ өргөхөд агуйд царс тасхийн хугарах чимээ цуурайтав.

- Түүний бамбай шатаж байна гэж Жэндри аяархан хэлэхэд Арьяа үүнийг даруй олж харлаа. Галын дөл сийчигдсэн шаргал будган дээгүүр гүйж гурван хар нохойг залгилаа.

Сандор Клегэйн хайр найргүй хариу цавчилт хийж байж хөл дээрээ босов. Тэгтэл лорд Берик ухрахад Хоточ гал хүрхрэн нүүр лүү нь үлээхийг мэдмэгц бамбай нь шатаж буйгаа мэдлээ. Тэр зэвүүцсэндээ хашгиран хэмхэрсэн бамбайгаа хэд цавчлан юу ч үгүй болгов. Бамбай нь дундуураа хуваагдахад нэг хэсэг нь галд авалцан эргэлдэн унаж нөгөө хэсэг нь бугуйнаас нь гэжүүдлэн зүүгдсэн хэвээр байв. Клегэйн бамбайнаасаа салах гээд галыг улам дүрэлзүүлсэн учир ханцуйд нь гал авалцан зүүн гар нь тэр чигээрээ шатлаа.

- Түүнийг дуусга! гэж Ногоон сахалт лорд Берикээс шаардахад бусад нь хоолой нийлүүлэн,

- Буруутай! гэж хашгирахад Арьяа нэгдлээ.

- *Буруутай, буруутай, түүнийг ал. Буруутай!*

Лорд Берик зуны торго шиг уян налархай хөдөлгөөнөөр урдаа байгаа хүнийг дуусгахаар хөдлөв. Хоточ хахир хоолойгоор хашгирч илдээ хоёр гараараа атган бүх хүчээрээ цохилоо. Лорд Берик цохилтыг тэр дор нь хаасан ч...

- Үгүй ээ гэж Арьяа хашгирлаа.

Шатаж буй галт илд хоёр хэсэг болон хуваагдахад Хоточийн хүйтэн илд лорд Берикийн ноорсон бамбайг хага цуулан мөрний яс хүзүүтэйгээ нэгдсэн уулзварт буухад бараан өнгийн халуун хар цус оргилов.

Сандор Клегэйн арагш шатсан хэвээр ухармагц бамбайныхаа хэмхэрхийг хараал тавин чулуудаж газар хөрсөн дээр өнхрөн гарынхаа галыг унтраахыг хичээлээ.

Лорд Берик мөргөл үйлдэх адил өвдөг сөхрөв. Түүний ам нээгдэхэд цус бургилан гарав. Ингээд Хоточийн илд зоолттой хэвээр царайгаараа газар унахад хөрсөнд цус нь шингэлээ. Хөндийн толгодын дотор зөвхөн галын зөөлөн тас нясхийх, Хоточ өндийхийг оролдон гиншихээс ондоо чимээ гарсангүй нам гүм болов. Арьяа Миках болон Хоточийг үхэхийг зальбирсан тэнэг мөргөлүүдийнхээ тухай бодлоо. *Хэрвээ бурхад байдаг юм бол яагаад лорд Берик ялсангүй вэ?* Тэр Хоточийн гэм буруутайг мэдэж байсан.

- Гуйж байна. Би шатаж байна. Надад хэн нэгэн туслаач. Надад туслаач гэж Хоточ гараа барин сөөнгөтсөнөө,

- Гуйж байна гэж уйллаа.

Арьяа түүн рүү мэл гайхан ширтэв. *Тэр яг л жижигхэн хүүхэд шиг уйлж байна.*

- Мелли түүний галыг унтраа. Лем, Жак хоёр надад лорд Берикийг босгоход тусал. Нэд чи ч гэсэн гэж Торос хэлэв. Улаан хувраг Хоточийн илдийг унасан лордын биенээс сугалаад үзүүрийг нь цусанд будагдсан газар зоолоо. Лем том гараа Дондаррионы суган доогуур оруулахад Азтай Жак хөлөөс нь өргөв. Тэд түүнийг гал тойруулан харанхуй хонгилын нэгэн рүү авчирав. Торос, Нэд хоёр араас нь хөдөллөө.

- Би түүнийг Чулуун дуганд аваачиж хэрээний торонд хий гэж хэлсэн биз дээ гээд галзуу анчин нулимлаа.

- Яг тийм. Тэр Микахыг алсан. Тэр алсан гэж Арьяа хэллээ.

- Ямар ууртай хэрэм бэ гэж Ногоон сахалт гүвтнэхэд,

- Р'хлор түүний гэм буруугүйг баталсан гээд Харвин санаа алдлаа.

- Ямар Рулор? гээд Арьяа юу болохыг нь мэдсэнгүй.

- Гэрлийн эзэн. Торос бидэнд зааж өгсөн юм...

Арьяад Торосын тэдэнд юу зааж өгсөн хамаа байсангүй. Тэр Ногоон сахалтын хутгыг хуйнаас нь сугалаад барьж амжихаас нь өмнө ухасхийн гүйлээ. Жэндри түүнийг барьж авах гэсэн ч Арьяа үргэлж түүнээс хурдан байсан билээ.

Долоон чавхдаст Том өөр нэг эмэгтэйн хамт Хоточийг хөл дээрээ босоход тусалж байв. Түүний гарны барааг харсан даруй Арьяа хэлэх үггүй болов. Бамбайн ширэн оосор байсан газар ягаан судал татаж биенийх нь дээд доод хэсэг болон гар нь тохойноосоо бугуй хүртэл улаан нялга болсон байлаа. Хоточийн нүд түүнийхтэй тулгармагц ам нь татвалзав.

- Чи намайг алахыг тэгтлээ хүсч байгаа хэрэг үү? Тэгвэл үүнийг хий, чоно охин минь. Хутгаа дүр. Наадах чинь галаас хамаагүй цэвэрхэн гээд Клегэйн босохыг оролдсон ч түлэгдсэн гараас нь хэсэг мах унжихад хөл нь ахин сөхөрлөө. Том түүний эрүүл гарнаас барин босоход туслав.

Түүний гар, түүний царай гэж Арьяа бодлоо. Гэхдээ л тэр Хоточ билээ. Тэр галт тамд шатах тавилантай. Хүнд хутга гарт нь мэдрэгдэхэд чанга атгалаа.

- Чи Микахыг алсан. Тэдэнд хэл. Чи үүнийг хийсэн. Хийсэн гэж ахин хэллээ.

- Би хийсэн. Би түүн рүү очиж биеийг нь тас цавчаад инээсэн. Би тэднийг чиний эгчийг ч гэсэн зодож, эцгийг чинь толгойг авахыг харсан гээд Хоточийн нүүр бүхэлдээ татвалзав.

Лем Арьяагын бугуйг барьж аваад мушгин хутгыг нь авав. Арьяа түүнийг өшиглөсөн ч буцааж өгсөнгүй. Тэр хоосон гартай яаж ч чадахгүй болсондоо уурлан,

- Там руугаа тонил, нохой минь. Чи там руугаа яв! гэж хашгирлаа.

- Тэр тэгнэ гэж шивнэхээс арай илүү хүчтэй хоолой хэлэв.

Арьяаг эргэж харахад ард нь лорд Берик Дондаррион зогсоод цус болсон гарыг нь Торос мөр хэсгээс нь барьжээ.

КАТЕЛИН

Өвлийн хаад газрын хөрсөн дорх хүйтэн бунхандаа нойрсож байг гэж Кателин бодлоо. Таллигийнхан хүч чадлаа мөрнийхөө уснаас тэтгэдэг болохоор амьдрал нь төгсгөл болохын цагт ахин голдоо эргэн очдог байв.

Тэд лорд Хостерийг турьхан модон завинд гялалзсан мөнгөн хуягтай нь тавьж улаан цэнхэр мяралзсан долгионтой нөмрөгийг нь дор нь дэвсчээ. Хүрэм нь бас улаан цэнхэр өнгөтэй байв. Мөнгөлөг хүрэл хайрстай хулд загастай их дуулгыг толгойных нь дэргэд тавьж цээжин дээр нь будагтай модон илд тавиад хуруугаар нь бариулыг нь атгууллаа. Хуягласан ган бээлий үрчийсэн гарыг нь далдалж ахин хүчтэй болсон юм шиг харагдана. Нүсэр том царсан дээр төмөр судалтай бамбайг нь зүүн талд тавьж ангийн бүрээг баруун талд нь байрлуулаад, завины үлдсэн хэсэгт голын усанд хөвж ирсэн мод овоолж, ноцоох цаасны өөдөс бэлдэн усанд хүндрүүлэхийн тулд чулуу хийгээд, завины хошуу дээр Риверраны үсэрч буй хулд загастай Таллигийн далбааг мандуулав.

Долоон нүүртэй бурхныг бэлгэдэн долоон сонгогдсон хүн оршуулгын завийг усанд түлхэн оруулахад Робб ганцаар лорд Хостерийн эзэн лорд байснаас түүний хамт лорд Бракен, Блаквүүд, Вэнс, Маллистер, сэр Марк Пайпер болон Ихрээс тэдний хүлээж байсан хариуг авчирсан Хазгар Лотар Фрей нар байв. Түүний бараа болон дагалдаж дөчин цэрэг ирснээс лорд Валдерийн ууган бутач буурал үстэй ширүүн догшин авираараа алдартай дайчин Валдер Риверс захирчээ. Тэд лорд Хостерийг өөд болсноос хэдхэн цагийн дараа ирсэн учир Эдмурын уур хилэнг бадруулжээ.

- Валдер Фрейг өвчиж хэдэн хэсэг тас татаж хаявал таарна! Тэр намайг сүрдүүлэхээр тахир дутуу, бутач хоёр илгээж үүнийгээ доромжлох гээгүй гэж хэлж байна хэмээн хашгирчээ.

- Би лорд Валдерийг элч нараа анхааралтай сонгосон гэдэгт эргэлзэхгүй байна. Энэ бол шалихгүй өшөө авахаар сэдсэн уур хүргэмээр зүйл ч гэсэн бид хэнтэй харьцаж буйгаа санах ёстой. Эцэг чинь түүнийг Хожуу лорд Фрей дууддаг байсан юм. Энэ хүн авир муу, атаархуу зантайгийн зэрэгцээ бардам ааштай гэж Кателин хэлэв.

Аз болж хүү нь дүүгээс нь дээр ухаантай байлаа. Робб Фрейгийнхныг эелдэгээр мэндчилэн хүлээн авч бараа бологсдод нь зориулан хуаранд хоноглох байр гаргаж өгөөд сэр Десмонд Греллийг явуулан Лотарыг хажуу тийш аваачиж лорд Хостерийг эцсийн замд үдэхэд нь туслах эсэхийг чимээгүйхэн асуулгажээ. *Миний хүү наснаасаа ахадсан цэцэн ухаан суралцжээ.* Фрейгийн овог Умардын хааныг орхисон байж болох ч Гармын лорд Риверраны хамгийн хүчирхэг тугчин хэвээр болохоор Лотар түүнийг энд орлож байлаа.

Долоон хүн лорд Хостерийг усны гишгүүрээр буулгаж дээш нь өргөсөн сараалжин хаалгаар гаргалаа. Лотар Фрей гэдэг цулцганасан махлаг хүн завийг голын урсгалд түлхэн тавихад уухилан амьсгаадана. Жэйсон Маллистер, Тайтос Блаквүүд хоёр завины хошуунаас атган цээж хүртэл гүн усанд орж замыг нь залж өгөв.

Кателин урьд өмнө хичнээн удаа хүлээж байсан шигээ бэхлэлтийн дээрээс харан хүлээв. Түүний

дор Унагаа хадны түргэн боргио ус Улаан өргөн салааны хажуу руу жад шиг дүрэн цутгаж цайвар цэнхэр урсгал булингартай улаан хүрэн өнгөөр эргэлдэн их голын дагуу урсана. Голын дээгүүр аалзны шүлс шиг нарийхан дурсамж адил бүдэг өглөөний манан татжээ.

Бран, Рикон хоёр урьд нь миний хүлээж байсан шиг түүнийг хүлээж байгаа гэж Кателин гунигтай бодов.

Турьхан завь Усны хаалганы улаан нуман чулуу доогуур гараад Унагаа хадны түргэн урсгалд орж хурдаа аван усны уулзаж буй хэсгийн ширүүн боргио руу туугдав. Завь шилтгээний сүндэрлэсэн өндөр хэрмийн доогуур өнгөрөхөд дөрвөлжин далбаа нь салхинд дэлгэгдэж Кателин эцгийнхээ дуулганд нарны гэрэл гялбан ойхыг олж харлаа. Лорд Хостер Таллигийн залуур зөв залагдсан тул сувгийн гол руу амирлангуй хөвөн мандаж буй нарны зүг одов.

- Одоо гэж авга ах нь шаардахад түүний дэргэд байсан одоо лорд болсон Эдмур нумныхаа хөвчинд сум онилоход хиа хошуунд нь шатаж буй цуцал хүргэлээ. Эдмур дөлний асахыг хүлээж байгаад том нумаа өргөж хөвчийг нь чихэндээ хүртэл татаж тавихад сум сэвхийтэл дээш шунгинан одов. Катели сумны нисэлтийг нүдээрээ дагуулан харахад лорд Хостерийн хитэгний цаана ус руу зөөлөн цүлхийн орсонд Эдмур аяархан дуугаар хараал тавьж,

- Салхинаас боллоо. Ахиад гээд хоёр дахь сумаа авч онилоход сумны толгой дахь тостой даавуунд цуцал хүргэн гал авалцмагц дээш нь татаж тавьсанд өндөрт харвахад дэндүү алс онилноос болж сум голд завинаас арван ярдын цаана алга болж гал нь даруй унтарлаа. Эдмурын хүзүү бавгар сахал шигээ улайв.

- Ахиад гэж тэр тушаагаад гурав дахь сумыг саадагнаасаа авлаа. *Тэр нум шигээ хөшүүн юм* гэж Кателин бодов.

Сэр Бринден бас ижил зүйл бодсон бололтой.

- Надад өгнө үү, эрхэм лорд гэв.

- Би чадна гэж Эдмур эсэргүүцлээ. Тэр суманд гал асмагц дээш нь өргөн гүн амьсгаа авч татав. Тэр удтал эргэлзэн татсаны эцэст гал сумны мод руу өгсч шаржигнахад эцэст нь тавилаа. Сум дээшээ цахилан улам бүр өндөр хөөрсөөр эцэст нь доош хазайн бууж доошлон салхинд хөөрөгдсөн далбааны хажуугаар шурхийн өнгөрлөө.

Ялихгүй зайтай өнгөрсөн ч алдсан бол алдсан билээ.

- Өөрүүд үүнийг аваасай! гэж дүү нь хараалаа. Завь бараг харвах зайнаас өнгөрч голын манан дунд далд орох гэж байв. Эдмур үг дуугүй авга ахдаа нумаа сарвайлаа.

- Түргэл гээд сэр Бринден сумыг онилж цуцалд эгц хүргэн Кателиныг гал авалцахыг харж амжихаас урд түргэн тавихад агаарт шаргал галын мөр татуулан харван одлоо. Завь манан дунд далд оржээ. Галт сум доошлон бас манан дунд далд орсон ч ганцхан агшин болов. Тэгснээ гэнэтийн найдвар болох улаан цэцэг дүрэлзэн далбаанд гал авалцаж мананд ягаан шаргалаар

улайрав. Кателин агшин зуур хуйларсан дөлөнд авалцсан завины дүрсийг тод харахад "Намайг харуулдаж байгаарай бяцхан, Кат минь" гэх эцгийнх нь шивнэлт сонсогдов.

Кателин дүүгийнхээ гарнаас барихаар сунгасан ч Эдмур цааш холдсон учир бэхлэлтийн өндөр орой дээр ганцаар хоцорчээ. Оронд нь авга ах Бринден түүний гарыг авч бадриун хуруугаараа атгав. Тэд хамтдаа бяцхан гал улам бүр жижгэрсээр шатаж буй завь алсад одохыг харлаа.

Тэгснээ голын уруу цааш хөвсөн эсвэл сүйрсэн, живсэн эсэх нь мэдэгдсэнгүй алга болов. Лорд Хостерийн бие хуягныхаа жинд татагдан Таллигийн мөнхийн ордон болсон голын хэвлийн зөөлөн шавар луу живж сүрэг загас сүүлчийн бараа бологч нь болох билээ.

Шатаж буй зав хараанаас далд ороод төдийлөн удсангүй Эдмур явлаа. Кателин түүнийг ганцхан хором ч болтугай тэврэн эсвэл цаг суух юм уу шөнө сар гартал үхэгсдийн тухай дурсан гашуудахыг хүсэв. Гэсэн ч түүнд цаг байхгүй гэдгийг мэдэж байлаа. Эдмур одоо Риверраны лорд болсон болохоор хүлэг баатрууд эргэн тойрон хуралдаж эмгэнэл илэрхийлэн, үнэнч зүтгэхээ андгайлан эгчийнх нь гашуудлаас холдууллаа.

- Сумаа алдах гутамшигтай явдал биш. Эдмур үүнийг мэдэх ёстой. Манай лорд эцгийг голын руу үдсэн өдөр Хостер бас сумаа алдаж байсан гэж авга ах нь аяархан хэлэв.

- Тэр эхний харвалтаа алдсан ч дараагийнхаараа далбааг оносон гээд Кателин энэ тухай санахад дэндүү жаахан байсан ч лорд Хостер үргэлж ярьж өгдөг байжээ.

Гэвч Эдмур санагдсан шигээ хүчтэй байсангүй. Эцгийнх нь үхэл эцэст нь ирэхэд дүү нь үүнийг хүндээр хүлээн авчээ.

Өнгөрсөн шөнө тэр хундагаа хага чулуудан уйлж дуусгаагүй зүйл, хэлж амжаагүй үгийнхээ талаар харамсал дүүрэн үг цувруулжээ. Тэр хэзээ ч гарамны тулаанд оролцох ёсгүй байж эцгийнхээ дэргэд үлдэх ёстой байсан гэж нулимс унаган ярьсан байна.

- Би тань шиг түүнтэй хамт байх ёстой байсан. Тэр таалал төгсөхийн өмнө миний тухай ярьсан болов уу? Надад үнэнийг хэлээч, Кат. Тэр намайг асуусан уу?

Лорд Хостерийн эцсийн үг "Танси" байсан ч Кателин үүнийг хэлж зүрхэлсэнгүй.

- Тэр чиний нэрийг шивнэсэн гэж худал хэлэхэд дүү нь талархан толгой дохиж гарыг нь үнслээ. *Хэрвээ тэр уй гашуудал гэмшилд автаагүй бол нумаа татаж чадах байсан* гэж Кателин өөртөө санаа алдан хэлсэн ч өөр үг хэлж чадсангүй.

Хар загас Кателиныг бараа болон дагалдаж хэрмээс буун Робб залуу хатантайгаа тугчидынхаа дунд хамт зогсож байгаа зүгт хүрлээ. Хүү нь ээжийнхээ барааг хармагц гарыг нь чимээгүй атгав.

- Лорд Хостер хаан шиг сүрлэг харагдаж байсан, хатагтай. Хэрвээ надад түүнийг мэдэх боломж байсан бол гэж Жейн хэлэв.

- Надад ч гэсэн түүнийг илүү мэдэх цаг байсан бол гэж Робб нэмэрлэв.

- Тэр үүнийг бас хүсч байсан. Гэвч Риверран, Винтерфелл хоёрын хооронд дэндүү олон бээрийн зайтай. *Дээрээс нь Риверран Эйри хоёрын дунд дэндүү олон уул, гол, армийн зайтай бололтой.* Лайза хариу захидал илгээсэнгүй.

Үүний зэрэгцээ Хааны газраас ч гэсэн чимээгүй байлаа. Кателин одоо Бриен, сэр Клеос хоёрыг хотод баригдсан хүнтэйгээ хүрсэн гэж найдаж байв. Бриен охидыг аваад буцах замдаа орсон ч байж магадгүй. *Сэр Клеос Бяцхан чөтгөр солилцоо хиймэгц даруй хэрээ илгээнэ гэж андгайлсан. Тэр үүнийг андгайлсан!* Гэсэн ч хэрээнүүд үргэлж газартаа хүрдэггүй байв. Аль нэг харваач шувууг харван доош унагаад шаран хоолондоо зоог болгон хэрэглэж болно. Түүний зүрх сэтгэлийг амраах үгтэй захиа одоо буудлын галын хажууд хэрээний овоолсон яс үнс дунд хэвтэж байгаа ч юм билүү.

Бусад хүмүүс Роббод тайтгарлын үг хэлэхээр хүлээж байсан болохоор Кателин хажуу тийш зогсож лорд Жэйсон Маллистер, Том Жон, сэр Рольф Спайсер нар ээлж ээлжээрээ эмгэнэл илэрхийлэхийг тэвчээртэй хүлээлээ. Гэвч Лотар Фрей дөхөх үед ханцуй дотор гар зангидав. Робб эргэж Лотарын хэлэх үгийг сонсохоор хүлээлээ.

- Эрхэм дээдсээ гээд гуч эргэм насны тарган Лотар Фрей ойрхон хөнхөр нүд, шовх үзүүртэй сахал, мөр лүүгээ цагариглан унжсан хар үстэй хүн байлаа. Хөл нь төрөлхийн хазгар муруй тул Хазгар Лотар нэрийг хүртжээ. Тэр арав гаран жил эцгийнхээ хэрэг эрхлэгчээр зүтгэж байв.

- Бид таны уй гашууд саад болохыг хүсээгүй ч өнөө шөнө биднийг хүлээн авч болох болов уу?

- Дуртайяа хүлээн авъя. Бидний дунд хэзээ ч дайсагнал байх ёсгүй байсан юм гэж Робб хэлэв.

- Минийхээр ч гэсэн шалтгаан байхгүй гэж хатан Жейн хэлэхэд Лотар Фрей инээмсэглэлээ.

- Би лорд эцгийнхээ хэлсэн үгийг ойлгож байна. Тэр надад залуу байхдаа үзэсгэлэн гоод зүрх алдаж байсан болохоор ямар болохыг нь сайн санаж байна гэж хэлэхийг тушаасан билээ гэв.

Кателин лорд Валдерийг ийм зүйл хэлсэн болон хэзээ нэгэн цагт үзэсгэлэн гоод зүрхээ алдаж байсан гэдэгт эргэлзлээ. Гармын лорд долоон эхнэрээсээ урт насалж одоо найм дахьтай нь суусан хэдий ч тэдний тухай зөвхөн өвөр дулаацуулагч болон үржлийн гүү шиг ярьдаг байв. Гэсэн ч үг шударга байсан болохоор Кателин тал зассан үгийг эсэргүүцсэнгүй. Робб ч мөн адил тэгэв.

- Эцэг чинь ямар нигүүлсэнгүй юм бэ. Оройны уулзалтыг тэсэн ядан хүлээе.

Лотар бөхийн хатны гарыг үнсэж ухарлаа. Үүнээс гадна эмгэнэл илэрхийлэхээр цугларсан арваад хүмүүс байлаа. Робб тэдэнтэй тус бүр ярьж ирсэнд нь талархан хэрэгтэй хүнд нь инээмсэглэж байлаа. Эцсийн хүн гарсан хойно тэр Кателин руу эргэлээ.

- Бидэнд хоорондоо ярилцах зүйл байна. Та надтай хамт алхахгүй юу?

- Таны тушаасан ёсоор больё, эрхэм дээдсээ.

- Энэ бол тушаал биш, ээж ээ.

- Тэгвэл дуртайяа алхах байна гээд Кателин хүүгээ Риверранд эргэн ирснээс нь хойш эелдэг сайхан харьцаж байсан ч ховорхон уулзаж байв. Хэрвээ түүнд залуу хатантайгаа байх нь илүү таатай байгаа бол үүнийг буруутгах хэрэг юун. *Жэйн түүнийг инээмсэглүүлж байхад би уй гашуунаас өөр юу ч өгч чадахгүй.* Робб хатныхаа ах дүүс болох дагуул залуу Роллам, туг баригч сэр Рэйналд нартай сайн харилцаатай байв. Тэд түүний алдсан хүмүүсийн байрыг орлож байна гэж Кателин тэднийг хамтад нь харах зуураа ойлгов. *Роллом Браны байрыг, Рэйналд Тоеон болон Жон Сноугын байрыг эзэлжээ.* Зөвхөн Вестерленгийнхэн Роббыг инээмсэглүүлж байсан болохоор тэр хөвгүүн байх үеийнх шигээ инээд алдаж байлаа. Бусад хүмүүст үргэлж Умардын хаан байж хөмсөг дээрээ духдуулан тавьсан титэмнийхээ жинд толгой нь дарагдан бөхийнө.

Робб эхнэрээ зөөлөн үнсээд өрөөндөө уулзахаа амлаж хатагтай ээжтэйгээ гарлаа. Түүний алхаа бурхдын модны зүг чиглэв.

- Лотар хөгжилтэй байгаа нь найдварын шинж. Бидэнд Фрейгийнхэн хэрэгтэй.

- Гэхдээ энэ тэднийг манай тал болсон гэсэн үг биш.

Робб баргар царайтай мөрөө унжуулан толгой дохиход Кателины зүрх шимширлээ. *Титэм түүнийг дарж байна. Тэр зоригтой нэр хүндтэй ухаалаг сайн хаан байхыг хүсч байгаа ч титэмний жин хөвгүүний дааж чадахаас дэндүү их байна.* Робб чадах бүх зүйлээ хийсэн ч цохилт нэг нэгнийхээ араас ирсэн хэвээр байлаа. Элч түүнд лорд Рэндилл Тарли Робетт Гловер, сэр Хелман Толхарт хоёрыг бут цохисон тухай мэдээ авчирах үедээ уурсан хилэгнэх байх гэж боджээ. Гэвч оронд нь тэр үл итгэсэн царайгаар ширтсэнээ,

- Уйтан тэнгисийн дэргэдэх Даскендэйл үү? Тэд яагаад Даскендэйл рүү явсан юм юм бол? гээд гайхширал тасран толгой сэгсрээд,

- Би явган цэргийн гурав дахь хүчээ Даскендэйлд алдлаа гэж үү дээ? гэжээ.

- Төмөр арлынхан миний цайзыг эзэлж харин одоо Ланнистерийнхан ахыг маань олзоллоо гэж Галбарт Гловер цөхрөнгөө баран хэлэв. Робетт Гловер тулалдаанаас амьд үлдсэн бол Хааны замын хаа нэгтээ олзлогдсон байв.

- Тийм ч их удахгүй. Би тэдэнтэй Мартин Ланнистерийг солилцох хэлэлцээр санал болгоно. Лорд Тайвин ахынхаа төлөө үүнийг зөвшөөрнө гэж Робб амлав. Мартин бол сэр Кеваны хүү лорд Карстаркад алагдсан Виллемийн ихэр нь билээ. Энэ аллага хүүгийнх нь санаанаас гарахгүй байгаа гэдгийг Кателин мэдэж байв. Тэр Мартины харуулын тоог гурав дахин нэмсэн ч аюулгүй байдлынх нь төлөө эмээсэн хэвээр байлаа.

- Би таныг анх шаардах үед л Хааны алуурчийг Сансагаар солих ёстой байж. Эсвэл түүнийг Цэцэгт хүлэг баатартай гэрлүүлэхийг санал болгосон бол Тайреллийнхан Жоффригийн оронд манай талд орох байсан юм. Би энэ тухай бодож үзэх ёстой байж гэж Робб модон дундуур алхах зуураа хэлэв.

- Чиний бодол тулалдааны талбарт байсан. Хаан хүн бүх зүйлийг бодож байх албагүй.

- Тулалдаан гэж Робб модны ёроолоос гарахдаа гүвтнэлээ.

- Би тулалдаан бүрт ялсан ч дайнд ялагдсан бололтой гээд хариулт нь тэнгэрт байгаа мэт дээшээ өлийж,

- Төмөр арлынхан Винтерфеллийг эзэлж Кайлины сувгийг бас барьж байгаа. Аав, Бран, Рикон үхэж магадгүй Арьяа ч гэсэн үрэгдсэн. Харин одоо таны эцэг нас нөгчлөө гэв.

Тэр хүүгээ цөхрүүлж болохгүй. Кателин үүний амт ямар болохыг өөрөө мэдэрсэн билээ.

- Миний эцэг удаан хугацааны өмнө үхлийн ирмэг дээр ирсэн. Чи үүнийг өөрчилж чадахгүй. Чи алдаа хийж болох байхад хаан хүн болохгүй гэж үү, Робб? Нэд чамаар бахархах байсан даа.

- Ээжээ таны мэдэх ёстой нэг зүйл байна гэхэд Кателины зүрх ёгхийлээ.

Үүнийг л тэр үзэн ядаж байсан байх нь. Тэр ямар нэг зүйлийн тухай надад хэлэхээс айж. Түүний бодож чадах ганц зүйл гэвэл Бриенид өгсөн даалгавар байлаа.

- Энэ Хааны алуурчийн тухай юу?

- Үгүй. Сансагын тухай.

Тэр үхэж. Бриен бүтэлгүйтэж Жэйми алагдан, Сергей миний хонгор охиныг хариуд нь цээрлүүлж гэсэн бодол даруй төрөв. Хормын зуур Кателин үг хэлэх чадваргүй боллоо.

- Тэр... тэр өнгөрсөн үү, Робб?

- Өнгөрсөн гэнэ ээ? гээд Робб гайхан ширтлээ.

- Үхсэн гэсэн үг үү? Үгүй дээ ээж ээ. Тийм биш тэд түүнд ийм аргаар гэм учруулаагүй ч зөвхөн... өнгөрсөн шөнө шувуу ирэхэд би таныг эцгийгээ эцсийн замд үдэх хүртэл үг дуулгаж чадсангүй. Тэд түүнтэй Тирион Ланнистерийг гэрлүүлсэн байна гээд Робб гарыг нь атгахад Кателины хуруугаараа зуурлаа.

- Бяцхан чөтгөр үү?

- Тийм.

- Тэр Сансаг ахаараа солилцохоор андгай тавьсан. Санса, Арьяа хоёрыг хоёуланг нь. Хэрвээ түүний үнэт Жэймиг нь буцааж өгвөл тэднийг эргүүлж явуулна гэж бүхий л ордны өмнө тангарагласан. Тэр яаж бурхад болон хүмүүсийн нүдний өмнө ийм андгай тавьсныхаа дараа түүнтэй гэрлэж чадав аа?

- Тэр Хааны алуурчийн дүү шүү дээ. Андгай эвдэх гэдэг бол тэдний цусанд байдаг зүйл гээд Робб хуруугаараа илднийхээ бариулын толгойг шүргэв.

- Хэрвээ чаддаг байсан бол би түүний толгойг тас цавчихсан. Тэгвэл Санса бэлэвсэрч чөлөөтэй болно. Үүнээс өөр арга би олж харахгүй байна. Тэд түүнийг хүчээр септоны өмнө андгай өргүүлэн хүрэн улаан өнгийн нөмрөг нөмрүүлсэн байна.

Кателин замын уулзварын дэн буудлаас баривчилж Эйри хүрэх бүх замын турш чирж явсан бяцхан одой хүнийг саналаа.

- Би түүнийг Лайзад өгч Сарны хаалгаар түлхүүлэх ёстой байж. Хөөрхий Санса минь яагаад ямар нэг хүн түүнд ийм зүйл хийх ёстой гэж?

- Винтерфеллийн төлөө. Бран, Рикон хоёр үхсэн болохоор Санса миний залгамжлагч болсон. Хэрвээ надад ямар нэг зүйл тохиолдвол... гэхэд Кателин гарыг нь чанга атгалаа.

- Чамд ямар ч зүйл тохиолдохгүй. Ямар ч зүйл шүү. Би үүнийг тэвчихгүй. Тэд Нэдийг чиний хонгор дүү нарыг авсан. Санса гэрлэж, Арьяа алдагдаж, эцэг минь өнгөрлөө. Хэрвээ чамд ямар нэг зүйл тохиолдвол би галзуурах болно, Робб. Чи надад үлдсэн ганц зүйл. Чи бол умардаас үлдсэн бүх зүйл.

- Би хараахан үхээгүй байна шүү дээ, ээж ээ гэхэд Кателинийг гэнэтийн айдас нөмөрлөө.

- Дайнд сүүлчийн цусаа дуустал тулалдах хэрэг байхгүй. Чи өвдөг сөгдсөн эхний хаан болон эхний Старк ч биш гэж цөхрөл дүүрэн хоолойгоор хэлэв.

- Үгүй. Хэзээ ч үгүй гээд Роббын ам чангарлаа.

- Үүнд ичгүүртэй зүйл байхгүй. Бэйлон Грэйжой бослого нь дарагдах үед Роберт хаанд өвдөг сөгдсөн. Торрен Старк армия галтай тулгарахыг мэдээд Эйгон байлдан дагуулагчид өвдөг сөгдсөн.

- Эйгон Торрен хааны эцгийг алсан бил үү? Хэзээ ч үгүй гэж би хэлсэн шүү гээд Робб гараа татлаа.

Тэр одоо хүү шиг тоглож байгаагаас биш хаан шиг биш байна.

- Ланнистерийнханд умард зүг хэрэггүй. Тэдэнд хүндэтгэл, барьцааны хүнээс илүү зүйл хэрэггүй. Тэгээд ч биднийг ямар ч зүйл хийсэн байсан хамаагүй Тирион Сансатай байх болохоор тэдний барьцааны хүн болно. Харин төмөр арлынхан эвлэршгүй дайснууд гэдгийг би чамд сануулах байна. Умард зүгийг барих найдлагын төлөө Грэйжойгийнхон эрхээ булаацалдахгүйн тулд Старкийн овгоос өчүүхэн төдий үндэс угсаа үлдээлгүй хядна. Теон Бран, Рикон хоёрыг алсан болохоор тэдэнд одоо зөвхөн чамайг алах үлдсэн. Дээрээс нь Жэйнийг ч гэсэн. Чи лорд Бэйлон түүнийг залгамжлагчийг чинь гэдсэндээ тээхийг хүлээн зөвшөөрнө гэж бодоо юу? гэхэд,

- Ийм учраас та Хааны алуурчийг суллаа юу? Ланнистерийнхантай найрамдахын тулд уу? гээд Роббын царай хүйтэрлээ.

- Би Сансагын төлөө Жэймиг сулласан. Хэрвээ амьд байгаа бол Арьяагын төлөө ч гэсэн. Чи

үүнийг мэдэж байгаа. Гэхдээ надад энхийг олж авах найдлага байгаа бол энэ тийм муу зүйл гэж үү?

- Тийм. Ланнистерийнхан эцгийг минь алсан.

- Чи намайг үүнийг мартсан гэж бодоо юу?

- Мэдэхгүй. Та тэгсэн юм биш үү?

Кателин уурандаа хэзээ ч хүүхэддээ гар хүрч байгаагүй ч Роббыг бараг цохих шахлаа. Биеэ барин түүнийг хичнээн ганцаардаж айсан болохыг өөртөө сануулав.

- Чи Умардын хаан болохоор сонголт чинийх. Би зөвхөн хэлсэн үгний маань талаар бодож үзэхийг чамаас гуйж байна. Дуучид хаадыг тулааны талбарт эр зоригтой үхдэг гэдэг ч чиний амьдрал дуунаас илүү үнэтэй. Ядаж л миний хувьд гээд толгойгоо бөхийлгөж,

- Би явж болох уу? гэлээ.

- Тэг гээд Робб цааш эргэн илдээ сугалахад юу хийх гэж байгааг нь Кателин мэдсэнгүй. Энд атаатан дайсан байтугай тулалдах нэг ч хүн байсангүй. Зөвхөн тэр хүүтэйгээ өндөр модод, унасан навчис дунд байлаа. *Илдээр ялж чадахгүй тулаан гэж бий* хэмээн Кателин хүүдээ хэлэхийг хүссэн ч хаад ийм үгэнд дөжирсэн байх гэж эмээлээ.

Хэдэн цагийн дараа Кателинийг унтлагын өрөөндөө юм оёж байтал залуу Роллам Вестерлинг гүйж ирээд зоогонд урьсаныг дуулгав. *Сайн байна* гэж Кателин сэтгэл амран бодлоо. Тэр ийм маргааны дараа хүүгээ уулзахыг хүснэ гэж бодсонгүй.

- Чи хичээнгүй хиа байна гэж Ролламд гунигтай хэлэв. *Бран байсан бол бас ижилхэн байсан даа.*

Робб ширээнд хүйтэндүү, Эдмур дүнсгэр байсан ч Хазгар Лотар тэднийг хоёуланг нь сэргээлээ. Тэр эелдэг ёсны жишээ болсон хүн болохоор лорд Хостерийн тухай дулаахан үг дурьдаж Кателинд Бран, Рикон хоёрыг алдсанд зөөлөн үгээр гашуудал илэрхийлээд, Эдмурын Чулуун тээрэм дэх ялалтыг магтаж, Роббод Рикард Карстаркийг “шударга ёсны түргэн” шүүсэн явдалд талархал илэрхийлэв. Харин Лотарын бутач ах Валдер Риверсийн тухайд өөр хэрэг байж яхир гашуун ааш лорд Валдерийн сэрдэнгүй царайтай тэрбээр ховор ярьж анхаарлынхаа ихэнхийг урдаа байгаа мах, балд төвлөрүүлэв.

Хатан болоод Вестерлингийнхэн хүлцэл хүсэн олон хоосон үг хэлсний эцэст хоолны үлдэгдлийг цэвэрлэхэд Лотар Фрей хоолой засав.

- Биднийг энд авчирсан зорилгоо дуулгахын урьд өөр хэрэг байна. Гашуудалтай мэдээ гэж эмээж байна. Энэ мэдээг та нарт авчирах үүрэг надад тохиохгүй гэж найдсан ч дуулгах ёстой болоод байна. Миний лорд эцэг ач хөвгүүдээсээ захиа авчээ.

Кателин өөрийнхөө хөвгүүдийг алдсан болохоор хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн Фрейгийн хоёр хүүгийн тухай таг мартсан байлаа. *Ахиад биш шүү. Ээж минь өршөө бид хичнээн цохилт давж*

дийлэх юм бэ? гэж бодов. Яагаад ч юм тэр дараагийн үг зүрхэнд нь хутга зоохыг мэдэж байлаа.

- Винтерфеллд байсан ач хөвгүүд үү? Миний хүмүүжүүлэхээр авсан?

- Валдер болон Валдер хоёр тийм. Тэд саяхан Дредфортод очсон, хатагтай. Таньд дуулгахад гашуудалтай ч тэнд тулаан болсон. Винтерфелл шатсан.

- Шатсан гэнэ ээ? хэмээн Робб гайхан дуу алдлаа.

- Умардын лордууд төмөр арлын хүмүүсээс Винтерфеллийг буцааж авахыг оролджээ. Теон Грэйжой ялагдахаа мэдмэгц цайзыг галдан шатаасан байна.

- Бид ямар ч тулалдааны тухай сонсоогүй гэж сэр Бринден хэлэв.

- Миний зээ нар залуу хөвгүүд ч гэсэн тэнд байсан гэдгийг тангараглах байна. Том Валдер захиа бичиж үеэл нь ч гэсэн гарын үсэг зуржээ. Энэ бол тэдний бодлоор хараал идсэн зүйл болжээ. Танай цайзын захирагч алагдсан байна. Түүний нэрийг сэр Родрик гэдэг байх аа?

- Сэр Родрик Кассел гэж Кателин балмагдан хэлэв. *Хүндэт зоригтой үнэнч хөгшин хүн минь.* Тэр бараг л түүнийг цагаан сахлынхаа үзүүрээс огцом дугтрахыг харлаа.

- Манай бусад хүмүүс яасан бэ?

- Төмөр арлынхан тэдний ихэнхийг хядсан гэж эмээж байна.

Робб өгүүлэшгүй уур хилэнд автсандаа нударгаа ширээн дээр тасхийтэл буулгаад Фрейгийнхэнд нулимсаа харуулахгүйн тулд эргэлээ.

Гэвч эх нь түүнийг харжээ. *Ертөнц өдөр ирэх тусам улам баргар болж байна.* Кателины бодол сэр Родрикийн бяцхан охин Бэт, эцэж цуцашгүй мэйстер Лювин болон хөгжилтэй септон Шэйл, дархан Миккен, нохойн байрны Фарлен, Палла хоёр, хөгшин Нан, энгийн Ходор нарыг санахад зүрх нь лүгхийн шимшрэв.

- Гуйж байна бүгд л биш шүү.

- Үгүй дээ. Эмэгтэйчүүд хүүхдүүд нуугдаж үлдсэний хамт миний зээ Валдер, Валдер хоёр байсан байна. Винтерфелл унахад амьд үлдэгдсдийг лорд Болтоны хүү Дредфорт луу аваачжээ.

- Болтоны хүү гэнэ ээ? гээд Роббын хоолой цахиртав.

- Бутагч хүү нь.

- Рамси Сноу л биш шүү? Лорд Русад өөр бутагч байдаг бил үү? Рамси бол алуурчин мангас болохоор хулчгар хүний ёсоор үхсэн. Үгүй дээ надад тэгж хэлсэн гээд Робб хөмсөг зангидлаа.

- Би үүнийг хэлж чадахгүй нь. Дайнд ээдрээтэй бэрх зүйл олон тохиолддог. Олон ч хуурамч

мэдээлэл ирдэг. Миний хэлж чадах зүйл гэвэл зээ нар маань Болтоны бутач хүү Винтерфеллийн хүүхэд эмэгтэйчүүдийг аварсан гэсэн. Тэднээс одоо амьд үлдсэн нь Дредфортод аюулгүй байгаа.

- Теон. Теон Грэйжойд юу болсон бэ? Тэр алагдсан уу? гэж Робб огцом асуухад Хазгар Лотар гараа дэлгэлээ.

- Энэ тухай юу ч хэлж чадахгүй нь, эрхэм дээдсээ. Валдер, Валдер хоёр түүний хувь заяаны тухай дурсаагүй. Магадгүй лорд Болтон хүүгээсээ үг сонссон бол мэдэх бизээ гэхэд,

- Бид түүнээс асуух болно гэж сэр Бринден хэлэв.

- Та бүгдийн сэтгэлийг үймүүлэн намайг ийм гашуудалтай мэдээ авчирсанд уучлаарай. Магадгүй бид маргаашийг хүртэл түр завсарлаж болох. Та нарыг тайтгарах хүртэл манай ажил хэрэг хүлээж байна биз...

- Үгүй. Би учрыг нь шийдэхийг хүсч байна гэж Робб хэллээ.

- Би ч гэсэн. Чи манай тавьсан саналын хариуг авчирав уу? гээд Эдмур толгой дохив.

- Би авчирсан гээд Лотар инээмсэглэлээ.

- Миний лорд эцэг надад эрхэм дээдсийг Фрейгийн овгийг доромжилсондоо өөрийн биеэр нүүр нүүрээ харалцан уучлал гуйвал манай хоёр овгийн хоорондын шинэ гэрлэлтийн холбоог зөвшөөрөн, Умардын хаанд үнэнч зүтгэлээ ахин батлахыг зөвшөөрөхийг дуулга гэж илгээсэн.

Уучлал гуйх өчүүхэн зүйл хэдий ч Кателинд лорд Валдерийн аар саархан нөхцөл таалагдсангүй.

- Надад таатай байна. Миний хүслээр болдог байсан бол бидний хооронд хэзээ ч ан цав гарахгүй байсан, Лотар. Фрейгийнхэн миний үйл хэрэгт зоригтой тулалдсан. Би ахин та нартай мөр зэрэгцэхийг хүсч байна гэж Робб болгоомжтой хэлэв.

- Та дэндүү эелдэг ажээ, эрхэм дээдсээ. Хэрвээ та энэ нөхцөлийг зөвшөөрч байгаа бол би лорд Таллид арван зургаан настай охин хатагтай Розлин болох дүүгийнхээ гарыг санал болгож байна. Розлин бол миний лорд эцэг болон зургаа дахь эхнэр Росбигийн овгийн хатагтай Бетани хоёрын дундаас төрсөн хамгийн бага охин нь юм. Тэр уян зөөлөн сэтгэл хөгжимд авъяастай гэхэд,

- Магадгүй би эхэлж уулзсан нь дээр байх... гээд Эдмур суудлаа шилгээв.

- Та нар гэрлэх үедээ уулзах болно. Эсвэл лорд Талли эхлээд түүний шүдийг тоолох хэрэгтэй юу? гэж Валдер Фрей хэлэхэд Эдмур уураа арай ядан барилаа.

- Би чиний үгийг түүний шүд шиг холуур хэрэгсэхгүй өнгөрүүлэе. Гэхдээ гэрлэхийн өмнө түүнийг царайг нь харвал таатай байна.

- Та түүнийг одоо л зөвшөөрөх ёстой, эрэхм лорд. Үгүй бол эцгийн маань санал хүчингүй болно гэж Валдер Риверс хэлэв.

- Миний ах цэргийн мохоо үгтэй ч үнэнийг хэллээ. Лорд эцгийн маань хүсэл бол гэрлэлтийг даруй батлуулах явдал гээд Хазгар Лотар хоёр гараа дэлгэлээ.

- Даруйхан гэнэ ээ? хэмээн Эдмур дургүйхэн хэлэхэд Кателин түүний тулалдаан дууссаны дараа гэрлэх бодол нь бүтэлгүйтсэнийг ойлгов.

- Лорд Валдер биднийг дайнд байлдаж байгааг мартсан хэрэг үү? хэмээн Бринден Хар загас огцом асуулаа.

- Хаанаас даа. Ийм учраас л тэр гэрлэлтийг одоо хийхийг шаардаж байгаа юм, сэр. Залуухан хүчтэй хүн хүртэл дайнд үхдэг. Иймээс лорд Эдмур тулаанд унахаасаа өмнө Розлиныг эхнэрээ болгосноор бидний холбоо тогтоно. Тэгээд ч эцгийн маань ч нас сүүдрийг харгалзан үзэх хэрэгтэй. Тэр ерэн насыг өнгөрч яваа болохоор энэ тулааны эцсийг үзэж чадахгүй. Тэр бурхад авч явахаас өмнө Розлиныхоо аюулгүй гэрлэхийг харж охиныгоо хамгаалж чадах хөгжилтэй хүчтэй нөхөртэй болсон гэдгийг мэдвэл уужим зүрх нь амгалан нойрсох бизээ.

Бид бүгд лорд Валдерийг баяртай үхэхийг хүсч байна. Кателинд энэ гэрээний нөхцөл таалагдах нь улам бага болж байлаа.

- Миний дүү дөнгөж сая эцгээ алдсан. Түүнд гашуудах хугацаа хэрэгтэй.

- Розлин хөгжилтэй охин. Тэр лорд Эдмурд уй гашуугаа давахад хамгийн ихээр туслах зүйл гэж Лотар хэлэв.

- Дээрээс нь миний эцэг сүй тавилтыг удаашруулахыг таашаахгүй байгаа. Яагаад гэдгийг төсөөлж ч мэдэхгүй нь гэж бутач Валдер Риверс нэмэрлэв.

- Би чиний санааг ойлголоо, Риверс. Биднийг өршөөж орхино уу гээд Робб түүн рүү хүйтнээр харлаа.

- Эрхэм дээдсийн тушаасан ёсоор больё гээд Хазгар Лотар босоход бутач ах нь догонцон өрөөнөөс гарахад туслав.

Эдмурын хилэн бадарчээ.

- Тэд миний амлалтыг ямар ч үнэ цэнэгүй гэж хэлж байна. Би ер нь яагаад хөгшин үенгээр сүйт бүсгүйгээ сонгуулах ёстой юм бэ? Лорд Валдерт Розлинээс гадна өөр охид байгаа. Ач охид ч гэсэн бий. Би ижилхэн зүйл санал болгосон. Би түүний эзэн лорд байхад тэр намайг охидуудынх нь хэнтэй нь ч гэрлэхээр сонгосон баярлах ёстой байсан юм.

- Тэр бардам хүн дээрээс нь бид гомдоосон гэж Кателин хэлэв.

- Өөрүүд түүний бардам занг аваасай! Би орон гэртээ гутаалгаж чадахгүй. Миний хариулт бол үгүй гэж Эдмур хэлэхэд Робб түүн рүү ядрангуй харлаа.

- Би чамд үүнийг тушааж чадахгүй. Үүнийг л биш шүү. Гэхдээ чи үүнээс татгалзвал лорд Фрей

ахин өө олж авах болохоор бидний эвлэрэх найдлага үгүй болно.

- Чи үүнийг яаж мэдэж байгаа юм бэ. Фрей намайг хожуу төрсөн охидынхоо нэгтэй гэрлүүлэх гэж байна. Тэр ийм боломжийг хурууны завсраа алдахгүй. Лотар манай хариуг аваачимагц тэр намайг сонгосон охинтойгоо... гэрлэхийг зөвшөөрхийг гуйж л таарна.

- Магадгүй тийм ч байж болох. Гэхдээ бид Лотарын саналыг маань хооронд нь дамжуулахыг хүлээгээд сууж чадах уу? гэж Бринден Хар загас хэлэв.

- Би умардыг буцааж авах ёстой. Миний дүү нар үхэж, Винтерфелл шатаагдан, хүмүүс маань илдэнд хядуулж... Болтоны бутчид юу тохиолдсоныг зөвхөн бурхад мэдэх байх. Эсвэл Теон амьд хэвээр эрх чөлөөтэй явж байгаа ч юм бил үү. Би энд суугаад болох болохгүй нь мэдэгдэхгүй хуримыг хүлээж чадахгүй гээд Робб нударга зангидлаа.

- Энэ хурим болох ёстой. Би чамаас дутуугүй Валдер Фрейгийн доромжлол гомдлыг сонсохыг хүсэхгүй байгаа ч энд сонголт алга, дүү минь. Хурим хийхгүй бол Роббын үйл хэрэг ялагдана. Эдмур бид зөвшөөрөх хэрэгтэй гэж Кателин дургүйхэн хэллээ.

- Бид зөвшөөрөх хэрэгтэй гэнэ ээ? Би таныг ес дэх хатагтай Фрей болгохоор санал болгосныг мэдэхгүй л юм байна шүү, Кат.

- Найм дахь хатагтай Фрей амьд дээрээс нь эрүүл энх байгаа. Бурхдын авралаар. Өөрөөр бол ийм зүйл болж болох л байлаа.

- Би Долоон ханлигийн тэднийг гэрлэхийг хүссэн эцсийн хүн, зээ минь. Чи Гармын тулалдаанд гаргасан алдаагаа залруулахын тулд юу гэж хэлсэн билээ хэмээн Хар загас хэлэв.

- Би бодолдоо шал өөр зүйл бодож байсан юм. Хааны алуурчтай хийх халз тулаан ч юм уу. Эсвэл долоон жил гуйлгачин ах дүү болох шийтгэл юм уу наран жаргах зүгийн тэнгист хөлөөсөө уяатай сэлэх гээд Эдмур хэн ч инээмсэглэхгүй байгааг хармагц гараа өргөж,

- Өөрүүд та нарыг бүгдийг чинь аваасай! Маш сайн байна би тэр хүүхэнтэй чинь гэрлэе. Алдаагаа залруулахын тулд шүү гэв.

ДАВОС

- Хоолой гарч байна. Давос, чи үүнийг сонсож байна уу? Хэн нэгэн бидэн рүү ирж байна гээд Лорд Алестер дээшээ огцом ширтэв.

- Нүд загас байх. Одоо хоолны цаг болсон юм уу дөхөж байгаа гээд тэдэнд өнгөрсөн шөнө Нүд загас үхэр, гахайн махан бялууны тал боов, домботой балтай авчирсан болохоор Давос энэ тухай бодохоос гэдэс нь хүржигнэв.

- Үгүй ээ нэгээс олон хүн байна.

Түүний зөв. Давост хоёроос багагүй хүний хоолой шатны уруу улам чангаран дуулдах сонсогдлоо. Тэр хөл дээрээ өндийж сараалж руу очив.

Лорд Алестер хувцсандаа наалдсан сүрлийн хогыг гүвлээ.

- Хаан намайг авахаар явуулсан байна. Эсвэл хатан ч юм уу. Селиса өөрийнх нь садны хүн болохоор хэзээ ч намайг энд орхихгүй.

Гяндангийн гадна Нүд загас гартаа хэлхээтэй түлхүүр барин ирэхэд сэр Акселл Флорент дөрвөн харуулын хамт ард нь зогсож байлаа. Тэд Нүд загасыг хэрэгтэй түлхүүрээ олох хүртэл бамбар барин хүлээв.

- Акселл. Бурхад минь гэж. Энэ хаан юм уу хатан намайг авахаар явуулсан биз дээ? гэж лорд Алестер асуухад,

- Хэн ч чамайг авахаар явуулаагүй, урвагчаа гэж сэр Акселл палхийтэл хэлсэнд лорд Алестер алгадуулсан мэт давхийтэл цочив.

- Үгүй. Би ямар ч урван тэрсэлсэн хэрэг хийгээгүй гэдгээ чамд тангараглаж байна. Чи яагаад намайг сонсохгүй байгаа юм бэ? Хэрвээ эрхэм дээдэс надад тайлбарлах боломж олговол...

Нүд загас том төмөр түлхүүр гаргаж ирээд цоожны нүхэнд шургуулан эргүүлэхэд зэвэрсэн нугас эсэргүүцэн хяхтнаж өрөө нээгдлээ.

- Чи. Эндээс гар гэж тэр Давост хэлэв.

- Хаашаа? Надад үнэнийг хэлээч сэр. Та нар намайг шатаах гэж байгаа юм уу? гээд Давос сэр Акселл руу харлаа.

- Чамайг биднийг авчир гэж явуулсан. Алхаж чадах нь уу?

- Чадна гээд Давос өрөөнөөс алхан гарахад лорд Алестер Нүд загасыг хаалга тас хийн хаахтай зэрэгцэн айсандаа хирдхийн бархирав.

- Бамбарыг нь ав. Урвагчийг харахуйд орхи гэж сэр Акселл харгалзагчид тушаалаа.

- Үгүй. Акселл гуйж байна гэрлийг битгий аваач... бурхад өршөөг гэж ах нь хэлэв.

- Бурхад гэнэ ээ? Энд зөвхөн Р'хлор болон Өөрүүд гэж бий гээд сэр Акселл огцом дохиход харуулын нэг бамбарыг хонуураас сугалан авч дээшээ тэргүүлэн өгслөө.

- Чи намайг Мелисандра руу аваачиж байгаа юм уу? гэж Давос асуув.

- Тэр тэнд байгаа. Тэр хэзээ ч хаанаас холддоггүй. Гэхдээ эрхэм дээдэс өөрийн биеэр чамайг асуусан гэж сэр Акселл хэллээ.

Давос гараа суран оосортой азын ширэн хүүдий өлгөөтэй байсан газар цээжиндээ хүргээд дөрвөн хурууны үзүүрийн хамт үгүй болсныг саналаа. Гэвч гар нь тэр эмэгтэйн хоолойг багалзуурдахад хангалттай урт хэвээр бөгөөд ялангуяа түүнийх шиг туяхан нарийхан хоолойтой бол шүү дээ.

Тэд эргүүлгэн шатаар ганц эгнээ цувран дээшээ өгсөв. Ханыг бараан өнгийн өө сэвтэй чулуугаар хийсэн болохоор хүрэхэд хүйтэн байлаа. Бамбарын гэрэл урд нь гийгүүлэн ханан дээр тэдний өнгөрөхөд сүүдэр тусна. Гурав дахь эргэлтэн дээр тэд харанхуй төмөр хаалгыг онгойлгож тав дахь эргэлтээ хийлээ. Давос ойр хавьцаа юм уу дээр нь газрын гадаргуу буйг таамаглав. Дараа нь тэд модон хаалгаар нэвтэрсэн ч дээш өгссөн хэвээр байлаа. Эндхийн хана сумны харвалтанд хэлтрэн сийчигдсэн ч нарны гэрэл зузаан чулуун ханын завсар тусч байсангүй. Гадаа шөнө болж байлаа.

Давосын хөл бадайрч эхлэхэд сэр Акселл хүнд хаалга онгойлгож гар гэж дохив. Түүний цаана хоосон агаар дээгүүр "Чулуун бөмбөр" гэж дууддаг нүсэр төв цамхаг руу татсан өндөр чулуун нуман гүүр байлаа. Тэнгисийн салхи дээврийн нуман тулгуур дундуур тасралтгүй үлээж Давос гүүрийг гатлахад давстай усны үнэр мэдрэгдэв. Тэр гүн амьсгаа авч уушгаа цэвэр хүйтэн агаараар дүүргэлээ. *Салхи, ус минь надад хүч өгөөч* гэж залбирлаа. Дор хашаанд шөнийн айдсыг эргээс хязгаарлаж буй том задгай түүдэг гал дүрэлзэн хатны хүмүүс тойрон цуглараад шинэ улаан бурханд аялгуулан мөргөнө.

Тэд гүүрний голд ирэх үед сэр Акселл гэнэтхэн зогсож Давосын гарнаас огцом шүүрэн аваад хүмүүсийн чихнээс холдуулав.

- Хэрвээ миний сонголтоор болдог бол би чамайг ах Алестертэйгээ хамт шатаах байлаа. Та хоёр хоёул урвагчид.

- Хүссэнээрээ хэлж болно. Би Станнис хаанаас урваагүй.

- Чи урвасан. Чи урвах гэж байсан. Би үүнийг царайнаас чинь харсан. Бас галын дөлнөөс ч гэсэн харсан. Р'хлор надад ийм авъяас хайрласан. Хатагтай Мелисандратай адил тэр надад ирээдүйг галын дөлд үзүүлсэн. Станнис Баратеон төмөр хаан ширээнд сууна. Би үүнийг харсан. Үүний тулд яах ёстойг нь мэдэж байна. Эрхэм дээдэс урвагч ахын минь оронд намайг Гар болгох ёстой. Харин чи түүнд ингэж хэлэх болно.

Би юу? Давос юу ч дуугарсангүй.

- Хатан миний томилогдохыг дэмжиж байгаа. Чиний Лайсын хуучин найз дээрэмчин Саан хүртэл ижилхэн зүйл хэлсэн. Тэр бид хоёр хамтдаа төлөвлөгөө боловсруулсан. Гэсэн ч одоохондоо эрхэм дээдэс зөвшөөрөөгүй байна. Ялагдал түүний дотроос сүнсийг нь хар өт шиг идэж байгаа. Энд зөвхөн түүнд биднээс хайртай хүн юу хийхийг нь үзүүлэх ёстой. Хэрвээ чи хэлсэн шигээ үйл хэрэгтээ үнэнч бол бидний талд нэгд нэгдэн дуу хоолойгоо нэмэрлэ, хориотой наймаачин минь. Түүнд намайг зөвхөн хэрэгтэй Гар нь гэж хэл. Хэрвээ түүнд ингэж хэлвэл биднийг дайлаар мордох үед би чамд шинэ онгоц өгнө шүү.

Онгоц. Давос түүний царайг ажлаа. Сэр Акселл хатныхтай адил Флорентийн дэлдэн чихтэй байв. Ширүүн хар үс чихнээс нь ургаж хамрын нүхнээс нь цухуйн давхар эрүүний доор хэсэг тугаараа байлаа. Түүний хамар өргөн, хөмсөг унжуу, дайсагнасан ойрхон нүдтэй ажээ. *Тэр надад хичнээн ийм зүйл хэлсэн ч хүсэлтийг нь биелүүлэх юм бол хөлөг онгоцноос илүү шатаалгын түүдэг шагнах биз.*

- Хэрвээ чи надаас урвахаар бодож байгаа бол удаан хугацаанд Лууны цохионы цайзын захирагч байсныг маань санаарай. Цэргийн анги миний мэдэлд байгаа. Би чамайг хааны зөвшөөрөлгүй шатааж чадахгүй ч гэлээ унаж үхэхгүй гэдгийг чинь хэн мэдэж байгаа юм бэ гээд сэр Акселл махлаг гараа Давосын шилэн хүзүүн дээр тавьж биеийг нь гүүрний бүсэлхий тулсан өндөр хашлага руу түлхэн царайг нь хашаа руу хүчээр харууллаа.

- Чи намайг сонсов уу?

- Би сонслоо. *Тэгээд чи намайг урвагч гэж хэлж зүрхэлж байгаа юм уу?*

- Сайн байна. эрхэм дээдэс хүлээж байгаа. Бид түүнийг хүлээлгэхгүй байсан нь дээр гээд сэр Акселл түүнийг тавин инээмсэглэв.

Чулуун бөмбөрийн хамгийн дээд талын оройн "Зурагтай ширээний өрөө" гэдэг дугуй том өрөөнд Станнис Баратеон өрөөний алдрыг олсон зүйл болох Эйгон Байлдан дагуулагчийн үеийн Вестеросын зураг дүрс модон сийлбэр бүхий нүсэр том модон хавтангын ард зогсч байлаа. Хааны дэргэд дотор нь нүүрс гал шаргал өнгөөр цогшин улайрсан төмөр тосгуур байлаа. Өрөөнд урд, хойд, баруун, зүүн зүг харсан дөрвөн өндөр цонх байв. Гадаа шөнө болж байсан болохоор цонхны цаана одот тэнгэр үзэгдэнэ. Давос салхи исгэрэн тэнгис сулхан давалгаалах чимээ сонслоо.

- Эрхэм дээдсээ таны таалал ёсоор би сонгино хүлэг баатрыг авчирлаа гэж сэр Акселл хэлэв.

- Би харж байна гээд Станнис саарал даавуун цамц, бараан улаан нөмрөг өмсч энгийн хар ширэн бүсэнд илд, хутга зүүжээ. Асан дүрэлзэж буй дөл хэлбэрийн улаан алтан титэм хөмсгийг нь тойрон дугуйран эмжинэ. Түүнийг харахаас нүд хальтирам байлаа. Тэр Давосыг Шуурганы адгаас тэдний бүтэлгүйтсэн Хар усны тулалдаан руу мордсон цагаас хойш арван насаар хөгширсөн юм шиг санагдав. Хаан ойрхон эмжсэн сахал, буурал сор суусан саарал үстэй бөгөөд хоёр чулуунаас багагүй жинтэй байлаа. Тэр хэзээ ч махлаг хүн байгаагүйн дээр одоо бүр яс арьс болж арьсны дор үе мөч нь цоо нэвтлэн гарах гэж байгаа жад шиг гүрвэлзэнэ. Толгой дээрх титэм нь хүртэл томдож байлаа. Цэнхэр нүд нь гүн хөнхийж хоцроод гавлын ясны дүрс царайнд нь зурайна.

Гэсэн хэдий ч хаан Давосыг хармагц сулхан инээмсэглэв.

- Тэгэхээр миний хүлэг баатар тэнгисээс сонгино, загастай ирсэн юм биз дээ.

- Тэгсэн, эрхэм дээдсээ. *Ингэхэд тэр намайг гянданд байсныг мэдэж байгаа болов уу?* Давос өрөөсөн өвдгөө сөхөрлөө.

- Бос, сэр Давос гэж Станис тушаав.

- Би чамайг үгүйлж байлаа, сэр. Надад сайн зөвөлгөө хэрэгтэй байгаа болохоор чи үргэлж намайг үүгээр дутааж байгаагүй. Тэгэхээр надад үнэнийг хэлээч... урван тэрслэлтэнд ямар ял оноох вэ?

Үг агаарт дүүжигнэв. *Аймшигтай үг* гэж Давос бодлоо. Тэр өрөөнд нь хамт байсан хүнийг асууж байгаа юм болов уу? Эсвэл түүний тухай юм болов уу? *Хаан урван тэрсэлсэн гэмт хэрэгт ямар ял оноохыг хэнээс ч илүү мэдэж байгаа.*

- Урван тэрслэлт гэнэ ээ? хэмээн Давос сулхан дуугарав.

- Хааныгаа үгүйсгэж хууль ёсны хаан ширээг нь хулгайлах арга зам хайсан хүнийг өөрөөр юу гэж нэрлэх болж байна. Би чамаас ахин асууя... хуулинд урван тэрслэлтэнд ямар ял оноодог вэ? гэхэд Давост хариулахаас өөр зам үлдсэнгүй.

- Үхэл. Үхлийн ял оноодог, эрхэм дээдсээ.

- Хэдийгээр үргэлж тийм байсан ч гэлээ би... би хэрцгий хүн биш, сэр Давос. Чи намайг мэднэ. Удаан хугацааны өмнөөс мэднэ. Энэ миний шийдвэр байгаагүй. Эйгон болон түүнээс ч өмнөх өдрүүдэд тийм байсан. Дэймон Блэкфайр, Тойны ахан дүүс, Тас хаан, эрхэмсэг мэйстер Харет болон Рэйнира Таргариан хүртэл үргэлж урвасан гэмт хэргийнхээ хариуг амиараа төлж байсан. Тэр хааны ууган охин байсан ч дүүгийнхээ титмийг булаахаар оролдсоны төлөө урвагчийн ёсоор үхсэн. Энэ бол хууль. Хууль, Давос. Хэрцгий явдал биш.

- Тиймээ, эрхэм дээдсээ. Тэр миний тухай яриагүй юм байна. Давос харанхуйд хоцорсон өрөөний ханиа өрөвдлөө. Тэр дуугүй байх ёстойгоо мэдэж байсан ч зүрх нь шимширч цуцсан тул өөрийн мэдэлгүй,

- Сэр лорд Флорент урван тэрсэлсэн хэрэг хийгээгүй гэв.

- Хууль бус зүйл явуулагчид бас өөр нэр байдаг юм уу? Би түүнийг Гар болгон өргөмжилсөн байтал тэр миний эрхийг таваг вандуйны будаагаар худалдсан. Тэр ч байтугай Ширийнийг хүртэл тэдэнд өгөх гэж байсан. Миний цорын ганц үрийг тэр нөхцөний дүнд төрсөн бутачтай гэрлүүлэх гэж байсан гээд хааны хоолойд уур хилэн бадарлаа.

- Миний ах үнэнч занг өөгшүүлдэг авъяастай байсан. Дайсныхаа хүртэл шүү. Зуны өргөөнд тэр ганц өдрийн дотор гурван тулаанд ялалт байгуулан лорд Грандисон, Кафферан хоёрыг Шуурганы адагт хоригдлоор авчирсан. Тэр далбааг нь танхимдаа ялалтын олз болгон өлгөсөн байлаа. Каффераны цусны толботой цагаан янзага болон Грандисоны унтаж буй арсланг хүү татан

хуваасан далбаа. Гэсэн ч тэд тэдгээр тугийн дор шөнөжингөө сууж Роберттой идэж ууж найрласан. Роберт тэднийг анд хүртэл авч явсан гээч. "Эдгээр хүмүүсийг чи Эйрист шатаалгахаар илгээх ёстой. Чи тэдний гарт сүх бариулах ёсгүй байсан юм" гэж би тэднийг дараа нь хашаанд сүх шидэж байхыг харж хэлэхэд Роберт ердөө инээд алдсан. Би Грандисон, Кафферан хоёрыг гянданд хийсэн байхад тэр эргүүлэн нөхдөө болгон авсан. Лорд Кафферан Робертийн төлөө тулааны үеэр Эшфордын Цайзад Рэндилл Тарлид цавчуулан үхсэн. Лорд Грандисон үүнээс жилийн дараа Сэрээнд шархдаж үхсэн. Миний ах тэднийг өөртөө хайртай болгосон ч би зөвхөн урван тэрслэлтийг өөгшүүлдэг бололтой. Миний өөрийн цусны төрлийн хүмүүс болох дүү, өвөө, үеэл, нагац нар маань хүртэл...

- Эрхэм дээдсээ. Би танаас бүх Флорентийнхон ийм сул дорой биш гэдгийг батлах боломж өгөхийг гуйж байна гэж сэр Акселл хэлэв.

- Сэр Акселл надад дайныг сэргээх гэж байгаа. Ланнистерийнхан намайг бут цохигдон ялагдаж андгай өргөсөн лордууд маань ойр хавийн бүх хүнтэй цуг орхисон гэж бодож байгаа. Миний эхийн эцэг лорд Эстермонт хүртэл Жоффрид өвдөг нугалан сөгдсөн. Надад ердөө зүрх зоригоо алдсан хэдхэн үнэнч хүн үлдсэн. Тэд өдрийг ууж наргин мөрийцөн өнгөрүүлж зодуулсан нохой шиг шархаа долоож байна.

- Тулаан тэдний зүрхийг ахин дүрэлзүүлнэ, эрхэм дээдсээ. Ялагдал бол өвчин хууч ялалт бол эмчилгээ гэж сэр Акселл үг хавчуулав.

- Ялалт гэнэ ээ. Тэр ялалт чинь бол ялалт сэр. Гэхдээ чи төлөвлөгөөнийхөө тухай сэр Давост танилцуул. Би чиний тавьсан саналд түүний бодлыг сонсмоор байна.

Сэр Акселл Давос руу эргэхэд царай нь Ариун Бэйлор хаан гуйлгачины идээтэй хөлийг угаахыг тушаасан бардам лорд Белгрэйвтэй адилхан царайтай байлаа. Гэсэн ч тэрбээр үг дуугүй дагалдав.

Сэр Акселлийн төлөвлөгөө Салладор Саантай хамт боловсруулсан энгийн ажээ. Лууны цохионоос Селтигарын овгийн эртний тэнгисийн суудал Сарвуу арал руу хүртэл хэдхэн цагийн зайтай байв. Лорд Ардриан Селтигар Хар усанд галт зүрхний дор тулалдсан ч олзлогдсон даруй цаг гарздалгүй Жоффрид дагаар оржээ. Тэр одоо хэр нь Хааны газарт байгаа билээ.

- Эрхэм дээдсийн уур хилэнгээс эмээсэндээ Лууны цохио руу ойртож зүрхлэхгүй байгаа нь эргэлзээгүй. Тэгсэн нь ч дээр. Тэр хүн хууль ёсны хаанаасаа урвасан гэж сэр Акселл тунхаглав.

Сэр Акселл Салладор Сааны флот болон Хар усны тулалдаанаас зугтан амьд үлдсэн цэргүүдийг ашиглахаар боджээ. Станнист Лууны цохионд мянга таван зуун цэрэг байгаагийн тэн хагасаас илүү нь Флорентийнх бөгөөд лорд Селтигарын урвалтыг цээрлүүлэхэд хангалттай байв. Сарвуу арал бага хэмжээний цэрэгтэй цайз нь Миришийн хивс, Волантиний шил, алт мөнгөн таваг, үнэт чулуун хундага, гайхамшигтай сайхан харцага, Валирианы ган сүх, мангасыг гүнээс дууддаг бүрээ, авдар бадмаараг болон зуугаад жилийн турш уугаад барахгүй дарстайгаараа алдартай байлаа. Гэсэн ч Селтигар ертөнцөд харамч нарийн царайгаа үзүүлэн өөрийн ая тухаа хүртэл хангаж байсангүй.

- Түүний цайзыг эзлэн шатааж хүмүүсийг нь хядна. Сарвуу арлыг үнс нурам яс болгож хэрээний хоол болгон орхивол хаант улс Ланнистерийнхантай дэр нийлүүлсэн хүнд ямар хувь заяа тохиохыг хараг гэж сэр Акселл сүржигнэв.

Станнис сэр Акселлийн яруу уншлагыг чимээгүй сонсох зуур эрүүгээ удаанаар хоёр тийш нь хавирав. Дууссан хойно нь,

- Үүнийг биелүүлж болно. Эрсдэл багатай юм. Жоффрид лорд Рэдвайн Арбороос ирэх хүртэл тэнгисийн цэргийн хүч байхгүй. Олз омог Лайсени дээрэмчин Салладор Сааныг үнэнч байлгахад тус болно. Хэдийгээр Сарвуу арал ямар ч үнэ цэнэгүй ч уналт нь лорд Тайвинд миний үйл хэрэг дуусаагүйн баталгаа болог гээд Давос руу эргэж,

- Үнэнийг хэл, сэр. Чи сэр Акселлийн төлөвлөгөөний талаар юу бодож байна? гэв.

Үнэнийг хэл, сэр. Давос харанхуй гяндан лорд Алестертэй хуваалцаж байсан үе болон Нүд загас, Агшаамал хоёрын тухай саналаа. Түүнчлэн сэр Акселлийн гүүрэн дээрээс хашаа руу өнгийлгөсөн заналхийллийг санав. *Хөлөг онгоц эсвэл түлхүүлэхийн алин вэ?* Гэхдээ үүнийг Станнис асуусан шүү дээ.

- Эрхэм дээдсээ. Би үүнийг хулчгар тэнэг явдал гэж хэлэх байна хэмээн тэр удаанаар хэлэв.

- Хулчгар гэнэ ээ? Ямар ч хүн намайг хааны урд хулчгар гэж зүрхлэхгүй! хэмээн сэр Акселл байдгаараа орилов.

- Чимээгүй. Сэр Давос ярьж болно. Би чиний шалтгааныг сонсоё гэж Станнис тушаалаа.

Давос сэр Акселл руу царайгаа хандан эргүүлэв.

- Чи биднийг хаант улсад дуусаагүй болохыг маань үзүүлнэ гэж хэлсэн. Гэнэтийн цохилт болон дайн хийх юм биз дээ... гэвч ямар дайсантай гэж? Ланнистерийнхан Сарвууны аралд байхгүй шүү дээ.

- Бид урвагчдийг олно. Зарим нэгийг нь орон гэрээс нь юм уу бүр энэ өрөөнд ч байж магадгүй гэж сэр Акселл хэлэв.

Давос тохуурхлыг үл тоомсорлолоо.

- Би лорд Селтигарыг хөвгүүн Жоффрид өвдөг сөгдсөн гэдэгт эргэлзэхгүй байна. Тэр хөгшин дуусч яваа хүн болохоор амьдралынхаа эцсийг шилтгээндээ үнэт чулуун хундаганаас сайн дарсаа уун өнгөрүүлэхээс өөр зүйл хүсээгүй гээд Станнис руу эргэлээ.

- Гэсэн ч тэр таныг дуудахад ирсэн, сэр. Хөлөг онгоц болон цэргүүдтэйгээ ирсэн. Тэр лорд Рэнлиг бидэн рүү ирэхэд Шуурганы адагт таны талд зогсож хөлөг онгоцууд нь Хар ус руу хамт хөдөлсөн. Түүний цэргүүд таны төлөө тулалдаж алуулж шатаагдсан. Сарвууны арал сул хамгаалалттай нь үнэн. Цөөн тооны хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшин хүмүүс байгаа. Харин яагаад тэр билээ? Учир нь тэдний эр нөхөр, хүү, эцгүүд Хар усанд амь үрэгдсэн учраас шүү дээ. Сэлүүр дээрээ, гартаа

илдтэйгээ үхэн манай тугийн дор тулалдсан. Гэтэл бид сэр Акселлээс болж тэдний ард үлдээсэн орон гэр лүү очиж бэлэвсэн эхнэрүүдийг нь эзэмдэн хүүхэд багачуудыг нь алж хядах гэж байна. Жирийн ардууд бол урвагчид биш...

- Тэд мөн. Селтигарын бүх эрчүүд Хар усанд алагдаагүй. Хэдэн зуугаад нь эзэнтэйгээ хамт үлдэж өвдөг сөгдөх үед нь дагасан гэж сэр Акселл уухилав.

- Тиймээ тэр тэгсэн. Гэхдээ тэд түүний хүмүүс, андгай өргөсөн хүмүүс байсан. Тэдэнд ямар сонголт байсан гэж?

- Хүн бүрт сонголт байдаг. Тэд өвдөг сөгдөхөөс татгалзаж болох байсан. Зарим нь үүнийг хийж алуулсан. Гэсэн ч тэд үнэнч хүний ёсоор үхсэн.

- Зарим хүн бусдаасаа хүчтэй байдаг юм гээд сулхан хариулт болохыг нь Давос мэдэж байлаа. Станнис Баратеон бол төмөр хүн болохоор сул дорой бусад хүнийг өршөөх талаар ямар ч ойлголтгүй байв. Би дийлдлээ гэж цөхрөн бодов.

- Хүн бүрийн үүрэг бол эзэн нь буруу талд орсон ч гэсэн хууль ёсны хаандаа үнэнч үлдэх явдал гэж Станнис маргахын аргагүй хатуу өнгөөр хэлэхэд Давос цөхөрсөн тэнэглэлд автсандаа ухаангүй зүйл хийж,

- Ах чинь далбаагаа мандуулах үед таны Эйрис хаанд үнэнч үлдсэн шиг үү? гээд хэлчихлээ.

Цочирдсон нам гүм болоход сэр Акселл,

- Урвагч! Эрхэм дээдсээ тэр таныг нүүрэн дээр чинь гутаасан үг ярьж байна! гэж орилоод хутгаа хуйнаас нь шүүрч авлаа.

Давост Станнисийн шүд хавирах чимээ сонсогдоход хааны хөмсгөн дээр цэнхэр судас овойн хөөж тэдний харц уулзлаа.

- Хутгаа далд хийгээд биднийг орхи, сэр Акселл.

- Эрхэм дээдсийн таалалд нийцвэл...

- Чиний явах миний таалалд нийцэж байна. Эндээс гараад Мелисандраг дууд.

- Таны тушаасан ёсоор больё гээд сэр Акселл хутгаа хуйлан мэхийн ёслоод хаалганы зүг яаран явахад гутлынх нь чимээ шалан дээр ууртай түсхийлээ.

- Чи үргэлж миний тэвчээрийг давж байх юм. Би хурууг чинь мухарлсан шигээ хэлийг чинь тайрч чадна шүү, хориотой наймаачин минь гэж Станнис Давост ганцаар хоцорсон хойно анхааруулав.

- Би таны хүн, эрхэм дээдсээ. Тэгэхээр энэ таны хэл болохоор хүссэн зүйлээ хийж болно.

- Тиймээ мөн. Тэгээд ч би түүгээр үнэнийг ярьж байна. Хичнээн гашуун байсан ч гэсэн үнэнийг.

Эйрис гэсэн үү? Тэгэхэд сонголт хэцүү байсныг чи мэдэхгүй байна. Миний өөрийн цусны хүн үү эсвэл эзэн лорд уу. Миний ах уу эзэн хаан уу гээд Станнис ярвайлаа.

- Чи ер нь хэзээ нэг цагт төмөр хаан ширээг харж байсан уу? Арын түшлэгийг нь мурийж тахийлгасан илдээр цутгасан болохоор илд хутганы үзүүрүүд нь хоорондоо холилдон хайлсан. Энэ бол тийм ч тавтай суудал биш, сэр. Эйрис өөрийгөө үргэлж зүсдэг учир Шархтай хаан гэж дуудуулдаг байлаа. Хэрцгий Мэйгор тэр сандалд алагдсан. Тэр сандлын тухай зарим нэг зүйл ярилцдаг. Энэ бол хүн амрахын тулд суудаг суудал биш. Заримдаа би яагаад миний ах дүүс үүний тэгтлээ хүсч байсан учрыг нь гайхдаг юм.

- Тэгвэл та яагаад хүсч байгаа юм бэ? гэж Давос асуулаа.

- Энэ бол хүсэх тухай асуудал биш. Робертийн залгамжлагч ёсоор хаан ширээ хууль ёсоор минийх. Миний дараа Селиса надад хүү гаргаж өгдөггүй юм бол охинд маань шилжинэ гээд Станнис олон жилийн туршид харлаж хатуурсан ширээний толигор гадаргуу дээгүүр гурван хуруугаараа хөнгөн товшлоо.

- Би бол хаан. Үүнд оролцоогүй ч байсан болоосой гэж хүсч байна. Надад охиныхоо өмнө биелүүлэх үүрэг бий. Хаант улсынхаа төлөө ч гэсэн. Робертийн төлөө хүртэл. Тэр надад өчүүхэн хайртай байсан ч ах минь байсан. Ланнистерийн эмэгтэй түүнд бишгүүр өгч эрээн хувцастай тэнэг болгосон. Тэр Жон Аррин, Нэд Старкийг алсан шигээ түүнийг ч гэсэн алсан байж магадгүй. Ийм гэмт хэргийг шүүх ёстой. Серсейгээс авахуулаад бүх бузар булайг нь. Гэвч энэ бол зөвхөн эхлэл. Сэрээний дараа Робертийн хийсэн зүйл шиг би ордонг хүсч цэвэрлэнэ. Сэр Барристан урьд нь надад нэг удаа Эйрисийн хаанчлал Варисаас эхлэн ялзарч эхэлсэн гэсэн. Тэр тайганыг хэзээ ч өршөөх ёсгүй байсан юм. Хааны алуурчийг ч гэсэн. Роберт түүний цагаан нөмрөгийг хуулан авч лорд Старкийн шаардсаны дагуу Хана руу явуулах ёстой байсан юм. Гэвч тэр оронд нь Жон Арриныг сонссон. Би Шуурганы адагт бүслэлтэнд байсан болохоор зөвөлгөөнд оролцож чадаагүй гээд тэр огцом эргэж Давос руу цоо ширтлээ.

- Одоо үнэнийг хэл. Чи яагаад хатагтай Мелисандраг алахыг хүссэн юм бэ?

Тэгэхээр тэр мэдэж байна. Давос түүнд худал хэлсэнгүй.

- Миний дөрвөн хөвгүүн Хар усанд шатаагдсан. Тэр тэднийг галд өгсөн.

- Чи буруу ярьж байна. Тэр гал бол түүний ажил биш. Хараал идсэн одой, пиромансер болон миний флотыг занганы аманд аваачиж оруулсан тэнэг Флорентийг хараа. Эсвэл хамгийн хамгийн хэрэгтэй цагт түүнийг авч яваагүй миний тэнэг бахархлыг хараа. Гэвч Мелисандраг биш. Тэр миний үнэнч зарц хэвээр үлдсэн.

- Мэйстер Крессен таны үнэнч зарц байсан. Тэр түүнийг сэр Кортни Пенроуз, таны дүү Рэнли хоёр шиг алсан.

- Одоо харин чи тэнэг сонсогдож байна гэж хаан гомдоллов.

- Тэр Рэнлигийн үхлийг галын дөлд харсан ч надаас илүүгүй үүнд оролцоогүй. Удган надтай хамт байсан. Чиний Деван үүнийг хэлж чадна. Хэрвээ миний үгэнд эргэлзэж байвал түүнээс асуугаарай. Хэрвээ тэр чадах байсан бол Рэнлиг аврах байсан. Мелисандра л намайг түүнд урван тэрслэлтээ залруулах эцсийн боломж өгөхөөр уулзахыг шаардсан. Бас Мелисандра надад сэр Акселл чамайг Р'хлор руу илгээхийг хүсэх үед уулзахыг зөвлөсөн. Энэ чиний гайхлыг төрүүлэхгүй байна уу? гээд Станнис үл мэдэг мушийн инээмсэглэв.

- Тийм. Тэр намайг өөрийнхөө болон улаан бурхны анд биш гэдгийг мэдэж байгаа.

- Гэхдээ чи миний анд. Тэр үүнийг сайн мэдэж байгаа гээд Станнис Давос руу ойртон бөхийж, - Хүү өвдсөн. Мэйстер Пайлос түүнийг хануур хорхойгоор эмчилж байгаа гэв.

- Хүү гэнэ ээ? Миний хүү юу, эзэнтээн? гээд Давосын бодол хааны хиа Деван хүү рүүгээ шилжлээ.

- Деван уу? Сайн хүү байгаа юм. Түүнд тэр хүүгээс илүү зүйл байгаа. Бидний Шуурганы адагт авчирсан Робертийн бутач хүү өвдсөн хэрэг.

Эдрик Сторм.

- Би түүнтэй Эйгоны цэцэрлэгт ярилцсан.

- Түүний хүсэл ёсоор. Мелисандра үүнийг харсан гээд Станнис санаа алдлаа.

- Хүү чиний сэтгэлийг татаа юу? Түүнд ийм авьяас бий. Үүнийг эцгийнхээ цуснаас өвлөж авсан юм. Тэр хааны хүү гэдгээ мэдэж байгаа болохоор дорд гаралтай бутач гэдгээ мартдаг юм. Түүнчлэн Рэнлигийн жаахан байх үеийнх шиг Робертийг биширдэг. Миний хаан ах Шуурганы адагт хайрт эцэг болгон тоглож айлчилан бэлэг сэлт болох сэлэм, одой морь, арьсан эмжээртэй нөмрөг бэлэглэдэг байсан. Бүгд тайганы хийсэн ажил. Хүү Улаан шилтгээн рүү талархал дүүрэн захидал бичихэд Роберт инээд алдан Варисаас энэ удаад юу илгээснийг нь асуудаг байсан. Рэнли ч гэсэн дээрдэх юмгүй. Тэр хүүг хүмүүжүүлэх ажлыг цайзын захирагч, мэйстерүүдэд орхисон болохоор бүгд түүний сэтгэл татах чадварын хохирогч болсон. Пенроуз түүнийг гаргаж өгөхөөс үхэхийг илүүд үзсэн гээд хаан шүдээ шажигнатал хавирлаа.

- Энэ одоо хүртэл миний уурыг хүргэсэн хэвээр байгаа. Чи яаж намайг хүүд муу зүйл хийж чадна гэж бодож чадав аа? Би Робертийг сонгосон биш үү? Тэр хүнд өдөр ирэхэд би нэр хүнднээсээ илүүтэй өөрийнхөө цусыг сонгосон.

Тэр хүүгийн нэрийг хүртэл хэлэхгүй байна. Энэ нь Давосын сэтгэлийг аягүйцүүлэв.

- Би залуу Эдрикийг удахгүй эдгэнэ гэж найдаж байна гэхэд Станнис сэтгэл зовних хэрэггүйн тэмдэг болгон гараа дохив.

- Энэ ердөө ханиаднаас илүүгүй. Тэр ханиалгаж чичирэн халуурч байгаа. Мэйстер Пайлос түүнийг удахгүй хэвийн болгоно. Хүүгийн хувьд юу ч биш ч түүний судсаар ахын маань цус гүйж байгааг чи ойлгож байгаа биз дээ. Хааны цусанд хүч бий гэж тэр эмэгтэй хэлсэн.

Давост тэр эмэгтэй гэж хэн болохыг асуухын ч хэрэг байсангүй.

Станнис Зурагтай ширээнд хүрлээ.

- Үүнийг хараач, сонгино хүлэг баатар минь. Миний хууль ёсны хаант улс. Миний Вестерос гээд гээд гараа дээгүүр нь савчсанаа,

- Энэ Долоон ханлигийн тухай яриа бол тэнэг хэрэг. Эйгон гурван зуун жилийн өмнө бидний байгаа газар зогсохдоо үүнийг харсан. Энэ ширээг түүний тушаалын дагуу хийсэн. Гол мөрөн, булан тохой, толгод, уулс, шилтээн, хот, зээлийн худалдаа, нуур, намаг, ой гээд ямар ч хил хязгааргүй зурсан. Энэ бүгд бол нэг зүйлс. Ганц л хаан захирах тавилантай ганц хаант улс.

- Ганц хаан. Ганц хаан энхийг тогтооно гэж Давос зөвшөөрөв.

- Би Вестеросд шударга ёсыг авчирна. Сэр Акселлийн ойлголт хийж байгаа дайн шигээ өчүүхэн зүйл. Сарвуу арал надад юу ч өгөхгүй үүнийг муу ёрын зүйл гэж чи хэлсэн. Селтигар урван тэрслэлтийнхээ хариуг өөрийн биеэр төлөх ёстой. Намайг хаант улс руугаа очих цагт тэр тэгэх болно. Өндөр дээд лордоос эхлээд дор муу усны харх хүртэл бүх хүн тарьсан үрээ хураадаг жамтай. Зарим нэг нь хурууныхаа үзүүрээс илүү зүйлийг алдах болно гэдгийг би чамд амлах байна. Тэд миний хаант улсад цус урсгасан болохоор би үүнийг мартажгүй гээд Станнис хаан ширээнээс эргэлээ.

- Өвдөг сөгд, Сонгино хүлэг баатар минь.

- Эрхэм дээдсээ?

- Би урьд нь чамайг загас, сонгино авчирсны чинь төлөө хүлэг баатар болгосон. Үүний чинь төлөө лорд болгон дэвшүүлье.

Үүний төлөө гэнэ ээ? Давос гайхаж хоцров.

- Би таны хүлэг баатар байгаадаа баяртай байна, эрхэм дээдсээ. Би яаж лорд байхыг хүртэл мэдэхгүй хүн.

- Сайн байна. Лорд байх бол хуурамч зүйл. Би үүнээс хатуу сургамж авсан. Одоо өвдөг сөгд гэж хаан чинь тушааж байна шүү

Давос өвдөг сөгдөхөд Станнис урт илдээ сугалав. Гэрэл гэгээ авчирагч гэж Мелисандра үүнийг нэрлэсэн бөгөөд долоон бурхныг шатаасан түүдгийн галаас сугалсан баатрын улаан илд билээ. Илдийг хуйнаас сугалахад өрөөнд улам гэгээтэй болох шиг санагдав. Илд цогшин улайж шаргалтсанаа шарлаж улаавтар боллоо. Эргэн тойрон агаар чичигнэхэд үнэт чулуу хүртэл тод цацрахаа болив. Гэвч Станнис Давосын мөрөнд хүрэх үед өөр урт илдээр хүрснээс ялгаагүй байлаа.

- Сивортын овгийн сэр Давос чи одооноос эхлэн үүрд миний үнэнч жинхэнэ хүн байх уу? гэж хаан асуув.

- Тиймээ, эрхэм дээдсээ.

- Тэгвэл чи надад үлдсэн амьдралынхаа туршид үнэнч зүтгэн, шударга зөвөлгөө өгч тушаалыг биелүүлэн, эрхийг минь хамгаалж хаант улсын их бага дайснуудын эсрэг тулалдан, хүмүүсийг минь хамгаалж дайсныг шийтгэхээ андгайлж байна уу?

- Би андгайлж байна, эрхэм дээдсээ.

- Тэгвэл ахин бос, Давос Сиворт. Рэйнвүүдийн лорд, Уйтан тэнгисийн усан цэргийн жанжин, Хааны Гар болон өндий.

Давос агшин зуур хөдөлж чадалгүй балмагдлаа. *Би өнөө өглөөхөн гянданд сэрсэн юмсан.*

- Эрхэм дээдсээ та ингэж болохгүй... Би Хааны Гар болоход тохирохгүй хүн.

- Чамаас өөр үүнд сайн тохирох хүн байхгүй гээд Станнис Гэрэл гэгээ авчирагчийг хуйлаад Давост гараа өгөн татаж босгов.

- Би дорд гаралтай. Дээш үсэрсэн хориотой наймаачин. Таны лордууд үгийг маань дагахгүй.

- Тэгвэл бид шинэ лордуудтай болно.

- Гэхдээ... би уншиж... бичиж чадахгүй.

- Мейстер Пайлос чамд уншиж сурахыг заана. Бичихийн хувьд гэвэл миний сүүлчийн Гар мөрнөөс толгой авхуулах үедээ бичиж байсан юм. Чамаас хүсэх ганц зүйл бол үргэлж надад өгдөг зүйл чинь болох шударга, үнэнч, зүтгэл чинь.

- Үүнд хэн нэгэн илүү дээр хүн тохирно... арай том лорд ч юм уу гэхэд Станнис тургиллаа.

- Бар Эммон тэр хүү юу? Миний итгэл даадаггүй өвөө юу? Селтигар намайг орхиж, шинэ Беларион зургаан настай, шинэ Сангласс ахыг нь намайг шатаасны дараа Волантис руу хөвсөн гээд уурсан зангаж,

- Сайн хүн цөөн үлдсэн гэдэг нь үнэн. Сэр Гилберт Фарринг Шуурганы адагт миний төлөө хоёр зуун үнэнч хүнтэй хамгаалсан хэвээр байгаа. Лорд Морриген, Шөнийн дууны Бутагч, залуу Читтеринг, миний үеэл Эндрюю гээд л. Гэхдээ би тэдний хэнд нь ч чамаас илүү итгэхгүй байна, Рэйнвүүдийн лорд минь. Чи миний Гар боллоо. Энэ бол би чамайг тулаанд дэргэд минь байхыг хүсэж байгаа гэсэн үг гэв.

Ахин нэг тулалдаан болоход бид бүхний төгсгөл болно. Лорд Алестер үүнийг зөв харжээ гэж Давос бодлоо.

- Эрхэм дээдэс шударга зөвөлгөө хүссэн. Үнэнийг хэлэхэд бид ахин нэг тулалдаанд Ланнистерийнхны эсрэг байлдахад хүч дутна гэхэд,

- Эрхэм дээдэс агуу тулалдааны тухай ярьж байна гэх дорно зүгийн аялгаар дүүрэн эмэгтэй хүний хоолой сонсогдлоо. Мелисандра хаалган дээр улаан торго, гялалзсан сатин даавуун хувцастайгаа гартаа бүтээлэгтэй мөнгөн таваг бариад зогсож байв.

- Түүнээс өмнөх өчүүхэн дайн бол ердөө хүүхдийн зодооноос илүүгүй. Нэрийг нь ч үл дурьдаж болох айсуй хүч чадлын өмнө муу ёр болон түүнээс ч цаадах зүйл унах болно, Давос Сиворт. Жинхэнэ хүн түүний эсрэг байлдах эр зориг олохгүй бол удахгүй хүйтэн болж шөнө эцэс төгсгөлгүй үргэлжилнэ. Галт зүрхтэй хүмүүс гээд тэр мөнгөн тавгаа Зурагтай ширээн дээр тавилаа.

- Тэр надад үүнийг үзүүлсэн, лорд Давос. Галын дөлд харуулсан гээд Станнис мөнгөн таваг руу ширтэв.

- Та үүнийг харлаа гэж үү дээ, эзэнтээн? гээд Станнис Баратеон ийм зүйлийн тухай худал хэлэх хүн биш байлаа.

- Би өөрийнхөө нүдээр харсан. Тулалдааны дараа намайг цөхрөнгөө барахад хатагтай Мелисандра зуухны гал руу харахыг зөвлөсөн. Яндан хүчтэй татаж байсан болохоор галаас үнс бужигнаж байлаа. Би тэнэг хүн аятай гал руу ширтсэн ч тэр намайг улам гүн рүү харуулж дээшээ хөөрч байсан цагаан үнс доош унаж байгаа юм шиг санагдсан. Цас гэж би бодлоо. Тэгтэл агаарт оч дугуйран эргэлдэж бамбарын цагариг болоход би гал дундуур өндөр толгод, ой харсан. Бамбарын ард талын нурам хар хүн болж амилан тэдгээр дүрс цасан дунд хөдөлж байлаа. Галын шатам халуун төөнөж байсан ч би хүйтэнд аймшигтай даарсандаа чичирэн үзэгдэл алга болсон хойно гал ахин дүрэлзэн ноцсон. Гэхдээ би жинхэнэ зүйл болох хаант улсаа харсан.

- Дээрээс нь биелнэ гэж Мелисандра хэлэв.

Хааны үнэмшсэн хоолой Давосыг голд нь хүртэл дагжуулав.

- Толгод ой... цастай дүрсүүд гэнэ ээ... би...

- Энэ бол тулалдаан эхэлж байна гэсэн үг. Элсэн цагны элс шилний завсар улам түргэн гоожиж хүний газар дэлхийн цаг бараг дуусч байна. Бид зоригтой хөдлөхгүй бол бүх найдлага алдагдана. Вестерос амлагдсан ханхүү болох Р'хлорын сонгосон Лууны цохионы лорд жинхэнэ хааны дор нэгдэнэ.

- Р'хлор хачин сонгосон санагдахгүй байна уу гээд хаан эвгүй зүйл амталсан мэт ярвайлаа.

- Яагаад миний ах дүүс биш би гэж? Рэнли лийртэйгээ ч юм уу. Би зүүдэндээ түүний амнаас шүүс урсаж хоолойноос нь цус гарахыг харсан. Хэрвээ тэр дүүгийн үүргээ биелүүлсэн бол бид лорд Тайвиныг бут цохиж болох байлаа. Байгуулсан ялалтанд маань Роберт хүртэл бахархах байсан. Робертийн хувьд гэвэл... гээд тэр шүдээ ээлжлэн хавирлаа.

- Тэр ч гэсэн миний зүүдэнд ордог. Инээж хөхрөн ууж сагсуурч байгаагаар. Тэд бол түүний чаддаг хамгийн сайн зүйл. Түүнээс гадна тулалдах. Би хэзээ ч түүнийг гүйцэж байгаагүй. Гэрлийн эзэн

Робертийг аваргаа болгох ёстой байсан юм. Яагаад би гэж?

- Учир нь та зөв шударга хүн учраас гэж Мелисандра хэлэв.

- Хануур хорхойтой зөв шударга хүн гээд Станнис мөнгөн тавагны тагийг хуруугаараа сөхлөө.

- Тийм. Гэхдээ энэ бол зүй ёсны арга биш гэж би таньд ахин хэлье гэж Мелисандра хэлэв.

- Чи үүнийг бүтнэ гэж амалсан гээд хаан уурсангуй харлаа.

- Тэгнэ. Эсвэл үгүй ч байж магад.

- Тэгээд аль нь юм бэ?

- Хоёул.

- Намайг сэнхрүүл, эмэгтэй минь.

- Гал энгийн өгүүлдэг шиг би ярья. Галын үнэн үргэлж харахад амар байдаггүй гээд Мелисандрагийн хоолойндoo зүүсэн том бадмаараг зуухны дөлийг уусган шингээв.

- Надад хүүг өг, эрхэм дээдсээ. Энэ бол итгэлтэй арга. Дээрээс нь хамаагүй дээр. Надад хүүг өгвөл би чулуун лууг сэрээе.

- Би чамд үгүй гэж хэлсэн биз дээ.

- Тэр бол Вестеросын бүх хөвгүүд охидын эсрэг ердөө дорд гаралтай хөвгүүн. Хаант улсын бүх хүүхэд болон ертөнцийн ч гэсэн.

- Хүү гэм зэмгүй.

- Хүү чиний хуримын орыг бузарласан. Үгүй бол чи хөвгүүдтэй болж болох байлаа. Тэр чамайг гутаасан.

- Роберт үүнийг хийсэн болохоос биш хүү биш. Миний охин түүнд сайн. Тэгээд ч тэр миний цусных.

- Чиний ахын цусных. Хааны цус. Зөвхөн хааны цус чулуун лууг сэрээж чадна гэхэд Станнис шүдээ хавирлаа.

- Би энэ тухай ахиж сонсмооргүй байна. Луунууд дууссан. Таргарианыхан тэднийг буцааж авчирахыг олон удаа оролдон өөрсдийгөө тэнэг болгосноос гадна цогцос болгосон. Нөхөөстэй царайт зөвхөн энэхүү бурхны мартсан газар байгаа цорын ганц тэнэг. Чамд хануур хорхой байна. Ажлаа гүйцэтгэ.

Мелисандра толгойгоо хөшүүн бөхийлгөж,

- Хааны тушаасан ёсоор больё гээд зүүн талын ханцуйгаа баруун гараараа шууж зуух руу атга дүүрэн нунтаг цацахад нүүрс хүрхрэн дүрэлзэж цайвар дөл орой дээр нь улалзахад улаан эмэгтэй мөнгөн тавгийг авч хаанд авчирлаа. Давос тагыг нь сөхөхөд дотогш шагайв. Дотор нь цусанд бэлцийсэн гурван том хар хануур хорхой байлаа.

Хүүгийн цус. Хааны цус байна гэж Давос мэдлээ.

Станнис гараа сунган хуруугаараа хануур хорхойн нэгийг авав.

- Нэрийг нь хэл гэж Мелисандра тушаалаа.

Хануур хорхой хааны гарт мурилзан хурууны нэг рүү авирахыг оролдов.

- Булаан эзлэгч Жоффри Баратеон гээд Станнис хануур хорхойг галд чулуудахад нүүрсэн дунд намрын навч шиг хуйлран шатлаа.

Станнис хоёр дахь хорхойг авлаа.

- Булаан эзлэгч Бэйлон Грэйжой гэж энэ удаад арай чанга хэлэн зуух руу хөнгөн чулуудахад бие нь хуваагдаж шаржигнан дотроос нь цус түсхийн хагарч уур савсуулан исгэрэв.

Сүүлчийн хорхой хааны гарт байлаа. Тэр үүнийг базсан хуруундаа хормын турш ширтсэнээ эцэст нь,

- Булаан эзлэгч Робб Старк гэж хэлээд хорхойг галд шидлээ.

ЖЭЙМИ

Харренхалын халуун усны газрын битүү уур савссан намхан адартай бүүдгэр өрөөнд том чулуун онгоцнууд дүүргэжээ. Жэймиг дотогш оруулах үед Бриен тэдгээр чулууны онгоцны нэгд суугаад гараа ууртай янзын ширүүн үрж байлаа.

- Тэгж хүчтэй үрэх хэрэггүй дээ, бүсгүй минь. Чи хамаг арьсаа зулга үрэх нь байна гэж Жэйми хэлэхэд тэр сойзоо алдаж цээжээ Грегор Клегэйнийх шиг том гараар халхлав. Түүний нуусан зүйл нь булчинлаг бүдүүн цээжин дээр арван настай хүүхдийнх шиг жижигхэн шовгор хөх байлаа.

- Чи энд юу хийж байгаа юм? гэж Бриен шаардав.

- Лорд Болтон надтай оройн зоог барихыг хүссэн ч нохой бөөсийг маань урихаа мартсан бололтой гээд Жэйми зүүн гараараа харуулыг дугтран,

- Надад энэ ноорхой өмхий хувцсыг тайлахад туслаач гээд ганц гараар бол өмднийхөө үдээсийг ч тайлж чадахгүй байлаа. Харуул дургүйцэн гүнгэнэсэн ч хэлсэн ёсоор гүйцэтгэв.

- Одоо биднийг орхи. Манай Тартын хатагтай та нар шиг амьтдыг хөх рүүгээ харуулахыг хүсэхгүй байна гэж Жэйми нойтон чулуун шалан дээр хувцас нь овоороход хэлээд мухар бугуйгаараа Бриенид тусалж байсан унжуу царайтай эмэгтэй рүү зангаж,

- Чи ч гэсэн. Хүлээх хэрэггүй. Энд ганцхан хаалга байгаа болохоор хүүхэн яндангийн нүхээр зугтаахад дэндүү том биетэй гэв.

Хүлцэнгүй дагалдах зан хүчтэй болохоор эмэгтэй харуулын араас гарч халуун усны газрыг тэдэнд үлдээв. Онгоцуудад Чөлөөт хотуудын маягаар зургаа долоон хүн зэрэг орж багтахуйц том тул Жэйми хүүхнийх рүү эв хавгүй удаан гэгч нь мацав. Түүний баруун талын хавдаж тагларсан нүд Кайбөрний хануур хорхойг үл харгалзан нээгджээ. Тэгсэн ч Жэймид зуун настай юм шиг сэтгэгдэл төрөн Харренхалд ирэх үеийнхээсээ арай дээрдсэн байлаа.

Бриен түүнээс цааш холдов.

- Тэнд өөр онгоц байна.

- Энэ онгоц надад хангалттай таарна гээд болгоомжтой эрүүгээ хүртэл уур савсуулсан халуун усанд орлоо.

- Айх хэрэггүй дээ, бүсгүй минь. Чиний гуя улаан ногоон хөхөрсөн болохоор би дунд нь юу байгааг сонирхохгүй байна гээд Кайбөрний боолтыг нь хуурай байлгахыг захьсан баруун гараа онгоцны ирмэг дээр тавихад хөл нь салхийн суларч толгой эргэлээ.

- Хэрвээ намайг ухаан алдвал эндээс гаргаарай. Ланнистерийнхан угаалгын онгоцонд живж үхэж байсан түүхгүй болохоор би эхнийх нь болмооргүй байна шүү.

- Би яагаад чиний үхэхэд санаа тавих ёстой юм бэ?

- Чи ариун андгай өргөсөн гэхэд түүний бүдүүн цагаан хүзүү улсхийсэнд Жэйми инээмсэглэв. Бриен түүнээс эргэлээ.

- Ичимхий охин хэвээр юм биз дээ? Намайг ийм зүйл хараагүй гэж бодож байна уу? гээд Жэйми түүний унагасан сойзыг хуруугаараа авч биеэ учир холбоогүй үрж эхэллээ. Энэ нь хэцүүхэн болхидуу ажил байв. Миний зүүн гар юунд ч хэрэг алга.

Тэгсэн ч усанд түүний биенээс салсан хир хөвж харлав. Хүүхэн түүнээс зай барьж булчинлаг том мөрөө чанга бөгцийжээ.

- Яасан миний мухар гар чиний дургүйг хүргээд байна уу? Чи харин ч үүнд баярлах ёстой. Би хааныг алсан гараа алдсан. Энэ гар бол Старкийн хүүг цамхагаас шидэж, эгчийнхээ хөлөн доогуур шургуулан нойтон болгодог байсан гар гээд мухар тохойгоороо нүүр рүү нь чичиж,

- Чамайг хамгаалж байхад Рэнли үхсэнд гайхах юм алга гэв.

Бриен хөл дээрээ цохиулсан аятай үсэрч босохдоо онгоцноос халуун ус цалгиулан асгачихлаа. Жэйми түүнийг дээш болоход хоёр хөлний уулзвар хэсэгт өтгөн шаргал үс байхыг хальт олж харлаа. Тэр эгчээс нь илүү үсэрхэг байв. Жэйми эвгүйцэн усан дор бие нь жирсхийхийг мэдэрлээ. *Одоо л би Серсейгээс дэндүү удаан хол байснаа мэдэж байна.* Тэр биенийхээ хариу үйлдлийг үл хайхран харцаа бурууллаа.

- Наадах чинь өөдгүй зүйл байна. Би тахир дутуу хүн учир гашуун авиртай. Намайг өршөө, бүсгүй минь. Чи намайг ямар ч эр хүнээс дутуугүй илүү дээр хамгаалсан гэхэд Бриен нүцгэн биеэ алчуураар халхлаад,

- Чи намайг шоолж байна уу? гэсэнд Жэймигийн уур дүрсхийв.

- Чи чинь шилтгээний хана шиг зузаан нэвтрэшгүй хүн үү? Энэ бол уучлал гуйлт байсан юм. Би чамтай тэмцэлдсээр залхаж гүйцлээ. Бид яагаад эвлэрч болдоггүй юм бэ?

- Эвлэрэлийг итгэл дээр босгодог. Хэрвээ чи намайг итгүүлэхийг хүсч байгаа бол...

- Хааны алуурч, тийм. Өгсөн андгайгаа зөрчиж хөөрхий гунигтай Эйрис Таргарианыг алсан гээд Жэйми тургиллаа. - Би Эйрисийн төлөө биш Робертийн төлөө харамсаж байна. "Би чамайг хүмүүс Хааны алуурч гэж нэрлэснийг сонслоо. Үүнийг дадал бүү болгочихоорой" гэж тэр хаан ширээний найран дээр хэлээд инээсэн. Ямар учраас хэн ч Робертийг өгсөн андгайгаа зөрчигч гэж хэлэхгүй байгаа юм бэ? Тэр хаант улсыг хэдэн хэсэг хуваасан байхад би ганцаараа нэр хүнд рүүгээ нулимсан хүн болсон байдаг.

- Роберт бүхнийг хайрынхаа төлөө хийсэн гэхэд Бриенигийн хөлийг ус даган онгоц руу урслаа.

- Роберт бүгдийг бардам зан, эмэгтэй хүн, хөөрхөн царайны төлөө хийсэн гээд Жэйми баруун гар нь байгаа юм шиг нударга зангидтал өвчин бугуйг нь даган хэрцгий инээд шиг хатгуулав.

- Тэр хаант улсыг аврахын төлөө мордсон гэж Бриен зүтгэлээ.

Хаант улсыг аврахын төлөө гэнэ ээ.

- Чи миний дүү Хар усанд түймэр тавьсан тухай мэдэх үү? Зэрлэг галаар усыг шатаасан. Хэрвээ Эйрис зүрх нь хүрсэн бол усанд орох байлаа. Таргарианыхан бүгд галд ухаангүй дуртай улс гээд Жэймигийн толгой хөнгөн эргэлээ. *Энд халуун байгаа болохоор сүүлчийн халууралтын хор цусанд маань орж би өөрийн биш болжээ.* Жэйми усанд эрүүгээ хүртэл доош болон суулаа.

- Би тэр өдөр цагаан нөмрөгөө гутааж алтан хуяг өмссөн ч...

- Алтан хуяг гэнэ ээ? хэмээн Бриенигийн хоолой алсад сулхан сонсогдов.

Жэйми халуун усанд дурсамжиндаа хөвөв.

- Бүжиглэж буй гриффинүүд Хонхны тулаанд ялагдсаны дараа Эйрис тэднийг цөлсөн. *Би ер нь яагаад түүнд ийм зүйл ярьж байгаа юм бол?* Тэр эцэст нь Робертийг ганц хуруугаар няцалж болох дээрэмчдийн толгойлогч биш Хар дөл Дэймоноос хойших Таргарианы овгийн хамгийн том аюул занал болохыг ойлгосон. Хаан Левин Мартеллд ичгүүр сонжуургүй Элиаг барьж байгаагаа сануулж арван мянган Дорнийнхныг Хааны зам руу ирэхийг тушаажээ. Жон Дарри, Барристан Сэлми хоёр Чулуун дуган руу гриффинтэй хүмүүсийн үлдэгдлийг цохихоор явахад, ханхүү Рэйгар өмнө зүгээс эргэж ирэн эцгээ бардам зангаа даран миний эцгийг дуудахыг ятгасан юм. Гэвч Кастерли Рокоос хэрээ эргэж ирээгүй болохоор хаан айсан. Тэр урван тэрслэлтийг газар сайгүй харж харахгүй өнгөрөөснийг нь Варис үргэлж барьж өгч байлаа. Иймээс эрхэм дээдэс алхимичдийг Хааны газар зэрлэг гал тараан байрлуулахыг тушаасан байна. Бэйлорын сүм, Нохой бөөсний мухрын яйжгий урц, жүчээ, агуулах, долоон хаалганы дор болон Улаан шилтгээний зооринд хүртэл нууж булсан.

- Бүх зүйл хуруу дарам хэдхэн ахлах пиромансерийн удирдлагын дор маш нууц байдалтай явагдсан. Тэд өөрсдийн дагалдан туслагч нартаа хүртэл итгэхгүй байлаа. Хатан хааны нүд хаалттай он жилүүд байсан болохоор Рэйгар армия цуглуулаад завгүй байлаа. Гэвч Эйрисийн бороохой-хутга шинэ Гар дүүрчихсэн тэнэг хүн биш болохоор Россарт, Белис, Гаригус нар өдөр шөнөгүй ямар нэг зүйл хийхийг хараад сэжиглэсэн юм. Түүний нэрийг лорд Челстэд гэдэг байсан. Би түүнийг хулчгар хүн гэж боддог байсан ч тэрбээр гэнэтхэн эр зоригоо хөвчлөн Эйристэй нүүр тулгаран уулзжээ. Тэр Эйрисийг ятган болиулахын тулд бүгдийг хийсэн юм. Учирлан тайлбарлаж, тоглож, сүрдүүлж эцэст нь гуйжээ. Эцэст нь энэ бүхэн бүтсэнгүйд албаныхаа гинжийг шалан дээр нь шидсэн байна. Эйрис үүнийх нь төлөө түүнийг амьдаар нь шатааж гинжийг өөрийн хайртай пиромансер Россартын хүзүүнд угласан. Тэр хүн лорд Рикард Старкийг хуяганд нь амьдаар нь чанасан. Харин би тэр бүх хугацаанд хаан ширээний хөлд цагаан хуягтайгаа үхдэл шиг хөдөлгөөнгүй зогсоод эзнийгээ бүх ариун нууцтай нь хамгаалж байлаа.

- Миний Тангарагт ахан дүүс бүгд явсан ч Эйрис намайг ойрхон байлгах дуртай байсан юм. Би эцгийнхээ хүү байсан тул надад итгэдэггүй байлаа. Тэр намайг өдөр шөнөгүй Варисын хараанд байлгахыг хүссэн юм. Ийм учраас би бүгдийг харж сонссон гээд Жэйми бодисыг нуусан газрын зургийг тэнийлгэн үзүүлэх үед Россартын нүд хэрхэн гялтагнаж байсныг саналаа. Гаригус, Белис хоёр ч гэсэн түүнээс дутсангүй.

- Рэйгар Роберттой Сэрээнд тулгарах үед чи тэнд юу болсныг мэднэ. Ордонд энэ тухай сураг ирэхэд Эйрис хатнаа Лууны цохио руу ханхүү Висеристэй хамт явуулсан. Гүнж Элиа бас явах байсан боловч тэр хоригложээ. Яагаад ч юм түүний толгойд ханхүү Левин Сэрээнд Рэйгараас урвахад хүрвэл Дорнийг үнэнч үлдээхийн тулд Элиа, Эйгон хоёрыг дэргэдээ байлгах нь зүйтэй гэсэн бодол орж ирсэн юм билээ. *Урван тэрслэгчид миний хотыг хүсч байна. Би тэдэнд үнс нурамнаас ондоо юу ч өгөхгүй. Роберт түлэгдсэн яс хуйхлагдсан махны хаан болог* гэж би түүний Россартад хэлэхийг сонссон. Таргарианыхан хэзээ ч үхэгсдээ оршуулдаггүй шатаадаг байлаа. Эйрис тэдэнд бүгдэд асар том оршуулгын түүдэг зэхсэн байсан юм. Үнэнийг хэлэхэд би түүнийг үнэнээсээ үхэх гэж байна гэдэгт итгээгүй. Түүний өмнөх Бадарсан дөл Эйрионы адил Эйрис гал түүнийг хувиргахад луу шиг ахин төрөн дайснуудаа үнс нурам болгон хувиргана гэж боддог байсан юм.

- Нэд Старк өмнө зүг Робертийн хошууч ангитай ирэхэд миний эцгийн цэрэг хотод түрүүлж хүрсэн. Пацилл хаанд Өрнөдийг хамаарагч хамгаалахаар ирсэн гэж итгүүлсэн тул хаалгаа нээсэн. Энэ удаа тэр Варисийн үгийг дагах ёстой цорын ганц тохиолдол байсан ч тоогоогүй юм. Миний эцэг Эйрисийн түүнд хийсэн бүх таагүй зүйлийн төлөө дайнаас холхон байж Ланнистерийн овог ялагчийн талд орох ёстой гэж бодож байлаа. Сэрээ түүнд шийдвэр өгсөн юм.

- Улаан шилтгээнийг хамгаалах үүрэг надад ногдсон ч би ялагдахаа мэдэж байлаа. Би Эйрисээс эсрэг талтайгаа энхийн гэрээ хийх зөвшөөрөл асуусан юм. Миний хүн "*Надад эцгийнхээ толгойг авчирвал чи урвагч биш болно*" хааны тушаалтай буцаж ирсэн. Эйрис бууж өгөөгүй. Лорд Россарт түүнтэй хамт байгааг би элчээс сонсоод юу болох гэж байгааг ойлгосон.

- Намайг Россарт руу очих үед тэр ердийн цэрэг шиг хувцаслан арын хаалгаар яаран гарч байлаа. Би эхэлж түүнийг алаад дараа нь Эйрисийг пиромансерт зурвасыг нь дамжуулах хүн олохоос өмнө алсан юм. Түүний дараагийн өдөр бусдыг нь ч гэсэн мөрдөж алсан. Белис надад алт амлаж, Гаригус өршөөл гуйн эхэр татан уйлж байлаа. Илд галаас илүү өршөөнгүй ч Гаригус миний түүнд үзүүлсэн сайхан сэтгэлийг үнэлсэн гэж бодохгүй байна.

Ус хөрчээ. Жэйми нүдээ нээхэд илд барьдаг гарных нь мухар уг харагдав. *Намайг Хааны алуурч болгосон гар. Ямаа түүний алдрыг ичгүүртэй нь цуг дээрэмджээ. Түүнд юу үлдсэн гэж? Би одоо хэн болсон хэрэг вэ?*

Бриен алчуураар цээжээ халхлан даавуун дороос бүдүүн цагаан хөл цухуйлгаж хачирхан ширтэнэ.

- Яасан миний яриа чамайг хэлгүй болгочихов уу? Алив намайг хараах юм уу үнсэж эсвэл худалч гэж дууд л даа. Ямар нэг зүйл хий.

- Хэрвээ энэ үнэн юм бол яагаад хэн ч мэдэхгүй байгаа юм бэ?

- Хааны хамгаалалтын хүлэг баатрууд хааны нууцыг хадгалах андгай өргөсөн байдаг. Чи намайг өгсөн амаа эвдэхийг хүсээ юу? гээд Жэйми хөхөрлөө.

- Чи хүндэт Винтерфеллийн лорд миний сулхан тайлбарыг сонсоно гэж бодоо юу? Дэндүү шударга журамтай хүн байсан. Тэр над руу ганц хараад гэм буруутай болохыг минь шүүсэн гээд

Жэйми хөл дээрээ босоход хүйтэн ус цээжийг нь даган урсав.

- Ер нь чоно арсланг шүүх ямар эрхтэй юм бэ? Ямар эрх? гээд бие нь чичирхийлэн онгоцноос гарахыг завдахдаа мухар гараа ирмэгт нь цохьчихлоо.

Өвчин биеийг нь дагжуулахад гэнэтхэн халуун усны газар дүйрэн эргэлдэв. Бриен түүнийг унахаас нь өмнө барьж авчээ. Түүний гарын арьс биржийсэн хүйтэн ч хүчтэй бодсоноос нь зөөлөн байлаа. Серсейгийнхээс ч зөөлөн юм гэж түүнийг онгоцноос гуйвсан хөлтэй алхан гарахад туслахад бодов.

- Харуулуудаа! Хааны алуурч! гэж тэр хашгирлаа.

Жэйми. Миний нэрийг Жэйми гэдэг гэж тэр бодов.

Дараагийн агшинд мэдсэн зүйл гэвэл нойтон шалан дээр харуулдан хэвтээд хүүхэн, Кайбөрн, харуулууд дээрээс нь сэтгэл зовсон шинжтэй бөөгнөрөн харж байлаа. Бриен нүцгэн байсан ч үүнийгээ мартсан бололтой.

- Халуун усанд цохиулж гэж мэйстер Кайбөрн тэдэнд хэлэв. *Үгүй ээ, тэр мэйстер биш. Түүний гинжсийг хураасан.* – Тэгээд ч түүний цусанд хор байгаа хэвээр болохоор хатангиршсан байна. Ингэхэд та нар түүнийг юугаар тэжээж байсан хэрэг вэ?

- Өт хорхой, шээс, саарал бөөлжис гэж Жэйми хэлэв.

- Хатсан талх, ус, овъёосны агшаамал. Тэр бараг юм иддэггүй байсан. Одоо бид түүнийг яах ёстой вэ? гэж харуулуудын нэг хэлэв.

- Түүнийг сойздож угаагаад хувцсыг нь өмсгөж Хааны оршуулгын түүдэг цамхаг руу аваач. Лорд Болтон өнөө шөнө түүнтэй зоог барих гэж байгаа. Хугацаа бага үлдэж гэж Кайбөрн хэлэв.

- Надад цэвэрхэн хувцас аваад ир. Би биеийг нь угааж өмсгөө гэж Бриен хэллээ.

Бусад нь түүнд баяртайяа даалгаварыг шилжүүлэв. Тэд түүнийг хөл дээр нь өргөн босгоод ханын дэргэдэх чулуун сандал дээр суулгалаа. Бриен ахин явж алчуур, ширүүн сойз олж ирээд үрэлтээ дуусгав. Харуулуудын нэг сахлыг нь тайрах хутга олж ирлээ. Кайбөрн бүдүүн даавуун дотуур хувцас, цэвэрхэн хар өмд, сул ногоон цамц, урдаа үдээстэй ширэн хантааз авчирлаа. Жэймигийн толгой эргэсэн хэвээр байсан авч урьдынх шиг болхи байсангүй. Бриенигийн тусламжтай хувцаслаж дөнгөлөө.

- Одоо надад хэрэгтэй ганц зүйл гэвэл мөнгөлсөн хардаг шил байна.

Мэйстер түүнд цэвэр хувцас авчирсны зэрэгцээ Бриенид ч гэсэн авчирчээ. Толбо суусан ягаан атлаасан дашинз, даавуун дотуур хувцас байв.

- Намайг өршөөгөөрэй, хатагтай. Энэ Харренхалд үлдсэн таньд багтах цорын ганц эмэгтэй хүний хувцас.

Төдийлөн удсангүй даашинзыг хэн нэг арай турьхан гар, богино хөл, арай цээж дүүрэн хүнд зориулсан нь илт болов. Миришийн хамгийн сайн тор хүртэл Бриенигийн хөхөрсөн арьсны толбыг далдалж чадахгүй байлаа. Эцэст нь хувцас түүнийг инээдтэй зохимжгүй болгов. *Тэр надаас илүү өргөн мөр бүдүүн хүзүүтэй юм. Ийм болохоор хуяг өмсөхийг эрхэмлэдэгт гайхах юм алга* гэж Жэйми бодов. Толгойд нь олон арван хэрцгий даажин орж ирсэн ч энэ удаад тэвчлээ. Түүнийг уурлуулахгүй байсан нь дээр. Жэйми түүний өрөөсөн гартай ч тэнцэхгүй.

Кайбөрн бас дашмаг авчирчээ.

- Энэ чинь юу юм? гэж Жэйми гинжгүй мэйстер уулгахаар өгөхөд асуулаа.

- Цуу, бал, сармисаар чангалсан чихэр өвс. Чамд хүч өгч толгойг чинь саруул болгоно.

- Надад шинэ гар ургуулах ханд өгөөч. Үүнийг л би хүсч байна.

- Наадхаа уу гэж Бриен инээмсэглэлгүй хэлэхэд Жэйми дагалаа.

Хагас цагийн дараа дээр хөл дээрээ тогтож хүрэлцэхүйц хүчтэй болов. Бүүдгэр нойтон дулаахан угаалгын газрын дараа гадаа гарахад агаар нүүр лүү нь алгадах мэт боллоо.

- Эрхэм лорд түүнтэй одоо уулзъя гэсэн. Тэр эмэгтэйтэй ч гэсэн. Би түүнийг өргөөд явах уу? гэж харуул Кайбөрнөөс асуув.

- Би явж чадна. Бриен надад гараа өгөөч.

Жэйми түүний гараас зууран хашаан дундуур явж Хааны газрын хаан ширээний өрөөнөөс ч уудам салхи нэвт салхилсан том танхимд орлоо. Ханын дагуу түүний тоолж чадахаас ч их арван футын өндөр том зуухнууд эгнэж байсан ч дотор нь гал асаагаагүй тул ханын хүйтэн яс нэвт жиндэж байлаа. Арьсан нөмрөгтэй арваад жадчин хаалга, шат болон дээд талын хоёр давхар тагтыг хамгаалжээ. Нүсэр том уудам хоосон зайн төвд толигор занар шалан дээр гурван хөлтэй ширээ тойруулан тавиад Дредфортын лорд хундага баригчтайгаа хүлээж байлаа.

- Эрхэм лорд гэж Бриен тэднийг урд нь зогсоход хэлэв.

Рус Болтоны нүд чулуунаас арай цайвар, сүүнээс бараан агаад хоолой нь намуухан зөөлхөн ажээ.

- Чамайг надад бараа болохоор хүчтэй болсонд баяртай байна, сэр. Хатагтай суугтун гээд ширээн дээр өрсөн талх, бяслаг, хүйтэн мах, жимс рүү зангаж, - Та нар улаан дарс уух уу эсвэл цагаан уу? Тааруухан дарс гэж айж байна. Сэр Амори хатагтай Вэнтийн зоорийг бараг хоосолж гүйцсэн гэв.

- Таныг үүнийх нь төлөө түүнийг алсан гэдэгт итгэлтэй байна. Цагаан өнгө бол Старкийнх. Би Ланнистерийн улаан өнгийн дарс уумаар байна гээд Жэйми Болтонд хичнээн сул дорой байгаагаа харуулахгүйн тулд түргэхэн суулаа.

- Би ус ууя гэж Бриен хэлэв.

- Элмар сэр Жэймид улаан дарс, хатагтай Бриенид ус, надад халуун ногоотой дарс өгөөч гээд Болтон тэдний дагуулуудыг тарахыг зангахад хүмүүс чимээгүйхэн ухарлаа.

Жэйми сурсан зангаараа дарсанд баруун талаараа хүрэхэд мухар гар нь хундага цохиж цэвэрхэн боолт нь тод улаан өнгийн толбонд шүршигдсэнд унахаас нь өмнө хундагыг зүүн гараараа шүүрч авсанд Болтон түүний болхи байдлыг анзаараагүй дүр эсгэлээ. Умардын хүн чавга авч жижигхэн хазан идлээ.

- Үүнээс амсаад үз, сэр Жэйми. Энэ бол хамгийн амттай болохоор гэдэс доторт сайн тустай гэдэг юм. Лорд Варго үүнийг дэн буудлыг шатаахаас нь өмнө авсан байсан.

- Миний гэдэс дотор сайн дээрээс нь ямаа лорд биш болохоор таны чавга миний сонирхлыг санаа шиг чинь өчүүхэн ч татахгүй байна.

- Чиний тухай юу? гээд Рус Болтоны уруул дээр өчүүхэн инээмсэглэл тодров.

- Чи бол амь өрссөн шан, сэр. Чи хаа явсан газартаа зөрөлдөөний үрийг тарьж байдаг. Миний жаргалтай гэр Харренхалд хүртэл гээд түүний хоолой шивнэхээс арай дээгүүр,

- Дээрээс нь Риверранд ч гэсэн адил санагдаж байна. Эдмур Талли чамайг барьж ирсэн хүнд мянган алтан луу амласныг мэдэх үү? гэв.

Иймхэн гэж үү?

- Миний эгч үүнээс чинь арав дахин ихийг төлнө.

- Тэр тэгнэ гэж үү? гээд ахин нөгөө инээмсэглэл тодорсноо агшин зуур алга боллоо.

- Арван мянган луу бол их хэмжээний мөнгө. Мэдээж лорд Карстаркийн саналыг ч гэсэн бодолцож үзэх нь зүйтэй. Тэр чамайг барьж ирэх юм уу толгойг чинь авчирсан хүнд охиныхоо гарыг амласан байсан.

- Тэгвэл ямаандаа өгөөд буцаахгүй юу гэж Жэйми хэллээ.

Болтон зөөлөн мушийв.

- Харрион Карстарк биднийг цайзыг эзлэх үеэр энд баригдсан байсныг чи мэдэх үү? Би түүнд өөртэйгээ байсан Кархолдын бүх хүнийг өгөөд Гловертэй цуг явуулсан. Би түүнд Даскендэйлд муу зүйл тохиолдоогүй байгаасай гэж найдна. Үгүй бол Алис Карстарк лорд Рикардын удмын цорын ганц хүн болно гээд Болтон ахин нэг чавга авлаа.

- Чиний аз болоход надад авгай хэрэггүй. Би Ихэрт байхдаа хатагтай Валда Фрейтэй гэрлэсэн.

- Үзэсгэлэнт Валда юу? гээд Жэйми мухар гараараа эв дүйгүйхэн талх барьж зүүнээрээ хуваахыг оролдлоо.

- Тарган Валда. Лорд Фрей надад сүйт бүсгүйн жинтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн сүй өгөхийг санал болгосон болохоор би зөвшөөрсөн юм. Элмар сэр Жэймид талхыг нь хуваагаад өгдөө.

Хүү талхнаас нударганы хэмжээтэй хэлтэлж Жэймид өглөө. Бриен өөрийнхийгөө хэлтэлж авав.

- Лорд Болтон таныг Харренхалыг Варго Хотод өгөх гэж байгаа гэсэн үнэн үү? гэж Бриен асуув.

- Энэ бол түүний шагнал. Ланнистерийнхан зөвхөн өрөө төлдөг хүмүүс биш. Би ямар ч тохиолдолд удахгүй энэ газрыг орхино. Эдмур Талли хатагтай Розлин Фрейтэй Ихэрт гэрлэх гэж байгаа болохоор хаан намайг байлцахыг тушаасан юм.

- Эдмурын гэрлэлт гэнэ ээ? Робб Старк биш үү? гэж Жэйми асуулаа.

- Эрхэм дээдэс Робб гэрлэсэн. Крагын Вестерлингтэй. Түүний нэрийг Жейн гэдэг гэсэн байхаа. Таныг түүний тухай мэднэ гэдэгт эргэлзэхгүй байна, сэр. Түүний аав танай эцгийн тугчин байсан гээд Болтон чавганы голыг сорж цааш нь тавилаа.

- Миний эцэг олон сайн тугчинтай болохоор тэдгээрийн ихэнхи нь охинтой гээд Жэйми өрөөсөн гараараа хундага аван Жейний тухай санахыг хичээв. Вистерлингийнхэн эртний гэр бүл бөгөөд хүч чадлаас илүү бардам ажээ.

- Энэ үнэн байж болохгүй. Робб хаан Фрейтэй гэрлэхээр амлалт өгсөн. Тэр хэзээ ч амлалтаа эвдэж... гэж Бриен зөрүүдлэн хэлэв.

- Эрхэм дээдэс арван зургаан настай хүү шүү дээ. Тэгээд ч таныг миний үгэнд асуулт тавихгүй бол талархах байна, хатагтай гэж Рус Болтон аяархан хоолойгоор хэлэв.

Жэйми бараг л Робб Старкийг өрөвдөх сэтгэл төрлөө. *Тэр тулааны талбарт дайнд ялсан хэр нь унтлагын өрөөндөө ялагджээ хөөрхий амьтан.*

- Лорд Валдер хоолондоо чонын оронд хул загас барьсандаа хэр дуртай байгаа юм бэ дээ?

- Өө, хул загас ч амттай зоог шүү гээд Болтон цайвар хуруугаа хундага баригчийнхаа зүг дохив.

- Энэ нь миний хөөрхий Элмарыг хагацалд унагасан. Тэр Арья Старктай гэрлэх ёстой байсан боловч миний хүндэт хадам Фрей Робб хааныг урвахад сүй тавилтыг цуцлахаас өөр аргагүй болсон.

- Арья Старкийн тухай сураг байна уу? Хатагтай Кателин охиныг амьд эсэхэд эмээж байсан гээд Бриен урагш бөхийлөө.

- Өө, тэгэлгүй яахав гэж Дредфортын лорд хэлэв.

- Та үүнийг баттай мэдэж байна уу, эрхэм лорд?

- Арья Старк хэсэг зуур алга болсон нь үнэн ч одоо тэр олдсон. Би түүнийг умард руу аюулгүй

буцах талаар санаа тавина гээд Рус Болтон мөрөө хавчлаа.

- Тэр эгчтэйгээ хоёул харина. Тирион Ланнистер ахынхаа төлөө хоёр охиныг өгөхөөр амалсан гэхэд энэ нь Дредфортын лордыг хөгжөөв бололтой.

- Хатагтай таньд хэн ч хэлээгүй юу? Ланнистерийнхан бол худалч гэв.

- Манай овгийн нэр хүндийг яриад байна уу? гээд Жэйми бяслагны хутга эрүүл гараараа авч хуруугаараа хутганы ирийг тэмтрээд,

- Үзүүр нь мохсон бөөрөнхий ч гэлээ нүд рүү чинь ижилхэн зоогдоно гэхэд духан дээр нь хөлс бөнжигнөхөд санагдаж байгаа шиг сул дорой харагдахгүй байгаасай гэж найдлаа.

Лорд Болтоны уруул дээр өчүүхэн мушийлт ахин ирэв.

- Чи талхыг нь хувааж өгөх хэрэгтэй хүн гэхэд дэндүү зоригтой ярьж байна. Миний харуулууд эргэн тойронд байгааг чамд сануулах хэрэг юун.

- Бидний эргэн тойронд хагас милийн зайд байна. Тэднийг хүрэх үед чи Эйрис шиг үхдэл болсон байх болно гээд Жэйми ханхар уудам танхимыг ажлаа.

- Гэрийн эзнийг бяслаг, жимснийх нь дэргэд сүрдүүлэх бол өчүүхэн хүлэг баатрын шинж. Умардад бид зочлох ёсны ариун хуулийг сахьдаг гэж Дредфортын лорд зэмлэнгүй хэлэв.

- Би энд баригдаж ирсэн хүнээс бус зочин биш. Чиний ямаа миний гарыг огтолсон. Хэрвээ чи намайг хэдэн чавга энэ тухай мартуулна гэж бодож байгаа бол гүнээ эндүүрсэн байна.

- Магадгүй л юм. Магадгүй би чамайг Эдмур Таллид хуримын бэлэг болгон илгээх юм уу эгчийн чинь Эддарт Старкад хийсэн зүйл шиг толгойг чинь огтолж болох юм гээд Рус Болтон хойш боллоо.

- Би ингэж зөвлөхөөргүй байна. Кастерли Рок удаан хугацааны ой сайтай.

- Чиний хад миний хананаас мянган бээрийн зайд уул, тэнгис, намгийн цаана оршиж байна. Ланнистерийн дайсагнал Болтонд өчүүхэн зүйл.

- Тэгвэл Ланнистерийн нөхөрлөл илүү ихийг өгч болох юм гээд Жэйми одоо тоглоом тоглож буйгаа мэдэж байлаа. *Гэхдээ хүүхэн үүнийг мэдэж байгаа болов уу?* Тэр түүн рүү харж зүрхэлсэнгүй.

- Би чамайг ухаалаг хүн хүсдэг төрлийн нөхөд гэдэгт итгэлгүй байна. Элмар зочдод шарсан мах огтолж өг гээд Рус Болтон хүү рүү дохилоо.

Бриенид түрүүлж үйлчилсэн ч идсэнгүй.

- Эрхэм лорд сэр Жэйми хатагтай Кателины охидын солилцоо болохоор илгээгдсэн. Та биднийг

суллаж замаа үргэлжлүүлэхийг зөвшөөрнө үү гэж хэлэв.

- Риверранаас түүний зугтсан тухай хэрээ ирснээс биш солилцооны тухай үг дурьдаагүй байсан. Чи энэ олзлогдогчийн хүлээсийг тайлахад тусалсан тул урван тэрсэлсэн хэрэгт буруутай, хатагтай гэхэд,

- Би хатагтай Кателинд зүтгэдэг гээд том бие биетэй хүүхэн хөл дээрээ ухасхийн өндийлөө.

- Харин би Умардын хаанд зүтгэдэг. Эсвэл Умардыг алдсан хаан ч юм уу зарим нь одоо түүнийг ингэж дууддаг болсон. Сэр Жэймиг Ланнистерийнхан руу буцаахыг хэзээ ч хүсээгүй хүн.

- Доошоо суугаад ид, Бриен гэж Жэйми шаардахад Элмар бараан өнгийн шүүрхий шарсан мах өмнө нь огтлон тавилаа.

- Хэрвээ Болтон биднийг алах байсан бол үнэт чавганаасаа өгөн гарздаж гэдсэндээ аюул учруулахгүй байсан гээд мах руу харж ганц гараар огтлох аргагүйг ойлголоо. *Би охин шиг арчаагүй болж дээ. Ямаа солилцоог хийлээ ч гэсэн хатагтай Кателин түүнд Сергей гөлөгнүүдийг нь ийм нөхцөлд буцааж өгөхөд талархана гэдэгт эргэлзэж байна. Энэ бодол түүнийг ярвайлгалаа. Би ч гэсэн үүнд зэмлэл хүртэнэ гэж бас мөрийцөх байна.*

Рус Болтон махаа хичээнгүй огтлоход тавган дээр шүүрхий махны цус урсав.

- Хатагтай Бриен хэрвээ би сэр Жэймиг хатагтай Старкийн хүсэл ёсоор чамтай илгээнэ гэвэл суух уу?

- Би... тэгэхээр та биднийг явуулах хэрэг үү? Сайн байна, эрхэм лорд гэж Бриен болгоомжтой хэлсэн ч суулаа.

- Тэгнэ. Хэдийгээр лорд Варго надад өчүүхэн хүндрэл учруулсан ч гэлээ гээд Болтон эргэхэд цайвар нүд нь Жэйми дээр тусав.

- Чи Ямаа яагаад гарыг чинь огтолсныг мэдэх үү?

- Тэр гар огтлох дуртай. Дэрээс нь бас хөл ч гэсэн огтлох дуртай. Түүнд шалтгаан хэрэггүй санагдаж байна гээд Жэймигийн шарх боосон даавуу цус дарсны толбонд будагджээ.

- Гэсэн хэдий ч түүнд нэг шалтгаан бий. Ямаа харагдаж байгаагаасаа илүү зальтай. Өөр хүн байсан бол Зоригт нөхдийг ийм удаан захирч чадахгүй болохоор түүнд ухаан бий гээд Болтон хэсэг махыг хутганы үзүүрээр хатган амандаа хийгээд бодогоширонгуй зажилснаа залгилаа.

- Лорд Варго Ланнистерийн гэр бүлийг орхисны учир гэвэл би түүнд лорд Тайвинаас авах шагналаас мянга дахин илүү Харренхалыг санал болгосон явдал юм. Тэр Вестеросд гадны хүн болохоор авсан шан нь хордуулсныг мэдээгүй.

- Хар Харрены хараал уу? гэж Жэйми ёжлов.

- Тайвин Ланистерийн хараал гээд Болтон хундагаа өргөхөд Элмар чимээгүйхэн дүүргэлээ.
- Манай ямаа Тарбек юм уу Рэйнисийнхэнтэй зөвлөлдвөл дээр байсан юм. Тэд түүнд лорд эцэг чинь урван тэрслэгчидтэй ямар тооцоо хийдэг талаар анхааруулах байсан даа.
- Тарбек болон Рэйнисийнхэн байхгүй болсон.
- Миний утга товч тодорхой. Лорд Варго эргэлзээгүй лорд Станнисийг Хааны газрыг эзэлж Ланнистерийн овгийг унагахад оролцсон өчүүхэн зүйлийнх нь төлөө эзэмшсэн цайзыг батлана гэж найдсан биз гээд Болтон хөндий инээмсэглэв.
- Тэр Станнис Баратеоны тухай ч гэсэн мэддэггүй гэж эмээж байна. Тэр түүнд гаргасан зүтгэлийнх нь төлөө Харренхалыг өгч болох байсан ч хийсэн хэргийнх нь төлөө дүүжлүүрийн гогцоо бас углах байсан.
- Миний эцгээс хүртэх зүйлийн оронд дүүжлүүрийн гогцоо хамаагүй эелдэг байна.
- Гэхдээ тэр одоо адилхан ойлголттой болсон. Станнис ялагдаж, Рэнли үхсэн болохоор зөвхөн Старкийн ялалт түүнийг лорд Тайвины өшөө авалтаас аврах хэдий ч найдлага тааруухан байна.
- Робб хаан тулаан бүрт ялалт байгуулж байгаа гэж Бриен хэзээний зөрүүд үнэнч аялгаараа хэлэв.
- Тулаан бүрт ялалт байгуулсан ч Фрей, Карстарк, Винтерфелл болон умардад ялагдсан. Чоно залуу байсан нь харамсалтай. Арван зургаатай хөвгүүд үргэлж өөрсдийгөө мөнх дийлдэшгүй гэдэгт итгэдэг юм. Арай ахмад хүн байсан бол өвдөг сөгдөх байсан гэж бодож байна. Дайны дараа үргэлж энхийн байдал тогтдог болохоор Робб Старкад өршөөлийн энх олодохоос бус Варго Хот мэтэд бол оногдохгүй гээд Болтон өчүүхэн мушийв.
- Хоёр тал хоёул түүнийг ашигласан ч алин ч өнгөрөхийг нь тэвчиж чадахгүй. Зоригт нөхөд Хар усны тулаанд байлдаагүй ч гэлээ тэд ижилхэн үхсэн.
- Миний гашуудал төрөхгүй байгаад өршөөнө үү.
- Чи манай заяа нь хаясан ямааг өрөвдөхгүй байна уу? Ай даа бурхад... яагаад чамайг түүний гар луу илгээсэн юм бол? гээд Болтон ахин хэсэг мах зажиллаа.
- Кархолд Харренхалаас жижигхэн муу ч арслангын сарвуунаас хол газар. Алис Карстарктай гэрлэвэл ямаа үнэхээр лорд болж болно. Хэдийгээр тэр эцгээс чинь алт авсан нь дээр ч гэлээ лорд Тайвин ямар ч үнэ төлсөн хамаагүй чамаагүй лорд Рикард руу илгээнэ. Түүний шан охин болон аюулгүй хоргодолт болно.
- Гэхдээ тэр чамайг зарахын тулд өөртэйгээ байлгах ёстой байхад голын хөндийгөөр дүүрэн чамайг дуртайяа хулгайлах хүмүүс бий. Гловер, Толхарт хоёул Даскендэйд цохиулсан ч цэргийнх нь үлдэгдэл Уулын хядлагаас үлдсэн хүмүүсийн хамт замд тэнэсэн хэвээр. Мянган Карстаркийнхан өмнө зүг болон Риверраны зүүн зүг чамайг агнан нэгжиж байна. Үүнээс гадна эзэнгүй хуульгүй болсон Дарригийнхан, дөрвөн хөлтэй чонын сүрэг, аянгат лордын дээрэмчдийн

бүлэг бас байгаа. Дондаррион чамайг дуртайяа ямаатай ижилхэн модонд хамт дүүжилнэ гээд Дредфортын лорд талхны хэлтэрхий цусанд дүрлээ.

- Харренхал бол зөвхөн лорд Варго аюулгүй байх газар хэдий ч Зоригт нөхдөөс нь энд миний хүмүүс болон сэр Эйнис Фрейгийнхэнтэйгээ тоогоор давамгайлж байгаа. Тэр эргэлзээгүй намайг чамайг Риверран руу сэр Эдмур руу илгээх юм уу эсвэл үүнээс ч дор эцэг рүү чинь явуулахаас эмээж байгаа.

- Чиний зэрэмдэг болсны хувьд тэр илднээс чинь сүрдсэний хувьд тайрч тостой олз омгоо эцэг рүү чинь илгээснээрээ чиний үнэ цэнийг надад бууруулсан. Би Робб хааны хүний адил тэр ч гэсэн миний хүн. Түүний хийсэн гэмт хэрэг миний болж үгүйдээ л эцгийн чинь нүдэнд тэгж харагдана. Энд л миний бяцхан хүндрэл оршиж байгаа юм гээд тэр Жэйми рүү цайвар нүдээ цавчилгүй хүйтнээр найдангуй ширтлээ.

Би ойлголоо.

- Чи намайг зэмлэлээс мултлахыг хүсч байгаа байх нь. Эцэгтээ миний мухар гар бол чиний хийсэн ажил биш гэж хэлэхийг хүсч байгаа юм биз дээ гээд Жэйми хөхөрлөө.

- Эрхэм лорд минь намайг Серсей рүү илгээвэл надтай хэр уян зөөлөн харьцаж байсан тухай хүссэн дууг чинь дуулж өгье гээд Жэйми өөр хариулт хэлвэл Болтон түүнийг буцааж ямаад өгөхийг мэдэж байлаа.

- Хэрвээ надад гар байсан бол захиа бичих байлаа. Хэрхэн эцгийн маань Вестеросд авчирсан хөлсний цэрэгт зэрэмдэглүүлэх үед хүндэт лорд Болтон аварсан тухай.

- Би чиний үгэнд итгэж байна, сэр.

Энэ ч миний үргэлж сонсоод байдаггүй зүйл байна даа.

- Биднийг хэр түргэн хугацааны дараа явахыг зөвшөөрөх вэ? Дээрээс нь намайг яаж чононуудыг болон Карстаркийнхны дээрэмчдийг өнгөрүүлэх гэж байна?

- Чи Кайбөрнийг хангалттай хүчтэй гэж хэлсэн цагт сонгож авсан хүчтэй цэргүүдээр хамгаалуулан миний ахмад Валтоны удирдлаганд явах болно. Ган шилбэт гэж түүнийг дууддаг юм. Төмөр мэт үнэнч цэрэг дээ. Валтон чамайг Хааны газар эсэн мэнд эрүүл энх аваачина.

- Хатагтай Кателины охидыг ч гэсэн эсэн мэнд хүргэх хэрэгтэй. Эрхэм лорд таны хүн Валтоны хамгаалалтанд баярлаж байгаа ч охид бол миний үүрэг гэж Бриен хэлэхэд Дредфортын лорд түүн рүү сонирхсон шинжгүй харлаа.

- Охид цаашид чиний сэтгэл зовох асуудал биш, хатагтай. Хатагтай Санса одойгийн эхнэр болж одоо зөвхөн бурхад тэднийг хооронд нь салгах болсон.

- Түүний эхнэр гэнэ ээ? Бяцхан чөтгөрийн үү? Гэхдээ тэр бүхий л ордны өмнө бурхад хүмүүсийн нүдэн дээр амалсан биз дээ гэж Бриен хирдхийн хэлэв.

Тэр хичнээн цайлган юм бэ. Жэйми үнэнийг хэлэхэд бас гайхсан ч үүнийгээ чадлаараа нуулаа. Санса Старк Тирионы царайд инээмсэглэл тодруулна. Тэр дүүгээ бяцхан тариачны охинтой хоёр долоо хоногийн турш хэр аз жаргалтай байсныг саналаа.

- Бяцхан чөтгөрийн юу хийсэн болон амалсан зүйл одоо хамаагүй болсон. Ядаж л чамд хамаагүй гэж лорд Болтон хэлэхэд Бриен гомдсон янзтай ширтэв. Магадгүй тэр эцэст нь Рус Болтоны харуулуудаа тавьсан ган төмөр хавхны эрүүг мэдэрсэн биз.

- Сэр Жэйми Хааны газар хүрэх замаа үргэлжлүүлнэ. Харин би чиний тухайд юу ч яриагүй байна. Лорд Варгог хоёр шангаас нь салгавал утгагүй зүйл болно гээд Дредфортын лорд гар сунган ахин нэг чавга авлаа.

- Хэрвээ би таны оронд байсан бол Старкаас илүү индраанилын тухайд сэтгэл зовох байсан даа, хатагтай.

ТИРИОН

Ард нь замын дагуу цувах алтан нөмрөгтөнгүүдийн эгнээ дундаас морь тэвчээргүйхэн янцгаах чимээ сонсогдоно. Тирион лорд Жайлсын ханиалгах дууг ч гэсэн сонслоо. Тэр Жайлс, сэр Аддам, Жалабар Зо болон бусад хүмүүсийн алиныг ч авч явахыг хүсээгүй ч лорд эцэг нь Доран Мартелл түүнийг Хар усны эрэг дээр бараа болон зөвхөн ганц одой угтвал гомдоно гэж боджээ.

Жоффри Дорнийхныг өөрөө угтах ёстой байсан юм. Гэхдээ тэр эргэлзээгүй бүхнийг гутаах байсан биз гэж сууж хүлээх завсраа бодлоо. Сүүлийн үед хаан Мэйс Тайреллийн цэргүүдээс сурсан Дорнийн тухай хошин үг хэлэх дуртай болоод байв. *Дорнийнхон мориндоо хичнээн тах хаддаг вэ? Ес. Нэгээр нь морио тахалж байх зуур нөгөө найм нь морийг дээш өргөнө.* Тирион Доран Мартеллийг үүнд хөгжинө гэдэгт эргэлзлээ.

Тэгтэл ногоон модон дундаас далбаагаа салхинд дэрвүүлсээр морьтонгуудын урт тоостой цуваа гарч ирэв. Эндээс гол хүртэл газар дайны үлдэгдэл болж ердөө хуйхлагдсан хар модод үлджээ. Дэндүү их далбаа байна гэж гашуунаар бодоод Тайреллийн хошууч анги Станнисийг хажуу жигүүрээс нь бут цохьсон үеийнх шиг морьдын туурайд үнс бужигнан ойртохыг харлаа. *Мартеллийнхан Дорнийн лордуудын тэн хагасыг авчирчээ.* Тирион үүнээс сайн зүйл бодож олох гэсэн ч бүтсэнгүй.

- Чамд хичнээн далбаа тоологдов? гэж Бронноос асуулаа.

- Найм юм уу ес гэж хөлсний цэрэг хүлэг нүдээ саравчлан халхалж хэлэв.

Тирион эмээл дээрээ эргэлээ.

- Под наашаа ир. Харсан зүйлээ дүрсэлж надад аль овгийнх болохыг нь хэлээдэх.

Подрик Пэйн морьтойгоо ойртов. Тэр хааны далбаа болох Жоффригийн арслан, бугатай том далбааны жинд түүртэн явлаа. Бронн Тирионы далбаа Ланнистерийн хүрэн улаан өнгийн дэвсгэр дээр арслантай туг намируулжээ.

Тэр өндөр болж байна. Тэр удахгүй миний дээгүүр бусад хүн шиг сүндэрлэх нь байна гэж Тирион Подыг сайн харахын тулд дөрөөн дээрээ босч зогсоход ойлголоо. Хүү Тирионы тушаалаар Дорнишийн сүлдийг хичээнгүй суралцсан ч үргэлжид байдаг шигээ сандарсаар ажээ.

- Надад сайн харагдахгүй байна. Далбаа салхинд дэрвээд байна.

- Бронн хүүд харсан зүйлээ хэлдээ.

Бронн цээжин дээрээ галт гинжтэй шинэ хантааз өмсөж нөмрөг нөмөрсөн тул өнөөдөр жинхэнэ хүлэг баатар шиг харагдаж байлаа.

- Шаргал дэвсгэр дээр жад нэвт зоосон улаан нар байна.

- Мартеллийнх. Мартеллийн овгийн Наран жад байна, эрхэм лорд. Дорнийн хунтайж гэж Подрик

Пэйн илт санаа амран хэллээ.

- Миний морь хүртэл наадхыг чинь мэднэ. Надад өөрийг хэлээдэх, Бронн гэж Тирион хөндий хэлэв.

- Шаргал бөмбөгтэй хөх ягаан далбаа байна.

- Зүрж үү? Хөх ягаан дэвсгэр дээр тарсан зүрж байна уу? Энэ Зүрж төглийн Долтын овгийнх байх гэж Под найдангуй хэлэв.

- Магадгүй л юм. Дараагийнх нь шар дэвсгэр дээр том хар шувуу байна. Сарвуундаа ягаан юм уу цагаан зүйл атгасан бололтой дэрвээд байгаа болохоор сайн мэдэгдэхгүй байна.

- Блакмонтын хүүхэд сарвуундаа атгасан тас. Блакмонтын Блакмонт овог, сэр гэхэд Бронн инээд алдлаа.

- Ахиад л номоо уншсаар байна уу? Ном чиний хурц нүдийг сүйтгэнэ дээ, хүү минь. Би бас гавлын ястай хар далбаа харж байна.

- Манвүүдийн овгийн хар дэвсгэр дээр алтан титэмтэй гавлын яс. Хааны булшны Манвүүд гэж Под зөв хариулах тусам улам итгэлтэй болон хэллээ.

- Гурван хар аалз юм уу даа?

- Хилэнц байгаа юм, сэр. Элсэн чулууны Коргилийн овог улаан дэвсгэр дээр гурван хар хилэнцтэй байдаг.

- Дундуураа шовх зураастай улаан шаргал өнгийн далбаа байна.

- Тамын нүхний дөл. Аллерийн овог.

Тирионд сэтгэгдэл төрлөө. *Хүү хэл нь уяатай биш үедээ тэнэг биш юм байна.*

- Алив үргэлжлүүл, Под. Хэрвээ чи тэднийг бүгдийг нь хэлвэл би шан өгнө шүү.

- Хар улаан хэрчмүүдтэй бялуу байна. Дундаа алтан гартай гэж Бронн хэлэв.

- Бурхдын соёрхлын Аллирион овог.

- Могой идэж буй улаан тахиа бололтой.

- Давст эргийн Гаргаленийхан. Кокатрайс байгаа юм, сэр. Өршөөгөөрэй, тахиа биш л дээ. Хошуундаа хар могой зуусан амьтан.

- Маш сайн байна! Цааш нь үргэлжлүүл гэж Тирион урамшуулав.

Бронн Дорнишийн морьтонгуудын ойртож буй эгнээг ажлаа.

- Сүүлчийнх нь ногоон шатрын хөлгөн дээр алтан өд байна.

- Алтан үзэг, сэр. Торын Жордэйн гэхэд Тирион инээд алдлаа.

- Ингээд ес болж байна. Сайн байна. Би хүртэл тэднийг бүгдийг нэрлэж чадахгүй юм байна гээд энэ нь худал үг байсан бөгөөд хүүд хамгийн хэрэгтэй бахархлыг өгөх хэрэгтэй байлаа.

Мартеллийнхан сүрлэг цуваа авчирчээ. Подын нэрлэсэн овгуудын алин ч өчүүхэн жижигхэн байсангүй. Дорнийн есөн том лорд юм уу тэдний угсаа залгамжлагч нар Хааны замаар ирж байсан бөгөөд Тирион тэднийг зөвхөн бүжиглэж буй баавгай харахын тулд ирсэн гэж бодсонгүй. Энэ нь дохио байлаа. *Надад таалагдахгүй дохио байна.* Тэр Мирцеллаг Наран жад руу хөлөг онгоцоор явуулсан нь эндүүрэл болсон эсэхийг эрэгцүүллээ.

- Эрхэм лорд энд дамнуурга алга гэж Под хулчгардуухан хэлэв.

Тирион толгойгоо огцом эргүүлэн харахад хүүгийн зөв байв.

- Доран Мартелл үргэлж дамнуургаар явдаг. Торгон унжлагатай сөхүүрэн дээрээ нар бүхий сийлбэртэй дамнуурга гэж хүү хэлэв.

Тирион бас ижил зүйл сонсчээ. Дорнийн хунтайж тавин насыг өнгөрч яваа тулай өвчинд нэрвэгдсэн хүн байв. *Магадгүй тэр түргэн явахыг хүссэн байж болох юм. Магадгүй тэр дамнуурга дээрэмчдийн бай болно гэж эмээсэн юм уу Ясан жимийн өндөр давааг давахад хэцүү санагдсан ч байсан байж болох юм. Эсвэл түүний өвчин эдгэрсэн юмуу.*

Гэхдээ яагаад түүнд ийм таагүй санагдаад байгаа юм бол?

Хүлээх нь тэвчихийн аргагүй байлаа.

- Далбаачид урагшаа. Бид тэднийг угтан уулзана гээд морио давиран ухасхийхэд Бронн, Под хоёр хоёр талд нь дагалаа. Дорнийнхон тэдний ирж буйг харсан бололтой морио ергүүлэхэд далбаа нь салхинд бнамирна. Тэд гоёмсог чимэглэлтэй эмээлдээ өөрсдийнхөө дуртай дугуй төмөр бамбай зүүж олонхи нь шиддэг богино жад юм уу морины нуруу дээрээс харвадаг давхар нугалаас бүхий Дорнишийн нум сум дүүрчээ.

Анхдугаар Дэйрон хааны ажигласнаар гурван төрлийн Дорнийнхон байлаа. Эрэг хөвөө бараадан амьдардаг давст Дорнийнхон, цөл урт голын хөндийгөөр нутагладаг элст Дорнийнхон, Улаан уулын орой даваагаар бэхлэлтээ барьж суурьшсан чулуун Дорнийнхон байв. Давст Дорнийнхонд Ройнишийн ихэнхи цус байсан агаад чулуун Дорнийнхонд арай бага байв.

Дораны бараа бологсдийг төлөөлөн гурван төрлийн цэрэг иржээ. Давст Дорнийнхон туранхай бараан өнгийн толигор хүрэн арьс салхинд намирсан урт хар үстэй байлаа. Элст Дорнийнхон Дорнийн халуун наранд түлэгдэж харласан илүү бараан өнгийн арьстай ажээ. Тэд нарны туяанаас хамгаалан дуулгандаа тод өнгийн урт ороолт зүүжээ. Чулуун Дорнийнхон царайлаг том биетэй бөгөөд Андал болон Анхны хүмүүсийн үр сад тул хүрэн, цайвар үс наранд түлэгдсэн бор царайны

оронд сэвхтэй нүүртэй байлаа.

Тэдгээрийн лордууд торго дурдан, үнэт даавуун хувцас өмсч үнэт чулуун шигтгээтэй бүс зүүгээд халхгар урт ханцуйтай байлаа. Хуяг дуулганы зүлгэсэн зэс, гялалзсан мөнгө, зөөлөн алт шигтгэн хээлсэн толигор гадаргуу гялалзана. Унаж ирсэн морьд нь ухаа хонгор, алтлаг зүсмийн цөөн хэд нь цасан цагаан өнгийн бөгөөд бүгд урт хүзүү, нарийхан үзэсгэлэнтэй толгойтой гоолиг хурдан хүлэг байлаа. Дорнийн элсний сүргийн тухай домог ярианд ердийн дайны хүлэг ийм хуяг дуулганы жинг хүнд даахгүй байхад тэд өдөр шөнөгүй давхисан ч цуцдаггүй гэж хэлэлцэнэ.

Дорнийхны удирдагч нь галт дэл сүүлтэй нүгэл хилэнц шиг тас хар азарга унасан хүн байлаа. Өндөр туранхай гоолиг биетэй тэрбээр эмээл дээрээ төрсөн юм шиг баттай сууж явлаа. Мөрөн дээрээ цайвар улаан өнгийн торгон нөмрөг намируулан, битүү зэс цагариг шигтгэсэн хуягласан цамц нь ергүүлэх аясаар наранд шинэхэн мянган зоос шиг гялалзана. Тэрбээр толгойдоо хүрэл нартай өндөр алтан дуулга асаж ардаа Мартеллийн овгийн нар сүлбэсэн жад бүхий толигор нүүртэй дугуй бамбай дүүрчээ.

Мартеллийн нар арван жилээр залуу хэт догшин харагдаж байна гэж Тирион жолоогоо татах зуур бодлоо. Тэр үүний учрыг олох ёстойгоо мэдэж байв. *Дайн эхлэхэд хичнээн Дорнийнхон хэрэгтэй билээ?* гэж өөрөөсөө асуухад зөвхөн "ганц" гэсэн хариулт байв. Гэсэн ч түүнд инээмсэглэхээс ондоо сонголт үлдсэнгүй.

- Та бүгдийн амгаланг айлтгая, эрхэм лордуудаа. Бид та бүхний ирж буй сургийг сонсоод эрхэм дээдэс Жоффри хаан намайг нэрийнхээ өмнөөс угтахыг даалгасан билээ. Миний лорд эцэг хааны Гар ч гэсэн мэнд дамжуулсан гээд хөгжилтэй будилсан дүр эсгэж,

- Та бүхний хэн чинь Доран ханхүү юм? гэлээ.

- Миний ах эрүүл мэндийн байдал чилээрхсэнээс Наран жаданд үлдсэн гээд ханхүү дуулгаа тайлахад дор нь баргар гүн үрчлээстэй царай, нимгэн нуман хөмсөг эрдсийн цөөрөм шиг гялалзсан том хар нүд байлаа. Гялалзсан хар үсэнд нь цөөн хэдэн буурал ширхэг сууж духан дээрээ шовх үзүүртэй хамар шигээ гүн хөхөлтэй байлаа. Гарцаагүй давст Дорн байна.

- Эрхэм дээдсийн таалалд нийцвэл Доран ханхүү намайг өөрийнхөө оронд зөвлөлийн суудал эзлэхээр илгээсэн юм.

- Эрхэм дээдэс Дорнийн алдарт дайчин ханхүү Оберинийг зөвлөлийн ширээнд ирснийг мэдвэл баяртай угтан авна. Таны хүндэт дагуулуудыг ч гэсэн баяртай хүлээн авах байна гээд Тирион *"Энэ ч хараал идсэн зүйл байна даа"* гэж бодлогоширлоо.

- Надад тэднийг таньд танилцуулахыг зөвшөөрнө үү, эрхэм лорд Ланнистер. Зүрж төглийн сэр Дезил Долт. Гаргалены лорд Тремонд, Лорд Хармен Аллер дүү сэр Алвиктэйгээ. Сэр Рион Аллирион хүү Дэймон Санд, Бурхдын соёрхлын бутачтайгаа. Лорд Дагос Манвүүд ах сэр Майлс хүү Морс, Дикон хоёртойгоо. Сэр Эррон Коргайл. Үүний зэрэгцээ хатагтай нарыг ч гэсэн орхилгүй танилцуулахад Торын залгамжлагч Мирия Жордейн. Хатагтай Ларра Блакмонт охин Жинесса, хүү Перрос нартайгаа гээд ханхүү гоолиг гараа толгой бөхийсөн хар үстэй эмэгтэйн зүг

зааж,

- Харин энэ бол миний нууц амраг Эллариа Санд гэв.

Тирион золтой дуу алдчихсангүй тэслээ. *Түүний дорд гаралтай нууц амрагийг Серсей хуримд оролцуулахыг хэрхэвч зөвшөөрөхгүй дээ.* Хэрвээ эгч нь түүнийг давснаас дор хар буланд суулгавал Улаан Хорт могойн хилэнг хүргэх аюултай. Харин түүнийг дэргэдээ өндөр ширээнд залан суулгавал хүндэт суудал дахь бусад хатагтай нар өөрсдийгөө доромжлогдсонд тооцож гомдох болно. *Доран ханхүү хэрүүл маргаан тарих гэсэн юм байх даа?*

Ханхүү Оберин морио Дорнийнхон руугаа эргүүлэв.

- Эллариа, ноёд хатагтай болон сэрүүдээ Жоффри хааны бидэнд хичнээн хайртай болохыг хараач. Эрхэм дээдэс сайхан сэтгэлийн үүднээс биднийг ордонд аваачихын тулд өөрийн нагац ах Бяцхан чөтгөрийг ирүүлсэн байна.

Бронн түсхийтэл инээд алдахад Тирион хүчээр инээмсэглэх аядав.

- Ганцаараа биш шүү, эрхэм лордуудаа. Над шиг ийм бяцхан хүний хувьд ахадсан хүнд даалгавар байлаа гээд өөрийн талаа нэр нэрээр нь ээлжлэн танилцууллаа.

- Хорнвэйлийн залгамжлагч сэр Флемент Бракс. Росбигийн лорд Жайлс, Хотын харуулын захирагч лорд сэр Аддам Марбранд, Улаан цэцэгт хөндийн ханхүү Жалабар Зо болон миний авга ах Кеваны хадам аав сэр Харис Свифт, Крэйкхолын сэр Мерлон, саяхан болсон Станнис Баратеоны бослогын эсрэг Хар усны тулалдааны хоёр баатар сэр Филип Пүүт, Хар усны сэр Бронн нарыг танилцуулахыг зөвшөөрнө үү. Түүнчлэн миний дагуул Пэйний овгийн залуу Подрик байна гээд Тирион тэднийг танилцуулахад нэрс нь чихэнд таатай жингэнэсэн ч Оберин ханхүүгийн бараа бологчидтой алдар нэрээрээ эн тэнцэхгүйг хоёр тал хоёул сайн мэдэж байлаа.

- Эрхэм Ланнистерийн лорд бид удаан тоостой аян замыг туулсан тул амарч сэргэвэл таатай байна. Бид хот руу замаа үргэлжлүүлж болох уу? гэж хатагтай Блакмонт асуув.

- Нэн даруй, хатагтай гээд Тирион мориныхоо амыг эргүүлэн сэр Аддам Марбрандад дохио өгөхөд цувааны ихэнхи хэсэг болох хүндэт харуулын алтан нөмрөгтөнгүүд сэр Аддамын тушаалаар морио эргүүлэн цуваа Хааны газрын зүг хөдлөв.

Оберин Нимерис Мартелл. Дорнийн Улаан хорт могой. Долоон там минь гэж би түүнийг яах болж байна? гэж Тирион зэрэгцэн очих зуур амандаа үглэв.

Тирион энэ хүний зөвхөн алдар нэрийг мэдэх бөгөөд нэр алдар нь айдас төрүүлэм байлаа. Оберин ханхүү арван зургаан настай байхдаа нүсэр том бие ууртай догшиноороо алдартай хөгшин лорд Айронвүүдийн нууц амрагтай нэг оронд байхдаа баригджээ. Ханз тулаан болоход ханхүүгийн залуу нас язгууртан гарлыг харгалзан үзэж эхний цус гартал үзэлцэхээр тогтжээ. Хоёр тал хоёул цавчилтын шарх олсноор сэтгэл ханасан байна. Гэвч ханхүү Оберин төдөлгүй эдгэрэхэд лорд Айронвүүдийн шарх хувиран хүндэрч үхжээ. Үүнээс дараанаас Оберинийг хордуулсан илдээр

тулалдсан гэсэн цуу яриа дэгдсэн учир нөхөр дайсан ялаагүй түүнийг Улаан Хорт могой гэж дуудах болсон байна.

Энэ бүхэн олон жилийн өмнө болсон явдал бөгөөд тэгэхэд арван зургаан настай байсан хүү одоо дөчин насыг зооглож домог түүх нь улам бараантжээ. Тэр Чөлөөт хотууд руу аялж хордуулах эрдэм болон түүнээс ч бараан урлагт суралцсан гэсэн яриа явдаг байв. Түүнчлэн Цайзад хүртэл суралцсан ч мэистерийн гинжний зургаа дахь цагаригаа давтахаас өмнө уйджээ. Тэр уйтан тэнгисийн тэртээх Маргаант газар хөлсний цэрэг байж нөхөдтэйгээ болохоос өмнө Удаах хөвгүүдтэй цуг мордон явжээ. Түүний тэмцээн, тулалдаан, халз тулаан, хүлэг морь болон тачаангуй явдлынх нь тухай эрэгтэй эмэгтэй хүнтэй хоёулантай нь нэг оронд орж чаддаг Дорноор нэг бутач охид төрүүлсэн гэлцэнэ. Түүний охидыг хүмүүс "элсний могойнууд" гэж нэрлэдэг бөгөөд Тирионы олж сонссоноор Оберин ханхүү хэзээ ч хүүгийн эцэг болж байсангүй.

Дээрээс нь бас Хайгардены удам залгамжлагчийг зэрэмдэглэжээ.

Долоон ханлигт Тайреллийнхан хуримдаа хамгийн урихыг хүсэхгүй хүн гэж Тирион бодлоо. Ханхүү Оберинийг лорд Мэйс Тайрелл хотод хоёр хүү, хэдэн мянган хүнд морин цэргийнхээ хамт байгаа Хааны газар илгээснээр өдөөн хатгалга хийсэн тохиолдолд ханхүүд өөрт нь аюултай байлаа. Ганц л буруу үг, цагаа олоогүй наргиа, хариц бүх зүйлийг эргүүлж манай хүндэт холбоотнууд нэг нэгнийхээ хоолойг огтлоно.

- Бид урьд нь уулзаж байсан байхаа. Гэсэн ч чамайг санаж байгаа гэж бодохгүй байна. Чи одооныхоос хамаагүй бяцхан байж билээ хэмээ Дорнийн ханхүү Тирионтой үнс болсон талбай, моддын араг ясыг өнгөрөн Хааны замаар зэрэгцэн явахад хэлэв.

Түүний хоолойны шоолонгуй өнгө Тирионд таалагдсангүй ч Дорнийн ханхүүгийн хатгалтанд автсангүй.

- Энэ хэзээ байсан юм бол, эрхэм лорд? гэж эелдэгээр сониучирхан асуув.

- Өө, маш олон жилийн өмнө миний ээж Дорнийг захирч, лорд эцэг чинь өөр хааны Гар байх үед.

Чиний бодож байгаа шиг тийм ялгаатай биш гэж Тирион ухаарлаа.

- Би Кастерли Рок руу ээж, эгч Элиа нартайгаа явсан. Би арван дөрөв юм уу тэр орчим настай байлаа. Элиа надаас нэгээр эгч байсан. Чиний ах эгч хоёр найм юм уу естэй харин чи дөнгөж төрсөн байсан санагдаж байна.

Айлчилах хачирхалтай цагаа олж дээ. Ээж нь Тирионыг төрүүлэх үедээ өнгөрсөн болохоор Мартелийнхан Кастерли Рокийг гүн гашуудалд автсан үед иржээ. Ялангуяа эцэг нь үүнд илүүтэй гашуудсан билээ. Лорд Тайвин эхнэрийнхээ тухай ховорхон ярьдаг байсан ч Тирион авга ах нараасаа тэдний хайрын тухай сонсож байжээ. Тэр үед эцэг нь Эйрисийн Гар байсан болохоор хүмүүс лорд Тайвин Ланнистер долоон ханлигийг жолооддог ч хатагтай Жоанна лорд Тайвиныг захирдаг гэлцдэг байв.

- Тэр эхнэрээ өнгөрсний дараа өөр хүн болсон. Түүний хамгийн сайн сайхан хэсэг түүнтэй цуг үхсэн гэж авга ах Гери нь Тирионд хэлжээ. Герион лорд Тайтос Ланнистерийн дөрвөн хүүгийн хамгийн бага Тирионы хамгийн хайртай авга ах нь байлаа.

Гэхдээ тэр тэнгисийн тэртээ явж үгүй болсон болохоор хатагтай Жоннагын үхэлд Тирион буруутай байлаа.

- Таньд тэгээд Кастерли Рокоос таалагдах зүйл олдов уу, эрхэм лорд?

- Өчүүхэн ч үгүй. Танай эцэг биднийг тэнд байх бүхий л хугацаанд үл тоомсорлож сэр Кеванд хүлээн авахыг тушаасан. Надад зориулсан өрөөнд өдөн ор тавьж, шалан дээр Миришийн хивс дэвсээтэй байсан ч цонхгүй харанхуй болохоор миний Элиад хэлсэн шиг дотогш орох үед гяндан шиг санагддаг байлаа. Танай тэнгэр чинь дэндүү бүрхэг, дарс чинь дэндүү амттай, эмэгтэйчүүд чинь хэтэрхий цэвэр ариун, хоол унд чинь хэт амтгүй байсан ч харин чи бүхнээс илүүтэй урмыг минь хугалж билээ.

- Би дөнгөж төрсөн байсан. Надаас юу хүлээж байсан гэж?

- Төсөөлөхийн аргагүй айдас гэж хар үстэй ханхүү хариулав.

- Чи жижигхэн байсан ч алдар нэр чинь алсад түгсэн байлаа. Бид чамайг төрөхөд Хуучин хотод байсан болохоор хот даяар хаант улсад гай зовлон тохиохын тэмдэг болон хааны Гарынд мангас төрсөн гэлцэж байсан.

- Эргэлзээгүй өлсгөлөн, тахал, дайн тулаан биз. Үүнд үргэлж өлсгөлөн, тахал, дайн байдаг. Өө, дээрээс нь нэмээд өвлийн эцэс төгсгөлгүй урт шөнө гээд Тирион гашуунаар инээмсэглэв.

- Энэ бүхэн эцгийг чинь унагасан. Лорд Тайвин өөрийгөө Эйрис хаанаас дээгүүр гаргасан ч би нэг гуйлгачин ах дүүгийн зөвхөн хааны дээр бурхан зогсож болно гэсэн үг номлохыг сонссон юм байна. Чи бол түүний бурхад ямар ч хүнээс дээр биш гэдгийг сургахын тулд явуулсан хараал шийтгэл байлаа.

- Би оролдсон ч тэр суралцахаас татгалзсан. Гэхдээ цааш нь үргэлжлүүлэхдээ сайхан түүх яриач гэж мөргөх байна гээд Тирион санаа алдлаа.

- Дээрээс нь чамайг гахайнх шиг жижигхэн мушгиа сүүлтэй төрсөн гэсэн. Чиний толгой биенээсээ хоёр дахин мангас шиг том, төрөлхийн хар үс сахал, муу ёрын нүд, арслангын сарвуутай байсан гэсэн. Шүд чинь дэндүү урт болохоор амаа хамхиж чаддаггүй, хөлийн чинь завсар чөтгөрийн тэмдэг болох эрэгтэй эмэгтэй хүүхдийн хос эрхтэн байдаг гэсэн.

- Хэрвээ хүн өөрөө өөртэйгээ унтдаг бол амьдрал хамаагүй энгийн байсан санагдахгүй байна уу? Би хэдэн ч удаа сарвуу шүдтэй байсан бол хэрэг болох байсан тухай бодож үзсэн юм байна. Иймээс би чиний яагаад гомдоллосон учрыг ойлгож байна.

Бронн инээд алдахад, Оберин мушийв.

- Бид эгч чинь байгаагүй бол чиний барааг хэзээ ч харахгүй байлаа. Чамайг танхимд юм уу ширээнд авчирдаггүй зарим шөнө Кастерли Рокийн гүнд хүүхэд уйлах сонсогддог байлаа. Чи аймшигтай чанга хоолойтой байсан. Чи олон цагийн турш бархирч эмэгтэй хүний хөхнөөс ондоо юу ч дуугүй болгодоггүй байлаа.

- Одоо ч гэсэн энэ хэвээр гэхэд энэ удаад ханхүү Оберин инээд алдлаа.

- Үүнд бидний сонирхол ижил юм байна. Лорд Гаргален урьд нь надад нэг удаа гартаа илдтэй үхэхийг хүсч байна гэхээр нь харин би түүнд эмэгтэй хүний энгэр дээр гар тавиастан үхэхийг эрхэмлэж байна гэж хэлсэн.

- Чи миний эгчийн тухай ярьсан уу? гээд Тирион инээлээ.

- Серсей чамайг бидэнд үзүүлэхийг Элиад амалсан юм. Биднийг явахын урьд өдөр манай ээж танай аавтай ярилцаж байх зуур Серсей, Жэйми хоёр биднийг асрагч руу чинь аваачихаар буулгасан. Чиний асрагч биднийг хөөх гэсэн ч эгч чинь зөвшөөрөөгүй. "Тэр минийх харин чи бол ердөө сүүний үнээ. Надад юу хэлэхийг минь заах ёсгүй. Амаа татахгүй бол би эцэгтээ хэлж хэлийг чинь огтуулна шүү. Үнээнд хэл хэрэггүй, зөвхөн дэлэн байхад болно" гэж эгч чинь хэлсэн юм.

- Эрхэм дээдэс эртнээс дур булаах урлагт суралцжээ. Тэр цагаас хойш хэзээ ч намайг өөрийнх болгохоор ухасхийгээгүйг бурхад мэднэ хэмээн Тирион эгчийгээ өөрийнх гэж хэлсэн үгэнд хошигнон хэлэв.

- Серсей бидэнд чамайг сайн харуулахын тулд өлгийг чинь хүртэл задалсан. Чиний өрөөсөн нүд эвгүй, хуйх чинь хар үстэй байсан. Толгой чинь ердийн хүүхдийнхээс том байсан ч сүүл, сахал, шүд, сарвууны алин ч байсангүй хөлийн чинь хооронд бяцхан ягаан эрхтэнгээс өөр юу ч байхгүй байлаа. Энэ бүх лорд Тайвины сүйрлийн тухай гайхамшигтай цуу ярианы дараа урд маань ердөө майга хөлтэй дөнгөж төрсөн аймшигтай улаан нялзрай хүүхэд байв. Элиа залуу охид нялх хүүхдийг хараад дууддаг шиг өхөөрдөхөд чамайг сонссон гэдэгт итгэлтэй байна. Тэд хөөрхөн муур, гөлөгтэй тоглохоороо ижил дуу гаргадаг юм. Би түүнийг чам шиг царай муутай амьтныг хүртэл асрахыг хүсч байсан гэдэгт итгэлтэй байна. Намайг чиний хичнээн хөөрхийлөлтэй мангас болохыг хэлэхэд эгч чинь "Тэр миний ээжийг алсан" гээд жижигхэн зүйлийг чинь мушгихад би суга татах нь гэж бодсон. Чамайг уйлахад ах Жэйми чинь "Больж үз чи түүнийг өвтгөөд байна" гэхэд Серсей "Тэр хамаагүй. Бүгд түүнийг удахгүй үхнэ удаан амьдрахгүй гэж хэлсэн" хэмээн бидэнд хэлсэн юм.

Нар толгой дээрээс хурцаар шарахад намрын дулаахан ээвэр өдөр байсан ч Тирион сонссон зүйлдээ бие нь жихүүцэхийг мэдрэв. *Миний хонгор эгч.* Тэр хамрынхаа сорвийг маажин Дорнийн ханхүүд муу ёрын нүдээ амтлуулан сөлийв. *Тэр ямар учраас одоо ийм зүйл ярьж байгаа юм бол? Тэр намайг туршихыг хүссэн юм уу эсвэл Серсей шиг намайг хашгируулахын тулд юмыг маань мушгиж байна уу?*

- Наад түүхээ эцэгт минь минь ярьсан нь дээр байх. Энэ түүнийг надаас дутуугүй баярлуулах байсан даа. Ялангуяа миний сүүлний тухай хэсэг онцгойлон таалагдах байсан. Надад урьд нь тийм зүйл байсан ч тэр тайрчихсан юм гэхэд,

- Чи биднийг сүүлд уулзсан үеийнхээс илүү хөгжилтэй болж хэмээн ханхүү Оберон инээд алдав.
- Тийм дээрээс нь өндөр болсон.
- Ингэхэд зугаатай ярианы тухай гэснээс би лорд Баклерийн захирагчаас сонирхолтой зүйл олж сонслоо. Тэр чамайг эмэгтэй хүний хувийн хэтэвчинд татвар оногдуулдаг болсон гэсэн.
- Энэ бол янхны татвар гээд Тирион ахиад л хамаг уур нь хүрлээ. *Энэ бол миний эцгийн санаа байсан.* - Үйлчлэх тус бүрд нэг зоос төлнө. Хааны Гар хотын ёс суртахууныг сайжруулах гэж байгаа юм. *Дээрээс нь Жофффригийн хуримын зардлыг ч гэсэн олно.* Гэсэн ч зоосны сангийн эзний хувьд энэ тухай ярих эрхгүй болохоор Тирион бүх зүйлд буруутгагдаж байлаа. Бронн түүний татварыг гудамжинд "одойгын зоос" гэж дуудаг болсныг ярьжээ. Хэрвээ хөлсний цэргийн үгэнд итгэх аваас "Одойн төлөө хөлөө тэнийлгэ" хэмээн эмсийн хүрээлэн, дарсны газар хашгиралддаг байна.
- Тэгвэл хэтэвчээ зоосоор дүүргэх хэрэгтэй болох нь. Ханхүү хүртэл татвар төлөх ёстой.
- Чамд хөлсний эм ямар хэрэгтэй юм бэ? Чи замдаа нууц амрагаасаа залхаж амжаа юу? гээд Тирион бусад эмэгтэйчүүдийн дунд явж байгаа Эллариа Санд руу арагш ширтлээ.
- Огтхон ч үгүй. Бид дэндүү олон зүйлээ хуваалцдаг гээд ханхүү Оберин мөрөө хавчив.
- Гэхдээ бид хэзээ ч үзэсгэлэнтэй шаргал үстэй эмэгтэй хуваалцаж байгаагүй болохоор Эллариа сонирхоод байгаа юм. Чи тиймэрхүү амьтан мэдэхгүй биз?
- Би гэрлэсэн хүн. *Тэгсэн ч хараахан дэр нэгтгээгүй байна.* Надад янхан эргүүлэх хэрэг байхгүй. *Тэднийг дүүжлүүлэхийг хүсээгүй бол шүү дээ.*
- Оберин сэдвийг огцом өөрчлөв.
- Хааны хурим дээр далан долоон төрлийн зууш зоогоор үйлчилнэ гэлцэж байсан.
- Та өлсөө юу, ханхүү минь?
- Би удаан хугацааны өмнөөс өлсөж байгаа ч хоолны төлөө биш. Надад шударга ёсны шүүх хэзээ болохыг хэлж өгөөч?
- Шударга ёсны шүүх гэнэ ээ? *Тиймээ, ийм учраас л тэр энд ирсэн байх нь. Би үүнийг даруйхан тааварлах ёстой байж.* Чи эгчтэйгээ ойр дотно байсан уу?
- Элиаг хүүхэд байхад бид танай ах эгч хоёр шиг хоорондоо огт салдаггүй байлаа.

Бурхад минь үгүй гэж найдъя.

- Дайн тулаан, хурим найр биднийг дүүрэн хүнтэй болгосон, ханхүү Оберин. Би одоо арван зургаан жилийн өмнөх аллагыг хэн ч сонирхохгүй гэж эмээж байна. Бидний хувьд аль болох

түргэн зохион байгуулна. Хаант улсад энхийг сэргээх Дорнийн ямар ч тусламжийн тулд миний лорд эцэг лавлан байцаалтыг яаралтай явуулна...

- Одой минь намайг Ланнистерийн худал үгнээсээ хол байлгаж үз гэж Улаан хорт могой найрсаг өнгө багатай дуугаар хэллээ.

- Чи биднийг хонь юм уу эсвэл тэнэг гэж бодоогүй биз? Миний ах цусанд шунамтгай хүн биш ч арван зураан жил хоосон гар хумхин суугаагүй. Жон Аррин Робертийн хаан ширээний бослогын дараа Наран жад руу жилийн дараа ирэхэд зуун хүнийх нь хамт ойроос байцаасан гэдэгт чи итгэлтэй байж болно. Би лавлан байцаалт гэдэг хошин наадам үзэхээр ирээгүй. Би Элиа болон хүүхдүүдийнх нь шударга ёсны өшөөг авахаар ирсэн болохоор авах ч болно. Тэрхүү болхи Грегор Клегэйнээс эхлээд түүгээр дуусна гэж бодохгүй л байна шүү. Уул үхэхийнхээ өмнө хэнээс тушаал авснаа хэлэх болно гэдэгт лорд эцгээ итгүүлж үзээрэй гээд инээмсэглэж,

- Хөгшин септон намайг нэг удаа бурхдын ивээлийн амьд баталгаа гэсэн. Харин чи үүнийг яагаад ийм болохыг мэдэх үү, Бяцхан чөтгөр өө? гэв.

- Үгүй гэж Тирион болгоомжтой хэлэв.

- Учир нь бурхад хэрцгий байсан бол намайг ээжийн ууган хүү болгож Дораныг гурав дахь хүү болгон төрүүлэх байсан. Миний хичнээн цусанд шунамтгай хүн болохыг харж байгаа биз дээ. Иймээс та нар одоо надтай учраа олохоос биш тэвчээртэй хэрсүү ухаантай тулай өвчинтэй ахтай минь биш шүү.

Тирион урд нь хагас милийн зайд Хар усанд нарны гэрэл гялалзан түүний цаанатай Хааны газрын хэрэм цамхаг толгод үргэлжилэхийг харлаа. Тэр мөрөн дээгүүрээ эргэн Хааны замаар араас нь дагаж буй сүрлэг цувааг харлаа.

- Чи ардаа их цэрэг дагуулсан хүн шиг ярьж байгаа ч би гурван зуухан хүнийг олж харлаа. Чи голын хойд эрэгт байгаа хотыг харж байна уу?

- Энэ овоолсон шивхийг чи Хааны Газар гэж байгаа юм уу?

- Дүрээрээ мөн.

- Би хараад ч зогсохгүй үнэртэж байна гэдэгт итгэж болно.

- Тэгвэл сайтар үнэрлэсэн чинь дээр дээ, эрхэм лорд. Чи хамраа дүүргэн үнэрлэвэл таван зуун мянган хүний өмхий үнэр гурван зуугаас илүү болохыг мэдэх болно. Чи алтан нөмрөгтөнгүүдийг үнэрлэж байна уу? Тэд таван зуу орчим байгаа. Дээрээс нь миний эцгийн арван хоёр мянган тангарагт цэргүүдийг нэмж болно. Үүний зэрэгцээ ч гэсэн сарнайнууд бий. Сарнай анхилуун үнэртэй биз дээ? Ялангуяа олуулаа байх тусам тэд улам ч анхилуун үнэртэй байдаг юм. Тавь, жар далан мянган сарнай хотын дотор юм уу гадна талд хуарагнасан болохоор би тэдний хичнээн тоотой болохыг яг хэлж чадахгүй нь гэхэд Мартелл мөрөө хавчив.

- Биднийг Дэйронтой худ ураг болохоос өмнө хуучин Дорнд бүх цэцэгс мандаж буй нарны өмнө бөхийдөг гэлцдэг байлаа. Сарнай надад саад болохыг оролдвол би тавхайгаараа дуртайяа няц гишгэлэх байна.

- Виллас Тайреллийг няц гишгэсэн шигээ юу? гэхэд Оберион ийм зүйл хүлээсэнгүй бололтой.

- Би Хагас жилийн өмнө Вилласаас захиа авсан. Бид үүлдэр сайтай сайн агт морины тухай бодлоо хуваалцдаг юм. Тэр тэмцээн дээр болсон зүйлийн төлөө надад хэзээ ч муу зүйл санаж байгаагүй. Би түүний цээж хуяг руу цэвэр цохиж унагаасан ч хөл нь унахдаа дөрөөндөө тээглэж чирэгдсэн юм. Би түүн рүү мэйстер илгээхэд хүүгийн хөлийг аврахын төлөө чадах бүх зүйлээ хийсэн ч эдгэхээсээ өнгөрсөн байлаа. Хэрвээ хэн нэгнийг буруутгах хэрэгтэй бол түүний тэнэг эцгийг л буруутга. Виллас Тайрелл ийм өрсөлдөгчийн эсрэг мордоход өмссөн хүрэм шигээ нялх ногоон амьтан байсан. Тарган Цэцэг түүнийг нөгөө хоёр хүү шигээ тэмцээнд дэндүү эрт оруулсан. Тэр ахин нэг Лео Лонгтонтой болохыг хүссэн ч хүүгээ тахир дутуу болгосноор төгссөн дөө.

- Сэр Лорас Лео Лонгторноос илүү гэж хэлцэх юм билээ гэж Тирион өчив.

- Рэнлигийн бяцхан сарнай юу? Би үүнд эргэлзэж байна.

- Хүссэнээрээ эргэлзэж болно. Гэхдээ сэр Лорас миний ах Жэймиг оролцуулаад олон тооны сайн хүлэг баатрыг дийлсэн.

- Ялсан гэдэг нь эмээлээс унагасан гэж чи хэлэх гээ юу. Хэрвээ намайг айлгахыг хүсч байгаа бол тулааны талбарт хэнийг алсныг нь хэлээдэх.

- Сэр Робар Ройс, сэр Эммон Кай хоёрыг. Харин Хар усны тулаанд түүнийг гайхамшигтай эр зориг гарган лорд Рэнлигийн сүнстэй зэрэгцэн дайтсан гэдэг.

- Тэгвэл гайхамшигтай эр зориг харсан хүмүүс бас сүнсийг олж харсан байх нь ээ? гээд Оберин хөхрөв.

Тирион түүн рүү удаанаар ширтлээ.

- Торгон гудамжны Чатаяад чамд тохирох хэдэн охид байгаа. Балын үст Данси, цайвар алтлаг Мария гээд л. Харин тэднийг авсан үедээ үргэлж аль нэгийг нь өөрөөсөө холдуулахгүй байхыг зөвлөх байна, эрхэм лорд.

- Үргэлж холдуулахгүй гэнэ ээ? Яагаад тэр билээ, хүндэт одой минь? гээд ханхүү Оберин нимгэн хар хөмсгөө өргөв.

- Чи үхэхийнхээ өмнө эмэгтэй хүний цээжин дээр гар тавиастай байхыг хүсч байна гэсэн гээд Тирион зөөврийн онгоц хүлээж буй Хар усны өмнө талын эрэг рүү урагш давирлаа. Тэр Дорнийн ханхүүгийн ухааныг давах гэсээр ядарч гүйцжээ. *Аав Жоффриг явуулах ёстой байсан юм. Тэр ханхүү Обериноос Дорнийн хүмүүс үнээний дэлэнгээс юугаар ялгаатайг асуух байсан даа. Энэ бодол түүний инээдийг хүргэлээ. Тэр Улаан Хорт могойг хаанд танилцуулах үед хамт байх ёстой*

юм байна.

АРЪЯА

Дээвэр дээр байсан хүн түрүүлж үхлээ. Тэр хашаанаас хоёр зуун ярдын зайтай газар яндан налан сууж үүр цайхын өмнөх бүрэнхийд бүрэлзсэн сүүдэр төдий байсан ч тэнгэр гэгээ орж эхлэх үед хөдөлснөө босч зогсон суниахад Энгайгийн сум цээжинд нь зоогдсонд занар чулуун эгц хавтан дээгүүр үегүй юм шиг нугаран сүмийн урд талын хаалга руу унав.

Жүжигчид тэнд хоёр харуул гаргасан байсан ч бамбарын гэрэлд нүд гялбаад харанхуйд дээрэмчдийн ойртохыг харсангүй. Кайл, Ноточ хоёр зэрэг харвахад нэгнийх нь хоолойд сум зоогдон, нөгөөгийнх нь гэдсэнд онолоо. Хоёр дахь харуулын хүн бамбараа унагахад дөл долоон өгсөж хувцсанд нь гал авалцахад хашгирснаар нууцхан гэтэлт төгсгөл болов. Торос хашгиран тушаал өгөхөд дээрэмчид тэсгэлгүй дайралтанд орлоо.

Арьяа сүм рүү өнгийсөн модтой хярын орой дээр морины нуруун дээрээс тээрэм, шар айрагны газар, жүчээ, зэрлэг өвс, шатсан мод, эргэн тойрон хүрээлсэн шаврыг харж байлаа. Мододын ихэнхи нүцгэрч хоосрон мөчирт үлдсэн цөөхөн хатсан хүрэн навч харахад нь саад болов. Лорд Берик Сахалгүй Нугас, Маж хоёроор тэднийг харгалзуулан үлдээжээ. Арьяа жижигхэн тэнэг хүүхэд шиг ард хоцрохыг үзэн ядаж байсан ч Жэндри бас үлдсэн тул ханьтай байлаа. Тэр үүнд маргахгүй байсан нь дээрийг мэдэж байв. Энэ бол тулаан болохоор тулаанд чи үг дуугүй дагах үүрэгтэй билээ.

Дорно зүг тэнгэрийн хаяа алтран ягаарахад толгой дээр нүүх сэмжин үүлсийн цаанаас хавирган саран цухуйна. Салхи хүйтнээр үлээхэд Арьяа усан тээрмийн том модон дугуй чахран эргэж ус гоожихыг сонслоо. Энд үүрийн агаарт борооны чийг нэвт ханхлан хараахан дусал орж эхлээгүй байв. Өглөөний мананд галт сум цайвар мөр татуулан нисэж сүмийн модон хананд зоогдоно. Хэдэн сум эвдэрсэн цонхоор нисэн ороход төдөлгүй хэмхэрсэн хаалтны завсар утаа суунаглан баагив.

Хоёр жүжигчин сүмээс зэрэгцэн гартаа сүх барин ухасхийн гарч ирэхэд Энгай бусад харваачдын хамт хүлээж байлаа. Сүхчингийн нэг даруй үхэв. Харин нөгөө нь тонгойн бултахад сум мөрөнд нь зоогдож гуйвлан алхахад ахин хоёр сум алин эхэлж оносныг бүү мэд сархийн зоогдов. Урт сум цээж хуягийг төмрийн оронд торгоор хийсэн юм шиг гүн нэвтрэхэд тэр түсхийн уналаа. Энгай сумаа өргөн толгойтой шөвгөөр үзүүрлэдэг байв. Шөвөг хүнд хуягийг хүртэл нэвт харвана. *Би ингэж харвахыг сурах хэрэгтэй юм байна* гэж Арьяа бодлоо. Тэр илдээр тулалдах дуртай ч сумны хэрхэн нисэхийг харах бас сайхан байв.

Сүмийн баруун талын ханыг даган гал өгсөж эвдэрхий цонхоор өтгөн утаа баагина. Мирийн харваач толгойгоо нөгөө талынх нь цонхоор цухуйлгаж сум тавьсанаа хариу харвалтаас нуугдлаа. Жүчээний зүгээс тулааны чимээ сонсогдон морьд янцгаах дуу илдийн харших чимээтэй хоршино. *Тэднийг бүгдийг ал* гэж Арьяа догшин бодлоо. Тэр уруулаа чанга хазахад аманд нь цус амтагдав. *Нэгийг нь ч үлдээлгүй бүгдийг ал.*

Нөгөө харваач ахин цухуйсан ч харваж амжихаас нь өмнө толгойных нь хажуугаар гурван сум сүнгэнэн өнгөрөхөд нэг нь дуулгыг нь шүргэж хангинав. Тэр нум сумтайгаа алга болов. Арьяа

хоёр давхрын хэсэг цонхноос гал дүрэлзэхийг харлаа. Өглөөний манан утаанд агаар униартаж хар цагаан өнгөөр сүлэгдэнэ. Энгай бусад харваачидтай байгаа сайн онилохын тул ойртон мөлхөв.

Сүм нурахад Жүжигчид үүрээ эвдүүлсэн ууртай шоргоолж шиг буцлан гарч ирэв. Хоёр Иббенс ноорсон хүрэн бамбай өндөрт өргөн ухасхийн гарч ирэхэд араас нь тахир том аракх барьсан гэгэгэндээ хонхтой Дотраки, сүрлэг шивээс бүхий Волантиний гурван хөлсний цэрэг гарч ирэв. Бусад нь цонхоор гадагш гарч газар луу үсэрлээ. Арьяа нэг хүн хөлөө цонхны тавцан давуулаад цээжиндээ сум зоолгон хашгиран унахыг харав. Утаа улам өтгөрөн баагихад сум урагш хойш нисэлдэнэ. Ватти дуу алдсанаа гараас нь нум гулган уналаа. Кайл хар гархин хуягтай хүн рүү сум онилохыг завдсан ч гэдсэнд нь жад нэвт зоов. Лорд Берикийн хашгирах дуу сонсогдоход шуудуу болон модны араас үлдсэн дээрэмчид гартаа илд барин дайралтанд оров. Арьяа Лем Кайлыг алсан хүн рүү ардаа тод шаргал өнгийн нөмрөг дэрвүүлэн гүйхийг харлаа. Торос, лорд Берик хоёр газар сайгүй байж илдэнд нь гал мушгиран дүрэлзэнэ. Улаан хувраг нэг хүний ард нь нуугдсан бамбайг хэдэн хэсэг болгон цавчихад морь нь түүний нүүр лүү өшиглөв. Нэг Дотраки аянгат лорд руу хашгиран дайрахад галт илд аркхтай тулгаран илд хоорондоо харшин үнсэлдсэнээ салж ахин үнсэлдэв. Тэгтэл Дотракийн үсэнд гал авалцсанаа хормын дараа үхлээ. Нэд аянгат лордын хажууд байлдаж байв. *Тэр надаас хэдхэн ах байтал энэ чинь шударга биш тэд намайг тулаанд оролцуулах ёстой байсан юм.*

Тулалдаан удаан үргэлжилсэнгүй. Зоригт нөхдийн хөл дээрээ тогтон үлдсэн нь төдөлгүй үхэх юм уу илдээ газар хаялаа. Хоёр Дотраки мориндоо мордон зугтахад лорд Берик тавьж явуулав.

- Тэд Харренхалд буцаж хэл хүргэг. Энэ Хануур лорд болон ямааг нь хэдэн шөнө нойргүй хонуулна гэж гартаа галт илд барин хэлэв.

Азтай Жак, Харвин, Сарны хотын Меррит нар шатаж буй дуган руу олзлогдсон хүн байгаа эсэхийг эрэхээр зориг гарган дайран оров. Тэд хэдэн хормын дараа дүрэлзсэн гал утаан дундаас найман хүрэн ахан дүүс гаргаж ирэхэд нэг нь сульдсан биетэй тул Меррит мөрөн дээрээ үүрчээ. Тэдэнтэй цуг бас дугуй мөртэй халзан, хар гархин хуяган дээгүүр саарал нөмрөг нөмөрсөн септон гарч ирэв.

- Түүнийг зоорины шатан доор нуугдаж байхад оллоо гэж Жак ханиалган хэллээ.

- Чи Утт уу? гээд Торос инээмсэглэв.

- Септон Утт. Бурхны хүн.

- Ямар бурхан чам шиг амьтныг хүсэх юм бэ? гэж Лем дургүйцэв.

- Би нүгэл хийсэн. Түүнийгээ мэднэ. Намайг өршөө, Эцэг минь. Өө би туйлын гэм нүгэлтэй гэж септон орь дуу тавив.

Арьяа септон Уттыг Харренхалд байхдаа харснаа саналаа. Тэнэг Шагвелл түүнийг үргэлж жижигхэн хөвгүүнийг алсны дараа өршөөл гуйн мөргөдөг гэж хэлж байсан билээ. Заримдаа тэр нүгэл хилэнцээ наманчилахын тулд Жүжигчидээр хүртэл ташуурдуулдаг байлаа. Тэдэнд энэ нь

маш зугаатай санагдана.

Лорд Берик илдээ тасхийтэл хуйлан галаа унтраав.

- Түүнд үхлийн өршөөл үзүүлэн бусдынх нь гарыг хүлэн шүүх хурал руу туу гэж дууссан хойно хэлэв.

Шүүх хурал түргэн явагдлаа. Дээрэмчид нэг нэгээрээ урагш гарч ирэн Зоригт нөхдийн хийсэн хэрэг болох тосгон суурин сүйтгэж, тариа будаа шатаан, эмэгтэйчүүдийг алж хүчирхийлэн, эрчүүдийг зэрэмдэглэж тамласан гэм нүглийг тоочив. Зарим нэг нь септон Уттын авч явсан хөвгүүдийн тухай ярилаа. Септон энэ бүх хугацаанд уйлж мөргөсөөр байв.

- Би зэгс шиг сулхан амьтан. Би Дайчнаас хүч хайрлахыг гуйсан ч бурхад намайг сул дорой болгосон. Миний сул доройг уучил. Тэр хөвгүүд сайн хөвгүүд байсан. Би хэзээ ч тэдэнд... муу зүйл хийх гэж бодоогүй.

Септон Утт төдөлгүй эхээс төрсөн биеэрээ өндөр хайлааснаас хүзүүгээрээ дүүжлэгдэн удаанаар савлахад бусад Зоригт нөхөд араас нь нэг нэгээрээ морилов. Зарим нэг нь тэмцэн эсэргүүцэж, хүзүүнд нь олс углахад өшиглөн мултрахыг оролдов. Харваачдын нэг "Би цэрэг. Би цэрэг" гэж Мирийн аялгаар хашгирсан хэвээр байлаа. Өөр нэг нь олзлогч нартаа алт санал болгож, гурав дахь нь сайн дээрэмчин болно гэж амлав. Тэднийг тус бүр нүцгэлэн дүүжиллээ. Долоон чавхдаст Том тэдэнд зориулан модон ятгаараа гашуудлын ая тоглоход, Торос Гэрлийн эзнээс сүнсийг нь ертөнцийн эцэс хүртэл тамд шарахыг гуйв.

Жүжигчний мод гэж Арьяа тэднийг дүүжлэхэд цайвар арьсан дээр нь шатаж буй сүмийн дүрэлзсэн улаан галын сүүдэр тусахыг хараад бодлоо. Хаанаас ч бүү мэд хэрээнүүд хүрэлцэн ирцгээжээ. Тэд тэдний юу ярьж буйг гайхах мэт хоорондоо гуаглана. Арьяа септон Уттаас Рог, Хазагч болон Харренхалд байсан бусад хүмүүс шиг айдаггүй байсан ч үхсэнд нь баяртай байлаа. *Тэд Хоточийг бас дүүжлэх юм уу толгойг нь авах ёстой байсан юм.* Гэвч оронд нь хамаг эгдүүцлийг нь хүргэн дээрэмчид Сандор Клегэйний түлэгдсэн гарыг эмчилж илд, морь, хуягийг нь буцаан олгоод хөндий толгодоос хэдэн милийн зайтай газар суллан тавьжээ. Харин тэд бүх алтыг нь авсан байна.

Удалгүй хана хүнд занар чулуун дээврийн жинг даахгүй болоход сүм нуран унаж утаа гал манарав. Найман хүрэн ах дүүс үүнийг хүлцэнгүй ширтэж байлаа. Үүнийг тэдэнд үлдсэн ганц зүйл гэж хүзүүндээ Дарханд сүсэглэдгийн тэмдэг болгон бяцхан төмөр алх оосорлон зүүсэн ахмад нь тайлбарлав.

- Бид дайны өмнө дөчин дөрвүүл байж энэ газар баян чинээлэг байлаа. Бидэнд арваад сүүний үнээ, нэг бух, зуун зөгийн үүр, усан үзмийн цэцэрлэг, алимны сүүдрэвч байсан. Гэтэл арслангууд ирж манай бүх дарс, сүү, балыг аваад үнээнүүдийг маань алж усан үзмийн цэцэрлэгийг галдан шатаасан. Үүний дараанаас ирсэн зочдынхоо тоог алдсан. Энэ хуурамч септон хамгийн сүүлд ирсэн юм. Нэг удаа мангас ирэхэд бид байгаа бүх мөнгөө өгсөн ч биднийг алтаа нуусан гэдэгт итгэлтэй байсан тул хүмүүс нь Ууган ахыг яриулахаар хуврагуудыг нэг нэгээр нь алсан.

- Та найм яаж үлдсэн юм? гэж Харваач Энгай асуув.

- Энэ тухай ярихаас ичгүүртэй байна. Энэ надаас болсон. Миний үхэх ээлж ирэхэд би алтаа нуусан газрыг зааж өгсөн юм гэж өвгөн хэлэв.

- Ах минь тэдэнд тэр даруй хэлээгүй чинь ичгүүртэй хэрэг байна даа гэж Мирийн Торос хэллээ.

Дээрэмчид тэр шөнөө бяцхан голын дэргэдэх шар айрагны газар хоноглов. Тэдний эзэд жүчээний шалан доор нуусан газраасаа энгийн хоол болох овъёосны талх, сонгино гаргаж сулхан сармис амтагдсан усархаг байцааны шөл хуваалцав. Арьяа аяганд нь луувангын хэлтэрхий байсанд өөрийгөө азтайд тооцлоо. Ах дүүс дээрэмчдээс нэрийг нь асуусангүй. *Тэд мэдэж байна* гэж Арьяа бодов. Тэд хэрхэн мэдэхгүй байх билээ дээ? Лорд Берик энгэр дээрээ аянгын цахилгаантай цээж хуяг, бамбай, нөмрөгтэй байхад Торос үлдсэн ганц зүйл болох улаан жанчтайгаа байв. Нэгэн залуу ахан дүү улаан хуврагыг тэдний дээвэр доор байх хугацаанд хуурамч бурхандаа мөргөхгүй байхыг хэлэх зоригтой байлаа.

- Чөтгөр аваг. Тэр бас бидний бурхан болохоор чи бидэнд хараал идсэн амийг чинь аварсны өртэй. Түүний юу нь хуурамч байна гэж? Магадгүй чиний Дархан хугарсан илдийг сэлбэж чадах ч үхсэн хүнийг эдгээж чаддаг билүү? гэж Шаргал нөмрөгт Лем хэлэв.

- Хангалттай, Лем. Бид тэдний дээвэр доор байхдаа дүрмийг нь сахина гэж лорд Берик тушаалаа.

- Биднийг ганц хоёр мөргөл алгаслаа гээд нар мандахаа болихгүй. Би үүнийг мэднэ гэж Торос эелдэгээр зөвшөөрөв.

Лорд Берик хоол идсэнгүй. Арьяа ер нь түүнийг үе үе хундага дарс уухыг нь эс тооцвол юм идэж байхыг нь харсангүй. Дээрээс нь огт унтдаггүй мэт санагдана. Эрүүл нүд нь ядарсандаа анилдсанаа урдаас нь хүн яримагц даруй нээгдэнэ. Маршийн лорд ноорхой хар нөмрөг, аянгын цахилгаан нь бүрэлзтэл цавчуулсан өм цөм хонхорхойтой цээж хуяг өмссөн хэвээр байв. Тэр унтахдаа хүртэл цээж хуягтайгаа байлаа. Бүүдгэр хар ган Хоточийн түүнд өгсөн аймшигт шархийг нууж, зузаан ноосон ороолт хоолойг нь тойрсон хар зураасыг халхална. Гэсэн ч шанаагаа цөм цохиулан хагарсан толгой болон байхгүй нүднийх нь улаан ухархай, царайны цаана тодорсон гавлын ясны дүрсийг юугаар ч нуух аргагүй байлаа.

Арьяа түүнийг эмээн ширтээд Харренхалд юу гэж ярилцдагыг нь саналаа. Лорд Берик түүнийг айдсыг мэдсэн бололтой. Толгойгоо эргүүлээд ойртон бөхийлөө.

- Би чамайг айлгаад байна уу, хүүхэд минь?

- Үгүй. Би зөвхөн Хоточ чамайг алсан гэж бодсон ч... гээд Арьяа уруулаа хазлаа.

- Ердөө шарх. Аймшигтай гүн шарх хэдий ч Торос эдгээсэн. Түүнээс сайн ангаагч байхгүй гэж Лем хэлэв.

Лорд Берик Лем рүү сайн талынхаа нүдээр хачин харахад байхгүй болсон нүдний ухархай нь

хатсан цустай боолтоор боолттой байлаа.

- Түүнээс дээр анагаагч байхгүй. Лем харуул солих цаг болсон гэж бодож байна. Чи явж үүнийг шалгаад ир гэж ядрангуй хэлэв.

- Гүйцэтгэе, эрхэм лорд гээд Лем салхитай шөнө том шаргал нөмрөгөө ардаа хуйлруулан гарлаа.

- Зоригт хүн хүртэл харахаас айсан үедээ харалган болдог юм. Торос чи намайг хичнээн удаа буцааж авчирсан билээ? гэж лорд Берик Лемийг явсан хойно асуув.

- Гэрлийн эзэн Р'хлор чамайг буцааж авчирсан, эрхэм лорд. Би ердөө түүний зэмсэг нь гээд улаан хувраг толгойгоо бөхийлгөв.

- Хичнээн удаа? гэж лорд Берик шаардангуй хэллээ.

- Зургаа. Одоо улам ирэх тусам хүндэрч байна. Та хайнга болж, эрхэм лорд. Үхэл тийм амттай байна уу? гэж Торос дургүйхэн хэлэв.

- Амттай гэнэ ээ? Үгүй дээ, анд минь. Амттай биш байна.

- Тэгвэл үүнийг эрэх хэрэггүй. Лорд Тайвин араас удирддаг. Лорд Станнис ч гэсэн. Та ч гэсэн адил ухаалаг зүйл хийх ёстой. Долоо дахь үхэл чинь бид хоёрын хоёулангын төгсгөл болж болох юм.

Лорд Берик зүүн чихнийхээ дээд талын чамархайн тус цөмөрсөн газар хүрлээ.

- Энд сэр Буртон Крэйкхол дуулгыг минь хэмх цохин бороохойгоор буулгаж билээ гээд боолтоо тайлан хүзүүгээ тойрсон хар ормыг харуулав.

- Энэ бол Унаж буй хүрхрээнд хүрхрээнд мантикорын тавьсан тэмдэг. Тэр хөөрхий зөгий үржүүлэгчийг эхнэртэй нь миний хүмүүс гэж бодон барьцаалж намайг өөрийгөө илчлээгүй цагт хоёуланг нь дүүжлэнэ гэсэн. Тэгээд намайг гарч ирмэгц тэр хоёрыг дунд дүүжилж билээ гээд хуруугаараа нүднийхээ хоосон улаан ухархай руу зааж,

- Энд Уул хутгаа дуулганы халхавчны минь завсар дүрсэн гээд уруул дээр нь ядрангуй инээмсэглэл тодров.

- Үүгээр би Клегэйний овгийн гарт гурван ч удаа үхсэн. Чи намайг сургамж авах ёстой байсан гэж бодож байна уу.

Энэ нь тоглоом гэдгийг Арьяа мэдэж байсан ч Торос инээсэнгүй. Тэр гараа лорд Берикийн мөрөн дээр тавилаа.

- Энэ тухай бодохгүй байсан чинь дээр.

- Би яаж санахгүй байгаа зүйлийнхээ талаар бодох юм бэ? Надад урьд нь Маршад шилтгээн,

гэрлэх эмэгтэй байсан ч цайзаа өнөөдөр олох нь битгий хэл эмэгтэгийнхээ үсний өнгө ямар болохыг ч санахгүй байна. Хэн намайг хүлэг баатар болгосон билээ, хуучин анд минь? Миний дуртай хоол юу билээ? Энэ бүхэн бүдгэрч мартагдсан. Заримдаа би үнсэн дундаас ургасан цустай өвснөөс төрсөн юм шиг цээжний минь дотор болон аманд гал амтагддаг. Ингэхэд чи миний ээж үү, Торос?

Арьяа сэгсгэр үс, ноорхой ягаан нөмрөг, хуучин хуягны үлдэгдэл бүхий Мирийн хувраг руу харлаа. Хацрыг нь буурал сахлын ёзоор бүрхэж эрүүн дор сул арьс унжжээ. Тэр Хөгшин Нанын үлгэрт гардаг шидтэнтэй адил харагдаагүй ч гэсэн...

- Та толгойгүй болсон хүнийг эргүүлэн авчирч чадах уу? Зургаа биш зөвхөн ганц удаа. Чадна биз дээ? гэж Арьяа асуулаа.

- Надад ид шид байхгүй, хүүхэд минь. Зөвхөн залбирал бий. Эхний удаа лорд баруун талдаа жадны шарх авч цус амаар нь бургилахад би найдлагагүй болсныг мэдсэн. Түүний хөөрхий сийчүүлсэн цээж хөдлөхөө болиход би түүнд бурхныхаа үнсэлтийг өгч замд нь үдсэн. Би амаа галаар дүүргэн түүний дотогш хоолой, уушги, зүрх сүнс рүү нь галаар амьсгалсан. Эцсийн үнсэлт гэж үүнийг нэрлэдэг бөгөөд би маш олон удаа хөгшин хуврагууд Эзний зарц нарыг үхэх үед хийхийг харсан билээ. Би үүнийг бүх хуврагуудын хийдэг шиг ганц хоёр удаа хийсэн. Гэсэн ч өмнө нь хэзээ ч түүний дотор гал дүүргэхэд нүд нь нээгдэхгүй байхыг хараад үхсэн хүн шиг чичирч байсангүй. Энэ бол би биш тэр түүнийг босгосон хэрэг, хатагтай. Энэ бол Гэрлийн эзэн байсан. Р'хлор түүнтэй үйл хэрэг дуусаагүй байгаа. Амьдрал бүлээхэн, гал дулаахан болохоор Бурхны гал зөвхөн түүнд байдаг.

Арьяагын нүдэнд нулимс цийлэгнэлээ. Торос олон үг хэлсэн ч тэд бүгд нь үгүй гэж байгааг сайн ойлгожээ.

- Чиний эцэг сайн хүн байсан. Харвин түүний тухай надад ярьсан. Түүний төлөө би чамаас дуртайяа барьцаа авахгүй байж болох ч бидэнд алт туйлын хэрэгтэй байна гэж лорд Берик хэлэв.

Арьяа уруулаа хазлаа. *Энэ үнэн болохыг харж байна.* Берик Хоточийн алтыг Ногоон сахалт, Анчин хоёрт өгч өмнө зүг Мандерийнхнаас хоол хүнс авахаар явуулжээ.

- Сүүлчийн ургац шатаж, байгаа нь ялзарсан болохоор бидэнд өвөл удахгүй ирнэ. Жирийн ардуудад үр тариа хэрэгтэйн зэрэгцээ бидэнд ч гэсэн илд, морьд хэрэгтэй. Бид хурдан хүлэгтэй дайсны эсрэг дэндүү олон хүн ачаа, тэрэгний морь луус унасан байна гэж Берик тэднийг явуулахдаа хэлэхийг нь сонсчээ.

Арьяа Робб түүний төлөө хэр их үнэ төлөхийг мэдсэнгүй. Тэр одоо хаан болсон болохоос Винтерфеллд үсэнд нь цас хайлж үлдсэн хүү биш болсон. Хэрвээ тэр Арьяагын хийсэн зүйл болох агтчин хүү, Харренхалын харуулыг алсныг мэдэх юм бол...

- Миний ах надад барьцаа төлөхийг хүсэхгүй бол яах вэ? гэхэд,

- Чи яагаад ингэж бодоо вэ? гэж лорд Берик асуулаа.

- Үс минь ширэлдэж, хумс минь буртагтай хөл минь эвэршиж гүйцсэн гэж Арьяа хэлэв. Робб үүнийг тоохгүй нь лавтай ч ээжийнх нь тухайд өөр хэрэг байв. Хатагтай Кателин түүнийг үргэлж Санса шиг дуулж бүжиглэн, юм ёож хатган, хатагтайн боловсон ёсыг суралцаасай гэж хүсдэг байсан юм. Энэ тухай бодол төрөхөд Арьяа үсээ хуруугаараа самнахыг оролдсон ч битүү ширэлдсэн тул заримыг нь таслахад хүрэв.

- Би хатагтай Смолвудын өгсөн даашинзыг сүйтгэж, сайн хатгаж чаддаггүй. Ер нь би сайн оёдоггүй. Септа Мордэйн намайг хар дархны гартай төрсөн гэдэг байсан гэж уруулаа хазан хэлэв.

- Энэ бяцхан зөөлөн амьтан уу даа? Чи алх ч барьж даахгүй гэж Жэндри дуу алдав.

- Би хүсвэл барьж чадна! гэж Арьяа урдаас нь зандарлаа.

- Ах чинь чамд төлөх болно, хүүхэд минь. Үүнд санаа зовох явдалгүй гээд Торос инээд алдав.

- Тийм л дээ гэхдээ тэр тэгэхгүй бол яах вэ? гээд Арьяа бууж өгсөнгүй.

- Тэгвэл би чамайг хатагтай Смолвуд руу хэсэг хугацаагаар явуулах юм уу Блэкхэвений цайз руугаа явуулж болох юм. Гэхдээ ингэх шаардлагагүй гэдэгт итгэлтэй байна. Надад Торосын хийдэг шиг чиний эцгийг буцаан авчрах хүч байхгүй ч ядахдаа ээжийн чинь гарт аюулгүй буцааж чадна гээд лорд Берик санаа алдлаа.

- Та үүнийг тангараглаж байна уу? гэж Арьяа асуулаа. Йорен түүнийг гэрт нь аваачиж өгнө гэж бас амалсан ч үүнийхээ оронд алагдсан билээ.

- Хүлэг баатрын нэр хүндээр амалж байна гэж аянгат лорд ёслол төгөлдөр хэлэв.

Лемийг шар айрагны газар орж ирэхэд бороо цутгаж байсан бөгөөд тэр хараал урсган шаргал нөмрөгнөөсөө шалан дээр ус гоожуулав. Энгай, Азтай Жак хоёр хаалганы дэргэд шоо хаяж тоглон ямар ч тоглоом тоглож байсан хамаагүй Жак азтай байсангүй. Долоон чавхдаст Том ятганыхаа хөвчийг сольж хийгээд "Ээжийн нулимс", "Вилламын эхнэр нойтон байсан", "Бороотой өдөр мордсон лорд Харт" болон "Кастамерийн бороо"-г дууллаа.

Чи хэн болоод би дор чинь бөхийх ёстой гэж?

Хэмээн бардам лорд асуулаа

Зөвхөн муур өөр өнгийн зүстэй байдаг

Үнэнг би мэднэ

Алтан байна уу улаан зүстэй байсан ч хамаагүй

Арслангийн сарвуу хэвээр байх болно

Харин минийх урт хури шүү, эрхэм лорд

Чинийхээс урт хамаагүй хури гэж мэдээрэй

Ингээд Кастамерийн лорд үгээ үргэлжлүүлэн ярьсаар байж гэнэ

Гэвч одоо түүний орон гэрт бороо уйлсан ч

Сонсох хүн байхгүй

Өргөө танхимд нь бороо шивэрсэн ч

Сонсох сүнс үлдсэнгүй гэнэ

Эцэст нь Том борооны тухай дуугаа дуусгаж ятгаа цааш тавилаа. Дотор зөвхөн шар айрагны газрын занар чулуун дээвэр дээр бороо шавшин нүдэх чимээ гарна. Шооны тоглоом дуусахад Арьяа өрөөсөн хөл дээрээ зогсож, бусад нь Мерритийн морины тах нь байхгүй болсон тухай гомдоллохыг сонсож байв.

- Би чамд тах хийж өгч чадна. Би ердөө дархны дагалдан ч эзэн минь миний гарыг алх барихад зориулагдсан гэдэг байсан. Би морины тах хийж, гархин хуяг сэлбэн, хүнд хуягны хонхорхой гаргаж чадна. Дээрээс нь бас сэлэм хийсэн ч чадна гэж Жэндри гэнэтхэн хэлэв.

- Чи юу гэж хэлсэн бэ, залуу минь? гэж Харвин асуулаа.

- Би танай дархан больё гээд Жэндри лорд Берикийн өмнө өрөөсөн өвдөг сөхөрлөө.

- Хэрвээ та намайг өөрийнхөө хүн болгож авбал хэрэг болно шүү, эрхэм лорд. Би багаж зэвсэг, хутга хийж нэг удаа дуулга хийсэн нь муугүй болсон. Та нарыг бидэнтэй тааралдахаас өмнө Уулын хүмүүсийн нэг түүнийг авсан юм гэв.

Тэр бас намайг орхих гэж байна. Арьяа уруулаа хазлаа.

- Чи Риверраны лорд Таллид зүтгэсэн нь дээр биз. Би чиний ажлын хөлсийг төлж чадахгүй гэж лорд Берик хэлэв.

- Хэн ч надад төлж байгаагүй. Би зөвхөн дарх хийж, идэх хоол, унтах газартай байхыг хүсч байна. Тэгэхэд л хангалттай, эрхэм лорд.

- Дархан хүнийг хаа ч дуртай угтана. Авъяаслаг дархныг бол бүр илүүтэй. Ингэхэд чи яагаад бидэнтэй үлдэхийг сонгоо вэ? гэхэд Арьяа Жэндригийн нүүрээ тэнэг үрчийлгэн бодохыг харлаа.

- Хөндий толгодод байхад таны Роберт хааны хүмүүс, ах дүүсийн тухай ярьсан чинь надад их таалагдсан. Надад бас Хоточийг шүүсэн явдал таалагдсан. Лорд Болтон зүгээр л хүмүүсийг дүүжлэх юм уу толгойг нь аван лорд Тайвин, сэр Амори ч адил зүйл хийдэг. Би таны дархан болохыг хүсч байна.

- Бидэнд засч сэлбэх гархин хуяг хангалттай байгаа. Ихэнхийг нь үхсэн хүмүүсээс авсан

болохоор нэвт цоорсон нүх ихтэй гэж Жак лорд Берикт сануулав.

- Чи лав ухаан муутай байхаа, хүү минь. Бид бол дээрэмчид. Эрхэм лордоос бусад нь дорд гаралтай хог новшнууд. Томын тэнэг дуу таалагдсан гэж бас битгий хэлээрэй дээ. Чи гүнжийн уруулаас үнсэлт хуйлгайлж, тэмцээнд хулгайлсан хуягтай явахгүй. Бидэнтэй нэгдсэн цагт хүзүүнд чинь дүүжлүүрийн гогцоо углагдан төгсгөл болох юм уу толгой чинь цайзын хаалганы оройг чимэглэх болно гэж Лем хэлэв.

- Тэдний чамд хийхээс илүүгүй гэж Жэндри хэллээ.

- Тийм шүү. Хэрээнүүд биднийг хүлээж байгаа. Эрхэм лорд хүү хангалттай зоригтой болохоор бидэнд түүний өгөх зүйл хэрэгтэй байна. Түүнийг авна гэж Жакад хэлээч хэмээн Азтай Жак хөгжилтэй хэлэв.

- Дээрээс нь түргэн авахгүй бол халуурал нь өнгөрч ухаан санаа нь эргэн ирнэ гээд Харвин хөхрөв.

Лорд Берикийн уруул дээр сулхан инээмсэглэл тодорлоо.

- Торос миний илдийг аваад ир.

Энэ удаад аянгат лорд илдэнд гал авалцуулсангүй Жэндригийн мөр лүү сунгалаа.

- Жэндри чи бурхад болоод хүмүүсийн нүдний өмнө өөрсдийгөө хамгаалж чадахгүй сул дорой хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалан, удирдагчийнхаа үгэнд захирагдан, хаана хэрэгтэй цагт эрэлхэгээр тулалдан оноосон даалгаварыг биелүүлж хүнд бэрх аюул ослыг давна гэдгээ андгайлж байна уу?

- Тиймээ, эрхэм лорд.

Маршийн лорд илдээ баруун зүүн мөрөнд нь ээлжлэн хүргээд,

- Бос сэр Жэндри хөндий толгодын хүлэг баатар минь ахан дүүстээ тавтай морил гэхэд хаалган дээрээс бүдүүлэг хахир инээд хадлаа

Бороо түүний биеийг даган урсаж навч тавин боолтоор боосон түлэгдсэн гараа цээжиндээ бүдүүлэг олсоор шахан дүүжлээд, хуучин түлэгдсэн царай нь харанхуйд бяцхан түүдгийн гэрэлд гялалзана.

- Ахиад л хүлэг баатар бий болгож байна уу? Би чамайг үүний чинь төлөө ахин алах байна гэж орж ирэгч хүнгэнэсэн дуугаар хэлэв.

Лорд Берик түүнийг хүйтнээр угтлаа.

- Би чамайг сүүлчийн удаа харсан гэж найдсан юмсан, Клегэйн. Чи яаж биднийг олоо вэ?

- Энэ тийм ч хэцүү биш байсан. Та нарын тавьсан утаа Хуучин хотоос ч гэсэн харагдахаар байна лээ.

- Тэгвэл миний тавьсан харуул яасан гэж?

- Тэр хоёр сохор хүн үү? Би тэднийг хоёуланг нь алж болох байлаа. Хэрвээ тэгсэн бол намайг яах юм? гээд Клегэйний ам татвалзлаа.

Энгай нумаа татахад, Нотч бас ижил зүйл хийв.

- Чи үхэхийг тэгтлээ хүсээд байгаа юм уу, Сандор? Биднийг энэ хүртэл дагаж ирдэг чи лав галзуу юм уу согтуу байхаа гэж Торос хэлэв.

- Би тэгээд борооны ус уух болж байна уу? Та нар надад аяга дарс ч худалдаж авах алт үлдээгээгүй шүү дээ, янхны хүү минь.

- Бид бол дээрэмчид. Дээрэмчид хулгайлдаг юм. Дуунд ингэж гардаг болохоор хэрвээ чи Томоос найрсгаар гуйвал нэгийг дуулж өгөх байх. Биднийг чамайг алаагүйд талархаж яв гээд Энгай сумаа хөвчлөв.

- Оролдоод үз л дээ, харваачаа. Би нумыг чинь аваад сумыг нь сэвхтэй бяцхан өгзгөнд чинь шигтгэнэ.

Энгай урт нумаа өргөсөн ч лорд Берик түүнийг харвахаас өмнө гараа өргөлөө.

- Клегэйн чи энд яах гэж ирээ вэ?

- Миний байсан зүйлээ буцааж авах гэж.

- Алт чинь уу?

- Өөр юу байх гэж? Надад чиний царайг харах таатай байна гэж бодоо юу, Дондаррион. Тэгвэл би чамд үүнийг хэлье. Чи одоо надаас илүү үзэшгүй муухай болжээ. Дээрээс нь бас дээрэмчин хүлэг баатар болсон бололтой.

- Би чиний алтанд бичиг хийж өгье. Дайн дуусмагц төлөхийг амласан баримт гэж лорд Берик тайван хэлэв.

- Би түүгээр чий өгзгөө арчина. Би алтаа авахыг хүсч байна.

- Бидэнд тэр чинь байхгүй. Ногоон сахалт, Анчин хоёрт өгөөд Мандер луу үр тариа худалдаж авахаар явуулчихсан.

- Та нарын ургацыг нь шатаасан хүмүүсийг тэжээх гэж хэмээн Жэндри хэлэв.

- Энэ чинь одоо бас юу түүх вэ? Ийм зүйл боллоо гэхэд би оролцмоор байна. Бөөн хэсэг царай

муутай тариачин, цоохор гөлгүүдийг нь тэжээнэ гээд Сандор Клегэйн инээд алдав.

- Чи худал хэлж байна гэж Жэндри тээнэгэлзлээ.

- Хүүг амтай болохыг нь харлаа. Яагаад надад биш тэдэнд итгэж байгаа юм бэ? Миний царайнаас болж уу? гээд Клегэйн Арьяа руу ширтэн,

- Чи тэрнийг бас хүлэг баатар болгосон уу, Дондаррион? Найман настай охин хүлэг баатар болгосон уу? гэв.

- Би арван хоёр настай тэгээд ч хүсэх л юм бол хүлэг баатар болж чадна. Хэрвээ Лем миний хутгыг аваагүй бол чамайг ч гэсэн алах байсан гэж Арьяа насаа нэмэн худал чанга хэлээд энэ тухай санахаас уур нь хүрлээ.

- Түүнийгээ надад биш Лемдээ гомдолло. Тэгвэл хөлийн хоорондох сүүлээ хавчин зугтаа л даа. Чи ноход чононуудыг хөөхөд юу болдогыг мэдэх үү?

- Дараагийн удаа би чамайг алах болно. Ахыг чинь ч гэсэн ална!

- Үгүй. Чи тэгж чадахгүй гээд Клегэйн хар нүд онийлгон лорд Берик руу эргэлээ.

- Миний морийг хүлэг баатар болгоно гэж хэлээч. Тэр хэзээ ч өргөө танхимд бааж бусад шигээ өшигчөөд байдаггүй болохоор хүлэг баатар болох эрхтэй. Үгүйдээ чи түүнийг бас хулгайлж болох юм.

- Мориндоо мордож эндээс арилсан чинь дээр шүү гэж Лем сүрдүүлэв.

- Би алтаа авсан цагт явна. Танай өөрийн бурхан чинь намайг гэм зэмгүй гэж батлаа биз дээ...

- Гэрлийн эзэн чамд амийг чинь буцааж өгсөн. Гэхдээ тэр чамайг Ариун Бэйлор ахин эргэн төрсөн гэж хэлээгүй гээд Торос илдээ сугалахад Жак, Меррит нар ч гэсэн сугаллаа. Лорд Берик Жэндриг адислаж байсан илдээ атгасан хэвээр байв. *Магадгүй энэ удаад тэд түүнийг алж болох юм.*

- Та нар ердийн хулгайчдаас ялгаагүй юм шив дээ гээд Хоточийн ам ахин татвалзлаа.

- Чиний арслан нөхөд чинь тосгон руу орж хоол унд, зоосыг нь тонон дээрэмдэхийгээ ургац хураах гэж нэрлэдэг юм билээ. Чононууд ч гэсэн тэгдэг байхад яагаад бид болохгүй гэж? Хэн ч чамайг дээрэмдээгүй, нохой минь. Чи дөнгөж түрүүхэн ургацаа хураалгасан гээд Лем муухай харлаа.

Сандор Клегэйн тэдний царайг тогтоох гэсэн мэт тус бүр ээлжлэн харлаа. Тэгснээ бороо цутгаж байсан харанхуй руу ахин үг хэлсэнгүй гарав. Дээрэмчид гайхширан хүлээзнэн хоцорлоо.

- Би явж түүнийг манай харуулыг яаж давсныг мэдье гээд Харвин хаалгаар гарахын өмнө Хоточийг гадна талд нуугдсан эсэхийг цэгнэн болгоомжтойгоор шагайн харав.

- Энэ новш яаж тийм их алт олсон юм бол? гэж Шаргал нөмрөгт Лем нам гүмийг эвдэн дуугарав.
- Тэр Хааны газар Гарын тэмцээнд түрүүлсэн. Би бас муугүй аз хожсон болохоор Данси, Жэйд, Алаяаяа нартай зугаалсан. Тэд надад хэрхэн шарсан хун амталж, Арборын дарсанд умбахыг зааж өгсөн юм гээд Энгай мөрөө хавчин инээлээ.
- Чи бүгдийг нь үгүй хийчихээ юу? гээд Харвин инээд алдав.
- Бүгдийг нь биш. Би энэ гутал болон маш сайхан хутга худалдаж авсан.
- Чи хэсэг газар худалдан авч шарсан хун охидынхоо нэгийг үнэнч эмэгтэй болгох ёстой байсан юм. Тэгээд манжин тарьж хөвгүүд өсгөх ёстой байсан юм гэж Азтай Жак хэллээ.
- Дайчин намайг хамгаалаг! Би алтаа манжин болгоогүй минь юутай гарз вэ.
- Би манжинд дуртай. Яг одоо нухсан манжин хийсэн ч чадна гэж Жак гоморхов.

Мирийн Торос наргианд оролцсонгүй.

- Хоточ хэдхэн хүүдий зоосноосоо илүү зүйлийг алджээ. Тэр эзнээ болон хонуураа ч гэсэн алдсан. Тэр Ланнистерийнхан руу буцаж болохгүй, Залуу чоно түүнийг хэзээ ч авахгүй болохоор ах нь ч гэсэн таатай угтахгүй. Алт бол зөвхөн түүнд үлдсэн ганц зүйл.
- Хараал идсэн там минь. Тэгвэл тэр биднийг унтаж байхад маань алах нь байна гэж Тээрэмчин Ватти хэлэв.
- Үгүй. Сандор Клегэйн биднийг дуртайяа алах ч унтаж байхад минь биш. Энгай маргааш Сахалгүй нугастай ард яваарай. Хэрвээ Клегэйн араас шиншилж яваа харагдвал морийг нь ал гээд лорд Берик илдээ хуйллаа.
- Тэр чинь сайн морь шүү дээ гэж Энгай харамсав.
- Яг тийм. Бид хараал идсэн морьтонг нь л алах ёстой. Бидэнд морь нь хэрэгтэй гэж Лем дэмжив.
- Би Лемтэй цуг явъя. Надад нохойг номхотгох хэдэн сум өгөөдөх гэж Нотч хэлэв.
- Клегэйнний амь хөндий толгодын дор өршөөгдсөн. Би үүний төлөө түүнийг дээрэмдэхгүй гээд лорд Берик толгой сэгсэрлээ.
- Эрхэм лорд ухаалаг ярьж байна. Ах дүүс минь тулааны шүүх бол ариун зүйл. Хэрвээ та нар надаас асуувал лорд Берик өрсөлдөгчөө төгсгөл болгох үед Р'хлорын галт хуруу илдийг нь хугалахыг харсан гэх байна. Гэрлийн эзэн Жоффригийн Хоточтой тооцоо дуусаагүй бололтой хэмээн Торос бусаддаа хэлэв.

Харвин төдөлгүй шар айрагны газар буцан орж ирэв.

- Паддингпүүт унтаж байгаа ч ямар нэг гэм учраагүй байна.

- Би түүнд үзүүлээд өгье өө. Хэлийг нь огтолно. Тэр биднийг бүгдийг нь алуулж болох байлаа хэмээн Лем дүрсхийв.

Тэр шөнө Сандор Клегэйн харанхуйд хаа нэгтээ ойрхон байгаа гэдгийг мэдэж байсан болохоор хэн ч тухтай унтаж чадсангүй. Арьяа галын ойролцоо дулаахан тухтай газар атиралдан хэвтсэн ч мөн амарч чадсангүй. Нөмрөгөн дор Жэйкен Х'гарын өгсөн зоосыг гарган гартаа эргэлдүүлэн хэвтэв. Зоосыг барихад сэтгэл нь зоригжин хэрхэн Харренхалын сүнс байсан үеэ санана. Тэр тэгэхэд шивнэлтээрээ алдаг байсан билээ.

Гэсэн ч Жэйкен байхгүй болжээ. Тэр түүнийг орхисон. *Халуун бялуу ч гэсэн орхисон. Харин одоо Жэндри намайг орхиж байна.* Ломми, Йорен, Сирио Форел үхэж эцэг нь ч гэсэн үхсэн болохоор Жэйкен түүнд хэнд ч хэрэггүй тэнэг төмөр зоос өгөөд алга болжээ. "*Валар моргулис*" гэж алгандаа төмөр зоосны ирмэгийг шигдтэл чанга атгаад зөөлөн шивнэв.

- Сэр Грегор, Дансен, Полливер, Рафф Свитлинг, Гижигдэгч болон Хоточ. Сэр Илин, сэр Мерин, хаан Жоффри, хатан Серсей гээд Арьяа тэдний үхсэн байхдаа хэрхэн харагдахыг төсөөлөхийг оролдсон ч царайг нь санахад бэрх байлаа. Зөвхөн Хоточ болон түүний ах Уулын царай харагдан, Жоффри ээжийнхээ царайтай мартагдахгүй байсан ч Рафф, Дансен, Полливер нарынх бүүдгэрч Гижигдэгч хүртэл арилан хуучирчээ.

Эцэст нь нойрссон ч шөнийн харанхуйд нэг зүйлд татагдан ахин сэрлээ. Гал цог болон унтарчээ. Маж хаалганы дэргэд зогсоод ахин нэг харуул гадна талд зогсож байв. Бороо зогсож чонын улих чимээ сонсогдоно. *Ийм ойрхон ямар олуул байна аа* гэж бодлоо. Тэд жүчээний эргэн тойронд олон арав бүр зуугаараа байгаа юм шиг сонсогдож байв. *Би тэднийг Хоточийг идээсэй гэж найдаж байна.* Арьяа түүний чоно болон нохдын тухай юу хэлснийг саналаа.

Өглөө болоход септон Утт модны мөчирт санжигнасан хэвээр хүрэн ах дүүс гадаа бороонд хүрээр намхан булш ухан үхэгсдээ оршуулж байв. Лорд Берик тэднийг шөнө хоолоор зочилсонд талархал илэрхийлэн сүмээ сэргээн босгоход туслан хүүдий дүүрэн мөнгөн зоос өглөө. Харвин, Хөөрхөн Люк, Тээрэмчин Ватти гадагш тандахаар яваад чоно битгий хэл хоточ нохойн ч мөр олдсонгүй.

Арьяаг эмээлийн олмоо чангалах зуур Жэндри уучлал гуйсан үг хэлэхээр ирэв. Тэр хөлөө дөрөөн дээгүүр давуулаад эмээлдээ мордож түүр хүү харахын оронд доошоо харлаа. *Чи Риверранд миний ахад илд хийч өгч болох л байсан* гэсэн бодол төрөхөд,

- Хэрвээ чи тэнэг дээрэмчин хүлэг баатар болж дүүжлүүлэхийг хүсч байвал надад ямар хамаатай юм бэ? Би Риверранд барьцаа төлөн ах руугаа буцлаа гэв.

Тэр өдөр аз болж ахин бороо орсонгүй тул тэд даруй замд гарлаа.

БРАН

Арал дээрх цамхагын дүрс гүн цэнхэр усанд ихэрлэн тусчээ. Салхи салхилахад нуурын толин мандал ар араасаа хөөцөлдөн тоглож байгаа хөвгүүд шиг мяралзана. Нуурын эргийн ойролцоо бүдүүн царс мод шигүү ургаж газар унасан боргоцой битүү зулжээ. Үүний цаахан талд урьд нь тосгон байсан газрын үлдэгдэл балгас байв.

Энэ нь тэднийг толгодыг орхисон цагаас хойш тааралдсан анхны тосгон байлаа. Мира нурангин дунд отоож буй хүн буй эсэхийг тандахаар явлаа. Тэр царснаас царс, алимны модны хооронд гартаа тор, жадаа барин шилжсээр бургасанд байсан гурван улаан бугыг үргээлгэн зугтаалгав. Зун цахилан зугтсан амьтдыг хармагц даруй тэдний араас хөөлөө. Бран зэрлэг чонын давхихыг ширтэн агшин зуур арьсанд нь орж хамт гүйхээс ондоо зүйл хүссэнгүй ч Мира тэднийг урагшил хэмээн даллав. Тэр дургүйхэн Зунаас харц салгаж Ходорыг тосгон руу яв гэлээ. Жожен тэдэнтэй хамт явж байв.

Хананаас энд хүртэлх газар өвсөрхөг бөгөөд Бран боловсруулж хагалаагүй талбай, намхан довцог толгод, өндөр нуга, нам дор намгархаг газар болохыг нь мэдэж байв. Эндээс уулын ард гарахад амархан байсан ч задгай газар Мирад таалагдсангүй.

- Надад нүцгэн болсон юм шиг санагдаж байна. Тэнд нуугдах газар байхгүй гэж хэлэв.

- Энэ хэний газар юм бэ? гэж Жожен Бранаас асуулаа.

- Шөнийн харуулын газар. Энэ газрыг Бэлэг гэдэг. Шинэ Бэлэг харин хойд зүгт Брандоны Бэлэг гэж бий гээд мэйстер Лювин түүнд энэ бүхнийг зааж өгчээ. - Брандон Баригч Хананаас өмнө зүг хүртэл хорин таван бээр газрыг бүхэлд нь хар ахан дүүст өгчээ. Тэдний оршин суухад дэмжлэг болохоор гээд энэ тухай санаж байгаадаа бардмаар,

- Зарим мэйстерүүд үүнийг Баригч биш өөр Брандон байсан гэдэг байсан ч Брандоны Бэлэг хэвээр. Мянган жилийн өмнө хатан Алиссана Хана руу Мөнгөн жигүүр лууны хамт айлчилахдаа Шөнийн харуулын эр зоригийг бахдахад Хөгшин хаан газар нутгийнх нь хэмжээг сунган тавин бээр болгож өгсөн юм. Энэ бол Шинэ Бэлэг гээд гараа савчиж,

- За ингээд л боллоо гэв.

Тосгонд удаан хугацааны туршид хэн ч оршин суугаагүй нь илт байв. Бүх байшин барилга, дэн буудал нь хүртэл нурж унажээ. Энэ нь хэзээ ч дэн буудал байгаагүй мэт харагдан чулуун ханан зуух, хоёр цуурсан хана арваад алимны модон дунд байлаа. Нэг нь нийтийн өрөөнд ургаж нойтон хүрэн навчис, ялзарсан алим шалан дээр хөглөрнө. Агаарт алимны үнэр ханхлахад нялуун шүүснийх нь үнэр хамар нэвт цоргино. Мира алимыг идэж болох эсэхийг мэлхийний жадаараа хатган шалгаж үзсэн ч бүгд хүрэнтэж өтсөн байлаа.

Энд амгалан тайван ноёрхсон тогтуун газар учир Бранд хоосон дэн буудал дэндүү уйтгартай санагдахад Ходорт ч бас тэгж санагдсан бололтой.

- Ходор? Ходор? Ходор? гэж мэгдсэн дуугаар хэлэв.

- Сайхан газар байна. Тосгон, дэн буудал, нуурын чулуун бэхлэлт энэ бүх алимны мод гээд л. Гэвч хүмүүс нь хаачаа вэ, Бран? Тэд яагаад ийм газрыг орхисон юм? гэж Жожен атга шороо самардан хурууны завсар гоожуулж хэлэв.

- Тэд зэрлэгүүдээс айсан юм. Зэрлэгүүд Ханыг давах юм уу уулын цаанаас ирж хулгай дээрэм хийн эмэгтэйчүүдийг авч явдаг. Хэрвээ тэд хүн барьж авбал гавлын ясаар нь цус уудаг аяга хийдэг гэж Хөгшин Нан хэлдэг юм. Шөнийн харуул Брандоны үе болон хатан Алисаннагын үед хүчирхэг биш байсан болохоор олон тооны зэрлэгүүд орж ирдэг байлаа. Ханын ойролцоох газрууд тонон дээрэмдүүлэхэд жирийн ардууд өмнө зүг, уул руу гарах юм уу эсвэл дорно зүг Хааны замаар Амберийнхан руу явсан. Том Жоно хүмүүс бас дээрэмдүүлдэг байсан ч Бэлэгт амьдарч байсан хүмүүс шиг тийм их биш.

Жожен Рид толгойгоо үл үзэгдэх хөгжим сонсож буй мэт удаанаар эргүүлээд,

- Бид энд хоноглох газар олох хэрэгтэй. Шуурга ирж байна. Маш хүчтэй шуурга гэв.

Бран тэнгэр лүү харлаа. Энэ нь намрын үзэсгэлэнтэй цэлмэг сайхан өдөр байсан бөгөөд нарлаг бара дулаахан гэмээр байсан ч баруун зүгт шуурганы тэмдэг болох хар үүл хуралдан салхины хүч ихэслээ.

- Дэн буудалд дээвэр байхгүй ердөө хоёр хана үлдсэн байна. Бид бэхлэлт рүү очих хэрэгтэй гэж Бран хэлэв.

- Ходор гэж Ходор зөвшөөрч буйгаа хэллээ.

- Бидэнд завь байхгүй, Бран гээд Мира мэлхийний жадаараа унасан навч хоосон чичив.

- Тэнд жим байгаа. Усан дор нуугдсан далд чулуун жим. Бид түүгээр явж болно гээд үнэндээ тэд явах учир Бран Ходорын нурууны сагсанд хуурай үлдэх байлаа.

Ридийнхэн харц солилцов.

- Чи үүнийг яаж мэдэж байгаа юм бэ? Чи өмнө нь энд байсан юм уу, ханхүү минь? гэж Жожен асуулаа.

- Үгүй. Хөгшин Нан ярьж өгсөн юм. Бэхлэлт алтан титэмтэй болохыг харж байгаа биз дээ? гээд Бран нууран дахь дээд талын хэрмийн шүдний алтан титмийн өнгө хуурч унасан бэхлэлт рүү заалаа.

- Хатан Алиссана энд унтаж байсан болохоор тэд түүний хүндэтгэлд зориулан хэрмийн шүдэн дээр алтан титэм зурсан юм.

- Жим гэнэ ээ? Чи итгэлтэй байна уу? гээд Жожен нуур луу харлаа.

- Гарцаагүй гэж Бран хэлэв.

Мира хөнгөн хөлтэй болохоор ганц хармагц нуурын баруун талаар хөтөлсөн гурван футын өргөн чулуун жим байгааг мэдэв. Тэр тэднийг дагуулан замаар урдаа мэлхийний жадаа барин болгоомжтой явлаа. Урд нь зам усан дороос арал руу гарч ирж буй хэсэгт бэхлэлтийн хаалга руу хөтөлсөн чулуун гишгүүр харагдана.

Зам, гишгүүр, хаалга бүгд шулуун шугамд байсан ч жим бодсон шиг шулуун байсангүй. Нуурын усан дор тахирлан арлыг тойрохын урд буцаж эргэжээ. Эргэсэн хэсэгтээ осолтой бөгөөд урт зам ойртож очсон хэнийг ч цамхагаас удаан хугацаанд галт сумаар харвах боломж өгнө. Дээрээс нь усан дор нуугдсан чулуу гөлгөр хальтирамтай учир Ходор хоёр ч удаа унах шахаад "ХОДОР!" гэж түгшин хашгирч тэнцвэрээ оллоо. Хоёр дахь удаад нь Бран муугүй айжээ. Хэрвээ Ходор түүнийг сагсанд үүрээстэй нуур луу унавал том биетэй агтчин хүү заримдаа самгардах үедээ түүний байгааг мартдаг үеийнх шиг мартаж болохоор живэх нь лавтай билээ. *Магадгүй бид алимны модон дор дэн буудалд үлдэж болох байсан юм* гэж бодсон ч дэндүү оройтсон байлаа.

Аз болоход гурав дахь удаагаа гэж болсонгүй ус Ходорын бүсэлхий, Ридийнхны цээжээр татаж байлаа. Тэд арал руу гарахын өмнө бэхлэлтийн чулуун шатаар авирав. Хаалгыг бат бөх хүнд царс модоор хийсэн учир олон жилийн явцад хагасаж хагаран бүрэн хаагдахаа больжээ. Мира түүнийг онгойлгоход зэвэрсэн төмөр нугас хяхтналаа. Тотго нь намхан ажээ.

- Ходор доошоо бол гэж Бран хэлэхэд тэр бөхийсөн ч хангалттай тонгойгоогүй учир толгойгоороо мөргөсөнд,

- Өвдөж байна шүү дээ гэж гомдоллов.

- Ходор гээд Ходор эгцлэн бослоо.

Тэд дотор нь дөрөн хүн багтаж хүрэлцэхүйц бүүдгэр чулуун өрөөнд оров. Зүүн талаар нь цамхагын дотор талын хана руу орсон шат дээш мушгиран өгсөж баруун талд нь төмөр хаалганы ард доошоо уруудсан шат байлаа. Бран толгой дээр нь онгойдог нүх байхыг харлаа. *Үхлийн нүх* байна. Тэр одоо түүгээр хэн ч толгой дээрээс нь халуун тос цутгахгүйд баярлах сэтгэл төрөв.

Хаалга цоожтой төмөр тор нь улаан зэвэнд идэгджээ. Ходор хаалганаас зүүн гараараа бариад хамаг хүчээ гарган татлаа. Юу ч болсонгүй. Тэр түлхсэн ч амжилт олсонгүй. Иймээс торыг сэгсэрч өшиглөн ахин харжигнатал түлхэж нугасыг нь нүсэр нударгаараа цохиход агаарт зэвний тоос бужигнаснаас ондоо төмөр хаалга хөдөлсөнгүй. Доогуур нь шургах аргагүй байлаа.

- Дотогш орж болохгүй нь гээд Мира мөрөө хавчив.

Үхлийн нүх Ходор нуруун дахь сагсанд сууж байсан Браны толгойн дээхэн талд байв. Бран түүнээс бариад торыг онгойлгохыг оролдоход доош нээгдэж улаан зэвний өөдөс пургин чулууны өөдөс нурлаа.

- ХОДОР! гэж Ходор орь дуу тавив. Хүнд төмөр хаалга Браны толгой руу буухад ахин тасхийтэл

цохиод Жожены хөл рүү унахад үсрэн холдлоо. Мира хөхөрч,

- Хараач, ханхүү минь. Та Ходороос хүчтэй юм гэхэд Бран улайлаа.

Нэгэнт хаалга байхгүй болсон тул Ходор Мира, Жожен хоёрыг үхлийн нүх рүү өргөн оруулав. Намгийн хүүхдүүд Браны хоёр гараас барьж дээш нь татлаа. Хамгийн хэцүү нь Ходорыг дотогш оруулах явдал байв. Тэр Бран шиг өргөхөд Ридийнхэнд даахын аргагүй дэндүү хүнд ажээ. Эцэст нь Бран түүнд том чулуу ол гэж хэлэв. Аралд чулуу мундахгүй их болохоор Ходор нүхний ирмэгт хүрэх хэмжээний чулуу овоолж дотогш авиран орлоо.

- Ходор гэж баяртай хэлээд байдгаараа инээв.

Тэд төөрдөг байшин шиг олон жижигхэн өрөөтэй харанхуй хоосон газар ороход Мира шат руу буцах замаа олов. Тэд гэрэлд гарахын тулд дээш өгсөхөд гурван давхарт гадна талын зузаан хана нь сумны харвадаг нүхтэй, дөрвөн давхар цонхтой, таван давхрын хамгийн дээд талын нуман хаалгатай том дугуй өрөө гурван талдаа жижигхэн чулуун тагттай байв. Дөрөв дэх нь жорлон байсан бөгөөд муу усны хоолой нуур луу унжжээ.

Тэднийг дээвэр дээр гарч ирэхэд тэнгэр битүү үүлэнд бүрхэгдэн баруун зүгээс хар үүл ирж байлаа. Салхи хүчтэй салхилахад Браны нөмрөг тас нясхийн намирав.

- Ходор гэж Ходор айсандаа дуу алдав.

- Надад бараг л ертөнцийн дээрээс өлийж байгаа аварга биет болсон юм шиг санагдаж байна гээд Мира дугуйран эргэлдэв.

- Хүзүүний модод үүнээс хоёр дахин өндөр гэж дүү нь түүнд сануулав.

- Гэхдээ тэдний эргэн тойронд түүнээс ч өндөр мод байдаг. Ертөнц Хүзүүнд шахуу ойрхон болохоор тэнгэр нь жижигхэн харагддаг. Энд салхи яаж салхилж байгааг мэдэрч байна уу, дүү минь? Ертөнц хичнээн том харагдаж байгааг хараач.

Эндээс олон бээрийн газар харагдах тул энэ үнэн байлаа. Өмнө зүгт довцог толгод үргэлжлэн саарал ногоон уулс тэдний ард хөхрөнө. Шинэ Бэлэгийн уудам тал бүх зүг нүдний хараа үл хүрэх алсад үргэлжилжээ.

- Би эндээс Хана харагдана гэж бодсон юмсан. Бид ахиад тавин бээр явах хэрэгтэй болох нь ямар тэнэг хэрэг вэ гэж Бран урам хугаран хэлээд зөвхөн энэ тухай ярихад хичнээн их зүдэрч даарснаа мэдрэв.

- Жожен бид Хананд хүрээд яах болж байна? Миний авга ах үргэлж Ханыг хичнээн том болохыг нь ярьдаг байсан. Долоон зуун фут өндөр суурь нь маш зузаан болохоор дотроо мөсөн хонгил дундуур гарсан хаалгануудтай гэсэн. Бид яаж түүгээр өнгөрөн гурван нүдтэй хэрээг олох юм бэ?

- Ханын ойролцоо хаягдсан эзгүй цамхагууд бий сонссон юм байна. Цамхагыг Шөнийн харуулууд босгосон ч одоо эзгүйрч хоосорсон. Бид тэдний нэгээр магадгүй нэвтэрч болох юм гэж Жожен

өчив.

Сүнстэй цайз гэж Хөгшин Нан тэд нарыг нэрлэдэг байлаа. Мэйстер Лювин урьд нь Бранд ханын дагуух бүх цамхагын нэрийг тогтоолгож байжээ. Тэд арван есүүл болохоор тогтооход бэрх ч гэсэн арван долоо нь хэзээ ч хүн суурьшиж байсангүй. Роберт хааныг Винтерфеллд ирэхэд зориулан хийсэн найрны үеэр Бран Бэнжин авга ахдаа өрнөөс дорно хүртэл бүх цамхагын нэрийг тоочжээ. Тэгэхэд Бэнжин инээд алдаад,

- Чи тэднийг надаас хавьгүй дээр мэддэг юм байна, Бран. Магадгүй чи тэргүүн эргүүл болж би оронд чинь энд үлдэх үү гэж хэлжээ. Энэ бүхэн Браныг унахаас өмнө болсон явдал билээ. Түүнийг нойрноосоо тахир дутуу болон сэрэхэд авга ах нь Хар цамхаг руу буцсан байлаа.

- Миний авга ах хаягдсан цамхагуудын хаалгыг чулуу мөсөөр овоолж дарсан гэсэн.

- Тэгвэл бид тэднийг буцаж нээнэ гэж Мира хэлэхэд Браны сэтгэл аягуйцэж,

- Бид тэгж болохгүй. Нөгөө талаас муу зүйл орж ирнэ. Бид Хар цамхаг руу явж захирагч лордоос цааш нь өнгөрүүлэхийг гуйх ёстой гэв.

- Эрхэм дээдсээ бид Хар цамхагаас Хааны зам шиг зайлсхийж явах болно. Тэнд хэдэн зуун хүн байгаа гэж Жожен хэлэв.

- Шөнийн харуулын хүмүүс. Тэд дайнд хэний ч талд орохгүй гэж андгай өргөсөн.

- Тийм л дээ гэхдээ ганц л хүн тангарагаа умартахад чиний нууцыг төмөр арлынхан юм уу Болтоны бутчид зарж болно. Тэгээд ч харуулууд биднийг гаргахыг зөвшөөрнө гэдэгт итгэлгүй байна. Тэд биднийг тэндээ байлгах юм уу буцааж явуулна.

- Гэхдээ миний эцэг Шөнийн харуулын анд нөхөр, авга ах маань тэргүүн эргүүл байсан. Тэр гурван нүдтэй хэрээ хаана байгааг мэдэж байж магадгүй. Жон ч гэсэн Хар цамхагт байгаа гээд Бран Жон болон авга ахтайгаа ахин уулзахыг найдлаа. Сүүлчийн удаа Винтерфеллд хар ахан дүүс зочлох үед Бэнжин Старк эргүүл хийх үеэрээ алга болсон гэж хэлсэн ч одоо буцах замаа олж ирсэн нь гарцаагүй.

- Би Харуулуудыг бидэнд морь өгнө гэж мөрийцсэн ч болох юм гэж Бран үргэлжлүүлэв.

- Чимээгүй гээд Жожен жаргаж буй нарны зүг нүдээ гараараа саравчлан ширтэв.

- Хараач. Тэнд нэг морьтой хүн... явж байх шиг байна. Та нар түүнийг харж байна уу?

Бран бас нүдээ саравчилсан ч онийлгоод ч харахад бэрх байлаа. Тэр эхэндээ юу ч харсангүй ч нүдэнд нь хөдөлгөөн өртөв. Эхлээд ухаанд нь Зун байж магадгүй гэсэн бодол орж ирсэн ч биш байлаа. Морьтой хүн байна. Гэхдээ тэр харахын аргагүй дэндүү хол байлаа.

- Ходор? Ходор? гээд Ходор гараараа саравчилсан ч буруу тийш ширтлээ.

- Тэр яарахгүй тосгонд саатах гэж байгаа бололтой гэж Мира хэлэв.
- Бид харагдахаасаа өмнө дотогш орсон нь дээр байх гэж Жожен санал болгоход,
- Тосгоны ойролцоо Зун байгаа гэж Бран эсэргүүцлээ.
- Зун яах ч үгүй. Тэр ердөө ядарсан морьтой ганц хүн байна гэж Мира тайтгаруулав.

Борооны том том дусал чулуун дээр дусалж эхлэхэд тэд доод талын давхар руу буулаа. Энэ нь ч цагаа олсон хэрэг болж түргэн хугацааны дараа бороо шаагиж зузаан ханыг нэвтлэн нуурын гадаргуу шавших сонсогдлоо. Тэд хоосон дугуй өрөөнд шалан дээр бүрэнхийд сууцгаав. Хойд зүг рүү харсан тагт хаягдсан тосгоны зүг чиглэжээ. Мира хэвлийгээрээ мөлхөн ойртоод морьтой хүн юу болсныг нуур луу шагайн харлаа.

- Тэр дэн буудлын нурангинд хоргодож байна. Зууханд гал түлж байгаа бололтой гэж буцаж ирээд хэлэв.

- Бид ч гэсэн гал түлж болох юм. Би даарч байна. Шатны доор эвдэрхий тавилга байсан. Бид Ходороор хугалуулан гал түлж дулаацаж болно гэж Бран хэлэхэд Ходорт энэ санаа таалагдсан бололтой,

- Ходор гэж найдангуй хэлэв.

- Гал түлэхэд утаа гарна. Цамхагаас гарсан утаа олон бээрийн зайд харагдана гээд Жожен толгой сэгсэрлээ.

- Тэнд чинь харах хүн хэн ч байхгүй шүү дээ гэж эгч нь маргалаа.

- Тосгонд байгаа хүн харна.

- Зөвхөн ганц хүн.

- Хэрвээ муу талын хүн байвал Браныг дайсанд худалдахаар ганц хүн. Бидэнд өчигдөрийн тал нугас хэвээр байгаа. Түүнийг идэж амаръя. Харин өглөө болоход тэр хүн замаа үргэлжлүүлэн бид ч гэсэн өөрсдийн замаар явна.

Жожен үргэлж бүхнийг өөрийнхөөрөө хийдэг байлаа. Мира нугасыг дундуур нь дөрөв хуваав. Тэр өмнөх өдөр намгаас нисэхийг завдсан нугасыг тороор барьжээ. Хүйтэн нугас шорноос дөнгөж гарсан нугас шиг шаржигнасан биш байсан ч тэд өлсөж байлаа. Бран, Мира хоёр цээжийг нь хуваан Жоженд гуя ногдов. Ходор өрөөсөн далавчийг нь нэг хөлтэй идэж "Ходор" гэж гүнгэнэн хазах тоолон хуруу даган гоожих шүүс долооно. Өнөөдөр Браны түүх ярих ээлж болохоор тэр өөр нэг Брандон Старк болох наран жаргах зүгийн тэгист далбаагаа өргөн одсон Хөлөг онгоц баригч Брандон гэдэг хүний тухай ярилаа.

Үдшийн бүрий өтгөрөхөд нугас, түүхийн хамт дууссан ч бороо орсон хэвээр байв. Бран Зуныг хэр хол хэсүүчилж нөгөө бугануудын нэгийг барьж чадсан эсэхийг бодлоо.

Цамхагт гэгээ бүдгэрэн аажмаар харанхуй болж хувирав. Ходор дугуй ханыг тасралтгүй тойрон эргэлт бүрдээ тэнд юу байгааг мартсан мэт жорлон руу шагайхаар зогсож байлаа. Жожен хойд талын тагтан дээр сүүдэрт нуугдан зогсож шөнийн бороог ширтэнэ. Хойд зүг хаа нэгтээ тэнгэрт цахилгаан зурсхийн цахилахад цамхагын дотор агшин зуур гэрэл гялсхийв. Ходор айсандаа үсрэн дуу алдлаа. Бран аянга буухыг хүлээн найм хүртэл тоолов. Аянга буухад Ходор "Ходор!" гэж хашгирлаа.

Зун айгаагүй байгаасай гэж Бран бодов. Винтерфеллийн нохойн байрны ноход үргэлж аянга цахилгаантай бороо ороход Ходор шиг эмээн үймэлддэг билээ. *Би түүнийг тайвшируулахаар очих ёстой....*

Цахилгаан ахин цахилахад энэ удаад аянга зургаа дахь тоон дээр буулаа.

- Ходор! ХОДОР! ХОДОР! гэж Ходор ахин хашгиран шуургатай байлдах гэж байгаа юм шиг илдээ шүүрч авав.

- Чимээгүй, Ходор. Бран түүнийг битгий хашгир гэж хэл. Мира чи илдийг нь авч чадах уу? гэж Жожен асуулаа.

- Оролдоод үзье.

- Ходор чимээгүй. Одоо чимээгүй бол. Битгий тэнэг юм шиг ходор гээд бай. Доошоо суу гэж Бран хэллээ.

- Ходор? гээд тэр урт илдээ Мирад хүлцэнгүй өгсөн ч царай нь самгардсан хэвээр байв.

Жожен харанхуй руу эргэн ямар нэг зүйлийг амьсгаа даран сонслоо.

- Энэ юу байсан бэ? гэж Мира асуув.

- Тосгонд байгаа хүн.

- Бидний өмнө харсан уу?

- Өөр хүмүүс. Зэвсэгтэй сүх жадтай юм байна. Би тэднийг цахилгаан цахихад модон доороос гарч ирэхийг харсан гээд Жожен хэзээ ч ийм жаахан хөвгүүн шиг сонсогдож байсангүй.

- Хэр олуулаа юм бэ?

- Маш олуул. Тоолохын аргагүй юм байна.

- Морьтой юм уу?

- Үгүй.

- Ходор. Ходор. Ходор гэж Ходор айсандаа хэлэв. Бран бас айсан ч үүнийгээ Мирагийн урд хэлж

зүрхэлсэнгүй.

- Тэд энд ирэх болов уу?

- Тэд ирэхгүй. Яагаад тэгэх ёстой гэж? гээд Мира дэргэд нь суулаа.

- Хоргодох газар олохоор ч юм уу. Үгүй бол шуурганд өртөнө. Мира чи доошоо бууж хаалга түгжиж чадах уу? гэж Жожен дүнсгэр дуугаар хэллээ.

- Би түүнийг хааж ч чадахгүй. Мод нь гажчихсан байсан. Тэд төмөр хаалгаар гарч чадахгүй гэж бодож байна.

- Тэд чадна. Тэд цоожыг эвдлэх юм уу нугасыг хэмх цохино. Эсвэл бидэн шиг нүхээр авиран орж ирнэ.

Тэнгэрт цахилгаан цахихад Ходор гиншгэнэлээ. Тэгтэл нуурын цаадтай аянга буув.

- ХОДОР! ХОДОР! ХОДОР! ХОДОР! гэж тэр гараараа чихээ даран орилоод харанхуйд бүдчин тойров.

- ҮГҮЙ! ХОДОР БАЙХГҮЙ! гэж Бран хашгирлаа. Гэвч энэ бүтсэнгүй.

- ХООООДОР! гэж Ходор ёолов. Мира түүнийг тайтгаруулахаар барихыг оролдсон ч дэндүү хүчтэй байлаа. Ердөө мөрөө хавчихын төдий хажуу тийш түлхэв.

- ХОООООООООООООООДОР! гэж агтчин хүү тэнгэрт ахин цахилгаан цахилахад хашгирлаа. Одоо Бран битгий хэл Жожен, Мира хоёр дуугүй болгохоор зэрэг хашгирлаа.

- Чимээгүй! гэж Бран айсандаа чичирсэн хоолойгоор хэлээд хажуугаар өнгөрөхөд нь Ходорын хөлнөөс зуурахыг хичээв.

Ходор гэнэтхэн дуугүй болж гуйван зогсоод толгойгоо удаанаар хоёр тийш савчин шалан дээр хөлөө зөрүүлэн суулаа. Аянга буухад барагтай сонссонгүй бололтой. Тэд дөрвүүл харанхуй цамхагт суугаад амьсгаа авч ч зүрхэлсэнгүй.

- Бран чи түүнийг яачихав? гэж Мира шивнэв.

- Яагаа ч үгүй. Би мэдэхгүй байна гэж Бран толгойгоо сэгсэрсэн ч хийсэн байлаа. *Би түүний дотор руу Зуны биед ордог аргаар нэвтэрсэн.* Тэр агшин зуур Ходор байсан ч үүндээ айжээ.

- Нуурын цаана ямар нэг зүйл болоод байна. Би цамхаг руу зааж байгаа хүнийг харлаа гэж Жожен мэдэгдэв.

Би айхгүй байна. Бран Винтерфеллийн ханхүү, Эддарт Старкийн хүү бараг л нас бие гүйцсэн хүний зэрэгцээ варг болохоос биш Рикон шиг аймхай бяцхан хүү биш билээ. *Зун ч айхгүй байсан.*

- Тэд магадгүй Амберийнхан байж болох юм. Эсвэл уулнаас бууж ирсэн Кнотт, Норри, Флинтийнхэн юм уу эсвэл Шөнийн харуулын ахан дүүс байх. Тэд хар нөмрөгтэй байна уу, Жожен?

- Шөнө бүх нөмрөг хар харагддаг, эрхэм дээдсээ. Тэгээд ч цахилгаан цахилсан ч ямар хувцастай болох нь харагдахад дэндүү хол байна.

- Хэрвээ тэд хар ахан дүүс бол морьтой байна биз дээ? гэж Мира болгоомжлов.

Браны санаанд өөр зүйл орж ирэхэд,

- Энэ хамаагүй. Тэд хүссэн ч бидэн рүү ирж чадахгүй. Завьтай юм уу нуурын жимийг мэддэггүй л юм бол гэж итгэлтэй хэллээ.

- Нуурын жим! Манай хонгор ханхүү! Түүний зөв Жожен тэд жимийн тухай мэдэхгүй. Мэддэг байлаа ч гэсэн харанхуй шөнө бороонд олж чадахгүй гээд Мира Браны үсийг сөргөөн духан дээр нь үнслээ.

- Шөнө дуусна шүү дээ. Хэрвээ тэд өглөө хүртэл байвал... гээд Жожен яриагаа цааш үргэлжлүүлсэнгүй. Хэсэг хугацааны дараа,

- Тэд нөгөө хүний эхэлж түлсэн галыг тэтгэж байна гэв. Тэнгэрт цахилгаан цахилахад цамхагт гэрэл гялсхийн сүүдэр цоохортов. Ходор урагш хойш гүнгэнэн ганхана.

Тэгтэл Бран агшин зуур Зуны айдсыг мэдрэв. Тэр хоёр нүдээ аниад гурав дахь мэлмийгээ нээхэд хүүгийн арьснаас нөмрөг шиг сугаран гараад цамхагыг ардаа орхилоо.

Ингээд бороон дунд гэдэс дүүрэн бугын махтай бутанд хоргодоход тэнгэрт аянга цахилна. Ялзарсан алим, нойтон навчны үнэрт бараг л хүний үнэрийг дарагдам байсан ч түүний энд байгааг нь мэдэж байв. Бран хангир жингэр хийн модон доогуур хүн явахыг харлаа. Тэр модонд бүдчин толгой дээгүүрээ нөмөрсөн арьс нүд чихийг нь хаажээ. Чоно түүний араар дугуйран тойрч нүцгэн мөчиртэй алимны модон доор очлоо. Хүмүүсийн ярилцах чимээ сонсогдоход бороо, навчны үнэр ханхалж морины огцом айдсын хурц үнэр зурсхийв.

ЖОН

Газар нарсны шилмүүс, салхинд унасан навчис хөглөрч саяхан орсон бороонд чийгтэй нойтон байлаа. Хөлийн дор нойтон навчис шалчигнана. Том нүцгэн царс, өндөр харуул модод, шулуун нарс эргэн тойрон шигүү сүндэрлэнэ. Толгодын дээр орой хүртэл хажуу тал нь зузаан ногоон хөвдөнд хучигдсан ахин нэг эртний хаягдсан хоосон дугуй цамхаг байлаа.

- Хэн чулуугаар ийм зүйл босгодог байна? Аль нэг хаан уу? гэж Игрит асуулаа.

- Үгүй. Зүгээр л дотор нь хүн амьдардаг байсан юм.

- Тэдэнд юу тохиолдоо вэ?

- Тэд үхэж үрэгдэх юм уу явцгаасан гээд Брандоны Бэлэг мянган жилийн өмнө Харуулууд зэрлэг байгальд суурьшин газар хагалж, зөгий үржүүлэн, жимсний цэцэрлэг тарьдаг байснаараа алдартай байлаа. Шинэ Бэлэгт татвар төлдөг тосгон суурин бэхлэлт байгуулагдаж хар ахан дүүсийн хувцсыг оён хэрэгцээтэй бүхий л зүйлсийг нь хийдэг байв. Гэвч энэ бүхэн үгүй болжээ.

- Тэд ийм сайхан цайзыг орхидог тэнэгүүд байна даа гэж Игрит хэлэв.

- Энэ чинь ердөө дугуй цамхаг. Урьд нь жижигхэн лордууд гэр бүл цөөн хэдэн хамжлагынхаа хамт амьдардаг байсан юм. Дээрэмчид ирвэл тэр дээвэр лүү гаран дохио өгнө. Винтерфеллд үүнээс гурав дахин том цамхаг бий гэхэд Игрит түүнийг л ийм зүйл хийчихсэн аятай алмайран ширтлээ.

- Хүн яаж ийм аварга биетийн өргөж даахгүй чулуугаар өндөр зүйл босгодог байна?

Домогт Брандон Баригч Винтерфеллийг босгоход аварга биетүүд тусалсан гэдэг ч Жон үүнийг дурьдсангүй.

- Хүмүүс үүнээс ч өндөр зүйл босгодог. Хуучин хотод Хананаас өндөр цамхаг бий гэж хэлсэн ч Игритийг итгүүлж чадсангүй. *Хэрвээ би чаддаг байсан бол түүнд Винтерфеллийг үзүүлэн шилэн цэцэрлэгээс цэцэг бэлэглэн, Их танхимд хамт найрлан, чулуун сэнтийд заларсан чулуун хаадыг үзүүлэх байсан даа. Бид халуун цөөрөмд усанд орж, хуучин бурхад ширтэж байхад зүрх модны дор дурлалцах байсан.*

Энэ нь сайхан мөрөөдөл байсан ч Винтерфелл хэзээ ч түүнийх болохгүй байв. Тэр Умардын хаан болох дүүгийнх нь билээ. Тэгээд ч тэр Сноу болохоос Старк биш. *Бутагч, өргөсөн андгайгаа зөрчигч, зүсээ буруулагч....*

- Магадгүй бид дараа нь эргэж ирээд энэ цамхагт амьдарч болох юм. Чи үүнийг хүсч байна уу, Жон Сноу? Дараа нь? гэж Игрит асуулаа.

Дараа нь. Дайны дараа. Булаан эзлэлтийн дараа. Зэрлэгүүд Ханыг нураасны дараа... гэсэн үг дотор нь харвалаа.

Лорд эцэг нэг удаа зэрлэгүүдийн эсрэг бамбай болгон шинэ лордуудыг хаягдсан бэхлэлтэнд суулгах тухай ярьж байжээ. Төлөвлөгөө ёсоор бол Харуул Бэлэгийн томоохон хэсэг газрыг тавьж өгөх байсан ч авга ах Бэнжин нь шинэ лордууд Винтерфеллээс илүү Хар цамхагт татвар төлөх учир захирагч лордод хожоотой гэжээ.

- Гэлээ ч гэсэн энэ хаврын хоосон зүүд. Газар нутаг амлаад ч өвөл ирж байхад хүмүүсийг хойд зүг татаж чадахгүй гэж лорд Эддарт хэлжээ.

Хэрвээ өвөл ирж түргэн өнгөрвөл араас нь хавар ээлжлэх болохоор би эдгээр цамхагын нэгийг эцгийнхээ нэрийн өмнөөс сонгон авч болох юм. Лорд Эддарт үхэж, дүү Бэнжин нь алдагдсан болохоор тэдний бамбайн тухай мөрөөдөл хэзээ ч биелэхгүй болжээ.

- Энэ газар нутаг бол Харуулынх гэж Жон хэллээ.

- Гэхдээ хэн ч энд амьдардаггүй шүү дээ гэж Игрит дургуйцсэн байртай хэлэв.

- Танай дээрэмчид тэднийг хөөн зайлуулсан.

- Тэгвэл тэд хулчгар байх нь. Хэрвээ газар нутаг хүссэн бол үлдэж тулалдах ёстой байсан юм.

- Магадгүй тэд тулалдахаас залхсан ч байж мэднэ. Хаалга үүдээ шөнө болгон цуургыг нь түгжиж Харжигнуур хүрэмт шиг амьтад эхнэрүүдийг нь хулгайлах болов уу хэмээн гайхширсаар залхаж гүйцсэн байх. Ургацаа юм уу үнэт зүйлсээ хулгайлуулахгүй байхыг хичээсээр зүдэрч гүйцсэн. Тэгснээс дээрэмчдийн гар хүрэхгүй газар хол байсан нь дээр. *Гэхдээ Хана унавал умард зүг бүхэлдээ дээрэмчдийн хөлд орно.*

- Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Охидыг хулгайлдаг болохоос биш эхнэрүүдийг хулгайлдаггүй юм. Та нар ч гэсэн хулгайч шүү дээ. Та нар бүхий л ертөнцийг авч Ханыг чөлөөт хүмүүсээс хязгаарлан босгосон.

- Бид тэгсэн гэж үү? Яаж тэгсэн хэрэг вэ? гээд Жон заримдаа түүний хичнээн зэрлэг болохыг мартаход урдаас нь сануулдаг байлаа.

- Бурхад газар дэлхийг бүх хүн хуваалцахаар бүтээсэн. Зөвхөн хаад титэм, илдтэйгээ ирж бүгдийг өөрийнх болгон тунхагласан. *Миний мод чи алимыг нь идэж болохгүй. Миний гол горхи чи загасыг нь барьж болохгүй. Миний ой чи ан агнаж болохгүй. Миний газар нутаг, миний ус, миний шилтгээн, миний охиноос сарвуугаа хол татахгүй бол тас цавчина шүү. Үгүй бол чи надад сөгдөж би чамд шинилэх төдийг өгч болох юм гэж тэд хэлсэн.* Чи биднийг хулгайч гэж дуудаж байгаа ч хулгайч хурдан шалмаг зоригтой байдаг. Харин өвдөг сөгдөгч бол ердөө өвдөг сөгдөгч.

- Харма, Хүүдийтэй Яс хоёр загас, алим дээрэмдэхийн тулд ирээгүй. Тэд илд, сүх, халуун ногоо, торго дурдан, арьс хулгайлахаар ирсэн. Тэд зоос, бөгж, үнэт чулуун хундага, торх зуны дарс, өвөлд зориулан нөөшилсөн үхрийн махыг тонож ямар ч тохиолдолд эмэгтэйчүүдийг олзолж Ханын цаана аваачдаг.

- Хэрвээ тэд тэгсэн бол юу гэж? Надад хүүхдийн сул дорой эцэг байснаас хүчтэй хүн хулгайлсан нь илүү дээр.

- Чи ингэж хэлж байгаа ч яаж мэдэж байгаа юм бэ? Чамайг үзэн яддаг хүн чинь хулгайлвал яах болж байна?

- Тэр намайг хулгайлахаар хурдан шалмаг зальжин зоригтой байна. Түүний хөвгүүд хүчирхэг ухаантай болно. Би яагаад ийм хүнийг үзэн ядах ёстой гэж?

- Хэрвээ тэр хэзээ ч усанд ордоггүй баавгай шиг өмхий үнэртэй бол яана.

- Би тэгвэл түүнийг гол руу түлхээд толгой дээрээс нь хувинтай ус цутгана. Тэгээд ч эр хүн цэцэг шиг үнэртэй байх албагүй.

- Цэцгэнд юу нь буруу байна гэж?

- Зөгийнөөс өөр тэр юунд ч хэрэггүй. Харин орондоо бол би ганцхан үүнийг хүсч байна гээд Игрит өмднийх нь урд талаас атгахад Жон бугуйг нь барив.

- Хэрвээ чамайг согтуу хүн хулгайлвал яах болж байна? Хэрцгий юм уу догшин байвал яана? Хэрвээ тэр чамаас хүчтэй байгаад үхтэл чинь зодвол яах болж байна? гээд гараа чангарууллаа.

- Тэгвэл би унтаж байхад нь хоолойг нь огтлоно. Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу гээд Игрит могой загас шиг мурилзан атгалтаас нь мултарлаа.

Би ганцхан зүйлийг мэднэ. Чамайг яс махны зэрлэг болохыг мэднэ. Энэ нь тэднийг инээлдэх юм уу үнсэлдэх үед заримдаа хялбархан мартагдана. Гэвч нэг нь үг дуугарах юм уу ямар нэг зүйл хийхэд Жон гэнэтхэн тэдний ертөнцийн хооронд хана байгааг санадаг байлаа.

- Эр хүн эмэгтэй юм уу хутгатай байж болно. Гэвч хоёуланг нь эзэмшиж болохгүй. Бяцхан охид бүр үүнийг ээжээсээ суралцдаг гээд Игрит эрүүгээ хамгаалсан байртай өргөж өтгөн улаан үсээ сэгсэрлээ.

- Хүмүүс тэнгис далай, тэнгэрийг эзэмшдэггүй шигээ газар нутгийг өөрийн болгож болохгүй. Танай өвдөг сөгдөгчид ингэж бодож байгаа ч Манс чамд өөр гэдгийг нь үзүүлээд өгнө.

Энэ нь бардам сагсуурал хэдий ч хоосон сонсогдож байв. Жон Магнарыг яриаг нь сонсож буй эсэхийг эргэж харав. Эррок, Том Батга, Хемпен Дан гурав тэдний ард хэдхэн метрийн зайд явж байсан ч анхаарал хандуулсангүй. Том Батга өгзөгнийхөө талаар гомдоллож байв.

- Игрит Манс энэ дайнд ялж чадахгүй гэж Жон аяархан дуугаар хэллээ.

- Тэр чадна! Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Чи хэзээ ч чөлөөт хүмүүсийн тулалдахыг харж байгаагүй! гэж Игрит эсэргүүцэв.

Зэрлэгүүд хэнтэй ярьж байгаагаас хамааран чөтгөр шиг юм уу баатар шиг тулалддаг ч энэ нь

ижилхэн зүйлээр төгсдөг билээ. *Тэдний хүн бүр алдар нэрийн төлөө ухаангүй зоригоор тулалддаг.*

- Би та нарыг бүгд эр зоригтой гэдэгт эргэлзэхгүй байгаа ч тулалдааны цагт сахилга бат эр зоригоос илүү чухал. Манс түүний урьд өмнөх Ханын цаадах хаадын адил төгсгөл болно. Харин түүнийг дуусахад чи үхнэ. Та нар бүгд гэхэд Игрит бараг цохиод авах нь уу гэмээр ууртай боллоо.

- Бид бүгд үхнэ. Чи ч гэсэн. Чи одоо хэрээ биш болсон, Жон Сноу. Би чамайг тийм биш гэж андгайлсан болохоор тэгэхгүй байсан чинь дээр шүү гээд цувааны дунд түүнийг мод руу шахан уруул дээр нь үнсэхэд Ямаа Григгийн шавдуулах дуу сонсогдов. Ард нь нэг хүн инээв. Гэсэн ч Жон тоохгүй үнсэлдсээр байлаа. Эцэст нь салах үед Игрит улайжээ.

- Чи минийх. Би чинийх адил чи минийх. Харин бид үхвэл цугтаа үхэх болно. Бүх хүн үхэх ёстой, Жон Сноу. Гэвч бид эхлээд амьд гарна гэж шивнэлээ.

- Тийм. Бид эхэлж амьд гарна гэж Жон хариулав.

Игрит үүнийг сонсоод орсгой шүдээ гарган инээхэд хайрлах сэтгэл төрлөө. *Яс махандаа хүртэл зэрлэг* гэж ахин бодоход сэтгэл нь шимширэн гуниг төрөв. Тэр илд барьдаг гарынхаа хурууг атгаж тэнийлгээд Игрит сэтгэл зүрхэнд нь байгаа зүйлийг мэдвэл яах эсэхийг гайхширлаа. Хэрвээ Жон түүнийг доош суулгаж байгаад Нэд Старкийн хүү, Шөнийн харуул хэвээр гэдгээ хэлвэл урвах болов уу? Тэр үгүй байх гэж найдсан ч эрсдэл гаргаж зүрхэлсэнгүй. Түүний Магнараас урьтан Хар цамхагт хүрэхээс маш олон хүний амь нас хамаарч байгаа учир зэрлэгүүдээс мултрах арга олох ёстой.

Тэд Ханын өмнө талаар хоёр зуун жилийн өмнө орхигдсон Саарал харуул руу буулаа. Том чулуун гишгүүрүүд зууны өмнө нурж унасан ч буухад авирахаас илүү хялбархан байлаа. Стер тэднийг Харуулын байнгын шалгалтаас зайлсхийн Бэлэгийн гүн рүү авч одов. Ямаа Григ энэхүү газар нутагт үлдсэн цөөн тооны тосгоны дэргэдүүр өнгөрүүлээ. Энд тэнд тэнгэр лүү чулуун хуруу шиг ёрдойх цөөхөн дугуй цамхагт хүний бараа харагдсангүй. Тэд хүйтэн чийгтэй толгод, салхитай тал дундуур хүний нүдэнд үзэгдэхгүйг хичээн далд явлаа.

Чи тэднийг ямар ч зүйл хэлсэн хамаагүй эргэлзэлгүй хийх ёстой. Тэдэнтэй хичнээн шаардагдах хугацаанд явж хамт идэн, хамт тулалд гэж Корин хэлсэн билээ. Жон явган явахаас илүүтэй олон бээр газрыг морьтой туулан талх давсыг нь хуваалцаж, Игрит бас хөнжлөө хуваалцаж байсан ч тэд түүнд итгэсэнгүй. Түүнийг урван тэрслэх өчүүхэн төдийл үйлдэл гаргах эсэхийг Тэннийхэн өдөр шөнөгүй харуулдана. Жон тэднээс удахгүй салахгүй бол хэт хожимдох байлаа.

Тэдэнтэй хамт тулалд гэж гэж Корин өөрийн амийг Урт сарвуунд тушаахын өмнө хэлсэн ч одоог хүртэл тийм явдал болсонгүй. *Би ахан дүүсийнхээ иусыг урсгамагц эзгүйрэн хаягдах болно. Би Ханыг сайн зүйлийн төлөө туулсан болохоор эргэж буцах зам байхгүй.*

Өдөр бүрийн аяны дараа Магнар түүнийг дуудан Хар цамхагт байгаа цэргийн тоо хамгаалалтын тухай ширүүн гярхай асуулт тавьдаг байлаа. Жон чадлаараа худал хэлж заримдаа үл

тоомсорлосон дүр эсгэдэг ч Ямаа Григг, Эррок хоёр бас сонсож байгаа болохоор Жоны болгоомжилж байгааг мэдэх байв. Илэрхий худал үг өөрөөсөө урвахад хүрнэ.

Гэвч үнэн аймшигтай байв. Хар цамхагт Хана байтугай өөрийгөө ч хамгаалах хүч, модон шивээ хашаа, газар ухсан шуудуу ч байсангүй. Цайз гэдэг нь хэсэг бүлэг цамхгууд байсны гуравны хоёр нь нурж унажээ. Цэргийн ангийн хувьд Хөгшин Баавгай эргүүлд хоёр зуун хүнийг нь авч явсан байлаа. Тэднээс хэд нь эргэж ирэх бол? Жон үүнийг мэдсэнгүй. Магадгүй цайзад дөрвөн зуугаад хүн үлдсэн байж болох ч ихэнхи нь баригч, бойдоо болохоос эргүүл байсангүй.

Харин Тэннийнхэн ердийн зэрлэгүүдээс илүү сахилга баттай тулаанд хатуужсан дайчид учраас Манс эргэлзээгүй сонгожээ. Хар цамхагын хамгаалалт сохор мэйстер Эймон тэргүүтэй, өрөөсөн нүд нь сохор Клидас, ганц гартай Донал Ной, согтуу септон Селладор, дүлий Дик Фоллард, гурван хуруутай тогооч Хобб, хөгшин сэр Винтон Стоут, Халдер, Бах, Пип, Албетт зэрэг Жонтой хамт сургуулилж байсан хөвгүүдээр хязгаарлагдана. Харин тэднийг захирч буй хүн нь лорд Мормонтыг эзгүйд цайзыг захирахаар томилогдсон улаан нүүртэй тарган бойдоогийн ахлагч Боуэн Марш байв. Долорус Эдд заримдаа Маршийг "Хөгшин Анар" гэж Мормонтыг "Хөгшин баавгай" гэдэгтэй адилтган дуудна.

- Тэр дайсантай тулалдахад урд гарах хүн биш. Тэр дайснаа чиний ардаас тоолно. Тоолохдоо гарамгай чөтгөр байгаа юм гэж Эдд ердийн гашуун хоолойгоороо өгүүлжээ.

Хэрвээ Магнар Хар цамхагыг гэнэдүүлэн дайрвал хядлага болж хөвгүүд дайралтанд өртсөнөө мэдэхээс урд орондоо үхнэ. Жон тэднийг анхааруулах ёстой байсан ч яаж тэр билээ? Түүнийг хэзээ ч хоол хүнс авахаар юм уу анд явуулдаггүйн зэрэгцээ харуулд ганцаар зогсохыг нь зөвшөөрдөггүй байв. Түүнчлэн Игритийн төлөө ч гэсэн айж байлаа. Жон түүнийг авч явалгүй орхивол Магнар урван тэрслэлтийнх нь хариуг авах болов уу? *Хоёр зүрх ганц шиг цохилно...*

Тэд шөнө бүр ижилхэн унтлагын хөнжил хуваалцаж Жоныг унтмагц Игрит цээжин дээр нь толгойгоо тавиад улаан үсээрээ эрүүг нь гижигдэнэ. Түүний үнэр Жоны биеийн нэг хэсэг болжээ. Түүний мурий шүд, цээжин дээр нь гараа тавихад мэдрэгддэг хөх, амных нь амт, баяр хөөр болон цөхрөл гуниг нь хамт байв. Тэр олон шөнийг Игритийн дэргэд дулаан өнгөрүүлэхдээ лорд эцэг нь ээжтэй нь өнгөрүүлэхдээ ингэж гэмшиж байсан болов уу гэж гайхширна. *Игрит урхи тавьж Манс Райдер намайг үүн рүү түлхсэн.*

Жон өдөр бүрийг зэрлэгүүдийн дунд өнгөрүүлэхдээ улам дордож байв. Тэр энэ хүмүүсээс урваж үхэх аргыг нь хайх ёстой. Жон тэдэнтэй нөхөрлөхөөс илүүтэй Игритийн хайрыг хүссэнгүй. Гэсэн ч Тэннийнхэн хоорондоо хуучны хэлээр ярилцан Жонтой бараг харьцдаггүйгээрээ Хана руу авирсан Жарлын морьтонгуудаас өөр байв. Жон хичнээн хичээж зай барьсан ч туранхай чимээгүй Эррок, нийтэч Ямаа Григг болон Кворт, Боджер, Хемпен Дат олс хийгч зэрэг хөвгүүдээс зайлсхийх арга байсангүй. Хамгийн дор нь Дел гэдэг Жоны үеийн морин царайтай ямар зэрлэг охин хулгайлах тухай мөрөөдөн ярьдаг хүү байв.

- Тэр яг л чиний Игрит шиг азтай байна. Тэр гал үнсэгч байх болно.

Жон хэлээ хазлаа. Тэр Делийн охин болон Боджерийн ээж, Хенк Хелм хоёры ирсэн тэнгисийн

тэртээх нутаг, Нүүрний арлын ногоон хүмүүс рүү очихыг хүсч байгаа Григг юм уу хандгайнд хөөгдөн мод руу гарсан Тоефингэрийн тухай мэдэхийг хүссэнгүй. Түүнчлэн том Батгын өгзгөн дэх хатиг холгогдож, Чулуун эрхий хуруу хэр их шар айраг уусан тухай болон Квортын бага дүү Жарлтай хамт явахгүй байхыг гуйсныг сонсохыг хүссэнгүй. Кворт арван дөрвөн наснаас хэтрээгүй ч аль хэдийн өөртөө эхнэр хулгайлж замд хүүхэдтэй болгожээ.

- Магадгүй хүү минь цайзад төрөх байх. Цайзад лорд шиг төрнө гэж хүү сагсуурна. Тэр цайз гэдгийг харсан харуулын цамхгаа гэж бодож байв.

Жон Сүнсийг одоо хаана байгаа тухай эрэгцүүллээ. Тэр Хар цамхаг руу явсан болов уу эсвэл чонын сүрэгтэй ойд гүйж байгаа юм уу? Тэр зэрлэг чоноо мэдрэх битгий зүүдэндээ хүртэл харсангүй. Энэ нь түүний дотор нэгэн хэсэг байхгүй болсон мэт санагдана. Дэргэд нь Игрит унтаж байсан ч ганцаардах сэтгэл төрнө. Жон ганцаар үхэхийг хүссэнгүй.

Үд дунд модод шингэрч эхлэн тэд дорно зүг тал дундуур явлаа. Бүсэлхий хүртэл өндөр ургасан өвсөнд зэрлэг буудай салхинд чимээгүй ганхан дулаахан цэлмэг өдөр байв. Наран жаргах зүгт үүлс хуралдаж эхэлжээ. Бараан үүл удахгүй шаргал наранг залгихад Лен хүчтэй шуурга ирж байна гэж хэлэв. Түүний ээж ойн шидтэн байсан болохоор бүх морьтонгууд цаг агаарыг зөгнөн хэлэх чадварыг нь зөвшөөрдөг байлаа.

- Тэнд ойрхон тосгон байна. Хоёр юм уу гурван милийн зайд. Бид тэнд хоноглож болох юм гэж Ямаа Григг Магнард хэлэхэд Стир даруй зөвшөөрөв.

Тэднийг хүрэхтэй зэрэг харанхуй болж шуурга эхэллээ. Нуурын дэргэдэх тосгон удаан хугацааны өмнө орхигдсон тул ихэнхи байшин нь нурж унажээ. Урьд нэгэн цагт аян замын хүмүүсийг тавтай морилохын тэмдэг болон угтдаг байсан жижигхэн дэн буудал дээвэр нь нураад хагас хана үлджээ. *Бид энд хоргодох газар олно* гэж Жон дүнсгэр бодлоо. Цахилгаан цахилахад нуурын арал дээр дугуй чулуун цамхаг харагдсан ч завьгүй бол хүрч чадахгүй байлаа.

Эррок, Дел хоёр балгасан дундуур тандуул хийхэд Дел бараг явсан даруй буцаж ирэв. Стир морьтонгуудын цувааг зогсоож арван Тэннийг урагш гарт нь жад бариулан илгээлээ. Тэгэхэд л Жон дэн буудлын ханан зууханд бүдэг гал улалзахыг олж харлаа. *Бид ганцаар биш байна.* Айдас түүнийг дотор могой шиг баглав. Тэгтэл морь янцгаах чимээ сонсогдсоноо хашгиралт гарлаа. *Тэдэнтэй явж цуг идэн хамт тулалд* гэж Корин хэлсэн билээ.

Гэвч тулалдаан дуусчээ.

- Ердөө ганц хүн байна. Морьтой өвгөн гэж Эррок буцаж ирэхдээ хэлэв.

Магнар хуучны хэлээр хашгиран тушаал өгөхд хориод Тэннийхэн тосгон нэгжихийн тулд тарж бусад нь байшингуудын нурсан чулуу зэрлэг ургамал дунд хүн нуугдсан эсэхийг шалгав. Үлдсэн хүмүүс зууханд татагдан дээвэргүй буудалд шахцалдан цугларлаа. Өвгөний түлсэн хугалсан мөчир дулаанаасаа илүү утаа ихтэй байсан ч ийм зэврүүн бороотой шөнө дулаанд ээх таатай байлаа. Тэннийн хоёр хүн нөгөө хүнийг газар түлхээд юмыг нь нэгжив. Нэг нь морийг нь авахад гурван хүн эмээлийн ганзгыг нь ухлаа.

Жон цааш явахад ялзарсан алим хөлийн дор няц гишгэгдэнэ. *Стир түүнийг ална.* Магнар Саарал харуулын тухай өвдөг сөгдөгч нартай тааралдах үед түгшүүр өгүүлэхгүйн тулд тэр дор нь алах тухай ярьсан билээ. *Тэдэнтэй явж, тэдэнтэй идэн, хамт тулалд.* Энэ бол зэрлэгүүдийг хөгшин өвгөний хоолой огтолж байхад юу ч хийхгүй хараад зогсоно гэсэн үг үү?

Тосгоны захын ойролцоо Жон Стирын тавьсан харуултай нүүр тулгарав. Тэннийн хүн Хуучны хэлээр ямар зүйл гүвтнэн жадаараа буудлын зүг зангав. *Байх ёстой газар луугаа буц гэж Жон таалаа. Гэвч хаашаа гэж?*

Тэр усны зүг яван нурсан байшин налсан шавардсан бургасан ханын дор бараг хуурай газар олов. Тэнд сууж байхад нь Игрит ирж нуурын мандал шавшиж буй бороон дусал руу харлаа.

- Би энэ газрыг мэднэ. Дараагийн удаа цахилгаан цахилах үеэр тэр цамхаг руу харж надад юу харж байгаагаа хэлээрэй гэж Жон түүнийг дэргэд нь суухад хэлэв.

- Хэрвээ чи дуртай байгаа бол тэгье л дээ. Тэннийн зарим хүн тэнд чимээ сонссон гэсэн. Хашгиралт гэсэн байхаа.

- Аянгын нүргээн.

- Тэд хашгиралт гэсэн. Магадгүй сүнс ч байж болох юм.

Бэхлэлт хий үзэгдэлтэй байрын баргар төрхтэй эргэн тойрон бороо шавших нуурын усан дахь чулуурхаг арал дээр шуурганы эсрэг зогсож байв.

- Хоёулаа тийшээ очиж харах уу. Одоо байгаагаасаа илүү норохгүй байх гэж Жон хэлэв.

- Сэлээд үү? Энэ шуурганд уу? Энэ чиний миний хувцсыг тайлуулах мэх үү, Жон Сноу? гээд Игрит гаргасан санаанд хөхөрлөө.

- Одоо надад үүнд мэх хэрэгтэй болсон уу? Эсвэл чи сөрөг сэлж чаддаггүй юм уу? гээд Жон хүүхэд байхдаа Винтерфеллийн гүн шуудуунд сэлж сурсан сайн сэлэгч байлаа.

- Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу. Намайг хагас загас хүн гэдгийг чи мэдэх болно гээд Игрит гарыг нь чимхлээ.

- Хагас загас, хагас ямаа, хагас морь. Чиний дэндүү олон зүйл хагас юм, Игрит гээд Жон толгой сэгсэрлээ. - Бидэнд ийм газар сэлэх хэрэг байхгүй гэж бодож байна. Бид явган явна гэхэд Игрит урдаас нь гайхширан ширтэв.

- Усан дээгүүр явах юм уу? Энэ өмнөдийн шид үү?

- Шид биш... гэж Жон эхэлсэн ч тэнгэрт аварга том цахилгаан цахилахад нуурын мандал цайран ертөнц агшин зуур өдрийн гэрэлтэй болов. Аянгын нүргээн чих дөжрөм чанга байсан тул Игрит дуу алдан чихээ таглалаа.

- Чи харав уу? Чи харсан уу? гэж Жон чимээ намдан ахин шөнийн харанхуй болоход хэлэв.

- Шаргал. Энэ чиний хэлэх гээд байсан зүйл үү? Чулууны оройд шаргал зүйл байна.

- Бид түүнийг хэрмийн шүд гэж дууддаг. Үүнийг удаан хугацааны өмнө алтаар будсан юм. Энэ бол хатан хааны титэм.

Нуурын тэртээ цамхаг ахин харанхуйлсан ч бүүдгэр дүрс нь харагдаж байлаа.

- Хатан тэнд амьдарч байгаа болов уу? гэж Игрит асуув.

- Хатан тэнд шөнө байдаг гээд Хөгшин Нан түүнд ийм үлгэр ярьж өгөхөд мэйстер Лювин ихэнхийг нь баталжээ.

- Эвлэрүүлэгч Жэйхерис хаан Алиссана гэдэг эхнэртэй байсан юм. Түүнийг удаан хугацаанд хаанчилсан учир Хөгшин хаан гэж дуудаг ч залуу байхдаа төмөр хаан ширээнд суужээ. Ингээд тэрбээр хаант улс даяар аялдаг байлаа. Нэг удаа Винтерфеллд ирэх үедээ хатнаа зургаан луу ордны хагасын хамт авчирсан гэдэг. Хаан умардын захирагчтай ярилцаж байх зуур Алиссана уйдсандаа Мөнгөн жигүүр луугаа унан хойд зүг Ханыг харахаар нисчээ. Тэр энэхүү тосгон байсан газар зогссон байна. Үүний дараа жирийн ардууд бэхлэлтийн оройг түүнийг шөнө ирэх үед өмссөн байсан алтан титэмтэй адилхан буджээ.

- Би хэзээ ч луу харж байгаагүй юм байна.

- Хэн ч харж байгаагүй. Сүүлчийн луу хэдэн зуун жилийн өмнө үгүй болсон. Энэ бол түүнээс өмнө болсон явдал.

- Хатан Алиссана гэж чи хэлсэн үү?

- Сайн хатан Алиссана гэж тэд түүнийг хожим нэрлэх болсон. Ханын цамхгуудын нэгийг түүний нэрээр Хатны хаалга гэж нэрлэсэн юм. Харин түүнээс өмнө Цасан хаалга гэж дууддаг байсан.

- Хэрвээ тэр тийм сайн байсан юм бол Ханыг буулгах ёстой байсан юм.

Үгүй. Хана хаант улсыг хамгаалж байгаа. Өөрүүдээс болон танай төрлүүдээс ч гэсэн хонгор минь.

- Надад луу мөрөөддөг өөр нэг найз байсан. Одой хүн. Тэр надад хэлэхдээ...

- ЖОН СНОУ! гээд Тэннийн нэг хүн дээгүүр нь хөмсөг зангидан цухуйж,

- Магнар чамтай уулзахыг хүсч байна гэхэд Жон түүнийг Хана руу авирахаас өмнө агуйн гадна талд байхад ирсэн хүн гэж бодсон ч итгэлтэй байсангүй. Тэр хөл дээрээ өндийв. Игрит түүнтэй цуг явдаг нь үргэлж Стирийг хөмсөг зангидуулдаг ч Жон түүнийг орхихыг оролдох тоолонд чөлөөт эмэгтэй болохоос биш өвдөг сөгдөгч бус болохоо сануулна. Тэр хүссэн газар луугаа ирж явдаг байв.

Тэднийг очих үед Магнар нийтийн өрөөний шалан дээр ургасан модны доор зогсож байлаа. Түүний барьсан хүнийг зуухны өмнө өвдөг сөгдүүлэн модон жад, хүрэл илдээр хүрээлжээ. Тэр Жоныг ойртохыг харсан ч үг дуугарсангүй. Бороо ханын дагуу урсаж модонд үлдсэн навчийг шавшихад зуухны утаа өтгөрөн баагив.

- Тэр үхэх ёстой. Үүнийг гүйцэтгэ, хэрээ минь гэж Магнар Стир тушаав.

Өвгөн үг дуугарсангүй. Зөвхөн зэрлэгүүдийн дунд зогсож байгаа Жон руу харлаа. Утаа, бороон дунд зөвхөн галын гэрэл байсан болохоор тэр Жоныг хонины арьсан нөмрөгнөөс ондоо хар хувцастай болохыг харсангүй. *Эсвэл тэр харсан юм болов уу?*

Жон Урт сарвууг хуйнаас нь сугалав. Бороонд илд угаагдан галын дүнсгэр шаргал гэрэл ирмэг дээгүүр нь ойн тоглов. *Ийм жаахан гал хүний аминд хүрч байх гэж.* Жон Корин тэднийг Хашгираа даваанд гал түлэх үед хэлсэн үгийг саналаа. *Гал энд амьдрал хайрлаж байгаа ч гэсэн үхэл өгч чадна.* Гэхдээ тэр бол Хананаас цаадах хуульгүй Мөсөн соёотын өндөр даваа байсан. Харин энэ Винтерфеллийн хүчин дор Шөнийн харуулын хамгаалдаг Бэлэг байлаа. Энд хүн түлсэн галынхаа төлөө үхэлгүй чөлөөтэй түүдэг өрдөж болно.

- Чи юунд эргэлзээ вэ? Түүний алж дуусга гэж Стир хэлэв.

Тэгсэн ч гэсэн олзны хүн үг дуугарсангүй.

<<Өршөө гэх юм уу эсвэл та нар миний морь, зоос, хоолыг авч болно. Зөвхөн амийг минь үлдээгээч. Үгүй, гуйж байна би та нарт муу зүйл хийгээгүй" зэрэг олон янзын зүйл хэлж уйлж дуулан тэнгэр бурхнаа дуудаж болох байлаа. Гэсэн ч үг түүний амийг аврахгүй билээ. Магадгүй тэр үүнийг мэдэж байсан биз. Иймээс үг дуугүй Жоныг ширтэв.

Чи тэдний хэлсэн зүйлийг эргэлзэлгүй хийх ёстой. Тэдэнтэй хамт мордон, тэдэнтэй идэн хамт тулалд... Гэвч хөгшин хүн эсэргүүцэл үзүүлсэнгүй. Ердөө азгүй хүн ажээ. Түүний хэн байсан хаанаас ирсэн болон хөөрхийлөлтэй морьтойгоо хаашаа явж байсан нь хамаа байсангүй.

Тэр хөгшин хүн байна. Тавь юм уу жаран настай байх. Тэр урт удаан амьдралыг туулсан. Тэннийхэн тэртээ тэргүй түүнийг алах болохоор би аврахын тулд юу ч хэлж хийгээд нэмэргүй гэж Жон өөртөө хэлэв. Урт сарвуу гарт нь тугалга цутгасан мэт даахын аргагүй хүндэрлээ. Өвгөн түүн рүү ширтсэн хэвээр нүд нь том болсон харагдана. Би цавчвал энэ нүд хамхигдана. Магнар бас түүн рүү ширтэж байсан тул бараг үл итгэл нь мэдрэгдлээ. *Энэ хүн үхнэ. Миний гар алсан гээд ямар ялгаа байна?* Ганц бөгөөд түргэн цэвэр цавчилт. *Урт сарвуу бол Валирианы давтсан ган. Яг л Мөс шиг.* Жон оргон зайлагчийг цаазлах үед цасан дээр толгой нь улаан мөр татуулан өнхөрснийг саналаа. Эцгийнх нь илд, эцгийнх нь үг, эцгийнх нь царай...

- Түүнийг ал, Жон Сноу. Чи хийх ёстой. Өөрийгөө хэрээ биш чөлөөт хүн гэдгийг батал хэмээн Игрит шавдуулав.

- Галын дэргэд сууж байгаа өвгөнийг үү?

- Орелл бас галын дэргэд сууж байсан. Чи түүнийг хангалттай түргэн алсан. Чи намайг эмэгтэй хүн гэдгийг мэдээгүй бол бас алах байсан. Тэгэхэд би унтаж байсан гээд Игритийн ширтэлт байдлыг улам хүндрүүлэв.

- Тэр чинь өөр хэрэг. Чи цэрэг... харуул байсан.

- Танай хэрээнүүд үүнийг харахыг ч хүсээгүй. Бид ч гэсэн ялгаагүй. Энэ ижил. Түүнийг ал гэхэд Жон өвгөнөөс эргэлээ.

- Үгүй.

Өндөр хүйтэн төрхтэй Магнар заналхийлэн ойртов.

- Би тийм гэж хэлж байна. Би энд тушааж байгаа.

- Чи Тэннийхэндээ л тушаах болохоос биш чөлөөт хүмүүсийг биш.

- Би ямар ч чөлөөт хүн харахгүй байна. Би хэрээ болон хэрээний эхнэрийг харж байна.

- Би хэрээний эхнэр биш! гээд Игрит хутгаа хуйнаас нь шүүрлээ. Тэр яах ийхийн зуургүй гурав алхаж өвгөний дагзнаас угзран хоолойг нь нэг чихнээс нөгөө чих хүртэл огтлов. Тэр үхэхдээ хүртэл дуу гарсангүй.

- Чи юу ч мэддэггүй юм байна, Жон Сноу! гэж Игрит түүн рүү хашгиран цустай хутгаа хөлд нь чулуудлаа.

Магнар хуучны хэлээр ямар нэг зүйл хэлэв. Тэр магадгүй Тэннийхэнд Жоныг зогсож буй газар нь ал гэж хэлсэн байж болох ч Жон үнэнийг мэдсэнгүй. Тэнгэрт аянга цахилан цэнхэр цагаан цахилгаан цахилгаан нуурын цамхагын оройд тусахад уур хилэн мэдрэгдэн аянгын дуунд шөнө чичирлээ.

Тэгтэл дунд нь үхэл үсрэн буув.

Цахилгаан цахихад Жон нүд гялбасан ч хашгиралт сонсогдохоос өмнө сүүдэр харав. Эхний Тэнн өвгөн шиг үхэхэд тас татуулсан хоолойноос нь цус урсав. Тэгтэл гэрэл үгүй болж дүрс цааш архирч мурилзан эргэхэд ахин нэг хүн харанхуйд уналаа. Эргэн тойрон хараал зүхэл, хашгиралт, өвчинд шаналсан хашгиралт дэгдэв. Жон Том Бтга хойш бүдрэн ардаа байсан гурван хүнийг дарж унахыг харлаа. *Сүнс. Сүнс Ханан дээгүүр харайж* гэж агшин зуур бодолд нь орж ирэв. Гэвч шөнийн харанхуйг гийгүүлэн цахилгаан цахихад Делийн цээжин дээр эрүүнээс нь цус савирсан чоно зогсож байхыг харлаа. *Саарал. Тэр саарал өнгөтэй байна.*

Харанхуйд аянгын ниргэлт буухад Тэннийнхэн дундуур нь давхисан чоныг жадны үзүүрээр чичив. Өвгөний гүү үхлийн үнэрийг аваад цоройж туурайгаараа газар цавчлаа. Урт сарвуу Жоны гарт хэвээр байв. Агшин зуур тэр хэзээ ч ийм агшин ахин олдохгүйг мэдэрлээ.

Жон эхний хүнийг цавчиж унагаад чоно руу эргэж хоёр дахийг нь түлхэн гурав дахийг нь цавчлаа.

Энэ бүх самуун дунд Жоны нэрийг нэг хүн дуудсан ч Игрит, Магнар хоёрын алин байсан мэдэгдсэнгүй. Морь тогтоохыг оролдож зэрлэг цааш болон түүнийг харсангүй. Урт сарвуу өд шиг хөнгөн байв. Жон түүний шилбэний ар луу цавчихад төмөр ясанд тултал шигдэв. Зэрлэг унахад гүү ухасхийн давхисанд Жон дэлнээс барьж нуруунд нь амжин мордлоо. Гүү цоройсноо урагш давхихад өрөөсөн туурай нь Тэннийн хүний шанаанд бууж дотор муухайрам чахрав.

Зугтах үед Жон морио залсангүй. Жолоог нь байгаа чигээр тавиад шавар, бороо, аянгын дундуур давхив. Нойтон өвс нүүр лүү нь шавхуурдан чихнийх нь хажуугаар жад сүнгэнэн өнгөрлөө. *Хэрвээ морьттой нь ивээж бүдрүүлсэнгүй. Харанхуй тэнгэрт цахилгаан цахилахад аянган тал дунд бууна.* Ард нь хашгиралт намдлаа.

Удаан хугацааны дараа бороо зогслоо. Жон ганцаар өндөр ургасан хар өвсөн тэнгист явж байв. Баруун талын гуя нь хатгуулан өвдөв. Тэр доошоо хараад ард нь сум зоогдсоныг хараад гайхлаа. *Хэзээ ингэсэн юм бол?* Жон сумнаас барьж сугалах гэсэн ч толгой нь хөлийн маханд гүн шигдсэн болохоор чангаахад тэсгэлгүй өвдөв. Тэгтэл дэн буудалд болсон зүйлийн тухай бодоход туранхай хэрзгэр аймшигт саарал араатан санагдав. *Энэ ердийн чононоос том байсан. Тэгвэл зэрлэг чоно байх нь. Энэ тийм байсан.* Жон хэзээ ч ийм хурдан амьтан харж байсангүй. *Яг л хөнгөн салхи шиг.* Робб умард зүг ирсэн юм болов уу?

Жон толгойгоо сэгсэрлээ. Тэр хариултыг нь мэдсэнгүй. Чоно, өвгөн болон Игритийн тухай бодохоос хүнд байв.

Морины нуруунаас арай ядан буугаад шархтай хөлөө доогуур нь бүсээр баглахдаа хашгирлаа. *Энэ өвдөх болно.* Араас нь сум харвасныг бодоход сайн зүйл хүлээх хэрэг байсангүй. Жон гараараа сумны өднөөс барин гүн амсгаа аваад сумыг урагш түлхэн хараал тавин дуу алдлаа. Сумыг зогсоох аргагүй дэндүү өвдөж байв. *Би яг л нядлуулсан гахай шиг цус алдаж байна* гэж бодсон ч толгой нь цухуйх хүртэл яах ч арга байсангүй. Тэр ярвайн ахин оролдсоноо төдөлгүй зогсож чичирлээ. *Ахиад нэг.* Энэ удаад Жон орь дуу тавин хашгирсан ч сумны толгой гуяных нь урд талд цухуйлаа. Тэр цустай өмдөө хойш нь шуугаад сумыг хөл дундуураа удаанаар татахдаа хэзээ ухаан алдсанаа мэдсэнгүй.

Нэг л мэдэхэд сумаа барьж газар хэвтээд цус алдаж хөдлөхөд дэндүү сульдсан байлаа. Хэсэг хугацааны дараа хөдлөхгүй бол цус алдаж үхэхээ ойлгов. Жон гүүнийхээ ус ууж байсан гүехэн горхи руу мөлхөж хүйтэн усаар гуяа шавшаад нөмрөгнөөсөө цуулан даавууны өөдсөөр чанга боолоо. Сумаа ч гэсэн угааж гартаа эргүүлэн үзэв. Саарал өдтэй юм болов уу эсвэл цагаан өдтэй юм уу? Игрит сумаа цагаан саарал галууны өдөөр өдөлдөг байсан. *Тэр намайг зугтахад арваас сум харвасан юм биш байгаа?* Жон үүнийх нь төлөө буруутгасангүй. Магадгүй түүний морийг нь онилсон ч байж мэдэх. Хэрвээ гүү нь оногдсон бол Жоны үхэл ирэх байсан.

- Аз болж миний хөлөнд зоогдож гэж амандаа хэлэв.

Тэр морио өвс зулгааж идээшлэх зуур хэсэг амарлаа. Гүү хол явсангүй. Энэ нь сайн хэрэг болжээ. Өрөөсөн хөл дээрээ догонцоод морины араас хэзээ ч гүйцэхгүй билээ. Иймээс бүх хүчээ гарган

хөл дээрээ босож морины нуруунд мордлоо. *Би яаж түүнийг урд нь эмээл, дөрөөгүй нэг гартаа илдтэй унасан юм бол?* Энэ нь бас нэг асуулт байсан ч хариулт байсангүй.

Алсад аянга сулхан нижигнэн толгой дээр хуралдсан үүлс сарнижээ. Жон тэнгэр лүү харан Мөсөн лууг олоод гүүгээ хойд зүг Ханын Хар цамхаг руу эргүүлэв. Өвгөний морийг өсгийгөөрөө гуядахад гуяны булчин чинэрэн өвдсөнд ярвайлаа. *Би гэр лүүгээ явж байна.* Гэхдээ хэрвээ энэ үнэн юм бол түүний дотор яагаад ийм хоосон оргиод байгаа юм бол?

Жон үүр гэгээрэх хүртэл давхин явахад толгой дээрээс нь одод ширтэнэ.

НЭГДҮГЭЭР ДЭВТЭР ТӨГСӨВ

Table of Contents

[ЭХЛЭЛ](#)
[ЖЭЙМИ](#)
[КАТЕЛИН](#)
[АРЪЯА](#)
[ТИРИОН](#)
[ДАВОС](#)
[САНСА](#)
[ЖОН](#)
[ДАНЕРИС](#)
[БРАН](#)
[ДАВОС](#)
[ЖЭЙМИ](#)
[ТИРИОН](#)
[АРЪЯА](#)
[КАТЕЛИН](#)
[ЖОН](#)
[САНСА](#)
[АРЪЯА](#)
[СЭМВЭЛ](#)
[ТИРИОН](#)
[КАТЕЛИН](#)
[ЖЭЙМИ](#)
[АРЪЯА](#)
[ДАНЕРИС](#)
[БРАН](#)
[ДАВОС](#)
[ЖОН](#)
[ДАНЕРИС](#)
[САНСА](#)
[АРЪЯА](#)
[ЖОН](#)
[ЖЭЙМИ](#)
[ТИРИОН](#)
[СЭМВЭЛ](#)
[АРЪЯА](#)
[КАТЕЛИН](#)
[ДАВОС](#)
[ЖЭЙМИ](#)
[ТИРИОН](#)
[АРЪЯА](#)

